

Тунхаглалын эцсийн хувилбар
2018 оны 8 дугаар сар

УСНББОУС™

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт™

УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр

IPSASB

Улсын Секторын Нягтлан
Бодох Бүртгэлийн Олон
Улсын Стандартын Зөвлөл™



**Улсын Секторын Нягтлан
Бодох Бүртгэлийн Олон
Улсын Стандартын Зөвлөл™**

Энэхүү баримт бичгийг Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ™) боловсруулж, баталсан.

УСНББОУСЗ-ийн зорилго нь улсын секторын нягтлан бодох бүртгэлийн өндөр чанартай стандартуудыг тогтоох, тэдгээрийн мөрдөлт ба хэрэгжүүлэлтэнд туслалцаа үзүүлэх, ингэснээр дэлхий дахины практикын чанар ба тууштай байдлыг сайжруулах, улсын секторын санхүүгийн ил тод, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх замаар олон нийтийн эрх ашигт үйлчлэх явдал юм.

Энэхүү зорилгыг биелүүлэхийн тулд УСНББОУСЗ нь улсын секторын байгууллагууд, үүн дотроо үндэсний, бүсийн, орон нутгийн засгийн газрууд болон засгийн газрын холбогдох агентлагууд ашиглахад зориулсан Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд™ (УСНББОУС-ууд™) ба Санал Болгосон Практик Удирдамж (СБПУ)-уудыг гаргадаг.

УСНББОУС нь нийтлэг зорилготой санхүүгийн тайлан (санхүүгийн тайлан)-д хамааралтай бөгөөд бүрэн эрхтэй байдаг. СБПУ-ууд нь санхүүгийн тайланг биш, харин нийтлэг зориулалттай санхүүгийн тайлан илтгэл (НЗСТИ)-ийг бэлтгэх сайн практикын талаархи заавар удирдамжаар хангадаг тунхаглалууд юм. УСНББОУС-аас ялгаатай нь, СБПУ нь шаардлагуудыг тогтоодоггүй. Санхүүгийн тайлан биш, харин НЗСТИ-тэй холбоотой бүх тунхаглалууд нь одоогоор СБПУ-ууд байна. СБПУ-ууд нь мэдээлэлд хамаарах баталгааны (хэрэв байгаа бол) түвшний талаархи заавар удирдамжаар хангадаггүй.

УСНББОУСЗ-ийн үйл ажиллагаагаа явуулах бүтэц болон үйл явцад Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо™ (ДНБХ™) дэмжлэг үзүүлдэг.

Зохиогчийн эрх © 2018 оны 8 дугаар сар, Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ). Зохиогчийн эрх, худалдааны тэмдэг, зөвшөөрлийн талаархи мэдээллийг [417-р хуудаснаас](#) үзнэ үү.

УСНББОУС 41–САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР**АГУУЛГА**

	Параграф
Зорилго	1
Цар хүрээ	2-8
Тодорхойлолт	9
Хүлээн зөвшөөрөлт ба үл хүлээн зөвшөөрөлт	10-38
Анхны хүлээн зөвшөөрөлт	10-11
Санхүүгийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлт	12-34
Санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт	35-38
Ангилал	39-56
Санхүүгийн хөрөнгийн ангилал	39-44
Санхүүгийн өр төлбөрийн ангилал	45-46
Дагалдах үүсмэл хэрэглүүр	47-53
Дахин ангилал	54-56
Хэмжилт	57-112
Анхны хэмжилт	57-60
Санхүүгийн хөрөнгийн дараагийн тайлант үеийн хэмжилт	61-63
Санхүүгийн өр төлбөрийн дараагийн тайлант үеийн хэмжилт	64-65
Бодит үнэ цэнийн хэмжилтийн анхаарах зүйлс	66-68
Хорогдуулсан өртгөөр хэмжилт	69-72
Үнэ цэнийн бууралт	73-93
Санхүүгийн хөрөнгийн дахин ангилал	94-100
Олз ба гарз	101-112
Хейжийн нягтлан бодох бүртгэл	113-155
Хейжийн нягтлан бодох бүртгэлийн зорилго ба цар хүрээ	113-115
Хейжийн хэрэглүүр	116-121
Хейжийн зүйлс	122-128
Хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуур	129
Шалгуур хангах хейжийн харилцааны нягтлан бодох бүртгэл	130-145
Зүйлсийн бүлгийн хейж	146-151
Зээлийн эрсдлийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилах боломж	152-155
Хүчин төгөлдөр болох хугацаа ба шилжилт	156-184
Хүчин төгөлдөр болох хугацаа	156-157
Шилжилт	158-184
Хавсралт А: Мөрдөх заавар удирдамж	
Хавсралт Б: Гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын хейж	
Хавсралт В: Санхүүгийн өр төлбөрийг өмчийн хэрэглүүрээр барагдуулах	
Хавсралт Г: Бусад Стандартуудад оруулсан нэмэлт өөрчлөлтүүд	
Дүгнэлтийн үндэслэл	
Үлгэрчилсэн жишээ	
Хэрэгжүүлэх заавар удирдамж	

Зорилго

1. Энэ Стандартын зорилго нь *санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн* санхүүгийн тайлагналын зарчмуудыг тогтооход оршино. Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн санхүүгийн тайлагнал нь байгууллагын ирээдүйн мөнгөн гүйлгээний дүн, хугацаа, тодорхойгүй байдлын талаар өөрсдийн үнэлгээг хийхэд зориулсан, хамааралтай ба ач холбогдолтой мэдээллийг санхүүгийн тайлангийн хэрэглэгч нарт толилуулах явдал юм.

Цар хүрээ

2. Бүх байгууллагууд нь доор дурдсанаас бусад, бүх төрлийн санхүүгийн хэрэглүүрийн хувьд энэ Стандартыг мөрдөнө:
 - (a) УСНББОУС 34, *Тусдаа Санхүүгийн Тайлан*, УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*, УСНББОУС 36, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт*-ын дагуу тайлагнадаг хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоо. Гэвч зарим тохиолдолд УСНББОУС 34, УСНББОУС 35, УСНББОУС 36 нь хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоог энэхүү Стандартын зарим эсвэл бүх шаардлагуудын дагуу тайлагнахыг байгууллагаас шаарддаг буюу зөвшөөрдөг. Хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоотой холбоотой үүсмэл хэрэглүүр нь УСНББОУС 28, *Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга*-д заасан тухайн байгууллагын өмчийн хэрэглүүрийн тодорхойлолтыг хангахгүй тохиолдолд байгууллагууд нь тэрхүү үүсмэл хэрэглүүрт мөн энэ Стандартыг дагаж мөрдөнө.
 - (б) УСНББОУС 13, *Түрээс*-ийг мөрдөх түрээсийн дагуу үүсэх эрх ба үүрэг. Гэхдээ:
 - (i) Түрээслүүлэгчийн хүлээн зөвшөөрсөн санхүүгийн түрээсийн авлага (өөрөөр хэлбэл, санхүүгийн түрээс дэх цэвэр хөрөнгө оруулалт) ба үйл ажиллагааны түрээсийн авлага нь энэ Стандартын үл хүлээн зөвшөөрөлтийн болон үнэ цэнийн бууралтын шаардлагуудад захирагдана;
 - (ii) Түрээслэгчийн хүлээн зөвшөөрсөн түрээсийн өр төлбөр нь энэ Стандартын 35-р параграфт заасан үл хүлээн зөвшөөрөлтийн шаардлагуудад захирагдана;
 - (iii) Түрээсийг дагалдан үүсдэг үүсмэл хэрэглүүр нь энэ Стандартын дагалдах үүсмэл хэрэглүүрийн шаардлагуудад захирагдана.
 - (в) УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ийг мөрдөх ажилтны тэтгэмжийн хөтөлбөрийн дагуу хүлээх ажил олгогчийн эрх ба үүрэг.
 - (г) Тухайн байгууллагын гаргасан бөгөөд УСНББОУС 28-д заасан өмчийн хэрэглүүрийн тодорхойлолтыг хангах, эсвэл УСНББОУС 28-ын 15, 16 буюу 17, 18-р параграфуудын дагуу өмчийн хэрэглүүр гэж анилах шаардлагатай санхүүгийн хэрэглүүр (үүн дотроо опцион ба баталгаа). Гэвч санхүүгийн хэрэглүүр нь дээрх (а)-д заасан гажих нөхцлийг хангахаас бусад тохиолдолд ийм өмчийн хэрэглүүрийн эзэмшигч нь тэдгээр хэрэглүүрийн хувьд энэ Стандартыг мөрдөнө.
 - (д) Дараах гэрээний дагуу үүсэх эрх ба үүрэг:
 - (i) 9-р параграфт заасан, санхүүгийн баталгааны гэрээний тодорхойлолтыг хангах даатгалын гэрээний дагуу үүсэх гаргагчийн эрх, үүргээс бусад даатгалын гэрээ; эсвэл
 - (ii) Сонголттой оролцох шинжийг агуулдаг учраас даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартын цар хүрээнд хамаарах гэрээ.

Хэрэв үүсмэл хэрэглүүр нь өөрөө даатгалын гэрээ биш бол тухайн гэрээг дагалдан гардаг үүсмэл хэрэглүүрт энэ Стандартыг мөрдөнө (энэ Стандартын 47-53-р параграф болон Хавсралт А-гийн МЗУ99-МЗУ110-р параграфыг үзнэ үү). Санхүүгийн баталгааны гэрээг гаргагч нь санхүүгийн баталгааны гэрээнд энэ Стандартыг мөрддөг боловч тэдгээр баталгааг хүлээн зөвшөөрч, хэмжих үедээ даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг мөрдөх сонголт хийсэн бол тэдгээр стандартыг мөрдөнө. Дээрх (i)-д зааснаас үл хамааран байгууллага нь санхүүгийн эрсдлийн шилжүүлэлтийг агуулсан даатгалын бусад гэрээний хувьд энэ Стандартыг мөрдөж болох юм.

- (е) Нэгдэж буй үйл ажиллагааг худалдан авах буюу худалдах талаар тухайн нэгтгэгч болон худалдаж буй хувьцаа эзэмшигчийн хооронд байгуулсан бөгөөд тэрхүү ирээдүйн худалдан авалтын өдрөөр УСНББОУС 40-ийг мөрдөх улсын секторын нэгдэл үүсгэхэд хүргэдэг аливаа форвард гэрээ. Форвард гэрээний хугацаа нь аливаа шаардлагатай зөвшөөрлийг олж авах ба тухайн ажил гүйлгээг хэрэгжүүлэхэд хэвийн шаардагдах үл үндэслэлтэй хугацаанаас хэтрэхгүй байвал зохино.
 - (ж) 4-р параграфт дурдсан зээл олгох баталгаанаас бусад зээл олгох баталгаа. Гэвч зээл олгох баталгаа гаргагч нь энэ Стандартын цар хүрээнд өөр бусад байдлаар хамаарахгүй уг зээл олгох баталгааны хувьд энэхүү Стандартын үнэ цэнийн бууралтын шаардлагуудыг мөрдөнө. Мөн зээл олгох бүх баталгаа нь энэ Стандартын үл хүлээн зөвшөөрөлтийн шаардлагад захирагдана.
 - (и) Энэ Стандартыг мөрддөг бөгөөд түүний 5-8-р параграфын цар хүрээнд хамаарах гэрээнүүдээс бусад, хувьцаанд суурилсан төлбөрийг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг мөрддөг хувьцаанд суурилсан төлбөрийн ажил гүйлгээний дагуу үүсэх санхүүгийн хэрэглүүр, гэрээ болон үүрэг.
 - (к) УСНББОУС 19, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө*-ийн дагуу нөөц гэж хүлээн зөвшөөрөх эсвэл УСНББОУС 19-ийн дагуу өмнөх тайлант үед нөөц гэж хүлээн зөвшөөрсөн өр төлбөрийг барагдуулахад шаардлагатай зарлагын хувьд тухайн байгууллагад нөхөн төлөгдөх төлбөрийг хүлээн авах эрх.
 - (л) УСНББОУС 23, *Арилжааны Бус Ажил Гүйлгээний Орлого (Татвар ба Шилжүүлэг)*-ыг мөрддөг боловч МЗУ6-д зааснаас бусад, арилжааны бус орлогын ажил гүйлгээнээс үүссэн эрх ба үүргийн анхны хүлээн зөвшөөрөлт болон анхны хэмжилт;
 - (м) УСНББОУС 32, *Үйлчилгээний Концессын Хэлцэл: Эрх бүхий этгээд*-ийг мөрддөг үйлчилгээний концессын хэлцлийн дагуу үүсэх эрх ба үүрэг. Гэвч санхүүгийн өр төлбөрийн загварын дагуу эрх бүхий этгээдийн хүлээн зөвшөөрсөн санхүүгийн өр төлбөр нь энэ Стандартын үл хүлээн зөвшөөрөлтийн заалтад захирагдана (энэ Стандартын 35-38-р параграф болон Хавсралт А-гийн МЗУ39-МЗУ47-р параграфыг үзнэ үү).
3. Үнэ цэнийн бууралтын олз, гарз хүлээн зөвшөөрөх зорилгын хувьд санхүүгийн хэрэглүүр үүсэхэд хүргэдэг бөгөөд УСНББОУС 9, *Арилжааны Ажил Гүйлгээний Орлого* болон УСНББОУС 23-ын дагуу тайлагнадаг ажил гүйлгээнээс үүсэх эрхийн хувьд энэхүү Стандартын үнэ цэнийн бууралтын шаардлагуудыг даган мөрдөнө.
4. Дараах зээл олгох баталгаа нь энэ Стандартын цар хүрээнд хамаарна:
- (а) Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг санхүүгийн өр төлбөр гэж тухайн байгууллагын ангилсан зээл олгох баталгаа (46-р параграфыг үзнэ үү). Зээл олгох баталгаанаасаа үүссэн хөрөнгийг түүний бий болсон даруйд худалдан борлуулж байсан өмнөх практик бүхий байгууллага нь тэрхүү зээл олгох

баталгааны ангид хамаарах өөрийн бүх зээл олгох баталгааны хувьд энэ Стандартыг мөрдөнө.

- (б) Цэвэр дүнгээр нь мөнгөөр, эсвэл бусад санхүүгийн хэрэглүүрийг өгөх буюу гаргах замаар барагдуулж болох зээл олгох баталгаа. Ийм зээл олгох баталгаа нь үүсмэл хэрэглүүр юм. Зээлийг хэсэгчлэн төлдөг (жишээлбэл; барилгын ажлын явцтай уялдуулан хэсэгчлэн төлдөг барилгын моргейжийн зээл) гэдгээс зөвхөн хамааран зээл олгох баталгааг цэвэр дүнгээр барагдуулдаг гэж үзэхгүй.
 - (в) Зах зээлийн хүүний түвшнээс бага хүүтэйгээр зээл олгох баталгаа (45(г) параграфыг үзнэ үү).
5. Санхүүгийн бус зүйлийг худалдан авах буюу борлуулах бөгөөд цэвэр дүнгээр нь мөнгөөр буюу бусад санхүүгийн хэрэглүүрээр барагдуулах, эсвэл санхүүгийн хэрэглүүрүүдээр солилцож болох гэрээнд, тэдгээр гэрээ нь өөрөө санхүүгийн хэрэглүүр байсан мэтээр энэхүү Стандартыг мөрдөнө; харин тухайн байгууллагын хүлээгдэж буй худалдан авалт, борлуулалт буюу ашиглалтын шаардлагуудын дагуу санхүүгийн бус зүйлийг хүлээн авах эсвэл өгөх зорилгоор байгуулсан ба ийм зорилгоор үргэлжлүүлэн эзэмшиж буй гэрээнд энэ Стандартыг мөрдөхгүй. Гэхдээ байгууллага нь 6-р параграфын дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилдаг гэрээний хувьд энэ Стандартыг мөрдөнө.
6. Санхүүгийн бус зүйлийг худалдан авах буюу борлуулах бөгөөд цэвэр дүнгээр нь мөнгөөр буюу бусад санхүүгийн хэрэглүүрээр барагдуулах, эсвэл санхүүгийн хэрэглүүрүүдээр солилцож болох гэрээг хэдийгээр тухайн байгууллагын хүлээгдэж буй худалдан авалт, борлуулалт буюу ашиглалтын шаардлагуудын дагуу санхүүгийн бус зүйлийг хүлээн авах эсвэл өгөх зорилгоор байгуулсан боловч уг гэрээг санхүүгийн хэрэглүүр байсан мэтээр ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж бүрмөсөн ангилж болох юм. Энэ Стандартын цар хүрээнд хамааруулахгүй хасаж, (5-р параграфыг үзнэ үү) тухайн гэрээг хүлээн зөвшөөрөөгүйн улмаас үүсэх байсан хүлээн зөвшөөрөлтийн тууштай бус байдлыг (зарим үед “нягтлан бодох бүртгэлийн уялдаагүй байдал” гэж нэрлэдэг) арилгах буюу мэдэгдэхүйц бууруулах зөвхөн тийм тохиолдолд, уг гэрээний зөвхөн эхэнд ийм ангилал хийх боломжтой байдаг.
7. Санхүүгийн бус зүйлийг худалдан авах буюу борлуулах гэрээг цэвэр дүнгээр нь мөнгөөр буюу бусад санхүүгийн хэрэглүүрээр барагдуулах, эсвэл санхүүгийн хэрэглүүрүүдийг солилцох янз бүрийн арга замууд байдаг. Үүнд:
- (а) Цэвэр дүнгээр нь мөнгөөр буюу бусад санхүүгийн хэрэглүүрээр барагдуулах, эсвэл санхүүгийн хэрэглүүрүүдийг солилцохыг аль нэг талд зөвшөөрсөн гэрээний нөхцөлтэй тохиолдол;
 - (б) Цэвэр дүнгээр нь мөнгөөр буюу бусад санхүүгийн хэрэглүүрээр барагдуулах, эсвэл санхүүгийн хэрэглүүрүүдийг солилцох боломжит байдлыг тухайн гэрээний нөхцөлд тодорхой заагаагүй боловч уг байгууллага нь ижил төсөөтэй гэрээг цэвэр дүнгээр нь мөнгөөр буюу бусад санхүүгийн хэрэглүүрээр барагдуулсан эсвэл санхүүгийн хэрэглүүрүүдийг солилцсон практик туршлагатай тохиолдол (харилцан суутгаж, цэвэр дүн гаргах гэрээг нөгөө талтайгаа байгуулснаар, эсвэл гэрээ хэрэгжих буюу түүний хугацаа дуусахаас өмнө уг гэрээг борлуулснаар);
 - (в) Ижил төсөөтэй гэрээний хувьд байгууллага нь тухайн суурь хэрэглүүрийг гаргах ба түүний үнийн богино хугацааны хэлбэлзлээс эсвэл дилерийн үнийн зөрүүгээс ашиг олох зорилгоор уг гаргалтаас хойшхи богино хугацааны дотор буцаан борлуулж байсан практик туршлагатай тохиолдол; ба
 - (г) Тухайн гэрээнд хамаарах санхүүгийн бус зүйлийг мөнгөнд шууд хөрвүүлэх боломжтой тохиолдол.

Тухайн байгууллагын хүлээгдэж буй худалдан авалт, борлуулалт буюу ашиглалтын шаардлагын дагуу санхүүгийн бус зүйлийг хүлээн авах эсвэл өгөх тийм зорилгоор дээрх (б)

буюу (в) заалтанд хамаарах гэрээг байгуулаагүй бол уг гэрээ нь энэ Стандартын цар хүрээнд хамаарна. Тухайн байгууллагын хүлээгдэж буй худалдан авалт, борлуулалт буюу ашиглалтын шаардлагын дагуу санхүүгийн бус зүйлийг хүлээн авах эсвэл өгөх зорилгоор гэрээг байгуулсан ба ийм зорилгоор үргэлжлүүлэн эзэмшиж буй эсэх, уг гэрээ нь энэ Стандартын цар хүрээнд хамаарах эсэхийг тодорхойлохын тулд 5-р параграфт хамаарах бусад гэрээг үнэлж үзнэ.

8. 7(a) буюу 7(г) параграфын дагуу, цэвэр дүнгээр нь мөнгөөр буюу бусад санхүүгийн хэрэглүүрээр барагдуулах, эсвэл санхүүгийн хэрэглүүрээр солилцох боломжтой, санхүүгийн бус зүйлийг худалдан авах буюу борлуулахаар гаргасан опцион нь энэ Стандартын цар хүрээнд хамаарна. Ийм гэрээг тухайн байгууллагын хүлээгдэж буй худалдан авалт, борлуулалт буюу ашиглалтын шаардлагуудын дагуу санхүүгийн бус зүйлийг хүлээн авах эсвэл өгөх зорилгоор байгуулахгүй.

Тодорхойлолт

9. Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдал гэдэг нь тайлант үеийн эцсээс хойш 12 сарын дотор санхүүгийн хэрэглүүрийн үл биелүүлэлтээс үүсэхээр хүлээгдэж буй зээлийн алдагдлыг илэрхийлэх тухайн нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэсэг юм.

Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртөг гэдэг нь санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөх үед хэмжсэн дүнгээс үндсэн төлбөрийн буцаан төлөлтийг хасаж, уг анхны дүн ба дуусгавар болгох дүнгийн хоорондох аливаа зөрүүгээс үр ашигт хүүний аргыг ашиглан тооцсон, хуримтлагдсан хорогдуулгыг нэмэх буюу хасаж, санхүүгийн хөрөнгийн хувьд аливаа гарзын хасагдуулгаар тохируулсан дүн байдаг.

Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртөг гэдэг нь санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөх үед хэмжсэн дүнгээс үндсэн төлбөрийн буцаан төлөлтийг хасаж, уг анхны дүн ба дуусгавар болгох дүнгийн хоорондох аливаа зөрүүгээс үр ашигт хүүний аргыг ашиглан тооцсон, хуримтлагдсан хорогдуулгыг нэмэх буюу хасаж, санхүүгийн хөрөнгийн хувьд аливаа гарзын хасагдуулгаар тохируулсан дүн байдаг.

Зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгө гэдэг нь тухайн санхүүгийн хөрөнгийн ирээдүйн тооцоолсон мөнгөн гүйлгээг муутгах үр нөлөө бүхий нэг буюу хэд хэдэн үйл явдал гарч тохиолдсон үед зээлийн үнэ цэнэ нь буурсан санхүүгийн хөрөнгө юм. Санхүүгийн хөрөнгийн зээлийн үнэ цэнэ буурсан талаархи нотолгоонд дараах үйл явдлуудын талаархи ажиглаж болох мэдээ хамаарна. Үүнд:

- (a) Гаргагч эсвэл зээлдэгчийн санхүүгийн мэдэгдэхүйц хүндрэлтэй байдал;
- (б) Гэрээний зөрчил, жишээлбэл; төлбөрийг үл биелүүлэх эсвэл хугацаа өнгөрөх;
- (в) Зээлдэгчид зээл олгосон зээлдүүлэгч (зээлдүүлэгчид) нь уг зээлдэгчийн санхүүгийн хүндрэлтэй байдалтай холбоотой эдийн засгийн буюу гэрээний учир шалтгааны улмаас өөр бусад нөхцөлд зөвшөөрөхөөргүй хөнгөлөлтийг тухайн зээлдэгчид үзүүлэх;
- (г) Зээлдэгч нь дампуурах эсвэл санхүүгийн бусад дахин зохион байгуулалт хийх нэлээд магадлалтай байх;
- (д) Санхүүгийн хүндрэлтэй байдлын улмаас уг санхүүгийн хөрөнгийн хувьд идэвхитэй зах зээлгүй болох;
- (e) Үүссэн зээлийн алдагдлыг тусгах тийм өндөр хөнгөлөлттэй дүнгээр санхүүгийн хөрөнгийг худалдан авах эсвэл шинээр бий болгох.

Ганц салангид үйл явдлыг тодорхойлох боломжгүй байж болно. Харин санхүүгийн хөрөнгийн үнэлэмж буурахад хүргэж болох хэд хэдэн үйл явдлуудын нэгдсэн үр нөлөөг тодорхойлж болно.

Зээлийн алдагдал гэдэг нь гэрээний дагуу байгууллагад төлөх гэрээний бүх мөнгөн гүйлгээ ба тухайн байгууллагын авахаар хүлээгдэж буй бүх мөнгөн гүйлгээний хоорондох зөрүүг (өөрөөр хэлбэл, мөнгөний бүх дутагдлыг) анхны үр ашигт хүүний хувиар (худалдан авсан буюу үүсгэн гаргасан зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд зээлийн эрсдлээр тохируулсан үр ашигт хүүний хувиар) дискаунтчилсан дүн юм. Байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн гэрээний бүх нөхцлүүдийг (тухайлбал; урьдчилан төлөлт, сунгалт, дуудах ба үүнтэй ижил төсөөтэй опцион) түүний хүлээгдэж буй хугацааны туршид харгалзан үзсэнээр мөнгөн гүйлгээг тооцоолно. Харгалзан үзэх тухайн мөнгөн гүйлгээнд эзэмшиж буй барьцаа хөрөнгийн борлуулалтаас эсвэл гэрээний нөхцлийн салшгүй хэсэг болох зээлийн чанарын бусад сайжруулалтаас бий болох мөнгөн гүйлгээ хамаарна. Санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааг найдвартай тооцоолж чадна гэсэн урьдчилсан нөхцөлтэй байдаг. Гэвч санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааг найдвартай тооцоолох боломжгүй тийм цөөн ховор тохиолдолд байгууллага нь уг санхүүгийн хэрэглүүрийн гэрээний үлдэж байгаа хугацааг ашиглана.

Зээлийн эрсдлээр тохируулсан үр ашигт хүүний хувь гэдэг нь санхүүгийн хөрөнгийн хүлээгдэж буй хугацааны туршид тооцоолсон ирээдүйн мөнгөн төлбөр эсвэл мөнгөн орлогыг тухайн санхүүгийн хөрөнгийн, өөрөөр хэлбэл худалдан авсан буюу үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртөг хүртэл яг нарийн дискаунтчилдаг хүүний хувь юм. Зээлийн эрсдлээр тохируулсан үр ашигт хүүний хувийг тооцоолохдоо байгууллага нь тухайн санхүүгийн хөрөнгийн гэрээний бүх нөхцлүүд (тухайлбал; урьдчилан төлөлт, сунгалт, дуудах ба үүнтэй ижил төсөөтэй опцион) болон хүлээгдэж буй зээлийн алдагдлыг харгалзан үзсэнээр уг хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг тооцоолно. Гэрээний талуудын хооронд төлсөн эсвэл хүлээн авсан, уг үр ашигт хүүний хувийн салшгүй хэсэг болох бүх хураамж ба оноо (МЗУ156-МЗУ158-р параграфыг үзнэ үү), ажил гүйлгээний зардал, бусад бүх урамшуулал буюу хөнгөлөлт нь энэхүү тооцоололд хамаарна. Ижил төсөөтэй санхүүгийн хэрэглүүрүүдийн бүлгийн мөнгөн гүйлгээ ба тэдгээрийн хүлээгдэж буй хугацааг найдвартай тооцоолж чадна гэсэн урьдчилсан нөхцөлтэй байдаг. Гэвч санхүүгийн хэрэглүүрийн (буюу санхүүгийн хэрэглүүрүүдийн бүлгийн) мөнгөн гүйлгээ эсвэл үлдэж буй хугацааг найдвартай тооцоолох боломжгүй тийм цөөн ховор тохиолдолд байгууллага нь тухайн санхүүгийн хэрэглүүрийн (санхүүгийн хэрэглүүрүүдийн бүлгийн) нийт гэрээний хугацаан дахь уг гэрээний мөнгөн гүйлгээг харгалзан үзнэ.

Үл хүлээн зөвшөөрөлт гэдэг нь өмнө хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг тухайн байгууллагын санхүүгийн байдлын тайлангаас хасалт юм.

Үүсмэл хэрэглүүр гэдэг нь энэ Стандартын цар хүрээнд хамаарах бөгөөд дараах бүх гурван шинж чанар бүхий санхүүгийн хэрэглүүр буюу бусад гэрээ юм:

- (a) Тохиролцсон хүүний хувь, санхүүгийн хэрэглүүрийн үнэ, бараа бүтээгдэхүүний үнэ, гадаад валютын ханш, үнийн буюу ханшийн индекс, зээлийн зэрэглэл буюу зээлийн индекс, түүнчлэн уг гэрээний аль нэг талд тусгайлан хамаарахгүй санхүүгийн бус хувьсагч гэх мэт бусад хувьсагчдын (зарим үед ‘суурь зүйл’ гэж нэрлэдэг) өөрчлөлтийн хариу болгон түүний үнэ цэнэ өөрчлөгддөг.
- (б) Анхны цэвэр хөрөнгө оруулалт шаарддаггүй эсвэл зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөнд ижил төсөөтэй хариу үзүүлэхээр хүлээгдэж буй бусад төрлийн гэрээний хувьд шаардлагатай дүнгээс бага хэмжээний анхны цэвэр хөрөнгө оруулалт шаарддаг.
- (в) Ирээдүйн өдөр барагддаг.

Ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт гэдэг нь капиталын тодорхой ангийн эзэмшилтэй нь шууд хамааралтай байдлаар өмчийн хэрэглүүрийн эзэмшигчдэд олгох хуваарилалт юм.

Үр ашигт хүүний арга гэдэг нь санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртгийг тооцоолох ба хүүний орлого буюу хүүний зардлыг холбогдох тайлант үед ашиг, алдагдалд хуваарилж, хүлээн зөвшөөрөхөд ашигладаг арга юм.

Үр ашигт хүүний хувь гэдэг нь санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн хүлээгдэж буй хугацааны туршид тооцоолсон ирээдүйн мөнгөн төлбөр эсвэл мөнгөн орлогыг тухайн санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнэ эсвэл санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртөг хүртэл яг нарийн дискаунтчилдаг хүүний хувь юм. Үр ашигт хүүний хувийг тооцоолохдоо байгууллага нь тухайн санхүүгийн хэрэглүүрийн гэрээний бүх нөхцлүүдийг (тухайлбал; урьдчилан төлөлт, сунгалт, дуудах ба үүнтэй ижил төсөөтэй опцион) харгалзан үзсэнээр уг хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг тооцоолох боловч хүлээгдэж буй зээлийн алдагдлыг харгалзан үзэхгүй. Гэрээний талуудын хооронд төлсөн эсвэл хүлээн авсан, уг үр ашигт хүүний хувийн салшгүй хэсэг болох бүх хураамж ба оноо (МЗУ156-МЗУ158-р параграфыг үзнэ үү), ажил гүйлгээний зардал, бусад бүх урамшуулал буюу хөнгөлөлт нь энэхүү тооцооллод хамаарна. Ижил төсөөтэй санхүүгийн хэрэглүүрүүдийн бүлгийн мөнгөн гүйлгээ ба тэдгээрийн хүлээгдэж буй хугацааг найдвартай тооцоолж чадна гэсэн урьдчилсан нөхцөлтэй байдаг. Гэвч санхүүгийн хэрэглүүрийн (буюу санхүүгийн хэрэглүүрүүдийн бүлгийн) мөнгөн гүйлгээ эсвэл хүлээгдэж буй хугацааг найдвартай тооцоолох боломжгүй тийм цөөн ховор тохиолдолд байгууллага нь тухайн санхүүгийн хэрэглүүрийн (санхүүгийн хэрэглүүрүүдийн бүлгийн) нийт гэрээний хугацаан дахь уг гэрээний мөнгөн гүйлгээг харгалзан үзнэ.

Хүлээгдэж буй зээлийн алдагдал гэдэг нь үл биелүүлэлт гарах харгалзах эрсдлүүдийг жинэлэх замаар тодорхойлсон зээлийн алдагдлын жинэлсэн дундаж юм.

Санхүүгийн баталгааны гэрээ гэдэг нь өрийн хэрэглүүрийн анхны буюу засварлан өөрчилсөн нөхцлийн дагуу төлөх ёстой төлбөрөө тухайн зээлдэгч барагдуулаагүйн улмаас учирсан алдагдлын хувьд уг гэрээг эзэмшигчид нөхөн төлбөр болгон тодорхой төлбөр төлөхийг түүний гаргагчаас шаарддаг гэрээ юм.

Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөр гэдэг нь дараах нөхцлүүдийн аль нэгийг хангадаг санхүүгийн өр төлбөр юм:

- (a) Худалдан арилжих зорилгоор эзэмшиж байгаа гэсэн тодорхойлолтыг хангадаг.
- (б) Анх хүлээн зөвшөөрөх үед тухайн байгууллага нь 46 эсвэл 51-р параграфын дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан.
- (в) Анх хүлээн зөвшөөрөх үед эсвэл дараагийн тайлант үед 152-р параграфын дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан.

Арилжааны баталгаа гэдэг нь ирээдүйн товлосон өдөр буюу өдрүүдэд, тогтоосон үнээр, тодорхой хэмжээний нөөцийг солилцох заавал биелүүлэх гэрээ юм.

Урьдчилан таамагласан ажил гүйлгээ гэдэг нь баталгаа гаргаагүй боловч урьдчилан төсөөлсөн ирээдүйн ажил гүйлгээ юм.

Санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнэ гэдэг нь аливаа гарзны хасагдуулгын хувьд тохируулга хийхийн өмнөх, санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртөг юм.

Хейжийн харьцаа гэдэг нь хейжийн хэрэглүүрийн тоо хэмжээ ба хейжийн зүйлийн тоо хэмжээний хоорондох, тэдгээрийн харгалзах хувийн жингээр илэрхийлэгдсэн харилцан хамаарал юм.

Худалдан арилжих зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хэрэглүүр гэдэг нь дараах санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр юм:

- (a) Ойрын хугацаанд худалдан борлуулах эсвэл буцаан худалдан авах зорилготойгоор үндсэндээ олж эзэмшсэн буюу гаргасан.

- (б) Анх хүлээн зөвшөөрөх үед, хамтад нь удирдан зохицуулдаг бөгөөд богино хугацаанд ашиг олох зорилготой гэсэн нотолгоо бүхий тодорхой санхүүгийн хэрэглүүрийн багцын нэг хэсэг байх; эсвэл
- (в) Үүсмэл хэрэглүүр байх (санхүүгийн баталгааны гэрээ эсвэл сонгосон ба үр дүнтэй хейжийн хэрэглүүр болох үүсмэл хэрэглүүрээс бусад).

Үнэ цэнийн бууралтын олз буюу гарз гэдэг нь 80-р параграфын дагуу ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг бөгөөд 73-93-р параграфт заасан үнэ цэнийн бууралтын шаардлагуудыг мөрдсөнөөр үүсдэг олз буюу гарз.

Нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдал гэдэг нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааны туршид бүх боломжит үл биелүүлэлтийн үйл явдлын улмаас үүсэн бий болох хүлээгдэж буй зээлийн алдагдал юм.

Гарзын хасагдуулга гэдэг нь 40-р параграфын дагуу хэмжсэн санхүүгийн хөрөнгийн хүлээгдэж буй зээлийн алдагдал, түрээсийн авлагын хасагдуулга, 41-р параграфын дагуу хэмжсэн санхүүгийн хөрөнгийн хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын дүн, зээл олгох баталгаа болон санхүүгийн баталгааны гэрээний хүлээгдэж буй зээлийн алдагдлын нөөц юм.

Өөрчлөлтөөс бий болсон олз, гарз гэдэг нь дахин хэлэлцэн тохирсон буюу өөрчилсөн гэрээний мөнгөн гүйлгээг тусгахын тулд санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнийг тохируулснаар үүссэн дүн юм. Байгууллага нь санхүүгийн хөрөнгийн анхны үр ашигт хүүний хувиар (худалдан авсан буюу үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд анхны зээлийн эрсдлээр тохируулсан үр ашигт хүүний хувиар), эсвэл хамааралтай тохиолдолд 139-р параграфын дагуу тооцоолсон, хянан засварласан үр ашигт хүүний хувиар дискаунтчилсан, уг дахин хэлэлцэн тохирсон буюу өөрчилсөн санхүүгийн хөрөнгийн хүлээгдэж буй хугацаан дахь тэрхүү тооцоолсон ирээдүйн мөнгөн төлбөрийн буюу мөнгөн орлогын өнөөгийн үнэ цэнэ байдлаар тухайн санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнийг дахин тооцоолно. Санхүүгийн хөрөнгийн хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг тооцоолохдоо байгууллага нь уг санхүүгийн хөрөнгийн гэрээний бүх нөхцлүүдийг (тухайлбал; урьдчилан төлөлт, дуудах ба үүнтэй ижил төсөөтэй опцион) харгалзан үзэх боловч санхүүгийн хөрөнгө нь худалдан авсан буюу үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгө байхаас бусад тохиолдолд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг харгалзан үзэхгүй. Харин ийм хөрөнгө байх тохиолдолд байгууллага нь анхны зээлийн эрсдлээр тохируулсан үр ашигт хүүний хувийг тооцоолохдоо харгалзан үзсэн уг анхны хүлээгдэж зээлийн алдагдлыг мөн харгалзан үзнэ.

Гэрээний дагуу төлөх ёстой хугацаа болсон төлбөрийг нөгөө тал нь барагдуулаагүй тохиолдолд санхүүгийн хөрөнгийн хугацаа өнгөрсөн гэнэ.

Худалдан авсан буюу үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгө гэдэг нь анх хүлээн зөвшөөрөх үед зээлийн үнэ цэнэ нь буурсан санхүүгийн хөрөнгө юм.

Дахин ангиллын өдөр гэдэг нь санхүүгийн хөрөнгөө байгууллага дахин ангилахад хүргэдэг удирдлагын загварын тийм өөрчлөлтийн дараах анхны тайлант үеийн эхний өдөр юм.

Ердийн нөхцөлтэй худалдан авалт буюу борлуулалт гэдэг нь тухайн хамаарах зах зээл дэх зохицуулалт буюу тогтсон журмаар ерөнхийдөө тогтоодог цаг хугацааны дотор уг хөрөнгийг нийлүүлэхийг шаарддаг нөхцөл бүхий гэрээний дагуу хийгдэх санхүүгийн хөрөнгийн худалдан авалт буюу борлуулалт юм.

Ажил гүйлгээний зардал гэдэг нь санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн олж эзэмшилт, гаргалт, данснаас хасалтанд шууд хамаарах өсөн нэмэгдэх зардал (МЗУ163-р параграфыг үзнэ үү) юм. Өсөн нэмэгдэх зардал нь хэрэв байгууллага тухайн санхүүгийн хэрэглүүрийг олж эзэмшээгүй, гаргаагүй, данснаас хасаагүй бол гарахгүй байсан зардал юм.

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь*-д дахин нийтэлсэн болно. Дараах нэр томъёог УСНББОУС 28 буюу УСНББОУС 30, *Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга*-д тодорхойлсон: зээлийн эрсдэл,¹ валютын эрсдэл, төлбөрийн чадварын эрсдэл, зах зээлийн эрсдэл, өмчийн хэрэглүүр, санхүүгийн хөрөнгө, санхүүгийн хэрэглүүр, санхүүгийн өр төлбөр, буцаах эрхтэй хэрэглүүр.

Хүлээн зөвшөөрөлт ба үл хүлээн зөвшөөрөлт

Анхны хүлээн зөвшөөрөлт

10. Байгууллага нь тухайн хэрэглүүрийн гэрээний нэг тал болсон (МЗУ15, МЗУ16-р параграфыг үзнэ үү) зөвхөн тийм тохиолдолд уг байгууллага нь санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг өөрийн санхүүгийн байдлын тайландаа хүлээн зөвшөөрнө. Байгууллага нь санхүүгийн хөрөнгийг анх удаа хүлээн зөвшөөрөх үед түүнийг 39-44-р параграфын дагуу ангилж, 57 ба 59-р параграфын дагуу хэмжинэ. Байгууллага нь санхүүгийн өр төлбөрийг анх удаа хүлээн зөвшөөрөх үед түүнийг 45, 46-р параграфын дагуу ангилж, 57-р параграфын дагуу хэмжинэ.

Санхүүгийн хөрөнгийн ердийн нөхцөлтэй худалдан авалт буюу борлуулалт

11. Санхүүгийн хөрөнгийн ердийн нөхцөлтэй худалдан авалт буюу борлуулалтыг арилжааны өдрийн нягтлан бодох бүртгэл эсвэл барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийн аль тохиромжтойг ашигласнаар хүлээн зөвшөөрөх буюу үл хүлээн зөвшөөрнө (МЗУ17-МЗУ20-р параграфыг үзнэ үү).

Санхүүгийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлт

12. Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд 13-20, МЗУ15, МЗУ16, МЗУ21-МЗУ38-р параграфуудыг нэгтгэсэн түвшинд мөрдөнө. Иймээс байгууллага нь эхлээд өөрийн хяналтанд буй бүх байгууллагуудыг УСНББОУС 35-ын дагуу нэгтгэх ба үүний үр дүн болох эдийн засгийн нэгдмэл байгууллагын хувьд эдгээр параграфуудыг дараа нь мөрдөнө.
13. Үл хүлээн зөвшөөрөлт нь тохиромжтой эсэх, түүнчлэн хэр тохиромжтой гэдгийг 14-20-р параграфын дагуу үнэлэхийн өмнө, байгууллага нь эдгээр параграфуудыг санхүүгийн хөрөнгийн тодорхой нэг хэсэгт (буюу ижил төсөөтэй санхүүгийн хөрөнгүүдийн бүлгийн тодорхой нэг хэсэгт) эсвэл санхүүгийн хөрөнгөнд (буюу ижил төсөөтэй санхүүгийн хөрөнгүүдийн бүлэгт) бүхэлд нь мөрдөх хэрэгтэй эсэхийг дараах байдлаар тодорхойлно:
 - (a) Үл хүлээн зөвшөөрөхөөр харгалзан үзэж буй санхүүгийн хөрөнгийн тодорхой нэг хэсэг (буюу ижил төсөөтэй санхүүгийн хөрөнгүүдийн бүлгийн тодорхой нэг хэсэг) нь дараах гурван нөхцлийн аль нэгийг хангаж байх зөвхөн тийм тохиолдолд уг хэсгийн хувьд 14-20-р параграфуудыг мөрдөнө.
 - (i) Тухайн хэсэг нь санхүүгийн хөрөнгөөс (буюу ижил төсөөтэй санхүүгийн хөрөнгүүдийн бүлгээс) олох зөвхөн тусгайлан тодорхойлсон мөнгөн гүйлгээг агуулдаг байх. Тухайлбал; байгууллага нь хүүний СТРИПС хийсэн бөгөөд ингэснээр оролцогч нөгөө тал нь өрийн хэрэглүүрийн үндсэн төлбөрийн мөнгөн гүйлгээг биш, харин хүүний мөнгөн гүйлгээг авах эрхтэй болсон. Ийм хүүний мөнгөн гүйлгээний хувьд 14-20-р параграфыг мөрдөнө.
 - (ii) Тухайн хэсэг нь санхүүгийн хөрөнгөөс (буюу ижил төсөөтэй санхүүгийн хөрөнгүүдийн бүлгээс) олох мөнгөн гүйлгээтэй шууд хамааралтай (хувь тэнцүүлэн) зөвхөн тэдгээр мөнгөн гүйлгээг агуулдаг байх. Тухайлбал;

¹ Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилдаг өр төлбөрийн (108-р параграфыг үзнэ үү) зээлийн эрсдлийн өөрчлөлтийн үр нөлөөг толилуулах шаардлагуудын хувьд энэхүү нэр томъёог (УСНББОУС 30-д тодорхойлсон) ашиглана.

оролцогч нөгөө тал нь өрийн хэрэглүүрийн бүх мөнгөн гүйлгээний 90 хувийг авах эрхтэй байхаар байгууллага нь хэлцэл хийсэн тохиолдолд тэдгээр мөнгөн гүйлгээний 90 хувьд 14-20-р параграфыг мөрдөнө. Харин нэгээс олон оролцогч талтай үед тухайн шилжүүлж буй байгууллага нь шууд хамаарах хувь хэсгийг эзэмшдэг бол бусад оролцогч тал бүр нь тэдгээр мөнгөн гүйлгээний хувьд заавал хувь тэнцүүлсэн оролцоотой байхыг шаардахгүй.

- (iii) Тухайн хэсэг нь санхүүгийн хөрөнгөөс (буюу ижил төсөөтэй санхүүгийн хөрөнгүүдийн бүлгээс) олох, тусгайлан тодорхойлсон мөнгөн гүйлгээтэй шууд хамааралтай (хувь тэнцүүлэн) зөвхөн тэдгээр мөнгөн гүйлгээг агуулдаг байх. Тухайлбал; оролцогч нөгөө тал нь санхүүгийн хөрөнгийн хүүний мөнгөн гүйлгээний 90 хувийг авах эрхтэй байхаар байгууллага нь хэлцэл хийсэн тохиолдолд тэдгээр хүүний мөнгөн гүйлгээний 90 хувьд 14-20-р параграфыг мөрдөнө. Харин нэгээс олон оролцогч талтай үед тухайн шилжүүлж буй байгууллага нь шууд хамаарах хувь хэсгийг эзэмшдэг бол бусад оролцогч тал бүр нь тэдгээр тусгайлан тодорхойлсон мөнгөн гүйлгээний хувьд заавал хувь тэнцүүлсэн оролцоотой байхыг шаардахгүй.
- (б) Бусад бүх тохиолдолд 14-20-р параграфыг санхүүгийн хөрөнгөнд (буюу ижил төсөөтэй санхүүгийн хөрөнгүүдийн бүлэгт) бүхэлд нь мөрдөнө. Жишээлбэл; байгууллага нь (i) санхүүгийн хөрөнгөөс (буюу ижил төсөөтэй санхүүгийн хөрөнгүүдийн бүлгээс) цуглуулах мөнгөн орлогын хамгийн эхний эсвэл хамгийн сүүлийн 90 хувийг авах эрхийг шилжүүлсэн, эсвэл (ii) бүлэг авлагаас цуглуулах мөнгөн гүйлгээний 90 хувийг авах эрхийг шилжүүлсэн бөгөөд уг авлагын үндсэн дүнгийн 8 хувь хүртэлх аливаа зээлийн алдагдлын хувьд тухайн авлагын худалдан авагчид нөхөн төлбөр олгох баталгааг гаргасан бол 14-20-р параграфыг тэрхүү санхүүгийн хөрөнгөнд (буюу ижил төсөөтэй санхүүгийн хөрөнгүүдийн бүлэгт) бүхэлд нь мөрдөнө.

14-23-р параграфуудын хувьд ‘санхүүгийн хөрөнгө’ гэсэн нэр томъёо нь дээрх (а)-д тодорхойлсон санхүүгийн хөрөнгийн тодорхой нэг хэсэг (буюу ижил төсөөтэй санхүүгийн хөрөнгүүдийн бүлгийн тодорхой нэг хэсэг)-ийг эсвэл санхүүгийн хөрөнгө (буюу ижил төсөөтэй санхүүгийн хөрөнгүүдийн бүлэг)-ийг бүхэлд нь илэрхийлнэ.

- 14. Байгууллага нь зөвхөн дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө:
 - (а) Тухайн санхүүгийн хөрөнгөөс бий болох мөнгөн гүйлгээг авах гэрээний эрхийн хүчинтэй хугацаа дууссан буюу хойшлуулсан; эсвэл
 - (б) Байгууллага нь 15, 16-р параграфт заасанчлан, тухайн санхүүгийн хөрөнгийг шилжүүлсэн бөгөөд уг шилжүүлэлт нь 17-р параграфт заасан үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангасан.

(Санхүүгийн хөрөнгийн ердийн нөхцөлтэй борлуулалтын хувьд 11-р параграфыг үзнэ үү.)
- 15. Байгууллага нь зөвхөн дараах хоёр хувилбарын аль нэгээр санхүүгийн хөрөнгийг шилжүүлнэ:
 - (а) Тухайн санхүүгийн хөрөнгөөс бий болох мөнгөн гүйлгээг хүлээн авах гэрээний эрхийг шилжүүлэх; эсвэл
 - (б) Тухайн санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээг хүлээн авах гэрээний эрхийг хадгалан үлдсэн боловч 16-р параграфт заасан нөхцлийг хангасан хэлцлийн дагуу нэг буюу хэд хэдэн хүлээн авагч талуудад уг мөнгөн гүйлгээг төлөх гэрээний үүргийг хүлээх.
- 16. Байгууллага нь санхүүгийн хөрөнгө (“анхны хөрөнгө”)-ийн мөнгөн гүйлгээг хүлээн авах гэрээний эрхийг хадгалан үлдсэн боловч нэг буюу хэд хэдэн байгууллагууд (“эцсийн хүлээн авагчид”)-д тэдгээр мөнгөн гүйлгээг төлөх гэрээний үүргийг хүлээсэн бол тухайн

байгууллага нь дараах гурван нөхцөл бүгд хангагдсан зөвхөн тийм тохиолдолд уг ажил гүйлгээг санхүүгийн хөрөнгийн шилжүүлэлт гэж үзнэ.

- (a) Байгууллага нь тухайн анхны хөрөнгөөс адилтгах дүнг цуглуулан авахгүй л бол тэдгээр эцсийн хүлээн авагчдад тэрхүү дүнг төлөх үүрэг хүлээхгүй байх. Зээлдүүлсэн дүн, түүнчлэн зах зээлийн түвшнээр хуримтлуулан тооцсон хүүг бүрэн буцаан авах эрхтэйгээр тухайн байгууллагын олгосон богино хугацааны урьдчилгаа нь энэ нөхцлийг зөрчихгүй.
- (б) Байгууллага нь эцсийн хүлээн авагчдад мөнгө төлөх үүргийн хувьд тэдэнд баталгаа болгохоос өөр бусад байдлаар тухайн анхны хөрөнгийг барьцаалах буюу борлуулахыг уг шилжүүлэлтийн гэрээний нөхцлөөр хориглодог байх.
- (в) Байгууллага нь эцсийн хүлээн авагчдын өмнөөс цуглуулсан аливаа мөнгөн гүйлгээг материаллаг хугацаагаар хойшлуулан саатуулахгүйгээр шилжүүлэх үүрэгтэй байх. Түүнчлэн, байгууллага нь мөнгийг цуглуулсан өдөр ба тухайн эцсийн хүлээн авагчдад шилжүүлэх шаардлагатай өдрийн хоорондох энэхүү барагдуулалтын богино хугацаанд мөнгө буюу түүнтэй адилтгах хөрөнгөнд (УСНББОУС 2, *Мөнгөн Гүйлгээний Тайлан*-д тодорхойлсон) хөрөнгө оруулалт хийх, тэрхүү хөрөнгө оруулалтаас олсон хүүний орлогыг мөн уг эцсийн хүлээн авагчдад шилжүүлэн өгөхөөс бусад тохиолдолд ийм мөнгөн гүйлгээгээр дахин хөрөнгө оруулалт хийх эрхгүй байдаг.

17. Байгууллага нь санхүүгийн хөрөнгийг шилжүүлэх (15-р параграфыг үзнэ үү) тохиолдолд тухайн байгууллага нь уг санхүүгийн хөрөнгийн өмчлөлийн эрсдэл болон өгөөжийг ямар хэмжээгээр хадгалан үлдэж байгаа эсэхээ үнэлнэ. Ингэж үнэлэх үед:

- (a) Хэрэв байгууллага нь санхүүгийн хөрөнгийн өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлэх бол тухайн байгууллага нь уг санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрч, тэрхүү шилжүүлэлтээр бий болсон эсвэл хадгалан үлдсэн аливаа эрх, үүргийг хөрөнгө эсвэл өр төлбөр гэж тусад нь хүлээн зөвшөөрнө.
- (б) Хэрэв байгууллага нь санхүүгийн хөрөнгийн өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалан үлдэх бол тухайн байгууллага нь уг санхүүгийн хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн хэвээр байна.
- (в) Хэрэв байгууллага нь санхүүгийн хөрөнгийн өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлдэггүй, мөн хадгалан үлддэггүй бол тухайн байгууллага нь уг санхүүгийн хөрөнгийн хувьд хяналтыг хадгалан үлдсэн эсэхийг тодорхойлно. Энэ тохиолдолд:
 - (i) Хэрэв байгууллага нь хяналтыг хадгалан үлдээгүй бол тухайн байгууллага нь уг санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрч, тэрхүү шилжүүлэлтээр бий болсон эсвэл хадгалан үлдсэн аливаа эрх, үүргийг хөрөнгө эсвэл өр төлбөр гэж тусад нь хүлээн зөвшөөрнө.
 - (ii) Хэрэв байгууллага нь хяналтыг хадгалан үлдсэн бол тухайн байгууллага нь уг санхүүгийн хөрөнгөнд өөрийн оролцоотой байгаа тэр хэмжээгээр санхүүгийн хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн хэвээр байна (27-р параграфыг үзнэ үү).

18. Тухайн шилжүүлсэн хөрөнгийн цэвэр мөнгөн гүйлгээний дүн болон хугацаанд гарах хувьсан өөрчлөлтийн хувьд байгууллагын хүлээх уг шилжүүлэлтийн өмнөх ба дараах эрсдлийг харьцуулснаар эрсдэл, өгөөжийн шилжүүлэлтийг үнэлнэ (17-р параграфыг үзнэ үү). Хэрэв санхүүгийн хөрөнгийн ирээдүйн цэвэр мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнэд гарах хувьсан өөрчлөлтийн хувьд байгууллагын хүлээх эрсдэл нь уг шилжүүлэлтийн үр дүнд мэдэгдэхүйц өөрчлөгдөхгүй бол (тухайлбал; байгууллага нь тогтмол үнээр эсвэл тухайн борлуулалтын үнэ дээр зээлдүүлэгчийн өгөөжийг нэмсэн дүнгээр буцаан худалдан авах тийм гэрээний дагуу санхүүгийн хөрөнгийг борлуулсан бол) тухайн байгууллага нь тэрхүү санхүүгийн хөрөнгийн өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалан үлдсэн байна. Хэрэв ийм хувьсан

өөрчлөлтийн хувьд байгууллагын хүлээх эрсдэл нь уг санхүүгийн хөрөнгөтэй холбоотой ирээдүйн цэвэр мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнэд гарах нийт хувьсан өөрчлөлттэй харьцуулахад мэдэгдэхүйц дүнтэй биш бол (тухайлбал; байгууллага нь санхүүгийн хөрөнгийг буцаан худалдан авах тохиолдолд тэр үеийн *бодит үнэ цэнээр* түүнийг буцаан худалдан авч болох зөвхөн тийм сонголттойгоор санхүүгийн хөрөнгийг борлуулсан эсвэл хэлэлцэн тохирсон арай том санхүүгийн хөрөнгөөс олох мөнгөн гүйлгээтэй шууд хамааралтай хэсгийг, жишээлбэл, дэд зээлийг шилжүүлсэн ба энэ нь 16-р параграфт заасан нөхцлийг хангах бол) тухайн байгууллага нь тэрхүү санхүүгийн хөрөнгийн өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн гэж үзнэ.

19. Байгууллага нь өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн эсвэл хадгалан үлдсэн эсэх нь ихэвчлэн илт тодорхой байдаг бөгөөд иймээс ямар нэг тооцоолол хийх шаардлагагүй байдаг. Харин зарим тохиолдолд ирээдүйн цэвэр мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийн хувьсан өөрчлөлтийн хувьд байгууллагын хүлээх уг шилжүүлэлтийн өмнөх ба дараах эрсдлийг тооцоолж, харьцуулан үзэх шаардлагатай байдаг. Одоогийн зах зээлийн хүүний тохирох хувийг дискантын хувь болгон ашигласнаар уг тооцоолол ба харьцуулалтыг хийдэг. Гарч тохиолдох илүү их магадлалтай үр дүнгүүдэд арай их хувийн жин өгөх замаар цэвэр мөнгөн гүйлгээний үл үндэслэлтэйгээр боломжит бүх хувьсан өөрчлөлтийг харгалзан үзнэ.
20. Уг шилжүүлсэн хөрөнгийн хувьд байгууллага хяналтыг хадгалан үлдсэн (17(в) параграфыг үзнэ үү) эсэх нь тухайн хөрөнгийг шилжүүлэн авч буй тал түүнийг борлуулах боломж чадвараас хамаардаг. Хэрэв шилжүүлэн авч буй тал нь харилцан холбоогүй гуравдагч этгээдэд уг хөрөнгийг бүхэлд нь худалдан борлуулах чадвар боломжтой бөгөөд тухайн шилжүүлэлтийн хувьд нэмэлт хязгаарлалт тавихгүйгээр тэрхүү өөрийн чадварыг дангаараа хэрэгжүүлэх боломжтой бол байгууллага нь хяналтыг хадгалан үлдээгүй гэж үзнэ. Бусад бүх тохиолдолд байгууллага нь хяналтыг хадгалан үлдсэн хэвээр байна.

Үл хүлээн зөвшөөрөх шалгуур хангах шилжүүлэлт

21. **Санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангах тийм шилжүүлэлтээр тухайн байгууллага нь санхүүгийн хөрөнгийг шилжүүлсэн бөгөөд уг санхүүгийн хөрөнгөнд төлбөртэй үйлчилгээ үзүүлэх эрхийг хадгалж үлдсэн бол байгууллага нь тэрхүү үйлчилгээний гэрээний хувьд үйлчилгээний хөрөнгө эсвэл үйлчилгээний өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Хэрэв хүлээн авах үйлчилгээний хураамж нь тухайн үйлчилгээнд хамаарах зохих нөхөн төлбөрөөс бага байхаар хүлээгдэж байвал тэрхүү үйлчилгээний үүргийн хувьд үйлчилгээний өр төлбөрийг түүний бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрнө. Хэрэв хүлээн авах үйлчилгээний хураамж нь тухайн үйлчилгээнд хамаарах зохих нөхөн төлбөрөөс илүү байхаар хүлээгдэж байвал 24-р параграфт заасан, арай том санхүүгийн хөрөнгийн дансны үнийн хуваарилалтанд үндэслэн тодорхойлсон дүнгээр уг үйлчилгээний эрхийн хувьд үйлчилгээний хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.**
22. **Шилжүүлэлтийн үр дүнд санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь үл хүлээн зөвшөөрсөн боловч тэрхүү шилжүүлэлт нь уг байгууллагыг шинэ санхүүгийн хөрөнгө олж эзэмших эсвэл шинэ санхүүгийн өр төлбөр болон үйлчилгээний өр төлбөрийг хариуцахад хүргэж байвал байгууллага нь тухайн шинэ санхүүгийн хөрөнгө, шинэ санхүүгийн өр төлбөр буюу үйлчилгээний өр төлбөрийг тэдгээрийн бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрнө.**
23. **Санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь үл хүлээн зөвшөөрөх тохиолдолд дараах дүнгүүдийн хоорондох зөрүүг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө:**
- (а) Дансны үнэ (үл хүлээн зөвшөөрөлтийн өдрөөр хэмжсэн) ба
 - (б) Хүлээн авсан төлбөр (үүнд: олж эзэмшсэн аливаа шинэ хөрөнгөөс уг хариуцсан аливаа шинэ өр төлбөрийг хассан дүн хамаарна).
24. **Шилжүүлсэн хөрөнгө нь арай том санхүүгийн хөрөнгийн нэг хэсэг (жишээлбэл; байгууллага нь өрийн хэрэглүүрийн нэг хэсэг болох хүүний мөнгөн гүйлгээг шилжүүлсэн, 13(а) параграфыг үзнэ үү) бөгөөд энэхүү шилжүүлсэн хэсэг нь түүнийг бүхэлд нь үл хүлээн**

зөвшөөрөх шалгуурыг хангаж байвал тухайн арай том санхүүгийн хөрөнгийн өмнөх дансны үнийг уг хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа хэсэг болон үл хүлээн зөвшөөрсөн хэсэгт тэрхүү шилжүүлэлтийн өдрөөрх тэдгээрийн харгалзах бодит үнэ цэнэд үндэслэн хуваарилна. Хадгалан үлдсэн үйлчилгээний хөрөнгийг энэхүү зорилгын хувьд хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа хэсэг гэж үзнэ. Дараах дүнгүүдийн хоорондох зөрүүг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө:

- (a) Үл хүлээн зөвшөөрсөн хэсэгт хуваарилсан дансны үнэ (үл хүлээн зөвшөөрөлтийн өдрөөр хэмжсэн) ба
- (б) Уг үл хүлээн зөвшөөрсөн хэсгийн хувьд хүлээн авсан төлбөр (үүнд: олж эзэмшсэн аливаа шинэ хөрөнгөөс уг хариуцсан аливаа шинэ өр төлбөрийг хассан дүн хамаарна).

25. Байгууллага нь уг арай том санхүүгийн хөрөнгийн өмнөх дансны үнийг тухайн хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа хэсэг ба үл хүлээн зөвшөөрсөн хэсэгт хуваарилах тохиолдолд тэрхүү хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа хэсгийн бодит үнэ цэнийг хэмжих шаардлагатай байдаг. Байгууллага нь уг хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа хэсэгтэй ижил төсөөтэй тийм хэсгүүдийг өмнө нь борлуулж байсан түүхэн туршлагатай эсвэл тийм хэсгүүдэд хамаарах зах зээлийн бусад ажил гүйлгээ байгаа бол тэдгээр бодит ажил гүйлгээний сүүлийн үеийн үнэ нь түүний бодит үнэ цэнийн хамгийн сайн тооцоолол болдог. Хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа хэсгийн бодит үнэ цэнийг дэмжин нотлох зах зээлийн жишиг үнэ байхгүй эсвэл сүүлийн үеийн зах зээлийн ажил гүйлгээ гарч тохиолдоогүй бол тэрхүү арай том санхүүгийн хөрөнгөнд бүхэлдээ хамаарах бодит үнэ цэнэ ба тухайн үл хүлээн зөвшөөрсөн хэсгийн хувьд шилжүүлэн авагчаас хүлээн авсан төлбөрийн хоорондох зөрүү нь бодит үнэ цэнийн хамгийн сайн тооцоолол болно.

Үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангахгүй шилжүүлэлт

26. Байгууллага нь шилжүүлсэн хөрөнгийн өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалан үлддэг учраас шилжүүлэлт нь үл хүлээн зөвшөөрөлтөнд хүргэдэггүй бол тухайн байгууллага нь уг шилжүүлсэн хөрөнгийг бүхэлд нь хүлээн зөвшөөрсөн хэвээр байх бөгөөд хүлээн авсан төлбөрийн хувьд санхүүгийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Байгууллага нь дараагийн тайлант үеүдэд уг шилжүүлсэн хөрөнгийн хувьд үүссэн аливаа орлого ба тухайн санхүүгийн өр төлбөрийн хувьд гарсан аливаа зардлыг хүлээн зөвшөөрнө.

Шилжүүлсэн хөрөнгө дэх цаашдын оролцоо

27. Байгууллага нь санхүүгийн хөрөнгийн өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлдэггүй, мөн хадгалан үлддэггүй бөгөөд уг шилжүүлсэн хөрөнгийн хувьд хяналтыг хадгалан үлддэг бол тухайн байгууллага нь өөрийн цаашдын оролцооны хэмжээгээр тэрхүү шилжүүлсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн хэвээр байна. Шилжүүлсэн хөрөнгө дэх байгууллагын цаашдын оролцооны хэмжээ нь уг шилжүүлсэн хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээх хэмжээ юм. Тухайлбал:

- (a) Байгууллагын цаашдын оролцоо нь уг шилжүүлсэн хөрөнгөнд гаргасан баталгаа хэлбэртэй байх тохиолдолд байгууллагын цаашдын оролцооны хэмжээ нь дараах дүнгүүдийн аль бага байх юм. Үүнд: (i) хөрөнгийн дүн, (ii) хүлээн авсан төлбөрөөс буцаан төлөхийг тухайн байгууллагаас шаардаж болох хамгийн их дүн (“баталгааны дүн”).
- (б) Байгууллагын цаашдын оролцоо нь уг шилжүүлсэн хөрөнгийн хувьд гаргасан эсвэл худалдан авсан опцион хэлбэртэй (эсвэл гаргасан ба худалдан авсан хувьцааны аль аль байх) байх тохиолдолд байгууллагын цаашдын оролцооны хэмжээ нь түүний буцаан худалдан авч болох тухайн шилжүүлсэн хөрөнгийн дүнтэй тэнцүү байна. Гэвч энэ нь уг хөрөнгийн хувьд гаргасан ба бодит үнэ цэнээр хэмжсэн, буцаах эрхтэй опцион байх тохиолдолд тухайн байгууллагын цаашдын оролцооны хэмжээ нь тэрхүү шилжүүлсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ ба опционы хэрэгжих үнийн аль багаар хязгаарлагдана (МЗУ34-р параграфыг үзнэ үү).

- (в) Байгууллагын цаашдын оролцоо нь уг шилжүүлсэн хөрөнгийн хувьд гаргасан бөгөөд мөнгөөр төлөгдөх опцион буюу үүнтэй ижил төсөөтэй нөхцөл хэлбэртэй байх тохиолдолд байгууллагын цаашдын оролцоог дээрх (б)-д заасан мөнгөөр төлөгдөхгүй опционы үр дагавартай ижил арга замаар хэмжинэ.
28. Байгууллага нь өөрийн цаашдын оролцооны хэмжээгээр хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн хэвээр байх тохиолдолд тухайн байгууллага нь холбогдох өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрсөн хэвээр байна. Уг шилжүүлсэн хөрөнгө болон холбогдох өр төлбөрийг тухайн байгууллагын хадгалан үлдсэн эрх, үүргийг тусгах тийм сууриар энэ Стандарт дахь хэмжилтийн бусад шаардлагуудыг үл харгалзан хэмжинэ. Шилжүүлсэн хөрөнгө болон холбогдох өр төлбөрийн цэвэр дансны үнэ нь дараах дүнгийн аль нэг байх тийм байдлаар уг холбогдох өр төлбөрийг хэмжинэ:
- (а) Хэрэв шилжүүлсэн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр хэмждэг бол тухайн байгууллагын хадгалан үлдсэн эрх, үүргийн хорогдуулсан өртөг; эсвэл
- (б) Хэрэв шилжүүлсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмждэг бол тухайн байгууллагын хадгалан үлдсэн эрх, үүргийг тус тусад нь хэмжих үед тэдгээрийн бодит үнэ цэнэтэй тэнцүү дүн.
29. Байгууллага нь уг шилжүүлсэн хөрөнгөөс үүсэх аливаа орлогыг түүний цаашдын оролцооны хэмжээгээр хүлээн зөвшөөрсөн хэвээр байх бөгөөд холбогдох өр төлбөрийн хувьд гарсан аливаа зардлыг хүлээн зөвшөөрнө.
30. Дараагийн тайлант үеийн хэмжилтийн зорилгоор, уг шилжүүлсэн хөрөнгө болон холбогдох өр төлбөрийн бодит үнэ цэнэд гарсан, хүлээн зөвшөөрсөн өөрчлөлтүүдийг 101-р параграфын дагуу аль алины хувьд тууштай тайлагнах бөгөөд харилцан суутгаж, цэвэр дүнгээр бүртгэхгүй.
31. Хэрэв байгууллагын цаашдын оролцоо нь санхүүгийн хөрөнгийн зөвхөн нэг хэсэгт хамаарах бол (жишээлбэл; байгууллага нь шилжүүлсэн хөрөнгийн тухайн хэсгийг буцаан худалдан авах сонголтыг хадгалж үлдсэн, эсвэл өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалан үлдэхэд хүргэхгүй тийм үлдэх хувь оролцоог хадгалан үлдсэн боловч уг байгууллага нь хяналтыг хадгалан үлдсэн бол) байгууллага нь уг санхүүгийн хөрөнгийн өмнөх дансны үнийг цаашдын оролцооны дагуу хүлээн зөвшөөрсөн хэвээр байх хэсэг болон цаашид хүлээн зөвшөөрөхгүй хэсэгт тэрхүү шилжүүлэлтийн өдрөөрх тухайн хэсгүүдийн харгалзах бодит үнэ цэнэд үндэслэн хуваарилна. Энэ зорилгын хувьд 25-р параграфын шаардлагуудыг мөрдөнө. Дараах дүнгүүдийн хоорондох зөрүүг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө:
- (а) Цаашид хүлээн зөвшөөрөхгүй тухайн хэсэгт хуваарилсан дансны үнэ (үл хүлээн зөвшөөрөлтийн өдрөөр хэмжсэн) ба
- (б) Цаашид хүлээн зөвшөөрөхгүй тухайн хэсгийн хувьд хүлээн авсан төлбөр.
32. Хэрэв шилжүүлсэн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр хэмжсэн бол санхүүгийн өр төлбөрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилах энэ Стандартад заасан сонголт нь уг холбогдох өр төлбөрийн хувьд хамаарахгүй.

Бүх шилжүүлэлт

33. Хэрэв шилжүүлсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн хэвээр байвал уг хөрөнгө болон холбогдох өр төлбөрийг харилцан суутгаж, цэвэр дүнг гаргахгүй. Үүнтэй адилаар, байгууллага нь уг шилжүүлсэн хөрөнгөөс бий болсон аливаа орлогыг тухайн холбогдох өр төлбөрийн хувьд гарсан аливаа зардалтай харилцан суутгаж, цэвэр дүнг гаргахгүй (УСНББОУС 28-ын 47-р параграфыг үзнэ үү).
34. Хэрэв шилжүүлэгч нь тухайн шилжүүлэн авагчид мөнгөн бус барьцаа (өрийн буюу өмчийн хэрэглүүр гэх мэт) өгсөн бол тэрхүү барьцааг бүртгэх шилжүүлэгч ба шилжүүлэн авагчийн нягтлан бодох бүртгэл нь шилжүүлэн авагч барьцааг борлуулах буюу бусдад

барьцаалах эрхтэй эсэх, шилжүүлэгч үүргээ үл биелүүлсэн эсэхээс хамаарна. Шилжүүлэгч ба шилжүүлэн авагч нь уг барьцааг дараах байдлаар тайлагнана:

- (а) Хэрэв шилжүүлэн авагч нь уг барьцааг борлуулах буюу бусад барьцаалах талаар гэрээнд заасан эрхтэй эсвэл ийм хэвшин тогтсон практиктай бол шилжүүлэгч нь тухайн хөрөнгийг өөрийн санхүүгийн байдлын тайландаа бусад хөрөнгөөс тусад нь салгаж, (жишээлбэл; зээлдүүлсэн хөрөнгө, барьцаалсан өмчийн хэрэглүүр эсвэл буцаан худалдан авах авлага гэх мэтээр) дахин ангилна.
- (б) Хэрэв шилжүүлэн авагч нь түүнд барьцаалсан барьцааны зүйлийг борлуулсан бол тэрээр уг борлуулалтын орлого, түүнчлэн тухайн барьцааг буцаан өгөх өөрийн үүргийн хувьд бодит үнэ цэнээр хэмжсэн өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.
- (в) Хэрэв шилжүүлэгч нь гэрээний дагуу үүргээ биелүүлээгүй бөгөөд барьцаагаа буцаан авах эрхгүй болсон бол тухайн шилжүүлэгч нь барьцааны зүйлийг үл хүлээн зөвшөөрөх ба шилжүүлэн авагч нь уг барьцааны зүйлийг түүний бодит үнэ цэнээр анх хэмжиж, хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө, харин барьцааны зүйлийг аль хэдийн борлуулсан бол тухайн барьцааны зүйлийг буцаан өгөх өөрийн үүргийг үл хүлээн зөвшөөрнө.
- (г) Дээрх (в)-д зааснаас бусад тохиолдолд шилжүүлэгч нь уг барьцааг өөрийн хөрөнгө гэж бүртгэсэн хэвээр байх бөгөөд шилжүүлэн авагч нь уг барьцааг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөхгүй.

Санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт

- 35. Байгууллага нь санхүүгийн өр төлбөрийг (буюу түүний нэг хэсгийг) дуусгавар болгосон үед, өөрөөр хэлбэл гэрээнд тусгайлан заасан үүргийг биелүүлсэн эсвэл цуцалсан буюу хугацаа дууссан үед өөрийн санхүүгийн байдлын тайлангаас хасна.
- 36. Өрийн хэрэглүүрийн одоогийн зээлдэгч ба зээлдүүлэгчийн хооронд мэдэгдэхүйц өөр нөхцлөөр хийсэн солилцоог уг анхны санхүүгийн өр төлбөрийн барагдуулалт ба шинэ санхүүгийн өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт байдлаар тайлагнана. Үүнтэй адилаар, одоогийн санхүүгийн өр төлбөрийн буюу түүний нэг хэсгийн нөхцөлд оруулсан мэдэгдэхүйц өөрчлөлтийг (тухайн зээлдэгчийн санхүүгийн хүндрэлтэй байдалтай холбоотой эсэхээс үл хамааран) уг анхны санхүүгийн өр төлбөрийн барагдуулалт ба шинэ санхүүгийн өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт байдлаар тайлагнана.
- 37. Барагдуулсан буюу бусад талд шилжүүлсэн санхүүгийн өр төлбөрийн (буюу түүний нэг хэсгийн) дансны үнэ ба төлсөн төлбөрийн (үүн дотроо, шилжүүлсэн аливаа мөнгөн бус хөрөнгө буюу хариуцсан өр төлбөрийн) хоорондох зөрүүг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Арилжааны бус ажил гүйлгээний нэг хэсэг байдлаар уг үүргийг зээлдүүлэгч цуцалсан буюу гуравдагч тал хариуцахаар болсон тохиолдолд байгууллага нь УСНББОУС 23-ыг мөрдөнө.
- 38. Хэрэв байгууллага нь санхүүгийн өр төлбөрийн нэг хэсгийг буцаан худалдан авсан бол байгууллага нь тэрхүү санхүүгийн өр төлбөрийн өмнөх дансны үнийг уг хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа хэсэг болон үл хүлээн зөвшөөрсөн хэсэгт тухайн буцаан худалдан авалтын өдрөөрх тэдгээрийн харгалзах бодит үнэ цэнэд үндэслэн хуваарилна. Дараах дүнгүүдийн хоорондох зөрүүг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө: (а) үл хүлээн зөвшөөрсөн хэсэгт хуваарилсан дансны үнэ, ба (б) уг үл хүлээн зөвшөөрсөн хэсгийн хувьд төлсөн төлбөр, үүн дотроо шилжүүлсэн аливаа мөнгөн бус хөрөнгө эсвэл хариуцсан өр төлбөр.

Ангилал

Санхүүгийн хөрөнгийн ангилал

39. **44-р параграфыг мөрдөхөөс бусад тохиолдолд, байгууллага нь дараах зүйлсийн аль алинд үндэслэн санхүүгийн хөрөнгийг дараагийн тайлант үед хорогдуулсан өртгөөр, цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр эсвэл ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилна:**
- (а) Санхүүгийн хөрөнгийг удирдан зохицуулах тухайн байгууллагын удирдлагын загвар, ба
 - (б) Санхүүгийн хөрөнгийн гэрээний мөнгөн гүйлгээний шинж чанар.
40. **Хэрэв дараах хоёр нөхцөл хоёулаа хангагдаж байвал санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр хэмжинэ:**
- (а) Гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулан авахын тулд санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилготой тийм удирдлагын загварын дагуу тухайн санхүүгийн хөрөнгийг эзэмшдэг байх.
 - (б) Тухайн санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөл нь тогтоосон өдрүүдээр мөнгөн гүйлгээ үүсэхэд хүргэдэг байх. Тэдгээр мөнгөн гүйлгээ нь зөвхөн үндсэн дүнгийн, түүнчлэн уг төлөгдөөгүй үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд байна.
- Эдгээр нөхцлүүдийг хэрхэн мөрдөх талаархи заавар удирдамжийг МЗУ48-МЗУ88-р параграфт заасан.**
41. **Хэрэв дараах хоёр нөхцөл хоёулаа хангагдаж байвал санхүүгийн хөрөнгийг цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжинэ:**
- (а) Гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулан авах ба санхүүгийн хөрөнгийг борлуулах гэсэн хоёр зорилготой тийм удирдлагын загварын дагуу тухайн санхүүгийн хөрөнгийг эзэмшдэг байх.
 - (б) Тухайн санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөл нь тогтоосон өдрүүдээр мөнгөн гүйлгээ үүсэхэд хүргэдэг байх. Тэдгээр мөнгөн гүйлгээ нь зөвхөн үндсэн дүнгийн, түүнчлэн уг төлөгдөөгүй үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд байна.
- Эдгээр нөхцлүүдийг хэрхэн мөрдөх талаархи заавар удирдамжийг МЗУ48-МЗУ88-р параграфт заасан.**
42. **40(б) ба 41(б) параграфуудыг мөрдөх зорилгын хувьд:**
- (а) Үндсэн дүн нь тухайн санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үе дэх түүний бодит үнэ цэнэ юм. Үндсэн дүнг хэрхэн ойлгох талаархи нэмэлт заавар удирдамжийг МЗУ64-р параграфт тусгасан.
 - (б) Хүү нь дараах зүйлсийн төлөөх төлбөрөөс бүрдэнэ. Үүнд: мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ, тухайн тайлант үеийн туршид төлөгдөөгүй байгаа үндсэн дүнд хамаарах зээлийн эрсдэл, зээлийн бусад суурь эрсдлүүд болон зардал, түүнчлэн ашиг. Хүү, үүн дотроо мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг хэрхэн ойлгох талаархи нэмэлт заавар удирдамжийг МЗУ63, МЗУ67-МЗУ71-р параграфт тусгасан.
43. **Санхүүгийн хөрөнгийг 40-р параграфын дагуу хорогдуулсан өртгөөр эсвэл 41-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэнээс бусад тохиолдолд түүнийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих байсан, өмчийн хэрэглүүрт оруулсан тодорхой хөрөнгө оруулалтыг анх хүлээн зөвшөөрөх үедээ, бодит үнэ цэнийн дараагийн тайлант үеүдийн өөрчлөлтүүдийг цэвэр хөрөнгө/өмчид толилуулахаар эргэлт буцалтгүй сонголт хийж болох юм (106-107-р параграфыг үзнэ үү).**

Санхүүгийн хөрөнгийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилах боломж

44. **Хөрөнгө, өр төлбөрийг өөр сууриудаар хэмжсэнээр эсвэл тэдгээрийн олз, гарзыг өөр сууриудаар хүлээн зөвшөөрснөөр үүсэх байсан хэмжилтийн болон хүлээн зөвшөөрөлтийн**

тууштай бус байдлыг (зарим үед “нягтлан бодох бүртгэлийн уялдаагүй байдал” гэж нэрлэдэг) арилгах буюу мэдэгдэхүйц бууруулах бол байгууллага нь 39-43-р параграфт заасныг үл харгалзан санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үедээ түүнийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж эргэлт буцалтгүйгээр ангилж болох юм (МЗУ91-МЗУ94-р параграфыг үзнэ үү).

Санхүүгийн өр төлбөрийн ангилал

45. Байгууллага нь доор дурдсанаас бусад, бүх санхүүгийн өр төлбөрийг дараагийн тайлант үед хорогдуулсан өртгөөр хэмжсэн гэж ангилна:

- (a) Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөр. Ийм өр төлбөрүүдийг, үүн дотроо өр төлбөр болох үүсмэл хэрэглүүрүүдийг дараагийн тайлант үеүдэд бодит үнэ цэнээр хэмжинэ.
- (б) Санхүүгийн хөрөнгийн шилжүүлэлт нь үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангахгүй байх эсвэл цаашдын оролцооны арга хандлагыг хэрэглэх үед үүссэн санхүүгийн өр төлбөр. Ийм санхүүгийн өр төлбөрийн хэмжилтэнд 26 ба 28-р параграфыг мөрдөнө.
- (в) Санхүүгийн баталгааны гэрээ. Ийм гэрээг гаргагч нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойшхи дараагийн тайлант үеүдэд түүнийг (45(a) буюу (б) параграфыг мөрдсөнөөс бусад тохиолдолд) доорх дүнгүүдийн аль өндрөөр хэмжинэ:
 - (i) 73-93-р параграфын дагуу тодорхойлсон гарзын хасагдуулгын дүн, ба
 - (ii) Анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс (57-р параграфыг үзнэ үү) хэрэв байгаа бол УСНББОУС 9-ийн зарчмуудын дагуу хүлээн зөвшөөрсөн, хорогдуулгын хуримтлагдсан дүнг хассан дүн.
- (г) Зах зээлийн хүүний түвшинээс бага хүүтэйгээр зээл олгох баталгаа. Ийм баталгааг гаргагч нь дараагийн тайлант үеүдэд түүнийг (45(a) параграфыг мөрдсөнөөс бусад тохиолдолд) доорх дүнгүүдийн аль өндрөөр хэмжинэ:
 - (i) 73-93-р параграфын дагуу тодорхойлсон гарзын хасагдуулгын дүн, ба
 - (ii) Анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс (57-р параграфыг үзнэ үү) хэрэв байгаа бол УСНББОУС 9-ийн зарчмуудын дагуу хүлээн зөвшөөрсөн, хорогдуулгын хуримтлагдсан дүнг хассан дүн.
- (д) УСНББОУС 40-ийг мөрдөх улсын секторын нэгдлийн хувьд нэгтгэгчийн хүлээн зөвшөөрсөн болзошгүй төлбөр. Ийм болзошгүй төлбөрийг дараагийн тайлант үеүдэд бодит үнэ цэнээр хэмжих бөгөөд бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн өр төлбөрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилах боломж

46. 51-р параграфтаар зөвшөөрсөн эсвэл дараах аль нэг шалтгаанаар илүү хамааралтай мэдээлэл бий болгох үр дүнтэй тохиолдолд байгууллага нь санхүүгийн өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөх үедээ түүнийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж эргэлт буцалтгүйгээр ангилж болно:

- (a) Хөрөнгө, өр төлбөрийг өөр сууриудаар хэмжсэнээр эсвэл тэдгээрийн олз, гарзыг өөр сууриудаар хүлээн зөвшөөрснөөр үүсэх байсан хэмжилтийн болон хүлээн зөвшөөрөлтийн тууштай бус байдлыг (зарим үед “нягтлан бодох бүртгэлийн уялдаагүй байдал” гэж нэрлэдэг) арилгах буюу мэдэгдэхүйц бууруулдаг (МЗУ91-МЗУ94-р параграфыг үзнэ үү); эсвэл
- (б) Санхүүгийн өр төлбөрүүдийн буюу санхүүгийн хөрөнгүүдийн бүлэг, түүнчлэн санхүүгийн өр төлбөрийг тухайн байгууллагын эрсдлийн удирдлагын болон хөрөнгө оруулалтын баримтжуулсан стратегийн дагуу удирдаж, түүний гүйцэтгэлийг бодит үнэ цэнийн сууриар үнэлдэг бөгөөд тэрхүү бүлгийн талаархи мэдээллийг уг байгууллагын эрх бүхий албан тушаалтанд (УСНББОУС 20,

Холбоотой Талуудын Тодруулга-д тодорхойлсон), тухайлбал, байгууллагын захирлуудын зөвлөл ба гүйцэтгэх захиралд дотооддоо танилцуулдаг (МЗУ95-МЗУ98-р параграфыг үзнэ үү).

Дагалдах үүсмэл хэрэглүүр

47. Дагалдах үүсмэл хэрэглүүр нь холимог гэрээний бүрэлдэхүүн хэсэг бөгөөд уг холимог гэрээ нь мөн үүсмэл бус үндсэн гэрээг агуулсан байдаг. Дагалдах үүсмэл хэрэглүүр нь түүний дангаараа байх үетэй ижил төсөөтэй байдлаар тухайн нэгдсэн (холимог) хэрэглүүрийн зарим мөнгөн гүйлгээ хувьсан өөрчлөгдөхөд хүргэдэг. Дагалдах үүсмэл хэрэглүүр нь тохиролцсон хүүний хувь, санхүүгийн хэрэглүүрийн үнэ, бараа бүтээгдэхүүний үнэ, гадаад валютын ханш, үнийн буюу ханшийн индекс, зээлийн зэрэглэл буюу зээлийн индекс, түүнчлэн уг гэрээний аль нэг талд тусгайлан хамаарахгүй санхүүгийн бус хувьсагч гэх мэт бусад хувьсагчдад нийцүүлэн зарим буюу бүх мөнгөн гүйлгээг засварлан өөрчлөх шалтгаан болдог бөгөөд хэрэв ингэж өөрчлөхгүй бол тийм өөрчлөлт хийхийг тухайн гэрээгээр шаардах юм. *Санхүүгийн хэрэглүүрийг* дагалдан гардаг боловч гэрээний дагуу тухайн санхүүгийн хэрэглүүрээс тусдаа бие даасан байдлаар шилжүүлж болох эсвэл гэрээний өөр оролцогч тал бүхий үүсмэл хэрэглүүр нь дагалдах үүсмэл хэрэглүүр биш, гэхдээ тусдаа санхүүгийн хэрэглүүр мөн юм.

Санхүүгийн хөрөнгийн үндсэн гэрээ бүхий холимог гэрээ

48. **Холимог гэрээ нь үндсэн гэрээг агуулдаг бөгөөд уг үндсэн гэрээ нь энэ Стандартын цар хүрээнд хамаарах хөрөнгө бол байгууллага нь 39-44-р параграфын шаардлагуудыг уг холимог гэрээнд бүхэлд нь дагаж мөрдөнө.**

Бусад холимог гэрээ

49. **Холимог гэрээ нь үндсэн гэрээг агуулдаг бөгөөд уг үндсэн гэрээ нь энэ Стандартын цар хүрээнд хамаарах хөрөнгө биш бол дагалдах үүсмэл хэрэглүүрийг зөвхөн дараах тохиолдолд үндсэн гэрээнээс салгаж, энэхүү Стандартын дагуу үүсмэл хэрэглүүр гэж тайлагнана:**
- (a) **Дагалдах үүсмэл хэрэглүүрийн эдийн засгийн шинж чанар ба эрсдэл нь үндсэн гэрээний эдийн засгийн шинж чанар ба эрсдэлтэй нягт холбоотой биш байх (МЗУ103, МЗУ106-р параграфыг үзнэ үү);**
 - (b) **Дагалдах үүсмэл хэрэглүүртэй ижил нөхцлөөр авч үзсэн тусдаа хэрэглүүр нь үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолтыг хангадаг;**
 - (b) **Холимог хэрэглүүрийг түүний бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх байдлаар бодит үнэ цэнээр хэмждэггүй байх (өөрөөр хэлбэл, ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөрийг дагалдаж буй үүсмэл хэрэглүүрийг түүнээс салгахгүй);**
50. **Хэрэв дагалдах үүсмэл хэрэглүүрийг салгаж тусгаарладаг бол тухайн үндсэн гэрээг тохирох Стандартуудын дагуу тайлагнана. Дагалдах үүсмэл хэрэглүүрийг санхүүгийн байдлын тайланд тусад нь толилуулах эсэхийг энэ Стандартад заагаагүй.**
51. **Гэрээ нь нэг буюу хэд хэдэн дагалдах үүсмэл хэрэглүүрийг агуулдаг бөгөөд түүний үндсэн гэрээ нь энэ Стандартын цар хүрээнд хамаарах хөрөнгө биш бол 49 ба 50-р параграфт заасныг үл харгалзан тухайн байгууллага нь доор дурдснаас бусад тохиолдолд уг холимог гэрээг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж бүхэлд нь ангилж болно:**
- (a) **Дагалдах үүсмэл хэрэглүүр нь тухайн гэрээгээр шаардах байсан мөнгөн гүйлгээг мэдэгдэхүйц өөрчилдөггүй; эсвэл**
 - (b) **Ижил төсөөтэй холимог хэрэглүүрийг анх авч үзэхэд уг дагалдах үүсмэл хэрэглүүрийг салгахыг хориглоно гэдэг нь шинжилгээ хийхгүйгээр эсвэл багахан**

шинжилгээ хийснээр илт тодорхой байх. Жишээлбэл; зээлийг түүний хорогдуулсан өртөгтэй ойролцоо дүнгээр буцаан төлөхийг тухайн эзэмшигчид зөвшөөрдөг уг зээлийг дагалдсан урьдчилан төлөлтийн опцион.

52. Дагалдах үүсмэл хэрэглүүрийг түүний үндсэн гэрээнээс салгахыг энэ Стандартаар байгууллагаас шаарддаг боловч анх олж эзэмших үед эсвэл дараагийн санхүүгийн тайлагналын үеийн эцэст уг дагалдах үүсмэл хэрэглүүрийг тусад нь хэмжих боломжгүй бол тухайн байгууллага нь тэрхүү холимог гэрээг бүхэлд нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилна.
53. Хэрэв байгууллага нь дагалдах үүсмэл хэрэглүүрийн нөхцөл, болзлуудад үндэслэн түүний бодит үнэ цэнийг найдвартайгаар хэмжих боломжгүй байвал уг дагалдах үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнэ нь тухайн холимог гэрээний бодит үнэ цэнэ ба үндсэн гэрээний бодит үнэ цэнийн зөрүүгээр тодорхойлогдоно. Хэрэв байгууллага нь энэ аргыг ашигласнаар уг дагалдах үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнийг хэмжих боломжгүй бол 52-р параграфыг мөрдөх бөгөөд тухайн холимог гэрээг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилна.

Дахин ангилал

54. Байгууллага нь санхүүгийн хөрөнгөө удирдан зохицуулах өөрийн удирдлагын загварыг өөрчилсөн зөвхөн тийм тохиолдолд уг байгууллага нь тухайн өөрчлөлтөөр нөлөө үзүүлэх бүх санхүүгийн хөрөнгийг 39-43-р параграфын дагуу дахин ангилна. Санхүүгийн хөрөнгийг дахин ангилах талаархи нэмэлт заавар удирдамжийг 94-100, МЗУ111-МЗУ113, МЗУ220-МЗУ221-р параграфаас үзнэ үү.
55. Байгууллага нь аливаа санхүүгийн өр төлбөрийг дахин ангилахгүй.
56. Нөхцөл байдлын дараах өөрчлөлтүүдийг 54-55-р параграфын зорилгын хувьд дахин ангилал гэж үзэхгүй:
- (а) Тухайн зүйл өмнө нь мөнгөн гүйлгээний хейж эсвэл цэвэр хөрөнгө оруулалтын хейжийн хувьд сонгосон ба үр дүнтэй хейжийн хэрэглүүр байсан боловч одоо ийм шинж чанаргүй болох;
 - (б) Тухайн зүйл нь мөнгөн гүйлгээний хейж эсвэл цэвэр хөрөнгө оруулалтын хейжийн хувьд сонгосон ба үр дүнтэй хейжийн хэрэглүүр болох;
 - (в) 152-155-р параграфын дагуу хэмжилтэнд гарсан өөрчлөлт.

Хэмжилт

Анхны хэмжилт

57. 60-р параграфын цар хүрээнд хамаарах богино хугацаат авлага, өглөгөөс бусад санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг байгууллага нь анх хүлээн зөвшөөрөхдөө түүний бодит үнэ цэнээр хэмжинэ, харин ашиг, алдагдлаар дамжуулан тусгах бодит үнэ цэнээс өөр дүнгээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр байх тохиолдолд тэдгээрийн олж эзэмшилт буюу гаргалтанд шууд хамаарах ажил гүйлгээний зардлыг тэрхүү дүн дээр нэмэх эсвэл хасах байдлаар хэмжинэ.
58. Гэвч санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнэ нь тухайн ажил гүйлгээний үнээс өөр байвал байгууллага нь МЗУ117-р параграфыг мөрдөнө.
59. Дараагийн тайлант үеүдэд хорогдуулсан өртгөөр хэмжих хөрөнгийн хувьд байгууллага нь барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэдэг тохиолдолд уг хөрөнгийг тухайн арилжааны өдрөөрх түүний бодит үнэ цэнээр анх хүлээн зөвшөөрнө (МЗУ17-МЗУ20-р параграфыг үзнэ үү).

60. Хэрэв дискаунтын нөлөө нь материаллаг бус бол 57-р параграфын шаардлагыг үл харгалзан байгууллага нь богино хугацаат авлага ба өглөгийг анх хүлээн зөвшөөрөхдөө анхны нэхэмжлэлийн үнээр хэмжиж болох юм.

Санхүүгийн хөрөнгийн дараагийн тайлант үеийн хэмжилт

61. **Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа, байгууллага нь санхүүгийн хөрөнгийг 39-44-р параграфын дагуу дараах дүнгээр хэмжинэ:**
- (a) **Хорогдуулсан өртгөөр;**
 - (b) **Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр;**
 - (в) **Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр.**
62. Байгууллага нь 40-р параграфын дагуу хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгөнд болон 41-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгөнд 73-93-р параграф дахь үнэ цэнийн бууралтын шаардлагуудыг мөрдөнө.
63. Байгууллага нь хейжийн зүйл² гэж сонгосон санхүүгийн хөрөнгөнд 137-143-р параграфт заасан хейжийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудыг (хэрэв мөрдөх боломжтой бол хүүний түвшний эрсдлийн багц хейжид хамаарах бодит үнэ цэнийн хейжийн нягтлан бодох бүртгэлийн хувьд УСНББОУС 29, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*-ийн 99-105-р параграфын шаардлагуудыг)-мөрдөнө.

Санхүүгийн өр төлбөрийн дараагийн тайлант үеийн хэмжилт

64. **Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа байгууллага нь санхүүгийн өр төлбөрийг 45-46-р параграфын дагуу хэмжинэ.**
65. Байгууллага нь хейжийн зүйл гэж сонгосон санхүүгийн өр төлбөрт 137-143-р параграфт заасан хейжийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудыг (хэрэв мөрдөх боломжтой бол хүүний түвшний эрсдлийн багц хейжид хамаарах бодит үнэ цэнийн хейжийн нягтлан бодох бүртгэлийн хувьд УСНББОУС 29-ийн 99-105-р параграфын шаардлагуудыг)-мөрдөнө.

Бодит үнэ цэнийн хэмжилтийн анхаарах зүйлс

66. Энэ Стандарт, УСНББОУС 28, УСНББОУС 30-ыг мөрдөх зорилгын хувьд санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо, байгууллага нь Хавсралт А-гийн МЗУ144-МЗУ155-р параграфыг даган мөрдөнө.
67. Бодит үнэ цэнийн хамгийн сайн нотолгоо нь идэвхитэй зах зээлийн жишиг үнэ юм. Хэрэв санхүүгийн хэрэглүүрийн зах зээл нь идэвхитэй биш бол байгууллага нь үнэлгээний арга зүй ашигласнаар бодит үнэ цэнийг тогтоодог. Үнэлгээний арга зүй ашиглахын зорилго нь хэвийн үйл ажиллагааны төлбөрт үндэслэн хийгдэх харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээний хувьд уг хэмжилтийн өдрөөр оршин байх ажил гүйлгээний үнийг тогтоох явдал юм. Үнэлгээний арга зүй нь хэрэв бэлэн боломжтой байгаа бол мэдэгдэхүйц ижил төсөөтэй, дискаунтчилсан мөнгөн гүйлгээний шинжилгээ болон опционы үнэ тогтоох загвар бүхий өөр хэрэглүүрийн одоогийн бодит үнэ цэнийг лавлагаа болгосноор зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хоорондох, харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээг ашигладаг. Хэрэглүүрийн үнийг тогтоохдоо зах зээлийн оролцогчдын нийтлэг ашигладаг үнэлгээний арга зүй байдаг бөгөөд тухайн хэрэглүүр нь зах зээлийн бодит ажил гүйлгээгээр

² 179-р параграфын дагуу байгууллага нь энэ Стандартын 113-155-р параграфын шаардлагуудыг биш, харин УСНББОУС 29-д заасан хейжийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудыг үргэлжлүүлэн мөрдөх байдлаар өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгож болох юм. Хэрэв байгууллага нь нийм сонголт хийсэн бол 113-155-р параграф дахь хейжийн нягтлан бодох бүртгэлийн тодорхой шаардлагуудын талаархи энэ Стандарт дахь заалтууд хамааралгүй болно. Харин үүний оронд байгууллага нь УСНББОУС 29 дэх хейжийн нягтлан бодох бүртгэлийн холбогдох шаардлагуудыг дагаж мөрдөнө.

олж авсан үнийн найдвартай тооцооллоор хангадаг гэдгээ батлан харуулсан бол байгууллага нь уг арга зүйг ашиглана. Тухайн сонгосон үнэлгээний арга зүй нь зах зээлийн орцуудыг хамгийн ихээр ашиглах ба байгууллагын тусгайлсан орц мэдээнд аль болох хамгийн бага хэмжээгээр итгэл хүлээлгэдэг. Энэ нь үнэ тогтоохдоо зах зээлийн оролцогчдын харгалзан үзэх бүх хүчин зүйлсийг нэгтгэн агуулдаг бөгөөд санхүүгийн хэрэглүүрийн үнэ тогтоох эдийн засгийн хүлээн зөвшөөрөгдсөн арга зүйтэй нийцдэг. Байгууллага нь үнэлгээний арга зүйг үечлэн туршин шалгаж, тухайн хэрэглүүрийн талаархи ажиглаж болох, одоогийн зах зээлийн аливаа ажил гүйлгээний үнийг ашигласнаар (өөрөөр хэлбэл, засвар өөрчлөлт оруулахгүй буюу дахин нэгтгэн багцлахгүйгээр), эсвэл бэлэн боломжтой байгаа ажиглаж болох аливаа зах зээлийн мэдээнд үндэслэн түүний хүчин төгөлдөр байдлыг сорьж магадлагдаж.

68. Шаардах шинж бүхий санхүүгийн өр төлбөрийн (жишээлбэл; харилцах ба хугацаагүй хадгаламж) бодит үнэ цэнэ нь тухайн дүнг төлөхийг шаардаж болох эхний өдрөөс эхлэн дискаунтчилсан, шаардсан даруйд төлөх дүнгээс багагүй байна.

Хорогдуулсан өртгөөр хэмжилт

Санхүүгийн хөрөнгө

Үр ашигт хүүний арга

69. **Үр ашигт хүүний арга (9-р параграф болон МЗУ156-МЗУ162-р параграфыг үзнэ үү)-ыг ашиглан хүүний орлогыг тооцоолно. Доор дурдсанаас бусад санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнийг уг үр ашигт хүүний хувиар үржүүлж, хүүний орлогыг тооцоолно:**
- (а) Худалдан авсан буюу үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгө. Ийм санхүүгийн хөрөнгийн хувьд байгууллага нь зээлийн эрсдлээр тохируулсан үр ашигт хүүний хувийг тухайн санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртөгт түүний анхны хүлээн зөвшөөрөлтөөс эхлэн хэрэглэнэ.
 - (б) Худалдан авсан буюу үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгө биш боловч дараагийн тайлант үеэд зээлийн үнэ цэнийн бууралттай болсон тийм санхүүгийн хөрөнгө. Ийм санхүүгийн хөрөнгийн хувьд байгууллага нь үр ашигт хүүний хувийг тухайн санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртөгт уг дараагийн тайлант үеэд хэрэглэнэ.
70. Санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдэл сайжирсан, ингэснээр санхүүгийн хөрөнгө нь зээлийн үнэ цэнийн бууралтгүй болсон бөгөөд тэрхүү сайжралт нь 66(б) параграфын шаардлагуудыг мөрдсөний дараа гарч тохиолдсон үйл явдалтай (зээлдэгчийн зээлийн зэрэглэлийн сайжралт гэх мэт) бодитойгоор холбоотой бол 69(б) параграфын дагуу санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртөгт үр ашигт хүүний аргыг хэрэглэж, тухайн тайлант үед хүүний орлогоо тооцоолдог байсан байгууллага нь дараагийн тайлант үед санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнийг энэхүү үр ашигт хүүний хувиар үржүүлж, хүүний орлогоо тооцоолно.

Гэрээний мөнгөн гүйлгээний өөрчлөлт

71. Санхүүгийн хөрөнгийн гэрээний мөнгөн гүйлгээг дахин хэлэлцэн тохирох буюу өөр бусад байдлаар өөрчлөх ба ийм дахин хэлэлцэн тохиролт ба өөрчлөлт нь тухайн санхүүгийн хөрөнгийг энэ Стандартын дагуу үл хүлээн зөвшөөрөхөд хүргэдэггүй бол байгууллага нь уг санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнийг дахин тооцоолж, өөрчлөлтөөс бий болсон олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Санхүүгийн хөрөнгийн анхны үр ашигт хүүний хувиар (худалдан авсан буюу үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд зээлийн эрсдлээр тохируулсан үр ашигт хүүний хувиар), эсвэл хамааралтай тохиолдолд 139-р параграфын дагуу тооцоолсон, хянан засварласан үр ашигт хүүний хувиар дискаунтчилсан, уг дахин хэлэлцэн тохирсон буюу өөрчилсөн гэрээний мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнээр тухайн санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнийг дахин тооцоолно. Гарсан аливаа өртөг зардал буюу үйлчилгээний хураамж нь тухайн өөрчилсөн санхүүгийн

хөрөнгийн дансны үнэд нэмэгдэх бөгөөд тэрхүү өөрчилсөн санхүүгийн хөрөнгийн үлдсэн ашиглалтын хугацааны туршид түүнийг хорогдуулна.

Данснаас хасалт

72. Байгууллага нь санхүүгийн хөрөнгийн дансны үнийг бүхэлд нь, эсвэл түүний зарим хэсгийг нөхнө гэсэн ул үндэслэлтэй хүлээлтгүй тохиолдолд тухайн байгууллага нь уг санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнийг шууд бууруулна. Данснаас хасалт нь үл хүлээн зөвшөөрөлт үүсгэх үйл явдал юм (МЗУ37(у) параграфыг үзнэ үү).

Үнэ цэнийн бууралт

Хүлээгдэж буй зээлийн алдагдлын хүлээн зөвшөөрөлт

Ерөнхий хандлага

73. **Байгууллага нь 40 эсвэл 41-р параграфын дагуу хэмжсэн санхүүгийн хөрөнгийн болон 2(ж), 45(в), 45(г) параграфын дагуу үнэ цэнийн бууралтын шаардлагуудыг мөрддөг түрээсийн авлага, зээл олгох баталгаа, санхүүгийн баталгааны гэрээний хүлээгдэж буй зээлийн алдагдлын хувьд гарзын хасагдуулгыг хүлээн зөвшөөрнө.**
74. Байгууллага нь 41-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг санхүүгийн хөрөнгийн гарзын хасагдуулгын хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийн хувьд үнэ цэнийн бууралтын шаардлагуудыг дагаж мөрдөнө. Гэвч гарзын хасагдуулгыг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрөх бөгөөд санхүүгийн байдлын тайлан дахь санхүүгийн хөрөнгийн дансны үнийг бууруулахгүй.
75. **85-88-р параграфт зааснаас бусад тохиолдолд, хэрэв санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдэл нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш мэдэгдэхүйц нэмэгдсэн бол байгууллага нь уг санхүүгийн хэрэглүүрт хамаарах гарзын хасагдуулгыг тухайн нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр тайлант үе бүрийн эцэст хэмжинэ.**
76. Үнэ цэнийн бууралтын шаардлагуудын зорилго нь ул үндэслэлтэй ба дэмжих бүх мэдээллийг, үүн дотроо хэтийн төлөвийн талаархи мэдээллийг харгалзан үзэж, бие даасан буюу нэгдсэн сууриар үнэлэхэд анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн бүх санхүүгийн хэрэглүүрийн хувьд тухайн нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх явдал юм.
77. **85-88-р параграфт зааснаас бусад тохиолдолд, хэрэв санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдэл нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш мэдэгдэхүйц нэмэгдээгүй бол байгууллага нь уг санхүүгийн хэрэглүүрт хамаарах гарзын хасагдуулгыг 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр тухайн тайлант үеийн эцэст хэмжинэ.**
78. Зээл олгох баталгаа ба санхүүгийн баталгааны гэрээ байх тохиолдолд тухайн байгууллага нь тэрхүү буцах боломжгүй баталгааны оролцогч нэг тал болсон өдрийг уг үнэ цэнийн бууралтын шаардлагуудыг мөрдөх зорилгын хувьд анхны хүлээн зөвшөөрөлтийн өдөр гэж үзнэ.
79. Байгууллага нь санхүүгийн хэрэглүүрт хамаарах гарзын хасагдуулгыг нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр өмнөх тайлант үед хэмжсэн боловч тухайн тайлант үеийн эцэст 75-р параграфын шаардлагыг хангахгүй болсон гэдгийг тодорхойлсон бол байгууллага нь гарзын хасагдуулгыг 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр уг тайлант үеийн эцэст хэмжинэ.
80. Байгууллага нь тухайн тайлант үеийн эцэс дэх гарзын хасагдуулгыг энэхүү Стандартын дагуу хүлээн зөвшөөрвөл зохих дүнтэй тохируулахад шаардлагатай уг хүлээгдэж буй зээлийн алдагдлын дүнг (эсвэл буцаалтыг) *үнэ цэнийн бууралтын олз эсвэл гарз* байдлаар ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Зээлийн эрсдлийн мэдэгдэхүйц нэмэгдэлтийг тодорхойлох

81. Санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдэл нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг байгууллага нь тайлант үе бүрийн эцэст үнэлнэ. Ийм үнэлгээг хийх үедээ байгууллага нь хүлээгдэж буй зээлийн алдагдлын дүнгийн өөрчлөлтийг биш, харин тухайн санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй нийт хугацааны туршид үл биелүүлэлт гарах эрсдлийн өөрчлөлтийг харгалзан үзнэ. Үнэлгээг хийхийн тулд байгууллага нь уг санхүүгийн хэрэглүүрт үл биелүүлэлт гарах талаархи тухайн тайлант үеийн эцсээрх эрсдлийг тэрхүү санхүүгийн хэрэглүүрт үл биелүүлэлт гарах талаархи анхны хүлээн зөвшөөрөлтийн өдрөөрх эрсдэлтэй харьцуулах ба их зардал буюу хүчин чармайлт гаргахгүйгээр олж болох бөгөөд анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэнийг илэрхийлэх үл үндэслэлтэй ба дэмжих мэдээллийг харгалзан үзнэ.
82. Хэрэв санхүүгийн хэрэглүүрийг тухайн тайлант үеийн эцсийн өдрөөр зээлийн эрсдэл багатай байна гэж тодорхойлсон бол байгууллага нь уг санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдэл анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш мэдэгдэхүйц нэмэгдэхгүй гэж үзэж болох юм (МЗУ186-МЗУ188-р параграфыг үзнэ үү).
83. Хэтийн талаархи үл үндэслэлтэй ба дэмжих мэдээллийг их зардал буюу хүчин чармайлт гаргахгүйгээр олж авах боломжтой бол байгууллага нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг тодорхойлох үедээ зөвхөн хугацаа өнгөрсөн мэдээлэлд тулгуурлаж болохгүй. Гэвч хугацаа өнгөрсөн гэхээсээ илүү хэтийн төлөв байдлын талаархи мэдээллийг (тусдаа буюу нэгдсэн байдлаараа) их зардал буюу хүчин чармайлт гаргахгүйгээр олж авах боломжгүй тохиолдолд байгууллага нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг тодорхойлохын тулд хугацаа өнгөрсөн мэдээллийг ашиглаж болно. Байгууллага нь зээлийн эрсдлийн мэдэгдэхүйц нэмэгдэлтийг ямар арга замаар үнэлдэгээс үл хамааран гэрээний төлбөр нь 30 хоногоос илүүгээр хугацаа өнгөрсөн тохиолдолд санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл нь мэдэгдэхүйц нэмэгдсэн гэсэн няцааж болох урьдчилсан нөхцөлтэй байдаг. Хэдийгээр гэрээний төлбөр нь 30 хоногоос илүүгээр хугацаа өнгөрсөн боловч зээлийн эрсдэл нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш мэдэгдэхүйц нэмэгдээгүй гэдгийг харуулах үл үндэслэлтэй ба дэмжих мэдээллийг байгууллага нь их зардал буюу хүчин чармайлт гаргахгүйгээр олж авах боломжтой бол тухайн байгууллага нь энэхүү урьдчилсан нөхцлийг няцааж болно. Байгууллага нь зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн гэдгийг тухайн гэрээний төлбөр 30 хоногоос илүүгээр хугацаа өнгөрөхөөс өмнө тодорхойлсон тохиолдолд уг няцааж болох урьдчилсан нөхцөл хамаарахгүй.

Өөрчилсөн санхүүгийн хөрөнгө

84. Санхүүгийн хөрөнгийн гэрээний мөнгөн гүйлгээг дахин хэлэлцэн тохирсон буюу өөрчилсөн ба тухайн санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөөгүй бол байгууллага нь 75-р параграфт заасанчлан, уг санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг дараах хоёр эрсдлийг харьцуулснаар үнэлнэ:
- (a) Үл биелүүлэлт гарч тохиолдох талаархи тухайн тайлант үеийн эцсээрх эрсдэл (гэрээний өөрчилсөн нөхцөлд үндэслэнэ);
 - (б) Үл биелүүлэлт гарч тохиолдох талаархи анхны хүлээн зөвшөөрөлтийн өдрөөрх эрсдэл (гэрээний анхны буюу өөрчлөөгүй нөхцөлд үндэслэнэ).

Худалдан авсан буюу үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгө

85. **75 ба 77-р параграфт заасныг үл харгалзан байгууллага нь нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлын зөвхөн хуримтлагдсан өөрчлөлтийг уг худалдан авсан буюу үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд гарзын хасагдуулга байдлаар тухайн тайлант үеийн эцэст хүлээн зөвшөөрнө.**
86. Байгууллага нь нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлын өөрчлөлтийн дүнг тайлант үе бүрийн эцэст үнэ цэнийн бууралтын олз эсвэл гарз байдлаар ашиг, алдагдалд хүлээн

зөвшөөрнө. Нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдал нь уг тооцоолсон мөнгөн гүйлгээнд анхны хүлээн зөвшөөрөлтөөр оруулсан тухайн хүлээгдэж буй зээлийн алдагдлын дүнгээс бага байсан ч гэсэн байгууллага нь нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлын тааламжтай өөрчлөлтийг үнэ цэнийн бууралтын олз гэж хүлээн зөвшөөрнө.

Авлагад зориулсан хялбаршуулсан арга хандлага

87. **75 ба 77-р параграфт заасныг үл харгалзан байгууллага нь дараах зүйлсийн хувьд гарзын хасагдуулгыг тухайн нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр ямагт хүлээн зөвшөөрнө:**
- (а) **УСНББОУС 9-ийн цар хүрээнд хамаарах арилжааны ажил гүйлгээ болон УСНББОУС 23-ын цар хүрээнд хамаарах арилжааны бус ажил гүйлгээнээс үүсдэг авлага;**
 - (б) **Хэрэв байгууллага нь гарзын хасагдуулгыг тухайн нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр хэмжихээр өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгосон бол УСНББОУС 13-ын цар хүрээнд хамаарах ажил гүйлгээнээс үүссэн түрээсийн авлага. Уг нягтлан бодох бүртгэлийн бодлогыг бүх түрээсийн авлагад мөрдөх боловч санхүүгийн болон үйл ажиллагааны түрээсийн авлагад тус тусад нь мөрдөж болох юм.**
88. Байгууллага нь худалдааны авлага, түрээсийн авлагын хувьд өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг нэг нэгнээс нь хамааралгүйгээр тусдаа сонгож болно.
89. Худалдан авсан буюу үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгөд хамаарах шаардлагуудыг (9 болон 85-86-р параграфыг үзнэ үү) богино хугацаат авлагад мөрдөхгүй.

Хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилт

90. **Байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй зээлийн алдагдлыг дараах зүйлсийг тусгах байдлаар хэмжинэ:**
- (а) **Боломжит үр дүнгүүдийн хамаарах мужийг үнэлэх замаар тодорхойлдог, хэт нэг талыг баримтлаагүй ба магадлалаар жинэлсэн дүн;**
 - (б) **Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ;**
 - (в) **Их зардал буюу хүчин чармайлт гаргахгүйгээр тухайн тайлант үеийн эцсээр олж авч болох бөгөөд өнгөрсөн үйл явдал, одоогийн нөхцөл байдал, ирээдүйн эдийн засгийн төлөв байдлын прогнозын талаархи үндэслэлтэй ба дэмжих мэдээлэл.**
91. Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжихдээ байгууллага нь боломжит бүх хувилбар нэг бүрийг заавал тодорхойлох шаардлагагүй юм. Гэхдээ байгууллага нь зээлийн алдагдал үүсэх боломж, түүнчлэн зээлийн алдагдал үүсэх боломж маш бага боловч зээлийн алдагдал үүсэхгүй байх боломжийг тусгаснаар зээлийн алдагдал үүсэх эрсдэл буюу магадлалыг харгалзан үзнэ.
92. Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжихдээ харгалзан үзэх хамгийн урт хугацаа нь тухайн байгууллагад зээлийн эрсдэл учрах уг гэрээний хамгийн урт хугацаа (үүн дотроо сунгах боломжтой хугацаа хамаарна) байх бөгөөд хэдийгээр үүнээс урт хугацаа нь бизнесийн практиктай нийцэхээр байлаа ч гэсэн тэрхүү илүү урт хугацааг харгалзан үзэхгүй.
93. Гэвч зарим санхүүгийн хэрэглүүр нь зээл, түүнчлэн зээл олгох баталгааны ашиглаагүй хэсгийн аль алиныг агуулсан байдаг бөгөөд зээлийг буцаан төлөхийг шаардах ба ашиглаагүй баталгааг хүчингүй болгох уг байгууллагын гэрээний эрх нь тэрхүү гэрээг өөрчлөх талаархи мэдэгдлийн хугацаанд тухайн байгууллагад зээлийн алдагдал үүссээр байх эрсдлийг хязгаарлаж чадахгүй. Зөвхөн ийм санхүүгийн хэрэглүүрүүдийн хувьд, байгууллага нь түүнд зээлийн эрсдэл учрах нийт хугацааны туршид, хэдийгээр уг хугацаа нь гэрээний хамгийн урт хугацаанаас хэтэрсэн

байлаа ч гэсэн тэрхүү хугацаанд хүлээгдэж буй бөгөөд зээлийн эрсдлийн удирдлагын арга хэмжээгээр бууруулж чадахгүй тэдгээр зээлийн алдагдлыг тооцоолж, хэмжинэ.

Санхүүгийн хөрөнгийн дахин ангилал

94. Хэрэв байгууллага нь санхүүгийн хөрөнгийг 54-р параграфын дагуу дахин ангилсан бол дахин ангилал хийсэн өдрөөс эхлэн уг дахин ангиллыг гүйцээх горимоор мөрдөнө. Байгууллага нь өмнө хүлээн зөвшөөрсөн аливаа олз, гарз (үүн дотроо, үнэ цэнийн бууралтын олз, гарз), хүүг дахин тайлагнахгүй. Дахин ангилах талаархи шаардлагуудыг 95-100-р параграфт заасан.
95. Хэрэв байгууллага нь санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр хэмждэг ангиллаас ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг ангилал болгон дахин ангилсан бол түүний бодит үнэ цэнийг уг дахин ангилал хийсэн өдрөөр хэмжинэ. Санхүүгийн хөрөнгийн өмнөх хорогдуулсан өртөг ба түүний бодит үнэ цэнийн хоорондох зөрүүгээс үүссэн аливаа олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.
96. Хэрэв байгууллага нь санхүүгийн хөрөнгийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг ангиллаас хорогдуулсан өртгөөр хэмждэг ангилал болгон дахин ангилсан бол тэрхүү дахин ангиллын өдрөөрх бодит үнэ цэнэ нь түүний шинэ нийт дансны үнэ болно. (Дахин ангиллын өдрөөр үр ашигт хүүний хувь болон гарзын хасагдуулгыг тодорхойлох талаархи заавар удирдамжийг МЗУ221-р параграфас үзнэ үү).
97. Хэрэв байгууллага нь санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр хэмждэг ангиллаас цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг ангилал болгон дахин ангилсан бол түүний бодит үнэ цэнийг уг дахин ангилал хийсэн өдрөөр хэмжинэ. Санхүүгийн хөрөнгийн өмнөх хорогдуулсан өртөг ба түүний бодит үнэ цэнийн хоорондох зөрүүгээс үүссэн аливаа олз, гарзыг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө. Үр ашигт хүүний хувь ба хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилтийг уг дахин ангиллын үр дүнд залруулахгүй. (МЗУ220-р параграфыг үзнэ үү).
98. Хэрэв байгууллага нь санхүүгийн хөрөнгийг цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг ангиллаас хорогдуулсан өртгөөр хэмждэг ангилал болгон дахин ангилсан бол тухайн санхүүгийн хөрөнгийг тэрхүү дахин ангиллын өдрөөрх түүний бодит үнэ цэнээр дахин ангилна. Харин цэвэр хөрөнгө/өмчид өмнө нь хүлээн зөвшөөрч байсан хуримтлагдсан олз, гарзыг цэвэр хөрөнгө/өмчийн хэсгээс хасаж, уг дахин ангиллын өдрөөрх тухайн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэд залруулна. Ингэснээр санхүүгийн хөрөнгийг анхнаасаа хорогдуулсан өртгөөр хэмжиж байсан мэтээр тухайн санхүүгийн хөрөнгийг уг дахин ангиллын өдрөөр хэмжих юм. Энэхүү залруулга нь цэвэр хөрөнгө/өмчид нөлөөлөх боловч ашиг, алдагдалд нөлөөлөхгүй тул дахин ангилах залруулга биш юм (УСНББОУС 1, *Санхүүгийн Тайлангийн Тогилуулга*-ыг үзнэ үү). Үр ашигт хүүний хувь ба хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилтийг уг дахин ангиллын үр дүнд залруулахгүй (МЗУ220-р параграфыг үзнэ үү).
99. Хэрэв байгууллага нь санхүүгийн хөрөнгийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг ангиллаас цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг ангилал болгон дахин ангилсан бол тухайн санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмжсэн хэвээр байна (Дахин ангиллын өдрөөрх үр ашигт хүүний хувь болон гарзын хасагдуулгыг тодорхойлох талаархи заавар удирдамжийг МЗУ221-р параграфас үзнэ үү).
100. Хэрэв байгууллага нь санхүүгийн хөрөнгийг цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг ангиллаас ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг ангилал болгон дахин ангилсан бол тухайн санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмжсэн хэвээр байна. Цэвэр хөрөнгө/өмчид өмнө нь хүлээн зөвшөөрч байсан хуримтлагдсан олз, гарзыг тухайн дахин ангиллын өдрөөр цэвэр хөрөнгө/өмчөөс хасаж,

дахин ангилах залруулга байдлаар ашиг, алдагдалд дахин ангилна (УСНББОУС 1-ийг үзнэ үү).

Олз ба гарз

101. Бодит үнэ цэнээр хэмждэг санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр нь дараах шинжтэй байхаас бусад тохиолдолд түүний олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө:
- (а) Энэ нь хейжийн харилцааны нэг хэсэг байх (137-143-р параграф болон хэрэв хамааралтай бол хүүний түвшний эрсдлийн багц хейжид хамаарах бодит үнэ цэнийн хейжийн нягтлан бодох бүртгэлийн хувьд УСНББОУС 29-ийн 99-105-р параграфыг үзнэ үү);
 - (б) Энэ нь өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт бөгөөд тухайн байгууллага нь уг хөрөнгө оруулалтын олз, гарзыг 106-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчид толилуулахаар сонгосон байх;
 - (в) Энэ нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан санхүүгийн өр төлбөр бөгөөд тухайн байгууллага нь уг өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтийн үр нөлөөг 108-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчид толилуулах шаардлагатай байх;
 - (г) Энэ нь 41-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг санхүүгийн хөрөнгө бөгөөд тухайн байгууллага нь бодит үнэ цэнийн зарим өөрчлөлтийг 111-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрөх шаардлагатай байх.
102. Ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг зөвхөн дараах тохиолдолд ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө:
- (а) Ногдол ашгийн төлбөрийг хүлээн авах уг байгууллагын эрх үүссэн;
 - (б) Ногдол ашигт хамаарах эдийн засгийн үр өгөөж нь тухайн байгууллагад орох нэлээд их магадлалтай байх;
 - (в) Ногдол ашгийн дүнг найдвартайгаар хэмжиж чадах.
103. Хорогдуулсан өртгөөр нь хэмждэг бөгөөд хейжийн харилцааны нэг хэсэг болдоггүй (137-143-р параграф болон хэрэв хамааралтай бол хүүний түвшний эрсдлийн багц хейжид хамаарах бодит үнэ цэнийн хейжийн нягтлан бодох бүртгэлийн хувьд УСНББОУС 29-ийн 99-105-р параграфыг үзнэ үү) санхүүгийн хөрөнгийн олз, гарзыг тухайн санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх эсвэл 95-р параграфын дагуу дахин ангилах тохиолдолд, эсвэл уг хөрөнгийн хорогдуулгыг тооцох явцад, эсвэл түүний үнэ цэнийн бууралтын олз, гарзыг хүлээн зөвшөөрөх үед ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр хэмждэг ангиллаас хасаж, дахин ангилсан бол уг байгууллага нь 95 ба 97-р параграфыг мөрдөнө. Хорогдуулсан өртгөөр нь хэмждэг бөгөөд хейжийн харилцааны нэг хэсэг болдоггүй (137-143-р параграф болон хэрэв хамааралтай бол хүүний түвшний эрсдлийн багц хейжид хамаарах бодит үнэ цэнийн хейжийн нягтлан бодох бүртгэлийн хувьд УСНББОУС 29-ийн 99-105-р параграфыг үзнэ үү) санхүүгийн өр төлбөрийн олз, гарзыг тухайн санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөх үед болон хорогдуулгыг тооцох явцад ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө (Гадаад валютын ханшийн олз буюу гарзын талаархи заавар удирдамжийг МЗУ224-р параграфас үзнэ үү).
104. Хейжийн харилцаанд хейжийн зүйл болдог санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн олз, гарзыг 137-143-р параграфын дагуу, хэрэв хамааралтай бол хүүний түвшний эрсдлийн багц хейжид хамаарах бодит үнэ цэнийн хейжийн нягтлан бодох бүртгэлийн хувьд УСНББОУС 29-ийн 99-105-р параграфын дагуу хүлээн зөвшөөрнө.

105. Хэрэв байгууллага нь барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийг ашиглан санхүүгийн хөрөнгийг хүлээн зөвшөөрдөг бол (11, МЗУ17, МЗУ20-р параграфыг үзнэ үү) арилжааны өдөр ба барагдуулалтын өдрийн хоорондох хугацаанд хүлээн авах тухайн хөрөнгийн бодит үнэ цэнийн аливаа өөрчлөлтийг хорогдуулсан өртгөөр нь хэмждэг хөрөнгүүдийн хувьд хүлээн зөвшөөрөхгүй. Харин бодит үнэ цэнээр нь хэмждэг хөрөнгүүдийн хувьд бодит үнэ цэнийн өөрчлөлтийг 101-р параграфын дагуу ашиг, алдагдал эсвэл цэвэр хөрөнгө/өмчийн аль тохиромжтойд хүлээн зөвшөөрнө. Арилжааны өдөр нь уг үнэ цэнийн бууралтын шаардлагуудыг мөрдөх зорилгын хувьд анхны хүлээн зөвшөөрөлтийн өдөр байна.

Өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт

106. Худалдан арилжих зорилгоор эзэмшээгүй, түүнчлэн улсын секторын нэгдлээр нэгтгэгчийн хүлээн зөвшөөрдөг болзошгүй төлбөр биш боловч энэхүү Стандартын цар хүрээнд хамаарах, өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн дараагийн тайлант үе дэх өөрчлөлтийг байгууллага нь анх хүлээн зөвшөөрөхдөө цэвэр хөрөнгө/өмчид толилуулахаар эргэлт буцалтгүй сонголт хийж болно (Гадаад валютын ханшийн олз буюу гарзын талаархи заавар удирдамжийг МЗУ226-р параграфас үзнэ үү).
107. Хэрэв байгууллага нь 106-р параграфт заасан сонголтыг хийсэн бол тухайн байгууллага нь уг хөрөнгө оруулалтаас хүлээн авах ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг 102-р параграфын дагуу ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилдаг өр төлбөр

108. Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилдаг санхүүгийн өр төлбөрийн олз, гарзыг байгууллага нь 46 эсвэл 51-р параграфын дагуу дараах байдлаар толилуулна:
- (а) Тухайн санхүүгийн өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтөнд хамааруулж болох түүний бодит үнэ цэнийн өөрчлөлтийн дүнг цэвэр хөрөнгө/өмчид толилуулна (МЗУ236-МЗУ243-р параграфыг үзнэ үү);
 - (б) Тухайн санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн үлдсэн хэсгийг ашиг, алдагдалд толилуулна.

Гэхдээ дээрх (а)-д дурдсан, өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтийн үр нөлөөг бүртгэх арга хандлага нь ашиг, алдагдалд нягтлан бодох бүртгэлийн уялдаагүй байдлыг үүсгэдэггүй буюу нэмэгдүүлдэггүй байвал зохино (энэ тохиолдолд 109-р параграфыг мөрдөнө). Нягтлан бодох бүртгэлийн уялдаагүй байдлыг үүсгэх буюу нэмэгдүүлэх эсэхийг тодорхойлох талаархи заавар удирдамжийг МЗУ228-МЗУ230, МЗУ233-МЗУ235-р параграфт заасан.

109. Хэрэв 108-р параграфын шаардлагууд нь ашиг, алдагдалд нягтлан бодох бүртгэлийн уялдаагүй байдлыг үүсгэдэг буюу нэмэгдүүлдэг бол байгууллага нь уг өр төлбөрийн бүх олз, гарзыг (үүн дотроо, тухайн өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтийн үр нөлөөг) ашиг, алдагдалд толилуулна.
110. 108, 109-р параграфын шаардлагуудыг үл харгалзан, байгууллага нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилдаг зээл олгох баталгаа болон санхүүгийн баталгааны гэрээний бүх олз, гарзыг ашиг, алдагдалд толилуулна.

Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгө

111. 41-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын олз, гарз (73-93-р параграфыг үзнэ үү) болон гадаад валютын ханшийн олз, гарзаас (МЗУ224-МЗУ225-р параграфыг үзнэ үү) бусад олз, гарзыг тухайн санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх эсвэл дахин ангилах хүртэл

цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө. Санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх тохиолдолд цэвэр хөрөнгө/өмчид өмнө нь хүлээн зөвшөөрч байсан, хуримтлагдсан олз, гарзыг дахин ангилах залруулга байдлаар өмчөөс ашиг, алдагдалд дахин ангилна (УСНББОУС 1-ийн МЗУ125А-МЗУ125В параграфыг үзнэ үү). Хэрэв санхүүгийн хөрөнгийг цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг ангиллаас хасаж, дахин ангилсан бол тухайн байгууллага нь цэвэр хөрөнгө/өмчид өмнө нь хүлээн зөвшөөрч байсан, хуримтлагдсан олз, гарзыг 98 ба 100-р параграфын дагуу тайлагнана. Үр ашигт хүүний аргыг ашиглан тооцоолсон хүүг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

112. 111-р параграфт дурдсанчлан, хэрэв санхүүгийн хөрөнгийг 41-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг бол ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх дүн нь тухайн санхүүгийн хөрөнгийг анхнаасаа хорогдуулсан өртгөөр хэмжсэн бол ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх байсан дүнтэй ижил байна.

Хейжийн нягтлан бодох бүртгэл**Хейжийн нягтлан бодох бүртгэлийн зорилго ба цар хүрээ**

113. Хейжийн нягтлан бодох бүртгэлийн зорилго нь ашиг, алдагдалд (байгууллага нь бодит үнэ цэнийн өөрчлөлтийг 106-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчид толилуулахаар сонголт хийсэн өмчийн хэрэглүүрийн хөрөнгө оруулалтын хувьд цэвэр хөрөнгө/өмчид) нөлөө үзүүлж болох тодорхой эрсдлээс үүсэх үр дагаврыг удирдахын тулд санхүүгийн хэрэглүүрийг ашигладаг уг байгууллагын эрсдлийн удирдлагын үйл ажиллагааны үр нөлөөг санхүүгийн тайланд илэрхийлэх явдал юм. Энэхүү арга хандлага нь хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэдэг хейжийн хэрэглүүрийн зорилго ба үр нөлөөг ойлгох боломжийг олгохын тулд түүний утга агуулгыг танилцуулахыг эрмэлздэг.
114. Байгууллага нь хейжийн хэрэглүүр ба хейжийн зүйлийн хоорондох хейжийн харилцааг 116-128 ба МЗУ244-МЗУ274-р параграфын дагуу сонгохоор шийдвэрлэж болох юм. Шалгуур хангах хейжийн харилцааны хувьд байгууллага нь тухайн хейжийн хэрэглүүрийн болон хейжийн зүйлийн олз, гарзыг 130-143 ба МЗУ294-МЗУ321-р параграфын дагуу тайлагнана. Хейжийн зүйл нь зүйлсийн бүлэг байх тохиолдолд байгууллага нь 146-151 ба МЗУ333-МЗУ348-р параграф дахь нэмэлт шаардлагуудыг даган мөрдөнө.
115. Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн багцын хүүний түвшний эрсдэлтэй холбоотой бодит үнэ цэнийн хейжийн (зөвхөн ийм хейжийн) хувьд, байгууллага нь энэ Стандартын шаардлагуудыг биш, харин УСНББОУС 29-д заасан хейжийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудыг мөрдөж болох юм. Энэ тохиолдолд байгууллага нь хүүний түвшний эрсдлийн багц хейжийн хувьд бодит үнэ цэнийн хейжийн нягтлан бодох бүртгэлд хамаарах тусгай шаардлагуудыг мөн даган мөрдөх бөгөөд мөнгөн дүн бүхий хэсгийг хейжийн зүйл гэж сонгоно (УСНББОУС 29-ийн 91, 100-р параграф болон МЗУ157-МЗУ175-р параграфыг үзнэ үү).

Хейжийн хэрэглүүр*Шалгуур хангах хэрэглүүр*

116. **Зарим гаргасан опционоос бусад, ашиг алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг үүсмэл хэрэглүүрийг хейжийн хэрэглүүр гэж сонгож болно (МЗУ247-р параграфыг үзнэ үү).**
117. **Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилдаг бөгөөд тухайн өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтөнд хамаарах түүний бодит үнэ цэнийн өөрчлөлтийн дүнг 108-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчид толилуулдаг санхүүгийн өр төлбөрөөс бусад, ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг үүсмэл бус санхүүгийн хөрөнгө буюу үүсмэл бус санхүүгийн өр төлбөрийг хейжийн хэрэглүүр гэж сонгож болно. Гадаад валютын эрсдлийн хейжийн хувьд, байгууллага бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь 106-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчид толилуулах сонголт хийсэн, өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтаас бусад, үүсмэл бус санхүүгийн хөрөнгө буюу үүсмэл бус санхүүгийн өр төлбөрийн гадаад валютын эрсдлийн бүрэлдэхүүн хэсгийг хейжийн хэрэглүүр гэж сонгож болно.**
118. **Тухайн тайлагнагч байгууллагын хувьд гадны (өөрөөр хэлбэл, уг тайлагнаж буй эдийн засгийн нэгдмэл байгууллага эсвэл бие даасан байгууллагын хувьд гадны) этгээд болох тийм оролцогч тал бүхий зөвхөн тэдгээр гэрээг хейжийн нягтлан бодох бүртгэлийн зорилгоор хейжийн хэрэглүүр гэж сонгож болно.**

Хейжийн хэрэглүүрийн сонголт

119. Шалгуур хангах хэрэглүүрийг бүхэлд нь хейжийн хэрэглүүр гэж сонгох ёстой. Зөвхөн дараах гажих тохиолдлыг зөвшөөрдөг. Үүнд:

- (а) Опционы гэрээний дотоод үнэ цэнэ ба цаг хугацааны үнэ цэнийг салган зааглаж, уг опционы зөвхөн дотоод үнэ цэнийн өөрчлөлтийг хейжийн хэрэглүүр гэж сонгох бөгөөд түүний цаг хугацааны үнэ цэнийн өөрчлөлтийг харгалзан үзэхгүй байх (144 ба МЗУ322-МЗУ326-р параграфыг үзнэ үү);
 - (б) Форвард гэрээний форвард элемент ба спот элементийг салган зааглаж, уг форвард гэрээний зөвхөн спот элементийн үнэ цэнийн өөрчлөлтийг хейжийн хэрэглүүр гэж сонгох бөгөөд түүний форвард элементийн өөрчлөлтийг харгалзан үзэхгүй байх; үүнтэй адилаар, гадаад валютын суурийн тархалтыг (нэмэгдлийг) салган зааглаж, тухайн санхүүгийн хэрэглүүрийг хейжийн хэрэглүүр гэж сонгоход уг гадаад валютын суурийн тархалтыг хамруулахгүй байж болно (145 ба МЗУ327-МЗУ332-р параграфыг үзнэ үү);
 - (в) Нийт хейжийн хэрэглүүрийн нэрлэсэн дүнгийн 50 хувь гэх мэт тодорхой хэсгийг тухайн хейжийн харилцаанд хейжийн хэрэглүүр гэж сонгож болно. Гэхдээ хейжийн хэрэглүүр эргэлтэнд байх үед түүний зөвхөн цаг хугацаанд хамаарах хэсгээс бодит үнэ цэнийн өөрчлөлтийн хэсгийн хувьд хейжийн хэрэглүүрийг сонгож болохгүй.
120. Байгууллага нь дараах зүйлсийг хамтад нь авч үзэж, тэдний аливаа нэгдлийг хамтад нь хейжийн хэрэглүүр гэж (үүнд: зарим хейжийн хэрэглүүрээс үүсэх эрсдэл буюу эрсдлүүд нь өөр хейжийн хэрэглүүрээс үүсэх эрсдэл буюу эрсдлүүдийг харилцан нөхөх нөхцөл байдал хамаарна) сонгож болно:
- (а) Үүсмэл хэрэглүүрүүд эсвэл тэдгээрийн бүрэлдэхүүн хэсэг;
 - (б) Үүсмэл бус хэрэглүүрүүд эсвэл тэдгээрийн бүрэлдэхүүн хэсэг.
121. Гэхдээ гаргасан опцион ба худалдан авсан опционыг нэгтгэсэн үүсмэл хэрэглүүр (жишээлбэл; хүүний түвшний баталгаа) нь тухайн сонгосон өдрөөр хэрэв эцсийн үр дүнгээрээ, гаргасан цэвэр опцион болохоор байвал (энэ нь МЗУ247-р параграфын дагуу шалгуур хангахаас бусад тохиолдолд) хейжийн хэрэглүүрийн шалгуурыг хангахгүй юм. Үүнтэй адилаар, хоёр буюу хэд хэдэн хэрэглүүр (эсвэл тэдгээрийн бүрэлдэхүүн хэсэг) нь тухайн сонгосон өдрөөр хэрэв нэгдсэн эцсийн үр дүнгээрээ, гаргасан цэвэр опцион биш байх зөвхөн тийм тохиолдолд (энэ нь МЗУ247-р параграфын дагуу шалгуур хангахаас бусад тохиолдолд) тэдгээрийг хамтад нь хейжийн хэрэглүүр гэж сонгож болно.

Хейжийн зүйлс

Шалгуур хангах зүйлс

122. **Хейжийн зүйл нь хүлээн зөвшөөрсөн хөрөнгө, өр төлбөр, хүлээн зөвшөөрөөгүй арилжааны баталгаа, урьдчилан таамагласан ажил гүйлгээ, гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалт байж болно. Хейжийн зүйл нь**
- (а) **Нэг зүйл; эсвэл**
 - (б) **Зүйлсийн бүлэг байж болно (146-151, МЗУ333-МЗУ348-р параграфт хамаарах)**
- Хейжийн зүйл нь мөн ийм нэг зүйл буюу зүйлсийн бүлгийн бүрэлдэхүүн хэсэг байж болно (128 ба МЗУ256-МЗУ274-р параграфыг үзнэ үү).**
123. **Хейжийн зүйлийг найдвартай хэмжих боломжтой байх ёстой.**
124. **Хэрэв хейжийн зүйл нь урьдчилан таамагласан ажил гүйлгээ (эсвэл түүний бүрэлдэхүүн хэсэг) бол уг ажил гүйлгээ нь хэрэгжих өндөр магадлалтай байх ёстой.**
125. **122-р параграфт заасан хейжийн зүйлийн шалгуурыг хангах эрсдэл ба үүсмэл хэрэглүүрийн хослол болох нэгтгэсэн эрсдлийг хейжийн зүйл гэж сонгож болно (МЗУ252-МЗУ253-р параграфыг үзнэ үү). Үүнд: хэрэв тэрхүү нэгтгэсэн эрсдэл нь өндөр магадлалтай бөгөөд гарч тохиолдмогц урьдчилан таамагласан ажил гүйлгээ биш болох, ингэснээр хейжийн зүйлийн шалгуурыг хангах нэгтгэсэн эрсдэл бүхий урьдчилан**

таамагласан ажил гүйлгээ (өөрөөр хэлбэл, эрсдэл болон үүсмэл хэрэглүүр үүсэхэд хүргэх хэдийгээр гэрээгээр баталгаажаагүй боловч урьдчилан төсөөлсөн ирээдүйн ажил гүйлгээ) хамаарна.

126. Тухайн тайлагнагч байгууллагын хувьд гадны этгээд болох тийм оролцогч тал бүхий зөвхөн тэдгээр хөрөнгө, өр төлбөр, арилжааны баталгаа, хэрэгжих өндөр магадлалтай урьдчилан таамагласан ажил гүйлгээг хейжийн нягтлан бодох бүртгэлийн зорилгоор хейжийн зүйл гэж сонгож болно. Нэг эдийн засгийн нэгдмэл байгууллагад хамаарах байгууллагуудын хооронд хийгдсэн бөгөөд уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд биш, харин зөвхөн тэдгээр байгууллагуудын бие даасан буюу тусдаа санхүүгийн тайланд тусгагдах ажил гүйлгээний хувьд хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэнэ. Харин үүнээс гажих тохиолдол нь:

- (а) Хөрөнгө оруулалтын байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлан бөгөөд УСНББОУС 35-д тодорхойлсноор, хөрөнгө оруулалтын байгууллага ба ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн түүний хяналтанд буй байгууллагуудын хооронд хийгдсэн ажил гүйлгээг уг нэгтгэсэн санхүүгийн тайланд устгаж, цэвэрлэдэггүй тул түүнд хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэнэ.
- (б) Өөрөө хөрөнгө оруулалтын байгууллага биш боловч хөрөнгө оруулалтын байгууллагад хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлан, УСНББОУС 35-д тодорхойлсноор, хяналтанд буй хөрөнгө хөрөнгө оруулалтын байгууллага ба ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн, уг хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын хөрөнгө оруулалт хооронд хийгдсэн ажил гүйлгээг уг нэгтгэсэн санхүүгийн тайланд устгаж, цэвэрлэдэггүй тул түүнд хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэнэ.

127. Эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрэн дэх мөнгөн зүйлсийн (жишээлбэл; хяналтанд буй хоёр байгууллагын хооронд үүссэн өглөг/авлага) гадаад валютын эрсдэл нь гадаад валютын ханшийн олз, гарз үүсэхэд хүргэдэг бөгөөд нэгтгэл хийх үед түүнийг УСНББОУС 4, *Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө*-ний дагуу бүрэн устгаж, цэвэрлэдэггүй бол энэ нь 126-р параграфын гажих нөхцөл болох бөгөөд уг нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд хейжийн зүйл болох шалгуурыг хангаж болох юм. Эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрэн дэх мөнгөн зүйл нь өөр өөр бүртгэлийн валют ашигладаг, нэг эдийн засгийн нэгдмэл байгууллагын хоёр байгууллагын хоорондох ажил гүйлгээгээр үүссэн тохиолдолд нэгтгэл хийхдээ тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрэн дэх мөнгөн зүйлсийн гадаад валютын ханшийн олз, гарзыг УСНББОУС 4-ийн дагуу бүрэн устгаж, цэвэрлэдэггүй. Мөн эдийн засгийн нэгдмэл байгууллагын доторх, хэрэгжих өндөр магадлалтай урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь тухайн ажил гүйлгээг хийж буй байгууллагын бүртгэлийн валютаас өөр валютаар илэрхийлэгдсэн бөгөөд түүний гадаад валютын эрсдэл нь нэгтгэсэн ашиг, алдагдалд нөлөөлөхөөр бол уг ажил гүйлгээний гадаад валютын эрсдэл нь тэрхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд хейжийн зүйл болох шалгуурыг хангаж болох юм.

Хейжийн зүйлсийн сонголт

128. Байгууллага нь хейжийн харилцаанд тухайн зүйлийг бүхэлд нь, эсвэл түүний бүрэлдэхүүн хэсгийг хейжийн зүйл гэж сонгож болно. Тухайн зүйл бүхэлдээ байх үед энэ нь өөрийн мөнгөн гүйлгээний буюу бодит үнэ цэнийн бүх өөрчлөлтийг агуулна. Харин түүний бүрэлдэхүүн хэсэг нь тэрхүү зүйлийн бодит үнэ цэнийн буюу мөнгөн гүйлгээний нийт хувьсан өөрчлөлтөөс бага байх тийм хэсгийг агуулна. Ийм тохиолдолд байгууллага нь зөвхөн дараах төрлийн бүрэлдэхүүн хэсгүүдийг (үүн дотроо, тэдгээрийн нэгдлүүдийг) хейжийн зүйл гэж сонгож болно:

- (а) Хэрэв тодорхой зах зээлийн бүтцийн хүрээнд хийсэн үнэлгээнд үндэслэн, эрсдлийн бүрэлдэхүүн хэсгийг тусад нь тодорхойлж, найдвартай хэмжих боломжтой бол (МЗУ257-МЗУ264-р параграфыг үзнэ үү) тухайн эрсдэлд буюу эрсдлүүдэд (эрсдлийн бүрэлдэхүүн хэсэгт) хамааруулж болох уг зүйлийн мөнгөн гүйлгээний буюу бодит үнэ

цэнийн зөвхөн тэдгээр өөрчлөлтүүд. Эрсдлийн бүрэлдэхүүн хэсгүүд нь тусгайлан заасан үнэ эсвэл бусад хувьсагчдаас уг хейжийн зүйлийн мөнгөн гүйлгээ буюу бодит үнэ цэнэ их эсвэл бага болох зөвхөн тэдгээр өөрчлөлтийг агуулсан байна (нэг талт эрсдэл).

- (б) Гэрээний нэг буюу хэд хэдэн сонгосон мөнгөн гүйлгээ.
- (в) Нэрлэсэн дүнгийн бүрэлдэхүүн хэсгүүд, өөрөөр хэлбэл, тухайн зүйлийн дүнгийн тусгайлан заасан хэсэг (МЗУ265-МЗУ269-р параграфыг үзнэ үү).

Хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуур

129. Дараах бүх шалгуур хангагдах зөвхөн тийм тохиолдолд хейжийн харилцаа нь хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангана:

- (а) Хейжийн харилцаа нь зөвхөн шалгуур хангах хейжийн хэрэглүүр ба шалгуур хангах хейжийн зүйлсээс бүрддэг байх.
- (б) Хейжийн харилцааны эхэнд, уг хейжийн харилцаа, түүнчлэн хейжийг хийх тухайн байгууллагын эрсдлийн удирдлагын зорилго ба стратегийн талаархи албан ёсны сонголт болон баримтжуулалт хийгдсэн байх. Ийм баримтжуулалт нь хейжийн хэрэглүүр, хейжийн зүйл, хейж хийгдэж буй эрсдлийн шинж төрөл, хейжийн үр дүнтэй байдлын шаардлагуудыг тухайн хейжийн харилцаа хангаж буй эсэхийг байгууллага хэрхэн үнэлэх талаархи тодорхойлолтыг (үүн дотроо, хейжийн үр дүнгүй байдлын шалтгааны талаархи шинжилгээ ба *хейжийн харьцааг* хэрхэн тодорхойлдог эсэхийг) агуулсан байдаг.
- (в) Хейжийн харилцаа нь хейжийн үр дүнтэй байдлын дараах бүх шаардлагуудыг хангах:
 - (i) Хейжийн зүйл ба хейжийн хэрэглүүрийн хооронд эдийн засгийн харилцан хамааралтай байх (МЗУ278-МЗУ280-р параграфыг үзнэ үү);
 - (ii) Зээлийн эрсдлийн үр нөлөө нь уг эдийн засгийн харилцааны үр дүн болох үнэ цэнийн өөрчлөлтөөс илүү давамгайлсан шинжтэй биш байх (МЗУ281-МЗУ282-р параграфыг үзнэ үү);
 - (iii) Хейжийн харилцаанд хамаарах тухайн хейжийн харьцаа нь байгууллага бодитойгоор хейж хийж буй уг хейжийн зүйлийн тоо хэмжээ ба тийм тоо хэмжээ бүхий хейжийн зүйлд хейж хийхдээ байгууллагын бодитойгоор ашигладаг хейжийн хэрэглүүрийн тоо хэмжээний үр дүн болох тэрхүү хейжийн харьцаатай ижил байх. Гэвч ийм сонголт нь хейжийн үр дүнгүй байдал үүсгэх (хүлээн зөвшөөрсөн, үгүй эсэхээс үл хамаарна), улмаар хейжийн нягтлан бодох бүртгэлийн зорилготой үл нийцэх нягтлан бодох бүртгэлийн үр дагаварт хүргэх, хейжийн зүйлийн хувийн жин ба хейжийн хэрэглүүрийн хувийн жин хоорондох тэнцвэргүй байдлыг тусган илэрхийлдэггүй (МЗУ283-МЗУ285-р параграфыг үзнэ үү).

Шалгуур хангах хейжийн харилцааны нягтлан бодох бүртгэл

130. Байгууллага нь 129-р параграфт заасан шалгуурыг (үүнд: хейжийн харилцааг сонгох талаархи уг байгууллагын шийдвэр хамаарна) хангадаг хейжийн харилцааны хувьд хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэнэ.

131. Дараах гурван төрлийн хейжийн харилцаа байдаг:

- (а) Бодит үнэ цэнийн хейж: хүлээн зөвшөөрсөн хөрөнгө буюу өр төлбөрийн эсвэл хүлээн зөвшөөрөөгүй арилжааны баталгааны, эсвэл ийм аливаа зүйлсийн бүрэлдэхүүн хэсгийн бодит үнэ цэнэд гарах бөгөөд тодорхой эрсдэлд хамааруулж болох, түүнчлэн ашиг, алдагдалд нөлөө үзүүлэх өөрчлөлтүүдийн хувьд хийгдэх хейж.

- (б) Мөнгөн гүйлгээний хейж: хүлээн зөвшөөрсөн бүх хөрөнгө буюу өр төлбөртэй (хувьсах хүүтэй өрийн ирээдүйн бүх буюу зарим хүүний төлбөр гэх мэт) эсвэл түүний бүрэлдэхүүн хэсэгтэй, эсвэл хэрэгжих өндөр магадлалтай урьдчилан таамагласан ажил гүйлгээтэй холбоотой тодорхой эрсдэлд хамааруулж болох, түүнчлэн ашиг, алдагдалд нөлөө үзүүлэх мөнгөн гүйлгээний аливаа хувьсан өөрчлөлтийн хувьд хийгдэх хейж.
- (в) УСНББОУС 4-д тодорхойлсон, гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын хейж.
132. Хейжийн зүйл нь тухайн байгууллага түүний бодит үнэ цэнийн өөрчлөлтийг 106-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчид толилуулахаар сонголт хийсэн өмчийн хэрэглүүр байх тохиолдолд 131(а) параграфт дурдсан, уг хейж хийсэн эрсдэл нь цэвэр хөрөнгө/өмчид нөлөө үзүүлэх тийм эрсдэл байх ёстой. Зөвхөн ийм тохиолдолд уг хүлээн зөвшөөрсөн хейжийн үр дүнгүй байдлыг цэвэр хөрөнгө/өмчид толилуулна.
133. Арилжааны баталгааны гадаад валютын эрсдийн хейжийг бодит үнэ цэнийн хейж эсвэл мөнгөн гүйлгээний хейж гэж тайлагнаж болно.
134. Хейжийн харилцаа нь хейжийн харьцаатай холбоотойгоор хейжийн үр дүнтэй байдлын шаардлагыг хангахаа больсон (129(в)(iii) параграфыг үзнэ үү) боловч тэрхүү сонгосон хейжийн харилцааны талаархи эрсдийн удирдлагын зорилт нь өөрчлөгдөөгүй хэвээрээ байгаа бол уг шалгуурыг дахин хангахаар болгохын тулд байгууллага нь тухайн хейжийн харилцааны хувьд хейжийн харьцааг тохируулна (үүнийг энэ Стандартад ‘дахин тэнцвэржүүлэх’ гэж нэрлэсэн, МЗУ300-МЗУ314-р параграфыг үзнэ үү).
135. Хейжийн харилцаа (буюу хейжийн харилцааны хэсэг) нь шалгуур хангахаа больсон (хэрэв боломжтой бол тухайн хейжийн харилцааны аливаа дахин тэнцвэржүүлэлтийг харгалзан үзсэний дараа) зөвхөн тийм тохиолдолд байгууллага нь хейжийн нягтлан бодох бүртгэлийг цаашид хэрэглэхгүй зогсооно. Үүнд хейжийн хэрэглүүрийн хугацаа дууссан, борлуулсан, дуусгавар болгосон эсвэл хэрэгжүүлсэн тохиолдлууд хамаарна. Хейжийн хэрэглүүрийг өөр хейжийн хэрэглүүрээр орлуулах буюу солих нь тухайн байгууллагын баримтжуулсан эрсдийн удирдлагын зорилтын нэг хэсэг ба түүнтэй нийцэж байвал хейжийн хэрэглүүрийн сольж, орлуулалтыг дээрх зорилгын хувьд түүний хугацаа дуусалт эсвэл дуусгавар болголт гэж үзэхгүй. Мөн түүнчлэн, энэ зорилгын хувьд дараах тохиолдол нь хейжийн хэрэглүүрийн хугацаа дуусалт буюу дуусгавар болголт биш юм. Үүнд:
- (а) Хууль, тогтоомжийн үйлчлэл эсвэл шинэ хууль, тогтоомжийн хэрэгжилтийн үр дүнд нэг буюу хэд хэдэн клирингийн байгууллагууд нь өөрийн анхны хамтрагч клирингийн байгууллагыг солих, ингэснээр бие биенийхээ хувьд шинэ хамтрагч клирингийн байгууллага болохыг уг хейжийн хэрэглүүрийн оролцогч талууд зөвшөөрөх. Энэ зорилгын хувьд клирингийн байгууллага гэдэг нь клирингийн төв байгууллага (зарим үед үүнийг “клирингийн төв” эсвэл “клирингийн агент” гэж нэрлэдэг) эсвэл нэг ба хэд хэдэн ийм клирингийн байгууллагууд юм. Жишээлбэл; клирингийн төв байгууллага нь өөрийн клирингийн үйл ажиллагааг гүйцэтгэхэд хамтрагчийн үүрэг гүйцэтгэх уг клирингийн байгууллагын гишүүн буюу клирингийн байгууллагын гишүүн бус хамтрагч. Гэхдээ хейжийн хэрэглүүрийн оролцогч талууд нь өөрсдийн анхны клирингийн байгууллагыг өөр клирингийн байгууллагаар солих тохиолдолд тэдгээр оролцогч тал бүр нь клирингийн үйл ажиллагаагаа нэг клирингийн төв байгууллагаар дамжуулан хийлгэдэг зөвхөн тийм тохиолдолд энэ дэд параграфын шаардлага хангагдах юм.
- (б) Хейжийн хэрэглүүрт оруулах аливаа бусад өөрчлөлтүүд нь тухайн оролцогч тал ийм сольж орлуулалт хийхэд зайлшгүй хүргэх тийм өөрчлөлтүүдээр хязгаарлагдсан байх. Ийм өөрчлөлт нь уг хейжийн хэрэглүүрийг анхнаасаа энэхүү клирингийн байгууллагаар гүйцэтгүүлсэн бол хүлээх байсан нөхцөлтэй нийцэх тийм нөхцлүүдээр хязгаарлагдана. Эдгээр өөрчлөлтөнд барьцааны шаардлага, авлага ба

өглөгийн үлдэгдлийг харилцан суутгаж, цэвэр дүн гаргах эрх, төлөх шимтгэл зэргийн өөрчлөлт хамаарна.

Хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэхгүй зогсоох нь хейжийн харилцаанд бүхэлд нь, эсвэл түүний зөвхөн зарим хэсэгт (ийм тохиолдолд уг хейжийн харилцааны үлдсэн хэсэгт хейжийн нягтлан бодох бүртгэлийг үргэлжлүүлэн хэрэглэнэ) нөлөө үзүүлж болно.

136. Байгууллага нь:

- (a) Хейжийн зүйл (буюу түүний бүрэлдэхүүн хэсэг) нь хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хэрэглүүр байх тийм бодит үнэ цэнийн хейжийн хувьд хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэхээ больж, зогсоосон тохиолдолд 139-р параграфыг,
- (б) Мөнгөн гүйлгээний хейжийн хувьд хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэхээ больж, зогсоосон тохиолдолд 141-р параграфыг тус тус мөрдөнө.

Бодит үнэ цэнийн хейж

137. **Бодит үнэ цэнийн хейж нь 129-р параграфт заасан шалгуурыг хангасан хэвээр байх үед хейжийн харилцааг дараах байдлаар тайлагнана:**

- (a) **Хейжийн хэрэглүүрийн олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө (хейжийн хэрэглүүр нь байгууллага түүний бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь 106-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчид толилуулахаар сонголт хийсэн өмчийн хэрэглүүр байвал уг хейжийн хэрэглүүрийн олз, гарзыг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө);**
- (б) **Хейжийн зүйлд хейж хийснээр үүссэн олз, гарзаар тухайн хейжийн зүйлийн дансны үнийг (хэрэв хамааралтай бол) тохируулах бөгөөд тэрхүү олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Хэрэв хейжийн зүйл нь 41-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг санхүүгийн хөрөнгө (буюу түүний бүрэлдэхүүн хэсэг) байвал тухайн хейжийн зүйлд хейж хийснээр үүссэн олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Харин хейжийн зүйл нь байгууллага түүний бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь 106-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчид толилуулахаар сонголт хийсэн өмчийн хэрэглүүр байвал тэдгээр олз, гарзыг цэвэр хөрөнгө/өмчид хэвээр үлдээнэ. Хейжийн зүйл нь хүлээн зөвшөөрөөгүй арилжааны баталгаа (буюу түүний бүрэлдэхүүн хэсэг) байх тохиолдолд түүнийг ингэж хейжийн зүйл гэж сонгосноос хойш тухайн хейжийн зүйлийн бодит үнэ цэнэд гарсан хуримтлагдсан өөрчлөлтийг хөрөнгө эсвэл өр төлбөр гэж хүлээн зөвшөөрөх бөгөөд харгалзах олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.**

138. Бодит үнэ цэнийн хейжийн хувьд хейжийн зүйл нь хөрөнгийг худалдан авах эсвэл өр төлбөрийг хариуцах арилжааны баталгаа (буюу түүний бүрэлдэхүүн хэсэг) байх тохиолдолд санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрсөн уг хейжийн зүйлийн бодит үнэ цэнийн хуримтлагдсан өөрчлөлтийг тусгахын тулд тэрхүү арилжааны баталгааг тухайн байгууллага биелүүлснээр үүссэн хөрөнгө эсвэл өр төлбөрийн анхны дансны үнийг тохируулна.

139. Хэрэв хейжийн зүйл нь хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хэрэглүүр (буюу түүний бүрэлдэхүүн хэсэг) бол 137(б) параграфт заасан аливаа тохируулгыг хорогдуулж, ашиг, алдагдалд тусгана. Тохируулгыг хиймэгц хорогдуулгыг эхлэн тооцож болох боловч хейжийн олз, гарзын хувьд тухайн хейжийн зүйлд тохируулга хийхээ болихоос өмнө хорогдуулгыг тооцож эхэлнэ. Хорогдуулгыг тооцож эхлэх өдрөөр дахин тооцоолсон үр ашигт хүүний хувьд үндэслэн хорогдуулгыг тооцно. Хейжийн зүйл нь 41-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө (буюу түүний бүрэлдэхүүн хэсэг) байх тохиолдолд уг дансны үнийг тохируулсан дүнгээс биш, харин 137(б) параграфын дагуу өмнө нь хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан олз, гарзыг илэрхийлэх дүнгээс хорогдуулгыг дээрхтэй ижил арга замаар тооцоолно.

Мөнгөн гүйлгээний хейж

140. **Мөнгөн гүйлгээний хейж нь 129-р параграфт заасан шалгуурыг хангасан хэвээр байх үед хейжийн харилцааг дараах байдлаар тайлагнана:**
- (a) **Хейжийн зүйлтэй холбоотой өмчийн тусдаа бүрэлдэхүүн хэсгийг (мөнгөн гүйлгээний хейжийн нөөцийг) доорх дүнгүүдийн (үнэмлэхүй дүнгээр) аль багатай тэнцүү болгон тохируулна:**
 - (i) **Хейжийн эхлэлийн өдрөөс хойш уг хейжийн хэрэглүүрийн хувьд хуримтлагдсан олз эсвэл гарз; ба**
 - (ii) **Хейжийн эхлэлийн өдрөөс хойш тухайн хейжийн зүйлийн бодит үнэ цэнэд (өнөөгийн үнэ цэнэд) гарсан хуримтлагдсан өөрчлөлт (өөрөөр хэлбэл, хейж хийсэн уг хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн гүйлгээний хуримтлагдсан өөрчлөлтийн өнөөгийн үнэ цэнэ).**
 - (б) **Тухайн хейжийн хэрэглүүрийн олз, гарзын үр дүнтэй хейж гэж тодорхойлогдсон тэрхүү хэсгийг (өөрөөр хэлбэл, дээрх (а)-гийн дагуу тооцоолсон, мөнгөн гүйлгээний хейжийн нөөцийн өөрчлөлтөөр нөхөгдөх тэрхүү хэсгийг) цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө.**
 - (в) **Тухайн хейжийн хэрэглүүрийн аливаа үлдсэн олз, гарз (эсвэл дээрх (а)-гийн дагуу тооцоолсон, мөнгөн гүйлгээний хейжийн нөөцийн өөрчлөлтийг нөхөхөд шаардлагатай аливаа олз, гарз) нь хейжийн үр дүнгүй байдал болох бөгөөд түүнийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.**
 - (г) **Дээрх (а)-гийн дагуу мөнгөн гүйлгээний хейжийн нөөцөд хуримтлагдсан дүнг доорх байдлаар тайлагнана:**
 - (i) **Хейж хийсэн, урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь дараагийн тайлант үед санхүүгийн бус хөрөнгө буюу санхүүгийн бус өр төлбөр хүлээн зөвшөөрөхөд хүргэдэг, эсвэл санхүүгийн бус хөрөнгө буюу санхүүгийн бус өр төлбөрт хамаарах хейж хийсэн, урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь бодит үнэ цэнийн хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэдэг тийм арилжааны баталгаа болохоор бол тухайн байгууллага нь тэрхүү дүнг мөнгөн гүйлгээний хейжийн нөөцөөс хасаж, уг хөрөнгө, өр төлбөрийн анхны өртөг буюу адилтгах бусад дансны үнэд шууд оруулан тусгана. Энэ нь дахин ангилах залруулга биш (УСНББОУС 1-ийг үзнэ үү), иймээс цэвэр хөрөнгө/өмчид нөлөө үзүүлэхгүй.**
 - (ii) **Дээрх (i)-д дурдсанаас бусад, мөнгөн гүйлгээний хейжийн хувьд, уг дүнг мөнгөн гүйлгээний хейжийн нөөцөөс хасаж, тухайн хейж хийсэн хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн гүйлгээ нь ашиг, алдагдалд нөлөө үзүүлэх тэрхүү тайлант үед буюу үеүдэд (жишээлбэл; хүүний орлого буюу хүүний зардлыг хүлээн зөвшөөрөх эсвэл урьдчилан таамагласан борлуулалт хийгдэх тайлант үеүдэд) дахин ангилах залруулга (УСНББОУС 1-ийн 125А-125В параграфыг үзнэ үү) байдлаар ашиг, алдагдалд шилжүүлэн дахин ангилна.**
 - (iii) **Харин уг дүн нь алдагдал бөгөөд байгууллага тэрхүү алдагдлын бүх буюу зарим хэсгийг ирээдүйн нэг буюу хэд хэдэн тайлант үеүдэд нөхөхгүй гэж хүлээж байгаа бол тухайн байгууллага нь нөхөгдөхөөр хүлээгдээгүй дүнг дахин ангилах залруулга (УСНББОУС 1-ийн 125А-125В параграфыг үзнэ үү) байдлаар ашиг, алдагдалд нэн даруй дахин ангилна.**
141. Байгууллага нь мөнгөн гүйлгээний хейжийн хувьд хейжийн нягтлан бодох бүртгэлийг цаашид хэрэглэхгүй зогсоох бол (135 ба 136(б) параграфыг үзнэ үү) тухайн байгууллага нь мөнгөн гүйлгээний хейжийн нөөцөд хуримтлагдсан уг дүнг 140(а) параграфын дагуу дараах байдлаар тайлагнана:

- (а) Хейж хийсэн ирээдүйн мөнгөн гүйлгээ нь гарч тохиолдоно гэж хүлээгдсээр байгаа бол тэрхүү ирээдүйн мөнгөн гүйлгээг гарч тохиолдох эсвэл 140(г)(iii) параграфыг мөрдөх хүртэл уг дүнг тухайн мөнгөн гүйлгээний хейжийн нөөцөд хэвээр үлдээнэ. Ирээдүйн мөнгөн гүйлгээ гарч тохиолдсон үед 140(г) параграфыг мөрдөнө.
- (б) Хейж хийсэн ирээдүйн мөнгөн гүйлгээ нь гарч тохиолдоно гэж хүлээгдэхээргүй бол уг дүнг дахин ангилах залруулга (УСНББОУС 1-ийг үзнэ үү) байдлаар тухайн мөнгөн гүйлгээний хейжийн нөөцөөс ашиг, алдагдалд нэн даруй дахин ангилна. Гарч тохиолдох өндөр магадлалгүй болсон, уг хейж хийсэн ирээдүйн мөнгөн гүйлгээ нь гарч тохиолдоно гэж хүлээгдсээр байж болох юм.

Гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын хейж

142. **Гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын хейжийг, үүн дотроо уг цэвэр хөрөнгө оруулалтын нэг хэсэг байдлаар тайлагнасан мөнгөн зүйлсийн хейжийг (УСНББОУС 4-ийг үзнэ үү) мөнгөн гүйлгээний хейжтэй ижил төсөөтэй байдлаар тайлагнана:**

- (а) **Тухайн хейжийн хэрэглүүрийн олз, гарзын үр дүнтэй хейж гэж тодорхойлогдсон тэрхүү хэсгийг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө (140-р параграфыг үзнэ үү); ба**
- (б) **Үр дүнгүй хэсгийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.**

143. **Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцөд хуримтлагдсан, уг хейжийн үр дүнтэй хэсэгтэй холбоотой хейжийн хэрэглүүрийн хуримтлагдсан олз, гарзыг тухайн гадаад үйл ажиллагааг данснаас хасах буюу хэсэгчлэн данснаас хасах үед УСНББОУС 4-ийн 57-58-р параграфын дагуу дахин ангилах залруулга (УСНББОУС 1-ийг үзнэ үү) байдлаар өмчөөс ашиг, алдагдалд дахин ангилна.**

Опционы цаг хугацааны үнэ цэнийг тайлагнах

144. Байгууллага нь опционы гэрээний дотоод үнэ цэнэ ба цаг хугацааны үнэ цэнийг салган зааглаж, уг опционы зөвхөн дотоод үнэ цэнийн өөрчлөлтийг хейжийн хэрэглүүр гэж сонгох тохиолдолд (119(а) параграфыг үзнэ үү) тухайн байгууллага нь опционы цаг хугацааны үнэ цэнийг дараах байдлаар тайлагнана (МЗУ322-МЗУ326-р параграфыг үзнэ үү):

- (а) Уг опционоор хейж хийж буй тухайн хейжийн зүйлийн дараах төрлүүдийн дагуу байгууллага нь опционы цаг хугацааны үнэ цэнийг салган зааглана (МЗУ322-р параграфыг үзнэ үү):
 - (i) Ажил гүйлгээтэй холбоотой хейжийн зүйл; эсвэл
 - (ii) Цаг хугацаатай холбоотой хейжийн зүйл.
- (б) Ажил гүйлгээтэй холбоотой хейжийн зүйлд хейж хийж байгаа тухайн опционы цаг хугацааны үнэ цэнэд хамаарах хэсгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт нь тэрхүү хейжийн зүйлд хамааралтай байх хэмжээгээр түүнийг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрч, өмчийн тусдаа бүрэлдэхүүн хэсэгт хуримтлуулан тусгана. Цэвэр хөрөнгө/өмчийн тусдаа бүрэлдэхүүн хэсэгт хуримтлуулан тусгасан уг опционы цаг хугацааны үнэ цэнэ ('дүн')-ээс үүссэн бодит үнэ цэнийн хуримтлагдсан өөрчлөлтийг дараах байдлаар тайлагнана:
 - (i) Хейжийн зүйл нь дараагийн тайлант үед санхүүгийн бус хөрөнгө буюу санхүүгийн бус өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхөд хүргэдэг, эсвэл санхүүгийн бус хөрөнгө буюу санхүүгийн бус өр төлбөрт хамаарах бөгөөд бодит үнэ цэнийн хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэдэг тийм арилжааны баталгаа болохоор бол тухайн байгууллага нь тэрхүү дүнг өмчийн тусдаа бүрэлдэхүүн хэсгээс хасаж, уг хөрөнгө, өр төлбөрийн анхны өртөг буюу адилтгах бусад дансны үнэд шууд оруулан тусгана. Энэ нь дахин ангилах залруулга биш (УСНББОУС 1-ийг үзнэ үү), иймээс цэвэр хөрөнгө/өмчид нөлөө үзүүлэхгүй.

- (ii) Дээрх (i)-д дурдсанаас бусад хейжийн харилцааны хувьд, уг дүнг өмчийн тусдаа бүрэлдэхүүн хэсгээс хасаж, тухайн хейж хийсэн хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн гүйлгээ нь ашиг, алдагдалд нөлөө үзүүлэх тэрхүү тайлант үед буюу үеүдэд (жишээлбэл; урьдчилан таамагласан борлуулалт хийгдэх тайлант үеүдэд) дахин ангилах залруулга (УСНББОУС 1-ийг үзнэ үү) байдлаар ашиг, алдагдалд шилжүүлэн дахин ангилна.
 - (iii) Харин уг дүнгийн бүх буюу зарим хэсгийг ирээдүйн нэг буюу хэд хэдэн тайлант үеүдэд нөхөхөөр хүлээгдээгүй бол ингэж нөхөгдөхөөр хүлээгдээгүй дүнг дахин ангилах залруулга (УСНББОУС 1-ийг үзнэ үү) байдлаар ашиг, алдагдалд нэн даруй дахин ангилна.
- (в) Цаг хугацаатай холбоотой хейжийн зүйлд хейж хийж байгаа тухайн опционы цаг хугацааны үнэ цэнэд хамаарах хэсгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт нь тэрхүү хейжийн зүйлд хамааралтай байх хэмжээгээр түүнийг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрч, өмчийн тусдаа бүрэлдэхүүн хэсэгт хуримтлуулан тусгана. Опционыг хейжийн хэрэглүүр гэж сонгосон өдрөөр тухайн цаг хугацааны үнэ цэнэ нь уг хейжийн зүйлтэй холбоотой байх тохиолдолд опционы дотоод үнэ цэнийн хувьд хийсэн хейжийн тохируулга нь ашиг, алдагдалд (хэрэв хейжийн зүйл нь тухайн байгууллага түүнийг бодит үнэ цэнийн өөрчлөлтийг 106-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчид толилуулахаар сонголт хийсэн өмчийн хэрэглүүр байх тохиолдолд цэвэр хөрөнгө/өмчид) нөлөө үзүүлэх тайлант үеийн туршид тэрхүү цаг хугацааны үнэ цэнийг системчилсэн ба ул үндэслэлтэй сууриар хорогдуулна. Иймээс хорогдуулгын дүнг тухайн тайлант үе бүрд дахин ангилах залруулга (УСНББОУС 1-ийг үзнэ үү) байдлаар өмчийн тусдаа бүрэлдэхүүн хэсгээс ашиг, алдагдалд дахин ангилна. Хэрэв хейжийн хэрэглүүр болох тухайн опционы дотоод үнэ цэнийн өөрчлөлтийг агуулсан хейжийн харилцааны хувьд хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэхгүй зогсоосон бол өмчийн тусдаа бүрэлдэхүүн хэсэгт хуримтлагдсан уг цэвэр дүнг (өөрөөр хэлбэл, хуримтлагдсан хорогдуулга үүнд хамаарна) дахин ангилах залруулга (УСНББОУС 1-ийг үзнэ үү) байдлаар ашиг, алдагдалд нэн даруй дахин ангилна.

Форвард гэрээний форвард элемент ба санхүүгийн хэрэглүүрийн гадаад валютын суурийн тархалтын тайлагнал

145. Байгууллага нь форвард гэрээний форвард элемент болон спот элементийг салгаж, уг форвард гэрээний зөвхөн спот элементийн үнэ цэнэд гарсан өөрчлөлтийг хейжийн хэрэглүүр гэж сонгодог, эсвэл байгууллага нь гадаад валютын суурийн тархалтыг санхүүгийн хэрэглүүрээс салгаж, тухайн санхүүгийн хэрэглүүрийг хейжийн хэрэглүүр гэж сонгохдоо тэрхүү суурийн тархалтыг хасаж оруулдаггүй (119(б) параграфыг үзнэ үү) тохиолдолд байгууллага нь 144-р параграфыг опционы цаг хугацааны үнэ цэнэд мөрддөгтэй адилаар, форвард гэрээний форвард элементэд эсвэл гадаад валютын суурийн тархалтанд мөрдөж болох юм. Энэ тохиолдолд байгууллага нь МЗУ327–МЗУ332-р параграф дахь мөрдөж заавар удирдамжийг дагаж мөрдөнө.

Зүйлсийн бүлгийн хейж

Зүйлсийн бүлэг нь хейжийн зүйл болох шалгуур хангах

146. **Зүйлсийн бүлэг (үүн дотроо, цэвэр төлөв байдлыг бүрдүүлэх зүйлсийн бүлэг хамаарна; МЗУ333-МЗУ340-р параграфыг үзнэ үү) нь зөвхөн дараах тохиолдолд шалгуур хангах хейжийн зүйл болно:**
- (а) Энэ нь бие даасан байдлаараа шалгуур хангах хейжийн зүйл болох тийм зүйлсээс (үүн дотроо уг зүйлсийн бүрэлдэхүүн хэсгүүдээс) бүрддэг;
 - (б) Бүлэг доторх зүйлсийг эрсдлийн удирдлагын зорилгоор бүлэг гэдэг утгаар хамтад нь удирдан зохицуулдаг;
 - (в) Зүйлсийн бүлгийн мөнгөн гүйлгээний хейжийн хувьд түүний мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлт нь харилцан нөхөх эрсдлийн төлөв байдал үүсгэх байдлаар

тухайн бүлгийн мөнгөн гүйлгээний ерөнхий хувьсан өөрчлөлттэй ойролцоогоор шууд хамааралтай байхаар хүлээгдээгүй тийм тохиолдолд:

- (i) Энэ нь гадаад валютын эрсдлийн хейж байх; ба
- (ii) **Ийм цэвэр төлөв байдлын сонголт нь ашиг, алдагдалд уг урьдчилан таамагласан ажил гүйлгээ нөлөө үзүүлэхээр хүлээгдэж буй тухайн тайлант үе, түүнчлэн тэдгээрийн шинж төрөл ба хэмжээг тусгайлан заадаг (МЗУ339-МЗУ340-р параграфыг үзнэ үү).**

Бүрэлдэхүүн хэсгийг нэрлэсэн дүнгээр хейжийн зүйл гэж сонгох

- 147. Хейжийн зүйл гэж сонгох нь тухайн байгууллагын эрсдлийн удирдлагын зорилготой нийцэж байвал шалгуур хангах зүйлсийн хувь тэнцүүлсэн хэсгийг өөртөө агуулдаг, бүрэлдэхүүн хэсэг нь шалгуур хангах хейжийн зүйл байна.
- 148. Зүйлсийн ерөнхий бүлгээс сонгосон давхарга бүрэлдэхүүн хэсэг (тухайлбал; хамгийн доод давхарга) нь зөвхөн дараах тохиолдолд хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангана:
 - (a) Түүнийг тусад нь тодорхойлж, найдвартай хэмжих боломжтой байх;
 - (b) Эрсдлийн удирдлага нь давхарга бүрэлдэхүүн хэсэгт хейж хийх зорилготой байх;
 - (в) Ерөнхий бүлэг дэх зүйлсээс давхаргыг тодорхойлдог бөгөөд тэдгээр зүйлс нь уг хейж хийсэн эрсдэлд өртдөг (иймээс ерөнхий бүлгээс сонгон авсан бөгөөд тухайн хейж хийсэн давхаргыг бүрдүүлдэг тодорхой зүйлс нь тэрхүү хейж хийсэн давхаргын хэмжилтэнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэггүй байх);
 - (г) Одоо байгаа зүйлсийн хейжийн хувьд (жишээлбэл; хүлээн зөвшөөрөөгүй арилжааны баталгаа эсвэл хүлээн зөвшөөрсөн хөрөнгө) байгууллага нь уг хейж хийсэн давхаргыг сонгож, тодорхойлсон тухайн зүйлсийн ерөнхий бүлгийг тогтоож, даган шалгах боломжтой байх (ингэснээр байгууллага нь шалгуур хангах хейжийн харилцааны хувьд нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудыг даган мөрдөх боломжтой байх);
 - (д) Урьдчилан төлөлтийн опционыг агуулсан тухайн бүлэг дэх аливаа зүйлс нь нэрлэсэн дүнгийн бүрэлдэхүүн хэсгүүдэд хамаарах шаардлагуудыг хангадаг байх (МЗУ269-р параграфыг үзнэ үү).

Толилуулга

- 149. Хейж хийсэн эрсдэл нь ашиг, алдагдал ба цэвэр хөрөнгө/өмчийн тайлан дахь өөр өөр мөрийн зүйлсэд нөлөөлдөг, харилцан нөхөх эрсдлийн төлөв байдал бүхий зүйлсийн бүлгийн хейжийн (өөрөөр хэлбэл, цэвэр төлөв байдлын хейжийн) хувьд уг санхүүгийн тайлан дахь хейжийн аливаа олз, гарзыг тухайн хейжийн нөлөөлөх мөрийн зүйлээс тусдаа мөрийн зүйлд толилуулна. Иймээс тухайн хейжийн зүйлтэй (жишээлбэл; орлого эсвэл зардал) өөртэй нь холбоотой уг мөрийн зүйл дэх дүн нь тэрхүү санхүүгийн тайланд өөрчлөгдөхгүй хэвээр байна.
- 150. Бодит үнэ цэнийн хейж байх тохиолдолд бүлэг байдлаар хамтад нь хейж хийдэг хөрөнгө, өр төлбөрийн хувьд санхүүгийн байдлын тайланд тусгасан, тэдгээр хөрөнгө, өр төлбөрөөс үүссэн олз, гарзыг 137(б) параграфын дагуу тэрхүү бүлгийг бүрдүүлж буй харгалзах бие даасан зүйлсийн дансны үнийн залруулга байдлаар хүлээн зөвшөөрнө.

Тэг (0) цэвэр төлөв байдал

- 151. Хейжийн зүйл нь тэг (0) цэвэр төлөв байдал бүхий (өөрөөр хэлбэл, тухайн хейжийн зүйлс нь бүлэг байдлаар удирддаг эрсдлийг өөрсдөө бүрэн харилцан нөхдөг) бүлэг бол түүнийг хейжийн хэрэглүүр агуулаагүй хейжийн харилцаанд дараах тохиолдолд сонгохыг байгууллагад зөвшөөрдөг:
 - (a) Тухайн хейж нь цэвэр эрсдлийн үечлэн үргэлжлэх хейжийн стратегийн нэг хэсэг байх. Ийм стратегийн үед байгууллага нь цаг хугацаа урсан өнгөрөхийн хэрээр нэг ижил

төрлийн шинэ шинэ төлөв байдлуудад тасралтгүй, тогтмол хейж хийдэг (жишээлбэл; ажил гүйлгээ нь тухайн байгууллагын хейж хийх уг цаг хугацааны хамрах хүрээнд үргэлжлэн гардаг байх);

- (б) Тухайн хейж хийсэн цэвэр төлөв байдал нь уг цэвэр эрсдлийн үечлэн үргэлжлэх хейжийн стратегийн явцад хэмжээний хувьд өөрчлөгддөг бөгөөд байгууллага нь тэрхүү цэвэр эрсдэлд хейж хийхийн тулд шалгуур хангах хейжийн хэрэглүүрийг ашигладаг (өөрөөр хэлбэл, цэвэр төлөв байдал нь тэг (0) биш) байх;
- (в) Цэвэр төлөв байдал нь тэг (0) биш бөгөөд шалгуур хангах хейжийн хэрэглүүрээр түүнд хейж хийдэг тохиолдолд хейжийн нягтлан бодох бүртгэлийг ийм цэвэр төлөв байдалд ихэвчлэн мөрддөг байх;
- (г) Тэг (0) цэвэр төлөв байдалд хейжийн нягтлан бодох бүртгэлийг мөрдөхгүй байх нь нягтлан бодох бүртгэлийн тууштай бус үр дагавар үүсэхэд хүргэнэ. Яагаад гэвэл, цэвэр төлөв байдлын хейжид хүлээн зөвшөөрөх байсан уг харилцан нөхөх эрсдлийн төлөв байдлыг нягтлан бодох бүртгэлд хүлээн зөвшөөрөхгүй байхад хүргэх юм.

Зээлийн эрсдлийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилах боломж

Зээлийн эрсдэл нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилах шалгуур хангах

152. Байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн бүх буюу зарим хэсгийн зээлийн эрсдлийг (зээлийн эрсдэлд өртөлтийг) удирдан зохицуулахын тулд ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн зээлийн үүсмэл хэрэглүүрийг ашигладаг бол тухайн байгууллага нь ингэж удирдан зохицуулсан хэмжээгээр (өөрөөр хэлбэл, бүх эсвэл түүний зарим хэсэг) уг санхүүгийн хэрэглүүрийг дараах тохиолдолд ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилж болно:

- (а) Зээлийн эрсдэлд өртөлтийн нэр (жишээлбэл; зээлдэгч эсвэл зээл олгох баталгааг эзэмшигч) нь тухайн зээлийн үүсмэл хэрэглүүрийн гаргагч байгууллагатай тохирч байх ('нэрийн уялдаатай байдал');
- (б) Тухайн санхүүгийн хэрэглүүрийн буцаан төлөгдөх дараалал нь уг зээлийн үүсмэл хэрэглүүрийн дагуу нийлүүлэх тэрхүү хэрэглүүрийн буцаан төлөгдөх дараалалтай тохирч байх.

Зээлийн эрсдлийн хувьд удирдан зохицуулсан уг санхүүгийн хэрэглүүр нь энэхүү Стандартын цар хүрээнд хамаарах эсэхээс үл шалтгаалан байгууллага нь ийм ангилал хийж болно (тухайлбал; байгууллага нь энэ Стандартын цар хүрээнд хамаарахгүй, зээл олгох баталгааг ингэж ангилж болох юм). Байгууллага нь уг санхүүгийн хэрэглүүрийг анх хүлэн зөвшөөрөх үед, эсвэл түүнээс хойшхи дараагийн тайлант үед, эсвэл хүлээн зөвшөөрөөгүй байх үед ингэж ангилж болно. Байгууллага нь ийм ангилал хийхдээ түүнийг мөн нэгэн зэрэг баримтжуулна.

Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан зээлийн эрсдэлд өртөлтийн тайлагнал

153. Санхүүгийн хэрэглүүрийг анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа 152-р параграфын дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан эсвэл түүнийг өмнө нь хүлээн зөвшөөрөөгүй байсан тохиолдолд хэрэв байгаа бол уг хэрэглүүрийн дансны үнэ ба бодит үнэ цэнийн хоорондох зөрүүг тэрхүү ангиллын өдрөөр ашиг, алдагдалд нэн даруй хүлээн зөвшөөрнө. 41-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг санхүүгийн хөрөнгийн хувьд цэвэр хөрөнгө/өмчид өмнө нь хүлээн зөвшөөрч байсан хуримтлагдсан олз, гарзыг дахин ангилах залруулга (УСНББОУС 1-ийг үзнэ үү) байдлаар өмчөөс ашиг, алдагдалд нэн даруй дахин ангилна.

154. Байгууллага нь зээлийн эрсдэл үүсэхэд хүргэдэг санхүүгийн хэрэглүүрийг эсвэл түүний зарим хэсгийг дараах тохиолдолд ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжихээ зогсооно:

- (a) 152-р параграфт заасан шалгуур цаашид хангагдахгүй болсон. Тухайлбал;
 - (i) Зээлийн үүсмэл хэрэглүүрийн, эсвэл зээлийн эрсдэл үүсэхэд хүргэдэг холбогдох санхүүгийн хэрэглүүрийн хугацаа дууссан, борлуулсан, дуусгавар болгосон буюу барагдуулсан; эсвэл
 - (ii) Санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдлийг цаашид зээлийн үүсмэл хэрэглүүр ашиглан удирдан зохицуулахаа больсон. Жишээлбэл; зээлдэгчийн буюу зээл олгох баталгаа эзэмшигчийн зээлийн чанар сайжирсан эсвэл байгууллагад хүлээлгэдэг капиталын шаардлагууд өөрчлөгдснөөр ийм нөхцөл байдал үүсэж болно;
 - (б) Зээлийн эрсдэл үүсэхэд хүргэдэг санхүүгийн хэрэглүүрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих шаардлагагүй болсон (өөрөөр хэлбэл, 54-р параграфын дагуу дахин ангилал хийхийг шаардах тийм байдлаар тухайн байгууллагын удирдлагын загвар өөрчлөгдөөгүй).
155. Байгууллага нь зээлийн эрсдэл үүсэхэд хүргэдэг санхүүгийн хэрэглүүр эсвэл түүний зарим хэсгийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнээр хэмжихээ зогсоосон тохиолдолд энэхүү зогсоосон өдрөөрх уг санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ нь түүний шинэ дансны үнэ болно. Санхүүгийн хэрэглүүрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилахын өмнө ашиглаж байсан тухайн хэмжилтийг (үүн дотроо, уг шинэ дансны үнээс тооцсон хорогдуулгыг) дараагийн тайлант үеүдэд мөрдөнө. Тухайлбал; хорогдуулсан өртгөөр хэмжсэн гэж анх ангилж байсан санхүүгийн хөрөнгийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжихээ зогсоосон өдрөөр түүнийг эргээд хорогдуулсан өртгөөр хэмжих бөгөөд тэрхүү өдрөөрх уг хөрөнгийн шинэ дансны үнэд үндэслэн үр ашигт хүүний хувийг дахин тооцоолно.

Хүчин төгөлдөр болох хугацаа ба шилжилт**Хүчин төгөлдөр болох хугацаа**

156. Байгууллага нь энэ Стандартыг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант жилд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь дурдсан хугацаанаас өмнөх тайлант үед энэ Стандартыг мөрдөх сонголт хийсэн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд энэ Стандартын бүх шаардлагуудыг мөн уг өмнөх тайлант хугацаанд дагаж мөрдөнө (гэхдээ 179-р параграфыг бас үзнэ үү). Түүнчлэн, Хавсралт Г дэх нэмэлт өөрчлөлтүүдийг мөн тэрхүү өмнөх тайлант хугацаанд мөрдөнө.
157. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

Шилжилт

158. 161-184-р параграфт тусгайлан зааснаас бусад тохиолдолд байгууллага нь УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-ны дагуу энэ Стандартыг буцаах горимоор мөрдөнө. Энэ Стандартыг анх мөрдөх өдөр аль хэдийн үл хүлээн зөвшөөрчихсөн байсан зүйлсийн хувьд түүнийг мөрдөхгүй.
159. 158, 160-184-р параграфууд дахь шилжилтийн нөхцлийн зорилгын хувьд анх мөрдөх өдөр нь энэ Стандартын шаардлагуудыг байгууллага анх удаа дагаж мөрдсөн өдөр бөгөөд энэ Стандартыг гаргасны дараах, тайлант үеийн эхэн байх ёстой.

Ангилал ба хэмжилттэй холбоотой шилжилтийн нөхцөл

160. Анх мөрдөх өдөр, санхүүгийн хөрөнгө нь 40(а) эсвэл 41(а) параграфт заасан нөхцлийг хангаж байгаа эсэхийг байгууллага нь уг өдрөөр оршин буй баримт материал болон нөхцөл байдалд үндэслэн үнэлнэ. Үүний үр дүн болох ангиллыг өмнөх тайлант үеүдэд тухайн байгууллагын хэрэглэж байсан удирдлагын загвараас үл хамааран буцаах горимоор мөрдөнө.
161. Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед оршин байсан баримт материал болон нөхцөл байдалд үндэслэн, байгууллага нь мөнгөний цаг хугацааны засварласан үнэ цэнийн элементийг МЗУ68-МЗУ70-р параграфын дагуу уг анх мөрдсөн өдрөөр үнэлэх практик боломжгүй (УСНББОУС 3-д тодорхойлсноор) тохиолдолд тухайн байгууллага нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн элементийн засвар өөрчлөлттэй холбоотой шаардлагуудыг МЗУ68-МЗУ70-р параграфын дагуу харгалзан үзэхгүйгээр уг санхүүгийн хөрөнгийн гэрээний мөнгөн гүйлгээний шинж чанаруудыг тэрхүү санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед оршин байсан баримт материал болон нөхцөл байдалд үндэслэн үнэлнэ (УСНББОУС 30-ийн 49У параграфыг бас үзнэ үү).
162. Урьдчилсан төлбөрийн шинжийн бодит үнэ цэнэ нь МЗУ74(в) параграфт заасанчлан мэдэгдэхүйц бус эсэхийг санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед оршин байсан баримт материал болон нөхцөл байдалд үндэслэн байгууллага нь уг анх мөрдөх өдрөөр үнэлэх практик боломжгүй (УСНББОУС 3-д тодорхойлсноор) тохиолдолд тухайн байгууллага нь МЗУ74-р параграфт заасан урьдчилсан төлбөрийн шинжүүдэд хамаарах гажих нөхцлийг харгалзан үзэхгүйгээр уг санхүүгийн хөрөнгийн гэрээний мөнгөн гүйлгээний шинж чанаруудыг тэрхүү санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед оршин байсан баримт материал болон нөхцөл байдалд үндэслэн үнэлнэ (УСНББОУС 30-ийн 49Ф параграфыг бас үзнэ үү).

163. Байгууллага нь холимог гэрээг 41, 43 эсвэл 44-р параграфын дагуу бодит үнэ цэнээр хэмждэг боловч зэрэгцүүлэгдэх тайлант үеүдэд тухайн холимог гэрээний бодит үнэ цэнийг хэмждэггүй тохиолдолд уг зэрэгцүүлэгдэх тайлант үеүд дэх холимог гэрээний бодит үнэ цэнэ нь хэрэв байгууллага өмнөх тайлант үеүдийг дахин тайлагнасан бол тэдгээр зэрэгцүүлэгдэх тайлант үе бүрийн эцэс дэх түүний бүрэлдэхүүн хэсгүүдийн (өөрөөр хэлбэл, үүсмэл бус үндсэн гэрээ ба дагалдах үүсмэл хэрэглүүр) бодит үнэ цэнүүдийн нийлбэртэй тэнцүү байна (173-р параграфыг үзнэ үү).
164. Хэрэв байгууллага нь анх мөрдөх өдрөөр 163-р параграфыг мөрдсөн бол уг анх мөрдөх өдрөөрх тухайн холимог гэрээний нийт бодит үнэ цэнэ ба мөн өдрөөрх түүний бүрэлдэхүүн хэсгүүдийн бодит үнэ цэнүүдийн нийлбэр хоорондох аливаа зөрүүг байгууллага нь энэхүү анх мөрдөх өдрийг багтаасан тайлант үеийн хуримтлагдсан ашгийн (эсвэл цэвэр хөрөнгө/өмчийн бусад бүрэлдэхүүн хэсгийн аль тохиромжтойд) эхний үлдэгдэлд тэрхүү анх мөрдөх өдөр хүлээн зөвшөөрнө.
165. Уг анх мөрдөх өдөр байгууллага нь дараах байдлаар ангилж болно:
- (а) Санхүүгийн хөрөнгийг 44-р параграфын дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж;
 - (б) Өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтыг 106-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж.
- Тухайн анх мөрдөх өдрөөр оршин байгаа баримт материал болон нөхцөл байдалд үндэслэн ийм ангиллыг хийнэ. Уг ангиллыг буцаах горимоор мөрдөнө.
166. Анх мөрдөх өдөр байгууллага нь:
- (а) Хэрэв санхүүгийн хөрөнгө нь 44-р параграфт заасан нөхцлийг хангахгүй бол тухайн санхүүгийн хөрөнгийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэсэн өөрийн өмнөх ангиллыг хүчингүй болгоно.
 - (б) Хэрэв санхүүгийн хөрөнгө нь 44-р параграфт заасан нөхцлийг хангаж байвал тухайн санхүүгийн хөрөнгийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэсэн өөрийн өмнөх ангиллыг хүчингүй болгож болох юм.
- Тухайн анх мөрдөх өдрөөр оршин байгаа баримт материал болон нөхцөл байдалд үндэслэн ийм хүчингүй болголтыг хийнэ. Уг ангиллыг буцаах горимоор мөрдөнө.
167. Анх мөрдөх өдөр байгууллага нь:
- (а) Санхүүгийн өр төлбөрийг 46(а) параграфын дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилж болно.
 - (б) Санхүүгийн өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөх үед 46(а) параграфт заасан нөхцлийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан бөгөөд уг ангилал нь анх мөрдөх өдрөөр тэрхүү нөхцлийг хангахгүй болсон бол санхүүгийн өр төлбөрийн ийм өмнөх ангиллыг хүчингүй болгоно.
 - (в) Санхүүгийн өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөх үед 46(а) параграфт заасан нөхцлийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан бөгөөд уг ангилал нь анх мөрдөх өдрөөр тэрхүү нөхцлийг хангаж байвал санхүүгийн өр төлбөрийн ийм өмнөх ангиллыг хүчингүй болгож болох юм.
- Тухайн анх мөрдөх өдрөөр оршин байгаа баримт материал болон нөхцөл байдалд үндэслэн ийм ангилал болон хүчингүй болголтыг хийнэ. Уг ангиллыг буцаах горимоор мөрдөнө.
168. Үр ашигт хүүний аргыг буцаах горимоор мөрдөх практик боломжгүй тохиолдолд (УСНББОУС 3-д тодорхойлсон) байгууллага нь:
- (а) Хэрэв байгууллага нь өмнөх тайлант үеүдийг дахин тайлагнадаг бол тухайн толилуулсан зэрэгцүүлэгдэх тайлант үе бүрийн эцэст уг санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

төлбөрийн бодит үнэ цэнийг тэрхүү санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнэ эсвэл тэрхүү санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртөг гэж үзнэ; ба

- (б) Анх мөрдөх өдрөөрх уг санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийг энэхүү Стандартыг анх мөрдөх өдрөөрх тэрхүү санхүүгийн хөрөнгийн шинэ нийт дансны үнэ эсвэл тэрхүү санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан шинэ өртөг гэж үзнэ.
169. Ижил төсөөтэй хэрэглүүрийн идэвхитэй зах зээлийн жишиг үнэ (өөрөөр хэлбэл, 1-р түвшний орц) байхгүй, тийм өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтыг (эсвэл ийм өмчийн хэрэглүүртэй холбоотой бөгөөд түүнийг нийлүүлснээр барагдуулах ёстой үүсмэл хөрөнгийг) байгууллага өмнө нь өртгөөр (УСНББОУС 29-ийн дагуу) тайлагнадаг байсан бол анх мөрдөх өдөр уг хэрэглүүрийг бодит үнэ цэнээр хэмжинэ. Өмнөх дансны үнэ ба бодит үнэ цэнийн хоорондох аливаа зөрүүг энэхүү анх мөрдөх өдрийг багтаасан тайлант үеийн хуримтлагдсан ашгийн (эсвэл цэвэр хөрөнгө/өмчийн бусад бүрэлдэхүүн хэсгийн аль тохиромжтойд) эхний үлдэгдэлд хүлээн зөвшөөрнө.
170. Ижил төсөөтэй хэрэглүүрийн идэвхитэй зах зээлийн жишиг үнэ (өөрөөр хэлбэл, 1-р түвшний орц) байхгүй, тийм өмчийн хэрэглүүртэй холбоотой бөгөөд түүнийг нийлүүлснээр барагдуулах ёстой үүсмэл өр төлбөрийг байгууллага өмнө нь УСНББОУС 29-ийн дагуу өртгөөр тайлагнадаг байсан бол анх мөрдөх өдөр уг үүсмэл өр төлбөрийг бодит үнэ цэнээр хэмжинэ. Өмнөх дансны үнэ ба бодит үнэ цэнийн хоорондох аливаа зөрүүг энэхүү анх мөрдөх өдрийг багтаасан тайлант үеийн цэвэр хөрөнгө/өмчийн эхний үлдэгдэлд хүлээн зөвшөөрнө.
171. 108-р параграфт заасан арга хандлага нь ашиг, алдагдалд нягтлан бодох бүртгэлийн уялдаагүй байдлыг үүсгэх буюу нэмэгдүүлэх эсэхийг байгууллага нь анх мөрдөх өдөр оршин буй баримт материал болон нөхцөл байдалд үндэслэн уг анх мөрдөх өдөр тодорхойлно. Ийм тодорхойлолтонд үндэслэн энэхүү Стандартыг буцаах горимоор мөрдөнө.
172. Ижил төсөөтэй бүх гэрээнүүдийг ангилдаг зөвхөн тийм тохиолдолд байгууллага нь 6-р параграфт заасан ангиллыг уг анх мөрдөх өдрөөр оршин байсан гэрээнүүдийн хувьд хийхийг түүнд зөвшөөрдөг. Ийм ангиллын үр дүнд цэвэр хөрөнгөнд гарсан өөрчлөлтийг уг анх мөрдөх өдөр цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө.
173. Энэ Стандартын ангилал ба хэмжилтийн шаардлагуудыг (69-72 ба 73-93-р параграфт санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртгийн хэмжилт ба үнэ цэнийн бууралттай холбоотой шаардлагуудыг агуулсан) мөрддөг байгууллага нь 158-р параграфт заасан шаардлагуудыг үл харгалзан, УСНББОУС 30-ийн 49Н–49П параграфт заасан тодруулгыг бэлтгэх боловч өмнөх тайлант үеүдийг дахин тайлагнах шаардлагагүй юм. Үр дагаврын талаархи мэдлэгийг ашиглахгүйгээр дахин тайлагнах боломжтой зөвхөн тийм тохиолдолд байгууллага нь өмнөх тайлант үеүдийг дахин тайлагнаж болох юм. Хэрэв байгууллага нь өмнөх тайлант үеүдийг дахин тайлагнаагүй бол тухайн байгууллага нь уг өмнөх дансны үнэ ба анх мөрдөх өдрийг багтаасан тайлант жилийн эхэн дэх дансны үнэ хоорондох аливаа зөрүүг тэрхүү анх мөрдөх өдрийг багтаасан тайлант жилийн хуримтлагдсан ашгийн (эсвэл цэвэр хөрөнгө/өмчийн бусад бүрэлдэхүүн хэсгийн аль тохиромжтойд) эхний үлдэгдэлд хүлээн зөвшөөрнө. Харин байгууллага нь өмнөх тайлант үеүдийг дахин тайлагнасан бол уг дахин тайлагнасан санхүүгийн тайланд энэ Стандартын бүх шаардлагуудыг тусгасан байх ёстой.
174. Хэрэв байгууллага нь завсар үеийн санхүүгийн тайланг бэлтгэдэг бол тухайн байгууллага нь уг анх мөрдөх өдрөөс өмнөх завсрын тайлант үеүдэд энэхүү Стандартын шаардлагуудыг мөрдөх практик боломжгүй тохиолдолд (УСНББОУС 3-д тодорхойлсон) тэдгээр шаардлагуудыг мөрдөх албагүй юм.

Үнэ цэнийн бууралт

175. Байгууллага нь 173, 176-178-р параграфт дурдсан нөхцөл байдлуудын хувьд 73-93-р параграфт заасан үнэ цэнийн бууралтын шаардлагуудыг УСНББОУС 3-ын дагуу буцаах горимоор мөрдөнө.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

176. Байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрсөн өдрөөрх (эсвэл байгууллага нь 78-р параграфт заасанчлан, уг буцах боломжгүй баталгааны оролцогч тал болсон өдрөөрх зээл олгох баталгаа болон санхүүгийн баталгааны гэрээний хувьд) зээлийн эрсдлийг тодорхойлох ба түүнийг энэ Стандартыг анх мөрдөх өдрөөрх зээлийн эрсдэлтэй харьцуулан үзэхийн тулд уг анх мөрдөх өдөр их зардал буюу хүчин чармайлт гаргахгүйгээр олж болох ул үндэслэлтэй ба дэмжих мэдээллийг ашиглана.
177. Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг тодорхойлохдоо байгууллага нь дараах зүйлсийг мөрдөж болно:
- (а) 82, МЗУ186-МЗУ188-р параграф дахь шаардлагууд;
 - (б) Байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрснөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг хугацаа өнгөрсөн мэдээлэлд тулгуурлан тодорхойлсноор үнэ цэнийн бууралтын шаардлагуудыг мөрддөг бол 30 хоногоос илүүгээр хугацаа өнгөрсөн гэрээний төлбөрийн хувьд 83-р параграфт заасан няцааж болох урьдчилсан нөхцөл.
178. Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг тэрхүү анх мөрдөх өдрөөр тодорхойлоход их зардал буюу хүчин чармайлт гаргах шаардлагатай байвал байгууллага нь уг санхүүгийн хэрэглүүрийг үл хүлээн зөвшөөрөх хүртэлх тайлант үе бүрийн эцэст (санхүүгийн хэрэглүүр нь тайлант үеийн эцэст зээлийн эрсдэл багатай байхаас бусад тохиолдолд, ийм үед 177(а) параграфыг мөрдөнө) гарзын хасагдуулгыг тухайн нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр хүлээн зөвшөөрнө.

Хейжийн нягтлан бодох бүртгэлийн шилжилтийн нөхцөл

179. Энэхүү Стандартыг анх мөрдөх үед байгууллага нь энэ Стандартын 113-155-р параграфын шаардлагуудыг биш, харин УСНББОУС 29-ийн хейжийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудыг үргэлжлүүлэн мөрдөхөөр өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгож болох юм. Байгууллага нь уг бодлогыг өөрийн бүх хейжийн харилцаанд мөрдөнө. Ийм бодлого сонгосон байгууллага нь УСНББОУС 29-ийн Хавсралт В-г бас мөрдөнө.
180. 184-р параграфт зааснаас бусад тохиолдолд, байгууллага нь энэ Стандартын хейжийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудыг гүйцээх горимоор мөрдөнө.
181. Энэ Стандартын хейжийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудыг анх мөрдсөн өдрөөс эхлэн хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэхийн тулд уг өдрөөр бүх шалгуур хангагдсан байх ёстой.
182. УСНББОУС 29-ийн дагуу хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангасан, түүнчлэн шилжилтийн үе дэх уг хейжийн харилцааны аливаа дахин тэнцвэржүүлэлтийг харгалзан үзсэний (183(б) параграфыг үзнэ үү) дараа энэ Стандартад заасан шалгуурын дагуу хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг (129-р параграфыг үзнэ үү) бас хангах хейжийн харилцааг үргэлжилж байгаа хейжийн харилцаа гэж үзнэ.
183. Энэ Стандартын хейжийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудыг анх мөрдөхдөө байгууллага нь:
- (а) УСНББОУС 29-ийн хейжийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудыг мөрдөхөө зогсоосон тэрхүү нэг ижил хугацааны агшнаас эхлэн эдгээр шаардлагуудыг эхлэн мөрдөж болох юм;
 - (б) Хэрэв мөрдөх боломжтой бол УСНББОУС 29-ийн дагуу энэхүү хейжийн харьцааг тухайн үргэлжилж байгаа хейжийн харилцааны хейжийн харьцааг дахин тэнцвэржүүлэх эхлэлийн цэг болгон авч үзнэ. Ийм дахин тэнцвэржүүлэлтээс үүссэн аливаа олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

184. Энэ Стандартын хейжийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудыг гүйцээх горимоор мөрдөх заалтын гажих нөхцөл болгон байгууллага нь:
- (a) Хэрэв опционы зөвхөн дотоод үнэ цэнийн өөрчлөлтийг УСНББОУС 29-ийн дагуу хейжийн харилцаанд хейжийн хэрэглүүр гэж сонгосон бол тухайн опционы цаг хугацааны үнэ цэнийн тайлагналыг 144-р параграфын дагуу буцаах горимоор мөрдөнө. Зэрэгцүүлэгдэх хамгийн эхний тайлант үеийн эхэнд байсан эсвэл үүнээс хойш сонгосон зөвхөн тэдгээр хейжийн харилцааны хувьд энэхүү буцаан мөрдөлтийг хэрэглэнэ.
 - (б) Хэрэв форвард гэрээний зөвхөн спот элементийн өөрчлөлтийг УСНББОУС 29-ийн дагуу хейжийн харилцаанд хейжийн хэрэглүүр гэж сонгосон бол тухайн форвард гэрээний форвард элементийн тайлагналыг 145-р параграфын дагуу буцаах горимоор мөрдөж болно. Зэрэгцүүлэгдэх хамгийн эхний тайлант үеийн эхэнд байсан эсвэл үүнээс хойш сонгосон зөвхөн тэдгээр хейжийн харилцааны хувьд энэхүү буцаан мөрдөлтийг хэрэглэнэ. Түүнчлэн, байгууллага нь энэхүү буцаан мөрдөх нягтлан бодох бүртгэлийг сонгосон бол ийм сонголтын шалгуурыг хангах бүх хейжийн харилцааны хувьд үүнийг мөрдөнө (өөрөөр хэлбэл, шилжилтийн үед хейжийн харилцаа тус бүрээр ийм сонголт хийх боломжгүй юм). Гадаад валютын суурийн тархалтын тайлагналыг (145-р параграфыг үзнэ үү) зэрэгцүүлэгдэх хамгийн эхний тайлант үеийн эхэнд байсан эсвэл үүнээс хойш сонгосон тэдгээр хейжийн харилцааны хувьд буцаан мөрдөж болно.
 - (в) Дараах тохиолдол нь хейжийн хэрэглүүрийн хугацаа дуусалт буюу дуусгавар болголт биш бөгөөд 135-р параграфын шаардлагыг буцаах горимоор мөрдөнө:
 - (i) Хууль, тогтоомжийн үйлчлэл эсвэл шинэ хууль, тогтоомжийн хэрэгжилтийн үр дүнд нэг буюу хэд хэдэн клирингийн байгууллагууд нь өөрийн анхны хамтрагч клирингийн байгууллагыг солих, ингэснээр бие биенийхээ хувьд шинэ хамтрагч клирингийн байгууллага болохыг уг хейжийн хэрэглүүрийн оролцогч талууд зөвшөөрөх; ба
 - (ii) Хейжийн хэрэглүүрт оруулах аливаа бусад өөрчлөлтүүд нь тухайн оролцогч тал ийм сольж орлуулалт хийхэд зайлшгүй хүргэх тийм өөрчлөлтүүдээр хязгаарлагдсан байх.

Мөрдөх заавар удирдамж

Энэ хавсралт нь УСНББОУС 41-ийн саллигүй бүрэлдэхүүн хэсэг юм.

Цар хүрээ (Бүлэг 2)

- МЗУ1. Зарим гэрээ нь уур амьсгалын, геологийн болон бусад биет хувьсагчдад үндэслэн төлбөр хийхийг шаарддаг. (Уур амьсгалын хувьсагчдад үндэслэдэг төлбөр бүхий гэрээг зарим үед “цаг агаарын үүсмэл хэрэглүүр” гэж нэрлэдэг.) Хэрэв ийм гэрээ нь даатгалын гэрээ биш бол энэ Стандартын цар хүрээнд хамаарна.
- МЗУ2. Энэ Стандарт нь тэтгэвэрт гарах үеийн тэтгэмжийн хөтөлбөрийн нягтлан бодох бүртгэл ба тайлагналын талаархи нягтлан бодох бүртгэлийн олон улсын буюу үндэсний холбогдох стандартад нийцсэн ажилтны тэтгэмжийн хөтөлбөр болон УСНББОУС 9, *Арилжааны Ажил Гүйлгээний Орлого*-ын дагуу тайлагнах борлуулалтын буюу үйлчилгээний орлогын хэмжээнд үндэслэх эрхийн шимтгэлийн гэрээтэй холбоотой шаардлагуудыг өөрчлөөгүй.
- МЗУ3. Зарим үед байгууллага нь “стратегийн хөрөнгө оруулалт” гэж үзсэн тохиолдолд хөрөнгө оруулалт хийж буй байгууллагатайгаа урт хугацаанд үйл ажиллагааны харилцаа тогтоох буюу хадгалах зорилгоор түүний гаргасан өмчийн хэрэглүүрт хөрөнгө оруулалт хийдэг. Уг хөрөнгө оруулагч буюу хамтарсан үйлдвэрийн хувь оруулагч байгууллага нь ийм хөрөнгө оруулалтын хувьд нягтлан бодох бүртгэлийн өмчийн аргыг хэрэглэх эсэхийг тодорхойлохын тулд УСНББОУС 36, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт*-ыг харгалзан үзнэ.
- МЗУ4. Даатгалын гэрээнээс үүсдэг учраас 2(д) параграфт заасанчлан, цар хүрээнд хамаардаггүй эрх, үүргээс бусад тухайн даатгагчийн санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрт энэ Стандартыг мөрдөнө. Гэвч байгууллага нь дараах зүйлсийн хувьд энэ Стандартыг мөрдөнө:
- (а) Гаргагч нь тухайн гэрээг УСНББОУС 28-ын дагуу даатгалын гэрээ гэж үзэх сонголт хийснээс бусад тохиолдол дахь санхүүгийн баталгааны гэрээ; ба
 - (б) Даатгалын гэрээнд агуулагдсан дагалдах үүсмэл хэрэглүүр.
- Байгууллага нь санхүүгийн эрсдлийн шилжүүлэлтийг агуулсан, бусад даатгалын гэрээнд энэ Стандартыг мөрдөж болох боловч заавал мөрдөхийг түүнээс шаардахгүй.
- МЗУ5. Санхүүгийн баталгааны гэрээ нь баталгаа, зарим төрлийн аккредитив, зээлийн үл биелүүлэлтийн гэрээ, даатгалын гэрээ гэх мэт хуулийн янз бүрийн хэлбэртэй байж болно. Тэдгээрийн нягтлан бодох бүртгэлийн хандлага нь уг хуулийн хэлбэрээс хамаарахгүй юм. Тохирох арга хандлагын жишээг доор дурдав (2(д) параграфыг үзнэ үү):
- (а) Хэрэв шилжүүлсэн эрсдэл нь мэдэгдэхүйц их бол санхүүгийн баталгааны гэрээ нь СТОУС 4-д заасан даатгалын гэрээний тодорхойлолтыг хангасан ч гэсэн тухайн гаргагч нь энэ Стандартыг мөрдөнө. Хэрэв гаргагч нь санхүүгийн баталгааны гэрээг даатгалын гэрээ гэж үзэх нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өмнө нь баримталж байсан бөгөөд даатгалын гэрээнд мөрдөж болох нягтлан бодох бүртгэлийг ашигладаг байсан бол тухайн гаргагч нь ийм санхүүгийн баталгааны гэрээнд энэ Стандартыг, эсвэл даатгалын гэрээний талаархи олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг мөрдөх сонголт хийж болно. Харин байгууллага нь УСНББОУС 28-ыг мөрдсөнөөр санхүүгийн баталгааны гэрээг зарим тохиолдолд санхүүгийн хэрэглүүрийн даатгалын гэрээ гэж үзэх сонголт хийж болох юм. Хэрэв гаргагч нь энэ Стандартыг мөрдөх бол 57-р параграфт шаардсаны дагуу, уг гаргагч нь санхүүгийн баталгааны гэрээг анх түүний бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрнө. Хэрэв санхүүгийн баталгааны гэрээг харилцан хамааралгүй талуудын нэг тусдаа ажил гүйлгээгээр холбоогүй талд гарган

өгсөн бол тэрхүү анх гаргах үед түүний бодит үнэ цэнэ нь эсрэг нотолгоотой байхаас бусад тохиолдолд тухайн хүлээн авсан хураамжийн дүнтэй тэнцүү байна. Тухайн санхүүгийн баталгааны гэрээг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж анх ангилсан эсвэл 26-34, МЗУ32-МЗУ38-р параграфыг мөрдсөнөөс бусад тохиолдолд (санхүүгийн хөрөнгийн шилжүүлэлт нь үл хүлээн зөвшөөрөх эсвэл цаашдын оролцооны арга хандлагыг мөрдөх шалгуурыг хангахгүй тохиолдолд) уг гаргагч нь түүнийг дараагийн тайлант үеүдэд дараах хоёр дүнгийн аль өндрөөр хэмжинэ:

- (i) 73-93-р параграфын дагуу тодорхойлсон дүн; ба
 - (ii) Анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс хэрэв тохиромжтой бол УСНББОУС 9-ийн зарчмуудын дагуу хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан хорогдуулгыг хассан дүн (45(в) параграфыг үзнэ үү).
- (б) Зээлтэй холбоотой зарим баталгаа нь энэхүү баталгааг эзэмшигч эрсдэлд өртөх ба уг баталгаа гаргасан хөрөнгийн хувьд хугацаа болсон төлбөрийг зээлдэгч төлөөгүйн улмаас гарз учирсан байхыг төлбөрийн урьдчилсан нөхцөл болгон шаарддаггүй. Ийм баталгааны жишээ нь тохиролцсон зээлийн зэрэглэл буюу зээлийн индексийн өөрчлөлтийн хариу болгон төлбөр хийхийг шаарддаг баталгаа юм. Ийм баталгаа нь энэ Стандартад тодорхойлсон санхүүгийн баталгааны гэрээ биш, даатгалын гэрээ ч бас биш юм. Ийм баталгаа нь үүсмэл хэрэглүүр бөгөөд гаргагч нь түүний хувьд энэ Стандартыг мөрдөнө.
- (в) Хэрэв санхүүгийн баталгааны гэрээг барааны борлуулалттай холбоотойгоор гаргасан бол гаргагч нь уг баталгааны болон бараа борлуулалтын орлогыг хэзээ хүлээн зөвшөөрөх эсэхийг тодорхойлохдоо УСНББОУС 9-ийг мөрдөнө.

МЗУ6. Эрх ба үүрэг (хөрөнгө, өр төлбөр) нь арилжааны бус орлогын ажил гүйлгээнээс үүсэж болно. Тухайлбал; байгууллага нь тодорхой үйл ажиллагааг гүйцэтгэхийн тулд олон талт тусламжийн агентлагаас мөнгө хүлээн авч болох юм. Тэдгээр үйл ажиллагааны гүйцэтгэл нь нөхцөлд захирагддаг тохиолдолд хөрөнгө, өр төлбөрийг нэгэн зэрэг хүлээн зөвшөөрнө. Хөрөнгө нь санхүүгийн хөрөнгө байх тохиолдолд түүнийг УСНББОУС 23-ын дагуу хүлээн зөвшөөрч, УСНББОУС 23 болон энэ Стандартын дагуу эхлээд хэмжинэ. Хөрөнгийн ашиглалтын хувьд тогтоосон нөхцлийн үр дүн байдлаар анх хүлээн зөвшөөрсөн өр төлбөр нь энэ Стандартын цар хүрээнд хамаарахгүй бөгөөд УСНББОУС 23-ын дагуу бүртгэнэ. УСНББОУС 23-ын дагуу өр төлбөр хүлээн зөвшөөрөлт нь цаашид тохиромжгүй гэдгийг анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа, нөхцөл байдал харуулж байвал байгууллага нь өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй эсэхийг энэ Стандартын дагуу авч үзнэ. Арилжааны бус орлогын ажил гүйлгээнээс үүсэж болох бусад өр төлбөр нь УСНББОУС 28-д заасан санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангаж байвал түүнийг энэ Стандартын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжинэ.

Тодорхойлолт

Үүсмэл хэрэглүүр

МЗУ7. Үүсмэл хэрэглүүрийн нийтлэг жишээ нь фьючерс, форвард, своп, опционы гэрээ юм. Үүсмэл хэрэглүүр нь ихэвчлэн нэрлэсэн дүнтэй байдаг. Энэ нь валютын дүн, хувьцааны тоо, жин, эзлэхүүн буюу гэрээнд тусгайлан заасан бусад нэгжийн тоо байна. Гэхдээ үүсмэл хэрэглүүр нь гэрээний эхэн дэх уг нэрлэсэн дүнгээр хөрөнгө оруулах буюу хүлээн авахыг эзэмшигч эсвэл гаргагчаас шаарддаггүй. Харин үүсмэл хэрэглүүр нь тогтмол дүнг эсвэл нэрлэсэн дүнтэй хамааралгүй ирээдүйн зарим үйл явдлын үр дүнд өөрчлөгдөж болох (гэхдээ суурь хэрэглүүрийн өөрчлөлттэй шууд хамааралгүй байдлаар) дүнг төлөхийг шаарддаг. Жишээлбэл; 6 сарын ЛИБОР хүү нь 100 суурь оноогоор нэмэгдвэл 1,000ТН-ийн тогтмол төлбөр хийхийг гэрээгээр шаарддаг байж болох юм. Хэдийгээр нэрлэсэн дүнг тусгайлан заагаагүй боловч ийм гэрээ нь үүсмэл хэрэглүүр болно.

МЗУ8. Энэ Стандарт дахь үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт нь суурь хэрэглүүрийг нийлүүлснээр нийт дүнгээр барагдуулах гэрээг (жишээлбэл; тогтмол хүүтэй өрийн хэрэглүүрийг худалдан авахын тулд байгуулсан форвард гэрээ) өөртөө агуулсан байдаг. Байгууллага цэвэр дүнгээр нь

мөнгөөр буюу бусад санхүүгийн хэрэглүүрээр барагдуулах, эсвэл санхүүгийн хэрэглүүрээр солилцож болох санхүүгийн бус зүйлийг худалдан авах буюу борлуулах гэрээтэй (жишээлбэл; бараа бүтээгдэхүүнийг тогтмол үнээр ирээдүйд худалдан авах буюу борлуулах гэрээтэй) байж болно. Тухайн байгууллагын хүлээгдэж буй худалдан авалт, борлуулалт буюу ашиглалтын шаардлагуудын дагуу санхүүгийн бус зүйлийг өгөх зорилгоор уг гэрээг байгуулсан ба тэр зорилгоор үргэлжлүүлэн эзэмшиж байгаагаас бусад тохиолдолд ийм гэрээ нь энэхүү Стандартын цар хүрээнд хамаарна. Харин байгууллага нь 6-р параграфын дагуу ангилсан бол тухайн байгууллагын хүлээгдэж буй худалдан авалт, борлуулалт буюу ашиглалтын шаардлагуудад зориулсан ийм гэрээний хувьд энэ Стандартыг дагаж мөрдөнө (5-8-р параграфыг үзнэ үү).

- МЗУ9. Үүсмэл хэрэглүүрийг тодорхойлох нэг шинж чанар нь зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөнд ижил төсөөтэй хариу үзүүлэхээр хүлээгдэж буй бусад төрлийн гэрээний хувьд шаардагдах байснаас бага хэмжээний анхны цэвэр хөрөнгө оруулалттай байдаг явдал юм. Опционы төлбөр нь уг опционтой холбоотой суурь санхүүгийн хэрэглүүрийг олж авахад шаардагдах хөрөнгө оруулалтаас бага дүнтэй байх тул опционы гэрээ нь энэ тодорхойлолтыг хангана. Тэнцүү бодит үнэ цэнэ бүхий өөр өөр валютын анхны арилжааг шаардах валютын своп нь тэг анхны цэвэр хөрөнгө оруулалттай байх учраас энэ тодорхойлолтыг хангана.
- МЗУ10. Ердийн нөхцөлтэй худалдан авалт буюу борлуулалт нь арилжааны өдөр ба барагдуулалтын өдрийн хооронд тогтмол үнийн баталгаа үүсэхэд хүргэдэг бөгөөд уг баталгаа нь үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолтыг хангадаг. Гэвч тэрхүү баталгааны үргэлжлэх хугацаа богино байдгаас хамааран түүнийг үүсмэл санхүүгийн хэрэглүүр гэж хүлээн зөвшөөрдөггүй. Харин ийм ердийн нөхцөлтэй гэрээний тусгай тайлагналыг энэхүү Стандартад заасан байдаг (11 болон МЗУ17-МЗУ20-р параграфыг үзнэ үү).
- МЗУ11. Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт нь уг гэрээний аль нэг талд тусгайлан хамаарахгүй санхүүгийн бус хувьсагчийн агуулсан байдаг. Ийм хувьсагчдад тодорхой бүс нутгийн газар хөдлөлтийн гарз хохирлын индекс, тодорхой нэг хотын агаарын хэмийн индекс хамаарна. Гэрээний аль нэг талд тусгайлан хамаарах санхүүгийн бус хувьсагчдад уг гэрээний талын хөрөнгийг сүйрүүлэх буюу хохирол учруулах гал түймрийн тохиолдол эсвэл үл тохиолдол хамаарна. Хэрэв бодит үнэ цэнэ нь санхүүгийн бус хөрөнгийн (санхүүгийн хувьсагчийн) зөвхөн зах зээлийн үнийн өөрчлөлт төдийгүй тухайн санхүүгийн бус хөрөнгийг эзэмших нөхцөл байдлыг (санхүүгийн бус хувьсагчийг) бас тусгадаг бол санхүүгийн бус хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт нь тэрхүү эзний хувьд тусгайлан хамаарах шинжтэй байна. Жишээлбэл; тодорхой нэг автомашины үлдэх үнэ цэнийн талаархи баталгаа нь тухайн автомашины биет нөхцөл байдлын өөрчлөлтийн эрсдлийг тэрхүү баталгаа гаргагчид хүлээлгэдэг бол уг үлдэх үнэ цэнийн өөрчлөлт нь автомашины эзний хувьд тусгайлан хамаарах шинжтэй байна.

Худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр

- МЗУ12. Худалдаа арилжаа нь ерөнхийдөө байнга, идэвхитэй хийгдэх худалдан авалт ба борлуулалтыг илэрхийлдэг бөгөөд худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хэрэглүүрийг үнийн богино хугацааны хэлбэлзэл буюу дилерийн ашиг олох зорилгоор ихэвчлэн ашигладаг.
- МЗУ13. Худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй санхүүгийн өр төлбөрт дараах зүйлс хамаарна:
- Хейжийн хэрэглүүр гэж тайлагнаагүй үүсмэл өр төлбөр;
 - Зээлээр авсан санхүүгийн хөрөнгөө үнэ буурна гэсэн хүлээлттэй байгаа тул борлуулсан ба тэрхүү хөрөнгийг буцаан өгөх үүрэг (өөрөөр хэлбэл, байгууллага нь зээлээр авсан ба өөрөө өмчилдөггүй санхүүгийн хөрөнгөө борлуулсан);
 - Ойрын хугацаанд буцаан худалдаж авах удирдлагын загварын дагуу гаргасан санхүүгийн өр төлбөр (жишээлбэл; гаргагч нь түүний бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс хамааран ойрын хугацаанд буцаан худалдан авч болох идэвхитэй арилжаалагддаг өрийн хэрэглүүр); ба

- (г) Хамтад нь удирдан зохицуулдаг, тодорхойлсон санхүүгийн хэрэглүүрүүдийн багцын нэг хэсэг бөгөөд богино хугацааны ашиг олж байсан сүүлийн үеийн тохиолдлын талаархи нотолгоо бүхий санхүүгийн өр төлбөр.

МЗУ14. Худалдаа арилжааны үйл ажиллагааг санхүүжүүлэхийн тулд уг өр төлбөрийг ашигладаг байдал нь тэрхүү өр төлбөрийг худалдаа арилжааны зорилгоор эзэмшдэг гэдгийг дангаараа илэрхийлэхгүй.

Хүлээн зөвшөөрөлт ба үл хүлээн зөвшөөрөлт

Анхны хүлээн зөвшөөрөлт

МЗУ15. 10-р параграфт заасан зарчмын үр дүнд, байгууллага нь санхүүгийн хөрөнгийн шилжүүлэлтийг борлуулалт гэж тайлагнахыг хориглодог үүсмэл хэрэглүүрээс (МЗУ35-р параграфыг үзнэ үү) бусад, үүсмэл хэрэглүүрийн хувьд гэрээний бүх эрх ба үүргээ өөрийн санхүүгийн байдлын тайландаа хөрөнгө, өр төлбөр гэж тус тус хүлээн зөвшөөрнө. Хэрэв санхүүгийн хөрөнгийн шилжүүлэлт нь үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангахгүй бол шилжүүлэн авагч нь уг шилжүүлсэн хөрөнгийг өөрийнхөө хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөхгүй (МЗУ36-р параграфыг үзнэ үү).

МЗУ16. 10-р параграфт заасан зарчмыг мөрдөх жишээг доор харуулав:

- (а) Байгууллага нь гэрээний нэг тал болсон, ингэснээр мөнгө хүлээн авах хууль ёсны эрхтэй эсвэл мөнгө төлөх хууль ёсны үүрэгтэй болсон тохиолдолд нөхцөлт бус авлага, өглөгийг хөрөнгө эсвэл өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө.
- (б) Бараа, үйлчилгээг худалдан авах эсвэл борлуулах арилжааны баталгааны үр дүнд олж эзэмших хөрөнгө ба хариуцах өр төлбөрийг, хамгийн наад зах нь талуудын нэг нь тухайн гэрээний дагуу үүргээ гүйцэтгэх хүртэл ерөнхийдөө хүлээн зөвшөөрдөггүй. Жишээлбэл; үл цуцлагдах захиалга хүлээн авсан байгууллага нь уг баталгаат захиалгын өдөр ерөнхийдөө хөрөнгө хүлээн зөвшөөрөхгүй (мөн захиалга өгсөн байгууллага нь өр төлбөр хүлээн зөвшөөрөхгүй), харин тухайн захиалсан барааг ачуулж, хүргэх буюу үйлчилгээг үзүүлэх хүртэл хүлээн зөвшөөрөлтийг хойшлуулна. Хэрэв санхүүгийн бус зүйлсийг худалдан авах буюу борлуулах арилжааны баталгаа нь 5-8-р параграфын дагуу энэ Стандартын цар хүрээнд хамаарах бол түүний цэвэр бодит үнэ цэнийг уг баталгааны өдрөөр хөрөнгө эсвэл өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө (МЗУ92(в) параграфыг үзнэ үү). Түүнчлэн, өмнө нь хүлээн зөвшөөрөгүй байсан арилжааны баталгааг бодит үнэ цэнийн хейжид хейжийн зүйл гэж сонгосон бол уг хейж хийсэн эрсдэлд хамаарах цэвэр бодит үнэ цэнийн аливаа өөрчлөлтийг тухайн хейжийн эхлэлээс хойш хөрөнгө эсвэл өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө (137(б) болон 138-р параграфыг үзнэ үү).
- (в) Энэ Стандартын цар хүрээнд хамаарах (2-р параграфыг үзнэ үү) форвард гэрээг түүний барагдуулалт хийгдсэн өдөр биш, харин баталгаат өдөр хөрөнгө эсвэл өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө. Байгууллага нь форвард гэрээний нэг тал болсон тохиолдолд эрх ба үүргийн бодит үнэ цэнэ нь ямагт тэнцүү, ингэснээр форвард гэрээний цэвэр бодит үнэ цэнэ нь тэг байдаг. Хэрэв эрх ба үүргийн цэвэр бодит үнэ цэнэ нь тэг биш бол уг гэрээг хөрөнгө эсвэл өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө.
- (г) Эзэмшигч эсвэл гаргагч нь тухайн опционы гэрээний аль нэг тал болсон тохиолдолд энэ Стандартын цар хүрээнд хамаарах (2-р параграфыг үзнэ үү) опционы гэрээг хөрөнгө эсвэл өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө.
- (д) Байгууллага нь гэрээний аль нэг тал болохгүй тул төлөвлөсөн ирээдүйн ажил гүйлгээ нь хэрэгжих хэр өндөр магадлалтай гэдгээс үл хамааран хөрөнгө эсвэл өр төлбөр биш юм.

Санхүүгийн хөрөнгийн ердийн нөхцөлтэй худалдан авалт буюу борлуулалт


МЗУ17. Санхүүгийн хөрөнгийн ердийн нөхцөлтэй худалдан авалт буюу борлуулалтыг МЗУ19 ба МЗУ20-р параграфт заасан, арилжааны өдрийн нягтлан бодох бүртгэл эсвэл барагдуулалтын

өдрийн нягтлан бодох бүртгэлийн аль нэгийг ашигласнаар хүлээн зөвшөөрнө. Байгууллага нь энэ Стандартын дагуу нэг ижил арга замаар ангилсан санхүүгийн хөрөнгийн бүх худалдан авалт ба борлуулалтын хувьд нэг аргыг тууштай мөрдөнө. Энэ зорилгын хувьд, ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр зайлшгүй хэмждэг хөрөнгө нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан хөрөнгөөс тусдаа ангилал болох юм. Түүнчлэн, 106-р параграфт заасан сонголтыг ашигласнаар тайлагнадаг өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт нь тусдаа ангилал болно.

- МЗУ18. Гэрээний үнэ цэнийн өөрчлөлтийг цэвэр дүнгээр барагдуулахыг шаарддаг буюу зөвшөөрдөг гэрээ нь ердийн нөхцөлд хамаарахгүй. Харин ийм гэрээг арилжааны өдөр ба барагдуулалтын өдрийн хоорондох хугацаанд үүсмэл хэрэглүүр гэж тайлагнана.
- МЗУ19. Арилжааны өдөр гэдэг нь байгууллага хөрөнгийг худалдан авах эсвэл борлуулах хариуцлагыг өөрөө хүлээсэн өдөр юм. Арилжааны өдрийн нягтлан бодох бүртгэл нь дараах зүйлсэд хамаарна: (а) уг арилжааны өдрөөр хүлээн авах хөрөнгө ба түүний хувьд төлөх өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт, (б) тухайн арилжааны өдрөөрх борлуулсан хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлт, данснаас хасалтын аливаа олз буюу гарзны хүлээн зөвшөөрөлт, төлбөрийн хувьд худалдан авагчаас авах авлагын хүлээн зөвшөөрөлт. Эрх шилжих уг барагдуулалтын өдөр хүртэл хөрөнгө, түүнчлэн холбогдох өр төлбөрийн хувьд хүүг ерөнхийдөө хуримтлуулж эхлэхгүй.
- МЗУ20. Барагдуулалтын өдөр гэдэг нь байгууллага хөрөнгийг хүргэн нийлүүлэх эсвэл хүлээн авах өдөр юм. Барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэл нь дараах зүйлсэд хамаарна: (а) байгууллага хүлээн авсан өдөр хөрөнгийг хүлээн зөвшөөрөлт, (б) байгууллага хүргэн нийлүүлсэн өдөр хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөлт, данснаас хасалтын аливаа олз буюу гарзны хүлээн зөвшөөрөлт. Барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэх тохиолдолд байгууллага нь уг арилжааны өдөр ба барагдуулалтын өдрийн хоорондох хугацаанд хүлээн авах хөрөнгийн бодит үнэ цэнийн аливаа өөрчлөлтийг тухайн олж эзэмшсэн хөрөнгийг тайлагнахтай ижил арга замаар тайлагнана. Өөрөөр хэлбэл, хорогдуулсан өртгөөр хэмжсэн хөрөнгийн хувьд үнэ цэнийн өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөхгүй; ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө гэж ангилсан хөрөнгийн хувьд үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө; 41-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө болон 106-р параграфын дагуу тайлагнасан өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтын хувьд үнэ цэнийн өөрчлөлтийг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлт

МЗУ21. Санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх эсэх, ямар хэмжээгээр үл хүлээн зөвшөөрөх талаархи үнэлгээг дараах блок схемд үлгэрчлэн харуулсан.



Байгууллага нь санхүүгийн хөрөнгөөс үүсэх мөнгөн гүйлгээг хүлээн авах гэрээний эрхийг хадгалан үлдэх боловч нэг буюу хэд хэдэн хүлээн авагч талуудад уг мөнгөн гүйлгээг төлөх гэрээний үүргийг хүлээдэг хэлцэл (15(б) параграф)

- МЗУ22. Тухайлбал; байгууллага нь итгэлцлийн сан бөгөөд өөрийн эзэмшдэг уг суурь санхүүгийн хөрөнгө дэх жинхэнэ хувь оролцоог хөрөнгө оруулагчдад санал болгон гаргах ба өөрөө тэдгээр санхүүгийн хөрөнгөнд үйлчилгээ үзүүлдэг тохиолдолд 15(б) параграфт дурдсан нөхцөл байдал үүснэ (байгууллага нь санхүүгийн хөрөнгөөс үүсэх мөнгөн гүйлгээг хүлээн авах гэрээний эрхийг хадгалан үлдэх боловч нэг буюу хэд хэдэн хүлээн авагч талуудад уг мөнгөн гүйлгээг төлөх гэрээний үүргийг хүлээнэ). Энэ тохиолдолд хэрэв 16 ба 17-р параграфт заасан нөхцөл биелвэл уг санхүүгийн хөрөнгө нь үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангах юм.
- МЗУ23. 16-р параграфыг мөрдөх үед байгууллага нь жишээлбэл; санхүүгийн хөрөнгийг үүсгэн бий болгогч эсвэл уг санхүүгийн хөрөнгийг олж эзэмшсэн бөгөөд түүний мөнгөн гүйлгээг харилцан хамааралгүй гуравдагч тал болох хөрөнгө оруулагчдад дамжуулан өгдөг хяналтанд буй байгууллагыг өөртөө агуулсан эдийн засгийн нэгдмэл байгууллага байж болно.

Өмчлөлтэй холбоотой эрсдэл ба өгөөжийн шилжүүлэлтийн үнэлгээ (17-р параграф)

- МЗУ24. Байгууллага нь өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн жишээ:
- (а) Санхүүгийн хөрөнгийн нөхцөлт бус борлуулалт;
 - (б) Санхүүгийн хөрөнгийг буцаан авах тэр үеийн бодит үнэ цэнээр түүнийг буцаан худалдан авах опционы хамтаар уг санхүүгийн хөрөнгийг борлуулах; ба
 - (в) Санхүүгийн хөрөнгийг их мөнгөн алдагдалтай буцаах опцион эсвэл дуудах опционы хамтаар борлуулах (өөрөө хэлбэл, одоогоор мөнгөн алдагдалтай байгаа опцион нь түүний хугацаа дуусахаас өмнө мөнгөн ашигтай болох магадлал маш бага байх).
- МЗУ25. Байгууллага нь өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалан үлдсэн жишээ:
- (а) Буцаан худалдан авах үнэ нь тогтмол дүн, эсвэл борлуулалтын үнэ дээр зээлдүүлэгчийн өгөөжийг нэмсэн дүн байх тийм тохиолдол дахь борлуулалт ба буцаан худалдан авалтын ажил гүйлгээ;
 - (б) Үнэт цаасыг зээлдүүлэх хэлцэл;
 - (в) Зах зээлийн эрсдлийг тухайн байгууллагад буцаан шилжүүлдэг тийм нийт өгөөжийн свопын хамтаар санхүүгийн хөрөнгийг борлуулах;
 - (г) Санхүүгийн хөрөнгийг их мөнгөн ашигтай буцаах опцион эсвэл дуудах опционы хамтаар борлуулах (өөрөөр хэлбэл, одоогоор мөнгөн ашигтай байгаа опцион нь түүний хугацаа дуусахаас өмнө мөнгөн алдагдалтай болох магадлал маш бага байх); ба
 - (д) Байгууллага нь тохиолдох магадлалтай зээлийн алдагдлын хувьд тухайн шилжүүлэн авагчид нөхөн төлбөр олгох баталгаа гаргаснаар уг богино хугацаат авлагыг борлуулах.
- МЗУ26. Шилжүүлэлтийн үр дүнд байгууллага нь уг шилжүүлсэн хөрөнгийн өмчлөлтэй холбоотой бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн гэж үзсэн бол тухайн байгууллага нь тэрхүү шилжүүлсэн хөрөнгийг өөр шинэ ажил гүйлгээгээр буцаан олж эзэмшихээс бусад тохиолдолд шилжүүлсэн хөрөнгийг ирээдүйн тайлант үеүдэд хүлээн зөвшөөрөхгүй.

Хяналтын шилжүүлэлтийн үнэлгээ

- МЗУ27. Хэрэв шилжүүлэн авагч нь уг шилжүүлсэн хөрөнгийг борлуулах практик боломжтой бол байгууллага нь тухайн шилжүүлсэн хөрөнгийн хувьд хяналтыг хадгалж үлдэхгүй. Харин шилжүүлэн авагч нь уг шилжүүлсэн хөрөнгийг борлуулах практик боломжгүй бол байгууллага нь тухайн шилжүүлсэн хөрөнгийн хувьд хяналтыг хадгалж үлдэнэ. Хэрэв шилжүүлсэн хөрөнгийг идэвхитэй зах зээлд арилждаг бол шилжүүлэн авагч нь тухайн хөрөнгийг байгууллагад буцаан өгөх шаардлагатай болсон үед түүнийг зах зээлээс буцаан худалдан авч

чадах учраас уг шилжүүлэн авагч нь тухайн шилжүүлсэн хөрөнгийг борлуулах практик боломжтой байна. Жишээлбэл; шилжүүлсэн хөрөнгө нь түүнийг буцаан худалдан авах боломжийг байгууллагад олгодог опционд хамаардаг боловч тухайн шилжүүлэн авагч нь опционыг хэрэгжүүлсэн үед уг шилжүүлсэн хөрөнгийг зах зээлээс шууд олж авах боломжтой бол шилжүүлэн авагч нь тэрхүү шилжүүлсэн хөрөнгийг борлуулах практик боломжтой байж болох юм. Харин байгууллага нь ийм опционыг өөртөө хадгалж үлдсэн бөгөөд түүнийг хэрэгжүүлэх үед уг шилжүүлэн авагч нь тухайн хөрөнгийг зах зээлээс шууд олж авч чадахгүй бол шилжүүлэн авагч нь тэрхүү шилжүүлсэн хөрөнгийг борлуулах практик боломжгүй байна.

МЗУ28. Шилжүүлэн авагч нь уг шилжүүлсэн хөрөнгийг харилцан хамааралгүй гуравдагч этгээдэд бүхэлд нь борлуулах боломжтой бөгөөд тэрхүү боломжоо өөрийн нэг талын санаачлагаар болон тухайн шилжүүлэлтийн хувьд нэмэлт хязгаарлалт тавихгүйгээр хэрэгжүүлэх чадвартай зөвхөн тийм тохиолдолд шилжүүлэн авагч нь уг шилжүүлсэн хөрөнгийг борлуулах практик боломжтой байна. Шилжүүлэн авагч нь уг шилжүүлсэн хөрөнгийн хувьд юу хийж болох талаархи гэрээний эрх эсвэл гэрээний ямар хязгаарлалт байгаа эсэх биш, харин тухайн шилжүүлэн авагч нь практикт юу хийх боломжтой гэдэг нь гол асуудал юм. Тухайлбал:

- (а) Шилжүүлсэн хөрөнгийн хувьд зах зээл байхгүй бол уг шилжүүлсэн хөрөнгийг данснаас хасах талаархи гэрээний эрх нь практик үр нөлөө багатай байна;
- (б) Шилжүүлсэн хөрөнгийг данснаас хасах боломжийг хэрэв чөлөөтэй хэрэгжүүлж чадахгүй бол практик үр нөлөө багатай байна. Ийм учраас:
 - (i) Шилжүүлсэн хөрөнгийг данснаас хасах уг шилжүүлэн авагчийн боломж нь бусдын үйл ажиллагаанаас хараат бус байх ёстой (өөрөөр хэлбэл, үүнийг нэг талын санаачлагаар хэрэгжүүлэх боломжтой байх ёстой); ба
 - (ii) Шилжүүлэн авагч нь тухайн шилжүүлэлтийн хувьд хязгаарлах нөхцөл тавих буюу ‘албадан хүчлэх’ шаардлагагүйгээр (жишээ нь; зээлийн хөрөнгөнд хэрхэн үйлчилгээ үзүүлэх талаархи нөхцөл эсвэл уг хөрөнгийг буцаан худалдан авах эрхийг тухайн шилжүүлэн авагчид олгох опцион) уг шилжүүлсэн хөрөнгийг данснаас хасах боломжтой байх ёстой.

МЗУ29. Уг шилжүүлсэн хөрөнгийг тухайн шилжүүлэн авагч борлуулах магадлалгүй байх нь шилжүүлэгч тэрхүү шилжүүлсэн хөрөнгийн хяналтыг хадгалж үлдсэн гэсэн утгыг дангаараа илэрхийлэхгүй юм. Харин буцаах опцион эсвэл баталгаа нь уг шилжүүлсэн хөрөнгийг тухайн шилжүүлэн авагч борлуулахад саад учруулж байвал шилжүүлэн авагч нь тэрхүү шилжүүлсэн хөрөнгийн хяналтыг хадгалж үлдсэн гэсэн үг юм. Жишээлбэл; буцаах опцион эсвэл баталгаа нь мэдэгдэхүйц үнэ цэнэтэй бол шилжүүлэн авагч нь үүнтэй ижил төсөөтэй опцион буюу бусад хязгаарлах нөхцөлтэйгээр уг шилжүүлсэн хөрөнгийг гуравдагч этгээдэд борлуулах практик боломжгүй учраас тэрхүү опцион эсвэл баталгаа нь тухайн шилжүүлсэн хөрөнгийг шилжүүлэн авагч борлуулахад саад учруулна. Харин шилжүүлэн авагч нь тухайн баталгаа буюу буцаах опционы дагуу төлбөрийг хүлээн авахын тулд уг шилжүүлсэн хөрөнгийг эзэмшсэн хэвээр байх юм. Ийм нөхцөлд шилжүүлэгч нь уг шилжүүлсэн хөрөнгийн хяналтыг өөртөө хадгалж үлдэнэ.

Үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангах шилжүүлэлт

МЗУ30. Байгууллага нь уг шилжүүлсэн хөрөнгийн хувьд төлөгдөх хүүний төлбөрийн зарим хэсгийг тэрхүү хөрөнгөнд үзүүлэх үйлчилгээний төлбөр байдлаар авах эрхийг хадгалан үлдэж болох юм. Үйлчилгээний гэрээг дуусгавар болгох буюу шилжүүлснээр байгууллагын өгөх уг хүүний төлбөрийн зарим хэсгийг тухайн үйлчилгээний хөрөнгө буюу үйлчилгээний өр төлбөрт хуваарилна. Байгууллага буцаан өгөхгүй хүүний төлбөрийн хэсэг нь зөвхөн хүүний СТРИПС-ийн авлага юм. Жишээлбэл; байгууллага нь үйлчилгээний гэрээг дуусгавар болгох буюу шилжүүлснээр ямар ч хүүг өгөхгүй бол нийт хүүний тархалт нь зөвхөн хүүний СТРИПС авлага болно. 24-р параграфыг мөрдөх зорилгын хувьд, тухайн үйлчилгээний хөрөнгийн үл хүлээн зөвшөөрсөн хэсэг ба хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа хэсэгт уг авлагын дансны үнийг хуваарилахын тулд тэрхүү үйлчилгээний хөрөнгийн бодит үнэ цэнэ болон зөвхөн хүүний СТРИПС-ийн авлагыг ашигладаг. Үйлчилгээний хураамжийг тусгайлан заагаагүй эсвэл хүлээн

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

авах үйлчилгээний хураамж нь үзүүлсэн үйлчилгээний хувьд тухайн байгууллагад зохих нөхөн төлбөр болж чадахааргүй бол тэрхүү үйлчилгээний үүргийн хувьд өр төлбөрийг түүний бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрнө.

МЗУ31. 24-р параграфыг мөрдөх зорилгын хувьд хүлээн зөвшөөрсөн хэвээр байх хэсэг болон үл хүлээн зөвшөөрөх хэсгийн бодит үнэ цэнийг хэмжихдээ, байгууллага нь 66-68, МЗУ144-МЗУ155-р параграф дахь бодит үнэ цэнийн хэмжилтийн шаардлагуудыг мөрдөнө.

Үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангахгүй шилжүүлэлт

МЗУ32. 26-р параграфт дурдсан зарчмыг хэрхэн мөрдөхийг доор илэрхийлсэн. Шилжүүлсэн хөрөнгийн үл биелүүлэлтийн алдагдлын хувьд байгууллагын гаргасан баталгаа нь уг шилжүүлсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхөд саад учруулж байвал тухайн байгууллага нь шилжүүлсэн хөрөнгийн өмчлөлтэй холбоотой бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалан үлдэх учраас тэрхүү шилжүүлсэн хөрөнгийг бүхэлд нь хүлээн зөвшөөрсөн хэвээр байх бөгөөд хүлээн авсан төлбөрийг өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө.

Онцгой бүрэн эрхээс үүсэх ирээдүйн гүйлгээний борлуулалт

МЗУ33. Улсын секторын хувьд, үнэт цаасжуулалтын схем нь татвар ногдуулах эрх гэх мэт өмнө нь хөрөнгө гэж хүлээн зөвшөөрдөггүй байсан онцгой бүрэн эрхээс үүсэх ирээдүйн гүйлгээний борлуулалтыг агуулсан байж болох юм. Байгууллага нь ийм гүйлгээнээс бий болох орлогыг холбогдох орлогын стандартын (УСНББОУС 9 ба УСНББОУС 23-ыг үзнэ үү) дагуу хүлээн зөвшөөрнө. Ийм ажил гүйлгээ нь УСНББОУС 28-д тодорхойлсон, санхүүгийн өр төлбөр үүсэхэд хүргэж болох юм. Ийм санхүүгийн өр төлбөрийн жишээнд зээллэг, санхүүгийн баталгаа, үйлчилгээний буюу захиргаа удирдлагын гэрээнээс үүсэх өр төлбөр, худалдан авагч байгууллагын нэрийн өмнөөс цуглуулсан мөнгөтэй холбоотой өглөг хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй. Байгууллага нь хэрэглүүрийн гэрээний нөхцлийн оролцогч нэг тал болсон тохиолдолд санхүүгийн өр төлбөрийг 10-р параграфын хүлээн зөвшөөрч, 45 ба 46-р параграфын дагуу ангилдаг. Санхүүгийн өр төлбөрийг 57-р параграфын дагуу анх хүлээн зөвшөөрч, дараа нь, 62 ба 63-р параграфын дагуу хэмждэг.

Шилжүүлсэн хөрөнгө дэх цаашдын оролцоо

МЗУ34. Байгууллага нь шилжүүлсэн хөрөнгө ба холбогдох өр төлбөрийг 27-р параграфын дагуу хэрхэн хэмжих жишээг доор харуулав.

Бүх хөрөнгө

(а) Шилжүүлсэн хөрөнгийн үл биелүүлэлтийн алдагдлыг төлөхөөр байгууллагын гаргасан баталгаа нь уг шилжүүлсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхөд түүний цаашдын оролцооны хэмжээгээр саад учруулж байвал тэрхүү шилжүүлсэн хөрөнгийг тухайн шилжүүлэлтийн өдөр дараах дүнгүүдийн аль багаар хэмжинэ: (i) хөрөнгийн дансны үнэ, ба (ii) тухайн шилжүүлэлтээр хүлээн авсан төлбөрөөс буцаан төлөхийг уг байгууллагаас шаардаж болох хамгийн их дүн (“баталгааны дүн”). Баталгааны дүн дээр уг баталгааны бодит үнэ цэнийг (энэ нь ихэвчлэн уг баталгааны төлөө хүлээн авсан төлбөр байдаг) нэмсэн дүнгээр холбогдох өр төлбөрийг анх хэмждэг. Үүргийг биелүүлэх (УСНББОУС 9-ийг үзнэ үү) ба аливаа гарзны хасагдуулгаар тухайн хөрөнгийн дансны үнийг бууруулахын хэрээр уг баталгааны анхны бодит үнэ цэнийг дараагийн тайлант үеүдэд ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Хорогдуулсан өртгөөр хэмжсэн хөрөнгө

(б) Байгууллагын гаргасан буцаах опционы үүрэг эсвэл байгууллагын эзэмшиж буй дуудах опционы эрх нь шилжүүлсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхөөс сэргийлдэг бөгөөд байгууллага нь шилжүүлсэн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр хэмждэг бол холбогдох өр төлбөрийг түүний өртгөөр (өөрөөр хэлбэл, хүлээн авсан төлбөрийн дүнгээр) хэмжиж, тэрхүү өртөг ба опционы хугацаа дуусах өдрөөрх тухайн шилжүүлсэн хөрөнгийн нийт

дансны үнэ хоорондох аливаа зөрүү болох хорогдуулгын хувьд уг өр төлбөрийн дансны үнийг тохируулна. Жишээлбэл; шилжүүлсэн өдөр уг хөрөнгийн нийт дансны үнэ нь 98ТН, хүлээн авсан төлбөр нь 95ТН байсан гэж үзье. Опционыг хэрэгжүүлэх өдөр тухайн хөрөнгийн нийт дансны үнэ нь 100ТН болно. Холбогдох өр төлбөрийн анхны дансны үнэ 95ТН бөгөөд тэрхүү 95ТН ба 100ТН-ийн хоорондох зөрүүг үр ашигт хүүний арга ашиглан ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Хэрэв опционыг хэрэгжүүлвэл холбогдох өр төлбөрийн дансны үнэ ба хэрэгжүүлэх үнийн хоорондох аливаа зөрүүг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгө

- (в) Хэрэв байгууллагын хадгалан үлдсэн, дуудах опционы эрх нь шилжүүлсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхөөс сэргийлдэг бөгөөд байгууллага нь шилжүүлсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмждэг бол тухайн хөрөнгийг түүний бодит үнэ цэнээр хэмжсэн хэвээр байна. Холбогдох өр төлбөрийг (i) хэрэв опцион нь мөнгөн ашигтай эсвэл мөнгөн ашиггүй бол уг опционы хэрэгжүүлэх үнээс түүний цаг хугацааны үнэ цэнийг хассан дүнгээр, эсвэл (ii) хэрэв опцион нь мөнгөн алдагдалтай бол уг шилжүүлсэн хөрөнгийн бодит үнэ цэнээс тухайн опционы цаг хугацааны үнэ цэнийг хассан дүнгээр хэмжинэ. Холбогдох өр төлбөрийн ийм хэмжилтэнд тохируулга хийснээр тухайн хөрөнгө болон холбогдох өр төлбөрийн цэвэр дансны үнэ нь уг дуудах опционы эрхийн бодит үнэ цэнэтэй тэнцүү гэдгийг ханган магадалдаг. Жишээлбэл; суурь хөрөнгийн бодит үнэ цэнэ 80ТН, опционыг хэрэгжүүлэх үнэ 95ТН, опционы цаг хугацааны үнэ цэнэ 5ТН бол холбогдох өр төлбөрийн дансны үнэ нь 75ТН (80ТН - 5ТН), уг шилжүүлсэн хөрөнгийн дансны үнэ 80ТН (өөрөөр хэлбэл, түүний бодит үнэ цэнэ) болно.
- (г) Байгууллагын гаргасан буцаах опцион нь шилжүүлсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхөөс сэргийлдэг бөгөөд байгууллага нь уг шилжүүлсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмждэг бол холбогдох өр төлбөрийг тухайн опционы хэрэгжүүлэх үнэ дээр түүний цаг хугацааны үнэ цэнийг нэмсэн дүнгээр хэмжинэ. Байгууллага нь уг шилжүүлсэн хөрөнгийн бодит үнэ цэнийг опционы хэрэгжүүлэх үнээс илүү болгон өсгөх эрхгүй учраас тэрхүү хөрөнгийн бодит үнэ цэнээр хэмжилт нь уг бодит үнэ цэнэ ба опционы хэрэгжүүлэх үнийн аль багаар хязгаарлагдана. Ингэснээр тухайн хөрөнгө болон холбогдох өр төлбөрийн цэвэр дансны үнэ нь уг буцаах опционы үүргийн бодит үнэ цэнэтэй тэнцүү гэдгийг ханган магадалдаг. Жишээлбэл; хэрэв суурь хөрөнгийн бодит үнэ цэнэ 120ТН, опционы хэрэгжүүлэх үнэ 100ТН, уг опционы цаг хугацааны үнэ цэнэ 5ТН бол холбогдох өр төлбөрийн дансны үнэ нь 105ТН (100ТН+5ТН) ба тухайн хөрөнгийн дансны үнэ 100ТН (энэ тохиолдолд опционы хэрэгжүүлэх үнэтэй тэнцүү) байна.
- (д) Худалдан авсан дуудах опцион ба гаргасан буцаах опцион хэлбэртэй байгаа үнийн баталгаа нь шилжүүлсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхөөс сэргийлдэг бөгөөд байгууллага нь уг хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмждэг бол тухайн байгууллага нь тэрхүү шилжүүлсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмжсэн хэвээр байна. Холбогдох өр төлбөрийг (i) хэрэв дуудах опцион нь мөнгөн ашигтай эсвэл ашиггүй бол дуудах опционы хэрэгжүүлэх үнэ ба буцаах опционы бодит үнэ цэнийн нийлбэрээс уг дуудах опционы цаг хугацааны үнэ цэнийг хассан дүнгээр, эсвэл (ii) хэрэв дуудах опцион нь мөнгөн алдагдалтай бол тухайн хөрөнгийн бодит үнэ цэнэ ба буцаах опционы бодит үнэ цэнийн нийлбэрээс уг дуудах опционы цаг хугацааны үнэ цэнийг хассан дүнгээр хэмжинэ. Холбогдох өр төлбөрт тохируулга хийснээр тухайн хөрөнгө ба холбогдох өр төлбөрийн цэвэр дансны үнэ нь уг байгууллагын эзэмшиж байгаа болон гаргасан опционуудын бодит үнэ цэнэтэй тэнцүү гэдгийг ханган магадалдаг. Жишээлбэл; байгууллага нь бодит үнэ цэнээр хэмждэг санхүүгийн хөрөнгөө шилжүүлэхийн хамтаар, үүнтэй нэгэн зэрэг 120ТН-ийн хэрэгжүүлэх үнэ бүхий дуудах опционыг худалдан авч, 80ТН-ийн хэрэгжүүлэх үнэ бүхий буцаах опционыг гаргасан гэж үзье. Мөн тухайн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь энэхүү шилжүүлэлтийн өдөр 100ТН байсан. Буцаах ба дуудах опционы цаг хугацааны үнэ цэнэ нь харгалзан 1ТН ба 5ТН байсан. Энэ тохиолдолд байгууллага нь хөрөнгийг 100ТН-ээр (тухайн хөрөнгийн бодит үнэ цэнээр), өр төлбөрийг 96ТН-ээр

$[(100\text{ТН} + 1\text{ТН}) - 5\text{ТН}]$ хүлээн зөвшөөрнө. Ингэснээр цэвэр хөрөнгийн үнэ цэнэ нь 4ТН болох бөгөөд энэ нь тухайн байгууллагын эзэмшиж байгаа болон гаргасан опционуудын бодит үнэ цэнэтэй тэнцүү болно.

Бүх шилжүүлэлт

- МЗУ35. Шилжүүлэлтээр үүсэж буй шилжүүлсэн хөрөнгө, өр төлбөр ба тухайн шилжүүлэлттэй холбоотой шилжүүлэгчийн гэрээний эрх, үүргийн аль алиныг хүлээн зөвшөөрснөөр нэг эрх, үүргийг хоёр удаа хүлээн зөвшөөрөхөд хүргэхээр байвал тэрхүү санхүүгийн хөрөнгийн шилжүүлэлт нь үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангахгүй байх хэмжээгээр уг шилжүүлэгчийн гэрээний эрх, үүргийг үүсмэл хэрэглүүр гэж тусад нь тайлагнахгүй. Жишээлбэл; шилжүүлэгчийн хадгалан үлдсэн дуудах опцион нь тухайн санхүүгийн хөрөнгийн шилжүүлэлтийг борлуулалт гэж тайлагнахаас сэргийлдэг байж болох юм. Энэ тохиолдолд уг дуудах опционыг үүсмэл хөрөнгө гэж тусад нь хүлээн зөвшөөрөхгүй.
- МЗУ36. Санхүүгийн хөрөнгийн шилжүүлэлт нь үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангахгүй байх хэмжээгээр уг шилжүүлэн авагч нь тухайн шилжүүлсэн хөрөнгийг өөрийнхөө хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөхгүй. Шилжүүлэн авагч нь төлсөн мөнгө буюу бусад төлбөрийг үл хүлээн зөвшөөрөх ба шилжүүлэгчээс авах авлагыг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Хэрэв шилжүүлэгч нь тухайн шилжүүлсэн бүх хөрөнгийн хяналтыг тогтмол дүнгээр (буцаан худалдан авах хэлцлийн дагуу гэх мэт) буцаан олж эзэмших эрх, үүргийн аль алиныг хадгалдаг бол шилжүүлэн авагч нь 40-р параграфт заасан шалгуур хангагдсан тохиолдолд өөрийн авлагыг хорогдуулсан өртгөөр хэмжиж болох юм.

Жишээ

- МЗУ37. Энэ Стандартын үл хүлээн зөвшөөрөлтийн зарчмуудын мөрдөлтийг дараах жишээнд үлгэрчлэн харуулав.
- (а) Буцаан худалдан авах хэлцэл ба үнэт цаасны зээлдүүлэлт. Хэрэв санхүүгийн хөрөнгийг тогтмол үнээр эсвэл борлуулалтын үнэ дээр зээлдүүлэгчийн өгөөжийг нэмсэн дүнгээр буцаан худалдан авах хэлцлийн дагуу борлуулсан эсвэл тухайн шилжүүлэгчид түүнийг буцаан өгөх хэлцлийн дагуу зээлдүүлсэн бол уг шилжүүлэгч нь өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалан үлдэх учраас санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхгүй. Хэрэв шилжүүлэн авагч нь тухайн хөрөнгийг борлуулах буюу барьцаалах эрхтэй бол шилжүүлэгч нь уг хөрөнгийг санхүүгийн байдлын тайландаа тухайлбал, зээлсэн хөрөнгө эсвэл буцаан худалдан авах авлага гэж дахин ангилна.
- (б) Буцаан худалдан авах хэлцэл ба үнэт цаасны зээлдүүлэлт – бараг ижил хөрөнгүүд. Хэрэв санхүүгийн хөрөнгөтэй ижил буюу бараг ижил хөрөнгийг тогтмол үнээр эсвэл борлуулалтын үнэ дээр зээлдүүлэгчийн өгөөжийг нэмсэн дүнгээр буцаан худалдан авах хэлцлийн дагуу санхүүгийн хөрөнгийг борлуулсан эсвэл тухайн шилжүүлэгчид ижил буюу бараг ижил хөрөнгийг буцаан өгөх хэлцлийн дагуу санхүүгийн хөрөнгийг зээлдсэн буюу зээлдүүлсэн бол уг шилжүүлэгч нь өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалан үлдэх учраас санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхгүй.
- (в) Буцаан худалдан авах хэлцэл ба үнэт цаасны зээлдүүлэлт – орлуулалтын эрх. Хэрэв тогтмол үнээр эсвэл борлуулалтын үнэ дээр зээлдүүлэгчийн өгөөжийг нэмсэн дүнгээр буцаан худалдан авах хэлцэл эсвэл үүнтэй ижил төсөөтэй үнэт цаасны зээлдүүлэх ажил гүйлгээ нь уг шилжүүлсэн хөрөнгөтэй ижил төсөөтэй бөгөөд тэнцүү бодит үнэ цэнэ бүхий хөрөнгийг тухайн буцаан худалдан авах өдөр орлуулан өгөх эрхийг уг шилжүүлэн авагчид олгодог бол шилжүүлэгч нь өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалан үлдэх учраас тэрхүү буцаан худалдан авах буюу үнэт цаасыг зээлдүүлэх ажил гүйлгээний дагуу борлуулсан эсвэл зээлдүүлсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхгүй.
- (г) Бодит үнэ цэнээр тэргүүн ээлжинд буцаан худалдан авах эрх. Байгууллага нь санхүүгийн хөрөнгийг борлуулсан бөгөөд шилжүүлэн авагч нь уг хөрөнгийг дараагийн тайлант үед хэрэв борлуулах бол түүнийг тэр үеийн бодит үнэ цэнээр тэргүүн ээлжинд худалдан авах

зөвхөн эрхийг хадгалж үлдсэн тохиолдолд байгууллага нь өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлэх учраас тухайн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

- (д) Угаах борлуулалтын ажил гүйлгээ. Санхүүгийн хөрөнгийг борлуулсны дараа богино хугацааны дотор буцаан худалдан авах ажил гүйлгээг зарим үед угаах борлуулалт гэж нэрлэдэг. Хэрэв анхны буюу борлуулах ажил гүйлгээ нь үл хүлээн зөвшөөрөлтийн шаардлагуудыг хангаж байвал ингэж буцаан худалдан авах нь тухайн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхөд саад учруулахгүй. Гэхдээ тухайн хөрөнгийг тогтмол үнээр эсвэл борлуулалтын үнэ дээр зээлдүүлэгчийн өгөөжийг нэмсэн дүнгээр буцаан худалдан авах хэлцлийн хамтаар санхүүгийн хөрөнгийг борлуулах хэлцлийг байгуулсан бол уг санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхгүй.
- (е) Их мөнгөн ашигтай буцаах опцион ба дуудах опцион. Шилжүүлэгч нь уг шилжүүлсэн санхүүгийн хөрөнгөө буцаан дуудан авч чадах бөгөөд дуудах опцион нь их мөнгөн ашигтай байгаа бол тухайн шилжүүлэгч нь өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалан үлдэх учраас ийм шилжүүлэлт нь үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангахгүй. Үүний адилаар, шилжүүлэн авагч нь уг санхүүгийн хөрөнгийг буцаан өгч чадах бөгөөд буцаах опцион нь их мөнгөн ашигтай байгаа бол шилжүүлэгч нь өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалан үлдэх учраас ийм шилжүүлэлт нь үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангахгүй.
- (ж) Их мөнгөн алдагдалтай буцаах опцион ба дуудах опцион. Шилжүүлэн авагчийн эзэмшиж буй их мөнгөн алдагдалтай буцаах опцион эсвэл шилжүүлэгчийн эзэмшиж буй их мөнгөн алдагдалтай дуудах опционд зөвхөн хамаарах уг шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө. Яагаад гэвэл, шилжүүлэгч нь өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн байна.
- (и) Их мөнгөн ашигтай ч биш, их мөнгөн алдагдалтай ч биш дуудах опционд хамаарах, шууд олж эзэмшиж болох хөрөнгө. Байгууллага нь зах зээлээс шууд олж эзэмшиж болох хөрөнгийн хувьд дуудах опционыг эзэмшиж байгаа бөгөөд уг опцион нь их мөнгөн ашигтай ч биш, их мөнгөн алдагдалтай ч биш бол тухайн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө. Яагаад гэвэл, байгууллага нь (i) өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалж үлдээгүй, бас шилжүүлээгүй, (ii) хяналтыг хадгалан үлдээгүй. Харин уг хөрөнгийг зах зээлээс шууд олж эзэмших боломжгүй бол байгууллага нь хөрөнгийн хяналтыг хадгалж үлдэх учраас тэрхүү дуудах опционд хамаарах тухайн хөрөнгийн дүнгийн хэмжээгээр үл хүлээн зөвшөөрөлтийг хязгаарлана.
- (к) Байгууллагын гаргасан, их мөнгөн ашигтай ч биш, их мөнгөн алдагдалтай ч биш дуудах опционд хамаарах, шууд олж эзэмших боломжгүй хөрөнгө. Байгууллага нь зах зээлээс шууд олж эзэмших боломжгүй санхүүгийн хөрөнгийг шилжүүлсэн бөгөөд их мөнгөн алдагдалтай биш тийм дуудах опционыг гаргасан бол уг гаргасан дуудах опционы үр дүнд тухайн байгууллага нь өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалан үлдэхгүй, бас шилжүүлэхгүй. Хэрэв дуудах опцион нь шилжүүлэн авагч уг хөрөнгийг борлуулахаас сэргийлэхүйц хангалттай үнэ цэнэтэй болвол байгууллага нь хөрөнгийн хяналтыг хадгалан үлдэх бөгөөд энэ тохиолдолд шилжүүлэгчийн цаашдын оролцооны хэмжээгээр тухайн хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн хэвээр байна (МЗУ29-р параграфыг үзнэ үү). Хэрэв дуудах опцион нь шилжүүлэн авагч уг хөрөнгийг борлуулахаас сэргийлэхүйц хангалттай үнэ цэнэгүй бол байгууллага нь хөрөнгийн хяналтыг шилжүүлэх бөгөөд энэ тохиолдолд тухайн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.
- (л) Бодит үнэ цэнийн буцаах опцион эсвэл дуудах опционд, эсвэл буцаан худалдан авах форвард хэлцэлд хамаарах хөрөнгө. Буцаан худалдан авах өдөр тухайн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэтэй тэнцүү байх, хэрэгжүүлэх буюу буцаан худалдан авах үнэ бүхий буцаах опцион эсвэл дуудах опционд, эсвэл буцаан худалдан авах форвард гэрээний хэлцэлд зөвхөн хамаарах санхүүгийн хөрөнгийн шилжүүлэлт нь өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлдэг учраас ийм шилжүүлэлтийг үл хүлээн зөвшөөрнө.

- (м) Мөнгөөр барагдуулах дуудах эсвэл буцаах опцион. Цэвэр дүнгээр нь мөнгөөр барагдуулах буцаах опцион эсвэл дуудах опционд, эсвэл буцаан худалдан авах форвард хэлцэлд хамаарах санхүүгийн хөрөнгийн шилжүүлэлт нь өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалж үлддэг эсвэл шилжүүлдэг эсэхийг тодорхойлохын тулд байгууллага нь ийм шилжүүлэлтийг үнэлнэ. Хэрэв байгууллага нь уг шилжүүлсэн хөрөнгийн өмчлөлтэй холбоотой бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалан үлддэггүй бол байгууллага нь тухайн шилжүүлсэн хөрөнгийн хяналтыг хадгалан үлдсэн эсэхийг тодорхойлно. Уг буцаах опцион эсвэл дуудах опцион, эсвэл буцаан худалдан авах форвард хэлцлийг цэвэр дүнгээр нь мөнгөөр барагдуулж байгаа нь тухайн байгууллага хяналтыг шилжүүлсэн гэсэн утгыг шууд илэрхийлэхгүй (МЗУ29-р параграф болон дээрх (ж), (и), (к) заалтыг үзнэ үү).
- (н) Зарим хэсгийг буцаан худалдан авах нөхцөл. Зарим хэсгийг буцаан худалдан авах нөхцөл гэдэг нь уг шилжүүлсэн хөрөнгийг тодорхой хязгаарлалттайгаар буцаан нэхэмжлэх эрхийг байгууллагад олгодог нөхцөлт бус буцаан худалдан авалтын (дуудах) опцион юм. Хэрэв ийм опцион нь өмчлөлтэй холбоотой бараг бүх эрсдэл ба өгөөжийг байгууллага хадгалан үлдэхгүй, бас шилжүүлэхгүй байхад хүргэж байвал энэ нь зөвхөн буцаан худалдан авахад хамаарах дүнгийн хэмжээгээр (шилжүүлэн авагч нь уг хөрөнгийг борлуулж чадахгүй гэж үзэх) үл хүлээн зөвшөөрөлтөнд саад учруулдаг. Жишээлбэл; зээлийн хөрөнгүүдийн дансны үнэ ба тэдгээрийн шилжүүлэлтийн орлого нь 100,000ТН бөгөөд аль ч зээлийг буцаан дуудаж чадах боловч буцаан худалдан авч болох зээлийн нийт дүн нь 10,000ТН-ээс хэтрэхгүй гэж үзье. Тэгвэл 90,000ТН-ийн зээл нь үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангана.
- (о) Үлдэх хөрөнгийн опцион. Уг шилжүүлсэн хөрөнгөнд үйлчилгээ үзүүлдэг байгууллага, тухайлбал шилжүүлэгч нь үйлчилгээнээс олж буй үр өгөөжтэй харьцуулахад үйлчилгээний өртөг зардал их болох тийм тодорхой түвшин хүртэл тэдгээр эргэлтэнд байгаа хөрөнгийн дүн багассан тохиолдолд тэрхүү шилжүүлсэн хөрөнгөөс үлдсэн хэсгийг худалдан авахын тулд үлдэх хөрөнгийн опционыг эзэмшдэг байж болно. Хэрэв ийм үлдэх хөрөнгийн опцион нь өмчлөлтэй холбоотой бараг бүх эрсдэл ба өгөөжийг байгууллага хадгалан үлдэхгүй, бас шилжүүлэхгүй байхад хүргэх бөгөөд шилжүүлэн авагч нь тухайн хөрөнгийг борлуулж чадахгүй бол энэ нь зөвхөн уг дуудах опционд хамаарах хөрөнгийн дүнгийн хэмжээгээр үл хүлээн зөвшөөрөлтөнд саад учруулна.
- (п) Хадгалан үлдсэн тэргүүн бус ээлжийн эрхтэй хувь оролцоо ба зээлийн баталгаа. Байгууллага нь уг шилжүүлсэн хөрөнгийн хувьд хадгалан үлдсэн өөрийн зарим буюу бүх хувь оролцоогоо тэргүүн бус ээлжийн эрхтэй болгосноор зээлийн сайжруулалтыг тухайн шилжүүлэн авагчид бүрдүүлж өгч болох юм. Үүнтэй адилаар, байгууллага нь ямар нэг хязгаарлалтгүй эсвэл тохиролцсон дүнгээр хязгаарлагдах зээлийн баталгаа хэлбэрээр зээлийн сайжруулалтыг тухайн шилжүүлэн авагчид бүрдүүлэн өгч болно. Хэрэв байгууллага нь уг шилжүүлсэн хөрөнгийн өмчлөлтэй холбоотой бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалан үлдсэн бол тухайн хөрөнгийг бүхэлд нь хүлээн зөвшөөрсөн хэвээр байна. Хэрэв байгууллага нь өмчлөлтэй холбоотой бараг бүх биш боловч зарим эрсдэл ба өгөөжийг хадгалан үлдсэн бөгөөд хяналтыг хадгалан үлдсэн бол тухайн байгууллагаас төлөхийг шаардаж болох тэрхүү мөнгө буюу бусад хөрөнгийн дүнгийн хэмжээгээр үл хүлээн зөвшөөрөлтийг хязгаарлана.
- (р) Нийт өгөөжийн своп. Байгууллага нь шилжүүлэн авагчид санхүүгийн хөрөнгийг борлуулах ба нийт өгөөжийн свопын гэрээг түүнтэй байгуулж болох юм. Ингэснээр шилжүүлэн авагч нь тогтмол төлбөр эсвэл хувьсах түвшний төлбөр хүлээн авсаны хариуд уг суурь хөрөнгөөс бий болох бүх хүүний төлбөрийн мөнгөн гүйлгээг тухайн байгууллагад буцаан өгөх бөгөөд тэрхүү суурь хөрөнгийн бодит үнэ цэнийн аливаа өсөлт, бууралтыг байгууллага хариуцна. Ийм тохиолдолд уг хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлтийг бүхэлд нь хориглодог.
- (с) Хүүний түвшний своп. Байгууллага нь шилжүүлэн авагчид тогтмол хүүтэй санхүүгийн хөрөнгийг шилжүүлж, уг шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийн үндсэн дүнтэй тэнцүү нэрлэсэн дүнд үндэслэн тооцогдох хувьсах хүүг төлөх ба тогтмол хүүг хүлээн авах

хүүний түвшний свопын гэрээг тухайн шилжүүлэн авагчтай байгуулж болох юм. Ийм свопын төлбөр нь уг шилжүүлсэн хөрөнгөтэй холбоотойгоор хийгдэх төлбөрөөс нөхцөлт хамааралтай биш бол хүүний түвшний своп нь уг шилжүүлсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхөд саад учруулахгүй.

- (т) Хорогдох хүүний түвшний своп. Байгууллага нь цаг хугацааны явцад төлж барагдах, тогтмол хүүтэй санхүүгийн хөрөнгийг тухайн шилжүүлэн авагчид шилжүүлж, нэрлэсэн дүнд үндэслэн тооцогдох хувьсах хүүг төлөх ба тогтмол хүүг хүлээн авах тийм хорогдох хүүний түвшний свопын гэрээг уг шилжүүлэн авагчтай байгуулж болох юм. Хэрэв свопын нэрлэсэн дүн нь эргэлтэнд байгаа, уг шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийн үндсэн дүнтэй дурын хугацаанд тэнцүү байхын тулд хорогдон буурдаг бол тухайн своп нь урьдчилан төлөлтийн ихэнх эрсдлийг ерөнхийдөө байгууллага хадгалан үлдэхэд хүргэнэ. Ийм тохиолдолд байгууллага нь уг шилжүүлсэн хөрөнгийг бүгдийг нь, эсвэл өөрийн цаашдын оролцооны хэмжээгээр зарим хэсгийг хүлээн зөвшөөрсөн хэвээр байна. Харин эсрэгээр, свопын нэрлэсэн дүнгийн хорогдуулга нь эргэлтэнд байгаа, уг шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийн үндсэн дүнтэй харилцан холбоогүй бол ийм своп нь тухайн хөрөнгийн урьдчилан төлөлтийн эрсдлийг байгууллага хадгалан үлдэхэд хүргэхгүй. Иймээс хэрэв свопын төлбөр нь шилжүүлсэн хөрөнгийн хувьд хийгдэж буй төлбөрөөс нөхцөлт хамааралтай биш бөгөөд своп нь уг шилжүүлсэн хөрөнгийн өмчлөлийн аливаа бусад мэдэгдэхүйц эрсдэл ба урамшууллыг байгууллага хадгалан үлдэхэд хүргэдэггүй бол тухайн своп нь тэрхүү шилжүүлсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхөд саад учруулахгүй.
- (у) Данснаас хасах. Байгууллага нь тухайн санхүүгийн хөрөнгийн гэрээний мөнгөн гүйлгээг бүхэлд нь, эсвэл түүний зарим хэсгийг нөхөн гэсэн ул үндэслэлтэй хүлээлтгүй байна.

МЗУ38. Байгууллага нь санхүүгийн хөрөнгийн зарим хэсэгт цаашдын оролцоотой байх тохиолдолд цаашдын оролцооны арга хандлагыг хэрхэн хэрэглэхийг энэ параграфт үлгэрчлэн харуулсан.

Байгууллага нь урьдчилан төлөгдөх зээлүүдийн багцтай бөгөөд түүний нэрлэсэн болон үр ашигт хүүний хувь 10, үндсэн дүн ба хорогдуулсан өртөг нь 10,000ТН байсан. Тус байгууллага нь зээлийн авлагаа шилжүүлэх ажил гүйлгээ хийж, 9,115ТН хүлээн авсан бөгөөд шилжүүлэн авагч нь энэхүү төлбөрийнхөө хариуд 9,000ТН-ийн зээлийн үндсэн дүн, түүнчлэн тэрхүү дүнгийн 9.5 хувийн хүүний аливаа цуглуулалтыг хүлээн авах эрхтэй болсон. Байгууллага нь 1,000ТН-ийн үндсэн төлбөр, түүний 10 хувийн хүү, түүнчлэн дээрх 9,000ТН-ийн үндсэн төлбөрийн 0.5 хувийн үлдэх хүүг авах эрхийг хадгалан үлдсэн. Урьдчилсан төлбөрийн цуглуулалтыг тухайн байгууллага ба шилжүүлэн авагч нь 1:9 гэсэн харьцаагаар хуваарилан авах боловч аливаа үл биелүүлэлтийг (үл төлөлтийг) уг байгууллагын мэдэлд байгаа 1,000ТН-ийг дуусах хүртэл түүнээс хасаж тооцно. Энэхүү ажил гүйлгээний өдөр зээлүүдийн бодит үнэ цэнэ нь 10,100ТН, харин 0.5 хувийн хүүний тархалтын (нэмэгдлийн) бодит үнэ цэнэ нь 40ТН байсан.

Байгууллага нь өмчлөлийн зарим мэдэгдэхүйц эрсдэл, өгөөжийг (жишээлбэл; урьдчилан төлөлтийн мэдэгдэхүйц эрсдэл) шилжүүлсэн боловч мөн зарим мэдэгдэхүйц эрсдэл, өгөөжийг (хадгалан үлдсэн тэргүүн бус ээлжийн хувь оролцооны улмаас) хадгалан үлдсэн ба хяналтыг хадгалан үлдсэн байна гэж тодорхойлсон. Иймээс байгууллага нь цаашдын оролцооны арга хандлагыг хэрэглэнэ.

Энэхүү Стандартыг мөрдөхийн тулд байгууллага нь уг аж гүйлгээг дараах байдлаар шинжилнэ: (а) шууд хамааралтай бүрэн оролцоо бүхий 1,000ТН-ийн хувь оролцоог хадгалан үлдсэн, түүнчлэн (б) зээлийн алдагдлын хувьд тухайн шилжүүлэн авагчид зээлийн сайжруулалт бүрдүүлж өгөхийн тулд өөрийн энэхүү хадгалан үлдсэн хувь оролцоогоо тэргүүн бус ээлжийн эрхтэй болгосон.

Уг хүлээн авсан 9,115ТН-ийн төлбөрөөс 9,090ТН (10,100ТН х 90 хувь) нь 90 хувийн шууд хамааралтай бүрэн оролцооны төлбөрийг илэрхийлнэ гэж байгууллага тооцоолсон. Хүлээн авсан төлбөрөөс үлдсэн хэсэг (25ТН) нь зээлийн алдагдлын хувьд тухайн шилжүүлэн авагчид зээлийн сайжруулалт бүрдүүлж өгөхийн тулд өөрийн хадгалан үлдсэн хувь оролцоогоо тэргүүн бус ээлжийн эрхтэй болгосны төлөө хүлээн авсан төлбөрийг илэрхийлнэ. Мөн 0.5

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

хувийн хүүний тархалт (нэмэгдэл) нь уг зээлийн сайжруулалтын хувьд хүлээн авсан төлбөрийг илэрхийлнэ. Иймээс зээлийн сайжруулалтын төлөө хүлээн авсан нийт төлбөр нь 65ТН (25ТН+40ТН) болно.

Байгууллага нь мөнгөн гүйлгээнийхээ 90 хувийг борлуулсны олз, гарзыг тооцоолно. Шилжүүлсэн 90 хувь ба хадгалан үлдсэн 10 хувийн тус бүрийн бодит үнэ цэнийг уг шилжүүлэлтийн өдрөөр тогтоох боломжгүй байсан гэж үзвэл байгууллага нь 25-р параграфын дагуу тухайн хөрөнгийн дансны үнийг доорх байдлаар хуваарилна:

	Бодит үнэ цэнэ	Хувийн жин	Хуваарилсан дансны үнэ
Шилжүүлсэн хэсэг	9,090	90%	9,000
Хадгалан үлдсэн хэсэг	1,010	10%	1,000
Дүн	10,100		10,000

Байгууллага нь тухайн шилжүүлсэн хэсэгт хуваарилсан дансны үнийг уг хүлээн авсан төлбөрөөс хассанаар мөнгөн гүйлгээний 90 хувийг борлуулсны олз, гарзыг тооцоолно, өөрөөр хэлбэл энэ нь 90ТН (9,090ТН- 9,000ТН) байна. Байгууллагын хадгалан үлдсэн хэсгийн дансны үнэ нь 1,000ТН болно.

Түүнчлэн, байгууллага нь өөрийн хадгалан үлдсэн хувь оролцоог зээлийн алдагдлын улмаас тэргүүн бус ээлжийн эрхтэй болгосны үр дүн болох цаашдын оролцоог хүлээн зөвшөөрнө. Иймээс байгууллага нь 1,000ТН-ийн хөрөнгө (тэргүүн бус ээлжийн эрхийн улмаас хүлээн авахгүй байж болох мөнгөн гүйлгээний хамгийн их дүн) ба 1,065ТН-ийн холбогдох өр төлбөрийг (тэргүүн бус ээлжийн эрхийн улмаас хүлээн авахгүй байж болох мөнгөн гүйлгээний хамгийн их дүн 1,000ТН дээр, тэргүүн бус ээлжийн эрхтэй болсны төлбөр 65ТН-ийн бодит үнэ цэнийг нэмсэн дүн) хүлээн зөвшөөрнө.

Байгууллага нь уг ажил гүйлгээг дараах байдлаар тайлагнахын тулд дээрх бүх мэдээллийг ашиглана:

	Дебет	Кредит
Анх байсан хөрөнгө	-	9,000
Тэргүүн бус ээлжийн эрхтэй болголт буюу үлдэх хувь оролцооны хувьд хүлээн зөвшөөрсөн хөрөнгө	1,000	-
Хүүний тархалт (нэмэгдэл) хэлбэрээр хүлээн авах төлбөрийг илэрхийлэх хөрөнгө	40	-
Ашиг, алдагдал (шилжүүлэлтийн олз)	-	90
Өр төлбөр	-	1,065
Хүлээн авсан мөнгө	9,115	-
Дүн	10,155	10,155

Энэхүү ажил гүйлгээний дараа, тухайн хөрөнгийн дансны үнэ нь 2,040ТН байх бөгөөд уг хадгалан үлдсэн хэсэгт хуваарилсан өртөг болох 1,000ТН ба байгууллага өөрийн хадгалан үлдсэн хэсгийг зээлийн алдагдалд зориулан тэргүүн бус ээлжийн эрхтэй болгосны үр дүнд түүний нэмэлт цаашдын оролцоог илэрхийлэх 1,040ТН-ээс (үүнд 40ТН-ийн хүүний тархалт багтсан) бүрдэнэ.

Дараагийн тайлант үеүдэд байгууллага нь зээлийн сайжруулалтын хувьд хүлээн авах төлбөрийг (65ТН) цаг хугацаагаар хувь тэнцүүлэн хүлээн зөвшөөрөх бөгөөд уг хүлээн зөвшөөрсөн хөрөнгөнд үр ашигт хүүний аргаар тооцогдох хүүг хуримтлуулж, тэрхүү хүлээн зөвшөөрсөн хөрөнгөнд хамаарах аливаа үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрнө. Ийм үнэ цэнийн бууралтын гарзын жишээ болгон дараагийн жилд уг суурь зэлийн хөрөнгийн

хувьд 300ТН-ийн үнэ цэнийн бууралтын гарз гарсан гэж үзье. Байгууллага нь уг хүлээн зөвшөөрсөн хөрөнгийг 600ТН-ээр (үүнээс 300ТН нь түүний хадгалан үлдсэн хувь оролцоонд хамаарах ба 300ТН нь тухайн хадгалан үлдсэн хувь оролцоогоо ийм үнэ цэнийн бууралтын гарзад зориулан тэргүүн бус ээлжийн эрхтэй болгосноор үүссэн цаашдын нэмэлт оролцоонд хамаарна) бууруулж, хүлээн зөвшөөрсөн өр төлбөрөө 300ТН-ээр бууруулна. Цэвэр үр дүн болох 300ТН-ийн үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдалд тусгана.

Санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт

- МЗУ39. Зээлдэгч нь дараах аль нэг байдлаар санхүүгийн өр төлбөрийг (эсвэл түүний хэсгийг) барагдуулдаг:
- (а) Зээлдүүлэгчид ихэвчлэн мөнгөөр, түүнчлэн бусад санхүүгийн хөрөнгө, бараа, үйлчилгээгээр төлбөр хийснээр өр төлбөрийг барагдуулах; эсвэл
 - (б) Хууль эрх зүйн процессоор эсвэл зээлдүүлэгч зөвшөөрснөөр тухайн өр төлбөрийн (эсвэл түүний хэсгийг) талаархи анхдагч хариуцлагаас хууль ёсоор чөлөөлсөн. (Хэрэв зээлдэгч нь баталгаа гаргасан бол тэр нөхцөл нь хангагдсан байж болох юм.)
- МЗУ40. Өрийн хэрэглүүрийн гаргагч нь уг хэрэглүүрээ буцаан худалдаж авсан бол хэдийгээр гаргагч нь тухайн хэрэглүүрийн хувьд зах зээлийн тоглогч байсан эсвэл ойрын ирээдүйд түүнийг буцаан борлуулах зорилготой байсан ч гэсэн өр төлбөрийг барагдуулсан гэж үзнэ.
- МЗУ41. Гуравдагч талд, үүн дотроо итгэлцлийн санд төлбөр хийх (үүнийг зарим үед “мөн чанарын хувьд барагдуулалт” гэж нэрлэдэг) нь хуулийн дагуу чөлөөлөгдөх заалтгүй тохиолдолд зээлдүүлэгчийн өмнө хүлээсэн анхдагч үүргээс тухайн зээлдэгчийг чөлөөлөхгүй.
- МЗУ42. Зээлдэгч нь түүний үүргийг хариуцах гуравдагч талд төлбөр хийсэн бөгөөд тэрхүү өрийн үүргийг гуравдагч тал хариуцах болсныг өөрийн зээлдүүлэгчид мэдэгдсэн ч гэсэн тухайн зээлдэгч нь МЗУ39(б) параграфт заасан нөхцөл хангагдахаас бусад тохиолдолд уг өрийн үүргийг үл хүлээн зөвшөөрөхгүй. Хэрэв зээлдэгч нь түүний үүргийг хариуцах гуравдагч талд төлбөр хийсэн бөгөөд өөрийн зээлдүүлэгчээс хууль ёсны дагуу чөлөөлөгдсөн бол тухайн зээлдэгч нь өрийг барагдуулсан гэж үзнэ. Гэвч зээлдэгч нь тухайн өрийн төлбөрийг гуравдагч талд эсвэл өөрийн анхны зээлдүүлэгчид шууд төлөхийг зөвшөөрсөн бол тухайн зээлдэгч нь уг гуравдагч талд төлөх шинэ өрийн үүргийг хүлээн зөвшөөрнө.
- МЗУ43. Байгууллагын үүргийг гуравдагч тал хариуцсан бөгөөд байгууллага нь үүний хариуд уг гуравдагч талд төлбөр төлдөггүй эсвэл багахан нэрлэсэн төлбөр зөвхөн төлдөг бол тухайн байгууллага нь энэ Стандартад, түүнчлэн УСНББОУС 23-ын 84-87-р параграфт заасан үл хүлээн зөвшөөрөлтийн шаардлагуудыг даган мөрдөнө.
- МЗУ44. Зээлдүүлэгч нь улсын секторын байгууллагын төлөх ёстой өрийг цуглуулан авах өөрийн эрхээс зарим үед татгалздаг. Жишээлбэл; үндэсний засгийн газар нь орон нутгийн засаг захиргааны төлөх ёстой зээлийг хүчингүй болгож болох юм. Өрийн ийм хүчингүй болголт нь зээлдэгчээс зээлдүүлэгчид төлөх ёстой өрийн хууль ёсны чөлөөлөлтийг орлоно. Байгууллагын үүргийг арилжааны бус ажил гүйлгээний нэг хэсэг байдлаар хүчингүй болгосон тохиолдолд тус байгууллага нь энэ Стандартын үл хүлээн зөвшөөрөлтийн шаардлагууд, түүнчлэн УСНББОУС 23-ын 84-87-р параграфыг мөрдөнө.
- МЗУ45. Шүүхийн журмаар эсвэл зээлдүүлэгчийн зөвшөөрснөөр өрөөс хууль ёсоор чөлөөлөгдөх нь өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөхөд хүргэдэг боловч тухайн шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийн хувьд 12-34-р параграфт заасан үл хүлээн зөвшөөрөх шалгуур хангагдаагүй тохиолдолд байгууллага нь шинэ өр төлбөрийг хүлээн зөвшөөрч болох юм. Хэрэв тэдгээр шалгуурууд хангагдаагүй бол уг шилжүүлсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд байгууллага нь тэрхүү шилжүүлсэн хөрөнгөтэй холбоотойгоор шинэ өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.
- МЗУ46. 36-р параграфын зорилгын хувьд тухайн шинэ нөхцлийн дагуу төлөх мөнгөн гүйлгээний, үүн дотроо хүлээн авсан аливаа хураамжийг хассан аливаа төлөх цэвэр хураамжийн уг анхны үр

ашигт хүүний түвшнээр дискаунтчилсан өнөөгийн үнэ цэнэ нь тэрхүү анхны санхүүгийн өр төлбөрийн үлдэж буй мөнгөн гүйлгээний дискаунтчилсан өнөөгийн үнэ цэнээс наад зах нь 10 хувиар зөрүүтэй бол тэдгээр нөхцлүүдийг мэдэгдэхүйц өөр байна гэж үзнэ. Хэрэв өрийн хэрэглүүрүүдийн солилцоо буюу нөхцлийн өөрчлөлтийг өр төлбөрийн барагдуулалттай нэгэн адилаар тайлагнадаг бол гарсан аливаа зардал буюу хураамжийг тухайн барагдуулалтын олз, гарзын нэг хэсэг байдлаар хүлээн зөвшөөрнө. Хэрэв солилцоо буюу нөхцлийн өөрчлөлтийг өр төлбөрийн барагдуулалт байдлаар тайлагнадаггүй бол гарсан аливаа зардал буюу хураамжаар тухайн өр төлбөрийн дансны үнийг тохируулах бөгөөд тэрхүү өөрчлөгдсөн өр төлбөрийн үлдэх хугацааны туршид хорогдуулна.

МЗУ47. Зарим тохиолдолд зээлдүүлэгч нь төлбөр төлөх одоогийн үүргээс зээлдэгчийг чөлөөлдөг боловч тэрхүү өрийг төлөх анхдагч хариуцлагыг хүлээсэн тал нь үүргээ биелүүлэхгүй бол тухайн зээлдэгч нь төлөх баталгааны үүргийг хариуцан хүлээдэг. Ийм тохиолдолд зээлдэгч нь:

- (а) Уг баталгааны хувьд өөрийн хүлээх үүргийн бодит үнэ цэнэд үндэслэн шинэ санхүүгийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө; ба
- (б) Дараах хоёр дүнгийн зөрүүд үндэслэн олз эсвэл гарзыг хүлээн зөвшөөрнө: (i) төлсөн аливаа шимтгэл, ба (ii) анхны санхүүгийн өр төлбөрийн дансны үнээс шинэ санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийг хассан дүн.

Ангилал

Санхүүгийн хөрөнгийн ангилал

Санхүүгийн хөрөнгөнд зориулсан тухайн байгууллагын удирдлагын загвар

МЗУ48. 44-р параграфыг мөрдөхөөс бусад тохиолдолд байгууллага нь санхүүгийн хөрөнгөнд зориулсан өөрийн удирдлагын загвартаа үндэслэн санхүүгийн хөрөнгөө ангилахыг 39(а) параграфтаар шаардсан байдаг. Тухайн санхүүгийн хөрөнгө нь 40(а) параграфт заасан нөхцлийг эсвэл 41(а) параграфт заасан нөхцлийг хангах эсэхийг байгууллага нь өөрийн эрх бүхий албан тушаалтны (УСНББОУС 20, *Холбоотой Талуудын Тодруулга*-д заасан) тодорхойлсон удирдлагын загварт үндэслэн үнэлнэ.

МЗУ49. Тодорхой зорилтонд хүрэхийн тулд санхүүгийн хөрөнгүүдийн бүлгийг хэрхэн хамтад нь удирдан зохицуулах эсэхийг тусгах тийм түвшинд байгууллагын удирдлагын загварыг тодорхойлдог. Байгууллагын удирдлагын загвар нь бие даасан санхүүгийн хэрэглүүрийн талаархи удирдлагын санаа зорилгоос хамаардаггүй. Иймээс энэ нь хэрэглүүр тус бүрээр ангилал хийх арга хандлага биш бөгөөд үүнийг нэгтгэл хийх дээд түвшинд тодорхойлвол зохино. Гэвч нэг байгууллага нь өөрийн санхүүгийн хэрэглүүрүүдийн хувьд удирдлагын нэгээс олон загвартай байж болно. Иймээс тухайн тайлагнагч байгууллагын түвшинд ангиллыг тодорхойлох шаардлагагүй юм. Жишээлбэл; байгууллага нь гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулан авахын тулд удирдан зохицуулдаг хөрөнгө оруулалтын нэг багцтай, бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс ашиг олохын тулд удирдан зохицуулдаг хөрөнгө оруулалтын өөр нэг багцыг эзэмшдэг байж болно. Үүнтэй адилаар, зарим тохиолдолд байгууллага нь санхүүгийн хөрөнгөө удирдан зохицуулдаг түвшинг тусган харуулахын тулд санхүүгийн хөрөнгийн нэг багцыг дэд багцуудад салган тусгаарлах нь тохиромжтой байж болох юм. Жишээлбэл; байгууллага нь моргейжийн зээлүүдийн багцыг үүсгэн гаргасан эсвэл худалдан авсан бөгөөд зарим зээлийг тэдгээрийн гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах зорилгоор эзэмшдэг, харин зарим зээлийг борлуулах зорилгоор удирдан зохицуулдаг бол ийм нөхцөл байдал үүсэж болно.

МЗУ50. Байгууллагын удирдлагын загвар нь мөнгөн гүйлгээг бий болгохын тулд тухайн байгууллага өөрийн санхүүгийн хөрөнгийг хэрхэн удирдаж байгааг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, байгууллагын удирдлагын загвар нь гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулснаар, санхүүгийн хөрөнгийг борлуулснаар эсвэл энэ хоёрын аль алины үр дүнд мөнгөн гүйлгээг бий болгож буй эсэхийг тодорхойлдог. Иймээс “хамгийн муу тохиолдол” эсвэл “дарамт шахалттай нөхцөл” гэх мэт тухайн байгууллагад гарч тохиолдохоор ул үндэслэлтэйгээр хүлээгдээгүй тийм хувилбарт үндэслэн үнэлгээг хийхгүй. Тухайлбал; байгууллага нь санхүүгийн хөрөнгийн тодорхой нэг

багцыг зөвхөн дарамт шахалттай нөхцөлд борлуулна гэж хүлээж байгаа боловч ийм хувилбар гарч тохиолдохгүй гэж тухайн байгууллага нь ул үндэслэлтэйгээр хүлээж байгаа бол тэдгээр хөрөнгийн удирдлагын загварын талаархи байгууллагын үнэлгээнд энэхүү хувилбар нөлөөлөхгүй юм. Удирдлагын загварыг үнэлсэн өдрөөрх уг байгууллагын хүлээлтээс өөр байдлаар мөнгөн гүйлгээ хэрэгжсэн (жишээлбэл; байгууллага нь хөрөнгийг ангилах үед хүлээж байснаас олон эсвэл цөөн санхүүгийн хөрөнгийг борлуулсан) тохиолдолд энэ нь тухайн байгууллагын санхүүгийн тайланд өмнөх үеийн алдаа байдлаар тусгагдахгүй (УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-г үзнэ үү), мөн удирдлагын загварыг үнэлэх үед бэлэн боломжтой байсан холбогдох бүх мэдээллийг байгууллага угаасаа харгалзан үзсэн бол тэрхүү удирдлагын загварын дагуу эзэмшиж буй үлдсэн бусад санхүүгийн хөрөнгийн (өөрөөр хэлбэл, байгууллага нь өмнөх тайлант үеүдэд хүлээн зөвшөөрсөн бөгөөд одоо ч эзэмшиж байгаа хөрөнгүүдийн) ангиллыг ч өөрчлөхгүй. Харин байгууллага нь шинээр үүсгэн гаргасан эсвэл шинээр худалдаж авсан санхүүгийн хөрөнгийн хувьд удирдлагын загвараа үнэлэх бол тухайн байгууллага нь өнгөрсөн үед мөнгөн гүйлгээг хэрхэн хэрэгжүүлсэн талаархи мэдээллийг бусад холбогдох бүх мэдээллийн хамтаар харгалзан үзэх ёстой.

МЗУ51. Санхүүгийн хөрөнгөнд зориулсан байгууллагын удирдлагын загвар нь зөвхөн батламж мэдэгдэл биш, харин бодит үйл явдал юм. Удирдлагын загварын зорилтондоо хүрэхийн тулд байгууллагын хэрэгжүүлж буй үйл ажиллагаанаас үүнийг ихэвчлэн ажиглан харах боломжтой байдаг. Санхүүгийн хөрөнгөнд зориулсан өөрийн удирдлагын загварыг үнэлэх үедээ байгууллага нь шүүн тунгаалт хийх шаардлагатай байдаг бөгөөд ийм үнэлгээг ганц хүчин зүйл эсвэл үйл ажиллагаагаар тодорхойлдоггүй. Харин байгууллага нь тухайн үнэлгээ хийх өдөр бэлэн, боломжтой байгаа холбогдох бүх нотолгоог харгалзан үзэх ёстой. Ийм холбогдох нотолгоонд дараах зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:

- (а) Удирдлагын загвар болон тухайн удирдлагын загварын хүрээнд эзэмшиж буй санхүүгийн хөрөнгийн хэрэгжилт, үр дүнг хэрхэн үнэлж, уг байгууллагын эрх бүхий албан тушаалтанд тайлагнадаг эсэх;
- (б) Удирдлагын загварын (болон тухайн удирдлагын загварын хүрээнд эзэмшиж буй санхүүгийн хөрөнгийн) хэрэгжилтэнд нөлөө үзүүлдэг эрсдлүүд, түүнчлэн тэдгээр эрсдлүүдийг удирдах арга замууд;
- (в) Байгууллагын удирдлагад хөлс урамшууллыг хэрхэн олгодог эсэх (жишээлбэл; хөлс урамшуулал нь удирдан зохицуулж буй хөрөнгүүдийн бодит үнэ цэнээс эсвэл цуглуулсан гэрээний мөнгөн гүйлгээнээс хамаардаг эсэх).

Гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулахын тулд хөрөнгийг эзэмших зорилго бүхий удирдлагын загвар

МЗУ52. Гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулахын тулд хөрөнгийг эзэмших зорилго бүхий удирдлагын загварын хүрээнд хамаарах санхүүгийн хөрөнгийг тухайн санхүүгийн хэрэглүүрийн хугацаанд гэрээний төлбөрүүдийг цуглуулснаар мөнгөн гүйлгээг хэрэгжүүлэх үүднээс удирдан зохицуулдаг. Өөрөөр хэлбэл, байгууллага нь тухайн тодорхой гэрээний мөнгөн гүйлгээнүүдийг цуглуулахын тулд (хөрөнгийн эзэмшилт ба борлуулалтын аль алианаар тухайн багцын нийт өгөөжийг удирдан зохицуулахын оронд) уг багцын хүрээнд эзэмшиж буй хөрөнгүүдийг удирдан зохицуулдаг. Санхүүгийн хөрөнгүүдийн гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулснаар мөнгөн гүйлгээг хэрэгжүүлэх эсэхийг тодорхойлохдоо, байгууллага нь өмнөх тайлант үеүд дэх борлуулалтын давтамж, үнэ цэнэ, цаг хугацаа болон ийм борлуулалт хийх учир шалтгаан, түүнчлэн ирээдүйн борлуулалтын үйл ажиллагааны талаархи хүлээлтийг харгалзан үзэх шаардлагатай. Гэвч борлуулалт нь өөрөө дангаараа тухайн удирдлагын загварыг тодорхойлдоггүй, иймээс тусад нь авч үзэхгүй. Харин өмнөх үеийн борлуулалт болон ирээдүйн борлуулалтын хүлээлтийн тухай мэдээлэл нь санхүүгийн хөрөнгийг удирдан зохицуулахын тулд уг байгууллагын тогтоосон зорилт хэрхэн биелэгдсэн, ялангуяа мөнгөн гүйлгээ хэрхэн хэрэгжүүлсэн талаархи нотолгоогоор хангадаг. Байгууллага нь тэдгээр борлуулалтын учир шалтгаан, түүнчлэн одоогийн нөхцөлтэй харьцуулахад тухайн үед оршин байсан нөхцөл зэргийг харгалзсанаар уг өмнөх борлуулалтын талаархи мэдээллийг шинжлэн үзэх ёстой.

- МЗУ53. Байгууллагын удирдлагын загварын зорилго нь гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулахын тулд санхүүгийн хөрөнгийг эзэмших явдал байж болох хэдий ч тухайн байгууллага нь бүх санхүүгийн хэрэглүүрийг тэдгээрийн дуусгавар болох хугацаа хүртэл заавал эзэмших албагүй юм. Иймээс санхүүгийн хөрөнгийг борлуулдаг эсвэл ойрын ирээдүйд борлуулахаар хүлээгдэж байгаа ч гэсэн тухайн байгууллагын удирдлагын загвар нь гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулахын тулд санхүүгийн хөрөнгийг эзэмших явдал байж болно.
- МЗУ54. Байгууллага нь хөрөнгийн зээлийн эрсдэл нэмэгдсэн үед түүнийг борлуулдаг боловч тухайн удирдлагын загвар нь гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулахын тулд хөрөнгийг эзэмшдэг байж болно. Хөрөнгийн зээлийн эрсдэл нэмэгдсэн эсэхийг тодорхойлохын тулд байгууллага нь үл үндэслэлтэй ба дэмжих мэдээллийг, үүн дотроо хэтийн мэдээллийг харгалзан үзнэ. Санхүүгийн хөрөнгийн зээлийн чанар нь гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах уг байгууллагын чадвар, боломжоос хамааралтай байдаг тул хөрөнгийн зээлийн эрсдэл нэмэгдсэний улмаас хийгдэх борлуулалт нь гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах үүднээс санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилго бүхий удирдлагын загвартай нийцэхгүй юм. Үүнд тэрхүү борлуулалтын давтамж ба үнэ цэнэ хамааралгүй байдаг. Зээлийн чанарын доройтлоос шалтгаалсан боломжит зээлийн алдагдлыг хамгийн бага болгоход чиглэгдсэн зээлийн эрсдлийн удирдлагын үйл ажиллагаа нь ийм удирдлагын загварын салшгүй нэг хэсэг байдаг. Байгууллагын баримтжуулсан хөрөнгө оруулалтын бодлогод тусгайлан заасан зээлийн шалгуурыг цаашид хангахгүй учраас санхүүгийн хөрөнгийг борлуулах нь зээлийн эрсдэл нэмэгдсэний улмаас хийгдсэн борлуулалтын жишээ юм. Гэвч ийм бодлого байхгүй тохиолдолд байгууллага нь зээлийн эрсдэл нэмэгдсэний улмаас хийгдсэн борлуулалт гэдгийг өөр бусад арга замаар харуулж болно.
- МЗУ55. Зээлийн төвлөрлийн эрсдлийг удирдахын тулд (тухайн хөрөнгийн зээлийн эрсдлийг нэмэгдүүлэхгүйгээр) хийсэн борлуулалт гэх мэт бусад шалтгаанаар хийсэн борлуулалт нь гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах үүднээс санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилго бүхий удирдлагын загвартай бас нийцдэг байж болно. Ялангуяа, борлуулалт нь (мэдэгдэхүйц үнэ цэнэтэй боловч) тогтмол хийгддэггүй эсвэл (тогтмол хийгддэг боловч) тус тусын болон нэгдсэн байдлаараа мэдэгдэхүйц дүнтэй биш бол ийм борлуулалт нь гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах үүднээс санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилго бүхий удирдлагын загвартай нийцэж болох юм. Ийм борлуулалтыг тогтмол бус гэдгээс илүү тоо хэмжээгээр тухайн багцаас хийсэн бөгөөд (тус тусын болон нэгдсэн байдлаараа) мэдэгдэхүйц бус гэдгээс илүү үнийн дүнтэй бол тэрхүү борлуулалт нь гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах удирдлагын загварын зорилготой нийцэх эсэх, хэр нийцэхийг байгууллага үнэлэх шаардлагатай. Санхүүгийн хөрөнгийг борлуулах талаар гуравдагч этгээдээс шаардлага тавьсан эсвэл уг үйл ажиллагааг байгууллага өөрийн хүсэл зоригоор хийсэн эсэх нь энэхүү үнэлгээнд хамааралгүй юм. Тодорхой нэг тайлант үед борлуулалтын давтамж буюу үнэ цэнэ нэмэгдсэн бөгөөд байгууллага нь түүний шалтгааныг тайлбарлаж, тэрхүү борлуулалт нь яагаад уг байгууллагын удирдлагын загварын өөрчлөлтийг тусгаагүй гэдгийг харуулж чадах бол ийм нэмэгдэлт нь гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах үүднээс санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилготой нийцэхгүй гэж заавал үзэх албагүй юм. Түүнчлэн, санхүүгийн хөрөнгийн дуусгавар болох хугацаа дөхсөн үед борлуулалтыг хийсэн бөгөөд борлуулалтаас олох мөнгөн орлого нь гэрээний үлдсэн мөнгөн гүйлгээний цуглуулалттай ойролцоогоор тэнцүү байгаа бол тухайн борлуулалт нь гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах үүднээс санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилготой нийцдэг байж болно.
- МЗУ56. Байгууллагын удирдлагын загварын зорилго нь гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах үүднээс санхүүгийн хөрөнгийг эзэмших явдал байж болох жишээг доор харуулав. Жишээнүүдийн энэхүү жагсаалтанд бүгдийг багтаагаагүй болно. Түүнчлэн, эдгээр жишээ нь байгууллагын удирдлагын загварын үнэлгээнд хамааралтай байж болох бүх хүчин зүйлсийг авч хэлэлцэх, түүнчлэн уг хүчин зүйлсийн холбогдох ач холбогдлыг тусгайлан заах зорилгогүй юм.

Жишээ	Шинжилгээ
Жишээ 1	Хэдийгээр байгууллага нь бусад мэдээллээс гадна уг санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийг төлбөрийн

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

<p>Байгууллага нь гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулахын тулд хөрөнгө оруулалтыг эзэмшдэг. Тухайн байгууллагын санхүүжилтийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан таамаглаж болох бөгөөд санхүүгийн хөрөнгийн дуусгавар болох хугацаа нь уг байгууллагын тооцоолсон санхүүжилтийн хэрэгцээ шаардлагатай уялдсан байдаг.</p> <p>Байгууллага нь зээлийн алдагдлыг хамгийн бага болгох зорилго бүхий зээлийн эрсдлийн удирдлагын үйл ажиллагааг явуулдаг. Санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл нэмэгдсэн, ингэснээр уг санхүүгийн хөрөнгө нь тухайн байгууллагын баримтжуулсан хөрөнгө оруулалтын бодлогод тусгайлан заасан зээлийн шалгуурыг цаашид хангахгүй болсон тохиолдолд өмнөх тайлант үед ихэвчлэн борлуулалт хийдэг байсан. Түүнчлэн, урьдчилан таамаглаагүй санхүүжилтийн хэрэгцээ шаардлагын улмаас тогтмол бус борлуулалт хийж байсан.</p> <p>Эрх бүхий албан тушаалтнуудад танилцуулдаг тайланд санхүүгийн хөрөнгийн зээлийн чанар ба гэрээний өгөөжийг онцлон заадаг. Байгууллага нь бусад мэдээллээс гадна тухайн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийг мөн хянан шинжилдэг.</p>	<p>чадварын (өөрөөр хэлбэл, байгууллага нь хөрөнгийг борлуулах шаардлагатай болвол хэрэгжүүлэх байсан мөнгөн дүн) талаас авч үздэг боловч тухайн байгууллагын зорилго нь гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулахын тулд санхүүгийн хөрөнгийг эзэмших явдал юм. Хөрөнгийн зээлийн эрсдэл нэмэгдэлтийн хариу болгож, тухайлбал, уг хөрөнгө нь байгууллагын баримтжуулсан хөрөнгө оруулалтын бодлогод тусгайлан заасан зээлийн шалгуурыг цаашид хангахгүй болсон үед борлуулалтыг хийсэн бол тэрхүү борлуулалт нь уг зорилготой зөрчилдөхгүй. Урьдчилан таамаглаагүй санхүүжилтийн хэрэгцээ шаардлагын улмаас (жишээ нь; дарамт шахалттай нөхцөлд) хийсэн борлуулалт нь хэдийгээр мэдэгдэхүйц үнэ цэнэтэй боловч уг зорилготой зөрчилдөхгүй юм.</p>
<p>Жишээ 2</p> <p>Байгууллагын удирдлагын загвар нь зээл гэх мэт санхүүгийн хөрөнгийн багцыг худалдан авах явдал байдаг. Ийм багц нь зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийг агуулдаг эсвэл агуулдаггүй байж болно.</p> <p>Зээлийн төлбөрийг цаг хугацаанд үндэслэн төлдөггүй бол байгууллага нь янз бүрийн арга замаар тухайлбал, шуудан, телефон утас буюу бусад аргаар тухайн зээлдэгчтэй холбоо барих замаар гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулахыг эрмэлздэг. Байгууллагын зорилго нь гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах явдал бөгөөд тухайн байгууллага нь тэдгээрийг борлуулснаар мөнгөн гүйлгээг хэрэгжүүлэх зорилгоор энэхүү багцын аливаа зээлийг удирдан зохицуулдаггүй.</p> <p>Зарим тохиолдолд байгууллага нь тухайн багц дахь тодорхой нэг санхүүгийн хөрөнгийн хүүний түвшинг хөвөгч хүүнээс тогтмол хүү болгон өөрчлөхийн тулд хүүний түвшний свопын гэрээг байгуулдаг.</p>	<p>Байгууллагын удирдлагын загварын зорилго нь гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулахын тулд санхүүгийн хөрөнгийг эзэмших явдал юм.</p> <p>Хэдийгээр байгууллага нь гэрээний бүх мөнгөн гүйлгээг хүлээн авна гэж хүлээгээгүй (жишээ нь; зарим санхүүгийн хөрөнгө нь анх хүлээн зөвшөөрөх үед зээлийн үнэ цэнийн бууралттай байдаг) боловч ийм шинжилгээг хийнэ.</p> <p>Түүнчлэн, уг багцын мөнгөн гүйлгээг өөрчлөхийн тулд байгууллага үүсмэл хэрэглүүрийн гэрээ байгуулах нь тухайн байгууллагын удирдлагын загварыг өөрчлөхөд хүргэхгүй юм.</p>
<p>Жишээ 3</p> <p>Байгууллага нь үйлчлүүлэгчдэд зээл олгох ба дараа нь тэрхүү зээлээ үнэт цаасжуулах нэгжид борлуулах зорилго бүхий удирдлагын загвартай.</p>	<p>Нэгтгэсэн эдийн засгийн нэгдмэл байгууллага нь гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах үүднээс зээлийг эзэмших зорилгоор зээлийг үүсгэн гаргасан.</p>

<p>Үнэт цаасжуулах нэгж нь хөрөнгө оруулагчдад зориулан санхүүгийн хэрэглүүрийг гаргадаг.</p> <p>Уг үүсгэгч байгууллага нь үнэт цаасжуулах нэгжийг хянадаг бөгөөд иймээс түүнийг нэгтгэдэг.</p> <p>Үнэт цаасжуулах нэгж нь тухайн зээлийн гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулж, түүнийгээ хөрөнгө оруулагчдад дамжуулан өгдөг.</p> <p>Үнэт цаасжуулах нэгж нь зээлийг үл хүлээн зөвшөөрдөггүй учраас энэхүү жишээний зорилгын хувьд нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд зээлийг хүлээн зөвшөөрсөн хэвээр байна гэж үздэг.</p>	<p>Гэвч уг үүсгэгч байгууллага нь үнэт цаасжуулах нэгжид зээлийг борлуулснаар тухайн зээлийн багцын мөнгөн гүйлгээг хэрэгжүүлэх зорилготой байдаг. Иймээс өөрийн тусдаа санхүүгийн тайлангийн зорилгын хувьд уг үүсгэгч байгууллага нь гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах үүднээс энэхүү багцыг удирдан зохицуулж байна гэж үзэхгүй.</p>
<p>Жишээ 4</p> <p>Санхүүгийн байгууллага нь “дарамт шахалттай” нөхцөлд (жишээлбэл; банкны харилцах, хадгаламжаас мөнгийг бөөнөөр татсан үед) төлбөрийн чадварын хэрэгцээ шаардлагаа хангахын тулд санхүүгийн хөрөнгийг эзэмшдэг. Ийм дарамт шахалттай байхаас бусад тохиолдолд байгууллага нь эдгээр хөрөнгийг борлуулахгүй юм.</p> <p>Байгууллага нь санхүүгийн хөрөнгийн зээлийн чанарт хяналт шинжилгээ хийдэг бөгөөд санхүүгийн хөрөнгөө удирдан зохицуулах түүний зорилго нь гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах явдал юм. Байгууллага нь олсон хүүний орлого ба хэрэгжсэн зээлийн алдагдалд үндэслэн тухайн хөрөнгийн гүйцэтгэлийг үнэлдэг.</p> <p>Гэхдээ дарамт шахалттай нөхцөлд байгууллага тухайн хөрөнгийг борлуулах шаардлагатай болсноор хэрэгжүүлэх мөнгөн дүн нь түүний төлбөрийн чадварын хэрэгцээ шаардлагыг хангахад хүрэлцээтэй эсэхийг магадлахын тулд тухайн байгууллага нь санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийг төлбөрийн чадвар талаас бас хянан үнэлдэг. Байгууллага нь төлбөрийн чадвараа батлан харуулахын тулд мэдэгдэхүйц бус дүнтэй борлуулалтыг үе үе хийдэг.</p>	<p>Байгууллагын удирдлагын загварын зорилго нь гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулахын тулд санхүүгийн хөрөнгийг эзэмших явдал юм.</p> <p>Өмнөх дарамт шахалттай үед байгууллага нь өөрийн төлбөрийн чадварын хэрэгцээ шаардлагыг хангахын тулд мэдэгдэхүйц дүнтэй борлуулалт хийсэн ч гэсэн уг шинжилгээ өөрчлөгдөхгүй юм. Үүнтэй адилаар, мэдэгдэхүйц бус дүнтэй, дахин давтагдсан борлуулалтын ажиллагаа нь гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах үүднээс санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилготой зөрчилдөхгүй юм.</p> <p>Харин эсрэгээр, байгууллага нь өөрийн өдөр тутмын төлбөрийн чадварын хэрэгцээ шаардлагаа хангахын тулд санхүүгийн хөрөнгийг эзэмшдэг бөгөөд энэ зорилгыг хангах үүднээс үнэ цэнийн хувьд мэдэгдэхүйц дүнтэй борлуулалтыг дахин давтан хийдэг бол тухайн байгууллагын удирдлагын загварын зорилго нь гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулахын тулд санхүүгийн хөрөнгийг эзэмших явдал биш юм.</p> <p>Үүнтэй адилаар, уг санхүүгийн хөрөнгө хөрвөх чадвартай гэдгийг батлан харуулахын түүнийг тогтмол борлуулахыг зохицуулагч байгууллага нь тухайн байгууллагаас шаарддаг бөгөөд борлуулсан хөрөнгийн үнэ цэнэ нь мэдэгдэхүйц дүнтэй бол байгууллагын удирдлагын загварын зорилго нь гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах үүднээс санхүүгийн хөрөнгийг эзэмших явдал биш юм. Санхүүгийн хөрөнгийг борлуулах шаардлагыг гуравдагч талаас тогтоодог</p>

	эсвэл ийм борлуулалтын ажиллагаа нь тухайн байгууллагын өөрийн хүсэл зоригоор хийгддэг эсэх нь уг шинжилгээнд хамааралгүй байдаг.
--	---

Гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах ба санхүүгийн хөрөнгийг борлуулах ажиллагааны аль алинаар зорилгодоо хүрдэг удирдлагын загвар

- МЗУ57. Гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах ба санхүүгийн хөрөнгийг борлуулах ажиллагааны аль алинаар өөрийн зорилгодоо хүрдэг тийм удирдлагын загвараар байгууллага нь санхүүгийн хөрөнгийг эзэмшдэг байж болох юм. Энэ төрлийн удирдлагын загварын хувьд гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах ба санхүүгийн хөрөнгийг борлуулах ажиллагааны аль алины талаар тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтны гаргах шийдвэр нь уг удирдлагын загварын зорилгын биелэлтийн салшгүй нэг хэсэг болно. Ийм төрлийн удирдлагын загвартай нийцэж болох янз бүрийн олон зорилго байдаг. Жишээлбэл; удирдлагын загварын зорилго нь өдөр тутмын төлбөрийн чадварын хэрэгцээ шаардлагыг удирдан зохицуулах, хүүний орлогын тодорхой түвшинг хадгалах, эсвэл санхүүгийн хөрөнгийн хугацааг тэдгээр хөрөнгийн эх үүсвэр болох өр төлбөрийн хугацаатай уялдуулах явдал байж болох юм. Ийм зорилгод хүрэхийн тулд байгууллага нь гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах ба санхүүгийн хөрөнгийг борлуулах ажиллагааны аль алиныг хэрэгжүүлдэг.
- МЗУ58. Гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах үүднээс санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилго бүхий удирдлагын загвартай харьцуулахад энэ удирдлагын загвар нь борлуулалтыг илүү олон удаа, өндөр дүнгээр хийдэг. Яагаад гэвэл, санхүүгийн хөрөнгийг борлуулах нь зөвхөн тохиолдлын шинжтэй бус, харин энэ удирдлагын загварын зорилгын биелэлтийн салшгүй нэг хэсэг юм. Харин гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах ба санхүүгийн хөрөнгийг борлуулах ажиллагааны аль аль нь зорилгын биелэлтийн салшгүй нэг хэсэг учраас энэхүү удирдлагын загварын хувьд хийх ёстой борлуулалтын давтамж буюу үнийн дүнгийн хувьд босго шалгуур байдаггүй.
- МЗУ59. Гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах ба санхүүгийн хөрөнгийг борлуулах ажиллагааны аль алинаар тухайн байгууллагын удирдлагын загварын зорилгод хүрч болох жишээг доор харуулав. Жишээнүүдийн энэхүү жагсаалтанд бүгдийг багтаагаагүй болно. Түүнчлэн, эдгээр жишээ нь байгууллагын удирдлагын загварын үнэлгээнд хамааралтай байж болох бүх хүчин зүйлсийг авч хэлэлцэх, түүнчлэн уг хүчин зүйлсийн холбогдох ач холбогдлыг тусгайлан заах зорилгогүй юм.

Жишээ	Шинжилгээ
<p>Жишээ 5</p> <p>Байгууллага нь хэдэн жилийн дараа капиталын зарлага гаргахаар төлөвлөж байна. Байгууллага нь шаардлагатай болсон үед тэрхүү зарлагыг санхүүжүүлэх боломжтой байхын тулд богино ба урт хугацаат санхүүгийн хөрөнгөнд өөрийн илүүдэл мөнгөөр хөрөнгө оруулалт хийдэг. Олон санхүүгийн хөрөнгө нь тухайн байгууллагын урьдчилан таамаглаж буй хөрөнгө оруулалтын хугацаанаас давсан гэрээний хугацаатай байдаг.</p> <p>Байгууллага нь гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах үүднээс санхүүгийн хөрөнгийг эзэмшдэг бөгөөд боломж гарсан үед</p>	<p>Гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах ба санхүүгийн хөрөнгийг борлуулах ажиллагааны аль алинаар уг удирдлагын загварын зорилгод хүрнэ. Гэрээний мөнгөн гүйлгээний цуглуулалт эсвэл санхүүгийн хөрөнгийн борлуулалт нь тухайн хөрөнгө оруулсан мөнгө шаардлагатай болох хүртэл уг багцын өгөөжийг хамгийн их болгох эсэх талаар байгууллага нь байнга шийдвэр гаргаж байх юм.</p> <p>Харин эсрэгээр, байгууллага нь капитал зарлагыг санхүүжүүлэхийн тулд таван жилийн дараа мөнгөн зарлага гаргана гэж төлөвлөж байгаа бөгөөд богино хугацаат санхүүгийн хөрөнгөнд өөрийн илүүдэл мөнгөөр хөрөнгө оруулалт хийдэг гэж үзнэ. Хөрөнгө оруулалтын хугацаа дуусах үед байгууллага нь богино хугацаат, шинэ санхүүгийн хөрөнгөнд уг мөнгөөр дахин хөрөнгө оруулалт хийнэ. Байгууллага нь мөнгө шаардлагатай болох хүртэл энэ стратегийг баримтлах бөгөөд ингэж мөнгө шаардлагатай болсон</p>

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

<p>санхүүгийн хөрөнгийг борлуулж, уг мөнгөөр илүү өндөр өгөөжтэй санхүүгийн хөрөнгөнд дахин хөрөнгө оруулалт хийдэг.</p> <p>Хөрөнгө оруулалтын багцыг хариуцан удирддаг менежерүүдэд тухайн багцаар бий болгосон нийт өгөөжид үндэслэн урамшуулал олгодог.</p>	<p>үед капитал зарлагыг санхүүжүүлэхийн тулд уг хугацаа дууссан санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн орлогыг ашигладаг. Ингэж хугацаа дуусахаас өмнө (хэрэв зээлийн эрсдэл нэмэгдээгүй л бол) зөвхөн мэдэгдэхүйц бус дүнтэй борлуулалтыг хийдэг. Энэхүү эсрэг тэсрэг удирдлагын загварын зорилго нь гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах үүднээс санхүүгийн хөрөнгийг эзэмших явдал юм.</p>
<p>Жишээ 6</p> <p>Санхүүгийн байгууллага нь өөрийн өдөр тутмын төлбөрийн чадварын хэрэгцээ шаардлагыг хангахын тулд санхүүгийн хөрөнгийг эзэмшдэг. Уг байгууллага нь эдгээр төлбөрийн чадварын хэрэгцээ шаардлагыг удирдан зохицуулах зардлаа хамгийн бага болгохыг эрмэлзэж байгаа бөгөөд иймээс хөрөнгө оруулалтын багцын өгөөжийг идэвхитэй удирдан зохицуулдаг. Өгөөж нь гэрээний төлбөрийн цуглуулалт, түүнчлэн санхүүгийн хөрөнгийн борлуулалтын олз, гарзаас бүрддэг.</p> <p>Иймээс байгууллага нь гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах, санхүүгийн хөрөнгийг борлуулж, арай өндөр өгөөжтэй санхүүгийн хөрөнгөнд дахин хөрөнгө оруулалт хийх эсвэл өр төлбөрийн хугацаатай илүү сайн уялдуулахын тулд санхүүгийн хөрөнгийг эзэмшдэг. Уг стратегийн үр дүнд мэдэгдэхүйц үнэ цэнэтэй борлуулалтыг өмнөх тайлант үед тогтмол хийдэг байсан. Ийм үйл ажиллагааг ирээдүйд үргэлжлүүлэн явуулахаар төлөвлөж байна.</p>	<p>Удирдлагын загварын зорилго нь өдөр тутмын төлбөрийн чадварын хэрэгцээ шаардлагыг хангах үүднээс тухайн хөрөнгө оруулалтын багцын өгөөжийг хамгийн их болгох явдал бөгөөд уг байгууллага нь гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах ба санхүүгийн хөрөнгийг борлуулах ажиллагааны аль алины үр дүнд энэ зорилгыг биелүүлнэ. Өөрөөр хэлбэл, гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах ба санхүүгийн хөрөнгийг борлуулах ажиллагааны аль аль нь тухайн удирдлагын загварын зорилгын биелэлтийн салшгүй нэг хэсэг юм.</p>
<p>Жишээ</p>	<p>Шинжилгээ</p>
<p>Жишээ 7</p> <p>Даатгагч нь даатгалын гэрээний өр төлбөрөө санхүүжүүлэхийн тулд санхүүгийн хөрөнгийг эзэмшдэг. Даатгалын гэрээний өр төлбөрийг барагдуулах шаардлагатай болсон үед даатгагч нь тухайн санхүүгийн хөрөнгөөс бий болох гэрээний мөнгөн орлогыг ашигладаг. Санхүүгийн хөрөнгийн гэрээний мөнгөн гүйлгээ нь тэрхүү өр төлбөрийг барагдуулахад хүрэлцээтэй эсэхийг магадлахын тулд даатгагч нь хөрөнгийн багцаа тэнцвэртэй байлгах, шаардлагатай</p>	<p>Уг удирдлагын загварын зорилго нь даатгалын гэрээний өр төлбөрийг санхүүжүүлэх явдал юм. Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд байгууллага нь шаардлагатай болсон үедээ гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах бөгөөд тухайн хөрөнгийн багцын хүссэн хэмжээг хадгалахын тулд санхүүгийн хөрөнгөө борлуулдаг. Иймээс гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах ба санхүүгийн хөрөнгийг борлуулах ажиллагааны аль аль нь тухайн удирдлагын загварын зорилгын биелэлтийн салшгүй нэг хэсэг юм.</p>

болсон үед мөнгөн гүйлгээний хэрэгцээ шаардлагаа хангах үүднээс мэдэгдэхүйц дүн бүхий худалдан авалт ба борлуулалтын ажиллагааг байнга гүйцэтгэж байдаг.	
--	--

Удирдлагын бусад загвар

МЗУ60. Гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах үүднээс санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилготой удирдлагын загварын хүрээнд, эсвэл гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах ба санхүүгийн хөрөнгийг борлуулах ажиллагааны аль алины зорилгодоо хүрдэг удирдлагын загварын хүрээнд санхүүгийн хөрөнгийг эзэмшдэггүй бол тэдгээр санхүүгийн хөрөнгийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжинэ (гэхдээ 106-р параграфыг бас үзнэ үү). Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжихэд хүргэдэг удирдлагын нэг загвар бол байгууллага тухайн санхүүгийн хөрөнгийг борлуулснаар мөнгөн гүйлгээг хэрэгжүүлэх тийм зорилготойгоор санхүүгийн хөрөнгийг удирдан зохицуулдаг загвар юм. Байгууллага нь хөрөнгийн бодит үнэ цэнэд үндэслэн шийдвэрээ гаргах бөгөөд тэдгээр бодит үнэ цэнийг хэрэгжүүлэхийн тулд тухайн хөрөнгийг удирдан зохицуулдаг. Энэ тохиолдолд уг байгууллагын зорилго нь идэвхитэй худалдан авалт ба борлуулалт хийхэд ихэвчлэн хүргэдэг. Хэдийгээр байгууллага нь санхүүгийн хөрөнгийг эзэмших явцад гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах боловч ингэж гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах, түүнчлэн санхүүгийн хөрөнгийг борлуулах ажиллагааны аль алинаар ийм удирдлагын загварын зорилгод хүрэхгүй. Яагаад гэвэл, гэрээний мөнгөн гүйлгээ цуглуулалт нь уг удирдлагын загварын зорилгын биелэлтийн салшгүй нэг хэсэг биш, харин тохиолдлын шинжтэй үйл ажиллагаа юм.

МЗУ61. Бодит үнэ цэнэд үндэслэн гүйцэтгэлийг нь үнэлж, удирдан зохицуулдаг (46(б) параграфт дурдсан) санхүүгийн хөрөнгийн багцыг түүний гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах зорилгоор ч эзэмшдэггүй, мөн гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах ба санхүүгийн хөрөнгийг борлуулах аль аль зорилгоор ч эзэмшдэггүй. Байгууллага нь бодит үнэ цэнийн мэдээлэлд юуны өмнө анхаарал хандуулдаг бөгөөд тухайн хөрөнгийн гүйцэтгэлийг үнэлж, шийдвэр гаргахын тулд уг мэдээллийг ашигладаг. Түүнчлэн, худалдан арилжих зорилгоор эзэмших гэсэн тодорхойлолтыг хангадаг санхүүгийн хөрөнгийн багцыг түүний гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах зорилгоор ч эзэмшдэггүй, мөн гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах ба санхүүгийн хөрөнгийг борлуулах аль аль зорилгоор ч эзэмшдэггүй. Ийм багцын хувьд, гэрээний мөнгөн гүйлгээний цуглуулалт нь тухайн удирдлагын загварын зорилгыг биелүүлэхэд зөвхөн тохиолдлын шинжтэй үйл явдал байдаг. Иймээс санхүүгийн хөрөнгийн ийм багцыг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ёстой.

Үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд зөвхөн болох гэрээний мөнгөн гүйлгээ

МЗУ62. Гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах үүднээс санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилготой удирдлагын загварын хүрээнд, эсвэл гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах ба санхүүгийн хөрөнгийг борлуулах ажиллагааны аль алинаар зорилгодоо хүрдэг удирдлагын загварын хүрээнд санхүүгийн хөрөнгийг эзэмшдэг бол 44-р параграфыг мөрдөхөөс бусад тохиолдолд байгууллага нь тухайн санхүүгийн хөрөнгийн гэрээний мөнгөн гүйлгээний шинж чанарт үндэслэн түүнийг ангилахыг 39(б) параграфтаар шаардсан байдаг. 40(б) ба 41(б) параграфт заасан нөхцлүүд нь байгууллага ийм ангилал хийхийн тулд тухайн санхүүгийн хөрөнгийн гэрээний мөнгөн гүйлгээ нь зөвхөн үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд мөн эсэхийг тодорхойлохыг шаардана.

МЗУ63. Үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд зөвхөн болох тийм гэрээний мөнгөн гүйлгээ нь энгийн зээлийн хэлцэлтэй нийцэх юм. Энгийн зээлийн хэлцлийн хувьд, мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн (МЗУ67-МЗУ71-р параграфыг үзнэ үү) болон зээлийн эрсдлийн төлбөр нь ихэвчлэн хүүний хамгийн чухал элементүүд байдаг. Гэхдээ ийм хэлцлийн хувьд хүү нь тухайн санхүүгийн хөрөнгийг тодорхой хугацаанд

эзэмшихтэй холбоотой зээлийн бусад үндсэн эрсдлүүд (жишээ нь; төлбөрийн чадварын эрсдэл) болон зардлыг (жишээ нь; захиргаа удирдлагын зардал) мөн багтаасан байдаг. Түүнчлэн, хүү нь энгийн зээлийн хэлцэлд тохирох ашгийг өөртөө агуулсан байна. Эдийн засгийн ховор онцгой тохиолдолд тухайлбал, санхүүгийн хөрөнгийн эзэмшигч нь өөрийн байршуулсан мөнгөний хувьд тодорхой хугацаанд ил буюу далд хэлбэрээр хураамж төлдөг (уг хураамж нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ, зээлийн эрсдэл, зээлийн бусад үндсэн эрсдэл ба зардлын төлөө хүлээн авах төлбөрөөс хэтэрдэг) бол цэвэр хүү нь сөрөг дүнтэй байна. Харин энгийн зээлийн хэлцэлд хамааралгүй өмчийн үнийн эсвэл барааны үнийн өөрчлөлт гэх мэт гэрээний мөнгөн гүйлгээний эрсдэл буюу хувьсан өөрчлөлтийн шалтгаан болдог гэрээний нөхцлүүд нь зөвхөн үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөр болох тийм гэрээний мөнгөн гүйлгээг нэмэгдүүлэхгүй юм. Үүсгэн гаргасан эсвэл худалдан авсан санхүүгийн хөрөнгө нь өөрийн хуулийн хэлбэрээрээ зээл гэж нэрлэгдэх эсэхээс үл хамааран энгийн зээлийн хэлцэлд хамаардаг байж болно.

- МЗУ64. 42(а) параграфт заасанчлан, үндсэн дүн нь тухайн санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үе дэх түүний бодит үнэ цэнэ юм. Гэхдээ уг үндсэн дүн нь тухайн санхүүгийн хөрөнгийн хугацааны туршид (жишээлбэл; үндсэн дүнгээс буцаан төлөлт хийсэн бол) өөрчлөгдөж болно.
- МЗУ65. Гэрээний мөнгөн гүйлгээ нь тухайн санхүүгийн хөрөнгийг илэрхийлсэн валютаар хийгдэх үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүдээс зөвхөн бүрддэг эсэхийг байгууллага үнэлнэ.
- МЗУ66. Хөшүүрэг нь зарим санхүүгийн хөрөнгийн гэрээний мөнгөн гүйлгээний шинж чанар юм. Хөшүүрэг нь хүүний эдийн засгийн шинж чанаргүй тийм үр дүнгээр тухайн гэрээний мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлтийг нэмэгдүүлдэг. Дангаараа байгаа опцион, форвард болон свопын гэрээнүүд нь ийм хөшүүргийг өөртөө агуулсан санхүүгийн хөрөнгийн жишээ юм. Иймээс уг гэрээ нь 40(б) болон 41(б) параграфт заасан нөхцлийг хангахгүй бөгөөд түүнийг дараагийн тайлант үед хорогдуулсан өртгөөр эсвэл цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжихгүй.

Мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн төлбөр

- МЗУ67. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ нь зөвхөн цаг хугацаа урсан өнгөрөлтийн хувьд олгодог төлбөр болох хүүний элемент юм. Өөрөөр хэлбэл, мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн элемент нь тухайн санхүүгийн хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бусад эрсдэл буюу зардлын хувьд төлбөр төлдөггүй. Уг элемент нь зөвхөн цаг хугацаа урсан өнгөрөлтийн хувьд төлбөр төлдөг эсэхийг үнэлэхийн тулд байгууллага нь шүүн тунгаалт хийх бөгөөд санхүүгийн хөрөнгийг илэрхийлсэн валют, хүүний хувийг тогтоосон хугацаа гэх мэт холбогдох хүчин зүйлсийг харгалзан үздэг.
- МЗУ68. Гэвч зарим тохиолдолд мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн элементийг засварлан өөрчилж болох юм (өөрөөр хэлбэл, төгс бус байдаг). Тухайлбал; санхүүгийн хөрөнгийн хүүний хувийг үечлэн тогтоодог боловч ингэж дахин тогтоох давтамж нь хүүний хувийн ерөнхий хугацаатай нийцдэггүй (жишээлбэл; нэг жилийн хүүний хувийг харгалзан хүүний хувийг сар бүр дахин тогтоодог), эсвэл тухайн богино ба урт хугацааны дундаж хүүний хувийг харгалзан санхүүгийн хөрөнгийн хүүний хувийг үечлэн тогтоодог бол ийм нөхцөл байдал үүсэж болно. Ийм нөхцөлд уг гэрээний мөнгөн гүйлгээ нь зөвхөн үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүдийг илэрхийлэх эсэхийг байгууллага үнэлэх ёстой. Зарим тохиолдолд байгууллага нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн элементийн чанарын үнэлгээг хийснээр үүнийг тодорхойлдог бол өөр зарим тохиолдолд тоон үнэлгээ хийх шаардлагатай байж болно.
- МЗУ69. Засварлан өөрчилсөн мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн элементийг үнэлэх үед түүний зорилго нь хэрэв мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн элементийг (стандарт мөнгөн гүйлгээ) өөрчлөөгүй бол үүсэх байсан мөнгөн гүйлгээнээс (дискаунтчлаагүй) уг гэрээний мөнгөн гүйлгээ (дискаунтчлаагүй) хэр өөр байх байсныг тодорхойлох явдал юм. Жишээлбэл; үнэлж буй санхүүгийн хөрөнгө нь хувьсах хүүний хувийг агуулдаг, өөрөөр хэлбэл, нэг жилийн хүүний

хувийг харгалзан хүүний хувийг сар бүр дахин тогтоодог бол байгууллага нь нэг жилийн хүүний хувийг харгалзан уг хувьсах хүүний хувийг сар бүр дахин тогтоохоос бусад талаар ижил гэрээний нөхцөл ба ижил зээлийн эрсдэл бүхий санхүүгийн хэрэглүүртэй тухайн санхүүгийн хөрөнгийг зэрэгцүүлж үзнэ. Засварлан өөрчилсөн мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн элемент нь уг стандарт мөнгөн гүйлгээнээс (дискаунтчлаагүй) мэдэгдэхүйц өөр гэрээний мөнгөн гүйлгээг (дискаунтчлаагүй) үүсгэхээр байвал тухайн санхүүгийн хөрөнгө нь 40(б) ба 41(б) параграфт заасан нөхцлийг хангахгүй юм. Үүнийг тодорхойлохын тулд байгууллага нь засварласан мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн элементийн үр нөлөөг тайлант үе бүрд болон тухайн санхүүгийн хэрэглүүрийн нийт хугацааны туршид хуримтлагдсан байдлаар шинжлэн үзэх ёстой. Хүүний түвшинг яагаад ийм арга замаар тогтоох болсон шалтгаан нь уг шинжилгээнд хамааралгүй юм. Үнэлж буй уг санхүүгийн хөрөнгийн гэрээний (дискаунтчлаагүй) мөнгөн гүйлгээ нь (дискаунтчлаагүй) стандарт мөнгөн гүйлгээнээс мэдэгдэхүйц өөр байна (эсвэл өөр бус байна) гэдэг нь багахан шинжилгээ хийснээр эсвэл огт шинжилгээ хийхгүйгээр тодорхой, ойлгомжтой байвал байгууллага нь нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагагүй юм.

МЗУ70. Засварласан мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн элементийг үнэлэх үед байгууллага нь ирээдүйн гэрээний мөнгөн гүйлгээнд нөлөөлж болох хүчин зүйлсийг харгалзан үзэх ёстой. Жишээлбэл; байгууллага нь таван жилийн хугацаатай бондыг үнэлж байгаа бөгөөд таван жилийн хүүний хувийг харгалзан зургаан сар бүр хувьсах хүүний хувийг дахин тогтоодог тохиолдолд тухайн үнэлгээний өдрөөрх хүүний түвшний муруй нь таван жилийн хүүний хувь ба зургаан сарын хүүний хувь хоорондох зөрүү мэдэгдэхүйц биш байх тийм хэмжээнд байна гэдэг үндэслэлээр уг гэрээний мөнгөн гүйлгээ нь зөвхөн үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд гэж байгууллага нь шууд дүгнэж болохгүй. Харин таван жилийн хүүний хувь ба зургаан сарын хүүний хувь хоорондох харилцан хамаарал нь тухайн санхүүгийн хэрэглүүрийн хугацаанд өөрчлөгдөх, ингэснээр уг санхүүгийн хэрэглүүрийн хугацаан дахь гэрээний (дискаунтчлаагүй) мөнгөн гүйлгээ нь (дискаунтчлаагүй) стандарт мөнгөн гүйлгээнээс мэдэгдэхүйц өөр байж болох эсэхийг байгууллага мөн харгалзан үзэх ёстой. Гэхдээ байгууллага нь боломжит хувилбар бүрийг биш, харин зөвхөн ул үндэслэлтэйгээр боломжтой хувилбарыг харгалзан үзэх ёстой. Гэрээний (дискаунтчлаагүй) мөнгөн гүйлгээ нь (дискаунтчлаагүй) стандарт мөнгөн гүйлгээнээс мэдэгдэхүйц өөр байж болно гэж байгууллага дүгнэсэн бол тухайн санхүүгийн хөрөнгө нь 40(б) болон 41(б) параграфт заасан нөхцлийг хангахгүй, иймээс түүнийг хорогдуулсан өртгөөр эсвэл цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжихгүй.

МЗУ71. Зарим улс орны хувьд Засгийн газар буюу зохицуулах эрх бүхий байгууллага нь хүүний хувь хэмжээг тогтоодог. Тухайлбал; хүүний хувийн талаархи засгийн газрын ийм зохицуулалт нь өргөн хүрээтэй макро эдийн засгийн бодлогын нэг хэсэг байж болно эсвэл эдийн засгийн тодорхой нэг салбарт хөрөнгө оруулах байгууллагуудыг дэмжихийн тулд ийм бодлого хэрэгжүүлж болох юм. Ийм зарим тохиолдолд мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн элементийн зорилго нь зөвхөн цаг хугацаа урсан өнгөрсний төлөө төлбөр төлөх явдал биш байдаг. Гэвч уг зохицуулалттай хүүний хувь хэмжээ нь цаг хугацаа урсан өнгөрөлттэй ерөнхийдөө нийцэх төлбөрийг бүрдүүлдэг бөгөөд энгийн зээлийн хэлцэлд үл нийцэх эрсдэл буюу мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлтийг бий болгодоггүй бол 40(б), 41(б) параграфт заасан нөхцлийг даган мөрдөх зорилгын хувьд МЗУ67-МЗУ70-р параграфыг үл харгалзан тэрхүү хүүний хувь хэмжээг мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн элементийн илэрхийлэл гэж үзнэ.

Гэрээний мөнгөн гүйлгээний хугацаа буюу дүнг өөрчилдөг гэрээний нөхцлүүд

МЗУ72. Санхүүгийн хөрөнгө нь гэрээний мөнгөн гүйлгээний хугацаа буюу дүнг өөрчилж болох гэрээний нөхцлүүдийг агуулдаг (жишээлбэл; хугацаа дуусахаас өмнө хөрөнгийг урьдчилан төлөх эсвэл хугацааг сунгаж болох) бол тэрхүү гэрээний нөхцлийн улмаас тухайн санхүүгийн хэрэглүүрийн хугацаанд үүсэж болох гэрээний мөнгөн гүйлгээ нь зөвхөн үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд эсэхийг байгууллага тодорхойлох ёстой. Ингэж тодорхойлохын тулд байгууллага нь гэрээний мөнгөн гүйлгээг өөрчлөхийн өмнө ба өөрчилсөний дараа үүсэж болох гэрээний мөнгөн гүйлгээнүүдийг үнэлэх

ёстой. Мөн байгууллага нь гэрээний мөнгөн гүйлгээний хугацаа буюу дүнг өөрчлөх аливаа болзошгүй үйл явдлын шинж чанарыг (өөрөөр хэлбэл, өдөөх үйл явдлыг) үнэлэх шаардлагатай байж болно. Гэрээний мөнгөн гүйлгээ нь зөвхөн үндсэн дүнгийн болон хүүний төлбөр эсэхийг үнэлэхэд болзошгүй үйл явдлын шинж чанар нь дангаараа тодорхойлогч хүчин зүйл болохгүй боловч түүний шинж тэмдгийн илэрхийлэгч байж болно. Жишээлбэл; хэрэв зээлдэгч нь төлбөрийг хэд хэдэн удаа төлөөгүй бол хүүг арай нэмэгдүүлж, дахин тогтоодог хүүний хувь бүхий санхүүгийн хэрэглүүрийг тохиролцсон өмчийн индекс нь тодорхой түвшинд хүрвэл хүүг арай нэмэгдүүлж, дахин тогтоодог хүүний хувь бүхий санхүүгийн хэрэглүүртэй харьцуулж үзье. Төлөгдөөгүй төлбөрүүд ба зээлийн эрсдлийн нэмэгдэлт хоорондох харилцан хамаарлаас шалтгаалан эхэнд дурдсан санхүүгийн хэрэглүүрийн хувьд уг хэрэглүүрийн хугацаан дахь гэрээний мөнгөн гүйлгээ нь зөвхөн үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд байх илүү өндөр магадлалтай юм (МЗУ80-р параграфыг бас үзнэ үү).

МЗУ73. Гэрээний мөнгөн гүйлгээ нь зөвхөн үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд болоход хүргэх гэрээний нөхцлийн жишээг доор дурдав:

- (а) Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ, тодорхой хугацааны туршид төлөгдөөгүй байгаа үндсэн дүнтэй холбоотой зээлийн эрсдэл (зөвхөн анх хүлээн зөвшөөрөх үед зээлийн эрсдлийн төлбөрийг тодорхойлж болох бөгөөд ингэснээр тогтмол дүнтэй байж болно), зээлийн бусад үндсэн эрсдлүүд болон зардал, түүнчлэн ашиг зэрэгт хамаарах төлбөрөөс бүрддэг хувьсах хүүний хувь хэмжээ;
- (б) Өрийн хэрэглүүрийг гаргагч (өөрөөр хэлбэл, зээлдэгч) нь түүний дуусгавар болох хугацаанаас өмнө урьдчилан төлөхийг зөвшөөрдөг эсвэл өрийн хэрэглүүрийг эзэмшигч (өөрөөр хэлбэл, зээлдүүлэгч) нь уг дуусгавар болохоос хугацаанаас өмнө буцаан өгөхийг зөвшөөрдөг гэрээний нөхцөл бөгөөд тэрхүү урьдчилсан төлбөр нь үндсэн дүнгийн төлөгдөөгүй хэсэг, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүг үндсэндээ илэрхийлэх ба хүү нь тухайн гэрээг хугацаанаас өмнө цуцалсны зохих нөхөн төлбөрийг багтаасан байж болно;
- (в) Өрийн хэрэглүүрийн гэрээний нөхцлийг сунгахыг гаргагч эсвэл эзэмшигчид зөвшөөрдөг гэрээний нөхцөл (өөрөөр хэлбэл, сунгах сонголт) бөгөөд сунгах сонголтын ийм нөхцөл нь тэрхүү сунгалтын хугацаанд үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөр зөвхөн болох гэрээний мөнгөн гүйлгээг үүсгэдэг ба уг хүү нь тухайн гэрээг хугацаанаас өмнө цуцалсны нэмэлт нөхөн төлбөрийг багтаасан байж болно.

МЗУ74. 40(б) ба 41(б) параграфт заасан нөхцлийг хангах байсан боловч өрийн хэрэглүүрийг түүний дуусгавар болох хугацаанаас өмнө урьдчилж төлөхийг гаргагчид зөвшөөрдөг (эсвэл шаарддаг) эсвэл өрийн хэрэглүүрийг түүний дуусгавар болох хугацаанаас өмнө буцаан өгөхийг эзэмшигчид зөвшөөрдөг (эсвэл шаарддаг) гэрээний зөвхөн тийм нөхцлийн улмаас дээрх параграфуудын нөхцлийг хангахгүй байгаа санхүүгийн хөрөнгийг МЗУ72-р параграфыг үл харгалзан дараах тохиолдолд хорогдуулсан өртгөөр эсвэл цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих шалгуурыг хангана (40(а) параграфт заасан нөхцлийг эсвэл 41(а) параграфт заасан нөхцлийг хангах зүйл) гэж үздэг:

- (а) Байгууллага нь гэрээний нэрлэсэн дүнгээс урамшуулал эсвэл хөнгөлөлт тооцсон дүнгээр санхүүгийн хөрөнгийг олж эзэмшсэн эсвэл үүсгэн гаргасан;
- (б) Урьдчилсан төлбөр нь гэрээний нэрлэсэн дүн болон гэрээний хуримтлагдсан (боловч төлөөгүй) хүүг үндсэндээ илэрхийлэх ба уг хүү нь тухайн гэрээг хугацаанаас өмнө цуцалсны зохих нөхөн төлбөрийг багтаасан байж болно; ба
- (в) Байгууллага нь санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед уг урьдчилсан төлбөрийн шинжүүдийн бодит үнэ цэнэ нь мэдэгдэхүйц биш байх.

МЗУ75. Үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд зөвхөн болох гэрээний мөнгөн гүйлгээг дараах жишээнд үлгэрчлэн харуулав. Жишээний жагсаалтанд бүгдийг багтаагаагүй болно.

Хэрэглүүр	Шинжилгээ
<p>Хэрэглүүр А</p> <p>А хэрэглүүр нь дуусгавар болох тогтоосон хугацаатай бонд юм. Үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд нь уг хэрэглүүрийг гаргасан валютын инфляцийн индекстэй уялдсан. Инфляцийн ийм уялдаа холбоо нь хөшүүрэггүй бөгөөд үндсэн дүнг хамгаалдаг.</p>	<p>Гэрээний мөнгөн гүйлгээ нь зөвхөн үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд байна. Үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүдийг хөшүүрэгдээгүй инфляцийн индекстэй холбох нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг одоогийн буюу тайлант үеийн хүүний түвшнээр тогтооно. Өөрөөр хэлбэл, уг хэрэглүүрийн хүүний түвшин нь 'бодит' хүүг тусгасан байна. Иймээс хүү нь тухайн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгийн мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн төлбөр болох юм.</p> <p>Харин хүүний төлбөрийг зээлдэгчийн үр дүн (жишээлбэл; зээлдэгчийн цэвэр ашиг) эсвэл өмчийн индекс гэх мэт бусад хувьсагчаар индексжүүлдэг бол гэрээний мөнгөн гүйлгээ нь зөвхөн үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд биш юм (зээлдэгчийн үр дүнгээр индексжүүлэх нь уг санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтийн хувьд түүний эзэмшигчид зөвхөн нөхөн төлбөр болох тохируулга хийхэд хүргэдэг ба ингэснээр гэрээний мөнгөн гүйлгээ нь зөвхөн үндсэн дүн болон хүүний төлбөр байхаас бусад тохиолдолд). Яагаад гэвэл, уг гэрээний мөнгөн гүйлгээ нь энгийн зээлийн хэлцэлтэй үл нийцэх өгөөжийг тусгасан байдаг (МЗУ63-р параграфыг үзнэ үү).</p>
<p>Хэрэглүүр Б</p> <p>Б хэрэглүүр нь зах зээлийн хүүний түвшинг байнга сонгох боломжийг зээлдэгчид олгодог хувьсах хүүний хувь хэмжээтэй, дуусгавар болох тогтоосон хугацаатай хэрэглүүр юм. Жишээлбэл; хүүний түвшинг дахин тогтоох өдөр бүрээр уг зээлдэгч нь гурван сарын хугацаанд 3 сарын ЛИБОР-оор эсвэл нэг сарын хугацаанд 1 сарын ЛИБОР-оор төлөх сонголтыг хийж болох юм.</p>	<p>Хэрэглүүрийн хугацаанд төлсөн хүү нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ, уг хэрэглүүртэй холбоотой зээлийн эрсдэл, зээлийн бусад үндсэн эрсдлүүд болон зардал, түүнчлэн ашиг зэрэгт хамаарах төлбөрүүдийг тусгадаг бол тэрхүү гэрээний мөнгөн гүйлгээ нь зөвхөн үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд байна (МЗУ63-р параграфыг үзнэ үү). Тухайн хэрэглүүрийн хугацаанд ЛИБОР хүүний түвшинг дахин тогтоодог бодит байдал нь уг хэрэглүүр шалгуур хангахгүй байх шалтгаан дангаараа болохгүй юм.</p> <p>Гэхдээ хүүний түвшинг гурван сар бүрээр тогтоодог боловч зээлдэгч нь нэг сарын хүүний түвшнээр төлөхөөр сонголт хийх боломжтой бол хүүний түвшний ерөнхий хугацаатай нийцэхгүй тийм давтамжаар хүүний түвшинг дахин тогтоох юм. Үүний үр дүнд мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн элементийг засварлан өөрчилдөг. Үүнтэй адилаар, хэрэв хэрэглүүр нь түүний үлдсэн хугацаанаас илүү урт хугацаанд үндэслэн тогтоосон гэрээний хүүний түвшинтэй (жишээлбэл; таван жилийн дуусгавар болох хугацаатай хэрэглүүр нь үечлэн дахин тогтоосон хувьсах хүүг төлдөг боловч уг таван жилийн дуусгавар болох хугацааг байнга тусгадаг) бол мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн элементийг засварлан өөрчилнө. Яагаад гэвэл, тайлант үе бүрд төлөх хүүний өглөг нь тэрхүү хүүний хугацаанаас хамааралгүй болсон байдаг.</p> <p>Ийм тохиолдолд мөнгөн гүйлгээ нь зөвхөн үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний</p>

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

	<p>төлбөр эсэхийг тодорхойлохын тулд хүүний түвшний ерөнхий хугацаа нь тухайн хүүний хугацаатай нийцдэг гэдгээс бусад бүх талаар ижил төсөөтэй байх санхүүгийн хэрэглүүрийн мөнгөн гүйлгээтэй харьцуулснаар байгууллага нь уг гэрээний мөнгөн гүйлгээг чанарын болон тоон талаас үнэлэх ёстой (зохицуулалттай хүүний хувь хэмжээний талаархи заавар удирдамжийг МЗУ71-р параграфаас үзнэ үү).</p> <p>Жишээлбэл; таван жилийн хугацаатай, хүүг нь зургаан сар тутамд дахин тогтоодог боловч таван жилийн дуусгавар болох хугацааг байнга тусгадаг, хувьсах хүүтэй бондыг үнэлэхдээ байгууллага нь зургаан сарын хугацааны хүүний түвшнээр 6 сар тутамд хүүг тогтоодогоос бусад талаар ижил төсөөтэй хэрэглүүрийн гэрээний мөнгөн гүйлгээг харгалзан үздэг.</p> <p>Хэрэв зээлдэгч нь тухайн зээлдүүлэгчийн хэвлэн нийтэлсэн янз бүрийн хүүний түвшнүүдээс сонголт хийх боломжтой (жишээлбэл; зээлдэгч нь тухайн зээлдүүлэгчийн хэвлэн нийтэлсэн нэг сарын хувьсах хүүний түвшин ба хэвлэн нийтэлсэн гурван сарын хувьсах хүүний түвшнээс сонгож болох) бол дээрхтэй ижил шинжилгээг хийнэ.</p>
<p>Хэрэглүүр В</p> <p>В хэрэглүүр нь дуусгавар болох тогтоосон хугацаатай бөгөөд зах зээлийн хувьсах хүүний түвшнээр хүүг төлдөг бонд юм. Ийм хувьсах хүүний түвшний хувьд дээд хэмжээг тогтоодог.</p>	<p>Хүү нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ, уг хэрэглүүрийн хугацаанд түүнтэй холбоотой зээлийн эрсдэл, зээлийн бусад үндсэн эрсдлүүд болон зардал, түүнчлэн ашиг зэрэгт хамаарах төлбөрүүдийг тусгадаг бол дараах хоёр хэрэглүүрийн аль алины гэрээний мөнгөн гүйлгээ нь зөвхөн үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд байна (МЗУ63-р параграфыг үзнэ үү):</p> <p>(а) тогтмол хүүний түвшинтэй хэрэглүүр ба</p> <p>(б) хувьсах хүүний түвшинтэй хэрэглүүр.</p> <p>Иймээс дээрх (а) ба (б)-г хослуулсан хэрэглүүр (жишээлбэл; хүүний түвшний дээд хэмжээ бүхий бонд) нь зөвхөн үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд болох мөнгөн гүйлгээтэй байж болно. Гэрээний ийм нөхцөл нь хувьсах хүүний түвшинд хязгаар (жишээлбэл; хүүний түвшний дээд буюу доод хэмжээ) тогтоосноор мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлтийг бууруулж эсвэл тогтмол хүүний хувийг хувьсах хүү болгосноор мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлтийг нэмэгдүүлж болох юм.</p>
<p>Хэрэглүүр Г</p> <p>Г хэрэглүүр нь бүрэн баталгаатай зээл бөгөөд барьцаагаар хамгаалагдсан байна.</p>	<p>Бүрэн баталгаатай зээл барьцаагаар хамгаалагдсан байх нь тухайн гэрээний мөнгөн гүйлгээ зөвхөн үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөр болох эсэх талаархи шинжилгээнд дангаараа нөлөө үзүүлэхгүй юм.</p>
<p>Хэрэглүүр Д</p> <p>Зохицуулалттай банк нь Д хэрэглүүрийг гаргасан бөгөөд уг хэрэглүүр нь дуусгавар болох тогтоосон хугацаатай. Энэхүү хэрэглүүр нь тогтмол хувь</p>	<p>Үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд зөвхөн болох мөнгөн гүйлгээг үүсгэдэг, иймээс энгийн зээлийн хэлцэлтэй нийцэх эсэхийг тодорхойлохын тулд эзэмшигч нь тухайн санхүүгийн хэрэглүүрийн гэрээний нөхцлийг шинжилж болох юм.</p> <p>Д хэрэглүүрийн эзэмшигчдэд алдагдлыг хүлээлгэх уг үндэсний зохицуулах байгууллагын бүрэн эрхийн үр дүнд зөвхөн үүсэх</p>

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

<p>хэмжээгээр хүүг төлдөг бөгөөд гэрээний бүх мөнгөн гүйлгээ нь заавал төлөгдөх шинж чанартай.</p> <p>Гэвч тодорхой нөхцөлд тухайн хэрэглүүрийн, үүн дотроо Д хэрэглүүрийн эзэмшигчдэд алдагдлыг хүлээлгэх эрхийг үндэсний зохицуулах байгууллагад олгодог буюу ингэхийг тэрхүү байгууллагаас шаарддаг хууль тогтоомжинд уг гаргагч захирагддаг. Жишээлбэл; үндэсний зохицуулах байгууллага нь тухайн гарагчийг санхүүгийн ноцтой хүндрэлд орж байгаа, зохицуулалтын нэмэлт капитал шаардлагатай эсвэл “төлбөрийн чадваргүй болсон” гэж тодорхойлсон бол уг байгууллага нь Д хэрэглүүрийн нэрлэсэн үнийг бууруулах эсвэл тухайн гаргагчийн тодорхой тооны энгийн хувьцаанд хөрвүүлэх бүрэн эрхтэй байдаг.</p>	<p>төлбөрүүдийг энэхүү шинжилгээнд харгалзан үзэхгүй. Яагаад гэвэл, энэхүү бүрэн эрх, түүнчлэн түүний үр дүн болох төлбөрүүд нь тухайн санхүүгийн хэрэглүүрийн гэрээний нөхцөл биш юм.</p> <p>Харин эсрэгээр, тухайн санхүүгийн хэрэглүүрийн гэрээний нөхцөл нь түүний эзэмшигчдэд алдагдлыг хүлээлгэхийг (жишээлбэл; хэрэглүүрийн нэрлэсэн үнийг бууруулах эсвэл гаргагчийн тодорхой тооны энгийн хувьцаанд хөрвүүлэхийг) гаргагчид буюу бусад этгээдэд зөвшөөрдөг эсвэл ингэхийг шаарддаг бол хэдийгээр алдагдлыг хүлээлгэх магадлал маш бага боловч гэрээний тийм заалт байгаа тохиолдолд уг гэрээний мөнгөн гүйлгээ нь зөвхөн үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд болохгүй юм.</p>
---	--

МЗУ76. Үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд зөвхөн болохгүй гэрээний мөнгөн гүйлгээг дараах жишээнд үлгэрчлэн харуулав. Жишээний жагсаалтанд бүгдийг багтаагаагүй болно.

Хэрэглүүр	Шинжилгээ
<p>Хэрэглүүр Е</p> <p>Е хэрэглүүр нь гаргагчийн тодорхой тооны өмчийн хэрэглүүрт хөрвөх бонд юм.</p>	<p>Эзэмшигч нь уг хөрвөх бондыг бүхэлд нь шинжилнэ.</p> <p>Энгийн зээлийн хэлцэлтэй (МЗУ63-р параграфыг үзнэ үү) үл нийцэх өгөөжийг тусгадаг учраас уг гэрээний мөнгөн гүйлгээ нь зөвхөн үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд биш юм; өөрөөр хэлбэл, өгөөж нь тухайн гаргагчийн өмчийн үнэ цэнэтэй холбоотой байна.</p>
<p>Хэрэглүүр Ж</p> <p>Ж хэрэглүүр нь урвуу хөвөх хүүний түвшнээр хүүг төлдөг зээл юм (өөрөөр хэлбэл, хүүний түвшин нь зах зээлийн</p>	<p>Гэрээний мөнгөн гүйлгээ нь зөвхөн үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд биш юм.</p> <p>Хүү нь төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгийн мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн төлбөр биш юм.</p>

хүүний түвшинтэй урвуу хамааралтай байдаг).	
<p>Хэрэглүүр И</p> <p>И хэрэглүүр нь хугацаагүй хэрэглүүр боловч гаргагч нь дурын хугацаанд уг хэрэглүүрийг дуудаж болох ба нэрлэсэн дүн дээр хуримтлагдсан хүүг нэмж төлнө.</p> <p>И хэрэглүүр нь зах зээлийн хүүний түвшнээр хүүг төлөх боловч хэрэв гаргагч нь төлбөр хийсний дараа төлбөрийн чадвартай байдлаа хадгалж үлдэхээргүй бол хүүг төлдөггүй.</p> <p>Хойшлогдсон хүүний төлбөрийн хувьд хүү тооцохгүй.</p>	<p>Гэрээний мөнгөн гүйлгээ нь зөвхөн үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд биш юм. Яагаад гэвэл, гаргагч нь хүүний төлбөрүүдийг хойшлуулах шаардлагатай байж болох бөгөөд тэдгээр хойшлогдсон хүүний хувьд нэмэлт хүү хуримтлуулан тооцдоггүй. Иймээс хүү нь төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгийн мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн төлбөр биш юм.</p> <p>Харин хойшлогдсон төлбөрийн хувьд хүүг хуримтлуулан тооцдог бол гэрээний мөнгөн гүйлгээ нь үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд байж болох юм.</p> <p>И хэрэглүүр хугацаагүй байгаа нь түүний гэрээний мөнгөн гүйлгээ зөвхөн үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд биш гэсэн үндэслэл дангаараа болохгүй юм. Үнэн хэрэгтээ, хугацаагүй хэрэглүүр нь тасралтгүй (олон удаа) сунгах опционуудтай байдаг. Хүүний төлбөрийг заавал хийдэг бөгөөд түүнийг тасралтгүй төлөх ёстой бол ийм опцион нь гэрээний мөнгөн гүйлгээг үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд болгох үр дүнтэй байж болно.</p> <p>Мөн И хэрэглүүрийг үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрийг бараг тусгаагүй дүнгээр дуудаж болохоос бусад тохиолдолд тэрхүү хэрэглүүрийг дуудах боломжтой байдал нь түүний гэрээний мөнгөн гүйлгээ зөвхөн үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд биш гэсэн үндэслэл дангаараа болохгүй юм. Уг дуудаж болох дүн нь тэрхүү хэрэглүүрийг хугацаанаас өмнө цуцалсны төлөө тухайн эзэмшигчид олгох зохих нөхөн төлбөрийн дүнг агуулсан байлаа ч гэсэн гэрээний мөнгөн гүйлгээ нь үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд байж болох юм. (МЗУ74-р параграфыг бас үзнэ үү.)</p>

- МЗУ77. Зарим тохиолдолд санхүүгийн хөрөнгө нь үндсэн дүн ба хүү гэж нэрлэн тодорхойлсон гэрээний мөнгөн гүйлгээтэй байж болох боловч тэдгээр мөнгөн гүйлгээ нь энэ Стандартын 40(б), 41(б), 42-р параграфуудад заасан үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүдийг төлөөлөн илэрхийлдэггүй.
- МЗУ78. Санхүүгийн хөрөнгө нь тодорхой хөрөнгөнд эсвэл мөнгөнд оруулсан хөрөнгө оруулалтыг илэрхийлдэг, иймээс гэрээний мөнгөн гүйлгээ нь зөвхөн үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд биш бол ийм тохиолдол үүсэж болно. Жишээлбэл; тодорхой нэг төлбөртэй замыг олон машин ашиглахын хэрээр уг санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээ нэмэгдэхээр гэрээний нөхцөлд заасан бол тэрхүү гэрээний мөнгөн гүйлгээ нь энгийн зээлийн хэлцэлтэй нийцэхгүй юм. Иймээс уг хэрэглүүр нь 40(б) болон 41(б) параграфт заасан нөхцлийг хангахгүй. Зээлдүүлэгчийн нэхэмжлэл нь зээлдэгчийн тодорхой хөрөнгөөр эсвэл тухайн тодорхой хөрөнгөөс орох мөнгөн гүйлгээгээр хязгаарлагддаг (жишээлбэл; ‘баталгаагүй’ санхүүгийн хөрөнгө) бол ийм тохиолдол үүсэж болно.
- МЗУ79. Гэвч санхүүгийн хөрөнгө баталгаагүй байгаа нь уг санхүүгийн хөрөнгө 40(б) болон 41(б) параграфт заасан нөхцлийг хангахгүй гэсэн үндэслэл дангаараа болохгүй юм. Ийм тохиолдолд тухайн ангилж буй санхүүгийн хөрөнгийн гэрээний мөнгөн гүйлгээ нь үндсэн дүнгийн,

түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд эсэхийг тодорхойлохын тулд зээлдүүлэгч нь уг суурь хөрөнгө буюу мөнгөн гүйлгээг үнэлэх (“иж бүрэн авч үзэх”) шаардлагатай байдаг. Хэрэв санхүүгийн хөрөнгийн нөхцөл нь үндсэн дүн болон хүүг илэрхийлэх төлбөртэй үл нийцэх байдлаар өөр бусад мөнгөн гүйлгээг үүсгэх эсвэл мөнгөн гүйлгээг хязгаарлах үр дүнтэй бол уг санхүүгийн хөрөнгө нь 40(б) болон 41(б) параграфт заасан нөхцлийг хангахгүй юм. Тухайн суурь хөрөнгө нь санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн бус хөрөнгө эсэх нь энэхүү үнэлгээнд нөлөөлөхгүй.

- МЗУ80. Гэрээний мөнгөн гүйлгээний шинж чанар нь тухайн санхүүгийн хөрөнгийн гэрээний мөнгөн гүйлгээнд маш бага үр нөлөөтэй бол тэрээр уг санхүүгийн хөрөнгийн ангилалд нөлөө үзүүлэхгүй. Үүнийг тодорхойлохын тулд байгууллага нь тайлант үе бүрд болон уг санхүүгийн хэрэглүүрийн хугацаанд хуримтлагдсан байдлаараа тэрхүү гэрээний мөнгөн гүйлгээний шинж чанаруудын үзүүлэх боломжит үр нөлөөг харгалзан үзэх ёстой. Түүнчлэн, гэрээний мөнгөн гүйлгээний шинж чанарууд нь тухайн гэрээний мөнгөн гүйлгээнд маш бага гэдгээс илүү үр нөлөө (нэг тайлант үед эсвэл хуримтлагдсан байдлаараа) үзүүлэх боломжтой боловч уг мөнгөн гүйлгээний шинж чанар нь бодитой бус бол санхүүгийн хөрөнгийн ангилалд нөлөөлөхгүй. Туйлын ховор, ихээхэн хэвийн бус бөгөөд гарч тохиолдох магадлал багатай үйл явдал зөвхөн гарч тохиолдсоноор мөнгөн гүйлгээний шинж чанар нь тухайн санхүүгийн хэрэглүүрийн мөнгөн гүйлгээнд нөлөөлөхөөр бол тийм мөнгөн гүйлгээний шинж чанарыг бодитой бус гэж үздэг.
- МЗУ81. Зээл олгох бараг бүх ажил гүйлгээнд тухайн зээлдүүлэгчийн хэрэглүүрийг уг зээлдэгчийн бусад зээлдүүлэгчдийн хэрэглүүртэй харьцуулан эрэмбийг тогтоодог. Зээлдэгч төлбөрийг үл төлөх нь гэрээний зөрчил болдог бөгөөд тэрхүү зээлдэгч дампуурсан ч гэсэн өрийн хэрэглүүрийн эзэмшигч нь төлөгдөөгүй үндсэн дүн, түүнчлэн үндсэн дүнгээс тооцогдох хүүг авах гэрээний эрхтэй бол бусад хэрэглүүртэй харьцуулахад тэргүүн бус ээлжийн эрхтэй хэрэглүүр нь үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцогдох хүүний төлбөр болох гэрээний мөнгөн гүйлгээтэй байж болох юм. Жишээлбэл; өөрийн зээлдүүлэгчийг ерөнхий зээлдүүлэгч гэж эрэмбэлдэг дансны авлага нь үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй үндсэн дүнгээс тооцогдох хүүний төлбөрүүдийг авах шалгуурыг хангах юм. Зээлдэгч нь барьцаат зээл гаргасан бөгөөд тэрээр дампуурсан ч гэсэн ерөнхий зээлдүүлэгчдээс тэргүүн ээлжинд уг барьцааг нэхэмжлэх эрхийг тухайн зээлийн эзэмшигчид олгодог боловч төлөөгүй үндсэн дүн болон бусад төлбөрийг авах тэдгээр ерөнхий зээлдүүлэгчдийн эрхэнд нөлөөлдөггүй бол ийм тохиолдол үүснэ.

Гэрээгээр холбогдсон хэрэглүүрүүд

- МЗУ82. Зарим төрлийн ажил гүйлгээнд гаргагч нь зээлийн эрсдлийн төвлөрөл (багц) үүсгэдэг, гэрээгээр холбогдсон олон хэрэглүүрүүдийг ашигласнаар санхүүгийн хөрөнгийн эзэмшигчдэд төлөх төлбөрийг тэргүүн ээлжийн эрхтэй болгож болох юм. Багц бүр нь уг гаргагчийн бий болгосон аливаа мөнгөн гүйлгээг тухайн багцад хуваарилах дарааллыг тусгайлан заасан тэргүүн бус ээлжийн эрэмбэтэй байдаг. Ийм тохиолдолд уг гаргагч нь арай өндөр эрэмбийн багцуудыг төлөх хангалттай мөнгөн гүйлгээг бий болгосон бол тухайн багцын эзэмшигчид нь үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүдийг авах эрхтэй байдаг.
- МЗУ83. Ийм ажил гүйлгээний хувьд багц нь зөвхөн дараах тохиолдолд үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд болох тийм мөнгөн гүйлгээний шинж чанартай байна:
- (а) Ангилал хийхийн тулд (санхүүгийн хэрэглүүрүүдийн үндсэн нэгдлийг иж бүрэн авч үзэхгүйгээр) үнэлж буй тухайн багцын гэрээний нөхцөл нь зөвхөн үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд болох гэрээний мөнгөн гүйлгээг үүсгэдэг (жишээлбэл; багцын хүүний түвшин нь бараа бүтээгдэхүүний индекстэй холбоогүй) байх;

- (б) Санхүүгийн хэрэглүүрүүдийн үндсэн нэгдэл нь МЗУ85, МЗУ86-р параграфт заасан мөнгөн гүйлгээний шинж чанаруудтай байх; ба
 - (в) Багцад хамаардаг санхүүгийн хэрэглүүрүүдийн үндсэн нэгдлийн зээлийн эрсдэл нь тухайн санхүүгийн хэрэглүүрүүдийн үндсэн нэгдлийн зээлийн эрсдэлтэй тэнцүү эсвэл түүнээс бага байх (жишээлбэл; ангилал хийхийн тулд үнэлж буй уг багцын зээлийн зэрэглэл нь тухайн санхүүгийн хэрэглүүрүүдийн үндсэн нэгдлийг санхүүжүүлэхэд ашигласан нэг багцад хамаарах зээлийн зэрэглэлтэй тэнцүү эсвэл түүнээс өндөр байна).
- МЗУ84. Байгууллага нь мөнгөн гүйлгээг (дамжуулах биш харин) үүсгэн бий болгодог хэрэглүүрүүдийн үндсэн нэгдлийг тодорхойлох хүртлээ тэдгээрийг иж бүрэн авч үзэх ёстой. Мөнгөн гүйлгээг бий болгодог хэрэглүүрүүд нь санхүүгийн хэрэглүүрүүдийн үндсэн нэгдэл юм.
- МЗУ85. Үндсэн нэгдэл нь зөвхөн үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд болох гэрээний мөнгөн гүйлгээ бүхий нэг буюу хэд хэдэн хэрэглүүрүүдийг өөртөө агуулсан байх ёстой.
- МЗУ86. Хэрэглүүрүүдийн үндсэн нэгдэл нь мөн дараах хэрэглүүрүүдийг агуулсан байж болно:
- (а) МЗУ85-р параграфт хамаарах хэрэглүүрийн мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлтийг бууруулдаг бөгөөд МЗУ85-р параграфт хамаарах хэрэглүүртэй нэгтгэсэн үед зөвхөн үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд болох мөнгөн гүйлгээг үүсгэдэг (жишээлбэл; хүүний түвшний дээд буюу доод хэмжээ, эсвэл МЗУ85-р параграфт хамаарах бүх буюу зарим хэрэглүүрүүдийн зээлийн эрсдлийг бууруулах гэрээ); эсвэл
 - (б) Зөвхөн доорх зүйлсээс шалтгаалсан зөрүүг авч үзэхийн тулд МЗУ85-р параграфт хамаарах хэрэглүүрүүдийн үндсэн нэгдлийн мөнгөн гүйлгээтэй тухайн багцын мөнгөн гүйлгээг тохируулдаг:
 - (i) Хүүний түвшин нь тогтмол эсвэл хөвөх эсэх;
 - (ii) Мөнгөн гүйлгээг илэрхийлсэн валют, үүн дотроо уг валютанд хамаарах инфляци; эсвэл
 - (iii) Мөнгөн гүйлгээний хугацаа.
- МЗУ87. Тухайн нэгдэл дэх аль нэг хэрэглүүр нь МЗУ85 эсвэл МЗУ86-р параграфт заасан нөхцлийг хангахгүй бол МЗУ83(б) параграфт заасан нөхцөл биелэхгүй юм. Ийм үнэлгээг хийхдээ тухайн нэгдлийн хэрэглүүр тус бүрээр нарийвчилсан шинжилгээ хийх шаардлагагүй байж болно. Гэхдээ тухайн нэгдэл дэх хэрэглүүрүүд нь МЗУ85-МЗУ86-р параграфт заасан нөхцлүүдийг хангах эсэхийг тодорхойлохын тулд байгууллага нь өөрийн шүүн тунгаалтыг ашиглах ба хангалттай шинжилгээ хийх ёстой. (Маш бага үр нөлөө бүхий гэрээний мөнгөн гүйлгээний шинж чанаруудын талаархи заавар удирдамжийг МЗУ80-р параграфтаас бас үзнэ үү).
- МЗУ88. Хэрэв эзэмшигч нь анх хүлээн зөвшөөрөх үедээ МЗУ83-р параграфт заасан нөхцлийг үнэлэх боломжгүй бол уг багцыг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ёстой. Хэрэглүүрүүдийн үндсэн нэгдэл нь МЗУ85-МЗУ86-р параграфт заасан нөхцлүүдийг хангахгүй болох тийм байдлаар анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа өөрчлөгдсөн бол уг багц нь МЗУ83-р параграфт заасан нөхцлийг хангахгүй бөгөөд түүнийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ёстой. Гэвч үндсэн нэгдэл нь МЗУ85-МЗУ86-р параграфт заасан нөхцлийг хангахгүй хөрөнгүүдээр барьцаа үүсгэж, хамгаалагдсан тийм хэрэглүүрүүдийг агуулж байгаа бол байгууллага нь тэрхүү барьцааг хяналтандаа авах үүднээс уг багцыг эзэмшсэнээс бусад тохиолдолд энэхүү параграфыг мөрдөх зорилгын хувьд тэдгээр барьцаа хөрөнгийг эзэмшилдээ авах боломжит байдлыг харгалзан үзэхгүй.

Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилах боломж

МЗУ89. 44 ба 46-р параграфт заасан нөхцлийн дагуу санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөр эсвэл санхүүгийн хэрэглүүрүүдийн бүлгийг (санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөр эсвэл эдгээрийн аль алиныг) ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилах нь илүү хамааралтай мэдээллээр хангах үр дүнтэй байвал энэхүү Стандарт нь ингэж ангилахыг байгууллагад зөвшөөрдөг.

МЗУ90. Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилах байгууллагын сонголт нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын сонголттой ижил төсөөтэй байдаг (гэвч нягтлан бодох бүртгэлийн бодлогын сонголтаас ялгаатай нь ийм сонголтыг ижил төсөөтэй бүх ажил гүйлгээнд тууштай мөрдөхийг заавал шаарддаггүй). Байгууллага нь бодлогын ийм сонголт хийсэн тохиолдолд тухайн сонгосон бодлого нь байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээнд ажил гүйлгээ, бусад үйл явдал болон нөхцөл байдлын үзүүлэх үр нөлөөний талаархи найдвартай бөгөөд илүү хамааралтай мэдээллийг тухайн санхүүгийн тайланд бий болгох үр дүнтэй байхыг УСНББОУС 3-ын 12-р параграфтаар шаарддаг. Тухайлбал; санхүүгийн өр төлбөрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилах тохиолдолд илүү хамааралтай мэдээллийн талаархи шаардлага хангагдах хоёр нөхцлийг 46-р параграфт заасан байдаг. Иймээс 46-р параграфын дагуу ийм ангилал хийхээр сонгохын тулд байгууллага нь эдгээр хоёр нөхцлийн аль нэгийг (эсвэл хоёуланг нь) хангасан гэдгээ батлан харуулах шаардлагатай юм.

Нягтлан бодох бүртгэлийн уялдаагүй байдлыг арилгах буюу мэдэгдэхүйц бууруулах ангилал

МЗУ91. Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн хэмжилт болон тэдгээрийн үнэ цэнийн хүлээн зөвшөөрсөн өөрчлөлтийн ангиллыг тухайн зүйлийн ангиллаар, түүнчлэн уг зүйл нь сонгосон хейжийн харилцааны нэг хэсэг эсэхээр тодорхойлдог. Энэ шаардлага нь хэмжилтийн эсвэл хүлээн зөвшөөрөлтийн тууштай бус байдлыг (зарим үед “нягтлан бодох бүртгэлийн уялдаагүй байдал” гэж нэрлэдэг) үүсгэж болох юм. Жишээлбэл; ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилаагүй тохиолдолд уг санхүүгийн хөрөнгийг дараагийн тайлант үед ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилах болсон ба тэрхүү санхүүгийн хөрөнгөтэй холбоотой гэж байгууллагын үзэж буй өр төлбөрийг дараагийн тайлант үед (бодит үнэ цэнийн өөрчлөлтүүдийг хүлээн зөвшөөрөхгүйгээр) хорогдуулсан өртгөөр хэмжсэн. Ийм тохиолдолд байгууллага нь тэдгээр хөрөнгө, өр төлбөрийн аль алиныг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн бол илүү хамааралтай мэдээллийг түүний санхүүгийн тайланд тусган илэрхийлэх байсан гэж үзэж болох юм.

МЗУ92. Ийм нөхцөл хэзээ үүсэж болохыг дараах жишээнд харуулав. 44 эсвэл 46-р параграфт дурдсан зарчим хангагдах бол байгууллага нь санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилахын тулд энэхүү нөхцлийг дараах бүх тохиолдолд ашиглаж болно:

- (а) Байгууллага нь СТОУС 17-гийн цар хүрээнд хамаарах гэрээний үүрэгтэй (түүний хэмжилтэнд одоогийн мэдээллийг нэгтгэн тусгадаг) бөгөөд түүнтэй холбоотой гэж үзсэн, харин үүнээс өөр тохиолдолд цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр эсвэл хорогдуулсан өртгөөр хэмжих санхүүгийн хөрөнгөтэй байх.
- (б) Байгууллага нь хүүний түвшний эрсдэл гэх мэт эрсдлийг хуваалцдаг бөгөөд бие биенийгээ харилцан нөхөх хандлагатайгаар бодит үнэ цэнийн эсрэг тэсрэг өөрчлөлтийг бий болгодог санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөртэй эсвэл тэдгээрийн аль алинтай байх. Гэвч зөвхөн зарим хэрэглүүрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг (жишээлбэл; үүсмэл хэрэглүүр болох эсвэл худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэж ангилсан зүйлс) байх. Тухайлбал, 129-р параграфт заасан хейжийн үр дүнтэй байдлын шаардлага хангагдаагүйн улмаас хейжийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагыг хангахгүй бол мөн ийм тохиолдол үүсэж болох юм.
- (в) Байгууллага нь хүүний түвшний эрсдэл гэх мэт эрсдлийг хуваалцдаг, бие биенийгээ харилцан нөхөх хандлагатайгаар бодит үнэ цэнийн эсрэг тэсрэг өөрчлөлтийг бий болгодог санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөртэй эсвэл тэдгээрийн аль алинтай

бөгөөд ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжээгүй учраас санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн аль нь ч хейжийн хэрэглүүр гэж ангилах шалгуурыг хангаагүй байх. Түүнчлэн, хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглээгүй үед олз, гарзын хүлээн зөвшөөрөлтөнд мэдэгдэхүйц тууштай бус байдлыг үүсгэхээр байх. Жишээлбэл; байгууллага нь бодит үнэ цэнийн өөрчлөлтөөрөө бие биенийгээ харилцан нөхөх хандлагатай бонд гаргах замаар зээлийн тодорхой бүлгийг санхүүжүүлэх. Мөн түүнчлэн, байгууллага нь бондыг байнга худалдан авч, борлуулдаг боловч зээлийг бараг худалдан авч, борлуулдаггүй бол тэдгээр зээл, бондын аль алиныг өөр бусад тохиолдолд хорогдуулсан өртгөөр хэмжиж, бондыг буцаан худалдан авах үед олз, гарзыг хүлээн зөвшөөрөх байсан бөгөөд харин уг зээл, бондын аль алиныг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр тайлагнаснаар олз, гарзын хүлээн зөвшөөрөлтийн хугацааны ийм тууштай бус байдлыг арилгах юм.

МЗУ93. Өөр бусад тохиолдолд ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилахгүй байсан санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийг өмнөх параграфт дурдсантай адил гэх мэт нөхцөл байдалд анх хүлээн зөвшөөрөхдөө ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилах нь хэмжилт болон хүлээн зөвшөөрөлтийн тууштай бус байдлыг арилгах буюу мэдэгдэхүйц бууруулах ба илүү хамааралтай мэдээлэл бий болоход хүргэж болох юм. Практик зорилгын хувьд байгууллага нь хэмжилт буюу хүлээн зөвшөөрөлтийн тууштай бус байдлыг үүсгэх хөрөнгө, өр төлбөрийн бүх ажил гүйлгээг яг нэг ижил хугацаанд хийсэн байх албагүй юм. Ажил гүйлгээ бүрийг анх хүлээн зөвшөөрөхдөө ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилдаг бөгөөд үлдсэн аливаа ажил гүйлгээнүүд нь гарч тохиолдоно гэж хүлээж байгаа бол зохих ёсоор хойшлуулахыг зөвшөөрдөг.

МЗУ94. Тууштай бус байдлыг үүсгэдэг санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийн зөвхөн зарим хэсгийг нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилах нь тэрхүү тууштай бус байдлыг арилгадаггүй эсвэл мэдэгдэхүйц бууруулдаггүй, иймээс илүү хамааралтай мэдээлэл бий болгодоггүй бол тэрхүү санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийн зарим хэсгийг ингэж ангилахыг зөвшөөрөхгүй. Харин ижил төсөөтэй, олон санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн зөвхөн зарим хэсгийг ингэж ангилах нь уг тууштай бус байдлыг мэдэгдэхүйц бууруулж байвал (хүлээн зөвшөөрч болох бусад ангилалуудаас илүү их хэмжээгээр бууруулах боломжтой бол) ингэж ангилахыг зөвшөөрнө. Жишээлбэл; байгууллага нь 100ТН-ийн үнийн дүн бүхий ижил төсөөтэй, олон санхүүгийн өр төлбөртэй ба 50ТН-ийн үнийн дүн бүхий ижил төсөөтэй, олон санхүүгийн хөрөнгөтэй боловч тэдгэрийг өөр өөр сууриар хэмждэг гэж үзье. Тухайн байгууллага нь анх хүлээн зөвшөөрөх үедээ тэдгээр хөрөнгийг бүгдийг нь, харин өр төлбөрийн зөвхөн зарим хэсгийг (жишээлбэл; нийт 45ТН-ийн дүн бүхий тусдаа өр төлбөрүүдийг) нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилснаар уг хэмжилтийн тууштай бус байдлыг мэдэгдэхүйц хэмжээгээр бууруулж болох юм. Гэхдээ ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэсэн ангиллыг тухайн санхүүгийн хэрэглүүрт бүхэлд нь зөвхөн хэрэглэж болох учраас энэ жишээнд байгууллага нь нэг буюу хэд хэдэн өр төлбөрийг бүхэлд нь ингэж ангилах ёстой. Харин өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсгийг (жишээлбэл; бенчмарк хүүний түвшний өөрчлөлт гэх мэт зөвхөн нэг эрсдэлд хамааруулж болох үнэ цэнийн өөрчлөлт) эсвэл тодорхой нэг хэсгийг (өөрөөр хэлбэл, хувийн жинг) ингэж ангилж болохгүй.

Санхүүгийн өр төлбөрийн буюу санхүүгийн хөрөнгийн бүлгийг болон санхүүгийн өр төлбөрийг удирдан зохицуулж, түүний гүйцэтгэлийг бодит үнэ цэнийн сууриар үнэлэх

МЗУ95. Санхүүгийн өр төлбөрийн буюу санхүүгийн хөрөнгийн бүлгийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих нь илүү хамааралтай мэдээлэл бий болгох тийм арга замаар байгууллага нь санхүүгийн өр төлбөрийн буюу санхүүгийн хөрөнгийн бүлгийг болон санхүүгийн өр төлбөрийг удирдан зохицуулж, гүйцэтгэлийг үнэлдэг. Энэ тохиолдолд гол анхаарах зүйл нь санхүүгийн хэрэглүүрийн өөрийн шинж төрөл биш, харин байгууллага түүнийг удирдан зохицуулж, гүйцэтгэлийг үнэлж буй арга зам юм.

МЗУ96. Жишээлбэл; 46(б) параграфт заасан зарчим хангагдаж байгаа бөгөөд байгууллага нь нэг буюу хэд хэдэн эрсдлийг хуваалцдаг санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөртэй, түүнчлэн тухайн

байгууллагын хөрөнгө, өр төлбөрийн удирдлагын баримтжуулсан бодлогын дагуу тэдгээрийг бодит үнэ цэнээр удирдан зохицуулж, үнэлдэг бол санхүүгийн өр төлбөрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилахын тулд байгууллага нь энэхүү нөхцлийг ашиглаж болох юм. Үүний жишээ нь; дагалдах олон үүсмэл хэрэглүүрийг агуулсан ‘нийлмэл бүтээгдэхүүн’-ийг гаргасан бөгөөд түүний үр дүн болох эрсдлүүдийг үүсмэл ба үүсмэл бус санхүүгийн хэрэглүүрүүдийн хольцыг ашигласнаар бодит үнэ цэнийн сууриар удирдан зохицуулдаг байгууллага байж болно.

- МЗУ97. Дээр дурдсанчлан, энэ нөхцөл нь уг харгалзан үзэж буй санхүүгийн хэрэглүүрүүдийн бүлгийн гүйцэтгэлийг тухайн байгууллага удирдан зохицуулж, үнэлдэг арга замд хамаардаг. Иймээс (анх хүлээн зөвшөөрөх үеийн ангиллын шаардлагын дагуу) энэхүү нөхцөлд үндэслэн санхүүгийн өр төлбөрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилдаг байгууллага нь хамтад нь удирдан зохицуулж, үнэлдэг бүх зохих санхүүгийн өр төлбөрийг ингэж ангилна.
- МЗУ98. Байгууллагын стратегийн баримтжуулалт нь хэт дэлгэрэнгүй байх шаардлагагүй боловч 46(б) параграфтай нийцэж буй эсэхийг батлан харуулахад хангалттай байвал зохино. Ийм баримтжуулалтыг бие даасан зүйл тус бүрээр хийх шаардлагагүй боловч багцын сууриар хийгдсэн байж болох юм. Жишээлбэл; байгууллагын эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөн баталсанчлан, хэлтэс, цехийн гүйцэтгэлийн удирдлагын систем нь түүний гүйцэтгэлийг ийм сууриар үнэлдэг гэдгийг тодорхой харуулдаг бол 46(б) параграфтай нийцсэн эсэхийг батлан харуулахын тулд цаашдын баримтжуулалт хийх шаардлагагүй юм.

Дагалдах үүсмэл хэрэглүүр

- МЗУ99. Байгууллага нь энэ Стандартын цар хүрээнд хамаарах хөрөнгө биш тийм үндсэн гэрээ бүхий холимог гэрээний оролцогч нэг тал болсон тохиолдолд 49-р параграф нь аливаа дагалдах үүсмэл хэрэглүүрийг тодорхойлох, түүнийг үндсэн гэрээнээс салган тусгаарлах шаардлагатай эсэхийг үнэлэх, түүнчлэн ингэж салгах шаардлагатай үүсмэл хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр, дараагийн тайлант үед ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжихийг тухайн байгууллагаас шаарддаг.
- МЗУ100. Үндсэн гэрээ нь тогтоосон буюу урьдчилан тодорхойлсон дуусгавар болох хугацаагүй бөгөөд байгууллагын цэвэр хөрөнгөнд үлдэх хувь оролцоог илэрхийлдэг бол энэ нь өмчийн хэрэглүүрийн эдийн засгийн шинж чанар ба эрсдэлтэй байх бөгөөд дагалдах үүсмэл хэрэглүүр нь тэрхүү үндсэн гэрээтэйгээ нягт уялдаатай байхын тулд тухайн байгууллагад хамаарах өмчийн шинж чанаруудыг агуулсан байх шаардлагатай. Хэрэв үндсэн гэрээ нь өмчийн хэрэглүүр биш бөгөөд санхүүгийн хэрэглүүрийн тодорхойлолтыг хангадаг бол энэ нь өрийн хэрэглүүрийн эдийн засгийн шинж чанар ба эрсдэлтэй байна.
- МЗУ101. Опцион бус дагалдах үүсмэл хэрэглүүрийг (дагалдах форвард буюу своп гэх мэт) анх хүлээн зөвшөөрөх үед тэг (0) бодит үнэ цэнэтэй байлгахын тулд түүний тусгайлан заасан буюу шууд бусаар илэрхийлэх нөхцлүүдэд үндэслэн үндсэн гэрээнээс салган тусгаарладаг. Опционд суурилсан дагалдах үүсмэл хэрэглүүрийг (дагалдах буцаах опцион, дуудах опцион, хүүний түвшний дээд хэмжээ эсвэл доод хэмжээ, своп гэх мэт) тухайн опционы шинжийн тусгайлан заасан нөхцлүүдэд үндэслэн үндсэн гэрээнээс салган тусгаарладаг. Үндсэн гэрээний анхны дансны үнэ нь уг дагалдах үүсмэл хэрэглүүрийг салгасны дараах үлдсэн дүн байна.
- МЗУ102. Нэг холимог гэрээн дэх дагалдах олон үүсмэл хэрэглүүрүүдийг ерөнхийдөө нэг нийлмэл дагалдах хэрэглүүр гэж үздэг. Гэхдээ өмч гэж ангилдаг дагалдах үүсмэл хэрэглүүрийг (УСНББОУС 28, *Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга*-ыг үзнэ үү) хөрөнгө эсвэл өр төлбөр гэж ангилсан үүсмэл хэрэглүүрүүдээс тусад нь тайлагнана. Түүнчлэн, холимог гэрээ нь нэгээс олон дагалдах үүсмэл хэрэглүүртэй бөгөөд тэдгээр үүсмэл хэрэглүүрүүд нь өөр өөр эрсдэлтэй холбоотой, мөн шууд салган тусгаарлаж болох ба бие биенээсээ хараат бус бол тэдгээрийг тус тусад нь тайлагнана.

МЗУ103. Дараах жишээн дэх дагалдах үүсмэл хэрэглүүрийн эдийн засгийн шинж чанар ба эрсдэл нь үндсэн гэрээтэй нягт холбоогүй байна (49(a) параграф). Эдгээр жишээнд 49(б) ба 49(в) параграфт заасан нөхцөл хангагдана гэж үзээд байгууллага нь уг дагалдах үүсмэл хэрэглүүрийг үндсэн гэрээнээс тусдаа тайлагнана:

- (a) Өмч эсвэл бараа бүтээгдэхүүний үнийн буюу индексийн өөрчлөлтөнд үндэслэн хувьсан өөрчлөгдөх дүн бүхий мөнгөөр эсвэл бусад хөрөнгөөр тухайн хэрэглүүрийг буцаан худалдан авахыг гаргагчаас шаардах боломжийг эзэмшигчдээ олгодог, уг хэрэглүүрийг дагалдсан буцаах опцион нь энэхүү өрийн үндсэн хэрэглүүртэй нягт уялдаатай байдаггүй.
- (б) Өрийн хэрэглүүрийн дуусгавар болох хугацаа хүртэлх үлдсэн хугацааг сунгах опцион буюу шууд биелүүлэх нөхцөл нь уг сунгалтын хугацаанд хүүний түвшинг одоогийн зах зээлийн хүүний түвшинтэй ойролцоо болгон мөн нэгэн зэрэг тохируулга хийдэггүй л бол энэ нь тухайн өрийн хэрэглүүртэй нягт уялдаатай байдаггүй. Байгууллага нь өрийн хэрэглүүр гаргасан бөгөөд өрийн хэрэглүүрийг эзэмшигч нь уг өрийн хэрэглүүрт хамаарах дуудах опционыг гуравдагч этгээдэд гаргасан бол дуудах опционыг хэрэгжүүлсний үр дүнд тэрхүү өрийн хэрэглүүрийг дахин зах зээлд гаргахад оролцох буюу туслалцаа үзүүлэхийг анхны өрийн хэрэглүүр гаргагчаас шаардаж болох тохиолдолд анхны өрийн хэрэглүүр гаргагч нь тухайн дуудах опционыг өрийн хэрэглүүрийн дуусгавар болох өдөр хүртэлх хугацааны сунгалттай адилтгаж үзнэ.
- (в) Өрийн үндсэн хэрэглүүр эсвэл даатгалын гэрээг дагалдан гарсан, ингэснээр хүү буюу үндсэн дүн нь өмчийн хэрэглүүрийн үнэ цэнээр индексжсэн, өмчөөр индексжүүлсэн хүү буюу үндсэн дүнгийн төлбөр нь үндсэн хэрэглүүртэй нягт холбоотой байдаггүй. Яагаад гэвэл, үндсэн гэрээний болон дагалдах үүсмэл хэрэглүүрийн эрсдлүүд нь өөр хоорондоо ижил төсөөгүй байдаг.
- (г) Өрийн үндсэн хэрэглүүр эсвэл даатгалын гэрээг дагалдан гарсан, ингэснээр хүү буюу үндсэн дүн нь бараа бүтээгдэхүүний (алт гэх мэт) үнээр индексжсэн, бараа бүтээгдэхүүнээр индексжүүлсэн хүү буюу үндсэн дүнгийн төлбөр нь үндсэн хэрэглүүртэй нягт холбоотой байдаггүй. Яагаад гэвэл, үндсэн гэрээний болон дагалдах үүсмэл хэрэглүүрийн эрсдлүүд нь өөр хоорондоо ижил төсөөгүй байдаг.
- (д) Өрийн үндсэн хэрэглүүр эсвэл даатгалын үндсэн гэрээг дагалдан гарсан, дуудах опцион, буцаах опцион, урьдчилсан төлбөрийн опцион нь доор дурдсанаас бусад тохиолдолд уг үндсэн гэрээтэй нягт холбоотой байдаггүй:
 - (i) Хэрэгжүүлэх өдөр тус бүрээрх тухайн опционы хэрэгжүүлэх үнэ нь өрийн үндсэн хэрэглүүрийн хорогдуулсан өртөг эсвэл даатгалын үндсэн гэрээний дансны үнэтэй ойролцоогоор тэнцүү байх; эсвэл
 - (ii) Урьдчилсан төлбөрийн опционы хэрэгжүүлэх үнэ нь тухайн үндсэн гэрээний үлдсэн хугацааны туршид алдсан хүүний өнөөгийн үнэ цэнэтэй бараг тэнцүү дүн бүхий нөхөн төлбөрийг уг зээлдүүлэгчид олгодог. Алдсан хүү гэдэг нь урьдчилан төлсөн уг үндсэн дүнг хүүний түвшний зөрүүгээр үржүүлж гаргасан үржвэр юм. Хүүний түвшний зөрүү гэдэг нь урьдчилан төлөгдсөн үндсэн дүнгээр тухайн үндсэн гэрээний үлдэх хугацааны туршид ижил төсөөтэй өөр гэрээнд дахин хөрөнгө оруулалт хийсэн бол уг урьдчилан төлөлтийн өдрөөр байгууллагын хүлээн авах байсан үр ашигт хүүний түвшнээс тэрхүү үндсэн гэрээний үр ашигт хүүний түвшний давсан хэсэг юм.

Хөрвөх өрийн хэрэглүүрийн өмчийн элементийг УСНББОУС 28-ын дагуу салган тусгаарлахын өмнө уг дуудах эсвэл буцаах опцион нь өрийн үндсэн гэрээтэй нягт холбоотой эсэх үнэлгээг хийдэг.

- (e) Өрийн үндсэн хэрэглүүрийг дагалдан гарсан бөгөөд өөрөө өмчилдөггүй байж болох тухайн харгалзах хөрөнгийн зээлийн эрсдлийг нөгөө талдаа ("баталгаа гаргагч") шилжүүлэх боломжийг гэрээний нэг талд ("жинхэнэ эзэн") олгодог зээлийн үүсмэл

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

хэрэглүүр нь өрийн үндсэн хэрэглүүртэй нягт холбоотой байдаггүй. Ийм зээлийн үүсмэл хэрэглүүр нь тухайн харгалзах хөрөнгийг шууд өмчлөхгүй боловч түүнтэй холбоотой зээлийн эрсдлийг хариуцах боломжийг уг баталгаа гаргагчид олгодог.

- МЗУ104. Холимог гэрээний жишээ нь; өмч буюу бараа бүтээгдэхүүний индексийн өсөх эсвэл буурах өөрчлөлтөнд үндэслэн хувьсан өөрчлөгдөх дүн бүхий мөнгөөр эсвэл бусад санхүүгийн хөрөнгөөр солилцож, тухайн санхүүгийн хэрэглүүрийг түүний гаргагчид буцаан өгөх эрхийг эзэмшигчдээ олгодог санхүүгийн хэрэглүүр ('буцаах эрхтэй хэрэглүүр') юм. Анх хүлээн зөвшөөрөх үедээ гаргагч нь тухайн буцаах эрхтэй хэрэглүүрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн, буцаах эрхтэй санхүүгийн хэрэглүүр гэж ангилдагаас бусад тохиолдолд үндсэн гэрээ нь МЗУ100-р параграфын дагуу өрийн хэрэглүүр болох ба индексжүүлсэн үндсэн төлбөр нь МЗУ103(а) параграфын дагуу уг өрийн үндсэн хэрэглүүртэй нягт холбоотой байдаггүй тул тэрхүү дагалдах үүсмэл хэрэглүүрийг (өөрөөр хэлбэл, индексжүүлсэн үндсэн төлбөрийг) 49-р параграфын дагуу салган тусгаарлах шаардлагатай байдаг. Үндсэн төлбөр нь өсөж эсвэл буурч болох учраас дагалдах үүсмэл хэрэглүүр нь суурь хувьсагчаар үнэ цэнийг нь индексжүүлсэн, опцион бус үүсмэл хэрэглүүр болох юм.
- МЗУ105. Байгууллагын цэвэр хөрөнгийн үнэ цэнэтэй хувь тэнцүүлсэн хэсэгтэй (нээлтэй хамтын сангийн нэгжүүд эсвэл нэгжээр-холбогдсон зарим хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн) тэнцүү мөнгөөр дурын хугацаанд буцааж болох, тийм буцаах эрхтэй хэрэглүүр байх тохиолдолд дагалдах үүсмэл хэрэглүүрийг салган тусгаарлах ба бүрэлдэхүүн хэсэг нэг бүрийг тайлагнахын үр нөлөө нь хэрэв эзэмшигч уг санхүүгийн хэрэглүүрийг түүний гаргагчид буцаан өгөх эрхээ хэрэгжүүлсэн бол тухайн тайлант үеийн эцэст төлөх дүн буюу эргэлтээс гаргах дүнгээр тэрхүү холимог хэрэглүүрийг хэмжихэд хүргэнэ.
- МЗУ106. Дараах жишээн дэх дагалдах үүсмэл хэрэглүүрийн эдийн засгийн шинж чанар ба эрсдэл нь үндсэн гэрээний эдийн засгийн шинж чанар ба эрсдэлтэй нягт холбоотой байна. Эдгээр жишээний хувьд байгууллага нь дагалдах үүсмэл хэрэглүүрийг тухайн үндсэн гэрээнээс тусад нь тайлагнахгүй.
- (а) Эзэмшигч нь өөрийн хүлээн зөвшөөрсөн бараг бүх хөрөнгө оруулалтыг нөхөхгүй байдлаар, эсвэл тухайн дагалдах үүсмэл хэрэглүүр нь үндсэн гэрээний дагуу эзэмшигчийн хүртэх анхны өгөөжийг хамгийн наад зах нь хоёр дахин нэмэгдүүлэх ба тэрхүү үндсэн гэрээтэй ижил төсөөтэй нөхцөл бүхий гэрээний хувьд зах зээлээр олгох өгөөжөөс наад зах нь хоёр дахин их өгөөжийг өгөх байдлаар холимог гэрээг барагдуулахаас бусад тохиолдолд, хүүтэй өрийн үндсэн гэрээний эсвэл даатгалын гэрээний дагуу төлөх эсвэл хүлээн авах байсан хүүний дүнг өөрчилж чадах хүүний түвшин буюу хүүний түвшний индекс болох суурь хэрэглүүрийг дагалдан гарсан үүсмэл хэрэглүүр нь тухайн үндсэн гэрээтэйгээ нягт холбоотой байдаг.
 - (б) Хүүний түвшний дээд эсвэл доод хэмжээний гэрээг гаргах үед дээд хэмжээ нь зах зээлийн хүүний түвшинтэй тэнцүү буюу түүнээс өндөр, харин доод хэмжээ нь зах зээлийн хүүний түвшинтэй тэнцүү буюу түүнээс бага бөгөөд тухайн үндсэн гэрээний хувьд хүүний түвшний дээд эсвэл доод хэмжээ нь хөшүүргийн нөлөөгүй бол өрийн гэрээ эсвэл даатгалын гэрээг дагалдан гарсан хүүний түвшний дээд буюу доод хэмжээ нь уг үндсэн гэрээтэйгээ нягт холбоотой байна. Үүнтэй адилаар, хөрөнгийн хувьд хүлээн авах эсвэл төлөх үнийн дээд болон доод хэмжээ нь анхнаасаа мөнгөн алдагдалтай байсан бөгөөд хөшүүргийн нөлөөгүй бол тэрхүү дээд болон доод хэмжээг тогтоосон, хөрөнгийг (жишээлбэл; бараа бүтээгдэхүүнийг) худалдан авах буюу борлуулах гэрээний заалт нь уг үндсэн гэрээтэйгээ нягт холбоотой байна.
 - (в) Гадаад валютаар илэрхийлэгдсэн үндсэн дүнгийн буюу хүүний цуврал төлбөрүүдийг бүрдүүлдэг бөгөөд өрийн үндсэн хэрэглүүрийг дагалдан гардаг гадаад валютын илэрхийлэгдсэн дагалдах үүсмэл хэрэглүүр (жишээлбэл; хоёр валютаар илэрхийлэгдсэн бонд) нь тухайн өрийн үндсэн хэрэглүүртэй нягт холбоотой байдаг. УСНББОУС 4, *Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө* нь мөнгөн зүйлсээс үүссэн гадаад валютын олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөхийг шаарддаг тул ийм үүсмэл хэрэглүүрийг түүний үндсэн хэрэглүүрээс салган тусгаарлахгүй.

- (г) Санхүүгийн хэрэглүүр биш (гадаад валютаар үнийг нь илэрхийлдэг санхүүгийн бус зүйлийг худалдан авах буюу борлуулах гэрээ гэх мэт), эсвэл даатгалын гэрээ байх тийм үндсэн гэрээг дагалдан гардаг, гадаад валютаар илэрхийлэгдсэн дагалдах үүсмэл хэрэглүүр нь хөшүүргийн нөлөөгүй, опционы шинжийг агуулаагүй бөгөөд дараах валютуудын аль нэгээр илэрхийлэгдэх төлбөрүүдийг шаарддаг бол ийм дагалдах хэрэглүүр нь тухайн үндсэн гэрээтэйгээ нягт холбоотой байна:
- (i) Тухайн гэрээний аль нэг үндсэн оролцогч талын бүртгэлийн валют;
 - (ii) Худалдан авах буюу нийлүүлэх уг холбогдох бараа, үйлчилгээний үнийг дэлхий дахинд хийгдэж буй худалдаа арилжаанд түгээмэл илэрхийлдэг валют (түүхий газрын тосны худалдаа арилжааны хувьд ам доллар гэх мэт); эсвэл
 - (iii) Тухайн ажил гүйлгээ хийгдэж буй эдийн засгийн орчинд санхүүгийн бус зүйлсийг худалдан авах буюу борлуулах гэрээнүүдэд нийтлэг ашигладаг валют (жишээлбэл; орон нутгийн бизнесийн ажил гүйлгээ эсвэл гадаад худалдаанд нийтлэг ашигладаг харьцангуй тогтвортой, хөрвөх чадвар сайтай валют).
- (д) Үндсэн гэрээ нь (i) дагалдах үүсмэл хэрэглүүрийг өөртөө агуулаагүй санхүүгийн хэрэглүүрийн гэрээний мөнгөн гүйлгээг хүлээн авах эрхийг салган тусгаарласнаар анх үүссэн, ба (ii) өрийн анхны үндсэн гэрээнд тусгаагүй аливаа нөхцлийг агуулаагүй тохиолдолд зөвхөн хүүний эсвэл зөвхөн үндсэн дүнгийн СТРИПС-ийг дагалдан гардаг урьдчилсан төлбөрийн дагалдах опцион нь үндсэн гэрээтэйгээ нягт холбоотой байна.
- (е) Хэрэв дагалдах үүсмэл хэрэглүүр нь (i) хэрэглээний үнийн индексээр тооцсон түрээсийн төлбөрийн индекс гэх мэт инфляцитай холбоотой индекс (түрээс нь хөшүүргийн нөлөөгүй бөгөөд тухайн индекс нь уг байгууллагын эдийн засгийн орчин дахь инфляцитай холбоотой), (ii) холбогдох борлуулалтанд үндэслэсэн түрээсийн хувьсах төлбөрүүд, эсвэл (iii) хувьсах хүүний түвшинд үндэслэсэн түрээсийн хувьсах төлбөрүүд бол түрээсийн үндсэн гэрээг дагалдан гардаг уг дагалдах үүсмэл хэрэглүүр нь үндсэн гэрээтэйгээ нягт холбоотой байна.
- (ж) Нэгжээр-илэрхийлсэн төлбөрүүдийг тухайн сангийн хөрөнгийн бодит үнэ цэнийг тусгах нэгжийн одоогийн үнэ цэнээр хэмждэг бол санхүүгийн үндсэн хэрэглүүр эсвэл даатгалын үндсэн гэрээг дагалдан гардаг, нэгжтэй холбогдох шинж нь тухайн үндсэн хэрэглүүр буюу үндсэн гэрээтэйгээ нягт холбоотой байна. Нэгжтэй холбогдох шинж гэдэг нь дотоод буюу гадаад хөрөнгө оруулалтын сангийн нэгжүүдээр илэрхийлэгдсэн төлбөрийг шаардах гэрээний нөхцөл юм.
- (и) Байгууллага нь (үндсэн гэрээг харгалзан үзэхгүйгээр) дагалдах үүсмэл хэрэглүүрийг тусад нь хэмжиж чадахааргүй тийм байдлаар тухайн дагалдах үүсмэл хэрэглүүр ба даатгалын үндсэн гэрээ нь харилцан бие биенээсээ хамааралтай бол даатгалын гэрээг дагалдан гардаг үүсмэл хэрэглүүр нь уг даатгалын үндсэн гэрээтэйгээ нягт холбоотой байна.

Дагалдах үүсмэл хэрэглүүрүүдийг агуулсан хэрэглүүр

МЗУ107. МЗУ99-р параграфт дурдсанчлан, байгууллага нь энэ Стандартын цар хүрээнд хамаарах хөрөнгө биш тийм үндсэн гэрээ бүхий холимог гэрээний оролцогч нэг тал болсон тохиолдолд 49-р параграф нь ийм аливаа дагалдах үүсмэл хэрэглүүрийг тодорхойлох, түүнийг үндсэн гэрээнээс салган тусгаарлах шаардлагатай эсэхийг үнэлэх, түүнчлэн ингэж салгах шаардлагатай үүсмэл хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрөх болон дараагийн тайлант үед бодит үнэ цэнээр хэмжихийг тухайн байгууллагаас шаарддаг. Ийм шаардлага нь нэлээд нарийн цогц буюу бүхэлдээ уг хэрэглүүрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжихээс арай найдвартай бус хэмжилт хийхэд хүргэдэг. Ийм учраас энэ Стандарт нь холимог гэрээг бүхэлд нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилахыг зөвшөөрдөг.

МЗУ108. 49-р параграф нь дагалдах үүсмэл хэрэглүүрийг түүний үндсэн гэрээнээс салган тусгаарлахыг шаарддаг эсвэл ингэж салгахыг хориглодог эсэхээс үл хамааран ийм ангиллыг ашиглаж болох юм. Гэвч холимог гэрээг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилах

нь уг нарийн цогц байдлыг багасгахгүй эсвэл найдвартай байдлыг нэмэгдүүлэхгүй учраас 51(а) ба 51(б) параграфт заасан тохиолдлуудад 51-р параграф нь ингэж ангилах үндэслэл болохгүй.

Дагалдах үүсмэл хэрэглүүрийн дахин үнэлгээ

МЗУ109. Байгууллага нь тухайн гэрээний оролцогч тал анх болсон үед 49-р параграфын дагуу уг байгууллага нь дагалдах үүсмэл хэрэглүүрийг түүний үндсэн гэрээнээс салгаж, үүсмэл хэрэглүүр байдлаар тайлагнах шаардлагатай эсэхийг үнэлнэ. Мөнгөн гүйлгээг мэдэгдэхүйц өөрчлөн засварлахад хүргэх байдлаар гэрээний нөхцөл өөрчлөгдөөгүй л бол дараагийн тайлант үед дахин үнэлгээ хийхийг хориглоно, харин дахин үнэлгээ шаардлагатай болох байдлаар гэрээний нөхцөл өөрчлөгдсөн тохиолдолд дахин үнэлгээг хийнэ. Дагалдах үүсмэл хэрэглүүртэй, үндсэн гэрээтэй эсвэл тэдгээрийн аль алинтай холбоотойгоор уг хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн гүйлгээ өөрчлөгдсөн хэмжээ, түүнчлэн тэрхүү өөрчлөлт нь тухайн гэрээний дагуу өмнө хүлээгдэж байсан мөнгөн гүйлгээтэй харьцуулахад мэдэгдэхүйц эсэхийг харгалзан үзсэнээр байгууллага нь мөнгөн гүйлгээний засварлан өөрчлөлт мэдэгдэхүйц дүнтэй эсэхийг тодорхойлно.

МЗУ110. Дараах байдлаар олж эзэмшсэн гэрээнүүд дэх дагалдах үүсмэл хэрэглүүрүүд эсвэл уг олж эзэмшсэн өдрөөрх тэдгээрийн боломжит дахин үнэлгээний хувьд МЗУ109-р параграфыг мөрдөхгүй:

- (а) Улсын секторын нэгдэл;
- (б) Ерөнхий хяналтанд байдаг байгууллагуудын нэгдэл; эсвэл
- (в) УСНББОУС 37, *Хамтын Хэлэлцээр*-т тодорхойлсны дагуу хамтарсан үйлдвэр үүсгэн байгуулалт.

Санхүүгийн хөрөнгийн дахин ангилал

МЗУ111. Байгууллага өөрийн санхүүгийн хөрөнгөө удирдан зохицуулах удирдлагын загвараа өөрчилсөн бол тухайн байгууллага нь санхүүгийн хөрөнгөө дахин ангилахыг 54-р параграфтаар шаардсан байдаг. Ийм өөрчлөлтийг маш ховорхон хийнэ гэж үздэг. Гадаад буюу дотоод өөрчлөлтүүдийн үр дүнд байгууллагын эрх бүхий албан тушаалтан нь ийм өөрчлөлтийг тодорхойлдог бөгөөд энэ нь тухайн байгууллагын үйл ажиллагаанд ач холбогдолтой бөгөөд гаднын талуудад батлан харуулах боломжтой байх ёстой. Иймээс байгууллага нь өөрийн үйл ажиллагаанд ач холбогдолтой ажиллагааг гүйцэтгэж эхэлсэн эсвэл зогсоосон зөвхөн тийм тохиолдолд байгууллагын удирдлагын загварт өөрчлөлт оруулдаг. Жишээлбэл; байгууллага нь нэг бизнесийн нэгжийг худалдан авсан, данснаас хассан эсвэл татан буулгасан. Удирдлагын загварын өөрчлөлтийн жишээг доор харуулав:

- (а) Засгийн газрын агентлаг нь жижиг бизнес эрхлэгчдэд зээл олгодог бөгөөд тэдгээр зээлийн цуглуулалтын урт хугацааны мөчлөгийн улмаас уг зээлийн багцаа хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй үнээр борлуулдаг тийм удирдлагын загвартай юм. Гэвч тус агентлаг нь мөнгийг цуглуулах үйлчилгээ үзүүлдэг гуравдагч талтай урт хугацааны гэрээ байгуулсан. Тэрхүү цуглуулалтын үйлчилгээ үзүүлэгчийн тусалцаатайгаар гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулан авахын тулд зээлийн багцыг эзэмшиж байгаа учраас уг зээлийн багцаа цаашид худалдан борлуулахгүй.
- (б) Засгийн газрын агентлаг нь тааламжтай нөхцөл бүхий зээлийг цаашид олгохгүй болсноор үндэсний автомашин үйлдвэрлэгчид үзүүлдэг дэмжлэгээ зогсоохоор шийдвэрлэсэн. Тус агентлаг нь цаашид шинэ зээл гаргахгүй бөгөөд өөрийн зээлийн багцыг борлуулахаар идэвхитэй үйл ажиллагаа явуулж байна.

МЗУ112. Байгууллагын удирдлагын загварын зорилгын өөрчлөлтийг тухайн дахин ангиллын өдрөөс өмнө хийж, хэрэгжүүлэх ёстой. Жишээлбэл; холбооны улсын моргейжийн зээл ба орон сууцны корпораци нь өөрийн моргейжийн жижиг зээлийн бизнесийг хаахаар 2 дугаар сарын 15-нд шийдвэрлэсэн, иймээс нөлөө үзүүлэх бүх хөрөнгүүдийг 4 дүгээр сарын 01-нээс (өөрөөр хэлбэл, тухайн байгууллагын дараагийн тайлант үеийн эхний өдрөөс) дахин ангилах ёстой бол уг

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

байгууллага нь моргейжийн жижиг зээл авах шинэ үйлчлүүлэгчийн саналыг 2 дугаар сарын 15-наас хойш хүлээн авах ёсгүй. Харин 2 дугаар сарын 15-наас хойш ийм шинэ хүсэлтийг хүлээн авах бол өөрийн хуучин удирдлагын загварт нийцсэн үйл ажиллагаа эрхэлсэн болох юм.

МЗУ113. Дараах зүйлс нь удирдлагын загварын өөрчлөлт биш юм:

- (a) Тодорхой санхүүгийн хөрөнгөтэй холбоотой бодол төлөвлөгөөний өөрчлөлт (зах зээлийн нөхцөл байдал мэдэгдэхүйц өөрчлөгдсөн ч гэсэн).
- (b) Санхүүгийн хөрөнгөнд хамаарах тодорхой зах зээл түр хугацаанд үгүй болох.
- (в) Тухайн байгууллагын өөр өөр удирдлагын загвар бүхий хэсгүүдийн хоорондох санхүүгийн хөрөнгийн шилжүүлэлт.

Хэмжилт

Арилжааны бус орлогын ажил гүйлгээ

МЗУ114. Арилжааны бус орлогын ажил гүйлгээний үр дүн болох хөрөнгө, өр төлбөрийн анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийг УСНББОУС 23-д авч үзсэн. Арилжааны бус орлогын ажил гүйлгээний үр дүн болох хөрөнгө нь гэрээний болон гэрээний бус тохиролцооны аль алинаас үүсэж болох юм (УСНББОУС 28-ын МЗУ20 ба МЗУ21-р параграфыг үзнэ үү). Эдгээр хөрөнгө нь гэрээний тохиролцооноос үүсдэг буюу санхүүгийн хэрэглүүрийн тодорхойлолтыг өөр бусад байдлаар хангадаг тохиолдолд тэдгээрийг:

- (a) УСНББОУС 23-ын дагуу анх хүлээн зөвшөөрнө;
- (b) Анх доорх байдлаар хэмжинэ:
 - (i) УСНББОУС 23-ын зарчмуудыг ашиглан бодит үнэ цэнээр; ба
 - (ii) Санхүүгийн хөрөнгийг дараагийн тайлант үед ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжихээс өөр бусад байдлаар хэмждэг тохиолдолд энэ Стандартын 57-р параграфын дагуу уг санхүүгийн хөрөнгийн худалдан авалтанд шууд хамааруулж болох ажил гүйлгээний зардлыг харгалзсанаар;

Анхны хэмжилт

Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн анхны хэмжилт (57-59-р параграф)

МЗУ115. Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнэ нь ихэвчлэн тухайн ажил гүйлгээний үнэ байдаг (өөрөөр хэлбэл, өгсөн эсвэл хүлээн авсан төлбөрийн бодит үнэ цэнэ, мөн МЗУ117-р параграфыг үзнэ үү). Гэвч өгсөн эсвэл хүлээн авсан төлбөрийн зарим хэсэг нь уг санхүүгийн хэрэглүүрээс өөр бусад зүйлсэд хамаарах бол үнэлгээний арга зүй ашигласнаар тухайн санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тооцоолдог (МЗУ149-МЗУ154-р параграфыг үзнэ үү). Жишээлбэл; хүүгүй, урт хугацаат зээл эсвэл авлагын бодит үнэ цэнийг адил зээлийн зэрэглэл бүхий ижил төсөөтэй хэрэглүүрийн (валют, нөхцөл, хүүний түвшний төрөл болон бусад хүчин зүйлсийн хувьд ижил төсөөтэй) зах зээлийн давамгайлах хүүний түвшинг ашиглан дискаунтчилсан, ирээдүйн бүх мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнээр тооцоолж болно. Зээлдүүлсэн аливаа нэмэлт дүн нь өөр ямар нэг төрлийн хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангахгүй бол зардал эсвэл орлогын бууралт болно.

МЗУ116. Байгууллага нь зах зээлийн түвшнээс бага хүүтэй (жишээлбэл; ижил төсөөтэй зээлийн зах зээлийн хүүний түвшин 8 хувь байх үед 5 хувийн хүүтэй) зээл гаргадаг бөгөөд үүнийхээ нөхөн төлбөр болгон урьдчилсан хураамж авдаг бол тухайн байгууллага нь уг зээлийг түүний бодит үнэ цэнээр, өөрөөр хэлбэл хүлээн авсан хураамжаа хассан цэвэр дүнгээр хүлээн зөвшөөрнө.

МЗУ117. Анх хүлээн зөвшөөрөх үед санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн хамгийн сайн нотолгоо нь ихэвчлэн тухайн ажил гүйлгээний үнэ байдаг. Анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнэ

нь 58-р параграфт дурдсан ажил гүйлгээний үнээс өөр гэж тодорхойлсон бол тухайн байгууллага нь тэрхүү өдөр уг хэрэглүүрийг дараах байдлаар тайлагнана:

- (а) Хэрэв бодит үнэ цэнэ нь адилтгах хөрөнгө буюу өр төлбөрийн идэвхитэй зах зээлийн жишиг үнээр (өөрөөр хэлбэл, Түвшин I-ийн орц) нотлогдож байгаа, эсвэл ажиглаж болох зах зээлийн тоон мэдээг зөвхөн ашиглан гаргасан үнэлгээний арга зүйд үндэслэдэг бол 57-р параграфтаар шаардсан хэмжилтийн дүнгээр. Байгууллага нь анхны хүлээн зөвшөөрөлтийн бодит үнэ цэнэ ба ажил гүйлгээний үнийн хоорондох зөрүүг олз эсвэл гарз гэж хүлээн зөвшөөрнө.
- (б) Бусад бүх тохиолдолд, анхны хүлээн зөвшөөрөлтийн бодит үнэ цэнэ ба ажил гүйлгээний үнийн хоорондох зөрүүг хойшлуулахын тулд залруулсан, 57-р параграфтаар шаардсан хэмжилтийн дүнгээр. Тухайн хөрөнгө буюу өр төлбөрийн үнийг тогтооходоо зах зээлд оролцогчдын харгалзан үзэж болох хүчин зүйлийн (үүн дотроо, цаг хугацааны) өөрчлөлтөөс үүсэн бий болох зөвхөн тэр хэмжээгээр байгууллага нь уг хойшлогдсон зөрүүг анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа, олз эсвэл гарз гэж хүлээн зөвшөөрнө.

Хөнгөлөлттэй зээл

МЗУ118. Хөнгөлөлттэй зээл гэдэг нь зах зээлийн нөхцлөөс доогуур нөхцөлтэйгээр байгууллагын хүлээн авсан буюу олгосон зээл юм. Зах зээлийн нөхцлөөс доогуур нөхцөл нь хүү ба/буюу үндсэн дүнгийн хөнгөлөлтөөс үүсэж болно. Зах зээлийн нөхцлөөс ихэвчлэн доогуур байдаг хөнгөлөлттэй зээлийн жишээнд хөгжиж буй орнуудад олгосон зээл, жижиг аж ахуйд олгосон зээл, их дээд сургуулийн боловсролын шалгуур хангасан оюутнуудад олгосон оюутны зээл, бага орлоготой өрхөд олгосон өрхийн зээл хамаардаг. Байгууллага нь хөнгөлөлттэй зээлийг тухайлбал, хөгжлийн агентлаг ба бусад засгийн газрын байгууллагаас авч болох юм.

МЗУ119. Хөнгөлөлттэй зээлийн олголт буюу хүлээн авалтыг байгууллагын авах буюу төлөх өрийн чөлөөлөлтөөс ялган тодорхойлдог. Ингэж ялган тодорхойлох нь тухайн зээлийн дараагийн тайлант үеийн хэмжилт буюу үл хүлээн зөвшөөрөлтийн нэг хэсэг байдлаар биш, харин анх хүлээн зөвшөөрөх болон хэмжихдээ тэрхүү зах зээлийн нөхцлөөс доогуур нөхцлийг харгалзан үзэх эсэхэд нөлөө үзүүлэх учраас чухал ач холбогдолтой байдаг.

МЗУ120. Хөнгөлөлттэй зээл нь анхнаасаа зах зээлийн нөхцлөөс доогуур нөхцлөөр тухайн нөөцийг хүлээн авах эсвэл олгох явдал байдаг. Харин өрөөс чөлөөлөлт нь зах зээлтэй холбоотой нөхцлөөр анх олгосон буюу хүлээн авсан зээлийн үр дүн бөгөөд энд тухайн зээлийн оролцогч аль нэг тал нь анхны олголт эсвэл хүлээн авалтын хувьд өөрийн санаа төлөвлөгөөг дараагийн тайлант үед өөрчлөх явдал юм. Жишээлбэл; засгийн газар нь зах зээлийн нөхцлөөр зээлийг бүрэн буцаан төлүүлэх санаа төлөвлөгөөтэйгээр ашгийн төлөө бус байгууллагад мөнгө зээлдүүлж болох юм. Гэвч засгийн газар нь зээлийн тодорхой хэсгийг дараагийн тайлант үед хүчингүй болгож болно. Тухайн зээл нь анхнаасаа уг байгууллагад зах зээлийн түвшнээр зээл олгох явдал байсан учраас энэ нь хөнгөлөлттэй зээл биш юм. Байгууллага нь уг зээлийн дараагийн тайлант үеийн данснаас хасалтыг өрөөс чөлөөлөлт гэж үзэх бөгөөд УСНББОУС 41-ийн үл хүлээн зөвшөөрөлтийн шаардлагуудыг (12-34-р параграфыг үзнэ үү) мөрдөнө.

МЗУ121. Хөнгөлөлттэй зээл нь үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай зээлтэй олон шинж чанараар мөн адил төсөөтэй байдаг. Зээлийг хөнгөлөлттэй эсвэл үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай гэж ангилах эсэх нь уг зээлийн ажил гүйлгээний үнэ ба бодит үнэ цэнийн хоорондох зөрүүг санхүүгийн үр дүнгийн тайланд хөнгөлөлт эсвэл зээлийн алдагдал гэж хүлээн зөвшөөрөх эсэхийг тодорхойлж өгдөг.

МЗУ122. Зээл нь хөнгөлөлттэй эсвэл үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай зээл эсэх нь түүний мөн чанараас хамаардаг. Нөөцийн шилжүүлэлт гэх мэт арилжааны бус бүрэлдэхүүн хэсгийг уг ажил гүйлгээнд нэгтгэн оруулах санаа зорилго нь уг зээл хөнгөлөлттэй гэдгийг илэрхийлдэг. Зээлийг зах зээлийн нөхцлөөс доогуур нөхцөлтэйгээр олгосноор арилжааны бус бүрэлдэхүүн хэсгийг уг ажил гүйлгээнд нэгтгэн оруулдаг. Харин эсрэгээр, үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай зээл гэдэг нь тухайн санхүүгийн хөрөнгийн тооцоолсон ирээдүйн мөнгөн гүйлгээнд муутгах нөлөө үзүүлэх нэг буюу хэд хэдэн үйл явдал гарч тохиолдсон зээл юм.

МЗУ123. Хөнгөлөлттэй зээлийг зах зээлийн нөхцлөөс доогуур нөхцлөөр олгох буюу хүлээн авдаг учраас уг зээлийг анх хүлээн зөвшөөрөх үеийн ажил гүйлгээний үнэ нь түүний бодит үнэ цэнэ биш байж болох юм. Иймээс анх хүлээн зөвшөөрөх үедээ байгууллага нь уг олгосон эсвэл хүлээн авсан зээлийн мөн чанарыг түүний бүрэлдэхүүн хэсгүүдээр задлан шинжлэх бөгөөд доорх МЗУ124, МЗУ126-р параграфт заасан зарчмуудыг ашиглан тэдгээр бүрэлдэхүүн хэсгүүдийг тайлагнадаг.

МЗУ124. Байгууллага нь уг хөнгөлөлттэй зээл мөн чанарын хувьд үнэн хэрэгтэй зээл, арилжааны бус ажил гүйлгээ, эздийн хувь оролцоо эсвэл эдгээрийн хослол эсэхийг УСНББОУС 28 ба УСНББОУС 23-ын 42-58-р параграфт заасан зарчмуудыг мөрдсөнөөр юуны өмнө үнэлнэ. Ажил гүйлгээ эсвэл түүний нэг хэсэг нь зээл гэж уг байгууллага тодорхойлсон бол тэрхүү ажил гүйлгээний үнэ нь анх хүлээн зөвшөөрөх үед тухайн зээлийн бодит үнэ цэнийг төлөөлөн илэрхийлэх эсэхийг үнэлнэ. Байгууллага нь МЗУ144-МЗУ155-р параграфт заасан зарчмуудыг ашиглан уг зээлийн бодит үнэ цэнийг тодорхойлно. Байгууллага нь идэвхитэй зах зээлийг лавлагаа болгосноор бодит үнэ цэнийг тодорхойлж чадахгүй тохиолдолд үнэлгээний арга зүйг ашиглана. Ижил төсөөтэй зээлийн хүүний зах зээлийн түвшинг ашигласнаар ирээдүйн бүх мөнгөн орлогыг дискаунтчилж, үнэлгээний арга зүйгээр бодит үнэ цэнийг тодорхойлж болно (МЗУ115-р параграфыг үзнэ үү).

МЗУ125. Зээлийн бодит үнэ цэнэ ба ажил гүйлгээний үнийн (зээлийн мөнгөн орлогын) хоорондох аливаа зөрүүг дараах байдлаар тайлагнана:

- (а) Байгууллага нь зээлийг хүлээн авсан тохиолдолд уг зөрүүг УСНББОУС 23-ын дагуу тайлагнана.
- (б) Байгууллага нь зээл олгосон тохиолдолд уг зээл нь эзэд болохын хувьд тэдний бүрэн эрхийн хүрээнд эзэдтэй хийсэн ажил гүйлгээ байхаас бусад тохиолдолд тэрхүү зөрүүг анх хүлээн зөвшөөрөх үед ашиг, алдагдалд зардал гэж тайлагнана. Зээл нь эзэд болохын хувьд тэдний бүрэн эрхийн хүрээнд эзэдтэй хийсэн ажил гүйлгээ байх, тухайлбал, хяналт тавигч байгууллага нь хяналтанд буй байгууллагадаа хөнгөлөлттэй зээл олгох тохиолдолд уг зөрүү нь капиталын хувь оролцоог, өөрөөр хэлбэл зардал биш, харин байгууллагад оруулсан хөрөнгө оруулалтыг илэрхийлж болох юм.

Үлгэрчилсэн жишээг УСНББОУС 23-ын ҮЖ54-р параграфт, түүнчлэн энэ Стандартыг дагалдах ҮЖ153-ҮЖ161-р параграфт харуулсан.

МЗУ126. Хөнгөлөлттэй зээлийн мөн чанарыг үнэлж, уг зээлийн бүрэлдэхүүн хэсгийг бодит үнэ цэнээр хэмжсэний дараа, байгууллага нь дараагийн тайлант үед хөнгөлөлттэй зээлийн ангиллыг 39-44-р параграфын дагуу үнэлэх ба 61-65-р параграфын дагуу хэмжинэ.

МЗУ127. Зарим тохиолдолд олгосон хөнгөлөлттэй зээл нь мөн үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай зээл байж болно. Тухайлбал; түүхэндээ зээлийг бүрэн хэмжээгээр буцаан төлж байгаагүй тийм зээлдэгчид хөнгөлөлттэй зээлийг засгийн газар нь үечлэн давтагдах байдлаар олгодог байж болох юм. Хэрэв уг хөнгөлөлттэй зээлийн үнэ цэнэ буурсан бол байгууллага нь тухайн хэрэглүүрийн нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тусгасан бодит үнэ цэнээр тэрхүү хэрэглүүрийг хэмжинэ. Байгууллага нь бүрэлдэхүүн хэсгүүдийг тайлагнаж, зээлийн алдагдал ба хөнгөлөлтийн элементийг бүхэлд нь, хөнгөлөлт гэж хүлээн зөвшөөрөхийн тулд МЗУ125(б) параграфыг мөрдөнө.

Арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн өмчийн хэрэглүүр

МЗУ128. Улсын секторт, нэг байгууллага нь улсын секторын өөр нэг байгууллагад санхүүжилт буюу татаас олгох арга зам болгон өмчийн хөрөнгө оруулалтыг ашиглаж болох юм. Ийм ажил гүйлгээн дэх тэдгээр хөрөнгө оруулалтын хувьд идэвхитэй зах зээл ерөнхийдөө байдаггүй (өөрөөр хэлбэл, өмчийн хэрэглүүрийн жишиг зах зээлийн үнэ байхгүй) бөгөөд уг гаргагч байгууллагын боломжит эргэлтээс гаргалтаас өөр бусад, тухайн хөрөнгө оруулалтаас бий болох ирээдүйн мөнгөн гүйлгээ байхгүй эсвэл маш бага хүлээлттэй байдаг. Санхүүжүүлэгч байгууллагаас тухайн санхүүжигчид олгож буй мөнгөн хөрөнгө нь тэрхүү санхүүжигчийн

эдийн засгийн буюу нийгмийн зорилтуудад ерөнхийдөө зарцуулагддаг. Ийм хөрөнгө оруулалтын жишээнд, хөгжлийн банк дахь гишүүнчлэлийн хувь оролцоо эсвэл нийгмийн тодорхой хөтөлбөр буюу үйлчилгээг үзүүлдэг (тухайлбал; хоргодох байр, хөнгөлөлттэй орон сууц, жижиг бизнес эрхлэгчдэд үзүүлэх тусламж гэх мэт) улсын секторын өөр нэг байгууллага дахь өмчийн хөрөнгө оруулалт хамаарна.

МЗУ129. Ийм ажил гүйлгээг анх хүлээн зөвшөөрөхдөө, байгууллага нь тухайн хэлцлийн мөн чанарыг шинжилж, анхнаасаа түүний санаа зорилго нь арилжааны бус ажил гүйлгээгээр дамжуулан нөөцөөр хангах буюу нөөцийг хүлээн авах явдал байсан эсэхийг үнэлэх хэрэгтэй. Ажил гүйлгээ буюу ажил гүйлгээний бүрэлдэхүүн хэсэг нь арилжааны бус ажил гүйлгээ байх хэмжээгээр тэрхүү ажил гүйлгээнээс үүссэн аливаа хөрөнгө болон орлогыг УСНББОУС 23-ын дагуу тайлагнана. Нөөцөөр хангаж буй байгууллага нь анх хүлээн зөвшөөрөх үедээ уг дүнг зардал гэж ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

МЗУ130. Өмчийн хэрэглүүр нь энэ Стандартын цар хүрээнд хамаарах ажил гүйлгээ буюу ажил гүйлгээний бүрэлдэхүүн хэсгээс үүсдэг тохиолдолд түүнийг анх 57-р параграфын дагуу бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрнө. Уг өмчийн хэрэглүүрийг дараагийн тайлант үед 61-63-р параграфын дагуу хэмжинэ. Хэрэв тухайн хэрэглүүрийн хувьд идэвхитэй зах зээл байхгүй бол байгууллага нь түүний бодит үнэ цэнийг тодорхойлохдоо, МЗУ149-МЗУ155-р параграфт заасан, үнэлгээний арга зүй болон орц мэдээг харгалзан үзнэ.

Арилжааны бус ажил гүйлгээгээр гаргасан санхүүгийн баталгааг үнэлэх

МЗУ131. Зөвхөн гэрээний санхүүгийн баталгаа (буюу мөн чанарын хувьд гэрээ болох баталгаа) нь энэ Стандартын цар хүрээнд хамаарна (УСНББОУС 28-ын МЗУ3, МЗУ4-р параграфыг үзнэ үү). Гэрээний бус баталгаа нь санхүүгийн хэрэглүүрийн тодорхойлолтыг хангахгүй учраас энэ Стандартын цар хүрээнд хамаарахгүй. Энэ Стандарт нь зөвхөн санхүүгийн баталгааны гэрээ гаргагчийн хувьд хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийн шаардлагуудыг тодорхойлдог.

МЗУ132. “Санхүүгийн баталгааны гэрээ” гэдэг нь “өрийн хэрэглүүрийн анхны буюу засварлан өөрчилсөн нөхцлийн дагуу төлөх ёстой төлбөрөө тухайн зээлдэгч барагдуулаагүйн улмаас учирсан алдагдлын хувьд уг гэрээг эзэмшигчид нөхөн төлбөр болгон тодорхой төлбөр төлөхийг түүний гаргагчаас шаарддаг гэрээ юм” гэж 9-р параграфт тодорхойлсон байдаг. Бусад санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийн адилаар санхүүгийн баталгааны гэрээг энэхүү Стандартын шаардлагуудын дагуу анх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөхийг шаарддаг. Бодит үнэ цэнийг тодорхойлох талаархи тайлбар ба заавар удирдамжийг энэ Стандартын 66-68-р параграфт заасан бөгөөд МЗУ144-МЗУ155-р параграфт тусгасан Мөрдөх Заавар Удирдамж нь үүний гүйцээлт болно. Санхүүгийн баталгааны гэрээний дараагийн тайлант үеийн хэмжилт нь 73-93-р параграфын дагуу тодорхойлсон гарзны хасагдуулгын дүн ба анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс хэрэв хамааралтай бол УСНББОУС 9, *Арилжааны Ажил Гүйлгээний Орлого*-д заасан хуримтлагдсан хорогдуулгыг хассан дүнгийн аль өндөр нь байдаг.

МЗУ133. Улсын секторын хувьд баталгааг ихэвчлэн арилжааны бус ажил гүйлгээний арга замаар, өөрөөр хэлбэл үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр гаргадаг. Байгууллагын эдийн засаг ба нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд энэ төрлийн баталгааг олгодог. Ийм зорилтуудад дэд бүтцийн төслүүдийг дэмжих, эдийн засгийн хямралын үед байгууллагуудад дэмжлэг үзүүлэх, засгийн чиг үүрэг хэрэгжүүлэгч байгууллагуудын бонд гаргалтанд баталгаа гаргах, ажилтны хувьд өөрийн үүрэг, хариуцлагыг биелүүлэхдээ ашиглах автомашин худалдан авахад ажилтанд зээл олгох зэрэг ажиллагаа хамаарна. Санхүүгийн баталгаа төлбөртэй байх тохиолдолд байгууллага нь уг төлбөр арилжааны ажил гүйлгээнээс үүссэн эсэх, мөн төлбөр нь бодит үнэ цэнийг илэрхийлэх эсэхийг тодорхойлно. Хэрэв төлбөр нь бодит үнэ цэнийг илэрхийлэх бол байгууллага нь санхүүгийн баталгааг тэрхүү төлбөрийн дүнгээр хүлээн зөвшөөрнө. Дараагийн тайлант үеийн хэмжилт нь 73-93-р параграфын дагуу тодорхойлсон гарзны хасагдуулгын дүн ба анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс хэрэв хамааралтай бол УСНББОУС 9-ийн дагуу хүлээн зөвшөөрсөн, хуримтлагдсан хорогдуулгыг хассан дүнгийн аль өндөр нь байдаг. Байгууллага нь тухайн төлбөр бодит үнэ цэнэ биш гэж үзсэн тохиолдолд уг байгууллага нь ямар нэг төлбөр төлөөгүйтэй адилаар түүний дансны үнийг анх хүлээн зөвшөөрөх үед тодорхойлно.

МЗУ134. Анх хүлээн зөвшөөрөх үед хураамж төлөөгүй эсвэл төлбөр нь бодит үнэ цэнэ биш байх тохиолдолд байгууллага нь тухайн байгуулсан гэрээтэй адилтгах санхүүгийн баталгааны гэрээний хувьд идэвхитэй зах зээлийн жишиг үнэ бэлэн боломжтой байгаа эсэхийг эхлээд харгалзан үздэг. Идэвхитэй зах зээлийн нотолгоонд зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хоорондох харилцан хамааралгүй талуудын сүүлийн үеийн ажил гүйлгээ ба гаргагч нь үнэгүй эсвэл нэрлэсэн төлбөртэйгээр нийлүүлдэг бараг ижил санхүүгийн баталгааны өөр бусад гэрээний одоогийн бодит үнэ цэнийн лавлагаа хамаарна. Зээлдэгч нь баталгаа гаргагчид төлбөр төлөхгүйгээр уг санхүүгийн баталгааны гэрээг байгуулж буй нь идэвхитэй зах зээл байхгүй гэсэн дүгнэлтийн шинжтэй нотолгоо дангаараа болохгүй юм. Худалдаа арилжааны зорилготой гаргагчаас баталгааг олж авах боломжтой боловч улсын секторын байгууллага нь худалдаа арилжааны бус олон учир шалтгааны улмаас санхүүгийн баталгааны гэрээ байгуулахыг зөвшөөрч болох юм. Жишээлбэл; зээлдэгч нь худалдаа арилжааны зорилготой хураамжийг төлөх боломжгүй бөгөөд тухайн байгууллагын нийгмийн буюу улс төрийн зорилтуудын нэгийг хэрэгжүүлэх төслийн санаачлага нь хэрэв санхүүгийн баталгаа гаргахгүй бол эрсдэлд орох тохиолдолд санхүүгийн баталгаа гаргуулахын тулд улсын секторын байгууллагад эсвэл засгийн газарт хандаж болох юм.

МЗУ135. Шууд адилтгах баталгааны гэрээний идэвхитэй зах зээл байхгүй тохиолдолд байгууллага нь идэвхитэй зах зээлийн ажиглалтаас бусад үнэлгээний арга зүйг ашиглах боломжтой бөгөөд бодит үнэ цэнийн найдвартай хэмжилт хийж чадах эсэхийг харгалзан үзнэ. Ийм үнэлгээний арга зүй нь санхүүгийн эрсдлийг харгалзан үзсэн математик загварт тулгуурлаж болох юм. Жишээлбэл; “В” үндэсний засгийн газар нь “Х” хотын захиргааны бондын гаргалтанд баталгаа гаргадаг. “Х” хотын захиргаа нь өөрийн бондын гаргалтыг дэмжсэн засгийн газрын баталгаатай учраас түүний бонд нь засгийн газрын баталгаагаар дэмжигдээгүй байх үеийнхээс арай бага купоны хүүтэй байна. Яагаад гэвэл, уг баталгаа нь хөрөнгө оруулагчдын хувьд бондын эрсдлийн хэмжээг бууруулах юм. Уг гаргалтыг засгийн газрын баталгаагаар дэмжээгүй бол тогтоогдох байсан купоны хүүний түвшин ба баталгаа бүхий купоны хүүний түвшин хоорондох зээлийн тархалтыг ашигласнаар тухайн баталгааны төлбөрийг тодорхойлж болно. Идэвхитэй зах зээлийн ажиглалтаар эсвэл үнэлгээний бусад арга зүйг ашигласнаар бодит үнэ цэнийг тодорхойлж болох тохиолдолд байгууллага нь уг санхүүгийн баталгааг санхүүгийн байдлын тайландаа бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх ба адилтгах дүн бүхий зардлыг санхүүгийн үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Идэвхитэй зах зээлийн ажиглалтанд тулгуурлаагүй үнэлгээний арга зүй ашиглах тохиолдолд байгууллага нь аливаа загварын гарц үр дүн найдвартай ба ойлгомжтой гэдэгт өөрөө итгэлтэй байх ёстой.

МЗУ136. Идэвхитэй зах зээлийн ажиглалтаар эсвэл үнэлгээний бусад арга зүйг ашигласнаар бодит үнэ цэнийн найдвартай хэмжүүрийг тодорхойлж чадахгүй бол байгууллага нь 73-93-р параграфын дагуу тодорхойлсон, гарзын хасагдуулгын дүнгээр уг санхүүгийн баталгааны гэрээг хэмжих шаардлагатай.

Дараагийн тайлант үеийн хэмжилт

МЗУ137. Санхүүгийн хөрөнгө гэж өмнө нь хүлээн зөвшөөрч байсан санхүүгийн хэрэглүүрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг бөгөөд түүний бодит үнэ цэнэ нь тэг (0)-ээс бага болж, буурсан бол энэ нь 45-р параграфын дагуу хэмжих санхүүгийн өр төлбөр болох юм. Харин энэ Стандартын цар хүрээнд хамаарах хөрөнгө биш тийм үндсэн гэрээ бүхий холимог гэрээг ямагт 48-р параграфын дагуу хэмжинэ.

МЗУ138. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан тусгах замаар 106 эсвэл 41-р параграфын дагуу бодит үнэ цэнээр хэмждэг санхүүгийн хөрөнгийн анхны болон дараагийн хэмжилтийн үеийн ажил гүйлгээний зардлыг хэрхэн тайлагнахыг дараах жишээнд үлгэрчлэн харуулав. Байгууллага нь 100ТН дээр 2ТН-ийн худалдааны шимтгэлийг нэмсэн дүнгээр санхүүгийн хөрөнгийг худалдаж авсан. Байгууллага нь уг хөрөнгийг эхлээд 102ТН-ээр хүлээн зөвшөөрнө. Тухайн тайлант үе нь нэг өдрийн дараа дуусах бөгөөд энэ үед уг хөрөнгийн зах зээлийн жишиг үнэ нь 100ТН байсан. Хэрэв хөрөнгийг борлуулсан бол 3ТН-ийн шимтгэл төлөх байсан. Энэ өдөр байгууллага нь тухайн хөрөнгийг 100ТН-ээр (борлуулахтай холбоотой боломжит шимтгэлийг харгалзан үзэхгүйгээр) хэмжиж, 2ТН-ийн гарзыг цэвэр хөрөнгө/өмчид

хүлээн зөвшөөрнө. Хэрэв тухайн санхүүгийн хөрөнгийг 41-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг бол уг ажил гүйлгээний зардлыг үр ашигт хүүний арга ашиглан хорогдуулж, ашиг, алдагдалд тусгана.

МЗУ139. Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн дараагийн тайлант үеийн хэмжилт болон МЗУ117-р параграфт заасан олз, гарзын дараагийн тайлант үеийн хүлээн зөвшөөрөлт нь энэхүү Стандартын шаардлагуудтай нийцсэн байна.

Өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтууд ба тэдгээр хөрөнгө оруулалтын гэрээнүүд

МЗУ140. Өмчийн хэрэглүүрт оруулсан бүх хөрөнгө оруулалтууд ба тэдгээр хөрөнгө оруулалтын гэрээнүүдийг бодит үнэ цэнээр хэмжих ёстой. Гэвч цөөн тохиолдолд өртөг нь бодит үнэ цэнийн зохих тооцоолол байж болох юм. Бодит үнэ цэнийг хэмжих илүү сүүлийн үеийн мэдээлэл хангалттай байгаагүй эсвэл бодит үнэ цэнийн боломжит хэмжилтийн муж өргөн хүрээтэй байсан бөгөөд өртөг нь тухайн мужийн доторх бодит үнэ цэнийн хамгийн сайн тооцооллыг төлөөлөн илэрхийлдэг бол ийм тохиолдол үүсэж болно.

МЗУ141. Өртөг нь бодит үнэ цэнийг төлөөлөн илэрхийлж чадахгүй байж болохыг илтгэх үзүүлэлтэнд дараах зүйлс хамаарна:

- (а) Төсөв, төлөвлөгөө буюу зорилтод үзүүлэлттэй харьцуулахад санхүүжигчийн гүйцэтгэлд гарсан мэдэгдэхүйц өөрчлөлт.
- (б) Санхүүжигчийн хүрвэл зохих, түүний бүтээгдэхүүний техникийн зорилтод үзүүлэлтүүдийн талаархи хүлээлтийн өөрчлөлт.
- (в) Санхүүжигчийн өмч эсвэл түүний бүтээгдэхүүн буюу боломжит бүтээгдэхүүний зах зээлд гарсан мэдэгдэхүйц өөрчлөлт.
- (г) Олон улсын эдийн засагт эсвэл санхүүжигчийн үйл ажиллагаагаа явуулж буй эдийн засгийн орчинд гарсан мэдэгдэхүйц өөрчлөлт.
- (д) Зэрэгцүүлэгдэх байгууллагуудын гүйцэтгэлд эсвэл ерөнхий зах зээлийн байдлаар илэрхийлэгдэх үнэлгээнд гарсан мэдэгдэхүйц өөрчлөлт.
- (е) Залилан, худалдааны маргаан, зарга маргаан, удирдлагын буюу стратегийн өөрчлөлт гэх мэт санхүүжигчийн дотоод асуудлууд.
- (ж) Санхүүжигч гүйцэтгэснээр (өмчийн шинээр гаргалт гэх мэт) эсвэл гуравдагч талуудын хооронд өмчийн хэрэглүүрийг шилжүүлснээр тухайн санхүүжигчийн өмчийн хувьд хийгдсэн гаднын ажил гүйлгээнээс үүссэн нотолгоо.

МЗУ142. МЗУ141-р параграф дахь жагсаалтанд бүгдийг хамруулаагүй болно. Байгууллага нь тухайн санхүүжигчийн гүйцэтгэл ба үйл ажиллагааны талаархи, уг анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш бэлэн боломжтой болсон бүх мэдээллийг ашиглах хэрэгтэй. Дээр дурдсан ийм аливаа холбогдох хүчин зүйлс оршин байхын хэрээр өртөг нь бодит үнэ цэнийг төлөөлөн илэрхийлж чадахгүй гэдгийг тэдгээр үзүүлэлтүүд илтгэн харуулж болох юм. Ийм тохиолдолд байгууллага нь бодит үнэ цэнийг хэмжих ёстой.

МЗУ143. Биржид арилжаалагддаг өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтын (эсвэл биржид арилжаалагддаг өмчийн хэрэглүүрийн гэрээний) хувьд өртөг нь хэзээ ч бодит үнэ цэнийн хамгийн сайн тооцоолол байдаггүй.

Бодит үнэ цэнийн хэмжилтийн анхаарах зүйлс

МЗУ144. Бодит үнэ цэнийн тодорхойлолтын суурь үндэслэл нь тухайн байгууллага татан буугдах, өөрийн үйл ажиллагааны цар хүрээг материаллаг хэмжээгээр багасгах эсвэл сөрөг нөхцлөөр ажил гүйлгээг хийх аливаа санаа төлөвлөгөөгүй буюу хэрэгцээ шаардлагагүй бөгөөд тасралтгүй байдлаар үйл ажиллагаагаа явуулна гэсэн урьдчилсан нөхцөл юм. Иймээс бодит үнэ цэнэ нь тухайн байгууллага албадан хүчилсэн ажил гүйлгээ, сайн дурын бус татан буугдалт

буюу дарамт шахалттай борлуулалтаар хүлээн авах эсвэл төлөх дүн биш юм. Гэхдээ бодит үнэ цэнэ нь тухайн хэрэглүүрийн зээлийн чанарыг тусгадаг.

МЗУ145. Энэ Стандарт нь жишиг зах зээлийн үнэтэй холбоотойгоор “санал болгосон худалдах үнэ”, “санал болгосон худалдан авах үнэ” (үүнийг зарим үед “одоогийн санал болгосон үнэ” гэж нэрлэдэг) гэсэн нэр томъёо, түүнчлэн зөвхөн ажил гүйлгээний зардлыг тусгахын тулд “санал болгосон худалдах-худалдан авах үнийн тархалт” нэр томъёог ашигладаг. Бодит үнэ цэнийг тодорхойлохын тулд хийх бусад тохируулга (жишээлбэл; оролцогч нөгөө талын зээлийн эрсдлийн хувьд хийх тохируулга) нь “санал болгосон худалдах-худалдан авах үнийн тархалт” нэр томъёонд хамаарахгүй.

Идэвхитэй зах зээл: Жишиг үнэ

МЗУ146. Хэрэв жишиг үнийг бирж, дилер, брокер, салбарын бүлэг, үнэ тогтоох үйлчилгээ, зохицуулалтын агентлагаас шууд, тогтмол авах боломжтой бөгөөд тэдгээр үнэ нь харилцан хамааралгүй талуудын сууриар бодитой ба тогтмол хийгдэх зах зээлийн ажил гүйлгээг төлөөлөн илэрхийлж байвал уг санхүүгийн хэрэглүүрийг идэвхитэй зах зээлийн жишиг үнэтэй гэж үзнэ. Арилжаанд оролцоход бэлэн байгаа худалдан авагч ба арилжаанд оролцоход бэлэн байгаа борлуулагч нар нь харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хүлээн зөвшөөрсөн үнийн нөхцлөөр бодит үнэ цэнийг тодорхойлдог. Идэвхитэй зах зээлд арилждаг санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тодорхойлох зорилго нь уг байгууллагын шууд хандан нэвтэрч болох хамгийн давуу талтай, идэвхитэй зах зээлд тэрхүү хэрэглүүрийг тухайн тайлант үеийн эцэст арилжих (өөрөөр хэлбэл, уг хэрэглүүрийг засварлан өөрчлөх буюу дахин нэгтгэн багцлахгүйгээр) ажил гүйлгээг хийх үнийг тогтоох явдал юм. Гэвч байгууллага нь тухайн зах зээлд арилжсан хэрэглүүрүүд болон уг үнэлж буй хэрэглүүрийн хоорондох оролцогч нөгөө талын зээлийн эрсдлийн аливаа зөрүүг тусгахын тулд тэрхүү илүү давуу талтай зах зээлийн үнийг тохируулдаг. Идэвхитэй зах зээлийн хэвлэн нийтэлсэн жишиг үнэ оршин байх нь бодит үнэ цэнийн хамгийн сайн нотолгоо болох бөгөөд хэрэв ийм үнэ байгаа бол санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг хэмжихдээ түүнийг ашиглана.

МЗУ147. Эзэмшиж буй хөрөнгө буюу гаргах өр төлбөрийн хувьд зах зээлийн тохиромжтой жишиг үнэ нь ихэвчлэн одоогийн санал болгосон худалдан авах үнэ байдаг. Харин олж эзэмших хөрөнгө буюу хариуцаж буй өр төлбөрийн хувьд зах зээлийн тохиромжтой жишиг үнэ нь санал болгосон худалдах үнэ байна. Байгууллага нь харилцан суутгаж, цэвэр дүн гаргах зах зээлийн эрсдэл бүхий хөрөнгө ба өр төлбөртэй тохиолдолд харилцан суутгах эрсдлийн төлөв байдлын хувьд бодит үнэ цэнийг тогтоох суурь болгон зах зээлийн дундаж үнийг ашиглаж болох бөгөөд тэрхүү цэвэр төлөв байдалдаа уг санал болгосон худалдан авах үнэ эсвэл санал болгосон худалдах үнийн аль тохиромжтойг мөрдөнө. Санал болгосон худалдан авах үнэ ба санал болгосон худалдах үнэ бэлэн боломжтой байхгүй тохиолдолд хамгийн сүүлийн үеийн ажил гүйлгээний үнэ нь тэрхүү ажил гүйлгээний өдрөөс хойш эдийн засгийн нөхцөл байдалд мэдэгдэхүйц өөрчлөлт ороогүй бол уг одоогийн бодит үнэ цэнийн талаархи нотолгоогоор хангадаг. Хэрэв уг ажил гүйлгээ гарсан өдрөөс хойш нөхцөл байдал өөрчлөгдсөн (жишээлбэл; засгийн газрын бондын хамгийн сүүлийн үеийн жишиг үнийн дараах эрсдэлгүй хүүний түвшний өөрчлөлт) бол тухайн бодит үнэ цэнэ нь ижил төсөөтэй санхүүгийн хэрэглүүрүүдийн одоогийн үнэ буюу ханшийг зохих ёсоор харгалзсанаар тэрхүү нөхцөл байдлын өөрчлөлтийг тусгана. Үүнтэй адилаар, уг хамгийн сүүлийн ажил гүйлгээний үнэ нь бодит үнэ цэнэ биш гэдгийг тухайн байгууллага батлан харуулж чадах (жишээлбэл; энэ нь албадан хүчилсэн ажил гүйлгээ, сайн дурын бус татан буугдалт буюу дарамт шахалттай борлуулалтаар тухайн байгууллагын хүлээн авах эсвэл төлөх дүнг тусгадаг байх) бол тэрхүү үнийг тохируулна. Санхүүгийн хэрэглүүрийн багцын бодит үнэ цэнэ нь уг хэрэглүүрийн нэгжүүдийн тоо ба түүний жишиг зах зээлийн үнийн үржвэр байдаг. Бүхэлдээ тухайн санхүүгийн хэрэглүүрийн хувьд идэвхитэй зах зээлийн хэвлэн нийтэлсэн жишиг үнэ байхгүй боловч түүний бүрэлдэхүүн хэсгүүдийн жишиг үнэ байх тохиолдолд тэдгээр бүрэлдэхүүн хэсгүүдийн холбогдох зах зээлийн үнүүдэд үндэслэн бодит үнэ цэнийг тодорхойлно.

МЗУ148. Хэрэв идэвхитэй зах зээлд жишиг ханш (үнээс бусад) байгаа бол байгууллага нь бодит үнэ цэнийг тодорхойлох үнэлгээний арга зүйн орц болгон тэрхүү жишиг зах зээлийн ханшийг

ашиглана. Хэрэв жишиг зах зээлийн ханш нь уг хэрэглүүрийн үнэ цэнийг тогтоохдоо зах зээлийн оролцогчдын харгалзан үздэг зээлийн эрсдэл буюу бусад хүчин зүйлсийг тусгаагүй бол тухайн байгууллага нь тэдгээр хүчин зүйлсийн хувьд тохируулга хийнэ.

Идэвхитэй бус зах зээл: Үнэлгээний арга зүй

- МЗУ149. Санхүүгийн хэрэглүүрийн зах зээл нь идэвхитэй бус бол байгууллага нь үнэлгээний арга зүйг ашигласнаар бодит үнэ цэнийг тогтоодог. Зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хоорондох харилцан хамааралгүй зах зээлийн сүүлийн үеийн ажил гүйлгээ, хэрэв байгаа бол бараг ижил, бусад хэрэглүүрийн одоогийн бодит үнэ цэнийн лавлагаа, дискаунтчилсан мөнгөн гүйлгээний шинжилгээ, опционы үнэ тогтоох загвар ашиглалт нь үнэлгээний арга зүйд хамаардаг. Хэрэглүүрийн үнийг тогтоохын тулд зах зээлийн оролцогчдын нийтлэг ашигладаг үнэлгээний арга зүй байдаг бөгөөд уг арга зүй нь зах зээлийн бодит ажил гүйлгээгээр олж авсан үнийн талаархи найдвартай тооцооллоор хангана гэдгийг харуулж байвал байгууллага нь тэрхүү арга зүйг ашиглана.
- МЗУ150. Үнэлгээний арга зүйг ашиглах зорилго нь хэвийн үйл ажиллагааны нөхцлөөр харилцан хамааралгүй талуудын хооронд хийгдэх ажил гүйлгээний үнийг уг хэмжилтийн өдрөөр тодорхойлох явдал байдаг. Зах зээлийн орцыг хамгийн ихээр ашиглах бөгөөд байгууллагын тусгайлсан орцод аль болох бага тулгуурлах үнэлгээний арга зүйн үр дүнд үндэслэн бодит үнэ цэнийг тооцоолдог. (а) Үнэлгээний арга зүй нь тухайн хэрэглүүрийн үнийг зах зээлээр хэрхэн тогтоох хүлээлтийг ул үндэслэлтэйгээр тусгадаг, ба (б) үнэлгээний арга зүйн орцууд нь зах зээлийн хүлээлт болон тухайн санхүүгийн хэрэглүүрийн угийн эрсдэл-өгөөжийн хүчин зүйлсийн хувьд хэмжилтийг ул үндэслэлтэйгээр илэрхийлдэг бол тэрхүү үнэлгээний арга зүйгээр бодит үнэ цэнийг бодитойгоор тооцоолно гэж үздэг.
- МЗУ151. Иймээс үнэлгээний арга зүй нь (а) зах зээлийн оролцогч нар үнэ тогтоохдоо харгалзах бүх хүчин зүйлсийг нэгтгэн тусгадаг, ба (б) санхүүгийн хэрэглүүрийн үнэ тогтоох эдийн засгийн хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалтай нийцдэг. Байгууллага нь үнэлгээний арга зүйг үечлэн шалгаж, тухайн хэрэглүүрийн ажиглаж болох одоогийн зах зээлийн аливаа ажил гүйлгээний үнийг (өөрөөр хэлбэл, засвар өөрчлөлт хийх буюу дахин нэгтгэн багцлахгүйгээр) ашигласнаар эсвэл ажиглаж болох зах зээлийн аливаа бэлэн боломжит мэдээнд үндэслэн түүний хүчин төгөлдөр байдлыг сорьж шалгадаг. Байгууллага нь тухайн хэрэглүүрийг анх үүсгэсэн буюу худалдан авсан зах зээл дэх зах зээлийн мэдээг тогтвортой олж авдаг.
- МЗУ152. Санхүүгийн хөрөнгийн анх олж эзэмшилт буюу үүсгэн гаргалт эсвэл санхүүгийн өр төлбөрийн анх үүсгэн хариуцалт нь тухайн санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тооцоолох суурь үндэслэлийг бүрдүүлэх зах зээлийн ажил гүйлгээ юм. Тухайлбал; санхүүгийн хэрэглүүр нь өрийн хэрэглүүр (зээл гэх мэт) бол түүний олж эзэмшилт буюу үүсгэлтийн өдрөөр оршин байсан зах зээлийн нөхцөл байдал ба одоогийн зах зээлийн нөхцөл байдал эсвэл ижил төсөөтэй өрийн хэрэглүүрийн (өөрөөр хэлбэл, дуусгавар болох үлдсэн хугацаа, мөнгөн гүйлгээний хэв маяг, валлот, зээлийн эрсдэл, барьцаа, хүүний суурийн хувьд ижил төсөөтэй) хувьд тухайн байгууллагын эсвэл бусад талуудын одоо тогтоосон хүүний түвшинг лавлагаа болгосноор уг өрийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тодорхойлдог. Нөгөө талаас, өрийн хэрэглүүрийг анх үүсгэсний дараах зээлдэгчийн зээлийн эрсдэл ба холбогдох зээлийн тархалтанд өөрчлөлт ороогүй бол уг суурь өрийн хэрэглүүрээс илүү сайн зээлийн чанартай бенчмарк хүүний түвшинг ашиглах, зээлийн тархалтыг тогтмол байлгах ба тэрхүү үүссэн өдрөөс хойш бенчмарк хүүний түвшинд орсон өөрчлөлтийн хувьд тохируулга хийснээр одоогийн зах зээлийн хүүний түвшний тооцооллыг хийж болно. Хамгийн сүүлийн үеийн зах зээлийн ажил гүйлгээнээс хойш нөхцөл байдал өөрчлөгдсөн бол уг үнэлж буй хэрэглүүрээс өөр байх аливаа ялгаатай талын хувьд зохих тохируулга хийсэн ижил төсөөтэй санхүүгийн хэрэглүүрийн одоогийн үнэ эсвэл ханшийг лавлагаа болгосноор тухайн үнэлж буй санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн харгалзах өөрчлөлтийг тодорхойлдог.
- МЗУ153. Тухайн мэдээлэл нь хэмжилтийн өдөр бүр бэлэн боломжтой байхгүй байж болох юм. Жишээлбэл; байгууллага нь зээл олгох эсвэл идэвхитэй арилждаггүй өрийн хэрэглүүрийг олж эзэмшсэн өдөр тухайн байгууллага нь уг ажил гүйлгээний үнийг мэддэг бөгөөд энэ нь мөн зах

зээлийн үнэ байна. Гэвч дараагийн хэмжилтийн өдөр шинэ ажил гүйлгээний мэдээлэл нь бэлэн боломжтой байхгүй байж болох бөгөөд хэдийгээр байгууллага нь зах зээлийн хүүний хувь хэмжээний ерөнхий түвшинг тодорхойлж чадах боловч тэрхүү өдрөөр уг хэрэглүүрийн үнийг тогтооходоо зах зээлийн оролцогчдын харгалзан үзэх зээлийн буюу бусад эрсдлийн түвшинг мэдэхгүй байж болох юм. Байгууллага нь өнөөгийн үнэ цэнийн тооцоололд хамаарах дискаунтын хувь хэмжээг тодорхойлоходоо ашиглах хүүний суурь түвшинд харгалзах зохих зээлийн тархалтыг тодорхойлох сүүлийн үеийн ажил гүйлгээний мэдээлэлгүй байж болох юм. Эсрэг нотолгоо байхгүй тохиолдолд уг зээлийг олгох үед оршин байсан тархалтанд өөрчлөлт ороогүй гэж үзэх нь ул үндэслэлтэй юм. Гэвч ийм хүчин зүйлс өөрчлөгдсөн талаархи нотолгоо байгаа эсэхийг тодорхойлохын тулд байгууллага нь ул үндэслэлтэй хүчин чармайлтыг гаргана гэж үздэг. Өөрчлөлт гарсан талаархи нотолгоо байгаа тохиолдолд байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тодорхойлоходоо уг өөрчлөлтийн үр нөлөөг харгалзан үзнэ.

МЗУ154. Дискаунтчилсан мөнгөн гүйлгээний шинжилгээг хэрэглэхдээ байгууллага нь тухайн хэрэглүүрийн зээлийн чанар, гэрээт хүүний хувь хэмжээ тогтмол байх үлдсэн хугацаа, үндсэн дүнг буцаан төлөх үлдсэн хугацаа, төлбөрийг барагдуулах валлот зэргийн хувьд бараг ижил нөхцөл ба шинж чанар бүхий санхүүгийн хэрэглүүрүүдийн өгөөжийн давамгайлах түвшинтэй тэнцүү нэг буюу хэд хэдэн дискаунтын хувийг ашигладаг.

Үнэлгээний арга зүйн орцууд

МЗУ155. Тодорхой санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тооцоолох тохиромжтой арга зүй нь зах зээлийн нөхцөл байдлын талаархи ажиглаж болох зах зээлийн мэдээ болон уг хэрэглүүрийн бодит үнэ цэнэд нөлөөлөх магадлалтай бусад хүчин зүйлсийг нэгтгэн тусгадаг. Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ нь дараах (магадгүй өөр бусад) нэг буюу хэд хэдэн хүчин зүйлсэд үндэслэдэг:

- (a) Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ (өөрөөр хэлбэл, суурь эсвэл эрсдэлгүй хүүний түвшин). Суурь хүүний түвшинг засгийн газрын бондын ажиглаж болох үнээс ихэвчлэн тооцон гаргадаг бөгөөд санхүүгийн хэвлэлд байнга нийтэлдэг. Эдгээр түвшин нь цаг хугацааны янз бүрийн интервалд хамаарах хүүний түвшний өгөөжийн муруйн дагуу уг төсөвлөсөн мөнгөн гүйлгээний хүлээгдэж буй өдрүүдээр ихэвчлэн хувьсан өөрчлөгддөг. Практик шалтгааны улмаас байгууллага нь свопын ханш гэх мэт нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн, шууд ажиглаж болох зах зээлийн ерөнхий түвшинг бенчмарк түвшин болгон ашиглаж болох юм (Хэрэв ашигласан хувь хэмжээ нь эрсдэлгүй хүүний түвшин биш бол тухайн санхүүгийн хэрэглүүрт тохиромжтой зээлийн эрсдлийн тохируулгыг энэхүү бенчмарк түвшинд хамаарах зээлийн эрсдэлтэй харьцуулсан түүний зээлийн эрсдэлд үндэслэн тодорхойлно). Зарим улс оронд төв засгийн газрын бонд нь зээлийн мэдэгдэхүйц эрсдэлтэй байж болох бөгөөд тухайн валютаар илэрхийлсэн хэрэглүүрийн хувьд тогтвортой бенчмарк суурь хүүний түвшин болж чадахгүй байж болох юм. Ийм улс оронд зарим байгууллагууд нь уг төв засгийн газраас илүү сайн зээлийн төлөв байдалтай бөгөөд зээллэгийн арай хүүтэй байж болно. Энэ тохиолдолд тухайн улсын валютаар гаргасан хамгийн өндөр зэрэглэлтэй, корпорацийн бондын хүүний түвшинг лавлагаа болгосноор суурь хүүний түвшинг илүү зохистой байдлаар тодорхойлж болох юм.
- (б) Зээлийн эрсдэл. Бодит үнэ цэнэд зээлийн эрсдлийн үзүүлэх үр нөлөөг (өөрөөр хэлбэл, зээлийн эрсдлийн хувьд суурь хүүний түвшин дээр нэмэгдэх урамшуулал) зээлийн янз бүрийн чанар бүхий, арилжаалсан хэрэглүүрүүдийн ажиглаж болох зах зээлийн үнээс эсвэл зээлийн өөр өөр зэрэглэл бүхий олгосон зээлийн хувьд зээлдүүлэгчийн тогтоосон, ажиглаж болох хүүний түвшнээс тооцон гаргаж болно.
- (в) Гадаад валютын ханш. Ихэнх гол валютын хувьд валютын арилжааны идэвхитэй зах зээл оршин байдаг бөгөөд санхүүгийн хэвлэлд ханшийг өдөр тутам жишиг болгон нийтэлдэг.
- (г) Бараа бүтээгдэхүүний үнэ. Маш олон бараа бүтээгдэхүүний хувьд ажиглаж болох зах зээлийн үнэ оршин байдаг.

- (д) Өмчийн үнэ. Арилжаалсан өмчийн хэрэглүүрийн үнийг (ба үнийн индексийг) зарим зах зээлд шууд ажиглах боломжтой байдаг. Ажиглаж болох үнэ байхгүй өмчийн хэрэглүүрийн одоогийн зах зээлийн үнийг тооцоолохын тулд өнөөгийн үнэ цэнийн арга зүйг ашиглаж болох юм.
- (е) Хувьсан өөрчлөлт (өөрөөр хэлбэл, санхүүгийн хэрэглүүр буюу бусад зүйлийн үнэд ирээдүйд гарах өөрчлөлтийн ач холбогдол). Идэвхитэй арилжаалдаг зүйлсийн хувьсан өөрчлөлтийн хэмжүүрийг зах зээлийн түүхэн мэдээнд үндэслэн эсвэл одоогийн зах зээлийн үнэд тусган илэрхийлэгдсэн хувьсан өөрчлөлтийг ашиглан ихэвчлэн ул үндэслэлтэйгээр тооцоолж болно.
- (ж) Урьдчилсан төлбөрийн эрсдэл ба төлбөр үл төлөх эрсдэл. Санхүүгийн хөрөнгийн хувьд хүлээгдэж буй урьдчилсан төлбөрийн хэв маяг ба санхүүгийн өр төлбөрийн хувьд хүлээгдэж буй төлбөр үл төлөх хэв маягийг түүхэн мэдээнд үндэслэн тооцоолж болно. (Нөгөө тал төлөхгүй байж болох санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнэ нь уг үл төлөх дүнгийн өнөөгийн үнэ цэнээс бага байж болохгүй - 68-р параграфыг үзнэ үү.)
- (и) Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрт үйлчилгээ үзүүлэх зардал. Зах зээлийн бусад оролцогчдын авах одоогийн хураамжтай хийсэн зэрэгцүүлэлтийг ашигласнаар үйлчилгээ үзүүлэх зардлыг тооцоолж болох юм. Хэрэв санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрт үйлчилгээ үзүүлэх зардал нь мэдэгдэхүйц хэмжээтэй бөгөөд зах зээлийн бусад оролцогчид нь зэрэгцүүлэгдэх зардал гаргадаг бол тэрхүү санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлоходоо гаргагч нь түүнийг харгалзан үзнэ. Ирээдүйн хураамж ба холбогдох зардал нь зах зээлийн зэрэгцүүлэгдэх дүнгүүдтэй нийцэхгүй байхаас бусад тохиолдолд ирээдүйн хураамжийг авах эрхийн уг гэрээ үүссэн өдрөөрх бодит үнэ цэнэ нь түүний хувьд төлсөн үүсгэлтийн зардалтай тэнцүү байх магадлалтай юм.

Хорогдуулсан өртгийн хэмжилт

Үр ашигт хүүний арга

МЗУ156. Үр ашигт хүүний аргыг хэрэглэх үед байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн үр ашигт хүүний салшгүй нэг хэсэг болох хураамжийг тодорхойлно. Санхүүгийн үйлчилгээний хураамжийн нэр утга нь тухайн үзүүлсэн үйлчилгээний шинж төрөл ба агуулгыг илэрхийлдэггүй байж болно. Санхүүгийн хэрэглүүрийг бодит үнэ цэнээр хэмжиж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөгөөс бусад тохиолдолд тухайн санхүүгийн хэрэглүүрийн үр ашигт хүүний салшгүй нэг хэсэг болох хураамжийг үр ашигт хүүний залруулга гэж үзнэ. Ийм тохиолдолд уг хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрөх үедээ хураамжийг орлого эсвэл зардал гэж хүлээн зөвшөөрнө.

МЗУ157. Санхүүгийн хэрэглүүрийн үр ашигт хүүний салшгүй нэг хэсэг болох хураамжинд дараах зүйлс хамаарна:

- (а) Санхүүгийн хөрөнгийг гаргах эсвэл худалдан авахтай холбоотойгоор байгууллагын хүлээн авдаг үүсгэлтийн хураамж. Ийм хураамж нь зээлдэгчийн санхүүгийн нөхцөл байдлыг үнэлэх, баталгаа, барьцаа болон бусад аюулгүй байдлын арга хэмжээг үнэлэх ба бүртгэх, санхүүгийн хэрэглүүрийн нөхцлийг хэлэлцэн тохирох, баримт бичгийг бэлтгэж боловсруулах, ажил гүйлгээг дуусгаж, хаах гэх мэт үйл ажиллагааны төлбөрийг багтаасан байж болно. Ийм хураамж нь уг үр дүн болох санхүүгийн хэрэглүүртэй холбоотой оролцоог бий болгох үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг юм.
- (б) Зээл олгох баталгааг 45(а) параграфын дагуу хэмждэггүй бөгөөд тохиролцсон зээлийн хэлцлийг байгууллага хийх нэлээд магадлалтай тохиолдолд зээл олгохын тулд байгууллагын хүлээн авдаг баталгааны хураамж. Ийм хураамжийг санхүүгийн хэрэглүүрийн худалдан авалттай холбоотой байнгын оролцооны нөхөн төлбөр гэж үздэг. Байгууллага нь зээл олгохгүйгээр уг баталгааны хугацаа дууссан бол хураамжийг тэрхүү хугацаа дууссан өдрөөр орлого гэж хүлээн зөвшөөрнө.

- (в) Хорогдуулсан өртгөөр нь хэмждэг санхүүгийн өр төлбөрийг гаргах үед төлдөг үүсгэлтийн хураамж. Ийм хураамж нь санхүүгийн өр төлбөртэй холбоотой оролцоог бий болгох үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг юм. Байгууллага нь санхүүгийн өр төлбөрийн үр ашигт хүүний салшгүй нэг хэсэг болох хураамж ба зардлыг хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ гэх мэт үйлчилгээ үзүүлэх эрхтэй холбоотой үүсгэлтийн хураамж ба ажил гүйлгээний зардлаас тусад нь ялгаж үзнэ.

МЗУ158. Санхүүгийн хэрэглүүрийн үр ашигт хүүний салшгүй нэг хэсэг болохгүй хураамжийг УСНББОУС 9-ийн дагуу тайлагнах бөгөөд үүнд дараах зүйлс хамаарна:

- (а) Зээл олгох үйлчилгээний хураамж;
- (б) Зээл олгох баталгааг 45(а) параграфын дагуу хэмждэггүй бөгөөд тохиролцсон зээлийн хэлцлийг хийх магадлал багатай тохиолдолд зээл олгох баталгааны хураамж;
- (в) Зээл олгох ажиллагааг зохион байгуулдаг бөгөөд зээлийн багцын тодорхой нэг хэсгийг өөртөө авч үлддэггүй (бусад оролцогчдын эрсдэлтэй адил, зэрэгцүүлэгдэх эрсдлийн хувьд тухайн үр ашигт хүүний хувиар тооцогдох тодорхой зарим хэсгийг авч үлддэг) байгууллагын хүлээн авсан зээлийн нэгдлийн хураамж.

МЗУ159. Үр ашигт хүүний аргыг хэрэглэх үедээ байгууллага нь аливаа хураамж, төлсөн эсвэл хүлээн авсан бусад дүн, ажил гүйлгээний зардал, түүнчлэн уг үр ашигт хүүний тооцоололд багтсан бусад урамшуулал буюу хөнгөлөлтийг ихэвчлэн тухайн санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацаанд хорогдуулдаг. Гэвч тэдгээр хураамж, төлсөн эсвэл хүлээн авсан бусад дүн, ажил гүйлгээний зардал, урамшуулал буюу хөнгөлөлтийн хамаарах хугацаа нь санхүүгийн хэрэглүүрийн хугацаанаас богино бол тэрхүү богино хугацаанд хорогдуулна. Хураамж, төлсөн эсвэл хүлээн авсан бусад дүн, ажил гүйлгээний зардал, урамшуулал буюу хөнгөлөлтийн хамаарах хувьсагчийг уг санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй дуусгавар болох хугацаанаас өмнө зах зээлийн түвшнээр дахин үнэлэн тогтоодог бол ийм тохиолдол үүсэж болно. Ингэж тохиолдолд зохих хорогдуулгын хугацаа нь дараагийн дахин үнэ тогтоох өдөр хүртэлх хугацаа байна. Жишээлбэл; хөвөгч хүүтэй санхүүгийн хэрэглүүрийн урамшуулал буюу хөнгөлөлт нь хүүг хамгийн сүүлд төлснөөс хойш тухайн санхүүгийн хэрэглүүрийн хувьд хуримтлагдсан хүүг, эсвэл уг хөвөгч хүүг зах зээлийн түвшнээр дахин тогтоосноос хойш зах зээлийн түвшинд гарсан өөрчлөлтийг тусгадаг бол хөвөгч хүүг зах зээлийн түвшнээр дахин тогтоох дараагийн өдөр хүртэлх хугацаанд урамшуулал, хөнгөлөлтийг хорогдуулна. Яагаад гэвэл, урамшуулал буюу хөнгөлөлтийн хамаарах хувьсагчийг (өөрөөр хэлбэл, хүүний түвшинг) тэрхүү өдөр зах зээлийн түвшнээр тогтоодог тул уг урамшуулал буюу хөнгөлөлт нь хүүг дахин тогтоох дараагийн өдөр хүртэлх хугацаанаас хамаардаг. Харин урамшуулал буюу хөнгөлөлт нь тухайн санхүүгийн хэрэглүүрт заасан хөвөгч хүүний зээлийн тархалтын өөрчлөлтөөс эсвэл зах зээлийн түвшнээр дахин тогтоодоггүй бусад хувьсагчдын үр дүн бол урамшуулал, хөнгөлөлтийг тэрхүү санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацаанд хорогдуулна.

МЗУ160. Хөвөгч хүүтэй санхүүгийн хөрөнгө ба хөвөгч хүүтэй санхүүгийн өр төлбөрийн хувьд зах зээлийн хүүний түвшинд гарсан өөрчлөлтийг тусгах үүднээс хийх мөнгөн гүйлгээний үечилсэн дахин тооцоолол нь уг үр ашигт хүүний хувийг өөрчилдөг. Хөвөгч хүүтэй санхүүгийн хөрөнгө буюу хөвөгч хүүтэй санхүүгийн өр төлбөрийг тэдгээрийн дуусгавар болох өдрөөрх авлага, өглөгийн үндсэн дүнтэй тэнцүү дүнгээр анх хүлээн зөвшөөрдөг бол ирээдүйн хүүний төлбөрүүдийн дахин тооцоолол нь тухайн хөрөнгө буюу өр төлбөрийн дансны үнэд ихэвчлэн мэдэгдэхүйц үр нөлөөгүй байдаг.

МЗУ161. Байгууллага нь мөнгөн орлого буюу төлбөрийн талаархи өөрийн тооцооллыг (71-р параграфт заасан засвар өөрчлөлт ба хүлээгдэж буй зээлийн алдагдлын тооцооллын өөрчлөлт хамаарахгүй) хянан засварладаг бол тухайн байгууллага нь бодит гүйцэтгэлийн болон хянан засварлаж, тооцоолсон гэрээний мөнгөн гүйлгээг тусгахын тулд уг санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнэ буюу санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртгийг (эсвэл санхүүгийн хэрэглүүрүүдийн бүлгийн) тохируулна. Байгууллага нь санхүүгийн хөрөнгийн анхны үр ашигт хүүний хувиар (худалдан авсан буюу үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд зээлийн эрсдлээр тохируулсан үр ашигт хүүний хувиар), эсвэл

хамааралтай тохиолдолд 139-р параграфын дагуу тооцоолсон, хянан засварласан үр ашигт хүүний хувиар дискаунтчилсан, уг тооцоолсон ирээдүйн гэрээний мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнээр тухайн санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнэ буюу санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртгийг дахин тооцоолно. Энэхүү тохируулгыг орлого эсвэл зардал байдлаар ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

МЗУ162. Зээлийн эрсдэл маш өндөр байгаа, түүнчлэн худалдан авалтын хувьд маш их хөнгөлөлттэйгээр олж эзэмшсэний улмаас зарим тохиолдолд санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үедээ зээлийн үнэ цэнийн бууралттай гэж үздэг. Анх хүлээн зөвшөөрөх үед худалдан авсан буюу үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай гэж үздэг санхүүгийн хөрөнгийн хувьд зээлийн эрсдлээр тохируулсан үр ашигт хүүний хувийг тооцоолохдоо байгууллага нь анхнаасаа хүлээгдэж байсан зээлийн алдагдлыг тэрхүү тооцоолсон мөнгөн гүйлгээнд тусган оруулах шаардлагатай юм. Гэхдээ анх хүлээн зөвшөөрөх үед тухайн санхүүгийн хөрөнгө нь зээлийн өндөр эрсдэлтэй учраас зээлийн эрсдлээр тохируулсан үр ашигт хүүний хувийг зөвхөн хэрэглэнэ гэсэн үг биш юм.

Ажил гүйлгээний зардал

МЗУ163. Ажил гүйлгээний зардал нь агент (үүн дотроо, борлуулалтын агент байдлаар ажиллаж буй ажилтнууд), зөвлөгч, брокер, дилерт төлсөн хураамж, шимтгэл, эрх бүхий байгууллагын болон хөрөнгийн биржээс ногдуулсан шимтгэл, гүйлгээний татвар, төлбөрөөс бүрддэг. Өрийн урамшуулал буюу хөнгөлөлт, санхүүжилтийн зардал, дотоод захиргаа удирдлагын буюу зэмшилтийн зардал нь ажил гүйлгээний зардалд хамаарахгүй.

Данснаас хасалт

МЗУ164. Санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь, эсвэл түүний зарим хэсгийг данснаас хасаж болно. Жишээлбэл; байгууллага нь санхүүгийн хөрөнгийн барьцааг албадан борлуулахаар төлөвлөж байгаа бөгөөд уг барьцаанаас санхүүгийн хөрөнгийн 30 хувиас илүүгүй хэсгийг нөхөхөөр хүлээгдэж байна. Хэрэв байгууллага нь тухайн санхүүгийн хөрөнгөөс цаашид ямар нэг мөнгөн гүйлгээ олж авах ул үндэслэлтэй хэтийн төлөвгүй бол тэрхүү санхүүгийн хөрөнгийн үлдэх 70 хувийг данснаас хасна.

Үнэ цэнийн бууралт

Бие даасан болон нэгдсэн үнэлгээний суурь

МЗУ165. Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойшхи зээлийн эрсдлийн мэдэгдэхүйц нэмэгдэлтийн хувьд нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх зорилгыг биелүүлэх үүднээс байгууллага нь тухайлбал, санхүүгийн хэрэглүүрүүдийн бүлгийн буюу дэд бүлгийн зээлийн эрсдлийн мэдэгдэхүйц нэмэгдэлтийн илрэл болох мэдээллийг харгалзан үзсэнээр тухайн зээлийн эрсдлийн мэдэгдэхүйц нэмэгдэлтийн үнэлгээг нэгдсэн сууриар хийх шаардлагатай байж болно. Ингэснээр бие даасан хэрэглүүрийн түвшинд зээлийн эрсдэл ингэж мэдэгдэхүйц нэмэгдсэн талаархи нотолгоо хараахан байхгүй байлаа ч гэсэн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн тохиолдолд байгууллага нь нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх зорилгоо биелүүлсэн гэдгийг ханган магадлах юм.

МЗУ166. Санхүүгийн хэрэглүүрийн төлбөрийн хугацаа хэтрэхээс өмнө тухайн нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг ерөнхийдөө хүлээн зөвшөөрнө гэж үздэг. Санхүүгийн хэрэглүүрийн төлбөрийн хугацаа хэтрэх эсвэл зээлдэгч төлбөрийг хойшлуулах бусад тусгай хүчин зүйлсийг (жишээлбэл; засварлан өөрчлөлт буюу бүтцийн өөрчлөлт) ажиглан тогтоохоос өмнө, зээлийн эрсдэл нь ихэвчлэн мэдэгдэхүйц нэмэгдсэн байдаг. Иймээс өнгөрсөн хугацааны биш, харин илүү хэтийн талаархи ул үндэслэлтэй ба дэмжих мэдээллийг их зардал буюу хүчин чармайлт гаргахгүйгээр олж авах боломжтой бол зээлийн эрсдлийн өөрчлөлтийг үнэлэхдээ уг мэдээллийг ашиглах ёстой.

МЗУ167. Гэвч санхүүгийн хэрэглүүрүүдийн шинж төрөл, түүнчлэн санхүүгийн хэрэглүүрүүдийн тодорхой бүлгийн хувьд зээлийн эрсдлийн мэдээлэл бэлэн боломжтой байгаа эсэхээс хамааран, байгууллага нь бие даасан санхүүгийн хэрэглүүрүүдийн зээлийн эрсдлийн мэдэгдэхүйц өөрчлөлтийг тухайн санхүүгийн хэрэглүүрийн төлбөрийн хугацаа хэтрэхээс өмнө тодорхойлох боломжгүй байж болох юм. Үйлчлүүлэгч нь гэрээний нөхцлөө зөрчихгүй л бол бие даасан хэрэглүүрийн хувьд тогтмол хүлээн авч, хянан үнэлдэг зээлийн эрсдлийн талаархи мэдээлэл байдаггүй эсвэл маш бага байх жижиг зээл гэх мэт санхүүгийн хэрэглүүрүүдийн хувьд ийм тохиолдол үүсэж болно. Бие даасан санхүүгийн хэрэглүүрүүдийн зээлийн эрсдлийн өөрчлөлтийг тэдгээр хэрэглүүрийн төлбөрийн хугацаа хэтрэхээс өмнө олж авдаггүй бол зөвхөн бие даасан санхүүгийн хэрэглүүрийн түвшин дэх зээлийн мэдээлэлд үндэслэсэн гарзын хасагдуулга нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш тухайн зээлийн эрсдэлд гарсан өөрчлөлтийг үнэн зөв төлөөлөн илэрхийлж чадахгүй юм.

МЗУ168. Зарим тохиолдолд байгууллага нь нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг бие даасан санхүүгийн хэрэглүүр бүрээр хэмжихэд шаардлагатай ул үндэслэлтэй ба дэмжих мэдээллийг их зардал буюу хүчин чармайлт гаргахгүйгээр олж авах боломжгүй байдаг. Ийм тохиолдолд нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тухайн зээлийн эрсдлийн дэлгэрэнгүй мэдээллийг харгалзсан нэгдсэн сууриар хүлээн зөвшөөрнө. Бие даасан хэрэглүүрийн түвшинд анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн бол нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлын хүлээн зөвшөөрөх байсан үр дүнтэй ойролцоо утга гаргахын тулд энэхүү зээлийн эрсдлийн дэлгэрэнгүй мэдээлэл нь зөвхөн өнгөрсөн хугацааны мэдээлэл төдийгүй зээлийн холбогдох бүх мэдээллийг, үүн дотроо макро эдийн засгийн хэтийн төлөвийн талаархи мэдээллийг тусгасан байх ёстой.

МЗУ169. Зээлийн эрсдлийн мэдэгдэхүйц нэмэгдэлтийг тодорхойлох ба гарзын хасагдуулгыг нэгдсэн сууриар хүлээн зөвшөөрөх зорилгоор, байгууллага нь зээлийн эрсдлийн мэдэгдэхүйц нэмэгдэлтийг тухайн цаг хугацаанд нь тодорхойлох боломж олгоход чиглэгдсэн шинжилгээнд туслалцаа үзүүлэх үүднээс санхүүгийн хэрэглүүрүүдийг тэдгээрийн зээлийн эрсдлийн нийтлэг шинж чанарт үндэслэн бүлэглэж болно. Байгууллага нь эрсдлийн өөр өөр шинж чанар бүхий санхүүгийн хэрэглүүрүүдийг бүлэглэснээр энэхүү мэдээллийг бүрхэгдүүлж болохгүй. Зээлийн эрсдлийн нийтлэг шинж чанаруудын жишээнд дараах зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:

- (а) Хэрэглүүрийн төрөл;
- (б) Зээлийн эрсдлийн зэрэглэл;
- (в) Барьцааны төрөл;
- (г) Анхны хүлээн зөвшөөрөлтийн өдөр;
- (д) Дуусгавар болох хүртэл үлдсэн хугацаа;
- (е) Салбар;
- (ж) Зээлдэгчийн газарзүйн байршил;
- (и) Үл биелүүлэх магадлалтай бол тухайн санхүүгийн хөрөнгөнд хамаарах барьцааны үнэ цэнэ (жишээлбэл; зарим эрх зүйн орчин дахь баталгаагүй зээл буюу зээл-барьцаа хөрөнгийн үнэ цэнийн харьцаа).

МЗУ170. 76-р параграф нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн бүх санхүүгийн хэрэглүүрийн хувьд нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөхийг шаарддаг. Энэхүү зорилгыг биелүүлэхийн тулд байгууллага нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн гэж үзсэн санхүүгийн хэрэглүүрүүдийг тэдгээрийн зээлийн эрсдлийн нийтлэг шинж чанарт үндэслэн бүлэглэх боломжгүй байвал тухайн байгууллага нь зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн гэж үзсэн уг санхүүгийн хөрөнгийн тэрхүү хэсгийн хувьд нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрнө. Зээлийн эрсдлийн өөрчлөлтийг нэгдсэн сууриар үнэлэх үүднээс санхүүгийн хэрэглүүрүүдийг нэгтгэх үйл явц нь бие даасан санхүүгийн хэрэглүүр эсвэл санхүүгийн

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

хэрэглүүрүүдийн бүлгийн талаархи шинэ мэдээлэл бий болсноор цаг хугацааны явцад өөрчлөгдөж болох юм.

Нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх хугацаа

- МЗУ171. Нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх эсэх үнэлгээ нь тухайн тайлант үеийн эцсээр санхүүгийн хөрөнгийн зээлийн үнэ цэнэ буурч байгаа эсвэл үл биелүүлэлт бодитойгоор гарч тохиолдсон талаархи нотолгоонд биш, харин анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш үл биелүүлэлт гарч тохиолдох магадлал буюу эрсдлийн мэдэгдэхүйц нэмэгдэлтэнд (зээлийн эрсдлийн нэмэгдэлтийг тусгахын тулд санхүүгийн хэрэглүүрийг дахин үнэлэн тусгадаг эсэхийг үл харгалзан) үндэслэдэг. Санхүүгийн хөрөнгийн зээлийн үнэ цэнэ буурах эсвэл үл биелүүлэлт бодитойгоор гарч тохиолдохоос өмнө ерөнхийдөө зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгддэг.
- МЗУ172. Зээл олгох баталгааны хувьд, байгууллага нь тэрхүү зээл олгох баталгаанд хамаарах тухайн зээлийг үл биелүүлэх эрсдлийн өөрчлөлтийг харгалзаж үздэг. Харин санхүүгийн баталгааны гэрээний хувьд, байгууллага нь тухайн тохиролцсон зээлдэгч уг гэрээгээ үл биелүүлэх эрсдлийн өөрчлөлтийг харгалзан үзнэ.
- МЗУ173. Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойшхи зээлийн эрсдлийн өөрчлөлт мэдэгдэхүйц нөлөөтэй эсэх нь анх хүлээн зөвшөөрөх үед тооцсон үл биелүүлэлт гарч тохиолдох эрсдлээс хамаардаг. Иймээс үл биелүүлэлт гарч тохиолдох эрсдлийн үнэмлэхүй утгаар илэрхийлэгдсэн өөрчлөлт нь үл биелүүлэлт гарах анхнаасаа өндөр эрсдэлтэй байсан санхүүгийн хэрэглүүртэй харьцуулахад үл биелүүлэлт гарах анхнаасаа бага эрсдэлтэй байсан санхүүгийн хэрэглүүрийн хувьд илүү мэдэгдэхүйц нөлөөтэй байдаг.
- МЗУ174. Адилтган зэрэгцүүлж болох зээлийн эрсдэл бүхий санхүүгийн хэрэглүүрүүдийн хувьд үл биелүүлэлт гарч тохиолдох эрсдэл нь арай урт хугацаатай байхаар хүлээгдэж буй санхүүгийн хэрэглүүрийн хувьд илүү өндөр байдаг. Жишээлбэл; 10 жилийн хугацаатай байхаар хүлээгдэж буй ААА зэрэглэлийн бондыг үл биелүүлэх эрсдэл нь 5 жилийн хугацаатай байхаар хүлээгдэж буй ААА зэрэглэлийн бондыг үл биелүүлэх эрсдлээс өндөр байдаг.
- МЗУ175. Хүлээгдэж буй хугацаа ба үл биелүүлэлт гарч тохиолдох эрсдэл хоорондоо харилцан хамааралтай байдаг учраас үл биелүүлэлт гарах үнэмлэхүй эрсдлийн өөрчлөлтийг зөвхөн тодорхой цаг хугацаагаар зэрэгцүүлснээр уг зээлийн эрсдлийн өөрчлөлтийг үнэлж болохгүй юм. Жишээлбэл; анх хүлээн зөвшөөрөх үед 10 жилийн хугацаатай байхаар хүлээгдэж буй санхүүгийн хэрэглүүрийн хувьд үл биелүүлэлт гарч тохиолдох эрсдэл нь дараагийн тайлант үеүдэд, тухайлбал түүний хүлээгдэж буй хугацаа ердөө 5 таван жил болсон үед тухайн санхүүгийн хэрэглүүрийн хувьд үл биелүүлэлт гарч тохиолдох эрсдэлтэй ижил байвал энэ нь зээлийн эрсдэл нэмэгдсэнийг илтгэж болох юм. Яагаад гэвэл, тухайн зээлийн эрсдэл өөрчлөгдөөгүй бол цаг хугацаа урсан өнгөрч, уг санхүүгийн хэрэглүүрийн дуусгавар болох хугацаа ойртохын хэрээр тэрхүү хүлээгдэж буй үлдсэн хугацаанд үл биелүүлэлт гарч тохиолдох эрсдэл ихэвчлэн буурдаг. Харин санхүүгийн хэрэглүүрийн дуусгавар болох өдөртэй зөвхөн ойр хугацаанд мэдэгдэхүйц төлбөр төлөх үүрэг бүхий санхүүгийн хэрэглүүрийн хувьд үл биелүүлэлт гарах эрсдэл нь цаг хугацаа урсан өнгөрснөөр заавал буурдаггүй байж болох юм. Ийм тохиолдолд байгууллага нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг батлан харуулах бусад чанарын хүчин зүйлсийг мөн харгалзан үзнэ.
- МЗУ176. Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг үнэлэх эсвэл хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжихдээ байгууллага нь янз бүрийн арга хандлагуудыг ашиглаж болох юм. Байгууллага нь өөр санхүүгийн хэрэглүүрийн хувьд өөр арга хандлагуудыг хэрэглэж болно. Байгууллага нь үл биелүүлэлт гарч тохиолдох эрсдлийн өөрчлөлтийг барьцаа гэх мэт тухайн хүлээгдэж буй зээлийн алдагдлын бусад хөтлөгч хүчин зүйлсийн өөрчлөлтөөс салган тусгаарлах боломжтой бөгөөд ийм үнэлгээг хийхдээ дараах зүйлсийг харгалзан үздэг бол үл биелүүлэлтийн магадлалыг анхдагч үзүүлэлт

болгон тусгадаггүй, зээлийн алдагдлын хувийн жингийн арга гэх мэт арга хандлага нь энэ Стандартын шаардлагуудтай нийцдэг байж болох юм:

- (а) Үл биелүүлэлт гарч тохиолдох эрсдэлд анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш орсон өөрчлөлт;
- (б) Санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацаа;
- (в) Их зардал буюу хүчин чармайлт гаргахгүйгээр олж авах боломжтой бөгөөд зээлийн эрсдэлд нөлөөлж болох ул үндэслэлтэй ба дэмжих мэдээлэл.

МЗУ177. Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг тодорхойлохын тулд ашиглах арга нь тухайн санхүүгийн хэрэглүүр (буюу санхүүгийн хэрэглүүрүүдийн бүлэг)-ийн шинж чанар, түүнчлэн адилтган зэрэгцүүлж болох санхүүгийн хэрэглүүрүүдийн хувьд өнгөрсөн хугацаанд гарч тохиолдсон үл биелүүлэлтийн хэв загварыг харгалзсан байна. Үл биелүүлэлт гарах хэв загвар нь тухайн санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааны тодорхой нэг цэгт төвлөрдөггүй санхүүгийн хэрэглүүрүүдийн хувьд 81-р параграфын шаардлагуудыг үл харгалзвал, дараагийн 12 сарын дотор үл биелүүлэлт гарах эрсдлийн өөрчлөлт нь нийт хугацаанд үл биелүүлэлт гарах эрсдлийн өөрчлөлттэй ул үндэслэлтэйгээр ойролцоо дүн байж болох юм. Ийм тохиолдолд нийт хугацааны үнэлгээг заавал хийх шаардлагатай гэдгийг нөхцөл байдал илэрхийлээгүй л бол байгууллага нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг тодорхойлохдоо дараагийн 12 сарын хугацаанд үл биелүүлэлт гарч тохиолдох эрсдлийн өөрчлөлтийг ашиглаж болно.

МЗУ178. Гэвч зарим санхүүгийн хэрэглүүр буюу зарим нөхцөл байдлын хувьд, нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх эсэхийг тодорхойлохдоо дараагийн 12 сарын хугацаанд үл биелүүлэлт гарч тохиолдох эрсдлийн өөрчлөлтийг ашиглах нь тохиромжгүй байж болно. Тухайлбал; дараагийн 12 сарын хугацаанд үл биелүүлэлт гарах эрсдлийн өөрчлөлт нь 12 сараас урт дуусгавар хугацаатай санхүүгийн хэрэглүүрийн хувьд дараах тохиолдолд зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг тодорхойлох тохиромжтой суурь биш байж болно:

- (а) Санхүүгийн хэрэглүүр нь зөвхөн дараагийн 12 сараас цаашхи хугацаанд мэдэгдэхүйц төлбөр төлөх үүрэгтэй байх;
- (б) Дараагийн 12 сарын хугацаанд үл биелүүлэлт гарч тохиолдох эрсдэлд зохих ёсоор тусгагдаагүй, холбогдох макро эдийн засгийн орчинд эсвэл зээлд хамаарах бусад хүчин зүйлсэд өөрчлөлт орсон; эсвэл
- (в) Санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдэлд зөвхөн 12 сараас цаашхи хугацаанд нөлөө үзүүлэх (эсвэл илт тодорхой нөлөө үзүүлэх) зээлд хамаарах бусад хүчин зүйлс өөрчлөгдсөн.

Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг тодорхойлох

МЗУ179. Нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх шаардлагатай эсэхийг тодорхойлох үедээ байгууллага нь их зардал буюу хүчин чармайлт гаргахгүйгээр олж авах боломжтой бөгөөд 90(в) параграфт зааснаар санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдэлд нөлөө үзүүлж болох ул үндэслэлтэй ба дэмжих мэдээллийг харгалзан үзнэ. Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг тодорхойлохдоо, байгууллага нь мэдээллийн иж бүрэн, хэт дэлгэрэнгүй эрэл хайгуул хийх шаардлагагүй юм.

МЗУ180. Зээлийн эрсдлийн шинжилгээ бол олон хүчин зүйлсийн цогц шинжилгээ юм; тухайн хүчин зүйл хамааралтай ба бусад хүчин зүйлстэй харьцуулахад ач холбогдолтой эсэх нь бүтээгдэхүүний төрөл, санхүүгийн хэрэглүүрийн шинж чанар, зээлдэгч, түүнчлэн газарзүйн бүс зэргээс хамаардаг. Байгууллага нь их зардал буюу хүчин чармайлт гаргахгүйгээр олж авах боломжтой бөгөөд тухайн үнэлж буй санхүүгийн хэрэглүүрт хамааралтай ул үндэслэлтэй ба дэмжих мэдээллийг харгалзан үзнэ. Гэхдээ зарим хүчин зүйлс буюу үзүүлэлтийг бие даасан

санхүүгийн хэрэглүүрийн түвшинд тодорхойлох боломжгүй байж болно. Ийм тохиолдолд нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх 75-р параграфт заасан шаардлага хангагдсан эсэхийг тодорхойлохын тулд санхүүгийн хэрэглүүрийн зохих багц, багцуудын бүлэг эсвэл багцын хэсгүүдийн хувьд эдгээр хүчин зүйлс буюу үзүүлэлтүүдийг үнэлнэ.

МЗУ181. Зээлийн эрсдлийн өөрчлөлтийг үнэлэхэд хамааралтай байж болох мэдээллийн жагсаалтыг доор харуулав. Гэхдээ энэхүү жагсаалтанд бүгдийг багтаагаагүй байгаа болно:

- (а) Хэрэв уг санхүүгийн хэрэглүүрийг эсвэл түүнтэй ижил нөхцөл ба ижил оролцогч тал бүхий, ижил төсөөтэй санхүүгийн хэрэглүүрийг тухайн тайлант үеийн эцэст шинээр үүсгэсэн буюу гаргасан бол гэрээний өдрөөс хойш зээлийн эрсдэлд орох өөрчлөлтийн үр дүнд зээлийн эрсдлийн үнийн дотоод үзүүлэлтүүдэд үүсэх байсан мэдэгдэхүйц өөрчлөлтүүд, үүнд зээлийн тархалт хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй.
- (б) Хэрэв уг хэрэглүүрийг тухайн тайлант үеийн эцэст (илүү хатуу нөхцөлтэй болгох, барьцаа буюу баталгааны дүнг нэмэгдүүлэх, орлогын хамаарах хэмжээг өсгөх гэх мэт) шинээр үүсгэсэн буюу гаргасан бол анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдэл өөрчлөгдсөний улмаас мэдэгдэхүйц өөр болох байсан, тэрхүү одоо байгаа санхүүгийн хэрэглүүрийн хувь хэмжээ буюу нөхцлийн бусад өөрчлөлтүүд.
- (в) Тухайн санхүүгийн хэрэглүүрийн эсвэл хүлээгдэж буй ижил хугацаа бүхий ижил төсөөтэй санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдлийн зах зээлийн гадаад үзүүлэлтүүдэд гарсан мэдэгдэхүйц өөрчлөлтүүд. Зээлийн эрсдлийн зах зээлийн үзүүлэлтийн өөрчлөлтүүдэд дараах зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:
 - (i) Зээлийн тархалт;
 - (ii) Зээлдэгчийн зээлийн үл биелүүлэлтийн свопын үнэ;
 - (iii) Санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь түүний хорогдуулсан өртгөөс бага болох хэмжээ буюу үргэлжлэх хугацаа;
 - (iv) Зээлдэгчтэй холбоотой, тухайн зээлдэгчийн өрийн болон өмчийн хэрэглүүрийн үнийн өөрчлөлт гэх мэт зах зээлийн бусад мэдээлэл.
- (г) Санхүүгийн хэрэглүүрийн зээлийн гадаад зэрэглэлд гарах бодит гүйцэтгэлийн буюу хүлээгдэж буй мэдэгдэхүйц өөрчлөлт.
- (д) Тухайн зээлдэгчийн зээлийн дотоод зэрэглэлд гарах бодит гүйцэтгэлийн буюу хүлээгдэж буй бууралт, эсвэл зээлийн эрсдлийг дотооддоо үнэлэхэд ашигладаг төлөв байдлын онооны бууралт. Зээлийн дотоод зэрэглэл ба төлөв байдлын дотоод оноо нь гаднын зэрэглэлтэй тохирдог буюу үл биелүүлэлтийн талаархи судалгаагаар дэмжигдэн батлагддаг бол илүү найдвартай үзүүлэлт байдаг.
- (е) Зээлдэгч өөрийн өрийн үүргээ биелүүлэх чадвар боломжинд мэдэгдэхүйц өөрчлөлт орох шалтгаан болохоор хүлээгдэж буй хүүний түвшний бодит буюу хүлээгдэж буй нэмэгдэлт, ажилгүйдлийн түвшний бодит буюу хүлээгдэж буй мэдэгдэхүйц өсөлт гэх мэт бизнес, санхүү буюу эдийн засгийн нөхцөл байдалд одоо гарсан эсвэл урьдчилан таамагласан сөрөг өөрчлөлтүүд.
- (ж) Зээлдэгчийн үйл ажиллагааны үр дүнд гарсан бодит гүйцэтгэлийн буюу хүлээгдэж буй мэдэгдэхүйц өөрчлөлт. Жишээлбэл; өөрийн өрийн үүргийг биелүүлэх тухайн зээлдэгчийн чадвар боломжинд мэдэгдэхүйц өөрчлөлт ороход хүргэдэг орлого, ашгийн бодит гүйцэтгэлийн буюу хүлээгдэж буй бууралт, үйл ажиллагааны эрсдлийн нэмэгдэлт, ажлын капиталын хүрэлцээгүй байдал, хөрөнгийн чанарын бууралт, баланс дахь өрийн эх үүсвэрийн нэмэгдэлт, төлбөрийн чадварын болон удирдлагын асуудлууд, үйл ажиллагааны цар хүрээний буюу зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлт (тухайн байгууллагын сегментийн үйл ажиллагааг зогсоох гэх мэт).

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

- (и) Тухайн зээлдэгчийн өөр бусад санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдэлт.
 - (к) Технологийн өөрчлөлтийн улмаас зээлдэгчийн борлуулдаг бүтээгдэхүүний эрэлт буурах гэх мэтээр зээлдэгч өөрийн өрийн үүргийг биелүүлэх чадвар боломжинд мэдэгдэхүйц өөрчлөлт оруулах тухайн зээлдэгчийн зохицуулалтын, эдийн засгийн, технологийн орчин дахь бодит гүйцэтгэлийн буюу хүлээгдэж буй өөрчлөлт.
 - (л) Үүргийн баталгаа болгосон барьцааны үнэ цэнэд эсвэл гуравдагч талын баталгаа буюу зээлийн сайжруулалтын чанарт орсон мэдэгдэхүйц өөрчлөлт. Энэ нь хуваарьт гэрээний төлбөрөө төлөх уг зээлдэгчийн эдийн засгийн сэдэл санаачлагыг бууруулах буюу ингэснээр үл биелүүлэх магадлалыг нэмэгдүүлэх үр нөлөөтэй байхаар хүлээгдэж байх. Жишээлбэл; орон байрны үнэ буурсаны улмаас барьцаа хөрөнгийн үнэ цэнэ буурсан бол зарим улс оронд зээлдэгч нь өөрийн моргейжийн зээлийг үл биелүүлэх илүү их сэдэл сонирхолтой болдог.
 - (м) Хувьцаа эзэмшигч (буюу хувь хүний хувьд батлан даагч) нь капитал эсвэл мөнгө оруулах замаар үл биелүүлэлтээс сэргийлэх сэдэл сонирхолтой бөгөөд санхүүгийн чадвартай бол тухайн хувьцаа эзэмшигч (буюу батлан даагч)-ийн гаргаж өгсөн баталгааны чанарт орсон мэдэгдэхүйц өөрчлөлт.
 - (н) Хяналт тавигч байгууллага буюу бусад холбоотой байгууллагаас үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн бууралт, эсвэл зээлийн сайжруулалтын чанарт гарсан бодит гүйцэтгэлийн буюу хүлээгдэж буй мэдэгдэхүйц өөрчлөлт гэх мэт мэдэгдэхүйц өөрчлөлтүүд. Тэдгээр нь хуваарьт гэрээний төлбөрөө төлөх уг зээлдэгчийн эдийн засгийн сэдэл санаачлагыг бууруулахаар хүлээгдэж байх. Зээлийн чанарын сайжруулалтууд буюу дэмжлэг нь баталгаа гаргагчийн санхүүгийн байдал, түүнчлэн үнэт цаасжуулалтаар гаргасан хувь оролцооны хувьд тэрхүү тэргүүн бус ээлжийн эрхтэй хувьцаа оролцоо нь хүлээгдэж буй зээлийн алдагдлыг (жишээлбэл; уг үнэт цаасны суурь үндэслэл болох зээлийн хувьд) нөхөх боломжтой байх эсэх талаархи шинжилгээг тусгасан байдаг.
 - (о) Зээлийн баримт бичгийн, үүн дотроо гэрээний зөрчилтийн талаархи хүлээгдэж буй өөрчлөлт. Энэ нь гэрээг түдгэлзүүлэх буюу нэмэлт өөрчлөлт оруулах, хүүний төлбөрөөс чөлөөлөх, хүүний түвшинг шатлан нэмэгдүүлэх, нэмэлт барьцаа буюу баталгаа шаардах буюу тухайн хэрэглүүрийн гэрээний цар хүрээнд бусад өөрчлөлт оруулахад хүргэж болох юм.
 - (п) Зээлдэгчийн хүлээгдэж буй гүйцэтгэл ба төлөв байдлын мэдэгдэхүйц өөрчлөлт, үүнд бүлэг доторх зээлдэгчдийн төлбөрийн төлөв байдалд оруулах өөрчлөлт (жишээлбэл; гэрээний хойшлогдсон төлбөрүүдийн хүлээгдэж буй тоо буюу хэмжээний өсөлт, эсвэл өөрийн зээлийн лимитэнд хүрч байгаа буюу лимитийг хэтрүүлэхээр хүлээгдэж буй, эсвэл сар тутам хамгийн бага дүнгээр төлөхөөр хүлээгдэж буй кредит картын зээлдэгчдийн хүлээгдэж буй тооны мэдэгдэхүйц нэмэгдэлт).
 - (р) Санхүүгийн хэрэглүүртэй холбоотой тухайн байгууллагын зээлийн удирдлагын арга хандлагын өөрчлөлт; өөрөөр хэлбэл, санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтийн шинээр гарч ирсэн үзүүлэлтүүдэд үндэслэн уг байгууллагын зээлийн эрсдлийн удирдлагын практик нь илүү идэвхитэй болох буюу хэрэглүүрийг удирдахад төвлөрөн чиглэх болсон. Үүнд: тухайн хэрэглүүрийг илүү сайн хянан үнэлж, шинжлэх эсвэл тэрхүү зээлдэгчтэй байгууллага нь тусгайлан хамтран ажиллах.
 - (с) Өнгөрсөн хугацааны мэдээлэл, үүн дотроо 83-р параграфт дурдсан няцааж болох урьдчилсан нөхцөл.
- МЗУ182. Зарим тохиолдолд, бэлэн боломжтой байгаа чанарын болон статистикийн бус тоон мэдээлэл нь нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр гарзын хасагдуулга хүлээн зөвшөөрөх шалгуурыг уг санхүүгийн хэрэглүүр хангасан эсэхийг тодорхойлоход хангалттай байж болох юм. Өөрөөр хэлбэл, санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг тодорхойлохын тулд статистик загвар эсвэл зээлийн зэрэглэл тогтоох үйл явцаар мэдээлэл олж авах шаардлагагүй юм. Харин өөр зарим тохиолдолд байгууллага нь бусад

мэдээллийг, үүн дотроо өөрийн статистик загвар эсвэл зээлийн зэрэглэл тогтоох үйл явцаар олж авсан мэдээллийг харгалзан үзэх шаардлагатай байж болно. Мөн түүнчлэн, дотоод зэрэглэл тогтоох үйл явцаар харгалзан үзэх боломжгүй чанарын хүчин зүйлс ба анх хүлээн зөвшөөрөх үеийн зээлийн эрсдлийн шинж чанаруудыг харгалзсан, тухайн тайлант үеийн эцсээрх дотоод зэрэглэл тогтоох тусгай ангилал гэсэн хоёр төрлийн мэдээллийн аль аль нь хамааралтай байвал байгууллага нь уг хоёр төрлийн мэдээллийн хоёуланд үндэслэн үнэлгээг хийж болно.

30 хоногоос илүүгээр хугацаа өнгөрөлтөнд хамаарах няцааж болох урьдчилсан нөхцөл

МЗУ183. 83-р параграфт дурдсан няцааж болох урьдчилсан нөхцөл нь нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй гэсэн туйлын үзүүлэлт биш боловч хэтийн мэдээллийг (үүн дотроо багцын түвшин дэх макро эдийн засгийн хүчин зүйлсийг) ашиглах үед ч гэсэн нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх хамгийн эцсийн цэг гэж төсөөлнө.

МЗУ184. Байгууллага нь энэхүү төсөөллийг няцааж чадах юм. Гэрээний төлбөр 30 хоногоос илүүгээр хугацаа хэтэрсэн боловч энэ нь санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдлийн мэдэгдэхүйц нэмэгдэлтийг илэрхийлэхгүй гэдгийг батлан харуулах ул үндэслэлтэй ба дэмжих мэдээлэл зөвхөн байх тохиолдолд байгууллага нь ингэж няцааж чадах юм. Жишээлбэл; төлбөр төлөөгүй нь зээлдэгчийн санхүүгийн хүндрэлтэй байдлын үр дүн биш, харин удирдлагын хайнга үйлдэл байсан эсвэл тухайн байгууллага нь үл биелүүлэлтийн эрсдлийн мэдэгдэхүйц нэмэгдэлт ба 30 хоногоос илүүгээр төлбөрийн хугацаа хэтэрсэн санхүүгийн хөрөнгийн хооронд ямар нэг харилцан хамаарал байхгүй гэдгийг батлан харуулж чадах түүхэн нотолгоотой боловч уг нотолгоо нь 60 хоногоос илүүгээр төлбөрийн хугацаа хэтэрсэн тохиолдолд ийм харилцан хамааралтай гэдгийг илэрхийлдэг байх.

МЗУ185. Байгууллага нь зээлийн эрсдлийн мэдэгдэхүйц нэмэгдэлтийн болон нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлын хүлээн зөвшөөрөлтийн хугацааг тухайн санхүүгийн хөрөнгийг зээлийн үнэ цэнийн бууралттай гэж үзэх эсвэл үл биелүүлэлтийг уг байгууллага дотооддоо тодорхойлох хугацаатай зэрэгцүүлэн харгалзуулж чаддаггүй.

Тухайн тайлант үеийн эцэст зээлийн эрсдэл багатай байгаа санхүүгийн хэрэглүүр

МЗУ186. Санхүүгийн хэрэглүүр нь үл биелүүлэлтийн эрсдэл багатай, зээлдэгч нь өөрийн гэрээний мөнгөн гүйлгээний үүргийг ойрын ирээдүйд биелүүлэх чадавхи сайтай байгаа бөгөөд урт хугацаанд эдийн засгийн болон бизнесийн нөхцөл байдалд сөрөг өөрчлөлт гарч болох боловч гэрээний мөнгөн гүйлгээний үүргээ биелүүлэх уг зээлдэгчийн чадварыг заавал бууруулахааргүй байвал 82-р параграфын зорилгын хувьд тухайн санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдлийг бага гэж үзнэ. Барьцаа хөрөнгийн үнэ цэнийг зөвхөн харгалзсанаар алдагдал хүлээх эрсдэл бага гэж тооцсон бөгөөд ийм барьцаа хөрөнгөгүй бол тэрхүү санхүүгийн хэрэглүүрийг зээлийн эрсдэл багатай гэж үзэхээргүй байсан бол тухайн санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдлийг бага гэж үзэхгүй. Мөн түүнчлэн, санхүүгийн хэрэглүүр нь тухайн байгууллагын бусад санхүүгийн хэрэглүүрийн үл биелүүлэлтийн эрсдэл эсвэл байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчны зээлийн эрсдэлтэй харьцуулахад эрсдэл багатай тул уг санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдэл бага гэж шууд үзэж болохгүй юм.

МЗУ187. Санхүүгийн хэрэглүүр нь зээлийн эрсдэл багатай эсэхийг тодорхойлохын тулд байгууллага нь зээлийн эрсдэл бага гэдэг талаархи дэлхий нийтээр ойлгодог тодорхойлолттой нийцсэн ба тухайн үнэлж буй санхүүгийн хэрэглүүрийн эрсдэл, төрлийг харгалзсан, зээлийн эрсдлийн талаархи өөрийн дотоод зэрэглэл буюу бусад арга зүйг ашиглаж болно. “Хөрөнгө оруулалтын үнэ цэнэг” гэсэн гаднын зэрэглэлтэй бол энэ нь зээлийн эрсдэл багатай гэж үзэж болох санхүүгийн хэрэглүүрийн жишээ юм. Гэвч санхүүгийн хэрэглүүрийг зээлийн эрсдэл багатай гэж үзэхийн тулд заавал гаднын үнэлэмж тогтоосон байхыг шаардахгүй. Харин зах зээлд оролцогчдын зүгээс тухайн санхүүгийн хэрэглүүрийн бүх нөхцөл, болзлыг харгалзснаар түүнийг зээлийн эрсдэл багатай гэж үзсэн байвал зохино.

МЗУ188. Зөвхөн өмнөх тайлант үед зээлийн эрсдэл багатай гэж үзсэн боловч тухайн тайлант үеийн эцэст зээлийн эрсдэл бага гэж үзээгүй санхүүгийн хэрэглүүрийн хувьд нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөхгүй. Энэ тохиолдолд байгууллага нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэх, иймээс нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг 75-р параграфын дагуу хүлээн зөвшөөрөх шаардлагатай эсэхийг тодорхойлно.

Өөрчлөлт

МЗУ189. Зарим тохиолдолд санхүүгийн хөрөнгийн гэрээний мөнгөн гүйлгээг дахин хэлэлцэн тохирох буюу өөрчлөх нь уг одоо байгаа санхүүгийн хөрөнгийг энэ Стандартын дагуу үл хүлээн зөвшөөрөхөд хүргэдэг. Санхүүгийн хөрөнгийн өөрчлөлт нь уг одоо байгаа санхүүгийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлт ба тухайн өөрчилсөн санхүүгийн хөрөнгийн дараагийн хүлээн зөвшөөрөлтийг бий болгох үр дүнтэй тохиолдолд тэрхүү өөрчилсөн хөрөнгийг энэ Стандартын зорилгын хувьд “шинэ” санхүүгийн хөрөнгө гэж үзнэ.

МЗУ190. Иймээс уг өөрчилсөн санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтын шаардлагуудыг мөрдөх үед энэхүү өөрчлөлтийн огноог тухайн санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн огноотой адилтгаж үзнэ. Энэ нь үндсэндээ 75-р параграфт заасан, нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх шаардлагууд хангагдах хүртэл 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр гарзын хасагдуулгыг хэмжинэ гэсэн үг юм. Гэвч анхны санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхөд хүргэсэн өөрчлөлтийн дараах зарим хэвийн бус нөхцөл байдалд, тэрхүү өөрчилсөн санхүүгийн хөрөнгө нь анх хүлээн зөвшөөрөх үед зээлийн үнэ цэнийн буурсан, иймээс уг санхүүгийн хөрөнгийг үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх байсан гэсэн нотолгоо байж болох юм. Жишээлбэл; анхны санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхөд хүргэх байдлаар тэрхүү асуудалтай хөрөнгөнд мэдэгдэхүйц өөрчлөлт хийсэн үед ийм тохиолдол үүсэж болно. Ийм тохиолдолд анх хүлээн зөвшөөрөх үед зээлийн үнэ цэнийн бууралттай, шинэ санхүүгийн хөрөнгө үүсгэн гаргах тийм өөрчлөлт байж болох юм.

МЗУ191. Санхүүгийн хөрөнгийн гэрээний мөнгөн гүйлгээг дахин хэлэлцэн тохирсон буюу бусад байдлаар өөрчилсөн боловч тухайн санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөөгүй бол тэрхүү санхүүгийн хөрөнгийг зээлийн эрсдэл багатай гэж шууд үзэж болохгүй юм. Байгууллага нь их зардал буюу хүчин чармайлт гаргахгүйгээр олж болох ул үндэслэлтэй ба дэмжих бүх мэдээлэлд үндэслэн анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг үнэлнэ. Ийм ул үндэслэлтэй ба дэмжих мэдээлэл нь түүхэн болон хэтийн төлөвийн мэдээлэл, санхүүгийн хөрөнгийн хүлээгдэж буй хугацаан дахь зээлийн эрсдлийн үнэлгээ, үүн дотроо уг өөрчлөлт хийхэд хүргэсэн нөхцөл байдлын талаархи мэдээллийг агуулсан байдаг. Нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх шалгуур цаашид хангагдахгүй талаархи нотолгоо нь уг өөрчилсөн гэрээний нөхцлийн дагуу сүүлийн үед болон тогтоосон цаг хугацаандаа хийгдсэн төлбөрийн талаархи түүхэн мэдээ байж болох юм. Зээлийн эрсдэл буурсан гэж үзэхээс өмнөх хугацааны туршид төлбөрийн тууштай, сайн төлөв байдалтай байсан гэдгээ үйлчлүүлэгч нь ихэвчлэн батлан харуулах шаардлагатай байдаг. Жишээлбэл; гэрээний нөхцлийг өөрчилсөний дараа нэг төлбөрийг хугацаанд нь хийснээр өмнөх орхигдуулсан буюу бүрэн бус хийсэн төлбөрийн талаархи түүхийг ихэвчлэн шууд арилган өөрчлөхгүй билээ.

Хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилт

Хүлээгдэж буй зээлийн алдагдал

МЗУ192. Хүлээгдэж буй зээлийн алдагдал нь тухайн санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацаан дахь зээлийн алдагдлын магадлалаар жинэлсэн тооцоолол (өөрөөр хэлбэл, мөнгөний бүх алдагдлын өнөөгийн үнэ цэнэ) юм. Мөнгөний алдагдал гэдэг нь гэрээний дагуу байгууллагад төлөгдөх ёстой мөнгөн гүйлгээ ба тухайн байгууллага авахаар хүлээж буй мөнгөн гүйлгээний хоорондох зөрүү юм. Хүлээгдэж буй зээлийн алдагдалд төлбөрийн дүн ба хугацааг харгалзан

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

үздэг учраас хэдийгээр байгууллага нь төлбөрөө бүрэн авах боловч гэрээний дагуу төлөх хугацаанаас хожимдож авснаар зээлийн алдагдал үүсдэг.

- МЗУ193. Санхүүгийн хөрөнгийн хувьд, зээлийн алдагдал нь дараах дүнгүүдийн хоорондох зөрүүний өнөөгийн үнэ цэнэ байна:
- (а) Гэрээний дагуу байгууллагад төлөгдөх ёстой гэрээний мөнгөн гүйлгээ; ба
 - (б) Байгууллага авахаар хүлээж буй мөнгөн гүйлгээ.
- МЗУ194. Зээл олгох ашиглаагүй баталгааны хувьд зээлийн алдагдал нь дараах дүнгүүдийн хоорондох зөрүүний өнөөгийн үнэ цэнэ байна:
- (а) Зээл олгох баталгааг эзэмшигч нь зээлийг авсан бол тухайн байгууллагад төлөгдөх байсан гэрээний мөнгөн гүйлгээ; ба
 - (б) Зээлийг авсан бол тухайн байгууллага авахаар хүлээж буй мөнгөн гүйлгээ.
- МЗУ195. Зээл олгох баталгааны хувьд хүлээгдэж буй зээлийн алдагдлын талаархи байгууллагын тооцоолол нь уг зээл олгох баталгааны дагуу авах зээлийн хүлээлттэй нийцсэн байвал зохино. Өөрөөр хэлбэл, 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолохдоо тухайн тайлант үеийн эцсээс хойшхи 12 сарын дотор ашиглахаар хүлээгдэж буй уг зээл олгох баталгааны хэсгийг харгалзан үзнэ. Харин нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолох үедээ уг зээл олгох баталгааны нийт хугацаанд ашиглахаар хүлээгдэж буй уг зээл олгох баталгааны хэсгийг харгалзан үзнэ.
- МЗУ196. Санхүүгийн баталгааны гэрээний хувьд, тухайн зээлдэгч нь уг баталгаа гаргасан хэрэглүүрийн нөхцлүүдийн дагуу төлбөрийн үүргээ үл биелүүлсэн зөвхөн тийм тохиолдолд байгууллага нь төлбөр төлөх шаардлагатай болдог. Иймээс мөнгөн алдагдал нь гарсан зээлийн алдагдлын хувьд тухайн баталгаа эзэмшигчид нөхөн төлбөр болгон төлөхөөр хүлээгдэж буй дүнгээс уг байгууллага нь тэрхүү баталгаа эзэмшигч, зээлдэгч буюу бусад талаас авахаар хүлээгдэж байгаа аливаа дүнг хассан дүн байна. Хэрэв хөрөнгийн хувьд бүрэн баталгаа гаргасан бол санхүүгийн баталгааны гэрээний хувьд мөнгөн алдагдлын талаархи тооцоолол нь тухайн баталгаанд хамаарах хөрөнгийн мөнгөн алдагдлын тооцоололтой нийцсэн байна.
- МЗУ197. Тухайн тайлант үеийн эцсээр зээлийн үнэ цэнэ буурсан боловч худалдан авсан буюу үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгө биш байх тийм санхүүгийн хөрөнгийн хувьд байгууллага нь тухайн хөрөнгийн нийт дансны үнэ ба уг санхүүгийн хөрөнгийн анхны үр ашигт хүүний түвшнээр дискаунтчилж, тооцоолсон ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ хоорондох зөрүүгээр тэрхүү хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжинэ. Аливаа тохируулгыг үнэ цэнийн бууралтын олз эсвэл гарз байдлаар ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.
- МЗУ198. Түрээсийн авлагын хувьд гарзын хасагдуулгыг хэмжих үед, хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тодорхойлоход ашигласан мөнгөн гүйлгээ нь тухайн түрээсийн авлагыг УСНББОУС 13, *Түрээс*-ийн дагуу хэмжихэд ашигласан мөнгөн гүйлгээтэй нийцсэн байна.
- МЗУ199. Хүлээгдэж буй зээлийн алдагдал нь 90-р параграфт заасан зарчимтай нийцдэг эсэхийг үнэлэх үедээ байгууллага нь практик арга туршлагыг ашиглаж болно. Практик арга туршлагын жишээ нь хасагдуулгын матрицыг ашигласнаар худалдааны авлагын хувьд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолох явдал юм. Байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн хувьд 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдал эсвэл нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлын аль тохиромжтойг тооцоолохын тулд худалдааны авлагын хувьд зээлийн алдагдлын талаархи (МЗУ215-МЗУ216-р параграфын дагуу зохих ёсоор тохируулсан) өөрийн түүхэн туршлагыг ашиглана. Тухайлбал; хасагдуулгын матриц нь худалдааны авлагын төлөгдөөгүй хугацаа хэтэрсэн хоногийн тооноос хамааран нөөцийг тогтмол хувиар (жишээ нь; хэрэв хугацаа хэтрээгүй бол 1%, 30-аас цөөн хоногоор хугацаа хэтэрсэн бол 2%, 30-аас дээш боловч 90-ээс цөөн хоногоор хугацаа хэтэрсэн бол 3%, 90-180 хоногоор хугацаа хэтэрсэн бол 20% гэх мэт) байгуулахаар зааж болох юм. Үйлчлүүлэгчдийн өөр өөр сегментүүдийн хувьд зээлийн

алдагдлын хэв загвар нь мэдэгдэхүйц ялгаатай гэдгийг зээлийн алдагдлын түүхэн туршлага харуулж байвал байгууллага нь өөрийн үйлчлүүлэгчдийн баазын олон төрөл, ялгаатай байдлаас хамааран тохирох бүлэглэлийг ашиглаж болно. Хөрөнгийг бүлэглэхийн тулд ашиглаж болох шалгуурын жишээнд газарзүйн бүс, бүтээгдэхүүний нэр төрөл, үйлчлүүлэгчийн зэрэглэл, барьцаа хөрөнгө буюу худалдааны зээлийн даатгал, үйлчлүүлэгчдийн төрөл (бөөний эсвэл жижиглэнгийн гэх мэт) хамаарна.

Үл биелүүлэлтийн тодорхойлолт

МЗУ200. Санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг тодорхойлох үедээ байгууллага нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш үл биелүүлэлт гарч тохиолдох эрсдлийн өөрчлөлтийг харгалзан үзэхийг 81-р параграфтаар шаардсан байдаг.

МЗУ201. Үл биелүүлэлт гарч тохиолдох эрсдлийг тогтоох зорилгоор үл биелүүлэлтийг тодорхойлох үедээ байгууллага нь холбогдох санхүүгийн хэрэглүүрийн хувьд зээлийн эрсдлийн дотоод удирдлагын зорилгоор ашигладаг тодорхойлолттой нийцсэн, үл биелүүлэлтийн тодорхойлолтыг ашиглах бөгөөд хэрэв тохиромжтой бол чанарын үзүүлэлтүүдийг (жишээлбэл; санхүүгийн хэлцлийг) харгалзан үзнэ. Гэвч үл биелүүлэлтийн арай урт хугацааны шалгуур илүү тохиромжтой гэдгийг батлан харуулах үл үндэслэлтэй ба дэмжих мэдээлэл тухайн байгууллагад байхаас бусад тохиолдолд санхүүгийн хөрөнгийн хувьд 90 хоногоос цаашир хугацаанд үл биелүүлэлт гарч тохиолдохгүй гэсэн няцааж болох урьдчилсан нөхцөлтэй байдаг. Тухайн санхүүгийн хэрэглүүрийн хувьд үл биелүүлэлтийн өөр тодорхойлолт илүү тохиромжтой гэдгийг батлан харуулах мэдээлэл үүсэн бий болсноос бусад тохиолдолд энэхүү зорилгын хувьд ашиглаж байсан үл биелүүлэлтийн тодорхойлолтыг бүх санхүүгийн хэрэглүүрт тууштай мөрдөнө.

Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолох хугацаа

МЗУ202. 92-р параграфт заасанчлан, хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжих хамгийн урт хугацаа нь тухайн байгууллагад зээлийн эрсдэл учрах уг гэрээний хамгийн урт хугацаа байна. Зээл олгох баталгаа ба санхүүгийн баталгааны гэрээний хувьд, зээлийн алдагдлыг хэмжих хамгийн урт хугацаа нь байгууллага уг зээлийг сунгах гэрээний одоогийн үүрэг бүхий тухайн гэрээний хамгийн урт хугацаа байна.

МЗУ203. Гэвч 93-р параграфт заасанчлан, зарим санхүүгийн хэрэглүүр нь зээл, түүнчлэн зээл олгох баталгааны ашиглаагүй хэсгийн аль алиныг агуулсан байдаг бөгөөд зээлийг буцаан төлөхийг шаардах ба ашиглаагүй баталгааг хүчингүй болгох уг байгууллагын гэрээний эрх нь тэрхүү гэрээг өөрчлөх талаархи мэдэгдлийн хугацаанд тухайн байгууллагад зээлийн алдагдал үүссээр байх эрсдлийг хязгаарлаж чадахгүй. Жишээлбэл; зээлдүүлэгч нь зээлийн карт, овердрафт гэх мэт богино хугацаат эргэлтийн зээлийн хэрэгслүүдийг гэрээний дагуу нэг өдрийн мэдэгдлийн хугацаа гэх мэт богино хугацааны дотор буцаан татаж чаддаг. Гэвч практикт, зээлдүүлэгч нь зээлийг илүү урт хугацаагаар сунгасан хэвээр байх бөгөөд хүлээгдэж буй зарим буюу бүх зээлийн алдагдлаас сэргийлэхэд хэт оройтож, тухайн зээлдэгчийн зээлийн эрсдэл нэмэгдсэний дараа л уг хэрэгслийг татаж чадахаар байж болох юм. Тухайн санхүүгийн хэрэглүүрийн шинж төрөл, санхүүгийн хэрэглүүрийг удирдах арга зам, зээлийн эрсдлийн мэдэгдэхүйц нэмэгдэлтийн талаархи бэлэн байгаа мэдээлэл зэргээс хамааран ийм санхүүгийн хэрэглүүр нь ерөнхийдөө дараах шинж чанартай байдаг:

- (а) Санхүүгийн хэрэглүүр нь тогтмол хугацаа буюу буцаан төлөх хуваарьгүй бөгөөд ихэвчлэн гэрээг цуцлах богино хугацаатай (жишээлбэл; нэг өдөр) байх;
- (б) Гэрээг цуцлах тэрхүү гэрээний нөхцөл, боломжийг санхүүгийн хэрэглүүрийн өдөр тутмын хэвийн удирдлагаар хэрэгжүүлдэггүй бөгөөд уг зээлийн арга хэрэгслийн түвшинд зээлийн эрсдэл нэмэгдсэнийг тухайн байгууллага мэдсэн үед гэрээг зөвхөн цуцалж болох юм;
- (в) Санхүүгийн хэрэглүүрийг нэгдсэн сууриар удирддаг.

МЗУ204. Байгууллагад зээлийн эрсдэл учрахаар хүлээгдэж байгаа боловч уг хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тухайн байгууллагын зээлийн эрсдлийн удирдлагын хэвийн арга хэмжээгээр бууруулах боломжгүй байх хугацааг тодорхойлох үедээ байгууллага нь дараах зүйлсийн талаархи түүхэн мэдээлэл болон туршлага гэх мэт хүчин зүйлсийг харгалзан үзнэ:

- (а) Ижил төсөөтэй санхүүгийн хэрэглүүрийн хувьд байгууллагад зээлийн эрсдэл учирч байсан хугацаа;
- (б) Зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэний дараа ижил төсөөтэй санхүүгийн хэрэглүүрийн хувьд холбогдох үл биелүүлэлт гарч тохиолдох хугацааны урт;
- (в) Санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдэл нэмэгдмэгц байгууллагын авч хэрэгжүүлэхээр хүлээж буй, ашиглаагүй зээлийн лимитийн бууруулалт буюу хүчингүй болголт гэх мэт зээлийн эрсдлийн удирдлагын арга хэмжээ.

Магадлалаар жинэлсэн үр дүн

МЗУ205. Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолох зорилго нь хамгийн муу эсвэл хамгийн сайн хувилбарыг тооцоолох явдал биш юм. Харин хүлээгдэж буй зээлийн алдагдлын тооцоолол нь зээлийн алдагдал үүсэх боломж, түүнчлэн хэдийгээр хамгийн магадлалтай үр дүн нь зээлийн алдагдалгүй байх явдал боловч ийм зээлийн алдагдал үүсэхгүй байх тийм боломжийг ямагт тусгадаг.

МЗУ206. Хүлээгдэж буй зээлийн алдагдлын тооцоолол нь боломжит үр дүнгүүдийн хамаарах мужийг үнэлэх замаар тодорхойлдог, хэт нэг талыг баримтлаагүй ба магадлалаар жинэлсэн дүнг тусгахыг 90(а) параграфтаар шаардсан байдаг. Практикт заавал иж бүрэн шинжилгээ хийх шаардлагагүй байж болох юм. Зарим тохиолдолд хувилбаруудын маш олон нарийвчилсан загварчлал шаардлагагүй бөгөөд харьцангуй энгийн загвар гаргах нь хангалттай байж болно. Жишээлбэл; эрсдлийг хамтран хуваах шинж чанар бүхий санхүүгийн хэрэглүүрүүдийн томоохон бүлгийн дундаж зээлийн алдагдал нь магадлалаар жинэлсэн дүнгийн ул үндэслэлтэй тооцоолол байж болох юм. Харин өөр зарим тохиолдолд, тодорхой үр дүнгүүд болон тэдгээр үр дүнгүүдийн тооцоолсон магадлалын хувьд мөнгөн гүйлгээний дүн ба хугацааг тусгайлан заасан хувилбаруудын тодорхойлолт шаардлагатай болох магадлалтай байдаг. Ийм нөхцөл байдалд тэрхүү хүлээгдэж буй зээлийн алдагдал нь 91-р параграфт заасанчлан, хамгийн наад зах нь хоёр үр дүнг тусгасан байвал зохино.

МЗУ207. Нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлын хувьд, байгууллага нь уг санхүүгийн хөрөнгийн хүлээгдэж буй нийт хугацаанд үл биелүүлэлт гарч тохиолдох эрсдлийг тооцоолдог. 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдал нь нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлын нэг хэсэг бөгөөд тухайн тайлант үеийн эцсээс хойшхи 12 сарын дотор (санхүүгийн хөрөнгийн хүлээгдэж буй хугацаа нь 12 сараас богино бол тэрхүү богино хугацаанд) хэрэв үл биелүүлэлт гарвал үүсэх ба тийм үл биелүүлэлт гарч тохиолдох магадлалаар жинэлсэн, нийт хугацаан дахь мөнгөний алдагдлыг илэрхийлдэг. Иймээс 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдал нь дараагийн 12 сарын дотор үл биелүүлэлт гарч тохиолдоно гэж урьдчилан таамаглаж байгаа санхүүгийн хэрэглүүрийн хувьд байгууллагад учрах, нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдал ч биш, дараагийн 12 сарын хугацаанд урьдчилан таамаглаж байгаа мөнгөний дутагдал ч биш юм.

Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ

МЗУ208. Анхны хүлээн зөвшөөрөлтийн үед тодорхойлсон үр ашигт хүүний хувь эсвэл түүнтэй ойролцоо хувийг ашигласнаар уг хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тэрхүү хүлээгдэж буй үл биелүүлэлтийн өдөр эсвэл өөр бусад өдөр хүртэл биш, харин зөвхөн тухайн тайлант үеийн эцэс хүртэл дискаунтчилна. Хэрэв санхүүгийн хэрэглүүр нь хувьсах хүүтэй бол МЗУ160-р параграфын дагуу тодорхойлсон, одоогийн үр ашигт хүүний хувийг ашигласнаар уг хүлээгдэж буй зээлийн алдагдлыг дискаунтчилдаг.

- МЗУ209. Худалдан авсан буюу үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд, анхны хүлээн зөвшөөрөлтийн үед тодорхойлсон, зээлийн эрсдлээр тохируулсан үр ашигт хүүний хувийг ашигласнаар уг хүлээгдэж буй зээлийн алдагдлыг дискаунтчилдаг.
- МЗУ210. Түрээсийн авлагыг УСНББОУС 13-ын дагуу хэмжих үед ашигласан тэрхүү дискаунтын хувийг ашигласнаар түрээсийн авлагын хүлээгдэж буй зээлийн алдагдлыг дискаунтчилна.
- МЗУ211. Зээл олгох баталгааны үр дүн болох санхүүгийн хөрөнгийг хүлээн зөвшөөрөх үедээ хэрэглэдэг үр ашигт хүүний хувь эсвэл түүнтэй ойролцоо хувийг ашигласнаар тухайн зээл олгох баталгааны хүлээгдэж буй зээлийн алдагдлыг дискаунтчилна. Яагаад гэвэл, үнэ цэнийн бууралтын шаардлагуудыг мөрдөх зорилгын хувьд, зээл олгох баталгааны дагуу зээлийг авсаны дараа хүлээн зөвшөөрдөг санхүүгийн хөрөнгийг шинэ санхүүгийн хэрэглүүр биш, харин тэрхүү зээл олгох баталгааны үргэлжлэл гэж үздэг. Иймээс байгууллага нь уг үл цуцлагдах зээлийн баталгааны оролцогч нэг тал болсон өдрөөс эхлэн тухайн зээл олгох баталгааны анхны зээлийн эрсдлийг харгалзан үзсэнээр уг санхүүгийн хөрөнгийн хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжинэ.
- МЗУ212. Мөнгөн гүйлгээнд тусгайлан хамаарах боловч уг дискаунтчилж буй мөнгөний дутагдлыг тохируулах биш, харин дискаунтын хувийг тохируулах замаар зөвхөн харгалзан үзсэн эрсдэл, түүнчлэн мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн одоогийн зах зээлийн үнэлгээг тусгасан дискаунтын хувийн ашигласнаар, үр ашигт хүүний хувийг нь тодорхойлох боломжгүй санхүүгийн баталгааны гэрээ эсвэл зээл олгох баталгааны хувьд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг дискаунтчилна.

Ул үндэслэлтэй ба дэмжих мэдээлэл

- МЗУ213. Энэ Стандартын зорилгын хувьд ул үндэслэлтэй ба дэмжих мэдээлэл гэдэг нь их зардал буюу хүчин чармайлт гаргахгүйгээр тухайн тайлант үеийн эцсээр олж авч болох бөгөөд өнгөрсөн үйл явдал, одоогийн нөхцөл байдал, ирээдүйн эдийн засгийн төлөв байдлын прогнозын талаархи мэдээлэл юм. Санхүүгийн тайлагналын зорилгоор ашиглахад бэлэн байгаа мэдээллийг их зардал буюу хүчин чармайлт гаргахгүйгээр олж авах боломжтой гэж үзнэ.
- МЗУ214. Байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй нийт хугацаан дахь ирээдүйн нөхцөл байдлын урьдчилсан таамаглалыг нэгтгэн тусгах шаардлагагүй юм. Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолоход шаардлагатай шүүн тунгаалтын зэрэг хэмжээ нь нарийвчилсан дэлгэрэнгүй мэдээллийн бэлэн олдоцтой байдлаас хамаардаг. Урьдчилан таамаглалын хамрах хугацаа нэмэгдэх тусам нарийвчилсан дэлгэрэнгүй мэдээллийн бэлэн олдоцтой байдал буурах бөгөөд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолоход шаардагдах шүүн тунгаалтын зэрэг хэмжээ нэмэгддэг. Хүлээгдэж буй зээлийн алдагдлын тооцоолол нь алс ирээдүйн тайлант үеүдийн хувьд нарийвчилсан дэлгэрэнгүй тооцоолол хийхийг шаарддаггүй. Харин ийм алс ирээдүйн тайлант үеүдийн хувьд байгууллага нь одоо бэлэн боломжтой байгаа нарийвчилсан мэдээлэлд үндэслэн төсөвлөлтийг экстраполяцийн аргаар тооцоолж болох юм.
- МЗУ215. Байгууллага нь мэдээллийн бүх талыг хамарсан эрэл хайгуул хийх шаардлагагүй боловч их зардал буюу хүчин чармайлт гаргахгүйгээр олж авах боломжтой бөгөөд хүлээгдэж буй зээлийн алдагдлын тооцоололд, үүн дотроо хүлээгдэж буй урьдчилсан төлбөрийн үр дагаварт хамааралтай бүх ул үндэслэлтэй ба дэмжих мэдээллийг харгалзан үзнэ. Ашиглах мэдээлэл нь уг зээлдэгчид тусгайлан хамаарах хүчин зүйлс, ерөнхий эдийн засгийн төлөв байдал, тухайн тайлант үеийн эцсийн өдрөөрх нөхцөл байдлын одоогийн болон таамагласан үнэлгээ зэргийг агуулсан байна. Байгууллага нь мэдээний янз бүрийн гадаад ба дотоод (байгууллагын тусгай) аль аль эх үүсвэрийг ашиглаж болох юм. Боломжит мэдээний эх үүсвэрт зээлийн алдагдлын талаархи дотоод түүхэн туршлага, зээлийн дотоод зэрэглэл, бусад байгууллагуудын зээлийн алдагдлын туршлага, зээлийн гадаад зэрэглэл, илтгэл тайлан, статистик мэдээ хамаардаг. Тухайн байгууллагын тусгай мэдээний эх үүсвэргүй буюу хангалттай бус эх үүсвэртэй байгууллагууд нь уг адилтган зэрэгцүүлэгдэх санхүүгийн хэрэглүүрийн (буюу санхүүгийн хэрэглүүрүүдийн бүлгийн) хувьд ижил төсөөтэй бүлгийн туршлагыг ашиглаж болох юм.

МЗУ216. Түүхэн мэдээлэл нь чухал тулгуур багана буюу суурь бөгөөд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг түүнээс эхлэн хэмжинэ. Гэвч байгууллага нь уг түүхэн мэдээний үндэслэл болох тэрхүү тайлант үед хамааралгүй одоогийн нөхцөл байдлын үр нөлөө ба ирээдүйн нөхцөл байдлуудын талаархи өөрийн урьдчилсан таамаглалыг тусгах, түүнчлэн ирээдүйн гэрээний мөнгөн гүйлгээнд хамааралгүй тухайн түүхэн тайлант үеийн нөхцөл байдлуудын нөлөөг арилгахын тулд одоогийн ажиглаж болох мэдээнд үндэслэн зээлийн алдагдлын туршлага гэх мэт түүхэн мэдээг засварлан тохируулна. Зарим тохиолдолд, түүхэн мэдээний шинж төрөл, түүнийг хэзээ тооцоолсон ба тухайн тайлант үеийн эцсийн өдрөөрх нөхцөл байдалтай адилтган зэрэгцүүлсэн эсэх, түүнчлэн уг харгалзан үзэж буй санхүүгийн хэрэглүүрийн шинж чанар зэргээс хамааран үл үндэслэлтэй ба дэмжих хамгийн сайн мэдээлэл нь тохируулаагүй түүхэн мэдээ байж болох юм. Хүлээгдэж буй зээлийн алдагдлын өөрчлөлтийн тооцоолол нь нэг тайлант үеэс нөгөө тайлант үед уг ажиглаж болох холбогдох мэдээнд гарсан өөрчлөлтийг (жишээлбэл; ажилгүйдлийн түвшин, үл хөдлөх хөрөнгийн үнэ, бараа бүтээгдэхүүний үнэ, төлбөрийн статус, түүнчлэн тухайн санхүүгийн хэрэглүүрийн буюу санхүүгийн хэрэглүүрүүдийн бүлгийн зээлийн алдагдлыг илтгэх бусад хүчин зүйлсийн өөрчлөлт болон тэдгээр өөрчлөлтийн холбогдол) тусгах бөгөөд чиглэлийн хувьд түүнтэй нийцсэн байвал зохино. Тооцоолол ба зээлийн алдагдлын бодит туршлагын хоорондох аливаа зөрүүг багасгахын тулд байгууллага нь уг хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолохдоо ашигласан арга зүй, таамаглалыг тогтмол нягталж шалгана.

МЗУ217. Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолохдоо зээлийн алдагдлын түүхэн туршлагыг ашиглах бол тухайн зээлийн алдагдлын түүхэн хувь хэмжээг ажиглан гаргасан бүлгүүдтэй нийцэх тийм арга замаар тодорхойлсон бүлгүүдийн хувьд тэрхүү зээлийн алдагдлын түүхэн хувь хэмжээний талаархи мэдээллийг хэрэглэх нь чухал ач холбогдолтой юм. Ингэснээр уг ашигласан арга зүй нь ижил төсөөтэй эрсдлийн шинж чанар ба одоогийн нөхцөл байдлыг тусгасан, ажиглаж болох холбогдох мэдээ бүхий санхүүгийн хөрөнгүүдийн бүлгийн зээлийн алдагдлын өмнөх туршлагын талаархи мэдээлэлтэй тухайн санхүүгийн хөрөнгүүдийн бүлэг нэг бүрийг харгалзуулан холбох боломжийг олгодог.

МЗУ218. Хүлээгдэж буй зээлийн алдагдал нь зээлийн алдагдлын талаархи байгууллагын хүлээлтийг тусгадаг. Гэвч их зардал буюу хүчин чармайлт гаргахгүйгээр олж болох үл үндэслэлтэй ба дэмжих бүх мэдээллийг уг хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолохдоо харгалзан үзэх үедээ байгууллага нь тухайн санхүүгийн хэрэглүүрийн эсвэл ижил төсөөтэй санхүүгийн хэрэглүүрүүдийн зээлийн эрсдлийн талаархи зах зээлийн ажиглаж болох мэдээллийг мөн харгалзан үзнэ.

Барьцаа

МЗУ219. Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжих зорилгын хувьд, уг хүлээгдэж буй мөнгөн алдагдлын тооцоолол нь тухайн гэрээний нөхцлийн нэг хэсэг бөгөөд байгууллага тусад нь хүлээн зөвшөөрөөгүй барьцаа болон зээлийн бусад сайжруулалтаас хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг тусгана. Барьцаатай санхүүгийн хэрэглүүрийн хувьд хүлээгдэж буй мөнгөн алдагдлын тооцоолол нь барьцаа хөрөнгийг эзэмшилдээ авах магадлалтай эсэхээс үл хамааран, тухайн барьцаа хөрөнгөөс түүнийг олж эзэмших, борлуулах зардлыг хассаны дараах, хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний дүн ба хугацааг тусгадаг (өөрөөр хэлбэл, хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний тооцоолол нь барьцаа хөрөнгийг эзэмшилдээ авах магадлал ба түүний үр дүн болох мөнгөн гүйлгээг харгалзан үздэг). Иймээс уг гэрээний дуусгавар болох хугацаанаас хойш барьцаа хөрөнгийг борлуулснаар хүлээгдэж буй аливаа мөнгөн гүйлгээг энэхүү шинжилгээнд харгалзан үзэх хэрэгтэй. Барьцааг эзэмшилдээ авсаны үр дүн болох аливаа барьцаа хөрөнгө нь энэ буюу бусад Стандартад заасан хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх зохих шалгуурыг хангахаас бусад тохиолдолд түүнийг уг барьцаатай санхүүгийн хэрэглүүрээс тусад нь хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөхгүй.

Санхүүгийн хөрөнгийн дахин ангилал

МЗУ220. Хэрэв байгууллага нь санхүүгийн хөрөнгөө 54-р параграфын дагуу дахин ангилдаг бол тэрхүү ангиллын өдрөөс эхлэн уг ангиллыг гүйцээх горимоор мөрдөхийг 94-р параграфтаар шаардсан

байдаг. Хорогдуулсан өртгөөр хэмжих ангилал ба цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангиллын аль аль нь анх хүлээн зөвшөөрөх үед тухайн үр ашигт хүүний хувийг тодорхойлохыг шаарддаг. Эдгээр хэмжилтийн ангиллын аль аль нь үнэ цэнийн бууралтын шаардлагуудыг дээр дурдсантай ижил арга замаар мөрдөхийг бас шаарддаг. Иймээс байгууллага нь хорогдуулсан өртгөөр хэмжих ангилал ба цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангиллын хооронд санхүүгийн хөрөнгийг дахин ангилсан тохиолдолд:

- (а) Хүүний орлогын хүлээн зөвшөөрөлт нь өөрчлөгдөхгүй, тийм учраас байгууллага нь уг үр ашигт хүүний хувийг ашигласан хэвээр байна.
- (б) Хэмжилтийн хоёр ангиллын аль аль нь үнэ цэнийн бууралтын нэг ижил арга хандлагыг мөрдөх учраас хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилт нь өөрчлөгдөхгүй. Гэвч санхүүгийн хөрөнгийг цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангиллаас гаргаж, хорогдуулсан өртгөөр хэмжих ангилалд оруулан дахин ангилсан бол тэрхүү дахин ангиллын өдрөс эхлэн гарзын хасагдуулгыг тухайн санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнийн тохируулга байдлаар хүлээн зөвшөөрнө. Харин санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр хэмжих ангиллаас гаргаж, цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангилалд оруулан дахин ангилсан бол гарзын хасагдуулгыг үл хүлээн зөвшөөрөх (ба ингэснээр нийт дансны үнийн тохируулга байдлаар цаашид хүлээн зөвшөөрөхгүй) боловч үүний оронд гарзын хасагдуулгыг хуримтлагдсан үнэ цэнийн бууралт байдлаар цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрөх бөгөөд тэрхүү дахин ангиллын өдрөс эхлэн тодруулга хийнэ.

МЗУ221. Харин байгууллага нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн хувьд хүүний орлого эсвэл үнэ цэнийн бууралтын олз, гарзыг тусад нь хүлээн зөвшөөрөх шаардлагагүй юм. Иймээс байгууллага нь санхүүгийн хөрөнгийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангиллаас гаргаж, дахин ангилах тохиолдолд уг дахин ангиллын өдрөөрх тухайн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэд үндэслэн үр ашигт хүүний хувийг тодорхойлно. Түүнчлэн, уг дахин ангиллын өдрөөс эхлэн тухайн санхүүгийн хөрөнгөнд 73-93-р параграфыг мөрдөх зорилгын хувьд тэрхүү дахин ангиллын өдрийг анхны хүлээн зөвшөөрөлтийн өдөр гэж үзнэ.

Олз ба гарз

МЗУ222. 106-р параграф нь өмчийн хэрэглүүрт оруулсан бөгөөд худалдаа арилжааны зорилгоор эзэмшдэггүй, хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлтийг цэвэр хөрөнгө/өмчид толилуулах эргэлт буцалтгүй сонголт хийхийг байгууллагад зөвшөөрдөг. Ийм сонголтыг хэрэглүүр тус бүрээр (өөрөөр хэлбэл, хувьцаа тус бүрээр) хийдэг. Цэвэр хөрөнгө/өмчид толилуулсан дүнг дараагийн тайлант үед ашиг, алдагдалд шилжүүлэхгүй. Гэвч байгууллага нь хуримтлагдсан олз, гарзыг цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгийн дотор шилжүүлж болох юм. Ногдол ашиг нь тухайн хөрөнгө оруулалтын өртгийн тодорхой нэг хэсгийн нөхөлт гэдгийг илт ойлгомжтой илэрхийлж байхаас бусад тохиолдолд ийм хөрөнгө оруулалтын ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг 107-р параграфын дагуу ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

МЗУ223. Санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцлүүд нь зөвхөн үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд болох тийм мөнгөн гүйлгээг бий болгодог бөгөөд гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулан авах ба санхүүгийн хөрөнгийг борлуулах гэсэн хоёр зорилготой удирдлагын загварын дагуу тухайн санхүүгийн хөрөнгийг эзэмшдэг бол 44-р параграфыг мөрдөхөөс бусад тохиолдолд уг санхүүгийн хөрөнгийг цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжихийг 41-р параграфтаар шаардсан байдаг. Санхүүгийн байдлын тайланд тухайн санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмждэг боловч хэмжилтийн ийм ангилал нь уг санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр хэмжсэн мэтээр холбогдох дүнг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг. 111-112-р параграфын дагуу ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрснөөс бусад, олз буюу гарзыг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө. Эдгээр санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх үед өмнө нь цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрч байсан, хуримтлагдсан олз буюу гарзыг ашиг, алдагдалд дахин ангилна. Энэ нь хэрэв

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр хэмжсэн бол түүнийг үл хүлээн зөвшөөрөх үед ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх байсан олз, гарзыг тусгадаг.

- МЗУ224. УСНББОУС 4-ийн дагуу мөнгөн зүйлс гэж үзэх бөгөөд гадаад валютаар илэрхийлэгдсэн, санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн хувьд байгууллага нь УСНББОУС 4-ийг мөрдөнө. УСНББОУС 4 нь мөнгөн зүйлсийн хөрөнгө ба мөнгөн зүйлсийн өр төлбөрийн гадаад валютын ханшийн зөрүүгийн аливаа олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөхийг шаарддаг. Үүнд хамаарахгүй, гажих зүйлс нь мөнгөн гүйлгээний хейжид хейжийн хэрэглүүр гэж сонгосон мөнгөн зүйлс (140-р параграфыг үзнэ үү), цэвэр хөрөнгө оруулалтын хейж (142-р параграфыг үзнэ үү), бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь 106-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчид толилуулахаар байгууллагын сонгосон, өмчийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн хейж (137-р параграфыг үзнэ үү) юм.
- МЗУ225. Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз, гарзыг УСНББОУС 4-ийн дагуу хүлээн зөвшөөрөх зорилгын хувьд, 41-р параграфт заасанчлан, цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг санхүүгийн хөрөнгийг мөнгөн зүйл гэж үзнэ. Өөрөөр хэлбэл, ийм санхүүгийн хөрөнгийг гадаад валютаар илэрхийлсэн, хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө гэж үзнэ. Хорогдуулсан өртгийн хувьд үүссэн ханшийн зөрүүг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх бөгөөд уг дансны үнийн бусад өөрчлөлтийг 111-р параграфын дагуу хүлээн зөвшөөрнө.
- МЗУ226. Байгууллага нь өмчийн хэрэглүүрт оруулсан тухайн тодорхой хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн дараагийн тайлант үеийн өөрчлөлтийг цэвэр хөрөнгө/өмчид толилуулах эргэлт буцалтгүй сонголт хийхийг 106-р параграфтаар зөвшөөрсөн байдаг. Ийм хөрөнгө оруулалт нь мөнгөн зүйл биш юм. Иймээс 106-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчид толилуулсан олз, гарзад аливаа холбогдох гадаад валютын ханшийн зөрүүгийн бүрэлдэхүүн хэсэг багтсан байдаг.
- МЗУ227. Үүсмэл бус мөнгөн зүйлийн хөрөнгө ба үүсмэл бус мөнгөн зүйлийн өр төлбөрийн хооронд хейжийн харилцаа байгаа бол тэдгээр санхүүгийн хэрэглүүрүүдийн гадаад валютын бүрэлдэхүүн хэсгийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд толилуулна.

Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан өр төлбөр

- МЗУ228. Байгууллага нь санхүүгийн өр төлбөрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилдаг тохиолдолд уг өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтийн үр нөлөөг цэвэр хөрөнгө/өмчид толилуулах нь ашиг, алдагдалд нягтлан бодох бүртгэлийн уялдаагүй байдал үүсгэх буюу нэмэгдүүлэх эсэхийг тухайн байгууллага тодорхойлох ёстой. Өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтийн үр нөлөөг цэвэр хөрөнгө/өмчид толилуулах нь тэрхүү өөрчлөлтийн үр нөлөөг ашиг, алдагдалд толилуулсантай харьцуулахад ашиг, алдагдалд илүү их уялдаагүй байдал үүсгэхээр бол нягтлан бодох бүртгэлийн уялдаагүй байдал үүсэх буюу нэмэгдэнэ.
- МЗУ229. Үүнийг тодорхойлохын тулд байгууллага нь өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтийн ашиг, алдагдалд үзүүлэх үр нөлөөг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн өөр санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөр нөхөхөөр хүлээгдэж буй эсэхийг үнэлэх ёстой. Ийм хүлээлт нь өр төлбөрийн шинж чанар ба уг өр санхүүгийн хэрэглүүрийн шинж чанар хоорондох эдийн засгийн харилцан хамааралд үндэслэх ёстой.
- МЗУ230. Ийм тодорхойлолтыг анх хүлээн зөвшөөрөх үед хийх бөгөөд дахин үнэлэх шаардлагагүй юм. Практик зорилгын хувьд байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн уялдаагүй байдал үүсгэх хөрөнгө, өр төлбөрийн бүх ажил гүйлгээг яг нэг ижил хугацаанд хийсэн байх албагүй юм. Үлдсэн аливаа ажил гүйлгээнүүд нь гарч тохиолдоно гэж хүлээж байгаа бол зохих ёсоор хойшлуулахыг зөвшөөрдөг. Өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтийн үр нөлөөг цэвэр хөрөнгө/өмчид толилуулах нь ашиг, алдагдалд нягтлан бодох бүртгэлийн уялдаагүй байдал үүсгэх буюу нэмэгдүүлэх эсэхийг тодорхойлох өөрийн арга зүйг байгууллага тууштай мөрдөх ёстой. Гэвч ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан өр төлбөрийн

шинж чанар ба өөр санхүүгийн хэрэглүүрийн шинж чанар хооронд эдийн засгийн өөр өөр харилцан хамаарлууд байгаа тохиолдолд байгууллага нь өөр арга зүйг ашиглаж болох юм. Ийм тодорхойлолт хийх өөрийн арга зүйн талаар байгууллага нь санхүүгийн тайлангийн тодруулга хэсэгт чанарын шинжтэй тодруулга хийхийг УСНББОУС 30-аар шаардсан байдаг.

- МЗУ231. Хэрэв ийм уялдаагүй байдал үүсэх буюу нэмэгдэхээр байвал байгууллага нь бодит үнэ цэнийн бүх өөрчлөлтийг (үүн дотроо, өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтийн үр нөлөөг) ашиг, алдагдалд толилуулах шаардлагатай. Хэрэв ийм уялдаагүй байдал үүсэхгүй буюу нэмэгдэхээргүй байвал байгууллага нь өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтийн үр нөлөөг цэвэр хөрөнгө/өмчид толилуулах шаардлагатай.
- МЗУ232. Цэвэр хөрөнгө/өмчид толилуулсан дүнгүүдийг дараагийн тайлант үед ашиг, алдагдалд шилжүүлэхгүй. Харин байгууллага нь хуримтлагдсан олз, гарзыг өмчийн бүрэлдэхүүн хэсгийн дотор шилжүүлж болох юм.
- МЗУ233. Хэрэв өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтийн үр нөлөөг цэвэр хөрөнгө/өмчид толилуулсан бол ашиг, алдагдалд нягтлан бодох бүртгэлийн уялдаагүй байдал үүсэхэд хүргэх нөхцөл байдлыг дараах жишээнд тайлбарлав. Холбооны улсын моргейжийн зээл ба орон сууцны корпораци банк нь үйлчлүүлэгчиддээ зээл олгодог бөгөөд тухайн зах зээлд нийцсэн шинж чанар бүхий (жишээ нь; төлөгдөөгүй дүн, буцаан төлөх нөхцөл, хугацаа, валютын нэгж) бондыг зах зээлд борлуулах замаар тэрхүү зээлээ санхүүжүүлдэг. Моргейжийн үйлчлүүлэгч нь холбогдох бондыг зах зээлийн бодит үнэ цэнээр худалдан авч, тэрхүү бондоо уг Моргейжийн зээл ба орон сууцны корпорацид өгөх замаар өөрийн зээлийг урьдчилан төлөх (өөрөөр хэлбэл, банкны өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх)-ийг тухайн зээлийн гэрээний нөхцлөөр зөвшөөрсөн байдаг. Бондын зээлийн чанар муудвал (ингэснээр Моргейжийн зээл ба орон сууцны корпорацийн өр төлбөрийн бодит үнэ цэнэ буурвал) урьдчилан төлөх энэхүү гэрээний эрхийн үр дүнд, тухайн Моргейжийн зээл ба орон сууцны корпорацийн зээлийн хөрөнгийн бодит үнэ цэнэ бас буурна. Хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт нь суурь бондыг бодит үнэ цэнээр (энэ жишээнд бодит үнэ цэнэ буурсан) худалдан авч, тэрхүү бондоо тухайн Моргейжийн зээл ба орон сууцны корпорацид өгөх замаар моргейжийн зээлээ урьдчилан төлөх уг моргейжийн үйлчлүүлэгчийн гэрээний эрхийг тусгадаг. Ингэснээр өр төлбөрийн (бондын) зээлийн эрсдлийн өөрчлөлтийн ашиг, алдагдалд үзүүлэх үр нөлөөг санхүүгийн хөрөнгө (зээл)-ийн бодит үнэ цэнийн харгалзах өөрчлөлтөөр нөхнө. Хэрэв өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтийн үр нөлөөг цэвэр хөрөнгө/өмчид толилуулвал ашиг, алдагдалд нягтлан бодох бүртгэлийн уялдаагүй байдал үүсгэх юм. Ингэснээр Моргейжийн зээл ба орон сууцны корпораци нь өр төлбөрийн бодит үнэ цэнийн бүх өөрчлөлтийг (үүн дотроо, өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтийн үр нөлөөг) ашиг, алдагдалд толилуулах шаардлагатай болно.
- МЗУ234. МЗУ233-р параграфт дурдсан жишээний хувьд, өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтийн үр нөлөө ба санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт хооронд (өөрөөр хэлбэл, бондыг бодит үнэ цэнээр худалдан авч, тэрхүү бондоо тухайн Моргейжийн зээл ба орон сууцны корпорацид өгөх замаар зээлээ урьдчилан төлөх уг моргейжийн үйлчлүүлэгчийн гэрээний эрхийн үр дүнд) гэрээний холбоо хамаарал байна. Гэхдээ гэрээний ийм холбоо хамаарал байхгүй үед нягтлан бодох бүртгэлийн уялдаагүй байдал бас үүсэж болох юм.
- МЗУ235. 108, 109-р параграфыг мөрдөх зорилгын хувьд, нягтлан бодох бүртгэлийн уялдаагүй байдал нь өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтийн үр нөлөөг тодорхойлохдоо байгууллагын ашигладаг хэмжилтийн арга зүйгээс зөвхөн шалтгаалдаггүй. Өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтийн нөлөө (УСНББОУС 30-д тодорхойлсноор) нь өөр санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөр нөхөгдөхөөр хүлээгдэж байх зөвхөн тийм тохиолдолд ашиг, алдагдалд нягтлан бодох бүртгэлийн уялдаагүй байдал үүснэ. Хэмжилтийн арга зүйгээс зөвхөн шалтгаалан (өөрөөр хэлбэл, байгууллага нь өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтийг түүний бодит үнэ цэнийн бусад зарим өөрчлөлтөөс салган зааглаагүйн улмаас) үүссэн уялдаагүй байдал нь 108 ба 109-р параграфээр шаардсан тодорхойлолтонд нөлөө үзүүлэхгүй. Тухайлбал; байгууллага нь өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтийг төлбөрийн чадварын эрсдлийн өөрчлөлтөөс салган зааглаагүй байж болно. Хэрэв байгууллага нь энэхүү хоёр хүчин зүйлийн аль алины нэгдсэн үр нөлөөг цэвэр хөрөнгө/өмчид толилуулдаг бол төлбөрийн

чадварын эрсдлийн өөрчлөлтийг тухайн байгууллагын санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжилтэнд оруулж болох ба тэдгээр хөрөнгийн бодит үнэ цэнийн нийт өөрчлөлтийг ашиг, алдагдалд толилуулдаг учраас уялдаагүй байдал үүсэж болох юм. Гэвч ийм уялдаагүй байдал нь МЗУ229-р параграфт тодорхойлсон нөхөх харилцан хамаарал биш, харин хэмжилтийн оновчгүй байдлаас шалтгаалдаг бөгөөд иймээс 108 ба 109-р параграфтаар шаардсан тодорхойлолтонд нөлөө үзүүлэхгүй.

“Зээлийн эрсдэл”-ийн утга (108 ба 109-р параграф)

МЗУ236. УСНББОУС 30 нь зээлийн эрсдлийг “санхүүгийн хэрэглүүрийн оролцогч нэг тал нь өөрийн үүргийг биелүүлээгүйн улмаас нөгөө талдаа санхүүгийн хохирол учруулах эрсдэл” гэж тодорхойлсон байдаг. 108(а) параграф дахь шаардлага нь тухайн гаргагч өөрийн тодорхой үүрэг хариуцлагыг биелүүлэхгүй байх эрсдэлтэй холбоотой байдаг. Энэ нь уг гаргагчийн зээл төлөх чадвартай заавал холбоотой байх албагүй юм. Жишээлбэл; байгууллага нь барьцаатай өр төлбөр, түүнчлэн бусад талаар түүнтэй ижил төсөөтэй барьцаагүй өр төлбөрийг гаргасан бол хэдийгээр энэхүү хоёр өр төлбөрийг нэг байгууллага гаргасан боловч тэдгээрийн зээлийн эрсдэл нь өөр байна. Барьцаатай өр төлбөрийн зээлийн эрсдэл нь барьцаагүй өр төлбөрийн зээлийн эрсдлээс арай бага байна. Барьцаатай өр төлбөрийн зээлийн эрсдэл нь тэгтэй ойролцоо байж болох юм.

МЗУ237. 108(а) параграф дахь шаардлагыг мөрдөх зорилгын хувьд, зээлийн эрсдэл нь тухайн хөрөнгийн тусгай гүйцэтгэлийн эрсдлээс өөр байдаг. Хөрөнгийн тусгай гүйцэтгэлийн эрсдэл нь тухайн үүргийг байгууллага биелүүлэхгүй байх эрсдэлтэй холбоогүй боловч тодорхой нэг хөрөнгө эсвэл хөрөнгүүдийн бүлэг нь муу гүйцэтгэлтэй (эсвэл огт гүйцэтгэлгүй) байх эрсдэлтэй холбоотой байдаг.

МЗУ238. Хөрөнгийн тусгай гүйцэтгэлийн эрсдлийн жишээг доор харуулав:

- (а) Нэгжтэй холбоотой шинж бүхий өр төлбөр, үүнд: тусгайлан заасан хөрөнгийн гүйцэтгэлд үндэслэн хөрөнгө оруулагчдад олгох дүнг гэрээний дагуу тодорхойлдог. Өр төлбөрийн бодит үнэ цэнэд ийм нэгжтэй холбоотой шинжийн үзүүлэх үр нөлөө нь зээлийн эрсдэл биш, харин хөрөнгийн тусгай гүйцэтгэлийн эрсдэл юм.
- (б) Дараах шинж чанар бүхий бүтэц зохион байгуулалттай байгууллагын гаргасан өр төлбөр. Байгууллага нь хуулийн дагуу хөрөнгөөс тусгаарлагдсан бөгөөд иймээс тухайн байгууллагын хөрөнгө нь зөвхөн түүний хөрөнгө оруулагчдын эрх ашгийн төлөө, түүнчлэн байгууллага дампуурахаар болсон ч гэсэн тусгаарлагдсан хэвээр байна. Байгууллага нь өөр бусад ажил гүйлгээ хийхгүй бөгөөд уг байгууллагын хөрөнгийг барьцаалж болохгүй. Тусгаарласан хөрөнгө нь мөнгөн гүйлгээ бий болгосон зөвхөн тийм тохиолдолд тухайн байгууллагын хөрөнгө оруулагчдад хуваарилалт хийнэ. Иймээс өр төлбөрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт нь юуны өмнө тухайн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тусгадаг. Өр төлбөрийн бодит үнэ цэнэд тухайн хөрөнгийн гүйцэтгэлийн үзүүлэх үр нөлөө нь зээлийн эрсдэл биш, харин хөрөнгийн тусгай гүйцэтгэлийн эрсдэл юм.

Зээлийн эрсдлийн өөрчлөлтийн үр нөлөөг тодорхойлох

МЗУ239. 108(а) параграфын шаардлагыг мөрдөх зорилгын хувьд, байгууллага нь санхүүгийн өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтөнд хамааруулж болох тухайн өр төлбөрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг дараах аль нэг байдлаар тодорхойлно:

- (а) Зах зээлийн эрсдэл үүсэхэд хүргэдэг тухайн зах зээлийн нөхцөл байдлын өөрчлөлтөнд хамааралгүй, бодит үнэ цэнийн өөрчлөлтийн дүн байдлаар (МЗУ240, МЗУ241-р параграфыг үзнэ үү); эсвэл
- (б) Тухайн өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтөнд хамааруулж болох түүний бодит үнэ цэнийн өөрчлөлтийн дүнг илүү бодитой илэрхийлнэ гэж байгууллагын найдаж буй өөр хувилбар аргыг ашигласнаар.

- МЗУ240. Зах зээлийн эрсдэл үүсэхэд хүргэдэг тухайн зах зээлийн нөхцөл байдлын өөрчлөлтөнд бенчмарк хүүний хувь, өөр байгууллагын санхүүгийн хэрэглүүрийн үнэ, бараа бүтээгдэхүүний үнэ, гадаад валютын ханш, үнэ буюу ханшийн индекс зэргийн өөрчлөлт хамаарна.
- МЗУ241. Өр төлбөрийн тухайн зах зээлийн нөхцөл байдалд гарсан цорын ганц, холбогдох мэдэгдэхүйц өөрчлөлт нь ажиглаж болох (бенчмарк) хүүний хувь хэмжээний өөрчлөлт бол МЗУ239(а) параграфт дурдсан дүнг дараах байдлаар тооцоолж болно:
- (а) Юуны өмнө, байгууллага нь тайлант үеийн эхэн дэх уг өр төлбөрийн бодит үнэ цэнэ ба түүний гэрээний мөнгөн гүйлгээг ашигласнаар тэрхүү өр төлбөрийн өгөөжийн дотоод хувийг тухайн тайлант үеийн эхлэлийн байдлаар тооцоолдог. Энэхүү өгөөжийн дотоод хувиас тухайн тайлант үеийн эхэн дэх ажиглаж болох (бенчмарк) хүүний хувийг хассанаар өгөөжийн дотоод хувийн уг хэрэглүүрт тусгайлан хамаарах бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлно.
 - (б) Үүний дараа, байгууллага нь тухайн тайлант үеийн эцэс дэх өр төлбөрийн гэрээний мөнгөн гүйлгээ, түүнчлэн (i) уг тайлант үеийн эцэс дэх ажиглаж болох (бенчмарк) хүүний хувь, ба (ii) (а)-д тодорхойлсон өгөөжийн дотоод хувиас тухайн хэрэглүүрт тусгайлан хамаарах бүрэлдэхүүн хэсэг хоёрын нийлбэртэй тэнцүү байх дискаунтын хувийг ашигласнаар өр төлбөртэй холбоотой уг мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийг тооцоолно.
 - (в) Тайлант үеийн эцэс дэх өр төлбөрийн бодит үнэ цэнэ ба (б)-д тодорхойлсон дүн хоёрын хоорондох зөрүү нь ажиглаж болох (бенчмарк) хүүний хувийн өөрчлөлтөнд үл хамаарах бодит үнэ цэнийн өөрчлөлт юм. Энэ нь 108(а) параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчид толилуулах дүн болно.
- МЗУ242. МЗУ241-р параграфт дурдсан жишээнд тухайн хэрэглүүрийн зээлийн эрсдлийн өөрчлөлт ба ажиглаж болох (бенчмарк) хүүний хувийн өөрчлөлтөөс бусад хүчин зүйлсээс үүссэн бодит үнэ цэнийн өөрчлөлт нь мэдэгдэхүйц нөлөөгүй гэж үзсэн. Хэрэв бусад хүчин зүйлсээс үүсэх бодит үнэ цэнийн өөрчлөлт нь мэдэгдэхүйц дүнтэй бол энэхүү арга тохиромжгүй болох юм. Ийм тохиолдолд байгууллага нь өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтийн үр нөлөөг илүү бодитой илэрхийлэх өөр хувилбар аргыг ашиглах шаардлагатай (МЗУ239(б) параграфыг үзнэ үү). Тухайлбал; хэрэв дээрх жишээнд дурдсан хэрэглүүр нь дагалдах үүсмэл хэрэглүүрийг агуулдаг бол 108(а) параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчид толилуулах дүнг тодорхойлохдоо, тэрхүү дагалдах үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг оруулахгүй.
- МЗУ243. Өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтөнд хамааруулж болох уг өр төлбөрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн тэрхүү хэсгийг тодорхойлох байгууллагын хэмжилтийн арга зүйн нь бодит үнэ цэнийн бусад бүх хэмжилтийн нэгэн адилаар, ажиглаж болох холбогдох орцуудыг хамгийн ихээр ашиглах ба ажиглах боломжгүй орцуудыг хамгийн багаар ашигласан байх ёстой.

Хейжийн нягтлан бодох бүртгэл

Хейжийн хэрэглүүр

Шалгуур хангах хэрэглүүр

- МЗУ244. Холимог гэрээг дагалдан гарсан боловч тусад нь тайлагнадаггүй үүсмэл хэрэглүүрийг хейжийн тусдаа хэрэглүүр гэж сонгож болохгүй.
- МЗУ245. Байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүр нь тухайн байгууллагын санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөр биш бөгөөд иймээс хейжийн хэрэглүүр гэж сонгож болохгүй.
- МЗУ246. Гадаад валютын эрсдлийн хейжийн хувьд, үүсмэл бус санхүүгийн хэрэглүүрийн гадаад валютын эрсдлийн бүрэлдэхүүн хэсгийг УСНББОУС 4-ийн дагуу тодорхойлдог.

Гаргасан опцион

МЗУ247. Гаргасан зарим опционоос бусад, ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг үүсмэл хэрэглүүрийг хейжийн хэрэглүүр гэж сонгож болох нөхцөл байдлуудыг энэхүү Стандартаар хязгаарладаггүй. Худалдан авсан опцион, үүн дотроо бусад санхүүгийн хэрэглүүрийг дагалдан гарсан опционы нөхөлт байдлаар сонгосноос (жишээлбэл; дуудаж болох өр төлбөрт хейж хийхийн тулд ашиглах гаргасан дуудах опцион) бусад тохиолдолд гаргасан опцион нь хейжийн хэрэглүүрийн шалгуурыг хангахгүй юм.

Хейжийн хэрэглүүрийн сонголт

МЗУ248. Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн үүсмэл бус санхүүгийн хөрөнгө буюу үүсмэл бус санхүүгийн өр төлбөрийг хейжийн хэрэглүүр гэж сонгодог гадаад валютын эрсдлийн хейжээс бусад, хейжийн хувьд байгууллага нь тухайн үүсмэл бус санхүүгийн хэрэглүүрийг бүхэлд нь, эсвэл түүний зарим хэсгийг зөвхөн хейжийн хэрэглүүр гэж сонгож болно.

МЗУ249. Тухайн хейжийн хэрэглүүр, түүнчлэн эрсдлийн янз бүрийн төлөв байдлуудыг хейжийн зүйл гэж тусгайлан сонгодог тохиолдолд хейжийн нэг хэрэглүүрийг нэгээс олон төрлийн эрсдлийн хувьд хейжийн хэрэглүүр гэж сонгож болно. Тэдгээр хейжийн зүйлс нь хейжийн өөр өөр харилцаанд хамаарч болох юм.

Хейжийн зүйлс

Шалгуур хангах зүйлс

МЗУ250. Хейж хийгдэж буй бусад эрсдлүүдийг тусгайлан тодорхойлж, хэмжих боломжгүй учраас улсын секторын нэгдлээр үйл ажиллагааг худалдан авах арилжааны баталгаа нь гадаад валютын ханшийн эрсдлээс бусад эрсдлийн хувьд хейжийн зүйл болж чадахгүй. Тэдгээр бусад эрсдэл нь ерөнхий бизнесийн эрсдэл юм.

МЗУ251. Өмчийн аргаар бүртгэдэг хөрөнгө оруулалт нь бодит үнэ цэнийн хейжийн хувьд хейжийн зүйл болж чадахгүй. Яагаад гэвэл, өмчийн арга нь санхүүжигчийн ашиг, алдагдал дахь тухайн хөрөнгө оруулагчийн хувь оролцоог тэрхүү хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлт байдлаар биш, харин ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг. Нэгтгэсэн хяналтанд буй байгууллагад оруулсан хөрөнгө оруулалт нь үүнтэй адил шалтгаанаар бодит үнэ цэнийн хейжийн хувьд хейжийн зүйл болж чадахгүй. Яагаад гэвэл, нэгтгэл нь хяналтанд буй байгууллагын ашиг, алдагдлыг тэрхүү хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлт байдлаар биш, харин ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг. Гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын хейж нь тухайн хөрөнгө оруулалтын үнэ цэнэд гарсан өөрчлөлтийн бодит үнэ цэнийн хейж биш, харин гадаад валютын эрсдлийн хейж учраас дээр дурдсанаас өөр байдаг.

МЗУ252. Байгууллага нь эрсдэл ба үүсмэл хэрэглүүрийн хослол болох нэгтгэсэн эрсдлийг хейжийн зүйл гэж сонгохыг 125-р параграфтаар зөвшөөрсөн байдаг. Энэхүү нэгтгэсэн эрсдэл нь нэгтгэсэн өөр эрсдэл үүсгэх бөгөөд тухайн тодорхой эрсдлийн (буюу эрсдлүүдийн) хувьд түүнийг нэг эрсдэл өртөлт байдлаар удирдан зохицуулахын тулд эрсдлийг үүсмэл хэрэглүүртэй нэгтгэн хослуулдаг эсэхийг байгууллага нь ийм хейжийн зүйлийг сонгох үедээ үнэлнэ. Ийм тохиолдолд байгууллага нь уг нэгтгэсэн эрсдэлд үндэслэн тэрхүү хейжийн зүйлийг сонгож болох юм. Жишээлбэл;

- (а) Газрын тосны 15-н сарын хугацаатай фьючерс гэрээг ашигласнаар, байгууллага нь 15-н сарын дараа хийгдэх өндөр магадлалтай, тодорхой тоо хэмжээний газрын тосны худалдан авалтын хувьд үнийн эрсдлийн (АНУ-ын долларт үндэслэн) хейж хийж болох юм. Газрын тосны өндөр магадлалтай худалдан авалт ба газрын тосны фьючерс гэрээний хослолыг эрсдлийн удирдлагын зорилгоор 15 сарын хугацаатай, тогтмол дүнтэй, ам.долларын гадаад валютын эрсдэл өртөлт (өөрөөр хэлбэл, 15-н сарын дараах, тогтмол дүнтэй ам долларын аливаа мөнгөн зарлага) гэж үзэж болно.

- (б) Байгууллага нь гадаад валютаар илэрхийлэгдсэн, 10 жилийн хугацаатай, тогтмол хүүтэй өрийн нийт хугацаанд хамаарах гадаад валютын эрсдлийн хувьд хейж хийж болох юм. Гэхдээ байгууллага нь өөрийн бүртгэлийн валютаар илэрхийлэгдэх тогтмол хүүний эрсдлийг зөвхөн богино буюу дунд хугацаатай (жишээлбэл; хоёр жил) байхыг, харин түүний бүртгэлийн валютаар илэрхийлэгдэх хөвөгч хүүний эрсдлийг дуусгавар болох хүртэлх үлдсэн хугацаанд байхыг шаарддаг. Хоёр жил бүрийн эцэст (өөрөөр хэлбэл, хоёр жил тутам дахин давтагдах сууриар) байгууллага нь дараагийн хоёр жилийн хүүний хувь хэмжээг өөрчлөн тогтоодог (хүүний хувь ийм байна гэж байгууллагын хүссэн тэр хэмжээгээр хүүний хувийг өөрчлөн тогтоодог). Ийм тохиолдолд байгууллага нь 10 жилийн хугацаатай, тогтмол хүүний хувийг хөвөгч хүү болгох валют хоорондын хүүний түвшний свопын гэрээ байгуулж болох юм. Энэхүү своп нь тогтмол хүүтэй, гадаад валютын өрийг хувьсах хүүтэй, бүртгэлийн валютын эрсдэл болгон хөрвүүлнэ. Үүнээс гадна бүртгэлийн валютанд үндэслэсэн хоёр жил тутмын хүүний түвшний своп байх бөгөөд энэ нь хувьсах хүүтэй өрийг тогтмол хүүтэй өрөөр солино. Үүний үр дүнд, гадаад валютаар илэрхийлэгдсэн, тогтмол хүүтэй өр ба 10 жилийн хугацаатай, тогтмол хүүний хувийг хөвөгч хүү болгох валют хоорондын хүүний түвшний свопын гэрээний хослолыг эрсдлийн удирдлагын зорилгоор 10 жилийн хугацаатай, хувьсах хүүтэй өрийн бүртгэлийн валютаар илэрхийлэгдсэн эрсдэл өртөлт гэж үзэж болно.

МЗУ253. Нэгтгэсэн эрсдэлд үндэслэн хейжийн зүйлийг сонгох үед байгууллага нь хейжийн үр дүнтэй байдлыг үнэлэх ба хейжийн үр дүнгүй байдлыг хэмжих зорилгын хувьд тэрхүү нэгтгэсэн эрсдлийг бүрдүүлэх зүйлсийн нэгтгэсэн үр нөлөөг харгалзан үзнэ. Гэхдээ тэрхүү нэгтгэсэн эрсдлийг бүрдүүлэх зүйлсийг тусад нь тайлагнасан хэвээр байна. Энэ нь тухайлбал, дараах утгатай байна:

- (а) Нэгтгэсэн эрсдлийн нэг хэсэг болох үүсмэл хэрэглүүрүүдийг бодит үнэ цэнээр хэмжсэн тусдаа хөрөнгө эсвэл тусдаа өр төлбөр байдлаар хүлээн зөвшөөрнө;
- (б) Нэгтгэсэн эрсдлийг бүрдүүлдэг зүйлсийн хоорондох хейжийн харилцааг сонгох тохиолдолд үүсмэл хэрэглүүрийг уг нэгтгэсэн эрсдлийн нэг хэсэг байдлаар нэгтгэн оруулах арга зам нь тэрхүү үүсмэл хэрэглүүрийг тухайн нэгтгэсэн эрсдлийн түвшинд хейжийн хэрэглүүр гэж сонгох арга замтай нийцсэн байх ёстой. Тухайлбал; уг нэгтгэсэн эрсдлийг бүрдүүлдэг зүйлсийн хоорондох хейжийн харилцааны хувьд байгууллага нь үүсмэл хэрэглүүрийн форвард элементийг хейжийн хэрэглүүр болох сонголтонд оруулахгүй хасдаг бол тухайн нэгтгэсэн эрсдлийн нэг хэсэг байдлаар уг үүсмэл хэрэглүүрийг хейжийн зүйл болгон оруулахдаа түүний форвард элементийг бас хасах ёстой. Ингэхгүй бол уг нэгтгэсэн эрсдэл нь үүсмэл хэрэглүүрийг бүхэлд нь, болон түүний зарим хэсгийн аль алиныг агуулсан байх юм.

МЗУ254. Эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрэн дэх хэрэгжих өндөр магадлалтай урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь тухайн ажил гүйлгээг хийж буй байгууллагын бүртгэлийн валютаас өөр валютаар илэрхийлэгдсэн бөгөөд түүний гадаад валютын эрсдэл нь нэгтгэсэн ашиг, алдагдалд нөлөөлөхөөр бол уг ажил гүйлгээний гадаад валютын эрсдэл нь тэрхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд мөнгөн гүйлгээний хейж дэх хейжийн зүйл болох шалгуурыг хангаж болох юм гэж 127-р параграфт заасан байдаг. Энэ зорилгын хувьд байгууллага нь хяналт тавигч байгууллага, хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр эсвэл салбар байж болно. Хэрэв эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрэн дэх урьдчилан таамагласан ажил гүйлгээний гадаад валютын эрсдэл нь нэгтгэсэн ашиг, алдагдалд нөлөөлдөггүй бол уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрэн дэх ажил гүйлгээ нь хейжийн зүйлийн шалгуурыг хангахгүй. Холбогдох гадаад ажил гүйлгээ байхгүй бол эрхийн шимтгэлийн төлбөр, хүүний төлбөр, нэг эдийн засгийн нэгдмэл байгууллагын гишүүдийн хоорондох менежментийн төлбөрийн хувьд ихэвчлэн ийм тохиолдол үүсдэг. Гэвч эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрэн дэх урьдчилан таамагласан ажил гүйлгээний гадаад валютын эрсдэл нь нэгтгэсэн ашиг, алдагдалд нөлөөлдөг тохиолдолд уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрэн дэх ажил гүйлгээ нь хейжийн зүйлийн шалгуурыг хангана. Жишээ нь; эдийн засгийн нэгдмэл байгууллагын хувьд гадны байх этгээдэд тухайн бараа материалыг өмнө нь борлуулж байсан бол уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын гишүүдийн хоорондох бараа

материалын урьдчилан таамагласан борлуулалт эсвэл худалдан авалт. Үүнтэй адилаар, үндсэн хөрөнгийг өөрийн үйл ажиллагаандаа ашиглах эдийн засгийн нэгдмэл байгууллагын нэг байгууллагад тэрхүү үндсэн хөрөнгийг үйлдвэрлэдэг уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын өөр нэг байгууллагаас хийх, тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллага доторх урьдчилан таамагласан борлуулалт нь нэгтгэсэн ашиг, алдагдалд нөлөөлж болох юм. Жишээлбэл; эдийн засгийн нэгдмэл байгууллагын доторх урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь тухайн худалдан авч буй байгууллагын бүртгэлийн валютаас өөр валютаар илэрхийлэгдсэн бол уг үндсэн хөрөнгийн хувьд анх хүлээн зөвшөөрсөн дүн нь өөрчлөгдөж болох бөгөөд тэрхүү худалдан авч буй байгууллага нь үндсэн хөрөнгийг элэгдүүлэх тул ийм тохиолдол үүсэж болно.

МЗУ255. Эдийн засгийн нэгдмэл байгууллага доторх урьдчилан таамагласан ажил гүйлгээний хейж нь хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангадаг бол аливаа олз, гарзыг 140-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө эсвэл түүнээс хасна. Хейж хийсэн ажил гүйлгээний гадаад валютын эрсдлээр ашиг, алдагдалд нөлөө үзүүлэх тэрхүү холбогдох тайлант үе буюу үеүд нь нэгтгэсэн ашиг, алдагдалд нөлөө үзүүлэх тайлант үе буюу үеүд юм.

Хейжийн зүйлсийн сонголт

МЗУ256. Бүрэлдэхүүн хэсэг гэдэг нь тухайн нийт зүйлээс бага, хейжийн зүйл юм. Иймээс бүрэлдэхүүн хэсэг нь өөрөө түүний нэг хэсэг болдог тухайн зүйлийнхээ эрсдлийн зөвхөн зарим хэсгийг эсвэл тэрхүү эрсдлийг зөвхөн зарим тодорхой хэмжээгээр (жишээлбэл; зүйлийн тодорхой хувь хэсгийг сонгох үед) тусгадаг.

Эрсдлийн бүрэлдэхүүн хэсгүүд

МЗУ257. Хейжийн зүйл гэж сонгох шалгуурыг хангахын тулд эрсдлийн бүрэлдэхүүн хэсэг нь санхүүгийн буюу санхүүгийн бус зүйлийн тусдаа тодорхойлж болох бүрэлдэхүүн хэсэг байх ёстой бөгөөд уг эрсдлийн бүрэлдэхүүн хэсгийн өөрчлөлтөнд хамааруулж болох тухайн зүйлийн мөнгөн гүйлгээний эсвэл бодит үнэ цэнийн өөрчлөлтийг найдвартай хэмжих боломжтой байх ёстой.

МЗУ258. Эрсдлийн ямар бүрэлдэхүүн хэсгүүд нь хейжийн зүйл гэж сонгох шалгуурыг хангаж байгаа гэдгийг тодорхойлох үедээ байгууллага нь уг эрсдэл буюу эрсдлүүд хамаарах бөгөөд хейжийн үйл ажиллагаа явагдаж буй тухайн зах зээлийн бүтцийн хүрээнд ийм эрсдлийн бүрэлдэхүүн хэсгүүдийг үнэлнэ. Ийм тодорхойлолт нь эрсдэл ба зах зээлээрээ ялгаатай байх уг холбогдох бодит байдал болон нөхцлийн талаар үнэлгээ хийхийг шаарддаг.

МЗУ259. Эрсдлийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хейжийн зүйл гэж сонгох үедээ байгууллага нь уг эрсдлийн бүрэлдэхүүн хэсгийг гэрээнд тодорхой заасан (гэрээгээр тусгайлан заасан эрсдлийн бүрэлдэхүүн хэсэг) эсвэл өөрөө түүний нэг хэсэг болдог тухайн зүйлийнхээ бодит үнэ цэнэ эсвэл мөнгөн гүйлгээнд далд хэлбэрээр агуулагдаж буй (гэрээгээр тусгайлан заагаагүй эрсдлийн бүрэлдэхүүн хэсэг) эсэхийг харгалзан үзнэ. Гэрээгээр тусгайлан заагаагүй эрсдлийн бүрэлдэхүүн хэсэг нь гэрээ биш зүйлстэй (жишээлбэл; урьдчилан таамагласан ажил гүйлгээ) эсвэл уг бүрэлдэхүүн хэсгийг тодорхой заагаагүй гэрээтэй (жишээлбэл; өөр өөр суурь зүйлсийг лавлагаа болгодог үнэ тогтоох томъёо биш, харин зөвхөн нэг үнийг агуулсан арилжааны баталгаа) холбоотой байж болно. Тухайлбал;

- (а) “А” байгууллага нь байгалийн хий нийлүүлэх урт хугацааны гэрээтэй бөгөөд бараа бүтээгдэхүүн болон бусад хүчин зүйлсийг (жишээлбэл; дизель түлш, мазут, түүнчлэн тээврийн зардал гэх мэт бусад зардал) лавлагаа болгон тодорхойлохоор гэрээнд тусгайлан заасан томъёог ашиглан түүний үнийг тогтоодог. “А” байгууллага нь дизель түлшний форвард гэрээг ашигласнаар энэхүү нийлүүлэлтийн гэрээн дэх дизель түлшний бүрэлдэхүүн хэсэгт хейж хийдэг. Дизель түлшний бүрэлдэхүүн хэсгийг уг нийлүүлэлтийн гэрээний нөхцөл, болзолд тодорхой заасан тул энэ нь гэрээгээр тусгайлан заасан эрсдлийн бүрэлдэхүүн хэсэг юм. Үнэ тогтоох томъёотой учраас “А” байгууллага нь уг дизель түлшний үнийн эрсдлийг тусад нь тодорхойлж болно гэж үздэг. Мөн энэ үед дизель түлшний форвард гэрээний хувьд зах зээл байсан. Иймээс “А” байгууллага нь

дизель түлшний үнийн эрсдлийг найдвартай хэмжих боломжтой гэж дүгнэсэн. Ийм учраас уг нийлүүлэлтийн гэрээн дэх дизель түлшний үнийн эрсдэл нь хейжийн зүйл гэж сонгох шалгуурыг хангасан эрсдлийн бүрэлдэхүүн хэсэг юм.

- (б) “Б” байгууллага нь өөрийн үйлдвэрлэлийн урьдчилсан таамаглалд үндэслэн кофены ирээдүйн худалдан авалтын хувьд хейж хийдэг. Хейж нь урьдчилан таамагласан худалдан авалтын тоо хэмжээний тодорхой хэсгийн хувьд нийлүүлэлт хийгдэж эхлэхээс 15 хүртэлх сарын өмнөөс эхэлдэг. “Б” байгууллага нь хейж хийсэн тоо хэмжээг цаг хугацааны явцад (нийлүүлэх өдөр ойртохын хэрээр) нэмэгдүүлдэг. “Б” байгууллага нь өөрийн кофены үнийн эрсдлийг удирдан зохицуулахын тулд хоёр өөр төрлийн гэрээг ашигладаг:

- (i) Биржээр арилжаалдаг кофены фьючерс гэрээ; ба
- (ii) Колумб улсаас Арабика кофег авч, үйлдвэрлэлийн тусгай талбарт хүргэх кофе нийлүүлэлтийн гэрээ. Энэ гэрээнд заасан нэг тонн кофены үнэ нь биржид арилжаалж буй кофены фьючерс гэрээний үнэ, түүн дээр үнэ тогтоох томъёоны дагуу тооцсон тогтмол үнийн зөрүү ба ложистикын үйлчилгээний хувьсах зардлыг нэмсэн дүнд үндэслэдэг. Кофе нийлүүлэх гэрээ нь гүйцэтгэлийн гэрээ бөгөөд “Б” байгууллага нь энэ гэрээний дагуу кофены бодит нийлүүлэлтийг хийнэ.

Одоогийн ургац хураалттай холбоотой хүргэлтийн хувьд кофе нийлүүлэх гэрээ байгуулах нь бодитойгоор худалдан авсан кофены чанар (Колумб улсаас авах Арабика кофе) ба биржид арилжаалж буй фьючерс гэрээний суурь үндэслэл болох бенчмарк чанарын хоорондох үнийн зөрүүг засварлах боломжийг “Б” байгууллагад олгодог. Харин дараагийн ургац хураалттай холбоотой хүргэлтийн хувьд кофе нийлүүлэх гэрээг хараахан байгуулаагүй учраас үнийн зөрүүг засварлаж чадахгүй юм. “Б” байгууллага нь одоогийн ургац хураалт, түүнчлэн дараагийн ургац хураалттай холбоотой хүргэлтийн хувьд өөрийн кофены үнийн эрсдлийн бенчмарк чанарын бүрэлдэхүүн хэсэгт хейж хийхийн тулд биржээр арилжаалж буй кофены фьючерс гэрээг ашигладаг. “Б” байгууллага нь гурван өөр эрсдэлд өртөнө гэж тодорхойлсон. Үүнд: бенчмарк чанарыг тусгах кофены үнийн эрсдэл, бенчмарк чанартай кофе ба Колумб улсаас бодитойгоор хүлээн авсан тухайн Арабика кофены үнэ хоорондох зөрүүг (тархалт)-г тусгах кофены үнийн эрсдэл, ложистикийн хувьсах зардал. Одоогийн ургац хураалттай холбоотой хүргэлтийн хувьд, “Б” байгууллага нь кофе нийлүүлэх гэрээ байгуулсны дараа, тэрхүү бенчмарк чанарыг тусгах кофены үнийн эрсдэл нь гэрээгээр тусгайлан заасан эрсдлийн бүрэлдэхүүн хэсэг болно. Яагаад гэвэл, уг үнэ тогтоох томъёо нь биржээр арилжаалж буй кофены фьючерс гэрээний үнээр хийгдэх индексжүүлэлтийг агуулсан байна. Энэ эрсдлийн бүрэлдэхүүн хэсгийг тусад нь тодорхойлж, найдвартай хэмжих боломжтой гэж “Б” байгууллага дүгнэдэг. Дараагийн ургац хураалттай холбоотой хүргэлтийн хувьд, “Б” байгууллага нь кофе нийлүүлэх ямар нэг гэрээг хараахан байгуулаагүй байна (өөрөөр хэлбэл, тэдгээр хүргэлт нь урьдчилан таамагласан ажил гүйлгээ юм). Иймээс бенчмарк чанарыг тусгах уг кофены үнийн эрсдэл нь гэрээгээр тусгайлан заагаагүй эрсдлийн бүрэлдэхүүн хэсэг юм. Зах зээлийн бүтцийн талаархи “Б” байгууллагын шинжилгээ нь хүлээн авах тухайн кофены эцсийн хүргэлтийн үнийг хэрхэн тогтоохыг харгалзан үздэг. Иймээс хэдийгээр гэрээгээр тусгайлан заагаагүй боловч эрсдлийн бүрэлдэхүүн хэсгийг тусад нь тодорхойлж, найдвартай хэмжих боломжтой тул уг урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь бенчмарк чанарыг тусгах тухайн кофены үнийн эрсдлийг бас агуулсан байна гэж “Б” байгууллага нь зах зээлийн бүтцийн талаархи энэхүү шинжилгээнд үндэслэн дүгнэдэг. Ийм учраас “Б” байгууллага нь кофе нийлүүлэх гэрээ, түүнчлэн урьдчилан таамагласан ажил гүйлгээний хувьд (бенчмарк чанарыг тусгах уг кофены үнийн эрсдлийн хувьд) эрсдлийн бүрэлдэхүүн хэсэгт үндэслэн хейжийн харилцааг сонгож болох юм.

- (в) “В” байгууллага нь хүргэлтээс өмнөх 24-н хүртэлх сарын хэрэглээндээ үндэслэн, онгоцны түлшний ирээдүйн худалдан авалтын зарим хэсгийн хувьд хейж хийдэг бөгөөд өөрийн хейж хийсэн тоо хэмжээг цаг хугацааны явцад нэмэгдүүлдэг. “В” байгууллага нь уг хейжийн хамрах цаг хугацаанаас шалтгаалан өөр өөр төрлийн гэрээг ашигласнаар

энэхүү эрсдэлд хейж хийдэг. Тухайн хейжийн хамрах цаг хугацаа нь уг үүсмэл хэрэглүүрийн зах зээлийн хөрвөх чадварт нөлөөлдөг. Хамрах цаг хугацаа нь урт (12–24 сар) байвал зөвхөн түүхий нефть нь зах зээлд хангалттай хөрвөх чадвартай учраас “В” байгууллага нь түүхий нефтийн гэрээг ашигладаг. Харин хамрах цаг хугацаа нь 6–12 сар байвал дизель түлш нь хангалттай хөрвөх чадвартай учраас “В” байгууллага нь дизель түлшний үүсмэл хэрэглүүрийг ашигладаг. Зургаан сар хүртэлх хамрах хугацааны хувьд “В” байгууллага нь онгоцны түлшний гэрээг ашигладаг. Нефть болон нефтийн бүтээгдэхүүний зах зээлийн бүтцийн талаархи “В” байгууллагын шинжилгээ болон холбогдох баримт материал, нөхцөл байдлын талаархи түүний үнэлгээ нь дараах байдалтай байна:

- (i) Түүхий нефтийн бенчмарк нь Brent байх газарзүйн бүс нутагт “В” байгууллага нь үйл ажиллагаагаа явуулдаг. Түүхий нефть нь боловсруулсан төрөл бүрийн нефтийн бүтээгдэхүүний хамгийн чухал, үндсэн орц болохын хувьд тэдгээрийн үнэд нөлөө үзүүлдэг түүхий эдийн бенчмарк юм. Харин дизель түлш нь боловсруулсан нефтийн бүтээгдэхүүний бенчмарк бөгөөд түүнийг нефтийн нэрдсүүдийн үнэ тогтоох лавлагаа болгон хамгийн өргөнөөр ашигладаг. “В” байгууллагын үйл ажиллагаа явуулдаг орчин дахь түүхий нефтийн болон боловсруулсан нефтийн бүтээгдэхүүний зах зээлд дараах гэх мэт үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн төрлүүдэд үүнийг бас ашигладаг:
- Түүхий нефтийн бенчмарк, өөрөөр хэлбэл Brent түүхий нефтийн фьючерс гэрээ;
 - Дизель түлшний бенчмарк фьючерс гэрээ, үүнийг нефтийн нэрдсүүдийн үнэ тогтоох лавлагаа болгон ашигладаг. Жишээлбэл; онгоцны түлшний үнийн тархалтын (нэмэгдлийн) үүсмэл хэрэглүүр нь онгоцны түлш ба бенчмарк дизель түлшний хоорондох үнийн зөрүүг агуулсан байдаг; ба
 - Brent түүхий нефтээр индексжүүлсэн бенчмарк дизель түлшний завсрын тархалтын (нэмэгдлийн) үүсмэл хэрэглүүр (өөрөөр хэлбэл, түүхий нефть ба дизель түлшний хоорондох үнийн зөрүү болох боловсруулалтын ашгийн үүсмэл хэрэглүүр).
- (ii) Боловсруулсан нефтийн бүтээгдэхүүнүүд (дизель түлш, онгоцны түлш гэх мэт) нь стандартчлагдсан бүтээгдэхүүн байдаг учраас тэдгээрийн үнэ тогтоолт нь ямар түүхий нефтийг аль боловсруулах үйлдвэр боловсруулсан эсэхээс хамаарахгүй.

Иймээс хэдийгээр түүхий нефть ба дизель түлшийг аль нэг гэрээний хэлцэлд тусгайлан заагаагүй боловч онгоцны түлшний худалдан авалтын үнийн эрсдэл нь Brent түүхий нефтинд үндэслэсэн түүхий нефтийн үнийн эрсдлийн бүрэлдэхүүн хэсэг ба дизель түлшний үнийн эрсдлийн бүрэлдэхүүн хэсгийг агуулна гэж “В” байгууллага дүгнэсэн. Хэдийгээр гэрээнд тусгайлан заагаагүй боловч энэхүү хоёр эрсдлийн бүрэлдэхүүн хэсгийг тусад нь тодорхойлж, найдвартай хэмжиж боломжтой гэж “В” байгууллага дүгнэдэг. Үүний үр дүнд, “В” байгууллага нь эрсдлийн бүрэлдэхүүн хэсгүүдийн суурьт (түүхий нефть эсвэл дизель түлш гэх мэт) үндэслэн, онгоцны түлшний урьдчилан таамагласан худалдан авалтын хувьд хейжийн харилцааг сонгож болох юм. Мөн энэ шинжилгээ нь хэрэв “В” байгууллага тухайлбал, Баруун Техасын Зуучлагчийн түүхий нефтинд үндэслэсэн, түүхий нефтийн үүсмэл хэрэглүүрийг ашигласан бол Brent түүхий нефть ба Баруун Техасын Зуучлагчийн түүхий нефтийн хоорондох үнийн зөрүүгийн өөрчлөлт нь уг хейжийг үр дүнгүй болгох байсан гэдгийг илэрхийлнэ.

- (г) “Г” байгууллага нь тогтмол хүүтэй өрийн хэрэглүүрийг эзэмшдэг. Ижил төсөөтэй, маш олон төрлийн өрийн хэрэглүүрүүдийг тэдгээрийн тархалтаар нь бенчмарк түвшинтэй (жишээлбэл; ЛИБОР) зэрэгцүүлдэг зах зээлийн орчинд энэхүү хэрэглүүрийг гаргадаг бөгөөд уг орчин дахь хувьсах хүүтэй хэрэглүүрийг ихэвчлэн тухайн бенчмарк түвшинээр индексжүүлдэг. Тухайн бенчмарк түвшинтэй харьцуулсан өрийн хэрэглүүрийн тархалтаас үл хамааран тэрхүү бенчмарк түвшинд үндэслэн хүүний хувь хэмжээний эрсдлийг удирдан зохицуулахын тулд хүүний түвшний свопыг ихэвчлэн ашигладаг.

Тогтмол хүүтэй өрийн хэрэглүүрийн үнэ нь уг бенчмарк хүүний түвшний өөрчлөлтөөс шууд хамааран хувьсан өөрчлөгддөг. “Г” байгууллага нь тухайн бенчмарк хүүний түвшинг тусад нь тодорхойлж, найдвартай хэмжиж боломжтой гэж дүгнэдэг. Иймээс “Г” байгууллага нь бенчмарк хүүний түвшний эрсдэлд хамаарах эрсдлийн бүрэлдэхүүн хэсэгт үндэслэн уг тогтмол хүүтэй өрийн хэрэглүүрийн хувьд хейжийн харилцааг сонгож болох юм.

- МЗУ260. Эрсдлийн бүрэлдэхүүн хэсгийг хейжийн зүйл гэж сонгох үед, эрсдлийн бүрэлдэхүүн хэсэг болдоггүй бусад хейжийн зүйлсэд мөрддөгтэй ижил арга замаар хейжийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудыг тухайн эрсдлийн бүрэлдэхүүн хэсэгт дагаж мөрдөнө. Тухайлбал; шалгуурыг дагаж мөрдөнө, үүнд: тухайн хейжийн харилцаа нь хейжийн үр дүнтэй байдлын шаардлагуудыг хангах ёстой бөгөөд хейжийн аливаа үр дүнгүй байдлыг хэмжиж, хүлээн зөвшөөрөх ёстой.
- МЗУ261. Байгууллага нь хейжийн зүйлийн зөвхөн мөнгөн гүйлгээний эсвэл зөвхөн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тодорхой үнэ буюу бусад хувьсагчаас илүү эсвэл бага байхаар (нэг талт эрсдэл) бас сонгож болох юм. Хейжийн хэрэглүүр болгон худалдан авсан опционы (сонгосон эрсдэлтэй үүнийг ижил үндсэн нөхцөлтэй гэж үзэх) цаг хугацааны үнэ цэнэ биш, харин дотоод үнэ цэнэ нь хейжийн зүйл дэх нэг талт эрсдлийг тусгадаг. Жишээлбэл; байгууллага нь барааны урьдчилан таамагласан худалдан авалтын үнийн өсөлтөөс бий болох ирээдүйн мөнгөн зарлагын өөрчлөлтийг сонгож болно. Энэ тохиолдолд байгууллага нь тогтоосон түвшнээс давсан үнийн өсөлтийн үр дүн болох зөвхөн мөнгөн гүйлгээний алдагдлыг сонгоно. Цаг хугацааны үнэ цэнэ нь ашиг, алдагдалд нөлөөлөх уг урьдчилан таамагласан ажил гүйлгээний бүрэлдэхүүн хэсэг биш учраас тэрхүү хейж хийсэн эрсдэл нь тухайн худалдан авсан опционы цаг хугацааны үнэ цэнийг өөртөө агуулаагүй байдаг.
- МЗУ262. Инфляцийн эрсдлийг гэрээгээр тусгайлан зааснаас бусад тохиолдолд түүнийг тусад нь тодорхойлж, найдвартай хэмжиж чадахгүй, иймээс санхүүгийн хэрэглүүрийн эрсдлийн бүрэлдэхүүн хэсэг гэж сонгож болохгүй гэсэн няцааж болох урьдчилсан нөхцөлтэй байдаг. Гэвч инфляцийн орчин ба холбогдох өрийн зах зээлийн тодорхой нөхцөл байдлаас хамааран тусад нь тодорхойлж болох инфляцийн эрсдлийн хувьд түүний эрсдлийн бүрэлдэхүүн хэсгийг цөөн хязгаарлагдмал тохиолдолд тодорхойлох боломжтой байдаг.
- МЗУ263. Тухайлбал; инфляцитай холбоотой бонд нь тэг купоны хүүтэй ба бодит хүүний түвшнээр хүүг тооцох хугацааны бүтэцтэй, ингэснээр зах зээлд хангалттай хөрвөх үр дүн бүхий тоо хэмжээ ба хугацааны бүтэцтэй байх тийм орчинд байгууллага нь өрийн хэрэглүүрийг гаргадаг. Энэ нь инфляци тухайн валютын хувьд уг өрийн зах зээлээр тусад нь харгалзан үзэх хамааралтай хүчин зүйл гэсэн утгыг илэрхийлнэ. Ийм тохиолдолд тэг купоны хүүтэй ба бодит хүүний түвшнээр хүүг тооцох хугацааны бүтцийг ашиглаж, уг хейж хийсэн өрийн хэрэглүүрийн мөнгөн гүйлгээг дискаунтчилснаар (өөрөөр хэлбэл, эрсдэлгүй (нэрлэсэн) хүүний түвшний бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлохтой ижил арга замаар) тухайн инфляцийн эрсдлийн бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлж болно. Харин эсрэгээр, ихэнх тохиолдолд инфляцийн эрсдлийн бүрэлдэхүүн хэсгийг тусад нь тодорхойлж, найдвартай хэмжих боломжгүй байдаг. Тухайлбал; инфляцитай холбоотой бонд нь тэг купоны хүүтэй ба бодит хүүний түвшнээр хүүг тооцох хугацааны бүтэцтэй, ингэснээр зах зээлд хангалттай хөрвөдөггүй тийм орчинд байгууллага нь зөвхөн нэрлэсэн хүүтэй өрийн хэрэглүүрийг гаргадаг. Ийм тохиолдолд зах зээлийн бүтэц болон баримт материал, нөхцөл байдлын талаархи шинжилгээ нь инфляци уг өрийн зах зээлээр тусад нь харгалзан үзэх хамааралтай хүчин зүйл гэж тухайн байгууллага дүгнэхийг дэмжихгүй. Иймээс гэрээгээр тусгайлан заагаагүй инфляцийн эрсдлийг тусад нь тодорхойлж, найдвартай хэмжих боломжгүй гэсэн няцааж болох урьдчилсан нөхцлийг байгууллага няцааж чадахгүй юм. Үүнээс үзвэл, инфляцийн эрсдлийн бүрэлдэхүүн хэсэг нь хейжийн зүйл гэж сонгох шалгуурыг хангахгүй юм. Байгууллагын бодитойгоор хийсэн инфляцийн хейжийн аливаа хэрэглүүрээс үл хамааран энэхүү зарчим хэвээр үйлчилнэ. Ялангуяа, байгууллага нь нэрлэсэн хүүтэй өрийн хэрэглүүрийн хугацаа, нөхцлийг төсөвлөн тооцноор бодит инфляцийн хейжийн хэрэглүүрийн хугацаа, нөхцлийг шууд төсөөлөн тооцож болохгүй юм.

МЗУ264. Хүлээн зөвшөөрсөн, инфляцитай холбоотой бондын бусад мөнгөн гүйлгээнд инфляцийн эрсдлийн бүрэлдэхүүн хэсэг нөлөө үзүүлэхгүй байх тохиолдолд уг бондын мөнгөн гүйлгээний гэрээгээр тусгайлан заасан инфляцийн эрсдлийн бүрэлдэхүүн хэсгийг (дагалдах үүсмэл хэрэглүүрийг тусад нь тайлагнах шаардлагагүй гэж үзье) тусад нь тодорхойлж, найдвартай хэмжих боломжтой байдаг.

Нэрлэсэн дүнгийн бүрэлдэхүүн хэсгүүд

МЗУ265. Хейжийн харилцаанд хейжийн зүйл гэж сонгож болох нэрлэсэн дүнгийн хоёр төрлийн бүрэлдэхүүн хэсэг байдаг. Үүнд: нийт зүйлийн хувь хэмжээний бүрэлдэхүүн хэсэг ба давхаргын бүрэлдэхүүн хэсэг. Бүрэлдэхүүн хэсгийн төрөл нь нягтлан бодох бүртгэлийн үр дүнг өөрчилдөг. Байгууллага нь тухайн бүрэлдэхүүн хэсгийг өөрийн эрсдлийн удирдлагын зорилготой нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн зорилгоор тууштай сонгодог.

МЗУ266. Хувь хэмжээ болох бүрэлдэхүүн хэсгийн жишээ нь; зээлийн гэрээний мөнгөн гүйлгээний 50 хувь гэх мэт.

МЗУ267. Тодорхойлсон нээлттэй олонлогоос эсвэл тодорхойлсон нэрлэсэн дүнгээс давхаргын бүрэлдэхүүн хэсгийг тусгайлан зааж болох юм. Жишээлбэл;

- (а) Мөнгөн ажил гүйлгээний хэмжээний тодорхой хэсэг. Жишээлбэл; 201X оны 3-р сард гадаад валютаар хийгдсэн борлуулалтын эхний 20ГВ-ын дараах 10ГВ-ын мөнгөн гүйлгээ;³
- (б) Биет тоо хэмжээний тодорхой хэсэг. Жишээлбэл; XYZ байршилд хадгалагдаж буй байгалийн хийн хамгийн доод давхаргын 5 сая куб метр хэсэг;
- (в) Биет буюу ажил гүйлгээний бусад тоо хэмжээний тодорхой хэсэг. Жишээлбэл; 201X оны 6-р сард хийгдэх газрын тосны худалдан авалтын эхний 100 баррел эсвэл 201X оны 6-р сард хийгдэх цахилгааны борлуулалтын эхний 100 мигавайт;
- (г) Хейжийн зүйлийн нэрлэсэн дүнгээс тооцсон давхарга. Жишээлбэл; 100 сая ТН-ийн арилжааны баталгааны сүүлийн 80 сая ТН, 100 сая ТН-ийн тогтмол хүүтэй бондын хамгийн сүүлийн 20 сая ТН-ийн давхарга, бодит үнэ цэнээр урьдчилан төлж болох тогтмол хүүтэй, 100ТН-ийн бондын хамгийн эхний 30 сая ТН-ийн давхарга (энд тодорхойлсон нэрлэсэн дүн нь 100 сая ТН байна).

МЗУ268. Бодит үнэ цэнийн хейжид давхаргын бүрэлдэхүүн хэсгийг сонгосон бол байгууллага нь тодорхойлсон, нэрлэсэн дүнгээс түүнийг тусгайлан заана. Шалгуур хангах бодит үнэ цэнийн хейжид хамаарах шаардлагуудыг даган мөрдөхийн тулд байгууллага нь бодит үнэ цэнийн өөрчлөлтийн хувьд уг хейжийн зүйлийг дахин хэмждэг (өөрөөр хэлбэл, тухайн хейж хийсэн эрсдэлд хамаарах бодит үнэ цэнийн өөрчлөлтийн хувьд уг зүйлийг дахин хэмждэг). Тухайн зүйлийг үл хүлээн зөвшөөрөхөөс өмнө тэрхүү бодит үнэ цэнийн хейжийн залруулгыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх ёстой. Иймээс уг бодит үнэ цэнийн хейжийн залруулгын хамаарах тухайн зүйлийг хөөн шалгах шаардлагатай байдаг. Бодит үнэ цэнийн хейж дэх давхаргын бүрэлдэхүүн хэсгийн хувьд, байгууллага нь түүнийг тодорхойлсон уг нэрлэсэн дүнг хөөн шалгах шаардлагатай юм. Жишээлбэл; МЗУ267(г) параграфт дурдсан, хамгийн сүүлийн 20 сая ТН-ийн давхарга эсвэл хамгийн эхний 30 сая ТН-ийн давхаргыг хөөн шалгахын тулд тодорхойлсон нийт нэрлэсэн дүн болох 100 сая ТН-ийг хөөн шалгах шаардлагатай байдаг.

МЗУ269. Хейжийн зүйлийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тодорхойлох үед тухайн сонгосон давхарга нь холбогдох урьдчилан төлөлтийн опционы үр нөлөөг агуулснаас бусад тохиолдолд хэрэв уг хейж хийсэн эрсдлийн өөрчлөлт нь урьдчилан төлөлтийн опционы бодит үнэ цэнэд нөлөөлдөг бол тэрхүү урьдчилан төлөлтийн опционыг агуулсан давхаргын бүрэлдэхүүн хэсэг нь бодит үнэ цэнийн хейжид хейжийн зүйл гэж сонгох шалгуурыг хангахгүй юм.

³ Энэхүү Стандартад мөнгөн дүнг 'тооцооны нэгж' буюу ТН гэж, 'гадаад валют'-ыг ГВ гэж тэмдэглэсэн.

Бүрэлдэхүүн хэсгүүд ба зүйлийн нийт мөнгөн гүйлгээний хоорондох харилцан хамаарал

- МЗУ270. Хэрэв санхүүгийн буюу санхүүгийн бус зүйлийн мөнгөн гүйлгээний бүрэлдэхүүн хэсгийг хейжийн зүйл гэж сонгосон бол тухайн бүрэлдэхүүн хэсэг нь уг зүйлийн нийт мөнгөн гүйлгээнээс бага эсвэл түүнтэй тэнцүү байх ёстой. Гэхдээ уг зүйлийн бүх мөнгөн гүйлгээг хейжийн зүйл гэж сонгож болох бөгөөд зөвхөн тодорхой нэг эрсдлийн хувьд (жишээлбэл; ЛИБОР эсвэл бараа бүтээгдэхүүний бенчмарк үнийн өөрчлөлтөнд хамааруулж болох зөвхөн тэдгээр өөрчлөлтийн хувьд) хейж хийж болох юм.
- МЗУ271. Жишээлбэл; үр ашигт хүүний хувь нь ЛИБОР-оос бага байх санхүүгийн өр төлбөрийн хувьд байгууллага нь дараах зүйлсийг хейжийн зүйл гэж сонгож болохгүй:
- (а) ЛИБОР хүүтэй тэнцүү хүүтэй байх өр төлбөрийн тэрхүү бүрэлдэхүүн хэсэг (түүнчлэн, бодит үнэ цэнийн хейжийн хувьд үндсэн дүнг нэмсэн дүн);
 - (б) Сөрөг дүн бүхий үлдэх бүрэлдэхүүн хэсэг.
- МЗУ272. Харин үр ашигт хүү нь ЛИБОР-оос бага, 100-н (жишээлбэл) суурь оноо байх тогтмол хүүтэй санхүүгийн өр төлбөрийн хувьд байгууллага нь ЛИБОР-ын өөрчлөлтөнд хамаарах уг нийт өр төлбөрийн үнэ цэнийн өөрчлөлтийг (өөрөөр хэлбэл, үндсэн дүн дээр ЛИБОР-оор тооцсон хүүг нэмж, 100-н суурь оноог хасах) хейжийн зүйл гэж сонгож болох юм. Тогтмол хүүтэй санхүүгийн хэрэглүүрт түүний анх үүссэнээс хойш тодорхой хугацааны дараа хейж хийсэн бөгөөд энэ хооронд хүүний хувь хэмжээ өөрчлөгдсөн бол байгууллага нь тухайн зүйлд төлөх гэрээний хүүнээс өндөр бенчмарк хүүтэй тэнцүү дүнгээр эрсдлийн бүрэлдэхүүн хэсгийг сонгоно. Тухайн хейжийн зүйлийг анх сонгосон өдрөөр байгууллага уг хэрэглүүрийг худалдан авсан гэсэн төсөөлөлд үндэслэн тооцсон үр ашигт хүүний хувиас бенчмарк хүү нь бага байвал байгууллага нь ийм сонголт хийх боломжтой юм. Жишээлбэл; байгууллага нь тогтмол хүүтэй, 100ТН-ийн санхүүгийн хөрөнгийг гаргасан бөгөөд энэ үед ЛИБОР 4 хувь байхад уг санхүүгийн хөрөнгийн үр ашигт хүү нь 6 хувь байсан гэж үзье. Тодорхой хугацааны дараа ЛИБОР 8 хувь болж өссөн ба уг санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ 90ТН болж буурсан үед байгууллага нь тухайн хөрөнгөнд хейж хийж эхэлсэн. Хэрэв холбогдох ЛИБОР хүүний түвшний эрсдлийг хейжийн зүйл гэж анх сонгосон өдөр уг хөрөнгийг худалдан авсан бол түүний 90ТН-ийн бодит үнэ цэнэд үндэслэсэн тухайн хөрөнгийн үр ашигт өгөөж нь 9.5 хувь болох байсан гэж байгууллага тооцоолсон. ЛИБОР хүү нь энэхүү үр ашигт өгөөжөөс бага учраас байгууллага нь 8 хувийн ЛИБОР бүрэлдэхүүн хэсгийг сонгож болох бөгөөд энэ нь нэг талаас, гэрээнд заасан хүүний мөнгөн гүйлгээнээс, нөгөө талаас одоогийн бодит үнэ цэнэ (өөрөөр хэлбэл, 90ТН) ба дуусгавар болох үед буцаан төлөх дүнгийн (өөрөөр хэлбэл, 100ТН) хоорондох зөрүүгээс бүрдэнэ.
- МЗУ273. Хувьсах хүүтэй санхүүгийн өр төлбөр нь гурван сарын ЛИБОР хүүнээс (жишээлбэл) 20-н суурь оноог хассан (тэг суурь оноо бүхий хамгийн доод хэмжээтэй) тийм хэмжээний хүүтэй бол байгууллага нь ЛИБОР-ын өөрчлөлтөнд хамаарах уг нийт өр төлбөрийн мөнгөн гүйлгээний өөрчлөлтийг (өөрөөр хэлбэл, гурван сарын ЛИБОР хүүнээс 20-н суурь оноог, үүн дотроо доод хэмжээг хассан) хейжийн зүйл гэж сонгож болно. Иймээс гурван сарын ЛИБОР хүүний форвард гэрээний муруй нь уг өр төлбөрийн үлдэх хугацааны туршид 20-н суурь онооноос доош болтол буурахгүй бол тухайн хейжийн зүйл нь тэг буюу эерэг тархалт бүхий гурван сарын ЛИБОР-оор тооцогдох хүүтэй өр төлбөрийн мөнгөн гүйлгээтэй ижил мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлттэй байна. Харин гурван сарын ЛИБОР хүүний форвард гэрээний муруй нь уг өр төлбөрийн үлдэх хугацааны (буюу түүний зарим хэсгийн) туршид 20-н суурь онооноос доош болтол буурах бол тухайн хейжийн зүйл нь тэг буюу эерэг тархалт бүхий гурван сарын ЛИБОР-оор тооцогдох хүүтэй өр төлбөрийн мөнгөн гүйлгээнээс бага мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлттэй байна.
- МЗУ274. Дээрхтэй ижил төсөөтэй санхүүгийн бус зүйлийн жишээ нь; холбогдох бенчмарк түүхий нефтис ялгаатай байдлаар үнийг тогтоодог, нефтийн тухайн ордоос олборлосон тодорхой төрлийн түүхий нефть байж болно. Бенчмарк түүхий нефтийн үнээс 10ТН-ийг, хамгийн доод хязгаарын үнэ нь 15ТН-ийг хассанаар нэг баррелийн үнийг тогтоодог гэрээнд заасан үнэ

тогтоох томъёог ашигласнаар, байгууллага нь түүхий нефтийг гэрээний дагуу борлуулдаг бол тухайн байгууллага нь тэрхүү бенчмарк түүхий нефтийн үнийн өөрчлөлтөнд хамаарах борлуулалтын гэрээний нийт мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлтийг хейжийн зүйл гэж сонгож болно. Гэхдээ байгууллага нь уг бенчмарк түүхий нефтийн үнийн бүх өөрчлөлттэй тэнцүү байх бүрэлдэхүүн хэсгийг сонгож болохгүй. Иймээс форвард үнэ (хүргэлт нэг бүрийн хувьд) нь 25ТН-ээс бага болтол буурахгүй бол тухайн хейжийн зүйл нь уг бенчмарк түүхий нефтийн үнээр (буюу эерэг тархалт бүхий) тооцогдох түүхий нефтийн борлуулалтын мөнгөн гүйлгээтэй ижил мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлттэй байна. Харин аливаа хүргэлтийн хувьд форвард үнэ нь 25ТН-ээс бага болтол буурах бол тухайн хейжийн зүйл нь уг бенчмарк түүхий нефтийн үнээр (буюу эерэг тархалт бүхий) тооцогдох түүхий нефтийн борлуулалтын мөнгөн гүйлгээнээс бага мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлттэй байна.

Хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуур

Хейжийн үр дүнтэй байдал

МЗУ275. Хейжийн үр дүнтэй байдал гэдэг нь уг хейжийн зүйлийн бодит үнэ цэнийн эсвэл мөнгөн гүйлгээний өөрчлөлтийг тухайн хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн эсвэл мөнгөн гүйлгээний өөрчлөлтөөр нөхөх хэмжээ юм (жишээлбэл; хейжийн зүйл нь эрсдлийн бүрэлдэхүүн хэсэг байх тохиолдолд уг зүйлийн бодит үнэ цэнийн эсвэл мөнгөн гүйлгээний холбогдох өөрчлөлт нь тухайн хейж хийсэн эрсдэлд хамаарах өөрчлөлт байна). Хейжийн үр дүнгүй байдал гэдэг нь уг хейжийн зүйлийн бодит үнэ цэнийн эсвэл мөнгөн гүйлгээний өөрчлөлтөөс тухайн хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн эсвэл мөнгөн гүйлгээний өөрчлөлт их эсвэл бага байх хэмжээ юм.

МЗУ276. Хейжийн харилцааг сонгох болон цаашид үргэлжлүүлэн хэрэглэх үед байгууллага нь уг хейжийн харилцаанд түүний хугацааны туршид нөлөө үзүүлэхээр хүлээгдэж буй хейжийн үр дүнгүй байдлын эх сурвалжийг шинжилнэ. Энэхүү шинжилгээ (үүн дотроо, МЗУ314-р параграфт заасан, хейжийн харилцааны дахин тэнцвэржүүлэлтээс үүсэх аливаа шинэчлэн баяжуулалт) нь хейжийн үр дүнтэй байдлын шаардлагуудыг хангаж буй эсэх талаархи уг байгууллагын үнэлгээний суурь үндэслэл болдог.

МЗУ277. Эргэлзээ төрүүлэхээс зайлсхийхийн тулд, 135-р параграфт заасанчлан, хейжийн хэрэглүүрийн оролцогч талууд нь өөрсдийн анхны клирингийн байгууллагыг өөр клирингийн байгууллагаар солих ба холбогдох өөрчлөлтийг хийсний үр нөлөөг тухайн хейжийн хэрэглүүрийн хэмжилтэнд, ингэснээр хейжийн үр дүнтэй байдлын үнэлгээ болон хейжийн үр дүнтэй байдлын хэмжилтэнд тусгана.

Хейжийн зүйл ба хейжийн хэрэглүүрийн хоорондох эдийн засгийн харилцан хамаарал

МЗУ278. Эдийн засгийн харилцан хамаарал оршин байх гэсэн шаардлага нь уг хейж хийсэн эрсдлийн хувьд хейжийн зүйл ба хейжийн хэрэглүүр ерөнхийдөө эсрэг чиглэлд хувьсан өөрчлөгдөх үнэ цэнүүдтэй байна гэсэн үг юм. Иймээс хейжийн хэрэглүүрийн үнэ цэнэ болон хейжийн зүйлийн үнэ цэнэ нь эдийн засгийн харилцан хамааралтай уг суурь хэрэглүүр буюу хэрэглүүрүүдийн өөрчлөлтөнд хариу үзүүлэх байдлаар системтэйгээр өөрчлөгддөг, ингэснээр тухайн хейж хийж буй эрсдлийн өөрчлөлттэй ижил арга замаар хариу үзүүлнэ гэсэн хүлээлт байх ёстой (жишээлбэл; Brent ба Баруун Техасын түүхий нефть).

МЗУ279. Суурь хэрэглүүрүүд нь нэг ижил биш боловч эдийн засгийн харилцан хамааралтай бол хейжийн хэрэглүүр ба хейжийн зүйлийн үнэ цэнүүд нь нэг ижил чиглэлд өөрчлөгдөх тохиолдол байж болно. Тухайлбал; суурь хэрэглүүрүүд нь өөрсдөө мэдэгдэхүйц өөрчлөгдөөгүй боловч харилцан хамааралтай хоёр суурь хэрэглүүрийн хоорондох үнийн зөрүү нь өөрчлөгдөж болох юм. Суурь хэрэглүүрүүд өөрчлөгдөх үед хейжийн хэрэглүүрийн болон хейжийн зүйлийн үнэ цэнүүд нь ерөнхийдөө эсрэг чиглэлд өөрчлөгдөхөөр хүлээгдэж байгаа бол энэ нь тэрхүү хейжийн хэрэглүүр ба хейжийн зүйлийн хоорондох эдийн засгийн харилцан хамааралтай нийцсэн хэвээр байх юм.

МЗУ280. Тухайн хейжийн харилцаа нь эрсдлийн удирдлагын зорилгыг хангахаар хүлээгдэж буй эсэхийг тодорхойлохын тулд уг харилцааны хугацааны туршид түүний боломжит төлөв байдлуудын талаар хийх шинжилгээ нь эдийн засгийн харилцан хамаарал оршин байгаа эсэх талаархи үнэлгээнд багтдаг. Хоёр хувьсагчийн хооронд статистик хамаарал зөвхөн оршин байх нь эдийн засгийн харилцан хамааралтай гэсэн хүчин төгөлдөр дүгнэлтийн үндэслэл дангаараа болохгүй юм.

Зээлийн эрсдлийн үр нөлөө

МЗУ281. Хейжийн нягтлан бодох бүртгэлийн загвар нь хейжийн хэрэглүүр ба хейжийн зүйлийн олз, гарзын хоорондох харилцан нөхөлт гэсэн ерөнхий ойлголтонд үндэслэдэг тул хейжийн үр дүнтэй байдлыг зөвхөн тэдгээр зүйлсийн хоорондох эдийн засгийн харилцан хамаарлаас (өөрөөр хэлбэл, тэдгээрийн суурь хэрэглүүрүүдийн өөрчлөлтөөс) гадна тухайн хейжийн хэрэглүүр ба хейжийн зүйлийн аль алины үнэ цэнэд зээлийн эрсдлийн үзүүлэх үр нөлөөгөөр тодорхойлдог. Зээлийн эрсдлийн үр нөлөө нь хейжийн хэрэглүүр ба хейжийн зүйлийн хооронд эдийн засгийн харилцан хамааралтай боловч тэдгээрийн харилцан нөхөлтийн түвшин жигд бус байж болно гэсэн утгыг илэрхийлдэг. Ийм жигд бус байдал нь хейжийн хэрэглүүр эсвэл хейжийн зүйлийн аль нэгний зээлийн эрсдлийн өөрчлөлтөөс бий болдог, өөрөөр хэлбэл зээлийн эрсдэл нь тухайн эдийн засгийн харилцан хамаарлын үр дүн болох үнэ цэнийн өөрчлөлтөөс (тухайлбал, суурь хэрэглүүрүүдийн өөрчлөлтийн үр нөлөөнөөс) илүү давамгайлах ач холбогдолтой байдаг. Давамгайлахад хүргэх ач холбогдлын түвшин гэдэг нь хэдийгээр тухайн суурь хэрэглүүрүүдийн өөрчлөлт мэдэгдэхүйц дүнтэй боловч хейжийн хэрэглүүрийн эсвэл хейжийн зүйлийн үнэ цэнэд тэдгээр өөрчлөлтийн үзүүлэх үр нөлөөг арилгаж, харин зээлийн эрсдлээс гарз (эсвэл олз) үүсэхэд хүргэхүйц тийм хэмжээтэй байхыг хэлнэ. Харин эсрэгээр, хейжийн хэрэглүүрийн эсвэл хейжийн зүйлийн үнэ цэнэд зээлийн эрсдэлтэй холбоотойгоор багахан өөрчлөлт орсон боловч тухайн тайлант үед суурь хэрэглүүрт орсон жижиг өөрчлөлтийн улмаас үнэ цэнэд илүү ихээр нөлөөлсөн бол энэ нь зээлийн эрсдлийн давамгайлах ач холбогдол биш юм.

МЗУ282. Хейжийн харилцаанд давамгайлах нөлөө бүхий зээлийн эрсдлийн жишээ нь байгууллага барьцаагүй үүсмэл хэрэглүүрийг ашигласнаар бараа бүтээгдэхүүний үнийн эрсдэлд хейж хийх тохиолдол юм. Хэрэв үүсмэл хэрэглүүрийн оролцогч талын зээлийн үнэлэмж ноцтой муудсан бол уг оролцогч талын зээлийн үнэ цэнийн өөрчлөлтийн үр нөлөө нь тухайн хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэд бараа бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтийн үзүүлэх үр нөлөөнөөс илүү байж болох бөгөөд хейжийн зүйлийн үнэ цэнийн өөрчлөлт нь бараа бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтөөс ихээхэн хамааралтай байна.

Хейжийн харьцаа

МЗУ283. Хейжийн үр дүнтэй байдлын шаардлагын дагуу, тухайн хейжийн харилцааны хейжийн харьцаа нь байгууллагын бодитойгоор хейж хийж буй хейжийн зүйлийн тоо хэмжээ ба уг тоо хэмжээний хейжийн зүйлд хейж хийхийн тулд байгууллага бодитойгоор ашиглах хейжийн хэрэглүүрийн тоо хэмжээнээс үүсэх үр дүнтэй ижил байх ёстой. Иймээс байгууллага нь тухайн зүйлийн эрсдлийн 100 хувиас бага, тухайлбал, 85 хувьд хейж хийвэл уг байгууллага нь эрсдлийн 85 хувь, түүнчлэн тэрхүү 85 хувьд хейж хийхийн тулд түүний бодитойгоор ашиглах хейжийн хэрэглүүрийн тоо хэмжээний үр дүнтэй ижил байх хейжийн харьцааг ашигласнаар уг хейжийн харилцааг сонгоно. Үүнтэй адилаар, хэрэв байгууллага нь жишээлбэл, санхүүгийн хэрэглүүрийн 40 нэгжийн нэрлэсэн дүнг ашигласнаар эрсдэлд хейж хийдэг бол тухайн байгууллага нь тэдгээр 40 нэгж (өөрөөр хэлбэл, байгууллага нь өөрийн эзэмшиж болох нийт нэгжээс сонгосон арай олон эсвэл арай цөөн тоо хэмжээнд үндэслэсэн хейжийн харьцааг ашиглах ёсгүй), түүнчлэн тэрхүү 40 нэгжээр бодитойгоор хейж хийж буй хейжийн зүйлийн тоо хэмжээний үр дүнтэй ижил хейжийн харьцааг ашигласнаар уг хейжийн харилцааг сонгоно.

МЗУ284. Гэхдээ хейжийн зүйл болон байгууллагын бодитойгоор ашигладаг хейжийн хэрэглүүрийн тоо хэмжээнүүдийн үр дүн болох уг хейжийн харьцааг ашигласнаар хийх тухайн хейжийн харилцааны сонголт нь хейжийн зүйл болон хейжийн хэрэглүүрийн хувийн жингүүдийн хоорондох тэнцвэргүй байдлыг тусган харуулдаггүй. Ийм тэнцвэргүй байдал нь эргээд

хейжийн нягтлан бодох бүртгэлийн зорилготой үл нийцэх нягтлан бодох бүртгэлийн үр дагаварт хүргэх хейжийн үр дүнгүй байдлыг үүсгэдэг. Иймээс хейжийн харилцааг сонгох зорилгын хувьд ийм тэнцвэргүй байдлаас хэрэв зайлсхийх шаардлагатай бол байгууллага нь хейжийн зүйлийн тоо хэмжээ ба түүний бодитойгоор ашиглах хейжийн хэрэглүүрийн тоо хэмжээний үр дүн болох тухайн хейжийн харьцааг тохируулах ёстой.

МЗУ285. Нягтлан бодох бүртгэлийн үр дагавар нь хейжийн нягтлан бодох бүртгэлийн зорилготой үл нийцэх эсэхийг үнэлэхдээ харгалзан үзэх зүйлсийн жишээнд дараах зүйлс хамаарна:

- (а) Мөнгөн гүйлгээний хейжийн хувьд хейжийн үр дүнгүй байдал хүлээн зөвшөөрөхөөс зайлсхийх, эсвэл бодит үнэ цэнийн нягтлан бодох бүртгэлийн ашиглалтыг нэмэгдүүлэх зорилготой боловч хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг харилцан нөхөхгүйгээр хейжийн илүү олон зүйлсийн хувьд бодит үнэ цэнийн хейжийн тохируулгыг хийхийн тулд зорилтот хейжийн харьцааг тогтоосон эсэх; ба
- (б) Хэдийгээр хейжийн үр дүнгүй байдал үүсгэдэг боловч хейжийн зүйл ба хейжийн хэрэглүүрийн тодорхой хувийн жингүүдийн хувьд арилжааны шалтгаан үндэслэл байгаа эсэх. Тухайлбал; хейжийн хэрэглүүрийн стандарт хэмжээ нь тухайн хейжийн хэрэглүүрийг яг оновчтой тоо хэмжээгээр гаргах боломж олгодоггүй ('багцын тоо хэмжээний асуудал') учраас байгууллага нь уг хейжийн зүйлийн хувьд хамгийн сайн хейж гэж тодорхойлсон тоо хэмжээтэй шууд тохирохгүй тийм тоо хэмжээгээр хейжийн хэрэглүүрийг сонгож, гаргадаг. Жишээлбэл; 1,000 баррел гэрээний тоо хэмжээтэй газрын тосны стандарт фьючерс гэрээ ашигласнаар байгууллага нь 1,000 тонн газрын тосны худалдан авалтанд хейж хийдэг. Тухайн байгууллага нь 1,000 тонн тоо хэмжээтэй худалдан авалтанд хейж хийхийн тулд долоо эсвэл найман гэрээний (харгалзан 980 тонн ба 1,120 тоннтай тэнцүү байна) зөвхөн аль нэгийг ашиглаж болох юм. Хейжийн зүйл ба хейжийн хэрэглүүрийн хувийн жингүүдийн уялдаагүй байдлаас үүсэх хейжийн үр дүнгүй байдал нь хейжийн нягтлан бодох бүртгэлийн зорилготой үл нийцэх нягтлан бодох бүртгэлийн үр дагаварт хүргэхгүй учраас энэ тохиолдолд байгууллага нь өөрийн бодитойгоор ашигладаг газрын тосны олон тооны фьючерс гэрээний үр дүн болох уг хейжийн харьцааг ашигласнаар тухайн хейжийн харилцааг сонгоно.

Хейжийн үр дүнтэй байдлын шаардлагууд хангагдах эсэхийг үнэлэх давтамж

МЗУ286. Хейжийн харилцаа нь хейжийн үр дүнтэй байдлын шаардлагуудыг хангах эсэхийг байгууллага нь уг хейжийн харилцааны эхэнд, түүнчлэн цаашид тасралтгүй сууриар үнэлнэ. Байгууллага наад зах нь тайлант үе бүрийн эцэст эсвэл хейжийн үр дүнтэй байдлын шаардлагуудад нөлөөлөх нөхцөл байдалд орсон мэдэгдэхүйц өөрчлөлтийн аль түрүүнд болсон өдрөөр тасралтгүй үнэлгээг хийнэ. Ийм үнэлгээ нь хейжийн үр дүнтэй байдлын талаархи хүлээлттэй холбоотой тул зөвхөн ирээдүйд чиглэсэн байна.

Хейжийн үр дүнтэй байдлын шаардлагууд хангагдах эсэхийг үнэлэх арга зүй

МЗУ287. Хейжийн харилцаа нь хейжийн үр дүнтэй байдлын шаардлагуудыг хангах эсэхийг үнэлэх арга зүйг энэ Стандартад тусгайлан заагаагүй. Гэхдээ байгууллага нь хейжийн харилцааны холбогдох шинж чанарууд, үүн дотроо хейжийн үр дүнгүй байдлын эх сурвалжийг илэрхийлэх арга зүйг ашиглана. Эдгээр хүчин зүйлсээс хамааран тухайн арга зүй нь чанарын эсвэл тоон үнэлгээ байж болно.

МЗУ288. Тухайлбал; хейжийн хэрэглүүр ба хейжийн зүйлийн чухал нөхцлүүд (нэрлэсэн дүн, дуусгавар болох хугацаа, суурь хэрэглүүр) нь харилцан уялдаатай буюу нягт холбоотой байх тохиолдолд уг хейжийн зүйл ба хейжийн хэрэглүүр нь ижил эрсдэлтэй, иймээс тэдгээрийн хооронд эдийн засгийн харилцан хамааралтай байх учраас байгууллага нь тэдгээр чухал нөхцлүүдийн чанарын үнэлгээнд үндэслэн тухайн хейжийн хэрэглүүр ба хейжийн зүйл ерөнхийдөө эсрэг чиглэлд өөрчлөгдөх үнэ цэнүүдтэй гэж дүгнэж болох юм (МЗУ278-МЗУ280-р параграфыг үзнэ үү).

МЗУ289. Хейжийн хэрэглүүр гэж сонгох үед үүсмэл хэрэглүүр нь мөнгөн ашигтай эсвэл мөнгөн алдагдалтай байх нь тухайн чанарын үнэлгээ тохиромжгүй гэсэн утгыг дангаараа

илэрхийлэхгүй. Мөнгөн ашиг эсвэл мөнгөн алдагдлаас бий болох хейжийн үр дүнгүй байдал нь уг чанарын үнэлгээ тохиромжгүй болоход хүргэх тийм ач холбогдолтой эсэх нь тухайн нөхцөл байдлаас хамаардаг.

- МЗУ290. Харин эсрэгээр, хейжийн хэрэглүүр ба хейжийн зүйлийн чухал нөхцлүүд нь нягт холбоогүй бол харилцан нөхөх хэмжээний талаархи тодорхойгүй байдлын түвшин нэмэгдэх юм. Ингэснээр тухайн хейжийн харилцааны хугацаанд хейжийн үр дүнтэй байдлыг урьдчилан таамаглахад илүү төвөгтэй болдог. Энэ тохиолдолд байгууллага нь тухайн хейжийн зүйл ба хейжийн хэрэглүүрийн хооронд эдийн засгийн харилцан хамаарал оршин байна гэж зөвхөн тоон үнэлгээнд үндэслэн дүгнэж болох юм (МЗУ278-МЗУ280-р параграфыг үзнэ үү). Зарим тохиолдолд хейжийн харилцааг сонгоход ашигласан тухайн хейжийн харьцаа нь хейжийн үр дүнтэй байдлын шаардлагуудыг хангах эсэхийг үнэлэхэд мөн тоон үнэлгээ хийх шаардлагатай байж болно (МЗУ283-МЗУ285-р параграфыг үзнэ үү). Байгууллага нь эдгээр хоёр өөр зорилгын хувьд нэг ижил эсвэл өөр өөр арга зүйг ашиглаж болно.
- МЗУ291. Хэрэв хейжийн үр дүнтэй байдалд нөлөөлдөг нөхцөл байдал өөрчлөгдсөн бол байгууллага нь уг хейжийн харилцааны холбогдох шинж чанарууд, үүн дотроо хейжийн үр дүнгүй байдлын эх сурвалжийг тусган илэрхийлсэн хэвээр байгаа эсэхийг ханган магадлахын тулд хейжийн үр дүнтэй байдлын шаардлагуудыг уг хейжийн харилцаа хангаж буй эсэхийг үнэлэх арга зүйгээ өөрчлөх шаардлагатай байж болох юм.
- МЗУ292. Байгууллагын эрсдлийн удирдлага нь хейжийн үр дүнтэй байдлын шаардлагуудыг уг хейжийн харилцаа хангаж буй эсэх үнэлгээг гүйцэтгэх мэдээллийн гол эх үүсвэр юм. Энэ нь шийдвэр гаргах зорилгын хувьд ашигладаг удирдлагын мэдээллийг (буюу шинжилгээг) тухайн хейжийн харилцаа нь хейжийн үр дүнтэй байдлын шаардлагуудыг хангах эсэхийг үнэлэх суурь үндэслэл болгон ашиглаж болно гэсэн үг юм.
- МЗУ293. Байгууллагын хейжийн харилцааны баримтжуулалт нь хейжийн үр дүнтэй байдлын шаардлагуудыг хэрхэн үнэлэх тухай, түүнчлэн ашиглах арга зүйг тусгасан байдаг. Арга зүйд орсон аливаа өөрчлөлтийн хувьд тухайн хейжийн харилцааны баримтжуулалтыг шинэчлэн баяжуулдаг (МЗУ291-р параграфыг үзнэ үү).

Шалгуур хангах хейжийн харилцааны нягтлан бодох бүртгэл

- МЗУ294. Бодит үнэ цэнийн хейжийн жишээ нь; хүүний хувь хэмжээний өөрчлөлтийн улмаас тогтмол хүүтэй өрийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэд гарах өөрчлөлтийн эрсдлийн хейж юм. Ийм хейжийг санхүүгийн хэрэглүүрийн гаргагч эсвэл эзэмшигч хийж болно.
- МЗУ295. Мөнгөн гүйлгээний хейжийн зорилго бол уг хейж хийсэн, хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн гүйлгээ нь ашиг, алдагдалд нөлөө үзүүлэх тайлант үе буюу үеүд хүртэл тухайн хейжийн хэрэглүүрийн олз, гарзыг хойшлуулах явдал юм. Мөнгөн гүйлгээний хейжийн жишээ нь хөвөгч хүүтэй өрийг (хорогдуулсан өртөг эсвэл бодит үнэ цэнээр хэмжсэн эсэхээс үл хамааран) тогтмол хүүтэй өр болгох свопын гэрээний ашиглалт (өөрөөр хэлбэл, хейж хийж буй ирээдүйн мөнгөн гүйлгээ нь ирээдүйн хүүний төлбөрүүд байх ирээдүйн ажил гүйлгээний хейж) байж болно. Харин эсрэгээр, олж эзэмшсэний дараа ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр нь тайлагнах өмчийн хэрэглүүрийн урьдчилан таамагласан худалдан авалт нь мөнгөн гүйлгээний хейжийн хувьд хейжийн зүйл болж чадахгүй зүйлсийн нэг жишээ юм. Яагаад гэвэл, уг хейжийн хэрэглүүрийн хувьд хойшлуулах аливаа олз, гарз нь харилцан нөхөлт хийх тухайн тайлант үеийн туршид тэдгээр олз, гарзыг ашиг, алдагдалд зохих ёсоор дахин ангилах боломжгүй байдаг. Үүнтэй адилаар, олж эзэмшсэний дараа бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь цэвэр хөрөнгө/өмчид тусгаж, бодит үнэ цэнээр тайлагнах өмчийн хэрэглүүрийн урьдчилан таамагласан худалдан авалт нь мөнгөн гүйлгээний хейжийн хувьд мөн хейжийн зүйл болж чадахгүй зүйлсийн нэг жишээ болно.
- МЗУ296. Арилжааны баталгааны хейж (жишээлбэл; түлшийг тогтмол үнээр худалдан авахын тулд цахилгаан ашиглалтын байгууллагын гаргасан, хүлээн зөвшөөрөөгүй байгаа гэрээний баталгаатай холбоотой түлшний үнийн өөрчлөлтийн хейж) нь бодит үнэ цэнийн өөрчлөлтийн

эрсдлийн хейж юм. Өөрөөр хэлбэл, ийм хейж нь бодит үнэ цэнийн хейж болно. Гэвч 133-р параграфт заасанчлан, арилжааны баталгааны гадаад валютын эрсдлийн хейжийг мөнгөн гүйлгээний хейжийг бүртгэдэг арга замтай адилаар тайлагнаж болох юм.

Хейжийн үр дүнгүй байдлын хэмжилт

МЗУ297. Хейжийн үр дүнгүй байдлыг хэмжихдээ байгууллага нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг харгалзан үзнэ. Үүний үр дүнд, байгууллага нь хейжийн зүйлийн үнэ цэнийг өнөөгийн үнэ цэнийн сууриар тодорхойлдог, иймээс уг хейжийн зүйлийн үнэ цэнийн өөрчлөлт нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн үр нөлөөг бас тусгасан байна.

МЗУ298. Хейжийн үр дүнгүй байдлыг хэмжих зорилгоор хейжийн зүйлийн үнэ цэнийн өөрчлөлтийг тооцоолохын тулд байгууллага нь тухайн хейжийн зүйлийн чухал нөхцлүүдтэй тохирох тийм нөхцөл бүхий үүсмэл хэрэглүүрийг (үүнийг ихэвчлэн ‘таамагласан үүсмэл хэрэглүүр’ гэж нэрлэдэг) ашиглаж болох юм. Жишээлбэл; урьдчилан таамагласан ажил гүйлгээний хейжийн хувьд уг хейж хийсэн үнийн (эсвэл хувь хэмжээний) түвшинг ашигласнаар өөрчлөлтийг хэмжин шалгадаг. Тухайлбал; одоогийн зах зээлийн түвшнээр хоёр талт эрсдлийн хувьд хейж хийсэн бол тухайн таамагласан үүсмэл хэрэглүүр нь уг хейжийн харилцааг сонгох үеийн тэг үнэ цэнэтэй харьцуулснаар хэмжин шалгагдах таамагласан форвард гэрээг илэрхийлнэ. Харин нэг талт эрсдлийн хувьд хейж хийсэн бол тухайн таамагласан ажил гүйлгээ нь уг хейжийн харилцааг сонгох үеийн таамагласан опционы дотоод үнэ цэнийг илэрхийлнэ. Тухайлбал; хэрэв хейж хийсэн үнийн түвшин нь одоогийн зах зээлийн түвшинд байвал энэхүү опционы дотоод үнэ цэнэ нь мөнгөн ашиггүй, харин хейж хийсэн үнийн түвшин нь одоогийн зах зээлийн түвшнээс өндөр (эсвэл нэмэгдэх төлөв байдлын хувьд бага) байвал мөнгөн алдагдалтай байна. Таамагласан үүсмэл хэрэглүүрийг ашиглах нь хейжийн зүйлийн үнэ цэнийн өөрчлөлтийг тооцоолох боломжит нэг арга зам юм. Таамагласан үүсмэл хэрэглүүр нь хейжийн зүйлийг орлох учраас тухайн үнэ цэнийн өөрчлөлтийг өөр арга хандлагаар тодорхойлсонтой ижил үр дүнд хүргэдэг. Иймээс ‘таамагласан үүсмэл хэрэглүүр’ ашиглах нь яг өөрөө арга зүй биш боловч тухайн хейжийн зүйлийн үнэ цэнийг тооцоолоход зөвхөн ашигладаг математик аргачлал юм. Ийм учраас зөвхөн хейжийн хэрэглүүрт (хейжийн зүйлд биш) оршин буй шинжүүдийг тухайн хейжийн зүйлийн үнэ цэнэд тусгахын тулд ‘таамагласан үүсмэл хэрэглүүр’-ийг ашиглах боломжгүй байдаг. Жишээлбэл; гадаад валютаар илэрхийлэгдсэн өр (тогтмол хүүтэй эсвэл хувьсах хүүтэй өр эсэхээс үл хамаарна). Ийм өрийн үнэ цэнийн өөрчлөлтийг эсвэл түүний мөнгөн гүйлгээний хуримтлагдсан өөрчлөлтийн өнөөгийн үнэ цэнийг тооцоолохын тулд таамагласан үүсмэл хэрэглүүрийг ашиглах тохиолдолд хэдийгээр өөр өөр валютаар арилжиж буй бодит үүсмэл хэрэглүүрүүд нь арилжааны шимтгэлийг тусгадаг байж болох (жишээлбэл; валют хоорондын хүүний түвшний своп) боловч уг таамагласан үүсмэл хэрэглүүр нь тэдгээр өөр өөр валютуудын арилжааны шимтгэлийг харгалзан тооцдоггүй.

МЗУ299. Таамагласан үүсмэл хэрэглүүрийг ашигласнаар тодорхойлсон уг хейжийн зүйлийн үнэ цэнийн өөрчлөлтийг тухайн хейжийн харилцаа нь хейжийн үр дүнтэй байдлын шаардлагуудыг хангах эсэхийг үнэлэх зорилгоор бас ашиглаж болох юм.

Хейжийн харилцааны дахин тэнцвэржүүлэлт ба хейжийн харьцааны өөрчлөлт

МЗУ300. Дахин тэнцвэржүүлэх гэдэг нь хейжийн үр дүнтэй байдлын шаардлагуудтай нийцэх хейжийн харьцааг хадгалах зорилгоор одоо оршин байгаа хейжийн харилцааны хейжийн зүйл эсвэл хейжийн хэрэглүүрийн тухайн сонгосон тоо хэмжээнд хийгдэх тохируулга юм. Хейжийн зүйл эсвэл хейжийн хэрэглүүрийн тухайн сонгосон тоо хэмжээнд өөр зорилгоор хийсэн өөрчлөлтүүд нь энэ Стандартад дурдсан дахин тэнцвэржүүлэлтийг орлохгүй.

МЗУ301. Дахин тэнцвэржүүлэлтийг МЗУ302-МЗУ314-р параграфын дагуу хейжийн харилцааны үргэлжлэл байдлаар тайлагнана. Дахин тэнцвэржүүлэх үед уг хейжийн харилцааны хейжийн үр дүнгүй байдлыг тодорхойлж, тухайн хейжийн харилцааг тохируулахаас өмнө нэн даруй хүлээн зөвшөөрнө.

МЗУ302. Хейжийн харьцааг тохируулах нь суурь хэрэглүүрүүд эсвэл эрсдлийн хувьсагчдын улмаас тухайн хейжийн хэрэглүүр ба хейжийн зүйлийн хоорондох харилцаанд орох өөрчлөлтөнд байгууллага хариу үзүүлэх боломжийг олгодог. Тухайлбал; хейжийн хэрэглүүр ба хейжийн зүйл нь өөр өөр боловч харилцан холбоотой суурь хэрэглүүрүүдтэй байх тийм хейжийн харилцаа нь эдгээр хоёр өөр суурь хэрэглүүрүүдийн (жишээлбэл; өөр боловч харилцан холбоотой лавлагаа болох индексүүд, хувь хэмжээнүүд буюу үнүүд) хоорондох харилцааны өөрчлөлтөнд хариу үзүүлдэг. Иймээс хейжийн хэрэглүүр ба хейжийн зүйлийн хоорондох харилцаа нь тухайн хейжийн харьцааг тохируулснаар нөхөн тэнцүүлж болохуйц тийм арга замаар өөрчлөгддөг нөхцөл байдалд дахин тэнцвэржүүлэлт нь уг хейжийн харилцааг цаашид үргэлжлүүлэх боломжийг олгодог.

МЗУ303. Жишээлбэл; Б гадаад валют суурь хэрэглүүр нь байх валютын үүсмэл хэрэглүүрийг ашигласнаар байгууллага нь А гадаад валютын эрсдлийн хувьд хейж хийдэг бөгөөд А ба Б гадаад валютыг тогтворжуулсан (өөрөөр хэлбэл, эдгээр валютын хоорондох арилжааны ханш нь төв банк эсвэл бусад эрх бүхий байгууллагаас тогтоосон хязгаарын дотор буюу тэр ханшаар байна). Хэрэв А ба Б гадаад валютын хоорондох арилжааны ханш өөрчлөгдвөл (өөрөөр хэлбэл, шинэ хязгаар буюу ханшийг тогтоосон бол) уг арилжааны шинэ ханшийг тусгахын тулд хейжийн харилцаанд хийх дахин тэнцвэржүүлэлт нь тухайн шинэ нөхцөл байдал дахь хейжийн харьцаанд хамаарах хейжийн үр дүнтэй байдлын шаардлагыг тэрхүү хейжийн харилцаа хангасан хэвээр байгаа гэдгийг ханган магадлах юм. Харин эсрэгээр, хэрэв тухайн валютын үүсмэл хэрэглүүрт үл биелүүлэлт гарсан бол уг хейжийн харьцааг өөрчлөх нь хейжийн үр дүнтэй байдлын шаардлагыг тэрхүү хейжийн харилцаа хангасан хэвээр байгаа гэдгийг ханган магадалж чадахгүй. Иймээс хейжийн хэрэглүүр ба хейжийн зүйлийн хоорондох харилцаа нь тухайн хейжийн харьцааг тохируулснаар нөхөн тэнцүүлж болохооргүй тийм арга замаар өөрчлөгддөг нөхцөл байдалд дахин тэнцвэржүүлэлт нь уг хейжийн харилцааг цаашид үргэлжлүүлэх боломжийг олгохгүй.

МЗУ304. Хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт ба хейжийн зүйлийн бодит үнэ цэнийн эсвэл мөнгөн гүйлгээний өөрчлөлт хоорондох харилцан нөхөлтийн аливаа өөрчлөлт бүр нь тухайн хейжийн хэрэглүүр болон хейжийн зүйлийн хоорондох харилцааны өөрчлөлтийг орлон бүрдүүлэхгүй. Хейжийн харилцааны хугацаанд түүнд нөлөөлөхөөр хүлээгдэж буй хейжийн үр дүнгүй байдлын эх сурвалжийг байгууллага нь шинжилж, харилцан нөхөлтийн хэмжээний өөрчлөлтүүд нь дараах шинжтэй эсэхийг үнэлнэ:

- (а) Хүчин төгөлдөр хэвээр байгаа тухайн хейжийн харьцааны хэлбэлзэл байх (өөрөөр хэлбэл, хейжийн хэрэглүүр ба хейжийн зүйлийн хоорондох уг харилцааг зохих ёсоор тусгасан хэвээр байх);
- (б) Тухайн хейжийн харьцаа нь хейжийн хэрэглүүр ба хейжийн зүйлийн хоорондох харилцааг цаашид зохих ёсоор тусгахгүй гэдгийг илэрхийлэх.

Тухайн хейжийн харьцаанд хамаарах хейжийн үр дүнтэй байдлын шаардлагатай харьцуулснаар байгууллага нь энэхүү үнэлгээг хийдэг. Өөрөөр хэлбэл, уг хейжийн харилцаа нь хейжийн үр дүнгүй байдал үүсгэх (хүлээн зөвшөөрсөн эсэхээс үл хамааран), улмаар хейжийн нягтлан бодох бүртгэлийн зорилготой үл нийцэх нягтлан бодох бүртгэлийн үр дагаварт хүргэх, хейжийн зүйл ба хейжийн хэрэглүүрийн хувийн жингүүдийн хоорондох тийм тэнцвэргүй байдлыг тусгаагүй гэдгийг ханган магадална. Иймээс энэ үнэлгээ нь шүүн тунгаалт хийхийг шаарддаг.

МЗУ305. Тухайн тодорхой үр дагавар бүрийн хариуд хейжийн харьцааг тохируулах замаар хейжийн тогтмол харьцааны хэлбэлзлийг (ингэснээр холбогдох хейжийн үр дүнгүй байдлыг) багасгаж чадахгүй. Өөрөөр хэлбэл, ийм нөхцөл байдалд харилцан нөхөх хэмжээний өөрчлөлт нь хейжийн үр дүнгүй байдлын хэмжилт болон хүлээн зөвшөөрөлтийн асуудал болох бөгөөд дахин тэнцвэржүүлэлт хийх шаардлагагүй юм.

МЗУ306. Эсрэгээр, хейжийн харьцааны хэлбэлзэл нь тухайн хейжийн харилцаанд одоогоор ашиглаж байгаа хейжийн харьцаанаас өөр эсвэл түүнээс өөр болох хандлагатай гэдгийг уг харилцан нөхөх хэмжээний өөрчлөлтүүд харуулж байвал хейжийн харьцааг тохируулснаар хейжийн үр

дүнгүй байдлыг багасгаж чадна, харин тэрхүү хейжийн харьцааг хэвээр хадгалах нь хейжийн үр дүнгүй байдлыг улам нэмэгдүүлэх юм. Иймээс энэ тохиолдолд уг хейжийн харилцаа нь хейжийн үр дүнгүй байдал үүсгэх (хүлээн зөвшөөрсөн эсэхээс үл хамааран), улмаар хейжийн нягтлан бодох бүртгэлийн зорилготой үл нийцэх нягтлан бодох бүртгэлийн үр дагаварт хүргэх, хейжийн зүйл ба хейжийн хэрэглүүрийн хувийн жингүүдийн хоорондох тийм тэнцвэргүй байдлыг тусгах эсэхийг байгууллага нь үнэлэх ёстой. МЗУ301-р параграфт заасанчлан, дахин тэнцвэржүүлэх үед уг хейжийн харилцааны хейжийн үр дүнгүй байдлыг тодорхойлж, тухайн хейжийн харилцааг тохируулахаас өмнө нэн даруй хүлээн зөвшөөрөх ёстой учраас хэрэв хейжийн харьцааг тохируулах бол хейжийн үр дүнгүй байдлын хэмжилт ба хүлээн зөвшөөрөлтийг бас тусган илэрхийлнэ.

МЗУ307. Хейжийн нягтлан бодох бүртгэлийн зорилгын хувьд дахин тэнцвэржүүлэлт гэдэг нь хейжийн харилцаа эхэлсэний дараа тухайн хейжийн харилцааны хейжийн харьцаанд нөлөөлөх нөхцөл байдлын өөрчлөлтийн хариу болгон байгууллага уг хейжийн хэрэглүүрийн эсвэл хейжийн зүйлийн тоо хэмжээг өөрчлөн тохируулах явдал юм. Ийм тохируулга нь бодитойгоор ашиглаж буй хейжийн хэрэглүүр болон хейжийн зүйлийн тоо хэмжээнд хийх тохируулгыг үндсэндээ тусгасан байвал зохино. Гэвч дараах тохиолдолд байгууллага нь бодитойгоор ашиглаж буй хейжийн зүйл болон хейжийн хэрэглүүрийн тоо хэмжээний үр дүн болох уг хейжийн харьцааг тохируулах ёстой:

- (а) Байгууллагын бодитойгоор ашигладаг хейжийн хэрэглүүр болон хейжийн зүйлийн тоо хэмжээнүүдийн үр дүн болох уг хейжийн харьцаа нь хейжийн үр дүнгүй байдал үүсгэх, улмаар хейжийн нягтлан бодох бүртгэлийн зорилготой үл нийцэх нягтлан бодох бүртгэлийн үр дагаварт хүргэх тийм тэнцвэргүй байдлыг тусган илэрхийлэх;
- (б) Байгууллага нь өөрийн бодитойгоор ашигладаг хейжийн хэрэглүүр болон хейжийн зүйлийн тоо хэмжээг хэвээр хадгалах, ингэснээр энэ нь шинэ нөхцөл байдалд хейжийн үр дүнгүй байдал үүсгэх, улмаар хейжийн нягтлан бодох бүртгэлийн зорилготой үл нийцэх нягтлан бодох бүртгэлийн үр дагаварт хүргэх тийм тэнцвэргүй байдлыг тусган илэрхийлэх хейжийн харьцаа болох (өөрөөр хэлбэл, байгууллага нь тухайн хейжийн харьцааг тохируулахгүй орхисноор тэнцвэргүй байдал үүсгэх ёсгүй юм).

МЗУ308. Хэрэв хейжийн харилцаанд хамаарах эрсдлийн удирдлагын зорилго өөрчлөгдсөн бол дахин тэнцвэржүүлэлтийг хийхгүй. Харин тухайн хейжийн харилцаанд зориулсан хейжийн нягтлан бодох бүртгэлийг цаашид хэрэглэхгүй зогсооно (МЗУ321-р параграфт заасанчлан, байгууллага нь өмнөх хейжийн харилцааны хейжийн хэрэглүүр эсвэл хейжийн зүйлийг багтаасан шинэ хейжийн харилцааг сонгож болох эсэхээс үл хамаарна).

МЗУ309. Хэрэв хейжийн харилцааг дахин тэнцвэржүүлэх бол уг хейжийн харьцаанд хийх тохируулгыг янз бүрийн арга замаар гүйцэтгэж болно:

- (а) Хейжийн зүйлийн хувийн жинг дараах байдлаар нэмэгдүүлж (нөгөө талаас, хейжийн хэрэглүүрийн хувийн жинг бууруулж) болно:
 - (i) Хейжийн зүйлийн тоо хэмжээг нэмэгдүүлэх; эсвэл
 - (ii) Хейжийн хэрэглүүрийн тоо хэмжээ бууруулах.
- (б) Хейжийн хэрэглүүрийн хувийн жинг дараах байдлаар нэмэгдүүлж (нөгөө талаас, хейжийн зүйлийн хувийн жинг бууруулж) болно:
 - (i) Хейжийн хэрэглүүрийн тоо хэмжээг нэмэгдүүлэх;
 - (ii) Хейжийн зүйлийн тоо хэмжээг бууруулах.

Тоо хэмжээний өөрчлөлт нь хейжийн харилцааны нэг хэсэг болох тоо ширхэгийг илэрхийлнэ. Иймээс тоо хэмжээний бууралт нь тухайн зүйл буюу ажил гүйлгээ цаашид оршин байхгүй эсвэл цаашид гарч тохиолдохоор хүлээгдээгүй гэсэн утгыг заавал илэрхийлэхгүй, харин тэдгээр зүйлс нь тухайн хейжийн харилцааны нэг хэсэг биш болох юм. Жишээлбэл; хейжийн хэрэглүүрийн тоо хэмжээг бууруулснаар тухайн байгууллага уг үүсмэл хэрэглүүрээ хадгалсан

хэвээр байх боловч түүний зөвхөн зарим хэсэг нь тэрхүү хейжийн харилцааны хувьд хейжийн хэрэглүүр хэвээр үлдэж болох юм. Хейжийн харилцаан дахь хейжийн хэрэглүүрийн тоо хэмжээг зөвхөн бууруулснаар дахин тэнцвэржүүлэлтийг хийж болох боловч цаашид шаардлагагүй тийм тоо хэмжээг тухайн байгууллага хадгалж үлдсэн бол ийм тохиолдол үүсэж болно. Ийм тохиолдолд үүсмэл хэрэглүүрийн сонгоогүй байгаа тэрхүү хэсгийг (үүнийг өөр хейжийн харилцаанд хейжийн хэрэглүүр гэж сонгосноос бусад тохиолдолд) ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр тайлагнана.

- МЗУ310. Хейжийн зүйлийн тоо хэмжээг нэмэгдүүлэх замаар хейжийн харьцааг тохируулах нь хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг хэрхэн хэмжихэд нөлөө үзүүлэхгүй. Өмнө сонгосон тоо хэмжээтэй холбоотой уг хейжийн зүйлийн үнэ цэнэд гарсан өөрчлөлтийн хэмжилт нь мөн нөлөө үзүүлэхгүй хэвээр байна. Харин дахин тэнцвэржүүлэлтийн өдрөөс хойш хейжийн зүйлийн үнэ цэнэд гарсан өөрчлөлт нь тухайн хейжийн зүйлийн нэмэлт тоо хэмжээний үнэ цэнийн өөрчлөлтийг бас агуулсан байдаг. Эдгээр өөрчлөлтүүдийг уг хейжийн харилцааг сонгосон өдрөөс биш, харин дахин тэнцвэржүүлэлтийн өдрөөс эхлэн тэрхүү тэнцвэржүүлэлтийг харгалзсанаар хэмждэг. Жишээлбэл; байгууллага нь 80ТН-ийн форвард үнээр (хейжийн харилцааны эхэн дэх форвард үнээр) анх 100 тонн бараанд хейж хийсэн ба дахин тэнцвэржүүлэхдээ 10 тонноор нэмэгдүүлсэн бөгөөд энэ үед форвард үнэ 90ТН байсан бол дахин тэнцвэржүүлэлтийн дараах уг хейжийн зүйл нь 80ТН-ээр хейж хийсэн 100 тонн бараа ба 90ТН-ээр хейж хийсэн 10 тонн бараа гэсэн хоёр давхаргаас бүрдэнэ.
- МЗУ311. Хейжийн хэрэглүүрийн тоо хэмжээг бууруулах замаар хейжийн харьцааг тохируулах нь хейжийн зүйлийн үнэ цэнийн өөрчлөлтийг хэрхэн хэмжихэд нөлөө үзүүлэхгүй. Үргэлжлүүлэн сонгох тоо хэмжээтэй холбоотой уг хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэд гарсан өөрчлөлтийн хэмжилт нь мөн нөлөө үзүүлэхгүй хэвээр байна. Харин дахин тэнцвэржүүлэлтийн өдрөөс хойш тухайн хейжийн хэрэглүүрийг бууруулсан тоо хэмжээ нь цаашид уг хейжийн харилцааны нэг хэсэг болохгүй. Жишээлбэл; байгууллага нь хейжийн хэрэглүүр болгон 100 тонн тоо хэмжээ бүхий үүсмэл хэрэглүүрийг ашигласнаар тухайн барааны үнийн эрсдэлд анх хейж хийсэн бөгөөд дахин тэнцвэржүүлэлтээр тоо хэмжээг 10 тонноор бууруулсан бол уг 90 тонн хейжийн хэрэглүүрийн нэрлэсэн дүн нь хэвээр үлдэнэ (цаашид хейжийн харилцааны нэг хэсэг болохгүй тоо хэмжээний (өөрөөр хэлбэл, 10 тонн) үүсмэл хэрэглүүрийн үр дагаврын талаар МЗУ309-р параграфас үзнэ үү).
- МЗУ312. Хейжийн хэрэглүүрийн тоо хэмжээг нэмэгдүүлэх замаар хейжийн харьцааг тохируулах нь хейжийн зүйлийн үнэ цэнийн өөрчлөлтийг хэрхэн хэмжихэд нөлөө үзүүлэхгүй. Өмнө сонгосон тоо хэмжээтэй холбоотой уг хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэд гарсан өөрчлөлтийн хэмжилт нь мөн нөлөө үзүүлэхгүй хэвээр байна. Харин дахин тэнцвэржүүлэлтийн өдрөөс хойш хейжийн хэрэглүүрийн үнэ цэнэд гарсан өөрчлөлт нь тухайн хейжийн хэрэглүүрийн нэмэлт тоо хэмжээний үнэ цэнийн өөрчлөлтийг бас агуулсан байдаг. Эдгээр өөрчлөлтүүдийг уг хейжийн харилцааг сонгосон өдрөөс биш, харин дахин тэнцвэржүүлэлтийн өдрөөс эхлэн тэрхүү тэнцвэржүүлэлтийг харгалзсанаар хэмждэг. Жишээлбэл; байгууллага нь хейжийн хэрэглүүр болгон 100 тонн тоо хэмжээ бүхий үүсмэл хэрэглүүрийг ашигласнаар тухайн барааны үнийн эрсдэлд анх хейж хийсэн бөгөөд дахин тэнцвэржүүлэлтээр тоо хэмжээг 10 тонноор нэмэгдүүлсэн бол дахин тэнцвэржүүлэлтийн дараах хейжийн хэрэглүүр нь нийт 110 тонн тоо хэмжээ бүхий үүсмэл хэрэглүүрээс бүрдэнэ. Тухайн хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт нь нийт 110 тонн тоо хэмжээнээс бүрдэх үүсмэл хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнийн ерөнхий өөрчлөлт байна. Эдгээр үүсмэл хэрэглүүрүүдийг өөр өөр цаг хугацаанд үүсгэсэн (үүн дотроо: анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа тэдгээр үүсмэл хэрэглүүрүүдийг хейжийн харилцаанд сонгох боломжит байдал) учраас форвард хувь хэмжээ гэх мэт чухал нөхцлүүд нь ялгаатай байж болно (ялгаатай байх нэлээд их магадлалтай).
- МЗУ313. Хейжийн зүйлийн тоо хэмжээг бууруулах замаар хейжийн харьцааг тохируулах нь хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг хэрхэн хэмжихэд нөлөө үзүүлэхгүй. Үргэлжлүүлэн сонгох тоо хэмжээтэй холбоотой уг хейжийн зүйлийн үнэ цэнэд гарсан өөрчлөлтийн хэмжилт нь мөн нөлөө үзүүлэхгүй хэвээр байна. Харин дахин тэнцвэржүүлэлтийн өдрөөс хойш тухайн хейжийн зүйлийг бууруулсан тоо хэмжээ нь цаашид уг хейжийн

харилцааны нэг хэсэг болохгүй. Жишээлбэл; байгууллага нь 80ТН-ийн форвард үнээр анх 100 тонн бараанд хейж хийсэн ба дахин тэнцвэржүүлэхдээ тоо хэмжээг 10 тонноор бууруулсан бол дахин тэнцвэржүүлэлтийн дараах уг хейжийн зүйл нь 80ТН-ээр хейж хийсэн 90 тонн бараа байна. Цаашид хейжийн харилцааны нэг хэсэг болохгүй уг 10 тонн хейжийн зүйлийг хейжийн нягтлан бодох бүртгэлийг зогсоох шаардлагуудын дагуу тайлагнана (135-136-р параграф болон МЗУ315-МЗУ321-р параграфыг үзнэ үү).

МЗУ314. Хейжийн харилцааг дахин тэнцвэржүүлэх үед байгууллага нь тухайн хейжийн харилцааны (үлдэж буй) хугацаанд түүнд нөлөө үзүүлэхээр хүлээгдэж буй хейжийн үр дүнгүй байдлын эх сурвалжийн талаархи өөрийн шинжилгээг шинэчлэн баяжуулна (МЗУ276-р параграфыг үзнэ үү). Хейжийн харилцааны баримтжуулалтыг зохих ёсоор шинэчлэн баяжуулах хэрэгтэй.

Хейжийн нягтлан бодох бүртгэлийг зогсоох

МЗУ315. Хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг цаашид хангахгүй болсон өдрөөс эхлэн хейжийн нягтлан бодох бүртгэлийг зогсоосон үйл явдлыг гүйцээх горимоор тайлагнана.

МЗУ316. Байгууллага нь дараах хейжийн харилцааг үл сонгож, ингэснээр зогсоох ёсгүй:

- (а) Хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангах үндэслэл болж буй эрсдлийн удирдлагын зорилгыг хангасаар байгаа (өөрөөр хэлбэл, байгууллага нь эрсдлийн удирдлагын зорилгыг биелүүлсээр байгаа);
- (б) Бусад бүх шалгуурыг (хэрэв хамааралтай бол хейжийн харилцааны аливаа дахин тэнцвэржүүлэлтийг харгалзан үзсэний дараа) хангасан хэвээр байгаа.

МЗУ317. Энэ Стандартын зорилгын хувьд, байгууллагын эрсдлийн удирдлагын стратегийг түүний эрсдлийн удирдлагын зорилгоос ялган авч үздэг. Байгууллага нь өөрийн эрсдлийг хэрхэн удирдахыг тодорхойлдог хамгийн дээд түвшинд энэхүү эрсдлийн удирдлагын стратегийг тогтоодог. Эрсдлийн удирдлагын стратеги нь байгууллагад учрах эрсдлийг үндсэндээ тодорхойлдог түүнд тухайн байгууллага хэрхэн хариу үзүүлэхийг тогтоодог. Эрсдлийн удирдлагын стратегийг ихэвчлэн урт хугацаагаар гаргадаг бөгөөд тэрхүү стратегийг боловсруулах явцад гарч тохиолдох нөхцөл байдлын өөрчлөлтүүдэд хариу үзүүлэх зарим уян хатан шинжийг (тухайлбал; янз бүрийн хейж үүсгэхэд хүргэх өөр өөр хүүний хувь хэмжээ буюу бараа бүтээгдэхүүний үнийн түвшинг) тусгасан байж болох юм. Үүнийг ихэвчлэн ерөнхий баримт бичигт тусгах бөгөөд байгууллагуудаар болон илүү тусгайлсан заавар удирдамжийг агуулах бодлогуудаар цааш салбарлан задардаг. Харин хейжийн харилцаанд хамаарах эрсдлийн удирдлагын зорилгыг тухайн тодорхой хейжийн харилцааны түвшинд баримталдаг. Энэ нь хейжийн зүйл гэж сонгосон тодорхой эрсдэлд хейж хийхийн тулд сонгосон тухайн хейжийн хэрэглүүрийг хэрхэн ашиглахтай холбоотой байдаг. Иймээс эрсдлийн удирдлагын стратеги нь тэрхүү эрсдлийн удирдлагын ерөнхий стратегийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрсдлийн удирдлагын зорилго бүхий янз бүрийн, олон хейжийн харилцааг хамарсан байж болно. Тухайлбал;

- (а) Байгууллага нь өрийн санхүүжилтэнд үзүүлэх хүүний түвшний эрсдлийг удирдах стратегитай бөгөөд энэ нь хувьсах ба тогтмол хүүтэй санхүүжилтийн хоорондох бүтцийн хувьд тухайн байгууллагад ерөнхийдөө хамаарах мужийг тогтоодог. Уг стратегийн дагуу тогтмол хүүтэй өрийг нийт өрийн 20-иос 40 хувийн хооронд байлгадаг. Байгууллага нь энэ стратегийг хэрхэн хэрэгжүүлэхээ (өөрөөр хэлбэл, нийт өрийн 20-40 хувийн хооронд тогтмол хүүний эрсдэл хүлээх) хүүний хувь хэмжээнээс хамааран тухайн үед шийдвэрлэдэг. Хэрэв хүүний хувь хэмжээ бага байвал байгууллага нь хүүний хувь хэмжээ өндөр байх үеийнхээс илүү их өр төлбөрийн хувьд хүүг тогтмол хувь хэмжээтэй болгодог. Байгууллага нь хувьсах хүүтэй 100ТН-ийн өртэй бөгөөд үүний 30ТН-ийн өрийг тогтмол хүүтэй болгох свопын гэрээ байгуулсан. Байгууллага нь томоохон хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхийн тулд нэмэлт 50ТН-ийн өрийн хэрэглүүр гаргаж, хүүний хувь хэмжээ бага байгаа давуу талыг ашиглах бөгөөд тогтмол хүүтэй бонд гаргаснаар үүнийг хэрэгжүүлнэ. Хүүний хувь хэмжээ бага байгааг харгалзан байгууллага нь өмнө хейж хийсэн өөрийн хувьсах хүүний түвшний эрсдлийн хэмжээг 20ТН-ээр

бууруулж, тогтмол хүүний хувь хэмжээний эрсдлийг нийт өрийн 40 хувиар тогтоох шийдвэр гаргасан бөгөөд үүний үр дүнд тогтмол хүүний хувь хэмжээний эрсдэл 60ТН болсон. Энэ тохиолдолд уг эрсдлийн удирдлагын стратеги нь өөрчлөгдөхгүй хэвээр байна. Харин тэрхүү стратегийн хэрэгжүүлэлт өөрчлөгдсөн, энэ нь өмнө хейж хийж байсан хувьсах хүүний хувь хэмжээтэй, 20ТН-ийн эрсдлийн хувьд эрсдлийн удирдлагын зорилго (өөрөөр хэлбэл, хейжийн харилцааны түвшинд) өөрчлөгдсөн гэсэн үг юм. Иймээс энэ тохиолдолд өмнө хейж хийж байсан хувьсах хүүний хувь хэмжээтэй, 20ТН-ийн эрсдлийн хувьд хейжийн нягтлан бодох бүртгэлийг зогсоох ёстой. Үүний үр дүнд свопын дүнг 20ТН-ийн нэрлэсэн дүнгээр бууруулж болох боловч тухайн нөхцөл байдлаас хамааран байгууллага нь тэрхүү свопын хэмжээг хэвээр хадгалж болох юм. Тухайлбал; янз бүрийн эрсдэлд хейж хийхийн тулд ашиглах эсвэл энэ нь арилжааны багцын нэг хэсэг болж болох юм. Харин эсрэгээр, байгууллага нь өөрийн тогтмол хүүтэй шинэ өрийн зарим хэсгийг хувьсах хүүний хувь хэмжээний эрсдэлтэй болгох свопын гэрээ байгуулсан бол уг өмнө хейж хийж байсан хувьсах хүүний эрсдлийн хувьд хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэвээр үргэлжлүүлэх шаардлагатай болно.

- (б) Байнга өөрчлөгддөг төлөв байдлуудын улмаас зарим эрсдэл үүсдэг. Жишээлбэл; өрийн хэрэглүүрийн нээлттэй багцын хүүний хувь хэмжээний эрсдэл. Шинэ өрийн хэрэглүүрийн нэмэгдэлт болон өрийн хэрэглүүрийн үл хүлээн зөвшөөрөлт нь тийм эрсдлийг байнга өөрчилж байдаг (өөрөөр хэлбэл, энэ нь дуусгавар хугацаа болохын хэрээр аажим буурах эрсдлийн төлөв байдлаас өөр юм). Энэ нь тухайн эрсдэл ба түүнийг удирдахын тулд ашиглаж буй хейжийн хэрэглүүрийн аль аль нь удаан хугацаанд тэр хэвээр байдаггүй, байнга хувьсан өөрчлөгддөг үйл явц юм. Үүний үр дүнд ийм эрсдэл бүхий байгууллага нь тухайн эрсдэл өөрчлөгдөхийн хэрээр өөрийн хүүний түвшний эрсдлийг удирдахын тулд ашиглаж буй хейжийн хэрэглүүрээ байнга тохируулдаг. Жишээлбэл; дуусгавар болоход 24 сарын хугацаа үлдсэн өрийн хэрэглүүрийг тэрхүү 24 сарын туршид хүүний түвшний эрсдлийн хувьд хейжийн зүйл гэж сонгосон. Хугацааны бусад муж буюу дуусгавар болох хугацааны хувьд энэхүү горимыг мөрддөг. Байгууллага нь дуусгавар болох хүртэлх хугацаагаар өмнө сонгосон бүх буюу зарим хейжийн харилцааг тодорхой богино хугацааны дараа зогсоож, шинэ хейжийн харилцааг түүний хэмжээ болон тухайн үед оршин буй хейжийн хэрэглүүрт үндэслэн дуусгавар болох хүртэлх хугацаагаар сонгодог. Ингэж хейжийн нягтлан бодох бүртгэлийг цаашид хэрэглэхгүй, зогсоож байгаа нь уг өмнө сонгосон хейжийн хэрэглүүр ба хейжийн зүйлээс хамааралгүй, харин шинэ хейжийн хэрэглүүр ба шинэ хейжийн зүйлийг тухайн байгууллага харгалзан үзснээр хейжийн харилцааг тогтоосон гэдгийг илэрхийлнэ. Эрсдлийн удирдлагын стратеги нь хэвээрээ байх боловч цаашид оршин байхааргүй болсон, уг өмнө сонгосон хейжийн харилцааны хувьд үргэлжлүүлэн баримтлах эрсдлийн удирдлагын зорилго байхгүй юм. Ийм нөхцөлд эрсдлийн удирдлагын зорилго өөрчлөгдсөн хэмжээгээр хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэхгүй зогсооно. Энэ нь тухайн байгууллагын нөхцөл байдлаас хамаарах бөгөөд жишээлбэл, дуусгавар болох хүртэлх хугацааны бүх эсвэл зөвхөн зарим хейжийн харилцаанд эсвэл хейжийн харилцааны зөвхөн тодорхой нэг хэсэгт нөлөөлж болох юм.
- (в) Байгууллага нь урьдчилан таамагласан борлуулалт ба түүний үр дүн болох авлагын гадаад валютын эрсдлийг удирдан зохицуулах эрсдлийн удирдлагын стратегитай. Энэхүү стратегийн хүрээнд байгууллага нь уг гадаад валютын эрсдлийг зөвхөн авлага хүлээн зөвшөөрөх өдөр хүртэл тодорхой хейжийн харилцаа байдлаар удирдан зохицуулдаг. Үүнээс хойш байгууллага нь тэрхүү тодорхой хейжийн харилцаанд үндэслэн гадаад валютын эрсдлийг удирдан зохицуулахгүй. Харин байгууллага нь тухайн гадаад валютаар илэрхийлэгдсэн авлага, өглөг, үүсмэл хэрэглүүрээс (одоогоор хүлээгдэж буй урьдчилан таамагласан ажил гүйлгээтэй холбоогүй) үүсэх гадаад валютын эрсдлийг хамтад нь удирдана. Эдгээр бүх зүйлсийн гадаад валютын эрсдлээс үүсэх олз, гарзыг ашиг, алдагдалд нэн даруй хүлээн зөвшөөрдөг учраас энэ нь нягтлан бодох бүртгэлийн зорилгын хувьд “ердийн” хейжийн үүрэг гүйцэтгэдэг. Иймээс нягтлан бодох бүртгэлийн зорилгоор уг хейжийн харилцааг төлбөр хийх хүртэлх хугацаагаар сонгосон бол авлага хүлээн зөвшөөрсөн үед энэхүү хейжийн харилцааг зогсоох ёстой. Яагаад гэвэл, уг анхны хейжийн харилцааны эрсдлийн удирдлагын зорилгыг цаашид

баримтлахгүй юм. Гадаад валютын эрсдлийг одоо тухайн стратегийн хүрээнд, гэхдээ өөр сууриар удирдан зохицуулна. Харин эсрэгээр, байгууллага нь эрсдлийн удирдлагын өөр зорилготой бөгөөд гадаад валютын эрсдлийг, ялангуяа тэрхүү урьдчилан таамагласан борлуулалтын дүн болон түүний үр дүн болох авлагын хувьд тухайн барагдуулах өдөр хүртэл нэг тасралтгүй хейжийн харилцаа байдлаар удирдан зохицуулах бол хейжийн нягтлан бодох бүртгэлийг уг өдөр хүртэл хэвээр үргэлжлүүлнэ.

МЗУ318. Хейжийн нягтлан бодох бүртгэлийг зогсоох нь дараах зүйлсэд нөлөө үзүүлж болох юм:

- (а) Нийт хейжийн харилцаанд;
- (б) Хейжийн харилцааны зарим хэсэгт (энэ нь тухайн хейжийн харилцааны үлдэж байгаа хэсэгт хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэвээр үргэлжлүүлнэ гэсэн үг юм).

МЗУ319. Хейжийн харилцаа нь бүхэлдээ тухайн шалгуурыг хангахаа больсон үед хейжийн харилцааг зогсоодог. Жишээлбэл:

- (а) Хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангах үндэслэл болж буй эрсдлийн удирдлагын зорилгыг уг хейжийн харилцаа нь цаашид хангахгүй болсон (өөрөөр хэлбэл, байгууллага нь эрсдлийн удирдлагын зорилгыг биелүүлэхгүй болсон);
- (б) Хейжийн хэрэглүүр буюу хэрэглүүрүүдийг (нийт тоо хэмжээтэй харьцуулахад уг хейжийн харилцааны тодорхой нэг хэсгийг) борлуулсан эсвэл холбогдох гэрээ, хэлцлийг цуцалсан;
- (в) Хейжийн зүйл ба хейжийн хэрэглүүрийн хооронд цаашид эдийн засгийн харилцан хамааралгүй болсон эсвэл зээлийн эрсдлийн үр нөлөө нь тухайн эдийн засгийн харилцан хамаарлаас үүсэх үнэ цэнийн өөрчлөлтөөс илүү, давамгайлж эхэлсэн.

МЗУ320. Хейжийн харилцааны зөвхөн зарим хэсэг нь тухайн шалгуурыг хангахаа больсон тохиолдолд хейжийн харилцааны зарим хэсгийг зогсооно (түүний үлдсэн хэсгийн хувьд хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэвээр үргэлжлүүлнэ). Жишээлбэл:

- (а) Хейжийн харилцааг дахин тэнцвэржүүлэх үед уг хейжийн зүйлийн зарим тоо хэмжээ нь цаашид тухайн хейжийн харилцааны нэг хэсэг болохгүй тийм арга замаар уг хейжийн харьцааг тохируулж болох юм (МЗУ313-р параграфыг үзнэ үү); иймээс цаашид хейжийн харилцааны нэг хэсэг болохгүй уг хейжийн зүйлийн зөвхөн тэдгээр тоо хэмжээний хувьд хейжийн нягтлан бодох бүртгэлийг зогсооно;
- (б) Урьдчилан таамагласан ажил гүйлгээ (эсвэл түүний бүрэлдэхүүн хэсэг) болох тухайн хейжийн зүйлийн зарим тоо хэмжээ нь цаашид гарч тохиолдох өндөр магадлалтай байхаа больсон бол уг хейжийн зүйлийн гарч тохиолдох магадлал нь өндөр байхаа больсон зөвхөн тэрхүү тоо хэмжээний хувьд хейжийн нягтлан бодох бүртгэлийг зогсооно. Гэвч байгууллага нь урьдчилан таамагласан ажил гүйлгээний хейжийг сонгодог бөгөөд тэрхүү урьдчилан таамагласан ажил гүйлгээ цаашид гарч тохиолдоно гэж хүлээхээргүй болсныг дараагийн тайлант үед тодорхойлдог түүхэн туршлагатай бол урьдчилан таамагласан ажил гүйлгээг үнэн зөв төсөөлөх тухайн байгууллагын чадвар нь урьдчилан таамагласан ижил төсөөтэй ажил гүйлгээг төсөөлөх үед эргэлзээ төрүүлэхүйц болдог. Ийм байдал нь урьдчилан таамагласан ижил төсөөтэй ажил гүйлгээ гарч тохиолдох өндөр магадлалтай эсэх (124-р параграфыг үзнэ үү), ингэснээр хейжийн зүйл болох шалгуурыг хангах эсэх талаархи үнэлгээнд нөлөөлдөг.

МЗУ321. Хейжийн нягтлан бодох бүртгэлийг (бүхэлд нь, эсвэл түүний зарим хэсгийн хувьд) зогсоосон өмнөх хейжийн харилцааны хувьд хейжийн хэрэглүүр эсвэл хейжийн зүйл байсан, тэрхүү хейжийн хэрэглүүр эсвэл хейжийн зүйлийг өөртөө агуулсан шинэ хейжийн харилцааг байгууллага нь сонгож болно. Энэ нь хейжийн харилцааны үргэлжлэл биш, харин дахин эхлэл юм. Жишээлбэл:

- (а) Хейжийн хэрэглүүрийн зээлийн үнэлэмж ноцтой муудсан ба байгууллага нь түүнийг шинэ хейжийн хэрэглүүрээр сольсон. Энэ нь тухайн анхны хейжийн хэрэглүүр өөрийн

эрсдлийн удирдлагын зорилгыг биелүүлж чадаагүй, иймээс түүнийг бүхэлд нь зогсоосон гэсэн үг юм. Шинэ хейжийн хэрэглүүрийг өмнө нь хейж хийж байсан тухайн эрсдлийн хейж гэж сонгосон бөгөөд ингэснээр хейжийн шинэ харилцааг үүсгэдэг. Иймээс уг хейжийн зүйлийн бодит үнэ цэнийн эсвэл мөнгөн гүйлгээний өөрчлөлтийг анхны хейжийн харилцааг сонгосон өдрөөс биш, харин шинэ хейжийн харилцааг сонгосон өдрөөс эхлэн түүнийг лавлагаа болгосноор хэмждэг.

- (б) Хейжийн харилцааг түүний хугацааны эцэс болохоос өмнө зогсоосон. Тухайн хейжийн харилцаан дахь хейжийн хэрэглүүрийг өөр хейжийн харилцаанд хейжийн хэрэглүүр гэж сонгож болно (тухайлбал; хейжийн хэрэглүүрийн тоо хэмжээг нэмэгдүүлэх замаар дахин тэнцвэржүүлэх үед уг хейжийн харьцааг тохируулах эсвэл бүхэлдээ шинэ хейжийн харилцааг сонгох үед).

Опционы цаг хугацааны үнэ цэнийн нягтлан бодох бүртгэл

МЗУ322. Опционы цаг хугацааны үнэ цэнэ нь уг опционы эзэмшигчид тодорхой хугацааны туршид хамгаалалт бүрдүүлэх төлбөрийг илэрхийлдэг учраас опционыг цаг хугацаатай холбоотой байдлаар авч үзэж болно. Гэвч опцион нь ажил гүйлгээтэй эсвэл цаг хугацаатай холбоотой хейжийн зүйлд хейж хийж буй эсэхийг үнэлэх зорилгын хувьд хамааралтай асуудал нь уг хейжийн зүйлийн шинж чанар, үүн дотроо энэ нь ашиг, алдагдалд хэзээ, хэрхэн нөлөөлөх байдал юм. Иймээс байгууллага нь хейжийн зүйлийн шинж төрөлд үндэслэн (хейжийн харилцаа нь мөнгөн гүйлгээний хейж эсвэл бодит үнэ цэнийн хейж эсэхээс үл хамааран) тухайн хейжийн зүйлийн төрөл, хэлбэрийг үнэлдэг (144(а) параграфыг үзнэ үү):

- (а) Хэрэв хейжийн зүйлийн төрөл нь ажил гүйлгээ бөгөөд түүний хувьд цаг хугацааны үнэ цэнэ нь тухайн ажил гүйлгээний зардал болох тийм шинж чанартай бол опционы цаг хугацааны үнэ цэнэ нь ажил гүйлгээтэй холбоотой хейжийн зүйлд хамааралтай байна. Анхны хэмжилтэндээ ажил гүйлгээний зардлыг багтаасан тийм зүйлийг хүлээн зөвшөөрөхөд хүргэх хейжийн зүйлтэй уг опционы цаг хугацааны үнэ цэнэ холбоотой байх нь үүний нэг жишээ юм (жишээлбэл; урьдчилан таамагласан ажил гүйлгээ эсвэл арилжааны баталгаа эсэхээс үл хамааран байгууллага нь барааны үнийн эрсдлийн хувьд бараа бүтээгдэхүүний худалдан авалтанд хейж хийдэг бөгөөд ажил гүйлгээний зардлыг тухайн бараа материалын анхны хэмжилтэнд тусган оруулдаг). Опционы цаг хугацааны үнэ цэнийг хейжийн зүйлийн анхны хэмжилтэнд оруулсны үр дүнд уг цаг хугацааны үнэ цэнэ нь тухайн хугацааны ашиг, алдагдалд тэрхүү хейжийн зүйлийн адилаар нөлөө үзүүлнэ. Үүнтэй адилаар, урьдчилан таамагласан ажил гүйлгээ эсвэл арилжааны баталгаа эсэхээс үл хамааран барааны борлуулалтын хувьд хейж хийдэг байгууллага нь уг опционы цаг хугацааны үнэ цэнийг тухайн борлуулалттай холбоотой өртгийн нэг хэсэг байдлаар тусган оруулна (ингэснээр уг хейж хийсэн борлуулалтаас үүсэх орлогыг хүлээн зөвшөөрөх тайлант үед энэхүү цаг хугацааны үнэ цэнийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө).
- (б) Хэрэв хейжийн зүйлийн төрөл нь тодорхой хугацааны туршид эрсдлээс хамгаалах хамгаалалтыг олж авах зардал болох тийм шинж чанар бүхий цаг хугацааны үнэ цэнэ бол опционы цаг хугацааны үнэ цэнэ нь цаг хугацаатай холбоотой хейжийн зүйлд хамааралтай байна (гэхдээ тухайн хейжийн зүйл нь дээрх (а)-д дурдсанчлан, ажил гүйлгээний зардлыг багтаасан тийм ажил гүйлгээг үүсгэхгүй). Жишээлбэл; зургаан сарын хугацаанд бодит үнэ цэнийн бууралтаас хамгаалахын тулд адилтгах хугацаа бүхий бараа бүтээгдэхүүний опционыг ашигласнаар бараанд хейж хийсэн бол уг опционы цаг хугацааны үнэ цэнийг тэрхүү зургаан сарын хугацаанд ашиг, алдагдалд хуваарилна (өөрөөр хэлбэл, системчилсэн ба ул үндэслэлтэй сууриар хорогдуулна). Өөр нэг жишээ нь; гадаад валютын арилжааны опционыг ашигласнаар гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтанд 18-н сарын хугацаатай хийсэн хейж бөгөөд уг опционы цаг хугацааны үнэ цэнийг тэрхүү 18-н сарын хугацаанд хуваарилах юм.

МЗУ323. Хейжийн зүйлийн шинж чанар, үүн дотроо ашиг, алдагдалд уг хейжийн зүйл хэзээ, хэрхэн нөлөөлөх эсэх нь цаг хугацаатай холбоотой хейжийн зүйлд хейж хийж буй тухайн опционы цаг хугацааны үнэ цэнийг хорогдуулах хугацаанд мөн нөлөө үзүүлдэг. Тэрхүү хорогдуулах хугацаа

нь уг опционы дотоод үнэ цэнэ хейжийн нягтлан бодох бүртгэлийн дагуу ашиг, алдагдалд нөлөө үзүүлэх хугацаатай нийцсэн байна. Жишээлбэл; хөвөгч хүүтэй бондын хүүний зардлын нэмэгдэлтээс хамгаалахын тулд хүүний түвшний опционыг (хүүний түвшний дээд хэмжээ) ашигладаг бол уг хүүний түвшний дээд хэмжээний аливаа дотоод үнэ цэнэ нь ашиг, алдагдалд нөлөө үзүүлэх хугацаатай ижил хугацаанд тэрхүү дээд хэмжээний цаг хугацааны үнэ цэнийг хорогдуулж, ашиг, алдагдалд тусгана:

- (a) Хэрэв хүүний түвшний дээд хэмжээ нь хөвөгч хүүтэй бондын таван жилийн нийт хугацаанаас эхний гурван жилийн хугацаан дахь хүүний түвшний өсөлтийн хувьд хейж хийдэг бол тэрхүү хүүний түвшний дээд хэмжээний цаг хугацааны үнэ цэнийг уг эхний гурван жилийн туршид хорогдуулна; эсвэл
- (б) Хэрэв хүүний түвшний дээд хэмжээ нь хойшлуулан эхлэх сонголтой, өөрөөр хэлбэл таван жилийн хугацаатай, хөвөгч хүүтэй бондын нийт хугацаанаас хоёр ба гурав дахь жилийн хүүний түвшний өсөлтийн хувьд хейж хийдэг бол уг хүүний түвшний дээд хэмжээний цаг хугацааны үнэ цэнийг тэрхүү хоёр ба гурав дахь жилийн туршид хорогдуулна.

МЗУ324. Хейжийн хэрэглүүр гэж сонгосон өдрөөр цаг хугацааны тэг цэвэр үнэ цэнэтэй байх уг гаргасан ба худалдан авсан опционы (нэг нь буцаах опцион, нөгөө нь дуудах опцион байна) нийлмэл хэрэглүүрийн (ихэвчлэн ‘тэг өртөгтэй хүүний түвшний баталгаа’ гэж нэрлэдэг) хувьд 144-р параграфт заасан, опционы цаг хугацааны үнэ цэнийн нягтлан бодох бүртгэлийг бас дагаж мөрдөнө. Энэ тохиолдолд хэдийгээр хейжийн харилцааны нийт хугацаан дахь цаг хугацааны үнэ цэнийн хуримтлагдсан өөрчлөлт нь тэг байх боловч байгууллага нь цаг хугацааны үнэ цэнийн аливаа өөрчлөлтийг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө. Иймээс хэрэв опционы цаг хугацааны үнэ цэнэ нь:

- (a) Ажил гүйлгээтэй холбоотой хейжийн зүйлд хамааралтай бол уг хейжийн зүйлийн дансны үнэд тохируулагддаг эсвэл ашиг, алдагдалд дахин ангилагддаг цаг хугацааны үнэ цэнийн дүн нь тухайн хейжийн харилцааны эцэст тэг байна (144(б) параграфыг үзнэ үү).
- (б) Цаг хугацаатай холбоотой хейжийн зүйлд хамааралтай бол уг цаг хугацааны үнэ цэнэтэй холбоотой хорогдуулгын зардал нь тэг байна.

МЗУ325. Опционы цаг хугацааны үнэ цэнэ нь хейжийн зүйлтэй холбоотой байх зөвхөн тэр хэмжээний (тохирох цаг хугацааны үнэ цэнийн) хувьд 144-р параграфт заасан, опционы цаг хугацааны үнэ цэнийн нягтлан бодох бүртгэлийг дагаж мөрдөнө. Опционы чухал нөхцлүүд (нэрлэсэн дүн, хугацаа, суурь хэрэглүүр гэх мэт) нь тухайн хейжийн зүйлтэй тохирч байвал опционы цаг хугацааны үнэ цэнэ нь уг хейжийн зүйлтэй холбоотой байдаг. Иймээс опционы чухал нөхцлүүд ба тухайн хейжийн зүйл нь хоорондоо бүрэн тохирохгүй байвал байгууллага нь тохирох цаг хугацааны үнэ цэнийг тодорхойлно. Өөрөөр хэлбэл, уг нэмэгдэл дүнд (бодит цаг хугацааны үнэ цэнэд) багтсан цаг хугацааны үнэ цэнээс хичнээн дүн нь тухайн хейжийн зүйлд хамааралтай эсэхийг тодорхойлно (ингэснээр 144-р параграфын дагуу тайлагнана). Байгууллага нь уг хейжийн зүйлтэй төгс уялдах чухал нөхцлүүд бүхий опционы үнэлгээг ашигласнаар тухайн тохирох цаг хугацааны үнэ цэнийг тодорхойлно.

МЗУ326. Бодит цаг хугацааны үнэ цэнэ ба тохирох цаг хугацааны үнэ цэнэ нь өөр байвал байгууллага нь 144-р параграфын дагуу өмчийн тусдаа бүрэлдэхүүн хэсэгт хуримтлуулан бүртгэх дүнг дараах байдлаар тодорхойлно:

- (a) Хэрэв хейжийн харилцааны эхэнд уг бодит цаг хугацааны үнэ цэнэ нь тохирох цаг хугацааны үнэ цэнээс их бол байгууллага нь:
 - (i) Өмчийн тусдаа бүрэлдэхүүн хэсэгт хуримтлуулан бүртгэх дүнг тэрхүү тохирох цаг хугацааны үнэ цэнэд үндэслэн тодорхойлно;
 - (ii) Эдгээр цаг хугацааны хоёр үнэ цэнийн хоорондох бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүсэх зөрүүг ашиг, алдагдалд тайлагнана.

- (б) Хэрэв хейжийн харилцааны эхэнд уг бодит цаг хугацааны үнэ цэнэ нь тохирох цаг хугацааны үнэ цэнээс бага бол байгууллага нь дараах хоёр цаг хугацааны үнэ цэнийн үр дүн болох бодит үнэ цэнийн хуримтлагдсан өөрчлөлтийн аль багад үндэслэн өмчийн тусдаа бүрэлдэхүүн хэсэгт хуримтлуулан бүртгэх дүнг тодорхойлно:
- (i) Бодит цаг хугацааны үнэ цэнэ; ба
 - (ii) Тохирох цаг хугацааны үнэ цэнэ.

Бодит цаг хугацааны үнэ цэнийн үр дүн болох уг бодит үнэ цэнийн өөрчлөлтийн аливаа үлдсэн дүнг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Форвард гэрээний форвард элементийн болон санхүүгийн хэрэглүүрийн гадаад валютын суурийн тархалтын нягтлан бодох бүртгэл

МЗУ327. Форвард гэрээний форвард элемент нь цаг хугацааны (түүнийг тодорхойлж буй ерөнхий хугацааны) төлбөрийг илэрхийлдэг учраас форвард гэрээг цаг хугацаатай холбоотой байдлаар авч үзэж болно. Гэвч хейжийн хэрэглүүр нь ажил гүйлгээтэй эсвэл цаг хугацаатай холбоотой хейжийн зүйлд хейж хийж буй эсэхийг үнэлэх зорилгын хувьд хамааралтай асуудал нь уг хейжийн зүйлийн шинж чанар, үүн дотроо энэ нь ашиг, алдагдалд хэзээ, хэрхэн нөлөөлөх байдал юм. Иймээс байгууллага нь хейжийн зүйлийн шинж төрөлд үндэслэн (хейжийн харилцаа нь мөнгөн гүйлгээний хейж эсвэл бодит үнэ цэнийн хейж эсэхээс үл хамааран) тухайн хейжийн зүйлийн төрөл, хэлбэрийг үнэлдэг (144(а) ба 145-р параграфыг үзнэ үү):

- (а) Хэрэв хейжийн зүйлийн төрөл нь ажил гүйлгээ бөгөөд түүний хувьд форвард элемент нь тухайн ажил гүйлгээний зардал болох тийм шинж чанартай бол форвард гэрээний форвард элемент нь ажил гүйлгээтэй холбоотой хейжийн зүйлд хамааралтай байна. Анхны хэмжилтэндээ ажил гүйлгээний зардлыг багтаасан тийм зүйлийг хүлээн зөвшөөрөхөд хүргэх хейжийн зүйлтэй уг форвард элемент холбоотой байх нь үүний нэг жишээ юм (жишээлбэл; урьдчилан таамагласан ажил гүйлгээ эсвэл арилжааны баталгаа эсэхээс үл хамааран байгууллага нь гадаад валютын эрсдлийн хувьд гадаад валютаар илэрхийлэгдсэн бараа материалын худалдан авалтанд хейж хийдэг бөгөөд ажил гүйлгээний зардлыг тухайн бараа материалын анхны хэмжилтэнд тусган оруулдаг). Форвард элементийг хейжийн зүйлийн анхны хэмжилтэнд оруулсны үр дүнд уг форвард элемент нь тухайн хугацааны ашиг, алдагдалд тэрхүү хейжийн зүйлийн адилаар нөлөө үзүүлнэ. Үүнтэй адилаар, урьдчилан таамагласан ажил гүйлгээ эсвэл арилжааны баталгаа эсэхээс үл хамааран гадаад валютын эрсдлийн хувьд гадаад валютаар илэрхийлэгдсэн бараа бүтээгдэхүүний борлуулалтанд хейж хийдэг байгууллага нь уг форвард элементийг тухайн борлуулалттай холбоотой өртгийн нэг хэсэг байдлаар тусган оруулна (ингэснээр уг хейж хийсэн борлуулалтаас үүсэх орлогыг хүлээн зөвшөөрөх тайлант үед энэхүү форвард элементийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө).
- (б) Хэрэв хейжийн зүйлийн төрөл нь тодорхой хугацааны туршид эрсдлээс хамгаалах хамгаалалтыг олж авах зардал болох тийм шинж чанар бүхий форвард элемент бол форвард гэрээний форвард элемент нь цаг хугацаатай холбоотой хейжийн зүйлд хамааралтай байна (гэхдээ тухайн хейжийн зүйл нь дээрх (а)-д дурдсанчлан, ажил гүйлгээний зардлыг багтаасан тийм ажил гүйлгээг үүсгэхгүй). Жишээлбэл; зургаан сарын хугацаанд бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс хамгаалахын тулд адилтгах хугацаа бүхий бараа бүтээгдэхүүний форвард гэрээг ашигласнаар бараа бүтээгдэхүүнд хейж хийсэн бол уг форвард гэрээний форвард элементийг тэрхүү зургаан сарын хугацаанд ашиг, алдагдалд хуваарилна (өөрөөр хэлбэл, системчилсэн ба ул үндэслэлтэй сууриар хорогдуулна). Өөр нэг жишээ нь; гадаад валютын арилжааны форвард гэрээг ашигласнаар гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтанд 18-н сарын хугацаатай хийсэн хейж бөгөөд уг форвард гэрээний форвард элементийг тэрхүү 18-н сарын хугацаанд хуваарилах юм.

МЗУ328. Хейжийн зүйлийн шинж чанар, үүн дотроо ашиг, алдагдалд уг хейжийн зүйл хэзээ, хэрхэн нөлөөлөх эсэх нь цаг хугацаатай холбоотой хейжийн зүйлд хейж хийж буй тухайн форвард гэрээний форвард элементийг хорогдуулах хугацаанд мөн нөлөө үзүүлдэг. Тэрхүү хорогдуулах

хугацаа нь уг форвард элементийн хамаарах хугацаа байна. Жишээлбэл; форвард гэрээ нь зургаан сарын дараа эхлэх гурван сарын туршид гурван сарын хугацаатай хүүний хувь хэмжээний хувьсан өөрчлөлтийн эрсдлийн хувьд хейж хийж байгаа бол уг форвард элементийг долоогоос ес дэх сарын хугацааны туршид хорогдуулна.

МЗУ329. Форвард гэрээг хейжийн хэрэглүүр гэж сонгосон өдөр форвард элемент нь тэг дүнтэй бол 145-р параграфт заасан, форвард гэрээний форвард элементийн нягтлан бодох бүртгэлийг бас дагаж мөрдөнө. Энэ тохиолдолд хэдийгээр хейжийн харилцааны нийт хугацааны туршид уг форвард элементэд хамаарах бодит үнэ цэнийн хуримтлагдсан өөрчлөлт нь тэг байх боловч байгууллага нь тэрхүү форвард элементэд хамаарах бодит үнэ цэнийн аливаа өөрчлөлтийг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө. Иймээс хэрэв форвард гэрээний форвард элемент нь:

- (а) Ажил гүйлгээтэй холбоотой хейжийн зүйлд хамааралтай бол уг хейжийн зүйлийн дансны үнэд тохируулагддаг эсвэл ашиг, алдагдалд дахин ангилагддаг форвард элементийн харгалзах дүн нь тухайн хейжийн харилцааны эцэст тэг байна (144(б) ба 145-р параграфыг үзнэ үү).
- (б) Цаг хугацаатай холбоотой хейжийн зүйлд хамааралтай бол уг форвард элементтэй холбоотой хорогдуулгын дүн нь тэг байна.

МЗУ330. Форвард элемент нь хейжийн зүйлтэй холбоотой байх зөвхөн тэр хэмжээний (тохирох форвард элементийн) хувьд 145-р параграфт заасан, форвард гэрээний форвард элементийн нягтлан бодох бүртгэлийг дагаж мөрдөнө. Форвард гэрээний чухал нөхцлүүд (нэрлэсэн дүн, хугацаа, суурь хэрэглүүр гэх мэт) нь тухайн хейжийн зүйлтэй тохирч байвал форвард гэрээний форвард элемент нь уг хейжийн зүйлтэй холбоотой байдаг. Иймээс форвард гэрээний чухал нөхцлүүд ба тухайн хейжийн зүйл нь хоорондоо бүрэн тохирохгүй байвал байгууллага нь тохирох форвард элементийг тодорхойлно. Өөрөөр хэлбэл, уг форвард гэрээнд (бодит форвард элементэд) багтсан форвард элементээс хичнээн дүн нь тухайн хейжийн зүйлд хамааралтай эсэхийг тодорхойлно (ингэснээр 144(в) параграфын дагуу тайлагнана). Байгууллага нь уг хейжийн зүйлтэй төгс уялдах чухал нөхцлүүд бүхий форвард гэрээний үнэлгээг ашигласнаар тухайн тохирох форвард элементийг тодорхойлно.

МЗУ331. Бодит форвард элемент ба тохирох форвард элемент нь өөр байвал байгууллага нь 145-р параграфын дагуу өмчийн тусдаа бүрэлдэхүүн хэсэгт хуримтлуулан бүртгэх дүнг дараах байдлаар тодорхойлно:

- (а) Хэрэв хейжийн харилцааны эхэнд уг бодит форвард элементийн үнэмлэхүй дүн нь тохирох форвард элементийн үнэмлэхүй дүнгээс их бол байгууллага нь:
 - (i) Өмчийн тусдаа бүрэлдэхүүн хэсэгт хуримтлуулан бүртгэх дүнг тэрхүү тохирох форвард элементэд үндэслэн тодорхойлно;
 - (ii) Эдгээр хоёр форвард элементүүдийн хоорондох бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүсэх зөрүүг ашиг, алдагдалд тайлагнана.
- (б) Хэрэв хейжийн харилцааны эхэнд уг бодит форвард элементийн үнэмлэхүй дүн нь тохирох форвард элементийн үнэмлэхүй дүнгээс бага бол байгууллага нь дараах хоёр форвард элементийн үр дүн болох бодит үнэ цэнийн хуримтлагдсан өөрчлөлтийн аль багад үндэслэн, өмчийн тусдаа бүрэлдэхүүн хэсэгт хуримтлуулан бүртгэх дүнг тодорхойлно:
 - (i) Бодит форвард элементийн үнэмлэхүй дүн; ба
 - (ii) Тохирох форвард элементийн үнэмлэхүй дүн.

Бодит форвард элементийн үр дүн болох уг бодит үнэ цэнийн өөрчлөлтийн аливаа үлдсэн дүнг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

МЗУ332. Байгууллага нь гадаад валютын суурийн тархалтыг санхүүгийн хэрэглүүрээс салган тусгаарлаж, тухайн санхүүгийн хэрэглүүрийг хейжийн хэрэглүүр гэж сонгохдоо тэрхүү гадаад

валютын суурийн тархалтыг оруулахгүй хасдаг тохиолдолд (119(б) параграфыг үзнэ үү) МЗУ327-МЗУ331-р параграфт заасан, мөрдөх заавар удирдамжийг форвард гэрээний форвард элементэд мөрддөгтэй ижил арга замаар тухайн гадаад валютын суурийн тархалтанд мөрдөнө.

Зүйлсийн бүлгийн хейж

Цэвэр төлөв байдлын хейж

Хейжийн нягтлан бодох бүртгэлийн болон цэвэр төлөв байдлын сонголтын шалгуур хангах

МЗУ333. Байгууллага нь эрсдлийн удирдлагын зорилгоор цэвэр сууриар хейж хийдэг зөвхөн тийм тохиолдолд цэвэр төлөв байдал нь хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангадаг. Байгууллага ийм арга замаар хейж хийх эсэх нь бодит байдлаас (зөвхөн мэдэгдэл эсвэл баримтжуулалтаас биш) хамаарах асуудал юм. Иймээс байгууллага нь өөрийн эрсдлийн удирдлагын арга хандлагыг тусган илэрхийлээгүй бол нягтлан бодох бүртгэлийн тодорхой үр дүнд зөвхөн хүрэхийн тулд цэвэр сууриар хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэж болохгүй. Цэвэр төлөв байдлын хейж нь эрсдлийн удирдлагын стратегийн нэг хэсэг байх ёстой. УСНББОУС 20-д тодорхойлсон, эрх бүхий албан тушаалтан нь үүнийг ихэвчлэн зөвшөөрөн баталдаг.

МЗУ334. Жишээлбэл; бүртгэлийн валют нь үндэсний валют байх “А” байгууллага нь 9 сарын дараа зар сурталчилгааны зардалд 150,000ГВ төлөх арилжааны баталгаатай, мөн 15-н сарын бэлэн бүтээгдэхүүнийг 150,000ГВ-аар борлуулах арилжааны баталгаатай байна. “А” байгууллага нь есөн сарын дараа барагдуулах, ингэхдээ 100ГВ-ыг хүлээн авах ба 70ГВ-ыг төлөх гадаад валютын үүсмэл хэрэглүүрийн гэрээ байгуулсан. “А” байгууллагад ГВ-ын өөр эрсдэл байхгүй. “А” байгууллага нь гадаад валютын эрсдлийг цэвэр сууриар удирдан зохицуулдаггүй. Иймээс “А” байгууллага нь уг гадаад валютын үүсмэл хэрэглүүр ба 100ГВ-ын цэвэр төлөв байдлын (150,000ГВ-ын худалдан авалтын баталгаа, өөрөөр хэлбэл зар сурталчилгааны үйлчилгээ ба (150,000ГВ-аас) 149,900ГВ-ын борлуулалтын баталгаанаас бүрдэх) хоорондох есөн сарын хугацаатай хейжийн харилцааны хувьд хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэх боломжгүй юм.

МЗУ335. Хэрэв “А” байгууллага нь гадаад валютын эрсдлийг цэвэр сууриар удирдан зохицуулсан ба гадаад валютын үүсмэл хэрэглүүрийн гэрээ байгуулаагүй (ингэснээр түүний гадаад валютын эрсдлийг бууруулах биш, харин нэмэгдүүлэх) бол тухайн байгууллага нь есөн сарын хугацаанд хейж хийсэн ердийн төлөв байдалтай байна. Уг ажил гүйлгээг ирээдүйд өөр өөр тайлант үеүдэд хүлээн зөвшөөрөх учраас энэхүү хейж хийсэн төлөв байдлыг санхүүгийн тайланд ихэвчлэн тусгадаггүй. 151-р параграфт заасан нөхцөл зөвхөн хангагдах тохиолдолд уг тэг цэвэр төлөв байдал нь хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангах юм.

МЗУ336. Зүйлсийн бүлгийг хейжийн зүйл гэж сонгосон тохиолдолд байгууллага нь цэвэр төлөв байдлыг бүрдүүлэх тэдгээр зүйлсийг өөртөө агуулсан тухайн зүйлсийн ерөнхий бүлгийг сонгоно. Байгууллага нь тусгайлан тохироогүй салангид нэг дүнгээр цэвэр төлөв байдлыг сонгохыг зөвшөөрөхгүй. Жишээлбэл; байгууллага нь 9 сарын дараа 100ГВ-ын борлуулалт хийх арилжааны баталгаануудын бүлэгтэй, 18 сарын дараа 120ГВ-ын худалдан авалт хийх арилжааны баталгаануудын бүлэгтэй. Уг байгууллага нь цэвэр төлөв байдлыг 20ГВ хүртэлх салангид нэг дүнгээр тодорхойлж болохгүй. Харин байгууллага нь уг хейж хийсэн цэвэр төлөв байдлыг хамтран үүсгэх тухайн худалдан авалтын нийт дүн ба борлуулалтын нийт дүнг сонгох ёстой. Байгууллага нь шалгуур хангах хейжийн харилцааны хувьд нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудыг даган мөрдөх боломжтой байхын тулд тэрхүү цэвэр төлөв байдлыг үүсгэх нийт төлөв байдлуудыг сонгоно.

Цэвэр төлөв байдлын хейжийн хувьд хейжийн үр дүнтэй байдлын шаардлагуудыг мөрдөх

МЗУ337. Цэвэр төлөв байдалд хейж хийхэд 129(в) параграфт заасан хейжийн үр дүнтэй байдлын шаардлагууд хангагдах эсэхийг тодорхойлох үедээ байгууллага нь хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн хамтаар уг хейжийн хэрэглүүртэй адил нөлөө үзүүлэх, тухайн

цэвэр төлөв байдал дахь хейжийн зүйлсийн үнэ цэнийн өөрчлөлтүүдийг харгалзан үзнэ. Жишээлбэл; байгууллага нь 9 сарын дараа 100ГВ-ын борлуулалт хийх арилжааны баталгаануудын бүлэгтэй, 18 сарын дараа 120ГВ-ын худалдан авалт хийх арилжааны баталгаануудын бүлэгтэй. Уг байгууллага нь 20ГВ-ын форвард арилжааны гэрээг ашигласнаар 20ГВ-ын цэвэр төлөв байдлын гадаад валютын эрсдлийн хувьд хейж хийдэг. 129(в) параграфт заасан хейжийн үр дүнтэй байдлын шаардлагууд хангагдах эсэхийг тодорхойлохдоо байгууллага нь дараах зүйлсийн хоорондох хейжийн харилцааг харгалзан үзнэ:

- (а) Форвард арилжааны гэрээний бодит үнэ цэнийн өөрчлөлтийг уг борлуулалтын баталгааны үнэ цэнэд гарах гадаад валютын эрсдэлтэй холбоотой өөрчлөлтийн хамт; ба
- (б) Худалдан авалтын баталгааны үнэ цэнэд гарах гадаад валютын эрсдэлтэй холбоотой өөрчлөлт.

МЗУ338. Үүнтэй адилаар, хэрэв МЗУ337-р параграфт дурдсан жишээнд байгууллага нь тэг цэвэр төлөв байдалтай байсан бол 129(в) параграфт заасан, хейжийн үр дүнтэй байдлын шаардлагууд хангагдах эсэхийг тодорхойлохдоо байгууллага нь борлуулалт хийх арилжааны баталгааны үнэ цэнэ дэх гадаад валютын эрсдэлтэй холбоотой өөрчлөлт ба худалдан авалт хийх арилжааны баталгааны үнэ цэнэ дэх гадаад валютын эрсдэлтэй холбоотой өөрчлөлтийн хоорондох харилцааг харгалзан үзэх байсан.

Цэвэр төлөв байдлыг бүрдүүлэх мөнгөн гүйлгээний хейж

МЗУ339. Байгууллага нь харилцан суутгах эрсдлийн төлөв байдал (өөрөөр хэлбэл, цэвэр төлөв байдал) бүхий тийм зүйлсийн бүлэгт хейж хийдэг тохиолдолд хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуур хангах эсэх нь тухайн хейжийн төрлөөс хамаардаг. Хэрэв хейж нь бодит үнэ цэнийн хейж бол уг цэвэр төлөв байдал нь хейжийн зүйл болох шалгуурыг хангаж болох юм. Харин хейж нь мөнгөн гүйлгээний хейж бол цэвэр төлөв байдал нь гадаад валютын эрсдлийн хейж байх бөгөөд тэрхүү цэвэр төлөв байдлыг хейжийн зүйл гэх сонголт нь ашиг, алдагдалд тухайн урьдчилан таамагласан ажил гүйлгээ нөлөө үзүүлэхээр хүлээгдэж буй тайлант үеийг тусгайлан заах ба тэдгээрийн шинж төрөл, тоо хэмжээг мөн тусгайлан илэрхийлэх зөвхөн тийм тохиолдолд уг цэвэр төлөв байдал нь хейжийн зүйл болох шалгуурыг хангаж болох юм.

МЗУ340. Жишээлбэл; байгууллага нь борлуулалтын 100ГВ-ын хамгийн доод давхарга ба худалдан авалтын 150ГВ-ын хамгийн доод давхаргаас бүрдэх цэвэр төлөв байдалтай байна. Борлуулалт ба худалдан авалтын аль алиныг нэг ижил гадаад валютаар илэрхийлдэг. Хейж хийсэн цэвэр төлөв байдлын сонголтыг хангалттай тусгайлан заахын тулд байгууллага нь уг хейжийн харилцааны анхны баримтжуулалтанд тусгайлан илэрхийлж болно. Тухайлбал; А эсвэл Б бүтээгдэхүүний борлуулалт, А төрлийн тоног төхөөрөмж, Б төрлийн тоног төхөөрөмж, А түүхий эд материалын худалдан авалт гэх мэт. Мөн байгууллага нь ажил гүйлгээний тоо хэмжээг шинж төрөл бүрээр тусгайлан заадаг. Жишээлбэл; байгууллага нь А бүтээгдэхүүний эхний 70ГВ ба Б бүтээгдэхүүний эхний 30ГВ-ын урьдчилан таамагласан борлуулалтын тоо хэмжээнээс бүрдэх борлуулалтын хамгийн доод давхаргыг (100ГВ-ын) баримтжуулж болно. Хэрэв эдгээр борлуулалтын тоо хэмжээ нь өөр өөр тайлант үеүдийн ашиг, алдагдалд нөлөөлөхөөр хүлээгдэж байвал байгууллага нь жишээлбэл; эхний тайлант үеийн ашиг, алдагдалд нөлөөлөхөөр хүлээгдэж буй А бүтээгдэхүүний борлуулалтын эхний 70ГВ ба хоёр дахь тайлант үеийн ашиг, алдагдалд нөлөөлөхөөр хүлээгдэж буй Б бүтээгдэхүүний борлуулалтын эхний 30ГВ-ыг уг баримтжуулалтанд тусгана. Мөн байгууллага нь А төрлийн тоног төхөөрөмжийн эхний 60ГВ, Б төрлийн тоног төхөөрөмжийн эхний 40ГВ, А түүхий эд материалын эхний 50ГВ-аас бүрдэх худалдан авалтын хамгийн доод давхаргыг (150ГВ) баримтжуулдаг. Хэрэв эдгээр худалдан авалтын тоо хэмжээ нь өөр өөр тайлант үеүдийн ашиг, алдагдалд нөлөөлөхөөр хүлээгдэж байвал байгууллага нь худалдан авалтын тоо хэмжээг ашиг, алдагдалд нөлөөлөхөөр хүлээгдэж буй тайлант үеүдээр салган (борлуулалтын тоо хэмжээг хэрхэн баримтжуулсантай ижил төсөөтэй байдлаар) уг баримт бичигт тусгана. Жишээлбэл; урьдчилан таамагласан ажил гүйлгээг дараах байдлаар тусгайлан заана:

- (а) Гурав дахь тайлант үеэс эхлэн дараагийн 10 тайлант үеийн туршид ашиг, алдагдалд нөлөөлөхөөр хүлээгдэж буй А төрлийн тоног төхөөрөмжийн эхний 60ГВ-ын худалдан авалт;
- (б) Дөрөв дэх тайлант үеэс эхлэн дараагийн 20 тайлант үеийн туршид ашиг, алдагдалд нөлөөлөхөөр хүлээгдэж буй Б төрлийн тоног төхөөрөмжийн эхний 40ГВ-ын худалдан авалт;
- (в) Гурав дахь тайлант үед хүлээн авах ба борлуулах, өөрөөр хэлбэл тухайн тайлант үед болон дараагийн тайлант үед ашиг, алдагдалд нөлөөлөхөөр хүлээгдэж буй А төрлийн түүхий эд материалын эхний 50ГВ-ын худалдан авалт.

Элэгдлийн хэв маяг гэх мэт тухайн зүйлсийн шинж төрөл нь уг байгууллага түүнийг хэрхэн ашиглаж байгаагаас хамааран хувьсан өөрчлөгддөг бол урьдчилан таамагласан ажил гүйлгээний тоо хэмжээний шинж төрлийн тусгайлан тодорхойлолт нь нэг төрлийн үндсэн хөрөнгийн элэгдлийн хэв маяг гэх мэт шинж төрлүүдийг өөртөө агуулсан байна. Жишээлбэл; байгууллага нь А төрлийн тоног төхөөрөмжийг арван тайлант үеийн туршид шулуун шугамын аргаар болон бүтээгдэхүүний нэгжийн аргаар харгалзан элэгдүүлэх үр дүн бүхий үйлдвэрлэлийн хоёр өөр процессод ашигладаг бол А төрлийн тоног төхөөрөмжийн урьдчилан таамагласан худалдан авалтын тоо хэмжээний талаархи түүний баримтжуулалт нь тэдгээр элэгдлийн хэв маягт хамаарах байдлаар уг тоо хэмжээг салгаж харуулна.

МЗУ341. Цэвэр төлөв байдлын мөнгөн гүйлгээний хейжийн хувьд 140-р параграфын дагуу тодорхойлсон дүн нь хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн хамтаар уг хейжийн хэрэглүүртэй адил нөлөө үзүүлэх, тухайн цэвэр төлөв байдал дахь хейжийн зүйлсийн үнэ цэнийн өөрчлөлтүүдийг багтаасан байна. Гэхдээ хейжийн хэрэглүүртэй адил нөлөө үзүүлдэг, тухайн цэвэр төлөв байдал дахь хейжийн зүйлсийн үнэ цэнийн өөрчлөлтийг уг зүйлийн хамаарах ажил гүйлгээг зөвхөн хүлээн зөвшөөрсөн үед хүлээн зөвшөөрнө. Жишээлбэл, урьдчилан таамагласан ажил гүйлгээг орлого гэж хүлээн зөвшөөрөх үед хүлээн зөвшөөрнө. Жишээлбэл; байгууллага нь есөн сарын дараа хэрэгжих өндөр магадлалтай, 100ГВ-ын урьдчилан таамагласан борлуулалтуудын бүлэгтэй, мөн 18 сарын дараа хэрэгжих өндөр магадлалтай, 120ГВ-ын урьдчилан таамагласан худалдан авалтуудын бүлэгтэй байна. Тухайн байгууллага нь 20ГВ-ын форвард арилжааны гэрээг ашигласнаар уг 20ГВ-ын цэвэр төлөв байдлын гадаад валютын эрсдэлд хейж хийдэг. 140(а)-140(б) параграфын дагуу мөнгөн гүйлгээний хейжийн нөөцөд хүлээн зөвшөөрөх дүнг тодорхойлохдоо, байгууллага нь:

- (а) Өндөр магадлалтай урьдчилан таамагласан борлуулалтын үнэ цэнэд гарах гадаад валютын эрсдэлтэй холбоотой өөрчлөлтийн хамтаар уг форвард арилжааны гэрээний бодит үнэ цэнийн өөрчлөлтийг;
- (б) Өндөр магадлалтай урьдчилан таамагласан худалдан авалтын үнэ цэнэд гарах гадаад гадаад валютын эрсдэлтэй холбоотой өөрчлөлттэй харьцуулж үзнэ.

Гэхдээ байгууллага нь уг өндөр магадлалтай, урьдчилан таамагласан борлуулалтын ажил гүйлгээг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөх, ингэснээр тэрхүү урьдчилан таамагласан ажил гүйлгээний олз, гарзыг (өөрөөр хэлбэл, хейжийн харилцааг сонгох өдөр ба орлогыг хүлээн зөвшөөрөх өдрийн хооронд гадаад валютын ханшинд гарах өөрчлөлтөнд хамааруулж болох үнэ цэнийн өөрчлөлтийг) хүлээн зөвшөөрөх хүртэл зөвхөн тухайн форвард арилжааны гэрээтэй холбоотой дүнг хүлээн зөвшөөрнө.

МЗУ342. Үүнтэй адилаар, тэг цэвэр төлөв байдалтай байх жишээнийн хувьд байгууллага нь өндөр магадлалтай урьдчилан таамагласан борлуулалтын үнэ цэнэд гарах гадаад валютын эрсдэлтэй холбоотой өөрчлөлтийг уг өндөр магадлалтай урьдчилан таамагласан худалдан авалтын үнэ цэнэд гарах гадаад гадаад валютын эрсдэлтэй харьцуулж үзнэ. Гэхдээ холбогдох урьдчилан таамагласан ажил гүйлгээг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн зөвхөн тэр үед эдгээр дүнгүүдийг хүлээн зөвшөөрнө.

Хейжийн зүйл гэж сонгосон зүйлсийн бүлгүүдийн давхарга

МЗУ343. Одоо байгаа зүйлсийн бүлгүүдийн давхарга бүрэлдэхүүн хэсгийг хейжийн зүйл гэж сонгохдоо МЗУ268-р параграфт дурдсан шалтгаантай адилаар, уг зүйлсийн бүлгийн нэрлэсэн дүнг тусгайлан тодорхойлох шаардлагатай байдаг. Эдгээр нэрлэсэн дүнгүүдээс уг хейж хийсэн давхаргын бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлдог.

МЗУ344. Хейжийн харилцаа нь зүйлсийн хэд хэдэн өөр бүлгүүдээс сонгосон давхаргуудыг агуулсан байж болно. Жишээлбэл; хөрөнгүүдийн бүлэг ба өр төлбөрүүдийн бүлгийн цэвэр төлөв байдлын хейжийн хувьд уг хейжийн харилцаа нь тэрхүү хөрөнгүүдийн бүлгийн давхарга бүрэлдэхүүн хэсэг болон өр төлбөрүүдийн бүлгийн давхарга бүрэлдэхүүн хэсгийн нэгдлээс бүрдэж болох юм.

Хейжийн хэрэглүүрийн олз, гарзын толилуулга

МЗУ345. Мөнгөн гүйлгээний хейжид зүйлсийг хамтад нь бүлэг байдлаар хейж хийдэг бол тэдгээр нь ашиг, алдагдлын болон цэвэр хөрөнгө/өмчийн тайлангийн өөр өөр мөрийн зүйлсэд нөлөөлж болох юм. Тухайн тайлан дахь хейжийн олз, гарзын толилуулга нь уг зүйлсийн бүлгээс хамаардаг.

МЗУ346. Хэрэв зүйлсийн бүлэг нь харилцан нөхөх аливаа эрсдлийн төлөв байдалгүй бол (тухайлбал; ашиг, алдагдлын болон цэвэр хөрөнгө/өмчийн тайлан дахь өөр өөр мөрийн зүйлсэд нөлөөлөх ба гадаад валютын эрсдлийн хувьд хейж хийсэн, гадаад валютын зардлын бүлэг) уг хейжийн хэрэглүүрийн дахин ангилсан олз, гарзыг тухайн хейжийн зүйлсээр нөлөө үзүүлэх мөрийн зүйлсэд хувь тэнцүүлэн хуваарилна. Энэхүү хувь тэнцүүлсэн хуваарилалтыг системчилсэн ба ул үндэслэлтэй сууриар хийх бөгөөд нэг хейжийн хэрэглүүрээс үүссэн цэвэр олз, гарзтай нийлүүлэхгүй.

МЗУ347. Хэрэв зүйлсийн бүлэг нь харилцан нөхөх эрсдлийн төлөв байдалгүй бол (тухайлбал; гадаад валютын эрсдлийн хувьд хамтад нь хейж хийсэн, гадаад валютаар илэрхийлэгдсэн борлуулалт ба зардлын бүлэг) байгууллага нь хейжийн олз, гарзыг ашиг, алдагдлын болон цэвэр хөрөнгө/өмчийн тайланд тусдаа мөрийн зүйлд толилуулна. Жишээлбэл; гадаад валютаарх 100ГВ-ын борлуулалт ба гадаад валютаарх 80ГВ-ын зардлын цэвэр төлөв байдлын хувьд 20ГВ-ын форвард арилжааны гэрээг ашигласнаар гадаад валютын эрсдлийн хейж хийдэг гэж үзье. Мөнгөн гүйлгээний хейжийн нөөцөөс ашиг, алдагдалд дахин ангилдаг форвард арилжааны гэрээний олз, гарзыг (цэвэр төлөв байдал нь ашиг, алдагдалд нөлөөлдөг) уг хейж хийсэн борлуулалт ба зардлаас тусдаа мөрийн зүйлд толилуулна. Түүнчлэн, борлуулалт нь уг зардлаас өмнөх тайлант үед хийгдсэн бол борлуулалтын орлогыг УСНББОУС 4-ийн дагуу спот ханшаар хэмжинэ. Цэвэр төлөв байдлын хейжийн үр нөлөөг уг мөнгөн гүйлгээний хейжийн нөөцөд хийсэн харгалзах тохируулгын хамтаар ашиг, алдагдалд тусгахын тулд хейжийн холбогдох олз, гарзыг тусдаа мөрийн зүйлд толилуулдаг. Хейж хийсэн зардал нь дараагийн тайлант үед ашиг, алдагдалд нөлөөлдөг тохиолдолд тухайн борлуулалтын хувьд мөнгөн гүйлгээний хейжийн нөөцөд өмнө хүлээн зөвшөөрсөн, хейжийн олз, гарзыг ашиг, алдагдалд дахин ангилах бөгөөд УСНББОУС 4-ийн дагуу спот ханшаар хэмжээн, уг хейж хийсэн зардлыг агуулсан мөрийн зүйлээс тусдаа мөрийн зүйл болгон толилуулна.

МЗУ348. Бодит үнэ цэнийн зарим төрлийн хейжийн хувьд, хейжийн зорилго нь юуны өмнө уг хейжийн зүйлийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нөхөх биш, харин тэрхүү хейжийн зүйлийн мөнгөн гүйлгээг хувирган өөрчлөх явдал байдаг. Жишээлбэл; байгууллага нь хүүний түвшний своп ашигласнаар тогтмол хүүтэй өрийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн хүүний түвшний эрсдэлд хейж хийдэг. Энэ тохиолдолд байгууллагын хейжийн зорилго нь тогтмол хүүний мөнгөн гүйлгээг хөвөгч хүүний мөнгөн гүйлгээ болгон хувиргах явдал юм. Уг хүүний түвшний свопын хувьд тооцогдох цэвэр хүүг ашиг, алдагдалд хуримтлуулснаар тухайн хейжийн харилцааны нягтлан бодох бүртгэлд энэхүү зорилгыг тусган илэрхийлдэг. Цэвэр төлөв байдлын хейжийн (тухайлбал; тогтмол хүүтэй хөрөнгө ба тогтмол хүүтэй өр төлбөрийн цэвэр төлөв байдлын) хувьд, энэхүү хүүний хуримтлагдсан цэвэр дүнг ашиг, алдагдлын болон цэвэр хөрөнгө/өмчийн тайлан дахь тусдаа мөрийн зүйлд толилуулах ёстой. Ингэснээр нэг хэрэглүүрийн цэвэр олз, гарзыг харилцан нөхөгдөх нийт дүнд оруулан нэгтгэх эсвэл тэдгээрийг өөр өөр мөрийн зүйлсэд хүлээн зөвшөөрөхөөс сэргийлдэг (жишээлбэл; энэ нь нэг хүүний түвшний свопын хувьд

тооцогдох цэвэр хүүний орлогыг нийт хүүний орлого болон нийт хүүний зардалд нэгтгэн оруулахаас сэргийлнэ).

Хүчин төгөлдөр болох хугацаа ба шилжилт

Шилжилт

Худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө

МЗУ349. Өөрийн аливаа санхүүгийн хөрөнгийг удирдан зохицуулах тухайн байгууллагын удирдлагын загварын зорилго нь 40(а) буюу 41(а) параграфт заасан нөхцлийг хангах, эсвэл санхүүгийн хөрөнгө нь 106-р параграфт дурдсан сонголтын шалгуурт тохирох эсэхийг байгууллага нь энэ Стандартыг анх мөрдөх өдөр тодорхойлох ёстой. Хэрэв байгууллага нь Стандартыг анх мөрдөх өдөр санхүүгийн хөрөнгийг худалдан авсан бол тэрхүү санхүүгийн хөрөнгө нь худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэсэн тодорхойлолтыг хангах эсэхийг тухайн байгууллага нь энэ зорилгын хувьд тодорхойлно.

Үнэ цэнийн бууралт

МЗУ350. Шилжилтийн өдөр байгууллага нь их зардал буюу хүчин чармайлт гаргахгүйгээр олж болох, ул үндэслэлтэй ба дэмжих бүх мэдээллийг харгалзан үзсэнээр анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн зээлийн эрсдлийг ойролцоогоор тооцоолохыг эрмэлзэх хэрэгтэй. Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг уг шилжилтийн өдрөөр тодорхойлохдоо, байгууллага нь мэдээллийн иж бүрэн, хэт дэлгэрэнгүй эрэл хайгуул хийх шаардлагагүй юм. Хэрэв байгууллага нь их зардал буюу хүчин чармайлт гаргахгүйгээр ингэж тодорхойлох боломжгүй байвал 178-р параграфыг дагаж мөрдөнө.

МЗУ351. Стандартыг анх мөрдөх өдрөөс өмнө, анх удаа хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хэрэглүүрийн (зээл олгох баталгааны, эсвэл байгууллага тухайн гэрээний оролцогч нэг тал болдог санхүүгийн баталгааны гэрээний) хувьд гарзын хасагдуулгыг шилжилтийн өдрөөр болон тэрхүү хэрэглүүрийг үл хүлээн зөвшөөрөх хүртэлх хугацаагаар тодорхойлохын тулд байгууллага нь анхны хүлээн зөвшөөрөлтөөр зээлийн эрсдлийг тодорхойлох буюу ойролцоогоор тооцоолоход хамааралтай мэдээллийг харгалзан үздэг. Анхны зээлийн эрсдлийг тодорхойлох буюу ойролцоогоор тооцоолохын тулд байгууллага нь дотоод ба гадаад мэдээллийг, үүн дотроо багцын мэдээллийг МЗУ165-МЗУ170-р параграфын дагуу харгалзан үзэж болох юм.

МЗУ352. Түүхэн мэдээлэл багатай байгууллага нь дотоод тайлан болон статистикаас авсан мэдээлэл (шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх эсэхийг шийдвэрлэх үедээ үүсгэн гаргасан байж болно), төсөөтэй бүтээгдэхүүний талаархи мэдээлэл, хэрэв хамааралтай бол адилтгах санхүүгийн хэрэглүүрийн талаархи ижил төсөөтэй бүлгийн туршлагыг ашиглаж болох юм.

Хавсралт Б**Хавсралт Б - Гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын хейж**

Энэ хавсралт нь УСНББОУС 41-ийн саллигүй бүрэлдэхүүн хэсэг юм.

Танилцуулга

- Б1. Тайлагнагч олон байгууллагууд нь гадаад үйл ажиллагаанд хөрөнгө оруулсан байдаг (УСНББОУС 4-ийн 10-р параграфт тодорхойлсон). Ийм гадаад үйл ажиллагаа нь хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр эсвэл салбар байж болно. Байгууллага нь өөрийн гадаад үйл ажиллагаа нэг бүрийн бүртгэлийн валютыг тухайн үйл ажиллагааны эдийн засгийн анхдагч орчны валют байдлаар тодорхойлохыг УСНББОУС 4-өөр шаардсан байдаг. Гадаад үйл ажиллагааны санхүүгийн байдал ба үр дүнг толилуулгын валютанд хөрвүүлэх үед байгууллага нь уг гадаад үйл ажиллагааг данснаас хасах хүртэл гадаад валютын ханшийн зөрүүг цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрөх шаардлагатай.
- Б2. Гадаад үйл ажиллагааны цэвэр хөрөнгө оруулалтыг санхүүгийн тайланд тусгадаг зөвхөн тийм тохиолдолд гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтаас үүссэн гадаад валютын эрсдлийн хейжийн нягтлан бодох бүртгэлийг мөрдөнө. Нэгтгэсэн санхүүгийн тайлан, мөн хараат байгууллага, хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтыг нь өмчийн аргыг ашиглан тайлагнадаг санхүүгийн тайлан, УСНББОУС 37-д тодорхойлсон салбар буюу хамтын үйл ажиллагааг агуулсан санхүүгийн тайлангийн хувьд ийм тохиолдол үүсдэг. Гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтаас үүсэх гадаад валютын эрсдлийн хувьд хейжийн зүйл нь тухайн гадаад үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн дансны үнэтэй тэнцүү эсвэл түүнээс бага дүн бүхий цэвэр хөрөнгө байж болох юм.
- Б3. Хейжийн нягтлан бодох бүртгэлийн харилцаанд шалгуур хангах хейжийн зүйл ба шалгуур хангах хейжийн хэрэглүүрийг сонгохыг УСНББОУС 41-ээр шаарддаг. Цэвэр хөрөнгө оруулалтын хейжийн хувьд сонгосон хейжийн харилцаа байгаа бол цэвэр хөрөнгө оруулалтын үр дүнтэй хейж гэж тодорхойлсон хейжийн хэрэглүүрийн олз, гарзыг цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрөх бөгөөд уг гадаад үйл ажиллагааны санхүүгийн байдал ба үр дүнгийн хөрвүүлэлтээс үүсэх гадаад валютын ханшийн зөрүүгийн хамт тусган оруулна.
- Б4. Гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтаас үүсэх гадаад валютын эрсдэлд хейж хийдэг ба хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг УСНББОУС 41-ийн дагуу хангахыг хүсэж буй байгууллагын хувьд энэ Хавсралтыг мөрдөнө. Хейжийн нягтлан бодох бүртгэлийн бусад төрлүүдэд үүнийг адилтган хэрэглэж болохгүй. Хяналт тавигч байгууллагатай адилтгах тийм байгууллага, түүнчлэн нэгтгэсэн санхүүгийн тайлан байдлаар уг гадаад үйл ажиллагааны цэвэр хөрөнгө оруулалтыг тусгадаг санхүүгийн тайланд энэ Хавсралт хамаарна. Хяналт тавигч байгууллага гэсэн бүх хэллэг нь хамтарсан үйлдвэр, хараат байгууллага, салбар гэх мэт гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалт бүхий байгууллагад мөн адил хамаарна.
- Б5. Энэ хавсралт нь дараах зүйлсийн талаархи заавар удирамжаар хангана:
- (а) Олон гадаад үйл ажиллагаа бүхий байгууллага нь олон тооны гадаад валютын эрсдэлд өртөж болно гэдгийг харгалзан үзвэл гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын хейжийн хувьд хейж хийсэн эрсдлийн шалгуурыг хангах гадаад валютын эрсдлийг тодорхойлох. Энэ нь ялангуяа доорх зүйлсийг харгалзан үзнэ:
- (i) Хяналт тавигч байгууллага нь уг хяналт тавигч байгууллага ба түүний гадаад үйл ажиллагааны бүртгэлийн валютуудын хоорондох зөрүүгээс үүсэх зөвхөн гадаад валютын ханшийн зөрүүг хейж хийсэн эрсдэл гэж сонгож болох эсэх, эсвэл тухайн байгууллага нь хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

толилуулгын валют ба гадаад үйл ажиллагааны бүртгэлийн валютуудын хоорондох зөрүүгээс үүсэх гадаад валютын ханшийн зөрүүг хейж хийсэн эрсдэл гэж бас сонгож болох эсэх; ба

- (ii) Хэрэв хяналт тавигч байгууллага нь гадаад үйл ажиллагааг шууд бусаар эзэмшдэг бол хейж хийсэн эрсдэл нь уг гадаад үйл ажиллагаа ба түүний шууд хяналт тавигч байгууллагын бүртгэлийн валютуудын хоорондох зөрүүгээс үүсэх зөвхөн гадаад валютын ханшийн зөрүүг агуулсан байж болох эсэх, эсвэл тухайн хейж хийсэн эрсдэл нь гадаад үйл ажиллагааны бүртгэлийн валют ба аливаа завсрын буюу эцсийн хяналт тавигч байгууллагын бүртгэлийн валют хоорондох аливаа гадаад валютын ханшийн зөрүүг бас агуулсан байж болох эсэх (өөрөөр хэлбэл, гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтыг завсрын хяналт тавигч байгууллагаар дамжуулан эзэмшиж байх нь уг эцсийн хяналт тавигч байгууллагад учрах эдийн засгийн эрсдэлд нөлөө үзүүлэх эсэх).
- (б) Эдийн засгийн нэгдмэл байгууллага нь хейжийн хэрэглүүрийг эзэмшиж болох бөгөөд дараах асуудлыг тусгайлан харгалзан үзнэ:
 - (i) Байгууллага нь үүсмэл эсвэл үүсмэл бус санхүүгийн хэрэглүүрийг (эсвэл үүсмэл ба үүсмэл бус санхүүгийн хэрэглүүрийн хослолыг) гадаад валютын эрсдлийн хейжийн хэрэглүүр гэж сонгохыг УСНББОУС 41-ээр зөвшөөрдөг. Хейжийн хэрэглүүрийн шинж төрөл (үүсмэл ба үүсмэл бус) эсвэл нэгтгэлийн арга нь хейжийн үр дүнтэй байдлын үнэлгээнд нөлөөлөх эсэхийг энэ Хавсралтаар авч үзсэн.
 - (ii) Гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтанд хейж хийдэг хейжийн хэрэглүүрийг хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангахын тулд эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээнд эзэмшиж болох тохиолдлыг, өөрөөр хэлбэл, цэвэр хөрөнгө оруулалтандаа хейж хийж буй байгууллага нь уг хейжийн хэрэглүүрийн оролцогч тал байх зөвхөн тийм тохиолдолд шалгуур хангах хейжийн нягтлан бодох бүртгэлийн харилцааг тогтоож болох эсэх, эсвэл тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрэн дэх аливаа байгууллага нь өөрийн бүртгэлийн валютаас үл хамааран хейжийн хэрэглүүрийг эзэмшиж болох эсэхийг энэ Хавсралтаар бас авч үзнэ.
- (в) Гадаад үйл ажиллагааны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүнгийн хөрвүүлэлтээс үүсэх гадаад валютын ханшийн зөрүү ба цэвэр хөрөнгө оруулалтын үр дүнтэй хейж гэж тодорхойлсон хейжийн хэрэглүүрийн олз, гарзын аль алинтай холбоотойгоор цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрч байсан хуримтлагдсан дүнг тухайн байгууллага нь уг гадаад үйл ажиллагааг данснаас хасах үед шууд хүлээн зөвшөөрөхийг УСНББОУС 4 ба УСНББОУС 41-ээр шаарддаг тул хейжийн хэрэглүүр болон хейжийн зүйлийн аль алины хувьд цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрч байсан олз, гарзаа тэрхүү байгууллага нь ямар дүнгээр ашиг, алдагдалд шууд хүлээн зөвшөөрөхөө хэрхэн тодорхойлдог эсэх. Энэ нь ялангуяа доорх зүйлсийг харгалзан үзнэ:
 - (i) Хейж хийсэн гадаад үйл ажиллагааг данснаас хасах тохиолдолд хейжийн хэрэглүүр ба тухайн гадаад үйл ажиллагааны хувьд уг хяналт тавигч байгууллагын гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцөөс ямар дүнгээр тэрхүү хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх эсэх; ба
 - (ii) Нэгтгэлийн арга нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх дүнг тодорхойлоход нөлөө үзүүлэх эсэх.

Гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын хейжид УСНББОУС 41-ийг мөрдөх

Хейж хийсэн эрсдлийн шинж төрөл ба хейжийн харилцааг сонгож болох тухайн хейжийн зүйлийн дүн

- Б6. Гадаад үйл ажиллагааны бүртгэлийн валют ба хяналт тавигч байгууллагын бүртгэлийн валют хоорондох зөрүүгээс зөвхөн үүсэх гадаад валютын ханшийн зөрүүнд хейжийн нягтлан бодох бүртгэлийг мөрдөж болно.
- Б7. Гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтаас үүсэх гадаад валютын эрсдлийн хейжийн хувьд хейжийн зүйл нь тухайн хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь уг гадаад үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн дансны үнэтэй тэнцүү эсвэл түүнээс бага дүн бүхий цэвэр хөрөнгө байж болно. Хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд хейжийн зүйл гэж сонгож болох гадаад үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн дансны үнэ нь уг гадаад үйл ажиллагааны арай доод түвшний аливаа хяналт тавигч байгууллага нь тухайн гадаад үйл ажиллагааны бүх эсвэл зарим цэвэр хөрөнгөнд хейжийн нягтлан бодох бүртгэлийг мөрддөг ба хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд тэрхүү нягтлан бодох бүртгэлийг хөтөлдөг эсэхээс хамаардаг.
- Б8. Хейж хийсэн эрсдлийг уг гадаад үйл ажиллагааны бүртгэлийн валют ба тэрхүү гадаад үйл ажиллагааны аливаа хяналт тавигч байгууллагын (шууд, завсрын эсвэл эцсийн хяналт тавигч байгууллагын) бүртгэлийн валют хоорондох зөрүүгээс үүсэх гадаад валютын эрсдэл гэж сонгож болох юм. Цэвэр хөрөнгө оруулалтыг завсрын хяналт тавигч байгууллагаар дамжуулан эзэмших нь уг эцсийн хяналт тавигч байгууллагад учрах гадаад валютын эрсдлээс үүсэх эдийн засгийн эрсдлийн шинж төрөлд нөлөө үзүүлэхгүй.
- Б9. Гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтаас үүсэх гадаад валютын эрсдэлд өртөлт нь зөвхөн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг нэг удаа хангаж болох юм. Иймээс эдийн засгийн нэгдмэл байгууллагын доторх нэгээс олон тооны хяналт тавигч байгууллага (жишээлбэл; шууд ба шууд бус хяналт тавигч байгууллагын аль аль) нь нэг эрсдлийн хувьд уг гадаад үйл ажиллагааны цэвэр хөрөнгөнд хейж хийдэг бол зөвхөн нэг хейжийн харилцаа нь эцсийн хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангана. Нэг хяналт тавигч байгууллага өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайланд сонгосон хейжийн харилцааг арай дээд түвшний өөр нэг хяналт тавигч байгууллага нь сонгох шаардлагагүй юм. Гэвч арай дээд түвшний хяналт тавигч байгууллага нь хейжийн харилцааг сонгоогүй бол тэрхүү арай дээд түвшний хяналт тавигч байгууллагын хейжийн нягтлан бодох бүртгэлийг хүлээн зөвшөөрөхийн өмнө уг арай доод түвшний хяналт тавигч байгууллагын мөрддөг хейжийн нягтлан бодох бүртгэлийг буцаах ёстой.

Хейжийн хэрэглүүрийг эзэмших тохиолдол

- Б10. Гадаад үйл ажиллагаан дахь цэвэр хөрөнгө оруулалтын хейжийн хувьд үүсмэл хэрэглүүр эсвэл үүсмэл бус хэрэглүүрийг (эсвэл үүсмэл ба үүсмэл бус хэрэглүүрийн хослолыг) хейжийн хэрэглүүр гэж сонгож болно. Цэвэр хөрөнгө оруулалтын хейжид хамаарах УСНББОУС 41-ийн 129-р параграфын сонголт, баримтжуулалт, үр дүнтэй байдлын шаардлагууд хангагдах тохиолдолд уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын доторх (өөрөө хейж хийгдэж буй гадаад үйл ажиллагаанаас бусад) байгууллага буюу байгууллагууд нь хейжийн хэрэглүүрийг (хэрэглүүрүүдийг) эзэмшиж болох юм. Ялангуяа эдийн засгийн нэгдмэл байгууллагын янз бүрийн түвшин дэх өөр өөр сонголтын боломжуудаас хамааран тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын хейжийн стратегийг оновчтой баримтжуулвал зохино.
- Б11. Үр дүнтэй байдлыг үнэлэх зорилгоор, уг хейж хийсэн эрсдлийг хейжийн нягтлан бодох бүртгэлийн баримтжуулалтын дагуу хэмждэг бүртгэлийн валют бүхий хяналт тавигч байгууллагын бүртгэлийн валютыг лавлагаа болгосноор тухайн гадаад валютын ханшийн эрсдлийн хувьд хейжийн хэрэглүүрийн үнэ цэнийн өөрчлөлтийг тооцоолно. Хейжийн нягтлан бодох бүртгэлгүй тохиолдолд үнэ цэнийн нийт өөрчлөлтийг тухайн хейжийн хэрэглүүрийг хэрхэн эзэмшиж байгаагаас хамааран ашиг, алдагдалд эсвэл цэвэр хөрөнгө/өмчид шууд, эсвэл эдгээрийн аль алинд хүлээн зөвшөөрнө. Гэвч хейжийн хэрэглүүрийн үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд эсвэл цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрөх эсэх нь хейжийн үр дүнтэй байдлын үнэлгээнд нөлөөлөхгүй. Хейжийн нягтлан бодох бүртгэлийн мөрдөлтийн нэг хэсэг болгон уг өөрчлөлтийн нийт үр дүнтэй хэсгийг цэвэр хөрөнгө/өмчид шууд тусгана. Хейжийн

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР


хэрэглүүр нь үүсмэл хэрэглүүр эсвэл үүсмэл хэрэглүүр эсэх болон нэгтгэлийн арга нь хейжийн үр дүнтэй байдлын үнэлгээнд нөлөө үзүүлэхгүй.

Хейж хийсэн гадаад үйл ажиллагааны данснаас хасалт

- Б12. Хейж хийсэн гадаад үйл ажиллагааг данснаас хассан тохиолдолд уг хейжийн хэрэглүүрийн хувьд тухайн хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцөөс хасаж, ашиг алдагдалд дахин ангилах дүн нь УСНББОУС 41-ийн 143-р параграфар тодорхойлохыг шаардсан дүн байна. Энэхүү дүн нь үр дүнтэй хейж гэж тодорхойлсон хейжийн хэрэглүүрт хуримтлагдсан олз буюу гарз байна.
- Б13. Гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын хувьд УСНББОУС 4-ийн 57-р параграфын дагуу уг хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцөөс хасаж, ашиг алдагдалд хүлээн зөвшөөрсөн дүн нь тэрхүү гадаад үйл ажиллагаатай холбоотойгоор тухайн хяналт тавигч байгууллагын гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцөд тусгаж байсан дүн байна. Эцсийн хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд, бүх гадаад үйл ажиллагаатай холбоотойгоор гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцөд хүлээн зөвшөөрөх нийт цэвэр дүнд нэгтгэлийн арга нөлөө үзүүлэхгүй. Гэвч уг эцсийн хяналт тавигч байгууллага нь нэгтгэлийн шууд эсвэл алхам алхамаар нэгтгэх аргыг ашигладаг эсэх нь тэрхүү бие даасан гадаад үйл ажиллагааны хувьд гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцөд тусгах дүнд нөлөөлж болох юм.
- Б14. Шууд арга гэдэг нь гадаад үйл ажиллагааны санхүүгийн тайланг тухайн эцсийн хяналт тавигч байгууллагын бүртгэлийн валютад шууд хөрвүүлдэг нэгтгэлийн арга юм. Алхам алхамаар арга нь гадаад үйл ажиллагааны санхүүгийн тайланг эхлээд аливаа завсрын хяналт тавигч байгууллагын (байгууллагуудын) бүртгэлийн валютад хөрвүүлэх ба дараа нь уг эцсийн хяналт тавигч байгууллагын бүртгэлийн валютад (хэрэв өөр бол толилуулгын валютад) хөрвүүлдэг нэгтгэлийн арга юм.
- Б15. Нэгтгэлийн алхам алхамаар аргыг ашиглах нь хейжийн үр дүнтэй байдлыг тодорхойлоход ашигласнаас өөр дүнг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөхөд хүргэж болох юм. Хэрэв нэгтгэлийн шууд аргыг ашигласан бол үүсэх байсан тухайн гадаад үйл ажиллагаатай холбоотой дүнг тодорхойлсноор энэхүү зөрүүг арилгаж болно. Ийм тохируулга хийхийг УСНББОУС 4-өөр шаардаагүй. Гэвч энэ нь бүх цэвэр хөрөнгө оруулалтын хувьд тууштай мөрдвөл зохих нягтлан бодох бүртгэлийн бодлогын сонголт юм.

Жишээ

- Б16. Өмнөх параграфын мөрдөлтийг доор дурдсан байгууллагын бүтцийг ашигласнаар дараах жишээнд үлгэрчлэн харуулав. Хэдийгээр хийгдэх сорилыг авч хэлэлцэхгүй боловч бүх тохиолдолд уг дурдсан хейжийн харилцааны үр дүнтэй байдлыг УСНББОУС 41-ийн дагуу сорьж шалгана. Эцсийн хяналт тавигч байгууллага болох “Г” хяналт тавигч байгууллага нь нэгтгэсэн санхүүгийн тайлангаа өөрийн бүртгэлийн валют еврогоор (Евро) толилуулдаг. Хяналтанд буй байгууллага нэг бүрийг, өөрөөр хэлбэл “А”, “Б”, “В” гэсэн хяналтанд буй байгууллагуудыг бүрэн өмчилдөг. “Б” хяналтанд буй байгууллага (бүртгэлийн валют нь фунт стерлинг (Стерлинг)) дахь “Г” хяналт тавигч байгууллагын 500 сая фунт стерлингийн цэвэр хөрөнгө оруулалт нь “В” хяналтанд буй байгууллагад (бүртгэлийн валют нь америк доллар (Доллар)) “Б” хяналтанд буй байгууллагын оруулсан 300 сая ам доллартай тэнцэх 159 сая фунт стерлингийн цэвэр хөрөнгө оруулалтыг агуулсан болно. Өөрөөр хэлбэл, “В” хяналтанд буй байгууллага дахь “Б” хяналтанд буй байгууллагын хөрөнгө оруулалтаас бусад түүний цэвэр хөрөнгө нь 341 сая фунт стерлинг байна.



Хейжийн харилцааг сонгож болох хейж хийсэн эрсдлийн шинж төрөл (Б6-Б9-р параграф)

Б17. “Г” хяналт тавигч байгууллага нь хяналтанд буй байгууллагуудын тус тусын бүртгэлийн валют (японы иен (иен), фунт стерлинг, ам доллар) ба евроны хоорондох гадаад валютын ханшийн эрсдлийн хувьд “А”, “Б”, “В” гэсэн хяналтанд буй байгууллага нэг бүр дэх өөрийн цэвэр хөрөнгө оруулалтанд хейж хийж болно. Мөн түүнчлэн, “Г” хяналт тавигч байгууллага нь “Б” хяналтанд буй байгууллага ба “В” хяналтанд буй байгууллагын бүртгэлийн валютуудын хоорондох Доллар/Стирлинг гадаад валютын ханшийн эрсдэлд хейж хийж болно. Өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайландаа, “Б” хяналтанд буй байгууллага нь тэдгээрийн бүртгэлийн валютууд болох ам доллар ба фунт стерлингийн хоорондох гадаад валютын ханшийн эрсдлийн хувьд “В” хяналтанд буй байгууллага дахь цэвэр хөрөнгөндөө хейж хийж болно. Хейжийн хэрэглүүрүүд нь үүсмэл хэрэглүүр биш учраас дараах жишээний хувьд сонгосон эрсдэл нь гадаад валютын спот ханшийн эрсдэл байна. Хэрэв хейжийн хэрэглүүр нь форвард гэрээ бол “Г” хяналт тавигч байгууллага нь гадаад валютын форвард ханшийн эрсдлийг сонгож болно.

Хейжийн харилцааг сонгож болох хейжийн зүйлийн дүн (Б6-Б9-р параграф)

Б18. “Г” хяналт тавигч байгууллага нь “В” хяналтанд буй байгууллагад оруулсан өөрийн цэвэр хөрөнгө оруулалтаас үүсэх гадаад валютын ханшийн эрсдлийн хувьд хейж хийхийг хүссэн. “А” хяналтанд буй байгууллага нь 300 сая ам долларын гаднаас авсан зээлтэй гэж үзье. Тайлант үеийн эхэнд “А” хяналтанд буй байгууллагын цэвэр хөрөнгө нь 400,000 сая иен байсан бөгөөд үүнд 300 сая ам долларын гаднын зээл багтаж байна.

Б19. Хейжийн зүйл нь “В” хяналтанд буй байгууллагад “Г” хяналт тавигч байгууллагын оруулсан, түүний нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь цэвэр хөрөнгө оруулалтын дансны үнэтэй (300 сая ам доллар) тэнцүү эсвэл түүнээс бага дүн бүхий цэвэр хөрөнгө байж болно. Өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайландаа “Г” хяналт тавигч байгууллага нь “В” хяналтанд буй байгууллагын 300 сая ам долларын цэвэр хөрөнгөнд оруулсан өөрийн цэвэр хөрөнгө оруулалттай холбоотой Евро/Долларын гадаад валютын спот ханшийн эрсдэл байдлаар уг “А” хяналтанд буй байгууллагын 300 сая ам долларын гаднын зээлийг сонгож болно. Энэ тохиолдолд “А” хяналтанд буй байгууллагын 300 сая ам долларын гаднын зээлд хамаарах Евро/Долларын гадаад валютын ханшийн зөрүү ба “В” хяналтанд буй байгууллага дахь 300 сая ам долларын цэвэр хөрөнгө оруулалтанд хамаарах Евро/Долларын гадаад валютын ханшийн зөрүүгийн аль алиныг хейжийн нягтлан бодох бүртгэлийг мөрдсөний дараа уг “Г” хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцөд тусгана.

Б20. Хейжийн нягтлан бодох бүртгэл байхгүй үед “А” хяналтанд буй байгууллагын 300 сая ам долларын гаднын зээлд хамаарах Доллар/Евроны гадаад валютын ханшийн нийт зөрүүг “Г” хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

- Доллар/Иений гадаад валютын спот ханшийн өөрчлөлтийг евронд хөрвүүлж, ашиг, алдагдалд тусгах; ба
- Иен/Евроны гадаад валютын спот ханшийн өөрчлөлтийг цэвэр хөрөнгө/өмчид шууд тусгах.

Б19-р параграфт заасан сонголтын оронд, “Г” хяналт тавигч байгууллага нь “В” хяналтанд буй байгууллага ба “Б” хяналтанд буй байгууллагын хоорондох Стирлинг/Доллар-ын гадаад валютын спот ханшийн хейж байдлаар уг “А” хяналтанд буй байгууллага дахь 300 сая ам долларын гаднын зээлийг өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайланд сонгож болно. Энэ тохиолдолд “А” байгууллагын 300 сая ам долларын гаднын зээлд хамаарах Доллар/Евроны гадаад валютын ханшийн нийт зөрүүг “Г” хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

- Стирлинг/Долларын гадаад валютын спот ханшийн өөрчлөлтийг “В” хяналтанд буй байгууллагатай холбоотой гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцөд тусгах;
- Стирлинг/Иений гадаад валютын спот ханшийн өөрчлөлтийг евронд хөрвүүлж, ашиг, алдагдалд тусгах;
- Иен/Евроны гадаад валютын спот ханшийн өөрчлөлтийг цэвэр хөрөнгө/өмчид шууд тусгах.

Б21. “Г” хяналт тавигч байгууллага нь уг 300 сая ам долларын гаднын зээлийг өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайландаа Евро/Долларын гадаад валютын спот ханшийн эрсдэл ба Стирлинг/Долларын гадаад валютын спот ханшийн эрсдлийн аль алины хейж байдлаар сонгож болохгүй. Нэг хейжийн хэрэглүүр нь тухайн нэг сонгосон эрсдэлд зөвхөн нэг удаа хейж хийдэг. “Б” ба “В” хяналтанд буй байгууллагуудаас бүрдэх тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагаас гадна уг хейжийн хэрэглүүрийг эзэмшдэг учраас “Б” хяналтанд буй байгууллага нь өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайландаа хейжийн нягтлан бодох бүртгэлийг мөрдөхгүй.

Эдийн засгийн нэгдмэл байгууллагын хаана нь хейжийн хэрэглүүрийг эзэмшиж болох вэ (Б10 ба Б11-р параграф)?

Б22. Б20-р параграфт дурдсанчлан, “А” хяналтанд буй байгууллагын 300 сая ам долларын гаднын зээлийн гадаад валютын ханшийн эрсдлийн хувьд үнэ цэнийн нийт өөрчлөлтийг хейжийн нягтлан бодох бүртгэл хэрэглэдэггүй үед “Г” хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд ашиг, алдагдал (Доллар/Иений спот эрсдэл) болон цэвэр хөрөнгө/өмчийн (Евро/Иений спот эрсдэл) аль алинд бүртгэж болно. “Г” хяналт тавигч байгууллагын бүртгэлийн валют еврог хейжийн баримтжуулалтын дагуу “В” хяналтанд буй байгууллагын бүртгэлийн валют ам доллартай харьцуулан лавлагаа болгосноор хейжийн хэрэглүүр ба хейжийн зүйлийн аль алины үнэ цэнийн өөрчлөлтийг тооцоолж болох учраас Б19-р параграфт сонгосон уг хейжийн үр дүнтэй байдлыг үнэлэх зорилгоор хоёр дүнгийн аль алиныг тусган оруулна. Нэгтгэлийн арга (өөрөөр хэлбэл, шууд арга эсвэл алхам алхамаар арга) нь хейжийн үр дүнтэй байдлын үнэлгээнд нөлөө үзүүлэхгүй.

Гадаад үйл ажиллагааны данснаас хасалтаар ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн дүн (Б12 ба Б13-р параграф)

Б23. “В” хяналтанд буй байгууллагыг данснаас хассан тохиолдолд “Г” хяналт тавигч байгууллагын гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц (ГВХН)-өөс шилжүүлж, түүний нэгтгэсэн санхүүгийн тайланд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн дүн нь:

- (а) “А” хяналтанд буй байгууллагын 300 сая ам долларын гаднын зээлийн хувьд УСНББОУС 41 нь тодорхойлохыг шаардах дүн өөрөөр хэлбэл, хейжийн үр дүнтэй хэсэг

байдлаар цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн гадаад валютын ханшийн эрсдлийн хувьд үнэ цэнийн нийт өөрчлөлтийн дүн байна; ба

- (б) “В” хяналтанд буй байгууллагад оруулсан 300 сая ам долларын цэвэр хөрөнгө оруулалтын хувьд тухайн байгууллагын нэгтгэлийн аргаар тодорхойлсон дүн байна. Хэрэв “Г” хяналт тавигч байгууллага нь шууд аргыг хэрэглэдэг бол “В” хяналтанд буй байгууллагын хувьд ГВХН-ийг Евро/Долларын гадаад валютын ханшаар шууд тодорхойлно. Хэрэв “Г” хяналт тавигч байгууллага нь алхам алхамаар нэгтгэх аргыг хэрэглэдэг бол Евро/Стирлингийн гадаад валютын ханшийг ашигласнаар “Г” хяналт тавигч байгууллагын бүртгэлийн валютад хөрвүүлсэн уг Стирлинг/Долларын гадаад валютын ханшийг тусгах “Б” хяналтанд буй байгууллагын хүлээн зөвшөөрсөн ГВХН-өөр тэрхүү “В” хяналтанд буй байгууллагын хувьд түүний ГВХН-ийг тодорхойлно. Өмнөх тайлант үеүдэд “Г” хяналт тавигч байгууллага алхам алхамаар нэгтгэх аргыг ашиглаж байсан нь тэрээр “В” хяналтанд буй байгууллагыг данснаас хасах үедээ ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх ГВХН-ийг өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогоос хамааран шууд аргыг ямагт ашигласан бол хүлээн зөвшөөрөх байсан тийм дүнгээр тодорхойлохыг шаардахгүй эсвэл ингэж тодорхойлоход саад учруулахгүй.

Нэгээс олон гадаад үйл ажиллагаанд хейж хийх (Б7, Б9, Б11-р параграф)

- Б24. “Г” хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд хейж хийж болох эрсдэл нь ямагт түүний бүртгэлийн валют (евро) ба “Б”, “В” хяналтанд буй байгууллагуудын бүртгэлийн валютууд хоорондох эрсдэл байна гэдгийг дараах жишээнд үлгэрчлэн харуулав. Хоёр гадаад үйл ажиллагааны аль алинд хейж хийдэг тохиолдолд хейжийг хэрхэн сонгосноос үл хамааран “Г” хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцөд тусгах үр дүнтэй хейжийн хамгийн их дүн нь Евро/Долларын эрсдлийн хувьд 300 сая ам доллар, Евро/Стирлингийн эрсдлийн хувьд 341 фунт стирлинг байна. Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн улмаас үнэ цэнэд гарах бусад өөрчлөлтүүдийг “Г” хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн ашиг, алдагдалд тусгана. Мэдээж, “Г” хяналт тавигч байгууллага нь зөвхөн Доллар/Стирлингийн гадаад валютын спот ханшийн өөрчлөлтийн хувьд 300 сая ам долларыг эсвэл зөвхөн Стирлинг/Евроны гадаад валютын спот ханшийн өөрчлөлтийн хувьд 500 сая фунт стирлингийг сонгох боломжтой юм.

“Г” байгууллага нь ам долларын болон фунт стирлингийн аль алины хейжийн хэрэглүүрийг эзэмших

- Б25. “Г” хяналт тавигч байгууллага нь “Б” хяналтанд буй байгууллагад оруулсан цэвэр хөрөнгө оруулалт, түүнчлэн “В” хяналтанд буй байгууллагад оруулсан хөрөнгө оруулалттай холбоотойгоор гадаад валютын ханшийн эрсдэлдээ хейж хийхийг хүсэж болох юм. “Г” хяналт тавигч байгууллага нь “Б” ба “В” хяналтанд буй байгууллагад оруулсан өөрийн цэвэр хөрөнгө оруулалтын хейж гэж сонгож болох ам доллар болон фунт стирлингээр илэрхийлэгдсэн зохих хейжийн хэрэглүүрүүдийг эзэмшдэг гэж үзье. Өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайландаа “Г” хяналт тавигч байгууллагын хейж болох сонголтуудад дараах зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:
- (а) “Г” хяналт тавигч байгууллага ба “В” хяналтанд буй байгууллагын хоорондох гадаад валютын (Евро/Доллар) спот ханшийн эрсдлийн хувьд “В” хяналтанд буй байгууллагад оруулсан 300 сая ам долларын цэвэр хөрөнгө оруулалтын хейж гэж сонгосон 300 сая ам долларын хейжийн хэрэглүүр, түүнчлэн “Г” хяналт тавигч байгууллага ба “Б” хяналтанд буй байгууллагын хоорондох гадаад валютын (Евро/Стирлинг) спот ханшийн эрсдлийн хувьд “Б” хяналтанд буй байгууллагад оруулсан 341 сая фунт стирлингийн цэвэр хөрөнгө оруулалтын хейж гэж сонгосон 341 сая фунт стирлинг хүртэлх хейжийн хэрэглүүр.
- (б) “Б” хяналтанд буй байгууллага ба “В” хяналтанд буй байгууллагын хоорондох гадаад валютын (Стирлинг/Доллар) спот ханшийн эрсдлийн хувьд “В” хяналтанд буй байгууллагад оруулсан 300 сая ам долларын цэвэр хөрөнгө оруулалтын хейж гэж сонгосон 300 сая ам долларын хейжийн хэрэглүүр, түүнчлэн “Г” хяналт тавигч

байгууллага ба “Б” хяналтанд буй байгууллагын хоорондох гадаад валютын (Евро/Стирлинг) спот ханшийн эрсдлийн хувьд “Б” хяналтанд буй байгууллагад оруулсан 500 сая фунт стирлингийн цэвэр хөрөнгө оруулалтын хейж гэж сонгосон 500 сая фунт стирлинг хүртэлх хейжийн хэрэглүүр.

- Б26. “В” хяналтанд буй байгууллагад оруулсан “Г” хяналт тавигч байгууллагын цэвэр хөрөнгө оруулалтаас үүсэх Евро/Долларын эрсдэл нь “Б” хяналтанд буй байгууллагад “Г” хяналт тавигч байгууллагын оруулсан цэвэр хөрөнгө оруулалтаас үүсэх Евро/Стирлингийн эрсдлээс өөр байна. Гэвч Б25(а) параграфт дурдсан тохиолдолд “Г” хяналт тавигч байгууллага нь өөрийн эзэмшиж буй ам долларын хейжийн хэрэглүүрийг сонгосноор “В” хяналтанд буй байгууллагад оруулсан хөрөнгө оруулалтаа Евро/Долларын эрсдлээс бүрэн хамгаалж, аль хэдийн хейж хийсэн байна. Хэрэв “Г” хяналт тавигч байгууллага нь өөрийн эзэмшиж буй Стирлингийн хэрэглүүрийг “Б” хяналтанд буй байгууллагад оруулсан 500 сая фунт стирлингийн цэвэр хөрөнгө оруулалтын хейж гэж бас сонговол “В” хяналтанд буй байгууллагад оруулсан түүний ам долларын цэвэр хөрөнгө оруулалттай тэнцүү дүн бүхий фунт стирлингийг илэрхийлэх 159 сая фунт стирлингийн цэвэр хөрөнгө оруулалтыг “Г” хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд Стирлинг/Евроны эрсдлийн хувьд хоёр удаа хейж хийхэд хүргэх юм.
- Б27. Б25(б) параграфт дурдсан тохиолдолд, хэрэв “Г” хяналт тавигч байгууллага нь уг хейж хийсэн эрсдлийг “Б” хяналтанд буй байгууллага ба “В” хяналтанд буй байгууллагын хоорондох гадаад валютын (Стирлинг/Доллар) спот ханшийн эрсдэл гэж сонгосон бол түүний 300 сая ам долларын хейжийн хэрэглүүрийн үнэ цэнийн өөрчлөлтийн зөвхөн Стирлинг/Долларын хэсгийг “В” хяналтанд буй байгууллагад хамааралтай “Г” хяналт тавигч байгууллагын гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцөд тусгана. Уг өөрчлөлтийн үлдэх хэсгийг (159 сая фунт стерлингэд хамаарах Стирлинг/Евроны өөрчлөлттэй тэнцүү дүнг) Б20-р параграфт заасанчлан, “Г” хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн ашиг, алдагдалд тусгана. “Б” болон “В” хяналтанд буй байгууллагуудын хоорондох Доллар/Стирлингийн эрсдлийн сонголтонд Стирлинг/Евроны эрсдэл хамаарахгүй учраас “Г” хяналт тавигч байгууллага нь “Г” хяналт тавигч байгууллага ба “Б” хяналтанд буй байгууллагын хоорондох гадаад валютын (Стирлинг/Евро) спот ханшийн эрсдлийн хувьд “Б” хяналтанд буй байгууллагад оруулсан 500 сая фунт стирлинг хүртэлх өөрийн цэвэр хөрөнгө оруулалтыг бас сонгох боломжтой байна.

“Б” байгууллага нь ам долларын хейжийн хэрэглүүрийг эзэмших

- Б28. “Б” хяналтанд буй байгууллага нь 300 сая ам долларын гаднын зээлтэй бөгөөд уг зээлийн мөнгөн орлогыг фунт стерлингээр илэрхийлэгдсэн байгууллага хоорондын зээл байдлаар “Г” хяналт тавигч байгууллагад шилжүүлсэн гэж үзье. Хөрөнгө ба өр төлбөрийн аль аль нь 159 сая фунт стерлингээр нэмэгдсэн тул “Б” хяналтанд буй байгууллагын цэвэр хөрөнгө өөрчлөгдөхгүй. “Б” хяналтанд буй байгууллага нь “В” хяналтанд буй байгууллагад оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын Стирлинг/Долларын эрсдлийн хейж байдлаар уг гаднын зээлийг өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайландаа сонгож болох юм. “Г” хяналт тавигч байгууллага нь Стирлинг/Долларын эрсдлийн хувьд (Б9-р параграфыг үзнэ үү) “В” хяналтанд буй байгууллагад оруулсан өөрийн 300 сая ам долларын цэвэр хөрөнгө оруулалтын хейж байдлаар тэрхүү хейжийн хэрэглүүрийн “Б” хяналтанд буй байгууллагын сонголтыг хэвээр хадгалж болох бөгөөд “Г” хяналт тавигч байгууллага нь өөрийн эзэмшдэг Стирлингийн хэрэглүүрийг “Б” хяналтанд буй байгууллагад оруулсан өөрийн 500 сая фунт стирлингийн нийт цэвэр хөрөнгө оруулалтын хейж гэж сонгож болно. “Б” хяналтанд буй байгууллагын сонгосон эхний хейжийг уг “Б” байгууллагын бүртгэлийн валютыг (фунт стерлинг) лавлагаа болгосноор үнэлнэ, харин “Г” хяналт тавигч байгууллагын сонгосон хоёр дахь хейжийг тэрхүү “Г” байгууллагын бүртгэлийн валютыг (евро) лавлагаа болгосноор үнэлнэ. Энэ тохиолдолд “В” хяналтанд буй байгууллагад “Г” хяналт тавигч байгууллагын оруулсан цэвэр хөрөнгө оруулалтаас үүсэх зөвхөн Стирлинг/Долларын эрсдлийг уг “Г” хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд Евро/Долларын нийт эрсдлээр биш, харин ам долларын хейжийн хэрэглүүрээр хамгаалж, хейж хийсэн байна. Иймээс “Б” хяналтанд буй байгууллагад “Г” хяналт тавигч байгууллагын оруулсан 500 сая фунт стерлингийн цэвэр хөрөнгө оруулалтаас үүсэх Евро/Долларын нийт эрсдлийг уг “Г” хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд хамгаалж, хейж хийж болох юм.

- Б29. Гэхдээ “Б” хяналтанд буй байгууллагад төлөх “Г” хяналт тавигч байгууллагын 159 сая фунт стерлингийн зээлийн өглөгийн тайлагналыг бас харгалзан үзэх ёстой. Хэрэв “Г” хяналт тавигч байгууллагын зээлийн өглөгийг “Б” хяналтанд буй байгууллагад оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын нэг хэсэг байдлаар харгалзан үзэхгүй бол энэ нь УСНББОУС 4-ийн 18-р параграфт заасан нөхцлийг хангахгүй учраас түүний хөрвүүлэлтээс үүсэх гадаад валютын Стирлинг/Евроны ханшийн зөрүүг “Г” хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн ашиг, алдагдалд тусган оруулахаар болох юм. “Б” хяналтанд буй байгууллагад төлөх 159 сая фунт стерлингийн өглөгийг “Г” хяналт тавигч байгууллагын цэвэр хөрөнгө оруулалтын нэг хэсэг байдлаар харгалзан үзвэл тэрхүү цэвэр хөрөнгө оруулалт нь ердөө 341 сая фунт стерлинг болох бөгөөд Стирлинг/Евроны эрсдлийн хувьд “Г” хяналт тавигч байгууллага хейжийн зүйл гэж сонгож болох дүн нь 500 сая фунт стерлингээс 341 сая фунт стерлинг болж, зохих ёсоор буурна.
- Б30. Хэрэв “Г” хяналт тавигч байгууллага нь “Б” хяналтанд буй байгууллагын сонгосон хейжийн харилцааг буцаасан бол уг “Г” хяналт тавигч байгууллага нь Евро/Долларын эрсдлийн хувьд “Б” хяналтанд буй байгууллагад оруулсан өөрийн 300 сая ам долларын цэвэр хөрөнгө оруулалтын хейж байдлаар тэрхүү “Б” хяналтанд буй байгууллагын эзэмшиж буй 300 сая ам долларын гаднын зээлийг сонгож болох бөгөөд өөрийн эзэмшиж буй фунт стерлингийн хейжийн хэрэглүүрийг “Б” хяналтанд буй байгууллагад оруулсан 341 сая фунт стерлинг хүртэлх цэвэр хөрөнгө оруулалтын хейж гэж сонгож болно. Энэ тохиолдолд хоёр хейжийн аль алины үр дүнтэй байдлыг уг “Г” хяналт тавигч байгууллагын бүртгэлийн валют (евро)-ыг лавлагаа болгосноор тооцоолно. Үүний үр дүнд “Б” хяналтанд буй байгууллагын эзэмшиж буй гаднын зээлийн үнэ цэнийн Доллар/Стирлингийн өөрчлөлт ба “Б” хяналтанд буй байгууллагад төлөх “Г” хяналт тавигч байгууллагын зээлийн өглөгийн үнэ цэнийн Стирлинг/Евроны өөрчлөлтийн аль алиныг (нийт дүнгээрээ Доллар/Евроны өөрчлөлттэй тэнцүү) “Г” хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцөд тусгана. “Г” хяналт тавигч байгууллага нь “Б” хяналтанд буй байгууллагад оруулсан өөрийн цэвэр хөрөнгө оруулалтаас үүсэх Евро/Долларын эрсдэлд аль хэдийн бүрэн хейж хийсэн учраас “Б” хяналтанд буй байгууллагад оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын Евро/Стирлингийн эрсдлийн хувьд ердөө 341 сая фунт стерлинг хүртэл дүнд хейж хийж болно.

Хавсралт В**Хавсралт В - Санхүүгийн өр төлбөрийг өмчийн хэрэглүүрээр барагдуулах**

Энэ хавсралт нь УСНББОУС 41-ийн саллигүй бүрэлдэхүүн хэсэг юм.

Танилцуулга

В1. Зээлдэгч нь зээлдүүлэгчид өмчийн хэрэглүүр гаргаж өгснөөр өр төлбөрийг бүрэн буюу хэсэгчлэн барагдуулсны үр дүнд зээлдэгч ба зээлдүүлэгч нь санхүүгийн өр төлбөрийн нөхцлийг дахин хэлэлцэн тохирч болох юм. Ийм ажил гүйлгээг зарим үед ‘өр ба өмчийн своп’ гэж нэрлэдэг.

Цар хүрээ

В2. Санхүүгийн өр төлбөрийн нөхцлийг дахин хэлэлцэн тохирох ба байгууллага нь өөрийн зээлдүүлэгчид өмчийн хэрэглүүр гаргаж өгснөөр санхүүгийн өр төлбөрийг бүрэн буюу хэсэгчлэн барагдуулах үр дүнтэй тохиолдол дахь тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийг энэхүү Хавсралтанд авч үзнэ.

В3. Байгууллага нь дараах нөхцөл дэх ажил гүйлгээний хувьд энэ Хавсралтыг мөрдөхгүй:

- (а) Зээлдүүлэгч нь мөн шууд буюу шууд бус хувьцаа эзэмшигч бөгөөд шууд буюу шууд бус хувьцаа эзэмшигч болохын хувьд өөрийн бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.
- (б) Уг ажил гүйлгээний өмнө болон дараа, нэг ижил тал буюу талууд тухайн байгууллага ба зээлдүүлэгчийг хянадаг бөгөөд тэрхүү ажил гүйлгээний мөн чанар нь байгууллагаас олгох өмчийн хуваарилалт эсвэл байгууллагад оруулах хувь оролцоог агуулсан байх.
- (в) Өмчийн хэрэглүүр гаргаж, санхүүгийн өр төлбөрийг барагдуулах нь тухайн санхүүгийн өр төлбөрийн анхны нөхцөлтэй нийцэж байх.

В4. Энэ Хавсралтанд дараах асуудлуудыг авч үзнэ:

- (а) Санхүүгийн өр төлбөрийг бүрэн буюу хэсэгчлэн барагдуулахын гаргасан байгууллагын өмчийн хэрэглүүр нь УСНББОУС 41-ийн 37-р параграфын дагуу ‘төлсөн төлбөр’ болох уу?
- (б) Байгууллага нь ийм санхүүгийн өр төлбөрийг барагдуулахын тулд гаргасан өмчийн хэрэглүүрийг анх хэрхэн хэмжих вэ?
- (в) Байгууллага нь барагдуулсан санхүүгийн өр төлбөрийн дансны үнэ ба гаргасан өмчийн хэрэглүүрийн анхны хэмжилтийн дүн хоорондох аливаа зөрүүг хэрхэн тайлагнах хэрэгтэй вэ?

Санал нэгтэй ойлголцол

В5. Санхүүгийн өр төлбөрийг бүрэн буюу хэсэгчлэн барагдуулахын тулд зээлдүүлэгчид олгох тухайн байгууллагын өмчийн хэрэглүүрийн гаргалт нь УСНББОУС 41-ийн 37-р параграфын дагуу ‘төлсөн төлбөр’ болно. Санхүүгийн өр төлбөрийг УСНББОУС 41-ийн 35-р параграфын дагуу барагдуулсан үед, зөвхөн тийм тохиолдолд байгууллага нь санхүүгийн өр төлбөрийг (буюу санхүүгийн өр төлбөрийн хэсгийг) өөрийн санхүүгийн байдлын тайлангаас хасна.

В6. Санхүүгийн өр төлбөрийг бүрэн буюу хэсэгчлэн барагдуулахын тулд зээлдүүлэгчид гаргаж өгсөн өмчийн хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрөх үед байгууллага нь бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадахгүй байхаас бусад тохиолдолд уг гаргасан өмчийн хэрэглүүрийг түүний бодит үнэ цэнээр хэмжинэ.

- В7. Гаргасан өмчийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадахгүй бол уг барагдуулсан санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийг тусгахын тулд тэрхүү өмчийн хэрэглүүрийг хэмжинэ. Шаардах шинжийг (жишээлбэл; харилцах ба хугацаагүй хадгаламж) агуулсан, уг барагдуулсан санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийг хэмжихдээ, УСНББОУС 41-ийн 68-р параграфыг мөрдөхгүй.
- В8. Санхүүгийн өр төлбөрийн зөвхөн тодорхой хэсгийг барагдуулсан бол уг төлсөн төлбөрийн зарим нь төлөгдөөгүй үлдсэн өр төлбөрийн нөхцлийг засварлан өөрчлөхтэй холбоотой эсэхийг байгууллага нь үнэлж үзнэ. Төлсөн төлбөрийн зарим хэсэг нь төлөгдөөгүй үлдсэн өр төлбөрийн нөхцлийн өөрчлөлттэй холбоотой бол байгууллага нь уг төлсөн төлбөрийг тухайн өр төлбөрийн барагдуулсан хэсэг ба төлөгдөөгүй үлдсэн тэрхүү хэсэгт хуваарилна. Ийм хуваарилалтыг хийхдээ байгууллага нь уг ажил гүйлгээнд хамаарах бүх холбогдох баримт материал болон нөхцөл байдлыг харгалзан үзнэ.
- В9. Барагдуулсан санхүүгийн өр төлбөрийн (буюу санхүүгийн өр төлбөрийн хэсгийн) дансны үнэ ба төлсөн төлбөрийн хоорондох зөрүүг УСНББОУС 41-ийн 37-р параграфын дагуу ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Уг гаргасан өмчийн хэрэглүүрийг тухайн санхүүгийн өр төлбөрийг (буюу өр төлбөрийн хэсгийг) барагдуулсан өдрөөр анх хүлээн зөвшөөрч, хэмжинэ.
- В10. Санхүүгийн өр төлбөрийн зөвхөн тодорхой хэсгийг барагдуулсан тохиолдолд уг төлсөн төлбөрийг В8-р параграфын дагуу хуваарилна. Төлөгдөөгүй үлдсэн өр төлбөрт хуваарилагдсан төлбөр нь тэрхүү үлдсэн өр төлбөрийн нөхцөл мэдэгдэхүйц өөрчлөгдсөн эсэх үнэлгээний нэг хэсгийг бүрдүүлнэ. Төлөгдөөгүй үлдсэн өр төлбөрийн нөхцөл мэдэгдэхүйц өөрчлөгдсөн бол УСНББОУС 41-ийн 36-р параграфтаар шаардсанчлан, байгууллага нь тэрхүү засвар өөрчлөлтийг уг анхны өр төлбөрийн барагдуулалт ба шинэ өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт байдлаар тайлагнана.
- В11. Дээрх В9 ба В10-р параграфын дагуу хүлээн зөвшөөрсөн олз, гарзыг байгууллага нь ашиг, алдагдалд эсвэл тодруулгад тусдаа мөрийн зүйл байдлаар тодруулах хэрэгтэй.

Бусад Стандартуудад оруулсан нэмэлт өөрчлөлтүүд**УСНББОУС 1, Санхүүгийн Тайлангийн Төлилуулга-д оруулсан нэмэлт өөрчлөлт**

7, 79, 82, 101, 102, 138-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 125А, 125Б, 125В, 153Н параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Тодорхойлолт

...

7. **Цэвэр хөрөнгө/өмч** гэдэг нь бүх өр төлбөрийг хассаны дараа уг байгууллагын хөрөнгөнд үлдэх хувь оролцоо юм.

Цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн нь хувь нийлүүлсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг буюу алдагдал, нөөц, хяналтын бус хувь оролцоо юм. Нөөцийн төрөлд дараах зүйлс хамаарна:

- (а) Дахин үнэлгээний нэмэгдлийн өөрчлөлт (УСНББОУС 17, *Үндсэн Хөрөнгө* ба УСНББОУС 31, *Биет Бус Хөрөнгө*-ийг үз);
- (б) Тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн дахин хэмжилт (УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ийг үз);
- (в) Гадаад үйл ажиллагааны санхүүгийн тайлангийн хөрвүүлэлтийн олз ба гарз (УСНББОУС 4, *Гадаад Валютын Ханиийн Өөрчлөлтийн Үр Нөлөө*-г үз);
- (г) УСНББОУС 41, *Санхүүгийн Хэрэглүүр*-ийн 106-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан, өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтаас үүссэн олз ба гарз;
- (д) УСНББОУС 41-ийн 41-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгөөс үүссэн олз ба гарз;
- (е) УСНББОУС 41-ийн 106-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн, өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтанд хейж хийх хейжийн хэрэглүүрийн олз, гарзын болон мөнгөн гүйлгээний хейж дэх хейжийн хэрэглүүрийн олз, гарзын үр дүнтэй хэсэг (УСНББОУС 41-ийн 113-155-р параграфыг үз);
- (ж) Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан тухайн өр төлбөрийн хувьд, өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтөнд хамаарах бодит үнэ цэнийн өөрчлөлтийн дүн (УСНББОУС 41-ийн 108-р параграфыг үз);
- (и) Опционы гэрээний дотоод үнэ цэнэ ба цаг хугацааны үнэ цэнийг салган зааглаж, уг опционы зөвхөн дотоод үнэ цэнийн өөрчлөлтийг хейжийн хэрэглүүр гэж сонгох тохиолдолд опционы цаг хугацааны үнэ цэнэд гарах өөрчлөлт (УСНББОУС 41-ийн 113-155-р параграфыг үз);
- (к) Форвард гэрээний форвард элемент ба спот элементийг салган зааглаж, зөвхөн спот элементийн үнэ цэнийн өөрчлөлтийг хейжийн хэрэглүүр гэж сонгох ба тухайн санхүүгийн хэрэглүүрийг хейжийн хэрэглүүр гэж сонгохдоо тэрхүү санхүүгийн хэрэглүүрийн гадаад валютын суурийн тархалтын үнэ цэнийн өөрчлөлтийг харгалзах

түсгахгүй байх үеийн форвард гэрээний форвард элементийн үнэ цэнийн өөрчлөлт (УСНББОУС 41-ийн 113-155-р параграфыг үз).

...

Санхүүгийн байдлын тайлан

...

Эргэлтийн хөрөнгө

...

79. Хэдийгээр тайлант үеийн эцсээс хойш 12 сарын дотор хэрэгжихээр хүлээгдээгүй байлаа ч гэсэн хэвийн үйл ажиллагааны циклийн нэг хэсэг болгон хөрөнгийг (татварын авлага, хэрэглэгчдээс авах авлага, торгуулийн болон зохицуулалтын хураамжийн авлага, бараа материал, хуримтлагдсан хөрөнгө оруулалтын авлага гэх мэт) хэрэгжүүлсэн, зарцуулсан буюу борлуулсан тохиолдолд түүнийг эргэлтийн хөрөнгөнд хамруулна. Юуны өмнө худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгө (жишээлбэл; УСНББОУС 41-д заасан УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зовшооролт ба Хэмжилт ийн дагуу худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй ~~гэж ангилсан~~, гэдэг тодорхойлолтыг хангах зарим санхүүгийн хөрөнгө) ба эргэлтийн бус санхүүгийн хөрөнгийн тайлант хугацаанд хамаарах хэсэг нь мөн эргэлтийн хөрөнгөнд хамаарна.

...

Богино хугацаат өр төлбөр

...

82. Бусад богино хугацаат өр төлбөр нь хэвийн үйл ажиллагааны циклийн нэг хэсэг байдлаар барагдахгүй боловч тайлант үеийн эцсээс хойш 12 сарын дотор барагдах хугацаатай эсвэл тэдгээрийг юуны өмнө худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж байдаг. Жишээлбэл; УСНББОУС 41-д заасан УСНББОУС 29-ийн дагуу худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй ~~гэж ангилсан~~ гэдэг тодорхойлолтыг хангах зарим санхүүгийн өр төлбөр, банкны овердрафт, урт хугацаат санхүүгийн өр төлбөрийн тайлант хугацаанд хамаарах хэсэг, ногдол ашгийн өглөг буюу адилтгах хуваарилалтын өглөг, орлогын албан татварын өглөг, бусад худалдааны бус өглөг. Урт хугацааны санхүүжилтээр хангах (өөрөөр хэлбэл, байгууллагын хэвийн үйл ажиллагааны циклд ашиглагдах ажлын капиталын нэг хэсэг болохгүй) ба тайлант үеийн эцсээс хойш 12 сарын дотор барагдуулахгүй санхүүгийн өр төлбөр нь 85 ба 86-р параграфуудын дагуу урт хугацаат өр төлбөр болох юм.

...

Санхүүгийн үр дүнгийн тайлан

...

101. Энэ Стандартад заасан орлого, зардлын тодорхойлолтыг хангаж болох боловч ашиг, алдагдалд ихэвчлэн оруулдаггүй зүйлсийг өөр бусад УСНББОУС-д заасан байдаг. Жишээлбэл; дахин үнэлгээний нэмэгдэл, үүнд: (а) гадаад үйл ажиллагааны санхүүгийн тайлангийн хөрвүүлэлтээс үүссэн олз ба гарз (УСНББОУС 4-ийг үзнэ үү), (б) цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгийн дахин хэмжилтээс үүссэн олз ба гарз (санхүүгийн хөрөнгийн хэмжилтийн талаархи заавар удирдамжийг УСНББОУС 41-ээс УСНББОУС 29-өөс үзэж болно).

...

Санхүүгийн үр дүнгийн тайланд толилуулах мэдээлэл

102. Санхүүгийн үр дүнгийн тайлан нь тухайн тайлант үеийн хувьд хамгийн наад зах нь дараах дүнгүүдийг толилуулах мөрийн зүйлсийг агуулсан байна:

- (a) **Орлого, доорх зүйлсийг тус тусад нь толилуулах:**
 - (i) **Үр ашигт хүүний аргыг ашиглан тооцоолсон хүүний орлого; ба**
 - (ii) **Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн олз ба гарз;**
- (б) Санхүүгийн зардал;
- (ба) **УСНББОУС 41-ийн 73-93-р параграфын дагуу тодорхойлсон үнэ цэнийн бууралтын гарз (үүн дотроо, үнэ цэнийн бууралтын гарз болон үнэ цэнийн бууралтын олзын буцаалт);**
- (в) Өмчийн арга ашиглан тайлагнасан хараат байгууллага ба хамтарсан үйлдвэрийн ашиг, алдагдал дахь хувь хэмжээ;
- (ва) **Санхүүгийн хөрөнгийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжихийн тулд хорогдуулсан өртгөөр хэмждэг ангиллаас гаргаж, дахин ангилсан бол тухайн санхүүгийн хөрөнгийн өмнөх хорогдуулсан өртөг ба уг дахин ангиллын өдрөөрх (УСНББОУС 41-д тодорхойлсон) түүний бодит үнэ цэнэ хоорондох зөрүүгээс үүссэн аливаа олз, гарз;**
- (вб) **Санхүүгийн хөрөнгийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжихийн тулд цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг ангиллаас гаргаж, дахин ангилсан бол өмнө нь цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрч байсан ба ашиг, алдагдалд дахин ангилсан аливаа хуримтлагдсан олз, гарз;**
- (г) Зогсоосон үйл ажиллагаанд хамаарах хөрөнгийн данснаас хасалт буюу өр төлбөрийн барагдуулалтаар хүлээн зөвшөөрсөн татварын өмнөх олз, гарз; ба
- (д) Ашиг, алдагдал.

...

Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

...

125А. Цэвэр хөрөнгө/өмчид өмнө нь хүлээн зөвшөөрч байсан дүнгүүдийг ашиг, алдагдалд дахин ангилах эсэх, хэзээ дахин ангилах эсэхийг бусад УСНББОУС-уудад тусгайлан заадаг. Ийм дахин ангиллыг энэхүү Стандартад дахин ангилах залруулга гэж нэрлэдэг. Залруулгыг ашиг, алдагдалд дахин ангилсан тухайн тайлант үед уг дахин ангилах залруулгыг цэвэр хөрөнгө/өмчийн холбогдох бүрэлдэхүүн хэсгийн хамтаар тусган оруулдаг. Эдгээр дүнгүүдийг тухайн тайлант үед эсвэл өмнөх тайлант үеүдэд хэрэгжээгүй олз байдлаар цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрч болох юм. Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд хоёр дахин тусгахаас зайлсхийхийн тулд уг хэрэгжсэн олзыг ашиг, алдагдалд дахин ангилсан тухайн тайлант үед тэдгээр хэрэгжээгүй олзыг цэвэр хөрөнгө/өмчөөс хасах ёстой.

125Б. Тухайлбал: гадаад үйл ажиллагааны данснаас хасалтаар (УСНББОУС 4-ийг үз), түүнчлэн хейж хийсэн, урьдчилан таамагласан зарим мөнгөн гүйлгээ нь ашиг, алдагдалд нөлөөлдөг (мөнгөн гүйлгээний хейжтэй холбоотойгоор УСНББОУС 41-ийн 140(г) параграфыг үз) тохиолдолд дахин ангилах залруулга үүсдэг.

125В. УСНББОУС 17 буюу УСНББОУС 31-ийн дагуу хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний нэмэгдлийн өөрчлөлтөөс, эсвэл УСНББОУС 39-ийн дагуу хүлээн зөвшөөрсөн, тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн дахин хэмжилтээс дахин ангилах залруулга үүсдэггүй. Эдгээр

бүрэлдэхүүн хэсгүүдийг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрдөг бөгөөд дараагийн тайлант үеүдэд ашиг, алдагдалд дахин ангилахгүй. Хөрөнгийг ашигласан буюу үл хүлээн зөвшөөрсөн дараагийн тайлант үеүдэд дахин үнэлгээний нэмэгдлийн өөрчлөлтийг хуримтлагдсан ашиг, алдагдалд шилжүүлж болох юм (УСНББОУС 17 буюу УСНББОУС 31-ийг үз). Хэрэв мөнгөн гүйлгээний хейж буюу опционы цаг хугацааны үнэ цэнийн тайлагнал (форвард гэрээний форвард элемент эсвэл санхүүгийн хэрэглүүрийн гадаад валютын суурийн тархалт) нь тухайн мөнгөн гүйлгээний хейжийн нөөцөөс хасагдах дүн эсвэл цэвэр хөрөнгө/өмчийн тусдаа бүрэлдэхүүн хэсгийг тус тус бий болгох үр дүнтэй бөгөөд хөрөнгө, өр төлбөрийн анхны өртөгт эсвэл дансны үнийн бусад дүнд шууд тусган оруулдаг бол УСНББОУС 41-ийн дагуу дахин ангиллын залруулга үүсэхгүй. Эдгээр дүнгүүдийг хөрөнгө буюу өр төлбөрт шууд шилжүүлдэг.

...

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулга

...

138. Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрдөхдөө, удирдлага нь санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дүнгүүдэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлж болох тооцоололтой холбоотойгоос өөр бусад, янз бүрийн шүүн тунгаалтуудыг хийдэг. Жишээлбэл; удирдлага нь дараах зүйлсийг тодорхойлохдоо шүүн тунгаалт хийдэг:

- Хөрөнгө нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө мөн эсэх;
- Тухайн зориулагдсан хөрөнгийн ашиглалттай холбоотой бараа, үйлчилгээгээр хангах хэлцэл нь түрээс мөн эсэх;
- Барааны тухайн тодорхой борлуулалт нь мөн чанарын хувьд санхүүжилтийн хэлцэл мөн, ингэснээр орлого үүсэхэд хүргэхгүй эсэх; ба
- Тайлагнагч байгууллага ба бусад байгууллагуудын хоорондох харилцааны мөн чанар нь тэдгээр бусад байгууллагуудыг уг тайлагнагч байгууллага хянадаг гэдгийг илэрхийлдэг эсэх; ба
- Санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцлүүд нь үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд зөвхөн болох гэрээний мөнгөн гүйлгээг тусгайлан заасан өдрүүдээр үүсэхэд хүргэдэг эсэх.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

153Н. 2018 оны 8 дугаар сард гаргасан, УСНББОУС 41-ээр 7, 79, 82, 101, 102, 138-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 125А, 125Б, 125В параграфыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд УСНББОУС 41-ийг мөн уг өмнөх тайлант хугацаанд дагаж мөрдөнө.

...

УСНББОУС 4, Гадаад Валютын Ханиийн Өөрчлөлтийн Үр Нөлөө-нд оруулсан нэмэлт өөрчлөлт

3, 4, 5, 31, 61-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 71Г параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Цар хүрээ

...

3. Нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь энэ Стандартыг дараах тохиолдолд мөрдөнө:

- (a) УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр-ийн ~~УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжээлт-ийн~~ цар хүрээнд хамаарах үүсмэл хэрэглүүрийн ажил гүйлгээ ба түүний үлдэгдлээс бусад гадаад валютаар гарсан ажил гүйлгээ болон үлдэгдлийг тайлагнахад;
- (б) Нэгтгэл буюу өмчийн аргын дагуу тухайн байгууллагын санхүүгийн тайланд тусган оруулсан гадаад дахь үйл ажиллагааны санхүүгийн үр дүн болон санхүүгийн байдлыг хөрвүүлэхэд;
- (в) Байгууллагын санхүүгийн үр дүн болон санхүүгийн байдлыг толилуулгын валютанд хөрвүүлэхэд.

4. Гадаад валютаарх маш олон үүсмэл хэрэглүүрийн хувьд УСНББОУС 41-ийг ~~УСНББОУС 29-ийг~~ мөрддөг тул тэдгээрийг энэ Стандартын цар хүрээнд хамруулаагүй. Харин УСНББОУС 41-ийн ~~УСНББОУС 29-ийн~~ цар хүрээнд хамаардаггүй, гадаад валютаарх үүсмэл хэрэглүүрүүд (жишээлбэл; өөр гэрээнүүдийг дагалдах гадаад валютаарх зарим үүсмэл хэрэглүүр) нь энэ Стандартын цар хүрээнд хамаарна. Түүнчлэн, байгууллага нь үүсмэл хэрэглүүрт хамаарах дүнгүүдийг өөрийн бүртгэлийн валютаас толилуулгын валютанд хөрвүүлэхдээ энэхүү Стандартыг даган мөрдөнө.

5. Гадаад валютаарх зүйлсийн хейжийн нягтлан бодох бүртгэл, үүн дотроо гадаад үйл ажиллагааны цэвэр хөрөнгө оруулалтын хейжийн хувьд энэ Стандартыг мөрдөхгүй. Хейжийн нягтлан бодох бүртгэлийн хувьд УСНББОУС 41-ийг ~~УСНББОУС 29-ийг~~ мөрдөнө.

...

Ханшийн зөрүүгийн хүлээн зөвшөөрөлт

31. 5-р параграфт дурдсанчлан, гадаад валютын зүйлсийн хейжийн нягтлан бодох бүртгэлд энэхүү Стандартыг мөрдөхгүй. Хейжийн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой заавар удирдамж, үүн дотроо хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэзээ ашиглах талаархи шалгуурыг УСНББОУС 41-ээс ~~УСНББОУС 29-өөс~~ үзэж болно.

...

Тодруулга

...

61. Байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:

- (a) УСНББОУС 41-ийн ~~УСНББОУС 29-ийн~~ дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хэрэглүүрээс үүссэн ханшийн зөрүүгээс бусад, ашиг алдагдалд хүлээн зөвшөөрсөн ханшийн зөрүүгийн дүн.
- (б) Цэвэр хөрөнгө/өмчийн тусдаа бүрэлдэхүүн хэсэгт ангилсан ханшийн цэвэр зөрүү болон уг ханшийн зөрүүгийн тухайн тайлант үеийн эхэн ба эцэс дэх дүнгүүдийн хоорондох тохируулгын тайлан.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

71Г. 2018 оны 8 дугаар сард гаргасан, УСНББОУС 41-ээр 3, 4, 5, 31, 61-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд УСНББОУС 41-ийг мөн уг өмнөх тайлант хугацаанд дагаж мөрдөнө.

...

УСНББОУС 9, *Арилжааны Ажил Гүйлгээний Орлого*-д оруулсан нэмэлт өөрчлөлт

10-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 41Г параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Цар хүрээ

...

10. Дараах зүйлсээс үүссэн орлогыг энэ Стандартад авч үзэхгүй:

- (а) Түрээсийн гэрээ (УСНББОУС 13, *Түрээс*-ийг үзнэ үү);
- (б) Өмчийн аргын дагуу тайлагнадаг хөрөнгө оруулалтаас үүссэн ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт (УСНББОУС 36, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт*-ыг үзнэ үү);
- (в) Үндсэн хөрөнгийн борлуулалтаас үүссэн олз (УСНББОУС 17, *Үндсэн хөрөнгө*-нд авч үздэг);
- (г) Даатгалын гэрээг авч үздэг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартын цар хүрээнд хамаарах даатгалын гэрээ;
- (д) Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт эсвэл тэдгээрийн данснаас хасалт (УСНББОУС 41, *Санхүүгийн Хэрэглүүр*-ийг үзнэ үү санхүүгийн хэрэглүүрийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийн талаархи заавар удирдамжийг УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба Хэмжилт-ээ харж болно);
- (е) Бусад эргэлтийн хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлт;
- (ж) Хөдөө аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой биологийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлт ба түүний бодит үнэ цэнийн өөрчлөлт (УСНББОУС 27, *Хөдөө Аж Ахуй*-г үзнэ үү);
- (и) Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний анхны хүлээн зөвшөөрөлт (УСНББОУС 27-г үзнэ үү); ба
- (к) Ашигт малтмалын олборлолт.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

41Г. 2018 оны 8 дугаар сард гаргасан, УСНББОУС 41-ээр 10-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь энэхүү нэмэлт өөрчлөлтийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед энэхүү нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд УСНББОУС 41-ийг мөн уг өмнөх тайлант хугацаанд дагаж мөрдөнө.

...

Хэрэгжүүлэх заавар удирдамж

Энэхүү хэрэгжүүлэх заавар удирдамж нь УСНББОУС 9-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

...

Үйлчилгээ үзүүлэх

...

Санхүүгийн үйлчилгээний хураамж

ХЗУ12. Санхүүгийн үйлчилгээний хураамжийн хувьд орлогын хүлээн зөвшөөрөлт нь (а) ийм хураамж авах зорилго, ба (б) аливаа холбогдох санхүүгийн хэрэглүүрийн нягтлан бодох бүртгэлийн сууриас хамаардаг. Санхүүгийн үйлчилгээний хураамжийн нэр утга нь тухайн үзүүлсэн үйлчилгээний шинж төрөл ба мөн чанарыг илэрхийлэхгүй байж болно. Иймээс санхүүгийн хэрэглүүрийн үр ашигт өгөөжийн салшгүй нэг хэсэг болох хураамж, үйлчилгээ үзүүлснээр авах хураамж, чухал үйлдлийг гүйцэтгэснээр авах хураамжийг өөр хооронд нь ялган зааглах шаардлагатай байдаг.

(а) Санхүүгийн хэрэглүүрийн үр ашигт өгөөжийн салшгүй нэг хэсэг болох хураамж

Ийм хураамжийг үр ашигт хүүний хувь хэмжээний тохируулга гэж ерөнхийдөө үздэг. Гэвч бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрснөөр тухайн санхүүгийн хэрэглүүрийг бодит үнэ цэнээр хэмждэг тохиолдолд уг хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрөх үед хураамжийг орлого гэж хүлээн зөвшөөрнө.

(i) УСНББОУС 41-ийн УСНББОУС 29-ийн дагуу “ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн” санхүүгийн хөрөнгө гэж ангилдагаас бусад, санхүүгийн хөрөнгийг бий болгох буюу худалдан авахтай холбоотойгоор тухайн байгууллагын хүлээн авсан үүсгэлтийн хураамж

Ийм хураамж нь зээлдэгчийн санхүүгийн нөхцөл байдлыг үнэлэх, баталгаа, барьцаа болон бусад аюулгүй байдлын арга хэмжээг үнэлэх ба бүртгэх, санхүүгийн хэрэглүүрийн нөхцлийг хэлэлцэн тохирох, баримт бичгийг бэлтгэж боловсруулах, ажил гүйлгээг дуусгаж, хаах гэх мэт үйл ажиллагааны нөхөн төлбөрийг багтаасан байж болно. Эдгээр хураамж нь уг үр дүн болох санхүүгийн хэрэглүүртэй холбоотой оролцоог бий болгох үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг бөгөөд тэдгээрийг холбогдох ажил гүйлгээний зардлын хамтаар (УСНББОУС 41-д УСНББОУС 29-д тодорхойлсон) хойшлуулж, үр ашигт хүүний хувь хэмжээний тохируулга байдлаар хүлээн зөвшөөрнө.

(ii) *Зээл олгох баталгаа нь УСНББОУС 41-ийн УСНББОУС 29-ийн цар хүрээнд хамаарахгүй тохиолдолд зээлийг үүсгэхийн тулд уг байгууллагын хүлээн авсан баталгааны хураамж.*

Байгууллага нь тодорхой нэг зээлийн хэлцлийг байгуулах нилээд их магадлалтай бөгөөд зээл олгох баталгаа нь УСНББОУС 41-ийн УСНББОУС 29-ийн цар хүрээнд хамаарахгүй тохиолдолд уг хүлээн авсан баталгааны хураамжийг тухайн

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

санхүүгийн хэрэглүүрийн худалдан авалттай холбоотой байнгын оролцооны нөхөн төлбөр гэж үзэх бөгөөд тэдгээрийг холбогдох ажил гүйлгээний зардлын хамтаар (УСНББОУС 41-д УСНББОУС 29-д тодорхойлсон) хойшлуулж, үр ашигт хүүний хувь хэмжээний тохируулга байдлаар хүлээн зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь зээл олгохгүйгээр уг баталгааны хугацаа дууссан бол хураамжийг тэрхүү хугацаа дууссан өдрөөр орлого гэж хүлээн зөвшөөрнө. УСНББОУС 41-ийн УСНББОУС 29-ийн цар хүрээнд хамаарах, зээл олгох баталгааг үүсмэл хэрэглүүр гэж тайлагнах бөгөөд бодит үнэ цэнээр нь хэмжинэ.

- (iii) *Хорогдуулсан өртгөөр нь хэмждэг санхүүгийн өр төлбөрийг гаргаснаар хүлээн авах үүсгэлтийн хураамж*

Ийм хураамж нь санхүүгийн өр төлбөртэй холбоотой оролцоог бий болгох үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг юм. Санхүүгийн өр төлбөрийг “ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн” гэж ангилдаггүй тохиолдолд уг хүлээн авсан үүсгэлтийн хураамжийг холбогдох ажил гүйлгээний гарсан зардлын хамтаар (УСНББОУС 41-д УСНББОУС 29-д тодорхойлсон) тухайн санхүүгийн өр төлбөрийн анхны дансанд үнэд тусган оруулж, үр ашигт хүүний хувь хэмжээний тохируулга байдлаар хүлээн зөвшөөрнө. Байгууллага нь санхүүгийн өр төлбөрийн үр ашигт хүүний хувь хэмжээний салшгүй нэг хэсэг болох хураамж ба зардлыг хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ гэх мэт үйлчилгээ үзүүлэх эрхтэй холбоотой үүсгэлтийн хураамж ба ажил гүйлгээний зардлаас тусад нь ялгаж үзнэ.

(б) **Үйлчилгээг үзүүлснээр авах хураамж**

- (i) *Зээл олгох үйлчилгээний хураамж*

Зээл олгох үйлчилгээний хувьд байгууллагын авах хураамжийг тухайн үйлчилгээг үзүүлснээр орлого гэж хүлээн зөвшөөрнө.

- (ii) *УСНББОУС 41-ийн УСНББОУС 29-ийн цар хүрээнд хамаардаггүй зээл олгох баталгааны хураамж*

Тодорхой нэг зээлийн хэлцлийг байгуулах магадлал багатай бөгөөд зээл олгох баталгаа нь УСНББОУС 41-ийн УСНББОУС 29-ийн цар хүрээнд хамаарахгүй тохиолдолд уг зээл олгох баталгааны хураамжийг тухайн баталгааны хугацаанд цаг хугацаатай хувь тэнцүүлсэн сууриар орлого гэж хүлээн зөвшөөрнө. УСНББОУС 41-ийн УСНББОУС 29-ийн цар хүрээнд хамаарах, зээл олгох баталгааг үүсмэл хэрэглүүр гэж тайлагнах бөгөөд бодит үнэ цэнээр нь хэмжинэ.

- (iii) *Хөрөнгө оруулалтын менежментийн хөлс*

Хөрөнгө оруулалтын менежментийн хөлсийг тухайн үйлчилгээг үзүүлснээр орлого гэж хүлээн зөвшөөрнө.

Хөрөнгө оруулалтын менежментийн гэрээний аюулгүй байдлыг хангахад шууд хамааралтай өсөн нэмэгдэх зардлыг тусдаа тодорхойлж, найдвартай хэмжиж чадах ба тэдгээр нь нөхөгдөх нилээд их магадлалтай тохиолдолд түүнийг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө. УСНББОУС 41-д УСНББОУС 29-д заасанчлан, ийм өсөн нэмэгдэх зардал нь хэрэв байгууллага тухайн хөрөнгө оруулалтын менежментийн гэрээний аюулгүй байдлыг хангаагүй бол гарахааргүй байсан зардал юм. Хөрөнгө нь хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлснээр үүсэх өгөөжийг хүртэх уг байгууллагын гэрээний эрхийг илэрхийлэх бөгөөд холбогдох орлогыг тухайн байгууллага хүлээн зөвшөөрөхийн хирээр түүнийг хорогдуулна. Хэрэв байгууллага нь хөрөнгө оруулалтын менежментийн гэрээнүүдийн багцтай бол тэдгээр гэрээний нөхөгдөх байдлыг багцаар нь үнэлж болно.

Санхүүгийн үйлчилгээний зарим гэрээ нь нэг буюу хэд хэдэн санхүүгийн хэрэглүүрийг үүсгэх ба хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны аль алиныг агуулсан байдаг. Жишээлбэл; өмчийн үнэт цааснуудын багцын менежменттэй уялдсан, сар тутмын хадгаламжийн урт

хугацаат гэрээ. Ийм гэрээгээр хангагч нь тухайн санхүүгийн хэрэглүүрийг үүсгэхтэй холбоотой ажил гүйлгээний зардлыг тэрхүү хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээг үзүүлэх эрхийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон зардлаас ялган зааглана.

(в) **Чухал үйлдлийг гүйцэтгэснээр авах хураамж**

Доорх жишээнд дурдсанчлан, чухал үйлдлийг гүйцэтгэсэн үед хураамжийг орлого гэж хүлээн зөвшөөрнө.

(i) *Үйлчлүүлэгчид оролцооны хувийг хуваарилсаны хураамж*

Оролцооны хувийг хуваарилсан үед хураамжийг орлого гэж хүлээн зөвшөөрнө.

(ii) *Зээлдэгч ба хөрөнгө оруулагчийн хооронд зээлийг зохион байгуулсаны төлөөх байршуулалтын хураамж*

Зээлийг зохион байгуулсан үед хураамжийг орлого гэж хүлээн зөвшөөрнө.

(iii) *Зээлийн түншлэлийн хураамж*

Зээл олгох ажиллагааг зохион байгуулдаг бөгөөд зээлийн багцын тодорхой нэг хэсгийг өөртөө авч үлддэггүй (эсвэл бусад оролцогчдын эрсдэлтэй адил, зэрэгцүүлэгдэх эрсдлийн хувьд тухайн үр ашигт хүүний хувиар тооцогдох тодорхой зарим хэсгийг авч үлддэг) байгууллагын хүлээн авсан зээлийн түншлэлийн хураамж нь түншлэлийн үйлчилгээний нөхөн төлбөр юм. Ийм хураамжийг уг түншлэлийг хийсэн үед орлого гэж хүлээн зөвшөөрнө.

...

УСНББОУС 12, *Бараа Материал*-д оруулсан нэмэлт өөрчлөлт

2-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 51Д параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Цар хүрээ

...

2. **Нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар Санхүүгийн тайлангаа бэлтгэн толилуулж буй байгууллага нь доор дурдсанаас бусад бүх бараа материалд энэ Стандартыг мөрднө:**

(a) **Барилгын гэрээний, түүнчлэн шууд холбоотой үйлчилгээний гэрээний дагуу үүссэн дуусаагүй үйлдвэрлэл (УСНББОУС 11, *Барилгын Гэрээ*-г үзнэ үү);**

(б) **Санхүүгийн хэрэглүүр (УСНББОУС 28, *Санхүүгийн хэрэглүүр: Толилуулга ба УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр-ийг УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт-ийг* үзнэ үү);**

(в) **Хөдөө аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой биологийн хөрөнгө ба үр шим хүртэх үеийн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн (УСНББОУС 27, *Хөдөө Аж Ахуй*-г үзнэ үү); ба**

(г) **Үйлчилгээг хүлээн авагчаас хариуд нь төлбөр шууд авахгүй эсвэл нэрлэсэн төлбөр авснаар нийлүүлэх үйлчилгээний дуусаагүй үйлдвэрлэл.**

...

51Д. 2018 оны 8 дугаар сард гаргасан, УСНББОУС 41-ээр 2-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь энэхүү нэмэлт өөрчлөлтийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрднө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө

эхлэх тайлант үед энэхүү нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд УСНББОУС 41-ийг мөн уг өмнөх тайлант хугацаанд дагаж мөрдөнө.

...

УСНББОУС 14, Тайлангийн Өдрийн Дараах Үйл Явдал-д оруулсан нэмэлт өөрчлөлт

11-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 32Е параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Тайлангийн өдрийн дараах залруулагдах үйл явдал

...

11. Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дүнгээ залруулах эсвэл өмнө хүлээн зөвшөөрөөгүй зүйлсээ хүлээн зөвшөөрөхийг тухайн байгууллагаас шаарддаг тайлангийн өдрийн дараах ийм залруулагдах үйл явдлын жишээг доор дурдав:

- (a) Тайлангийн өдрөөр тухайн байгууллага ийм одоогийн үүрэгтэй байсан гэдгийг баталгаажуулах шүүхийн заргаан маргаан нь уг тайлангийн өдрийн дараа шийдвэрлэгдэх. Байгууллага нь энэхүү шүүхийн маргаантай холбоотойгоор УСНББОУС 19, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө*-ийн дагуу өмнө хүлээн зөвшөөрсөн аливаа нөөцийн дүнг залруулах буюу шинээр нөөцийг хүлээн зөвшөөрнө. Зарга маргааны шийдвэрлэлт нь УСНББОУС 19-ийн 24-р параграфын дагуу харгалзан үзвэл зохих нэмэлт нотолгоогоор хангах учраас байгууллага нь болзошгүй өр төлбөрийн талаар зөвхөн тодруулга хийгээд орхихгүй юм.
- (б) Тайлангийн өдрөөр хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсвэл тухайн хөрөнгийн хувьд өмнө нь хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзны дүнг залруулах шаардлагатай гэдгийг илэрхийлэх мэдээллийг тэрхүү тайлангийн өдрийн дараа хүлээн авсан. Жишээлбэл:
 - (i) ~~Тайлангийн өдрийн дараа гарч тохиолдсон худалдан авагчийн дампуурал нь тэрхүү тайлант үеийн эцэст уг зээлдэгчийн зээлийн үнэлэмж буурсан тайлангийн өдрөөр авлагын дансанд аль хэдийн гарз үүссэн байсан бөгөөд авлагын дансны үнийг тухайн байгууллага залруулах шаардлагатай байсан гэдгийг ихэвчлэн батлан илэрхийлдэг; ба~~
 - (ii) Тайлангийн өдрийн дараах бараа материалын борлуулалт нь уг тайлангийн өдрөөрх тэрхүү бараа материалын цэвэр боломжит үнэ цэнийн талаархи нотолгоо болж болох юм.
- (в) Тайлангийн өдрөөс өмнө худалдан авсан хөрөнгийн өртөг эсвэл борлуулсан хөрөнгийн орлогыг уг тайлангийн өдрийн дараа тодорхойлох;
- (г) Тухайн тайлант үеийн туршид хүчин төгөлдөр байсан орлого-хуваах гэрээний дагуу засгийн газрын өөр нэг байгууллагатай хуваах ёстой бөгөөд уг тайлант үед цуглуулсан орлогын дүнг тэрхүү тайлангийн өдрийн дараа тодорхойлсон;
- (д) Тайлангийн өдрөөс өмнөх үйл явдлын үр дүнд тухайн тайлангийн өдрөөр байгууллага нь ажиллагчиддаа үр дүнгийн урамшуулал олгох гэрээний буюу гэрээний бус одоогийн үүрэгтэй байсныг тэрхүү тайлангийн өдрийн дараа тодорхойлсон; ба
- (е) Тухайн санхүүгийн тайлан буруу гэдгийг илэрхийлэх залилан эсвэл алдааг илрүүлсэн.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

- 32Е. 2018 оны 8 дугаар сард гаргасан, УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр-ээр 11-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь энэхүү нэмэлт өөрчлөлтийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед энэхүү нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд УСНББОУС 41-ийг мөн уг өмнөх тайлант хугацаанд дагаж мөрдөнө.

...

УСНББОУС 19, Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө-нд оруулсан нэмэлт өөрчлөлт

4-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 111И параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Цар хүрээ

...

4. УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр-ийн УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжээт-ийн цар хүрээнд хамаарах санхүүгийн хэрэглүүрт (үүн дотроо баталгаанд) энэ Стандартыг мөрдөхгүй.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

- 111И. 2018 оны 8 дугаар сард гаргасан, УСНББОУС 41-ээр 4-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь энэхүү нэмэлт өөрчлөлтийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед энэхүү нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд УСНББОУС 41-ийг мөн уг өмнөх тайлант хугацаанд дагаж мөрдөнө.

...

Хэрэгжүүлэх заавар удирдамж

Энэхүү хэрэгжүүлэх заавар удирдамж нь УСНББОУС 19-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

Ганц баталгаа

- ХЗУ14. Өрөн нутгийн засаг захиргаа нь нийтийн үйлчилгээг төлбөртэйгээр үзүүлэх хувийн хэвшлийн оператор компанийн тодорхой зээлд 2004 оны туршид баталгаа гаргасан бөгөөд тэр үед уг операторын Санхүүгийн нөхцөл байдал нь сайн байсан. 2005 онд уг операторын санхүүгийн байдал муудаж, 2005 оны 6 дугаар сарын 30-нд уг оператор компани нь дампуурлаа зарласан.

Зээлийн гаргагч нь даатгалын гэрээг зохицуулах олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартуудын дагуу ийм гэрээг даатгалын гэрээ гэж үзэх сонголт

~~хийснээс бусдаар тухайн гэрээ нь УСНББОУС 29-д заасан, санхүүгийн баталгааны гэрээний тодорхойлолтыг хангаж байна. УСНББОУС 29-ийн цар хүрээнд хамаарах санхүүгийн баталгааны гэрээний хувьд УСНББОУС 29-ийн шаардлагуудыг даган мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишээ нь дараах байдалтай байна.~~

Шинжилгээ

~~(а) 2004 оны 12 дугаар сарын 31 нээр~~

~~Үүрэг хүлээлгэх онгөрсөн үйл явдлын үр дүн болох одоогийн үүрэг—Хуулийн ёсны үүрэг үүсгэх уг баталгаа гаргалт нь үүрэг хүлээлгэх үйл явдал болно.~~

~~Үүргийг барагдуулахад эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нооцийг зарцуулна—2004 оны 12 дугаар сарын 31 нээр үр өгөөжийг зарцуулах магадлалгүй байна.~~

Дүгнэлт

~~Уг баталгааг бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрнө.~~

Шинжилгээ

~~(б) 2005 оны 12 дугаар сарын 31 нээр~~

~~Үүрэг хүлээлгэх онгөрсөн үйл явдлын үр дүн болох одоогийн үүрэг—Хуулийн ёсны үүрэг үүсгэх уг баталгаа гаргалт нь үүрэг хүлээлгэх үйл явдал болно.~~

~~Үүргийг барагдуулахад эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нооцийг зарцуулна—2005 оны 12 дугаар сарын 31 нээр уг үүргийг барагдуулахын тулд эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нооцийг зарцуулах нилээд магадлалтай байна.~~

Дүгнэлт

~~Уг баталгааг дараагийн тайлант үед доорх хоёр дүнгийн аль ондрөөр хэмжинэ: (а) үүргийн хамгийн сайн тооцоолол (22, 31, 109-р параграфуудыг үзнэ үү), ба (б) анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс тохиромжтой бол УСНББОУС 9, *Арилжааны Ажил Гүйлгээний Орлого*-ын дагуу тооцсон, хуримтлагдсан хорөгдуулгыг хассан дүн.~~

...

УСНББОУС 21, Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт-д оруулсан нэмэлт өөрчлөлт

2, 9, 13-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 82К параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Цар хүрээ

...

2. **Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь доор дурдсанаас бусад, мөнгө бий болгодоггүй хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тайлагнахдаа энэ Стандартыг мөрднө.**

(а) **Бараа материал (УСНББОУС 12, *Бараа Материал*-ыг үзнэ үү);**

(б) **Барилгын гэрээнээс үүссэн хөрөнгө (УСНББОУС 11, *Барилгын гэрээ*-г үзнэ үү);**

- (в) УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр-ийн УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт-ийн цар хүрээнд хамаарах санхүүгийн хөрөнө;
- (г) Бодит үнэ цэнийн загвар ашиглан хэмждэг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө (УСНББОУС 16, *Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө*-ийг үзнэ үү);
- (д) [Хассан]
- (е) [Хассан]
- (ж) Үнэ цэнийн бууралтын талаархи нягтлан бодох бүртгэлийн шаардлагууд нь өөр УСНББОУС-д тусгагдсан бусад хөрөнгүүд.

...

9. УСНББОУС 28, *Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга*-ын цар хүрээнд хамаарах санхүүгийн хөрөнгийн хувьд энэ Стандартыг мөрдөхгүй. Эдгээр хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг УСНББОУС 41-д УСНББОУС 29-д авч үзсэн.

...

13. Дараах байгууллагуудад оруулсан хөрөнгө оруулалтууд нь УСНББОУС 41-ийн УСНББОУС 29-ийн цар хүрээнд хамаарахгүй санхүүгийн хөрөнгүүд юм:

- (а) УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*-д тодорхойлсон хяналтанд буй байгууллагууд;
- (б) УСНББОУС 36, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт*-д тодорхойлсон хараат байгууллага;
- (в) УСНББОУС 37, *Хамтын Хэлэлцээр*-т тодорхойлсон хамтын хэлэлцээр.

Ийм хөрөнгө оруулалтыг мөнгө бий болгогч хөрөнгө гэж ангилдаг бол түүнийг УСНББОУС 26-гийн дагуу тайлагнана. Харин эдгээр хөрөнгө оруулалт нь мөнгө бий болгодоггүй хөрөнгө бол тэдгээрийг энэ Стандартын дагуу тайлагнана.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

- 82К. 2018 оны 8 дугаар сард гаргасан, УСНББОУС 41-ээр 2, 9, 13-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд УСНББОУС 41-ийг мөн уг өмнөх тайлант хугацаанд дагаж мөрдөнө.

...

УСНББОУС 23, *Арилжааны Бус Ажил Гүйлгээний Орлого (Татвар ба Шилжүүлэг)*-д оруулсан нэмэлт өөрчлөлт

- 43, 105А параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 124Е параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үеийн хэмжилт

...

43. Арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн хөрөнгийг УСНББОУС 12, *Бараа Материал*, УСНББОУС 16, *Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө*, УСНББОУС 17-ийн, УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр-ийн дагуу уг олж эзэмшсэн өдрөөрх тэдгээрийн бодит үнэ цэнээр хэмжинэ.

...

Хөнгөлөлттэй зээл

- 105А. Хөнгөлөлттэй зээл нь зах зээлийн нөхцлөөс хөнгөлөлттэйгээр уг байгууллагын авсан зээл юм. Аливаа хүүний төлбөрийн хамт буцаан төлөх зээлийн хэсэг нь арилжааны ажил гүйлгээ болох бөгөөд түүнийг УСНББОУС 41-ийн УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт-ийн дагуу тайлагнана. Анх хүлээн зөвшөөрөх үеийн ажил гүйлгээний үнэ (зээлийн орлого) ба зээлийн бодит үнэ цэнийн (УСНББОУС 41-ийг УСНББОУС 29-ийг үзнэ үү) хоорондох аливаа зөрүү нь энэ Стандартын дагуу тайлагнавал зохих арилжааны бус орлого эсэхийг байгууллага нь харгалзан үзнэ.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

- 124Е. 2018 оны 8 дугаар сард гаргасан, УСНББОУС 41-ээр 43, 105А параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд УСНББОУС 41-ийг мөн уг өмнөх тайлант хугацаанд дагаж мөрдөнө.

...

Хэрэгжүүлэх заавар удирдамж

Энэхүү хэрэгжүүлэх заавар удирдамж нь УСНББОУС 23-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

...

Хөнгөлөлттэй зээл (105А ба 105Б параграф)

- ХЗУ54. Байгууллага нь дараагийн 5 жилийн хугацаанд 10 сургууль барихын тулд олон талын хөгжлийн агентлагаас 6 сая ТН-ийн санхүүжилт хүлээн авсан. Санхүүжилтийг дараах нөхцөлтэйгээр олгосон:

- Хэрэв сургуулиудыг баривал 1 сая ТН-ийн санхүүжилтийг буцаан төлөх шаардлагагүй.
- 5 сая ТН-ийн санхүүжилтийг дараах байдлаар буцаан төлнө:

Жил 1: Үндсэн дүнгээс буцаан төлөхгүй

Жил 2: Үндсэн дүнгийн 10 хувийг буцаан төлнө

Жил 3: Үндсэн дүнгийн 20 хувийг буцаан төлнө

Жил 4: Үндсэн дүнгийн 30 хувийг буцаан төлнө

Жил 5: Үндсэн дүнгийн 40 хувийг буцаан төлнө

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

- Зээлийн хугацаанд жил тутам 5 хувийн хүү тооцно (хүүний өглөгийг жил бүр төлнө гэж төсөөлөх). Адилтгах зээлийн зах зээлийн хүүний түвшин 10 хувь байсан.
- Сургуулиудыг бариагүй тохиолдолд хүлээн авсан санхүүжилтийг хандивлагчид буцааж төлнө (уг хандивлагч нь үр дүнтэй хяналт үнэлгээний системтэй бөгөөд аливаа зарцуулаагүй мөнгө санг буцаахыг шаарддаг өмнөх туршлагатай гэж төсөөлөх).
- Тус байгууллага нь зээлийн хугацаанд дараах байдлаар сургуулиудыг барьсан:
 - Жил 1: 1 сургууль барьсан
 - Жил 2: 3 сургууль барьсан
 - Жил 3: 5 сургууль барьсан
 - Жил 4: 10 сургууль барьсан

Шинжилгээ

Тус байгууллага нь 1 сая ТН-ийн буцалтгүй тусламж болон 5 сая ТН-ийн зээлийг үр дүнтэйгээр хүлээн авсан (Жич: уг 1 сая ТН-ийн хөрөнгө нь мөн чанарын хувьд эздийн хувь оролцоо эсвэл орлого эсэхийг тухайн байгууллага харгалзан үзнэ; энэ жишээний хувьд 1 сая ТН-ийн орлого гэж үзнэ). Мөн тус байгууллага нь 784,550 ТН-ийн нэмэлт буцалтгүй тусламжийг хүлээн авсан (Энэ нь 5 сая ТН-ийн зээлийн орлого ба 10 хувийн зах зээлийн холбогдох хүүний түвшинг ашиглан дискаунтчилсан уг зээлийн гэрээний мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийн хоорондох зөрүү юм).

1 сая ТН дээр 784,550ТН-ийг нэмсэн дүн болох буцалтгүй тусламжийг энэ Стандартын дагуу тайлагнах бөгөөд тухайн зээл, түүний гэрээний холбогдох хүү ба үндсэн дүнгийн төлөлтийг УСНББОУС 41-ийн ~~УСНББОУС 29-ийн~~ дагуу тайлагнана.

1. Анх хүлээн зөвшөөрөх үед тус байгууллага нь дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

Дебит	Банкны харилцах данс	ТН 6,000,000	
	Кредит	Зээлийн өглөг	ТН 4,215,450
	Кредит	Өр төлбөр	ТН 1,784,550

2. Жил 1: тус байгууллага нь дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

Дебит	Өр төлбөр	ТН 178,455	
	Кредит	Арилжааны бус орлого	ТН 178,455

(Барих сургуулийн 1/10 x ТН 1,784,550)

(Жич: энэ жишээ нь хөнгөлөлттэй зээлээс үүсэх орлогын хүлээн зөвшөөрөлтийг үлгэрчлэн харуулах зорилготой тул хүүний болон үндсэн дүнгийн буцаан төлөлт, хүүний хуримтлуулалтыг бүртгэх журналын бичилтүүдийг харуулаагүй болно. Дэлгэрэнгүй жишээг УСНББОУС 41-ийн ~~УСНББОУС 29-ийн~~ Үлгэрчилсэн жишээнд харуулсан.)

3. Жил 2: тус байгууллага нь дараах байдлаар хүлээн зөвшөөрнө (дараагийн тайлант үед байгууллага нь уг хөнгөлөлттэй зээлийг хорогдуулсан өртгөөр хэмждэг гэж төсөөлөх):

Дебит	Өр төлбөр	ТН 356,910	
	Кредит	Арилжааны бус орлого	ТН 356,910

(Барих сургуулийн 3/10 x ТН 1,784,550 – өмнө хүлээн зөвшөөрсөн дүн ТН 178,455)

4. Жил 3: тус байгууллага нь дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

Дебит	Өр төлбөр	ТН 356,910	
	Кредит	Арилжааны бус орлого	ТН 356,910

(Барих сургуулийн 5/10 x ТН 1,784,550 – өмнө хүлээн зөвшөөрсөн дүн ТН 535,365)

5. Жил 4: тус байгууллага нь дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Дебит	Өр төлбөр	ТН 892,275	
	Кредит	Арилжааны бус орлого	ТН 892,275

(Бүх сургуулиуд баригдсан: ТН 1,784,550 –ТН 892,275)

Хэрэв уг хөнгөлөлттэй зээлийг ямар нэг нөхцөлгүйгээр олгосон бол анх хүлээн зөвшөөрөх үед тус байгууллага нь дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

Дебит	Банкны харилцах данс	ТН 6,000,000	
	Кредит	Зээлийн өглөг	ТН 4,215,450
	Кредит	Арилжааны бус орлого	ТН 1,784,550

УСНББОУС 23 ба УСНББОУС 41-ийн хэмжилтийн шаардлагуудын хоорондох уялдаа

Танилцуулга

ХЗУ55. 20X8 оны 01-р сарын 01-нд хувь хүн нь хөрөнгийн биржид бүртгэлтэй Х байгууллагын хувьцааг улсын секторын А байгууллагад хандивласан. Тухайн өдөр Х байгууллагын хувьцаа нь 1,000,000 ТН-ийн бодит үнэ цэнэтэй байсан. 20X8 оны 12 дугаар сарын 31-нд хувьцааны бодит үнэ цэнэ нь 900,000 ТН болсон. Уг хэлцлийн нэг хэсэг болгон А байгууллага нь тэдгээр хувьцааг өөрийн нэр дээр болгох шилжүүлгийн хураамжийг хариуцсан. Хураамжийн зардлын дүн 10,000 ТН юм.

ХЗУ56. Хөрөнгийн биржид бүртгэлтэй Х байгууллага нь харилцаа холбооны дэд бүтцийн үйлчилгээ болон холбогдох үйлчилгээг олон нийтэд үзүүлдэг. 20X9 онд харилцаа холбооны салбарт шинэ технологи нэвтрүүлснээр тус Х байгууллагын ашигладаг дэд бүтэц ба тоног төхөөрөмж нь бараг хоцрогдолд орсон. Энэ нь хөрөнгийн биржид бүртгэлтэй Х байгууллагын үнэ цэнэд байнгын бууралт гарахад хүргэсэн. 20X9 оны 12 дугаар сарын 31-нд үнэ цэнийн бууралтын гарзны дүн 700,000 ТН байсан. Хувьцааг худалдаа арилжааны зорилгоор эзэмшдэггүй тохиолдолд А байгууллага нь хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалтыг цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг. Тохиролцоо нь гэрээний тохиролцоо бөгөөд хандив тусламжаас одоогийн үүрэг үүсдэггүй, уг байгууллагын тайлант үе нь 20X8 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болдог.

Шинжилгээ

ХЗУ57. А байгууллага нь хувьцааг хандив байдлаар хүлээн авдаг тул уг олж эзэмшсэн хувьцаа ба холбогдох арилжааны бус орлогыг анх хүлээн зөвшөөрөхдөө УСНББОУС 23-ыг мөрдөнө. Харин А байгууллага нь санхүүгийн хөрөнгийг олж авсан тул УСНББОУС 23 ба УСНББОУС 41-ийн анхны хэмжилтийн шаардлагуудыг харгалзан үзнэ.

ХЗУ58. Санхүүгийн хөрөнгийг анх бодит үнэ цэнээр хэмждэг бөгөөд тэдгээрийн ангиллаас хамааран ажил гүйлгээний зардлыг тусган оруулж, эсвэл оруулахгүй байж болно гэж УСНББОУС 41-д заасан, харин УСНББОУС 23 нь арилжааны бус орлогын ажил гүйлгээний нэг хэсэг байдлаар олж эзэмшсэн хөрөнгийг анх бодит үнэ цэнээр хэмжинэ гэж заасан. Байгууллага нь хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалтыг цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих бодлоготой тул 10,000 ТН-ийн ажил гүйлгээний зардлыг анх хүлээн зөвшөөрөхдөө хувьцааны 1,000,000 ТН-ийн үнэ цэнэ дээр нэмдэг.

ХЗУ59. Хувьцааны дараагийн тайлант үеийн хэмжилт ба үл хүлээн зөвшөөрөлтийг УСНББОУС 41-д авч үздэг. Хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалтыг байгууллага нь цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих нь бодит үнэ цэнийн дараагийн тайлант үеийн аливаа өөрчлөлтийг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрснөөр хувьцааг бодит үнэ цэнээр хэмжинэ гэсэн утгатай юм. Гэвч ногдол ашгийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг.

Анхны олж эзэмшилтийн өдөр болон тухайн тайлангийн өдөр хийх журналын бичилтүүд нь дараах байдалтай байна:

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

1. Хандиваар хувьцааг олж эзэмшилт:

Дебит	Х байгууллагад оруулсан хөрөнгө оруулалт	ТН 1,010,000
Кредит	Арилжааны бус орлого	ТН 1,000,000
Кредит	Харилцах данс (төлсөн ажил гүйлгээний зардал)	ТН 1,784,550

2. 20X8 оны 12 дугаар сарын 31-нээрх дараагийн тайлант үеийн хэмжилт:

Дебит	Цэвэр хөрөнгө/өмч (хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн залруулга)	ТН 110,000
Кредит	Х байгууллага дахь хөрөнгө оруулалт	ТН 110,000

3. 20X9 оны 12 дугаар сарын 31-нээрх дараагийн тайлант үеийн хэмжилт:

Дебит	Үнэ цэнийн бууралтын гарз (цэвэр хөрөнгө/өмч)	ТН 700,000
Кредит	Х байгууллага дахь хөрөнгө оруулалт	ТН 700,000

...

УСНББОУС 26, Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт-д оруулсан нэмэлт өөрчлөлт

2, 9, 12-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 126М параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Цар хүрээ

...

2. **Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь доор дурдсанаас бусад, мөнгө бий болгогч хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тайлагнахдаа энэ Стандартыг мөрдөнө:**

- (а) **Бараа материал (УСНББОУС 2, Бараа Материал-ыг үзнэ үү);**
- (б) **Барилгын гэрээнээс үүссэн хөрөнгө (УСНББОУС 11, Барилгын Гэрээ-г үзнэ үү);**
- (в) **УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр-ийн ~~УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зовшооролт ба Хэмжилт-ийн~~ цар хүрээнд хамаарах санхүүгийн хөрөнгө;**
- (г) ...

...

9. **УСНББОУС 28, Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга-ын цар хүрээнд хамаарах аливаа санхүүгийн хөрөнгөнд энэ Стандартыг мөрдөхгүй. Эдгээр хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг УСНББОУС 41-д ~~УСНББОУС 29-д~~ авч үзнэ.**

...

12. Дараах этгээдэд оруулсан хөрөнгө оруулалт нь УСНББОУС 41-ийн ~~УСНББОУС 29-ийн~~ цар хүрээнд хамаарахгүй санхүүгийн хөрөнгө юм:

- (а) УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*-д тодорхойлсон, хяналтанд буй байгууллагууд;
- (б) УСНББОУС 36, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт*-д тодорхойлсон хараат байгууллагууд;
- (в) УСНББОУС 37, *Хамтын Хэлэлцээр*-т тодорхойлсон хамтын хэлэлцээрүүд.

Эдгээр хөрөнгө оруулалт нь мөнгө бий болгогч хөрөнгийн шинж чанартай байх тохиолдолд тэдгээрийг энэ Стандартын дагуу тайлагнана. Эдгээр хөрөнгө оруулалт нь мөнгө бий болгодоггүй хөрөнгийн шинж чанартай байх тохиолдолд тэдгээрийг УСНББОУС 21-ийн дагуу тайлагнана.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

126М. 2018 оны 8 дугаар сард гаргасан, УСНББОУС 41-ээр 2, 9, 12-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд УСНББОУС 41-ийг мөн уг өмнөх тайлант хугацаанд дагаж мөрдөнө.

...

УСНББОУС 28, Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга-д оруулсан нэмэлт өөрчлөлт

2, 3, 4, 9, 10, 14, 28, 36, 47, 48, МЗУ2, МЗУ55-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, МЗУ63-р параграфыг хассан ба 60Е, МЗУ63А, МЗУ63Б, МЗУ63В, МЗУ63Г, МЗУ63Д, МЗУ63Е параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

Зорилго

...

2. Энэ Стандартад заасан зарчмууд нь санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрч, хэмжих УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр-ийн ~~УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжээлт~~ ~~ийн~~ зарчмууд болон санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийн талаархи мэдээллийг тодруулах УСНББОУС 30, *Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга*-ын зарчмуудын нэмэлт гүйцээлт юм.

...

Цар хүрээ

3. **Нягтлан бодох бүртгэлийн аккрузл суурийн дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь доор дурдсанаас бусад бүх төрлийн санхүүгийн хэрэглүүрийн хувьд энэ Стандартыг мөрдөнө:**

- (а) УСНББОУС 35, Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан, УСНББОУС 34, Тусдаа Санхүүгийн Тайлан, УСНББОУС 36, Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө

Оруулалт-ын дагуу тайлагнадаг хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоо. Гэвч зарим тохиолдолд УСНББОУС 34, УСНББОУС 35, УСНББОУС 36 нь хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоог УСНББОУС 41-ийг ~~УСНББОУС 29-ийг~~ ашиглан тайлагнахыг байгууллагаас шаарддаг буюу зөвшөөрдөг; ийм тохиолдолд байгууллагууд нь энэ Стандартын шаардлагуудыг мөрдөнө. Мөн байгууллагууд нь хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоотой холбоотой бүх үүсмэл хэрэглүүрийн хувьд энэ Стандартыг мөрдөнө.

- (б) УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ийг мөрдөх ажилтны тэтгэмжийн хөтөлбөрийн дагуу хүлээх ажил олгогчийн эрх ба үүрэг;
- (в) Даатгалын гэрээнээс үүссэн үүрэг. Гэвч доорх зүйлсийн хувьд энэ Стандартыг мөрдөнө:
 - (i) Даатгалын гэрээнүүдийг дагалдах, үүсмэл хэрэглүүрийг хэрэв УСНББОУС 41 ~~УСНББОУС 29~~ нь тусдаа тайлагнахыг уг байгууллагаас шаарддаг бол дагалдах үүсмэл хэрэглүүрт;
 - (ii) Гаргагч нь тухайн гэрээг хүлээн зөвшөөрөх ба хэмжихдээ УСНББОУС 41-ийг ~~УСНББОУС 29-ийг~~ мөрддөг боловч уг гаргагч нь тэдгээрийг хүлээн зөвшөөрөх ба хэмжихдээ даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг мөрдөх сонголт хийсэн тохиолдолд тэрхүү стандартыг мөрддөг санхүүгийн баталгааны гэрээ.

Дээрх (i) ба (ii)-д дурдснаас гадна, байгууллага нь санхүүгийн эрсдлийн шилжүүлгийг агуулсан даатгалын гэрээний хувьд энэхүү Стандартыг мөрдөж болох юм.

- (г) Сонголттой оролцох шинжийг агуулсан учраас даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартын цар хүрээнд хамаарах санхүүгийн хэрэглүүрүүд. Ийм санхүүгийн хэрэглүүрийн гаргагч нь санхүүгийн өр төлбөр ба өмчийн хэрэглүүрийн хоорондох ялгаатай байдлын талаархи энэ Стандартын 13-37-р болон МЗУ49-МЗУ60-р параграфуудыг эдгээр шинжүүдэд мөрдөхөөс чөлөөлөгдөнө. Харин эдгээр хэрэглүүр нь энэ Стандартын бусад бүх шаардлагуудад захирагдана. Түүнчлэн, эдгээр хэрэглүүрийг дагалдах, үүсмэл хэрэглүүрүүдэд энэ Стандартыг мөрдөнө (УСНББОУС 41-ийг ~~УСНББОУС 29-ийг~~ үзнэ үү).
 - (д) Хувьцаанд суурилсан төлбөрийг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг мөрдөх доор дурдснаас бусад, хувьцаанд суурилсан төлбөртэй ажил гүйлгээний дагуух санхүүгийн хэрэглүүр, гэрээ ба үүрэг:
 - (i) Энэ Стандартын 4-6-р параграфын цар хүрээнд хамаарах бөгөөд энэ Стандартыг мөрдөх гэрээнүүд;
 - (ii) Ажилтны хувьцааны опционы хөтөлбөр, ажилтны хувьцаа худалдан авах хөтөлбөр болон хувьцаанд суурилсан төлбөр бүхий бусад бүх хэлцэлтэй холбоотойгоор худалдан авсан, борлуулсан, гаргасан буюу хүчингүй болгосон бөгөөд энэ Стандартын 38 ба 39-р параграфыг мөрдөх халаасны хувьцаа.
4. Санхүүгийн бус зүйлийг худалдан авах буюу борлуулах бөгөөд цэвэр дүнгээр нь мөнгөөр буюу бусад санхүүгийн хэрэглүүрээр барагдуулах, эсвэл санхүүгийн хэрэглүүрүүдээр солилцож болох гэрээнүүдэд, тэдгээр гэрээ нь өөрөө санхүүгийн хэрэглүүр байсан мэтээр энэхүү Стандартыг мөрдөнө; харин байгууллагын хүлээгдэж буй худалдан авалт, борлуулалт буюу ашиглалтын шаардлагуудын дагуу санхүүгийн бус зүйлийг хүлээн авах эсвэл өгөх зорилгоор байгуулсан ба ийм зорилгоор үргэлжлүүлэн эзэмшиж буй гэрээнүүдэд хамаарахгүй. Гэвч байгууллага нь УСНББОУС 41-ийн 6-р параграфын дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилдаг гэрээнүүдэд энэхүү Стандартыг мөрдөнө.

...

Тодорхойлолт

...

9. Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

...

Санхүүгийн өр төлбөр нь дараах аливаа өр төлбөр юм:

- (a) Доорх гэрээний үүрэг:
- (i) Өөр байгууллагад мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг өгөх; эсвэл
 - (ii) Санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрийг тухайн байгууллагад тааламжгүй байх нөхцлөөр өөр байгууллагатай солилцох; эсвэл
- (б) Тухайн байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрээр барагдуулах буюу барагдуулж болох гэрээ ба үүнд:
- (i) Уг байгууллага нь өөрийн өмчийн хэрэглүүрийг тогтмол бус тоо ширхэгээр өгөх үүрэг хүлээсэн буюу хүлээж болох үүсмэл бус хэрэглүүр; эсвэл
 - (ii) Тухайн байгууллагын тогтмол тоо ширхэгтэй өөрийн өмчийн хэрэглүүрийн хариуд тогтмол дүн бүхий мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг солилцохоос бусад байдлаар барагдуулах буюу барагдуулж болох үүсмэл хэрэглүүр. Энэ зорилгын хувьд хэрэв байгууллага нь өөрийн үүсмэл бус өмчийн хэрэглүүрийн тухайн нэг ангийн одоогийн бүх эздэд хувь тэнцүүлсэн байдлаар эрх, опцион, баталгааг санал болгодог бол уг байгууллагын тогтмол тоо ширхэгтэй өөрийн өмчийн хэрэглүүрийг тогтмол дүн бүхий аливаа валютаар худалдан авах эрх, опцион, баталгаа нь өмчийн хэрэглүүр юм. Мөн эдгээр зорилгын хувьд тухайн байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрт дараах зүйлс хамаарахгүй: 15 ба 16-р параграфын дагуу өмчийн хэрэглүүр гэж ангилсан буцаах эрхтэй санхүүгийн хэрэглүүр; тухайн байгууллагыг зөвхөн татан буулгах үед түүний цэвэр хөрөнгөөс хувь тэнцүүлэн нөгөө талдаа өгөх үүргийг уг байгууллагад хүлээлгэдэг бөгөөд 17, 18-р параграфын дагуу өмчийн хэрэглүүр гэж ангилсан хэрэглүүр; тухайн байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрийг ирээдүйд хүлээн авах эсвэл өгөх тийм гэрээ болох хэрэглүүр.

Хэрэв санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангах хэрэглүүр нь 15, 16-р параграфт эсвэл 17, 18-р параграфт заасан бүх шинжүүдтэй ба нөхцлүүдийг хангаж байвал гажих тохиолдол болгон уг хэрэглүүрийг өмчийн хэрэглүүр гэж ангилна.

10. Дараах нэр томъёог УСНББОУС 41-ийн 9-р параграфт болон УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт-ийн 10-р параграфт тодорхойлсон бөгөөд тэдгээрт түүнд заасан утгаар энэхүү Стандартад хэрэглэнэ:

- Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртөг;
- Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө;
- Үл хүлээн зөвшөөрөлт Үл хүлээн зөвшөөрөх;
- Үүсмэл хэрэглүүр;
- Үр ашигт хүүний арга;
- Санхүүгийн баталгааны гэрээ;

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

- Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн ~~хөрөнгө буюу санхүүгийн~~ өр төлбөр;
- Арилжааны баталгаа;
- Урьдчилан таамагласан ажил гүйлгээ;
- Хейжийн үр дүнтэй байдал;
- Хейжийн зүйл;
- Хейжийн хэрэглүүр;
- ~~Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт;~~
- ~~Зээл ба авлага;~~
- Худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй;
- Ердийн нөхцөлтэй худалдан авалт буюу борлуулалт;
- Ажил гүйлгээний зардал.

...

14. Санхүүгийн хэрэглүүр нь санхүүгийн өр төлбөр биш, харин өмчийн хэрэглүүр болох эсэхийг тодорхойлохын тулд гаргагч нь 9-р параграфт заасан тодорхойлолтыг ашиглах бол дараах (а) ба (б) заалтанд дурдсан нөхцлүүд хоёулаа хангагдаж байх зөвхөн тийм тохиолдолд уг хэрэглүүрийг өмчийн хэрэглүүр гэж үзнэ.

- (а) Уг хэрэглүүр нь доорх гэрээний үүргийг агуулаагүй байх:
- (i) Өөр байгууллагад мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг өгөх; эсвэл
 - (ii) Санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрийг тухайн гаргагчийн хувьд тааламжгүй байх нөхцлөөр өөр байгууллагатай солилцох.
- (б) Хэрэв уг хэрэглүүрийг тухайн гаргагчийн өөрийн өмчийн хэрэглүүрээр барагдуулах буюу барагдуулж болох бол энэ нь:
- (i) Гаргагч өөрийн өмчийн хэрэглүүрийг тогтмол бус тоо ширхэгээр өгөх тийм гэрээний үүргийг агуулаагүй үүсмэл бус хэрэглүүр байх; эсвэл
 - (ii) Гаргагч тогтмол тоо ширхэгтэй өөрийн өмчийн хэрэглүүрийн хариуд тогтмол дүн бүхий мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг солилцсоноор зөвхөн барагдуулж болох үүсмэл хэрэглүүр байх. Энэ зорилгын хувьд хэрэв байгууллага нь өөрийн үүсмэл бус өмчийн хэрэглүүрийн тухайн нэг ангийн одоогийн бүх эздэд хувь тэнцүүлсэн байдлаар эрх, опцион, баталгааг санал болгодог бол уг байгууллагын тогтмол тоо ширхэгтэй өөрийн өмчийн хэрэглүүрийг тогтмол дүн бүхий аливаа валютаар худалдан авах эрх, опцион, баталгаа нь өмчийн хэрэглүүр юм. Мөн эдгээр зорилгын хувьд гаргагчийн өөрийн өмчийн хэрэглүүрт дараах хэрэглүүр хамаарахгүй: 15, 16-р параграфт эсвэл 17, 18-р параграфт заасан бүх шинжүүдтэй ба нөхцлүүдийг хангах хэрэглүүр; тухайн гаргагчийн өөрийн өмчийн хэрэглүүрийг ирээдүйд хүлээн авах эсвэл өгөх тийм гэрээ болох хэрэглүүр.

Гэрээний үүрэг, үүн дотроо үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс үүссэн үүрэг нь тухайн гаргагчийн өөрийн өмчийн хэрэглүүрийг ирээдүйд хүлээн авах эсвэл өгөхөд хүргэдэг буюу хүргэж болох боловч дээрх (а) ба (б)-д заасан нөхцлийг хангахгүй, иймээс өмчийн хэрэглүүр биш юм. Хэрэв санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангах хэрэглүүр нь 15, 16-р параграфт эсвэл 17, 18-р параграфт заасан бүх шинжүүдтэй ба нөхцлүүдийг хангаж байвал гажих тохиолдол болгон уг хэрэглүүрийг өмчийн хэрэглүүр гэж ангилна.

...

28. 15, 16-р параграф эсвэл 17, 18-р параграфуудад заасан нөхцлүүдийг гажих тохиолдолд өөрийн өмчийн хэрэглүүрийг мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгөөр худалдан авах тухайн байгууллагын үүргийг агуулсан гэрээ нь уг эргэлтээс гаргах дүнгийн (жишээлбэл; буцаан худалдан авах форвард үнэ, опционыг хэрэгжүүлэх үнэ буюу эргэлтээс гаргах бусад дүнгийн) өнөөгийн үнэ цэнийн хэмжээгээр санхүүгийн өр төлбөр үүсэхэд хүргэнэ. Хэдийгээр уг гэрээ нь өөрөө өмчийн хэрэглүүр байсан ч гэсэн ийм нөхцөл байдал үүсдэг. Форвард гэрээний дагуу өөрийн өмчийн хэрэглүүрийг мөнгөөр худалдан авах уг байгууллагын үүрэг нь үүний нэг жишээ болно. Санхүүгийн өр төлбөрийг тухайн эргэлтээс гаргах дүнгийн өнөөгийн үнэ цэнээр анх хүлээн зөвшөөрөх ба УСНББОУС 29-ийн дагуу эхлээд хүлээн зөвшөөрдөг тохиолдолд түүний бодит үнэ цэнийг (эргэлтээс гаргах дүнгийн өнөөгийн үнэ цэнийг) цэвэр хөрөнгө/өмчөөс дахин ангилдаг. Уг санхүүгийн өр төлбөрийг дараа нь УСНББОУС 41-ийн УСНББОУС 29-ийн дагуу хэмжинэ. Хэрэв хөрөнгө өгөөгүй байхад тухайн гэрээний хугацаа дууссан бол уг санхүүгийн өр төлбөрийн дансны үнээр нь цэвэр хөрөнгө/өмчид дахин ангилна. Хэдийгээр өөрийн өмчийн хэрэглүүрийг худалдан авах тухайн байгууллагын гэрээний үүрэг нь нөгөө тал эргэлтээс гаргах өөрийн эрхийг хэрэгжүүлэх эсэхээс (жишээ нь; байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрийг тухайн байгууллагад тогтмол үнээр борлуулах эрхийг нөгөө талд олгодог, гаргасан буцаах эрхтэй опцион) нөхцөлт хамааралтай боловч уг худалдан авах гэрээний үүрэг нь тэрхүү эргэлтээс гаргах дүнгийн өнөөгийн үнэ цэнийн хэмжээгээр санхүүгийн өр төлбөр үүсэхэд хүргэнэ.

...

41. УСНББОУС 41 ~~УСНББОУС 29~~ нь санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн хэмжилтийг тодорхойлдог. Өмчийн хэрэглүүр нь бүх өр төлбөрийг хассаны дараа байгууллагын хөрөнгөнд үлдэх хувь оролцоог илэрхийлдэг хэрэглүүр юм. Иймээс нийлмэл санхүүгийн хэрэглүүрийн анхны дансны үнийг түүний бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваарилах үед тухайн хэрэглүүрт бүхэлд нь хамаарах бодит үнэ цэнээс өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсгийн хувьд тусад нь тодорхойлсон дүнг хассаны дараах уг үлдэх дүнгээр цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлно. Тухайн нийлмэл санхүүгийн хэрэглүүрт агуулагдаж буй аливаа үүсмэл хэсгүүд (дуудах опцион гэх мэт) нь цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгийг (өмчид хөрвөх опцион гэх мэт) бүрдүүлж байхаас бусад тохиолдолд тэдгээрийг өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсэгт хамааруулна. Анхны хүлээн зөвшөөрөлтөөр өр төлбөрийн болон цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваарилсан дансны үнүүдийн нийлбэр нь бүхэлдээ уг хэрэглүүрт хамааруулах байсан бодит үнэ цэнэтэй ямагт тэнцүү байна. Хэрэглүүрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тус тусад нь анх хүлээн зөвшөөрөх үед ямар нэгэн олз, гарз үүсэхгүй.

...

Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийг харилцан суутгаж, цэвэр дүн гаргалт (Мөн МЗУ63А-МЗУ63Е параграфыг үзнэ үү)

47. Зөвхөн дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийг харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах бөгөөд уг цэвэр дүнг санхүүгийн байдлын тайланд толилуулна:
- (а) Байгууллага нь одоогоор уг хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг харилцан суутгаж, цэвэр дүн гаргах хууль ёсны хүчин төгөлдөр эрхтэй байх; ба
 - (б) Байууллага нь цэвэр дүнгээр барагдуулах эсвэл хөрөнгийг борлуулж, өр төлбөрийг үүнтэй нэгэн зэрэг барагдуулах төлөвлөгөөтэй байх.

Үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаагүй санхүүгийн хөрөнгийн шилжүүлэлтийг тайлагнахдаа тухайн байгууллага нь уг шилжүүлсэн хөрөнгө ба холбогдох өр төлбөрийг харилцан суутгаж, цэвэр дүнг гаргахгүй (УСНББОУС 41-ийн УСНББОУС 29-ийн 33 38-р параграфыг үзнэ үү).

48. Хоёр буюу хэд хэдэн тусдаа санхүүгийн хэрэглүүрийг барагдуулснаар үүсэх байгууллагын ирээдүйн хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг тусгах тийм байдлаар санхүүгийн хөрөнгө ба

санхүүгийн өр төлбөрийг цэвэр сууриар толилуулахыг энэхүү Стандартаар шаарддаг. Байгууллага нь нэг цэвэр дүнгээр төлбөрийг хүлээн авах буюу барагдуулах эрхтэй бөгөөд ингэж цэвэр дүнгээр хийхээр төлөвлөж байгаа тохиолдолд энэ нь үнэн хэрэгтээ зөвхөн нэг санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөртэй адил байна. Бусад тохиолдолд санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийг тэдгээрийн шинж чанарт нийцүүлэн тухайн байгууллагын нөөц буюу үүрэг байдлаар нэг нэгнээс нь тусдаа толилуулдаг. Байгууллага нь УСНББОУС 30-ийн 17А параграфын цар хүрээнд хамаарах уг хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хэрэглүүрийн хувьд УСНББОУС 30-ийн 17Б-17Д параграфээр шаардсан мэдээллийг тодруулна.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

60Е. 2018 оны 8 дугаар сард гаргасан, УСНББОУС 41-ээр 2, 3, 4, 9, 10, 14, 28, 36, 47, 48, МЗУ2, МЗУ55-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, МЗУ63-р параграфыг хассан ба 60Е, МЗУ63А, МЗУ63Б, МЗУ63В, МЗУ63Г, МЗУ63Д, МЗУ63Е параграфыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд УСНББОУС 41-ийг мөн уг өмнөх тайлант хугацаанд дагаж мөрдөнө.

...

Мөрдөх заавар удирдамж

Энэ Хавсралт нь УСНББОУС 28-ын салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.

...

МЗУ2 Энэ Стандартад санхүүгийн хэрэглүүрийн хүлээн зөвшөөрөлт буюу хэмжилтийг авч үзэхгүй. Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн хэмжилт, хүлээн зөвшөөрөлтийн талаархи шаардлагуудыг УСНББОУС 41-д УСНББОУС 29-д заасан.

...

Нийлмэл санхүүгийн хэрэглүүр (33-37-р параграф)

МЗУ55. Үүсмэл бус нийлмэл санхүүгийн хэрэглүүрийн гаргагч л 33-р параграфыг мөрдөнө. 33-р параграф нь эзэмшигчийн зүгээс авч үзсэн нийлмэл санхүүгийн хэрэглүүрт хамаарахгүй. Эзэмшигчийн зүгээс авч үзвэл, Өр ба өмчийн хэрэглүүрийн аль алины шинжийг агуулан нийлмэл санхүүгийн хэрэглүүрийн эзэмшигчийн зүгээс авч үзсэн, дагалдах үүсмэл хэрэглүүрийн ялган тусгаарлалтыг болох санхүүгийн хөрөнгийн ангилал ба хэмжилтийг УСНББОУС 41-д УСНББОУС 29-д авч үзсэн.

...

Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийг харилцан суутгаж, цэвэр дүн гаргалт (47-55-р параграф)

МЗУ63. Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийг харилцан суутгаж, цэвэр дүн гаргахын тулд байгууллага нь одоогоор уг хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг харилцан суутгаж, цэвэр дүн гаргах хууль ёсны хүчин төгөлдөр эрхтэй байх ёстой. Цэвэр дүнгээр тооцох мастер хэлцэл буюу зарим хэлбэрийн баталгаагүй өр гэх мэт тохиолдолд байгууллага нь хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг харилцан суутгаж, цэвэр дүн гаргах нөхцөлт эрхтэй байж болох бөгөөд ийм эрх нь зөвхөн нрээдүйн зарим үйл явдал гарч тохиолдсон, ихэвчлэн нөгөө тал үүргээ үл биелүүлсэн үед хууль

~~ёсоор хүчин төгөлдөр хэрэгждэг. Ийм учраас ийм хэлцэл нь харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах нөхцлийг хангадаггүй.~~

Байгууллага нь 'одоогоор уг хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах хууль ёсны хүчин төгөлдөр эрхтэй' эсэх шалгуур (47(а) параграф)

МЗУ63А. Харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах эрх нь одоогоор бэлэн боломжтой эсвэл ирээдүйн үйл явдлаас болзошгүй хамааралтай байж болох юм (жишээлбэл; оролцогч нөгөө талуудын аль нэг нь төлбөрийн үүргээ үл биелүүлэх, төлбөрийн чадваргүй болох, дампуурах гэх мэт ирээдүйн зарим үйл явдал гарч тохиолдсоноор зөвхөн эрх үүсдэг буюу хэрэгждэг байж болно). Харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах эрх нь ирээдүйн үйл явдлаас болзошгүй хамаардаггүй боловч хэвийн үйл ажиллагааны явцад, эсвэл оролцогч нөгөө талуудын аль нэг нь төлбөрийн үүргээ үл биелүүлсэн, эсвэл төлбөрийн чадваргүй болсон буюу дампуурсан тохиолдолд зөвхөн хууль ёсны хүчин төгөлдөр болж болох юм.

МЗУ63Б. 47(а) параграфт заасан шалгуурыг хангахын тулд байгууллага нь одоогоор харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах хууль ёсны хүчин төгөлдөр эрхтэй байх ёстой. Энэ нь харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах эрх дараах байдалтай байна гэсэн утгыг илэрхийлнэ:

(а) Ирээдүйн үйл явдлаас хамаардаг болзошгүй байх ёсгүй; ба

(б) Дараах бүх нөхцөлд хууль ёсоор хүчин төгөлдөр болох ёстой:

(i) Хэвийн үйл ажиллагааны явцад;

Оролцогч нөгөө талуудын аль нэг нь

(ii) Төлбөрийн үүргээ үл биелүүлсэн; ба

(iii) Төлбөрийн чадваргүй болсон буюу дампуурсан.

МЗУ63В. Харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах эрхийн шинж төрөл ба хэмжээ, үүн дотроо эрхийн хэрэгжилтэнд хамаарах аливаа нөхцөл, түүнчлэн төлбөрийн үүргээ үл биелүүлсэн, эсвэл төлбөрийн чадваргүй болсон буюу дампуурсан тохиолдолд эрх хэвээр хадгалагдах эсэх нь улс орон бүрд өөр өөр байж болно. Иймээс харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах эрх нь хэвийн үйл ажиллагааны явцаас бусад тохиолдолд автоматаар шууд хэрэгжих боломжтой байдаг гэж үзэж болохгүй юм. Тухайлбал; зарим нөхцөлд төлбөрийн чадваргүй болсон буюу дампуурсан тохиолдолд тухайн улсын дампуурлын буюу төлбөрийн чадваргүй байдлын хуулиар ингэж харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах эрхийг хориглодог эсвэл хязгаарладаг байж болно.

МЗУ63Г. Харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах эрх нь хэвийн үйл ажиллагааны явцад, тухайн байгууллага болон оролцогч бүх нөгөө талууд төлбөрийн үүргээ үл биелүүлсэн, төлбөрийн чадваргүй болсон буюу дампуурсан тохиолдолд хүчин төгөлдөр хэрэгжих эсэхийг (МЗУ63Б-гийн (б)-д тусгайлан зааснаар) тодорхойлохын тулд талуудын хоорондох харилцаанд хамаарах хуулийг (жишээлбэл; гэрээний заалт, тухайн гэрээг зохицуулах хууль, тэдгээр талуудад хамаарах үл биелүүлэлт, төлбөрийн чадваргүй байдал буюу дампуурлын хуулиудыг) харгалзан үзэх шаардлагатай байдаг.

Байгууллага нь 'цэвэр дүнгээр барагдуулах эсвэл хөрөнгийг борлуулж, өр төлбөрийг үүнтэй нэгэн зэрэг барагдуулах төлөвлөгөөтэй' эсэх шалгуур (47(б) параграф)

МЗУ63Д. 47(б) параграфт заасан шалгуурыг хангахын тулд байгууллага нь цэвэр дүнгээр барагдуулах эсвэл хөрөнгийг борлуулж, өр төлбөрийг үүнтэй нэгэн зэрэг барагдуулах төлөвлөгөөтэй байх ёстой. Хэдийгээр байгууллага нь цэвэр дүнгээр барагдуулах эрхтэй байж болох боловч хөрөнгийг борлуулж, өр төлбөрийг тусад нь барагдуулах эрхтэй хэвээр байж болно.

МЗУ63Е. Үр дүн нь үнэн хэрэгтээ, цэвэр дүнгээр барагдуулсантай адил байх тийм арга замаар дүнг барагдуулдаг бол тухайн байгууллага нь 47(б) параграфт заасан, цэвэр дүнгээр барагдуулах шалгуурыг хангана. Нийт дүнгээр барагдуулах механизм нь зээлийн болон төлбөрийн чадварын эрсдлийг арилгах эсвэл эрсдлийг өчүүхэн бага болгох үр дүнтэй бөгөөд авлага,

өглөгийг барагдуулалтын нэг процесс буюу циклээр боловсруулдаг бол, зөвхөн тийм тохиолдолд шалгуур хангах нөхцөл байдал үүснэ. Тухайлбал: дараах бүх шинж чанар бүхий нийт дүнгээр барагдуулах систем нь 47(б) параграфт заасан, цэвэр дүнгээр барагдуулах шалгуурыг хангана:

- (а) Харилцан суутгаж, цэвэр дүн гаргах шалгуурыг хангаж буй санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийг боловсруулалтанд оруулахаар хугацааны нэг агшинд танилцуулдаг байх;
- (б) Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийг боловсруулахаар танилцуулмагц талууд нь уг барагдуулалтын үүргийг биелүүлэх хариуцлага хүлээдэг байх;
- (в) Хөрөнгө, өр төлбөрийг боловсруулахаар танилцуулмагц (боловсруулалт амжилтгүй болсноос бусад тохиолдолд – доорх (г)-г үзнэ үү) тэдгээрээс үүсэх мөнгөн гүйлгээг өөрчлөх боломжгүй байх;
- (г) Хэрэв үнэт цаасны шилжүүлэлт амжилтгүй болвол уг үнэт цаасаар барьцаалагдсан холбогдох авлага буюу өглөгийн боловсруулалтыг (харилцан эсрэгээр) бас зогсоохын тулд үнэт цаасаар барьцаалсан хөрөнгө, өр төлбөрийг тухайн үнэт цаасны шилжүүлэлт эсвэл адилтгах системээр (жишээлбэл: хүргэлт ба төлбөрийг харгалзуулан) барагдуулдаг байх;
- (д) Дээрх (г)-д дурдсан, аливаа ажил гүйлгээг барагдуулах хүртэл боловсруулалтанд дахин оруулдаг байх;
- (е) Барагдуулалтын тухайн нэг институтээр (арилжааны банк, төв банк, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв) дамжуулан барагдуулалтыг гүйцэтгэдэг байх; ба
- (ж) Барагдуулалтын өдрөөр төлбөрийг тухайн талууд тус бүрийн хувьд боловсруулах боломжтой байхын тулд хангалттай хэмжээний овердрафтаар хангах, өдрийн доторх зээлийн хэрэгсэлтэй байх бөгөөд хэрэв шаардлагатай болвол ийм өдрийн доторх зээлийн хэрэгслийг ашиглана гэдэг нь үндсэндээ тодорхой байх;

...

Хавсралт Б-гийн Б19 ба Б21-р параграфыг дараах байдалтай болгож, нэмэлт өөрчлөлт оруулсан.

...

Хавсралт Б - Хоршоон дахь Гишүүдийн Хувь Оролцоо ба Адилтгах Хэрэглүүрүүд

...

Удирдан зохицуулах дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулахын өмнө

Б19. Эргэлтээс гаргалтын хориг хязгаарлалтаас давсан гишүүдийн хувь оролцоо нь санхүүгийн өр төлбөр юм. Тус хоршоо нь энэхүү санхүүгийн өр төлбөрийг түүний анх гаргах үеийн бодит үнэ цэнээр хэмждэг. Эдгээр хувь оролцоог эзэмшигчийн шаардлагын дагуу эргэлтээс гаргах учраас тус хоршоо нь дараах байдлаар заасан УСНББОУС 41-ийн 68-р параграфын дагуу ~~УСНББОУС 29-ийн 52-р параграф~~аар шаардсанчлан, ийм санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийг хэмжинэ төдөрхөйлнэ: “Шаардах шинж бүхий санхүүгийн өр төлбөрийн (жишээлбэл; хугацаагүй хадгаламжийн) бодит үнэ цэнэ нь уг шаардлагаар төлөх дүнгээс багагүй байна...”. Иймээс хоршоо нь эргэлтээс гаргах нөхцлийн дагуу шаардсанаар төлөх хамгийн их дүнгээр санхүүгийн өр төлбөр гэж ангилна.

...

Удирдан зохицуулах дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсаны дараа

Б21. Өөрийн удирдан зохицуулах дүрэмд өөрчлөлт оруулсны дараа тус хоршоо нь одоо эргэлтэнд байгаа хувь оролцооныхоо хамгийн ихдээ 25 хувь буюу нэгжийн 20ТН-ийн үнэтэй хамгийн ихдээ 50,000 ширхэг хувьцааг эргэлтээс гаргах шаардлагатай болно. Иймээс 20Х3 оны 01 дүгээр сарын 01-нд тус хоршоо нь УСНББОУС 41-ийн 68-р ~~УСНББОУС 28-ын 52-р~~ параграфын дагуу тодорхойлсон, эргэлтээс гаргах нөхцлийн дагуу шаардсанаар төлөх хамгийн их дүн болох 1,000,000ТН-ээр санхүүгийн өр төлбөр гэж ангилна. Иймээс уг хоршоо нь 20Х3 оны 01 дүгээр сарын 01-нд 200,000ТН-ийг цэвэр хөрөнгө/өмчөөс санхүүгийн өр төлбөр болгон шилжүүлэх бөгөөд 2,000,000ТН-ийг өмчийн хэрэглүүр гэж ангилсан хэвээр үлдээнэ. Энэ жишээнд байгууллага нь уг шилжүүлэлтээр ямар нэг олз буюу гарз хүлээн зөвшөөрөхгүй.

...

Дүгнэлтийн Үндэслэл

Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 28-ыг дагалдах боловч түүний салиггүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

...

Цар хүрээ

ДҮ5. Гаргагч нь тухайн гэрээг хүлээн зөвшөөрч, хэмжихдээ СТОУС 9, Санхүүгийн Хэрэглүүр-ийг ~~НББОУС 39, Санхүүгийн Хэрэглүүр- Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт~~ -ийг мөрддөг санхүүгийн баталгааны гэрээнээс бусад бүх даатгалын гэрээг НББОУС 32 нь өөрийн цар хүрээнд хамруулдаггүй. Доор дурдсанаас бусад бүх даатгалын гэрээ нь УСНББОУС 28-ын цар хүрээнд бас хамаарахгүй:

- Байгууллага нь даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартын дагуу тухайн гэрээг даатгалын гэрээ гэж үзэх сонголт хийснээс бусад тохиолдолд санхүүгийн хэрэглүүр гэж үзэх санхүүгийн баталгааны гэрээ; ба
- Даатгалын гэрээ мөн боловч УСНББОУС 28, ~~УСНББОУС 29~~, УСНББОУС 30, УСНББОУС 41-ийн дагуу санхүүгийн хэрэглүүр гэж үзэж болох санхүүгийн эрсдлийн шилжүүлэлтийг агуулсан гэрээнүүд.

...

Үлгэрчилсэн жишээ

Энэхүү үлгэрчилсэн жишээ нь УСНББОУС 28-ыг дагалдах боловч түүний салиггүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

Байгууллагын өмчийн хэрэглүүрийн гэрээний тайлагнал

ҮЖ1. Байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрийн гэрээний тайлагналд УСНББОУС 41-ийн ~~УСНББОУС 28-ын~~ 13-32-р параграфуудыг хэрхэн мөрдөхийг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан. Эдгээр жишээнд мөнгөн дүнг “тооцооны нэгж” (ТН) гэж тэмдэглэсэн.

...

ҮЖ5. Төлбөрийг тогтмол дүн бүхий мөнгө өгөх ба “А” байгууллагын тогтмол тооны хувьцааг авснаар барагдуулахаас бусад нөхцөл нь дээрх (а)-д дурдсантай ижил гэж үзье. Дээрх (а) ба (б)-д дурдсантай адилаар, нэг жилийн дараа “А” байгууллагын төлөх нэгж хувьцааны үнэ нь тогтмол 104ТН байна. Иймээс нэг жилийн дараа “А” байгууллага нь 104,000ТН (104ТНх1,000)-ийн мөнгийг “Б” байгууллагад төлөх, харин “Б” байгууллага нь “А” байгууллагын эргэлтэнд буй 1,000 ширхэг хувьцааг “А” байгууллагад өгөх үүрэгтэй. Иймээс “А” байгууллага нь дараах журналын бичилт хийнэ:

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

20Х2 оны 02-р сарын 01.

Дебит	Цэвэр хөрөнгө/өмч	100,000ТН	
Кредит	Өр төлбөр		100,000ТН

Нэг жилийн дараа төлөх 104,000ТН-ийн зохих хүүний түвшинг ашиглан дискаунтчилсан 100,000ТН-ийн өнөөгийн үнэ цэнээр бүртгэх (УСНББОУС 41-ийн МЗУ115-р УСНББОУС 29-ийн МЗУ82-р параграфыг үзнэ үү).

20Х2 оны 12-р сарын 31.

Дебит	Хүүний зардал	3,660ТН	
Кредит	Өр төлбөр		3,660ТН

Хувьцааг эргэлтээс гаргах өр төлбөрийн хувьд үр ашигтай хүүний аргын дагуу хууг хуримтлуулан бүртгэх.

20Х3 оны 01-р сарын 31.

Дебит	Хүүний зардал	340ТН	
Кредит	Өр төлбөр		340ТН

Хувьцааг эргэлтээс гаргах өр төлбөрийн хувьд үр ашигтай хүүний аргын дагуу хууг хуримтлуулан бүртгэх.

“А” байгууллага нь 104,000ТН-ийн мөнгийг “Б” байгууллагад төлсөн, харин “Б” байгууллага нь “А” байгууллагын 1,000 ширхэг хувьцааг “А” байгууллагад өгсөн.

Дебит	Өр төлбөр	104,000ТН	
Кредит	Мөнгө		104,000ТН

“А” байгууллагын өөрийн хувьцааг мөнгөөр эргэлтээс гаргах уг өр төлбөрийн барагдуулалтыг бүртгэх.

...

УСНББОУС 29, , Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт-д оруулсан нэмэлт өөрчлөлт

2, 9, 10, 80, 98, 99, 101, 102, 107, 108, 109, 111, 112, 113, МЗУ128, МЗУ157, МЗУ161-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 1, 3, 4, 5, 6, 11-79, 88, МЗУ1-МЗУ126, МЗУ129-р параграфыг хассан ба 125И, МЗУ156А параграфыг шинээр нэмсэн.

Зорилго

1. ~~Энэ Стандартын зорилго нь санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөр болон санхүүгийн санхүүгийн бус зүйлсийг худалдан авах буюу борлуулах зарим гэрээг хүлээн зөвшөөрөх ба хэмжих зарчмуудыг тогтооход оршино. Санхүүгийн хэрэглүүрийн талаархи мэдээллийг толилуулах шаардлагуудыг УСНББОУС 28, Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга д заасан. Санхүүгийн хэрэглүүрийн талаархи мэдээллийг тодруулах шаардлагуудыг УСНББОУС 30, Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга д тусгасан.~~

Цар хүрээ

2. Бүх байгууллагууд нь доор дурдсанаа тохиолдолд УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүрийн цар хүрээнд хамаарах бусад бүх төрлийн санхүүгийн хэрэглүүрийн хувьд энэ Стандартыг мөрдөнө:

- (а) Энэ Стандартын хейжийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудыг мөрдөхийг УСНББОУС 41-ээр зөвшөөрдөг. УСНББОУС 34, Тусдаа Санхүүгийн Тайлан,

~~УСНББОУС 35, Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан, УСНББОУС 36, Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хоронго Оруулалт~~ -ын дагуу тайлагнадаг хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоо. Гэвч зарим тохиолдолд ~~УСНББОУС 34, УСНББОУС 35, УСНББОУС 36~~ нь хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоог энэхүү Стандартын зарим эсвэл бүх шаардлагуудын дагуу тайлагнахыг байгууллагаас шаарддаг буюу зөвшөөрдөг. Хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоотой холбоотой үүсмэл хэрэглүүр нь ~~УСНББОУС 28~~ д заасан тухайн байгууллагын өмчийн хэрэглүүрийн тодорхойлолтыг хангахгүй тохиолдолд байгууллагууд нь тэрхүү үүсмэл хэрэглүүрт мөн энэ Стандартыг дагаж мөрднө.

- (б) Санхүүгийн хэрэглүүр нь энэ Стандартын дагуу хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангадаг хейжийн харилцааны нэг хэсэг байх. ~~УСНББОУС 13, Түрээсийг мөрдөх түрээсийн дагуу үүсэх эрх ба үүрэг. Гэхдээ:~~
- (i) ~~Түрээслүүлэгчийн хүлээн зөвшөөрсөн түрээсийн авлага нь энэ Стандартын үл хүлээн зөвшөөрөлтийн болон үнэ цэнийн бууралтын шаардлагуудад захирагдана (17-39, 67, 68, 72-р параграфууд болон Хавералт А-гийн МЗУ51-МЗУ67, МЗУ117-МЗУ126-р параграфуудыг үзнэ үү);~~
 - (ii) ~~Түрээслэгчийн хүлээн зөвшөөрсөн санхүүгийн түрээсийн ор толбор нь энэ Стандартын үл хүлээн зөвшөөрөлтийн шаардлагуудад захирагдана (41-44-р параграфууд болон Хавералт А-гийн МЗУ72-МЗУ80-р параграфуудыг үзнэ үү);~~
 - (iii) ~~Түрээсийг дагалдан үүсдэг үүсмэл хэрэглүүр нь энэ Стандартын дагалдах үүсмэл хэрэглүүрийн шаардлагуудад захирагдана (11-15-р параграфууд болон Хавералт А-гийн МЗУ40-МЗУ46-р параграфуудыг үзнэ үү).~~
- (в) ~~УСНББОУС 39, Ажилтны Тэтгэмж~~ -ийг мөрдөх ажилтны тэтгэмжийн хотөлбөрийн дагуу хүлээх ажил олгогчийн эрх ба үүрэг.
- (г) Тухайн байгууллагын гаргасан богоод ~~УСНББОУС 28~~ д заасан өмчийн хэрэглүүрийн тодорхойлолтыг хангах эсвэл ~~УСНББОУС 28~~ -ын 15, 16-р параграф эсвэл 17, 18-р параграфуудын дагуу өмчийн хэрэглүүр гэж ангилах шаардлагатай санхүүгийн хэрэглүүр (үүн дотроо онцион ба баталгаа). Гэвч санхүүгийн хэрэглүүр нь дээрх (а)-д заасан гажих нохцлийг хангахаас бусад тохиолдолд ийм өмчийн хэрэглүүрийн эзэмшигч нь тэдгээр хэрэглүүрийн хувьд энэ Стандартыг мөрднө.
- (д) Дараах зүйлээс үүсэж эрх ба үүрэг;
- (i) ~~10-р параграфт заасан санхүүгийн баталгааны гэрээний тодорхойлолтын хангах даатгалын гэрээний дагуу үүсэх, гаргагчийн эрх ба үүргээс бусад даатгалын гэрээ; эсвэл~~
 - (ii) ~~Сонголттой оролцох шинжийг агуулдаг учраас даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартын нар хүрээнд хамаарах гэрээ.~~

Даатгалын гэрээг дагалдан гардаг үүсмэл хэрэглүүр нь оороо даатгалын гэрээ бинш бол уг үүсмэл хэрэглүүрт энэ Стандартыг мөрднө (энэ Стандартын 11-15-р параграф болон Хавералт А-гийн МЗУ40-МЗУ46-р параграфыг үзнэ үү). Байгууллага нь санхүүгийн баталгааны гэрээнд энэ Стандартыг мөрдөх боловч тухайн санхүүгийн баталгааны гэрээг гаргагч нь түүнийг хүлээн зөвшөөрөх ба хэмжихдээ даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг мөрдөх сонголт хийсэн бол тэдгээр стандартыг мөрднө. Дээрх (i)-д заасныг үл харгалзан байгууллага нь санхүүгийн эрдлийн нилжүүлэлтийг агуулсан бусад даатгалын гэрээнд энэ Стандартыг мөрдөж болох юм.

- (е) ~~Худалдан авч буй үйл ажиллагааг худалдан авах буюу худалдах талаар тухайн нэгтгэгч болон борлуулагчийн хооронд байгуулсан бөгөөд тэрхүү ирээдүйн худалдан авалтын одор улсын секторын нэгдэл үүсэхэд хүргэх аливаа форвард гэрээ. Форвард гэрээний хугацаа нь аливаа шаардлагатай зовшоорлийг олж авах ба тухайн ажил гүйлгээг хэрэгжүүлэхэд хэвийн шаардагдах үл үндэслэлтэй хугацаанаас хэтрэхгүй байвал зохино.~~
- (ж) ~~4-р параграфт дурдсан зээл олгох баталгаанаас бусад зээл олгох баталгаа. Гэвч зээл олгох баталгаа гаргагч нь энэ Стандартын цар хүрээнд хамаарахгүй уг зээл олгох баталгааны хувьд УСНББОУС 19, Нооц, Болзошгүй Ор Толбор ба Болзошгүй Хоронго-ийг мөрдөнө. Гэвч зээл олгох бүх баталгаа нь энэ Стандартын үл хүлээн зовшооролтийн шаардлагад захирагдана (17-44-р параграф болон Хавералт А-гийн МЗУ51-МЗУ80-р параграфыг үзнэ үү).~~
- (и) ~~Энэ Стандартын мөрддөг ба түүний 4-6-р параграфын цар хүрээнд хамаарах гэрээнүүдээс бусад бөгөөд хувьцаанд суурилсан төлбөрийг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг мөрддөг хувьцаанд суурилсан төлбөрийн ажил гүйлгээнээс үүсэж санхүүгийн хэрэглүүр, гэрээ, үүрэг.~~
- (к) ~~УСНББОУС 19-ийн дагуу нооц гэж хүлээн зовшоорох эсвэл УСНББОУС 19-ийн дагуу өмнөх тайлант үед нооц гэж хүлээн зовшоорсон ор төлбөрийг барагдуулахад шаардлагатай зарлагын хувьд тухайн байгууллагад нохон төлөгдөх төлбөрийг хүлээн авах эрх.~~
- (л) ~~УСНББОУС 23, Арилжааны Бус Ажил Гүйлгээний Орлого (Татвар ба Шилжүүлэг)-ын мөрдөх арилжааны бус орлогын ажил гүйлгээнээс үүсэж эрх, үүргийн анхны хүлээн зовшооролт ба анхны хэмжилт.~~
- (м) ~~УСНББОУС 32, Үйлчилгээний Концессын Хэлцэл: Эрх бүхий этгээд-ийг мөрдөх үйлчилгээний концессын хэлцлээс үүсэж эрх ба үүрэг. Гэвч санхүүгийн ор төлбөрийн загварын дагуу уг эрх бүхий этгээдийн хүлээн зовшоорох санхүүгийн ор төлбөр нь энэ Стандартын үл хүлээн зовшооролтийн шаардлагуудад захирагдана (41-44-р параграф болон Хавералт А-гийн МЗУ72-МЗУ80-р параграфыг үзнэ үү).~~

3. Дараах зээл олгох баталгаа нь энэ Стандартын цар хүрээнд хамаарна:

- (а) ~~Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг санхүүгийн ор төлбөр гэж тухайн байгууллагын ангилсан зээл олгох баталгаа. Зээл олгох баталгаанаасаа үүсэж хоронгийг түүний бий болсон даруйд худалдан борлуулж байсан өмнөх практик бүхий байгууллага нь тэрхүү зээл олгох баталгааны ангид хамаарах өөрийн бүх зээл олгох баталгааны хувьд энэ Стандартыг мөрдөнө.~~
- (б) ~~Цэвэр дүнгээр нь мөнгөөр эсвэл бусад санхүүгийн хэрэглүүрийг огох буюу гаргах замаар барагдуулж болох зээл олгох баталгаа. Ийм зээл олгох баталгаа нь үүсмэл хэрэглүүр юм. Зээлийг хэсэгчлэн төлдөг (жинсээлбэл; барилгын ажлын явцтай уялдуулан хэсэгчлэн төлдөг барилгын мөргөйжийн зээл) гэдгээс зөвхөн хамааран зээл олгох баталгааг цэвэр дүнгээр барагдуулдаг гэж үзэхгүй.~~
- (в) ~~Зах зээлийн хүүний түвшинээс бага хүүтэйгээр зээл олгох баталгаа. Ийм зээл олгох баталгаанаас үүсэх ор төлбөрийн дараагийн тайлант үеийн хэмжилтийг 49(г) параграфт тусгайлан заасан.~~

4. Санхүүгийн бус зүйлийг худалдан авах буюу борлуулах бөгөөд цэвэр дүнгээр нь мөнгөөр буюу бусад санхүүгийн хэрэглүүрээр барагдуулах, эсвэл санхүүгийн хэрэглүүрүүдээр еоллцож болох гэрээнд энэхүү Стандартыг гэдгээр гэрээ нь өөрөө санхүүгийн хэрэглүүр байсан мэтээр мөрдөнө; харин тухайн байгууллагын хүлээгдэж буй худалдан авалт, борлуулалт буюу ашиглалтын шаардлагуудын дагуу санхүүгийн бус зүйлийг хүлээн авах эсвэл огох зорилгоор байгуулсан ба ийм зорилгоор үргэлжлүүлэн эзэмшиж буй гэрээнд энэ Стандартыг мөрдөхгүй.

5. Санхүүгийн бус зүйлийг худалдан авах буюу борлуулах гэрээг цэвэр дүнгээр нь мөнгөөр буюу бусад санхүүгийн хэрэглүүрээр барагдуулах эсвэл санхүүгийн хэрэглүүрүүдийг солилцох янз бүрийн арга замууд байдаг. Үүнд:

(а) Цэвэр дүнгээр нь мөнгөөр буюу бусад санхүүгийн хэрэглүүрээр барагдуулах, эсвэл санхүүгийн хэрэглүүрүүдийг солилцохыг аль нэг талд зөвшөөрсөн гэрээний нөхцөлтэй тохиолдол;

(б) Цэвэр дүнгээр нь мөнгөөр буюу бусад санхүүгийн хэрэглүүрээр барагдуулах, эсвэл санхүүгийн хэрэглүүрүүдийг солилцох боломжит байдлыг тухайн гэрээний нөхцөлд тодорхой заагаагүй боловч уг байгууллага нь ижил төсөөтэй гэрээг цэвэр дүнгээр нь мөнгөөр буюу бусад санхүүгийн хэрэглүүрээр барагдуулан эсвэл санхүүгийн хэрэглүүрүүдийг солилцсон практик туршлагатай тохиолдол (харилцан суутгаж, цэвэр дүн гаргах гэрээг ногоо талтайгаа байгуулснаар, эсвэл гэрээ хэрэгжих буюу түүний хугацаа дуусахаас өмнө уг гэрээг борлуулснаар);

(в) Ижил төсөөтэй гэрээний хувьд байгууллага нь тухайн хэрэглүүрийг гаргах ба түүний үнийн богино хугацааны хэлбэлзлээс эсвэл дилерийн үнийн зөрүүгээс ашиг олох зорилгоор уг гаргалтаас хойшхи богино хугацааны дотор буцаан борлуулж байсан практик туршлагатай тохиолдол; ба

(г) Тухайн гэрээнд хамаарах санхүүгийн бус зүйлийг мөнгөнд шууд хөрвүүлэх боломжтой тохиолдол.

Тухайн байгууллагын хүлээгдэж буй худалдан авалт, борлуулалт буюу ашиглалтын шаардлагын дагуу санхүүгийн бус зүйлийг хүлээн авах эсвэл өгөх тийм зорилгоор дээрх (б) буюу (в) заалтанд хамаарах гэрээг байгуулаагүй бол уг гэрээ нь энэ Стандартын цар хүрээнд хамаарна. Тухайн байгууллагын хүлээгдэж буй худалдан авалт, борлуулалт буюу ашиглалтын шаардлагын дагуу санхүүгийн бус зүйлийг хүлээн авах эсвэл өгөх зорилгоор гэрээг байгуулан ба нийм зорилгоор үргэлжлүүлэн эзэмшиж буй эсэх, уг гэрээ нь энэ Стандартын цар хүрээнд хамаарах эсэхийг тодорхойлохын тулд 4-р параграфыг мөрдөх бусад гэрээг үнэлж үзнэ.

6. 5(а) буюу 5(г) параграфын дагуу, цэвэр дүнгээр нь мөнгөөр буюу бусад санхүүгийн хэрэглүүрээр барагдуулах эсвэл санхүүгийн хэрэглүүрээр солилцох боломжтой, санхүүгийн бус зүйлийг худалдан авах буюу борлуулахаар гаргасан опцион нь энэ Стандартын цар хүрээнд хамаарна. Ийм гэрээг тухайн байгууллагын хүлээгдэж буй худалдан авалт, борлуулалт буюу ашиглалтын шаардлагуудын дагуу санхүүгийн бус зүйлийг хүлээн авах эсвэл өгөх зорилгоор байгуулахгүй.

...

Тодорхойлолт

9. УСНББОУС 28 ба УСНББОУС 41-д тодорхойлсон нэр томъёог энэ Стандартад УСНББОУС 28-ын 9-р параграфт болон УСНББОУС 41-ийн 9-р параграфт тусгайлан заасан утгаар ойлгож хэрэглэнэ. УСНББОУС 28 ба УСНББОУС 41 нь дараах нэр томъёог тодорхойлж, эдгээр тодорхойлолтыг хэрэглэх заавар удирдамжаар хангадаг:

- Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртөг;
- Үл хүлээн зөвшөөрөлт;
- Үүсмэл хэрэглүүр;
- Үр ашигт хүүний арга;
- Үр ашигт хүүний хувь;
- Өмчийн хэрэглүүр;
- Санхүүгийн хөрөнгө;

- Санхүүгийн хэрэглүүр;
- Санхүүгийн өр төлбөр;
- Арилжааны баталгаа;
- Урьдчилан таамагласан ажил гүйлгээ;

10. Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт

Үүсмэл хэрэглүүр гэдэг нь энэ Стандартын цар хүрээнд хамаарах (2-6-р параграфыг үзнэ үү) бөгөөд дараах бүх гурван шинж чанар бүхий санхүүгийн хэрэглүүр буюу бусад гэрээ юм:

- (а) — Тохиролцсон хүүний хувь, санхүүгийн хэрэглүүрийн үнэ, бараа бүтээгдэхүүний үнэ, гадаад валютын ханш, үнийн буюу ханшийн индекс, эзэлийн зэрэглэл буюу эзэлийн индекс, түүнчлэн уг гэрээний аль нэг талд тусгайлан хамаарахгүй санхүүгийн бус хувьсагч гэх мэт бусад хувьсагчдын (зарим үед ‘суурь зүйл’ гэж нэрлэдэг) оорчлолтийн хариу болгон түүний үнэ цэнэ оорчлогддог.
- (б) — Анхны цэвэр хоронго оруулалт шаарддаггүй эсвэл зах зээлийн хүчин зүйлсийн оорчлолтонд ижил төсөөтэй хариу үзүүлэхээр хүлээгдэж буй бусад төрлийн гэрээний хувьд шаардлагатай дүнгээс бага хэмжээний анхны цэвэр хоронго оруулалт шаарддаг.
- (в) — Ирээдүйн өдөр барагдуулдаг.

Санхүүгийн хэрэглүүрийн дорвон ангиллын тодорхойлолт

Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хоронго буюу санхүүгийн өр төлбөр гэдэг нь дараах нөхцлүүдийн аль нэгийг хангадаг санхүүгийн хоронго буюу санхүүгийн өр төлбөр юм:

- (а) — Худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэж ангилдаг. Дараах тохиолдолд санхүүгийн хоронго буюу санхүүгийн өр төлбөрийг худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэж ангилна:
 - (i) — Ойрын хугацаанд худалдан борлуулах эсвэл буцаан худалдан авах зорилготойгоор үндсэндээ олж эзэмшсэн буюу гаргасан;
 - (ii) — Анх хүлээн зовшоорох үед, хамтад нь удирдан зохицуулдаг бөгөөд богино хугацаанд ашиг олох зорилготой гэсэн нотолгоо бүхий тодорхой санхүүгийн хэрэглүүрийн багцын нэг хэсэг байх;
 - (iii) — Үүсмэл хэрэглүүр байх (санхүүгийн баталгааны гэрээ эсвэл сонгосон ба үр дүнтэй хейжийн хэрэглүүр болох үүсмэл хэрэглүүрээс бусад).
- (б) — Анх хүлээн зовшоорох үед тухайн байгууллага нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан. Байгууллага нь зөвхөн 13-р параграфтаар зөвшөөрсөн тохиолдолд эсвэл дараах шалтгааны улмаас ингэж ангилах нь илүү хамааралтай мэдээлэл бий болгох үр дүнтэй тохиолдолд ийм ангиллыг ашиглаж болно:
 - (i) — Энэ нь хоронго, өр төлбөрийг оор сууриудаар хэмжсэнээр эсвэл тэдгээрийн өлз, гарзыг оор сууриудаар хүлээн зовшоореноор үүсэх байсан хэмжилтийн болон хүлээн зовшооролтийн тууштай бус байдлыг (зарим үед “нягтлан бодох бүртгэлийн уялдаагүй байдал” гэж нэрлэдэг) арилгах буюу мэдэгдэхүйц бууруулдаг; эсвэл
 - (ii) — Санхүүгийн хоронгүүдийн, санхүүгийн өр төлбөрүүдийн бүлэг эсвэл эдгээрийн аль алины бүлгийг тухайн байгууллагын эрдлийн удирдлагын болон хоронго оруулалтын баримтжуулсан стратегийн дагуу удирдаж, түүний

~~гүйцэтгэлийг бодит үнэ цэнийн суурнар үнэлдэг бөгөөд тэрхүү бүлгийн талаархи мэдээллийг уг байгууллагын эрх бүхий албан тушаалтанд (УСНББОУС 20, Холбоотой Талуудын Тодруулга-д тодорхойлсон), тухайлбал, байгууллагын удирдах зөвлөл ба гүйцэтгэх захиралд дотооддоо танилцуулдаг.~~

~~Байгууллага нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжээн гэж ангилсан санхүүгийн хоронго ба санхүүгийн ор төлбөрийн талаар, үүн дотроо эдгээр нохцлүүдийг хэрхэн хангаж буй талаар тодруулга хийхийг УСНББОУС 30-ийн 11-13-р параграф болон МЗУ4-р параграфээр шаардсан байдаг. Дээрх (ii)-ын дагуу шалгуур хангах хэрэглүүрүүдийн хувьд ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжээн гэсэн ангилал нь тухайн байгууллагын эрэлтийн удирдлагын болон хоронго оруулалтын баримтжуулан стратегитай хэрхэн нийцэж буй талаархи хүүрнэсэн тайлбарыг уг тодруулгад тусган оруулна.~~

~~Идэвхитэй зах зээл дэх зах зээлийн жишиг үнэ байхгүй бөгөөд бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжиж чадахгүй, өмчийн хэрэглүүрийн хоронго оруулалтыг (48(в) параграф болон Хавералт А-гийн МЗУ113, МЗУ114-р параграфуудыг үзнэ үү) ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжээн гэж ангилахгүй.~~

~~Санхүүгийн хоронго буюу санхүүгийн ор төлбөрийн бодит үнэ цэнийн найдвартай хэмжүүрийг тодорхойлох шаардлагуудыг тогтоодог 50, 51, 52-р параграфууд болон Хавералт А-гийн МЗУ101-МЗУ115-р параграфуудыг бодит үнэ цэнээр хэмжээн бүх зүйлээд, тэдгээрийг ингэж ангилсан үгүй эсэх, эсвэл тэдгээрийн бодит үнэ цэнийг тодруулсан эсэхээ үл хамааран мөн адил мордоно гэдгийг анхаарах хэрэгтэй.~~

~~Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хоронго оруулалт гэдэг нь тухайн байгууллага түүнийг дуусгавар хугацаа хүртэл эзэмших эерэг санаа зорилго ба чадвар боломжтой бөгөөд тогтмол буюу тодорхойлж болох төлбөрүүдтэй, тогтоосон дуусгавар болох хугацаатай, доор дурдсанаас бусад, үүсэмэл бус санхүүгийн хоронго юм (Хавералт А-гийн МЗУ29-МЗУ38-р параграфыг үзнэ үү):~~

- ~~(а) — Анх хүлээн зөвшөөрөх үед уг байгууллага нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжээн гэж ангилсан санхүүгийн хоронго;~~
- ~~(б) — Байгууллага нь борлуулах боломжтой гэж ангилсан санхүүгийн хоронго; ба~~
- ~~(в) — Зээл ба авлагын тодорхойлолтыг хангадаг санхүүгийн хоронго.~~

~~Хэрэв байгууллага нь дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших, мэдэгдэхүйц бус хэмжээнээ илүү дүн (дуусгавар болох хугацаа хүртэл эзэмшиж буй хоронго оруулалтын нийт дүнтэй харьцуулахад мэдэгдэхүйц бус хэмжээнээ илүү дүн) бүхий хоронго оруулалтыг дараах борлуулалт буюу дахин ангиллаас оор бусад байдлаар түүний дуусгавар болох хугацаанаас өмнө тухайн тайлант жилд болон өмнөх хоёр жилийн хугацаанд борлуулж эсвэл дахин ангилж байсан бол уг байгууллага нь ийм аливаа санхүүгийн хоронгийг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмшиж буй гэж ангилахгүй:~~

- ~~(а) — Дуусгавар болох хугацаа буюу тухайн санхүүгийн хоронгийн дуудах өдөртэй маш ойрхон (жишээлбэл; дуусгавар болох хугацаа хүртэл гурван сараас бөгино хугацаатай), ингэснээр хүүний зах зээлийн түвшний оорчлолт нь уг санхүүгийн хоронгийн бодит үнэ цэнэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхээргүй байх;~~
- ~~(б) — Байгууллага нь хуваарьт төлбөрүүд буюу урьдчилсан төлбөрөөр тухайн санхүүгийн хоронгийн бараг бүх анхны үндсэн дүнг цуглуулсны дараа хийгдсэн; эсвэл~~
- ~~(в) — Тухайн байгууллагын хяналтанд хамаарахгүй, дахин үл давтагдах ба уг байгууллага үл үндэслэлтэйгээр урьдчилан таамаглаж чадахгүй тусдаа үйл явдалд хамаарах.~~

~~Зээл ба авлага гэдэг нь идэвхитэй зах зээлд арилжаалдаггүй бөгөөд тогтмол буюу тодорхойлж болох төлбөрүүдтэй доор дурдсанаас бусад, үүсэмэл бус санхүүгийн хоронго юм:~~

- (а) ~~Байгууллага нь нэн даруй эсвэл ойрын хугацаанд худалдан борлуулах санаа төлөвлөгөөтэй бөгөөд худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэж ангилах санхүүгийн хоронго ба анх хүлээн зовшоорох үед байгууллага нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан санхүүгийн хоронго;~~
- (б) ~~Анх хүлээн зовшоорох үед байгууллага нь борлуулах боломжтой гэж ангилсан санхүүгийн хоронго; эсвэл~~
- (в) ~~Зээлийн чанаргүйдлээс оор бусад шалтгааны улмаас эзэмшигч нь оорийн бараг бүх анхны хоронго оруулалтыг нохож чадахааргүй болсон бөгөөд борлуулах боломжтой гэж ангилсан санхүүгийн хоронго.~~

~~Зээл буюу авлага бинн хоронгүүдийн нэгдлээс (жишээлбэл; хамтын сан буюу адилтгах сан дахь хувь оролцооноос) олж эзэмшсэн хувь оролцоо нь зээл эсвэл авлага болохгүй юм.~~

~~Борлуулах боломжтой санхүүгийн хоронго гэдэг нь (а) зээл ба авлага, (б) дуусгавар болох хугацаа хүртэл эзэмшиж буй хоронго оруулалт, (в) ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хоронго гэж ангилаагүй буюу борлуулах боломжтой гэж ангилсан үүемэл бус санхүүгийн хоронго юм.~~

Санхүүгийн баталгааны гэрээний тодорхойлолт

~~Санхүүгийн баталгааны гэрээ гэдэг нь өрийн хэрэглүүрийн анхны буюу засварлан өөрчилсөн нохцлийн дагуу төлөх ёстой төлбөрөө тухайн эзэлдэгч барагдуулаагүйн улмаас учирсан алдагдлын хувьд уг гэрээг эзэмшигчид нохон төлбөр болгон тодорхой төлбөр төлөхийг түүний гаргагчаас шаарддаг гэрээ юм.~~

Хүлээн зовшооролт ба хэмжилттэй холбоотой тодорхойлолт

~~Санхүүгийн хоронго буюу санхүүгийн ор төлбөрийн хөрөгдүүлсэн өртөг гэдэг нь санхүүгийн хоронго буюу санхүүгийн ор төлбөрийг анх хүлээн зовшоорох үед хэмжсэн дүнгээс үндсэн төлбөрийн буцаан төлөлтийг хасаж, уг анхны дүн ба дуусгавар болгох дүнгийн хоорондох аливаа зөрүүгээс үр ашигт хүүний аргыг ашиглан тооцсон, хуримтлагдсан хөрөгдуулгыг нэмэх буюу хасаж, үнэ цэнийн бууралт буюу үл нуглуулагдах байдлын аливаа хасагдуулгыг (шууд эсвэл хасагдуулгын данс ашигласнаар) хассан дүн юм.~~

~~Үр ашигт хүүний арга гэдэг нь санхүүгийн хоронго буюу санхүүгийн ор төлбөрийн (санхүүгийн хоронгүүд болон санхүүгийн ор төлбөрүүдийн бүлгийн) хөрөгдүүлсэн өртгийг тооцоолох ба хүүний орлого буюу хүүний зардлыг холбогдох тайлант үед хуваарилах арга юм. Үр ашигт хүүний хувь гэдэг нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааны туршид буюу тохиромжтой бол үүнээс богино хугацаанд тооцоолсон ирээдүйн мөнгөн төлбөр эсвэл мөнгөн орлогыг тухайн санхүүгийн хоронго болон санхүүгийн ор төлбөрийн цэвэр дансны үнэ хүртэл яг нарийн дискаунтчилдаг хүүний хувь юм. Үр ашигт хүүний хувийг тооцоолохдоо байгууллага нь тухайн санхүүгийн хэрэглүүрийн гэрээний бүх нохцолүүдийг (тухайлбал; урьдчилан төлөлт, дуудах онцион ба үүнтэй ижил төсөөтэй онцион) харгалзан үзсэнээр уг хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг тооцоолох боловч ирээдүйн зээлийн алдагдлыг харгалзан үзэхгүй. Гэрээний талуудын хооронд төлсөн эсвэл хүлээн авсан, уг үр ашигт хүүний хувийн салнгүй хэсэг болох бүх хураамж ба өнөө (УСНББОУС 9, Арилжааны Ажил Гүйлгээний Орлого-ыг үзнэ үү), ажил гүйлгээний зардал, бусад бүх урамшуулал буюу хөнгөлөлт нь энэхүү тооцооллод хамаарна. Ижил төсөөтэй санхүүгийн хэрэглүүрүүдийн бүлгийн мөнгөн гүйлгээ ба тэдгээрийн хүлээгдэж буй хугацааг найдвартай тооцоолж чадна гэсэн урьдчилсан нохцолтэй байдаг. Гэвч санхүүгийн хэрэглүүрийн (санхүүгийн хэрэглүүрүүдийн бүлгийн) мөнгөн гүйлгээ эсвэл хүлээгдэж буй хугацааг найдвартай тооцоолох боломжгүй тийм цөөн хөвөр тохиолдолд байгууллага нь тухайн санхүүгийн хэрэглүүрийн (санхүүгийн хэрэглүүрүүдийн бүлгийн) нийт гэрээний хугацаан дахь уг гэрээний мөнгөн гүйлгээг харгалзан үзнэ.~~

~~Ул хүлээн зөвшөөрөлт гэдэг нь өмнө хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг тухайн байгууллагын санхүүгийн байдлын тайлангаас хасах явдал юм.~~

~~Ердийн нохиолтэй худалдан авалт буюу борлуулалт гэдэг нь тухайн хамаарах зах зээл дэх зохингуулалт буюу тогтоон журмаар ерөнхийдөө тогтоодог цаг хугацааны дотор уг хөрөнгийг нийлүүлэхийг шаарддаг нохцол бүхий гэрээний дагуу санхүүгийн хөрөнгийг худалдан авах буюу борлуулах ажиллагаа юм.~~

~~Ажил гүйлгээний зардал гэдэг нь санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн олж эзэмшилт, гаргалт, данснаас хасалтанд шууд хамаарах орон нэмэгдэх зардал (Хавсралт А-гийн МЗУ26-р параграфыг үзнэ үү) юм. Орон нэмэгдэх зардал нь хэрэв байгууллага тухайн санхүүгийн хэрэглүүрийг олж эзэмшээгүй, гаргаагүй, данснаас хасаагүй бол гарахгүй байсан тийм зардал байдаг.~~

Хейжийн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тодорхойлолт

~~Арилжааны баталгаа гэдэг нь ирээдүйн төвлөсөн өдөр, тогтоосон үнээр, тодорхой хэмжээний нооцийг солилцох заавал биелүүлэх хэлцэл юм.~~

~~Урьдчилан таамагласан ажил гүйлгээ гэдэг нь баталгаа гаргаагүй боловч урьдчилан төсөөлсөн ирээдүйн ажил гүйлгээ юм.~~

Хейжийн хэрэглүүр гэдэг нь сонгосон хейжийн зүйлийн бодит үнэ цэнийн эсвэл мөнгөн гүйлгээний өөрчлөлтийг өөрийн бодит үнэ цэнээр эсвэл мөнгөн гүйлгээгээр нөхөхөөр хүлээгдэж буй, сонгосон үүсмэл хэрэглүүр (зөвхөн гадаад валютын ханшийн өөрчлөлтийн эрсдлийн хейжийн хувьд) эсвэл сонгосон үүсмэл бус санхүүгийн хөрөнгө, үүсмэл бус санхүүгийн өр төлбөр юм (хейжийн хэрэглүүрийн тодорхойлолтыг 81-86-р параграф болон Хавсралт А-гийн МЗУ127-МЗУ130-р параграфт тайлбарласан).

Хейжийн зүйл гэдэг нь (а) өөрийн бодит үнэ цэнийн эсвэл ирээдүйн мөнгөн гүйлгээний өөрчлөлтийн хувьд тухайн байгууллагыг эрсдэлд өртүүлдэг, (б) хейж хийхээр сонгосон тийм хөрөнгө, өр төлбөр, арилжааны баталгаа, хэрэгжих өндөр магадлалтай урьдчилан таамагласан ажил гүйлгээ, гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалт юм (хейжийн зүйлийн тодорхойлолтыг 87-94-р параграф болон Хавсралт А-гийн МЗУ131-МЗУ141-р параграфт тайлбарласан).

Хейжийн үр дүнтэй байдал гэдэг нь хейж хийсэн эрсдэлд хамаарах уг хейжийн зүйлийн бодит үнэ цэнийн эсвэл мөнгөн гүйлгээний өөрчлөлтийг тухайн хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн эсвэл мөнгөн гүйлгээний өөрчлөлтөөр нөхөх хэмжээ юм. (Хавсралт А-гийн МЗУ145-МЗУ156-р параграфыг үзнэ үү).

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь*-д дахин нийтэлсэн болно.

Дагалдах үүсмэл хэрэглүүр

11-79. [Хассан]

Хейж

80. Байгууллага нь УСНББОУС 41-ийг мөрддөг бөгөөд энэ Стандартын хейжийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудыг өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлого байдлаар үргэлжлүүлэн мөрдөх сонголт хийгээгүй (УСНББОУС 41-ийн 177-р параграфыг үзнэ үү) бол тухайн байгууллага нь УСНББОУС 41-ийн 113-155-р параграф дахь хейжийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудыг даган мөрднө. Харин санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрийн багцын нэг хэсэгт хамаарах хүүний түвшний эрсдлийн бодит үнэ цэнийн хейжийн хувьд УСНББОУС 41-ийн 115-р параграфт заасанчлан, байгууллага нь УСНББОУС 41-ийн шаардлагуудыг биш, харин энэ Стандартын хейжийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудыг мөрдөж болно. Энэ тохиолдолд байгууллага нь хүүний

түвшний эрсдлийн багц хейжийн хувьд бодит үнэ цэнийн хейжийн нягтлан бодох бүртгэлийн тусгай шаардлагуудыг мөн даган мөрдөх ёстой (91, 100, МЗУ157-МЗУ175-р параграфыг үзнэ үү). 95-98-р параграф болон Хавералт А-гийн МЗУ142-МЗУ144-р параграфт заасанчлан, хейжийн хэрэглүүр ба хейжийн зүйлийн хооронд сонгосон хейжийн харилцаа оршин байгаа бол уг хейжийн хэрэглүүр болон хейжийн зүйлийн олз гарзын тайлагналд 99-113-р параграфыг мөрдөнө.

...

88. ~~Хоронго оруулалтыг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших гэж ангилах нь хүүний түвшний өөрчлөлтийн улмаас уг хоронго оруулалтын бодит үнэ цэнэ буюу мөнгөн гүйлгээнд гарах өөрчлөлтөөс үл хамааран тухайн хоронго оруулалтыг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших санаа зорилготой байхыг шаарддаг тул зээл ба авлагаас ялгаатай нь, ийм дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хоронго оруулалт нь хүүний түвшний эрсдэл болон урьдчилан төлөх эрсдлийн хувьд хейжийн зүйл болж чадахгүй. Харин дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хоронго оруулалт нь гадаад валютын ханшийн өөрчлөлтийн эрсдэл болон эзэлийн эрсдлийн хувьд хейжийн зүйл байж болно.~~

...

98. Дараах бүх нөхцлүүд хангагдах зөвхөн тийм тохиолдолд хейжийн харилцаа нь 99-113-р параграфын дагуу хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангана:

- (a) Хейжийн эхэнд, уг хейжийн харилцаа, түүнчлэн хейжийг хийх тухайн байгууллагын эрсдлийн удирдлагын зорилго ба стратегийн талаархи албан ёсны сонголт болон баримтжуулалт хийгдсэн байх. Ийм баримтжуулалт нь хейжийн хэрэглүүр, хейжийн зүйл буюу ажил гүйлгээ, хейж хийгдэж буй эрсдлийн шинж төрөл, хейж хийсэн эрсдэлд хамаарах уг хейжийн зүйлийн бодит үнэ цэнийн буюу мөнгөн гүйлгээний өөрчлөлтийн эрсдлийг нөхөх тухайн хейжийн хэрэглүүрийн үр дүнтэй байдлыг тэрхүү байгууллага хэрхэн үнэлэх талаархи тодорхойлолтыг агуулсан байдаг.
- (б) Хейж нь уг хейж хийгдэж буй эрсдэлд хамаарах бодит үнэ цэнийн эсвэл мөнгөн гүйлгээний өөрчлөлтийг нөхөхөд өндөр үр дүнтэй (Хавералт А-гийн МЗУ145-МЗУ156-р параграфыг үзнэ үү) бөгөөд тухайн хейжийн харилцааны хувьд анх баримтжуулсан эрсдлийн удирдлагын стратегитай нийцнэ гэж хүлээгдэж байх.
- (в) Мөнгөн гүйлгээний хейжийн хувьд тухайн хейжийн зүйл болох урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь хэрэгжих өндөр магадлалтай байх ёстой бөгөөд ашиг, алдагдалд эцэстээ нөлөө үзүүлэх мөнгөн гүйлгээний хэлбэлзэл өөрчлөлтийн эрсдлийг илэрхийлдэг байх.
- (г) Хейжийн үр дүнтэй байдлыг найдвартай хэмжиж чадахаар байх. Өөрөөр хэлбэл, тухайн хейж хийсэн эрсдэлд хамаарах хейжийн зүйлийн бодит үнэ цэнэ буюу мөнгөн гүйлгээ болон хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадахаар байх (~~бодит үнэ цэнийг тодорхойлох талаархи заавар удирдамжийг 48, 49-р параграф болон Хавералт А-гийн МЗУ113, МЗУ114-р параграфыг үзнэ үү~~).
- (д) Хейжийг тасралтгүй сууриар үнэлэх бөгөөд уг хейжийг сонгосон тухайн санхүүгийн тайлагналын үеийн туршид түүнийг өндөр үр дүнтэй байна гэдгийг бодитойгоор тодорхойлсон байх.

Бодит үнэ цэнийн хейж

99. Хэрэв бодит үнэ цэнийн хейж нь тухайн тайлант үеийн туршид 98-р параграфт заасан нөхцлүүдийг хангаж байвал түүнийг дараах байдлаар тайлагнана:

- (a) Хейжийн хэрэглүүрийг (үүсмэл хейжийн хэрэглүүрийн хувьд) бодит үнэ цэнээр дахин хэмжсэнээр үүссэн эсвэл УСНББОУС 4-ийн дагуу хэмжсэн (үүсмэл бус

хейжийн хэрэглүүрийн хувьд) түүний дансны үнэ дэх гадаад валютын бүрэлдэхүүн хэсгээс үүссэн олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө; ба

- (б) Хейж хийсэн эрсдэлд хамаарах тухайн хейжийн зүйлийн олз, гарзаар энэхүү хейжийн зүйлийн дансны үнийг тохируулах ба ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Хейжийн зүйлийг өртгөөс өөрөөр хэмжсэн бол үүнийг мөрдөнө. Тухайн хейжийн зүйл нь УСНББОУС 41-ийн 41-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн борлуулах бөлөмжтөй санхүүгийн хөрөнгө байх тохиолдолд уг хейж хийсэн эрсдэлд хамаарах олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

...

101. Хэрэв хейжийн зүйлд хамаарах зөвхөн зарим тодорхой эрсдэлд хейж хийдэг уг хейж хийсэн эрсдэлтэй холбоогүй хейжийн зүйлийн бодит үнэ цэнийн хүлээн зөвшөөрсөн өөрчлөлтийг УСНББОУС 41-ийн 101-р 64-р параграфт заасны дагуу хүлээн зөвшөөрнө.

102. Дараах тохиолдолд байгууллага нь 99-р параграфт заасан хейжийн нягтлан бодох бүртгэлийг цаашид үргэлжлүүлэхгүй:

- (а) Хейжийн хэрэглүүрийн хугацаа дууссан, борлуулсан, дуусгавар болгосон эсвэл хэрэгжүүлсэн. (Хейжийн хэрэглүүрийг өөр хейжийн хэрэглүүрээр орлуулах буюу солих нь тухайн байгууллагын баримтжуулсан хейжийн стратегийн нэг хэсэг бол дээрх зорилгын хувьд хейжийн хэрэглүүрийн сольж, орлуулалтыг түүний хугацаа дуусалт эсвэл дуусгавар болголт гэж үзэхгүй); Мөн түүнчлэн, энэ зорилгын хувьд доорх тохиолдол нь хейжийн хэрэглүүрийн хугацаа дуусалт буюу дуусгавар болголт биш юм. Үүнд:

(i) Хууль, тогтоомжийн үйлчлэл эсвэл шинэ хууль, тогтоомжийн хэрэгжилтийн үр дүнд нэг буюу хэд хэдэн клирингийн байгууллагууд нь өөрийн анхны хамтрагч клирингийн байгууллагыг солих, ингэснээр бие биенийхээ хувьд шинэ хамтрагч клирингийн байгууллага болохыг уг хейжийн хэрэглүүрийн оролцогч талууд зөвшөөрөх. Энэ зорилгын хувьд клирингийн байгууллага гэдэг нь клирингийн төв байгууллага (зарим үед үүнийг “клирингийн төв” эсвэл “клирингийн агент” гэж нэрлэдэг) эсвэл нэг ба хэд хэдэн ийм клирингийн байгууллагууд юм. Жишээлбэл; клирингийн төв байгууллага нь өөрийн клирингийн үйл ажиллагааг гүйцэтгэхэд хамтрагчийн үүрэг гүйцэтгэх уг клирингийн байгууллагын гишүүн буюу клирингийн байгууллагын гишүүн бус хамтрагч. Гэхдээ хейжийн хэрэглүүрийн оролцогч талууд нь өөрсдийн анхны клирингийн байгууллагыг өөр клирингийн байгууллагаар солих тохиолдолд тэдгээр оролцогч тал бүр нь клирингийн үйл ажиллагаагаа нэг клирингийн төв байгууллагаар дамжуулан хийлгэдэг зөвхөн тийм тохиолдолд энэ дэд параграфын шаардлага хангагдах юм.

(ii) Хейжийн хэрэглүүрт оруулах аливаа бусад өөрчлөлтүүд нь тухайн оролцогч тал ийм сольж орлуулалт хийхэд зайлшгүй хүргэх тийм өөрчлөлтүүдээр хязгаарлагдсан байх. Ийм өөрчлөлт нь уг хейжийн хэрэглүүрийг анхнаасаа энэхүү клирингийн байгууллагаар гүйцэтгүүлсэн бол хүлээх байсан нөхцөлтэй нийцэх тийм нөхцлүүдээр хязгаарлагдана. Эдгээр өөрчлөлтөнд барьцааны шаардлага, авлага ба өглөгийн үлдэгдлийг харилцан суутгаж, цэвэр дүн гаргах эрх, төлөх шимтгэл зэргийн өөрчлөлт хамаарна.

- (б) Тухайн хейж нь 98-р параграфт заасан хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг цаашид хангахгүй болсон; эсвэл
- (в) Байгууллага нь хейжийн хэрэглүүрээр сонгохоо больсон.

...

Мөнгөн гүйлгээний хейж

...

107. Арай тодруулбал, мөнгөн гүйлгээний хейжийг дараах байдлаар тайлагнана:
- (a) Хейжийн зүйлтэй холбоотой цэвэр хөрөнгө/өмчийн тусдаа бүрэлдэхүүн хэсгийг доорх дүнгүүдийн (үнэмлэхүй дүнгээр) аль багатай тэнцүү болгон тохируулна:
 - (i) Хейжийн эхлэлийн өдрөөс хойш уг хейжийн хэрэглүүрийн хувьд хуримтлагдсан олз эсвэл гарз; ба
 - (ii) Хейжийн эхлэлийн өдрөөс хойш тухайн хейжийн зүйлээс хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн гүйлгээний бодит үнэ цэнийн (өнөөгийн үнэ цэнийн) хуримтлагдсан өөрчлөлт;
 - (б) Хейжийн хэрэглүүрийн эсвэл түүний сонгосон хэсгийн аливаа үлдсэн олз, гарзыг (энэ нь үр дүнтэй хейж биш) ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө; ба
 - (в) Хейжийн харилцааны талаархи тухайн байгууллагын эрсдлийн удирдлагын баримтжуулсан стратеги нь хейжийн хэрэглүүрийн олз, гарзын эсвэл холбогдох мөнгөн гүйлгээний тодорхой бүрэлдэхүүн хэсгийг хейжийн үр дүнтэй байдлын үнэлгээнд харгалздаггүй бол (83, 84, 98(a) параграфыг үзнэ үү) тэрхүү харгалзан оруулдаггүй олз, гарзын бүрэлдэхүүн хэсгийг УСНББОУС 41-ийн 101-р 64-р параграфын дагуу хүлээн зөвшөөрнө.
108. Урьдчилан таамагласан ажил гүйлгээний хейж нь дараагийн тайлант үед санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөр хүлээн зөвшөөрөхөд хүргэдэг бол 106-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн холбогдох олз, гарзыг уг хейж хийсэн урьдчилан таамагласан мөнгөн гүйлгээ нь ашиг, алдагдалд нөлөө үзүүлэх тэрхүү тайлант үед буюу үеүдэд (хүүний орлого эсвэл хүүний зардлыг хүлээн зөвшөөрсөн тайлант үед гэх мэт) дахин ангилах залруулга байдлаар ашиг, алдагдалд дахин ангилна. Гэвч цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн бүх буюу зарим гарз нь ирээдүйн нэг болон хэд хэдэн тайлант үеүдэд нөхөгдөхгүй гэж уг байгууллага хүлээж байгаа бол тэрхүү нөхөгдөхөөргүй байгаа дүнг дахин ангилах залруулга байдлаар ашиг, алдагдалд дахин ангилна.
109. Урьдчилан таамагласан ажил гүйлгээний хейж нь дараагийн тайлант үед санхүүгийн бус хөрөнгө буюу санхүүгийн бус өр төлбөр хүлээн зөвшөөрөхөд хүргэдэг, эсвэл санхүүгийн бус хөрөнгө буюу санхүүгийн бус өр төлбөрийн талаархи урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь арилжааны баталгаа болдог бөгөөд түүнд бодит үнэ цэнийн хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэх бол байгууллага нь доорх (a) эсвэл (б) заалтыг баримтална:
- (a) 106-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн холбогдох олз, гарзыг уг худалдаж авсан хөрөнгө буюу хариуцсан өр төлбөр нь ашиг, алдагдалд нөлөө үзүүлэх тэрхүү тайлант үед буюу үеүдэд (элэгдлийн зардал эсвэл бараа материалыг зардал гэж хүлээн зөвшөөрсөн тайлант үед гэх мэт) дахин ангилах залруулга байдлаар ашиг, алдагдалд дахин ангилна. Гэвч цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн бүх буюу зарим гарз нь ирээдүйн нэг болон хэд хэдэн тайлант үеүдэд нөхөгдөхгүй гэж уг байгууллага нь хүлээж байгаа бол тэрхүү нөхөгдөхөөргүй байгаа дүнг дахин ангилах залруулга байдлаар цэвэр хөрөнгө/өмчөөс ашиг, алдагдалд дахин ангилна.
 - (б) 106-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн холбогдох олз, гарзыг цэвэр хөрөнгө/өмчөөс хасаж, тухайн хөрөнгө, өр төлбөрийн анхны өртөгт буюу бусад адилтгах дансны үнэд тусган оруулна.
- ...
111. 108 ба 109-р параграфт хамаарахаас бусад, мөнгөн гүйлгээний хейжийн хувьд цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрч байсан дүнгүүдийг уг хейж хийсэн урьдчилан таамагласан мөнгөн гүйлгээ нь ашиг, алдагдалд нөлөө үзүүлэх тэрхүү тайлант үед буюу

үеүдэд (жишээлбэл; урьдчилан таамаглаж байсан борлуулалт хийгдсэн үед) дахин ангилах залруулга байдлаар ашиг, алдагдалд дахин ангилна.

112. Дараах аль нэг нөхцөл байдалд байгууллага нь 106-111-р параграфт заасан хейжийн нягтлан бодох бүртгэлийг цаашид үргэлжлүүлэхгүй:

(а) Хейжийн хэрэглүүрийн хугацаа дууссан, борлуулсан, дуусгавар болгосон эсвэл хэрэгжүүлсэн (~~Хейжийн хэрэглүүрийг өөр хейжийн хэрэглүүрээр орлуулах буюу солих нь тухайн байгууллагын баримтжуулсан хейжийн стратегийн нэг хэсэг бол дээрх зорилгын хувьд хейжийн хэрэглүүрийн сольж, орлуулалтыг түүний хугацаа дуусалт эсвэл дуусгавар болголт гэж үзэхгүй~~). Ийм тохиолдолд уг хейж үр дүнтэй болсон тайлант үеэс эхлэн цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа, хейжийн хэрэглүүрийн хуримтлагдсан олз, гарз (106(а) параграфыг үзнэ үү) нь тухайн урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарч тохиолдох хүртэл цэвэр хөрөнгө/өмчид тусдаа тусгагдсан хэвээр байна. Уг ажил гүйлгээ гарч тохиолдсон үед 108, 109 эсвэл 111-р параграфыг мөрдөнө. Хейжийн хэрэглүүрийг өөр хейжийн хэрэглүүрээр орлуулах буюу солих нь тухайн байгууллагын баримтжуулсан хейжийн стратегийн нэг хэсэг бол энэхүү дэд параграфын зорилгын хувьд хейжийн хэрэглүүрийн сольж, орлуулалтыг түүний хугацаа дуусалт эсвэл дуусгавар болголт гэж үзэхгүй. Мөн түүнчлэн, энэ дэд параграфын зорилгын хувьд доорх тохиолдол нь хейжийн хэрэглүүрийн хугацаа дуусалт буюу дуусгавар болголт биш юм. Үүнд:

(i) Хууль, тогтоомжийн үйлчлэл эсвэл шинэ хууль, тогтоомжийн хэрэгжилтийн үр дүнд нэг буюу хэд хэдэн клирингийн байгууллагууд нь өөрийн анхны хамтрагч клирингийн байгууллагыг солих, ингэснээр бие биенийхээ хувьд шинэ хамтрагч клирингийн байгууллага болохыг уг хейжийн хэрэглүүрийн оролцогч талууд зөвшөөрөх. Энэ зорилгын хувьд клирингийн байгууллага гэдэг нь клирингийн төв байгууллага (зарим үед үүнийг “клирингийн төв” эсвэл “клирингийн агент” гэж нэрлэдэг) эсвэл нэг ба хэд хэдэн ийм клирингийн байгууллагууд юм. Жишээлбэл; клирингийн төв байгууллага нь өөрийн клирингийн үйл ажиллагааг гүйцэтгэхэд хамтрагчийн үүрэг гүйцэтгэх уг клирингийн байгууллагын гишүүн буюу клирингийн байгууллагын гишүүн бус хамтрагч. Гэхдээ хейжийн хэрэглүүрийн оролцогч талууд нь өөрсдийн анхны клирингийн байгууллагыг өөр клирингийн байгууллагаар солих тохиолдолд тэдгээр оролцогч тал бүр нь клирингийн үйл ажиллагаагаа нэг клирингийн төв байгууллагаар дамжуулан хийлгэдэг зөвхөн тийм тохиолдолд энэ дэд параграфын шаардлага хангагдах юм.

(ii) Хейжийн хэрэглүүрт оруулах аливаа бусад өөрчлөлтүүд нь тухайн оролцогч тал ийм сольж орлуулалт хийхэд зайлшгүй хүргэх тийм өөрчлөлтүүдээр хязгаарлагдсан байх. Ийм өөрчлөлт нь уг хейжийн хэрэглүүрийг анхнаасаа энэхүү клирингийн байгууллагаар гүйцэтгүүлсэн бол хүлээх байсан нөхцөлтэй нийцэх тийм нөхцлүүдээр хязгаарлагдана. Эдгээр өөрчлөлтөнд барьцааны шаардлага, авлага ба өглөгийн үлдэгдлийг харилцан суутгаж, цэвэр дүн гаргах эрх, төлөх шимтгэл зэргийн өөрчлөлт хамаарна.

(б) Тухайн хейж нь 98-р параграфт заасан хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг цаашид хангахгүй болсон. Ийм тохиолдолд уг хейж үр дүнтэй болсон тайлант үеэс эхлэн цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа, хейжийн хэрэглүүрийн хуримтлагдсан олз, гарз (106(а) параграфыг үзнэ үү) нь тухайн урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарч тохиолдох хүртэл цэвэр хөрөнгө/өмчид тусдаа тусгагдсан хэвээр байна. Уг ажил гүйлгээ гарч тохиолдсон үед 108, 109 эсвэл 111-р параграфыг мөрдөнө.

(в) Урьдчилан таамагласан ажил гүйлгээг цаашид гарч тохиолдоно гэж хүлээхгүй болсон. Ийм тохиолдолд уг хейж үр дүнтэй болсон тайлант үеэс эхлэн цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа, хейжийн хэрэглүүрийн аливаа холбогдох хуримтлагдсан олз, гарзыг (106(а) параграфыг үзнэ үү) дахин

ангилах залруулга байдлаар ашиг, алдагдалд дахин ангилна. Хэрэгжих өндөр магадлалтай (98(в) параграфыг үзнэ үү) байгаа больсон уг урьдчилан таамагласан ажил гүйлгээг хэрэгжинэ гэж хүлээсэн хэвээр байж болно.

- (г) Байгууллага нь хейжийн хэрэглүүрээр сонгохоо больсон. Урьдчилан таамагласан ажил гүйлгээний хейжийн хувьд, уг хейж үр дүнтэй болсон тайлант үеэс эхлэн цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа, хейжийн хэрэглүүрийн хуримтлагдсан олз, гарз (106(а) параграфыг үзнэ үү) нь тухайн урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарч тохиолдох эсвэл гарч тохиолдоно гэж хүлээхээ болих хүртэл цэвэр хөрөнгө/өмчид тусдаа тусгагдсан хэвээр байна. Уг ажил гүйлгээ гарч тохиолдсон үед 108, 109 эсвэл 111-р параграфыг мөрдөнө. Хэрэв тухайн ажил гүйлгээг гарч тохиолдоно гэж хүлээхээ больсон бол цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн уг хуримтлагдсан олз, гарзыг дахин ангилах залруулга байдлаар ашиг, алдагдалд дахин ангилна.

Цэвэр хөрөнгө оруулалтын хейж

113. Гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын хейжийг, үүн дотроо уг цэвэр хөрөнгө оруулалтын нэг хэсэг байдлаар тайлагнасан мөнгөн зүйлсийн хейжийг (УСНББОУС 4-ийг үзнэ үү) мөнгөн гүйлгээний хейжийн нэгэн адилаар тайлагнана:

- (а) Үр дүнтэй хейж (98-р параграфыг үзнэ үү) гэж тодорхойлсон хейжийн хэрэглүүрийн олз, гарзын тэрхүү хэсгийг цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлангаар (УСНББОУС 1-ийг үзнэ үү) дамжуулан цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрөх; ба
- (б) Хейжийн хэрэглүүрийн үр дүнгүй хэсгийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх.

Хейжийн үр дүнтэй хэсэгтэй холбоотой бөгөөд цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн уг хейжийн хэрэглүүрийн олз, гарзыг тухайн гадаад үйл ажиллагааг данснаас хасах үед УСНББОУС 4-ийн 56-57-р параграфын дагуу дахин ангилах залруулга байдлаар ашиг, алдагдалд дахин ангилна.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

- 125И. 2018 оны 8 дугаар сард гаргасан, УСНББОУС 41-ээр 2, 9, 10, 80, 98, 99, 101, 102, 107, 108, 109, 111, 112, 113, МЗУ128, МЗУ157, МЗУ161-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, МЗУ156А параграфыг шинээр нэмсэн ба 1, 3, 4, 5, 6, 11-79, 88, МЗУ1-МЗУ126, МЗУ129-р параграфыг хассан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд УСНББОУС 41-ийг мөн уг өмнөх тайлант хугацаанд дагаж мөрдөнө.

...

Мөрдөх заавар удирдамж

Энэ Хавсралт нь УСНББОУС 29-ийн салиггүй бүрэлдэхүүн хэсэг юм.

...

МЗУ1-МЗУ126. [Хассан] ...

Шалгуур хангах хейжийн хэрэглүүр (81 ба 82-р параграф)

...

МЗУ128. ~~Хорогдуулсан өртгөөр бүртгээн, дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтыг хэмжсэн санхүүгийн хөрөнгийг~~ гадаад валютын эрсдлийн хейжийн хувьд хейжийн хэрэглүүр гэж сонгож болно.

МЗУ129. ~~Бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжиж чадахгүйн улмаас бодит үнэ цэнээр бүртгэдэггүй, жишиг зах зээлийн үнэгүй өмчийн хэрэглүүрт эсвэл ийм жишиг зах зээлийн үнэгүй өмчийн хэрэглүүртэй уялдан ба түүнийг өгөнөөр барагдуулах ёстой үүемэл хэрэглүүрт оруулан хөрөнгө оруулалтыг (48(в) ба 49-р параграфыг үзнэ үү) хейжийн хэрэглүүр гэж сонгож болохгүй.~~

Шалгуур хангах хейжийн зүйлс (87-89-р параграф)

...

МЗУ134. Эдийн засгийн нэгдмэл байгууллагын доторх урьдчилан таамагласан ажил гүйлгээний хейж нь хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангадаг бол 106(а) параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн аливаа олз, гарзыг уг хейж хийсэн ажил гүйлгээний гадаад валютын эрсдэл нь нэгтгэсэн ашиг, алдагдалд нөлөө үзүүлэх тэрхүү тайлант үед буюу үеүдэд дахин ангилах залруулга байдлаар ашиг, алдагдалд дахин ангилна.

...

Хейжийн үр дүнтэй байдлыг үнэлэх

...

~~МЗУ156А. — Эргэлээ торүүлэхээ зайлсхийхийн тулд, 102(а)(ii) ба 112(а)(ii) параграфт заасанчлан, өөрсдийн анхны клирингийн байгууллагыг өөр клирингийн байгууллагаар сольж ба холбогдох өөрчлөлтийг хийсний үр нөлөөг тухайн хейжийн хэрэглүүрийн хэмжилтэнд, ингэснээр хейжийн үр дүнтэй байдлын үнэлгээ болон хейжийн үр дүнтэй байдлын хэмжилтэнд тусгана.~~

Хүүний түвшний эрсдлийн багц хейжид хамаарах бодит үнэ цэнийн хейжийн нягтлан бодох бүртгэл

МЗУ157. Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн багцтай холбоотой хүүний түвшний эрсдлийн бодит үнэ цэнийн хейжийн хувьд байгууллага нь доорх (а)-(к)-д болон МЗУ158-МЗУ175-р параграфт заасан горимуудыг даган мөрдвөл энэ Стандартын шаардлагуудыг хангах юм.

- (а) Хүүний түвшний эрсдлийнх хувьд хейж хийхийг хүсэж буй зүйлсийн багцыг байгууллага нь өөрийн эрсдлийн удирдлагын үйл ажиллагааны нэг хэсэг байдлаар тодорхойлно. Тухайн багц нь зөвхөн хөрөнгөөс эсвэл зөвхөн өр төлбөрөөс, эсвэл хөрөнгө, өр төлбөрийн аль алинаас бүрдэж болно. Байгууллага нь хоёр ба түүнээс олон багцыг тодорхойлж болох (~~жинээлбэл, байгууллага нь өөрийн бөрлуулах боломжтой хөрөнгүүдийг тусдаа багцад бүлэглэж болох~~) бөгөөд энэ тохиолдолд доорх заавар удирдамжийг багц нэг бүрд тусад нь мөрдөнө.
- (б) Байгууллага нь гэрээнд заасан бус, харин хүлээгдэж буй дахин хянах өдрүүдэд үндэслэн уг багцыг тэдгээр дахин хянах тайлант үеүдээр шинжилнэ. Дахин хянах тайлант үеүдээр хийгдэх шинжилгээг янз бүрийн арга замаар гүйцэтгэж болно. Үүнд: мөнгөн гүйлгээг түүний үүсэхээр хүлээгдэж буй тайлант үеүдээр хуваарилан гаргах эсвэл нэрлэсэн үндсэн төлбөрүүдийг дахин хяналт хийхээр хүлээгдэж буй өдөр хүртэлх бүх тайлант үеүдэд хуваарилан гаргах.
- (в) Энэхүү шинжилгээнд үндэслэн, байгууллага нь хейж хийхийг хүсэж буй дүнг тодорхойлно. Тухайн тодорхойлсон багцаас авсан бөгөөд хейж хийгдэж буй гэж сонгохыг хүссэн дүнтэй тэнцүү байх тийм хөрөнгө эсвэл өр төлбөрийн дүнг (гэхдээ цэвэр

дүн биш) уг байгууллага нь хейжийн зүйл гэж сонгоно. Мөн энэ дүн нь МЗУ169(б) параграфын дагуу үр дүнтэй байдлыг сориход ашиглагдах хувийн жингийн хэмжигдэхүүнийг тодорхойлно.

- (г) Байгууллага нь хейж хийгдэж буй хүүний түвшний эрсдлийг сонгоно. Энэхүү эрсдэл нь хейж хийгдэж буй төлөв байдал дахь зүйлс тус бүрд хамаарах бенчмарк хүүний түвшин (жишээ нь; свопын түвшин) гэх мэт хүүний түвшний эрсдлийн тодорхой нэг хэсэг байж болно.
- (д) Байгууллага нь дахин хянах тайлант үе тус бүрд нэг буюу хэд хэдэн хейжийн хэрэглүүрийг сонгоно.
- (е) Дээрх (в)-(д)-д хийсэн сонголтыг ашигласнаар, байгууллага нь уг хейжийг сонгосон тайлант үеийн туршид тухайн хейж өндөр үр дүнтэй байхаар хүлээгдэж буй эсэхийг хейжийн эхэнд болон дараагийн тайлант үеүүдэд үнэлнэ.
- (ж) Байгууллага нь (б)-д дурдсан, хүлээгдэж буй дахин хянах өдрүүдэд үндэслэн тухайн хейж хийсэн эрсдэлд ((г)-д сонгосон) хамаарах хейжийн зүйлийн ((в)-д сонгосон) бодит үнэ цэнийн өөрчлөлтийг хэмжинэ. Үр дүнтэй байдлыг үнэлэх уг байгууллагын баримтжуулсан аргыг ашиглан үнэлгээ хийж үзэхэд тухайн хейж нь өндөр үр дүнтэй гэдгийг бодитойгоор тодорхойлсон бол байгууллага нь хейжийн зүйлийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд олз эсвэл гарз гэж хүлээн зөвшөөрөх бөгөөд 100-р параграфт дурдсан, санхүүгийн байдлын тайлангийн хоёр мөрийн зүйлийн аль нэгэнд тусгана. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бие даасан хөрөнгө эсвэл өр төлбөрт хуваарилах шаардлагагүй юм.
- (и) Байгууллага нь хейжийн хэрэглүүрийн ((д)-д сонгосон) бодит үнэ цэнийн өөрчлөлтийг хэмжиж, ашиг, алдагдалд олз эсвэл гарз гэж хүлээн зөвшөөрнө. Тухайн хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг санхүүгийн байдлын тайланд хөрөнгө эсвэл өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө.
- (к) Аливаа үр дүнгүй байдлыг дээрх (ж) болон (и)-д дурдсан бодит үнэ цэнийн өөрчлөлтүүдийн хоорондох зөрүүгээр ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө (бусад УСНББОУС-д заасантай ижил материаллаг байдлын ач холбогдлыг харгалзсанаар үр дүнтэй байдлыг хэмждэг).

...

МЗУ161. МЗУ157(в) параграфт заасан сонголтыг дараах жишээгээр авч үзье. Байгууллага нь дахин хянах тайлант үе бүрийн хувьд тогтмол хүүтэй 100ТН-ийн хөрөнгөтэй, тогтмол хүүтэй 80ТН-ийн өр төлбөртэй байна гэж тооцоолсон бөгөөд 20ТН-ийн нийт цэвэр дүнд хейж хийхээр шийдвэрлэсэн бол 20ТН бүхий хөрөнгийг (байгууллага нь шалгуур хангах бэлэн боломжтой байгаа хөрөнгө буюу өр төлбөрийн дурын дүнг, өөрөөр хэлбэл энэ жишээнд 0ТН-ээс 100ТН-ийн хоорондох хөрөнгийн дурын дүнг сонгохыг энэ Стандартаар зөвшөөрдөг тул тэрхүү хөрөнгийн хэсгийг) хейжийн зүйл гэж сонгоно. Сонголтыг бие даасан хөрөнгөөр биш, харин “мөнгөн дүн”-гээр (жишээлбэл, доллар, евро, фунт стирлингийн эсвэл рандын дүн) илэрхийлнэ. Эндээс дараах дүгнэлтийг хийж болно: тухайн хейж хийгдэж буй дүнг гарган авч буй бүх хөрөнгө (эсвэл өр төлбөр) өөрөөр хэлбэл, дээрх жишээн дэх 100ТН-ийн бүх хөрөнгө нь:

- (а) Хүүний түвшний өөрчлөлтийн улмаас түүний бодит үнэ цэнэд гарах өөрчлөлтийн хувьд хейж хийгдэж буй зүйлс байх ёстой; ба
- (б) Хэрэв тэднийг тус тусад нь хейж хийхээр сонгосон бол бодит үнэ цэнийн хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангаж чадах зүйлс байх ёстой. Тухайлбал; шаардсан даруйд олгох шинж бүхий санхүүгийн өр төлбөрийн (харилцах данс, хугацаагүй хадгаламж ба зарим төрлийн хугацаат хадгаламж гэх мэт) бодит үнэ цэнэ нь тухайн дүнг төлөхийг шаардаж болох хамгийн эхний өдрөөс эхлэн дискаунтчилсан, уг шаардсан даруйд олгох өглөгийн дүнгээс багагүй байна гэж УСНББОУС 41-д энэ Стандартын 52-р параграфт тусгайлан заасан учраас ийм зүйл нь түүний эзэмшигч төлбөрийг шаардаж болох хамгийн богино тайлант үеэс цаашхи аливаа тайлант үед

бодит үнэ цэнийн хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангахгүй юм. Дээрх жишээнд хейж хийсэн төлөв байдал нь хөрөнгийн дүн байна. Тийм учраас ийм өр төлбөр нь сонгосон хейжийн зүйлийн нэг хэсэг болохгүй боловч байгууллага нь хейж хийж буй гэж сонгох хөрөнгийн дүнг тодорхойлохын тулд уг өр төлбөрийг ашигладаг. Хэрэв байгууллагын хейж хийхийг хүссэн төлөв байдал нь өр төлбөрийн дүн байсан бол арай эрт буцаан төлөхийг тухайн байгууллагаас шаардаж чадах тийм өр төлбөрөөс бусад, тогтмол хүүтэй өр төлбөрөөс уг сонгосон хейжийн зүйлийг төлөөлөн илэрхийлэх дүнг гарган авах ёстой бөгөөд МЗУ169(б) параграфын дагуу хейжийн үр дүнтэй байдлыг үнэлэхэд ашигласан хувийн жингийн хэмжигдэхүүнийг тэрхүү бусад өр төлбөрийн хувийн жин байдлаар тооцоолно. Жишээлбэл; байгууллага нь дахин хянах тайлант үе бүрийн хувьд тогтмол хүүтэй 100ТН-ийн өр төлбөртэй, тогтмол хүүтэй 70ТН-ийн хөрөнгөтэй байхаар тооцоолсон гэж үзье. Энэхүү 100ТН-ийн өр төлбөр нь шаардсан даруйд олгох 40ТН-ийн өр төлбөр, шаардсан даруйд олгох тийм шинж чанаргүй 60ТН-ийн өр төлбөрөөс бүрддэг. Хэрэв байгууллага нь 30ТН-ийн бүх цэвэр төлөв байдал буюу цэвэр дүнд хейж хийхээр шийдвэрлэсэн бол тухайн байгууллага нь шаардсан даруйд олгох шинж чанаргүй өр төлбөрийн 30ТН буюу 50 хувийг $(30ТН / (100ТН - 40ТН) = 50$ хувь) хейжийн зүйл гэж сонгоно.

...

Хавсралт Б-г хассан. Заавар удирдамжийг УСНББОУС 41-ийн МЗУ109 ба МЗУ110-р параграфт тусган оруулсан.

...

Хавсралт Б: Дагалдах үүсмэл хэрэглүүрийн дахин үнэлэлт

Б1-Б7. [Хассан]

...

Хэрэгжүүлэх заавар удирдамж

Энэхүү хэрэгжүүлэх заавар удирдамж нь УСНББОУС 29-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

Хэсэг А-Ж

[Хассан]

...

Үлгэрчилсэн жишээ

Энэхүү үлгэрчилсэн жишээ нь УСНББОУС 29-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

ҮЖ32-ҮЖ50. [Хассан]

...

УСНББОУС 30, Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга-д оруулсан нэмэлт өөрчлөлт

2, 3, 4, 5, 8, 11, 12, 13, 14, 18, 24, 34, 35, 36, 37, 41, 43, 45, МЗУ1, МЗУ5, МЗУ9, МЗУ10, МЗУ24, МЗУ29-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 16, 17, 20, 26, 27, 28, 44-р параграфыг хасаж, зарим гарчиг болон 5А, 13А, 14А, 14Б, 15А, 15Б, 15В, 17А, 17Б, 17В, 17Г, 17Д, 17Е, 20А, 24А, 25А, 25Б, 25В, 25Г, 26А, 26Б, 26В, 27А, 27Б, 27В, 27Г, 27Д, 27Е, 28А, 28Б, 28В, 28Г, 28Д, 28Е, 28Ж, 37А, 39А, 42А, 42Б, 42В, 42Г, 42Д, 42Е, 42Ж, 42И, 42К, 42Л, 42М, 42Н, 42О, 42П, 49А, 49Б, 49В, 49Г, 49Д, 49Е, 49И, 49К, 49Л, 49М, 49О, 49П, 49Р, 49С, 49Т, 49У, 49Ф, 52Е, МЗУ8А, МЗУ8Б, МЗУ8В, МЗУ8Г, МЗУ8Д, МЗУ8Е, МЗУ8Ж, МЗУ8И, МЗУ8К, МЗУ8Л, МЗУ31, МЗУ32, МЗУ32А, МЗУ33, МЗУ34, МЗУ35, МЗУ36, МЗУ37, МЗУ38, МЗУ39, МЗУ40, МЗУ41, МЗУ42, МЗУ43, МЗУ44, МЗУ45, МЗУ46, МЗУ47, МЗУ48, МЗУ49, МЗУ50, МЗУ51, МЗУ52, МЗУ53, МЗУ54, МЗУ55-р параграфыг шинээр нэмсэн.

Зорилго

...

2. Энэхүү Стандарт дахь зарчмууд нь УСНББОУС 28, *Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга* болон УСНББОУС 41, *Санхүүгийн Хэрэглүүр-г* ~~УСНББОУС 29, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт-г*~~ заасан санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх, хэмжих, толилуулах зарчмуудын нэмэлт гүйцээлт болно.

...

Цар хүрээ

3. Бүх байгууллагууд нь доор дурдсанаас бусад бүх төрлийн санхүүгийн хэрэглүүрийн хувьд энэ Стандартыг мөрдөнө:
- (а) УСНББОУС 34, *Тусдаа Санхүүгийн Тайлан*, УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*, УСНББОУС 36, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт*-ын дагуу тайлагнадаг хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоо. Гэвч зарим тохиолдолд УСНББОУС 34, УСНББОУС 35, УСНББОУС 36 нь хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоог УСНББОУС 41-ийн ~~УСНББОУС 29-ийн~~ дагуу тайлагнахыг байгууллагаас шаарддаг буюу зөвшөөрдөг. Ийм тохиолдолд байгууллага нь энэ Стандартын шаардлагуудыг мөрдөнө. Хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоотой холбоотой үүсмэл хэрэглүүр нь УСНББОУС 28-д заасан тухайн байгууллагын өмчийн хэрэглүүрийн тодорхойлолтыг хангахаас бусад тохиолдолд байгууллагууд нь тэрхүү үүсмэл хэрэглүүрт мөн энэ Стандартыг дагаж мөрдөнө.
 - (б) УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ийг мөрдөх ажилтны тэтгэмжийн хөтөлбөрийн дагуу хүлээх ажил олгогчийн эрх ба үүрэг.
 - (в) Даатгалын гэрээний дагуу үүсэх эрх ба үүрэг. Гэхдээ энэ Стандартыг дараах зүйлсэд мөрдөнө:
 - (i) Хэрэв УСНББОУС 41 ~~УСНББОУС 29~~ нь даатгалын гэрээг дагалдан гардаг үүсмэл хэрэглүүрийг тусдаа тайлагнахыг байгууллагаас шаарддаг бол тэдгээр үүсмэл хэрэглүүрт;
 - (ii) Санхүүгийн баталгааны гэрээ гаргагч нь уг гэрээг хүлээн зөвшөөрөх ба хэмжихдээ УСНББОУС 41-ийг ~~УСНББОУС 29-ийг~~ мөрддөг бол тэрхүү санхүүгийн баталгааны гэрээ гаргагчийн хувьд энэ Стандартыг мөрдөнө; харин гаргагч нь даатгалын гэрээг хүлээн зөвшөөрч, хэмжихдээ тухайн даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг мөрдөх сонголт хийсэн бол тэдгээр стандартаа мөрдөнө.

Дээрх (i) ба (ii)-д дурдсанаас гадна байгууллага нь санхүүгийн эрсдлийн шилжүүлэлтийг агуулсан даатгалын гэрээнд энэ Стандартыг мөрдөж болох юм.

- (г) УСНББОУС 41-ийг УСНББОУС 29-ийг мөрддөг ба түүний 6-8-р 4-6-р параграфын цар хүрээнд хамаарах гэрээнүүдээс бусад бөгөөд хувьцаанд суурилсан төлбөрийг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг мөрддөг хувьцаанд суурилсан төлбөрийн ажил гүйлгээнээс үүссэн санхүүгийн хэрэглүүр, гэрээ ба үүрэг.
- (д) УСНББОУС 28-ын 15, 16-р параграфууд эсвэл 17, 18-р параграфуудын дагуу өмчийн хэрэглүүр гэж ангилах шаардлагатай санхүүгийн хэрэглүүр.

...

4. Хүлээн зөвшөөрсөн болон хүлээн зөвшөөрөөгүй санхүүгийн хэрэглүүрийн хувьд энэ Стандартыг мөрдөнө. Хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хэрэглүүр нь УСНББОУС 41-ийн УСНББОУС 29-ийн цар хүрээнд хамаарах санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийг агуулсан байна. Харин хүлээн зөвшөөрөөгүй санхүүгийн хэрэглүүр нь УСНББОУС 41-ийн УСНББОУС 29-ийн цар хүрээнд хамаарахгүй боловч энэ Стандартын цар хүрээнд хамаарах зарим санхүүгийн хэрэглүүрийг агуулсан байна.

...

5. УСНББОУС 41-ийн УСНББОУС 29-ийн цар хүрээнд хамаарах санхүүгийн бус зүйлийг худалдан авах буюу борлуулах гэрээний хувьд энэ Стандартыг мөрдөнө (УСНББОУС 41-ийн УСНББОУС 29-ийн 6-8-р 4-6-р параграфыг үзнэ үү).

- 5A. УСНББОУС 41-ийн 3-р параграфт заасанчлан, үнэ цэнийн бууралтын олз, гарз хүлээн зөвшөөрөх зорилгын хувьд санхүүгийн хэрэглүүр үүсэхэд хүргэдэг ба УСНББОУС 23-ын цар хүрээнд хамаарах арилжааны бус ажил гүйлгээ болон УСНББОУС 9-ийн цар хүрээнд хамаарах арилжааны ажил гүйлгээний үр дүн болох авлагыг цуглуулах эрхүүдийн хувьд 42A-42П параграфт дурдсан, зээлийн эрсдлийн тодруулгын шаардлагуудыг мөрдөнө. Өөрөөр зааснаас бусад тохиолдолд эдгээр параграфт дурдсан санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн хэрэглүүр гэсэн аливаа хэллэгт тэдгээр эрхийг хамруулна.

...

Тодорхойлолт

...

8. Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

Зээлийн эрсдэл гэдэг нь санхүүгийн хэрэглүүрийн оролцогч нэг тал нь үүргээ биелүүлээгүйн улмаас оролцогч нөгөө талдаа санхүүгийн хохирол учруулах эрсдэл юм.

Зээлийн эрсдлийн зэрэглэлийн түвшин гэдэг нь санхүүгийн хэрэглүүрийн хувьд үл биелүүлэлт гарах эрсдэлд үндэслэсэн зээлийн эрсдлийн зэрэглэл юм.

Валютын эрсдэл гэдэг нь санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ буюу ирээдүйн мөнгөн гүйлгээ нь гадаад валютын ханшийн өөрчлөлтийн улмаас хэлбэлзэн өөрчлөгдөх эрсдэл юм.

Хүүний түвшний эрсдэл гэдэг нь санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ буюу ирээдүйн мөнгөн гүйлгээ нь зах зээлийн хүүний түвшний өөрчлөлтийн улмаас хэлбэлзэн өөрчлөгдөх эрсдэл юм.

Төлбөрийн чадварын эрсдэл гэдэг нь мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг өгснөөр барагдуулах санхүүгийн өр төлбөртэй холбоотой үүргийг тухайн байгууллага биелүүлэхэд хүндрэлтэй болох эрсдэл юм.

Зээлийн өглөг гэдэг нь зээлийн хэвийн нөхцөл бүхий богино хугацаат худалдааны өглөгөөс бусад санхүүгийн өр төлбөр юм.

Зах зээлийн эрсдэл гэдэг нь санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ буюу ирээдүйн мөнгөн гүйлгээ нь зах зээлийн үнийн өөрчлөлтийн улмаас хэлбэлзэн өөрчлөгдөх эрсдэл юм. Зах зээлийн эрсдэл нь валютын эрсдэл, хүүний түвшний эрсдэл, үнийн бусад эрсдэл гэсэн гурван төрлийн эрсдлээс бүрддэг.

Үнийн бусад эрсдэл гэдэг нь санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ буюу ирээдүйн мөнгөн гүйлгээ нь зах зээлийн үнийн өөрчлөлтийн (хүүний түвшний эрсдэл буюу валютын эрсдлээс үүссэнээс бусад өөрчлөлтийн) улмаас хэлбэлзэн өөрчлөгдөх эрсдэл бөгөөд тэдгээр өөрчлөлт нь тухайн санхүүгийн хэрэглүүр буюу түүний гаргагчид тусгайлан хамаарах хүчин зүйлсээс эсвэл зах зээлд арилжаалагдаж буй ижил төсөөтэй бүх санхүүгийн хэрэглүүрт нөлөөлөх хүчин зүйлсээс шалтгаалсан эсэхээс үл хамаарна.

~~Гэрээний дагуу толох ёстой хугацаа болсон төлбөрийг нөгөө тал нь барагдуулаагүй тохиолдолд санхүүгийн хөрөнгийн хугацаа өнгөрсөн гэнэ.~~

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь*-д дахин нийтэлсэн болно.

...

Санхүүгийн байдал ба санхүүгийн үр дүнд санхүүгийн хэрэглүүрийн үзүүлэх ач холбогдол

...

Санхүүгийн байдлын тайлан

Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн ангилал

...

11. УСНББОУС 41-д ~~УСНББОУС 29-д~~ тодорхойлсон, дараах ангилал тус бүрийн дансны үнийг санхүүгийн байдлын тайланд эсвэл тодруулгад нэмж тодруулна:

- (а) Доорх байдлаар тусад нь харуулсан бөгөөд ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө: (i) анх хүлээн зөвшөөрөх үед буюу дараагийн тайлант үед УСНББОУС 41-ийн 152-р параграфын дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан санхүүгийн хөрөнгө, ба (ii) УСНББОУС 41-ийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр заавал хэмждэг УСНББОУС 29-ийн дагуу худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэж ангилсан санхүүгийн хөрөнгө;
- (б) ~~Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт;~~
- (в) ~~Зээл ба авлага;~~
- (г) ~~Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө;~~
- (д) Доорх байдлаар тусад нь харуулсан бөгөөд ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөр: (i) анх хүлээн зөвшөөрөх үед ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан буюу дараагийн тайлант үед УСНББОУС 41-ийн 152-р параграфын дагуу хэмжсэн санхүүгийн өр төлбөр, ба (ii) УСНББОУС 41-д заасан, худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэсэн тодорхойлолтыг хангасан УСНББОУС 29-ийн дагуу худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэж ангилсан санхүүгийн өр төлбөр; ба
- (е) ~~Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө өр төлбөр;~~
- (ж) Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн өр төлбөр; ба

- (и) Доорх байдлаар тусад нь харуулсан бөгөөд цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө: (i) УСНББОУС 41-ийн 41-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө; ба (ii) анх хүлээн зөвшөөрөх үед УСНББОУС 41-ийн 106-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан, өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт.

Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр

12. Бусад тохиолдолд цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр эсвэл хорогдуулсан өртгөөр хэмжих байсан санхүүгийн хөрөнгийг (буюу санхүүгийн хөрөнгүүдийн бүлгийг) байгууллага нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр Хэрэв байгууллага нь эзэл буюу авлагыг (эсвэл эзэлүүд буюу авлагуудын бүлгийг) ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан бол тухайн байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:

- (а) Тухайн тайлант үеийн эцэс дэх санхүүгийн хөрөнгийн (буюу санхүүгийн хөрөнгүүдийн бүлгийн) эзэл буюу авлагын (эсвэл эзэлүүд буюу авлагуудын бүлгийн) зээлийн эрсдлийн хамгийн их хэмжээ (43(а) параграфыг үзнэ үү);
- (б) Холбогдох аливаа зээлийн үүсмэл хэрэглүүр буюу ижил төсөөтэй хэрэглүүрээр уг зээлийн эрсдлийн хамгийн их хэмжээг бууруулах дүн (43(б) параграфыг үзнэ үү);
- (в) Санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдлийн өөрчлөлтөнд хамааруулж болох бөгөөд доорх хоёр хувилбарын аль нэгээр тодорхойлсон, уг санхүүгийн хөрөнгийн (буюу санхүүгийн хөрөнгүүдийн бүлгийн) эзэл буюу авлагын (эсвэл эзэлүүд буюу авлагуудын бүлгийн) бодит үнэ цэнэд тухайн тайлант үеийн туршид болон хуримтлагдсан байдлаар гарсан өөрчлөлтийн дүн:
- (i) Зах зээлийн эрсдэл үүсэхэд хүргэдэг тухайн зах зээлийн нөхцөл байдлын өөрчлөлтөнд хамааруулж болохгүй түүний бодит үнэ цэнийн өөрчлөлтийн дүн байдлаар; эсвэл
- (ii) Тухайн хөрөнгийн зээлийн эрсдлийн өөрчлөлтөнд хамааруулж болох түүний бодит үнэ цэнийн өөрчлөлтийн дүнг илүү үнэн зөв илэрхийлнэ гэж уг байгууллагын найдаж буй өөр хувилбар аргыг ашигласнаар.

Зах зээлийн эрсдэл үүсэхэд хүргэдэг, зах зээлийн нөхцөл байдлын өөрчлөлтөнд ажиглаж болох (бенчмарк) хүүний түвшин, бараа бүтээгдэхүүний үнэ, гадаад валютын ханш, үнийн буюу ханшийн индексийн өөрчлөлтүүд хамаарна.

- (г) Холбогдох аливаа зээлийн үүсмэл хэрэглүүр буюу ижил төсөөтэй хэрэглүүрийн бодит үнэ цэнэд уг санхүүгийн хөрөнгийг эзэл буюу авлагын ингэж ангилснаас хойш тухайн тайлант үеийн туршид болон хуримтлагдсан байдлаар гарсан өөрчлөлтийн дүн.

13. Хэрэв байгууллага нь УСНББОУС 41-ийн 46-р УСНББОУС 29-ийн 10-р параграфын дагуу санхүүгийн өр төлбөрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан ба тухайн өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтийн үр нөлөөг цэвэр хөрөнгө/өмчид толилуулах шаардлагатай (УСНББОУС 41-ийн 108-р параграфыг үзнэ үү) бол уг байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:

- (а) Санхүүгийн өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтөнд хамааруулж болох бөгөөд доорх хоёр хувилбарын аль нэгээр тодорхойлсон, уг санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнэд тухайн тайлант үеийн туршид болон хуримтлагдсан байдлаар гарсан өөрчлөлтийн дүн (өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтийн үр нөлөөг тодорхойлох заавар удирдамжийн хувьд УСНББОУС 41-ийн МЗУ236-МЗУ243-р параграфыг үзнэ үү):
- (i) Зах зээлийн эрсдэл үүсэхэд хүргэдэг тухайн зах зээлийн нөхцөл байдлын өөрчлөлтөнд хамааруулж болохгүй түүний бодит үнэ цэнийн өөрчлөлтийн дүн байдлаар (Хавералт А-гийн МЗУ4-р параграфыг үзнэ үү); эсвэл

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

~~(ii) Тухайн өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтөнд хамааруулж болох түүний бодит үнэ цэнийн өөрчлөлтийн дүнг илүү үнэн зөв илэрхийлнэ гэж уг байгууллагын найдаж буй өөр хувилбар аргыг ашигласнаар.~~

~~Зах зээлийн эрсдэл үүсэхэд хүргэдэг, зах зээлийн нөхцөл байдлын өөрчлөлтөнд бенчмарк хүүний түвшин, өөр байгууллагын санхүүгийн хэрэглүүрийн үнэ, бараа бүтээгдэхүүний үнэ, гадаад валютын ханш, үнийн буюу ханшийн индексийн өөрчлөлтүүд хамаарна. Нэгжтэй уялдах шинж бүхий гэрээний хувьд зах зээлийн нөхцөл байдлын өөрчлөлтөнд тухайн холбогдох дотоодын буюу гаднын хөрөнгө оруулалтын сангийн гүйцэтгэлийн өөрчлөлтүүд хамаардаг.~~

- (б) Санхүүгийн өр төлбөрийн дансны үнэ ба дуусвар болох өдөр уг өрийн хэрэглүүрийн эзэмшигчид гэрээний дагуу тухайн байгууллагын төлөх шаардлагатай дүн хоорондох зөрүү.
- (в) Хуримтлагдсан олз, гарзыг тухайн тайлант үеийн туршид цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгийн хооронд шилжүүлэх аливаа шилжүүлэлт, үүн дотроо ийм шилжүүлэлтийн учир шалтгаан.
- (г) Хэрэв өр төлбөрийг тухайн тайлант үеийн туршид үл хүлээн зөвшөөрсөн бол тэрхүү үл хүлээн зөвшөөрөлтөөр хэрэгжсэн бөгөөд цэвэр хөрөнгө/өмчид толилуулсан дүн (хэрэв байгаа бол).

13A. Хэрэв байгууллага нь УСНББОУС 41-ийн 46-р параграфын дагуу санхүүгийн өр төлбөрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан бөгөөд тэрхүү өр төлбөрийн бодит үнэ цэнийн бүх өөрчлөлтийг (үүн дотроо, өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтийн үр нөлөөг) ашиг, алдагдалд толилуулах шаардлагатай бол (УСНББОУС 41-ийн 108 ба 109-р параграфыг үзнэ үү) уг байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:

- (а) Санхүүгийн өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтөнд хамааруулж болох бөгөөд түүний бодит үнэ цэнэд тухайн тайлант үеийн туршид болон хуримтлагдсан байдлаар гарсан өөрчлөлтийн дүн (өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтийн үр нөлөөг тодорхойлох заавар удирдамжийг УСНББОУС 41-ийн МЗУ236-МЗУ243-р параграфтаас үзнэ үү); ба
- (б) Санхүүгийн өр төлбөрийн дансны үнэ ба дуусвар болох өдөр уг өрийн хэрэглүүрийн эзэмшигчид гэрээний дагуу байгууллагын төлөх шаардлагатай дүн хоорондох зөрүү.

14. Байгууллага нь мөн дараах зүйлсийг тодруулна:

- (а) 12(в), ~~ба~~ 13(а) ба УСНББОУС 41-ийн 13A(а), 108(а) параграфуудад заасан шаардлагуудыг даган мөрдөхийн тулд ашигласан аргууд, үүн дотроо тухайн арга яагаад тохиромжтой талаархи тайлбар.
- (б) 12(в), ~~эвэж~~ 13(а) эсвэл УСНББОУС 41-ийн 13A(а) буюу 108(а) параграфуудад заасан шаардлагуудыг даган мөрдөхийн тулд санхүүгийн байдлын тайланд эсвэл тодруулгад түүний хийсэн тодруулгууд нь санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтөнд хамааруулж болох тэдгээрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг үнэн зөв толилуулаагүй гэж уг байгууллага нь үзэж байвал ийм дүгнэлтэнд хүрэх болсон шалтгаан ба хамааралтай гэж түүний найдаж буй хүчин зүйлс.
- (в) Өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтийн үр нөлөөг цэвэр хөрөнгө/өмчид толилуулах нь ашиг, алдагдалд нягтлан бодох бүртгэлийн уялдаагүй байдал үүсгэх буюу түүнийг нэмэгдүүлэх эсэхийг тодорхойлохын тулд ашигласан арга зүй буюу арга зүйнүүдийн дэлгэрэнгүй тайлбар тодорхойлолт (УСНББОУС 41-ийн 108 ба 109-р параграфыг үзнэ үү). Хэрэв байгууллага нь өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтийн үр нөлөөг ашиг, алдагдалд толилуулах шаардлагатай бол (УСНББОУС 41-ийн 109-р параграфыг үзнэ үү) тодруулга нь УСНББОУС 41-ийн МЗУ229-р параграфт дурдсан, эдийн засгийн харилцаа хамаарлын талаархи дэлгэрэнгүй тайлбар тодорхойлолтыг агуулсан байх ёстой.

Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт

14А. УСНББОУС 41-ийн 106-р параграфтаар зөвшөөрсөнчлөн, байгууллага нь өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтыг цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан бол уг байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:

- (а) Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан, өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт.
- (б) Ингэж толилуулах хувилбарыг ашигласан шалтгаан.
- (в) Тухайн тайлант үеийн эцэс дэх ийм хөрөнгө оруулалт тус бүрийн бодит үнэ цэнэ.
- (г) Тухайн тайлант үед хүлээн зөвшөөрсөн ногдол ашиг, үүнд: тайлант үеийн туршид үл хүлээн зөвшөөрсөн хөрөнгө оруулалттай холбоотой ногдол ашиг ба тайлант үеийн эцэст эзэмшиж буй хөрөнгө оруулалттай холбоотой ногдол ашгийг тус тусад нь харуулна.
- (д) Хуримтлагдсан олз, гарзыг тухайн тайлант үеийн туршид цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгийн хооронд шилжүүлэх аливаа шилжүүлэлт, үүн дотроо ийм шилжүүлэлтийн учир шалтгаан.

14Б. Хэрэв байгууллага нь тухайн тайлант үеийн туршид цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн, өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтыг үл хүлээн зөвшөөрсөн бол уг байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:

- (а) Тухайн хөрөнгө оруулалтыг данснаас хассан шалтгаан.
- (б) Үл хүлээн зөвшөөрсөн өдрөөрх уг хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ.
- (в) Данснаас хасалтын хуримтлагдсан олз буюу гарз.

Дахин ангилал

15. Хэрэв байгууллага нь дараах аль нэг байдлаар хэмжсэнээр санхүүгийн хөрөнгийг (УСНББОУС 29-ийн 60-63-р параграфын дагуу) дахин ангилсан бол тухайн байгууллага нь ангилал тус бүрийн хувьд түүнд оруулсан ба түүнээс гарган дахин ангилсан дүн, түүнчлэн тийм дахин ангиллын учир шалтгааныг тодруулна:

- (а) Бодит үнэ цэнээр биш, харин өртөг буюу хөрөгдуулсан өртгөөр хэмжсэн; эсвэл
- (б) Өртөг буюу хөрөгдуулсан өртгөөр биш, харин бодит үнэ цэнээр хэмжсэн;

15А. Хэрэв байгууллага нь тухайн тайлант үед болон өмнөх тайлант үеүдэд аливаа санхүүгийн хөрөнгийг УСНББОУС 41-ийн 54-р параграфын дагуу дахин ангилсан бол энэ тухай тодруулга хийнэ. Ингэж дахин ангилсан үйл явдал тус бүрийн хувьд байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:

- (а) Дахин ангилал хийсэн өдөр.
- (б) Удирдлагын загварын өөрчлөлтийн талаархи дэлгэрэнгүй тайлбар ба байгууллагын санхүүгийн тайланд түүний үзүүлэх үр нөлөөний тухай чанарын шинжтэй тайлбар тодорхойлолт.
- (в) Ангилал тус бүрийн хувьд түүнд оруулсан ба түүнээс гарган дахин ангилсан дүн.

15Б. Хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх хүртэлх хугацаанд түүний дахин ангиллын өдрийн дараах тайлант үе тус бүрд байгууллага нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангиллаас гаргаж, ингэснээр УСНББОУС 41-ийн 54-р параграфын дагуу хөрөгдуулсан өртгөөр эсвэл цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих хөрөнгийн хувьд дараах зүйлсийг тодруулна:

- (а) Тухайн дахин ангиллын өдрөөр тодорхойлсон үр ашигт хүүний хувь;

- (б) Хүлээн зөвшөөрсөн хүүний орлого.
- 15В. Хэрэв байгууллага нь сүүлийн тайлант жилийн эцсээс хойш санхүүгийн хөрөнгийг цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангиллаас гаргаж, ингэснээр хорогдуулсан өртгөөр хэмжсэн эсвэл ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангиллаас гаргаж, ингэснээр хорогдуулсан өртгөөр эсвэл цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн бол уг байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:
- (а) Тайлант үеийн эцэс дэх уг санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ;
- (б) Хэрэв уг санхүүгийн хөрөнгийг дахин ангилаагүй бол тухайн тайлант үеийн туршид ашиг, алдагдалд эсвэл цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрөх байсан бодит үнэ цэнийн олз, гарз.
16. Хэрэв байгууллага нь УСНББОУС 29-ийн 55-бүлэг 57-р параграфын дагуу санхүүгийн хөрөнгийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэсэн ангиллаас хасаж, дахин ангилсан, эсвэл УСНББОУС 29-ийн 58-р параграфын дагуу борлуулах боломжтой гэсэн ангиллаас хасаж, дахин ангилсан бол тухайн байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:
- (а) Ангилаж тус бүрийн хувьд түүнд оруулсан ба түүнээс гарган дахин ангилсан дүн;
- (б) Үл хүлээн зөвшөөрөх хүртэлх тайлант үе тус бүрийн хувьд, одоогийн болон өмнөх тайлант үеүдэд дахин ангилсан бүх санхүүгийн хөрөнгүүдийн дансны үнэ ба бодит үнэ цэнэ;
- (в) Санхүүгийн хөрөнгийг УСНББОУС 29-ийн 55-р параграфын дагуу дахин ангилсан бол ийм цөөн хөвөр тохиолдол, түүнчлэн уг тохиолдол цөөн хөвөр гэдгийг илэрхийлэх баримт материал болон нөхцөл байдлууд;
- (г) Санхүүгийн хөрөнгийг дахин ангилсан тайлант үеийн хувьд тэрхүү тайлант үед болон өмнөх тайлант үед ашиг, алдагдалд эсвэл цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн уг санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн олз буюу гарз;
- (д) Санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх хүртэлх түүний дахин ангиллын дараах тайлант үе тус бүрийн (үүн дотроо, санхүүгийн хөрөнгийг дахин ангилсан тайлант үеийн) хувьд, хэрэв уг санхүүгийн хөрөнгийг дахин ангилаагүй бол ашиг, алдагдалд эсвэл цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрөх байсан бодит үнэ цэнийн олз буюу гарз, түүнчлэн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн олз, гарз, орлого, зардал;
- (е) Санхүүгийн хөрөнгийн дахин ангиллын өдрөөр уг байгууллагын нөхөхөөр хүлээж буй мөнгөн гүйлгээний тооцоолсон дүн ба үр ашигт хүүний түвшин.

Үл хүлээн зөвшөөрөлт

17. Санхүүгийн хөрөнгийн бүх бүлэг зарим хэсэг нь үл хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангах тийм шилжүүлэлтээр тухайн байгууллага нь санхүүгийн хөрөнгийг шилжүүлж болох юм (УСНББОУС 29-ийн 17-39-р параграфыг үзнэ үү). Байгууллага нь ийм санхүүгийн хөрөнгийн анги тус бүрийн хувьд дараах зүйлсийг тодруулна:
- (а) Хөрөнгийн шинж төрөл;
- (б) Байгууллага нь ортеон хэвээр байх өмчлөлийн эрэдэл ба урамшууллын шинж төрөл;
- (в) Байгууллага нь бүх хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн хэвээр байх тохиолдолд тэдгээр хөрөнгүүд болон хөлбөгдөх өр төлбөрүүдийн дансны үнэ;
- (г) Байгууллага нь хөрөнгийг өөрийн цаашдын оролцооны хэмжээгээр хүлээн зөвшөөрсөн хэвээр байх тохиолдолд уг анхны хөрөнгүүдийн нийт дансны үнэ, тухайн байгууллага хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа хөрөнгүүдийн дүн болон хөлбөгдөх өр төлбөрүүдийн дансны үнэ.

Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийг харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах

- 17А. 17Б-17Д параграфт дурдсан тодруулгууд нь энэ Стандартын тодруулгын бусад шаардлагуудын нэмэлт гүйцээлт болох бөгөөд УСНББОУС 28-ын 47-р параграфын дагуу харилцан суутгаж, цэвэр дүнг гаргадаг, хүлээн зөвшөөрсөн бүх санхүүгийн хэрэглүүрийн хувьд эдгээр тодруулгыг хийх шаардлагатай. Хууль ёсоор хүчин төгөлдөр болох “цэвэр дүнгээр тооцох мастер хэлцэл” буюу түүнтэй ижил төсөөтэй хэлцлийн зүйл болох, хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хэрэглүүрүүдийг УСНББОУС 28-ын 47-р параграфын дагуу харилцан суутгаж, цэвэр дүнг гаргадаг эсэхээс үл хамааран тэдгээр санхүүгийн хэрэглүүрийн хувьд энэхүү тодруулгын шаардлагыг бас даган мөрдөнө.
- 17Б. Байгууллага нь түүний санхүүгийн тайланд уг цэвэр дүнгээр тооцох хэлцлийн үзүүлэх нөлөө буюу боломжит үр нөлөөг үнэлэх боломжийг өөрийн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгохын тулд мэдээллийг тодруулна. Энэхүү мэдээлэл нь 17А параграфын цар хүрээнд хамаарах тухайн байгууллагын хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгө ба хүлээн зөвшөөрсөн санхүүгийн өр төлбөртэй холбоотой харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах эрхийн нөлөө буюу боломжит үр нөлөөг агуулсан байна.
- 17В. 17Б параграфт дурдсан зорилгыг хангахын тулд байгууллага нь 17А параграфын цар хүрээнд хамаарах, хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгө ба хүлээн зөвшөөрсөн санхүүгийн өр төлбөрийн хувьд дараах тоон мэдээллийг тухайн тайлант үеийн эцэст тус тусад нь тодруулна:
- (а) Тэдгээр хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгө ба хүлээн зөвшөөрсөн санхүүгийн өр төлбөрийн нийт дүн;
 - (б) Санхүүгийн байдлын тайланд толилуулах цэвэр дүнг тодорхойлох үедээ УСНББОУС 28-ын 47-р параграфт заасан шалгуурын дагуу харилцан суутгах дүнгүүд;
 - (в) Санхүүгийн байдлын тайланд толилуулсан цэвэр дүн;
 - (г) Хууль ёсоор хүчин төгөлдөр болох “цэвэр дүнгээр тооцох мастер хэлцэл” буюу түүнтэй ижил төсөөтэй хэлцлийн зүйл болох, иймээс 17В(б) параграфт заасан тодруулгад хамаарахгүй дүнгүүд, үүнд:
 - (i) УСНББОУС 28-ын 47-р параграфт заасан, харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах бүх буюу зарим шалгуурыг хангахгүй, хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хэрэглүүртэй холбоотой дүнгүүд;
 - (ii) Санхүүгийн барьцаатай холбоотой дүнгүүд (үүн дотроо, мөнгөн барьцаа).
 - (д) Дээрх (в)-д дурдсан дүнгээс (г)-д дурдсан дүнг хассаны дараах цэвэр дүн.
- Өөр загвар илүү тохиромжтой байхаас бусад тохиолдолд энэ параграфтаар шаардсан мэдээллийг санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн хувьд тус тусад нь хүснэгт хэлбэрээр толилуулна.
- 17Г. Хэрэглүүрийн хувьд 17В(г) параграфын дагуу тодруулах нийт дүн нь уг хэрэглүүрийн хувьд 17В(в) параграфын дурдсан дүнгээр хязгаарлагдана.
- 17Д. Байгууллага нь хууль ёсоор хүчин төгөлдөр болох “цэвэр дүнгээр тооцох мастер хэлцэл” болон түүнтэй ижил төсөөтэй хэлцлийн зүйл болох ба 17В(г) параграфын дагуу тодруулсан, өөрийн хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгө ба хүлээн зөвшөөрсөн санхүүгийн өр төлбөртэй холбоотой харилцан суутгах эрхийн тодруулгад тайлбар тодорхойлолтыг, үүн дотроо тэдгээр эрхийн шинж төрлийн талаархи тайлбар тодорхойлолтыг оруулна.
- 17Е. 17Б-17Д параграфтаар шаардсан мэдээллийг тухайн санхүүгийн тайланд нэгээс олон тодруулгад харуулсан бол байгууллага нь тэдгээр тодруулгын хооронд харилцан лавлагаа үүсгэнэ.

Барьцаа

18. Байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

- (a) Өр төлбөр буюу болзошгүй өр төлбөрийн баталгаа болгон барьцаалсан санхүүгийн хөрөнгийн дансны үнэ, үүн дотроо УСНББОУС 41-ийн 34(a) УСНББОУС 29-ийн 39(a) параграфын дагуу дахин ангилсан дүн; ба
- (б) Түүний барьцаатай холбоотой нөхцөл, болзол.

...

Зээлийн гарзын хасагдуулгын данс

20. ~~Зээлийн гарзын улмаас санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан бөгөөд байгууллага нь хөрөнгийн дансны үнийг шууд бууруулахын өрөнд үнэн цэнийн бууралтыг тусдаа дансанд бүртгэдэг (жишээлбэл; тус тусын үнэ цэнийн бууралтыг бүртгэж ийн тулд хасагдуулгын данс ашигладаг эсвэл хөрөнгүүдийн нийт үнэ цэнийн бууралтыг бүртгэж ийн тулд үүнтэй адилтгах дансыг ашигладаг) тохиолдолд уг байгууллага нь санхүүгийн хөрөнгийн анги тус бүрийн хувьд тухайн тайлант үеийн туршид тэрхүү дансанд өрсөн оорчлолтийн тохируулгыг тодруулна.~~

20A УСНББОУС 41-ийн 41-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн, санхүүгийн хөрөнгийн дансны үнийг түүний гарзын хасагдуулгаар бууруулахгүй бөгөөд байгууллага нь тухайн санхүүгийн хөрөнгийн дансны үнийн бууралт байдлаар уг гарзын хасагдуулгыг санхүүгийн байдлын тайланд тусад нь толилуулахгүй. Харин байгууллага нь гарзын хасагдуулгыг санхүүгийн байдлын тайлангийн тодруулга хэсэгт тодруулна.

...

Санхүүгийн үр дүнгийн тайлан

Орлого, зардал, олз, гарзын зүйлс

24. Байгууллага нь орлого, зардал, олз, гарзын дараах зүйлсийг санхүүгийн үр дүнгийн тайланд эсвэл тодруулгад тусгана:

- (a) Доорх зүйлсийн цэвэр олз эсвэл цэвэр гарз:
 - (i) Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн; үүн дотроо анх хүлээн зөвшөөрөх үед ингэж ангилсан буюу дараагийн тайлант үед УСНББОУС 41-ийн 152-р параграфын дагуу хэмжсэн санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийн болон УСНББОУС 41-ийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр заавал хэмждэг санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийн (жишээлбэл; УСНББОУС 41-д заасан худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэдэг тодорхойлолтыг хангах санхүүгийн өр төлбөрийн) гэдгийг тус тусад нь харуулах. Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан УСНББОУС 29-ийн дагуу худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэж ангилсан санхүүгийн өр төлбөрийн хувьд байгууллага нь цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн олз, гарзын дүн ба ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн олз, гарзын дүнг тус тусад нь харуулна;
 - (ii) Бөрлуулах боломжтой санхүүгийн хөрөнгийн хувьд тухайн тайлант үеийн туршид цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн олз, гарзын дүн ба цэвэр хөрөнгө/өмчөөс дахин ангилж, тайлант үеийн ашиг, алдагдалд шууд хүлээн зөвшөөрсөн дүнг тус тусад нь харуулах;
 - (iii) Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт;
 - (iv) Зээл ба авлага; ба
 - (v) Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн өр төлбөр;
 - (vi) Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө;

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

- (vii) УСНББОУС 41-ийн 106-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан, өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт; ба
- (viii) УСНББОУС 41-ийн 41-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө, үүн дотроо тухайн тайлант үеийн туршид цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн олз, гарзын дүн ба цэвэр хөрөнгө/өмчөөс гаргаж, тайлант үеийн ашиг, алдагдалд дахин ангилсан дүнг тус тусад нь харуулах;
- (б) Хорогдуулсан өртгөөр хэмждэг эсвэл УСНББОУС 41-ийн 41-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг (эдгээр дүнгүүдийг тус тусад нь харуулах) Ашиг, алдагдлаар дамжуулан бодит цэнээр хэмжээгүй санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн, эсвэл ашиг, алдагдлаар дамжуулан бодит цэнээр хэмждэггүй санхүүгийн өр төлбөрийн нийт хүүний орлого ба нийт хүүний зардал (үр ашигт хүүний арга ашиглан тооцоолсон);
- (в) Дараах зүйлсээс үүссэн хураамжийн орлого ба зардал (үр ашигт хүүний түвшинг тодорхойлоход оруулж тооцсон дүнгээс бусад):
- (i) Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжээгүй санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр;
- (ii) Хувь хүмүүс, итгэлцлийн сан, тэтгэвэрт гарах үеийн тэтгэмжийн хөтөлбөр болон бусад байгууллагын нэрийн өмнөөс хөрөнгийг эзэмших буюу хөрөнгө оруулалт хийх үр дүн бүхий итгэлцлийн сангийн болон бусад итгэмжлэгдсэн үйл ажиллагаа.
- ~~(г) Үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгийн хувьд УСНББОУС 29-ийн МЗУ126-р параграфын дагуу хуримтлуулсан хүүний орлого; ба~~
- ~~(д) Санхүүгийн хөрөнгийн анги тус бүрд хамаарах үнэ цэнийн бууралтын аливаа гарзын дүн.~~

24А. Байгууллага нь хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн бөгөөд санхүүгийн үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрсөн олз, гарзын задаргаа шинжилгээг тэдгээр санхүүгийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн олз эсвэл гарз гэдгээр тусад нь салгаж харуулна. Энэхүү тодруулга нь тэдгээр санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрсөн шалтгааныг тусгасан байна.

...

Хейжийн нягтлан бодох бүртгэл

25А. Байгууллага нь хейж хийдэг бөгөөд хейжийн нягтлан бодох бүртгэлийг мөрдөх сонголт хийсэн тэдгээр эрсдлийн хувьд 25Б-28Е параграфт заасан тодруулгын шаардлагуудыг дагаж мөрднө. Хейжийн нягтлан бодох бүртгэлийн тодруулга нь дараах зүйлсийн талаархи мэдээллээр хангадаг:

- (а) Байгууллагын эрсдлийн удирдлагын стратеги ба эрсдлийг удирдан зохицуулахын тулд түүнийг хэрхэн ашигладаг эсэх;
- (б) Байгууллагын хейжийн үйл ажиллагаа нь түүний ирээдүйн мөнгөн гүйлгээний дүн, хугацаа, тодорхойгүй байдалд хэрхэн нөлөөлж болох эсэх;
- (в) Хейжийн нягтлан бодох бүртгэл нь тухайн байгууллагын санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд үзүүлэх үр нөлөө.

25Б. Байгууллага нь уг шаардлагатай тодруулгыг өөрийн санхүүгийн тайлан дахь нэг тодруулгад эсвэл тусдаа хэсэгт толилуулна. Гэвч санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд тэрхүү санхүүгийн тайлантай адил нөхцлөөр, ижил хугацаанд хүргэн танилцуулах боломжтой удирдлагын тайлбар буюу эрсдлийн тайлан гэх мэт өөр бусад тайланд тухайн санхүүгийн тайлангаас харилцан лавлагаа үүсгэснээр уг мэдээллийг тусгасан бол өөр хаа нэгтээ аль хэдийн толилуулсан

мэдээллийг байгууллага нь дахин тодруулах шаардлагагүй юм. Харилцан лавлагаа үүсгэснээр уг мэдээллийг тусгаагүй бол тухайн санхүүгийн тайлан нь иж бүрэн бус болно.

- 25B 26А–28Е параграф нь уг тодруулсан мэдээллийг эрсдлийн ангиллаар тусдаа харуулахыг байгууллагаас шаарддаг тохиолдолд тухайн байгууллага нь түүний хувьд хейж хийх ба хейжийн нягтлан бодох бүртгэлийг мөрдөхөөр шийдвэрлэсэн тэрхүү эрсдэлд үндэслэн, эрсдлийн ангилал нэг бүрийг тодорхойлно. Байгууллага нь хейжийн нягтлан бодох бүртгэлийн бүх тодруулгын хувьд эрсдлийн ангиллыг түүшгэй баримтална.
- 25Г 25А параграфт дурдсан зорилгыг хангахын тулд (доор өөрөөр зааснаас бусад тохиолдолд) байгууллага нь тодруулгыг хэр дэлгэрэнгүй хийх, тодруулгын шаардлагуудын янз бүрийн төлөв байдалд хэр их ач холбогдол өгөх, дүнг нэгтгэх эсвэл тусдаа салган харуулах тохиромжтой түвшин ямар байх, уг тодруулсан тоон мэдээллийг үнэлэхэд санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд нэмэлт тайлбар шаардлагатай эсэхийг тодорхойлно. Гэхдээ байгууллага нь энэ Стандартад заасан холбогдох мэдээллийн тодруулгын шаардлагуудын хувьд дүнг нэгтгэх эсвэл тусдаа салган харуулахдаа ашигласан түвшинтэй ижил түвшинг ашиглана.
26. Байгууллага нь УСНББОУС 29 д дурдсан хейжийн төрөл тус бүрийн (өөрөөр хэлбэл, бодит үнэ нэнийн хейж, мөнгөн гүйлгээний хейж, гадаад үйл ажиллагаанд оруулсан нэвэр хөрөнгө оруулалтын хейж) хувьд дараах зүйлсийг тус тусад нь тодруулна:
- (а) — Хейжийн төрөл тус бүрийн тайлбар тодорхойлолт;
 - (б) — Хейжийн хэрэглүүр гэж сонгосон санхүүгийн хэрэглүүрийн тайлбар тодорхойлолт ба тухайн тайлант үеийн эцэс дэх тэдгээрийн бодит үнэ цэнэ; ба
 - (в) — Хейж хийж буй эрсдлийн шинж төрөл;

Эрсдлийн удирдлагын стратеги

- 26А. Байгууллага нь түүний хувьд хейж хийх ба хейжийн нягтлан бодох бүртгэлийг мөрдөхөөр шийдвэрлэсэн тэрхүү эрсдлийн ангилал тус бүрийн хувьд өөрийн эрсдлийн удирдлагын стратегийг тайлбарлана. Энэхүү тайлбар нь (жишээлбэл) дараах зүйлсийг үнэлэх боломжийг санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгодог:
- (а) Эрсдэл нэг бүр хэрхэн үүссэн.
 - (б) Байгууллага нь эрсдэл нэг бүрийг хэрхэн удирдан зохицуулж байгаа. Үүнд: байгууллага нь бүх эрсдлийн хувьд тухайн зүйлд бүхэлд нь хейж хийдэг эсвэл уг зүйлийн эрсдлийн бүрэлдэхүүн хэсэгт (эсвэл бүрэлдэхүүн хэсгүүдэд) хейж хийдэг эсэх ба түүний шалтгаан.
 - (в) Байгууллагын удирдан зохицуулж байгаа эрсдлийн хэмжээ.
- 26Б. 26А параграфт дурдсан шаардлагудыг хангахын тулд тухайн мэдээлэл нь дараах зүйлсийн талаархи (гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй) тайлбар тодорхойлолтыг агуулсан байна:
- (а) Учрах эрсдэлд хейж хийхийн тулд ашиглах хейжийн хэрэглүүр (ба түүнийг хэрхэн ашиглаж байгаа);
 - (б) Хейжийн үр дүнтэй байдлыг үнэлэх зорилгоор бйгууллага нь хейжийн зүйл ба хейжийн хэрэглүүрийн хоорондох эдийн засгийн харилцан хамаарлыг хэрхэн тодорхойлдог; ба
 - (в) Байгууллага нь хейжийн харьцааг, түүнчлэн хейжийн үр дүнгүй байдлын эх сурвалжийг хэрхэн тодорхойлдог.
- 26В. Байгууллага нь эрсдлийн тусгай нэг бүрэлдэхүүн хэсгийг хейжийн зүйл гэж сонгосон (УСНББОУС 41-ийн 128-р параграфыг үзнэ үү) бол уг байгууллага нь 26А ба 26Б параграфтаар шаардсан тодруулгаас гадна дараах зүйлсийн талаархи тоон эсвэл чанарын шинжтэй мэдээллээр хангана:

- (а) Байгууллага нь хейжийн зүйл гэж сонгосон уг эрсдлийн бүрэлдэхүүн хэсгийг хэрхэн тодорхойлсон (үүнд: эрсдлийн бүрэлдэхүүн хэсэг ба тухайн нийт зүйлийн хоорондох харилцааны шинж төрлийн талаархи тайлбар тодорхойлолт);
- (б) Эрсдлийн бүрэлдэхүүн хэсэг нь тухайн нийт зүйлтэй ямар холбоотой байгаа эсэх (жишээлбэл: түүхэн туршлагаас харахад, уг сонгосон эрсдлийн бүрэлдэхүүн хэсэг нь тухайн нийт зүйлийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн дундажаар 80 хувийг хамардаг байх).

Ирээдүйн мөнгөн гүйлгээний дүн, хугацаа ба тодорхойгүй байдал

27 Мөнгөн гүйлгээний хейжийн хувьд байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:

- (а) Мөнгөн гүйлгээнүүд гарч тохиолдохоор хүлээгдэж буй тайлант үеүд болон ашиг, алдагдалд тэдгээрийн нөлөө үзүүлэхээр хүлээгдэж буй тайлант үеүд;
- (б) Өмнө нь хейжийн нягтлан бодох бүртгэлийг ашиглаж байсан боловч цаашид гарч тохиолдохоор хүлээгдэхээргүй болсон аливаа урьдчилан таамагласан ажил гүйлгээний тайлбар тодорхойлолт;
- (в) Тухайн тайлант үеийн туршид цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн дүн;
- (г) Цэвэр хөрөнгө/өмчөөс гаргаж дахин ангилсан ба тухайн тайлант үеийн ашиг, алдагдалд тусган оруулсан дүн, үүнд санхүүгийн үр дүнгийн тайлангийн мөрийн зүйл нэг бүрд тусган оруулсан дүнг харуулна; ба
- (д) Олж эзэмшилт буюу гарч тохиолдолт нь хейж хийсэн өндөр магадлалтай урьдчилан таамагласан ажил гүйлгээ байх тийм санхүүгийн бус хөрөнгө буюу санхүүгийн бус өр төлбөрийн анхны өртөг болон бусад дансны үнэд тусган оруулж, тухайн тайлант үеийн туршид цэвэр хөрөнгө/өмчөөс хаасан дүн.

27А. 27В параграфтаар чөлөөлснөөс бусад тохиолдолд, байгууллага нь хейжийн хэрэглүүрийн нөхцөл ба болзол, түүнчлэн тухайн байгууллагын ирээдүйн мөнгөн гүйлгээний дүн, хугацаа, тодорхойгүй байдалд тэдгээр нь хэрхэн нөлөөлдөгийг үнэлэх боломжийг өөрийн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгохын тулд тоо мэдээллийг эрсдлийн ангиллаар ялгаж тодруулна.

27Б. 27А параграфт заасан шаардлагыг ханган биелүүлэхийн тулд байгууллага нь дараах зүйлсийг тодруулсан дэлгэрэнгүй задаргааг бэлтгэнэ:

- (а) Хейжийн хэрэглүүрийн нэрлэсэн дүнгийн хугацааны бүтэц хуваарь;
- (б) Хэрэв хамааралтай бол уг хейжийн хэрэглүүрийн дундаж үнэ буюу хувь хэмжээ (жишээлбэл: хэрэгжих үнэ буюу форвард үнэ гэх мэт).

27В. Хейжийн хэрэглүүр ба хейжийн зүйлийн аль аль нь байнга өөрчлөгддөг (өөрөөр хэлбэл, УСНББОУС 41-ийн МЗУ317(б) параграфт дурдсан жишээний нөхцөлтэй адилаар, тухайн эрсдэл ба түүнийг удирдахын тулд ашиглаж буй хейжийн хэрэглүүрийн аль аль нь удаан хугацаанд тэр хэвээр байдаггүй, байнга хувьсан өөрчлөгддөг үйл явцыг уг байгууллага ашигладаг) учраас байгууллага нь хейжийн харилцаагаа байнга дахин тогтоодог (өөрөөр хэлбэл, хейжийн харилцааг зогсоох ба дахин эхлүүлдэг) тохиолдолд тухайн байгууллага нь:

(а) 27А ба 27Б параграфтаар шаардсан тодруулгыг бэлтгэхээс чөлөөлөгдөнө.

(б) Доорх зүйлсийг тодруулна:

- (i) Тэдгээр хейжийн харилцаатай холбоотой эцсийн эрсдлийн удирдлагын стратегийн талаархи мэдээлэл;
- (ii) Байгууллага нь хейжийн нягтлан бодох бүртгэлийг ашиглах ба тэдгээр хейжийн харилцааг сонгосноор өөрийн эрсдлийн удирдлагын стратегийг хэрхэн тусгадаг талаархи тайлбар тодорхойлолт;

(iii) Тэдгээр хейжийн харилцаатай холбоотой уг байгууллагын үйл явцын нэг хэсэг байдлаар хейжийн харилцааг хэр тогтмол хугацаанд зогсоож, мөн дахин эхлүүлдэг талаархи үзүүлэлт.

27Г. Хейжийн харилцааны хугацаанд түүнд нөлөөлөхөөр хүлээгдэж буй уг хейжийн үр дүнгүй байдлын эх сурвалжийн талаархи тайлбар тодорхойлолтыг байгууллага нь эрсдлийн ангиллаар ялгаж тодруулна.

27Д. Хэрэв хейжийн үр дүнгүй байдлын бусад эх сурвалж нь хейжийн харилцаанд үүссэн бол байгууллага нь тэдгээр эх сурвалжийг эрсдлийн ангиллаар ялган тодруулах ба түүний үр дүн болох уг хейжийн үр дүнгүй байдлыг тайлбарлана.

27Е. Мөнгөн гүйлгээний хейжийн хувьд, байгууллага нь урьдчилан таамагласан ажил гүйлгээнд зориулан өмнөх тайлант үед хейжийн нягтлан бодох бүртгэлийг ашиглаж байсан боловч цаашид гарч тохиолдохооргүй болсон аливаа урьдчилан таамагласан ажил гүйлгээний талаархи тайлбар тодорхойлолтыг бэлтгэж тодруулна.

Санхүүгийн байдал ба санхүүгийн үр дүнд хейжийн нягтлан бодох бүртгэлийн үзүүлэх үр нөлөө

28. Байгууллага нь дараах зүйлсийг тус тусад нь тодруулна:

(а) Бодит үнэ цэнийн хейжийн хувьд доорх зүйлсийн ояз буюу гарз:

(i) Хейжийн хэрэглүүрийн; ба

(ii) Уг хейж хийсэн эрдэлд хамааруулж болох хейжийн зүйлийн.

(б) Мөнгөн гүйлгээний хейжээ үүссэн ба ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн үр дүнгүй байдал; ба

(в) Гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын хейжээ үүссэн ба ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн үр дүнгүй байдал.

28А. Байгууллага нь хейжийн хэрэглүүр гэж сонгосон зүйлстэй холбоотой дараах дүнгүүдийг хейжийн төрөл тус бүрээр (бодит үнэ цэнийн хейж, мөнгөн гүйлгээний хейж, гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын хейж) эрсдлийн ангиллаар тус тусад нь ялгаж, хүснэгтэн хэлбэрээр тодруулна:

(а) Хейжийн хэрэглүүрийн дансны үнэ (санхүүгийн хөрөнгийг санхүүгийн өр төлбөрөөс тусад нь);

(б) Санхүүгийн байдлын тайлан дахь уг хейжийн хэрэглүүрийг багтаасан мөрийн зүйл;

(в) Тухайн тайлант үед хейжийн үр дүнгүй байдлыг хүлээн зөвшөөрөх суурь болгон ашигласан уг хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт;

(г) Хейжийн хэрэглүүрийн нэрлэсэн дүн (үүн дотроо, тонн, куб метр гэх мэт тоон хэмжүүр).

28Б. Байгууллага нь хейжийн зүйлтэй холбоотой дараах дүнгүүдийг хейжийн төрлийн хувьд эрсдлийн ангиллаар тус тусад нь ялгаж, хүснэгтэн хэлбэрээр тодруулна:

(а) Бодит үнэ цэнийн хейжийн хувьд:

(i) Санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрсөн хейжийн зүйлийн дансны үнэ (хөрөнгийг өр төлбөрөөс тусад нь толилуулах);

(ii) Санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрсөн хейжийн зүйлийн дансны үндэс багтсан, уг хейжийн зүйлд хийх бодит үнэ цэнийн хейжийн тохируулгын хуримтлагдсан дүн (хөрөнгийг өр төлбөрөөс тусад нь толилуулах);

(iii) Санхүүгийн байдлын тайлан дахь уг хейжийн зүйлийг багтаасан мөрийн зүйл;

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

- (iv) Тухайн тайлант үед хейжийн үр дүнгүй байдлыг хүлээн зөвшөөрөх суурь болгон ашигласан уг хейжийн зүйлийн үнэ цэнийн өөрчлөлт;
- (v) УСНББОУС 41-ийн 139-р параграфын дагуу хейжийн олз, гарзын хувьд тохируулахаа больсон аливаа хейжийн зүйлд хамаарах ба санхүүгийн байдлын тайланд үлдээсэн бодит үнэ цэнийн хейжийн тохируулгын хуримтлагдсан дүн.
- (б) Мөнгөн гүйлгээний хейж ба гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын хейжийн хувьд:

 - (i) Тухайн тайлант үед хейжийн үр дүнгүй байдлыг хүлээн зөвшөөрөх суурь болгон ашигласан уг хейжийн зүйлийн үнэ цэнийн өөрчлөлт (өөрөөр хэлбэл, мөнгөн гүйлгээний хейжийн хувьд, уг хүлээн зөвшөөрсөн хейжийн үр дүнгүй байдлыг УСНББОУС 41-ийн 140(в) параграфын дагуу тодорхойлохын тулд ашигласан үнэ цэнийн өөрчлөлт);
 - (ii) УСНББОУС 41-ийн 140 ба 142(а) параграфын дагуу тайлагнадаг, үргэлжилж буй хейжид хамаарах мөнгөн гүйлгээний хейжийн нөөцийн болон гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцийн үлдэгдлүүд;
 - (iii) Хейжийн нягтлан бодох бүртгэлийг цаашид хэрэглэхгүй болсон аливаа хейжийн харилцаанаас үлдсэн, мөнгөн гүйлгээний хейжийн нөөцийн болон гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцийн үлдэгдлүүд.
- 28В. Байгууллага нь хейжийн төрлийн хувьд дараах дүнгүүдийг эрсдлийн ангиллаар тус тусад нь ялгаж, хүснэгтэн хэлбэрээр доорх байдлаар тодруулна:

 - (а) Бодит үнэ цэнийн хейжийн хувьд:

 - (i) Хейжийн үр дүнгүй байдал-өөрөөр хэлбэл, ашиг, алдагдалд (байгууллага нь УСНББОУС 41-ийн 106-р параграфын дагуу бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь цэвэр хөрөнгө/өмчид толилуулахаар сонголт хийсэн өмчийн хэрэглүүрийн хейжийн хувьд цэвэр хөрөнгө/өмчид) хүлээн зөвшөөрсөн, уг хейжийн хэрэглүүр ба хейжийн зүйлийн тэрхүү хейжийн олз буюу гарзын хоорондох зөрүү;
 - (ii) Уг хүлээн зөвшөөрсөн хейжийн үр дүнгүй байдлыг багтаасан, санхүүгийн үр дүнгийн тайлан дахь мөрийн зүйл.
 - (б) Мөнгөн гүйлгээний хейж ба гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын хейжийн хувьд:

 - (i) Цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн тухайн тайлант үеийн хейжийн олз, гарз;
 - (ii) Ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн хейжийн үр дүнгүй байдал;
 - (iii) Уг хүлээн зөвшөөрсөн хейжийн үр дүнгүй байдлыг багтаасан санхүүгийн үр дүнгийн тайлан дахь мөрийн зүйл;
 - (iv) Мөнгөн гүйлгээний хейжийн нөөцөөс эсвэл гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцөөс дахин ангилах залруулга байдлаар (УСНББОУС 1-ийг үзнэ үү) ашиг, алдагдалд дахин ангилсан дүн (хейжийн нягтлан бодох бүртгэлийг өмнө нь ашиглаж байсан боловч уг хейж хийсэн ирээдүйн мөнгөн гүйлгээ цаашид гарч тохиолдоно гэж хүлээгдэхээргүй болсон дүн ба тухайн хейжийн зүйлээр ашиг, алдагдалд нөлөө үзүүлсэн учраас шилжүүлсэн дүнг өөр хооронд нь ялгаж харуулна);
 - (v) Дахин ангилах залруулгыг (УСНББОУС 1-ийг үзнэ үү) багтаасан, санхүүгийн үр дүнгийн тайлан дахь мөрийн зүйл;
 - (vi) Цэвэр төлөв байдлын хейжийн хувьд, санхүүгийн үр дүнгийн тайланд тусдаа мөрийн зүйл болгон хүлээн зөвшөөрсөн хейжийн олз, гарз (УСНББОУС 41-ийн 149-р параграфыг үзнэ үү).

28Г. 27В параграфт заасан чөлөөлөх нөхцлийг хэрэглэх уг хейжийн харилцааны тоо хэмжээ нь тухайн тайлант үеийн турш дахь хэвийн тоо хэмжээг төлөөлөн илэрхийлэхгүй байх (өөрөөр хэлбэл, тайлант үеийн эцэс дэх тоо хэмжээ нь тухайн тайлант үеийн турш дахь тоо хэмжээг тусгаагүй байх) тохиолдолд байгууллага нь энэ тухай, түүнчлэн уг тоо хэмжээ төлөөлөн илэрхийлэхгүй гэж үзэх болсон шалтгааныг тодруулна.

28Д. Байгууллага нь дараах зүйлсийг гүйцэтгэхийн хамтаар УСНББОУС 1-ийн дагуу цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн тохируулгын тайлан болон цэвэр хөрөнгө/өмчийн задаргаа шинжилгээг бэлтгэнэ:

(а) 28В(б)(i), (б)(iv) параграфт заасан тодруулгатай холбоотой дүнгүүд болон УСНББОУС 41-ийн 140(г)-ийн (i), (г)-ийн (iii)-ийн дагуу тайлагнах дүнгүүдийг хамгийн наад зах нь өөр хооронд нь ялган зааглах;

(б) Байгууллага нь опционы цаг хугацааны үнэ цэнийг УСНББОУС 41-ийн 144-р параграфын дагуу тайлагнадаг тохиолдолд ажил гүйлгээтэй холбоотой хейжийн зүйлсэд хейж хийдэг опционы цаг хугацааны үнэ цэнэд хамаарах дүн ба цаг хугацаатай холбоотой хейжийн зүйлсэд хейж хийдэг опционы цаг хугацааны үнэ цэнэд хамаарах дүнгүүдийг өөр хооронд нь ялган зааглах;

(в) Форвард гэрээний форвард элементэд, түүнчлэн ажил гүйлгээтэй холбоотой хейжийн зүйлсэд хейж хийдэг санхүүгийн хэрэглүүрийн гадаад валютын суурийн тархалтанд хамаарах дүнгүүд ба форвард гэрээний форвард элементэд, түүнчлэн цаг хугацаатай холбоотой хейжийн зүйлсэд хейж хийдэг санхүүгийн хэрэглүүрийн гадаад валютын суурийн тархалтанд хамаарах дүнгүүдийг байгууллага нь УСНББОУС 41-ийн 145-р параграфын дагуу тайлагнадаг бол тэдгээр дүнгүүдийг өөр хооронд нь ялган зааглах.

28Е. Байгууллага нь 28Д параграфтаар шаардсан мэдээллийг эрсдлийн ангиллаар тус тусад нь тодруулна. Эрсдлээр ангилсан ийм задаргааг санхүүгийн тайлангийн тодруулгад харуулж болно.

Зээлийн эрсдлийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилах боломж

28Ж. Санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдлийг удирдан зохицуулахын тулд зээлийн үүсмэл хэрэглүүрийг ашигладаг учраас байгууллага нь санхүүгийн хэрэглүүр буюу түүний хэсгийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан бол уг байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:

(а) УСНББОУС 41-ийн 152-р параграфын дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдлийг удирдан зохицуулахын тулд ашигласан зээлийн үүсмэл хэрэглүүрийн хувьд тухайн тайлант үеийн эхэн ба эцэс дэх нэрлэсэн дүн болон бодит үнэ цэнэ тус бүрийн тохируулгын тайлан;

(б) УСНББОУС 41-ийн 152-р параграфын дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж санхүүгийн хэрэглүүр буюу түүний хэсгийг ангилснаар ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн олз, гарз;

(в) Санхүүгийн хэрэглүүр буюу түүний хэсгийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжихээ зогсоосон тохиолдолд УСНББОУС 41-ийн 155-р параграфын дагуу шинэ дансны үнэ болох, уг санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ ба холбогдох нэрлэсэн буюу үндсэн дүн (УСНББОУС 1-ийн дагуу зэрэгцүүлэгдэх мэдээллийг бэлтгэхээс бусад тохиолдолд байгууллага нь дараагийн тайлант үеүдэд энэхүү тодруулгыг үргэлжлүүлэн хийх шаардлагагүй юм).

...

34. Санхүүгийн хэрэглүүрийн зах зээл нь идэвхитэй биш бол байгууллага нь үнэлгээний арга зүйг ашигласнаар түүний бодит үнэ цэнийг тогтооно (УСНББОУС 41-ийн МЗУ149-МЗУ154-р УСНББОУС 29-ийн МЗУ106-МЗУ112-р параграфыг үзнэ үү). Гэвч УСНББОУС 41-ийн

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

~~МЗУ151-р УСНББОУС 29-ийн МЗУ108-р~~ параграфт дурдсан нөхцөл биелэхээс бусад тохиолдолд анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнийн хамгийн сайн нотолгоо нь тухайн ажил гүйлгээний үнэ (өөрөөр хэлбэл, өгсөн эсвэл хүлээн авсан төлбөрийн бодит үнэ цэнэ) байдаг. Эндээс, анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнэ ба үнэлгээний арга зүйг ашигласнаар тэрхүү өдрөөр тодорхойлсон дүн хоорондоо зөрүүтэй байж болно гэж дүгнэж болно. Хэрэв ийм зөрүү байгаа бол байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн ангиар дараах зүйлсийг тодруулна:

- (a) Хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтоохдоо тухайн зах зээлийн оролцогчдын харгалзан үзэх хүчин зүйлсийн (үүн дотроо, цаг хугацааны) өөрчлөлтийг тусгахын тулд уг зөрүүг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх түүний нягтлан бодох бүртгэлийн бодлого (УСНББОУС 41-ийн МЗУ117(б) ~~УСНББОУС 29-ийн МЗУ109-р~~ параграфыг үзнэ үү); ба
- (б) Тухайн тайлант үеийн эхэн ба эцсийн байдлаар ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх нийт зөрүү, түүнчлэн энэхүү зөрүүний үлдэгдлийн өөрчлөлтийн тохируулга.

35. Дараах тохиолдолд бодит үнэ цэнийг тодруулах шаардлагагүй:

- (a) Дансны үнэ нь жишээлбэл, богино хугацаат худалдааны авлага ба өглөг гэх мэт санхүүгийн хэрэглүүрийн хувьд бодит үнэ цэнийн ул үндэслэлтэй ойролцоо дүн байх; ~~ба эвэж~~
- (б) ~~Идэвхитэй зах зээл дэх зах зээлийн жишиг үнэгүй өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт эсвэл ийм өмчийн хэрэглүүртэй уялдан бөгөөд бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжиж чадахгүйн улмаас УСНББОУС 29-ийн дагуу өртгөөр хэмждэг үүемэл хэрэглүүр; ба~~
- (в) Сонголттой оролцох шинжийг нь найдвартай хэмжиж чадахгүй тийм Сонголттой оролцох шинж бүхий гэрээ.

36. ~~35(б) ба~~ (в) параграфт дурдсан тохиолдлын тохиолдлуудын хувьд, байгууллага нь тэдгээр гэрээгүүдийн санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн дансны үнэ ба бодит үнэ цэнийн хоорондох боломжит зөрүүгийн хэмжээний талаар өөрсдийн шүүн тунгаалтыг хийхэд тухайн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд туслах мэдээллийг, үүн дотроо дараах зүйлсийг тодруулна:

- (a) Бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжиж чадахгүйн улмаас тэдгээр хэрэглүүрүүдийн хувьд бодит үнэ цэнийн мэдээллийг тодруулаагүй тухай;
- (б) Санхүүгийн хэрэглүүрийн тайлбар тодорхойлолт, тэдгээрийн дансны үнэ, яагаад бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжиж чадаагүй талаархи тайлбар;
- (в) Тухайн хэрэглүүрийн зах зээлийн талаархи мэдээлэл;
- (г) Байгууллага нь уг санхүүгийн хэрэглүүрийг данснаас хасах санаа зорилготой байгаа эсэх, хэрхэн данснаас хасах талаархи мэдээлэл; ба
- (д) Бодит үнэ цэнийг өмнө нь найдвартай хэмжиж чадахгүй байсан санхүүгийн хэрэглүүрийг үл хүлээн зөвшөөрсөн бол энэ тухай, түүнчлэн уг үл хүлээн зөвшөөрөх үе дэх тэдгээрийн дансны үнэ, хүлээн зөвшөөрсөн олз буюу гарзын дүн.

Хөнгөлөлттэй зээл

37. Хөнгөлөлттэй зээл гэдэг нь зах зээлийн нөхцлөөс доогуур нөхцөлтэйгээр байгууллагын олгосон зээл юм. Байгууллагын олгодог хөнгөлөлттэй зээлийн жишээнд хөгжиж буй орнуудад олгосон зээл, жижиг аж ахуйд олгосон зээл, их дээд сургуулийн боловсролын шалгуур хангасан оюутнуудад олгосон оюутны зээл, бага орлоготой гэр бүлд олгосон өрхийн зээл хамаардаг. Олгосон ба УСНББОУС 41-ийн 40-р параграфын дагуу хорогдуулсан өртгөөр хэмжсэн, хөнгөлөлттэй зээлийн хувьд байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:

- (a) Тухайн зээлийн эхний ба эцсийн дансны үнэ хоорондох тохируулга, үүнд:

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

- (i) Тухайн тайлант үеийн туршид олгосон шинэ зээлийн нэрлэсэн үнэ;
 - (ii) Анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн бодит үнэ цэнийн залруулга;
 - (iii) Тайлант үеийн туршид буцаан төлсөн зээл;
 - (iv) Хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарз;
 - (v) Цаг хугацаа урсан өнгөрсөний үр дүнд уг дискаунтчилсан дүнд тухайн тайлант үеийн туршид гарсан аливаа нэмэгдэлт;
 - (vi) Бусад өөрчлөлтүүд.
- (б) Тухайн тайлант үеийн эцэс дэх зээлийн нэрлэсэн үнэ цэнэ;
 - (в) Төрөл бүрийн зээлийн зорилго ба хугацаа, үүн дотроо хөнгөлөлтийн шинж төрөл;
 - (г) Үнэлгээний таамаглалууд.

37А. УСНББОУС 41-ийн 41 эсвэл 43-р параграфын дагуу бодит үнэ цэнээр хэмжсэн, хөнгөлөлттэй зээлийн хувьд байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:

- (a) Тухайн зээлийн эхний ба эцсийн дансны үнэ хоорондох тохируулга, үүнд:
 - (i) Тухайн тайлант үеийн туршид олгосон шинэ зээлийн нэрлэсэн үнэ;
 - (ii) Анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн бодит үнэ цэнийн залруулга;
 - (iii) Тайлант үеийн туршид буцаан төлсөн зээл;
 - (iv) Тайлант үеийн туршид хийсэн бодит үнэ цэнийн залруулга (анхны хүлээн зөвшөөрөлтөөс тусдаа); ба
 - (v) Бусад өөрчлөлтүүд.
- (б) Тухайн тайлант үеийн эцэс дэх зээлийн нэрлэсэн үнэ цэнэ;
- (в) Төрөл бүрийн зээлийн зорилго ба хугацаа, үүн дотроо хөнгөлөлтийн шинж төрөл;
- (г) Үнэлгээний таамаглалууд.

...

Санхүүгийн хэрэглүүрээс үүсэх эрсдлийн шинж төрөл ба хэмжээ

...

39А. Тоон тодруулгын хүрээнд чанарын шинжтэй тодруулгыг бэлтгэж тусгах нь холбогдох тодруулгуудыг уялдуулан холбох ба ингэснээр санхүүгийн хэрэглүүрээс үүсэх эрсдлийн шинж төрөл, хэмжээний талаархи ерөнхий дүр зургийг гаргах боломжийг хэрэглэгчдэд олгодог. Чанарын шинжтэй болон тоон тодруулгын харилцан үйлчлэл нь байгууллагын эрсдэл өртөлтийг үнэлэх илүү сайн боломжоор хэрэглэгчдийг хангах тийм арга замаар мэдээллийг тодруулахад хувь нэмрээ оруулдаг.

...

Тоон шинжтэй тодруулга

41. Санхүүгийн хэрэглүүрээс үүсэх эрсдлийн төрөл тус бүрийн хувьд байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:
- (a) Тухайн тайлант үеийн эцэст уг эрсдэлд өртөх талаархи хураангуй тоон мэдээ. Энэхүү тодруулга нь тухайн байгууллагын удирдах зөвлөл буюу захирал гэх мэт эрх бүхий албан тушаалтанд (УСНББОУС 20, *Холбоотой Талуудын Тодруулга*-д тодорхойлсон) дотооддоо танилцуулсан мэдээлэлд үндэслэдэг.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

- (б) ~~Эрсдэл нь материаллаг бус байхаас бусад тохиолдолд 43-49-р параграфтаар шаардсан бөгөөд дээрх (а)-гийн дагуу бэлтгэж танилцуулснаас бусад тодруулга (материаллаг байдлын хэлэлцүүлгийг УСНББОУС 1-ийн 45-47-р параграфтаас үзнэ үү).~~
- (в) Дээрх (а) ба (б)-гээс д заасны дагуу хийсэн тодруулгаас хэрэв илт тодорхой биш бол эрсдлийн төвлөрөл.

Зээлийн эрсдэл

Цар хүрээ ба зорилго

42А. УСНББОУС 41-ийн үнэ цэнийн бууралтын шаардлагуудыг мөрдөх санхүүгийн хэрэглүүрүүдийн хувьд байгууллага нь 42Е-42П параграфт заасан тодруулгын шаардлагуудыг дагаж мөрдөнө. Гэхдээ:

- (а) УСНББОУС 9-ийн цар хүрээнд хамаарах арилжааны ажил гүйлгээнээс, УСНББОУС 23-ын цар хүрээнд хамаарах арилжааны бус ажил гүйлгээнээс үүсдэг авлага болон түрээсийн авлагын хувьд, 30 хоногоос илүүгээр хугацаа өнгөрсөн тийм санхүүгийн хөрөнгүүдийг засварлан өөрчилдөг бол нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг нь УСНББОУС 41-ийн 87-р параграфын дагуу хүлээн зөвшөөрдөг, тэдгээр авлага буюу түрээсийн авлагад 42Л(а) параграфыг мөрдөнө;
- (б) Түрээсийн авлагын хувьд 42М(б) параграфыг мөрдөхгүй.

42Б. 42Е-42П параграфын дагуу хийсэн, зээлийн эрсдлийн тодруулга нь ирээдүйн мөнгөн гүйлгээний дүн, хугацаа, тодорхойгүй байдалд уг зээлийн эрсдлийн үзүүлэх үр нөлөөг ойлгох боломжийг санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгодог. Энэхүү зорилгыг биелүүлэхийн тулд зээлийн эрсдлийн тодруулга нь дараах мэдээллээр хангана:

- (а) Байгууллагын зээлийн эрсдлийн удирдлагын практик, түүнчлэн хүлээгдэж буй зээлийн алдагдлын хүлээн зөвшөөрөлт ба хэмжилттэй тэдгээр нь хэрхэн холбогдох талаархи мэдээлэл, үүн дотроо хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжихэд ашигласан арга зүй, таамаглал болон мэдээлэл;
- (б) Хүлээгдэж буй зээлийн алдагдлаас үүссэн бөгөөд санхүүгийн тайланд тусгасан дүнгүүдийг үнэлэх боломжийг тухайн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгох тоон болон чанарын шинжтэй мэдээлэл, үүн дотроо хүлээгдэж буй зээлийн алдагдлын дүнгийн өөрчлөлт ба тэдгээр өөрчлөлтийн шалтгаан;
- (в) Байгууллагын зээлийн эрсдэл өртөлтийн талаархи мэдээлэл (өөрөөр хэлбэл, байгууллагын санхүүгийн хөрөнгөнд угаасаа байдаг зээлийн эрсдэл ба зээлийн хугацааг сунгах баталгаа), үүн дотроо зээлийн эрсдлийн мэдэгдэхүйц төвлөрлүүд.

42В. Санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд тэрхүү санхүүгийн тайлантай адил нөхцлөөр, ижил хугацаанд хүргэн танилцуулах боломжтой удирдлагын тайлбар буюу эрсдлийн тайлан гэх мэт өөр бусад тайланд тухайн санхүүгийн тайлангаас харилцан лавлагаа үүсгэснээр уг мэдээллийг тусгасан бол өөр хаа нэгтээ аль хэдийн толилуулсан мэдээллийг байгууллага нь дахин тодруулах шаардлагагүй юм. Харилцан лавлагаа үүсгэснээр уг мэдээллийг тусгаагүй бол тухайн санхүүгийн тайлан нь иж бүрэн бус болно.

42Г. 42Б параграфт дурдсан зорилгыг хангахын тулд (доор өөрөөр зааснаас бусад тохиолдолд) байгууллага нь тодруулгыг хэр дэлгэрэнгүй хийх, тодруулгын шаардлагуудын янз бүрийн төлөв байдалд хэр их ач холбогдол өгөх, дүнг нэгтгэх эсвэл тусдаа салган харуулах тохиромжтой түвшин ямар байх, уг тодруулсан тоон мэдээллийг үнэлэхэд санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд нэмэлт тайлбар шаардлагатай эсэхийг тодорхойлно.

42Д. 42Е-42П параграфын дагуу хийсэн тодруулга нь 42Б параграфт дурдсан зорилгыг биелүүлэхэд хангалтгүй байвал байгууллага нь тэдгээр зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нэмэлт мэдээллийг тодруулна.

Зээлийн эрсдлийн удирдлагын практик

42Е. Байгууллага нь өөрийн зээлийн эрсдлийн удирдлагын практик, түүнчлэн хүлээгдэж буй зээлийн алдагдлын хүлээн зөвшөөрөлт ба хэмжилттэй тэдгээр нь хэрхэн холбогддог талаар тайлбарлана. Энэхүү зорилгыг хангахын тулд байгууллага нь дараах зүйлсийг ойлгож, үнэлэх боломжийг санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгох мэдээллийг тодруулна:

(a) Санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдэл нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг байгууллага хэрхэн тодорхойлсон, үүнд:

(i) Хэрэв санхүүгийн хэрэглүүрийг, түүнчлэн уг санхүүгийн хэрэглүүрийн хамаарах санхүүгийн хэрэглүүрүүдийн ангийг УСНББОУС 41-ийн 82-р параграфын дагуу зээлийн эрсдэл багатай гэж үзсэн бол, ингэж хэрхэн дүгнэсэн эсэх; ба

(ii) Санхүүгийн хөрөнгийн төлбөр нь 30-аас дээш хоногоор хугацаа хэтэрсэн тохиолдолд анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл нь мэдэгдэхүйц нэмэгдсэн байна гэсэн УСНББОУС 41-ийн 83-р параграфт заасан урьдчилсан нөхцөл хэрэв няцаагдсан бол, ингэж хэрхэн няцаасан эсэх;

(б) Үл биелүүлэлтийн талаархи байгууллагын тодорхойлолт, үүн дотроо уг тодорхойлолтыг сонгох болсон шалтгаан;

(в) Хэрэв хүлээгдэж буй зээлийн алдагдлыг нэгдсэн сууриар хэмждэг бол санхүүгийн хэрэглүүрүүдийг хэрхэн бүлэглэсэн эсэх;

(г) Тухайн санхүүгийн хөрөнгө нь зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгө гэдгийг байгууллага хэрхэн тодорхойлсон эсэх;

(д) Байгууллагын данснаас хасах бодлого, үүнд хөрөнгийн дүн нөхөгдөх үл үндэслэлтэй хүлээлт байхгүй гэдгийг илтгэх үзүүлэлт, түүнчлэн данснаас хасах боловч албадан хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хамаарах санхүүгийн хөрөнгийн хувьд баримтлах бодлогын талаархи мэдээлэл;

(e) Санхүүгийн хөрөнгийн гэрээний мөнгөн гүйлгээг засварлан өөрчлөх талаархи УСНББОУС 41-ийн 84-р параграфт заасан шаардлагуудыг хэрхэн даган мөрддөг. Үүнд: байгууллага нь:

(i) Нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр гарзын хасагдуулгыг хэмжих үед засварлан өөрчилсөн уг санхүүгийн хөрөнгийн зээлийн алдагдал нь УСНББОУС 41-ийн 77-р параграфын дагуу 12-сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр хэмжигдэх уг гарзын хасагдуулгын буцаалтын хэмжээгээр сайжирсан эсэхийг хэрхэн тодорхойлдог эсэх; ба

(ii) Дээрх (i)-д дурдсан шалгуурыг хангах санхүүгийн хөрөнгийн гарзын хасагдуулгыг УСНББОУС 41-ийн 75-р параграфын дагуу нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр дараагийн тайлант үед дахин хэмжих хэмжээг хэрхэн хянан үнэлдэг эсэх.

42Ж. Байгууллага нь УСНББОУС 41-ийн 73-93-р параграфт заасан шаардлагуудыг даган мөрдөхийн тулд ашигласан орц, таамаглал, тооцооллын арга техникээ тайлбарлана. Энэхүү зорилгоор байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:

(a) Доорх зүйлсийн хувьд ашигласан орц, таамаглал, тооцооллын арга техникийн суурь үндэслэл:

(i) 12 сарын хугацаанд болон нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжих;

(ii) Санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдэл нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг тодорхойлох; ба

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

- (iii) Санхүүгийн хөрөнгө нь зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгө эсэхийг тодорхойлох.
- (б) Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тодорхойлохдоо хэтийн мэдээллийг хэрхэн тусгадаг, үүн дотроо макро эдийн засгийн мэдээллийг хэрхэн ашигладаг эсэх;
- (в) Тооцооллын арга техник болон тухайн тайлант үеийн туршид хийсэн гол таамаглалуудын өөрчлөлт ба тэдгээр өөрчлөлтийн шалтгаан.

Хүлээгдэж буй зээлийн алдагдлаас үүсэх дүнгийн талаархи тоон болон чанарын шинжтэй мэдээлэл

42И. Гарзын хасагдуулгын өөрчлөлтүүд ба тэдгээр өөрчлөлтийн шалтгааныг тайлбарлахын тулд байгууллага нь дараах зүйлсийн хувьд тухайн тайлант үеийн туршид гарсан өөрчлөлтүүдийг тус тусад нь харуулсан, уг гарзын хасагдуулгын эхний үлдэгдлээс эцсийн үлдэгдэл хүртэлх тохируулгын тайланг санхүүгийн хөрөнгийн ангиудаар хүснэгтэн хэлбэрээр бэлтгэж толилуулна:

- (a) 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр хэмжсэн гарзын хасагдуулга;
- (б) Доорх зүйлсийн хувьд нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр хэмжсэн гарзын хасагдуулга:
 - (i) Зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгө биш боловч анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл нь мэдэгдэхүйц нэмэгдсэн санхүүгийн хэрэглүүр;
 - (ii) Тухайн тайлант үеийн эцсээр зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгө (гэхдээ худалдан авсан буюу үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай хөрөнгө биш);
 - (iii) Гарзын хасагдуулгыг нь УСНББОУС 41-ийн 87-р параграфын дагуу хэмждэг, УСНББОУС 9-ийн цар хүрээнд хамаарах арилжааны ажил гүйлгээнээс эсвэл УСНББОУС 23-ын цар хүрээнд хамаарах арилжааны бус ажил гүйлгээнээс үүсдэг авлага болон түрээсийн авлага.
- (в) Худалдан авсан буюу үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгө. Тохируулгын тайлангаас гадна байгууллага нь тухайн тайлант үеийн туршид анх хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн дискаунтчлаагүй, хүлээгдэж буй зээлийн алдагдлын нийт дүнг тодруулна.

42К. 42И параграфын дагуу тодруулсан гарзын хасагдуулгын өөрчлөлтийг ойлгох боломжийг санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгохын тулд санхүүгийн хэрэглүүрийн нийт дансны үнэд тухайн тайлант үеийн туршид гарсан мэдэгдэхүйц өөрчлөлт нь уг гарзын хасагдуулгын өөрчлөлтөнд хэрхэн нөлөөлсөн талаархи тайлбарыг байгууллага нь бэлтгэж толилуулна. 42И параграфын (а)-(в)-д жагсаан харуулсан гарзын хасагдуулгыг илэрхийлэх санхүүгийн хэрэглүүрүүдийн хувьд энэхүү мэдээллийг тус тусад нь бэлтгэх бөгөөд үүнд холбогдох тоон болон чанарын шинжтэй мэдээллийг тусгана. Гарзын хасагдуулгын өөрчлөлтөнд нөлөө үзүүлэх тэдгээр санхүүгийн хэрэглүүрүүдийн нийт дансны үнийн өөрчлөлтийн жишээнд дараах зүйлс хамаарч болно:

- (a) Тухайн тайлант үеийн туршид үүсгэн гаргасан буюу олж эзэмшсэн санхүүгийн хэрэглүүрүүдээс хамаарах өөрчлөлт;
- (б) УСНББОУС 41-ийн дагуу санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхөд хүргэхгүй, уг санхүүгийн хөрөнгүүдийн гэрээний мөнгөн гүйлгээний өөрчлөлт;
- (в) Тухайн тайлант үеийн туршид үл хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хэрэглүүрүүдээс (үүн дотроо, данснаас хассан санхүүгийн хэрэглүүрүүдээс) хамаарах өөрчлөлт;
- (г) Гарзын хасагдуулгыг 12 сарын хугацаанд эсвэл нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр хэмжсэн эсэхээс хамаарах өөрчлөлт.

42Л. Санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхөд хүргэхгүй, уг санхүүгийн хөрөнгүүдийн гэрээний мөнгөн гүйлгээний өөрчлөлтийн шинж төрөл ба үр нөлөө, түүнчлэн хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилтэнд ийм өөрчлөлтийн үзүүлэх нөлөөг ойлгох боломжийг санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгохын тулд байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:

- (а) Нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр хэмжсэн гарзын хасагдуулга бүхий санхүүгийн хөрөнгийн гэрээний мөнгөн гүйлгээг тухайн тайлант үеийн туршид өөрчилснөөр уг санхүүгийн хөрөнгийн хувьд хүлээн зөвшөөрсөн өөрчлөлтийн цэвэр олз, гарз ба тэрхүү өөрчлөлтийн өмнөх хорогдуулсан өртөг;
- (б) Гарзын хасагдуулгыг нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр хэмжсэн үед анх хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгийн хувьд уг гарзын хасагдуулгыг 12-сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү болгож, тайлант үеийн туршид өөрчилснөөр анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш засварлан өөрчлөгдсөн тэрхүү санхүүгийн хөрөнгийн тухайн тайлант үеийн эцэс дэх нийт дансны үнэ.

42М. Хүлээгдэж буй зээлийн алдагдлаас үүсэх дүнд барьцаа болон зээлийн бусад сайжруулалтын үзүүлэх үр нөлөөг ойлгох боломжийг санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгохын тулд байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн ангиудаар дараах зүйлсийг тодруулна:

- (а) Эзэмшиж буй аливаа барьцаа буюу зээлийн бусад сайжруулалтуудыг харгалзан үзээгүй тохиолдолд тухайн тайлант үеийн эцэст зээлийн эрсдэлд өртөх хамгийн их дүнг хамгийн сайн төлөөлөн илэрхийлэх дүн (жишээлбэл; харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах УСНББОУС 28-д заасан шалгуурыг хангахгүй цэвэр дүнгээр тооцох хэлцэл).
- (б) Баталгаа болгон эзэмшиж буй барьцаа болон зээлийн бусад сайжруулалтын талаархи хүүрнэсэн тайлбар тодорхойлолт, үүнд:
 - (i) Эзэмшиж буй барьцааны шинж төрөл ба чанарын талаархи тайлбар тодорхойлолт;
 - (ii) Тайлант үеийн туршид барьцаа хөрөнгийн чанарт гарсан доройтол эсвэл барьцаа хөрөнгийн талаархи тухайн байгууллагын бодлогын өөрчлөлтийн үр дүнд уг барьцаа буюу зээлийн сайжруулалтын чанарт орсон аливаа мэдэгдэхүйц өөрчлөлтийн тайлбар;
 - (iii) Барьцааны хөрөнгийг харгалзан байгууллага нь гарзын хасагдуулга хүлээн зөвшөөрөөгүй санхүүгийн хэрэглүүрүүдийн талаархи мэдээлэл.
- (в) Тухайн тайлант үеийн эцэст зээлийн үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгийн хувьд баталгаа болгон эзэмшиж буй барьцаа болон зээлийн бусад сайжруулалтын талаархи тоон мэдээлэл (жишээлбэл; барьцаа болон зээлийн бусад сайжруулалт нь зээлийн эрсдлийг бууруулах тоо хэмжээ).

42Н. Байгууллага нь тухайн тайлант үеийн туршид данснаас хассан боловч албадан хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хамаарсан хэвээр байгаа санхүүгийн хөрөнгөнд хамаарах гэрээний үлдэгдэл дүнг тодруулна.

Зээлийн эрсдэлд өртөлт

42О. Байгууллагын зээлийн эрсдэлд өртөлтийг үнэлэх ба зээлийн эрсдлийн мэдэгдэхүйц төвлөрлийг ойлгох боломжийг санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгохын тулд тухайн байгууллага нь санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнэ, зээл олгох баталгааны болон санхүүгийн баталгааны гэрээнүүдийн зээлийн эрсдэлд өртөлтийг зээлийн эрсдлийн зэрэглэлийн түвшнээр тодруулна. Энэхүү мэдээллийг дараах санхүүгийн хэрэглүүрүүдийн хувьд тус тусад нь бэлтгэж тогилуулна:

- (а) Гарзын хасагдуулгыг нь 12-сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр хэмждэг;

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

(б) Гарзын хасагдуулгыг нь нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр хэмждэг, доорх санхүүгийн хэрэглүүр:

(i) Зээлийн эрсдэл нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш мэдэгдэхүйц нэмэгдсэн санхүүгийн хэрэглүүр боловч зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгө биш;

(ii) Тухайн тайлант үеийн эцэст зээлийн үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгө (гэхдээ худалдан авсан буюу үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай хөрөнгө биш);

(iii) Гарзын хасагдуулгыг нь УСНББОУС 41-ийн 87-р параграфын дагуу хэмждэг УСНББОУС 9-ийн цар хүрээнд хамаарах арилжааны ажил гүйлгээнээс эсвэл УСНББОУС 23-ын цар хүрээнд хамаарах арилжааны бус ажил гүйлгээнээс үүсдэг авлага болон түрээсийн авлага.

(в) Худалдан авсан буюу үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгө.

42П. Байгууллага нь УСНББОУС 41-ийн 87-р параграфыг мөрддөг, УСНББОУС 9-ийн цар хүрээнд хамаарах арилжааны ажил гүйлгээнээс эсвэл УСНББОУС 23-ын цар хүрээнд хамаарах арилжааны бус ажил гүйлгээнээс үүсдэг авлага болон түрээсийн авлагын хувьд, 42О параграфын дагуу бэлтгэх мэдээлэл нь хасагдуулгын матрицад үндэслэж болох юм (УСНББОУС 41-ийн МЗУ199-р параграфыг үзнэ үү).

43. Энэ Стандартын цар хүрээнд хамаарах боловч УСНББОУС 41-ийн үнэ цэнийн бууралтын шаардлагуудыг мөрддөггүй бүх санхүүгийн хэрэглүүрийн хувьд байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн ангиудаар дараах зүйлсийг тодруулна:

(а) Эзэмшиж буй аливаа барьцаа буюу зээлийн бусад сайжруулалтуудыг харгалзан үзээгүй тохиолдолд тухайн тайлант үеийн эцэст зээлийн эрсдэлд өртөх хамгийн их дүнг хамгийн сайн төлөөлөн илэрхийлэх дүн (жишээлбэл; УСНББОУС 28-д заасан харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах шалгуурыг хангахгүй цэвэр дүнгээр тооцох хэлцэл); дансны үнэ нь зээлийн эрсдэл өртөлтийн хамгийн их дүнг хамгийн сайн төлөөлөн илэрхийлэх санхүүгийн хэрэглүүрүүдийн хувьд энэ тодруулга шаардлагагүй юм.

(б) Дээрх (а) д тодруулсан дүнгийн хувьд Зээлийн эрсдэл өртөлтийн хамгийн их дүнг хамгийн сайн төлөөлөн илэрхийлэх дүнгийн (дээрх (а)-гийн дагуу тодруулах эсвэл санхүүгийн хэрэглүүрийн дансны үнээр илэрхийлэх дүнгийн) хувьд баталгаа болгон эзэмшиж буй барьцаа болон зээлийн бусад сайжруулалт, тэдгээрийн санхүүгийн үр нөлөөний (жишээлбэл; барьцаа болон зээлийн бусад сайжруулалт нь зээлийн эрсдлийг бууруулах тоо хэмжээ) талаархи тайлбар тодорхойлолт.

~~(в) Хугацаа онгороогүй, үнэ цэнэ буураагүй санхүүгийн хөрөнгийн зээлийн чанарын талаархи мэдээлэл; ба~~

~~(г) Нөхцлийг дахин хэлэлцэн тохироогүй бол хугацаа онгорох эсвэл үнэ цэнэ буурах байсан санхүүгийн хөрөнгүүдийн дансны үнэ.~~

Хугацаа онгосон буюу үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгө

44. Байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн ангиар дараах тодруулгыг хийнэ:

~~(а) Тухайн тайлант үеийн эцсээр хугацаа онгосон боловч үнэ цэнэ буураагүй санхүүгийн хөрөнгийн наажилтын шинжилгээ;~~

~~(б) Тухайн тайлант үеийн эцсийн байдлаар үнэ цэнэ нь буурна гэж тус бүрд нь тодорхойлсон санхүүгийн хөрөнгүүдийн шинжилгээ, үүн дотроо тэдгээрийн үнэ цэнэ буурсан эсэхийг тодорхойлохдоо уг байгууллагын харгалзан үзсэн хүчин зүйлс; ба~~

~~(в) Дээрх (а) ба (б) д тодруулсан дүнүүдийн хувьд, уг байгууллагын баталгаа болгон эзэмшиж буй барьцаа болон зээлийн бусад сайжруулалтын талаархи тайлбар~~

~~тодорхойлолт, түүнчлэн практик боломжгүй бич бол тэдгээрийн бодит үнэ цэнийн төөцөөлөл.~~

Олж эзэмшсэн барьцаа болон зээлийн бусад сайжруулалт

45. Байгууллага нь баталгаа болгон эзэмшиж буй барьцаа буюу зээлийн бусад сайжруулалтыг (жишээлбэл; зээлийн баталгаа) харгалзан үзсэнээр тухайн тайлант үеийн туршид санхүүгийн буюу санхүүгийн бус хөрөнгийг хүлээн авсан бөгөөд ийм хөрөнгүүд нь бусад Стандартууд дахь хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангаж байвал уг байгууллага нь тайлант үеийн эцэст тэдгээр хөрөнгийн хувьд дараах зүйлсийг тодруулна:

- (а) Хүлээн авсан хөрөнгүүдийн шинж төрөл ба дансны үнэ;
- (б) Тухайн хөрөнгийг мөнгөнд шууд хөрвүүлэх боломжгүй тохиолдолд ийм хөрөнгийг данснаас хасах эсвэл өөрийн үйл ажиллагаанд ашиглах талаархи түүний бодлого.

...

Санхүүгийн хөрөнгийн шилжүүлэлт

49А. Санхүүгийн хөрөнгийн шилжүүлэлттэй холбоотойгоор 49Б-49И параграфт заасан, тодруулгын шаардлагууд нь энэхүү Стандартын тодруулгын бусад шаардлагуудын нэмэлт гүйцээлт болно. Байгууллага нь 49Б-49И параграфтаар шаардсан тодруулгыг өөрийн санхүүгийн тайланд нэг тодруулга байдлаар толилуулна. Холбогдох шилжүүлэлтийн ажил гүйлгээ нь хэзээ хийгдсэн эсэхээс үл хамааран, байгууллага нь тайлант үеийн эцэст үл хүлээн зөвшөөрөөгүй байгаа, шилжүүлсэн бүх санхүүгийн хөрөнгө болон шилжүүлсэн хөрөнгө дэх аливаа цаашдын оролцооны хувьд уг шаардлагатай тодруулгыг хийнэ. Эдгээр параграфууд дахь тодруулгын шаардлагуудыг мөрдөх зорилгын хувьд байгууллага нь зөвхөн дараах аль нэг байдлаар бүх санхүүгийн хөрөнгийг эсвэл (уг шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийн) зарим хэсгийг шилжүүлдэг:

- (а) Тухайн санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээг хүлээн авах гэрээний эрхийг шилжүүлэх; эсвэл
- (б) Тухайн санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээг хүлээн авах гэрээний эрхийг хадгалан үлдэх боловч нэг буюу хэд хэдэн хүлээн авагч талуудад уг мөнгөн гүйлгээг төлөх гэрээний үүргийг хүлээх.

49Б. Байгууллага нь өөрийн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд дараах боломж олгох мэдээллийг тодруулна:

- (а) Бүхэлд нь үл хүлээн зөвшөөрөөгүй байгаа, шилжүүлсэн санхүүгийн хөрөнгө ба холбогдох өр төлбөрийн хоорондох харилцаа холбоог ойлгох;
- (б) Үл хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгө дэх тухайн байгууллагын цаашдын оролцооны шинж төрөл ба холбогдох эрсдлийг үнэлэх.

49В. 49Д-49И параграф дахь тодруулгын шаардлагуудыг мөрдөх зорилгын хувьд, хэрэв шилжүүлэлтийн нэг хэсэг байдлаар, байгууллага нь уг шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийн гэрээний аль нэг эрх буюу үүргийг хадгалан үлддэг, эсвэл шилжүүлсэн санхүүгийн хөрөнгөтэй холбоотойгоор шинэ гэрээний аль нэг эрх буюу үүргийг хүлээн авдаг бол тухайн байгууллага нь шилжүүлсэн санхүүгийн хөрөнгөнд цаашдын оролцоотой хэвээр байна. 49Д-49И параграф дахь тодруулгын шаардлагуудыг мөрдөх зорилгын хувьд дараах зүйлс нь цаашдын оролцоог илэрхийлэхгүй:

- (а) Хуулийн процессын үр дүнд хүчингүй болгох боломжтой хуурамч шилжүүлэлт, түүнчлэн үл үндэслэлтэй, найдвартай, шударга арилжааны үзэл баримтлалтай холбоотой хэвийн төлөөлөл ба баталгаа;

- (б) Шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийг буцаан олж эзэмших гэрээний үнэ (эсвэл хэрэгжүүлэх үнэ) нь уг шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ байх форвард, опцион болон бусад гэрээ; эсвэл
- (в) Байгууллага нь санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээг хүлээн авах гэрээний эрхийг хадгалан үлддэг боловч уг мөнгөн гүйлгээг нэг буюу хэд хэдэн байгууллагуудад төлөх гэрээний үүргийг хүлээдэг бөгөөд УСНББОУС 41-ийн 16(а)-(в) параграфт заасан нөхцөл хангагддаг хэлцэл.

Бүхэлд нь үл хүлээн зөвшөөрөөгүй байгаа, шилжүүлсэн санхүүгийн хөрөнгө

49Г. Шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийн бүх буюу зарим хэсэг нь үл хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангахгүй байх тийм арга замаар байгууллага нь санхүүгийн хөрөнгийг шилжүүлж болох юм. 49Б(а) параграфт заасан зорилгыг хангахын тулд байгууллага бүхэлд нь үл хүлээн зөвшөөрөөгүй байгаа, шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийн анги тус бүрийн хувьд тайлант үе бүрийн эцэст дараах зүйлсийг тодруулна:

- (а) Шилжүүлсэн хөрөнгийн шинж төрөл.
- (б) Байгууллагад учрах өмчлөлийн эрсдэл болон өгөөжийн шинж төрөл.
- (в) Шилжүүлсэн хөрөнгө ба холбогдох өр төлбөрийн хоорондох харилцаа холбооны шинж төрлийн тайлбар тодорхойлолт, үүнд тайлагнагч байгууллага нь тухайн шилжүүлсэн хөрөнгийг ашиглахад уг шилжүүлэлтээр тогтоосон хязгаарлалтууд.
- (г) Холбогдох өр төлбөрийг хариуцах тухайн оролцогч нөгөө тал (талууд) нь зөвхөн уг шилжүүлсэн хөрөнгийн хувьд оролцох эрхтэй тохиолдолд тэрхүү шилжүүлсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ, холбогдох өр төлбөрийн бодит үнэ цэнэ болон цэвэр төлөв байдлыг (шилжүүлсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ ба холбогдох өр төлбөрийн бодит үнэ цэнийн зөрүүг) харуулсан хуваарь.
- (д) Байгууллага нь шилжүүлсэн бүх хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа тохиолдолд уг шилжүүлсэн хөрөнгө ба холбогдох өр төлбөрийн дансны үнүүд.
- (е) Байгууллага нь өөрийн цаашдын оролцооны хэмжээгээр тухайн хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа тохиолдолд (УСНББОУС 41-ийн 17(в)(ii) ба 27-р параграфыг үзнэ үү) шилжүүлэлтийн өмнөх уг анхны хөрөнгийн нийт дансны үнэ, байгууллага хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа хөрөнгийн дансны үнэ ба холбогдох өр төлбөрийн дансны үнэ.

Бүхэлд нь үл хүлээн зөвшөөрдөг, шилжүүлсэн санхүүгийн хөрөнгө

49Д. Байгууллага нь шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь үл хүлээн зөвшөөрдөг (УСНББОУС 41-ийн 17(а) ба 17(в)(i) параграфыг үзнэ үү) боловч тэдгээрийн хувьд цаашдын оролцоотой байгаа тохиолдолд 49Б(б) параграфт заасан зорилгыг хангахын тулд байгууллага хамгийн наад зах нь цаашдын оролцооны төрөл тус бүрийн хувьд тайлант үе бүрийн эцэст дараах зүйлсийг тодруулна:

- (а) Байгууллагын санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрсөн бөгөөд тухайн үл хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгө дэх байгууллагын цаашдын оролцоог илэрхийлэх уг хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ, түүнчлэн тэдгээр хөрөнгө, өр төлбөрийн дансны үнийг тусгасан мөрийн зүйлс.
- (б) Тухайн үл хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгө дэх байгууллагын цаашдын оролцоог илэрхийлэх уг хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнэ.
- (в) Тухайн үл хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгө дэх байгууллагын цаашдын оролцооноос түүнд учрах хамгийн их эрсдлийг хамгийн сайн төлөөлөн илэрхийлэх дүн ба уг хамгийн их эрсдлийг хэрхэн тодорхойлсныг харуулах мэдээлэл.
- (г) Үл хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгийг буцаан худалдан авахад шаардагдах буюу шаардагдаж болох дискаунтчлаагүй мөнгөн зарлага (жишээлбэл; опционы гэрээн дэх

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

хэрэгжих үнэ) болон уг шилжүүлсэн хөрөнгийн хувьд шилжүүлэн авагчид төлөх бусад өглөг. Хэрэв мөнгөн зарлага нь хувьсан өөрчлөгддөг бол уг тодруулах дүн нь тайлант үе бүрийн эцэст оршин буй нөхцөл байдалд үндэслэсэн байвал зохино.

(д) Үл хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгийг буцаан худалдан авахад шаардагдах буюу шаардагдаж болох дискаунтчлаагүй мөнгөн зарлага болон уг шилжүүлсэн хөрөнгийн хувьд шилжүүлэн авагчид төлөх бусад өглөгийн дуусгавар болох хугацааны задаргаа шинжилгээ, үүнд тухайн байгууллагын цаашдын оролцооны хувьд гэрээний үлдсэн дуусгавар болох хугацааг харуулна.

(е) Дээрх (а)-(д) параграфт шаардсан тоон тодруулгыг тайлбарлах ба дэмжих чанарын шинжтэй мэдээлэл.

49Е. Хэрэв байгууллага нь үл хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгөнд нэгээс олон төрлийн цаашдын оролцоотой бөгөөд түүнийг цаашдын оролцооны нэг төрлийн дагуу тайлагнадаг бол уг байгууллага нь тухайн тодорхой хөрөнгийн хувьд 49Д параграфтаар шаардсан мэдээллийг нэгтгэн нийлүүлж болох юм.

49Ж. Түүнчлэн, байгууллага нь цаашдын оролцооны төрөл тус бүрийн хувьд дараах зүйлсийг тодруулна:

(а) Тухайн хөрөнгийг шилжүүлэх өдрөөр хүлээн зөвшөөрсөн олз, гарз.

(б) Үл хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгө дэх уг байгууллагын цаашдын оролцооны үр дүнд тухайн тайлант үед болон хуримтлагдсан байдлаар хүлээн зөвшөөрсөн орлого ба зардал (жишээлбэл; үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтүүд).

(в) Тайлант үе дэх шилжүүлэлтийн үйл ажиллагаанаас (үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангадаг) үүссэн мөнгөн орлогын нийт дүнг тухайн тайлант үеийн туршид жигд хуваарилдаггүй (жишээлбэл; шилжүүлэлтийн үйл ажиллагааны нийт дүнгийн ихэнх хэсгийг уг тайлант үеийн хаалтын өдрөөр хүлээн авсан) бол:

(i) Уг шилжүүлэлтийн хамгийн том үйл ажиллагааг тухайн тайлант үеийн аль хэсэгт хийсэн эсэх (жишээлбэл; тайлант үеийн эцсээс өмнөх сүүлийн таван өдөр).

(ii) Тухайн тайлант үеийн тэрхүү хэсэгт шилжүүлэлтийн үйл ажиллагаанаас хүлээн зөвшөөрсөн дүн (жишээлбэл; холбогдох олз буюу гарз).

(iii) Тухайн тайлант үеийн тэрхүү хэсэгт хийгдсэн шилжүүлэлтийн үйл ажиллагааны мөнгөн орлогын нийт дүн.

Цэвэр хөрөнгө/өмчийн тайланг толилуулж байгаа тайлант үе бүрийн хувьд байгууллага нь энэхүү мэдээллийг бэлтгэнэ.

Нэмэлт мэдээлэл

49И. Байгууллага нь 49Б параграфт дурдсан тодруулгын зорилгыг хангахад шаардлагатай гэж үзсэн аливаа нэмэлт мэдээллийг тодруулна.

УСНББОУС 41-ийг анх удаа мөрдөх

49К. УСНББОУС 41-ийг анх удаа мөрдөх өдрийг багтаасан тухайн тайлант үед байгууллага нь санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн анги тус бүрийн хувьд тэрхүү анх удаа мөрдөх өдрөөр дараах мэдээллийг тодруулна:

(а) УСНББОУС 29-ийн эвэвчлэл УСНББОУС 41-ийн өмнөх хувилбарын дагуу тодорхойлсон анхны хэмжилтийн ангилал ба дансны үнэ (хэрэв УСНББОУС 41-ийг мөрдөхдөө байгууллагын сонгосон арга хандлага нь янз бүрийн шаардлагуудын хувьд анх удаа мөрдөх нэгээс олон өдрийг багтаадаг бол);

(б) УСНББОУС 41-ийн дагуу тодорхойлсон шинэ хэмжилтийн ангилал ба дансны үнэ;

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

(в) Санхүүгийн байдлын тайланд өмнө нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан боловч цаашид ингэж ангилахаа больсон аливаа санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн дүн, үүнд анх мөрдөх өдрөөр дахин ангилахаар байгууллагын сонголт хийсэн дүн ба УСНББОУС 41-ийн дагуу дахин ангилахыг байгууллагаас шаарддаг дүнг өөр хооронд нь ялган харуулна.

49Л. УСНББОУС 41-ийг анх удаа мөрдөх өдрийг багтаасан тухайн тайлант үед байгууллага нь дараах зүйлсийг ойлгох боломжийг санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгох чанарын шинжтэй мэдээллийг тодруулна:

(а) УСНББОУС 41-ийг мөрдсөний үр дүнд ангилал нь өөрчлөгдсөн санхүүгийн хөрөнгүүдэд УСНББОУС 41-ийн ангиллын шаардлагуудыг хэрхэн мөрдсөн.

(б) Анх мөрдөх өдрөөр санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан эсвэл ингэж ангилахаа больсон шалтгаан.

49М. Байгууллага нь санхүүгийн хөрөнгүүдэд УСНББОУС 41-ийн ангилал ба хэмжилтийн шаардлагуудыг анх удаа мөрдсөн тухайн тайлант үеийн хувьд (өөрөөр хэлбэл, байгууллага нь санхүүгийн хөрөнгөнд УСНББОУС 29-ийг биш, харин УСНББОУС 41-ийг мөрдөхөөр шилжсэн үед) уг байгууллага нь УСНББОУС 41-ийн 173-р параграфтаар шаардсанчлан, энэхүү Стандартын 49Н-49Р-р параграфт заасан тодруулгыг хийнэ.

49Н. 49М параграфтаар шаардсан тохиолдолд байгууллага нь УСНББОУС 41-ийг анх мөрдсөн өдрөөр санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн ангиллын өөрчлөлтийг тодруулах бөгөөд дараах зүйлсийг тус тусад нь харуулна:

(а) УСНББОУС 29-ийн дагуу хийсэн тэдгээрийн хэмжилтийн ангилалд үндэслэсэн, дансны үнийн өөрчлөлтүүд (өөрөөр хэлбэл, УСНББОУС 41-д шилжих үеийн хэмжилтийн онцлог шинжийн өөрчлөлтөөс үүсээгүй);

(б) УСНББОУС 41-д шилжих үеийн хэмжилтийн онцлог шинжийн өөрчлөлтөөс үүссэн дансны үнийн өөрчлөлт.

Байгууллага нь санхүүгийн хөрөнгүүдэд УСНББОУС 41-ийн ангилал ба хэмжилтийн шаардлагуудыг анх удаа мөрдсөн тайлант жилийн дараа энэхүү параграфт дурдсан тодруулгыг хийх шаардлагагүй юм.

49О. УСНББОУС 41-д шилжсэний үр дүнд дахин ангилсан, ингэснээр хорогдуулсан өртгөөр хэмждэг санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөр, түүнчлэн ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангиллаас гаргаж, дахин ангилсан, ингэснээр цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг санхүүгийн хөрөнгийн хувьд 49М параграфтаар шаардсан тохиолдолд байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:

(а) Тайлант үеийн эцэс дэх уг санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнэ; ба

(б) Хэрэв санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг дахин ангилаагүй байсан бол тухайн тайлант үеийн туршид ашиг, алдагдалд эсвэл цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрөх байсан бодит үнэ цэнийн олз, гарз.

Байгууллага нь санхүүгийн хөрөнгүүдэд УСНББОУС 41-ийн ангилал ба хэмжилтийн шаардлагуудыг анх удаа мөрдсөн тайлант жилийн дараа энэхүү параграфт дурдсан тодруулгыг хийх шаардлагагүй юм.

49П. УСНББОУС 41-д шилжсэний үр дүнд ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангиллаас гаргаж, дахин ангилсан санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн хувьд 49М параграфтаар шаардсан тохиолдолд байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:

(а) Анх удаа мөрдсөн өдрөөр тодорхойлсон үр ашигт хүүний хувь хэмжээ;

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

(б) Хүлээн зөвшөөрсөн хүүний орлого буюу зардал.

Хэрэв байгууллага нь санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийг анх мөрдөх өдрөөр шинэ, нийт дансны үнэ гэж үздэг бол (УСНББОУС 41-ийн 168-р параграфыг үзнэ үү) үл хүлээн зөвшөөрөх хүртэлх тайлант үе бүрийн хувьд энэхүү параграфт дурдсан тодруулгыг хийнэ. Бусад тохиолдолд, байгууллага нь санхүүгийн хөрөнгүүдэд УСНББОУС 41-ийн ангилал ба хэмжилтийн шаардлагуудыг анх удаа мөрдсөн тайлант жилийн дараа энэхүү параграфт дурдсан тодруулгыг хийх шаардлагагүй юм.

49P. Байгууллага нь 49M-49П параграфт дурдсан тодруулгыг толилуулдаг тохиолдолд тэдгээр тодруулга болон энэ Стандартын 29-р параграфт заасан тодруулга нь анх мөрдөх өдрөөрх дараах зүйлсийн хоорондох тохируулгыг бэлтгэх боломж олгохоор байх ёстой:

(а) УСНББОУС 29 ба УСНББОУС 41-ийн дагуу толилуулсан хэмжилтийн ангиллууд; ба

(б) Санхүүгийн хэрэглүүрийн анги.

49C. УСНББОУС 41-ийн 73-93-р параграфыг анх мөрдөх өдөр байгууллага нь УСНББОУС 29-ийн дагуу тодорхойлох үнэ цэнийн бууралтын хасагдуулгын болон УСНББОУС 19-ийн дагуу тооцох нөөцийн эцсийн үлдэгдлийг УСНББОУС 41-ийн дагуу тодорхойлсон гарзын хасагдуулгын эхний үлдэгдэлтэй тохируулах боломжийг олгох мэдээллийг тодруулах шаардлагатай. Санхүүгийн хөрөнгийн хувьд, УСНББОУС 29 ба УСНББОУС 41-д заасан холбогдох санхүүгийн хөрөнгүүдийн хэмжилтийн ангиллаар энэхүү тодруулгыг хийх бөгөөд хэмжилтийн ангиллын өөрчлөлт нь уг өдрөөрх гарзын хасагдуулгад үзүүлэх үр нөлөөг тусад нь харуулна.

49T. УСНББОУС 41-ийг анх мөрдсөн өдрийг багтаасан тайлант үеийн хувьд, байгууллага нь дараах стандартуудын ангилал ба хэмжилтийн шаардлагуудын (үүнд УСНББОУС 41-ийн 69-72 ба 73-93-р параграфт заасан, санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртгөөр хэмжилт ба үнэ цэнийн бууралттай холбоотой шаардлагууд хамаарна) дагуу тайлагнах байсан мөрийн зүйлийн дүнг тодруулах шаардлагагүй юм:

(а) Өмнөх тайлант үеүдийн хувьд УСНББОУС 41-ийн;

(б) Тухайн тайлант үеийн хувьд УСНББОУС 29-ийн.

49У. Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед оршин байсан баримт материал ба нөхцөл байдалд үндэслэн УСНББОУС 41-ийн МЗУ68-МЗУ70-р параграфын дагуу засварласан мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн элементийг байгууллага нь УСНББОУС 41-ийг анх мөрдөх өдрөөр УСНББОУС 41-ийн 161-р параграфын дагуу үнэлэх практик боломжгүй (УСНББОУС 3-д тодорхойлсон) бол уг байгууллага нь УСНББОУС 41-ийн МЗУ68-МЗУ70-р параграфт заасан мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн элементийн засварлан өөрчлөлттэй холбоотой шаардлагуудыг үл харгалзан, тухайн санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед оршин байсан баримт материал болон нөхцөл байдалд үндэслэн санхүүгийн хөрөнгийн гэрээний мөнгөн гүйлгээний шинж чанаруудыг үнэлнэ. УСНББОУС 41-ийн МЗУ68-МЗУ70-р параграфт заасан мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн элементийн засварлан өөрчлөлттэй холбоотой шаардлагуудыг үл харгалзан тухайн санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед оршин байсан баримт материал болон нөхцөл байдалд үндэслэн гэрээний мөнгөн гүйлгээний шинж чанаруудыг нь үнэлдэг санхүүгийн хөрөнгийн тайлант үеийн эцэс дэх дансны үнийг байгууллага нь уг санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх хүртэл тодруулна.

49Ф. Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед оршин байсан баримт материал ба нөхцөл байдалд үндэслэн УСНББОУС 41-ийн МЗУ74(в) параграфын дагуу урьдчилсан төлбөрийн шинжийн бодит үнэ цэнэ нь мэдэгдэхүйц бус байсан эсэхийг байгууллага нь УСНББОУС 41-ийг анх мөрдөх өдрөөр УСНББОУС 41-ийн 162-р параграфын дагуу үнэлэх практик боломжгүй (УСНББОУС 3-д тодорхойлсон) бол уг байгууллага нь УСНББОУС 41-ийн МЗУ74-р параграфт заасан, урьдчилсан төлбөрийн шинжид хамаарах гажих нөхцлийг үл харгалзан тухайн санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед оршин байсан баримт материал болон нөхцөл байдалд үндэслэн санхүүгийн хөрөнгийн гэрээний мөнгөн гүйлгээний шинж чанаруудыг

үнэлнэ. УСНББОУС 41-ийн МЗУ74-р параграфт заасан, урьдчилсан төлбөрийн шинжилгээг хамаарах гажих нөхцлийг үл харгалзан тухайн санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед оршин байсан баримт материал болон нөхцөл байдалд үндэслэн гэрээний мөнгөн гүйлгээний шинж чанаруудыг нь үнэлдэг санхүүгийн хөрөнгийн тайлант үеийн эцэс дэх дансны үнийг байгууллага нь уг санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх хүртэл тодруулна.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

52Е. 2018 оны 8 дугаар сард гаргасан, УСНББОУС 41-ээр 2, 3, 4, 5, 8, 11, 12, 13, 14, 18, 24, 34, 35, 36, 37, 41, 43, 45, МЗУ1, МЗУ5, МЗУ9, МЗУ10, МЗУ24, МЗУ29-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 16, 17, 20, 26, 27, 28, 44-р параграфыг хасаж, зарим гарчиг болон 5А, 13А, 14А, 14Б, 15А, 15Б, 15В, 17А, 17Б, 17В, 17Г, 17Д, 17Е, 20А, 24А, 25А, 25Б, 25В, 25Г, 26А, 26Б, 26В, 27А, 27Б, 27В, 27Г, 27Д, 27Е, 28А, 28Б, 28В, 28Г, 28Д, 28Е, 28Ж, 37А, 39А, 42А, 42Б, 42В, 42Г, 42Д, 42Е, 42Ж, 42И, 42К, 42Л, 42М, 42Н, 42О, 42П, 49А, 49Б, 49В, 49Г, 49Д, 49Е, 49И, 49К, 49Л, 49М, 49О, 49П, 49Р, 49С, 49Т, 49У, 49Ф, 52Е, МЗУ8А, МЗУ8Б, МЗУ8В, МЗУ8Г, МЗУ8Д, МЗУ8Е, МЗУ8Ж, МЗУ8И, МЗУ8К, МЗУ8Л, МЗУ31, МЗУ32, МЗУ32А, МЗУ33, МЗУ34, МЗУ35, МЗУ36, МЗУ37, МЗУ38, МЗУ39, МЗУ40, МЗУ41, МЗУ42, МЗУ43, МЗУ44, МЗУ45, МЗУ46, МЗУ47, МЗУ48, МЗУ49, МЗУ50, МЗУ51, МЗУ52, МЗУ53, МЗУ54, МЗУ55-р параграфыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд УСНББОУС 41-ийг мөн уг өмнөх тайлант хугацаанд дагаж мөрдөнө.

...

Мөрдөх заавар удирдамж

Энэ Хавсралт нь УСНББОУС 30-ийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.

...

Санхүүгийн хэрэглүүрийн ангиуд ба тодруулгын түвшин (9-р параграф)

МЗУ1. 9-р параграф нь тодруулсан мэдээллийн шинж төрөлд тохирох бөгөөд тэдгээр санхүүгийн хэрэглүүрүүдийн шинж чанарыг харгалзсан ангиудаар санхүүгийн хэрэглүүрийг бүлэглэхийг байгууллагаас шаарддаг. 9-р параграфт дурдсан ангиудыг тухайн байгууллага тодорхойлдог, иймээс УСНББОУС 41-д УСНББОУС 29-д тусгайлан заасан санхүүгийн хэрэглүүрийн ангиллаас (санхүүгийн хэрэглүүрийг хэрхэн хэмжих ба бодит үнэ цэнийн өөрчлөлтийг хэрхэн хүлээн зөвшөөрөхийг тодорхойлсон) өөр байдаг.

...

Санхүүгийн байдал ба санхүүгийн үр дүнд санхүүгийн хэрэглүүрийн үзүүлэх ач холбогдол

Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хоронго буюу санхүүгийн ор толбор (13 ба 14-р параграф)

МЗУ4. Хэрэв байгууллага нь санхүүгийн ор толборийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан бол санхүүгийн ор толборийн зээлийн эредлийн өөрчлөлтөнд хамааруулж болох уг санхүүгийн ор толборийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн дүнг тодруулахыг 13(а) параграфтаар шаарддаг. Зах зээлийн эредэл үүсэхэд хүргэдэг зах зээлийн

нохцол байдлын өөрчлөлтөнд хамааруулж болохгүй уг ор төлбөрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн дүн байдлаар байгууллага нь энэхүү дүнг тодорхойлохыг 13(a)(i) параграфтаар зөвшөөрдөг. Хэрэв ор төлбөрийн хувьд зах зээлийн нөхцөл байдлын цорын ганц хамааралтай өөрчлөлт нь ажиглаж болох (бенчмарк) хүүний түвшний өөрчлөлт бол энэхүү дүнг дараах байдлаар тооцоолно:

- (a) — Эхлээд, байгууллага нь тухайн тайланг үеийн эхэн дэх ор төлбөрийн ажигласан зах зээлийн үнэ ба ор төлбөрийн гэрээний мөнгөн гүйлгээг ашиглан тэрхүү тайланг үеийн эхний байдлаар ор төлбөрийн өгөөжийн дотоод хувийг тооцоолно. Тус байгууллага нь өгөөжийн дотоод хувийн уг хэрэглүүрт хамаарах тусгай бүрэлдэхүүн хэсгийг гаргахын тулд энэхүү өгөөжийн дотоод хувиас тухайн тайланг үеийн эхэн дэх тэрхүү ажигласан (бенчмарк) хүүний түвшинг хасна.
- (б) — Үүний дараа, байгууллага нь тухайн тайланг үеийн эцэс дэх ор төлбөрийн гэрээний мөнгөн гүйлгээ болон (i) тухайн тайланг үеийн эцэст ажигласан (бенчмарк) хүүний түвшин, ба (ii) дээрх (a) д тодорхойлсон, өгөөжийн дотоод хувийн уг хэрэглүүрт хамаарах тусгай бүрэлдэхүүн хэсгийн нийлбэртэй тэнцүү байх дискаунтын хувийг ашигласнаар ор төлбөртэй холбоотой мөнгөн гүйлгээний оноогийн үнэ цэнийг тооцоолно.
- (в) — Тайланг үеийн эцэс дэх ор төлбөрийн ажигласан зах зээлийн үнэ ба дээрх (б) д тодорхойлсон дүн хоорондох зөрүү нь уг ажигласан (бенчмарк) хүүний түвшний өөрчлөлтөнд хамааруулж болохгүй бодит үнэ цэнийн өөрчлөлт юм. Энэ нь тодруулах дүн байна.

Тухайн хэрэглүүрийн зээлийн эредлийн өөрчлөлтөөс бусад хүчин зүйлсээс үүссэн бодит үнэ цэнийн өөрчлөлт буюу хүүний түвшний өөрчлөлт нь энэ жишээний хувьд мэдэгдэхүйц биш гэж үзсэн. Энэ жишээн дэх хэрэглүүр нь дагалдах үүсэмэл хэрэглүүрийг агуулдаг бол уг дагалдах үүсэмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг 13(a) параграфын дагуу тодруулах дүнг тодорхойлохдоо харгалзан оруулахгүй.

Бусад тодруулга - Нягтлан бодох бүртгэлийн бодлого (25-р параграф)

МЗУ5. 25-р параграф нь санхүүгийн тайланг бэлтгэхэд ашигласан хэмжилтийн суурь (буюу сууриуд) болон тухайн санхүүгийн тайланг ойлгоход ач холбогдолтой, ашигласан нягтлан бодох бүртгэлийн бусад бодлогуудыг тодруулахыг шаарддаг. Санхүүгийн хэрэглүүрийн хувьд ийм тодруулгад дараах зүйлс хамаарч болох юм:

- (a) Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн ор төлбөрийн хувьд:
 - (i) Байгууллага нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн ор төлбөрийн шинж төрөл;
 - (ii) Ийм санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн ор төлбөрийг анх хүлээн зөвшөөрөх үед ингэж ангилах шалгуур; ба
 - (iii) Байгууллага нь ийм ангиллын хувьд УСНББОУС 41-ийн 46-р УСНББОУС 29-ийн 10, 13, 14-р параграфын нөхцлүүдийг хэрхэн хангасан эсэх. УСНББОУС 29-д заасан, ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн ор төлбөрийн тодорхойлолтын (б)(i) параграфын дагуу ангилсан хэрэглүүрүүдийн хувьд, ийм тодруулга нь үүсэх байсан хэмжилтийн буюу хүлээн зөвшөөрөлтийн тууштай бус байдлын суурь үндэслэл болох нөхцөл байдлын талаархи хүүрнэсэн тайлбар тодорхойлолтыг агуулсан байдаг. УСНББОУС 29-д заасан, Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн ор төлбөрийн тодорхойлолтын (б)(ii) параграфын дагуу ангилсан хэрэглүүрүүдийн хувьд, ийм тодруулга нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэсэн ангилал тухайн байгууллагын баримтжуулсан эредлийн удирдлага буюу хөрөнгө оруулалтын

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

~~стратегитай хэрхэн нийцэж байгаа талаархи хүүрнэсэн тайлбар тодорхойлолтыг агуулан байдаг.~~

- (б) Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан санхүүгийн хөрөнгийн хувьд:
- (i) Байгууллага нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан санхүүгийн хөрөнгийн шинж төрөл;
- (ii) Байгууллага нь ийм ангиллын хувьд УСНББОУС 41-ийн 44-р параграфын шалгуурыг хэрхэн хангасан эсэх.
- ~~(б) Санхүүгийн хөрөнгийг борлуулах боломжтой гэж ангилах шалгуур.~~
- (в) Санхүүгийн хөрөнгийн ердийн нөхцөлтэй худалдан авалт ба борлуулалтыг арилжааны өдрөөр эсвэл барагдуулалтын өдрөөр тайлагнадаг эсэх (УСНББОУС 41-ийн 11-р УСНББОУС 29-ийн 40-р параграфыг үзнэ үү.)
- (г) ~~Зээлийн гарзын улмаас үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгийн дансны үнийг бууруулахын тулд хасагдуулгын данс ашигладаг тохиолдолд:~~
- (i) ~~Үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгийн дансны үнийг хэзээ шууд бууруулах (данснаас хассан авлагыг буцаах үед шууд нэмэгдүүлэх) эсвэл хэзээ хасагдуулгын данс ашиглах эсэхийг тодорхойлох шалгуур; ба~~
- (ii) ~~Хасагдуулгын дансанд тусгасан дүнгүүдийг уг үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгийн дансны үнээс хасах шалгуур (20-р параграфыг үзнэ үү).~~
- (д) Санхүүгийн хэрэглүүрийн ангилал тус бүрийн хувьд цэвэр олз буюу цэвэр гарзыг хэрхэн тодорхойлдог (24(а) параграфыг үзнэ үү), жишээлбэл; ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг зүйлсийн цэвэр олз буюу цэвэр гарз нь хүүний орлого эсвэл ногдол ашиг болон адилтгах хуваарилалтаас үүссэн орлогыг агуулдаг эсэх.
- (е) ~~Үнэ цэнийн бууралтын гарз үүссэн гэсэн бодит нотолгоо байгаа эсэхийг тодорхойлохын тулд уг байгууллагын ашигладаг шалгуур (24(д) параграфыг үзнэ үү).~~
- (ж) ~~Хугацаа өнгөрсөн эсвэл үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгийн нөхцлүүдийг дахин хэлэлцэн тохирсон тохиолдолд тэрхүү дахин хэлэлцсэн нөхцөлд хамаарсан санхүүгийн хөрөнгөнд баримтлах нягтлан бодох бүртгэлийн бодлого (43(г) параграфыг үзнэ үү).~~
- (и) Бодит үнэ цэнийг нь тодорхойлж чадахгүй арилжааны бус ажил гүйлгээгээр гаргасан бөгөөд хасагдуулгыг нь УСНББОУС 19, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө*-ийн дагуу байгуулсан санхүүгийн баталгааны гэрээний хувьд ингэж хасагдуулгыг хүлээн зөвшөөрөхөд хүргэсэн нөхцөл байдлын талаархи тодруулга.

Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дүнгүүдэд хамгийн их мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх уг байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрдөхдөө удирдлагын хийсэн шүүн тунгаалтыг тухайн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын тоймд эсвэл бусад тодруулгад, тооцоололтой холбоотой шүүн тунгаалтаас тусад нь тодруулахыг УСНББОУС 1-ийн 137-р параграфтаар бас шаардсан байдаг.

...

Зээлийн эрсдлийн удирдлагын практик (42E-42Ж параграф)

МЗУ8А. 42E(б) параграф нь янз бүрийн санхүүгийн хэрэглүүрүүдийн үл биелүүлэлтийг байгууллага хэрхэн тодорхойлсон ба тэдгээр тодорхойлолтыг сонгох болсон учир шалтгааны талаархи мэдээллийг тодруулахыг шаарддаг. УСНББОУС 41-ийн 81-р параграфт заасанчлан, нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх эсэх тодорхойлолт нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш үл биелүүлэлт гарч тохиолдох эрсдлийн нэмэгдэлтэнд үндэслэдэг. УСНББОУС 41-д заасан, хүлээгдэж буй зээлийн алдагдлын шаардлагуудыг байгууллага хэрхэн мөрдсөнийг ойлгоход санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд туслах, байгууллагын үл биелүүлэлтийн тодорхойлолтын талаархи мэдээлэлд дараах зүйлс хамаарч болох юм:

- (а) Үл биелүүлэлтийг тодорхойлохдоо харгалзаж үзсэн тоон болон чанарын шинжтэй хүчин зүйлс;
- (б) Санхүүгийн хэрэглүүрийн янз бүрийн төрлүүдийн хувьд өөр өөр тодорхойлолтыг ашигласан эсэх;
- (в) Санхүүгийн хөрөнгөнд үл биелүүлэлт гарсаны дараа засварлагдсан түвшний талаархи таамаглалууд (өөрөөр хэлбэл, гүйцэтгэлийн төлөв байдал нь эргэж сэргэсэн санхүүгийн хөрөнгийн тоо).

МЗУ8Б. Байгууллагын бүтцийн өөрчлөлт ба засвар өөрчлөлтийн бодлогыг үнэлэхэд санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд туслахын тулд 42E(e)(ii) параграф нь 42E(e)(i) параграфын дагуу өмнө тодруулсан санхүүгийн хөрөнгийн гарзын хасагдуулгыг УСНББОУС 41-ийн 75-р параграфын дагуу нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр дараагийн тайлант үед хэмжих хэмжээг байгууллага хэрхэн хянан үнэлдэг талаархи мэдээллийг тодруулахыг шаарддаг. Засварлан өөрчилсөн санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдлийн дараагийн тайлант үе дэх нэмэгдэлтийг ойлгоход санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд туслах тоон мэдээлэл нь 42E(e)(i) параграфт заасан шалгуурыг хангах бөгөөд гарзын хасагдуулгыг нь нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай (өөрөөр хэлбэл, чанарын муудалтын хувь хэмжээ) тэнцүү дүнгээр хэмжиж, буцаасан, уг засварлан өөрчилсөн санхүүгийн хөрөнгийн талаархи мэдээллийг агуулсан байж болно.

МЗУ8В. 42Ж(а) параграф нь УСНББОУС 41-ийн үнэ цэнийн бууралтын шаардлагуудыг мөрдөхдөө ашигласан орц, таамаглал, тооцооллын арга техникийн суурь үндэслэлийн талаархи мэдээллийг тодруулахыг шаарддаг. Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжих буюу анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдлийн нэмэгдсэн хэмжээг тодорхойлохын тулд байгууллагын ашигласан таамаглал ба орц нь дотоод түүхэн мэдээлэл буюу үнэлэмж зэрэглэлийн тайлангаас олж авсан мэдээлэл, санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацаа болон барьцаа хөрөнгийг борлуулах цаг хугацааны талаархи таамаглалыг агуулсан байж болох юм.

Гарзын хасагдуулгын өөрчлөлтүүд (42И параграф)

МЗУ8Г. 42И параграфын дагуу байгууллага нь тухайн тайлант үед гарзын хасагдуулгыг өөрчилсөн учир шалтгаанаа тайлбарлах шаардлагатай байдаг. Гарзын хасагдуулгын эхний үлдэгдлээс эцсийн үлдэгдэл хүртэлх тохируулгын тайлангаас гадна тухайн өөрчлөлтүүдийн талаархи хүүрнэсэн тайлбарыг бэлтгэх шаардлагатай байж болно. Ийм хүүрнэсэн тайлбар нь тухайн тайлант үед гарзын хасагдуулгад орсон өөрчлөлтийн шалтгааны талаархи шинжилгээг, үүн дотроо дараах зүйлсийг агуулсан байж болно:

- (а) Багцын бүрдэл хэсэг;
- (б) Худалдан авсан буюу үүсгэн гаргасан санхүүгийн хэрэглүүрийн хэмжээ;
- (в) Хүлээгдэж буй зээлийн алдагдлын ноцтой байдал.

МЗУ8Д. Зээл олгох баталгаа ба санхүүгийн баталгааны гэрээний хувьд гарзын хасагдуулгыг нөөц байдлаар хүлээн зөвшөөрдөг. Байгууллага нь санхүүгийн хөрөнгийн гарзын хасагдуулгын өөрчлөлтийн талаархи мэдээллийг зээл олгох баталгаа ба санхүүгийн баталгааны гэрээний гарзын хасагдуулгын өөрчлөлтөөс тусад нь тодруулна. Гэвч санхүүгийн хэрэглүүр нь зээл (өөрөөр хэлбэл, санхүүгийн хөрөнгө) ба ашиглаагүй баталгааны (өөрөөр хэлбэл, зээл олгох баталгааны) бүрэлдэхүүн хэсгийн аль алиныг агуулдаг бөгөөд байгууллага нь зээл олгох баталгааны бүрэлдэхүүн хэсгээс хүлээгдэж буй зээлийн алдагдлыг уг санхүүгийн хөрөнгийн бүрэлдэхүүн хэсгээс хүлээгдэж буй зээлийн алдагдлаас тусад нь тодорхойлж чадахгүй бол тэрхүү зээл олгох баталгааны хувьд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тухайн санхүүгийн хөрөнгийн гарзын хасагдуулгатай хамт хүлээн зөвшөөрнө. Энэхүү нэгтгэсэн, хүлээгдэж буй зээлийн алдагдал нь тухайн санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнээс давсан хэмжээгээр уг хүлээгдэж буй зээлийн алдагдлыг нөөц гэж хүлээн зөвшөөрнө.

Барьцаа (42М параграф)

МЗУ8Е. 42М параграф нь хүлээгдэж буй зээлийн алдагдлын дүнд барьцаа болон зээлийн бусад сайжруулалтын үзүүлэх үр нөлөөг ойлгох боломжийг санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгох мэдээллийг тодруулахыг шаарддаг. Байгууллага нь барьцаа болон зээлийн бусад сайжруулалтын бодит үнэ цэнийн талаархи мэдээллийг тодруулах шаардлагагүй, мөн уг хүлээгдэж буй зээлийн алдагдлын (өөрөөр хэлбэл, үл биелүүлэлтэнд хүргэх тухайн алдагдлын) тооцоололд тусгасан тухайн барьцааны яг тодорхой үнэ цэнийг тоогоор илэрхийлэх шаардлагагүй байдаг.

МЗУ8Ж. Барьцаа, түүнчлэн хүлээгдэж буй зээлийн алдагдлын дүнд түүний үзүүлэх үр нөлөөний талаархи хүрэнэсэн тайлбар тодорхойлолт нь дараах зүйлсийн талаархи мэдээллийг агуулсан байж болно:

- (а) Баталгаа болгон эзэмшиж буй барьцаа болон зээлийн бусад сайжруулалтын гол төрлүүд (зээлийн бусад сайжруулалтын жишээ нь; санхүүгийн баталгаа, зээлийн үүсмэл хэрэглүүр болон УСНББОУС 28-д заасан харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах шалгуурыг хангахгүй цэвэр дүнгээр тооцох хэлцэл).
- (б) Эзэмшиж буй барьцаа болон зээлийн бусад сайжруулалтын хэмжээ, түүнчлэн гарзын хасагдуулгын хувьд тэдгээрийн үзүүлэх ач холбогдол;
- (в) Барьцаа болон зээлийн бусад сайжруулалтыг үнэлэх, удирдан зохицуулах бодлого ба процесс;
- (г) Барьцаа болон зээлийн бусад сайжруулалтын оролцогч нөгөө талын гол төрлүүд ба тэдгээрийн зээл төлөх чадвар;
- (д) Барьцаа болон зээлийн бусад сайжруулалтын хүрэн дэх эрсдлийн төвлөрлийн талаархи мэдээлэл.

Зээлийн эрсдэлд өртөлт (42О–42П параграф)

МЗУ8И. 42О параграф нь тухайн тайлант үеийн эцсийн байдлаарх байгууллагын зээлийн эрсдэлд өртөлт ба зээлийн эрсдлийн мэдэгдэхүйц төвлөрлийн талаархи мэдээллийг тодруулахыг шаарддаг. Оролцогч олон талууд нь газарзүйн нэг бүсэд байрладаг эсвэл ижил төсөөтэй үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд эдийн засгийн буюу бусад нөхцөл байдлын өөрчлөлт нь гэрээний үүргээ биелүүлэх тэдний чадвар боломжинд ижил нөлөө үзүүлэхэд хүргэх гийм ижил төсөөтэй эдийн засгийн шинж чанаруудтай байх тохиолдолд зээлийн эрсдлийн төвлөрөл үүсдэг. Санхүүгийн хэрэглүүрүүдийн бүлгийн томоохон хэсэгт нөлөө үзүүлж чадах тухайлсан эрсдлийн төвлөрөл гэх мэт тодорхой шинж бүхий санхүүгийн хэрэглүүрүүдийн бүлэг буюу багц байгаа эсэхийг ойлгох боломжийг уг санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгох мэдээллийг байгууллага нь тодруулна. Ийм тодруулга нь тухайлбал, зээл-үнэ цэнийн бүлгээр, газарзүйн бүсээр, аж үйлдвэрийн салбараар, гаргагчийн төрлөөр төвлөрлийг харуулж болох юм.

МЗУ8К. 42О параграфын дагуу мэдээллийг тодруулахдаа ашигласан, зээлийн эрсдлийн зэрэглэлийн түвшний тоо нь зээлийн эрсдлийн удирдлагын зорилгоор тухайн байгууллага өөрийн эрх бүхий албан тушаалтанд тайлагнадаг тоотой нийцсэн байна. Хугацаа өнгөрсөн мэдээлэл нь зөвхөн зээлдэгчид тусгайлан хамаарах, бэлэн боломжтой байгаа мэдээлэл бөгөөд байгууллага нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг УСНББОУС 41-ийн 82-р параграфын дагуу үнэлэхдээ уг хугацаа өнгөрсөн мэдээллийг ашигладаг бол тухайн байгууллага нь тэдгээр санхүүгийн хэрэглүүрийн хувьд хугацаа өнгөрсөн төлөв байдлаар харуулсан задаргаа шинжилгээг бэлтгэнэ.

МЗУ8Л. Байгууллага нь хүлээгдэж буй зээлийн алдагдлыг нэгдсэн сууриар хэмждэг тохиолдолд уг байгууллага нь нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлын хувьд хүлээн зөвшөөрөх зээлийн эрсдлийн зэрэглэлийн түвшингүүдэд тодорхой санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнэ эсвэл зээлийн олгох баталгааны болон санхүүгийн баталгааны гэрээний зээлийн эрсдлийг хуваарилах боломжгүй байж болох юм. Энэ тохиолдолд, байгууллага нь зээлийн эрсдлийн

зэрэглэлийн түвшинд шууд хуваарилж болох тэдгээр санхүүгийн хэрэглүүрт 42О параграфын шаардлагыг мөрдөх ба нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг нэгдсэн сууриар хэмждэг уг санхүүгийн хэрэглүүрийн нийт дансны үнийг тусад нь тодруулна.

Зээлийн эрсдэлд өртөх хамгийн их дүн (43(a) параграф)

МЗУ9. 42М(а) ба 43(a) параграф нь тухайн байгууллагын зээлийн эрсдэлд өртөх хамгийн их дүнг хамгийн сайн төлөөлөн илэрхийлэх дүнгийн тодруулга хийхийг шаарддаг. Санхүүгийн хөрөнгийн хувьд энэ нь ихэвчлэн дараах зүйлсийг хассан нийт дансны үнэ байдаг:

- (a) УСНББОУС 28-ын дагуу дагуу харилцан суутгаж, цэвэр дүнг гаргасан аливаа дүн; ба
- (б) УСНББОУС 41-ийн ~~УСНББОУС 29-ийн~~ дагуу хүлээн зөвшөөрсөн аливаа ~~үнэ цэнийн бууралтын~~ гарзын хасагдуулга.

МЗУ10. Зээлийн эрсдэл болон зээлийн эрсдлийн холбогдох хамгийн их өртөлтийг үүсэхэд хүргэх үйл ажиллагаанд дараах зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:

- (a) Үйлчлүүлэгчдэд зээл олгох, ~~авлага үүсгэж~~ ба бусад байгууллагуудад харилцах, хадгаламж байршуулах. Энэ тохиолдолд зээлийн эрсдэлд өртөлтийн хамгийн их дүн нь уг холбогдох санхүүгийн хөрөнгийн дансны үнэ байна.
- (б) Үүсмэл хэрэглүүрийн (жишээлбэл; гадаад валютын арилжааны гэрээ, хүүний түвшний своп, зээлийн үүсмэл хэрэглүүрийн) гэрээ байгуулах. Уг үр дүн болох хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмждэг тохиолдолд тухайн тайлант үеийн эцэс дэх зээлийн эрсдэлд өртөлтийн хамгийн их дүн нь түүний дансны үнэтэй тэнцүү байна.
- (в) Санхүүгийн баталгаа гаргах. Энэ тохиолдолд зээлийн эрсдлийн хамгийн их өртөлт нь тухайн баталгааг шаардан нэхэмжилснээр уг байгууллага төлөх шаардлагатай болж болох хамгийн их дүн бөгөөд өр төлбөр гэж хүлээн зөвшөөрсөн дүнгээс мэдэгдэхүйц их байж болох юм.
- (г) Уг хэрэглүүрийн хугацаанд буцаах боломжгүй эсвэл зөвхөн материаллаг сөрөг өөрчлөлтийн хариуд буцаах боломжтой зээл олгох баталгааг гаргах. Хэрэв гаргагч нь тухайн зээл олгох баталгааг цэвэр дүнгээр нь мөнгөөр эсвэл бусад санхүүгийн хэрэглүүрээр барагдуулж чадахгүй бол зээлийн эрсдлийн хамгийн их өртөлт тухайн зээл олгох баталгааны нийт дүн байна. Яагаад гэвэл, аливаа ашиглаагүй зээл олгох баталгааг ирээдүйд ашиглах эсэхээс хамааран энэ нь тодорхой бус байдаг. Энэ нь өр төлбөр гэж хүлээн зөвшөөрсөн дүнгээс мэдэгдэхүйц их байж болох юм.

...

Хүүний түвшний эрсдэл

МЗУ24. Хүүний түвшний эрсдэл нь санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрсөн хүүтэй санхүүгийн хэрэглүүр (жишээлбэл; ~~зээл ба авлага,~~ олж эзэмшсэн буюу гаргасан өрийн хэрэглүүр) ба санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрөөгүй зарим санхүүгийн хэрэглүүр (жишээлбэл; зээл олгох зарим баталгаа)-ээс үүсдэг.

...

Үнийн бусад эрсдэл

...

МЗУ29. 47(a) параграфын дагуу, ашиг, алдагдал өөрчлөгдөх мэдрэмжит байдлыг (жишээлбэл; ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн ~~гэж ангилсан~~ хэрэглүүрээс ~~болон берлуулах боломжтой санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтаас~~ үүсдэг) цэвэр хөрөнгө/өмчийн мэдрэмжит байдлаас (жишээлбэл; бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь цэвэр хөрөнгө/өмчид

толилуулдаг, өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтаас ~~бөрлүүлэх боломжтой гэж ангилсан хэрэглүүрээ~~ үүсдэг) тусад нь тодруулна.

...

Үл хүлээн зөвшөөрөлт (49В-49И параграф)

Цаашдын оролцоо (49В параграф)

МЗУ31. 49Д-49И параграфт заасан тодруулгын шаардлагуудын зорилгын хувьд, уг шилжүүлсэн санхүүгийн хөрөнгө дэх цаашдын оролцооны үнэлгээг тухайн тайлагнагч байгууллагын түвшинд хийдэг. Жишээлбэл; хяналтанд буй байгууллага нь өөрийн хяналт тавигч байгууллага цаашид оролцоотой байх санхүүгийн хөрөнгийг харилцан хамааралгүй гуравдагч талд шилжүүлсэн бол уг хяналтанд буй байгууллага нь өөрийн тусдаа буюу бие даасан санхүүгийн тайлангийн хувьд (өөрөөр хэлбэл, хяналтанд буй байгууллага нь тайлагнагч байгууллага байх тохиолдолд) тэрхүү шилжүүлсэн хөрөнгөнд цаашдын оролцоотой эсэхийг үнэлэхдээ хяналт тавигч байгууллагын оролцоог харгалзан тусгахгүй. Харин хяналт тавигч байгууллага нь өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд (өөрөөр хэлбэл, тайлагнагч байгууллага нь тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллага байх тохиолдолд) уг шилжүүлсэн хөрөнгөнд цаашдын оролцоотой эсэхийг тодорхойлохдоо тэрхүү хяналтанд буй байгууллагаас шилжүүлсэн санхүүгийн хөрөнгө дэх өөрийн цаашдын оролцоог (эсвэл тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын өөр бусад гишүүний оролцоог) харгалзан тусгана.

МЗУ32. Шилжүүлэлтийн нэг хэсэг болгон, байгууллага нь уг шилжүүлсэн санхүүгийн хөрөнгөнд үгийн агуулагдах, гэрээний аливаа эрх буюу үүргийг хадгалан үлддэггүй, мөн тэрхүү шилжүүлсэн санхүүгийн хөрөнгөтэй холбоотойгоор шинэ гэрээний аливаа эрх буюу үүргийг хүлээн авдаггүй бол тухайн байгууллага нь шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийн хувьд цаашдын оролцоогүй байна. Хэрэв байгууллага нь шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийн ирээдүйн үр дүнд хувь оролцоогүй, мөн уг шилжүүлсэн хөрөнгийн хувьд аливаа нөхцөл байдалд ирээдүйд төлбөр төлөх үүрэг хариуцлагагүй бол тухайн байгууллага нь шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийн хувьд цаашдын оролцоогүй байна. Энэ текстэнд дурдсан, “төлбөр” гэдэг нэр томъёонд байгууллага цуглуулан авч, тухайн шилжүүлэн авагчид шилжүүлэх ёстой, уг шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээ хамаарахгүй юм.

МЗУ32А. Байгууллага нь санхүүгийн хөрөнгийг шилжүүлсэн тохиолдолд тухайн байгууллага нь тухайлбал, үйлчилгээний гэрээнд заасан төлбөртэйгээр уг санхүүгийн хөрөнгөнд үйлчилгээ үзүүлэх эрхийг хадгалан үлдэж болох юм. Байгууллага нь үйлчилгээний гэрээний үр дүнд уг шилжүүлсэн хөрөнгөнд цаашдын оролцоотой байгаа эсэхээ тодруулгын шаардлагын зорилгоор тогтоохын тулд 49В ба МЗУ32-р параграфт заасан заавар удирдамжийн дагуу тухайн үйлчилгээний гэрээг үнэлнэ. Тухайлбал; үйлчилгээний хураамж нь шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээний дүн буюу хугацаанаас хамаардаг бол үйлчилгээ үзүүлэгч нь тодруулгын шаардлагын зорилгын хувьд уг шилжүүлсэн санхүүгийн хөрөнгөнд цаашдын оролцоотой байна. Үүнтэй адилаар, тогтмол үйлчилгээний хураамжийг уг шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийн үр дүнгүй байдлын улмаас бүрэн төлдөггүй бол тухайн үйлчилгээ үзүүлэгч нь тодруулгын шаардлагын зорилгын хувьд тэрхүү шилжүүлсэн хөрөнгөнд цаашдын оролцоотой байна. Эдгээр жишээнд, үйлчилгээ үзүүлэгч нь уг шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийн ирээдүйн үр дүнгээс хамаарах хувь оролцоотой байна. Хүлээн авах үйлчилгээний хураамж нь уг үйлчилгээг үзүүлсний төлөө байгууллагад зохих нөхөн төлбөр болох эсэхээс энэхүү үнэлгээ хамааралгүй байдаг.

МЗУ33. Шилжүүлсэн санхүүгийн хөрөнгө дэх цаашдын оролцоо нь уг шилжүүлэлттэй холбоотойгоор шилжүүлэн авагчтай эсвэл гуравдагч талтай байгуулсан тухайн хөрөнгө шилжүүлэх гэрээ буюу тусдаа гэрээний нөхцлүүдээс үүсдэг байж болох юм.

Бүхэлд нь үл хүлээн зөвшөөрөөгүй байгаа, шилжүүлсэн санхүүгийн хөрөнгө (49Г параграф)

МЗУ34. Шилжүүлсэн бүх буюу зарим санхүүгийн хөрөнгө нь үл хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангахгүй тохиолдолд тодруулга хийхийг 49Г параграфтаар шаардсан байдаг. Шилжүүлэлтийг хэзээ хийсэн эсэхээс үл хамааран байгууллага нь уг шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа тайлант үе бүрийн эцэст эдгээр тодруулгыг хийх шаардлагатай.

Цаашдын оролцооны төрлүүд (49Д–49И параграф)

МЗУ35. 49Д-49И параграф нь үл хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгө дэх цаашдын оролцооны төрөл тус бүрийн хувьд чанарын болон тоон шинжтэй тодруулга хийхийг шаарддаг. Байгууллага нь өөрт учрах эрсдлийг төлөөлөн илэрхийлэх төрлүүдээр цаашдын оролцоог нэгтгэн тусгадаг. Тухайлбал; байгууллага нь өөрийн цаашдын оролцоог санхүүгийн хэрэглүүрийн төрлөөр (жишээлбэл; баталгаа болон дуудах опцион) эсвэл шилжүүлэлтийн төрлөөр (жишээлбэл; авлагын факторинг, үнэт цаасжуулалт, үнэт цаасны зээлдүүлэлт) нэгтгэж болно.

Шилжүүлсэн хөрөнгийг буцаан худалдан авах дискаунтчлаагүй мөнгөн зарлагын дуусгавар болох хугацааны задаргаа шинжилгээ (49Д(д) параграф)

МЗУ36. 49Д(д) параграф нь үл хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгийг буцаан худалдан авахад шаардагдах дискаунтчлаагүй мөнгөн зарлага болон уг шилжүүлсэн хөрөнгийн хувьд шилжүүлэн авагчид төлөх бусад өглөгийн дуусгавар болох хугацааны задаргаа шинжилгээг тодруулах, үүнд тухайн байгууллагын цаашдын оролцооны хувьд гэрээний дуусгавар болох үлдсэн хугацааг харуулахыг байгууллагаас шаарддаг. Энэхүү задаргаа шинжилгээ нь төлөх шаардлагатай мөнгөн гүйлгээ (жишээлбэл; форвард гэрээ), төлөхийг байгууллагаас шаардаж болох мөнгөн гүйлгээ (жишээлбэл; гаргасан буцаах опцион), төлөхөөр байгууллага сонгож болох мөнгөн гүйлгээг (жишээлбэл; худалдан авсан дуудах опцион) ялган харуулдаг.

МЗУ37. 49Д(д) параграфтаар шаардсан, дуусгавар болох хугацааны задаргаа шинжилгээг бэлтгэхдээ, байгууллага нь хугацааны мужийн тохиромжтой тоог тодорхойлохын тулд өөрийн шүүн тунгaalтыг ашигладаг. Жишээлбэл; байгууллага нь дараах хугацааны мужийг тохиромжтой гэж тодорхойлж болох юм:

- (а) нэг сараас хэтрэхгүй;
- (б) нэг сараас илүү боловч гурван сараас хэтрэхгүй;
- (в) гурван сараас илүү боловч зургаан сараас хэтрэхгүй;
- (г) зургаан сараас илүү боловч нэг жилээс хэтрэхгүй;
- (д) нэг жилээс илүү боловч гурван жилээс хэтрэхгүй;
- (е) гурван жилээс илүү боловч таван жилээс хэтрэхгүй;
- (ж) таван жилээс дээш.

МЗУ38. Хэрэв дуусгавар болох боломжит хугацаа нь тодорхой үргэлжлэл буюу мужтай бол төлбөр төлөхийг байгууллагаас шаардах буюу түүнд зөвшөөрч болох хамгийн эхний өдөрт үндэслэн тухайн мөнгөн гүйлгээг тусган оруулдаг.

Чанарын шинжтэй мэдээлэл (49Д(е) параграф)

МЗУ39. 49Д(е) параграфтаар шаардсан чанарын шинжтэй мэдээлэл нь тухайн үл хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгө, тэдгээр хөрөнгийг шилжүүлсний дараа хадгалан үлдсэн цаашдын оролцооны шинж төрөл ба зорилгын талаархи тайлбар тодорхойлолтыг агуулсан байдаг. Энэ нь байгууллагад учрах эрсдлийн талаархи тайлбар тодорхойлолтыг бас агуулдаг, үүнд:

- (а) Үл хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгө дэх өөрийн цаашдын оролцоонд угаасаа байдаг эрсдлийг байгууллага хэрхэн удирдан зохицуулдаг талаархи тайлбар тодорхойлолт.

- (б) Байгууллага нь бусад талуудаас түрүүлж гарзыг хариуцах шаардлагатай эсэх, уг хөрөнгөн дэх тухайн байгууллагын хувь оролцооноос (өөрөөр хэлбэл, уг хөрөнгөн дэх түүний цаашдын оролцооноос) бага хувь оролцоотой талуудын зүгээс гарзыг хариуцах дараалал ба дүн.
- (в) Санхүүгийн дэмжлэг үзүүлэх эсвэл шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийг буцаан худалдан авах үүрэгтэй холбоотой аливаа хүчин зүйлсийн тайлбар тодорхойлолт.

Үл хүлээн зөвшөөрөлтийн олз, гарз (49Ж(а) параграф)

МЗУ40. 49Ж(а) параграф нь тухайн байгууллага цаашид оролцоотой байх санхүүгийн хөрөнгөтэй холбоотой үл хүлээн зөвшөөрөлтийн олз, гарзыг тодруулахыг уг байгууллагаас шаарддаг. Өмнө хүлээн зөвшөөрсөн хөрөнгийн бүрэлдэхүүн хэсгүүдийн (өөрөөр хэлбэл, үл хүлээн зөвшөөрсөн хөрөнгө дэх хувь оролцоо ба байгууллагын хадгалан үлдсэн хувь оролцооны) бодит үнэ цэнэ нь тэрхүү өмнө бүхэлд нь хүлээн зөвшөөрсөн хөрөнгийн бодит үнэ цэнээс өөр байсны улмаас үл хүлээн зөвшөөрөлтийн олз, гарз үүссэн бол байгууллага нь үүнийг тодруулна. Энэ тохиолдолд, 32-р параграфт заасанчлан, зах зээлийн ажиглаж болох мэдээнд үндэслэсэн, чухал орцуудыг уг бодит үнэ цэнийн хэмжилтэнд тусган оруулсан эсэхийг байгууллага мөн тодруулна.

Нэмэлт мэдээлэл (49И параграф)

МЗУ41. 49Г-49Ж параграфтаар шаардсан тодруулга нь 49Б параграфт дурдсан тодруулгын зорилгыг ханган биелүүлэхэд хангалтгүй байж болох юм. Ийм тохиолдолд байгууллага нь уг тодруулгын зорилгыг хангахад шаардлагатай аливаа нэмэлт мэдээллийг тодруулна. Байгууллага нь хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээг хангахын тулд хэр их нэмэлт мэдээллээр хангах шаардлагатай ба уг нэмэлт мэдээллийн янз бүрийн төлөв байдлуудад хэр их ач холбогдол өгөх эсэхийг өөрийн нөхцөл байдлыг харгалзан шийдвэрлэнэ. Санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд ач тусгүй байж болох хэт дэлгэрэнгүй мэдээллээр санхүүгийн тайланг дүүргэх ба хэт хураангуйлан нэгтгэснээр чухал мэдээллийг бүрхэгдүүлэхийн хоорондох зохистой тэнцвэрийг олох шаардлагатай юм.

...

Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийг харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах (17А-17Е параграф)

Цар хүрээ (17А параграф)

МЗУ42. УСББОУС 28-ын 47-р параграфын дагуу харилцан суутгаж, цэвэр дүнг гаргадаг, хүлээн зөвшөөрсөн бүх санхүүгийн хэрэглүүрийн хувьд 17Б-17Д параграфт заасан тодруулгыг хийх шаардлагатай. Түүнчлэн, УСНББОУС 28-ын 47-р параграфын дагуу санхүүгийн хэрэглүүрүүдийг харилцан суутгаж, цэвэр дүнг гаргадаг эсэхээс үл хамааран тухайн санхүүгийн хэрэглүүр нь ижил төсөөтэй санхүүгийн хэрэглүүр ба ажил гүйлгээг агуулсан, хууль ёсоор хүчин төгөлдөр болох, “цэвэр дүнгээр тооцох мастер хэлцэл” буюу түүнтэй адилтгах хэлцлийн зүйл болдог бол тэрхүү санхүүгийн хэрэглүүр нь 17Б-17Д параграфт заасан тодруулгын шаардлагуудын цар хүрээнд хамаарна.

МЗУ43. 17А, МЗУ31-р параграфт дурдсан, ижил төсөөтэй хэлцэл гэдэгт үүсмэл клирингийн хэлцэл, буцаан худалдан авах глобал мастер хэлцэл, үнэт цаас зээлдүүлэх глобал мастер хэлцэл, санхүүгийн барьцааны аливаа холбогдох эрх хамаардаг. МЗУ31-р параграфт дурдсан, ижил төсөөтэй санхүүгийн хэрэглүүр ба ажил гүйлгээ гэдэгт үүсмэл хэрэглүүр, борлуулах ба буцаан худалдан авах хэлцэл, сөрөг борлуулах ба буцаан худалдан авах хэлцэл, үнэт цаас зээлдэн авах ба үнэт цаас зээлдүүлэх хэлцэл хамаарна. 17А параграфын цар хүрээнд хамаарахгүй санхүүгийн хэрэглүүрийн жишээ нь: худалдан авагчийн нэг санхүүгийн байгууллагаас авсан зээл ба түүнд байршуулсан урьдчилгаа төлбөр (тэдгээрийг санхүүгийн байдлын тайланд харилцан суутгаж, цэвэр дүнгээр тусгаснаас бусад тохиолдолд), зөвхөн барьцааны гэрээний зүйл болох санхүүгийн хэрэглүүр юм.

17А параграфын цар хүрээнд хамаарах хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгө ба хүлээн зөвшөөрсөн санхүүгийн өр төлбөрийн талаархи тоон мэдээллийн тодруулга (17В параграф)

МЗУ44. 17В параграфын дагуу тодруулсан санхүүгийн хэрэглүүр нь хэмжилтийн өөр өөр шаардлагуудад хамаардаг байж болно (жишээлбэл; үүсмэл хэрэглүүрийг бодиг үнэ цэнээр хэмжих боловч буцаан худалдан авах хэлцэлтэй холбоотой өглөгийг хорогдуулсан өртгөөр хэмжиж болох юм). Байгууллага нь хэрэглүүрүүдийг тэдгээрийн хүлээн зөвшөөрсөн дүнгээр тусган оруулах ба хэмжилтийн аливаа үр дүнгийн зөрүүг холбогдох тодруулгад тайлбарлана.

17А параграфын цар хүрээнд хамаарах хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгө ба хүлээн зөвшөөрсөн санхүүгийн өр төлбөрийн нийт дүнгийн тодруулга (17В(а) параграф)

МЗУ45. 17В(а) параграфтаар шаардсан дүн нь УСНББОУС 28-ын 47-р параграфын дагуу харилцан суутгаж, цэвэр дүнг гаргадаг, хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн хэрэглүүртэй холбоотой байдаг. Хууль ёсоор хүчин төгөлдөр болох “цэвэр дүнгээр тооцох мастер хэлцэл” буюу түүнтэй адилтгах хэлцлийн зүйл болдог, тухайн хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хэрэглүүртэй уг 17В(а) параграфтаар шаардсан дүн нь бас холбоотой байдаг бөгөөд энэ нь тэдгээр санхүүгийн хэрэглүүр харилцан суутгах шалгуурыг хангах эсэхээс үл хамаарна. Гэвч 17В(а) параграфтаар шаардсан тодруулга нь УСНББОУС 28-ын 47-р параграфт заасан, харилцан суутгах шалгуурыг хангадаггүй барьцааны гэрээний үр дүнд хүлээн зөвшөөрсөн аливаа дүнтэй холбоогүй байна. Харин ийм дүнг 17В(г) параграфын дагуу тодруулах шаардлагатай байдаг.

УСНББОУС 28-ын 47-р параграфт заасан шалгуурын дагуу харилцан суутгадаг дүнгүүдийн тодруулга (17В(б) параграф)

МЗУ46. Санхүүгийн байдлын тайланд толилуулах цэвэр дүнг байгууллага тодорхойлохдоо, УСНББОУС 28-ын 47-р параграфын дагуу харилцан суутгадаг дүнгүүдийг тодруулахыг 17В(б) параграфтаар шаардсан байдаг. Нэг хэлцлийн дагуу хийгдэх харилцан суутгалд хамаарах уг хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгө ба хүлээн зөвшөөрсөн санхүүгийн өр төлбөрийн аль алины дүнг тухайн санхүүгийн хөрөнгийн болон санхүүгийн өр төлбөрийн тодруулгын аль алинд тусгана. Гэвч тухайн тодруулсан (жишээлбэл; хүснэгтээр харуулсан) дүн нь харилцан суутгалд хамаарах дүнгүүдээр хязгаарлагдана. Тухайлбал; байгууллага нь УСНББОУС 28-ын 47-р параграфт заасан, харилцан суутгалын шалгуурыг хангах, хүлээн зөвшөөрсөн үүсмэл хөрөнгө ба хүлээн зөвшөөрсөн үүсмэл өр төлбөртэй байж болох юм. Хэрэв үүсмэл хөрөнгийн нийт дүн нь үүсмэл өр төлбөрийн нийт дүнгээс их бол уг санхүүгийн хөрөнгийн тодруулгын хүснэгт нь тэрхүү үүсмэл хөрөнгийн нийт дүн (17В(а) параграфт заасан) ба үүсмэл өр төлбөрийн нийт дүнг (17В(б) параграфт заасан) тусгасан байна. Харин санхүүгийн өр төлбөрийн тодруулгын хүснэгт нь уг үүсмэл өр төлбөрийн нийт дүнг (17В(а) параграфт заасан) тусгах боловч тэрхүү үүсмэл өр төлбөрийн дүнтэй зөвхөн тэнцүү хэмжээний үүсмэл хөрөнгийн дүнг (17В(б) параграфт заасан) агуулсан байна.

Санхүүгийн байдлын тайланд толилуулсан цэвэр дүнгийн тодруулга (17В(в) параграф)

МЗУ47. Хэрэв байгууллага нь эдгээр тодруулгын цар хүрээнд хамаарах (17А параграфт тусгайлан заасан) боловч УСНББОУС 28-ын 47-р параграфт заасан, харилцан суутгах шалгуурыг хангахгүй хэрэглүүртэй бол 17В(в) параграфтаар тодруулахыг шаардсан дүн нь 17В(а) параграфтаар тодруулахаар шаардсан дүнтэй тэнцүү байна.

МЗУ48. 17В(в) параграфтаар тодруулахыг шаардсан дүнгүүдийг санхүүгийн байдлын тайланд толилуулсан, мөрийн зүйлс бүрийн дүнгүүдтэй тохируулах ёстой. Жишээлбэл; санхүүгийн тайлангийн мөрийн зүйлс бүрийн дүнгүүдийн нэгтгэн нийлүүлэлт эсвэл салган тусгаарлалт нь илүү хамааралтай мэдээллээр хангана гэж байгууллага тодорхойлсон бол тухайн байгууллага нь 17В(в) параграфт тодруулсан, нэгтгэн нийлүүлсэн эсвэл салган тусгаарласан дүнгүүдийг уг санхүүгийн байдлын тайланд толилуулсан мөрийн зүйлс бүрийн дүнгүүдтэй эргээд тохируулах ёстой.

Хууль ёсоор хүчин төгөлдөр болох “цэвэр дүнгээр тооцох мастер хэлцэл” буюу түүнтэй ижил төсөөтэй хэлцлийн зүйл болдог бөгөөд 17В(б) параграфын шаардлагад хамаарахгүй дүнгүүдийн тодруулга (17В(г) параграф)

МЗУ49. Хууль ёсоор хүчин төгөлдөр болох “цэвэр дүнгээр тооцох мастер хэлцэл” буюу түүнтэй адилтгах хэлцлийн зүйл болдог бөгөөд 17В(б) параграфын шаардлагад хамаарахгүй дүнгүүдийг тодруулахыг байгууллагаас 17В(г) параграфтаар шаардсан байдаг. 17В(г)(i) параграф нь УСНББОУС 28-ын 47-р параграфт заасан, харилцан суутгах бүх буюу зарим шалгуурыг хангадаггүй (тухайлбал; УСНББОУС 28-ын 47(б) параграфт заасан шалгуурыг хангадаггүй, харилцан суутгах одоогийн эрх, эсвэл зөвхөн үл биелүүлэлт үүссэн эсвэл оролцогч талуудын аль нэг нь төлбөрийн чадваргүй болсон буюу дампуурсан үед зөвхөн хууль ёсоор хүчин төгөлдөр болох ба хэрэгжих, харилцан суутгах нөхцөлт эрх), хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хэрэглүүртэй холбоотой дүнгүүдэд хамаарах юм.

МЗУ50. 17В(г)(ii) параграф нь хүлээн авсан ба өгсөн санхүүгийн барьцаа, үүн дотроо мөнгөн барьцаатай холбоотой дүнгүүдэд хамаардаг. Байгууллага нь барьцаа болгон хүлээн авсан буюу өгсөн санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнийг тодруулна. 17В(г)(ii) параграфын дагуу тодруулсан дүн нь бодитойгоор хүлээн авсан буюу өгсөн барьцаатай холбоотой бөгөөд ийм барьцааг буцаан авах буюу өгөхийн тулд хүлээн зөвшөөрсөн аливаа үр дүнгийн авлага эсвэл өглөгт хамаарахгүй.

17В(г) параграфын дагуу тодруулах дүнгүүдийн хязгаарлалт (17Г параграф)

МЗУ51. 17В(г) параграфын дагуу дүнгүүдийг тодруулахдаа, байгууллага нь илүүдэл барьцааны үр нөлөөг санхүүгийн хэрэглүүр бүрээр харгалзан үзэх шаардлагатай. Ингэхийн тулд байгууллага нь эхлээд 17В(в) параграфын дагуу тодруулсан дүнгээс 17В(г)(i) параграфын дагуу тодруулсан дүнг хасах ёстой. Үүний дараа байгууллага нь 17В(г)(ii) параграфын дагуу тодруулсан дүнг холбогдох санхүүгийн хэрэглүүрийн хувьд 17В(в) параграфын дагуу тодорхойлсон, үлдсэн дүнгээр хязгаарлана. Гэхдээ барьцааны эрхийг санхүүгийн хэрэглүүрээр хуваарилах боломжтой бол ийм эрхийг 17Г параграфын дагуу бэлтгэх тодруулгад тусгаж болох юм.

Хууль ёсоор хүчин төгөлдөр болох “цэвэр дүнгээр тооцох мастер хэлцэл” болон түүнтэй ижил төсөөтэй хэлцлийн зүйл болох харилцан суутгах эрхүүдийн тайлбар тодорхойлолт (17Д параграф)

МЗУ52. Байгууллага нь 17В(г) параграфын дагуу тодруулсан, харилцан суутгах эрхийн болон түүнтэй ижил төсөөтэй хэлцлүүдийн төрлийг, үүн дотроо тэдгээр эрхийн шинж төрлийг тодорхойлно. Тухайлбал; байгууллага нь өөрийн нөхцөлт эрхүүдийг тодорхойлдог. Ирээдүйн үйл явдлаас болзошгүй байдлаар хамаарахгүй боловч УСНББОУС 28-ын 47-р параграфт заасан, бусад үлдсэн шалгуурыг хангахгүй, харилцан суутгах эрхэд хамаарах санхүүгийн хэрэглүүрүүдийн хувьд, байгууллага нь уг шалгуурыг хангагдаагүй шалтгааныг тодорхойлон тайлбарлана. Хүлээн авсан буюу өгсөн аливаа санхүүгийн барьцааны хувьд байгууллага нь уг барьцааны гэрээний нөхцлүүдийг (жишээлбэл; барьцааг хязгаарласан тохиолдолд) тодорхойлно.

Санхүүгийн хэрэглүүрийн төрлөөр эсвэл оролцогч нөгөө талаар хийх тодруулга

МЗУ53. 17В(а)-(д) параграфтаар шаардсан тоон тодруулгыг санхүүгийн хэрэглүүрийн болон ажил гүйлгээний төрлөөр (жишээлбэл; үүсмэл хэрэглүүр, буцаан худалдан авах ба сөрөг буцаан худалдан авах хэлцэл, үнэт цаасны зээл авах ба үнэт цаас зээлдүүлэх хэлцэл) бүлэглэж болох юм.

МЗУ54. Үүнтэй адилаар, байгууллага нь 17В(а)-(в) параграфтаар шаардсан тоон тодруулгыг санхүүгийн хэрэглүүрийн төрлөөр, 17В(в)-(д) параграфтаар шаардсан тоон тодруулгыг оролцогч нөгөө талаар бүлэглэж болно. Хэрэв байгууллага нь шаардлагатай мэдээллийг оролцогч нөгөө талаар бүлэглэн бэлтгэдэг бол тухайн байгууллага нь оролцогч нөгөө талуудыг тэдний нэрээр тодорхойлох шаардлагагүй юм. Харин тухайн толилуулсан жилүүдийн хувьд зэрэгцүүлэгдэх байдлыг хадгалахын тулд оролцогч нөгөө талуудын тодорхойлолт (Оролцогч тал А, Оролцогч тал Б, Оролцогч тал В гэх мэт) нь нэг жилээс дараагийн жилд тууштай байвал зохино. Оролцогч

нөгөө талуудын төрлийн талаархи нэмэлт мэдээллээр хангахын тулд чанарын шинжтэй тодруулгыг харгалзан үздэг. 17В(в)-(д) параграфтаар шаардсан дүнгийн тодруулгыг оролцогч нөгөө талаар бүлэглэн бэлтгэх тохиолдолд оролцогч нөгөө талын нийт дүнгийн хувьд тус бүрдээ мэдэгдэхүйц нөлөөтэй байх дүнгүүдийг тусад нь тодруулна, тус бүрдээ мэдэгдэхүйц нөлөөгүй оролцогч нөгөө талын үлдсэн дүнгүүдийг нэг мөрийн зүйлд нэгтгэж харуулна.

Бусад

МЗУ55. 17В-17Д параграфтаар шаардсан тусгай тодруулга нь хамгийн наад захын шаардлагууд юм. 17Б параграфт дурдсан зорилгыг ханган биелүүлэхийн тулд байгууллага нь хууль ёсоор хүчин төгөлдөр болох “цэвэр дүнгээр тооцох мастер хэлцэл” болон холбогдох хэлцлүүдийн нөхцөл, үүн дотроо харилцан суутгах эрхийн шинж төрөл, уг байгууллагын санхүүгийн байдалд тэдгээрийн үзүүлэх үр нөлөө буюу боломжит үр нөлөөнөөс хамааран нэмэгдэл (чанарын шинжтэй) тодруулгаар тэдгээрийг гүйцээн баяжуулах шаардлагатай байж болох юм.

...

Хэрэгжүүлэх заавар удирдамж

Энэхүү заавар удирдамж нь УСНББОУС 30-ыг дагалдах боловч түүний салигүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

...

Материаллаг байдал

ХЗУ3.— Хэрэв мэдээлэл материаллаг биш бол УСНББОУС-ын тодруулгын тусгай шаардлагын биелүүлэх албагүй юм гэж УСНББОУС 1-д тэмдэглэсэн байдаг. УСНББОУС 1 нь материаллаг байдлыг дараах байдлаар тодорхойлсон:

Тухайн зүйлийн орхигдуулалт буюу буруу илэрхийлэлт нь уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн шийдвэр, хяналт үнэлгээнд дангаараа эсвэл хамтдаа нөлөө үзүүлж чадахаар байвал түүнийг материаллаг гэж үзнэ. Материаллаг байдал нь тухайн нөхцөл байдлын хүрээнд шүүн тунгаах уг орхигдуулалт буюу буруу илэрхийлэлтийн шинж төрөл ба хэмжээнээс хамаардаг. Тухайн зүйлийн хэмжээ эсвэл шинж төрөл нь, эсвэл хоёулаа нэгдсэн байдлаараа тодорхойлогч хүчин зүйл байж болох юм.

ХЗУ4.— Мөн УСНББОУС 1-д уг тодорхойлолтыг дараах байдлаар тайлбарласан:

Орхигдуулалт эсвэл буруу илэрхийлэлт нь хэрэглэгчдийн шийдвэрт нөлөөлж чадах, иймээс материаллаг байх эсэхийг үнэлэхдээ тухайн хэрэглэгчдийн шинж төрлийг харгалзан үзэх шаардлагатай. Хэрэглэгчид нь улсын сектор, эдийн засгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн талаар зохих мэдлэгтэй бөгөөд тэд мэдээллийг ул үндэслэлтэй хянамгай байдлаар судлан мэдэх хүсэл эрмэлзэлтэй байдаг гэж төсөөлдөг. Тиймээс, ийм төлөв шинж бүхий хэрэглэгчдийн шийдвэрийн үнэлгээ болон гаргалтанд хэрхэн нөлөө үзүүлэхээр ул үндэслэлтэйгээр хүлээгдэж болохыг уг үнэлэлтэнд харгалзан үзэх шаардлагатай.

...

Санхүүгийн байдал ба санхүүгийн үр дүнд санхүүгийн хэрэглүүрийн үзүүлэх ач холбогдол (10-36-р параграф ба МЗУ4, МЗУ5-р параграф)⁴

Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжэсэн санхүүгийн ор толбор (13(a)(i) параграф ба МЗУ4-р параграф)

⁴ УСНББОУС 41, *Санхүүгийн Хэрэглүүр*-ийн үр дүнд УСНББОУС 30-ийн МЗУ4-р параграфыг хассан.

- X3Y7. Байгууллага нь энэхүү Стандартын Хавсралт А-гийн МЗУ4-р параграфын дагуу гүйцэтгэж болох тооцооллыг дараах жишээнд үлгэрчлэн харуулан.
- X3Y8. 20X1 оны 01 дүгээр сарын 01-нд байгууллага нь 150,000 ТН⁵-ийн нэрлэсэн үнэтэй, 10 жилийн хугацаатай, жилийн 8 хувийн купоны тогтмол хүүтэй гаргасан бөгөөд хүүний түвшин нь ижил төсөөтэй шинж чанар бүхий бондуудын зах зээлийн хүүний түвшинтэй нийцэж байна.
- X3Y9. Байгууллага нь Лондонгийн Банк Хоорондын Санал Болгосон Хүү (LIBOR ЛАЙБОР) г-оорийн ажиглаж болох (бенчмарк) хүүний түвшин болгон ашигласан. Бондын үүсээн өдрөөр ЛАЙБОР нь 5 хувь байсан. Эхний жилийн эцэст:
- (а) — ЛАЙБОР нь 4.75 хувь болж буурсан.
- (б) — Бондын бодит үнэ цэнэ нь 153,811 ТН буюу 7.6 хувийн хүүтэй адилтгах дүнтэй байсан.⁶
- X3Y10. Хүүний түвшний бүх оорчлолт нь огоожийн муруйн харгалзах оорчлолтийн үр дүн байх жигд огоожийн муруйтай бөгөөд зах зээлийн нохцол байдлын цорын ганц холбогдох оорчлолт нь ЛАЙБОР-ын оорчлолт байна гэж уг байгууллага дүгнэсэн.
- X3Y11. Байгууллага нь зах зээлийн нохцол байдлын оорчлолтонд хамааруулж болохгүй бөгөөд зах зээлийн эредэл үүсэхэд хүргэх уг бондын бодит үнэ цэнийн оорчлолтийн дүнг дараах байдлаар тооцоолсон:

<p>[МЗУ4(а) параграф]</p> <p>Эхлээд, байгууллага нь тухайн тайлант үеийн эхэн дэх ор төлбөрийн ажигласан зах зээлийн үнэ ба ор төлбөрийн гэрээний мөнгөн гүйлгээг ашиглан тэрхүү тайлант үеийн эхний байдлаар ор төлбөрийн огоожийн дотоод хувийг тооцоолно.</p> <p>Тус байгууллага нь огоожийн дотоод хувийн уг хэрэглүүрт хамаарах тусгай бүрэлдэхүүн хэсгийг гаргахын тулд энэхүү огоожийн дотоод хувиас тухайн тайлант үеийн эхэн дэх тэрхүү ажигласан (бенчмарк) хүүний түвшинг хасна.</p>	<p>10 жилийн хугацаатай, 8 хувийн купоны хүүтэй бондын тухайн тайлант үеийн эхэн дэх огоожийн дотоод хувь нь 8 хувь байсан.</p> <p>Ажигласан (бенчмарк) хүүний түвшин (ЛАЙБОР) нь 5 хувь учраас огоожийн дотоод хувийн уг хэрэглүүрт хамаарах тусгай бүрэлдэхүүн хэсэг нь 3 хувь байна.</p>
<p>[МЗУ4(б) параграф]</p> <p>Үүний дараа, байгууллага нь тухайн тайлант үеийн эцэс дэх ор төлбөрийн гэрээний мөнгөн гүйлгээ болон (i) тухайн тайлант үеийн эцэст ажигласан (бенчмарк) хүүний түвшин, ба (ii) дээрх (а)-д тодорхойлсон, огоожийн дотоод хувийн уг хэрэглүүрт хамаарах тусгай бүрэлдэхүүн хэсгийн нийлбэртэй тэнцүү байх дискаунтын хувийг ашигласнаар ор төлбөртэй холбоотой мөнгөн гүйлгээний оноогийн үнэ цэнийг тооцоолно.</p>	<p>Тухайн тайлант үеийн эцэст уг хэрэглүүрийн гэрээний мөнгөн гүйлгээ нь:</p> <ul style="list-style-type: none"> • Хүү: 2 10 дахь жил тус бүрийн хувьд жил бүр 12,000 ТН⁽⁶⁾ байна. • Үндсэн дүн: 10 жилийн дараа 150,000 ТН байна. <p>Иймээс бондын оноогийн үнэ цэнийг тооцоолоход ашиглах дискаунтын хувь нь 7.75 хувь байх бөгөөд энэ нь тайлант үеийн эцэс дэх 4.75 хувийн ЛАЙБОР хүүн дээр уг хэрэглүүрт хамаарах тусгай бүрэлдэхүүн хэсгийн 3 хувийг нэмсэн дүн юм.</p>

⁵ Энэхүү заавар удирдамжид мөнгөн дүнг “тооцооны нэгж (ТН)” гэж тэмдэглэсэн.

⁶ Энэ нь ЛАЙБОР 5 хувиас 4 хувь болсон оорчлолтийг илэрхийлэх бөгөөд зах зээлийн нохцол байдалд бусад холбогдох оорчлолт гараагүй тохиолдолд үүний 0.15 хувийн оорчлолт нь тухайн хэрэглүүрийн эзэлийн эредлийн оорчлолтийг тусгана гэж үзнэ.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

	Үүний үр дүнд оноогийн үнэ цэнэ нь 152,367 ТН ⁽⁶⁾ болно.
[МЗУ4(в) параграф]	Тайлант үеийн эцэст өр төлбөрийн зах зээлийн үнэ нь 153,811 ТН^(*) байна.
Тайлант үеийн эцэс дэх өр төлбөрийн ажигласан зах зээлийн үнэ ба дээрх МЗУ4(б) параграфын дагуу тодорхойлсон дүн хөөрөндөх зөрүү нь уг ажигласан (бенчмарк) хүүний түвшний өөрчлөлтөнд хамааруулж болохгүй бодит үнэ цэнийн өөрчлөлт юм. Энэ нь тодруулах дүн байна.	Иймээс байгууллага нь зах зээлийн эрдэл үүсгэх тухайн зах зээлийн ноцол байдлын өөрчлөлтөнд хамааруулж болохгүй уг бондын бодит үнэ цэнийн өөрчлөлт болох 1,444 ТН (153,811 ТН - 152,367 ТН) ийг тодруулна.
^(*) 150,000 ТН x 8% = 12,000 ТН	
⁽⁶⁾ ОҮЦ (PV) = [12,000 ТН x (1 - (1 + 0.0775) ⁻⁹) / 0.0775] + 150,000 ТН x (1 + 0.0775) ⁻⁹	
^(*) Зах зээлийн үнэ = [12,000 ТН x (1 - (1 + 0.076) ⁻⁹) / 0.076] + 150,000 ТН x (1 + 0.076) ⁻⁹	

...

Бодит үнэ цэнэ (31-34-р параграф)

ХЗУ14. Санхүүгийн байдлын тайланд хэмжиж тусгасан хөрөнгө, өр төлбөрийн хувьд бодит үнэ цэнийн хэмжилтийг ангилах бодит үнэ цэнийн шатлалын түвшингийн талаар тодруулга хийхийг УСНББОУС 30-аар шаарддаг. Өөр хэлбэр загвар илүү тохиромжтой байхаас бусад тохиолдолд хүснэгтэн хэлбэр ашиглахыг шаарддаг. 33(а) параграфыг даган мөрдөхийн тулд байгууллага нь хөрөнгийн хувьд дараах зүйлсийг тодруулж болно. (Зэрэгцүүлэгдэх мэдээллийн тодруулга хийхийг бас шаарддаг боловч энэ жишээнд тусган оруулаагүй болно.)

Бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгө				
Агуулга	20X2.12.31	Дараах мэдээллийг ашиглан тухайн тайлант үеийн эцэст бодит үнэ цэнийг хэмжих		
		Түвшин 1 Сая ТН	Түвшин 2 Сая ТН	Түвшин 3 Сая ТН
Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө				
Худалдаа арилжааны үнэт цаас	100	40	55	5
Худалдаа арилжааны үүсмэл хэрэглүүр	39	17	20	2
<u>Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн</u> Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө				
Өмчийн хөрөнгө оруулалт	75	30	40	5
Нийт дүн	214	87	115	12
Жич: Өр төлбөрийг үүнтэй ижил хүснэгтээр толилуулж болно.				

ХЗУ15. Аливаа мэдэгдэхүйц орц нь ажиглаж болох зах зээлийн мэдээнд (Түвшин 3) үндэслээгүй үнэлгээний арга зүйгээр тооцсон бодит үнэ цэнээр тухайн санхүүгийн тайланд хэмжсэн тэдгээр хөрөнгө, өр төлбөрийн хувьд эхний үлдэгдлээс эцсийн үлдэгдэл хүртэлх тохируулгын тайланг тодруулахыг УСНББОУС 30-аар шаардсан байдаг. Өөр хэлбэр загвар илүү тохиромжтой байхаас бусад тохиолдолд хүснэгтэн хэлбэр ашиглахыг шаарддаг. 33(б) параграфыг даган

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

мөрдөхийн тулд байгууллага нь хөрөнгийн хувьд дараах зүйлсийг тодруулж болно. (Зэрэгцүүлэгдэх мэдээллийн тодруулга хийхийг бас шаарддаг боловч энэ жишээнд тусган оруулаагүй болно.)

Түвшин 3-д үндэслэн бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгө				
Тайлант үеийн эцэс дэх бодит үнэ цэнийн хэмжилт				
	Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө		Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө	Дүн
	Худалдаа арилжааны үнэт цаас	Худалдаа арилжааны үүсмэл хэрэглүүр	Өмчийн хөрөнгө оруулалт	
	Сая ТН	Сая ТН	Сая ТН	Сая ТН
Эхний үлдэгдэл	6	5	4	15
Нийт олз, гарз				
Ашиг, алдагдалд	(2)	(2)	-	(4)
Цэвэр хөрөнгө/өмчид	-	-	(1)	(1)
Худалдан авалт	1	2	2	5
Гаргалт	-	-	-	-
Барагдуулалт	-	(1)	-	(1)
Түвшин 3-с гаргах шилжүүлэлт	-	(2)	-	(2)
Эцсийн үлдэгдэл	5	2	5	12
Тайлант үеийн эцэст эзэмшиж буй хөрөнгийн хувьд ашиг, алдагдалд тусгах тухайн тайлант үеийн нийт олз, гарз	(1)	(1)	-	(2)
(Жич: Өр төлбөрийг үүнтэй ижил хүснэгтээр толилуулж болно.)				
Тайлант үеийн ашиг, алдагдалд тусган оруулсан олз, гарзыг дараах байдлаар орлогод толилуулна:				
			Орлого	
Тайлант үеийн ашиг, алдагдалд тусган оруулсан нийт олз, гарз				(4)
Тухайн тайлант үеийн эцэст эзэмшиж буй хөрөнгийн хувьд ашиг, алдагдалд тусган оруулсан тайлант үеийн нийт олз, гарз				(2)
Жич: Өр төлбөрийг үүнтэй ижил хүснэгтээр толилуулж болно.				

ХЗУ16. Идэвхитэй зах зээлд арилжаалдаггүй санхүүгийн хэрэглүүрийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн бодит үнэ цэнийг УСНББОУС 41-ийн МЗУ151-р ~~УСНББОУС 29-ийн МЗУ108-р~~ параграфын дагуу тодорхойлдог. Гэвч анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа байгууллага нь ажиглаж болох зах зээлээс олж авч чадахгүй тоон мэдээг нэгтгэн гаргадаг үнэлгээний арга зүйг ашиглах тохиолдолд анхны хүлээн зөвшөөрөлтийн ажил гүйлгээний үнэ ба үнэлгээний арга

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

зүй ашиглан анх хүлээн зөвшөөрөх үед тодорхойлсон дүн хооронд зөрүү үүсэж болох юм. Ийм тохиолдолд зөрүүг УСНББОУС 41 ~~УСНББОУС 29~~ болон тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу дараагийн тайлант үеүдэд ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Ийм хүлээн зөвшөөрөлт нь үнийг тогтоохдоо тухайн зах зээлийн оролцогчдын харгалзан үзэх хүчин зүйлсийн (үүн дотроо, цаг хугацааны) өөрчлөлтийг тусгадаг (УСНББОУС 41-ийн МЗУ151-р ~~УСНББОУС 29-ийн МЗУ108-р~~ параграфыг үзнэ үү). Эдгээр тохиолдолд тодруулга хийхийг 33-р параграфтаар шаардсан байдаг. 34-р параграфыг даган мөрдөхийн тулд байгууллага нь дараах зүйлсийг тодруулж болох юм:

Танилцуулга		
<p>20X1 оны 01 дүгээр сарын 01-нд байгууллага нь идэвхитэй зах зээлд арилжаалдаггүй санхүүгийн хөрөнгийг 15 сая ТН-ээр худалдан авсан. Байгууллага нь ийм санхүүгийн хөрөнгийн зөвхөн нэг ангитай.</p> <p>15 сая ТН-ийн ажил гүйлгээний үнэ нь анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн бодит үнэ цэнэ юм.</p> <p>Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа, байгууллага нь уг санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоохын тулд үнэлгээний арга зүйг ашиглана. Энэхүү үнэлгээний арга зүй нь ажиглаж болох зах зээлийн мэдээнээс бусад хувьсагчдыг агуулсан байдаг.</p> <p>Анх хүлээн зөвшөөрөх үед уг үнэлгээний арга зүйг ашигласан бол 14 сая ТН бүхий дүнг гаргах байсан бөгөөд энэ нь бодит үнэ цэнээс 1 сая ТН-ээр зөрүүтэй байна.</p> <p>Байгууллага нь 20X1 оны 01 дүгээр сарын 01-нд 5 сая ТН-ийн зөрүүтэй байсан.</p>		
Шаардлагуудын даган мөрдөлт		
<p>Тухайн байгууллагын 20X2 оны тодруулгад дараах зүйлс хамаарна:</p> <p><i>Нягтлан бодох бүртгэлийн бодлого:</i></p> <p>Идэвхитэй зах зээлд арилжаалдаггүй санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тодорхойлохын тулд байгууллага нь дараах үнэлгээний арга зүйг ашигладаг: [үнэлгээний арга зүйн тайлбар тодорхойлолтыг энэ жишээнд тусган оруулаагүй болно]. Анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн бодит үнэ цэнэ (<u>УСНББОУС 41-д</u> УСНББОУС 29-д заасанчлан, энэ нь ихэвчлэн ажил гүйлгээний үнэ байдаг) ба үнэлгээний арга зүйг ашиглан анх хүлээн зөвшөөрөх үед тодорхойлсон дүн хооронд зөрүү үүсэж болох юм. Ийм аливаа зөрүүг [тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын тайлбар тодорхойлолт] тусгана.</p> <p><i>Санхүүгийн тайлангийн тодруулгад:</i></p> <p>Тодруулга Х-д авч хэлэлцсэнчлэн, байгууллага нь идэвхитэй зах зээлд арилждаггүй дараах санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнийг хэмжихийн тулд [үнэлгээний арга зүйн нэр]-г ашигладаг. Гэвч <u>УСНББОУС 41-д</u> УСНББОУС 29-д заасанчлан, хэрэглүүрийн үүсэх үеийн бодит үнэ цэнэ нь ерөнхийдөө ажил гүйлгээний үнэ байдаг. Хэрэв ажил гүйлгээний үнэ нь хэрэглүүрийг анх үүсэх үед үнэлгээний арга зүйг ашиглан тодорхойлсон дүнгээс өөр байвал тэрхүү зөрүүг [тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын тайлбар тодорхойлолт] тусгана.</p> <p>Ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх зөрүү нь дараах байдалтай байна:</p>		
	X2.12.31	X1.12.31
	Сая ТН	Сая ТН
Жилийн эхний үлдэгдэл	5.3	5.0
Шинэ ажил гүйлгээ	-	1.0
Тухайн жилийн туршид ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн дүн	(0.7)	(0.8)
Бусад нэмэгдэлт	-	0.2
Бусад бууралт	(0.1)	(0.1)
Жилийн эцсийн үлдэгдэл	4.5	5.3

...

Зээлийн чанар (43(в) параграф)

~~ХЗУ25. Байгууллага нь зээлийн эрэдэлтэй бөгөөд хугацаа онгороогүй, үнэ цэнэ буураагүй санхүүгийн хөрөнгийн зээлийн чанарын талаархи мэдээллийг тодруулахыг 43(в) параграфтаар шаардсан байдаг. Үүний тулд байгууллага нь дараах мэдээллийг тодруулж болох юм:~~

- ~~(а) Гаднын болон дотоодын зээлийн үнэлэмжийн системийг ашигласнаар хийх зээлийн эрэдлийн шинжилгээ;~~
- ~~(б) Оролцогч ногоо талын шинж төрөл;~~
- ~~(в) Оролцогч ногоо талын үл биелүүлэлтийн хувь хэмжээний талаархи түүхэн мэдээлэл; ба~~
- ~~(г) Зээлийн чанарыг үнэлэхэд ашигласан аливаа бусад мэдээлэл.~~

~~ХЗУ26. Зээлийн чанарыг удирдан зохицуулах ба хянан үнэлэхдээ байгууллага нь гаднын үнэлэмж зэрэглэлийг харгалзан үздэг тохиолдолд дараах зүйлсийн талаархи мэдээллийг тодруулж болно:~~

- ~~(а) Зээлийн гаднын зэрэглэл тус бүрд хамаарах зээлийн эрэдэл ортолтийн дүн;~~
- ~~(б) Түүний ашигласан зэрэглэл тогтоодог агентлагууд;~~
- ~~(в) Байгууллагын зэрэглэл тогтоосон ба зэрэглэл тогтоогоогүй зээлийн эрэдлийн дүн;~~
- ~~(г) Гаднын болон дотоодын зэрэглэлийн хоорондох уялдаа хөлбөө.~~

~~ХЗУ27. Зээлийн чанарыг удирдан зохицуулах ба хянан үнэлэхдээ байгууллага нь зээлийн дотоод зэрэглэлийг харгалзан үздэг тохиолдолд дараах зүйлсийн талаархи мэдээллийг тодруулж болно:~~

- ~~(а) Зээлийн дотоод зэрэглэлийн процесс;~~
- ~~(б) Зээлийн дотоод зэрэглэл тус бүрд хамаарах зээлийн эрэдэл ортолтийн дүн; ба~~
- ~~(в) Гаднын болон дотоодын зэрэглэлийн хоорондох уялдаа хөлбөө.~~

Хугацаа онгосон эсвэл үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгө (44 р параграф)

~~ХЗУ28. Оролцогч ногоо тал нь гэрээний дагуу төлөх ёстой хугацаа болсон төлбөрийг барагдуулаагүй тохиолдолд санхүүгийн хөрөнгийн хугацаа онгосон гэдэг. Жишээ болгон байгууллага нь хүүг еар бүр төлөхийг шаарддаг зээлийн гэрээг байгуулсан гэж үзье. Хэрэв дараагийн сарын эхний өдөр хүүг төлөөгүй бол уг зээлийн хугацаа онгорно. Хугацаа онгөрөлт гэдэг нь ногоо тал хэзээ ч төлөхгүй гэсэн үг биш бөгөөд дахин хэлэлцэн төхирөлцөх, гэрээг албадан хэрэгжүүлэх, хуулийн ажиллагаа явуулах гэх мэт янз бүрийн арга хэмжээг эхлүүлж болно.~~

~~ХЗУ29. Хугацаа онгосон гэж ангилсан санхүүгийн хөрөнгийн нөхцөл, болзлыг дахин хэлэлцэн төхирөлцсөн тохиолдолд тухайн санхүүгийн хөрөнгийн хугацаа онгосон хэвээр байгаа эсэхийг тодорхойлохдоо шинэ гэрээний төхирөлцооны нөхцөл, болзлыг харгалзан үзнэ.~~

~~ХЗУ30. Хугацаа онгосон боловч үнэ цэнэ буураагүй санхүүгийн хөрөнгийн нажилтын ангиар шинжилгээ хийхийг 44(а) параграфтаар шаардсан байдаг. Байгууллага нь хугацааны мужийн төхирөмжтой тоог тодорхойлохын тулд өөрийн шүүн тунгаалтыг ашигладаг. Жишээлбэл; байгууллага нь дараах хугацааны мужийн төхирөмжтой гэж тодорхойлж болох юм:~~

- ~~(а) Гурван сараас хэтрэхгүй;~~
- ~~(б) Гурван сараас илүү боловч зургаан сараас хэтрэхгүй;~~

(в) — Зургаан сараас илүү бөлөвч нэг жилээс хэтрэхгүй;

(г) — Нэг жилээс дээш.

ХЗУ31. — Үнэ цэнэ буурсан санхүүгийн хоронгүүдийн ангиар шинжилгээ хийхийг 44(б) параграфтаар шаардсан байдаг. Ийм шинжилгээнд дараах зүйлс хамаарч болно:

(а) — Аливаа үнэ цэнийн бууралтын гарзыг хасахын өмнөх дансны дүн;

(б) — Аливаа холбогдох үнэ цэнийн бууралтын гарзын дүн; ба

(в) — Олж эзэмшсэн барьцаа болон эзэлийн бусад сайжруулалтын шинж төрөл ба бодит үнэ цэнэ.

Зах зээлийн эрсдэл (47-49-р параграф ба МЗУ19-МЗУ30-р параграф)

...

ХЗУ36. 47(а) параграфт заасан, тодруулгын шаардлагыг хэрхэн мөрдөхийг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан:

Хүүний түвшний эрсдэл

20X2 оны 12 дугаар сарын 31-нд хэрэв бусад бүх хувьсагч тогтмол байхад хүүний түвшин нь уг өдөр 10 суурь оноогоор бага байсан бол тухайн жилийн ашиг нь хувьсах хүүтэй зээлийн арай бага хүүний зардлаас үндсэндээ хамааран 1.7 сая ТН-ээр илүү (20X1 онд 2.4 сая ТН байсан); харин бусад орлого нь борлуулах боломжтой гэж ангилсан тогтмол хүүтэй санхүүгийн хоронгийн бодит үнэ цэнийн өсөлтөөс үндсэндээ хамааран 2.8 сая ТН-ээр илүү (20X1 онд 3.2 сая ТН байсан) байх байсан. Хэрэв бусад бүх хувьсагч тогтмол байхад хүүний түвшин нь 10 суурь оноогоор их байсан бол тухайн жилийн ашиг нь хувьсах хүүтэй зээлийн арай өндөр хүүний зардлаас үндсэндээ хамааран 1.5 сая ТН-ээр бага (20X1 онд 2.1 сая ТН байсан); харин бусад орлого нь борлуулах боломжтой гэж ангилсан тогтмол хүүтэй санхүүгийн хоронгийн бодит үнэ цэнийн өсөлтөөс үндсэндээ хамааран 3.0 сая ТН-ээр бага (20X1 онд 3.4 сая ТН байсан) байх байсан. Хязгаар тогтоосон хүүтэй зээлээс хамааран ашиг нь хүүний түвшний өсөлтөнд биш, харин хүүний түвшний бууралтанд илүү мэдрэмжтэй байна. Тухайн байгууллагын өрийн хугацаа дууссанаар төлөгдөөгүй зээлийн үлдэгдэл буурсаны үр дүнд мэдрэмж нь 20X1 онтой харьцуулахад 20X2 онд арай бага байна (Тодруулга Х-ыг үзнэ үү).^(a)

Гадаад валютын ханшийн эрсдэл

20X2 оны 12 дугаар сарын 31-нд хэрэв бусад бүх хувьсагч тогтмол байхад ТН-ийн ам доллартай харьцах ханш нь 10 хувиар суларсан бол тухайн жилийн ашиг нь 2.8 сая ТН-ээр бага (20X1 онд 6.4 сая ТН байсан), орлого нь 1.2 сая ТН-ээр их (20X1 онд 1.1 сая ТН байсан) болох байсан. Харин эсрэгээр, хэрэв бусад бүх хувьсагч тогтмол байхад ТН-ийн ам доллартай харьцах ханш нь 10 хувиар чангарсан бол тухайн жилийн ашиг нь 2.8 сая ТН-ээр их (20X1 онд 6.4 сая ТН байсан), орлого нь 1.2 сая ТН-ээр бага (20X1 онд 1.1 сая ТН байсан) болох байсан. 20X1 онтой харьцуулахад 20X2 оны ашиг дахь гадаад валютын ханшийн мэдрэмж бага байгаа нь гадаад валютаар илэрхийлэгдсэн өр буурсантай холбоотой юм. Гадаад валютаар илэрхийлэгдсэн өр буурснаар нөхөгдөх гадаад валютаар хийсэн худалдан авалтын хейжийн ашиглалт нэмэгдсэний улмаас орлого нь 20X1 онтой харьцуулахад 20X2 онд илүү мэдрэмжтэй байна.

^(a) Өр төлбөрийн дуусгавар болох хугацааны шинжилгээг тодруулахыг 46(а) параграфтаар шаардсан байдаг.

...

Үл хүлээн зөвшөөрөлт (49Г ба 49Д параграф)

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

ХЗУ41. 49Г ба 49Д параграфт заасан, тоон шинжтэй тодруулгын шаардлагуудыг хангах зарим боломжит арга замыг дараах жишээнд үлгэрчлэн харуулав.

ХЗУ42. УСНББОУС 41-ийг мөрддөг байгууллага нь 49Г ба 49Д параграфт заасан, тоон шинжтэй тодруулгын шаардлагуудыг хэрхэн хангаж болохыг дараах жишээнд үлгэрчлэн харуулав.

Бүхэлд нь үл хүлээн зөвшөөрөөгүй байгаа, шилжүүлсэн санхүүгийн хөрөнгө

49Г(г) ба (д) параграфын мөрдөлтийг үлгэрчлэн харуулах

	<u>Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө</u>		<u>Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө</u>		<u>Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө</u>
	<u>Сая ТН</u>		<u>Сая ТН</u>		<u>Сая ТН</u>
	<u>Худалдаа арилжааны хөрөнгө</u>	<u>Үүсмэл хэрэглүүр</u>	<u>Моргейжийн зээл</u>	<u>Хэрэглэгчийн зээл</u>	<u>Өмчийн хөрөнгө оруулалт</u>
<u>Хөрөнгийн дансны үнэ</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>
<u>Холбогдох өр төлбөрийн дансны үнэ</u>	<u>(X)</u>	<u>(X)</u>	<u>(X)</u>	<u>(X)</u>	<u>(X)</u>
<u>Зөвхөн шилжүүлсэн хөрөнгийн хувьд оролцох эрхтэй өр төлбөрийн хувьд:</u>					
<u>Хөрөнгийн бодит үнэ цэнэ</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>
<u>Холбогдох өр төлбөрийн бодит үнэ цэнэ</u>	<u>(X)</u>	<u>(X)</u>	<u>(X)</u>	<u>(X)</u>	<u>(X)</u>
<u>Цэвэр төлөв байдал</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>

Бүхэлд нь үл хүлээн зөвшөөрдөг, шилжүүлсэн санхүүгийн хөрөнгө

49Д(а)-(г) параграфын мөрдөлтийг үлгэрчлэн харуулах

<u>Шилжүүлсэн (үл хүлээн зөвшөөрсөн) хөрөнгийг буцаан худалдан авах мөнгөн зарлага</u>	<u>Санхүүгийн байдлын тайлан дахь уг цаашдын оролцооны дансны үнэ</u>	<u>Цаашдын оролцооны бодит үнэ цэнэ</u>	<u>Гарзын хамгийн их эрсдэл</u>
<u>Сая ТН</u>	<u>Сая ТН</u>	<u>Сая ТН</u>	<u>Сая ТН</u>

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

<u>Шилжүүлсэн (үл хүлээн зөвшөөрсөн) хөрөнгийг буцаан худалдан авах мөнгөн зарлага</u>	<u>Санхүүгийн байдлын тайлан дахь уг цаашдын оролцооны дансны үнэ</u>			<u>Цаашдын оролцооны бодит үнэ цэнэ</u>	<u>Гарзын хамгийн их эрсдэл</u>	
	<u>Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө</u>	<u>Цэвэр хөрөнгө/ өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө</u>	<u>Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөр</u>	<u>Хөрөнгө</u>	<u>Өр төлбөр</u>	
<u>Цаашдын оролцооны төрөл</u>						
<u>Гаргасан буцаах эрхтэй опцион</u>	(X)			(X)	(X)	X
<u>Худалдан авсан дуудах опцион</u>	(X)	X		X		X
<u>Үнэт цаасны зээллэг</u>	(X)			(X)	(X)	X
<u>Нийт дүн</u>		X		(X)	(X)	X

49Д(д) параграфын мөрдөлтийг үлгэрчлэн харуулах

<u>Шилжүүлсэн хөрөнгийг буцаан худалдан авах дискаунтчилсан мөнгөн гүйлгээ</u>								
<u>Цаашдын оролцооны төрөл</u>	<u>Цаашдын оролцооны дуусгавар болох хугацаа – Сая ТН</u>							
	<u>Бүгд</u>	<u>1 сараас бага</u>	<u>1–3 сар</u>	<u>3–6 сар</u>	<u>6 сараас 1 жил</u>	<u>1–3 жил</u>	<u>3–5 жил</u>	<u>5 жилээс дээш</u>
<u>Гаргасан буцаах эрхтэй опцион</u>	X		X	X	X	X		
<u>Худалдан авсан дуудах опцион</u>	X			X	X	X		X
<u>Үнэт цаасны зээллэг</u>	X	X	X					

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

ХЗУ43. УСНББОУС 41-ийг мөрддөггүй байгууллага нь 49Г ба 49Д параграфт заасан, тоон шинжтэй тодруулгын шаардлагуудыг хэрхэн хангаж болохыг дараах жишээнд үлгэрчлэн харуулав.

Бүхэлд нь үл хүлээн зөвшөөрөөгүй байгаа, шилжүүлсэн санхүүгийн хөрөнгө

49Г(г) ба (д) параграфын мөрдөлтийг үлгэрчлэн харуулах

	<u>Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө</u>		<u>Зээл ба авлага</u>		<u>Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө</u>
	<u>Сая ТН</u>		<u>Сая ТН</u>		<u>Сая ТН</u>
	<u>Худалдаа арилжааны үнэт цаас</u>	<u>Үүсмэл хэрэглүүр</u>	<u>Моргейжийн зээл</u>	<u>Хэрэглэгчийн зээл</u>	<u>Өмчийн хөрөнгө оруулалт</u>
<u>Хөрөнгийн дансны үнэ</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>
<u>Холбогдох өр төлбөрийн дансны үнэ</u>	<u>(X)</u>	<u>(X)</u>	<u>(X)</u>	<u>(X)</u>	<u>(X)</u>
<hr/>					
<u>Зөвхөн шилжүүлсэн хөрөнгийн хувьд оролцох эрхтэй өр төлбөрийн хувьд:</u>					
<u>Хөрөнгийн бодит үнэ цэнэ</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>
<u>Холбогдох өр төлбөрийн бодит үнэ цэнэ</u>	<u>(X)</u>	<u>(X)</u>	<u>(X)</u>	<u>(X)</u>	<u>(X)</u>
<u>Цэвэр төлөв байдал</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>

Бүхэлд нь үл хүлээн зөвшөөрдөг, шилжүүлсэн санхүүгийн хөрөнгө

49Д(а)-(г) параграфын мөрдөлтийг үлгэрчлэн харуулах

<u>Шилжүүлсэн (үл хүлээн зөвшөөрсөн) хөрөнгийг буцаан худалдан авах мөнгөн зарлага</u>	<u>Санхүүгийн байдлын тайлан дахь үг цаашдын оролцооны дансны үнэ</u>	<u>Цаашдын оролцооны бодит үнэ цэнэ</u>	<u>Гарзын хамгийн их эрсдэл</u>
<u>Сая ТН</u>	<u>Сая ТН</u>	<u>Сая ТН</u>	<u>Сая ТН</u>

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

<u>Шилжүүлсэн (үл хүлээн зөвшөөрсөн) хөрөнгийг буцаан худалдан авах мөнгөн зарлага</u>	<u>Санхүүгийн байдлын тайлан дахь үг цаашдын оролцооны дансны үнэ</u>				<u>Цаашдын оролцооны бодит үнэ цэнэ</u>	<u>Гарзын хамгийн их эрсдэл</u>
	<u>Цаашдын оролцооны төрөл</u>	<u>Худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй</u>	<u>Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө</u>	<u>Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөр</u>	<u>Хөрөнгө</u>	<u>Өр төлбөр</u>
<u>Гаргасан буцаах эрхтэй опцион</u>	(X)			(X)		(X) X
<u>Худалдан авсан дуудах опцион</u>	(X)	X			X	X
<u>Үнэт цаасны зээллэг</u>	(X)		X	(X)	X	(X) X
<u>Нийт дүн</u>		X	X	(X)	X	(X) X

49Д(д) параграфын мөрдөлтийг үлгэрчлэн харуулах

<u>Шилжүүлсэн хөрөнгийг буцаан худалдан авах дискаунтчилсан мөнгөн гүйлгээ</u>								
<u>Цаашдын оролцооны төрөл</u>	<u>Цаашдын оролцооны дуусгавар болох хугацаа – Сая ТН</u>							
	<u>Бүгд</u>	<u>1 сараас бага</u>	<u>1–3 сар</u>	<u>3–6 сар</u>	<u>6 сараас 1 жил</u>	<u>1–3 жил</u>	<u>3–5 жил</u>	<u>5 жилээс дээш</u>
<u>Гаргасан буцаах эрхтэй опцион</u>	X		X	X	X	X		
<u>Худалдан авсан дуудах опцион</u>	X			X	X	X		X
<u>Үнэт цаасны зээллэг</u>	X	X	X					

...

Тодруулга (17А-17Е ба МЗУ42-МЗУ55-р параграф)

ХЗУ44. 17В параграфтаар шаардсан тоон шинжтэй тодруулгыг тухайн байгууллага нь бэлтгэж болох арга замуудыг дараах жишээнд үлгэрчлэн харуулав. Гэвч 17Б-17Д параграфт заасан, тодруулгын шаардлагуудыг мөрдөх боломжит бүх арга замыг эдгээр үлгэрчилсэн жишээнд авч үзээгүй болно.

Танилцуулга

Байгууллага нь хууль ёсоор хүчин төгөлдөр болох “цэвэр дүнгээр тооцох мастер хэлцэл” буюу түүнтэй ижил төсөөтэй хэлцлийн зүйл болох ажил гүйлгээг дараах оролцогч талуудтай хийсэн. Тус байгууллага нь 17А параграф дахь тодруулгын шаардлагуудын цар хүрээнд хамаарах тэдгээр ажил гүйлгээний үр дүнд хүлээн зөвшөөрсөн дараах санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөртэй байна.

“А” оролцогч нөгөө тал:

Тус байгууллага нь “А” оролцогч нөгөө талын хувьд УСНББОУС 28-ын 47-р параграфт заасан, харилцан суутгаж, цэвэр дүн гаргах шалгуурыг хангах үүсмэл санхүүгийн хөрөнгө (100 сая ТН-ийн бодит үнэ цэнэтэй) болон үүсмэл санхүүгийн өр төлбөртэй (80 сая ТН-ийн бодит үнэ цэнэтэй) байна. Иймээс нийт үүсмэл өр төлбөрийг нийт үүсмэл хөрөнгөөс харилцан суутгаж, үр дүн болох 20 сая ТН-ийн үүсмэл цэвэр хөрөнгийг уг байгууллагын санхүүгийн байдлын тайланд толилуулна. Үүсмэл цэвэр хөрөнгийн зарим хэсгийн (10 сая ТН-ийн) хувьд “А” оролцогч нөгөө талаас мөн мөнгөн барьцаа хүлээн авсан. Уг 10 сая ТН-ийн мөнгөн барьцаа нь УСНББОУС 28-ын 47-р параграфт заасан, харилцан суутгаж, цэвэр дүн гаргах шалгуурыг хангахгүй боловч үл биелүүлэлт, төлбөрийн чадваргүй байдал буюу дампуурал үүссэн тохиолдолд холбогдох барьцааны гэрээний дагуу тэрхүү үүсмэл хөрөнгө ба үүсмэл өр төлбөрийн цэвэр дүнгээс суутган тооцож болох юм.

“Б” оролцогч нөгөө тал:

Тус байгууллага нь “Б” оролцогч нөгөө талын хувьд УСНББОУС 28-ын 47-р параграфт заасан, харилцан суутгаж, цэвэр дүн гаргах шалгуурыг хангахгүй үүсмэл санхүүгийн хөрөнгө (100 сая ТН-ийн бодит үнэ цэнэтэй) болон үүсмэл санхүүгийн өр төлбөртэй (80 сая ТН-ийн бодит үнэ цэнэтэй) боловч үл биелүүлэлт, төлбөрийн чадваргүй байдал буюу дампуурал үүссэн тохиолдолд харилцан суутгаж, цэвэр дүн гаргах эрхтэй юм. Иймээс үүсмэл санхүүгийн хөрөнгө (100 сая ТН) ба үүсмэл санхүүгийн өр төлбөрийг (100 сая ТН) нийт дүнгээр тухайн байгууллагын санхүүгийн байдлын тайланд тус тусад нь толилуулна. Үүсмэл санхүүгийн хөрөнгө ба үүсмэл санхүүгийн өр төлбөрийн цэвэр дүнгийн хувьд (20 сая ТН) “Б” оролцогч нөгөө талаас мөн мөнгөн барьцаа хүлээн авсан. Уг мөнгөн барьцаа (20 сая ТН) нь УСНББОУС 28-ын 47-р параграфт заасан, харилцан суутгаж, цэвэр дүн гаргах шалгуурыг хангахгүй боловч үл биелүүлэлт, төлбөрийн чадваргүй байдал буюу дампуурал үүссэн тохиолдолд холбогдох барьцааны гэрээний дагуу тэрхүү үүсмэл хөрөнгө ба үүсмэл өр төлбөрийн цэвэр дүнгээс суутган тооцож болох юм.

“В” оролцогч нөгөө тал:

Тус байгууллага нь “В” оролцогч нөгөө талтай борлуулах ба буцаан худалдан авах хэлцэл хийсэн бөгөөд үүнийг барьцаат зээл авалт байдлаар тайлагнадаг. Барьцаа болгон ашиглаж байгаа ба тухайн ажил гүйлгээний хувьд байгууллагын шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийн (бондын) дансны үнэ нь 79 сая ТН, харин түүний бодит үнэ цэнэ нь 85 сая ТН байна. Уг авсан барьцаат зээлийн дансны үнэ (репо өглөг) нь 80 сая ТН юм.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Мөн тус байгууллага нь “В” оролцогч нөгөө талтай сөрөг борлуулах ба буцаан худалдан авах хэлцэл хийсэн бөгөөд үүнийг барьцаат зээл олголт байдлаар тайлагнадаг. Барьцаа болгон хүлээн авсан (боловч уг байгууллагын санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрдөггүй) санхүүгийн хөрөнгийн (бондын) бодит үнэ цэнэ нь 105 сая ТН байна. Уг олгосон барьцаат зээллэгийн дансны үнэ (сөрөг репо авлага) нь 90 сая ТН юм.

Энэхүү ажил гүйлгээ нь зөвхөн үл биелүүлэлт, төлбөрийн чадваргүй байдал буюу дампуурал үүссэн тохиолдолд харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах эрх бүхий буцаан худалдан авах глобал мастер хэлцэлд хамаарах тул УСНББОУС 28-ын 47-р параграфт заасан, харилцан суутгаж, цэвэр дүн гаргах шалгуурыг хангахгүй. Иймээс холбогдох репо өглөг ба репо авлагыг тухайн байгууллагын санхүүгийн байдлын тайланд тус тусад нь толилуулна.

17В(а)-(д) параграфын мөрдөлтийг санхүүгийн хэрэглүүрийн төрлөөр үлгэрчлэн харуулах

Санхүүгийн хөрөнгө нь харилцан суутгаж, цэвэр дүн гаргах, хууль ёсоор хүчин төгөлдөр болох “цэвэр дүнгээр тооцох мастер хэлцэл” болон адилтгах хэлцлийн зүйл болох

Сая ТН

<u>20XX оны 12- р сарын 31- нээр</u>	<u>(а)</u>	<u>(б)</u>	<u>(в)=(а)-(б)</u>	<u>(г)</u>	<u>(д)=(в)-(г)</u>	
				<u>Холбогдох дүнгүүдийг санхүүгийн байдлын тайланд харилцан суутгаж, цэвэр дүнг гаргаагүй</u>		
	<u>Хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгийн нийт дүн</u>	<u>Санхүүгийн байдлын тайланд харилцан суутгаж, цэвэр дүнг гаргасан, хүлээн зөвшөөрсөн санхүүгийн өр төлбөрийн нийт дүн</u>	<u>Санхүүгийн байдлын тайланд толилуулсан санхүүгийн хөрөнгийн цэвэр дүн</u>	<u>(г)(i), (г)(ii) Санхүүгийн хэрэглүүр</u>	<u>(г)(ii) Хүлээн авсан мөнгөн барьцаа</u>	<u>Цэвэр дүн</u>
<u>Утга</u>						
<u>Үүсмэл хэрэглүүр</u>	<u>200</u>	<u>(80)</u>	<u>120</u>	<u>(80)</u>	<u>(30)</u>	<u>10</u>
<u>Сөрөг буцаан худалдан авах үнэт цаасны зээллэг ба адилтгах хэлцэл</u>	<u>90</u>	<u>=</u>	<u>90</u>	<u>(90)</u>	<u>=</u>	<u>=</u>

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

<u>Бусад санхүүгийн хэрэглүүр</u>	=	=	=	=	=	=
<u>Нийт дүн</u>	<u>290</u>	<u>(80)</u>	<u>210</u>	<u>(170)</u>	<u>(30)</u>	<u>10</u>

Санхүүгийн өр төлбөр нь харилцан суутгаж, цэвэр дүн гаргах, хууль ёсоор хүчин төгөлдөр болох “цэвэр дүнгээр тооцох мастер хэлцэл” болон адилтгах хэлцлийн зүйл болох

Сая ГН

<u>20XX оны 12-р сарын 31-нээр</u>	<u>(а)</u>	<u>(б)</u>	<u>(в)=(а)-(б)</u>	<u>(г)</u>	<u>(д)=(в)-(г)</u>	
				<u>Холбогдох дүнгүүдийг санхүүгийн байдлын тайланд харилцан суутгаж, цэвэр дүнг гаргаагүй</u>		
	<u>Хүлээн зөвшөөрсөн санхүүгийн өр төлбөрийн нийт дүн</u>	<u>Санхүүгийн байдлын тайланд харилцан суутгаж, цэвэр дүнг гаргасан, хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгийн нийт дүн</u>	<u>Санхүүгийн байдлын тайланд толилуулсан санхүүгийн өр төлбөрийн цэвэр дүн</u>	<u>(г)(i), (г)(ii) Санхүүгийн хэрэглүүр</u>	<u>(г)(ii) Хүлээн авсан мөнгөн барьцаа</u>	<u>Цэвэр дүн</u>

Утга

<u>Үүсмэл хэрэглүүр</u>	<u>160</u>	<u>(80)</u>	<u>80</u>	<u>(80)</u>	=	=
<u>Буцаан худалдан авах үнэт цаасны зээллэг ба адилтгах хэлцэл</u>	<u>80</u>	=	<u>80</u>	<u>(80)</u>	=	=
<u>Бусад санхүүгийн хэрэглүүр</u>	=	=	=	=	=	=
<u>Нийт дүн</u>	<u>240</u>	<u>(80)</u>	<u>160</u>	<u>(160)</u>	=	=

17B(а)-(в) параграфын мөрдөлтийг санхүүгийн хэрэглүүрийн төрлөөр, 17B(в)-(д) параграфын мөрдөлтийг оролцогч нөгөө талаар үлгэрчлэн харуулах

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Санхүүгийн хөрөнгө нь харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах, хууль ёсоор хүчин төгөлдөр болох “цэвэр дүнгээр тооцох мастер хэлцэл” болон адилтгах хэлцлийн зүйл болох

Сая ТН

<u>20XX оны 12-р сарын 31-нээр</u>	<u>(а)</u>	<u>(б)</u>	<u>(в)=(а)-(б)</u>
	<u>Хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгийн нийт дүн</u>	<u>Санхүүгийн байдлын тайланд харилцан суутгаж, цэвэр дүнг гаргасан, хүлээн зөвшөөрсөн санхүүгийн өр төлбөрийн нийт дүн</u>	<u>Санхүүгийн байдлын тайланд толилуулсан санхүүгийн хөрөнгийн цэвэр дүн</u>
<u>Үүсмэл хэрэглүүр</u>	<u>200</u>	<u>(80)</u>	<u>120</u>
<u>Сөрөг буцаан худалдан авах үнэт цаасны зээллэг ба адилтгах хэлцэл</u>	<u>90</u>	<u>=</u>	<u>90</u>
<u>Бусад санхүүгийн хэрэглүүр</u>	<u>=</u>	<u>=</u>	<u>=</u>
<u>Нийт дүн</u>	<u>290</u>	<u>(80)</u>	<u>210</u>

Цэвэр санхүүгийн хөрөнгө нь хууль ёсоор хүчин төгөлдөр болох “цэвэр дүнгээр тооцох мастер хэлцэл” болон адилтгах хэлцлийн зүйл болох-Оролцогч нөгөө талаар

Сая ТН

<u>20XX оны 12-р сарын 31-нээр</u>	<u>(в)</u>	<u>(г)</u>	<u>(д)=(в)-(г)</u>
	<u>Санхүүгийн байдлын тайланд толилуулсан санхүүгийн хөрөнгийн цэвэр дүн</u>	<u>Холбогдох дүнгүүдийг санхүүгийн байдлын тайланд харилцан суутгаж, цэвэр дүнг гаргаагүй</u>	<u>Цэвэр дүн</u>
		<u>(г)(i), (г)(ii)</u>	
		<u>Санхүүгийн хэрэглүүр</u>	<u>Хүлээн авсан мөнгөн барьцаа</u>
<u>“А” оролцогч нөгөө тал</u>	<u>20</u>	<u>=</u>	<u>(10)</u>
<u>“Б” оролцогч нөгөө тал</u>	<u>100</u>	<u>(80)</u>	<u>(20)</u>
<u>“В” оролцогч нөгөө тал</u>	<u>90</u>	<u>(90)</u>	<u>=</u>

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

<u>Бусад оролцогч талууд</u>	=	=	=	=
<u>Нийт дүн</u>	<u>210</u>	<u>(170)</u>	<u>(30)</u>	<u>10</u>

Санхүүгийн өр төлбөр нь харилцан суутгаж, цэвэр дүн гаргах, хууль ёсоор хүчин төгөлдөр болох “цэвэр дүнгээр тооцох мастер хэлцэл” болон адилтгах хэлцлийн зүйл болох

Сая ТН

<u>20XX оны 12-р сарын 31-нээр</u>	<u>(а)</u>	<u>(б)</u>	<u>(в)=(а)-(б)</u>
	<u>Хүлээн зөвшөөрсөн санхүүгийн өр төлбөрийн нийт дүн</u>	<u>Санхүүгийн байдлын тайланд харилцан суутгаж, цэвэр дүнг гаргасан, хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгийн нийт дүн</u>	<u>Санхүүгийн байдлын тайланд толилуулсан санхүүгийн өр төлбөрийн цэвэр дүн</u>

Утга

<u>Үүсмэл хэрэглүүр</u>	<u>160</u>	<u>(80)</u>	<u>80</u>
<u>Буцаан худалдан авах үнэт цаасны зээллэг ба адилтгах хэлцэл</u>	<u>80</u>	=	<u>80</u>
<u>Бусад санхүүгийн хэрэглүүр</u>	=	=	=
<u>Нийт дүн</u>	<u>240</u>	<u>(80)</u>	<u>160</u>

Цэвэр санхүүгийн өр төлбөр нь хууль ёсоор хүчин төгөлдөр болох “цэвэр дүнгээр тооцох мастер хэлцэл” болон адилтгах хэлцлийн зүйл болох-Оролцогч нөгөө талаар

Сая ТН

<u>20XX оны 12-р сарын 31-нээр</u>	<u>(в)</u>	<u>(г)</u>	<u>(д)=(в)-(г)</u>
		<u>Холбогдох дүнгүүдийг санхүүгийн байдлын тайланд харилцан суутгаж, цэвэр дүнг гаргаагүй</u>	
	<u>Санхүүгийн байдлын тайланд толилуулсан санхүүгийн өр төлбөрийн цэвэр дүн</u>	<u>(г)(i), (г)(ii) Санхүүгийн хэрэглүүр</u>	<u>(г)(ii) Хүлээн авсан мөнгөн барьцаа</u>
			<u>Цэвэр дүн</u>

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

<u>“А” оролцогч нөгөө тал</u>	=	=	=	=
<u>“Б” оролцогч нөгөө тал</u>	80	(80)	=	=
<u>“В” оролцогч нөгөө тал</u>	80	(80)	=	=
<u>Бусад оролцогч талууд</u>	=	=	=	=
<u>Нийт дүн</u>	<u>160</u>	<u>(160)</u>	=	=

УСНББОУС 29-өөс УСНББОУС 41-д шилжилт (49М-49Р параграф)

ХЗУ45. УСНББОУС 41-ийг анх мөрдөх өдрөөр УСНББОУС 30-ийн 49М-49Р параграфт заасан, тоон шинжтэй тодруулгын шаардлагуудыг хангах боломжит нэг арга замыг дараах жишээнд үлгэрчлэн харуулав. Гэхдээ энэ Стандартын тодруулгын шаардлагуудыг мөрдөх боломжит бүх арга замыг уг жишээнд авч үзээгүй болно.

2022 оны 01 дүгээр сарын 01-нд УСНББОУС 29-өөс УСНББОУС 41-д шилжих үеийн санхүүгийн байдлын тайлангийн үлдэгдлүүдийн тохируулга

<u>Санхүүгийн хөрөнгө</u>	<u>(i)</u>	<u>(ii)</u>	<u>(iii)</u>	<u>(iv) = (i) + (ii) + (iii)</u>	<u>(v) = (iii)</u>
	<u>УСНББОУС 29-ийн дагуух дансны үнэ - 2021 оны 12-р сарын 31 ⁽¹⁾</u>	<u>Дахин ангилал</u>	<u>Дахин хэмжилт</u>	<u>УСНББОУС 41-ийн дагуух дансны үнэ - 2022 оны 01-р сарын 01</u>	<u>2022 оны 01-р сарын 01 дэх хуримтлагдсан ашиг, алдагдлын нөлөө ^{(2), (3)}</u>

Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжилт

Нэмэгдэлт:

Борлуулах боломжтой ангиллаас (УСНББОУС 29)

(a)

(b)

Хорогдуулсан өртөг ангиллаас (УСНББОУС 29) – шаардлагатай дахин ангилал

(б)

Хорогдуулсан өртөг ангиллаас (УСНББОУС 29) – 2022 оны 01-р сарын 01-нээр бодит үнэ цэнийг сонгосон

Хасагдалт:

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

2022 оны 01 дүгээр сарын 01-нд УСНББОУС 29-өөс УСНББОУС 41-д шилжих үеийн санхүүгийн байдлын тайлангийн үлдэгдлүүдийн тохируулга

<u>Санхүүгийн хөрөнгө</u>	<u>(i)</u>	<u>(ii)</u>	<u>(iii)</u>	<u>(iv) = (i) + (ii) + (iii)</u>	<u>(v) = (iii)</u>
	<u>УСНББОУС 29-ийн дагуух дансны үнэ - 2021 оны 12-р сарын 31⁽¹⁾</u>	<u>Дахин ангилал</u>	<u>Дахин хэмжилт</u>	<u>УСНББОУС 41-ийн дагуух дансны үнэ - 2022 оны 01-р сарын 01</u>	<u>2022 оны 01-р сарын 01 дэх хуримтлагдсан ашиг, алдагдлын нөлөө^{(2), (3)}</u>
<u>Хорогдуулсан өртөг ангилалд (УСНББОУС 41)</u>					
<u>Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангилалд – өрийн хэрэглүүр (УСНББОУС 41)</u>					
<u>Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангилалд – өмчийн хэрэглүүр (УСНББОУС 41)</u>					
<u>Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжилтийн нийт өөрчлөлт</u>					
<u>Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжилт</u>					
<u>Нэмэгдэлт – өрийн хэрэглүүр:</u>					
<u>Борлуулах боломжтой ангиллаас (УСНББОУС 29)</u>					<u>(ж)</u>
<u>Хорогдуулсан өртөг ангиллаас (УСНББОУС 29)</u>					<u>(и)</u>
<u>Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангиллаас (УСНББОУС 29) – ангиллын шалгуурт үндэслэсэн шаардлагатай дахин ангилал</u>					<u>(к)</u>

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

2022 оны 01 дүгээр сарын 01-нд УСНББОУС 29-өөс УСНББОУС 41-д шилжих үеийн санхүүгийн байдлын тайлангийн үлдэгдлүүдийн тохируулга

<u>Санхүүгийн хөрөнгө</u>	<u>(i)</u>	<u>(ii)</u>	<u>(iii)</u>	<u>(iv) = (i) + (ii) + (iii)</u>	<u>(v) = (iii)</u>
	<u>УСНББОУС 29-ийн дагуух дансны үнэ - 2021 оны 12-р сарын 31 ⁽¹⁾</u>	<u>Дахин ангилал</u>	<u>Дахин хэмжилт</u>	<u>УСНББОУС 41-ийн дагуух дансны үнэ - 2022 оны 01-р сарын 01</u>	<u>2022 оны 01-р сарын 01 дэх хуримтлагдсан ашиг, алдагдлын нөлөө ^{(2), (3)}</u>

Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангиллаас (УСНББОУС 29-ийн дагуух бодит үнэ цэнийн сонголт) – 2022 оны 01-р сарын 01-нээр бодит үнэ цэнийн сонголтын шалгуур хангагдаагүй

(л)

Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангиллаас (УСНББОУС 29) – бодит үнэ цэнийн сонголтоос 2022 оны 01-р сарын 01-нээр сайн дураар татгалзсан

(м)

Нэмэгдэлт – өмчийн хэрэглүүр:

Борлуулах боломжтой ангиллаас (УСНББОУС 29)

Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангиллаас (УСНББОУС 29-ийн дагуух бодит үнэ цэнийн сонголт)–2022 оны 01-р сарын 01-нд цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих сонголт хийсэн

Өртгөөс (УСНББОУС 29)

Нэмэгдэлт – өрийн ба өмчийн хэрэглүүр:

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

2022 оны 01 дүгээр сарын 01-нд УСНББОУС 29-өөс УСНББОУС 41-д шилжих үеийн санхүүгийн байдлын тайлангийн үлдэгдлүүдийн тохируулга

<u>Санхүүгийн хөрөнгө</u>	<u>(i)</u>	<u>(ii)</u>	<u>(iii)</u>	<u>(iv) = (i) + (ii) + (iii)</u>	<u>(v) = (iii)</u>
	<u>УСНББОУС 29-ийн дагуух дансны үнэ - 2021 оны 12-р сарын 31 ⁽¹⁾</u>	<u>Дахин ангилал</u>	<u>Дахин хэмжилт</u>	<u>УСНББОУС 41-ийн дагуух дансны үнэ - 2022 оны 01-р сарын 01</u>	<u>2022 оны 01-р сарын 01 дэх хуримтлагдсан ашиг, алдагдлын нөлөө ^{(2), (3)}</u>
<u>Борлуулах боломжтой ангиллаас (УСНББОУС 29) ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангилалд (УСНББОУС 41) - ангиллын шалгуурт үндэслэсэн шаардлагатай дахин ангилал</u>					(г)
<u>Борлуулах боломжтой ангиллаас (УСНББОУС 29) ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангилалд (УСНББОУС 41) - 2022 оны 01-р сарын 01-нээр бодит үнэ цэнийг сонгосон</u>					
<u>Борлуулах боломжтой ангиллаас (УСНББОУС 29) хорогдуулсан өртөг ангилалд (УСНББОУС 41)</u>					(д)
<u>Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжилтийн нийт өөрчлөлт</u>					
<u>Хорогдуулсан өртөг</u>					
Нэмэгдэлт:					
<u>Борлуулах боломжтой ангиллаас (УСНББОУС 29)</u>					(е)

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

2022 оны 01 дүгээр сарын 01-нд УСНББОУС 29-өөс УСНББОУС 41-д шилжих үеийн санхүүгийн байдлын тайлангийн үлдэгдлүүдийн тохируулга

<u>Санхүүгийн хөрөнгө</u>	<u>(i)</u>	<u>(ii)</u>	<u>(iii)</u>	<u>(iv) = (i) + (ii) + (iii)</u>	<u>(v) = (iii)</u>
	<u>УСНББОУС 29-ийн дагуух дансны үнэ - 2021 оны 12-р сарын 31⁽¹⁾</u>	<u>Дахин ангилал</u>	<u>Дахин хэмжилт</u>	<u>УСНББОУС 41-ийн дагуух дансны үнэ - 2022 оны 01-р сарын 01</u>	<u>2022 оны 01-р сарын 01 дэх хуримтлагдсан ашиг, алдагдлын нөлөө^{(2), (3)}</u>

Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангиллаас (УСНББОУС 29) – шаардлагатай дахин ангилал

Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангиллаас (УСНББОУС 29-ийн дагуух бодит үнэ цэнийн сонголт) – 2022 оны 01-р сарын 01-нээр бодит үнэ цэнийн сонголтын шалгуур хангагдаагүй

Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангиллаас (УСНББОУС 29) – бодит үнэ цэнийн сонголтоос 2022 оны 01-р сарын 01-нээр сайн дураар татгалзсан

Хасагдалт:

Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангилалд (УСНББОУС 41)

(н)

Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангилалд (УСНББОУС 41) – ангиллын шалгуурт үндэслэсэн шаардлагатай дахин ангилал

2022 оны 01 дүгээр сарын 01-нд УСНББОУС 29-өөс УСНББОУС 41-д шилжих үеийн санхүүгийн байдлын тайлангийн үлдэгдлүүдийн тохируулга

<u>Санхүүгийн хөрөнгө</u>	<u>(i)</u>	<u>(ii)</u>	<u>(iii)</u>	<u>(iv) = (i) + (ii) + (iii)</u>	<u>(v) = (iii)</u>
	<u>УСНББОУС 29-ийн дагуух дансны үнэ - 2021 оны 12-р сарын 31⁽¹⁾</u>	<u>Дахин ангилал</u>	<u>Дахин хэмжилт</u>	<u>УСНББОУС 41-ийн дагуух дансны үнэ - 2022 оны 01-р сарын 01</u>	<u>2022 оны 01-р сарын 01 дэх хуримтлагдсан ашиг, алдагдлын нөлөө^{(2), (3)}</u>

Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангилалд (УСНББОУС 41) – 2022 оны 01-р сарын 01-нээр бодит үнэ цэнийг сонгосон

Хорогдуулсан өртгөөр хэмжилтийн нийт өөрчлөлт

2022 оны 01-р сарын 01-нээрх нийт санхүүгийн хөрөнгийн үлдэгдэл, дахин ангилал, дахин хэмжилт

<u>(i)</u>	<u>Нийт дүн (ii) = 0</u>	<u>(iii)</u>	<u>(iv) = (i) + (ii) + (iii)</u>

1 УСНББОУС 29-ийн дагуу дараах байдлаар задлан хуваагдах холимог хэрэглүүрийг дахин ангилсны үр нөлөөг агуулсан, үүнд: (а) 2021 оны 12-р сарын 31-ний байдлаар Х-ийн бодит үнэ цэнэтэй холбогдох дагалдах үүсмэл хэрэглүүр бүхий үндсэн гэрээний хэсэг, ба (б) 2021 оны 12-р сарын 31-ний байдлаар У-ийн бодит үнэ цэнэтэй холбогдох дагалдах үүсмэл хэрэглүүр бүхий үндсэн гэрээний хэсэг.

2 Анх мөрдөх өдрөөр дүнгүүдийг нь цэвэр хөрөнгө/өмчөөс хуримтлагдсан ашиг, алдагдалд дахин ангилдаг (в), (г), (д), (е)-г тусган агуулсан.

3 Анх мөрдөх өдрөөр дүнгүүдийг нь хуримтлагдсан ашиг, алдагдлаас цэвэр хөрөнгө/өмчид дахин ангилдаг (ж), (и), (к), (л), (м), (н)-ийг тусган агуулсан.

...

УСНББОУС 32, Үйлчилгээний Концессын Хэлиэл-д оруулсан нэмэлт өөрчлөлт

20, 29, МЗУ37, МЗУ45, МЗУ52, МЗУ53-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 36Г параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Санхүүгийн өр төлбөрийн загвар (МЗУ37-МЗУ46-р параграфыг үзнэ үү)

...

20. Энэ Стандарт нь шаардлагууд болон заавар удирдамжаар хангаснаас бусад тохиолдолд 14-р параграфын дагуу хүлээн зөвшөөрсөн санхүүгийн өр төлбөрийн хувьд УСНББОУС 28, *Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга, УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт* ийн үл хүлээн зөвшөөрөлтийн шаардлагууд, УСНББОУС 30, *Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга, УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр*-ийн үл хүлээн зөвшөөрөлтийн шаардлагуудыг мөрдөнө.

...

Бусад өр төлбөр, үүрэг амлалт, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө (МЗУ51-МЗУ54-р параграфыг үзнэ үү)

...

29. Эрх бүхий этгээд нь үйлчилгээний концессын хэлцлээс үүссэн бусад өр төлбөр, үүрэг амлалт, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгийг УСНББОУС 19, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө, УСНББОУС 28, ~~УСНББОУС 29~~, УСНББОУС 30, УСНББОУС 41-ийн* дагуу тайлагнана.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

- 36Г. 2018 оны 8 дугаар сард гаргасан, УСНББОУС 41-ээр 20, 29, МЗУ37, МЗУ45, МЗУ52, МЗУ53-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд УСНББОУС 41-ийг мөн уг өмнөх тайлант хугацаанд дагаж мөрдөнө.

...

Мөрдөх заавар удирдамж

Энэ Хавсралт нь УСНББОУС 32-ын салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.

...

Өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

...

- МЗУ37. Эрх бүхий этгээд нь урьдчилан тодорхойлсон цуврал төлбөрүүдийг тухайн эзэмшигчид төлөх нөхцөлт бус үүрэгтэй тохиолдолд уг өр төлбөр нь УСНББОУС 41-д ~~УСНББОУС 29~~ д тодорхойлсон санхүүгийн өр төлбөр гэж үзнэ. Эзэмшигчтэй байгуулсан заавал биелүүлэх хэлцэл нь хуулийн дагуу хүчин төгөлдөр хэрэгжих учраас эрх бүхий этгээд нь тэрхүү үүргээс нэг талын санаачлагаар зайлсхийх ямар нэг боломжтой байлаа гэхэд ийм боломж ихэвчлэн бага байх тул нөхцөлт бус үүргийг хүлээдэг.

...

МЗУ45. Үйлчилгээний концессын хэлцлийн өр төлбөртэй холбоотой санхүүгийн зардлыг УСНББОУС 28, ~~УСНББОУС 29~~, УСНББОУС 30, УСНББОУС 41-ийн дагуу бусад санхүүгийн зардалтай нийцсэн байдлаар толилуулна.

...

МЗУ52. Эрх бүхий этгээдийн гаргасан зарим баталгаа нь санхүүгийн баталгааны гэрээний тодорхойлолтыг хангаж болох юм. Үйлчилгээний концессын хэлцлийн нэг хэсэг байдлаар эрх бүхий этгээдийн гаргасан баталгаа нь санхүүгийн баталгааны гэрээний тодорхойлолтыг хангах эсэхийг тухайн эрх бүхий этгээд нь тодорхойлох ба уг баталгааны тайлагналын хувьд УСНББОУС 28, ~~УСНББОУС 29~~, УСНББОУС 30, УСНББОУС 41-ийг мөрдөнө. Баталгаа нь даатгалын гэрээ байх тохиолдолд эрх бүхий этгээд нь даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг мөрдөх сонголт хийж болно. Цаашдын заавар удирдамжийн хувьд УСНББОУС 28-ын МЗУ3-МЗУ9-р параграфыг үзнэ үү.

МЗУ53. Санхүүгийн баталгааны гэрээтэй холбоотой УСНББОУС 28 ба УСНББОУС 41-ийн ~~УСНББОУС 29-ийн~~ шаардлагуудыг хангадаггүй буюу даатгалын гэрээ биш, тийм баталгаа болон үүрэг амлалтыг УСНББОУС 19-ийн дагуу тайлагнана.

...

Дүгнэлтийн Үндэслэл

Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 32-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

...

Санхүүгийн өр төлбөрийн загвар

...

ДҮ26. Үйлчилгээний концессын хэлцлийг заавал биелүүлэх хэлцэл хэлбэрээр байгуулдаг. Энэ нь хэрэв гэрээний хэлбэртэй байсан бол талуудад хүлээлгэх эрх, үүрэгтэй адилтгах эрх, үүргийг бий болгодог гэрээ болон бусад хэлцлийг агуулсан байж болно. Хэрэв гэрээний хэлбэртэй байсан бол талуудад хүлээлгэх эрх, үүрэгтэй адилтгах эрх, үүргийг бий болгодог бусад хэлцэл байх тохиолдолд ийм хэлцэлд УСНББОУС 28, *Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга*, ~~УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт~~, УСНББОУС 30, *Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга*-ыг, УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр-ийг мөн адил мөрдөх хэрэгтэй гэж УСНББОУС3 дүгнэсэн.

...

Хэрэгжүүлэх заавар удирдамж


Энэхүү заавар удирдамж нь УСНББОУС 32-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

...

Үйлчилгээний концессын хэлцлийн нягтлан бодох бүртгэлийн хүрээ

ХЗУ2. УСНББОУС 32-т тодорхойлсон, үйлчилгээний концессын хэлцлийн тайлагналыг дараах схемд үлгэрчлэн харуулав:

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР



...

УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх-д оруулсан нэмэлт өөрчлөлт

36, 64, 72, 113, 114, 115, 116, 117, 118, 119, 120, 121, 122, 124-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 114А, 119А, 119В, 119Г, 122А, 122Б, 122В, 122Г, 154Г параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Хөрөнгө ба/буюу өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилт

36. **Анх удаа мөрдөж буй байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөггүй тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс хойшхи гурван жилийн доторх тодорхой нэг өдрөөс эхлэх тайлант үеүдийн хувьд дараах хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх буюу хэмжих шаардлагагүй юм:**

- (а) Бараа материал (УСНББОУС 12, *Бараа материал-ыг* үзнэ үү);
- (б) Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө (УСНББОУС 16, *Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө-ийг* үзнэ үү);
- (в) Үндсэн хөрөнгө (УСНББОУС 17, *Үндсэн Хөрөнгө-ийг* үзнэ үү);
- (г) Тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр ба ажилтны урт хугацааны бусад тэтгэмж (УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж-ийг* үзнэ үү);
- (д) Биологийн хөрөнгө ба хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн (УСНББОУС 27, *Хөдөө Аж Ахуй-г* үзнэ үү);
- (е) Биет бус хөрөнгө (УСНББОУС 31, *Биет Бус Хөрөнгө-ийг* үзнэ үү);
- (ж) Санхүүгийн өр төлбөрийн загвар эсвэл эзэмшигчид эрх олгох загварын дагуух үйлчилгээний концессын хөрөнгө ба холбогдох өр төлбөр (УСНББОУС 32, *Үйлчилгээний Концессын Хэлцэл: Эрх бүхий этгээд-ийг* үзнэ үү);
- (и) Санхүүгийн хэрэглүүр (УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр ~~УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт~~-ийг үзнэ үү).

...

Хөрөнгө ба/буюу өр төлбөрийг хэмжихэд төсөөлөн тооцсон өртөг ашиглах

64. **Хөрөнгө, өр төлбөрийн талаархи өртгийн найдвартай мэдээлэл байхгүй тохиолдолд анх удаа мөрдөж буй байгууллага нь дараах хөрөнгө, өр төлбөрийг тэдгээрийн бодит үнэ цэнээр хэмжих ба тэрхүү бодит үнэ цэнийг эдгээр хөрөнгийн хувьд төсөөлөн тооцсон өртөг болгон ашиглах сонголт хийж болох юм:**

- (а) Бараа материал (УСНББОУС 12-ыг үзнэ үү);
- (б) Хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 16-д заасан өртгийн загварыг ашиглах сонголт хийсэн бол Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө;
- (в) Үндсэн хөрөнгө (УСНББОУС 17-г үзнэ үү);
- (г) Дараах шалгуурыг хангасан бөгөөд дотооддоо бий болгосноос бусад биет бус хөрөнгө (УСНББОУС 31-ийг үзнэ үү):
 - (i) УСНББОУС 31-д заасан хүлээн зөвшөөрөлтийн шалгуур (найдартай хэмжилтийн шалгуур хамаарахгүй); ба

- (ii) УСНББОУС 31-д заасан дахин үнэлгээний шалгуур (үүн дотроо, идэвхитэй зах зээлийн оршин байдал хамаарна);
- (д) Санхүүгийн хэрэглүүр (УСНББОУС 41-ийг УСНББОУС 29-ийг үзнэ үү);
- (е) Үйлчилгээний концессын хөрөнгө (УСНББОУС 32-ыг үзнэ үү).

...

Хяналтанд буй байгууллага, хамтарсан үйлдвэр, хараат байгууллага дахь хөрөнгө оруулалтын хувьд төсөөлөн тооцсон өртгийг ашиглах (УСНББОУС 34)

72. Анх удаа мөрдөж буй байгууллага нь хяналтанд буй байгууллага, хамтарсан үйлдвэр буюу хараат байгууллага дахь хөрөнгө оруулалтыг өөрийн тусдаа санхүүгийн тайландаа өртгөөр хэмждэг бол УСНББОУС-ыг мөрдсөн өдөр уг байгууллага нь тэрхүү хөрөнгө оруулалтыг дараах дүнгүүдийн аль нэгээр өөрийн эхлэлийн, тусдаа санхүүгийн байдлын тайландаа хэмжих сонголт хийж болно:

- (a) Өртөг; эсвэл
- (б) Төсөөлөн тооцсон өртөг. Ийм хөрөнгө оруулалтын төсөөлөн тооцсон өртөг нь уг анх удаа мөрдөж буй байгууллага өөрийн тусдаа санхүүгийн тайландаа УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөрх түүний бодит үнэ цэнэ (УСНББОУС 41-ийн УСНББОУС 29-ийн дагуу тодорхойлсон) байна.

...

УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт

УСНББОУС-ыг мөрдсөн өдөр эсвэл шилжилтийн хугацаанд санхүүгийн хэрэглүүрийг ангилах

113. Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 41-д УСНББОУС 29-д заасан, ангиллын шалгуурыг хангадаг санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийг 114-р параграфын дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн, санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөр гэж ангилж болно. Анх удаа мөрдөж буй байгууллага нь ингэж ангилсан өдөр тухайн ангилал бүрээр тусгасан санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнэ, тэдгээрийн ангилал, дансны үнийг тодруулна.

114. УСНББОУС 41 УСНББОУС 29 нь анх хүлээн зөвшөөрөх үед санхүүгийн хөрөнгийг ~~бөрлуулах боломжтой гэж ангилах~~, эсвэл санхүүгийн хэрэглүүрийг (хэрэв тодорхой шалгуурыг хангасан бол) ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн, санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр гэж ангилахыг зөвшөөрдөг. Энэхүү шаардлагыг үл харгалзан дараах тохиолдолд гажих нөхцлүүдийг мөрддөг:

- (a) ~~Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдөр бөрлуулах боломжтой гэж ангилахыг түүнд зөвшөөрдөг.~~
- (б) УСНББОУС-ыг мөрдсөн өдөр хэрэв хөрөнгө буюу өр төлбөр нь УСНББОУС 41-ийн 44, 46(a) эсвэл 46(б) УСНББОУС 29-ийн 10 (б)(i), 10(б)(ii), 13-р параграфт заасан, шалгуурыг хангаж байвал уг анх удаа мөрдөж буй байгууллага нь тэрхүү өдөр аливаа санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилахыг түүнд зөвшөөрдөг.

114A. Өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтыг байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр оршин буй баримт материал болон нөхцөл байдалд үндэслэн УСНББОУС 41-ийн 106-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилж болох юм.

Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт

115. 116-р параграфтаар зөвшөөрснөөс бусад тохиолдолд, УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, эсвэл анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийг хүлээн зөвшөөрөхгүй байхыг зөвшөөрдөг шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг бол тэрхүү чөлөөлөх хугацаа дууссан ба/буюу тухайн санхүүгийн хэрэглүүрийг хүлээн зөвшөөрсөн өдөр (аль түрүүнд болох өдөр) болон түүнээс хойш гарч тохиолдсон ажил гүйлгээний хувьд уг анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 41-д УСНББОУС 29-д заасан, үл хүлээн зөвшөөрөлтийн шаардлагуудыг гүйцээх горимоор мөрдөнө. Жишээлбэл; УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс өмнө гарч тохиолдсон ажил гүйлгээний үр дүнд уг анх удаа мөрдөж буй байгууллага нь үүсмэл бус санхүүгийн хөрөнгө буюу үүсмэл бус санхүүгийн өр төлбөрийг өөрийн нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу үл хүлээн зөвшөөрсөн бол тэдгээр хөрөнгө, өр төлбөр нь дараагийн ажил гүйлгээ буюу үйл явдлын үр дүнд хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангаснаас бусад тохиолдолд тэдгээрийг УСНББОУС 41-ийн УСНББОУС 29-ийн дагуу хүлээн зөвшөөрөхгүй.
116. Өнгөрсөн ажил гүйлгээний үр дүнд үл хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрт УСНББОУС 41 УСНББОУС 29-ийг мөрдөхөд шаардлагатай мэдээллийг тэдгээр ажил гүйлгээг анх тайлагнах үед олж авсан бол 115-р параграфт заасан нөхцлийг үл харгалзан, уг анх удаа мөрдөж буй байгууллага нь өөрийн сонгосон өдрөөс эхлэн УСНББОУС 41 УСНББОУС 29-ийн үл хүлээн зөвшөөрөлтийн шаардлагуудыг буцаах горимоор мөрдөж болно.

Хейжийн нягтлан бодох бүртгэл

117. УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, эсвэл анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийг хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг гурван жилийн шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг бол тэрхүү чөлөөлөх хугацаа дууссан ба/буюу холбогдох санхүүгийн хэрэглүүрийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдөр (аль түрүүнд болох өдөр) УСНББОУС 41-ээр УСНББОУС 29-өөр шаардсанчлан, уг анх удаа мөрдөж буй байгууллага нь:
- (а) Бүх үүсмэл хэрэглүүрийг бодит үнэ цэнээр хэмжинэ; ба
 - (б) Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хөрөнгө, өр төлбөр байсан мэтээр тайлагнасан үүсмэл хэрэглүүрүүдээс үүссэн бүх хойшлогдсон олз, гарзыг устгаж цэвэрлэнэ.
118. Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 41-д УСНББОУС 29-д заасан хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангахгүй тийм төрлийн хейжийн харилцааг (жишээлбэл; хейжийн хэрэглүүр нь ~~мөнгөн хэрэглүүр эсвэл~~ дангаар нь гаргасан опцион байх, эсвэл хейжийн зүйл нь гадаад валютын эрсдлээс бусад эрсдлийн хувьд мөнгөн гүйлгээний хейжийн цэвэр төлөв байдал байх хейжийн олон харилцааг) өөрийн эхлэлийн санхүүгийн байдлын тайландаа тусгахгүй. Гэвч анх удаа мөрдөж буй байгууллага нь цэвэр төлөв байдлыг өөрийн нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хейжийн зүйл гэж сонгосон бол УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, эсвэл анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийг хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг гурван жилийн шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг бол тэрхүү чөлөөлөх хугацаа дууссан ба/буюу холбогдох санхүүгийн хэрэглүүрийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдрөөс (аль түрүүнд болох өдрөөс) хожуу биш хугацаанд тус байгууллага нь тэрхүү цэвэр төлөв байдлын хүрэн дэх бие даасан зүйлийг УСНББОУС-ын дагуу хейжийн зүйл эсвэл УСНББОУС 41-ийн 146-р параграфын шаардлагуудыг хангадаг цэвэр төлөв байдлыг УСНББОУС-ын дагуу хейжийн зүйл гэж сонгож болно.
119. УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, эсвэл анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийг хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг гурван

жилийн шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг бол тэрхүү чөлөөлөх хугацаа дууссан ба/буюу холбогдох санхүүгийн хэрэглүүрийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдрөөс (аль түрүүнд болох өдрөөс) өмнө уг анх удаа мөрдөж буй байгууллага нь ажил гүйлгээг хейж гэж сонгосон боловч тухайн хейж нь УСНББОУС 41-д УСНББОУС 29-д заасан, хейжийн нягтлан бодох бүртгэлийн нөхцлүүдийг хангахгүй байвал тус байгууллага нь хейжийн нягтлан бодох бүртгэлийг зогсоохын тулд УСНББОУС 41-ийн 135 ба 136-р УСНББОУС 29-ийн 102 ба 112-р параграфыг мөрдөнө. УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, эсвэл анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийг хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг гурван жилийн шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг бол тэрхүү чөлөөлөх хугацаа дууссан ба/буюу холбогдох санхүүгийн хэрэглүүрийг УСНББОУС 41-ийн УСНББОУС 29-ийн дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдрөөс (аль түрүүнд болох өдрөөс) өмнө хийгдсэн ажил гүйлгээг хейж гэж буцаан сонгохгүй.

Санхүүгийн хэрэглүүрийн ангилал ба хэмжилт

- 119А. Санхүүгийн хөрөнгө нь УСНББОУС 41-ийн 40-р параграфт эсвэл 41-р параграфт заасан нөхцлүүдийг хангаж буй эсэхийг байгууллага нь УСНББОУС-д шилжсэн өдрөөр оршин байсан баримт материал болон нөхцөл байдалд үндэслэн үнэлнэ.
- 119Б. Засварлан өөрчилсөн мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн элементийг УСНББОУС-д шилжсэн өдрөөр оршин байсан баримт материал болон нөхцөл байдалд үндэслэн УСНББОУС 41-ийн МЗУ68-МЗУ70-р параграфын дагуу үнэлэх практик боломжгүй бол байгууллага нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн элементийн өөрчлөлттэй холбоотой УСНББОУС 41-ийн МЗУ68-МЗУ70-р параграфын шаардлагуудыг үл харгалзан УСНББОУС-д шилжсэн өдрөөр оршин байсан баримт материал болон нөхцөл байдалд үндэслэн уг санхүүгийн хөрөнгийн гэрээний мөнгөн гүйлгээний шинж чанаруудыг үнэлнэ. (Энэ тохиолдолд, байгууллага нь УСНББОУС 30-ийн 49Л параграфыг бас мөрдөх боловч “УСНББОУС 41-ийн 161-р параграф” гэсэн хэллэгийг энэ параграф гэдэг утгаар, “санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлт” гэсэн хэллэгийг “УСНББОУС-д шилжсэн өдөр” гэдэг утгаар ойлгож, унших хэрэгтэй.)
- 119В. Урьдчилсан төлбөрийн шинжийн бодит үнэ цэнэ нь УСНББОУС 41-ийн МЗУ74(в) параграфын дагуу мэдэгдэхүйц биш эсэхийг УСНББОУС-д шилжсэн өдрөөр оршин байсан баримт материал болон нөхцөл байдалд үндэслэн үнэлэх практик боломжгүй бол байгууллага нь УСНББОУС 41-ийн МЗУ74-р параграфт заасан урьдчилсан төлбөрийн шинжүүдэд хамаарах гажих нөхцлийг үл харгалзан, УСНББОУС-д шилжсэн өдрөөр оршин байсан баримт материал болон нөхцөл байдалд үндэслэн уг санхүүгийн хөрөнгийн гэрээний мөнгөн гүйлгээний шинж чанаруудыг үнэлнэ. (Энэ тохиолдолд, байгууллага нь УСНББОУС 30-ийн 49М параграфыг бас мөрдөх боловч “УСНББОУС 41-ийн 162-р параграф” гэсэн хэллэгийг энэ параграф гэдэг утгаар, “санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлт” гэсэн хэллэгийг “УСНББОУС-д шилжсэн өдөр” гэдэг утгаар ойлгож, унших хэрэгтэй.)
- 119Г. Байгууллага нь УСНББОУС 41-д заасан үр ашигт хүүний аргыг буцаах горимоор мөрдөх практик боломжгүй (УСНББОУС 3-д тодорхойлсон) бол УСНББОУС-д шилжсэн өдрөөрх санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнэ нь тэрхүү УСНББОУС-д шилжсэн өдрөөрх тухайн санхүүгийн хөрөнгийн шинэ нийт дансны үнэ эсвэл тухайн санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан шинэ өртөг болно.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

120. Санхүүгийн хэрэглүүрийг гурван жилийн шилжилтийн хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг 36, 38, 42-р параграфын чөлөөлөх нөхцлүүдийн давуу талыг ашигладаг тийм санхүүгийн хөрөнгүүдтэй холбоотой байхаас бусад тохиолдолд анх удаа мөрдөж буй байгууллага нь үнэ цэнийн бууралтын шаардлагуудыг УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс эхлэн гүйцээх горимоор мөрдөнө. Анх удаа мөрдөж буй байгууллага нь гурван жилийн шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийг ашигладаг бол тус

байгууллага нь тэрхүү чөлөөлөх хугацаа дууссан ба/буюу холбогдох санхүүгийн хэрэглүүрийг УСНББОУС 41-ийн УСНББОУС 29-ийн дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдрөөс (аль түрүүнд болох өдрөөс) уг үнэ цэнийн бууралтын нөхцлүүдийг мөрдөнө.

...

122. Анх удаа мөрдөж буй байгууллага нь үнэ цэнийн бууралтын шаардлагуудыг гүйцээх горимоор мөрдөнө. Энэ нь УСНББОУС 41-ийг ~~УСНББОУС 29-ийг~~ мөрдсөн өдөр эсвэл ийм чөлөөлөлт олгосон шилжилтийн үеийн нөхцлүүдийн хугацаа дууссан ба/буюу анх мөрдөж буй байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэнэ буурсан гэсэн шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлэх шаардлагатай бол холбогдох санхүүгийн хэрэглүүрийг хүлээн зөвшөөрч, хэмжсэн зөвхөн тэр үе (аль түрүүнд болох өдөр) гэсэн үг юм. Аливаа үнэ цэнийн бууралтын гарзыг УСНББОУС-ыг мөрдсөн өдөр хуримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдэлд эсвэл тухайн шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүдийн хугацаа дууссан ба/буюу холбогдох санхүүгийн хэрэглүүрийг хүлээн зөвшөөрч, хэмжсэн (аль түрүүнд болох өдөр) тайлант үед хуримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдэлд хүлээн зөвшөөрнө.

122А. УСНББОУС 41-ийг мөрдсөн өдөр, тэрхүү чөлөөлөлт олгосон шилжилтийн үеийн нөхцлүүдийн хугацаа дууссан ба/буюу холбогдох санхүүгийн хэрэглүүрийг хүлээн зөвшөөрч, хэмжсэн тохиолдолд уг анх удаа мөрдөж буй байгууллага нь тухайн санхүүгийн хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрсөн өдрөөрх (эсвэл зээл олгох баталгаа ба санхүүгийн баталгааны гэрээний хувьд байгууллага нь УСНББОУС 41-ийн 78-р параграфын дагуу үл цуцлагдах хариуцлагыг хүлээх нэг тал болсон өдрөөрх) зээлийн эрсдлийг тодорхойлж, УСНББОУС-д шилжсэн өдрөөрх зээлийн эрсдэлтэй түүнийг харьцуулахын тулд их зардал буюу хүчин чармайлт гаргахгүйгээр олж авч болох үл үндэслэлтэй ба дэмжих мэдээллийг ашиглана (УСНББОУС 41-ийн МЗУ350-МЗУ351-р параграфыг бас үзнэ үү).

122Б. Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг тодорхойлох үедээ байгууллага нь дараах шаардлагуудыг мөрдөж болох юм:

(а) УСНББОУС 41-ийн 82-р параграф болон МЗУ179-МЗУ182-р параграфын шаардлагууд;

(б) Санхүүгийн хэрэглүүрийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг өнгөрсөн хугацааны мэдээлэлд үндэслэн тодорхойлсноор байгууллага нь үнэ цэнийн бууралтын шаардлагуудыг даган мөрдөх бол 30 хоногоос илүүгээр хугацаа хэтэрсэн гэрээний төлбөрүүдийн хувьд УСНББОУС 41-ийн 83-р параграфт заасан няцааж болох урьдчилсан нөхцөл.

122В. Санхүүгийн хэрэглүүрийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг УСНББОУС-д шилжсэн өдрөөр тодорхойлох нь их зардал буюу хүчин чармайлт шаардахаар бол байгууллага нь нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр гарзын хасагдуулгыг уг санхүүгийн хэрэглүүрийг үл хүлээн зөвшөөрөх хүртэл тайлант үе бүрийн эцэст хүлээн зөвшөөрнө (санхүүгийн хэрэглүүр нь тухайн тайлант үеийн эцэст зээлийн эрсдэл багатай байх, ингэснээр 122Б(а) параграфыг мөрдөхөөс бусад тохиолдолд).

Дагалдах үүсмэл хэрэглүүр

122Г. Анх удаа мөрдөж буй байгууллага нь уг гэрээний оролцогч тал анх болсон өдөр ба УСНББОУС 41-ийн МЗУ109-р параграфтаар шаардсан дахин үнэлэх өдрийн аль сүүлд болох өдрийн байдлаар оршин байсан нөхцөл байдалд үндэслэн, тухайн дагалдах үүсмэл хэрэглүүрийг үндсэн гэрээнээс салган тусгаарлаж, үүсмэл хэрэглүүр байдлаар тайлагнах шаардлагатай эсэхийг үнэлнэ.

УСНББОУС 30, Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга

...

124. Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, эсвэл ийм чөлөөлөлт олгосон шилжилтийн үеийн нөхцлүүдийн хугацаа дууссан ба/буюу холбогдох санхүүгийн хэрэглүүрийг УСНББОУС 41-ийн УСНББОУС 29-ийн дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн үед (аль түрүүнд болох өдөр) УСНББОУС 30-ийн шаардлагуудыг гүйцээх горимоор мөрдөнө.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

154Г. 2018 оны 8 дугаар сард гаргасан, УСНББОУС 41-ээр 36, 64, 72, 113, 114, 115, 116, 117, 118, 119, 120, 121, 122, 124-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 114А, 119А, 119В, 119Г, 122А, 122Б, 122В, 122Г параграфыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд УСНББОУС 41-ийг мөн уг өмнөх тайлант хугацаанд дагаж мөрдөнө.

...

Дүгнэлтийн Үндэслэл

Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 33-ыг дагалдах боловч түүний салиггүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

...

УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт

ДҮ61. УСНББОУС 41-д УСНББОУС 29-д заасан, одоо байгаа шилжилтийн нөхцлүүд нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд уг анх удаа мөрдөж буй байгууллагад ямар нэг чөлөөлөлт олгодоггүй. Улсын секторын олон байгууллагууд нь өөрсдийн санхүүгийн хэрэглүүрийг тогтоох ба зохих ёсоор ангилахад тодорхой хугацаа шаардлагатай учраас УСНББОУС3 нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд уг анх удаа мөрдөж буй байгууллагад шилжилтийн үеийн чөлөөлөх хугацаа олгох хэрэгтэй гэдгийг зөвшөөрсөн. Бусад зүйлсийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд олгосон чөлөөлөлтийн хугацаатай уялдуулан гурван жилийн шилжилтийн үеийн чөлөөлөх хугацааг олгосон.

...

ДҮ63. УСНББОУС3 нь мөнгөн зүйлсийн хөрөнгө, өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтэнд мөрддөгтэй ижил зарчмыг мөнгөн зүйлсийн бус хөрөнгийн хувьд мөрдөх хэрэгтэй гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, анх удаа мөрдөж буй байгууллага нь өөрийн нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу санхүүгийн хэрэглүүрийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд УСНББОУС3 нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрийн дараах, санхүүгийн хэрэглүүрийн хэмжилт, ангиллын хувьд гурван жилийн чөлөөлөх хугацааг олгох хэрэгтэй гэдгийг зөвшөөрсөн. Энэхүү шилжилтийн хугацаанд уг анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 41-д УСНББОУС 29-д заасан зарчмуудыг мөрдөхөд зориулсан найдвартай загварыг боловсруулах боломжтой болох юм. Мөн санхүүгийн хэрэглүүрийн хэмжилтийн хувьд УСНББОУС 41-д УСНББОУС 29-д заасан, шаардлагуудаас өөр нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тэрхүү шилжилтийн хугацаанд мөрдөх боломжийг тус байгууллагад олгох юм.

...

Хяналтанд буй байгууллага, хамтарсан үйлдвэр буюу хараат байгууллага дахь хөрөнгө оруулалтын төсөөлөн тооцсон өртөг

ДҮ85. Анх удаа мөрдөж буй байгууллага нь хяналтанд буй байгууллага, хамтарсан үйлдвэр буюу хараат байгууллагад оруулсан хөрөнгө оруулалтыг УСНББОУС-ыг мөрдсөн өдөр өөрийн тусдаа санхүүгийн тайландаа УСНББОУС 6-гийн дагуу тодорхойлсон өртгөөр эсвэл төсөөлөн тооцсон өртгөөр хэмжих сонголт хийж болно гэдгийг УСНББОУСЗ бас хүлээн зөвшөөрсөн. Төсөөлөн тооцсон өртгийг УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр-ийн ~~УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт~~-ийн дагуу бодит үнэ цэнэ байдлаар тодорхойлдог.

...

УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр ~~УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба Хэмжилт~~

ДҮ111. Ихэнх тохиолдолд үнэ цэнийн бууралтын зарчмуудыг буцаах горимоор мөрдөх практик боломжгүй тул санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэнийн бууралтыг гүйцээх горимоор тайлагнах хэрэгтэй гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Энэхүү чөлөөлөлт нь мөнгө бий болгодоггүй хөрөнгө болон мөнгө бий болгогч хөрөнгөнд УСНББОУС 21, УСНББОУС 26-гийн дагуу олгодог чөлөөлөлтийн нөхцөлтэй нийцдэг.

...

Хэрэгжүүлэх заавар удирдамж

Энэхүү хэрэгжүүлэх заавар удирдамж нь УСНББОУС 33-ыг дагалдах боловч түүний салиггүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

...

УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр ~~УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт~~

Хүлээн зөвшөөрөлт

ХЗУ67. УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс, эсвэл хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээн зөвшөөрөлтийн хувьд чөлөөлөлт олгодог нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан буюу тэрхүү санхүүгийн хэрэглүүрийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдрөөс (аль түрүүнд болох өдрөөс) өмнө, нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу үл хүлээн зөвшөөрсөн бөгөөд анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 33-ын 116-р параграфыг мөрдөх сонголт хийгээгүй (УСНББОУС 33-ын 115 ба 116-р параграфыг үзнүү) тийм үүсмэл бус санхүүгийн хөрөнгө ба үүсмэл бус санхүүгийн өр төлбөрөөс бусад, УСНББОУС 41-д ~~УСНББОУС 29-д~~ заасан хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангадаг боловч УСНББОУС 41-д ~~УСНББОУС 29-д~~ заасан үл хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хараахан хангаагүй бүх санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийг (үүн дотроо, бүх үүсмэл хэрэглүүрийг) уг анх удаа мөрдөж буй байгууллага нь хүлээн зөвшөөрнө.

ХЗУ68. Жишээлбэл; УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс өмнө гарч тохиолдсон үнэт цаасжуулалт, шилжүүлэг болон үл хүлээн зөвшөөрөлтийн бусад ажил гүйлгээ нь нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж байвал УСНББОУС 33-ын 116-р параграфыг мөрддөггүй анх удаа мөрдөж буй байгууллага нь эдгээр ажил гүйлгээгээр шилжүүлсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрөхгүй. Харин УСНББОУС-д шилжсэн өдрөөс, эсвэл хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд чөлөөлөлт олгодог нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

олгосон нөхцлийн хугацаа дууссан буюу тэрхүү санхүүгийн хэрэглүүрийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдрөөс (аль түрүүнд болох өдрөөс) хойшхи дараагийн шилжүүлгийн хувьд уг анх удаа мөрдөж буй байгууллага нь тухайн үнэт цаасжуулалтын хэлцэл буюу үл хүлээн зөвшөөрөлтийн бусад хэлцлийг ашиглаж байгаа бол тэдгээр дараагийн шилжүүлгүүд нь УСНББОУС 41-д УСНББОУС 29-д заасан, үл хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангаж буй зөвхөн тийм тохиолдолд үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангана.

Дагалдах үүсмэл хэрэглүүр

ХЗУ69. УСНББОУС 41 ~~УСНББОУС 29~~ нь дагалдах үүсмэл хэрэглүүрийг үндсэн гэрээнээс салган тусгаарлахыг уг анх удаа мөрдөж буй байгууллагаас шаарддаг тохиолдолд УСНББОУС 41-д УСНББОУС 29-д заасан, хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг тухайн хэрэглүүр анх хангасан өдрөөрх түүний бүрэлдэхүүн хэсгүүдийн анхны дансны үнэ нь тэрхүү өдрөөрх нөхцөл байдлыг тусган илэрхийлдэг (УСНББОУС 41-ийн 49-р УСНББОУС 29-ийн 12-р параграф). Хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь дагалдах үүсмэл хэрэглүүр ба үндсэн гэрээний анхны дансны үнүүдийг найдвартай тодорхойлж чадахгүй бол тус байгууллага нь уг нийт нийлмэл хэрэглүүрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжинэ (УСНББОУС 41-ийн 52-р УСНББОУС 29-ийн 14-р параграф).

Хэмжилт

ХЗУ70. Эхлэлийн санхүүгийн байдлын тайлангаа бэлтгэх үедээ уг анх удаа мөрдөж буй байгууллага нь бодит үнэ цэнээр хэмжсэн ба хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийг ялган тодорхойлохын тулд УСНББОУС 41-д УСНББОУС 29-д заасан шалгуурыг ашиглана.

Аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдөр эсвэл шилжилтийн хугацаанд санхүүгийн хэрэглүүрийн дансны үнийг тохируулах

ХЗУ71. УСНББОУС 41-ийг ~~УСНББОУС 29-ийг~~ зөвхөн мөрдсөний үр дүнд, санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн дансны үнэд хийх тохируулгыг уг анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, эсвэл хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд чөлөөлөлт олгодог нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан буюу тэрхүү санхүүгийн хэрэглүүрийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдөр (аль түрүүнд болох өдөр) хуримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдэлд хүлээн зөвшөөрөх залруулга байдлаар бүртгэнэ. Санхүүгийн баталгааны гэрээ, эсвэл хейжийн хэрэглүүр гэж сонгосон болон үр дүнтэй хейжийн хэрэглүүр байх хэрэглүүрээс бусад, бүх үүсмэл хэрэглүүрийг худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэж ангилдаг учраас тэдгээр үүсмэл хэрэглүүрүүдийн өмнөх дансны үнэ (энэ нь тэг байж болно) ба бодит үнэ цэнийн хоорондох зөрүүг УСНББОУС 41-ийг ~~УСНББОУС 29-ийг~~ анх мөрдсөн санхүүгийн жилийн эхэнд, эсвэл хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд чөлөөлөлт олгодог нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан буюу тэрхүү санхүүгийн хэрэглүүрийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдөр (аль түрүүнд болох өдөр) хуримтлагдсан ашиг, алдагдлын үлдэгдлийн залруулга байдлаар хүлээн зөвшөөрнө.

Хейжийн нягтлан бодох бүртгэл

...

ХЗУ74. Анх удаа мөрдөж буй байгууллага нь урьдчилан таамагласан ажил гүйлгээний мөнгөн гүйлгээний хейжийн хувьд олз, гарзыг өөрийн нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хойшлуулдаг байж болно. УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, эсвэл хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд чөлөөлөлт олгодог нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан буюу тэрхүү санхүүгийн хэрэглүүрийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдөр

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

(аль түрүүнд болох өдөр) уг хейж хийсэн урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь өндөр магадлалтай биш боловч гарч тохиолдохоор хүлээгдэж байвал тэрхүү хойшлуулсан нийт олз, гарзыг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө. УСНББОУС 41-ийг ~~УСНББОУС 29-ийг~~ анх мөрдсөн өдөр, эсвэл хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд чөлөөлөлт олгодог нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан буюу тэрхүү санхүүгийн хэрэглүүрийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдөр (аль түрүүнд болох өдөр) цэвэр хөрөнгө/өмчид дахин ангилсан аливаа хуримтлагдсан цэвэр олз, гарз нь (а) уг урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь дараагийн тайлант үед санхүүгийн бус хөрөнгө эсвэл санхүүгийн бус өр төлбөр хүлээн зөвшөөрөхөд хүргэх, (б) уг урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь ашиг, алдагдалд нөлөөлөх, эсвэл (в) дараагийн тайлант үед нөхцөл байдал өөрчлөгдөж, уг урьдчилан таамагласан ажил гүйлгээ цаашид гарч тохиолдохоор хүлээгдэхээргүй болсон ба ингэснээр аливаа холбогдох хуримтлагдсан цэвэр олз, гарзыг цэвэр хөрөнгө/өмчөөс ашиг, алдагдалд дахин ангилах хүртэл цэвэр хөрөнгө/өмчид хэвээр үлдэнэ. Хэдийгээр хейжийн хэрэглүүрийг эзэмшсэн хэвээр байгаа боловч тухайн хейж нь УСНББОУС 41-д ~~УСНББОУС 29-д~~ заасан, мөнгөн гүйлгээний хейжийн шалгуурыг хангахгүй тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс эсвэл хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд чөлөөлөлт олгодог нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан буюу тэрхүү санхүүгийн хэрэглүүрийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдрөөс (аль түрүүнд болох өдрөөс) эхлэн хейжийн нягтлан бодох бүртгэл цаашид тохиромжгүй болдог.

...

УСНББОУС 33, Аккруэл Суурьт УСНББОУС-ыг Анх Удаа Мөрдөх-д заасан, шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд ба заалтуудын товчоо

ХЗУ91. Аккруэл суурьт бусад УСНББОУС-д тусгасан, шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд ба заалтуудыг дараах схемд товчоолон харуулав.

УСНББОУС	Олгосон шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд							
	Үгүй	Тийм						
		Төсөөлөн тооцсон өртөг	Хүлээн зөвшөөрөлтөөс 3 жилийн хугацаанд чөлөөлөх	Хэмжилтээс 3 жилийн хугацаанд чөлөөлөх	Хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтээс 3 жилийн хугацаанд чөлөөлөх	Тодруулгаас 3 жилийн хугацаанд чөлөөлөх	Ажил гүйлгээ, үлдэгдэл, орлого, зардлыг устгаж цэвэрлэх	Бусад
УСНББОУС 1, Санхүүгийн Тайлангийн Толилуулга						√ 3 жилийн чөлөөлөх хугацааг ашигладаг хэмжээгээр		• Зэрэгцүүлэгдэх мэдээлэл толилуулахыг дэмжсэн
УСНББОУС 2, Мөнгөн Гүйлгээний Тайлан	√							
УСНББОУС 3, Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа	√							
УСНББОУС 4, Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө								• Хуримтлагдсан хөрвүүлэлтийн шаардлагыг мөрдөхөөс чөлөөлсөн
УСНББОУС 5, Зээлийн Өртөг			√ Зөвшөөрөгдсөн сонголтот аргыг нягтлан бодох бүртгэлийн					• Бенчмарк аргыг буцаах горимоор мөрдөхийг дэмжсэн • Зөвшөөрөгдсөн сонголтот аргыг буцаах горимоор мөрдөх ёстой.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

			бодлого гэж сонгосон үед				
УСНББОУС 6, <i>Нэгтгэсэн ба Тусдаа Санхүүгийн Тайлан</i> (УСНББОУС 35, <i>Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан</i>)		√			√ Бусад байгууллага дахь хувь оролцоог зохих ёсоор ангилж, тодорхойлох		√ • Хяналт тавигч байгууллага ба хяналтанд буй байгууллага нь УСНББОУС-ыг өөр өөр хугацаанд мөрдсөн үеийн заалт • Нэгтгэсэн санхүүгийн тайлан байдлаар санхүүгийн тайланг бэлтгэхгүй байх чөлөөлөх нөхцөл • (<i>Хөрөнгө оруулалтын байгууллагыг УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр үнэлэх ба уг өдөр бодит үнэ цэнээр хэмжих</i>)
УСНББОУС 7, <i>Хараат Байгууллага дахь Хөрөнгө Оруулалт</i> (УСНББОУС 36, <i>Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт</i>)		√			√ Бусад байгууллага дахь хувь оролцоог зохих ёсоор ангилж, тодорхойлох		√ • Хяналт тавигч байгууллага ба хараат байгууллага нь УСНББОУС-ыг өөр өөр хугацаанд мөрдсөн үеийн заалт • Хараат байгууллага дахь хөрөнгө оруулалтыг нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгахгүй байх чөлөөлөх нөхцөл
УСНББОУС 8, <i>Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт</i> (УСНББОУС 36, <i>Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт</i>)		√			√ Бусад байгууллага дахь хувь оролцоог зохих ёсоор ангилж, тодорхойлох		√ • Хяналт тавигч байгууллага, хараат байгууллага, хамтын хяналтанд буй байгууллага нь УСНББОУС-ыг өөр өөр хугацаанд мөрдсөн үеийн заалт • Хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоог нэгтгэсэн

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

								санхүүгийн тайланд тусгахгүй байх чөлөөлөх нөхцөл
(УСНББОУС 37, <i>Хамтын Хэлэлцээр</i>)								<ul style="list-style-type: none"> Хувь тэнцүүлэн нэгтгэх аргыг ашиглан өмнө нь тайлагнасан хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтыг хэрхэн хэмжих талаархи заалт
УСНББОУС 9, <i>Арилжааны Ажил Гүйлгээний Орлого</i>	√				√ Хөрөнгө, өр төлбөрийн хувьд 3 жилийн чөлөөлөх хугацааг ашигладаг хэмжээгээр			
УСНББОУС 10, <i>Хэт Инфляцитай Эдийн Засгийн Үеийн Санхүүгийн Тайлагнал</i>								<ul style="list-style-type: none"> Ноцтой хэт инфляцийн талаархи заалт
УСНББОУС 11, <i>Барилгын Гэрээ</i>	√							
УСНББОУС 12, <i>Бараа Материал</i>		√	√ Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрөөгүй бараа материал	√ Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрсөн бараа материал				
УСНББОУС13, <i>Түрээс</i>			√ Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрөөгүй түрээсийн	√ Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрсөн түрээсийн				

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

			хөрөнгө, өр төлбөр	хөрөнгө, өр төлбөр				
УСНББОУС 14, <i>Тайлангийн Өдрийн Дараах Үйл Явдал</i>	√							
УСНББОУС 16, <i>Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө</i>		√	√ Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрөөгүй хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	√ Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрсөн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө				
УСНББОУС 17, <i>Үндсэн Хөрөнгө</i>		√	√ Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрөөгүй үндсэн хөрөнгө	√ Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрсөн үндсэн хөрөнгө				
УСНББОУС 18, <i>Сегментийн Тайлагнал</i>	√ 3 жилийн чөлөөлөх хугацааг ашигладаг бол сегментийн тайлан гаргахгүй							
УСНББОУС 19, <i>Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө</i>			√ Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрөөгүй хөрөнгөгэй	√ Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрсөн				

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

			зөвхөн холбоотой өр төлбөрийг тухайн зүйлийн буулгах, холдуулах ба газар талбайг хэвийн байдалд оруулах өртөг зардлын анхны тооцоололд оруулна	хөрөнгөтэй зөвхөн холбоотой өр төлбөрийг тухайн зүйлийн буулгах, холдуулах ба газар талбайг хэвийн байдалд оруулах өртөг зардлын анхны тооцоололд оруулна				
УСНББОУС 20, <i>Холбоотой Талуудын Тодруулга</i>						√		
УСНББОУС 21, <i>Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт</i>								• Гүйцээх горимоор мөрдөх
УСНББОУС 22, <i>Засгийн Газрын Үндсэн Секторын Талаархи Санхүүгийн Мэдээллийн Тодруулга</i>	√							
УСНББОУС 23, <i>Арилжааны Бус Ажил Гүйлгээний Орлого</i>			√ Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрөөгүй арилжааны бус бүх орлого	√ Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрсөн арилжааны бус бүх орлого	√ Хөрөнгө, өр төлбөрийн хувьд 3 жилийн чөлөөлөх хугацааг ашигладаг хэмжээгээр			
УСНББОУС 24, <i>Санхүүгийн Тайлан</i>	√							

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

дахь Төсвийн Мэдээллийн Толлуулга								
УСНББОУС 25, Ажилтны Тэтгэмж (УСНББОУС 39, Ажилтны Тэтгэмж)			√ Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрөөгүй тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр ба ажилтны урт хугацааны бусад тэтгэмж	√ Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрсөн тогтоосон тэтгэмж болон ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийн хувьд				<ul style="list-style-type: none"> • Анхны өр төлбөрийг хэрхэн тодорхойлох талаархи заалт • Хуримтлагдсан актуар олз ба гарзыг салган тусгаарлахгүй байх заалт • Туршлагад үндэслэсэн тохируулгын талаархи хэтийн мэдээлэл
УСНББОУС 26, Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт			√					<ul style="list-style-type: none"> • Гүйцээх горимоор мөрдөх
УСНББОУС 27, Хөдөө Аж Ахуй			√ Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрөөгүй биологийн хөрөнгө ба хөдөө аж ахуйн үйл ажиллагаа	√ Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрсөн биологийн хөрөнгө ба хөдөө аж ахуйн үйл ажиллагаа				
УСНББОУС 28, Санхүүгийн Хэрэглүүр: Толлуулга								<ul style="list-style-type: none"> • Тодорхой нөхцөлд өр төлбөр ба цэвэр хөрөнгө/ өмчийн бүрэлдэхүүн хэсгүүдийг салган зааглахгүй байх заалт
УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн		√	√ Нягтлан бодох бүртгэлийн	√ Нягтлан бодох бүртгэлийн				<ul style="list-style-type: none"> • Хөйжийн сонголт, үл хүлээн зөвшөөрөлт, хөйжийн нягтлан бодох

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

<i>Зөвшөөрөлт ба Хэмжилт</i>			өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрөөгүй санхүүгийн хэрэглүүр	өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хэрэглүүр				бүртгэлийн талаархи заалт • Үнэ цэнийн бууралтын зарчмыг гүйцээх горимоор мөрдөх
УСНББОУС 30, <i>Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга</i>								• Эрсдлийн шинж төрөл ба хэмжээний талаар зэрэгцүүлэгдэх мэдээлэл толилуулахгүй
УСНББОУС 31, <i>Биет Бус Хөрөнгө</i>		√ Дотооддоо бий болгосноос бусад биет бус хөрөнгө	√ Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрөөгүй биет бус хөрөнгө	√ Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрсөн биет бус хөрөнгө				• Дотооддоо бий болгосон ба өмнө нь зардлаар бүртгэсэн биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрөх заалт
УСНББОУС 32, <i>Үйлчилгээний Концессын Хэлцэл</i>		√ Үйлчилгээний концессын хөрөнгө	√ Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрөөгүй үйлчилгээний концессын хөрөнгө ба холбогдох өр төлбөр	√ Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрсөн үйлчилгээний концессын хөрөнгө ба холбогдох өр төлбөр				• Холбогдох өр төлбөрийг хэрхэн хүлээн зөвшөөрөх талаархи заалт
УСНББОУС 41, <i>Санхүүгийн Хэрэглүүр</i>		√	√ Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрөөгүй санхүүгийн хэрэглүүр	√ Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хэрэглүүр				• Хейжийн сонголт, үл хүлээн зөвшөөрөлт, хейжийн нягтлан бодох бүртгэлийн талаархи заалт • Үнэ цэнийн бууралтын зарчмыг гүйцээх горимоор мөрдөх

Хавсралт

Аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, анх удаа мөрдөж буй байгууллага нь мөрдөх шаардлагатай ба/буюу мөрдөхөөр сонгож болох шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд ба заалтуудын хоорондох ялгаатай талууд

Шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцөл буюу заалт	Мөрдөх шаардлагатай шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд буюу заалтууд	Мөрдөж эсвэл сонгож болох шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд буюу заалтууд	
	Үнэн зөв толилуулга ба аккруэл суурьт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөхгүй	Үнэн зөв толилуулга ба аккруэл суурьт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөхгүй	Үнэн зөв толилуулга ба аккруэл суурьт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөх
УСНББОУС 1 • Зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулах		√	
УСНББОУС 4 • УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөрх шилжилтийн үеийн хуримтлагдсан зөрүү		√	
УСНББОУС 5 • Зөвшөөрөгдсөн сонголтот арга, түүнчлэн чөлөөлтийн хугацааны давуу талыг ашигладаг • УСНББОУС-ыг мөрдсөн өдөр зөвшөөрөгдсөн сонголтот аргыг хэрэглэх – буцаах горимоор мөрдөх • УСНББОУС-ыг мөрдсөн өдөр бенчмарк аргыг хэрэглэх – Мөрдсөн өдрөөс өмнө болон дараа гарсан өртөг зардлын хувьд буцаах горимоор мөрдөх	√	√	√
УСНББОУС 6 (УСНББОУС 35) • Хяналтанд буй байгууллага дахь хувь оролцоог хүлээн зөвшөөрөх ба/буюу хэмжихээс чөлөөлөх • Байгууллага хоорондын үлдэгдэл, ажил гүйлгээ, орлого, зардлыг устгаж цэвэрлэхгүй байх сонголт хийх • Хяналтанд буй байгууллага нь өөрийн хяналт тавигч байгууллагаас хожуу эсвэл эрт анх удаа мөрдөж буй байгууллага болох • Хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилт, устгаж цэвэрлэх сонголтын хувьд гурван жилийн	√		√ √ √

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

<p>чөлөөлөх хугацааг ашигладаг бол санхүүгийн тайлангаа нэгтгэсэн санхүүгийн тайлан байдлаар толилуулахгүй байх</p> <ul style="list-style-type: none"> • <i>(Хөрөнгө оруулалтын байгууллагыг УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр үнэлэх ба уг өдөр бодит үнэ цэнээр хэмжих)</i> 	√		
<p>УСНББОУС 7 (УСНББОУС 36)</p> <ul style="list-style-type: none"> • Хараат байгууллага дахь хувь оролцоог хүлээн зөвшөөрөх ба/буюу хэмжихээс чөлөөлөх • Хараат байгууллагын ашиг, алдагдал дахь хувь оролцоог устгаж цэвэрлэхгүй байх сонголт хийх • Хараат байгууллага нь өөрийн хяналт тавигч байгууллагаас хожуу эсвэл эрт анх удаа мөрдөж буй байгууллага болох • Хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилт, устгаж цэвэрлэх сонголтын хувьд гурван жилийн чөлөөлөх хугацааг ашигладаг бол хараат байгууллага дахь хөрөнгө оруулалтыг нэгтгэсэн санхүүгийн тайланд толилуулахгүй байх 	√		√ √ √
<p>УСНББОУС 8 (УСНББОУС 36)</p> <ul style="list-style-type: none"> • Хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоог хүлээн зөвшөөрөх ба/буюу хэмжихээс чөлөөлөх • Хамтын хяналтанд буй байгууллагуудын хоорондох үлдэгдэл ба ажил гүйлгээг устгаж цэвэрлэхгүй байх сонголт хийх • Хамтарсан үйлдвэр нь өөрийн хяналт тавигч байгууллагаас хожуу эсвэл эрт анх удаа мөрдөж буй байгууллага болох • Хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилт, устгаж цэвэрлэх сонголтын хувьд гурван жилийн чөлөөлөх хугацааг ашигладаг бол хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоог нэгтгэсэн санхүүгийн тайланд толилуулахгүй байх 	√		√ √ √
<p>УСНББОУС 37</p> <ul style="list-style-type: none"> • <i>Хувь тэнцүүлэн нэгтгэх аргыг ашиглан өмнө нь тайлагнасан хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтыг хэмжих</i> 	√		

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

УСНББОУС 9 • Санхүүгийн хэрэглүүрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд гурван жилийн чөлөөлөх хугацааг мөрдсөнтэй холбоотойгоор орлогын хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтээс чөлөөлөх			√
УСНББОУС 10 • Хэт инфляцитай эдийн засаг нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр ноцтой хэт инфляцид өртөх эсэхийг тодорхойлох • УСНББОУС-ыг мөрдсөн өдөр нь тогтворжуулалтын өдөр эсвэл түүнээс хойш байвал хөрөнгө, өр төлбөрийг хэмжих	√ √		
УСНББОУС 12 • Хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд гурван жилийн чөлөөлөх хугацаа олгох ба хөрөнгийг хэмжих нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрчлөх			√
УСНББОУС 13 • Хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд чөлөөлөх хугацааг ашигладаг бол санхүүгийн түрээсийн өр төлбөр ба санхүүгийн түрээсийн хөрөнгийг хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй • Түрээсийн ангилал нь аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөрх нөхцөл байдалд үндэслэдэг	√		√
УСНББОУС 16 • Хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд гурван жилийн чөлөөлөх хугацаа олгох ба хөрөнгийг хэмжих нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрчлөх			√
УСНББОУС 17 • Хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд гурван жилийн чөлөөлөх хугацаа олгох ба хөрөнгийг хэмжих нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрчлөх			√
УСНББОУС 18			

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

<ul style="list-style-type: none"> • УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс хойш гурван жилийн дотор сегментийн тайланг бэлтгэхгүй 		√	
<p>УСНББОУС 19</p> <ul style="list-style-type: none"> • Хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд чөлөөлөх хугацааг ашигладаг бол тухайн зүйлийн буулгах, холдуулах өртөг зардлын анхны тооцоололтой холбоотойгоор өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй ба хэмжихгүй 			√
<p>УСНББОУС 20</p> <ul style="list-style-type: none"> • Холбоотой талуудын харилцаа, холбоотой талуудын ажил гүйлгээ болон эрх бүхий албан тушаалтны талаархи мэдээллийг тодруулахгүй 			√
<p>УСНББОУС 21</p> <ul style="list-style-type: none"> • УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс, эсвэл хэрэв чөлөөлөлтийн хугацааг ашигладаг бол хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн өдрөөс эхлэн үнэ цэнийн бууралтын нөхцлийг гүйцээх горимоор мөрдөх 	√		
<p>УСНББОУС 25 (УСНББОУС 39)</p> <ul style="list-style-type: none"> • Хөрөнгө, өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд гурван жилийн чөлөөлөх хугацаа олгох ба хөрөнгө, өр төлбөрийг хэмжих нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрчлөх • Тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн болон ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийн хувьд анхны өр төлбөрийг УСНББОУС-ыг мөрдсөн өдөр эсвэл чөлөөлөх нөхцлийн хугацаа дууссан өдөр тодорхойлох • Нэмэгдэлт/бууралтыг УСНББОУС-ыг мөрдсөн өдөр эсвэл чөлөөлөх нөхцлийн хугацаа дууссан өдөр хуримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдэлд хүлээн зөвшөөрөх 	√		√
<p>УСНББОУС 26</p> <ul style="list-style-type: none"> • УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс, эсвэл хэрэв чөлөөлөлтийн хугацааг ашигладаг бол хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн өдрөөс эхлэн үнэ 	√		

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

цэнийн бууралтын нөхцлийг гүйцээх горимоор мөрдөх			
УСНББОУС 27 • Хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд гурван жилийн чөлөөлөх хугацаа олгох ба хөрөнгийг хэмжих нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрчлөх			√
УСНББОУС 28 • Санхүүгийн хэрэглүүр нь УСНББОУС-ыг мөрдсөн өдөр өр төлбөрийн болон цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсэгтэй эсэхийг тодорхойлох • УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр өр төлбөр байгаагүй бол нийлмэл санхүүгийн хэрэглүүрийг салган зааглах шаардлагагүй	√ √		
УСНББОУС 29 • Хөрөнгө, өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд гурван жилийн чөлөөлөх хугацаа олгох ба хөрөнгө, өр төлбөрийг хэмжих нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрчлөх <i>Ангилал</i> • УСНББОУС-ыг мөрдсөн өдөр санхүүгийн хөрөнгө буюу өр төлбөрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилах <i>Үнэ цэнийн бууралт</i> • УСНББОУС-ыг мөрдсөн өдөр үнэ цэнийн бууралтын нөхцлийг гүйцээх горимоор мөрдөх <i>Үл хүлээн зөвшөөрөлт</i> • УСНББОУС-ыг мөрдсөн өдөр үл хүлээн зөвшөөрөлтийн нөхцлийг гүйцээх горимоор мөрдөх • Анх бүртгэх өдөр мэдээлэл нь бэлэн боломжтой байвал үл хүлээн зөвшөөрөлтийн нөхцлийг буцаах горимоор мөрдөх <i>Хейжийн нягтлан бодох бүртгэл</i> • Үүсмэл хэрэглүүрийг бодит үнэ цэнээр хэмжих	√ √ √ √	√	

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

<ul style="list-style-type: none"> • Хойшлуулсан бүх олз, гарзыг устгаж цэвэрлэх • УСНББОУС-ыг мөрдсөн өдөр хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг зөвхөн хангах хейжийг тусгах • УСНББОУС-ыг мөрдсөн өдөр хейжийн нягтлан бодох бүртгэлийн нөхцөл хангагдахгүй бол хейжийн ажил гүйлгээг зогсоох 	√		
<p>УСНББОУС 30</p> <ul style="list-style-type: none"> • Эрсдлийн шинж төрөл ба хэмжээний талаархи мэдээллийг тодруулахгүй 		√	
<p>УСНББОУС 31</p> <ul style="list-style-type: none"> • Хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд гурван жилийн чөлөөлөх хугацаа олгох ба хөрөнгийг хэмжих нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрчлөх • Дотооддоо бий болгосон бүх биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрөх 	√		√
<p>УСНББОУС 32</p> <ul style="list-style-type: none"> • Хөрөнгө, өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд гурван жилийн чөлөөлөх хугацаа олгох ба хөрөнгө, өр төлбөрийг хэмжих нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрчлөх • УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, эсвэл хэрэв чөлөөлөлтийн хугацааг ашигладаг бол хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн өдөр санхүүгийн өр төлбөрийн загвар ба эзэмшигчид эрх олгох загварын аль нэгээр өр төлбөрийг хэмжих 	√		√
<p>Хөрөнгө, өр төлбөрийн хувьд төсөөлөн тооцсон өртгийг ашиглах</p>		√	
<p>Арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн хөрөнгийн хувьд төсөөлөн тооцсон өртгийг ашиглах</p>		√	
<p>Хяналтанд буй байгууллага, хамтын хяналтанд буй байгууллага, хараат байгууллагад оруулсан хөрөнгө оруулалтын хувьд төсөөлөн тооцсон өртгийг ашиглах</p>		√	

УСНББОУС 34, Тусдаа Санхүүгийн Тайлан-д оруулсан нэмэлт өөрчлөлт

6, 12, 13, 14, 15, 22, 26, 30-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 32Б параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Тодорхойлолт

6. Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

Нэгтгэсэн санхүүгийн тайлан гэдэг нь хяналт тавигч байгууллага болон түүний хяналтанд буй байгууллагуудын хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч, орлого, зардал, мөнгөн гүйлгээг эдийн засгийн нэг аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан мэтээр толилуулдаг эдийн засгийн нэгдмэл байгууллагын санхүүгийн тайлан юм.

Тусдаа санхүүгийн тайлан гэдэг нь хяналтанд буй байгууллага, хамтарсан үйлдвэр, хараат байгууллага дахь өөрийн хөрөнгө оруулалтыг УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр-ийн УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зовшооролт ба Хэмжээний дагуу өртгөөр нь, эсвэл УСНББОУС 36, Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт-д заасан өмчийн аргыг ашиглан тайлагнах сонголтыг энэхүү Стандартын шаардлагуудын дагуу хийж чадах тийм байгууллагын толилуулж буй санхүүгийн тайлан юм.

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь*-д дахин нийтэлсэн болно. Дараах нэр томъёог УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*, УСНББОУС 36, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт*, УСНББОУС 37, *Хамтын Хэлэлцээр*-т тодорхойлсон. Үүнд: хараат байгууллага, хяналт, хяналтанд буй байгууллага, хяналт тавигч байгууллага, эдийн засгийн нэгдмэл байгууллага, өмчийн арга, хөрөнгө оруулалтын байгууллага, хамтын хяналт, хамтын үйл ажиллагаа, хамтарсан үйлдвэр, хамтарсан үйлдвэрийн хувь оруулагч, мэдэгдэхүйц нөлөө.

...

Тусдаа санхүүгийн тайланг бэлтгэх

...

12. Байгууллага нь тусдаа санхүүгийн тайлан гаргадаг тохиолдолд хяналтанд буй байгууллага, хамтарсан үйлдвэр, хараат байгууллага дахь адилтгах хөрөнгө оруулалтуудыг дараах хувилбаруудын аль нэгээр бүртгэж тайлагнана:

- (a) Өртгөөр нь;
- (b) УСНББОУС 41-ийн УСНББОУС 29-ийн дагуу; эсвэл
- (в) УСНББОУС 36-д заасны дагуу өмчийн аргыг ашиглана.

13. УСНББОУС 36-гийн 24-р параграфт заасанчлан, хэрэв байгууллага нь хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх өөрийн хөрөнгө оруулалтыг УСНББОУС 41-ийн УСНББОУС 29-ийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих сонголт хийсэн бол тусдаа санхүүгийн тайландаа тэдгээр хөрөнгө оруулалтыг мөн энэхүү арга замаар тайлагнана.

14. УСНББОУС 35-ын 56-р параграфт заасанчлан, хэрэв хяналт тавигч байгууллага нь хяналтанд буй байгууллага дахь өөрийн хөрөнгө оруулалтыг УСНББОУС 41-ийн

~~УСНББОУС 29-ийн~~ дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих шаардлагатай бол хяналтанд буй байгууллага дахь уг хөрөнгө оруулалтыг өөрийн тусдаа санхүүгийн тайландаа мөн энэхүү арга замаар тайлагнана. Өөрөө хөрөнгө оруулалтын байгууллага биш, хяналт тавигч байгууллага нь УСНББОУС 35-ын 58-р параграфт заасанчлан, хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын хөрөнгө оруулалтыг УСНББОУС 41-ийн ~~УСНББОУС 29-ийн~~ дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ба уг хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын бусад хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг нэгтгэх шаардлагатай бол тус байгууллага нь хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллага дахь тэрхүү хөрөнгө оруулалтыг өөрийн тусдаа санхүүгийн тайландаа мөн энэхүү арга замаар тайлагнана.

15. Хяналт тавигч байгууллага нь хөрөнгө оруулалтын байгууллага байхаа больсон, эсвэл хөрөнгө оруулалтын байгууллага болсон тохиолдолд ийнхүү статус өөрчлөгдсөн өдрөөс эхлэн уг өөрчлөлтийг дараах байдлаар тайлагнана:

(а) Байгууллага нь хөрөнгө оруулалтын байгууллага байхаа больсон тохиолдолд хяналтанд буй байгууллага дахь хөрөнгө оруулалтаа 12-р параграфын дагуу тайлагнана. Ийм статусын өөрчлөлтийн огноо нь төсөөлөн тооцсон худалдан авалтын өдөр байна. Хөрөнгө оруулалтыг 12-р параграфын дагуу тайлагнах үед тэрхүү төсөөлөн тооцсон худалдан авалтын өдрөөрх уг хяналтанд буй байгууллагын бодит үнэ цэнэ нь төсөөлөн тооцсон, шилжүүлэх төлбөрийн дүнг илэрхийлнэ.

(б) Байгууллага нь хөрөнгө оруулалтын байгууллага болсон тохиолдолд хяналтанд буй байгууллага дахь хөрөнгө оруулалтаа УСНББОУС 41-ийн ~~УСНББОУС 29-ийн~~ дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр тайлагнана. Хяналтанд буй байгууллагын өмнөх дансны үнэ ба хөрөнгө оруулагчийн статуст өөрчлөлт орсон уг өдрөөрх түүний бодит үнэ цэнийн хоорондох зөрүүг ашиг, алдагдалд олз эсвэл гарз байдлаар хүлээн зөвшөөрнө. Тэдгээр хяналтанд буй байгууллагуудтай холбоотойгоор цэвэр хөрөнгө/өмчид өмнө нь шууд хүлээн зөвшөөрч байсан аливаа олз, гарзын хуримтлагдсан дүнг тухайн хөрөнгө оруулалтын байгууллага нь статуст өөрчлөлт орсон өдрөөр тэдгээр хяналтанд буй байгууллагуудаа данснаас хассан мэтээр бүртгэнэ.

...

Тодруулга

...

22. Өөрөө хөрөнгө оруулалтын байгууллага биш, хяналт тавигч байгууллага нь УСНББОУС 35-ын 56-р параграфт заасанчлан, хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын хөрөнгө оруулалтыг УСНББОУС 41-ийн ~~УСНББОУС 29-ийн~~ дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ба уг хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын бусад хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг нэгтгэх шаардлагатай бол энэ тухай тодруулга хийнэ. Тус байгууллага нь УСНББОУС 38, Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцооны Тодруулга-аар шаардсан, хөрөнгө оруулалтын байгууллагуудад хамаарах тодруулгыг мөн толилуулна.

...

Шилжилтийн нөхцөл

...

26. УСНББОУС 41-ийн ~~УСНББОУС 29-ийн~~ дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжихээр өмнө нь сонгож шийдсэн, хяналтанд буй байгууллага дахь хувь

оролцооны өмнөх тайлагналын хувьд 12-р параграфтаар зөвшөөрсний дагуу хөрөнгө оруулалтын байгууллага нь Стандартыг анх мөрдөх үедээ тохируулга хийхгүй.

...

30. Стандартыг анх мөрдсөн өдөр, өөрөө хөрөнгө оруулалтын байгууллага биш боловч УСНББОУС 35-ын 56-р параграфт заасанчлан, хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын хөрөнгө оруулалтыг УСНББОУС 41-ийн УСНББОУС 29-ийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ба уг хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын бусад хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг нэгтгэх шаардлагатай, хяналт тавигч байгууллага нь тэрхүү хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллага дахь өөрийн хөрөнгө оруулалтыг тусдаа санхүүгийн тайландаа тайлагнахдаа 24-29-р параграфт заасан, шилжилтийн нөхцлүүдийг ашиглана.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

- 32Б. 2018 оны 8 дугаар сард гаргасан, УСНББОУС 41-ээр 6, 12, 13, 14, 15, 22, 26, 30-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд УСНББОУС 41-ийг мөн уг өмнөх тайлант хугацаанд дагаж мөрдөнө.

...

Дүгнэлтийн Үндэслэл

Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 34-ийг дагалдах боловч түүний салиггүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

...

Тусдаа санхүүгийн тайланд өмчийн аргыг ашиглах

- ДҮ3. Байгууллага нь хяналтанд буй байгууллага, хамтын хяналтанд буй байгууллага, хараат байгууллага дахь хөрөнгө оруулалтыг өөрийн тусдаа санхүүгийн тайландаа дараах байдлаар хэмжихийг УСНББОУС 6-гаар зөвшөөрдөг байсан:

- (а) Өмчийн арга ашиглан;
- (б) Өртгөөр; эсвэл
- (в) УСНББОУС 41-д УСНББОУС 29-д заасанчлан, санхүүгийн хэрэглүүр байдлаар.

...

- ДҮ6. УСНББОУС3 нь дараах шалтгааны улмаас тусдаа санхүүгийн тайланд өмчийн арга ашиглахыг үргэлжлүүлэн зөвшөөрөхөөр шийдвэрлэсэн:

- (а) Өмчийн арга нь улсын секторын зарим хөрөнгө оруулалтыг тайлагнах сайн зохион байгуулагдсан арга юм. Улсын секторын байгууллагууд нь хөрөнгө оруулалтыг эзэмшиж байх маш олон нөхцөл байдалд өмчийн арга нь өртгийн арга ба бодит үнэ цэнийн аргаас илүү найдвартай, ач холбогдолтой бөгөөд магадгүй арай бага өртөг зардалтай мэдээллээр хангадаг. Хувийн секторт нийтлэг тохиолддогийн адилаар хөрөнгө

оруулалтын зорилгоор эзэмших биш, харин үйлчилгээ үзүүлэх боломжтой байхын тулд хөрөнгө оруулалтын байгууллагуудыг улсын секторт ихэвчлэн “хэрэглүүр” болгон ашигладаг. Өмчийн арга нь хөрөнгө оруулалтаас хамааран өмч болон үр дүнд цаг хугацааны явцад гарах хувьсан өөрчлөлтийг санхүүгийн тайланд өртөг зардал багатай бөгөөд хялбар ойлгомжтой байдлаар тусган харуулах боломж олгодог тул зарим тохиолдолд улсын секторын хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангахад илүү сайн тохирдог байж болох юм.

- (б) Өртгийн аргыг хэрэглэхэд ихэвчлэн харьцангуй хялбар байдаг боловч хөрөнгө оруулалтыг тодорхой хугацаагаар эзэмших тохиолдолд өртгийн арга ашиглах нь хуучирсан ба хамаарал багатай мэдээлэл бий болгох үр дүнтэй бөгөөд ингэснээр хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байж болох юм.
- (в) Улсын секторын хувьд идэвхитэй зах зээлгүй болон бодит үнэ цэнийг нь шууд ажиглах боломжгүй тийм хөрөнгө оруулалтууд өндөр хувь хэмжээтэй байх магадлалтай юм. Ийм хөрөнгө оруулалтуудын үнэ цэнийг тогтоохдоо УСНББОУС 41-д ~~УСНББОУС 29-д~~ заасан, заавар удирдамжийг ашиглаж болох боловч энэ арга хандлага нь ерөнхийдөө суурь нөхцөл байдлыг үнэн зөв төлөөлөн илэрхийлэхгүй тийм мэдээллийг бий болгох үр дүнтэй байдаг гэж УСНББОУС3 үзсэн.

...

Хөрөнгө оруулалтын байгууллагын тусдаа санхүүгийн тайлан

ДҮ8. УСНББОУС 35-ыг боловсруулахдаа, УСНББОУС3 нь хөрөнгө оруулалтын байгууллага гэсэн ойлголт ухагдахууныг нэвтрүүлэх, түүнчлэн хөрөнгө оруулалтын байгууллага болох хяналт тавигч байгууллага нь өөрийн хяналтанд буй ихэнх байгууллагууд дахь хөрөнгө оруулалтыг УСНББОУС 41-ийн ~~УСНББОУС 29-ийн~~ дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжихийг шаардах шийдвэр гаргасан. Иймээс УСНББОУС3 нь өөрийн хяналтанд буй байгууллагуудад оруулсан хөрөнгө оруулалтыг тусдаа санхүүгийн тайландаа ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжихийг хөрөнгө оруулалтын байгууллагаас шаардахаар шийдвэрлэсэн. Өөрийн цорын ганц санхүүгийн тайлан байдлаар тусдаа санхүүгийн тайланг бэлтгэж буй хөрөнгө оруулалтын байгууллага нь хяналтанд буй байгууллагууд дахь хувь оролцооны талаар УСНББОУС 38-д шаардсан тодруулгыг мөн хийх хэрэгтэй гэж УСНББОУС3 шийдвэрлэсэн.

ДҮ9. Өөрөө хөрөнгө оруулалтын байгууллага биш боловч хөрөнгө оруулалтын байгууллагын хяналт тавигч байгууллага нь дараах байдлаар нэгтгэсэн санхүүгийн тайланг толилуулахыг УСНББОУС3 нь түүнээс шаардахаар шийдвэрлэсэн. Үүнд: (i) хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын хөрөнгө оруулалтыг УСНББОУС 41-ийн ~~УСНББОУС 29-ийн~~ дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих, ба (ii) уг хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын бусад хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг нэгтгэх. Ингэснээр хөрөнгө оруулалтын бус хяналт тавигч байгууллага нь хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллага дахь өөрийн хөрөнгө оруулалтыг тусдаа санхүүгийн тайландаа ижил арга замаар хэмжих хэрэгтэй гэж УСНББОУС3 нь шаардахаар шийдвэрлэсэн.

...

УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*-д оруулсан нэмэлт өөрчлөлт

22, 45, 52, 55А, 56, 58, МЗУ105-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 79Д параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Хяналт

...

22. Хоёр буюу хэд хэдэн байгууллагууд нь холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэхийн тулд хамтран ажиллах шаардлагатай тохиолдолд тэдгээр нь бусад байгууллагыг хамтран хянадаг. Энэ тохиолдолд нэг байгууллага нь нөгөө байгууллагуудтай хамтрахгүйгээр үйл ажиллагааг удирдан чиглүүлж чадахгүй учраас аль нэг байгууллага нь уг бусад байгууллагыг дангаараа хянахгүй. Байгууллага бүр нь уг бусад байгууллага дахь өөрийн хувь оролцоог УСНББОУС 36, УСНББОУС 37 буюу санхүүгийн хэрэглүүрийг зохицуулдаг УСНББОУС-ууд (УСНББОУС 28, *Санхүүгийн Хэрэглүүр: Толлуулга, УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*, УСНББОУС 30, *Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга, УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр*) гэх мэт холбогдох УСНББОУС-уудын дагуу тайлагнана.

...

Боломжит саналын эрх

...

45. Нэгтгэсэн хяналтанд буй байгууллагуудын хувь оролцооны хувьд УСНББОУС 28 ба УСНББОУС 41-ийг ~~УСНББОУС 29-ийг~~ мөрдөхгүй. Боломжит саналын эрхийг агуулсан хэрэглүүр нь хяналтанд буй байгууллага дахь өмчлөлийн хувь оролцоотой холбоотой өгөөжийг хүртэх эрхийг мөн чанарын хувьд одоо олгодог тохиолдолд уг хэрэглүүр нь УСНББОУС 28 ба УСНББОУС 41-ийн ~~УСНББОУС 29-ийн~~ шаардлагуудад хамаарахгүй. Бусад бүх тохиолдолд хяналтанд буй байгууллага дахь боломжит саналын эрхийг агуулсан хэрэглүүрийг УСНББОУС 28 ба УСНББОУС 41-ийн ~~УСНББОУС 29-ийн~~ дагуу тайлагнана.

...

Хяналтаа алдах

52. **Хэрэв хяналт тавигч байгууллага нь хяналтанд буй байгууллага дахь хяналтаа алдвал уг хяналт тавигч байгууллага нь:**
- (a) **Өмнө нь хяналтанд байсан байгууллагын хөрөнгө, өр төлбөрийг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаас хасаж, үл хүлээн зөвшөөрнө;**
 - (б) **Хяналтаа алдах үед өмнө нь хяналтанд байсан уг байгууллагад хадгалан үлдсэн аливаа хөрөнгө оруулалтыг хүлээн зөвшөөрч, түүнийг болон тухайн хяналтанд байсан байгууллагаас авах эсвэл түүнд төлөх дүнг холбогдох УСНББОУС-уудын дагуу дараагийн тайлант үед тайлагнана. Тэрхүү үлдсэн хувь оролцоог 54(б)(iii) ба 55А параграфт заасны дагуу дахин хэмжинэ. Хяналтаа алдсан өдрөөр уг дахин хэмжсэн үнэ цэнийг УСНББОУС 41-ийн ~~УСНББОУС 29-ийн~~ дагуу санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнэ, хэрэв хамааралтай бол тухайн хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтыг анх хүлээн зөвшөөрөх үеийн өртөг гэж үзнэ.**
 - (в) **Өмнөх хяналтын хувь оролцоонд хамаарах хяналтаа алдсантай холбоотой олз, гарзыг 54-55А параграфт тусгайлан заасны дагуу хүлээн зөвшөөрнө.**

...

- 55А. **Өмчийн арга ашиглан тайлагнадаг хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэртэй холбоотой ажил гүйлгээний үр дүнд хяналт тавигч байгууллага нь УСНББОУС 40-д тодорхойлсон үйл ажиллагааг өөртөө агуулаагүй тийм хяналтанд буй байгууллагын хяналтаа алдсан бол тухайн хяналт тавигч байгууллага нь уг олз, гарзыг 54-55-р параграфын дагуу тодорхойлно. Уг ажил гүйлгээнээс үүссэн олз, гарзыг тэрхүү хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх зөвхөн харилцан холбоогүй хөрөнгө оруулагчдын хувь оролцооны хэмжээгээр тухайн хяналт тавигч байгууллагын ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Олзын үлдсэн хэсгийг тэрхүү хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтын дансны үнээс хасаж, устгана. Түүнчлэн, хэрэв**

хяналт тавигч байгууллага өмнө нь хяналтанд байсан байгууллагадаа хөрөнгө оруулалтын тодорхой хэсгийг хадгалж үлдсэн бөгөөд уг хяналтанд байсан байгууллага нь одоо өмчийн арга ашиглан тайлагнах хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр болсон бол тухайн хяналт тавигч байгууллага нь уг хяналтанд байсан байгууллагад хадгалж үлдсэн хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнээр дахин хэмжсэнээр үүссэн олз, гарзын хэсгийг тэрхүү шинэ хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх зөвхөн харилцан холбоогүй хөрөнгө оруулагчдын хувь оролцооны хэмжээгээр өөрийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Олзын үлдсэн хэсгийг уг өмнө нь хяналтанд байсан байгууллагад хадгалж үлдсэн хөрөнгө оруулалтын дансны үнээс хасаж, устгана. Хэрэв хяналт тавигч байгууллага нь одоо УСНББОУС 41-ийн ~~УСНББОУС 29-ийн~~ дагуу тайлагнах уг өмнө нь хяналтанд байсан байгууллагадаа хөрөнгө оруулалтын зарим хэсгийг хадгалж үлдсэн бол тэрхүү хяналтанд байсан байгууллагад хадгалж үлдсэн хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнээр дахин хэмжсэнээр үүссэн олз, гарзын хэсгийг тухайн хяналт тавигч байгууллагын ашиг, алдагдалд бүтэн дүнгээр нь хүлээн зөвшөөрнө.

Хөрөнгө оруулалтын байгууллага: Бодит үнэ цэнийн шаардлага

56. 57-р параграфт зааснаас бусад тохиолдолд, хөрөнгө оруулалтын байгууллага нь өөр байгууллагын хяналтыг олж авах үедээ өөрийн хяналтанд буй байгууллагуудыг нэгтгэхгүй буюу УСНББОУС 40-ийг мөрдөхгүй. Харин үүний оронд, хөрөнгө оруулалтын байгууллага нь хяналтанд буй байгууллага дахь хөрөнгө оруулалтаа УСНББОУС 41-ийн ~~УСНББОУС 29-ийн~~ дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжинэ.

...

58. Өөрөө хөрөнгө оруулалтын байгууллага биш боловч хөрөнгө оруулалтын байгууллагад хяналт тавигч байгууллага нь нэгтгэсэн санхүүгийн тайланг толилуулах бөгөөд үүнд: (i) уг хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллага дахь хөрөнгө оруулалтаа УСНББОУС 41-ийн ~~УСНББОУС 29-ийн~~ дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжинэ, ба (ii) хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын бусад хөрөнгө ба өр төлбөр, орлого, зардлыг энэ Стандартын 38-55-р параграфын дагуу нэгтгэнэ.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

79Д. 2018 оны 8 дугаар сард гаргасан, УСНББОУС 41-ээр 22, 45, 52, 55А, 56, 58, МЗУ105-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд УСНББОУС 41-ийг мөн уг өмнөх тайлант хугацаанд дагаж мөрдөнө.

...

Мөрдөх заавар удирдамж

Энэ Хавсралт нь УСНББОУС 35-ын салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.

...

Бодит үнэ цэнийн хэмжилт

...

МЗУ105. МЗУ104(а) параграфын шаардлагыг хангахын тулд хөрөнгө оруулалтын байгууллага нь:

- (а) Хөрөнгө оруулалтын зориулалттай аливаа үл хөдлөх хөрөнгийг УСНББОУС 16, *Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө*-д заасан бодит үнэ цэнийн загвар ашигласнаар тайлагнах сонголт хийнэ;
- (б) Хараат байгууллага болон хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтын хувьд УСНББОУС 36-д заасан, өмчийн аргыг мөрдөхөөс чөлөөлөгдөх нөхцлийг сонгоно; ба
- (в) УСНББОУС 41-ийн ~~УСНББОУС 29-ийн~~ шаардлагуудын дагуу өөрийн санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь хэмжинэ.

...

Дүгнэлтийн Үндэслэл

Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 35-ыг дагалдах боловч түүний саллигүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

...

Хөрөнгө оруулалтын байгууллагууд

...

ДҮ29. Хэрэглэгчид нь хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын талаархи ямар төрлийн мэдээлэл хамгийн чухал ач холбогдолтой гэж үзэх эсэхийг УСНББОУС3 харгалзан үзсэн. Хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын санхүүгийн тайланд ашигласан хөрөнгө оруулалтын нягтлан бодох бүртгэлийг түүний хяналт тавигч байгууллагын санхүүгийн тайланд өргөжүүлэн хэрэглэвэл энэ нь хэрэглэгч нарт хамгийн чухал ач холбогдолтой байна гэж УСНББОУС3 үзсэн. Иймээс хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллага бүхий тийм хяналт тавигч байгууллага нь нэгтгэсэн санхүүгийн тайлан толилуулах шаардлагатай бөгөөд үүнд (i) уг хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын хөрөнгө оруулалтыг УСНББОУС 41-ийн ~~УСНББОУС 29-ийн~~ дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнээр хэмжих, ба (ii) хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын бусад хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг энэ Стандартаар шаардсан, нэгтгэлийн ердийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу нэгтгэхийг УСНББОУС3 санал болгосон. Хяналт тавигч байгууллага нь хөрөнгө оруулалтын байгууллагаа өөрийг нь бодит үнэ цэнийн сууриар удирддаггүй тийм нөхцөл байдлыг энэхүү саналд тусгасан эсэхийг УСНББОУС3 харгалзан үзсэн. Харин тухайн байгууллага нь уг хөрөнгө оруулалтын байгууллагын хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнийн сууриар удирддаг. Энэхүү арга хандлага нь бусад байгууллагууд дахь өөрийн хөрөнгө оруулалтын хувьд уг хөрөнгө оруулалтын байгууллагын хийх нягтлан бодох бүртгэлтэй мөн нийцэх юм.

...

УСНББОУС 36, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт*-д оруулсан нэмэлт өөрчлөлт

20, 24, 25, 26, 43, 44, 45-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 44А, 44Б, 44В, 51Г параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Өмчийн арга

...

20. Өмчийн аргыг ашиглан тайлагнадаг хараат байгууллага болон хамтарсан үйлдвэр дэх хувь оролцооны хувьд УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр-ийг ~~УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр, Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт~~-ийг мөрдөхгүй. Боломжит саналын эрхийг агуулсан хэрэглүүр нь хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх өмчлөлийн хувь оролцоотой холбоотой өгөөжийг мөн чанарын хувьд одоо хүртэх боломж олгодог тохиолдолд уг хэрэглүүрийг УСНББОУС 41-ээр ~~УСНББОУС 29-өөр~~ зохицуулахгүй. Бусад бүх тохиолдолд, хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх боломжит саналын эрхийг агуулсан хэрэглүүрүүдийг УСНББОУС 41-ийн ~~УСНББОУС 29-ийн~~ дагуу тайлагнана.

...

Өмчийн аргын хэрэглээ

...

24. Жижиг дунд үйлдвэрт хөрөнгө оруулагч байгууллагууд, хамтын сан, хамтын итгэлцлийн сан болон тэдгээртэй адилтгах байгууллагууд, үүн дотроо хөрөнгө оруулалттай хосолсон даатгалын сан гэх мэт байгууллага нь хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтыг шууд ба шууд бусаар эзэмшдэг тохиолдолд уг байгууллага нь тэдгээр хараат байгууллага болон хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтыг УСНББОУС 41-ийн ~~УСНББОУС 29-ийн~~ дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих сонголт хийж болно. Тодорхойлолт ёсоор хөрөнгө оруулалтын байгууллага нь ийм сонголтыг хийнэ.
25. Байгууллага нь хараат байгууллагад хөрөнгө оруулалттай бөгөөд түүний тодорхой хэсгийг жижиг дунд үйлдвэрт хөрөнгө оруулагч байгууллагууд, хамтын сан, хамтын итгэлцлийн сан болон тэдгээртэй адилтгах байгууллагууд, үүн дотроо хөрөнгө оруулалттай хосолсон даатгалын сангаар дамжуулан шууд бусаар эзэмшдэг тохиолдолд уг жижиг дунд үйлдвэрт хөрөнгө оруулагч байгууллагууд, хамтын сан, хамтын итгэлцлийн сан болон тэдгээртэй адилтгах байгууллагууд, үүн дотроо хөрөнгө оруулалттай хосолсон даатгалын сан нь хөрөнгө оруулалтын тухайн хэсгийн хувьд мэдэгдэхүйц нөлөөтэй эсэхээс үл хамааран тухайн байгууллага нь хараат байгууллага дахь хөрөнгө оруулалтын тэрхүү хэсгийг УСНББОУС 41-ийн ~~УСНББОУС 29-ийн~~ дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих сонголт хийж болно. Хэрэв байгууллага нь ийм сонголт хийвэл тэдгээр жижиг дунд үйлдвэрт хөрөнгө оруулагч байгууллагууд, хамтын сан, хамтын итгэлцлийн сан болон тэдгээртэй адилтгах байгууллагууд, үүн дотроо хөрөнгө оруулалттай хосолсон даатгалын сангийн эзэмшдэггүй уг хараат байгууллага дахь түүний хөрөнгө оруулалтын аливаа үлдсэн хэсгийн хувьд тухайн байгууллага нь өмчийн аргыг хэрэглэнэ. Байгууллага нь хараат байгууллагад хөрөнгө оруулалттай бөгөөд түүний тодорхой хэсгийг хөрөнгө оруулалтын байгууллагаар дамжуулан шууд бусаар эзэмшдэг тохиолдолд тухайн байгууллага нь хөрөнгө оруулалтын тэрхүү хэсгийг УСНББОУС 41-ийн ~~УСНББОУС 29-ийн~~ дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжинэ.

Өмчийн арга хэрэглэхийг зогсоох

26. **Байгууллагын хөрөнгө оруулалт нь хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр байхаа больсон өдрөөс эхлэн тухайн байгууллага нь өмчийн арга хэрэглэхийг дараах байдлаар зогсооно:**
- (а) Хэрэв хөрөнгө оруулалт нь хяналтанд буй байгууллага болсон бол тухайн байгууллага нь өөрийн хөрөнгө оруулалтыг УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл ба УСНББОУС 35-ын дагуу тайлагнана.
 - (б) Хэрэв өмнөх хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх үлдсэн хувь оролцоо нь санхүүгийн хөрөнгө бол байгууллага нь уг үлдсэн хувь оролцоог бодит үнэ цэнээр хэмжинэ. Уг үлдсэн хувь оролцооны бодит үнэ цэнийг УСНББОУС 41-ийн ~~УСНББОУС 29-ийн~~ дагуу санхүүгийн хөрөнгө гэж анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнэ гэж үзнэ. ~~Байгууллага нь үлдсэн хувь оролцоог бодит үнэ цэнээр~~

~~хэмжихийг УСНББОУС 29-ийн МЗУ113 ба МЗУ114-р параграфтаар хориглодог тохиолдолд тэрхүү хөрөнгө оруулалт нь хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр байгаа болсон өдрөөс эхлэн тус байгууллага нь уг үлдсэн хувь оролцоог тухайн хөрөнгө оруулалтын дансны үнээр хэмжих бөгөөд энэхүү дансны үнийг УСНББОУС 29-ийн дагуу санхүүгийн хөрөнгө гэж анх хүлээн зөвшөөрөх үеийн өртөг гэж үзнэ. Байгууллага нь дараах дүнгүүдийн хоорондох аливаа зөрүүг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө:~~

- (i) ~~Аливаа үлдсэн хувь оролцооны, түүнчлэн хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх хувь оролцооны тодорхой хэсгийг данснаас хассаны аливаа мөнгөн орлогын бодит үнэ цэнэ (буюу хамааралтай тохиолдолд дансны үнэ); ба~~
 - (ii) ~~Өмчийн арга хэрэглэхийг зогсоосон өдрөөрх тухайн хөрөнгө оруулалтын дансны үнэ.~~
- (в) ~~Байгууллага нь өмчийн арга хэрэглэхээ зогсоосон тохиолдолд уг хөрөнгө оруулалттай холбоотойгоор тэрхүү байгууллагын цэвэр хөрөнгө/өмчид өмнө нь шууд хүлээн зөвшөөрч байсан бүх дүнг, хэрэв санхүүжигч нь холбогдох бүх хөрөнгө буюу өр төлбөрөө шууд данснаас хассан бол шаардах байсантай ижил сууриар тухайн байгууллага нь тайлагнана.~~

...

Үнэ цэнийн бууралтын гарз

43. ~~Өмчийн аргыг хэрэглэсэн, үүн дотроо хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн алдагдлыг 41-р параграфын дагуу хүлээн зөвшөөрснөөс хойш уг хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх түүний цэвэр хөрөнгө оруулалттай холбоотой үнэ цэнэ бууралтыг нэмж хүлээн зөвшөөрөх шаардлагатай оруулалтын үнэ цэнэ буурсан талаар аливаа бодитой нотолгоо байгаа эсэхийг тодорхойлохын тулд тухайн байгууллага нь 44А-44В параграфыг УСНББОУС 29-ийг мөрдөнө.~~

44. ~~Байгууллага нь цэвэр хөрөнгө оруулалтын нэг хэсгийг бүрдүүлдэггүй ба УСНББОУС 41-ийн цар хүрээнд хамаарах уг хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх өөрийн бусад хувь оролцооны хувьд УСНББОУС 41-ийн үнэ цэнийн бууралтын шаардлагуудыг аливаа нэмэлт үнэ цэнийн бууралтын гарз хүлээн зөвшөөрөх эсэж, түүнчлэн уг үнэ цэнийн бууралтын гарзын дүнг тодорхойлохын тулд УСНББОУС 29-ийг мөн мөрдөнө.~~

44А. Цэвэр хөрөнгө оруулалтын анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа гарч тохиолдсон нэг буюу хэд хэдэн үйл явдлуудын ('гарзын үйл явдал') үр дүнд үнэ цэнийн бууралт үүссэн талаархи бодитой нотолгоо байгаа бөгөөд тэрхүү гарзын үйл явдал (буюу үйл явдлууд) нь найдвартайгаар тооцоолж болох уг цэвэр хөрөнгө оруулалтын тооцоолсон ирээдүйн мөнгөн гүйлгээнд нөлөө үзүүлэх зөвхөн тийм тохиолдолд хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх цэвэр хөрөнгө оруулалтын үнэ цэнэ буурсан ба үнэ цэнийн бууралтын гарз үүссэн гэж үзнэ. Үнэ цэнийн бууралтын шалтгаан болох нэг, тусдаа үйл явдлыг тодорхойлох боломжгүй байж болно. Харин хэд хэдэн үйл явдлуудын нэгдсэн үр нөлөө нь уг үнэ цэнийн бууралтын шалтгаан байж болох юм. Ирээдүйн үйл явдлуудын үр дүнд байдлаар хүлээгдэж буй гарзыг хэр их магадлалтай гэдгээс үл хамааран хүлээн зөвшөөрөхгүй. Доорх гарзын үйл явдлуудын хувьд тухайн байгууллагын анхааралд өртсөн, ажиглан мэдэж болох мэдээ нь цэвэр хөрөнгө оруулалтын үнэ цэнэ буурсан талаархи бодит нотолгоонд хамаарна:

- (a) Хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрт тулгарсан санхүүгийн томоохон хүндрэл;
- (б) Хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр нь төлбөрөө төлж чадахгүй эсвэл төлбөрийн хугацаа хэтрүүлэх гэх мэт гэрээний зөрчилт;
- (в) Хэрэв нөхцөл байдал өөр байсан бол тухайн байгууллага олгохооргүй байсан боловч хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийнхээ санхүүгийн хүндрэлтэй байдалтай

холбоотойгоор эдийн засгийн эсвэл хууль эрх зүйн шалтгаанаар уг хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрт хөнгөлөлт үзүүлэлт:

(г) Хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр нь дампуурах эсвэл өөр бусад байдлаар санхүүгийн дахин зохион байгуулалт хийх нь нэлээд их магадлалтай байх; эсвэл

(д) Хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн санхүүгийн хүндрэлийн улмаас цэвэр хөрөнгө оруулалтын хувьд идэвхитэй зах зээлгүй болох.

44Б. Хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн өмч эсвэл санхүүгийн хэрэглүүрийг олон нийтэд арилжахгүй байгаа учраас идэвхитэй зах зээлгүй болох нь үнэ цэнийн бууралтын нотолгоо биш юм. Хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн зээлийн үнэ цэнийн бууралт, хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн бодит үнэ цэнийн бууралт нь бусад боломжит мэдээллийн хамтаар авч үзсэн тохиолдолд үнэ цэнийн бууралтын нотолгоо болж болох боловч эдгээр нь дангаараа үнэ цэнийн бууралтын нотолгоо болохгүй юм.

44В. Хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн өмчийн хэрэглүүрт оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо нь 44А параграфт дурдсан үйл явдлуудын төрлөөс гадна тухайн хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн үйл ажиллагаа явуулдаг технологийн, зах зээлийн, эдийн засгийн, хууль эрх зүйн орчинд гарсан сөрөг нөлөө бүхий томоохон өөрчлөлтүүдийн талаархи мэдээллийг багтаан агуулах бөгөөд уг өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтын өртөг нөхөгдөхгүй байж болохыг илэрхийлдэг. Өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ нь өөрийн өртгөөс бага болсон мэдэгдэхүйц буюу удаан хугацааны бууралт нь мөн үнэ цэнийн бууралтын бодитой нотолгоо юм.

45. 44А-44В параграфыг УСНББОУС 29-ийг мөрдөх аливаа тохиолдолд уг хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтын үнэ цэнэ буурсан байж болохыг илтгэн харуулж байвал тухайн байгууллага нь УСНББОУС 26, *Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-ыг, магадгүй УСНББОУС 21 *Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-ыг мөрдөнө.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

51Г. 2018 оны 8 дугаар сард гаргасан, УСНББОУС 41-ээр 20, 24, 25, 26, 43, 44, 45-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 44А, 44Б, 44В параграфыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд УСНББОУС 41-ийг мөн уг өмнөх тайлант хугацаанд дагаж мөрдөнө.

...

Дүгнэлтийн Үндэслэл

Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 36-г дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

...

Хөрөнгө оруулалтын байгууллагууд

ДҮ11. Хөрөнгө оруулалтын байгууллагууд, түүнчлэн хөрөнгө оруулалтын байгууллага болох хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрт хөрөнгө оруулсан хөрөнгө оруулагч нар нь өмчийн

аргыг хэрхэн мөрдөхийг тодруулахыг СТ 50-д хариулт өгсөн хүмүүс нь УСНББОУСЗ-өөс хүссэн. Иймээс УСНББОУСЗ нь:

- (а) Тодорхойлолт ёсоор, хөрөнгө оруулалтын байгууллага нь хараат байгууллага ба хамтарсан үйлдвэр дэх өөрийн хөрөнгө оруулалтыг УСНББОУС 41-ийн ~~УСНББОУС 29-ийн~~ дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр тайлагнах сонголт хийнэ гэдгийг тодорхой болгосон; ба
- (б) Хөрөнгө оруулалтын байгууллага болох хараат байгууллага буюу хөрөнгө оруулалтын байгууллага болох хамтарсан үйлдвэрт хувь оролцоотой байгууллага нь өмчийн аргыг мөрдөх үедээ тэрхүү хөрөнгө оруулалтын байгууллага болох хараат байгууллага буюу хөрөнгө оруулалтын байгууллага болох хамтарсан үйлдвэрийн хэрэглэдэг бодит үнэ цэнийн хэмжилтийг хяналтанд буй байгууллагууд дахь өөрийн хувь оролцооны хувьд хэвээр хадгалахыг шаардсан.

...

УСНББОУС 37, Хамтын Хэлэлцээр-т оруулсан нэмэлт өөрчлөлт

28, 30, 41, МЗУ11, МЗУ33А параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 42Г параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Хамтарсан үйлдвэр

...

- 28. Хамтарсан үйлдвэрт оролцдог боловч хамтын хяналтгүй тал нь тухайн хамтарсан үйлдвэрт мэдэгдэхүйц нөлөөтэй байхаас бусад тохиолдолд тэрхүү хэлэлцээр дэх өөрийн хувь оролцоог УСНББОУС 28, Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга, УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зовшооролт ба Хэмжээлт, УСНББОУС 30, Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга, УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр гэх мэт санхүүгийн хэрэглүүрийг зохицуулдаг УСНББОУС-уудын дагуу тайлагнана, харин мэдэгдэхүйц нөлөөтэй бол хувь оролцоогоо УСНББОУС 36-гийн дагуу тайлагнана.

...

Тусдаа санхүүгийн тайлан

...

- 30. Хамтын хэлэлцээрт оролцдог боловч хамтын хяналтгүй тал нь хувь оролцоогоо өөрийн тусдаа санхүүгийн тайланд дараах байдлаар тайлагнана:
 - (а) Хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцоог 26-р параграфын дагуу; ба
 - (б) Тухайн хамтарсан үйлдвэрт мэдэгдэхүйц нөлөөтэй байхаас бусад тохиолдолд хамтарсан үйлдвэр дэх өөрийн хувь оролцоогоо УСНББОУС 41-ийн ~~УСНББОУС 29-ийн~~ дагуу, харин мэдэгдэхүйц нөлөөтэй бол УСНББОУС 34-ийн 12-р параграфын дагуу.

...

Байгууллагын тусдаа санхүүгийн тайлан дахь шилжилтийн нөхцлүүд

- 41. Хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцоогоо өөрийн тусдаа санхүүгийн тайланд өмнө нь УСНББОУС 6, *Нэгтгэсэн ба Тусдаа Санхүүгийн Тайлан*-гийн 58-р параграфын дагуу

өмчийн арга ашиглан эсвэл УСНББОУС 41-ийн ~~УСНББОУС 29-ийн~~ дагуу өртгөөр хөрөнгө оруулалт гэж тайлагнадаг байсан байгууллага нь:

- (а) Тухайн хөрөнгө оруулалтыг үл хүлээн зөвшөөрч, хамтын үйл ажиллагаан дахь өөрийн хувь оролцоотой холбоотой хөрөнгө, өр төлбөрийг 37-39-р параграфын дагуу тодорхойлсон дүнгээр хүлээн зөвшөөрнө.
- (б) Үл хүлээн зөвшөөрсөн хөрөнгө оруулалт ба хүлээн зөвшөөрсөн хөрөнгө, өр төлбөрийн хоорондох тохируулгын тайланг, тэрхүү яг өмнөх тайлант үеийн эхэнд хуримтлагдсан ашиг, алдагдалд залруулсан аливаа үлдэх зөрүүгийн хамт харуулна.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

42Г. 2018 оны 8 дугаар сард гаргасан, УСНББОУС 41-ээр 28, 30, 41, МЗУ11, МЗУ33А параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд УСНББОУС 41-ийг мөн уг өмнөх тайлант хугацаанд дагаж мөрдөнө.

...

Мөрдөх заавар удирдамж

Энэ Хавсралт нь УСНББОУС 37-гийн салиггүй бүрэлдэхүүн хэсэг юм.

...

Хамтын хяналт (12-18-р параграф)

...

МЗУ11. Хэлэлцээр нь УСНББОУС 37, *Хамтын Хэлэлцээр*-ийн цар хүрээнд хамаарахгүй бол байгууллага нь уг хэлэлцээр дэх өөрийн хувь оролцоог УСНББОУС 35, УСНББОУС 36, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт*, УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр ~~УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжээ~~ гэх мэт холбогдох УСНББОУС-уудын дагуу тайлагнана.

...

Хамтын хэлэлцээрийн оролцогч талуудын санхүүгийн тайлан (23-28-р параграф)

Хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцооны худалдан авалтын тайлагнал

МЗУ33А. Байгууллага нь хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцоог олж эзэмшсэн бөгөөд тэрхүү хамтын үйл ажиллагаа нь УСНББОУС 40-д тодорхойлсон, үйл ажиллагааг бүрдүүлэх тийм үйл ажиллагаа байх тохиолдолд 23-р параграфт дурдсанчлан, өөрийн хувь оролцоонд хамаарах хэмжээгээр тухайн байгууллага нь энэ Стандарт дахь заавар удирдамжтай үл зөрчилдөх, УСНББОУС 40 болон бусад УСНББОУС-д заасан худалдан авалтын нягтлан бодох бүртгэлийн бүх зарчмуудыг даган мөрдөх бөгөөд худалдан авалттай холбоотойгоор тэдгээр УСНББОУС-уудад шаардсан мэдээллийг тодруулна. Энэ Стандарт дахь заавар удирдамжтай үл зөрчилдөх, худалдан авалтын нягтлан бодох бүртгэлийн зарчмуудад дараах зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

- (а) Гажих нөхцлүүдийг нь УСНББОУС 40 болон бусад УСНББОУС-д зааснаас бусад, тодорхойлогдох хөрөнгө ба өр төлбөрийг бодит үнэ цэнээр хэмжих;
- (б) Өрийн буюу өмчийн үнэт цаас гаргах зардлыг УСНББОУС 28 ба УСНББОУС 41-ийн УСНББОУС 29-ийн дагуу хүлээн зөвшөөрдөг гажих тохиолдлоос бусад, худалдан авалттай холбоотой өртөг зардлыг тухайн өртөг зардал гарсан ба үйлчилгээг хүлээн авсан тайлант үеүдэд зардлаар хүлээн зөвшөөрөх;
- (в) Олж эзэмшсэн тодорхойлогдох хөрөнгө ба хариуцсан өр төлбөрийн тухайн худалдан авалтын өдрөөрх цэвэр дүнгээс илүү шилжүүлсэн төлбөр хэрэв байгаа бол уг илүү давсан дүнг гүүдвил гэж хүлээн зөвшөөрөх; ба
- (г) Гүүдвилийг хуваарилсан мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтыг хамгийн наад зах нь жил бүр сорьж шалгах ба худалдан авалтаар олж эзэмшсэн гүүдвилийн хувьд УСНББОУС 26, *Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-аар шаардсанчлан, тухайн мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнэ буурсан шинж тэмдэг байгаа эсэхийг сорьж шалгах.

...

УСНББОУС 38, *Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцооны Тодруулга*-д оруулсан нэмэлт өөрчлөлт

4-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 61В параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Цар хүрээ

...

4. Энэ Стандартыг дараах зүйлсэд мөрдөхгүй:

- (а) **УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ийг мөрддөг, ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хөтөлбөр буюу ажилтны бусад урт хугацаат тэтгэмжийн хөтөлбөр.**
- (б) **УСНББОУС 34, *Тусдаа Санхүүгийн Тайлан*-г мөрддөг, байгууллагын тусдаа санхүүгийн тайлан. Гэвч:**
 - (i) **Хэрэв байгууллага нь нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллагуудад хувь оролцоотой бөгөөд өөрийн цорын ганц санхүүгийн тайлан болгон тусдаа санхүүгийн тайланг бэлтгэдэг бол тухайн байгууллага нь тэрхүү тусдаа санхүүгийн тайланг бэлтгэхдээ 40-48-р параграфын шаардлагуудыг мөрдөнө.**
 - (ii) **Өөрийн хяналтанд буй бүх байгууллагуудыг УСНББОУС 35-ын 56-р параграфын дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжиж, тусгадаг тийм санхүүгийн тайланг бэлтгэдэг хөрөнгө оруулалтын байгууллага нь хөрөнгө оруулалтын байгууллагуудтай холбоотойгоор энэ Стандартаар шаардсан тодруулгыг толилуулна.**
- (в) **Хамтын хэлэлцээрт оролцдог боловч хамтын хяналт тавьдаггүй байгууллагын эзэмшиж буй хувь оролцоо нь уг хэлэлцээрт мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх үр дүнтэй, эсвэл тусгай бүтэц бүхий байгууллага дахь хувь оролцоо байхаас бусад тохиолдолд тэрхүү байгууллагын эзэмшиж буй хувь оролцоо.**
- (г) **УСНББОУС 41, *Санхүүгийн Хэрэглүүр*-ийн УСНББОУС 29, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжээ*-ийн дагуу тайлагнадаг, өөр байгууллага дахь хувь оролцоо. Гэвч байгууллага нь доорх тохиолдолд энэ Стандартыг мөрдөнө:**

- (i) Уг хувь оролцоо нь УСНББОУС 36, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт*-ын дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг, хараат байгууллага эсвэл хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоо байх тохиолдолд; эсвэл
- (ii) Уг хувь оролцоо нь нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллага дахь хувь оролцоо байх тохиолдолд.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

61В. 2018 оны 8 дугаар сард гаргасан, УСНББОУС 41-ээр 4-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд УСНББОУС 41-ийг мөн уг өмнөх тайлант хугацаанд дагаж мөрдөнө.

...

УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-д оруулсан нэмэлт өөрчлөлт

25, 45, 70, 111, 115, 117, МЗУ88-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 126А параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Нийлүүлэлтэнд хамаарах хөрөнгө, өр төлбөрийг ангилах буюу сонгох

...

25. Байгууллага нь тодорхой хөрөнгө, өр төлбөрийг хэрхэн ангилдаг буюу сонгодог эсэхээс хамааран нягтлан бодох бүртгэл нь зарим тохиолдолд өөр өөр байхаар УСНББОУС-д заасан байдаг. Нэгдэгч үйл ажиллагаануудын өмнө ашиглаж байсан ангилал буюу сонголтонд үндэслэн тухайн үр дүнгийн байгууллага нь ангилал буюу сонголтыг хийх жишээнд дараах зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:

- (a) УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр-ийн УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт-ийн дагуу бодит үнэ цэнээр эсвэл хорогдуулсан өртгөөр хэмжсэн гэж ангилсан тухайн тодорхой санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн ангилал;
- (б) Үүсмэл хэрэглүүрийг УСНББОУС 41-ийн УСНББОУС 29-ийн дагуу хейжийн хэрэглүүр гэж ангилах сонголт; ба
- (в) Дагалдах үүсмэл хэрэглүүрийг УСНББОУС 41-ийн УСНББОУС 29-ийн дагуу үндсэн гэрээнээс салган тусгаарлах хэрэгтэй эсэх үнэлгээ (уг нэр томъёог энэ Стандартад ашиглах үед энэ нь “ангилал”-д хамаарах асуудал байна).

...

Нийлүүлэлттэй холбоотой зардал

...

45. Нийлүүлэлттэй холбоотой зардал нь уг нийлүүлэлтийг хийхийн тулд тухайн үр дүнгийн байгууллагын болон нэгдэгч үйл ажиллагаануудын гаргасан зардал юм. Үүнд дараах зардал

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

хамаарна: зөвлөх, хуулийн, нягтлан бодох бүртгэлийн, үнэлгээний болон бусад мэргэжилтний буюу зөвлөх үйлчилгээний хөлс; ерөнхий удирдлагын зардал; өрийн болон өмчийн үнэт цаасыг бүртгүүлэх ба гаргах зардал. Үр дүнгийн байгууллага болон нэгдэгч үйл ажиллагаанууд нь нийлүүлэлттэй холбоотой өртөг зардлыг ганцхан тохиолдлоос бусад үед зардал гарсан ба үйлчилгээг хүлээн авсан тайлант үед зардал гэж тайлагнана. Харин өрийн болон өмчийн үнэт цаас гаргахтай холбоотой зардлыг УСНББОУС 28, Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга ба УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр-ийн УСНББОУС 29-ийн дагуу хүлээн зөвшөөрнө.

...

Худалдан авалтаар олж эзэмшсэн тодорхойлогдох хөрөнгө ба хариуцсан өр төлбөрийн ангилал буюу сонголт

...

70. Зарим тохиолдолд УСНББОУС-ууд нь тухайн тодорхой хөрөнгө буюу өр төлбөрийг байгууллага хэрхэн ангилдаг буюу сонгодог эсэхээс хамааран өөр байдлаар тайлагнахаар заасан байдаг. Нэгтгэгч нь уг худалдан авалтын өдрөөр оршин байсан холбогдох нөхцлүүдэд үндэслэн хийх ангилал буюу тодорхойлолтын жишээнд дараах зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:

- (а) УСНББОУС 41-ийн УСНББОУС 29-ийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр эсвэл хорогдуулсан өртгөөр хэмжсэн гэж ангилсан тухайн тодорхой санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн, эсвэл цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан санхүүгийн хөрөнгийн ангилал;
- (б) Үүсмэл хэрэглүүрийг УСНББОУС 41-ийн УСНББОУС 29-ийн дагуу хейжийн хэрэглүүр гэж ангилах сонголт; ба
- (в) Дагалдах үүсмэл хэрэглүүрийг УСНББОУС 41-ийн УСНББОУС 29-ийн дагуу үндсэн гэрээнээс салган тусгаарлах хэрэгтэй эсэх үнэлгээ (уг нэр томъёог энэ Стандартад ашиглах үед энэ нь “ангилал”-д хамаарах асуудал байна).

...

Худалдан авалттай холбоотой зардал

111. Худалдан авалттай холбоотой зардал гэдэг нь уг худалдан авалтыг хийхийн тулд нэгтгэгчийн гаргасан зардал юм. Үүнд дараах зардал хамаарна: зуучлагчийн шимтгэл; зөвлөх, хуулийн, нягтлан бодох бүртгэлийн, үнэлгээний болон бусад мэргэжилтний буюу зөвлөх үйлчилгээний хөлс; ерөнхий удирдлагын зардал, үүн дотроо дотоод худалдан авалтын хэлтсийн үйл ажиллагааны зардал; өрийн болон өмчийн үнэт цаасыг бүртгүүлэх ба гаргах зардал. Нэгтгэгч нь худалдан авалттай холбоотой өртөг зардлыг ганцхан тохиолдлоос бусад үед зардал гарсан ба үйлчилгээг хүлээн авсан тайлант үед зардал гэж тайлагнана. Харин өрийн буюу өмчийн үнэт цаас гаргахтай холбоотой зардлыг УСНББОУС 28 ба УСНББОУС 41-ийн УСНББОУС 29-ийн дагуу хүлээн зөвшөөрнө.

Дараагийн тайлант үеийн хэмжилт ба нягтлан бодох бүртгэл

...

Болзошгүй өр төлбөр

115. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа уг өр төлбөрийг барагдуулах, хүчингүй болгох буюу түүний хугацаа дуусах хүртэл нэгтгэгч нь худалдан авалтаар хүлээн зөвшөөрсөн болзошгүй өр төлбөрийг дараах дүнгүүдийн аль ихээр хэмжинэ:

- (а) УСНББОУС 19-ийн дагуу хүлээн зөвшөөрөх байсан дүн; ба

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

- (б) Анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс хэрэв тохиромжтой бол УСНББОУС 9, *Арилжааны Ажил Гүйлгээний Орлого*-ын дагуу хүлээн зөвшөөрсөн, хуримтлагдсан хорогдуулгыг хассан дүн.

Энэхүү шаардлагыг УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр-ийн УСНББОУС 29 -ийн дагуу тайлагнадаг гэрээний хувьд мөрдөхгүй.

...

Болзошгүй төлбөр

117. Нэгтгэгчийн хүлээн зөвшөөрсөн болзошгүй төлбөрийн бодит үнэ цэнэд худалдан авалтын өдрөөс хойш гарсан зарим өөрчлөлт нь тухайн худалдан авалтын өдрөөр оршин байсан баримт материал ба нөхцөл байдлын талаархи боловч нэгтгэгч уг өдрөөс хойш олж авсан нэмэлт мэдээллийн үр дүн байж болох юм. Ийм өөрчлөлтүүд нь 103-107-р параграфт заасанчлан, хэмжилтийн хугацааны залруулга болно. Харин ашгийн зорилтот хэмжээг биелүүлэх, хувьцааны үнэ тохиролцсон түвшинд хүрэх, судалгаа ба хөгжлийн төслийн гол зорилго биелэх гэх мэт тухайн худалдан авалтын өдрөөс хойшхи үйл явдлын үр дүн болох өөрчлөлт нь хэмжилтийн хугацааны залруулга биш юм. Хэмжилтийн хугацааны залруулгад хамаарахгүй, болзошгүй төлбөрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нэгтгэгч нь дараах байдлаар тайлагнана:

- (а) Цэвэр хөрөнгө/өмч гэж ангилсан болзошгүй төлбөрийг дахин хэмжихгүй бөгөөд түүний дараагийн тайлант үеийн барагдуулалтыг тухайн цэвэр хөрөнгө/өмчийн ангиллын хүрээнд тайлагнана.
- (б) Бусад болзошгүй төлбөрүүд нь:
- (i) УСНББОУС 41-ийн УСНББОУС 29 -ийн цар хүрээнд хамаарах бол тайлант үе бүрийн эцэст бодит үнэ цэнээр хэмжих бөгөөд бодит үнэ цэнийн өөрчлөлтийг УСНББОУС 41-ийн УСНББОУС 29 -ийн дагуу ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.
- (ii) УСНББОУС 41-ийн УСНББОУС 29 -ийн цар хүрээнд хамаарахгүй бол тайлант үе бүрийн эцэст бодит үнэ цэнээр хэмжих бөгөөд бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

126А. 2018 оны 8 дугаар сард гаргасан, УСНББОУС 41-ээр 25, 45, 70, 111, 115, 117, МЗУ88-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд УСНББОУС 41-ийг мөн уг өмнөх тайлант хугацаанд дагаж мөрдөнө.

...

Мөрдөх заавар удирдамж

Энэ Хавсралт нь УСНББОУС 40-ийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.

...

Худалдан авалтын үед тухайн тодорхойлогдох хөрөнгө ба худалдан авсан үйл ажиллагаан дахь хяналтын бус хувь оролцооны бодит үнэ цэнийг хэмжих (72-73-р параграфыг үзнэ үү)

Тодорхой бус мөнгөн гүйлгээ бүхий хөрөнгө (үнэлгээний хасагдуулга)

МЗУ88. Худалдан авалтаар олж эзэмшсэн хөрөнгүүдийн ирээдүйн мөнгөн гүйлгээний тодорхой бус байдлын үр нөлөөг бодит үнэ цэнийн хэмжилтэнд тусган оруулдаг учраас тухайн худалдан авалтын өдрөөрх тэдгээрийн бодит үнэ цэнээр хэмждэг хөрөнгүүдийн хувьд нэгтгэгч нь уг худалдан авалтын өдрөөр үнэ цэнийн бууралтын тусдаа хасагдуулга хүлээн зөвшөөрөхгүй. Жишээлбэл; энэ Стандарт нь худалдан авалтыг тайлагнахдаа тухайн олж эзэмшсэн авлага, үүн дотроо зээлийг уг худалдан авалтын өдрөөрх тэдгээрийн бодит үнэ цэнээр хэмжихийг нэгтгэгчээс шаарддаг тул нэгтгэгч нь тэрхүү өдрөөр үл цуглуулагдах гэж төсөөлсөн учраас заавал биелүүлэх хэлцлийн мөнгөн гүйлгээний хувьд үнэ цэнийн бууралтын тусдаа хасагдуулга эсвэл хүлээгдэж буй зээлийн алдагдлын хувьд гарзын хасагдуулгыг хүлээн зөвшөөрөхгүй.

Дүгнэлтийн Үндэслэл

Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 41-ийг дагалдах боловч түүний салиггүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

Оршил

- ДҮ1. УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр-ийн дүгнэлтүүдэд хүрэхдээ УСНББОУС3-ийн харгалзан үзсэн зүйлсийг энэхүү Дүгнэлтийн Үндэслэлд нэгтгэн товчоолсон. Энэхүү Стандарт нь НББОУС3-өөс гаргасан СТОУС 9, Санхүүгийн Хэрэглүүр-т үндэслэсэн тул УСНББОУС 41 нь СТОУС 9-ийн үндсэн шаардлагуудаас гажих зөвхөн тэдгээр талбаруудыг энэ Дүгнэлтийн Үндэслэлд тусган илэрхийлсэн.
- ДҮ2. 2014 оны 7 дугаар сард НББОУС3 нь СТОУС 9-ийн эцсийн хувилбарыг гаргасан бөгөөд энэ нь НББОУС 39, Санхүүгийн Хэрэглүүр-ийг сольж орлуулах НББОУС3-ийн төслийн ангилал ба хэмжилт, үнэ цэнийн бууралт ба хейжийн нягтлан бодох бүртгэлийн үе шатуудыг нэгтгэн тусгасан болно. УСНББОУС-уудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-тай нийцүүлэхийг эрмэлзэж буй УСНББОУС3-ийн нийцүүлэлтийн хөтөлбөрийн нэг хэсэг болгон 2016 онд УСНББОУС3 нь санхүүгийн хэрэглүүрүүдийн тайлагналыг зохицуулдаг УСНББОУС-уудыг шинэчлэн баяжуулах төслийн ажлыг эхлүүлсэн. УСНББОУС 41-ийн текст нь улсын секторын байгууллагуудад тохиромжтой байх ба бусад УСНББОУС-ын шаардлагуудыг тусгах үүднээс засварлан өөрчилсөн СТОУС 9-ийн шаардлагуудад үндэслэдэг. Энэхүү шинэ УСНББОУС нь УСНББОУС 29-ийн хейжийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудыг үргэлжлүүлэн мөрдөх шилжилтийн үеийн сонголтыг байгууллагуудад олгохын зэрэгцээгээр УСНББОУС 29-ийг орлох юм.
- ДҮ3. Улсын сектортой холбоотой учраас СТОУС 9-д авч үздэггүй санхүүгийн хэрэглүүрийн бусад төлөв байдлууд байдаг гэдгийг УСНББОУС3 цохон тэмдэглэсэн. УСНББОУС3 нь дараах зүйлсийг авч үзэхийн тулд *Улсын Секторын Тодорхой Санхүүгийн Хэрэглүүрүүд, Орлого ба Арилжааны бус Зардлын талаархи тусдаа төслүүдийг хэрэгжүүлсэн:*
- Валютын зохицуулалтын эрх бүхий байгууллагын хийдэг зарим ажил гүйлгээ; ба
 - Мөн чанарын хувьд санхүүгийн хэрэглүүртэй төсөөтэй ба эдийн засгийн ижил үр нөлөөтэй боловч гэрээний шинж төрөлгүй хэлцлээс үүсдэг авлага ба өглөг.
- ДҮ4. Энэ Стандартыг боловсруулахдаа, УСНББОУС3 нь одоо байгаа УСНББОУС-уудтай нийцэх тохиолдолд СТОУС 9-ийн одоогийн текстийг тэр хэвээр хадгалах ба улсын секторын зарим тусгай асуудлуудын хувьд жишээ болон хэрэгжүүлэх заавар удирдамжаар хангахыг зөвшөөрсөн. Тухайлбал; арилжааны бус ажил гүйлгээгээр гаргасан хөнгөлөлттэй зээл ба санхүүгийн баталгааны талаархи мөрдөх заавар удирдамж нь УСНББОУС 29-д ач холбогдолтой бөгөөд ийм заавар удирдамж УСНББОУС 41-д хэрэгцээтэй хэвээр байна гэдгийг УСНББОУС3 цохон тэмдэглэсэн. Энэхүү Стандартын зарчмуудыг мөрдөхийн тулд бүрэлдэхүүн хэсгүүдэд дэмжлэг үзүүлэх бүрэн эрхэт бус материалаар хангах нь нэн чухал гэж УСНББОУС3 үзсэн. Иймээс УСНББОУС3 нь энэ Стандартын мөрдөлтөд туслалцаа үзүүлэхийн тулд улсын секторын дараах нэмэлт жишээнүүдийг боловсруулах хатуу чанд процессыг баримтлан ажилласан:
- (а) Хөнгөлөлттэй зээлтэй, үүн дотроо болзошгүй урьдчилсан төлбөрийн шинжүүдийн ангилал (жишээ 20 ба 21, хэрэгжүүлэх заавар удирдамж Ж.1-ийг үзнэ үү) ба үр нөлөөг (хэрэгжүүлэх заавар удирдамж Ж.2-ыг үзнэ үү) үнэлэхтэй холбоотой жишээнүүд;
 - (б) Жишиг үнэгүй өмчийн хэрэглүүрийн хэмжилттэй, үүн дотроо бодит үнэ цэнийг тодорхойлох (жишээ 23-26, хэрэгжүүлэх заавар удирдамж Д.2.4 ба Д.2.5-ыг үзнэ үү) болон арилжааны бус бүрэлдэхүүн хэсгийн үнэ цэнийг тайлагнахад (жишээ 27, 28 ба

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

хэрэгжүүлэх заавар удирдамж Ж.3-ыг үзнэ үү) харгалзан үзэх хүчин зүйлстэй холбоотой жишээнүүд;

- (в) Эргэлтээс гаргах шинжүүд бүхий өмчийн хэрэглүүрийн тайлагналтай холбоотой жишээ (жишээ 31-ийг үзнэ үү);
- (г) Санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртгийн тооцоололд үр ашигтай хүүний хувийг ашиглахтай холбоотой жишээнүүд (жишээ 32 ба хэрэгжүүлэх заавар удирдамж И.1-ийг үзнэ үү).

ДҮ5. НББОУС-ууд/СТОУС-ууд дахь “орлого” /income/ нэр томъёотой дүйцүүлэн УСНББОУС 1, *Санхүүгийн Тайлангийн Толилуулга*-д “орлого” /revenue/ нэр томъёог ашигласан тул түүнд нийцүүлэн УСНББОУС3 нь СТОУС 9, *Санхүүгийн Хэрэглүүр*-ийн “орлого” /income/ нэр томъёоны оронд “орлого” /revenue/ нэр томъёо ашиглахыг бас зөвшөөрсөн. Иймээс УСНББОУС 1-д “орлого” /revenue/ эсвэл зардал /expense/ гэж дурдан хүлээн зөвшөөрсөн зарим зүйлс нь цэвэр дүнгээр илэрхийлэгдсэн байдаг. УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд дурдсанчлан, УСНББОУС3 нь “орлого” /income/-ын тодорхойлолтыг тусган оруулаагүй. “Орлого” /income/ нэр томъёо нь “орлого” /revenue/ нэр томъёоноос илүү өргөн хүрээтэй ба “орлого” /revenue/-оос гадна олзыг мөн өөртөө агуулсан байдаг.

Цар хүрээ

ДҮ6. Хөрөнгө ба өр төлбөр нь арилжааны бус гэрээний орлогын ажил гүйлгээнээс үүсэж болох юм. Арилжааны бус орлогын ажил гүйлгээнээс үүсэж буй хөрөнгө, өр төлбөрийн анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийг УСНББОУС 23, *Арилжааны Бус Ажил Гүйлгээний Орлого (Татвар ба Шилжүүлэг)*-д авч үздэг. УСНББОУС 23 нь эдгээр хөрөнгө, өр төлбөрийн дараагийн тайлант үеийн хэмжилт буюу үл хүлээн зөвшөөрөлтөд хамаарах шаардлагууд болон заавар удирдамжаар хангадаггүй. Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангадаг арилжааны бус орлогын ажил гүйлгээнээс үүссэн хөрөнгө, өр төлбөрийн хувьд энэ Стандарт ба УСНББОУС 23-ын хоорондох уялдаа холбоог УСНББОУС3 харгалзан үзсэн.

ДҮ7. Арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн хөрөнгө нь санхүүгийн хөрөнгө бол байгууллага нь дараах байдлаар тусгана гэдгийг УСНББОУС3 хүлээн зөвшөөрсөн:

- Тухайн хөрөнгийг УСНББОУС 23-ыг ашигласнаар анх хүлээн зөвшөөрнө; ба
- Тухайн хөрөнгийг УСНББОУС 23-ыг ашигласнаар анх хэмжих бөгөөд тэрхүү хөрөнгийг олж эзэмшихийн тулд гаргасан аливаа ажил гүйлгээний зардлын хувьд тохиромжтой арга хандлагыг тодорхойлохын тулд энэ Стандартын шаардлагуудыг харгалзан үзнэ.

УСНББОУС 23 нь арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн хөрөнгийн хувьд дараагийн тайлант үеийн хэмжилт буюу үл хүлээн зөвшөөрөлтийн шаардлагуудыг заагаагүй тул тэдгээр хөрөнгө нь санхүүгийн хөрөнгө бол энэ Стандартыг мөрдөнө.

ДҮ8. УСНББОУС 23-д заасан нөөцийн шилжүүлэлтэнд тавигдах нөхцлүүдээс үүссэн өр төлбөр нь анх хүлээн зөвшөөрөх үед санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг ихэвчлэн хангадаггүй учраас (УСНББОУС 28-ыг үзнэ үү) тэдгээр өр төлбөрийг уг УСНББОУС-ыг ашиглан анх хүлээн зөвшөөрч, хэмжинэ гэдгийг УСНББОУС3 нь өр төлбөрийн хувьд хүлээн зөвшөөрсөн. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа, уг өр төлбөр нь санхүүгийн өр төлбөр мөн гэдгийг нөхцөл байдал харуулж байвал байгууллага нь УСНББОУС 23-ын дагуу хүлээн зөвшөөрсөн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөх ба санхүүгийн өр төлбөрийг энэ Стандартын дагуу хүлээн зөвшөөрөх хэрэгтэй эсэхийг үнэлнэ.

ДҮ9. Арилжааны бус орлогын ажил гүйлгээнээс үүсдэг бусад өр төлбөр, тухайлбал, хөрөнгийн ашиглалтанд тавигдах хязгаарлалтанд үндэслэсэн нөөцийн буцаалт нь санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангаж байвал түүнийг энэ Стандартын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжинэ гэдгийг УСНББОУС3 хүлээн зөвшөөрсөн.

Анхны хэмжилт

- ДҮ10. Арилжааны бус ажил гүйлгээгээр дамжуулан олж эзэмшсэн бөгөөд санхүүгийн хөрөнгийн тодорхойлолтыг бас хангадаг хөрөнгүүдийн хувьд УСНББОУС 23 ба энэ Стандартын хооронд уялдаа холбоо байна гэдгийг УСНББОУС3 хүлээн зөвшөөрсөн. УСНББОУС 23 нь арилжааны бус орлогын ажил гүйлгээгээр олж эзэмшсэн хөрөнгийг эхлээд түүний бодит үнэ цэнээр хэмжихийг шаарддаг. Хэрэв санхүүгийн хөрөнгийг дараагийн тайлант үед ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэггүй бол тухайн санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнэ дээр ажил гүйлгээний зардлыг нэмсэн дүнгээр анх хэмжихийг энэ Стандартаар шаарддаг. Хэмжилтийн энэхүү хоёр хандлага нь ажил гүйлгээний зардлын тайлагналаас бусад зүйлсийн хувьд хоорондоо ихээхэн нийцтэй байдаг.
- ДҮ11. Арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн хөрөнгийг арилжааны ажил гүйлгээнээс үүссэн хөрөнгөөс өөр байдлаар хэмжих нь тохиромжгүй гэж УСНББОУС3 дүгнэсэн. Иймээс арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн хөрөнгийг УСНББОУС 23-ын шаардлагуудыг харгалзан эхлээд бодит үнэ цэнээр хэмжих хэрэгтэй боловч тухайн хөрөнгийг олж эзэмшихийн тулд ажил гүйлгээний зардал гаргадаг тохиолдолд энэ Стандартыг бас харгалзан үзвэл зохино гэдгийг УСНББОУС3 хүлээн зөвшөөрсөн.

Арилжааны бус ажил гүйлгээнээс үүсэх өмчийн хэрэглүүр

- ДҮ12. Улсын секторын хувьд, үйлчилгээ үзүүлэхэд зориулан улсын секторын өөр нэг байгууллагад санхүүжилт олгох арга зам болгон өмчийн хэрэглүүрийг зарим үед мөнгөн гүйлгээний хамгийн бага хүлээлттэйгээр худалдан авдаг. УСНББОУС3 нь зах зээлийн бус нөхцлөөр олж эзэмшсэн ийм өмчийн хэрэглүүрийн хувьд хөнгөлөлттэй зээлтэй адил нэмэлт заавар удирдамж шаардлагатай гэж үзсэн. Түүнчлэн, хөнгөлөлттэй зээлтэй харьцуулахад ийм хэрэглүүрийн эдийн засгийн мөн чанарын хувьд суурь ялгаа байна гэдгийг УСНББОУС3 хүлээн зөвшөөрсөн. УСНББОУС 23 болон энэ Стандарт дахь заавар удирдамж нь ийм ажил гүйлгээний хүлээн зөвшөөрөлт, хэмжилтийг хангалттай сайн харгалзан тусгасан бөгөөд илүү тодорхой болгох үүднээс нэмэлт заавар удирдамжийг оруулдаг гэдгийг УСНББОУС3 мөн хүлээн зөвшөөрсөн.

Онцгой бүрэн эрхээс үүсэх ирээдүйн гүйлгээний борлуулалт

- ДҮ13. Улсын секторын хувьд, үнэт цаасжуулалтын схем нь татвар ногдуулах эрх гэх мэт онцгой бүрэн эрхээс үүсэх ирээдүйн гүйлгээний борлуулалтыг агуулсан байж болох юм. Ийм ажил гүйлгээ нь санхүүгийн өр төлбөр үүсэхэд хүргэж болно гэдгийг заан мэдэгдэх нь ач холбогдолтой гэж УСНББОУС3 үзсэн бөгөөд МЗУ33-р параграфыг нэмж оруулахыг зөвшөөрсөн. Ийм гүйлгээнээс бий болох орлогыг холбогдох орлогын стандартын дагуу хүлээн зөвшөөрөх хэрэгтэй гэдгийг УСНББОУС3 цохон тэмдэглэсэн. Үүнтэй адилтгах хувилбаруудыг харгалзан тусгах нэмэлт мөрдөх заавар удирдамж шаардлагатай эсэхийг УСНББОУС3 судлан үзсэн. УСНББОУС3 нь тэдгээр ажил гүйлгээнээс үүсэх аливаа санхүүгийн хэрэглүүрийн тайлагналыг зохицуулах хангалттай заавар удирдамж тухайн Стандартад байгаа гэж дүгнэсэн.

Үнэ цэнийн бууралт

- ДҮ14. Улсын секторын байгууллагуудын хувьд, авлага нь түүний эзэмшиж буй цорын ганц, мэдэгдэхүйц дүнтэй санхүүгийн хөрөнгө байж болох юм гэдгийг УСНББОУС3 онцлон тэмдэглэсэн. Түүнчлэн, улсын секторын байгууллагууд нь өөрийн үзүүлж буй үйлчилгээний шинж төрөл ба бүх хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлэхийг (жишээлбэл; нийтийн ашиглалт, үйлчилгээний байгууллага нь усны буюу усан хангамжийн үйлчилгээ үзүүлэх) шаарддаг хууль буюу зохицуулалтын улмаас ажил гүйлгээ хийх оролцогч нөгөө талаа сонгох чадвар боломжгүй байж болно. Ийм тохиолдолд бие даасан оролцогч нөгөө талын түвшин дэх зээлийн эрсдийн мэдээлэл болон хэтийн чиглэлтэй мэдээлэл/прогнозыг их зардал буюу хүчин чармайлт гаргахгүйгээр олж авах боломжгүй байж болох юм. Улсын сектор гэдгийг харгалзан засвар өөрчлөлт эсвэл нэмэлт заавар удирдамжийг энэ Стандартад оруулах хэрэгтэй эсэхийг УСНББОУС3 авч үзсэн бөгөөд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тодорхойлоход ашиглаж болох практик арга зүй бүхий авлагын хялбаршуулсан хандлага нь ийм нөхцөл байдалд үүсэх

практикын асуудлуудын хувьд тохиромжтой шийдлийг бүрдүүлнэ гэж УСНББОУСЗ дүгнэсэн. “Стандартад заасанчлан, одоогийн, түүнчлэн урьдчилан таамагласан хэтийн нөхцлийг тусгахад шаардлагатай аливаа залруулгыг харгалзахын хамтаар ийм нөхцөл байдалд үүсэхээр хүлээгдэж буй зээлийн алдагдлын тооцоололд түүхэн мэдээ болон оршин буй загваруудыг тусган оруулахыг энэхүү Стандартаар зөвшөөрдөг” гэдгийг УСНББОУСЗ бас тэмдэглэсэн.

Үр ашигт хүүний арга

ДҮ15. Санал өгсөн хүмүүс нь үр ашигт хүүний арга ашигласнаар санхүүгийн өр төлбөрийг (бондыг) хорогдуулсан өртгөөр хэмжихийн өртөг/өгөөжийг харгалзан үзэхийг УСНББОУСЗ-д санал болгосон. Ажил гүйлгээний зардал ба гаргалтын аливаа урамшуулал буюу хөнгөлөлт нь мэдэгдэхүйц дүнтэй биш тохиолдолд үр ашигт хүүний хувь ашиглаж, хорогдуулсан өртгөөр хэмжих нь шулуун шугамын арга ашигласантай ижил буюу адилтгах үр дүнд хүргэдэг гэж тэдгээр хүмүүс үзэж байсан. Харин үр ашигт хүүний арга ашиглах өртөг зардал нь илүү өндөр байдаг.

ДҮ16. Энэ асуудлыг УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-ны 10-р параграфт авч үзсэн гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. УСНББОУС 3-ын 10-р параграфт дараах байдлаар заасан:

“Тухайн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрдөх ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын талаар хамааралтай ба үнэн зөв илэрхийлэх мэдээллийг агуулсан санхүүгийн тайланг бэлтгэхэд хүргэнэ гэж УСНББОУСЗ-өөс дүгнэсэн тийм нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг УСНББОУС-д тодорхойлж заадаг. Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрдсөний үр нөлөө нь материаллаг бус тохиолдолд тэдгээр бодлогыг мөрдөхийг шаарддаггүй. Гэвч байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тухайлсан нэг толилуулгад хүрэхийн тулд УСНББОУС-аас материаллаг бус байдлаар гажуудуулах эсвэл тийм гажилтыг засварлахгүй орхих нь зохисгүй юм.”

ДҮ17. Тухайлбал; үр ашигт хүүний арга ашиглан тооцоолсон хорогдуулсан өртөг нь одоогийн арга зүйгээс материаллаг зөрүүгүй тохиолдолд тэрхүү хувилбар арга ашиглахыг стандартаар угаасаа зөвшөөрсөн байна гэж УСНББОУСЗ үзсэн. Тодруулгын хувьд үүнтэй ижил төсөөтэй заалт УСНББОУС 1-д байдаг гэдгийг УСНББОУСЗ бас тэмдэглэсэн. Иймээс үр ашигт хүүний арга ашиглалтын гажих тохиолдлын хувьд УСНББОУС 41-д өртөг/өгөөжийн зөвтгөн батлалт шаардлагагүй гэж УСНББОУСЗ дүгнэсэн.

Алтан гулдмай

ДҮ18. Алтан гулдмай нь СТОУС 9-д заасан, санхүүгийн хэрэглүүрийн тодорхойлолтыг хангахгүй. Валютын алттай холбоотой Улсын Секторын Тусгай Санхүүгийн Хэрэглүүрийн талаархи өөрийн төсөлд УСНББОУСЗ-ийн илэрхийлсэн саналд, энэ нь тохиромжтой эсэхийг УСНББОУСЗ авч үзсэн байна. Алтан гулдмай нь валютын алтаас илүү өргөн утгатай бөгөөд валютын талаар бүрэн эрхгүй байгууллагуудын хувьд уг заавар удирдамж нь тохиромжтой гэдгийг УСНББОУСЗ цохон тэмдэглэсэн. Иймээс УСНББОУСЗ нь Хэрэгжүүлэх Заавар Удирдамж Б.1-ийг тусган оруулахыг зөвшөөрсөн. Улсын Секторын Тусгай Санхүүгийн Хэрэглүүрийн талаархи өөрийн төслийг эцэслэн дүгнэх үедээ УСНББОУСЗ нь энэ асуудлыг дахин авч үзсэн.

Шилжилт

ДҮ19. Улсын секторын зарим ажил гүйлгээг УСНББОУС 41-ийн дагуу дахин ангилж болох юм гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Ийм дахин ангиллын хувьд шилжилтийн үеийн тусгай нөхцөл шаардлагатай байж болох эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн. Шилжилтийн үеийн ерөнхий ба тусгай чөлөөлөх нөхцлийн аль алиныг СТОУС 9-д тусган оруулсан бөгөөд УСНББОУС 41-д үүнийг мөрдсөн гэдгийг УСНББОУСЗ цохон тэмдэглэсэн. УСНББОУС 41 нь зэрэгцүүлэгдэх мэдээлэл бэлтгэх шаардлагаас чөлөөлөх тусгай нөхцлийг агуулсан байдаг. Иймээс УСНББОУСЗ нь нэмэлт чөлөөлөх нөхцөл шаардлагагүй гэж дүгнэсэн.

Үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай богино хугацаат авлага

- ДҮ20. 85-86-р параграфт шаардсанчлан, санхүүгийн хөрөнгийн нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг байгууллага нь худалдан авалт буюу үүсгэн гаргалтаар зээлийн үнэ цэнийн бууралттай уг хэрэглүүрийн анхны хэмжилгэнд тусган оруулдаг. Зээлийн эрсдлээр тохируулсан үр ашигт хүүний хувийг тооцоолох үедээ байгууллага нь анхны хүлээгдэж буй зээлийн алдагдлыг уг тооцоолсон мөнгөн гүйлгээнд мөн тусган оруулах шаардлагатай байдаг.
- ДҮ21. Хүлээн авсан үйлчилгээнийхээ төлбөрийг оролцогч нөгөө талууд төлж чадах эсэхээс үл хамааран улсын секторын байгууллагууд нь суурь үйлчилгээг үзүүлэхийн тулд тэдгээр бусад талуудтай ажил гүйлгээг ихэвчлэн хийх шаардлагатай байдаг гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Энэ нь ажил гүйлгээг анх хийх үед түүний төлбөрийн цуглуулагдах байдал эргэлзээтэй тийм ажил гүйлгээнүүд өндөр хувь хэмжээтэй байдаг гэсэн үг юм. Иймээс худалдан авсан буюу үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай ажил гүйлгээнд хамаарах шаардлагуудыг нэвтрүүлэн оруулсны боломжит үр дагавар нь улсын секторын байгууллагуудад нийтлэг нөлөө үзүүлж болох юм.
- ДҮ22. Боломжит үр дагаврыг харгалзсанаар, Зөвлөл нь авлагын хэмжилгэнд, түүнчлэн бараа, үйлчилгээний борлуулалттай холбоотой орлогын хүлээн зөвшөөрөлтөнд зээлийн алдагдлыг оруулан тооцохын ач холбогдлыг авч үзсэн. Тухайлбал; авлагын хувьд үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай гэсэн шаардлага тавихыг улсын секторын байгууллагуудаас шаардсанаар энэхүү зарчим нь улсын секторын байгууллагуудад санхүүгийн тайлагналын алдаатай шаардлага бий болгох эсэхийг Зөвлөл авч хэлэлцсэн.
- ДҮ23. Үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай гэсэн шаардлагыг богино хугацаат авлагад мөрдөх өртөг зардал нь улсын секторын байгууллагуудад бий болох өгөөжөөс хэтэрч илүү гарна гэж УСНББОУСЗ үзсэн. Яагаад гэвэл, богино хугацаат авлага нь үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай эсвэл хэвийн үүссэн эсэхээс үл хамааран тухайн байгууллага нь хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолох ёстой. Богино хугацаат авлага нь 12 сараас илүүгүй хугацааны дотор төлөгдөх ёстой тул нийт хугацаанд болон 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдал нь тэнцүү байна. Иймээс УСНББОУС 41 дэх үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай гэсэн шаардлагыг мөрдсөнөөр ханган бүрдүүлэх мэдээллийн өгөөж нь түүнийг бэлтгэх өртөг зардлаар дэмжигдэхгүй. Түүнийг бэлтгэх өртөг зардал нь тухайн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг болох хэвийн дахин давтагдах, маш олон тоо хэмжээтэй ажил гүйлгээний үр дүн болох богино хугацаат авлагын багц дундаас үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай авлагыг тогтоон тодорхойлох өртөг зардал юм.
- ДҮ24. Ийм учраас Зөвлөл нь худалдан авсан буюу үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай хэрэглүүрт хамаарах зарчмуудыг богино хугацаат авлагад мөрдөх хэрэггүй гэж үзсэн. СТОУС 9-өөс гажихыг дэмжихийн хамтаар Зөвлөл нь тухайн зарчмын онолын ач холбогдлыг үгүйсгэсэн бус, харин өртөг/өгөөжийн нөлөөллийг харгалзсан гэдгээ цохон тэмдэглэсэн.

Арилжааны бус ажил гүйлгээнээс үүсэх өмчийн хэрэглүүрийн мөн чанарыг шинжлэх

- ДҮ25. Санал өгсөн хүмүүс нь арилжааны бус ажил гүйлгээнээс өмчийн хэрэглүүр хэзээ үүссэн гэдгийг тогтооход төвөгтэй байж болно гэж дурдсан ба энэ талаархи нэмэлт заавар удирдамжийг хүссэн.
- ДҮ26. Эдгээр асуудлуудыг аль хэдийн зохих ёсоор харгалзан зохицуулж буй УСНББОУС 28 ба УСНББОУС 23-ын одоогийн шаардлагууд болон заавар удирдамжийг УСНББОУСЗ авч үзсэн. УСНББОУС 28 нь өмчийн хэрэглүүрийг тодорхойлж, санхүүгийн хэрэглүүрийг санхүүгийн өр төлбөр эсвэл өмчийн хэрэглүүр гэж хэрхэн тогтоох эсэхийг тайлбарладаг. УСНББОУС 23, *Арилжааны Бус Ажил Гүйлгээний Орлого (Татвар ба Шилжүүлэг)*-ын 28-р параграфт эздийн оруулсан хувь оролцооны жишээг тусгасан байдаг. Хэдийн тийм боловч арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн санхүүгийн хэрэглүүрийн мөн чанарыг шинжлэхэд тэдгээр санал өгсөн

хүмүүст дэмжлэг үзүүлэхийн тулд УСНББОУС3 нь хэрэгжүүлэх заавар удирдамж (Ж.4 параграф) боловсруулахыг зөвшөөрсөн.

Нэгтгэсэн санхүүгийн тайланд хейжийн зүйлс гэж сонгох

- ДҮ27. Аль хэрэглүүрийг хейжийн зүйлс гэж сонгож болох эсэхийг тодорхойлох үед УСНББОУС 35 ба энэ Стандарт хоорондоо харилцан уялдаатай үйлчилнэ гэдгийг УСНББОУС3 мэдэгдсэн. Ерөнхийдөө, тухайн тайлагнагч байгууллагын хувьд гадны этгээд болох тийм оролцогч тал бүхий тэдгээр хөрөнгө, өр төлбөр, арилжааны баталгаа, хэрэгжих өндөр магадлалтай урьдчилан таамагласан ажил гүйлгээг хейжийн нягтлан бодох бүртгэлийн зорилгоор хейжийн зүйл гэж сонгохыг энэ Стандартаар зөвшөөрдөг. Эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээнд гүйцэтгэсэн ажил гүйлгээг УСНББОУС 35-ын дагуу устгаж цэвэрлэдэг тул тухайн тайлагнагч байгууллагын хувьд гадны этгээд болох зөвхөн тийм оролцогч талтай хийгдсэн хэрэглүүрийг хүлээн зөвшөөрөх хязгаарлалт нь зайлшгүй шаардлагатай юм.
- ДҮ28. Гэвч УСНББОУС 35-ын 56 ба 58-р параграфт заасанчлан, хөрөнгө оруулалтын байгууллага нь өөрийн хяналтанд буй байгууллагуудыг нэгтгэдэггүй бөгөөд хөрөнгө оруулалтын байгууллагад хяналт тавигч байгууллага нь өөрийн хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллага дахь хөрөнгө оруулалтыг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжиж, нэгтгэсэн санхүүгийн тайлангаа толилуулдаг.
- ДҮ29. Хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллага ба уг хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын хөрөнгө оруулалт хооронд хийгдсэн ажил гүйлгээ нь хейжийн зүйлс гэж сонгох шалгуурыг хангахгүй гэж үзэх нь зохисгүй гэж УСНББОУС3 дүгнэсэн. Иймээс нэг эдийн засгийн нэгдмэл байгууллагад хамаарах байгууллагуудын хооронд хийгдсэн бөгөөд хөрөнгө оруулалтын байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд эсвэл хөрөнгө оруулалтын байгууллагын хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгагдах ажил гүйлгээний хувьд хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэхээр УСНББОУС3 шийдвэрлэсэн.

Улсын орны тусгайлсан хэв шинж бүхий үлгэрчилсэн жишээ

- ДҮ30. Санал өгсөн зарим хүмүүс нь улс орны тусгайлсан шинж чанаруудыг агуулсан, үлгэрчилсэн жишээ илүү ач холбогдолтой гэсэн санааг илэрхийлсэн. Зарим улс орнуудад нийтлэг байх шинж чанаруудыг үлгэрчлэн харуулвал тэдгээр ерөнхий жишээнүүд нь улс орнуудад илүү ач тустай болно гэж тэдгээр хүмүүс үзэж байв.
- ДҮ31. Төслийн явцад УСНББОУС3 нь тэдгээр бие даасан улс орнуудын санал болгосон хэв шинжид үндэслэсэн, үлгэрчилсэн жишээг боловсруулсан. Энэ нь олон зарчмуудын мөрдөлтийг үлгэрчлэн харуулах нарийн цогц жишээ боловсруулахад хүргэсэн. Санал өгсөн хүний хэв шинж нь тухайн үлгэрчилсэн жишээний шинж чанарыг толь адил тусган илэрхийлээгүй тохиолдолд аливаа бие даасан зарчмын мөрдөлтийг тайлбарлах нь асуудал маргаан үүсгэж байв. Түүнчлэн, байгууллага нь санхүүгийн хэрэглүүрүүдийн суурь үндэслэл болох тэдгээр нягтлан бодох бүртгэлийн зарчмууд хэрхэн харилцан үйлчлэх талаар угаасаа ойлголттой байх зөвхөн тийм тохиолдолд уг тайлбар ач холбогдолтой байсан. УСНББОУС3 нь ихэнх байгууллагуудын хувьд ийм жишээ ач холбогдолгүй гэж дүгнэсэн.
- ДҮ32. Иймээс үлгэрчилсэн жишээ бүр нь зөвхөн нэг зарчмын мөрдөлтийг үлгэрчлэн харуулах хэрэгтэй гэж УСНББОУС3 шийдвэрлэсэн. Энэ нь илүү олон байгууллагуудад ач тустай заавар удирдамжаар хангах бөгөөд суурь ухагдахууныг ойлгож мэдэхэд туслах юм. Байгууллага нь илүү нарийн төвөгтэй хэв шинжтэй байх тохиолдолд зарчмуудын зохистой мөрдөлтийг тодорхойлохын тулд бие даасан үлгэрчилсэн жишээнүүдийг шаардлагатай хэмжээгээр нэгтгэн нийлүүлж болох юм.

СТОУС 9-тэй нийцэлт

- ДҮ33. УСНББОУС 41-ийг боловсруулахдаа, УСНББОУС3 нь *НББОУС3-ийн Баримт Бичгийг Нягталж Шалгах ба Завсарлан Өөрчлөх Өөрийн Процесс*ыг даган мөрдсөн. СТОУС 9-ийн

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

гажилт гэдгийг батлан харуулах улсын секторын асуудлуудыг олж тогтоосон тийм нөхцөл байдалд СТОУС 9-д засвар өөрчлөлт оруулж ашигладаг. Ийм боловсруулалтын нэг хэсэг болгон УСНББОУСЗ нь олон асуудлуудыг судлан гаргаж, гажилт зохистой эсэхийг авч хэлэлцдэг.

Богино хугацаат авлага ба өглөг

- ДҮ34. УСНББОУС 29 дэх бодит үнэ цэнийн хэмжилтийн заавар удирдамжид нийцүүлэн УСНББОУС 41 нь дискаунтчлалын нөлөө материаллаг бус тохиолдолд тогтоосон хүүгүй, богино хугацаат авлага, өглөгийг анхны нэхэмжлэлийн дүнгээр хэмжихийг зөвшөөрсөн байдаг. Энэхүү сонголтыг УСНББОУС 41-ийн Мөрдөх Заавар Удирдамжид тусгасан. СТОУС 9 нь богино хугацаат зарим авлагын (СТОУС 15-д тодорхойлсон) хувьд бодит үнэ цэнийн хэмжилтийн гажих нөхцөлтэй байдаг бөгөөд УСНББОУС 41-д үүнтэй адилтгах гажих нөхцөл байхгүй байгааг хэрхэн ойлгох талаар санаа зовж буйгаа УСНББОУС 41-д хариулт ирүүлсэн хүмүүс илэрхийлсэн. УСНББОУСЗ нь тухайн заалтыг стандартын үндсэн текстэнд оруулж, СТОУС 9 дэх богино хугацаат авлагын гажих нөхцөлтэй ижил байршилд түүнийг тусгаснаар уг сонголт оршин байгаа гэдгийг онцлон харуулахаар шийдвэрлэсэн. УСНББОУС-уудын дагуу тогтоосон нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрдсөний үр нөлөө нь материаллаг бус тохиолдолд тэдгээр бодлогыг мөрдөхгүй байхыг УСНББОУС 3-ын 10-р параграфтаар байгууллагуудад угаасаа зөвшөөрсөн гэдгийг УСНББОУСЗ бас цохон тэмдэглэсэн.
- ДҮ35. Хэмжилтийн шаардлагуудын тууштай байдлыг хадгалахын тулд УСНББОУСЗ нь дискаунтчлалын нөлөө материаллаг бус тохиолдолд богино хугацаат авлага, өглөгийг анхны нэхэмжлэлийн дүнгээр хэмжихийг зөвшөөрсөн (60-р параграфыг үзнэ үү).

Үнэлгээний зөвшөөрөгдсөн арга зүй

- ДҮ36. УСНББОУС 41 нь өмчийн хэрэглүүрийг бодит үнэ цэнээр хэмжихийг байгууллагуудаас шаарддаг. Жишиг үнэгүй өмчийн хэрэглүүр хэлбэрээр байх хөрөнгө оруулалтын хувьд мэдэгдэхүйц олон боломжууд оршин байдаг тул улсын секторын байгууллагуудын олон нийтийн бодлогын зорилтуудыг харгалзан үзвэл бодит үнэ цэнийн хэмжилт нь нэлээд төвөгтэй байж болно гэдгийг тэдгээр санал өгсөн хүмүүс илэрхийлсэн.
- ДҮ37. Харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр ийм хөрөнгө оруулалтыг хэдээр борлуулж болохыг тооцоолох зорилго бүхий хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг зөвхөн лавлагаа болгосноор тухайн хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг тодорхойлох, эсвэл уг жишиг үнэгүй өмчийн хөрөнгө оруулалтын үйлчилгээний чадавхи гэх мэт бусад хүчин зүйлсийг бодит үнэ цэнийн хэмжилтэнд харгалзах эсэхийг санал өгсөн зарим хүмүүс тодруулж лавласан.
- ДҮ38. Энэхүү асуудлыг авч үзсэнээр, УСНББОУСЗ нь үлгэрчилсэн жишээ 24-28-ыг боловсруулсан бөгөөд жишиг үнэгүй өмчийн хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг тодорхойлохдоо тухайн улсын секторын байгууллагын хэрэглэж болох үнэлгээний янз бүрийн арга зүйг энд дурдсан. Жишээнд дурдсан, үнэлгээний арга техникүүд нь үнэлгээний боломжит бүх арга зүйг багтаан агуулаагүй болно.
- ДҮ39. Улсын секторын байгууллагууд нь жишиг үнэгүй өмчийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо ашиглаж болох үнэлгээний маш олон арга техник байдаг гэдгийг онцлон дурдахын тулд УСНББОУСЗ нь хэрэгжүүлэх тусгай заавар удирдамжийг боловсруулсан. ХЗУ-ын Д.2.4-д үнэлгээний тодорхой нэг арга зүй ашиглахаар заагаагүй, харин хэмжилтийн тохиромжтой арга зүйн сонголттой холбоотойгоор мэргэжлийн шүүн тунгаалт хийж, бүх баримт материал болон нөхцөл байдлыг харгалзан үзэхийг сайшаан дэмжсэн байдаг.

Үнэлгээний төсөөллүүд

- ДҮ40. Бодит үнэ цэнийн хэмжилтэнд ямар орц мэдээг тусган оруулах ба тэдгээр орц мэдээг боловсруулахдаа ямар төсөөлөл ашиглах хэрэгтэй эсэхийг авч үзсэн заавар удирдамж нэмж оруулахыг хариулт ирүүлсэн зарим хүмүүс санал болгосон. Хариулт ирүүлсэн хүмүүс нь

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

адилтгах зээлийн давамгайлах зах зээлийн хүүний түвшин, үл биелүүлэлтийн магадлал гэх мэт орц мэдээг тодорхойлох хүндрэл ба нарийн төвөгтэй байдлыг онцлон дурдсан.

ДҮ41. Зарим санхүүгийн хэрэглүүрийн хэмжилт нь нэлээд төвөгтэй үйл явц байж болох бөгөөд энэхүү төвөгтэй үйл явцын нэг төлөв байдал нь орц мэдээтэй холбоотой байдаг гэдгийг УСНББОУС3 цохон тэмдэглэсэн.

ДҮ42. Үнэлгээний нэмэлт заавар удирдамж боловсруулалт нь энэ Стандартын цар хүрээнд хамаарахгүй гэж УСНББОУС3 дүгнэсэн ба мэргэжлийн шүүн тунгаалт хийх нь санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн хэмжилтийн чухал төлөв байдал гэж үзсэн.

Анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн бодит үнэ цэнэ нь ажил гүйлгээний үнэтэй тэнцүү байдаггүй

ДҮ43. УСНББОУС 29-ийн МЗУ103-МЗУ116-р параграфыг хэвээр үлдээх нь санхүүгийн хэрэглүүрийн үнэлгээнд тууштай арга хандлага мөрдөхөд зайлшгүй шаардлагатай гэж УСНББОУС3 нь энэхүү Стандартыг боловсруулах үедээ дүгнэсэн. СТОУС 9 нь санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг хэмжих заавар удирдамж болгон хэрэглэгчдэд СТОУС 13, *Бодит Үнэ Цэнийн Хэмжилт*-ийг санал болгодог, харин СТОУС-аас ялгаатай нь, СТОУС 13-ын оронд боловсруулсан, адилтгах УСНББОУС байхгүй ба уг сонголтыг хийх боломжгүй тул УСНББОУС3 нь ийм шийдвэрт хүрсэн.

Улсын секторын тусгай жишээнүүд

ДҮ44. Стандартын практик мөрдөлтөнд дэмжлэг үзүүлэхийн тулд УСНББОУС3 нь нэмэлт үлгэрчилсэн жишээг боловсруулах хэрэгтэй гэдгийг хариулт ирүүлсэн зарим хүмүүс санал болгосон. УСНББОУС3 нь энэ хүсэлтийг харгалзан үзсэн ба улсын секторт тусгайлан хамаарах асуудалтай холбоотой тохиолдолд нэмэлт үлгэрчилсэн жишээ болон хэрэгжүүлэх заавар удирдамж боловсруулахыг зөвшөөрсөн. Хувийн хэвшилд мөн түгээмэл байдаг хэрэглүүрүүдийн хувьд нэмэлт үлгэрчилсэн жишээ боловсруулах талаархи тэдгээр хариулт ирүүлсэн хүмүүсийн саналыг УСНББОУС3 хүлээн зөвшөөрөөгүй. Ийм хэрэглүүрүүдийн хувьд СТОУС 9-өөс авсан заавар удирдамж нь тэдгээр хариулт ирүүлсэн хүмүүсийн сонирхож буй асуудлыг харгалзан үзэхэд хангалттай бөгөөд гажих тусгай тохиолдол байхгүй гэж УСНББОУС3 дүгнэсэн.

ҮЛГЭРЧИЛСЭН ЖИШЭЭ

АГУУЛГА

	Параграф
Үлгэрчилсэн жишээ	
Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг санхүүгийн өр төлбөр	ҮЖ1
Үнэ цэнийн бууралт (73-93-р параграф)	
Жишээ 1 – Зээлийн эрсдлийн мэдэгдэхүйц нэмэгдэлт	ҮЖ7
Жишээ 2 – Зээлийн эрсдлийн мэдэгдэхүйц нэмэгдэлт үүсээгүй	ҮЖ12
Жишээ 3 – Өндөр барьцаатай санхүүгийн хөрөнгө	ҮЖ18
Жишээ 4 – Олон нийтийн хөрөнгө оруулалт – Үнэ цэнэт бонд	ҮЖ24
Жишээ 5 – Зээлийн эрсдлийн өөрчлөлтөнд үзүүлэх хариу	ҮЖ29
Жишээ 6 – Зээлийн анхны хамгийн их эрсдэлтэй харьцуулалт	ҮЖ40
Жишээ 7 – Зээлийн эрсдлийн талаархи оролцогч нөгөө талын үнэлгээ	ҮЖ43
Жишээ 8 – “Үл биелүүлэлтийн тодорхой магадлал”-ын хандлагыг ашигласан, 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилт	ҮЖ49
Жишээ 9 – Алдагдлын хувийн жингийн хандлагад үндэслэсэн, 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилт	ҮЖ53
Жишээ 10 – Эргэлтийн зээлийн хэрэгслүүд	ҮЖ58
Жишээ 11 – Гэрээний мөнгөн гүйлгээний өөрчлөлт	ҮЖ66
Жишээ 12 – Хасагдуулгын матриц	ҮЖ74
Жишээ 13 – Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн өрийн хэрэглүүр	ҮЖ78
Жишээ 14 – Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулсан бодит үнэ цэнийн хэмжилтийн ангилал ба гадаад валютаар илэрхийлэлтийн хоорондох уялдаа, бодит үнэ цэнийн хейжийн нягтлан бодох бүртгэл ба үнэ цэнийн бууралт	ҮЖ82
Санхүүгийн хөрөнгийн дахин ангилал (94-100-р параграф)	
Жишээ 15 – Санхүүгийн хөрөнгийн дахин ангилал	ҮЖ104
Нэгтгэсэн эрсдлийн хейжийн нягтлан бодох бүртгэл	
Жишээ 16 – Бараа бүтээгдэхүүний үнийн эрсдэл ба Гадаад валютын эрсдлийн нэгдсэн хейж (Мөнгөн гүйлгээний хейж/Мөнгөн гүйлгээний хейжийн хослол)	ҮЖ116
Жишээ 17 – Хүүний түвшний эрсдэл ба Гадаад валютын эрсдлийн нэгдсэн хейж (Бодит үнэ цэнийн хейж/Мөнгөн гүйлгээний хейжийн хослол)	ҮЖ128
Жишээ 18 – Хүүний түвшний эрсдэл ба Гадаад валютын эрсдлийн нэгдсэн хейж (Мөнгөн гүйлгээний хейж/Бодит үнэ цэнийн хейжийн хослол)	ҮЖ138
Гадаад үйл ажиллагаа	
Жишээ 19 – Гадаад үйл ажиллагааны данснаас хасалт	ҮЖ149
Хөнгөлөлттэй зээл (МЗУ118-МЗУ127-р параграф)	
Жишээ 20 – Хөнгөлөлттэй зээлийн хүлээн авалт (Хүүний хөнгөлөлт)	ҮЖ153
Жишээ 21 – Хөнгөлөлттэй зээлийн төлөлт (Үндсэн дүнгийн хөнгөлөлт)	ҮЖ156
Жишээ 22 – Хөнгөлөлттэй зээлийн төлөлт (Зээл олгох баталгаа)	ҮЖ162
Санхүүгийн баталгаа (МЗУ131-МЗУ136-р параграф)	
Жишээ 23 – Нэрлэсэн төлбөртэй гаргасан санхүүгийн баталгааны гэрээ	ҮЖ173
Бодит үнэ цэнийн хэмжилтийн анхаарах зүйлс (66-68-р параграф)	
Жишээ 24 – Жишиг үнэгүй өмчийн хэрэглүүрийн үнэлгээ (Ижил буюу төсөөтэй хэрэглүүрийн хувьд төлсөн ажил гүйлгээний үнэ)	ҮЖ178
Жишээ 25 – Жишиг үнэгүй өмчийн хэрэглүүрийн үнэлгээ (Дискаунтчилсан мөнгөн гүйлгээ)	ҮЖ182
Жишээ 26 – Жишиг үнэгүй өмчийн хэрэглүүрийн үнэлгээ (Хязгаарлагдмал мэдээлэл бүхий тогтмол өсөлт)	ҮЖ186
Жишээ 27 – Жишиг үнэгүй өмчийн хэрэглүүрийн үнэлгээ (Залруулсан цэвэр хөрөнгө)	ҮЖ191

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Жишээ 28 – Арилжааны бус бүрэлдэхүүн хэсэгтэй, жишиг үнэгүй өмчийн хэрэглүүрийн үнэлгээ	ҮЖ196
Жишээ 29 – Арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн, жишиг үнэгүй өмчийн хэрэглүүрийн үнэлгээ	ҮЖ198
Жишээ 30 – Өрийн үүргийн үнэлгээ: Жишиг үнэ	ҮЖ203
Жишээ 31 – Өрийн үүргийн үнэлгээ: Өнөөгийн үнэ цэнийн арга зүй	ҮЖ206
Санхүүгийн хөрөнгийн ангилал (39-44-р параграф)	
Жишээ 32 – Эргэлтээс гаргах шинж бүхий капиталын захиалгын эрх	ҮЖ211
Үр ашигт хүүний арга (69-70-р параграф)	
Жишээ 33 – Хөнгөлөлттэй гаргасан ба ажил гүйлгээний зардалтай бондын үр ашигт хүүний хувийг хэмжих	ҮЖ215

Үлгэрчилсэн жишээ

Энэхүү үлгэрчилсэн жишээ нь УСНББОУС 41-ийг дагалдах боловч түүний салиггүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг санхүүгийн өр төлбөр

- ҮЖ1. УСНББОУС 41-ийн МЗУ241-р параграфын дагуу байгууллагын хийж болох тооцооллыг дараах жишээнд үлгэрчлэн харуулав.
- ҮЖ2. 20Х1 оны 01-р сарын 01-нд байгууллага нь 150,000 ТН-ийн⁷ нэрлэсэн үнэтэй, 10 жилийн хугацаатай, жилийн тогтмол 8 хувийн купоны хүүтэй бондыг гаргасан. Купоны хүү нь адилтгах шинж чанар бүхий бондуудын зах зээлийн түвшинтэй нийцэж байна.
- ҮЖ3. Тус байгууллага нь өөрийн ажиглаж болох (бенчмарк) хүүний түвшин болгон ЛАЙБОР-ыг ашигладаг. Бондын үүссэн өдрөөр ЛАЙБОР нь 5 хувь байсан. Эхний жилийн эцэст:
 - (а) ЛАЙБОР нь 4.75 хувь болж буурсан.
 - (б) Бондын бодит үнэ цэнэ нь 153,811 ТН буюу 7.6 хувийн хүүтэй адилтгах дүнтэй байсан.⁸
- ҮЖ4. Хүүний түвшний бүх өөрчлөлт нь өгөөжийн муруйн харгалзах өөрчлөлтийн үр дүн байх жигд өгөөжийн муруйтай бөгөөд зах зээлийн нөхцөл байдлын цорын ганц холбогдох өөрчлөлт нь ЛАЙБОР-ын өөрчлөлт байна гэж уг байгууллага дүгнэсэн.
- ҮЖ5. Байгууллага нь зах зээлийн нөхцөл байдлын өөрчлөлтөнд хамааруулж болохгүй бөгөөд зах зээлийн эрсдэл үүсэхэд хүргэх уг бондын бодит үнэ цэнийн өөрчлөлтийн дүнг дараах байдлаар тооцоолсон:

<p>[МЗУ241(а) параграф]</p> <p>Эхлээд, байгууллага нь тайлант үеийн эхэн дэх өр төлбөрийн ажиглаж болох зах зээлийн үнэ ба өр төлбөрийн гэрээний мөнгөн гүйлгээг ашигласнаар тухайн тайлант үеийн эхний байдлаар уг өр төлбөрийн өгөөжийн дотоод хувийг тооцоолдог. Өгөөжийн дотоод хувиас тухайн хэрэглүүрт хамаарах тусгайлсан бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлохын тулд тайлант үеийн эхэнд ажигласан (бенчмарк) хүүний түвшнээс энэхүү өгөөжийн түвшинг хасдаг.</p>	<p>10 жилийн хугацаатай, 8 хувийн купоны хүүтэй бондын тухайн тайлант үеийн эхэн дэх өгөөжийн дотоод хувь нь 8 хувь байсан.</p> <p>Ажигласан (бенчмарк) хүүний түвшин (ЛАЙБОР) нь 5 хувь учраас өгөөжийн дотоод хувиас тухайн хэрэглүүрт хамаарах тусгайлсан бүрэлдэхүүн хэсэг нь 3 хувь байна.</p>
--	---

⁷ Энэхүү заавар удирдамжид мөнгөн дүнг “тооцооны нэгж (ТН)” гэж тэмдэглэсэн.

⁸ Энэ нь ЛАЙБОР 5 хувиас 4.75 хувь болсон өөрчлөлтийг илэрхийлэх бөгөөд зах зээлийн нөхцөл байдалд бусад холбогдох өөрчлөлт ороогүй тохиолдолд үүний 0.15 хувийн өөрчлөлт нь тухайн хэрэглүүрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтийг тусгана гэж үзнэ.

<p>[МЗУ241(б) параграф]</p> <p>Үүний дараа, байгууллага нь (i) тайлант үеийн эцэс дэх ажиглаж болох (бенчмарк) хүүний түвшин, ба (ii) МЗУ241(а) параграфын дагуу тодорхойлсон, өгөөжийн дотоод хувиас тухайн хэрэглүүрт хамаарах тусгайлсан бүрэлдэхүүн хэсгийн нийлбэртэй тэнцүү байх дискаунтын хувь, түүнчлэн уг тайлант үеийн эцэс дэх өр төлбөрийн гэрээний мөнгөн гүйлгээг ашигласнаар тэрхүү өр төлбөрт хамаарах мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийг тооцоолдог.</p>	<p>Тайлант үеийн эцэс дэх хэрэглүүрийн гэрээний мөнгөн гүйлгээ нь:</p> <ul style="list-style-type: none"> • Хүү: 2-10 дахь жил тус бүрд 12,000ТН^(a). • Үндсэн дүн: 10 жилийн эцэст 150,000ТН. <p>Бондын өнөөгийн үнэ цэнийг тооцоолоход ашиглах дискаунтын хувь нь 7.75 хувь, энэ нь тайлант үеийн эцэс дэх 4.75 хувийн ЛАЙБОР дээр тухайн хэрэглүүрт хамаарах 3 хувийн тусгайлсан бүрэлдэхүүн хэсгийг нэмсэн дүн юм.</p> <p>Ингэснээр өнөөгийн үнэ цэнэ нь 152,367ТН болно.^(b)</p>
<p>[МЗУ241(в) параграф]</p> <p>Тайлант үеийн эцэс дэх өр төлбөрийн ажиглаж болох зах зээлийн үнэ ба МЗУ241(б) параграфын дагуу тодорхойлсон дүн хоорондох зөрүү нь ажиглаж болох (бенчмарк) хүүний түвшний өөрчлөлтөнд хамаарахгүй бодит үнэ цэнийн өөрчлөлт юм. Энэ нь 108(а) параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчид толилуулах дүн болно.</p> <p>(a) $150,000\text{TND} \times 8 \text{ хувь} = 12,000\text{TND}$.</p> <p>(б) $PV = [12,000\text{TND} \times (1 - (1 + 0.0775)^{-9})/0.0775] + 150,000\text{TND} \times (1 + 0.0775)^{-9}$.</p> <p>(в) Зах зээлийн үнэ $= [12,000\text{TND} \times (1 - (1 + 0.076)^{-9})/0.076] + 150,000\text{TND} \times (1 + 0.076)^{-9}$.</p>	<p>Тайлант үеийн эцэс дэх өр төлбөрийн зах зээлийн үнэ нь 153,811ТН байна.^(b)</p> <p>Иймээс 153,811ТН-аас 152,367ТН хассан зөрүү болох 1,444ТН-ийг байгууллага нь зах зээлийн эрсдэл үүсэхэд хүргэдэг зах зээлийн нөхцөл байдлын өөрчлөлтөнд хамааруулах боломжгүй бондын бодит үнэ цэнийн нэмэгдэлт байдлаар цэвэр хөрөнгө/өмчид толилуулна.</p>

Үнэ цэнийн бууралт (73-93-р параграф)

Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойшхи зээлийн эрсдлийн мэдэгдэхүйц нэмэгдэлтийг үнэлэх

ҮЖ6. Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг үнэлэх боломжит арга замуудыг дараах жишээнд үлгэрчлэн харуулав. Хялбарчлах үүднээс уг жишээнд зээлийн эрсдлийн шинжилгээний зөвхөн нэг төлөв байдлыг авч үзсэн. Гэвч нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй эсэх үнэлгээ нь их зардал буюу хүчин чармайлт гаргахгүйгээр олж авах боломжтой бөгөөд тухайн үнэлж буй санхүүгийн хэрэглүүрт хамааралтай, зохих ул үндэслэлтэй, дэмжих мэдээллийг харгалзах, олон хүчин зүйлсийн нэгдмэл шинжилгээ байдаг.

Жишээ 1—Зээлийн эрсдлийн мэдэгдэхүйц нэмэгдэлт

ҮЖ7. У компани нь өөр өөр багц бүхий хамгаалагдсан, тэргүүн ээлжийн эрхтэй зээлийн хэрэгслийг агуулсан санхүүжилтийн бүтэцтэй⁹. У компани нь түүнд багц зээлийн хэрэгсэл олгох Үндэсний Хөгжлийн Банкнаас тусалцаа авах шалгуурыг хангадаг. Адилтгах зээлийн эрсдэл бүхий бусад өрийн хэрэглүүр гаргагчидтай харьцуулахад У компанийн хөшүүрэг харьцангуй өндөр байсан боловч Үндэсний Хөгжлийн Банк нь зээлийг олгох үедээ У компани тухайн хэрэглүүрийн нийт хугацааны туршид зээлийн нөхцлүүдийг ханган биелүүлэх боломжтой гэж үзсэн. Түүнчлэн, орлого болон мөнгөн гүйлгээ бий болголт нь У компанийн үйл ажиллагаа явуулдаг салбарт тэрхүү тэргүүн ээлжийн эрхтэй хэрэглүүрийн нийт хугацааны туршид тогтвортой байхаар хүлээгдэж байв. Гэхдээ түүний

⁹ Зээлийн хамгаалалт нь зээлийн төлбөрийн үл биелүүлэлт үүссэн үед учрах гарзыг бууруулж нөлөөлдөг боловч төлбөрийн үл биелүүлэлт үүсэх эрсдэлд нөлөө үзүүлдэггүй. Иймээс УСНББОУС 41-ийн 75-р параграфар шаардсанчлан, анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг тодорхойлох үед зээлийн хамгаалалтыг харгалзан үздэггүй.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

одоогийн бизнесийн хүрээнд нийт ашгийн түвшинг нэмэгдүүлэх чадвар боломжийн хувьд бизнесийн зарим эрсдэлтэй байсан.

- ҮЖ8. Уг зээл нь УСНББОУС 41-ийн 9-р параграфт заасан, зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн тодорхойлолтыг хангахгүй тул Үндэсний Хөгжлийн Банк нь анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн зээлийн эрсдлийн түвшинг үл харгалзаж, дээрх ҮЖ7-р параграфт дурдсан зүйлсийн үр дүнд тухайн зээлийг анх хүлээн зөвшөөрөхдөө, үүсгэн гаргасан зээлийн үнэ цэнийн бууралттай зээл биш гэж үзсэн.
- ҮЖ9. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараах макро эдийн засгийн өөрчлөлтүүд нь нийт борлуулалтын тоо хэмжээнд сөргөөр нөлөөлсөн бөгөөд У компани нь орлого болон цэвэр мөнгөн гүйлгээ бий болголтын хувьд өөрийн бизнесийн төлөвлөгөөг биелүүлж чадаагүй. Хэдийгээр бараа материалд зарцуулсан хөрөнгө нэмэгдсэн боловч төсөөлсөн борлуулалтыг хийгээгүй. Хөрвөх чадвараа нэмэгдүүлэхийн тулд У компани нь эргэлтийн зээлийн тусдаа хэрэгслийг илүү ихээр арилжсан бөгөөд ингэснээр түүний хөшүүргийн харьцаа нэмэгдсэн. Үүний улмаас У компани нь Үндэсний Хөгжлийн Банктай байгуулсан, хамгаалагдсан, тэргүүн ээлжийн эрхтэй зээлийн хэрэгслийн нөхцлүүдийг зөрчихөд ойрхон болоод байна.
- ҮЖ10. Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш нэмэгдсэн зээлийн эрсдлийн хэмжээг үнэлэхэд хамааралтай бөгөөд их зардал буюу хүчин чармайлт гаргахгүйгээр олж болох ул үндэслэлтэй ба дэмжих бүх мэдээллийг харгалзан үзсэнээр Үндэсний Хөгжлийн Банк нь У компанид олгосон зээлийн эрсдлийн ерөнхий үнэлгээг тухайн тайлангийн өдрөөр хийнэ. Үүнд дараах гэх мэт хүчин зүйлс хамаарч болох юм:
- (а) У компанийн мөнгөн гүйлгээ бий болгох ба өрийн түвшинг бууруулах чадвар боломжид цаашид сөргөөр нөлөөлөх макро эдийн засгийн орчны таагүй өөрчлөлт нь ойрын ирээдүйд үргэлжилнэ гэсэн Үндэсний Хөгжлийн Банкны хүлээлт.
 - (б) У компани нь зээлийн хэрэгслийн нөхцлүүдийг зөрчихөд ойрхон болоод байгаа, иймээс тухайн зээлд бүтцийн өөрчлөлт хийх эсвэл нөхцлүүдийг дахин тогтоох шаардлагатай болж болох юм.
 - (в) У компанийн бондын арилжааны үнэ буурсан ба шинээр үүсгэн бий болгох зээлийн хувьд тогтоох зээлийн маржин нь уг зээлийн эрсдлийн нэмэгдэлтийг тусгахын тулд нэмэгдэнэ, эдгээр өөрчлөлтийг тухайн зах зээлийн орчны өөрчлөлтөөр тайлбарлаж чадахгүй (тухайлбал; бенчмарк хүүний түвшин нь өөрчлөгдөхгүй хэвээр байна) гэсэн Үндэсний Хөгжлийн Банкны үнэлгээ. У компанийн бондын үнийн бууралт болон түүний зээлийн маржины нэмэгдэлт нь тухайн компанийн тусгай хүчин зүйлсээс шалтгаалсан байх магадлалтай гэдгийг У компанийн өрсөлдөгч компаниудын үнийн түвшинтэй хийсэн цаашдын харьцуулалтаар харуулна.
 - (г) Зээлийн эрсдлийн нэмэгдэлтийг тусгахын тулд бэлэн боломжтой байгаа мэдээлэлд үндэслэн Үндэсний Хөгжлийн Банк нь уг зээлийн талаархи өөрийн дотоод эрсдлийн үнэлгээг дахин үнэлж үзнэ.

ҮЖ11. Уг зээлийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг Үндэсний Хөгжлийн Банк нь УСНББОУС 41-ийн 75-р параграфын дагуу тодорхойлно. Иймээс Үндэсний Хөгжлийн Банк нь У компанид олгосон, өөрийн хамгаалагдсан, тэргүүн ээлжийн эрхтэй зээлийн нийт хугацаанд хүлээгдэж буй алдагдлыг хүлээн зөвшөөрнө. Хэдийгээр Үндэсний Хөгжлийн Банк нь тухайн зээлийн талаархи өөрийн дотоод эрсдлийн үнэлгээг хараахан өөрчлөөгүй байгаа боловч ийм дүгнэлтэнд хүрч болно—эрсдлийн үнэлгээнд өөрчлөлт орсон эсвэл үгүй эсэх нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг тодорхойлогч зүйл биш юм.

Жишээ 2—Зээлийн эрсдлийн мэдэгдэхүйц нэмэгдэлт үүсээгүй

ҮЖ12. В компани нь улирлын шинж чанартай салбарт үйл ажиллагаа явуулдаг группын холдинг компани юм. Б мужийн засгийн газар нь В компанид зээл олгосон. Энэ үед тухайн салбарын хэтийн төлөв нь олон улс дахь эрэлтийн цаашдын өсөлтийн хүлээлтээс хамааран эерэг байсан. Гэвч орцын үнэ хувьсамтгай бөгөөд мөчлөгийн тодорхой цэгт борлуулалт буурч магадгүй гэж урьдчилан таамаглаж байв.

- ҮЖ13. Түүнчлэн, өнгөрсөн хугацаанд В компани нь холбогдох секторууд дахь компаниудын олонхийн хувьцааг худалдан авч, гадаад өсөлтөнд голлон анхаарч байсан. Үүний үр дүнд тус группын бүтэц нарийн цогц болж, хувьсан өөрчлөгдсөн. Ингэснээр тухайн группын хүлээгдэж буй гүйцэтгэлийг шинжилж, холдинг компанийн түвшинд бэлэн боломжтой байх мөнгөн дүнг прогнозчилоход хөрөнгө оруулагч нарт төвөгтэй болсон. Б мужийн засгийн газар нь зээлийг үүсгэн бий болгох үед хөшүүрэг нь В компанийн зээлдүүлэгчдийн хүлээн зөвшөөрнө гэж үзсэн түвшинд байгаа боловч одоогийн санхүүжилтийн хугацаа дуусах хүртэл богино хугацаа үлдсэн тул өөрийн өрийг дахин санхүүжүүлэх В компанийн чадварт түүний зээлдүүлэгч нар санаа зовж байна. Өөрийн үйл ажиллагааны охин компаниудаас авах ногдол ашгаараа В компани нь хүүгээ цаашид төлсөөр байх түүний чадвар боломжид бас эргэлзэж байгаа юм.
- ҮЖ14. Б мужийн засгийн газар нь зээлийг үүсгэн бий болгох үед В компанийн хөшүүрэг нь ижил төсөөтэй зээлийн эрсдэл бүхий бусад зээлдэгчдийн хөшүүрэгтэй адилтгах түвшинд байсан бөгөөд уг зээлийн хүлээгдэж буй хугацаан дахь төсөвлөлтөнд үндэслэн авч үзвэл, төлбөрийн үл биелүүлэлтэнд хүргэхээс өмнөх түүний хүү нөхөлтийн харьцааны боломжит хэмжээ (өөрөөр хэлбэл, “хоосон зай”) нь өндөр байв. Б мужийн засгийн газар нь зээлийн эрсдлийг тодорхойлох өөрийн дотоод үнэлгээ зэрэглэлийн аргуудыг хэрэглэдэг бөгөөд зээлүүддээ дотоод зэрэглэлийн тусгай оноог хуваарилдаг. Б мужийн засгийн газрын дотоод зэрэглэлийн ангилал нь түүхэн, одоогийн болон хэтийн мэдээлэлд үндэслэдэг бөгөөд зээлүүдийн ерөнхий хугацааны турш дахь зээлийн эрсдлийг тусгадаг. Уг зээл нь зээлийн мэдэгдэхүйц эрсдэлтэй ба сэжиглэн таамаглах элементүүдтэй, түүнчлэн В компанид нөлөөлөх тодорхойгүй байдал, үүн дотроо тухайн группын мөнгө бий болголтын тодорхой бус хэтийн төлөв нь төлбөрийн үл биелүүлэлтэнд хүргэж болох юм гэж Б мужийн засгийн газар нь анх хүлээн зөвшөөрөх үедээ тодорхойлсон. Гэвч УСНББОУС 41-ийн 9-р параграфт заасан, худалдан авсан буюу үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн тодорхойлолтыг хангахгүй учраас Б мужийн засгийн газар нь уг зээлийг үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгө гэж үзээгүй.
- ҮЖ15. В компани нь таван охин компанитай бөгөөд зах зээлийн доройтсон нөхцөл байдлын улмаас тэдгээрийн гурван охин компанийн борлуулалтын хэмжээ мэдэгдэхүйц буурсан боловч тухайн салбарын урьдчилан таамагласан мөчлөгийн дагуу борлуулалтын хэмжээ ирэх саруудад нэмэгдэхээр хүлээгдэж буй гэдгийг анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа зарлан мэдэгдсэн. Нөгөө хоёр охин компанийн борлуулалт нь тогтвортой байсан. Мөн В компани нь өөрийн үйл ажиллагааны охин компаниудыг оновчтой болгох үүднээс корпорацийн бүтцийн өөрчлөлт хийхээр мэдэгдсэн. Энэхүү бүтцийн өөрчлөлт нь одоо байгаа өрийг дахин санхүүжүүлэх ба В компанид ногдол ашиг төлөх уг үйл ажиллагааны охин компаниудын чадвар боломжийг нэмэгдүүлэх юм.
- ҮЖ16. В компанид олгосон зээлийн хувьд зээлийн эрсдэл нь түүний анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш УСНББОУС 41-ийн 75-р параграфт заасантай адил мэдэгдэхүйц нэмэгдээгүй гэж Б мужийн засгийн газар нь зах зээлийн нөхцөл байдлын хүлээгдэж буй цаашдын доройтлыг үл харгалзан тодорхойлсон. Үүнийг дараах гэх мэт хүчин зүйлсээр илэрхийлсэн:
- (а) Одоогийн борлуулалтын хэмжээ буурсан боловч Б мужийн засгийн газар нь анх хүлээн зөвшөөрөх үед үүнийг урьдчилан таамаглаж байсан. Түүнчлэн, борлуулалтын хэмжээ нь ирэх саруудад нэмэгдэхээр хүлээгдэж байна.
 - (б) Одоогийн өрийг тухайн үйл ажиллагааны охин компанийн түвшинд дахин санхүүжүүлэх тэрхүү нэмэгдсэн уян хатан байдал ба В компанид ногдол ашиг төлөх нэмэгдсэн чадвар боломжийг харгалзаж, Б мужийн засгийн газар нь уг корпорацийн бүтцийн өөрчлөлтөөр зээлийн чанар сайжирсан гэж үзсэн. Энэ нь холдинг компанийн түвшинд уг одоогийн өрийг дахин санхүүжүүлэх чадвар боломжийн талаархи зарим эргэлзээнд цохилт өгсөн.
 - (в) Сүүлийн үеийн хөгжил өөрчлөлт нь түүний зээлийн эрсдлийн дотоод зэрэглэлийг өөрчлөхөд хүргэх хангалттай хэмжээнд байгаагүй гэж уг В компанийг хянан зохицуулдаг Б мужийн засгийн газрын зээлийн эрсдлийн хэлтэс дүгнэсэн.
- ҮЖ17. Иймээс Б мужийн засгийн газар нь уг зээлийн нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр гарзын хасагдуулга хүлээн зөвшөөрөхгүй. Харин дараагийн 12 сарын хугацаанд гарах төлбөрийн үл биелүүлэлтийн нэмэгдсэн эрсдэл, түүнчлэн хэрэв төлбөрийн үл биелүүлэлт үүсвэл

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

нэмэгдэх зээлийн алдагдлын одоогийн хүлээлтийн хувьд 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлын талаархи өөрийн хэмжилтийг шинэчлэн баяжуулна.

Жишээ 3—Өндөр барьцаатай санхүүгийн хөрөнгө

- ҮЖ18. И компани нь төрийн өмчит Хөдөө Аж Ахуйн Банкнаас таван жилийн хугацаатай авсан зээлээр санхүүжүүлсэн газрыг өмчилдөг бөгөөд зээл-үнэ цэнийн (ЗҮЦ) харьцаа нь 50 хувь байв. Газраар илэрхийлэгдэх нэгдүгээр зэрэглэлийн барьцаагаар уг зээл хамгаалагдсан. Зээлийг анх хүлээн зөвшөөрөх үед төрийн өмчит Хөдөө Аж Ахуйн Банк нь уг зээлийг УСНББОУС 41-ийн 9-р параграфт тодорхойлсончлон, үүсгэн гаргасан үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгө гэж үзээгүй.
- ҮЖ19. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа, И компанийн орлого болон үйл ажиллагааны ашиг нь эдийн засгийн зогсонги байдлын улмаас буурсан. Түүнчлэн, зохицуулалтын хүлээгдэж буй чангаралт нь орлого болон үйл ажиллагааны ашигт цаашид сөргөөр нөлөөлөх боломжтой юм. И компанийн үйл ажиллагаанд үзүүлэх эдгээр сөрөг үр дагавар нь мэдэгдэхүйц дүнтэй бөгөөд цаашид үргэлжлэхээр байна.
- ҮЖ20. Сүүлийн үеийн эдгээр үйл явдлууд болон эдийн засгийн хүлээгдэж буй сөрөг нөхцөл байдлын улмаас И компанийн чөлөөт мөнгөн гүйлгээ нь буурч, уг хуваарьт зээлийн төлбөрийг барагдуулахад ихээхэн төвөгтэй болох тийм цэгт хүрэхээр байна. Мөнгөн гүйлгэний цаашдын доройтол нь И компани зээлийн гэрээт төлбөрүүдийг төлж чадахгүй ба төлбөрийн хугацаа хэтрэлтэнд хүргэж магадгүй гэдгийг төрийн өмчит Хөдөө Аж Ахуйн Банк тооцоолсон.
- ҮЖ21. Гуравдагч талын хийсэн сүүлийн үеийн үнэлгээ нь уг газрын үнэ цэнэ буурсан ба ингэснээр ЗҮЦ-ийн харьцаа 70 хувь болсон гэдгийг харуулж байна.
- ҮЖ22. И компанид олгосон зээлийг тухайн тайлангийн өдөр УСНББОУС 41-ийн 82-р параграфын дагуу зээлийн эрсдэл багатай гэж үзэхгүй. Иймээс зээлийн эрсдэл нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш УСНББОУС 41-ийн 75-р параграфт заасантай адил мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг уг төрийн өмчит Хөдөө Аж Ахуйн Банк нь эзэмшиж буй барьцааны үнэ цэнийг үл харгалзан үнэлэх шаардлагатай юм. Мөнгөн гүйлгээний багахан доройтол нь И компани уг зээлийн гэрээт төлбөрийг барагдуулж чадахгүй болоход хүргэх учраас тус зээл нь тухайн тайлангийн өдрөөр зээлийн нэлээд эрсдэлтэй гэж үзсэн. Үүний улмаас төрийн өмчит Хөдөө Аж Ахуйн Банк нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл (өөрөөр хэлбэл, үл биелүүлэлт гарах эрсдэл) мэдэгдэхүйц нэмэгдсэн гэж тодорхойлсон. Иймээс төрийн өмчит Хөдөө Аж Ахуйн Банк нь И компанид олгосон зээлийн хувьд нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрнө.
- ҮЖ23. Хэдийгээр нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй боловч тухайн хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилт нь УСНББОУС 41-ийн МЗУ219-р параграфтаар шаардсанчлан, үл хөдлөх хөрөнгийн барьцаанаас олж болох нөхөлтийг (барьцаа хөрөнгийг олж эзэмших ба борлуулах зардлаар тохируулсан) тусгах тул зээлийн хүлээгдэж буй алдагдал нь маш бага дүтэй байж болох юм.

Жишээ 4—Олон нийтийн хөрөнгө оруулалт – Үнэ цэнэт бонд

- ҮЖ24. А компани нь биржид бүртгэлтэй, үндэсний томоохон ложистик компани юм. Түүний капиталын бүтэц дэх цорын ганц өр нь нийтэд гаргасан таван жилийн хугацаатай бонд бөгөөд уг бондын гол нөхцөл болгон өөр бусад зээллэг авахыг хязгаарласан. А компани нь хувьцаа эзэмшигчиддээ улирлаар тайлагнадаг. Үндэсний Олон Нийтийн Хөрөнгө Оруулалтын Сан нь бондоор санхүүжилт хийсэн олон хөрөнгө оруулагчдын нэг юм. Тус Хөрөнгө Оруулалтын Сан нь уг бондыг анх хүлээн зөвшөөрөх үед УСНББОУС 41-ийн 82-р параграфын дагуу зээлийн эрсдэл багатай гэж дүгнэсэн. Яагаад гэвэл, бонд нь үл биелүүлэлтийн эрсдэл багатай ба А компани нь өөрийн үүргийг ойрын хугацаанд барагдуулах чадвар сайтай байна гэж үзсэн. Хөрөнгө Оруулалтын Сангийн урт хугацааны хүлээлтээр бол эдийн засгийн болон бизнесийн нөхцөл байдалд сөрөг өөрчлөлт гарч болох боловч бондын хувьд өөрийн үүргийг биелүүлэх А компанийн чадвар боломжийг заавал бууруулах албагүй юм. Түүнчлэн, анх хүлээн зөвшөөрөх үед бонд нь зээлийн дотоод зэрэглэлтэй байсан бөгөөд тэрхүү зэрэглэл нь олон улсад хэрэглэдэг 'хөрөнгө оруулалтын үнэ цэнэт' гэсэн гадны зээлийн зэрэглэлтэй харилцан уялдаг.

- ҮЖ25. Тухайн тайлангийн өдрөөр Хөрөнгө Оруулалтын Сангийн зээлийн эрсдлийн гол асуудал нь А компанийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ буурахад хүргэж буй борлуулалтын нийт тоо хэмжээний байнгын бууралт юм.
- ҮЖ26. Хөрөнгө Оруулалтын Сан нь зөвхөн нийтэд танилцуулсан улирал тутмын мэдээнд итгэл үзүүлдэг бөгөөд зээлийн эрсдлийн хувийн мэдээлэлд хандан нэвтэрдэггүй (энэ нь бондын хөрөнгө оруулагч) учраас зээлийн эрсдлийн өөрчлөлтийн талаархи түүний үнэлгээ нь нийтэд зарласан мэдэгдэл ба мэдээлэлд, үүн дотроо зэрэглэл тогтоогч агентлагуудаас хэвлэлд өгсөн зээлийн хэтийн төлвийн шинэчилсэн мэдээнд үндэслэдэг.
- ҮЖ27. Хөрөнгө Оруулалтын Сан нь УСНББОУС 41-ийн 82-р параграфт заасан, зээлийн бага эрсдлийн хялбарчилсан горимыг мөрддөг. Иймээс их зардал буюу хүчин чармайлт гаргахгүйгээр олж авах боломжтой, ул үндэслэлтэй ба дэмжих бүх мэдээллийг ашигласнаар Хөрөнгө Оруулалтын Сан нь уг бонд зээлийн эрсдэл багатай эсэхийг тухайн тайлангийн өдрөөр үнэлдэг. Ийм үнэлгээг хийхдээ, Хөрөнгө Оруулалтын Сан нь бондын зээлийн дотоод зэрэглэлийг дахин хянан үнэлж, уг бонд дараах зүйлсийн улмаас хөрөнгө оруулалтын үнэ цэнэт гэсэн зэрэглэлтэй адилтгах үнэлэмжтэй байхаа больсон гэж дүгнэсэн:
- (а) Өмнөх улиралтай харьцуулахад, А компанийн орлого 20 хувиар, үйл ажиллагааны ашиг 12 хувиар буурсан гэдгийг түүний хамгийн сүүлийн улирлын тайлангаар харуулсан.
 - (б) Зэрэглэл тогтоогч агентлагууд нь А компанийн ашгийн талаархи сэрэмжлүүлэгт сөрөг хариу үзүүлж, тухайн шалган үзэж буй зээлийн зэрэглэлийг хөрөнгө оруулалтын үнэ цэнэт гэдгээс хөрөнгө оруулалтын бус үнэ цэнэт болгон бууруулах боломжтой юм. Гэвч гаднын зээлийн эрсдлийн зэрэглэл нь тухайн тайлангийн өдрөөр өөрчлөгдөөгүй байсан.
 - (в) Бондын үнэ бас мэдэгдэхүйц буурснаар дуусгавар хугацаа хүртэлх өгөөж өндөр болоход хүргэсэн. А компанийн зээлийн эрсдэл нэмэгдсэний улмаас бондын үнэ буурсан гэж Хөрөнгө Оруулалтын Сан дүгнэсэн. Яагаад гэвэл, зах зээлийн орчин өөрчлөгдөөгүй (тухайлбал; бенчмарк хүүний түвшин, хөрвөх чадвар гэх мэт өөрчлөгдөөгүй) ба уг бууралт нь тухайн компаниас хамаарах тусгайлсан шинжтэй (жишээлбэл; бенчмарк хүүний түвшний өөрчлөлт нь компанийн тусгайлсан зээлийн эрсдлийн илрэл биш юм) гэдгийг түүний өрсөлдөгч компаниудын бондын үнэтэй хийсэн харьцуулалт харуулсан.
- ҮЖ28. А компани нь өөрийн үүрэг хариуцлагыг биелүүлэх чадвартай байгаа боловч бизнесийн болон эдийн засгийн сөрөг нөхцөл байдлуудаас үүсэх ихээхэн тодорхойгүй байдал нь уг бондын хувьд үл биелүүлэлт гарах эрсдлийг нэмэгдүүлсэн. ҮЖ27-р параграфт дурдсан хүчин зүйлсийн үр дүнд, тус бонд нь тухайн тайлангийн өдрөөр зээлийн эрсдэл багатай биш байна гэж Хөрөнгө Оруулалтын Сан тодорхойлсон. Иймээс анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойшхи зээлийн эрсдлийн нэмэгдэлт нь мэдэгдэхүйц дүнтэй эсэхийг Хөрөнгө Оруулалтын Сан тодорхойлох шаардлагатай. Өөрийн үнэлгээнд үндэслэн Хөрөнгө Оруулалтын Сан нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн бөгөөд нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр гарзын хасагдуулгыг УСНББОУС 41-ийн 75-р параграфын дагуу хүлээн зөвшөөрөх хэрэгтэй гэж үзсэн.

Жишээ 5—Зээлийн эрсдлийн өөрчлөлтөнд үзүүлэх хариу

- ҮЖ29. АБВ Орон Сууцны Корпораци нь амьдран суух зориулалттай үл хөдлөх хөрөнгийг санхүүжүүлэхийн тулд АБВ-гийн гурван өөр нутаг дэвсгэр дэх иргэдэд моргейжийн зээлийн үйлчилгээ үзүүлдэг. Моргейжийн зээлийг ЗҮЦ-ийн төрөл бүрийн шалгуураар, янз бүрийн орлогын бүлгийн хүмүүст олгодог. Моргейжийн өргөдөл гаргах үйл явцын нэг хэсэг болгон зээлдэгч нар нь өөрийн ажил, хөдөлмөр эрхэлдэг салбар, моргейжийн зээлийн барьцаа болгох үл хөдлөх хөрөнгийн шуудангийн дугаар гэх мэт мэдээллээр хангах шаардлагатай юм.
- ҮЖ30. АБВ Орон Сууцны Корпораци нь зээлийн оноонд үндэслэсэн өөрийн хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг тогтоосон. Зээлдэгч нар нь гэрээний төлбөрийн үүргээ биелүүлж чадна гэж үздэг учраас “хүлээн зөвшөөрөх түвшин”-ээс дээш оноо бүхий зээлийг зөвшөөрөн баталдаг. Моргейжийн шинэ

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

зээл олгох үедээ АБВ Орон Сууцны Корпораци нь гарч тохиолдох үл биелүүлэлтийн эрсдлийг анхны хүлээн зөвшөөрөлтийн өдрийн байдлаар тодорхойлохын тулд уг зээлийн оноог ашигладаг.

ҮЖ31. Бүх нутаг дэвсгэрт эдийн засгийн нөхцөл байдал мэдэгдэхүйц доройтохоор хүлээгдэж буйг АБВ Орон Сууцны Корпораци нь тухайн тайлангийн өдрөөр тодорхойлсон. ЗҮЦ-ийн харьцаа өссөний улмаас амьдран суух зориулалттай үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнэ нь буурахаар хүлээгдэж байгаа боловч ажилгүйдлийн түвшин нэмэгдэхээр байна. Эдийн засгийн нөхцөл байдлын хүлээгдэж буй доройтлын улмаас моргейжийн зээлийн багцын хувьд төлбөрийн үл биелүүлэлтийн түвшин нэмэгдэнэ гэж АБВ Орон Сууцны Корпораци үзэж байна.

Тус тусын үнэлгээ

ҮЖ32. Нэгдүгээр нутаг дэвсгэрийн хувьд АБВ Орон Сууцны Корпораци нь төлөв байдлын автоматжуулсан оноо тогтоох процессыг ашигласнаар өөрийн зээл нэг бүрийг сар тутам үнэлдэг. Түүний оноо тогтоох загвар нь одоогийн болон өнгөрсөн түүхэн төлөв байдал, зээлдэгчийн өрийн түвшин, ЗҮЦ-ийн хэмжүүр, зээлийн хэмжээ, зээл үүссэнээс хойшхи хугацаа зэрэгт үндэслэдэг. Шуудангийн дугаарт нутаг дэвсгэр бүр дэх сүүлийн үеийн борлуулалт, түүнчлэн их зардал буюу хүчин чармайлт гаргахгүйгээр олж авах боломжтой, ул үндэслэлтэй ба дэмжих хэтийн мэдээллийг ашигласнаар үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнийг дахин тооцоолдог автоматжуулсан процессоор дамжуулан АБВ Орон Сууцны Корпораци нь ЗҮЦ-ийн хэмжүүрийг үечилсэн сууриар шинэчлэн баяжуулдаг.

ҮЖ33. Амьдран суух зориулалттай үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнэ ба моргейжийн зээлийн төлбөрийн үл биелүүлэлтийн түвшин хооронд хүчтэй харилцан хамаарал байгааг харуулсан түүхэн мэдээ АБВ Орон Сууцны Корпорацид байдаг. Өөрөөр хэлбэл, амьдран суух зориулалттай үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнэ буурсан тохиолдолд зээлдэгч нь моргейжийн зээлийн буцаан төлөлтийн хуваарьт төлбөрийг хийх эдийн засгийн сэдэл урамшуулал багатай болж, төлбөрийн үл биелүүлэлт гарах эрсдэл нэмэгддэг.

ҮЖ34. Амьдран суух зориулалттай үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнийн хүлээгдэж буй бууралтаас шалтгаалсан төлбөрийн үл биелүүлэлтийн нэмэгдсэн эрсдлээр тухайн төлөв байдлын оноог залруулдаг. Ингэхдээ төлөв байдлын оноо тогтоох загвар дахь ЗҮЦ-ийн хэмжүүрийн нөлөөгөөр дамжуулан уг залруулгыг хийнэ. Моргейжийн зээл нь хугацааны эцэст (болон дараагийн 12 сараас урт хугацаанд) ихэнх төлбөрийг барагдуулах үүрэг бүхий найрсаг зээл байсан ч гэсэн үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнийн хүлээгдэж буй бууралтын үр дүн байдлаар тэрхүү төлөв байдлын оноог залруулж болох юм. ЗҮЦ-ийн өндөр харьцаа бүхий моргейжийн зээл нь амьдран суух зориулалттай үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлтөнд илүү мэдрэмжтэй байх бөгөөд хэрэв төлөв байдлын оноо буурч муудвал моргейжийн зээлийн хугацаа өнгөрөхөөс өмнө тухайн тодорхой зээлдүүлэгчдийн хувьд АБВ Орон Сууцны Корпораци нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойшхи зээлийн эрсдлийн мэдэгдэхүйц нэмэгдэлтийг тодорхойлж чадах юм.

ҮЖ35. Зээлийн эрсдлийн нэмэгдэлт нь мэдэгдэхүйц дүнтэй байх тохиолдолд нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр гарзын хасагдуулгыг хүлээн зөвшөөрдөг. АБВ Орон Сууцны Корпораци нь алдагдлын ноцтой байдлыг, өөрөөр хэлбэл үл биелүүлэлтийн алдагдал (ҮБА)-ыг тооцоолохын тулд ЗҮЦ-ийн хэмжүүрийг ашигласнаар гарзын хасагдуулгыг хэмждэг. Бусад бүх нөхцөл өөрчлөгдөөгүй боловч ЗҮЦ-ийн хэмжүүр өндөр байх тусам хүлээгдэж буй зээлийн алдагдал өндөр байдаг.

ҮЖ36. Хэрэв АБВ Орон Сууцны Корпораци нь үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнийн хүлээгдэж буй бууралтыг тусгахын тулд төлөв байдлын оноог шинэчлэн баяжуулах боломжгүй бол анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл нь мэдэгдэхүйц нэмэгдсэн зээлүүдийг тодорхойлж, тэдгээр зээлийн нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөхийн тулд нэгдсэн үнэлгээ хийх үүднээс их зардал буюу хүчин чармайлт гаргахгүйгээр олж авах боломжтой, ул үндэслэлтэй ба дэмжих мэдээллийг ашиглана.

Нэгдсэн үнэлгээ

ҮЖ37. Хоёр ба гуравдугаар нутаг дэвсгэрийн хувьд АБВ Орон Сууцны Корпораци нь автоматжуулсан оноо тогтоох хэрэгсэл байхгүй. Харин зээлийн эрсдлийн удирдлагын зорилгоор АБВ Орон Сууцны Корпораци нь хугацаа өнгөрсөн төлөв байдлуудыг харгалзан үзсэнээр, уг гарч тохиолдох үл биелүүлэлтийн эрсдлийг мөшгин шалгадаг. Корпораци нь 30 хоногоос илүүгээр хугацаа өнгөрсөн төлөв байдал бүхий бүх зээлийн хувьд нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр гарзын хасагдуулгыг хүлээн зөвшөөрдөг. Хэдийгээр АБВ Орон Сууцны Корпораци нь хугацаа өнгөрсөн төлөв байдлын мэдээллийг зөвхөн зээлдэгчийн тусгай мэдээлэл байдлаар ашигладаг боловч 30-аас бага хоногоор хугацаа өнгөрсөн зээлүүдийн хувьд нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй эсэхийг үнэлэхийн тулд их зардал буюу хүчин чармайлт гаргахгүйгээр олж авах боломжтой, ул үндэслэлтэй ба дэмжих бусад хэтийн мэдээллийг бас ашигладаг. Энэ нь зээлийн эрсдлийн бүх мэдэгдэхүйц нэмэгдэлтийн хувьд нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх УСНББОУС 41-ийн 76-р параграфын зорилгыг ханган биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай юм.

Хоёрдугаар нутаг дэвсгэр

ҮЖ38. Хоёрдугаар нутаг дэвсгэрт уул уурхайн нийгэмлэг хамаардаг бөгөөд энэ нь нүүрсний болон холбогдох бүтээгдэхүүний экспортоос ихээхэн хамааралтай байдаг. АБВ Орон Сууцны Корпораци нь нүүрсний экспорт мэдэгдэхүйц буурсныг мэдэж байсан, түүнчлэн нүүрсний хэд хэдэн уурхай хаагдана гэж урьдчилан таамаглаж байв. Хэдийгээр нүүрсний уурхайд ажилладаг хүмүүсийн зээл нь тухайн тайлангийн өдрөөр хугацаа өнгөрөөгүй байгаа боловч ажилгүйдлийн түвшний хүлээгдэж буй нэмэгдэлтийн улмаас тэдгээр зээлдэгчдэд олгосон моргейжийн зээлийн хувьд үл биелүүлэлт гарах эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдэнэ гэж тодорхойлсон. Иймээс АБВ Орон Сууцны Корпораци нь ажил эрхлэлтийн голлох эх үүсвэр болгон нүүрсний уурхайд найдлага тавьдаг зээлдэгчдийг тогтоохын тулд зээлдэгчдийн ажилладаг салбараар (моргейжийн зээлийн өргөдлийн процессын нэг хэсэг байдлаар бүртгэсэн мэдээллийг ашиглан) өөрийн моргейжийн зээлийн багцыг (өөрөөр хэлбэл, эрсдлийн нийтлэг шинж чанарт үндэслэн зээлийг тодорхойлох ‘доороос дээш’ арга хандлагаар) ангилан сегментчилсэн. Эдгээр моргейжийн зээлийн хувьд АБВ Орон Сууцны Корпораци нь нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр гарзын хасагдуулгыг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээгээр хоёрдугаар нутаг дэвсгэрийн бусад бүх моргейжийн зээлийн хувьд 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр гарзын хасагдуулгыг хүлээн зөвшөөрсөн хэвээр байна.¹⁰ Харин тус нийгэмлэгийн нүүрсний уурхайнуудаас эдийн засгийн хувьд хамааралтай зээлдэгчдэд шинээр олгох моргейжийн зээлийн хувьд анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдээгүй учраас 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр гарзын хасагдуулгыг тооцоолно. Гэвч нүүрсний уурхайн хүлээгдэж буй хаагдалтын улмаас моргейжийн зарим шинэ зээлийн эрсдэл нь анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа, тун удалгүй мэдэгдэхүйц нэмэгдсэн байж болох юм.

Гуравдугаар нутаг дэвсгэр

ҮЖ39. Гуравдугаар нутаг дэвсгэрийн хувьд, тухайн моргейжийн зээлийн хүлээгдэж буй хугацаан дахь хүүний түвшний хүлээгдэж буй нэмэгдэлтийн үр дүнд үл биелүүлэлтийн эрсдэл үүснэ, ингэснээр зээлийн эрсдэл нэмэгдэнэ гэж АБВ Орон Сууцны Корпораци урьдчилан таамагласан. Түүхийн үүднээс авч үзвэл, хүүний түвшний нэмэгдэлт нь Гуравдугаар нутаг дэвсгэрт, ялангуяа зээлдэгч нарын авсан зээл нь тогтмол хүүтэй биш тохиолдолд ирээдүйн үл биелүүлэлтийн гол тодорхойлогч үзүүлэлт байсан. Гуравдугаар нутаг дэвсгэр дэх хувьсах хүүтэй моргейжийн зээлийн багц нь ижил төсөөтэй бөгөөд зээлийн эрсдэл нь мэдэгдэхүйц нэмэгдэхээр хүлээгдэж буй зээлдэгчдийг төлөөлөн илэрхийлэх тэдний эрсдлийн нийтлэг шинж чанарт үндэслэн дэд багцуудыг тогтоох боломжгүй байдгаараа Хоёрдугаар нутаг дэвсгэрийн зээлүүдээс ялгаатай гэж АБВ Орон Сууцны Корпораци тодорхойлсон. Гэвч Гуравдугаар нутаг дэвсгэр дэх моргейжийн зээлүүдийн ижил төсөөтэй шинж төрлийн үр дүнд АБВ Орон Сууцны Корпораци нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл нь мэдэгдэхүйц нэмэгдсэн уг ерөнхий багцын хувийн жин байдлаар (өөрөөр хэлбэл, ‘дээрээс доош’ арга хандлагыг ашиглан) үнэлгээг хийж болно гэж дүгнэсэн. Хүүний түвшний 200 суурь онооны

¹⁰ Тус тусын үнэлгээнд үндэслэн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн гэж тодорхойлсон, тухайлбал; 30 хоногоос илүүгээр хугацаа өнгөрсөн моргейжийн зээлээс бусад, зээлд хамаарна. Эдгээр зээлийн хувьд мөн нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрнө.

нэмэгдэлт нь уг хувьсах хүүтэй зээлийн багцын 20 хувийн хувьд зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдэхэд хүргэнэ гэж АБВ Орон Сууцны Корпораци нь түүхэн мэдээлэлд үндэслэн тооцоолсон. Иймээс энэхүү хүүний түвшний урьдчилан таамагласан өсөлтийн үр дүнд Гуравдугаар нутаг дэвсгэр дэх моргейжийн зээлийн 20 хувьд хамаарах зээлийн эрсдэл нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш мэдэгдэхүйц нэмэгдсэн гэдгийг АБВ Орон Сууцны Корпораци тодорхойлсон. Ингэснээр АБВ Орон Сууцны Корпораци нь хувьсах хүүтэй моргейжийн зээлийн багцын 20 хувийн хувьд нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг, харин тухайн багцын үлдсэн хэсгийн хувьд 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр гарзын хасагдуулгыг хүлээн зөвшөөрсөн.¹¹

Жишээ 6—Зээлийн анхны хамгийн их эрсдэлтэй харьцуулалт

- ҮЖ40. Эдийн Засгийн Хөгжлийн Агентлаг нь Ш нутаг дэвсгэрийн жижиг бизнес эрхлэгчдэд ижил төсөөтэй нөхцөл ба болзолтойгоор олгосон зээлүүдийн хоёр багцтай. Зээл бүрийг санхүүжүүлэх шийдвэрийн хувьд Эдийн Засгийн Хөгжлийн Агентлагийн баримталдаг бодлого нь зээлийн дотоод зэрэглэлийн системд үндэслэдэг. Уг систем нь зээлдэгчийн зээлийн түүх, төлбөрийн төлөв байдал болон бусад хүчин зүйлсийг харгалзан тусгадаг бөгөөд тухайн олгох зээл бүрийн хувьд зээлийн эрсдлийн 1-ээс (зээлийн хамгийн бага эрсдэлтэй) 10 хүртэлх (зээлийн хамгийн өндөр эрсдэлтэй) дотоод зэрэглэлийг тогтоодог. Зээлийн эрсдлийн зэрэглэл буурахын хэрээр үл биелүүлэлтийн эрсдэл илүү хурдацтай нэмэгддэг. Иймээс тухайлбал; зээлийн эрсдлийн 1 ба 2-р зэрэглэлийн үнэ цэнүүдийн хоорондох зөрүү нь зээлийн эрсдлийн 2 ба 3-р зэрэглэлийн үнэ цэнүүдийн хоорондох зөрүүгээс бага байна. Багц 1-ийн зээлүүд нь зээлийн эрсдлийн ижил төсөөтэй дотоод зэрэглэлтэй, зөвхөн дахин үйлчлүүлж буй зээлдэгч нарт олгодог зээл бөгөөд бүх зээлийг анх хүлээн зөвшөөрөх үед уг дотоод зэрэглэлийн дагуу 3 эсвэл 4-р зэрэглэлийн зээл гэж үнэлдэг. Анх хүлээн зөвшөөрөх үед Багц 1-ийн хувьд зөвшөөрч болох зээлийн анхны хамгийн их эрсдэл нь дотоод зэрэглэлийн 4-р шатлал байна гэж Эдийн Засгийн Хөгжлийн Агентлаг тогтоосон. Жижиг бизнесийн зээл олгоно гэсэн зар сурталчилгааны дагуу ирсэн зээлдэгч нарт Багц 2-ын зээлүүдийг санал болгодог бөгөөд эдгээр зээлдэгчдийн зээлийн эрсдлийн дотоод зэрэглэл нь уг дотоод зэрэглэлийн шатлалын дагуу 4-7-р зэрэглэлд хамаардаг. Эдийн Засгийн Хөгжлийн Агентлаг нь зээлийн эрсдлийн 7-гоос муу дотоод зэрэглэлтэй (өөрөөр хэлбэл, 8-10 гэсэн дотоод зэрэглэлтэй) жижиг бизнесийн зээлийг хэзээ ч олгож байгаагүй.
- ҮЖ41. Зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг үнэлэх зорилгоор Эдийн Засгийн Хөгжлийн Агентлаг нь Багц 1-ийн бүх зээлүүд анх хүлээн зөвшөөрөх үед ижил төсөөтэй зээлийн эрсдэлтэй байсан гэж үздэг. Эрсдлийн дотоод зэрэглэлийн үнэ цэнэд тусгагдсан үл биелүүлэлтийн эрсдлийг харгалзан үзсэнээр, дотоод зэрэглэл 3-аас 4 болох өөрчлөлт нь зээлийн эрсдлийн мэдэгдэхүйц нэмэгдэлтийг илэрхийлэхгүй, харин энэ багцын аливаа зээлийн дотоод зэрэглэл 5-аас муу байх нь зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн гэдгийг илтгэнэ гэж тодорхойлсон. Өөрөөр хэлбэл, Санхүүгийн Хэлтэс нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдлийн өөрчлөлтийг үнэлж, тогтоохын тулд уг багц дахь зээл нэг бүрийн анхны зэрэглэлийг мэдэх албагүй гэсэн үг юм. Нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг УСНББОУС 41-ийн 75-р параграфын дагуу хүлээн зөвшөөрөх хэрэгтэй эсэхийг тодорхойлохын тулд зээлийн эрсдэл нь тухайн тайлангийн өдөр 5-аас муу зэрэглэлтэй байгаа эсэхийг зөвхөн тодорхойлох шаардлагатай юм.
- ҮЖ42. Гэвч Багц 2-ын хувьд анхны хүлээн зөвшөөрөлтийн үед зөвшөөрч болох зээлийн анхны хамгийн их эрсдлийг тэрхүү зээлийн эрсдлийн 7-р дотоод зэрэглэлээр тодорхойлсноор УСНББОУС 41-ийн 76-р параграфт заасан, шаардлагуудын зорилгыг бүрэн ханган биелүүлэхгүй юм. Яагаад гэвэл, зээлийн эрсдлийн мэдэгдэхүйц нэмэгдэлт нь шинэ санхүүгийн хөрөнгийг тухайн байгууллага үүсгэн гаргах үеийн эрсдлийн түвшнээс уг зээлийн эрсдэл илүү гарч нэмэгдсэнээр (өөрөөр хэлбэл, дотоод зэрэглэл нь 7-гоос муу болох тохиолдолд) зөвхөн үүсдэггүй гэдгийг Эдийн Засгийн Хөгжлийн Агентлаг тодорхойлсон. Эдийн Засгийн Хөгжлийн Агентлаг нь зээлийн эрсдлийн 7-гоос муу дотоод зэрэглэлтэй жижиг бизнесийн зээлийг хэзээ ч олгож байгаагүй боловч Багц 2 дахь зээлүүдийн дотоод зээлийн эрсдэл нь анхны хүлээн зөвшөөрөлтийн үед Багц 1-д ашигласан арга хандлагыг хэрэглэж болохуйц хангалттай ижил төсөөтэй биш юм. Өөрөөр хэлбэл, энэхүү багц дахь зээлүүдийн хувьд зээлийн анхны чанар нь маш олон янз байдаг учраас зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг

¹¹ Тус тусын үнэлгээнд үндэслэн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн гэж тодорхойлсон, тухайлбал; 30 хоногоос илүүгээр хугацаа өнгөрсөн моргейжийн зээлээс бусад, зээлд хамаарна. Эдгээр зээлийн хувьд мөн нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрнө.

тодорхойлохын тулд Эдийн Засгийн Хөгжлийн Агентлаг нь тухайн тайлангийн өдрөөрх зээлийн эрсдлийг анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн зээлийн хамгийн бага чанартай шууд зэрэгцүүлж (жишээлбэл; Багц 2 дахь зээлүүдийн хувьд тэдний зээлийн эрсдлийн дотоод зэрэглэлийг уг зээлийн эрсдлийн 7-р дотоод зэрэглэлтэй зэрэгцүүлж) болохгүй гэсэн үг юм. Тухайлбал; анх зээлийн эрсдлийн 4-р зэрэглэлтэй байсан зээлийн эрсдэл нь 6-р зэрэглэл болж өөрчлөгдсөн бол уг зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн байж болох юм.

Жишээ 7—Зээлийн эрсдлийн талаархи оролцогч нөгөө талын үнэлгээ

Хувилбар 1

ҮЖ43. 20X0 онд А улсын Дэд Бүтцийн Банк нь Т компанид 15 жилийн гэрээний хугацаатайгаар 10,000 ТН-ийн зээл олгосон. Энэ үед тус компани нь зээлийн эрсдлийн 1-ээс (зээлийн хамгийн бага эрсдэлтэй) 10 хүртэлх (зээлийн хамгийн өндөр эрсдэлтэй) шатлалын 4-р зэрэглэлийн дотоод зээлийн эрсдэлтэй байсан. Зээлийн эрсдлийн зэрэглэл буурахын хэрээр үл биелүүлэлтийн эрсдэл илүү хурдацтай нэмэгддэг. Иймээс тухайлбал; зээлийн эрсдлийн 1 ба 2-р зэрэглэлийн үнэ цэнүүдийн хоорондох зөрүү нь зээлийн эрсдлийн 2 ба 3-р зэрэглэлийн үнэ цэнүүдийн хоорондох зөрүүгээс бага байна. 20X5 онд Т компани нь зээлийн эрсдлийн 6-р дотоод зэрэглэлтэй байх үед Дэд Бүтцийн Банк нь Т компанид 10 жилийн гэрээний хугацаатайгаар 5,000 ТН-ийн өөр нэг зээлийг олгосон. 20X7 онд Т компани нь өөрийн гол үйлчлүүлэгчтэй гэрээгээ үргэлжлүүлэн байгуулах боломжгүй болж, ингэснээр түүний орлого ихээхэн буурсан. Уг гэрээг алдсанаар зээлийн үүргээ биелүүлэх Т компанийн чадвар эрс буурах ба түүний зээлийн эрсдлийн зэрэглэл нь 8 болж өөрчлөгдөнө гэж Дэд Бүтцийн Банк үзэж байна.

ҮЖ44. Дэд Бүтцийн Банк нь зээлийн эрсдлийн удирдлагын зорилгоор уг оролцогч нөгөө талын түвшинд зээлийн эрсдлийг үнэлдэг бөгөөд Т компанийн зээлийн эрсдлийн нэмэгдэлт мэдэгдэхүйц дүнтэй гэж тодорхойлсон. Хэдийгээр Дэд Бүтцийн Банк нь зээл тус бүрийн хувьд түүний анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойшхи зээлийн эрсдлийн өөрчлөлтүүдийг нэг бүрчлэн үнэлээгүй боловч оролцогч нөгөө талын түвшинд зээлийн эрсдлийг үнэлж, Т компанид олгосон бүх зээлийн хувьд нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх нь УСНББОУС 41-ийн 76-р параграфт заасан, үнэ цэнийн бууралтын шаардлагуудын зорилгыг биелүүлэх юм. Яагаад гэвэл, зээлийг олгох үед Т компани хамгийн өндөр зээлийн эрсдэлтэй байсан уг хамгийн сүүлийн зээлийг олгосон (20X7 он) хугацаанаас хойш ч гэсэн түүний зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн. Иймээс оролцогч нөгөө талын эрсдлийн үнэлгээ нь зээл нэг бүрийн хувьд зээлийн эрсдлийн өөрчлөлтийг үнэлсэнтэй ижил үр дүнд хүргэх юм.

Хувилбар 2

ҮЖ45. 20X0 онд А улсын Дэд Бүтцийн Банк нь Э компанид 20 жилийн гэрээний хугацаатайгаар 150,000 ТН-ийн зээл олгосон. Энэ үед тус компани нь зээлийн эрсдлийн 4-р зэрэглэлтэй байсан. 20X5 онд эдийн засгийн нөхцөл байдал доройтож, Э компанийн бүтээгдэхүүний эрэлт мэдэгдэхүйц буурсан. Борлуулалт багассанаас шалтгаалсан мөнгөн гүйлгээний бууралтын үр дүнд Э компани нь өөрийн зээлийн хэсэгчилсэн төлбөрийг Дэд Бүтцийн Банкинд бүрэн хэмжээгээр барагдуулж чадахааргүй болсон. Дэд Бүтцийн Банк нь Э компанийн зээлийн эрсдлийн дотоод зэрэглэлийг дахин хянан үнэлж, тухайн тайлангийн өдрөөр түүнийг 7 байна гэж тодорхойлсон. Дэд Бүтцийн Банк нь уг зээлийн хувьд зээлийн эрсдлийн өөрчлөлтийг харгалзан үзсэн, үүн дотроо зээлийн эрсдлийн дотоод зэрэглэлийн өөрчлөлтийг хянасан ба зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн гэдгийг тодорхойлж, тэрхүү 150,000 ТН-ийн зээлийн нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрсөн.

ҮЖ46. Зээлийн эрсдлийн дотоод зэрэглэлийн сүүлийн үеийн бууралтаас үл хамааран Дэд Бүтцийн Банк нь Э компанид 50,000 ТН-ийн өөр нэг зээлийг 20X6 онд олгосон бөгөөд тухайн өдрөөрх зээлийн өндөр эрсдлийг харгалзан гэрээний хугацааг 5 жилээр тогтоосон.

ҮЖ47. Э компанийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн гэж өмнө нь үнэлж байсан (оролцогч нөгөө талд үндэслэн үнэлсэн) нь уг шинэ зээлийн хувьд нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдал хүлээн зөвшөөрөхөд хүргэхгүй юм. Яагаад гэвэл, уг шинэ зээлийн хувьд зээлийн эрсдэл нь түүнийг анх хүлээн зөвшөөрснөөс хойш мэдэгдэхүйц нэмэгдээгүй. Зээлийн эрсдлийн өөрчлөлтүүдийн талаархи дүгнэлт

нь тухайн нэг зээлдэгчид олгосон, бие даасан бүх санхүүгийн хэрэглүүрт хамаарах эсэхийг харгалзан үзэхгүйгээр Дэд Бүтцийн Банк нь зөвхөн оролцогч нөгөө талын түвшинд зээлийн эрсдлийг үнэлсэн бол УСНББОУС 41-ийн 76-р параграфын зорилт хангагдан биелэгдэхгүй.

Хүлээгдэж буй зээлийн алдагдлын хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

ҮЖ48. УСНББОУС 41-ийн 73-93-р параграфт заасан, хүлээн зөвшөөрөлтийн болон хэмжилтийн шаардлагуудын мөрдөлт, түүнчлэн хейжийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудтай холбогдох уялдааг дараах жишээнд үлгэрчлэн харуулав.

Жишээ 8—“Үл биелүүлэлтийн тодорхой магадлал”-ын хандлагыг ашигласан, 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилт

Хувилбар 1

ҮЖ49. А засгийн газар нь 1 сая ТН-ийн дүнтэй, 10 жилд хорогдуулан төлөх нэг зээлийг олгосон. Ижил төсөөтэй зээлийн эрсдэл бүхий хэрэглүүрүүдийн талаархи хүлээлт (их зардал буюу хүчин чармайлт гаргахгүйгээр олж авах боломжтой, ул үндэслэлтэй ба дэмжих мэдээллийг ашиглах), тухайн зээлдэгчийн зээлийн эрсдэл, дараагийн 12 сар хугацаан дахь эдийн засгийн хэтийн төлвийг харгалзсанаар А засгийн газар нь анх хүлээн зөвшөөрөх үед уг зээл дараагийн 12 сарын хугацаанд төлбөрийн үл биелүүлэлтийн 0.5 хувийн магадлалтай (ҮБМ) байна гэж тооцоолсон. Мөн анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг тодорхойлох зорилгын хувьд, 12 сарын хугацаан дахь ҮБМ-ын өөрчлөлт нь нийт хугацаан дахь ҮБМ-ын өөрчлөлттэй ул үндэслэлтэйгээр ойролцоо байна гэж А засгийн газар үзсэн.

ҮЖ50. Тухайн тайлангийн өдрийн байдаар (зээлийг төлөх хугацаа болохын өмнө¹²) уг 12 сарын хугацааны ҮБМ-д өөрчлөлт ороогүй бөгөөд А засгийн газар нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдээгүй гэж тодорхойлсон. Хэрэв төлбөр үл биелэгдвэл уг зээлийн нийт дансны үнийн 25 хувийг алдана (өөрөөр хэлбэл, ҮБА нь 25 хувь) гэж А засгийн газар тооцоолсон.¹³ А засгийн газар нь 12 сарын хугацааны 0.5 хувийн ҮБМ-ыг ашигласнаар 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр гарзын хасагдуулгыг хэмждэг. Үл биелүүлэлт үүсэхгүй байх магадлал 99.5 хувь гэдэг нь уг тооцооллоос илэрхий харагдаж байна. 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлын хувьд гарзын хасагдуулга нь тухайн тайлангийн өдөр 1,250 ТН (0.5 хувь х 25 хувь х 1,000,000ТН) байна.

Хувилбар 2

ҮЖ51. Б засгийн газар нь нэгжийн 1,000 ТН-ийн дүнтэй, 5 жилийн хугацаатай 1,000 ширхэг бүхий багц (өөрөөр хэлбэл, нийт 1 сая ТН), найрсаг зээлийг олгосон ба уг багцын 12 сарын дундаж ҮБМ нь 0.5 хувь байсан. Тус зээлийн ихэнх төлбөрийн үүрэг нь дараагийн 12 сараас илүү урт хугацаанд хамаарах учраас анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг тодорхойлох үедээ зөвхөн 12 сарын ҮБМ-ын өөрчлөлтийг харгалзах нь тохиромжгүй гэж Б засгийн газар үзсэн. Иймээс анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш уг багцын зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг тодорхойлохдоо Б засгийн газар нь нийт хугацаанд хүлээгдэж буй ҮБМ-ын өөрчлөлтийг тухайн тайлангийн өдөр ашигласан.

ҮЖ52. Б засгийн газар нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдээгүй гэж тодорхойлсон бөгөөд багцын ҮБА дундажаар 25 хувь гэж тооцоолсон. Б засгийн газар нь гарзын хасагдуулгыг УСНББОУС 41-ийн дагуу нэгдсэн сууриар хэмжих нь тохиромжтой гэж үзсэн. 12 сарын ҮБМ нь тухайн тайлангийн өдөр 0.5 хувь хэвээрээ байсан. Иймээс Б засгийн газар нь 12 сарын дундаж ҮБМ 0.5 хувьд үндэслэн 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр гарзын хасагдуулгыг нэгдсэн сууриар хэмжсэн. Үл биелүүлэлт үүсэхгүй байх магадлал 99.5 хувь гэдэг нь уг тооцооллоос илэрхий харагдаж байна. 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлын

¹² Жишээг хялбарчлахын тулд зээлийг төлж хорогдуулаагүй байсан гэж үзсэн.

¹³ ҮБА нь нийт дансны үнийн өнөөгийн үнэ цэнийн хувийн жинг илэрхийлдэг учраас энэ жишээнд мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг үлгэрчлэн харуулаагүй.

хувьд гарзын хасагдуулга нь тухайн тайлангийн өдөр 1,250 ТН (0.5 хувь х 25 хувь х 1,000,000ТН) байна.

Жишээ 9—Алдагдлын хувийн жингийн хандлагад үндэслэсэн, 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилт

- ҮЖ53. А засгийн газар нь нийт 500,000 ТН-ийн дансны үнэтэй, 2,000 ширхэг найрсаг зээл олгосон. Анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн зээлийн эрсдлийн нийтлэг шинж чанарт үндэслэн А засгийн газар нь өөрийн багцыг зээлдэгчийн бүлгүүдэд (Х ба У бүлэг) сегментчлэн хуваасан. Х бүлэг нь нэг зээлдэгчийн 200 ТН-ийн дансны үнэтэй буюу нийт 200,000 ТН-ийн дансны үнэ бүхий 1,000 ширхэг зээлээс бүрддэг. У бүлэг нь нэг зээлдэгчийн 300 ТН-ийн дансны үнэтэй буюу нийт 300,000 ТН-ийн дансны үнэ бүхий 1,000 ширхэг зээлээс бүрддэг. Ажил гүйлгээний зардал гараагүй бөгөөд тэдгээр зээлийн гэрээнүүд нь опцион (жишэлбэл; урьдчилсан төлөлт буюу дуудах опцион), урамшуулал эсвэл хөнгөлөлт, төлсөн оноо болон бусад хураамж шимтгэлийг тусган агуулдаггүй.
- ҮЖ54. Х ба У бүлгийн алдагдлын хувийн жингийн хандлагад үндэслэн А засгийн газар нь хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмждэг. Алдагдлын хувийн жинг тооцоолохын тулд А засгийн газар нь өөрийн түүхэн үл биелүүлэлтийн түүвэр болон зээлийн төрлүүдээрх алдагдлын тохиолдлыг харгалзан үздэг. Түүнчлэн, А засгийн газар нь хэгийн мэдээллийг харгалзан үзэж, эдийн засгийн одоогийн нөхцөл байдал, түүнчлэн эдийн засгийн ирээдүйн нөхцөл байдлын ул үндэслэлтэй ба дэмжих урьдчилсан таамаглалд үндэслэн өөрийн түүхэн мэдээллийг шинэчлэн баяжуулдаг. Бүлэг бүр 1,000 ширхэг зээлтэй олонлогийн түүхийг авч үзвэл, Х бүлгийн алдагдлын хувийн жин нь дөрвөн үл биелүүлэлт буюу 0.3 хувь, У бүлгийн түүхэн алдагдлын хувийн жин нь хоёр үл биелүүлэлт буюу 0.15 хувь байна.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

	Түүвэр дэх үйлчлүүлэгчдийн тоо	Нэгж үйлчлүүлэгч дэх үл биелүүлэлтийн тооцоолсон дансны үнэ	Жилийн үл биелүүлэлтийн тооцоолсон нийт дансны үнэ	Жил тутмын түүхэн дундаж үл биелүүлэлт	Нийт үл биелүүлэлтийн тооцоолсон нийт дансны үнэ	Ажигласан алдагдлын өнөөгийн үнэ цэнэ ^(a)	Алдагдлын хувийн жин
Бүлэг	А	Б	$B = A \times \Gamma$	Г	$D = B \times \Gamma$	Е	$Ж = E \times B$
Х	1,000	200ТН	200,000ТН	4	800ТН	600ТН	0.3 хувь
У	1,000	300ТН	300,000ТН	2	600ТН	450ТН	0.15 хувь
^(a) 90(б) параграфт заасанчлан, үр ашигт хүүний хувийг ашигласнаар хүлээгдэж буй зээлийн алдагдлыг дискаунтчилдаг. Гэвч энэ жишээнд хялбарчлах зорилгоор уг ажигласан алдагдлын өнөөгийн үнэ цэнэ гэж төсөөллөө.							

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

- ҮЖ55. Түүхэн хувь хэмжээтэй харьцуулахад дараагийн 12 сарын хугацаанд үл биелүүлэлт нэмэгдэнэ гэж А засгийн газар нь тухайн тайлангийн өдрөөр тооцон хүлээж байна. Үүний улмаас дараагийн 12 сарын хугацаанд Х бүлгийн зээлүүдэд таван үл биелүүлэлт, У бүлгийн зээлүүдэд гурван үл биелүүлэлт үүснэ гэж А засгийн газар тооцоолсон. Нэгж үйлчлүүлэгч дэх ажигласан зээлийн алдагдлын өнөөгийн үнэ цэнэ нь нэгж үйлчлүүлэгч дэх түүхэн алдагдалтай нийцсэн дүнтэй хэвээр байна гэж тооцоолсон.
- ҮЖ56. Үл биелүүлэлтийн хүлээгдэж буй нэмэгдэлт нь тухайн багцуудын хувьд анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойшхи зээлийн эрсдлийн мэдэгдэхүйц нэмэгдэлтийг илэрхийлэхгүй гэж А засгийн газар нь тэдгээр зээлүүдийн хүлээгдэж буй нийт хугацаанд үндэслэн тодорхойлсон. Өөрийн урьдчилсан таамаглалд үндэслэн А засгийн газар нь бүлэг тус бүрийн 1,000 зээлийн хувьд 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр буюу харгалзан 750ТН ба 675ТН-ээр гарзын хасагдуулгыг хэмжсэн. Ингэснээр эхний жилийн алдагдлын хувь хэмжээ нь Х бүлэгт 0.375 хувь, У бүлэгт 0.225 хувь байна.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

	Түүвэр дэх үйлчлүүлэгчдийн тоо	Нэгж үйлчлүүлэгч дэх үл биелүүлэлтийн тооцоолсон дансны үнэ	Жилийн үл биелүүлэлтийн тооцоолсон нийт дансны үнэ	Жил тутмын түүхэн дундаж үл биелүүлэлт	Нийт үл биелүүлэлтийн тооцоолсон нийт дансны үнэ	Ажигласан алдагдлын өнөөгийн үнэ цэнэ	Алдагдлын хувийн жин
Бүлэг	А	Б	$B = A \times B$	Г	$D = B \times \Gamma$	Е	$Ж = E \times B$
Х	1,000	200ТН	200,000ТН	5	1,000ТН	750ТН	0.375 хувь
У	1,000	300ТН	300,000ТН	3	900ТН	675ТН	0.225 хувь

ҮЖ57. Тухайн жилд үүсгэсэн ба анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл нь мэдэгдэхүйц нэмэгдээгүй шинэ зээлүүдийн хувьд 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолохын тулд А засгийн газар нь Х бүлэгт 0.375 хувийн, У бүлэгт 0.225 хувийн алдагдлын хувь хэмжээг ашигладаг.

Жишээ 10—Эргэлтийн зээлийн хэрэгслүүд

ҮЖ58. А улсын Хөгжлийн Агентлаг нь олон нийтийн дэд бүтцийг барьж нийлүүлэх барилгын жижиг компанид эргэлтийн уян зээл олгосон. Тус эргэлтийн уян зээл нь уг барилгын жижиг компанийн мөнгөн орлого хязгаарлагдмал үед түүнд төлбөрийн чадвар бүрдүүлж өгдөг. Эргэлтийн уян зээл нь мэдэгдлийн нэг өдрийн хугацаатай, өөрөөр хэлбэл Хөгжлийн Агентлаг нь мэдэгдэж, уг хугацаа өнгөрсний дараа зээлээ (олгосон ба олгоогүй байгаа бүрэлдэхүүн хэсгүүдийн аль алиныг) цуцлах гэрээний эрхтэй юм. Гэвч Хөгжлийн Агентлаг нь тус хэрэглүүрийн өдөр тутмын хэвийн менежментийн явцад уг эргэлтийн уян зээлийг цуцлах өөрийн гэрээний эрхийг хэрэгжүүлдэггүй, харин зээлийн эрсдэл нэмэгдсэн гэдгийг мэдэж, зээлдэгч нэг бүрээр хяналт үнэлгээг хийж эхэлсэн зөвхөн тийм тохиолдолд хэрэглүүрийг цуцалдаг. Иймээс Хөгжлийн Агентлаг нь тухайн гэрээний мэдэгдлийн хугацаагаар өөрийн зээлийн алдагдлын эрсдлийг хязгаарлахын тулд уг эргэлтийн уян зээлийг цуцлах гэрээний эрхийг харгалзан үздэггүй.

ҮЖ59. Зээлийн эрсдлийн менежментийн зорилгоор Хөгжлийн Агентлаг нь зээлдэгчдээс бий болох гэрээний зөвхөн нэг цогц мөнгөн гүйлгээ байдаг гэж үздэг бөгөөд тухайн тайлангийн өдрөөр олгосон ба олгоогүй байгаа бүрэлдэхүүн хэсгүүдийн үлдэгдлүүдийг ялган тодорхойлдоггүй. Иймээс тус багцыг хэрэглүүрийн түвшинд удирдан зохицуулж, хүлээгдэж буй зээлийн алдагдлыг мөн хэрэглүүрийн түвшинд хэмждэг.

ҮЖ60. Тухайн тайлангийн өдрөөр эргэлтийн уян зээлийн багцын эргэлтэнд гаргасан үлдэгдэл нь 60,000 ТН, олгоогүй боломжит хэрэгслийн дүн 40,000 ТН байсан. Хөгжлийн Агентлаг нь дараах зүйлсийг харгалзан үзэж, тухайн тайлангийн өдрөөрх уг хэрэглүүрийн зээлийн эрсдэлд өртөхөөр хүлээгдэж буй хугацааг тооцоолсноор тус багцын нийт хүлээгдэж буй хугацааг тодорхойлдог:

- (а) Барилгын ажлын эргэлтийн уян зээлүүдийн ижил төсөөтэй багцад зээлийн эрсдэл учрахаар хүлээгдэж буй хугацаа;
- (б) Ижил төсөөтэй санхүүгийн хэрэглүүрүүдэд холбогдох үл биелүүлэлт үүсэх хүртэлх хугацааны урт; ба
- (в) Ижил төсөөтэй санхүүгийн хэрэглүүрүүдийн зээлийн эрсдэл нэмэгдсэний улмаас олгоогүй зээлийн хэмжээг бууруулах буюу хүчингүй болгох гэх мэт зээлийн эрсдлийн менежментийн арга хэмжээ авахад хүргэсэн өмнөх үйл явдлууд.

ҮЖ61. ҮЖ60-д жагсаан харуулсан мэдээлэлд үндэслэн Хөгжлийн Агентлаг нь уг эргэлтийн уян зээлийн багцын хүлээгдэж буй хугацааг 30 сар гэж тодорхойлсон.

ҮЖ62. Хөгжлийн Агентлаг нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойшхи уг багцын зээлийн эрсдлийн өөрчлөлтийг тухайн тайлангийн өдрөөр үнэлсэн бөгөөд багцын 25 хувийг илэрхийлэх тэрхүү зээлийн хэрэгслийн хэсгийн хувьд зээлийн эрсдэл нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш мэдэгдэхүйц нэмэгдсэн гэж УСНББОУС 41-ийн 75-р параграфын дагуу тодорхойлсон. Нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг нь хүлээн зөвшөөрөх хэрэгтэй тэдгээр зээлийн хэрэгслийн төлөгдөөгүй үлдэгдэл нь 20,000 ТН, олгоогүй боломжит хэрэгслийн дүн 10,000 ТН байсан.

ҮЖ63. Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг УСНББОУС 41-ийн 93-р параграфын дагуу хэмжих үедээ Хөгжлийн Агентлаг нь МЗУ195-р параграфт заасанчлан, уг багцын хүлээгдэж буй хугацааны (өөрөөр хэлбэл, 30-н сарын) турш дахь ирээдүйн оргил цэгээс бууралтын хувьд өөрийн хүлээлтийг харгалзан үзэх ба хэрэв зээлдэгч нар төлбөрийн үүргээ үл биелүүлвэл тухайн багцын төлөгдөөгүй үлдэгдэл (өөрөөр хэлбэл, үл биелүүлэлтийн эрсдэл) хэд болохыг тооцоолно. Нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг нь хүлээн зөвшөөрөх уг эргэлтийн уян зээлийн хэрэгслүүдийн үл биелүүлэлтийн эрсдэл өртөлт 25,000 ТН (өөрөөр хэлбэл, олгосон үлдэгдэл 20,000ТН ба ашиглаагүй байгаа боломжит зээл олгох баталгаанаас үүсэх ирээдүйн оргил цэгээс бууралтын 5,000ТН хоёрын нийлбэр) байна гэж

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Хөгжлийн Агентлаг нь өөрийн зээлийн эрсдлийн загварыг ашиглан тодорхойлсон. 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг нь хүлээн зөвшөөрөх уг зээлийн хэрэгслүүдийн үл биелүүлэлтийн эрсдэл өртөлт 45,000 ТН (өөрөөр хэлбэл, олгосон үлдэгдэл 40,000ТН ба ашиглаагүй байгаа зээл олгох баталгаанаас дараагийн 12 сарын хугацаанд үүсэх ирээдүйн оргил цэгээс бууралтын 5,000ТН хоёрын нийлбэр) байна.

ҮЖ64. Хөгжлийн Агентлагийн тодорхойлсон үл биелүүлэлтийн эрсдэл өртөлт ба хүлээгдэж буй хугацааг түүний зээлийн багцын нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдал болон 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжихэд ашигладаг.

ҮЖ65. Хөгжлийн Агентлаг нь хүлээгдэж буй зээлийн алдагдлыг уг хэрэгслийн түвшинд хэмждэг, иймээс зээл олгох баталгааны ашиглаагүй бүрэлдэхүүн хэсэгт хүлээгдэж буй зээлийн алдагдал ба зээлийн бүрэлдэхүүн хэсэгт хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тус тусад нь тодорхойлж чадахгүй. Агентлаг нь ашиглаагүй зээл олгох баталгааны хүлээгдэж буй зээлийн алдагдлыг уг зээлийн бүрэлдэхүүн хэсгийн гарзын хасагдуулгын хамтаар санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрдөг. Нийт хүлээгдэж буй зээлийн алдагдал нь тухайн санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнээс хэтэрсэн хэмжээгээр уг хүлээгдэж буй зээлийн алдагдлыг (УСНББОУС 30, *Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга*-ын дагуу) хасагдуулга байдлаар толилуулна.

Жишээ 11—Гэрээний мөнгөн гүйлгээний өөрчлөлт

ҮЖ66. А засгийн газар нь гэрээний нийт дүнг хугацааны эцэст бүтэн дүнгээр буцаан төлөхийг шаарддаг 5 жилийн хугацаатай зээл олгосон. Түүний гэрээний нэрлэсэн дүн нь 1,000ТН бөгөөд 5 хувийн хүүг жил бүр төлнө. Үр ашигт хүү нь 5 хувь юм. Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдээгүй учраас эхний тайлант үеийн (Тайлант үе 1) эцэст А засгийн газар нь 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр гарзын хасагдуулгыг хүлээн зөвшөөрнө. Гарзын хасагдуулгын үлдэгдлийг 20ТН-ээр хүлээн зөвшөөрнө.

ҮЖ67. Дараагийн тайлант үед (Тайлант үе 2) уг зээлийн хувьд зээлийн эрсдэл нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш мэдэгдэхүйц нэмэгдсэн гэж А засгийн газар тодорхойлсон. Энэхүү нэмэгдэлтийн улмаас А засгийн газар нь уг зээлийн нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрнө. Гарзын хасагдуулгын үлдэгдэл нь 30ТН болно.

ҮЖ68. Зээлдэгчийн мэдэгдэхүйц санхүүгийн хүндрэлийн дараа, гурав дахь тайлант үеийн (Тайлант үе 3) эцэст А засгийн газар нь уг зээлийн гэрээний мөнгөн гүйлгээнд засвар өөрчлөлт оруулсан. Энэхүү засвар өөрчлөлтийн өдрийн байдлаар үлдэж буй хугацаа нь гурван жил болгохын тулд уг зээлийн гэрээний хугацааг нэг жилээр сунгасан. Ийм засвар өөрчлөлт нь А засгийн газар уг зээлийг үл хүлээн зөвшөөрөхөд хүргэхгүй.

ҮЖ69. Тус засвар өөрчлөлтийн үр дүнд А засгийн газар нь зээлийн 5 хувийн анхны үр ашигт хүүний хувиар дискаунтчилсан, тэрхүү засварлан өөрчилсөн гэрээний мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ байдлаар тухайн санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнийг дахин тооцоолно. Энэхүү дахин тооцоолсон нийт дансны үнэ ба уг засвар өөрчлөлтийн өмнөх нийт дансны үнэ хоорондох зөрүүг УСНББОУС 41-ийн 71-р параграфын дагуу засвар өөрчлөлтийн олз эсвэл гарз гэж хүлээн зөвшөөрнө. Засвар өөрчлөлтийн гарзыг (300ТН гэж тооцоолсон) А засгийн газар нь уг зээлийн нийт дансны үнээс хасаж, түүнийг 700 ТН болгох ба 300 ТН-ийн засвар өөрчлөлтийн гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

ҮЖ70. Засварлан өөрчилсөн гэрээний мөнгөн гүйлгээг харгалзсанаар А засгийн газар нь уг гарзын хасагдуулгыг мөн дахин хэмжих ба тэрхүү зээлийн гарзын хасагдуулгыг нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр хэмжсэн хэвээр байх эсэхийг үнэлдэг. А засгийн газар нь одоогийн зээлийн эрсдлийг (засварлан өөрчилсөн мөнгөн гүйлгээг харгалзсан) анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн зээлийн эрсдэлтэй (засварлан өөрчлөөгүй анхны мөнгөн гүйлгээнд үндэслэсэн) харьцуулж үзсэн. Тухайн тайлангийн өдрөөр уг зээл нь зээлийн үнэ цэнийн бууралттай болоогүй боловч анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн зээлийн эрсдэлтэй харьцуулахад зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн ба нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр гарзын хасагдуулгыг хэмжсэн хэвээр байх хэрэгтэй гэж А засгийн газар тодорхойлсон. Нийт хугацаанд

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

хүлээгдэж буй зээлийн алдагдлын хувьд гарзын хасагдуулгын үлдэгдэл нь тухайн тайлангийн өдөр 100ТН байна.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Тайлант үе	Нийт дансны үнийн эхний үлдэгдэл	Үнэ цэнийн бууралтын (гарз)/олз	Засвар өөрчлөлтийн (гарз)/олз	Хүүний орлого	Мөнгөн гүйлгээ	Нийт дансны үнийн эхний үлдэгдэл	Гарзын хасагдуулга	Хорогдуулсан өртгийн эцсийн үлдэгдэл
	А	Б	В	Г Нийт: Ах5 хувь	Д	$E = A + B + Г - Д$	Ж	$И = E - Ж$
1	1,000ТН	(20ТН)		50ТН	50ТН	1,000ТН	20ТН	980ТН
2	1,000ТН	(10ТН)		50ТН	50ТН	1,000ТН	30ТН	970ТН
3	1,000ТН	(70ТН)	(300ТН)	50ТН	50ТН	700ТН	100ТН	600ТН

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

ҮЖ71. УСНББОУС 41-ийн 84-р параграфт заасанчлан, А засгийн газар нь анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн зээлийн эрсдлийг (анхны, засварлан өөрчлөөгүй мөнгөн гүйлгээнд үндэслэсэн) тухайн тайлангийн өдрөөрх зээлийн эрсдэлтэй (засварлан өөрчилсөн мөнгөн гүйлгээнд үндэслэсэн) харьцуулах замаар зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг дараагийн тайлант үе бүрийн эцэст үнэлнэ.

ҮЖ72. Зээлийн засвар өөрчлөлтөөс хойш хоёр тайлант үеийн дараа (Тайлант үе 5), зээлдэгч нь уг засвар өөрчлөлтийн өдрөөрх хүлээлттэй харьцуулахад өөрийн бизнес төлөвлөгөөг мэдэгдэхүйц давуулан биелүүлсэн. Түүнчлэн, бизнесийн хэтийн төлөв нь өмнө төсөөлж байснаас илүү эерэг хандлагатай болсон. Их зардал буюу хүчин чармайлт гаргахгүйгээр олж авах боломжтой, ул үндэслэлтэй ба дэмжих бүх мэдээллийн үнэлгээ нь уг зээлийн ерөнхий эрсдэл буурсан ба зээлийн хүлээгдэж буй хугацаанд үл биелүүлэлт гарах эрсдэл багассан гэдгийг харуулсан. Иймээс А засгийн газар нь уг зээлдэгчийн зээлийн дотоод зэрэглэлийг тухайн тайлант үеийн эцэст залруулсан.

ҮЖ73. Ерөнхий эерэг өөрчлөлтийг харгалзан А засгийн газар нь нөхцөл байдлыг дахин хянан үнэлж, уг зээлийн хувьд зээлийн эрсдэл буурсан ба анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдэлгүй болсон гэж дүгнэсэн. Үүний үр дүнд А засгийн газар нь эргээд 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр гарзын хасагдуулгыг хэмжсэн.

Жишээ 12—Хасагдуулгын матриц

ҮЖ74. М хотын захиргаа нь өөрийн харьяа нутаг дэвсгэрийн хүрээн дэх айл өрхүүдэд усан хангамжийн үйлчилгээ үзүүлдэг. Тухайн тайлант хугацаанд зарцуулсан усны хэмжээнд үндэслэн айл өрхүүдээс сар тутам төлбөрийг нэхэмжилдэг. Ингэснээр 20X1 онд М хотын захиргааны хувьд 30 сая ТН-ийн худалдааны авлагын багц үүссэн. Уг багц нь төлөгдөөгүй бага дүн бүхий үлдэгдэлтэй маш олон тооны айл өрхүүдээс бүрддэг. Гэрээний нөхцлүүдийн дагуу төлөх ёстой бүх дүнг барагдуулах тэдгээр айл өрхүүдийн чадвар боломжийг илэрхийлэх эрсдлийн ерөнхий шинж чанаруудаар уг худалдааны авлагыг ангилдаг. Тус худалдааны авлага нь санхүүжилтийн мэдэгдэхүйц бүрэлдэхүүн хэсэггүй. УСНББОУС 41-ийн 87-р параграфт заасанчлан, ийм худалдааны авлагын гарзын хасагдуулгыг нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр ямагт хэмждэг.

ҮЖ75. Уг багцын хувьд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тодорхойлохын тулд М хотын захиргаа нь хасагдуулгын матрицыг ашигладаг. Хасагдуулгын матриц нь тухайн худалдааны авлагын хүлээгдэж буй хугацаан дахь үл биелүүлэлтийн ажигласан түүхэн хувь хэмжээнд үндэслэдэг бөгөөд хэтийн тооцооллоор түүнд залруулга хийдэг. Тайлант үе бүрийн эцэст уг үл биелүүлэлтийн ажигласан түүхэн хувь хэмжээг шинэчлэн баяжуулж, хэтийн тооцооллын өөрчлөлтийг шинжилдэг. Энэ жишээ тохиолдлын хувьд эдийн засгийн нөхцөл байдал дараагийн жил доройтно гэсэн урьдчилсан таамаглалтай байна.

ҮЖ76. Ийм үндэслэлээр М хотын захиргаа нь дараах хасагдуулгын матрицыг тооцоолсон:

	Хэвийн	1–30 хоног хугацаа хэтэрсэн	31–60 хоног хугацаа хэтэрсэн	61–90 хоног хугацаа хэтэрсэн	90-ээс дээш хоног хугацаа хэтэрсэн
Үл биелүүлэлтийн хувь	0.3 хувь	1.6 хувь	3.6 хувь	6.6 хувь	10.6 хувь

ҮЖ77. Маш олон айл өрхүүдээс авах худалдааны авлага нь 30 сая ТН-ийн дүнтэй бөгөөд хасагдуулгын матриц ашиглан хэмжсэн.

	Нийт дансны үнэ	Нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлын хасагдуулга (Нийт дансны үнэ х нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлын хувь)
Хэвийн	15,000,000 ТН	45,000 ТН

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

	Нийт дансны үнэ	Нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлын хасагдуулга (Нийт дансны үнэ х нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлын хувь)
1–30 хоног хугацаа хэтэрсэн	7,500,000 ТН	120,000 ТН
31–60 хоног хугацаа хэтэрсэн	4,000,000 ТН	144,000 ТН
61–90 хоног хугацаа хэтэрсэн	2,500,000 ТН	165,000 ТН
90-ээс дээш хоног хугацаа хэтэрсэн	1,000,000 ТН	106,000 ТН
	30,000,000 ТН	580,000 ТН

Жишээ 13—Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн өрийн хэрэглүүр

ҮЖ78. А Олон Нийтийн Хөрөнгө Оруулалтын Сан нь 20X0 оны 12-р сарын 15-нд 1,000 ТН-ийн бодит үнэ цэнэтэй өрийн хэрэглүүрийг худалдан авч, уг өрийн хэрэглүүрийг цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн. Тус хэрэглүүр нь 10 жилийн гэрээний хугацаанд 5 хувийн хүүтэй бөгөөд үр ашигт хүү 5 хувь байна. Анх хүлээн зөвшөөрөх үед уг хөрөнгө нь худалдан авсан буюу үүсгэн гаргасан зээлийн үнэ цэнийн бууралттай хөрөнгө биш гэж тус байгууллага тодорхойлсон.

	Дебит	Кредит
Санхүүгийн хөрөнгө—Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн	1,000ТН	
Мөнгө		1,000ТН
<i>(Бодит үнэ цэнээр нь хэмжсэн өрийн хэрэглүүрийг хүлээн зөвшөөрөх)</i>		

ҮЖ79. Зах зээлийн хүүний түвшний өөрчлөлтийн үр дүнд уг хэрэглүүрийн бодит үнэ цэнэ нь 20X0 оны 12-р сарын 31-нд (тайлангийн өдөр) 950ТН болж буурсан. Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдээгүй бөгөөд 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр буюу 30ТН-ээр уг хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжих хэрэгтэй гэж тус байгууллага тодорхойлсон. Хялбарчлах үүднээс хүүний орлого хүлээн авалтын журналын бичилтийг энд харуулаагүй.

	Дебит	Кредит
Үнэ цэнийн бууралтын гарз (ашиг, алдагдал)	30ТН	
Цэвэр хөрөнгө/өмч ^(a)	20ТН	
Санхүүгийн хөрөнгө—Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн		50ТН
<i>(Өрийн хэрэглүүрийн 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдал болон бодит үнэ цэнийн бусад өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөх)</i>		
^(a) Тухайн тайлангийн өдрөөрх цэвэр хөрөнгө/өмч дэх хуримтлагдсан гарз 20ТН байсан. Энэ нь 50ТН-ийн нийт бодит үнэ цэнийн өөрчлөлт (өөрөөр хэлбэл, 1,000ТН-950ТН) ба 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг илэрхийлэх, хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын өөрчлөлтийн дүн (30ТН) хоорондох зөрүү юм.		

ҮЖ80. 30ТН-ийн хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын талаар тодруулга хийнэ.

ҮЖ81. 20X1 оны 01-р сарын 01-нд тус байгууллага нь тухайн өдрийн бодит үнэ цэнэ болох 950ТН-ээр уг өрийн хэрэглүүрийг борлуулахаар шийдвэрлэсэн.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

	Дебит	Кредит
Мөнгө	950ТН	
Санхүүгийн хөрөнгө—Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн		950ТН
Гарз (ашиг, алдагдал)	20ТН	
Цэвэр хөрөнгө/өмч ^(а) <i>(Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулсан бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрч, цэвэр хөрөнгө/өмчид хуримтлагдсан дүнг ашиг, алдагдалд хаасан)</i>		20ТН

Жишээ 14— Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулсан бодит үнэ цэнийн хэмжилтийн ангилал ба гадаад валютаар илэрхийлэлтийн хоорондох уялдаа, бодит үнэ цэнийн хейжийн нягтлан бодох бүртгэл ба үнэ цэнийн бууралт

ҮЖ82. Гадаад валютаар илэрхийлэгдэж, цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн ба бодит үнэ цэнийн хейжийн нягтлан бодох бүртгэлийн харилцаанд сонгосон өрийн хэрэглүүрийн нягтлан бодох бүртгэлийг энэхүү жишээнд үлгэрчлэн харуулав. Үнэ цэнийн бууралтын тайлагналтай холбогдох уялдааг уг жишээнд мөн үлгэрчлэн харуулсан.

ҮЖ83. 20X0 оны 01-р сарын 01-нд байгууллага нь гадаад валют (ГВ)-аар илэрхийлэгдсэн өрийн хэрэглүүрийг (бондыг) түүний 100,000 ГВ-ын бодит үнэ цэнээр худалдан авч, цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн бонд гэж ангилсан. Бонд нь дуусгавар болох хүртэл үлдсэн 5 жилийн хугацаатай ба гэрээний хугацаанд уг гэрээний 100,000ГВ-ын нэрлэсэн дүнгээс тооцогдох тогтмол 5 хувийн купоны хүүтэй. Анх хүлээн зөвшөөрөх үед бонд нь 5 хувийн үр ашигт хүүтэй байсан. Байгууллагын бүртгэлийн валют нь түүний орон нутгийн валют (ОНВ) юм. 20X0 оны 01-р сарын 01-нд 1ГВ-ын ханш нь 1ОНВ байсан. Анх хүлээн зөвшөөрөх үед уг бонд нь худалдан авсан буюу үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай хөрөнгө биш байсан гэж тус байгууллага тодорхойлсон. Түүнчлэн, 20X0 оны 01-р сарын 01-ний байдлаар 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг 1,200 ГВ гэж тодорхойлсон. 20X0 оны 01-р сарын 01-ний байдлаар түүний ГВ-аар илэрхийлсэн, хорогдуулсан өртөг нь нийт 100,000 ГВ-ын дансны үнээс 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хассан дүнтэй (100,000ГВ-1,200ГВ) тэнцүү байна.

ҮЖ84. Байгууллага нь дараах зээлийн эрсдэл өртөлттэй байна:

- (а) ГВ-аар илэрхийлэгдсэн бодит үнэ цэнийн хүүний түвшний эрсдэл: тогтмол хүүтэй хэрэглүүрийн худалдан авалтын үр дүнд үүсэх эрсдэл өртөлт; ба
- (б) Гадаад валютын ханшийн эрсдэл: ОНВ-аар хэмжсэн, гадаад валютын ханшийн өөрчлөлтийн эрсдэл өртөлт.

ҮЖ85. Байгууллага нь дараах эрсдлийн удирдлагын стратегийг ашигласнаар өөрийн эрсдэл өртөлтөнд хейж хийдэг:

- (а) Тогтмол хүүний түвшний (ГВ-аарх) эрсдлийн хувьд байгууллага нь ГВ-аарх өөрийн хүүний орлогыг ГВ-аарх одоогийн хувьсах хүүний түвшинтэй холбон уялдуулахаар шийдвэрлэсэн. Ингэснээр байгууллага нь ГВ-аар илэрхийлэгдсэн хүүний түвшний свопыг ашиглах бөгөөд түүний дагуу тогтмол хүү төлж, хувьсах хүүг ГВ-аар хүлээн авна; ба
- (б) Гадаад валютын ханшийн эрсдлийн хувьд байгууллага нь гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс үүсэх ОНВ-ын аливаа хувьсан өөрчлөлтийн эсрэг хейж хийхгүй байхаар шийдвэрлэсэн.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

ҮЖ86. Байгууллага нь дараах хейжийн харилцааг сонгосон:¹⁴ ГВ-аар илэрхийлэгдсэн бенчмарк хүүний түвшний өөрчлөлтийн эрсдлийг хейж хийсэн эрсдэл байдлаар хейжийн зүйл гэж сонгосон ГВ-аарх бондын бодит үнэ цэнийн хейж. Байгууллага нь тогтмол хүү төлж, тухайн өдөр хувьсах хүү хүлээн авах зах зээлийн түвшний свопын гэрээ байгуулсан бөгөөд уг свопыг хейжийн хэрэглүүр гэж сонгосон. Свопын ерөнхий хугацаа нь уг хейжийн зүйлийн хугацаатай (өөрөөр хэлбэл, таван жилтэй) нийцэн уялдаг.

ҮЖ87. Энэ жишээнд хялбарчлах үүднээс, хейжийн нягтлан бодох бүртгэлийн харилцааны хувьд хейжийн үр дүнгүй байдал үүсээгүй гэж төсөөлсөн. Яагаад гэвэл, бодит үнэ цэнийн хейжийн харилцаанд сонгосон, гадаад валютаарх санхүүгийн хэрэглүүрийн цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулсан бодит үнэ цэнийн хэмжилт бүхий нөхцөл байдал дахь нягтлан бодох бүртгэлийн арга механизмыг үлгэрчлэн харуулахад илүү сайн төвлөрөн чиглэх, мөн ийм хэрэглүүрийн үнэ цэнийн бууралтын олз, гарзын хүлээн зөвшөөрөлтөнд төвлөрөн чиглэхийн тулд таамаглалуудыг дэвшүүлсэн.

ҮЖ88. 20X0 оны 01-р сарын 01-нд байгууллага нь бонд ба свопыг хүлээн зөвшөөрөхийн тулд дараах журналын бичилт хийнэ:

	Дебит-ОНВ	Кредит-ОНВ
Санхүүгийн хөрөнгө—Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн	100,000	
Мөнгө		100,000
<i>(Бондыг түүний бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх)</i>		
Үнэ цэнийн бууралтын гарз (ашиг, алдагдал)	1,200	
Цэвэр хөрөнгө/өмч		1,200
<i>(12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх)^(a)</i>		
Своп	-	
Мөнгө		-
<i>(Свопыг түүний бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх)</i>		
^(a) Холбогдох зүйлсийг уг байгууллагын бүртгэлийн валютаар хэмждэг тохиолдолд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх журналын бичилтийг тухайн тайлангийн өдрөөр хийнэ.		

ҮЖ89. Зах зээлийн хүүний түвшин нэмэгдсэний улмаас бондын бодит үнэ цэнэ нь 20X0 оны 12-р сарын 31-ний (тайлангийн өдөр) байдлаар 100,000ГВ-аас 96,370ГВ болж буурсан. Свопын бодит үнэ цэнэ нь 1,837ГВ болж өссөн. Түүнчлэн, байгууллага нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш бондын зээлийн эрсдэл өөрчлөгдөөгүй гэж 20X0 оны 12-р сарын 31-ний байдлаар тодорхойлсон бөгөөд 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлын хувьд гарзын хасагдуулгыг 1,200ГВ-аар үргэлжлүүлэн бүртгэсэн.¹⁵ 20X0 оны 12-р сарын 31-нд 1ГВ-ын ханш нь 1.4 ОНВ байсан. Үүнийг дараах хүснэгтэнд харуулсан:

	20X0 оны 01-р сарын 01	20X0 оны 12-р сарын 31
Бонд		
Бодит үнэ цэнэ (ГВ)	100,000	96,370
Бодит үнэ цэнэ (ОНВ)	100,000	134,918

¹⁴ Энэ жишээний хувьд хейжийн нягтлан бодох бүртгэлийн бүх шалгуур хангагдсан гэж төсөөлсөн (УСНББОУС 41-ийн 129-р параграфыг үзнэ үү). Хейжийн сонголтын дараах тайлбар тодорхойлолт нь зөвхөн энэ жишээг ойлгомжтой болгох зорилготой билээ (өөрөөр хэлбэл, энэ нь УСНББОУС 41-ийн 129-р параграфтаар шаардсан албан ёсны цогц баримтжуулалтын жишээ биш юм).

¹⁵ Хялбарчлах үүднээс, хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолох үедээ дискаунтчлалын нөлөөг энэ жишээнд харгалзан үзээгүй.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

...		
Хорогдуулсан өртөг (ГВ)	98,800	98,800
Хорогдуулсан өртөг (ОНВ)	98,800	138,320
...		
Хууний түвшний своп		
Хууний түвшний своп (ГВ)	-	1,837
Хууний түвшний своп (ОНВ)	-	2,572
...		
Үнэ цэнийн бууралт-Гарзын хасагдуулга		
Гарзын хасагдуулга (ГВ)	1,200	1,200
Гарзын хасагдуулга (ОНВ)	1,200	1,680
Гадаад валютын ханш (ГВ:ОНВ)	1:1	1:1.4

ҮЖ90. Бонд нь мөнгөн зүйлсийн хөрөнгө юм. Иймээс байгууллага нь гадаад валютын ханшийн хөдөлгөөнөөс хамаарсан өөрчлөлтийг УСНББОУС 4, *Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө*-ний 27(а) ба 32-р параграфын дагуу ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө, бусад өөрчлөлтийг УСНББОУС 41-ийн дагуу хүлээн зөвшөөрнө. УСНББОУС 4-ийн 32-р параграфыг мөрдөх зорилгын хувьд уг хөрөнгийг гадаад валютаар хорогдуулсан өртгөөр хэмжсэн хөрөнгө гэж үзнэ.

ҮЖ91. Хүснэгтэнд харуулсанчлан, 20X0 оны 12-р сарын 31-нд бондын бодит үнэ цэнэ нь 134,918 (96,370ГВ х 1.4) ОНВ, хорогдуулсан өртөг нь 138,320 ((100,000ГВ-1,200ГВ)х1.4) ОНВ байна.

ҮЖ92. Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн улмаас ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн олз нь 39,520 ОНВ (138,320 ОНВ-98,800 ОНВ) байна, өөрөөр хэлбэл 20X0 онд бондын хорогдуулсан өртөгт ОНВ-аар гарсан өөрчлөлт юм. Бондын бодит үнэ цэнэд ОНВ-аар гарсан 34,918 ОНВ-ын өөрчлөлтийг уг дансны үнийн залруулга байдлаар хүлээн зөвшөөрнө. ОНВ-аар илэрхийлэгдсэн бондын бодит үнэ цэнэ ба түүний хорогдуулсан өртгийн хоорондох зөрүү нь 3,402 ОНВ (134,918 ОНВ – 138,320 ОНВ) байна. Харин цэвэр хөрөнгө/өмчийн бууралт байдлаар цэвэр хөрөнгө/өмчид 20X0 онд хүлээн зөвшөөрсөн, хуримтлагдсан олз буюу гарын өөрчлөлт нь 4,602 ОНВ (3,402 ОНВ + 1,200 ОНВ) юм.

ҮЖ93. Свопын 2,572 ОНВ (1,837 ГВ х 1.4)-ын олзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн бөгөөд хейжийн үр дүнгүй байдал үүсээгүй гэж төсөөлсөн учраас адилтгах дүнг тухайн тайлант үед цэвэр хөрөнгө/өмчөөс хассан. Хялбарчлах үүднээс, хүүний орлогын хүлээн зөвшөөрөлтийн хувьд журналын бичилтүүдийг тусган харуулаагүй. Хуримтлуулсан хүүг тухайн тайлант үед нь хүлээн авсан гэж үзсэн.

ҮЖ94. 20X0 оны 12-р сарын 31-нд байгууллага нь дараах журналын бичилт хийнэ:

	Дебит-ОНВ	Кредит-ОНВ
Санхүүгийн хөрөнгө—Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн	34,918	
Цэвэр хөрөнгө/өмч	4,602	
Ашиг, алдагдал		39,520
<i>(Бондын гадаад валютын ханшийн олз, ОНВ-аар бодит үнэ цэнээр хэмжсэн түүний дансны үнийн залруулга, гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс хамаарсан хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын өөрчлөлтийн дүнг хүлээн зөвшөөрөх)</i>		
Своп	2,572	
Ашиг, алдагдал		2,572
<i>(Свопыг бодит үнэ цэнээр дахин хэмжих)</i>		
Ашиг, алдагдал	2,572	

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

	Дебит-ОНВ	Кредит-ОНВ
Цэвэр хөрөнгө/өмч		2,572
<i>(Хейж хийсэн эрсдлийн өөрчлөлтийн улмаас бондын бодит үнэ цэнэд гарсан өөрчлөлтийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх)</i>		

ҮЖ95. УСНББОУС 30-ын 20А параграфт заасанчлан, цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн гарзын хасагдуулгыг тухайн санхүүгийн хөрөнгийн дансны үнийн бууралт байдлаар тусад нь толилуулахгүй. Гэвч цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын дүнгийн талаар тодруулга хийнэ.

ҮЖ96. Зах зээлийн хүүний түвшний нэмэгдэлт ба бондын зээлийн эрсдлийн нэмэгдэлтийн улмаас бондын бодит үнэ цэнэ нь 20X1 оны 12-р сарын 31-ний байдлаар (тайлангийн өдөр) 87,114 ГВ болж буурсан. Свопын бодит үнэ цэнэ нь 2,092 ГВ болж, 255 ГВ-аар өссөн. Түүнчлэн, байгууллага нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш бондын зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн гэж 20X1 оны 12-р сарын 31-ний байдлаар тодорхойлсон, иймээс нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр гарзын хасагдуулгыг хүлээн зөвшөөрсөн.¹⁶ 20X1 оны 12-р сарын 31-ний байдлаар нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг 9,700 ГВ гэж тооцоолсон. 20X1 оны 12-р сарын 31-нд 1ГВ-ын ханш нь 1.25 ОНВ байсан. Үүнийг дараах хүснэгтэнд харуулав:

	20X0 оны 12-р сарын 31	20X1 оны 12-р сарын 31
Бонд		
Бодит үнэ цэнэ (ГВ)	96,370	87,114
Бодит үнэ цэнэ (ОНВ)	134,918	108,893
Хорогдуулсан өртөг (ГВ)	98,800	90,300
Хорогдуулсан өртөг (ОНВ)	138,320	112,875
Хүүний түвшний своп		
Хүүний түвшний своп (ГВ)	1,837	2,092
Хүүний түвшний своп (ОНВ)	2,572	2,615
Үнэ цэнийн бууралт-Гарзын хасагдуулга		
Гарзын хасагдуулга (ГВ)	1,200	9,700
Гарзын хасагдуулга (ОНВ)	1,680	12,125
Гадаад валютын ханш (ГВ:ОНВ)	1:1.4	1:1.25

ҮЖ97. Хүснэгтэнд харуулсанчлан, 20X1 оны 12-р сарын 31-нд бондын бодит үнэ цэнэ нь 108,893 (87,114ГВ х 1.25) ОНВ, хорогдуулсан өртөг нь 112,875 ((100,000ГВ-9,700ГВ)х1.25) ОНВ байна.

ҮЖ98. Бондын нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг 20X1 оны 12-р сарын 31-ний байдлаар 9,700 ГВ гэж хэмжсэн. Иймээс ОНВ-аар ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарз нь 10,625 ((9,700ГВ-1,200ГВ)х1.25) ОНВ байна.

ҮЖ99. Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн улмаас ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн гарз нь 14,820 ОНВ (112,875 ОНВ-138,320 ОНВ + 10,625 ОНВ), энэ нь 20X1 онд бондын нийт дансны үнэд ОНВ-аар гарсан өөрчлөлт бөгөөд хорогдуулсан өртөгт үндэслэн тухайн үнэ цэнийн бууралтын гарзын хувьд залруулга хийсэн дүн байна. 20X1 оны 12-р сарын 31-нд тухайн байгууллагын бүртгэлийн валютаар илэрхийлэгдсэн бондын бодит үнэ цэнэ ба түүний хорогдуулсан өртгийн хоорондох зөрүү нь 3,982 ОНВ (108,893 ОНВ – 112,875 ОНВ) байна. Харин цэвэр хөрөнгө/өмчийн бууралт байдлаар цэвэр хөрөнгө/өмчид 20X1 онд хүлээн зөвшөөрсөн, хуримтлагдсан олз буюу гарын өөрчлөлт нь 11,205 ОНВ (3,982 ОНВ - 3,402 ОНВ + 10,625 ОНВ) юм.

¹⁶ Хялбарчлах үүднээс, энэ жишээний хувьд зээлийн эрсдэл нь бодит үнэ цэнийн хейжийн харилцаанд голлох үүрэггүй гэж үзсэн

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

ҮЖ100. Свопын 43 ОНВ (2,615 ОНВ – 2,572 ОНВ)-ын олзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн бөгөөд хейжийн үр дүнгүй байдал үүсээгүй гэж төсөөлсөн учраас адилтгах дүнг тухайн тайлант үед цэвэр хөрөнгө/өмчөөс хассан.

ҮЖ101. 20X1 оны 12-р сарын 31-нд байгууллага нь дараах журналын бичилт хийнэ:

	Дебит-ОНВ	Кредит-ОНВ
Санхүүгийн хөрөнгө—Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн		26,025
Цэвэр хөрөнгө/өмч	11,205	
Ашиг, алдагдал	14,820	
<i>(Бондын гадаад валютын ханиийн олз, ОНВ-аар бодит үнэ цэнээр хэмжсэн түүний дансны үнийн залруулга, гадаад валютын ханиийн өөрчлөлтөөс хамаарсан хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын өөрчлөлтийн дүнг хүлээн зөвшөөрөх)</i>		
Своп	43	
Ашиг, алдагдал		43
<i>(Свопыг бодит үнэ цэнээр дахин хэмжих)</i>		
Ашиг, алдагдал	43	
Цэвэр хөрөнгө/өмч		43
<i>(Хейж хийсэн эрсдлийн өөрчлөлтийн улмаас бондын бодит үнэ цэнэд гарсан өөрчлөлтийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх)</i>		
Ашиг, алдагдал (үнэ цэнийн бууралтын гарз)	10,625	
Цэвэр хөрөнгө/өмч (хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын дүн)		10,625
<i>(Нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх)</i>		

ҮЖ102. 20X2 оны 01-р сарын 01-нд байгууллага нь бондыг түүний тухайн өдрийн бодит үнэ цэнэ болох 87,114 ГВ-аар борлуулах ба свопыг мөн бодит үнэ цэнээр хаахаар шийдвэрлэсэн. Гадаад валютын ханш нь 20X1 оны 12-р сарын 31-ний ханштай ижил байсан. Бондыг үл хүлээн зөвшөөрөх ба цэвэр хөрөнгө/өмчид хуримтлагдсан олз, гарзыг дахин ангилах журналын бичилт нь дараах байдалтай байна:

	Дебит-ОНВ	Кредит-ОНВ
Мөнгө	108,893	
Санхүүгийн хөрөнгө—Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн		108,893
Борлуулалтын гарз (ашиг, алдагдал)	1,367 ^(a)	
Цэвэр хөрөнгө/өмч		1,367
<i>(Бондыг үл хүлээн зөвшөөрөх)</i>		
Своп		2,615
Мөнгө	2,615	
<i>(Свопыг хаах)</i>		

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

	Дебит-ОНВ	Кредит-ОНВ
(a) Энэ дүн нь бондын бодит үнэ цэнийн өөрчлөлт, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын дүн, цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс (2,572 ОНВ + 1,200 ОНВ + 43 ОНВ + 10,625 ОНВ – 4,602 ОНВ – 11,205 ОНВ = -1,367 ОНВ, үүнийг гарз байдлаар ашиг, алдагдалд хаасан) бүрдэнэ.		

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

ҮЖ106. Хэрэв уг багцыг дахин ангиллын яг өмнө, хорогдуулсан өртгөөр эсвэл цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн бол тэрхүү дахин ангиллын өдөр хүлээн зөвшөөрөх гарзын хасагдуулга нь 6,000 ТН болох байсан (анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойшхи зээлийн эрсдлийн мэдэгдэхүйц нэмэгдэлтийг, улмаар нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилтийг тусгах).

ҮЖ107. 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдал нь уг дахин ангиллын өдөр 4,000 ТН байсан.

ҮЖ108. Хялбарчлах үүднээс, хүүний орлогын хүлээн зөвшөөрөлтийг бүртгэх журналын бичилтийг харуулаагүй.

Хувилбар 1: Хорогдуулсан өртгөөр хэмжих ангиллаас гаргаж, ашиг алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангилал болгох дахин ангилал

ҮЖ109. А төрийн сангийн газар нь бондуудын багцыг хорогдуулсан өртгөөр хэмжих ангиллаас гаргаж, ашиг алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангилал болгон дахин ангилдаг. Дахин ангиллын өдөр бондуудын багцыг бодит үнэ цэнээр хэмждэг. Бондуудын багцын өмнөх хорогдуулсан өртгийн дүн ба уг бондуудын багцын бодит үнэ цэнийн хоорондох зөрүүгээс үүссэн аливаа олз буюу гарзыг тэрхүү дахин ангиллын үед ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг.

	Дебит	Кредит
Бонд—(Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгө)	490,000ТН	
Бонд—(Хорогдуулсан өртөг бүхий хөрөнгийн нийт дансны үнэ)		500,000ТН
Гарзын хасагдуулга	6,000ТН	
Дахин ангиллын гарз (ашиг, алдагдал)	4,000ТН	
<i>(Бондуудыг хорогдуулсан өртгөөр хэмжих ангиллаас ашиг алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангилал болгох дахин ангиллыг хүлээн зөвшөөрөх ба гарзын хасагдуулгыг үл хүлээн зөвшөөрөх)</i>		

Хувилбар 2: Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангиллаас гаргаж, хорогдуулсан өртгөөр хэмжих ангилал болгох дахин ангилал

ҮЖ110. А төрийн сангийн газар нь бондуудын багцыг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангиллаас гаргаж, хорогдуулсан өртгөөр хэмжих ангилал болгон дахин ангилдаг. Дахин ангиллын өдрөөрх бондуудын багцын бодит үнэ цэнэ нь түүний шинэ нийт дансны үнэ болох бөгөөд уг нийт дансны үнэд үндэслэн үр ашигт хүүний хувийг тодорхойлно. Үнэ цэнийн бууралтын шаардлагуудыг тэрхүү дахин ангиллын өдрөөс эхлэн бондуудад даган мөрдөнө. Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх зорилгын хувьд, уг дахин ангиллын өдрөөрх тэрхүү бондуудын багцын зээлийн эрсдэл нь ирээдүйд зээлийн эрсдэлд орох өөрчлөлтийг харьцуулах суурь зээлийн эрсдэл болно.

	Дебит	Кредит
Бонд—(Хорогдуулсан өртөг бүхий хөрөнгийн нийт дансны үнэ)	490,000ТН	
Бонд—(Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгө)		490,000ТН
Үнэ цэнийн бууралтын гарз (ашиг, алдагдал)	4,000ТН	
Гарзын хасагдуулга		4,000ТН
<i>(Бондуудыг ашиг алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангиллаас хорогдуулсан өртгөөр хэмжих ангилал болгох дахин ангиллыг хүлээн зөвшөөрөх, түүнчлэн үнэ цэнийн бууралтыг тайлагнах)</i>		

Хувилбар 3: Хорогдуулсан өртгөөр хэмжих ангиллаас гаргаж, цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангилал болгох дахин ангилал

ҮЖ111. А төрийн сангийн газар нь бондуудын багцыг хорогдуулсан өртгөөр хэмжих ангиллаас гаргаж, цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангилал болгон дахин ангилдаг. Дахин ангиллын өдөр бондуудын багцыг бодит үнэ цэнээр хэмждэг. Бондуудын багцын өмнөх хорогдуулсан өртгийн дүн ба уг бондуудын багцын бодит үнэ цэнийн хоорондох зөрүүгээс үүссэн аливаа олз буюу гарзыг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрдөг. Үр ашигт хүүний хувь ба хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилтийг тэрхүү дахин ангиллын үр дүнд өөрчлөн залруулахгүй. Зээлийн эрсдлийн өөрчлөлтийг үнэлэхийн тулд уг анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн зээлийн эрсдлийг үргэлжлүүлэн ашиглана. Гарзын хасагдуулгыг уг бондын нийт дансны үнийн залруулга байдлаар хүлээн зөвшөөрөхийг тэрхүү дахин ангиллын өдрөөс эхлэн зогсоох ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын дүн байдлаар хүлээн зөвшөөрөх бөгөөд түүнийг тодруулна.

	Дебит	Кредит
Бонд—(Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгө)	490,000ТН	
Бонд—(Хорогдуулсан өртөг бүхий хөрөнгийн нийт дансны үнэ)		500,000ТН
Гарзын хасагдуулга	6,000ТН	
Цэвэр хөрөнгө/өмч ^(a)	4,000ТН	
<i>(Хорогдуулсан өртгөөр хэмжих ангиллаас цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангилал болгох дахин ангиллыг хүлээн зөвшөөрөх. Гэвч хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилт нь өөрчлөгдөхгүй.)</i>		
^(a) Хялбарчлах үүднээс, үнэ цэнийн бууралттай холбоотой дүнг тусад нь харуулаагүй. Хэрэв тусад нь харуулсан бол энэхүү журналын бичилтийг (өөрөөр хэлбэл, Дт 4,000ТН гэдгийг) дараах хоёр бичилт болгон задална: Дт Цэвэр хөрөнгө/өмч 10,000ТН (бодит үнэ цэнийн өөрчлөлт) ба Кт Цэвэр хөрөнгө/өмч 6,000ТН (хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын дүн).		

Хувилбар 4: Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангиллаас гаргаж, хорогдуулсан өртгөөр хэмжих ангилал болгох дахин ангилал

ҮЖ112. А төрийн сангийн газар нь бондуудын багцыг цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангиллаас гаргаж, хорогдуулсан өртгөөр хэмжих ангилал болгон дахин ангилдаг. Бондуудын багцыг бодит үнэ цэнээр дахин ангилдаг. Гэхдээ цэвэр хөрөнгө/өмчид өмнө нь хүлээн зөвшөөрч байсан хуримтлагдсан олз, гарзыг тэрхүү дахин ангиллын өдөр цэвэр хөрөнгө/өмчөөс хасаж, бондуудын багцын бодит үнэ цэнэд залруулсан. Үүний үр дүнд бондуудын багцыг угаасаа хорогдуулсан өртгөөр хэмжиж байсантай адилаар уг дахин ангиллын өдөр хэмжих юм. Үр ашигт хүүний хувь ба хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилтийг тэрхүү дахин ангиллын үр дүнд өөрчлөн залруулахгүй. Бондуудын зээлийн эрсдлийн өөрчлөлтийг үнэлэхийн тулд уг анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн зээлийн эрсдлийг үргэлжлүүлэн ашиглана. Гарзын хасагдуулгыг тэрхүү дахин ангиллын өдрөөс эхлэн уг бондын нийт дансны үнийн залруулга байдлаар (хорогдуулсан өртгийн дүнг тусгахын тулд) хүлээн зөвшөөрнө.

	Дебит	Кредит
Бонд—(Хорогдуулсан өртөг бүхий хөрөнгийн нийт дансны үнэ)	490,000ТН	
Бонд—(Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгө)		490,000ТН
Бонд—(Хорогдуулсан өртөг бүхий хөрөнгийн нийт дансны үнэ)	10,000ТН	
Гарзын хасагдуулга		6,000ТН
Цэвэр хөрөнгө/өмч ^(a)		4,000ТН

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

	Дебит	Кредит
<i>(Бондуудыг цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангиллаас хорогдуулсан өртгөөр хэмжих ангилал болгох дахин ангиллыг хүлээн зөвшөөрөх, түүнчлэн уг хорогдуулсан өртгийн дүнг тодорхойлохын тулд хассан гарзын хасагдуулгыг хүлээн зөвшөөрөх.)</i>		
^(a) Уг дахин ангиллын өдрөөрх цэвэр хөрөнгө/өмч дэх хуримтлагдсан гарз 4,000ТН байсан. Энэ нь 10,000ТН-ийн нийт бодит үнэ цэнийн өөрчлөлт (өөрөөр хэлбэл, 500,000ТН-490,000ТН), түүнчлэн тухайн хөрөнгийг цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих явцад хүлээн зөвшөөрсөн, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын дүн (6,000ТН) хоорондох зөрүү юм.		

Хувилбар 5: Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангиллаас гаргаж, цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангилал болгох дахин ангилал

ҮЖ113. А төрийн сангийн газар нь бондуудын багцыг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангиллаас гаргаж, цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангилал болгон дахин ангилдаг. Бондуудын багцыг бодит үнэ цэнээр хэмжсэн хэвээр байна. Гэвч үр ашигт хүүний аргыг мөрдөх зорилгын хувьд тэрхүү дахин ангиллын өдрөөрх бондуудын багцын бодит үнэ цэнэ нь түүний шинэ нийт дансны үнэ болох бөгөөд уг нийт дансны үнэд үндэслэн үр ашигт хүүний хувийг тодорхойлно. Үнэ цэнийн бууралтын шаардлагуудыг тэрхүү дахин ангиллын өдрөөс эхлэн даган мөрдөнө. Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх зорилгын хувьд, уг дахин ангиллын өдрөөрх тэрхүү бондуудын багцын зээлийн эрсдэл нь ирээдүйд зээлийн эрсдэлд орох өөрчлөлтийг харьцуулах суурь зээлийн эрсдэл болно.

	Дебит	Кредит
Бонд—(Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгө)	490,000ТН	
Бонд—(Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгө)		490,000ТН
Үнэ цэнийн бууралтын гарз (ашиг, алдагдал)	4,000ТН	
Цэвэр хөрөнгө/өмч		4,000ТН
<i>(Бондуудыг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангиллаас цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангилал болгох дахин ангиллыг хүлээн зөвшөөрөх, түүнчлэн үнэ цэнийн бууралтын тайлагналыг эхлүүлэх. Цэвэр хөрөнгө/өмчийн дүн нь уг дахин ангиллын өдрөөрх 4,000ТН-ийн гарзын хасагдуулгыг (тодруулгын зорилгод хамааралтай хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын дүнг) тусгадаг.)</i>		

Хувилбар 6: Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангиллаас гаргаж, ашиг алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангилал болгох дахин ангилал

ҮЖ114. А төрийн сангийн газар нь бондуудын багцыг цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангиллаас гаргаж, ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангилал болгон дахин ангилдаг. Бондуудын багцыг бодит үнэ цэнээр хэмжсэн хэвээр байна. Гэхдээ цэвэр хөрөнгө/өмчид өмнө нь хүлээн зөвшөөрч байсан хуримтлагдсан олз, гарзыг дахин ангиллын залруулга байдлаар цэвэр хөрөнгө/өмчөөс хасаж, ашиг алдагдалд дахин ангилна (УСНББОУС 1, Санхүүгийн Тайлангийн Толилуулга-ыг үзнэ үү).

	Дебит	Кредит
Бонд—(Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгө)	490,000ТН	
Бонд—(Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгө)		490,000ТН

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

	Дебит	Кредит
Дахин ангиллын гарз (ашиг, алдагдал)	4,000ТН	
Цэвэр хөрөнгө/өмч ^(а)		4,000ТН
<i>(Бондуудыг цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангиллаас ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ангилал болгох дахин ангиллыг хүлээн зөвшөөрөх.)</i>		
^(а) Уг дахин ангиллын өдрөөрх цэвэр хөрөнгө/өмч дэх хуримтлагдсан гарз 4,000ТН байсан. Энэ нь 10,000ТН-ийн нийт бодит үнэ цэнийн өөрчлөлт (өөрөөр хэлбэл, 500,000ТН-490,000ТН), түүнчлэн тухайн хөрөнгийг цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих явцад хүлээн зөвшөөрсөн, гарзын хасагдуулга (6,000ТН) хоорондох зөрүү юм.		

Нэгтгэсэн эрсдлийн хейжийн нягтлан бодох бүртгэл

ҮЖ115. Нэгтгэсэн эрсдлийн хейжийн нягтлан бодох бүртгэлийн арга механизмыг дараах жишээнд үлгэрчлэн харуулав.

Жишээ 16—Бараа бүтээгдэхүүний үнийн эрсдэл ба Гадаад валютын эрсдлийн нэгдсэн хейж (Мөнгөн гүйлгээний хейж/Мөнгөн гүйлгээний хейжийн хослол)

Өгөгдөл

ҮЖ116. А хотын захиргаа нь хэрэгжих өндөр магадлалтай урьдчилан таамагласан (Тайлант үе 5-ын эцэст гарч тохиолдохоор хүлээгдэж буй) цахилгаан эрчим хүчний худалдан авалтанд хейж хийхийг хүссэн. А байгууллагын бүртгэлийн валют нь түүний орон нутгийн валют (ОНВ) юм. Цахилгаан эрчим хүчийг гадаад валют (ГВ)-аар арилждаг. А байгууллага нь дараах эрсдэлд өртөнө:

- (а) Бараа бүтээгдэхүүний үнийн эрсдэл: худалдан авалтын үнийн хувьд мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлт, энэ нь ГВ-аар илэрхийлэгдсэн цахилгааны спот үнийн хэлбэлзлээс үүсдэг; ба
- (б) Гадаад валют (ГВ)-ын эрсдэл: ОНВ ба ГВ-ын хоорондох спот ханшийн хэлбэлзлээс үүсэх мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлт.

ҮЖ117. А хотын захиргаа нь эрсдлийн удирдлагын дараах стратегийг ашигласнаар өөрийн эрсдэл өртөлтөнд хейж хийдэг:

- (а) Нийлүүлэлтийн өмнөх дөрвөн тайлант үеийн цахилгаан эрчим хүчний худалдан авалтанд хейж хийхийн тулд А хотын захиргаа нь ГВ-аар илэрхийлэгдсэн, бараа бүтээгдэхүүний бенчмарк форвард гэрээг ашигласан. Өөрийн худалдан авалтын хувьд А хотын захиргааны бодитойгоор төлөх цахилгааны үнэ нь цахилгаан эрчим хүчний төрөл, байршил, нийлүүлэх арга маягийн ялгаатай байдлаас хамааран уг бенчмарк үнээс өөр байдаг.¹⁷ Энэ нь цахилгаан эрчим хүчний хоёр үнийн хоорондох харилцан уялдаа өөрчлөгдөх эрсдэлд (үүнийг зарим үед “суурийн эрсдэл” гэж нэрлэдэг) хүргэх бөгөөд ингэснээр уг хейжийн харилцааны үр дүнтэй байдалд нөлөөлнө. Өртөг/өгөөжийг харгалзсанаар үүнийг үр өгөөжтэй гэж үзээгүй учраас А хотын захиргаа нь энэ эрсдэлд хейж хийгээгүй.
- (б) А хотын захиргаа нь гадаад валютын эрсдэлд бас хейж хийдэг. Гэхдээ гадаад валютын эрсдэлд өөр хугацаагаар буюу нийлүүлэлтийн өмнөх ердөө гурван тайлант үеийн хувьд хейж хийдэг. А хотын захиргаа нь цахилгааны худалдан авалтын ГВ-аарх хувьсах төлбөр болон ГВ-аар илэрхийлэгдсэн, бараа бүтээгдэхүүний бенчмарк форвард гэрээний олз, гарзаас үүсэх ГВ-ын эрсдлийг ГВ-ын нэгтгэн нийлүүлсэн нэг эрсдэл байдлаар авч үздэг. Иймээс А хотын захиргаа нь урьдчилан таамагласан цахилгаан эрчим хүчний худалдан авалт болон холбогдох бараа

¹⁷ Энэ жишээний зорилгын хувьд уг хейж хийсэн эрсдлийг тухайн цахилгаан эрчим хүчний бенчмарк үнийн эрсдлийн бүрэлдэхүүн хэсэгт үндэслэн сонгоогүй гэж үзсэн. Иймээс цахилгаан эрчим хүчний нийт үнийн эрсдэлд хейж хийсэн.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

бүтээгдэхүүний форвард гэрээнээс үүсэх гадаад валютын мөнгөн гүйлгээнд хейж хийхийн тулд ГВ-ын зөвхөн нэг форвард гэрээг ашигладаг.

ҮЖ118. Жишээ 16-д ашигласан үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэнд харуулав ('суурийн тархалт' гэдэг нь А хотын захиргаа бодитойгоор төлөх цахилгааны эрчим хүчний үнэ ба бенчмарк цахилгаан эрчим хүчний үнэ хоорондох зөрүү бөгөөд үүнийг хувийн жин байдлаар илэрхийлдэг):

Жишээ 16-Үзүүлэлтүүд					
Тайлант үе	1	2	3	4	5
Дуусгавар болох үлдсэн хугацаан дахь хүүний түвшин [ГВ]	0.26%	0.21%	0.16%	0.06%	0.00%
Дуусгавар болох үлдсэн хугацаан дахь хүүний түвшин [ОНВ]	1.12%	0.82%	0.46%	0.26%	0.00%
Форвард үнэ [ГВ/МВтЦ]	1.25	1.01	1.43	1.22	2.15
Суурийн тархалт	-5.00%	-5.50%	-6.00%	-3.40%	-7.00%
Гадаад валютын ханш (спот) [ГВ/ОНВ]	1.3800	1.3300	1.4100	1.4600	1.4300

Нягтлан бодох бүртгэлийн арга механизм

ҮЖ119. А хотын захиргаа нь дараах хоёр хейжийн харилцааг мөнгөн гүйлгээний хейж гэж сонгосон:¹⁸

- (а) Хейжийн зүйл болох ГВ-аар илэрхийлэгдсэн, урьдчилан таамагласан цахилгаан эрчим хүчний худалдан авалтанд хамаарах мөнгөн гүйлгээний уг цахилгааны үнэтэй холбоотой хувьсан өөрчлөлт ба хейжийн хэрэглүүр болох ГВ-аар илэрхийлэгдсэн, бараа бүтээгдэхүүний форвард гэрээ хоорондох бараа бүтээгдэхүүний үнийн эрсдлийн хейжийн харилцаа ('нэгдүгээр түвшний харилцаа'). Энэхүү хейжийн харилцааг Тайлант үе 5-ын эцэс хүртэлх хугацаатайгаар Тайлант үе 1-ийн эцэст сонгосон. А хотын захиргаа бодитойгоор төлөх цахилгааны эрчим хүчний үнэ ба бенчмарк цахилгаан эрчим хүчний үнэ хоорондох зөрүү буюу суурийн тархалтын улмаас А хотын захиргаа нь 112,500 МВтЦ цахилгаан эрчим хүчийг хейжийн хэрэглүүр гэж, 118,421 МВтЦ цахилгаан эрчим хүчийг хейжийн зүйл гэж сонгосон.¹⁹
- (б) Хейжийн зүйл болох уг нэгтгэсэн эрсдэл өртөлт ба хейжийн хэрэглүүр болох гадаад валютын форвард гэрээ хоорондох гадаад валютын эрсдлийн хейжийн харилцаа ('хоёрдугаар түвшний харилцаа'). Энэхүү хейжийн харилцааг Тайлант үе 5-ын эцэс хүртэлх хугацаатайгаар Тайлант үе 2-ын эцэст сонгосон. Хейжийн зүйл гэж сонгосон уг нэгтгэсэн эрсдэл өртөлт нь дараах зүйлсийг илэрхийлдэг. Үүнд: бараа бүтээгдэхүүний үнийн эрсдлийн хейжийн харилцаанд сонгосон хоёр зүйлс болох, урьдчилан таамагласан цахилгаан эрчим хүчний худалдан авалт ба бараа бүтээгдэхүүний форвард гэрээний гадаад валютаарх нийт мөнгөн гүйлгээний хувьд валютын ханш нь Тайлант үе 2-ын эцэс дэх (өөрөөр хэлбэл, гадаад валютын эрсдлийн хейжийн харилцааны сонголтын хугацаа) форвард гадаад валютын ханштай харьцуулахад өөрчлөгдсөний үр дүн болох гадаад валютын ханшийн эрсдэл. Бодитойгоор төлөх цахилгааны эрчим хүчний үнэ ба бенчмарк цахилгаан эрчим хүчний үнэ хоорондох зөрүү буюу суурийн тархалтын талаархи А хотын захиргааны урт хугацааны хэтийн төлөв нь Тайлант үе 1-ийн эцсээс хойш өөрчлөгдөөгүй. Иймээс А хотын захиргааны байгуулсан хейжийн хэрэглүүрийн бодит гүйцэтгэлийн тоо хэмжээ (гадаад валютын форвард гэрээний нэрлэсэн дүн 140,625 ГВ) нь -5 хувь хэвээр байгаа уг суурийн тархалттай холбоотой мөнгөн гүйлгээний эрсдлийг

¹⁸ Энэ жишээний хувьд хейжийн нягтлан бодох бүртгэлийн бүх шалгуур хангагдсан гэж төсөөлсөн (УСНББОУС 41-ийн 129-р параграфыг үзнэ үү). Хейжийн сонголтын дараах тайлбар тодорхойлолт нь зөвхөн энэ жишээг ойлгомжтой болгох зорилготой билээ (өөрөөр хэлбэл, энэ нь УСНББОУС 41-ийн 129-р параграфтаар шаардсан албан ёсны цогц баримтжуулалтын жишээ биш юм).

¹⁹ Энэ жишээний хувьд хейжийн сонголтын хугацаан дахь одоогийн суурийн тархалт нь бодитойгоор хейж хийж буй цахилгаан эрчим хүчний худалдан авалтын тоо хэмжээг тодорхойлох уг А хотын захиргааны суурийн тархалтын урт хугацааны хэтийн төлөвтэй (-5 хувь) санамсаргүй тохиолдлоор ижил хэмжээтэй байна. Мөн А хотын захиргаа нь хейжийн хэрэглүүрийг бүхэлд нь сонгох ба өөрийн хамгийн өндөр магадлалтай урьдчилан таамагласан худалдан авалтанд аль болох их хэмжээгээр хейж хийхээр сонгоно гэж энэ жишээнд төсөөлсөн байна. Ингэснээр хейжийн харьцаа нь $\frac{1}{100}$ хувь⁻⁵ хувь болно. Өөр бусад байгууллагууд нь өөрийн бодитойгоор хейж хийж буй эрсдлийн тоо хэмжээг тодорхойлохдоо өөр арга хандлагыг ашиглаж болох бөгөөд ингэснээр хейжийн өөр харьцаатай болох ба хейжийн хэрэглүүрийн нийт хэмжээнээс арай бага хэсгийг сонгох юм (УСНББОУС 41-ийн 129-р параграфыг үзнэ үү).

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

тусгадаг. Гэхдээ А хотын захиргааны бодит гүйцэтгэлээрх нэгтгэсэн эрсдэл өртөлтөнд тухайн суурийн тархалтын өөрчлөлт нөлөөлдөг. Суурийн тархалт нь Тайлант үе 2-д -5 хувиас, -5.5 хувь болж өөрчлөгдсөн учраас А хотын захиргааны бодит гүйцэтгэлээрх нэгтгэсэн эрсдэл өртөлт нь Тайлант үе 2-ын эцэст 140,027ГВ байна.

ҮЖ120. Үүсмэл хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнэ, хейжийн зүйлсийн үнэ цэнийн өөрчлөлтүүд, мөнгөн гүйлгээний хейжийн нөөцийн болон хейжийн үр дүнгүй байдлын тооцооллыг дараах хүснэгтэнд харуулав:²⁰

Жишээ 16—Тооцоолол		Тайлант үе	1	2	3	4	5
Бараа бүтээгдэхүүний үнийн эрсдлийн хейжийн харилцаа (Нэгдүгээр түвшний харилцаа)							
<i>Цахилгаан эрчим хүчний форвард худалдан авалтын гэрээ</i>							
Тоо хэмжээ (МВтЦ)	112,500						
Форвард үнэ [ГВ/МВтЦ]	1.25	Үнэ (форвард) [ГВ/МВтЦ]	1.25	1.01	1.43	1.22	2.15
		Бодит үнэ цэнэ [ГВ]	0	(26,943)	20,219	(3,373)	101,250
		Бодит үнэ цэнэ [ОНВ]	0	(20,258)	14,339	(2,310)	70,804
		Бодит үнэ цэнийн өөрчлөлт [ОНВ]		(20,258)	34,598	(16,650)	73,114
<i>Хейж хийсэн урьдчилан таамагласан цахилгаан эрчим хүчний худалдан авалт</i>							
Хейжийн харьцаа	105.26%	Суурийн тархалт	-5.00%	-5.50%	-6.00%	-3.40%	-7.00%
Хейж хийсэн тоо хэмжээ	118,421	Үнэ (форвард) [ГВ/МВтЦ]	1.19	0.95	1.34	1.18	2.00
Төсөөлсөн форвард үнэ	1.1875	Өнөөгийн үнэ цэнэ [ГВ]	0	27,540	(18,528)	1,063	(96,158)
		Өнөөгийн үнэ цэнэ [ОНВ]	0	20,707	(13,140)	728	(67,243)
		Өнөөгийн үнэ цэнийн өөрчлөлт [ОНВ]		20,707	(33,847)	13,868	(67,971)
<i>Нягтлан бодох бүртгэл</i>			<i>ОНВ</i>	<i>ОНВ</i>	<i>ОНВ</i>	<i>ОНВ</i>	<i>ОНВ</i>
Үүсмэл хэрэглүүр			0	(20,258)	14,339	(2,310)	70,804
Мөнгөн гүйлгээний хейжийн нөөц			0	(20,258)	13,140	(728)	67,243
Мөнгөн гүйлгээний хейжийн нөөцийн өөрчлөлт				(20,258)	33,399	(13,868)	67,971
Ашиг, алдагдал				0	1,199	(2,781)	5,143
Хуримтлагдсан ашиг, алдагдал			0	0	1,199	(1,582)	3,561
Гадаад валютын эрсдлийн хейжийн харилцаа (Хоёрдугаар түвшний харилцаа)							
Гадаад валютын ханш [ГВ/ОНВ]		Спот	1.3800	1.3300	1.4100	1.4600	1.4300
		Форвард	1.3683	1.3220	1.4058	1.4571	1.4300

²⁰ Тооцооллын дараах хүснэгтэнд бүх дүнгүүдийг (үүн дотроо, хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч, ашиг, алдагдлын дүнгүүдийн нягтлан бодох бүртгэлийн зорилго бүхий тооцооллыг) эерэг (нэмэх) ба сөрөг (тоо) тоогоор илэрхийлсэн (жишээлбэл; ашиг, алдагдлын дүнгийн хувьд сөрөг тоо нь алдагдал гэсэн утгатай байна).

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Жишээ 16—Тооцоолол		Тайлант үе	1	2	3	4	5
<i>Гадаад валютын форвард гэрээ (ГВ худлдан авах/ОНВ-ыг борлуулах)</i>							
Тоо хэмжээ [ГВ]	140,625						
Форвард ханш (Тайлант үе 2)	1.3220	Бодит үнэ цэнэ [ОНВ]		0	(6,313)	(9,840)	(8,035)
		Бодит үнэ цэнийн өөрчлөлт [ОНВ]			(6,313)	(3,528)	1,805
<i>Хейж хийсэн гадаад валютын эрсдэл</i>							
Гадаад валютын нэгтгэсэн эрсдэл өртөлт	Хейж хийсэн тоо хэмжээ [ГВ]		140,027	138,932	142,937	135,533	
	Өнөөгийн үнэ цэнэ [ОНВ]		0	6,237	10,002	7,744	
	Өнөөгийн үнэ цэнийн өөрчлөлт [ОНВ]			6,237	3,765	(2,258)	
<i>Нягтлан бодох бүртгэл</i>			<i>ОНВ</i>	<i>ОНВ</i>	<i>ОНВ</i>	<i>ОНВ</i>	
Үүсмэл хэрэглүүр			0	(6,313)	(9,840)	(8,035)	
Мөнгөн гүйлгээний хейжийн нөөц			0	(6,237)	(9,840)	(7,744)	
Мөнгөн гүйлгээний хейжийн нөөцийн өөрчлөлт				(6,237)	(3,604)	2,096	
Ашиг, алдагдал					(76)	76	(291)
Хуримтлагдсан ашиг, алдагдал			0	(76)	0	(291)	

ҮЖ121. Бараа бүтээгдэхүүний үнийн эрсдлийн хейжийн харилцаа нь Тайлант үе 1-ийн эцэст эхлэх, хэрэгжих өндөр магадлалтай урьдчилан таамагласан ажил гүйлгээний мөнгөн гүйлгээний хейж бөгөөд Тайлант үе 2-ын эцэст гадаад валютын эрсдлийн хейжийн харилцаа эхлэх хүртэл үйлчилсэн хэвээр байна, өөрөөр хэлбэл нэгдүгээр түвшний харилцаа нь тусдаа хейжийн харилцаа байдлаар үргэлжилнэ.

ҮЖ122. Гадаад валютын эрсдлийн хейжийн харилцааны уг хейж хийсэн тоо хэмжээ болох гадаад валютын нэгтгэсэн эрсдэл өртөлтийн тоо хэмжээ (ГВ-аар) нь дараах зүйлсийн нийлбэр байна:²¹

- (а) Хейж хийсэн цахилгаан эрчим хүчний худалдан авалтын тоо хэмжээг одоогийн форвард үнээр үржүүлсэн дүн (энэ нь цахилгаан эрчим хүчний бодит гүйцэтгэлийн худалдан авалтын хүлээгдэж буй спот үнийг илэрхийлдэг); ба
- (б) Хейжийн хэрэглүүрийн тоо хэмжээг (сонгосон нэрлэсэн дүнг) форвард гэрээний хүү ба одоогийн форвард хүү хоёрын хоорондох зөрүүгээр үржүүлсэн дүн (энэ нь бараа бүтээгдэхүүний форвард гэрээний дагуу А хотын захиргааны хүлээн авах буюу төлөх дүн ба ГВ-аар илэрхийлэгдсэн цахилгаан эрчим хүчний бенчмарк үнэ хоорондох хүлээгдэж буй үнийн зөрүүг харуулна).

ҮЖ123. Хэмжилтийн өдрөөрх форвард гадаад валютын ханш ба тухайн хейжийн харилцааг сонгосон өдрөөрх (өөрөөр хэлбэл, Тайлант үе 2-ын эцэс дэх) форвард гадаад валютын ханш хоорондох зөрүүгээр уг хейж хийсэн тоо хэмжээг (ГВ-аар) үржүүлснээр тэрхүү гадаад валютын эрсдлийн хейжийн

²¹ Энэ жишээний хувьд Тайлант үе 3-ын эцэст гадаад валютын нэгтгэсэн эрсдэл өртөлтийг дараах байдлаар тодорхойлно: цахилгаан эрчим хүчний бодит гүйцэтгэлийн худалдан авалтын хүлээгдэж буй үнэ $118,421 \text{ МВтЦ} \times 1.34 \text{ ГВ/МВтЦ} = 159,182 \text{ ГВ}$ ба бараа бүтээгдэхүүний форвард гэрээний дагуу хүлээгдэж буй үнийн зөрүү $112,500 \text{ МВтЦ} \times (1.25 \text{ ГВ/МВтЦ} - 1.43 \text{ ГВ/МВтЦ}) = (20,250) \text{ ГВ}$, иймээс Тайлант үе 3-ын эцэс дэх гадаад валютын нэгтгэсэн эрсдэл өртөлтийн тоо хэмжээ нь эдгээрийн нийлбэр буюу $138,932 \text{ ГВ}$ болно.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

харилцааны (өөрөөр хэлбэл, нэгтгэсэн эрсдэл өртөлт) хувьд хейжийн зүйлийн өнөөгийн үнэ цэнийг (ОНВ-аар) тооцоолдог.²²

ҮЖ124. Хейжийн зүйлийн өнөөгийн үнэ цэнэ ба хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг ашигласнаар мөнгөн гүйлгээний хейжийн нөөц болон хейжийн үр дүнгүй байдлыг тодорхойлдог (УСНББОУС 41-ийн 140-р параграф).

ҮЖ125. А хотын захиргааны санхүүгийн үр дүнгийн болон санхүүгийн байдлын тайланд үзүүлэх үр нөлөөг дараах хүснэгтэнд харуулав (ойлгомжтой болгох үүднээс, бараа бүтээгдэхүүний үнийн эрсдлийн хейжийн харилцаа ба гадаад валютын эрсдлийн хейжийн харилцаа гэсэн уг хоёр хейжийн харилцаагаар мөрийн зүйлсийг²³ санхүүгийн байдлын тайланд задлан харуулдаг).

Жишээ 16—Санхүүгийн үр дүнгийн болон санхүүгийн байдлын тайланд үзүүлэх үр нөлөөний тойм <i>[Бүх дүнгүүд ОНВ-аар]</i>						
	Тайлант үе	1	2	3	4	5
Санхүүгийн үр дүнгийн тайлан						
Хейжийн үр дүнгүй байдал						
Бараа бүтээгдэхүүний хейж			0	(1,199)	2,781	(5,143)
Гадаад валютын хейж			0	76	(76)	291
Ашиг, алдагдал		0	0	(1,123)	2,705	(4,852)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан						
Цэвэр хөрөнгө/өмч						
Бараа бүтээгдэхүүний хейж			20,258	(33,399)	13,868	(67,971)
Гадаад валютын хейж			0	6,237	3,604	(2,096)
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн		0	20,258	(27,162)	17,472	(70,067)
Санхүүгийн байдлын тайлан						
Бараа бүтээгдэхүүний хейж						
Бараа бүтээгдэхүүний хейж		0	(20,258)	14,339	(2,310)	70,804
Гадаад валютын форвард			0	(6,313)	(9,840)	(8,035)
Цэвэр хөрөнгийн дүн		0	(20,258)	8,027	(12,150)	62,769
<i>Цэвэр хөрөнгө/өмч</i>						
Цэвэр хөрөнгө/өмч						
Бараа бүтээгдэхүүний хейж		0	20,258	(13,140)	728	(67,243)
Гадаад валютын хейж			0	6,237	9,840	7,744
		0	20,258	(6,904)	10,568	(59,499)
Хуримтлагдсан ашиг, алдагдал						
Бараа бүтээгдэхүүний хейж		0	0	(1,199)	1,582	(3,561)
Гадаад валютын хейж			0	76	0	291
		0	0	(1,123)	1,582	(3,270)
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн		0	20,258	(8,027)	12,150	(62,769)

²² Тайлант үе 3-ын эцсийг жишээ болгон авч үзвэл: Тайлант үе 3-ын эцэс дэх форвард гадаад валютын ханш ^(1/1.4058) ба тухайн хейжийн харилцааг сонгосон өдрөөрх форвард гадаад валютын ханш хоорондох (өөрөөр хэлбэл, Тайлант үе 2-ын эцэс: ^{1/1.3220}) зөрүүгээр Тайлант үе 3-ын эцэс дэх уг нэгтгэсэн эрсдэл өртөлтийн тоо хэмжээг (138,932ГВ) үржүүлж, дараа нь Тайлант үе 3-ын эцэс дэх хүүний хувийг (ОНВ-аар) ашиглан хоёр тайлант үеийн хугацаагаар (өөрөөр хэлбэл, Тайлант үе 5-ын эцэс хүртэлх 0.46 хувиар) тооцож, дискаунтчилснаар хейжийн зүйлийн өнөөгийн үнэ цэнийг тодорхойлдог. Тооцоолол нь: $138,932ГВ \times (1/(1.4058(ГВ/ОНВ)) - 1/(1.3220(ГВ/ОНВ))) \times (1 + 0.46 \text{ хувь}) = 6,237 \text{ ОНВ}$.

²³ Энэ жишээнд ашигласан мөрийн зүйлс нь боломжит толилуулга юм. Мөн үүнээс өөр мөрийн зүйлсийг (энд харуулсан дүнгүүдийг агуулсан мөрийн зүйлсээс гадна) ашигласан толилуулгын янз бүрийн хэлбэр загвартай байж болно. (Хейжийн нягтлан бодох бүртгэлийн тодруулгын шаардлагуудыг УСНББОУС 30-д заасан байдаг. Үүнд: хейжийн үр дүнгүй байдал, хейжийн хэрэглүүрийн дансны үнэ, мөнгөн гүйлгээний хейжийн нөөцийн талаархи тодруулга хамаарна).

Жишээ 16—Санхүүгийн үр дүнгийн болон санхүүгийн байдлын тайланд үзүүлэх үр нөлөөний тойм <i>[Бүх дүнгүүд ОНВ-аар]</i>					
Тайлант үе	1	2	3	4	5

ҮЖ126. Хейжийн дараах, бараа материалын нийт өртөг дараах байдалтай байна:²⁴

<i>Бараа материалын өртөг [Бүх дүн ОНВ-аар]</i>	
Мөнгөн үнэ (бараа бүтээгдэхүүний үнийн эрсдэл болон гадаад валютын эрсдлийн хувьд)	165,582
Бараа бүтээгдэхүүний үнийн эрсдлийн хувьд МГХН-өөс үүсэх олз/гарз	(67,243)
Гадаад валютын эрсдлийн хувьд МГХН-өөс үүсэх олз/гарз	7,744
Бараа материалын өртөг	<u>106,083</u>

ҮЖ127. Бүх ажил гүйлгээнээс үүсэн ерөнхий мөнгөн гүйлгээний нийт дүн (spot үнээрх цахилгаан эрчим хүчний бодит гүйцэтгэлийн худалдан авалт ба хоёр үүсмэл хэрэглүүрийн барагдуулалт) нь 102,813 ОНВ байна. Энэ нь хоёр хейжийн харилцаанаас үүссэн хейжийн хуримтлагдсан үр дүнгүй байдлын цэвэр дүн болох 3,270 ТН-ээр хейжийн залруулга хийгдсэн бараа материалын өртгөөс өөр дүнтэй байна. Энэхүү хейжийн үр дүнгүй байдал нь мөнгөн гүйлгээний хувьд үр нөлөөтэй боловч уг бараа материалын хэмжилтэнд тусган оруулаагүй.

Жишээ 17—Хүүний түвшний эрсдэл ба Гадаад валютын эрсдлийн нэгдсэн хейж (Бодит үнэ цэнийн хейж/Мөнгөн гүйлгээний хейжийн хослол)

Өгөгдөл

ҮЖ128. Б мужийн засгийн газар нь гадаад валют (ГВ)-аар илэрхийлэгдсэн, тогтмол хүүтэй өр төлбөрт хейж хийхийг хүссэн. Уг өр төлбөр нь Тайлант үе 1-ийн эхнээс Тайлант үе 4-ийн эцэс хүртэлх дөрвөн тайлант үеийн хугацаатай. Б мужийн засгийн газрын бүртгэлийн валют нь түүний орон нутгийн валют (ОНВ) юм. Б мужийн засгийн газар нь дараах эрсдэл өртөлттэй байна:

- Бодит үнэ цэнийн хүүний түвшний эрсдэл ба гадаад валютын эрсдэл: хүүний түвшний өөрчлөлтөнд хамааруулж болох уг тогтмол хүүтэй өр төлбөрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ОНВ-аар хэмжсэн.
- Мөнгөн гүйлгээний хүүний түвшний эрсдэл: ГВ-аар илэрхийлэгдсэн тогтмол хүүтэй өр төлбөрийн талаархи Б мужийн засгийн газрын эрсдлийн удирдлагын стратегийн (доорх ҮЖ129(а) параграфыг үзнэ үү) дагуу уг тогтмол хүүтэй өр төлбөртэй холбоотой бодит үнэ цэнийн хүүний түвшний болон гадаад валютын (дээрх (а) заалтыг үзнэ үү) нийт эрсдлийг ОНВ-аар илэрхийлэгдсэн хувьсах хүүтэй эрсдэлд своп хийсний үр дүнд үүсэх эрсдэл.

ҮЖ129. Б мужийн засгийн газар нь дараах эрсдлийн удирдлагын стратегийг ашигласнаар өөрийн эрсдэл өртөлтөнд хейж хийдэг:

- Б мужийн засгийн газар нь өөрийн ГВ-аар илэрхийлэгдсэн, тогтмол хүүтэй өр төлбөрийг ОНВ-аар илэрхийлэгдсэн хувьсах хүүний эрсдэл болгон своп хийхийн тулд валют-хоорондын хүүний түвшний свопыг ашигладаг. Б мужийн засгийн газар нь өөрийн ГВ-аар илэрхийлэгдсэн, өр төлбөрийн (үүн дотроо, хүүний) хувьд түүний нийт хугацаагаар хейж хийдэг. Иймээс ГВ-аар илэрхийлэгдсэн өр төлбөрийг гаргасан хугацаатай ижил хугацаанд Б мужийн засгийн газар нь валют-хоорондын хүүний түвшний свопын хэлцлийг хийдэг. Валют-хоорондын хүүний түвшний свопын дагуу Б мужийн засгийн газар нь (өр төлбөрийн хүүг төлдөг байсан) ГВ-аар тогтмол хүүг хүлээн авч, ОНВ-аар хувьсах хүү төлөх юм.

²⁴ 'МГХН' нь мөнгөн гүйлгээний хейжийн нөөц гэсэн үг, өөрөөр хэлбэл мөнгөн гүйлгээний хейжийн хувьд цэвэр хөрөнгө/өмчид хуримтлагдсан дүн юм.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

- (б) Хейж хийсэн өр төлбөрийн болон холбогдох валют-хоорондын хүүний түвшний свопын мөнгөн гүйлгээг Б мужийн засгийн газар нь ОНВ-аар илэрхийлэгдсэн, нэгтгэсэн нэг хувьсах хүүний эрсдэл байдлаар авч үздэг. Хувьсах хүүтэй, хүүний түвшний эрсдлийн (ОНВ-аарх) талаархи өөрийн эрсдлийн удирдлагын стратегийн дагуу Б мужийн засгийн газар нь хүүний төлбөрийг цаг хугацааны явцад тогтмол байлгах ба үүний тулд уг ОНВ-аар илэрхийлэгдсэн, нэгтгэсэн хувьсах хүүний эрсдлийг ОНВ-аар илэрхийлэгдсэн тогтмол хүүтэй эрсдэл болгон своп хийхээр шийдвэрлэсэн. Иймээс тогтмол хүүтэй эрсдэл болгон Б мужийн засгийн газар нь нэгтгэсэн нэг купоны тогтмол хүүтэй (өөрөөр хэлбэл, хейжийн харилцааны эхэнд оршин байх ба хейж хийсэн хугацаанд хамаарах форвард купоны ерөнхий хүүтэй) болгохыг хүссэн.²⁵ Ингэснээр Б мужийн засгийн газар нь (бүхэлдээ ОНВ-аар илэрхийлэгдсэн) хүүний түвшний свопыг ашигласан бөгөөд үүний дагуу (валют-хоорондын хүүний түвшний свопын тэрхүү төлөх хэсгийн хувьд хүүг тооцож төлдөг байсан) хувьсах хүүг хүлээн авах ба тогтмол хүүг төлнө.

ҮЖ130. Жишээ 17-д ашигласан үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэнд харуулав:

Жишээ 17—Үзүүлэлтүүд					
	t₀	Тайлант үе 1	Тайлант үе 2	Тайлант үе 3	Тайлант үе 4
Гадаад валютын спот ханш [ОНВ/ГВ]	1.2000	1.0500	1.4200	1.5100	1.3700
Хүүний муруй (жилийн сууриар улирал бүрийн хүүний түвшинг босоо чиглэлээр толилуулсан)					
ОНВ	2.50%	5.02%	6.18%	0.34%	[Х/гүй]
	2.75%	5.19%	6.26%	0.49%	
	2.91%	5.47%	6.37%	0.94%	
	3.02%	5.52%	6.56%	1.36%	
	2.98%	5.81%	6.74%		
	3.05%	5.85%	6.93%		
	3.11%	5.91%	7.19%		
	3.15%	6.06%	7.53%		
	3.11%	6.20%			
	3.14%	6.31%			
	3.27%	6.36%			
	3.21%	6.40%			
	3.21%				
	3.25%				
	3.29%				
	3.34%				
ГВ	3.74%	4.49%	2.82%	0.70%	[Х/гүй]

²⁵ Байгууллага нь нэгтгэсэн нэг хүүтэй биш боловч тус тусын харгалзах хүүний тайлант үеийн хувьд тогтмол байх хэд хэдэн форвард хүүний хувь бүхий тогтмол хүүний эрсдэл өртөлтэй болохын тулд эрсдлийн удирдлагын өөр стратегийг ашиглаж болох юм. Ийм стратегийн хувьд тухайн хейжийн харилцааны эхэнд оршин байсан форвард хүү ба тус тусын хүүний тайлант үеүдийн үр ашигт байдлыг хэмжих өдрөөр оршин байх форвард хүү хоорондох зөрүүд үндэслэн хейжийн үр дүнтэй байдлыг хэмждэг. Уг стратегийн хувьд тус тусын хүүний тайланд үеүдэд харгалзах хэд хэдэн форвард гэрээ нь хүүний түвшний свопоос (нэгтгэсэн нэг тогтмол хүүтэй свопын хувьд тогтмол төлбөр бүхий хэсгээс) илүү үр дүнтэй байдаг.

Жишээ 17—Үзүүлэлтүүд				
t_0	Тайлант үе 1	Тайлант үе 2	Тайлант үе 3	Тайлант үе 4
4.04%	4.61%	2.24%	0.79%	
4.23%	4.63%	2.00%	1.14%	
4.28%	4.34%	2.18%	1.56%	
4.20%	4.21%	2.34%		
4.17%	4.13%	2.53%		
4.27%	4.07%	2.82%		
4.14%	4.09%	3.13%		
4.10%	4.17%			
4.11%	4.13%			
4.11%	4.24%			
4.13%	4.34%			
4.14%				
4.06%				
4.12%				
4.19%				

Нягтлан бодох бүртгэлийн арга механизм

ҮЖ131. Б мужийн засгийн газар нь дараах хейжийн харилцааг сонгосон:²⁶

- (а) Хейжийн зүйл болох ГВ-аар илэрхийлэгдсэн тогтмол хүүтэй өр төлбөр (тогтмол хүүтэй ГВ-ын өр төлбөр) ба хейжийн хэрэглүүр болох валют-хоорондын хүүний түвшний своп хоорондох бодит үнэ цэнийн хүүний түвшний эрсдэл болон гадаад валютын эрсдлийн хейжийн харилцааг бодит үнэ цэнийн хейж гэж сонгох ('нэгдүгээр түвшний харилцаа'). Энэхүү хейжийн харилцааг Тайлант үе 4-ийн эцэс хүртэлх хугацаатайгаар Тайлант үе 1-ийн эхэнд (өөрөөр хэлбэл, t_0 -д) сонгосон.
- (б) Хейжийн зүйл болох уг нэгтгэсэн эрсдэл өртөлт ба хейжийн хэрэглүүр болох хүүний түвшний своп хоорондох хейжийн харилцааг мөнгөн гүйлгээний хейж гэж сонгох ('хоёрдугаар түвшний харилцаа'). Б мужийн засгийн газар нь өөрийн хүүний төлбөрүүдийг тогтмол байлгах ба үүний тулд тэрхүү ОНВ-аар илэрхийлэгдсэн, нэгтгэсэн хувьсах хүүний эрсдлийг ОНВ-аар илэрхийлэгдсэн тогтмол хүүтэй эрсдэл болгон своп хийхээр шийдвэрлэсэн үед буюу Тайлант үе 1-ийн эцэст энэхүү хейжийн харилцааг сонгосон ба Тайлант үе 4-ийн эцэс хүртэлх хугацаатай байна. Хейжийн зүйл гэж сонгосон уг нэгтгэсэн эрсдэл өртөлт нь дараах зүйлсийг ОНВ-аар илэрхийлдэг. Үүнд: бодит үнэ цэнийн хейжид сонгосон бодит үнэ цэнийн хүүний түвшний эрсдэл ба гадаад валютын эрсдэл (дээрх (а) заалтыг үзнэ үү) гэсэн хоёр зүйлсийн нийт мөнгөн гүйлгээний хувьд хүүний түвшин нь Тайлант үе 1-ийн эцэс дэх (өөрөөр хэлбэл, уг нэгтгэсэн эрсдэл өртөлт ба хүүний түвшний свопын хоорондох хейжийн харилцааны сонголтын хугацаа) хүүний түвшинтэй харьцуулахад өөрчлөгдсөний үр дүн болох мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлт.

²⁶ Энэ жишээний хувьд хейжийн нягтлан бодох бүртгэлийн бүх шалгуур хангагдсан гэж төсөөлсөн (УСНББОУС 41-ийн 129-р параграфыг үзнэ үү). Хейжийн сонголтын дараах тайлбар тодорхойлолт нь зөвхөн энэ жишээг ойлгомжтой болгох зорилготой билээ (өөрөөр хэлбэл, энэ нь УСНББОУС 41-ийн 129-р параграфтаар шаардсан албан ёсны цогц баримтжуулалтын жишээ биш юм).

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

ҮЖ132. Үүсмэл хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнэ, хейжийн зүйлсийн үнэ цэнийн өөрчлөлтүүд, мөнгөн гүйлгээний хейжийн нөөцийн болон хейжийн үр дүнгүй байдлын тооцооллыг дараах хүснэгтэнд²⁷ харуулав.²⁸ Энэ жишээний хувьд хейжийн үр дүнгүй байдал нь хоёр хейжийн харилцааны аль алины хувьд үүссэн байна.²⁹

Жишээ 17—Тооцоолол	t₀	Тайлант үе 1	Тайлант үе 2	Тайлант үе 3	Тайлант үе 4
Тогтмол хүүтэй ГВ-ын өр төлбөр					
Бодит үнэ цэнэ [ГВ]	(1,000,000)	(995,522)	(1,031,008)	(1,030,193)	(1,000,000)
Бодит үнэ цэнэ [ОНВ]	(1,200,000)	(1,045,298)	(1,464,031)	(1,555,591)	(1,370,000)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт [ОНВ]		154,702	(418,733)	(91,560)	185,591
ВХХТС (тогтмол ГВ хүлээн авах/хувьсах ОНВ төлөх)					
Бодит үнэ цэнэ [ОНВ]	0	(154,673)	264,116	355,553	170,000
Бодит үнэ цэнийн өөрчлөлт [ОНВ]		(154,673)	418,788	91,437	(185,553)
ХТС (хувьсах дүнг хүлээн авах/тогтмол дүнг төлөх)					
Бодит үнэ цэнэ [ОНВ]		0	18,896	(58,767)	0
Бодит үнэ цэнийн өөрчлөлт [ОНВ]			18,896	(77,663)	(58,767)
Уг нэгтгэсэн эрсдэл өртөлтийн МГ-ийн хувьсан өөрчлөлт					
Өнөөгийн үнэ цэнэ [ОНВ]		0	(18,824)	58,753	0
Өнөөгийн үнэ цэнийн өөрчлөлт [ОНВ]			(18,824)	77,577	(58,753)
МГХН					
Үлдэгдэл (тайлант үеийн эцэс) [ОНВ]		0	18,824	(58,753)	0
Өөрчлөлт [ОНВ]			18,824	(77,577)	58,753

ҮЖ133. Тогтмол хүүтэй ГВ-ын өр төлбөр ба валют-хоорондын хүүний түвшний свопын хоорондох хейжийн харилцаа нь Тайлант үе 1-ийн эхнээс (өөрөөр хэлбэл, t₀) эхлэх бөгөөд хоёрдугаар түвшний харилцааны хувьд хейжийн харилцаа Тайлант үе 1-ийн эцэст эхлэх хүртэл үйлчилсэн хэвээр байна, өөрөөр хэлбэл нэгдүгээр түвшний харилцаа нь тусдаа хейжийн харилцаа байдлаар үргэлжилнэ.

²⁷ Энэ жишээний хүснэгтүүдэд дараах товчилсон үгсийг ашигласан болно: 'ВХХТС'-Валют-хоорондын хүүний түвшний своп, 'МГ'-мөнгөн гүйлгээ, 'МГХ'-мөнгөн гүйлгээний хейж, 'МГХН'-мөнгөн гүйлгээний хейжийн нөөц, 'БҮЦХ'-бодит үнэ цэнийн хейж, 'ХТС'-хүүний түвшний своп, 'ӨҮЦ'-өнөөгийн үнэ цэнэ.

²⁸ Тооцооллын дараах хүснэгтэнд бүх дүнгүүдийг (үүн дотроо, хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүнгүүдийн нягтлан бодох бүртгэлийн зорилго бүхий тооцооллыг) эерэг (нэмэх) ба сөрөг (тоо) тоогоор илэрхийлсэн (жишээлбэл; мөнгөн гүйлгээний хейжийн нөөцийн хувьд хаалтан дотор тусгасан тоо нь гарз гэсэн утгатай байна).

²⁹ Энэ жишээнд дурдсантай адил гэх мэт нөхцөл байдалд хейжийн үр дүнгүй байдал нь янз бүрийн хүчин зүйлсээс үүсэж болох юм. Жишээлбэл; зээлийн эрсдэл, хоног тоолох аргын ялгаатай байдал, хейжийн хэрэглүүрийн сонголтонд оруулсан эсэхээс хамааран валют-хоорондын хүүний түвшний свопод оруулсан өөр өөр валютын арилжааны зардал (ихэвчлэн 'валютын суурь' гэж нэрлэдэг).

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

ҮЖ134. Уг нэгтгэсэн эрсдэл өртөлтийн мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлтийг дараах байдлаар тооцоолно:

- (a) Уг нэгтгэсэн эрсдэл өртөлтийн мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлтөд хейж хийж эхлэх үед (өөрөөр хэлбэл, Тайлант үе 1-ийн эцэс дэх хоёрдугаар түвшний харилцааны эхэнд) тэдгээр тогтмол хүүтэй ГВ-ын өр төлбөр ба валют-хоорондын хүүний түвшний свопоос тухайн хейжийн хугацаанд (өөрөөр хэлбэл, Тайлант үе 4-ийн эцэс хүртэл) хүлээгдэж буй бүх мөнгөн гүйлгээг төлөвлөн гаргаж, нийт өнөөгийн үнэ цэнийг (ОНВ-аар) тэг байлгах нэгтгэсэн нэг купоны тогтмол хүүгээр тэнцүүлж тооцно. Энэ тооцоолол нь уг нэгтгэсэн эрсдэл өртөлтийн мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлтийг тухайн хейжийн харилцааны эхлэлээс хойш хэмжихдээ лавлагаа цэг болгон дараагийн тайлант үеүдэд ашиглах тэрхүү нэгтгэсэн нэг купоны тогтмол хүүг (лавлагаа болгох хүүний хувийг) тогтоох юм. Тооцооллыг дараах хүснэгтэнд үлгэрчлэн харуулав:

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Жишээ 17—Нэгтгэсэн эрсдэл өртөлтийн мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлт (Туршилт)									
Нэгтгэсэн эрсдэл өртөлтийн мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлт									
	ГВ-ын өр төлбөр		ВХХТС-ГВ-ын хэсэг		ВХХТС-ОНВ-ын хэсэг		Турших дүн	ӨҮЦ	
	МГ	ӨҮЦ	МГ	ӨҮЦ	МГ	ӨҮЦ	Нэрлэсэн дүн 1,200,000, хүү 5.6963 хувь, давтамж 4		
	[ГВ]	[ГВ]	[ГВ]	[ГВ]	[ОНВ]	[ОНВ]	[ОНВ]	[ОНВ]	
Хугацаа									
Тайлант үе 1	t ₀								
	t ₁								
	t ₂								
	t ₃								
	t ₄								
Тайлант үе 2	t ₅	0	0	0	0	(14,771)	(14,591)	17,089	16,881
	t ₆	(20,426)	(19,977)	20,246	19,801	(15,271)	(14,896)	17,089	16,669
	t ₇	0	0	0	0	(16,076)	(15,473)	17,089	16,449
	t ₈	(20,426)	(19,543)	20,582	19,692	(16,241)	(15,424)	17,089	16,229
Тайлант үе 3	t ₉	0	0	0	0	(17,060)	(15,974)	17,089	16,002
	t ₁₀	(20,426)	(19,148)	20,358	19,084	(17,182)	(15,862)	17,089	15,776
	t ₁₁	0	0	0	0	(17,359)	(15,797)	17,089	15,551
	t ₁₂	(20,426)	(18,769)	20,582	18,912	(17,778)	(15,942)	17,089	15,324
Тайлант үе 4	t ₁₃	0	0	0	0	(18,188)	(16,066)	17,089	15,095
	t ₁₄	(20,426)	(18,391)	20,246	18,229	(18,502)	(16,095)	17,089	14,866
	t ₁₅	0	0	0	0	(18,646)	(15,972)	17,089	14,638
	t ₁₆	(1,020,426)	(899,695)	1,020,582	899,832	(1,218,767)	(1,027,908)	1,217,089	1,026,493
Нийт дүн		(995,522)		995,550		(1,200,000)			1,199,971
Нийт дүн-ОНВ-аар		(1,045,298)		1,045,327		(1,200,000)			1,199,971

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Жишээ 17—Нэгтгэсэн эрсдэл өртөлтийн мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлт (Туршилт)							
Нэгтгэсэн эрсдэл өртөлтийн мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлт							
ГВ-ын өр төлбөр		ВХХТС-ГВ-ын хэсэг		ВХХТС-ОНВ-ын хэсэг		Турших дүн	ӨҮЦ
МГ	ӨҮЦ	МГ	ӨҮЦ	МГ	ӨҮЦ	Нэрлэсэн дүн 1,200,000, хүү 5.6963 хувь, давтамж 4	
[ГВ]	[ГВ]	[ГВ]	[ГВ]	[ОНВ]	[ОНВ]	[ОНВ]	[ОНВ]
Бүх МГ-ний ӨҮЦ [ОНВ]		<div style="border: 1px solid black; width: 100%; height: 20px; margin-bottom: 5px;"></div> <div style="display: flex; justify-content: space-between; align-items: center;"> 0 ← Σ </div>					

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Лавлагаа хувь хэмжээний туршилтанд ашигласан нэрлэсэн дүн нь ОНВ-аар хувьсах мөнгөн гүйлгээ (1,200,000ОНВ) үүсгэх уг нэгтгэсэн эрсдэл өртөлтийн нэрлэсэн дүнтэй ижил байна. Энэ нь хувьсах хүүний хэсэгт хамаарах тэрхүү валют-хоорондын хүүний түвшний свопын ОНВ-аарх нэрлэсэн дүнтэй дүйцнэ. Үүний үр дүнд лавлагаа хувь хэмжээ нь 5.6963 хувь болно (бүх мөнгөн гүйлгээний нийт өнөөгийн үнэ цэнийг тэг болгох давтамжаар тодорхойлогдоно).

- (6) Тайлант үе 1-ийн эцэст тогтоосон, лавлагаа цэгтэй харьцуулснаар уг нэгтгэсэн эрсдэл өртөлтийн мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлтүүдийг дараагийн тайлант үеүдэд тодорхойлдог. Тогтмол хүүтэй ГВ-ын өр төлбөр болон валют-хоорондын хүүний түвшний свопын хувьд уг хейжийн үлдсэн хугацаанд (өөрөөр хэлбэл, үр дүнтэй байдлын хэмжилтийн өдрөөс Тайлант үе 4-ийн эцэс хүртэл) хүлээгдэж буй үлдэгдэл бүх мөнгөн гүйлгээг энэхүү зорилгоор (хэрэв шаардлагатай бол) шинэчлэн баяжуулж, дараа нь дискаунтчилна. Хейжийн үлдсэн хугацаанд цуврал мөнгөн гүйлгээг үүсгэж, дараа нь мөн дискаунтчлахын тулд Тайлант үе 1-ийн эцэс дэх хүүний хувь хэмжээний туршилтанд ашигласан, нэрлэсэн дүнг (1,200,000ОНВ) уг 5.6969 хувийн лавлагаа хувь хэмжээгээр үржүүлнэ. Эдгээр бүх өнөөгийн үнэ цэнүүдийн нийт дүн нь уг нэгтгэсэн эрсдэл өртөлтийн мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлтийг илэрхийлдэг. Тайлант үе 2-ын эцэс дэх энэхүү тооцооллыг дараах хүснэгтэнд үлгэрчлэн харуулав.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Жишээ 17—Нэгтгэсэн эрсдэл өртөлтийн мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлт (Тайлант үе 2-ын эцэст)									
Нэгтгэсэн эрсдэл өртөлтийн мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлт									
	ГВ-ын өр төлбөр		ВХХТС-ГВ-ын хэсэг		ВХХТС-ОНВ-ын хэсэг		Турших дүн	ӨҮЦ	
	МГ	ӨҮЦ	МГ	ӨҮЦ	МГ	ӨҮЦ	Нэрлэсэн дүн 1,200,000, хүү 5.6963 хувь, давтамж 4		
	[ГВ]	[ГВ]	[ГВ]	[ГВ]	[ОНВ]	[ОНВ]	[ОНВ]	[ОНВ]	
Хугацаа									
Тайлант үе 1	t ₀								
	t ₁								
	t ₂								
	t ₃								
	t ₄								
Тайлант үе 2	t ₅	0	0	0	0	0	0	0	
	t ₆	0	0	0	0	0	0	0	
	t ₇	0	0	0	0	0	0	0	
	t ₈	0	0	0	0	0	0	0	
Тайлант үе 3	t ₉	0	0	0	0	(18,120)	(17,850)	17,089	16,835
	t ₁₀	(20,426)	(20,173)	20,358	20,106	(18,360)	(17,814)	17,089	16,581
	t ₁₁	0	0	0	0	(18,683)	(17,850)	17,089	16,327
	t ₁₂	(20,426)	(19,965)	20,582	20,117	(19,203)	(18,058)	17,089	16,070
Тайлант үе 4	t ₁₃	0	0	0	0	(19,718)	(18,243)	17,089	15,810
	t ₁₄	(20,426)	(19,726)	20,246	19,553	(20,279)	(18,449)	17,089	15,547
	t ₁₅	0	0	0	0	(21,014)	(18,789)	17,089	15,280
	t ₁₆	(1,020,426)	(971,144)	1,020,582	971,292	(1,221,991)	(1,072,947)	1,217,089	1,068,643
Нийт дүн		(1,031,008)		1,031,067		(1,200,000)		1,181,092	
Нийт дүн-ОНВ-аар		(1,464,031)		1,464,116		(1,200,000)		1,181,092	
Бүх МГ-ний ӨҮЦ [ОНВ]									
	(18,824)				Σ				

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Хүүний түвшний болон ханшийн өөрчлөлтүүд нь Тайлант үе 1-ийн эцэс ба Тайлант үе 2-ын эцэс хоорондох хугацаанд уг нэгтгэсэн эрсдэл өртөлтийн мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөгдөж, өнөөгийн үнэ цэнэ нь -18,824 ОНВ³⁰ болоход хүргэнэ.

ҮЖ135. Хейжийн зүйлийн өнөөгийн үнэ цэнэ ба хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг ашигласнаар мөнгөн гүйлгээний хейжийн нөөц болон хейжийн үр дүнгүй байдлыг тодорхойлдог (УСНББОУС 41-ийн 140-р параграф).

ҮЖ136. Б байгууллагын санхүүгийн үр дүнгийн болон санхүүгийн байдлын тайланд үзүүлэх үр нөлөөг дараах хүснэгтэнд харуулав (ойлгомжтой болгох үүднээс, тогтмол хүүтэй ГВ-ын өр төлбөрийн бодит үнэ цэнийн хейж ба нэгтгэсэн эрсдэл өртөлтийн мөнгөн гүйлгээний хейж гэсэн уг хоёр хейжийн харилцаагаар мөрийн зүйлсийг³¹ санхүүгийн байдлын тайланд задлан харуулдаг).³²

Жишээ 17—Санхүүгийн үр дүнгийн болон санхүүгийн байдлын тайланд үзүүлэх үр нөлөөний тойм						
<i>[Бүх дүнгүүд ОНВ-аар]</i>						
	Тайлант үе	to	1	2	3	4
Санхүүгийн үр дүнгийн тайлан						
Хүүний зардал						
	ГВ-ын өр төлбөр		45,958	50,452	59,848	58,827
	БҮЦХ-ийн залруулга		(12,731)	11,941	14,385	(49,439)
			33,227	62,393	74,233	9,388
Дахин ангилал (МГХ)				5,990	(5,863)	58,982
Хүүний зардлын дүн				33,227	68,383	68,370
Бусад олз/гарз						
	ВХХТС-ын бодит үнэ цэнийн өөрчлөлт		154,673	(418,788)	(91,437)	185,553
	БҮЦХ-ийн залруулга (ГВ-ын өр төлбөр)		(154,702)	418,733	91,560	(185,591)
	Хейжийн үр дүнгүй байдал		0	(72)	(54)	(19)
Бусад олз/гарзын дүн				(29)	(127)	68
Ашиг, алдагдал				33,198	68,255	68,438
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан						
Цэвэр хөрөнгө/өмч						
	Үр дүнтэй МГХ-ийн олз/гарз			(12,834)	71,713	229
	Дахин ангилал			(5,990)	5,863	(58,982)

³⁰ Энэ нь тооцооллын товч тойм бүхий хүснэгтэнд (ҮЖ132-р параграфыг үзнэ үү) уг нэгтгэсэн эрсдэл өртөлтийн мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлтийн өнөөгийн үнэ цэнэ байдлаар Тайлант үе 2-ын эцэст тусгасан дүн юм.

³¹ Энэ жишээнд ашигласан мөрийн зүйлс нь боломжит толилуулга юм. Мөн үүнээс өөр мөрийн зүйлсийг (энд харуулсан дүнгүүдийг агуулсан мөрийн зүйлсээс гадна) ашигласан толилуулгын янз бүрийн хэлбэр загвартай байж болно. (Хейжийн нягтлан бодох бүртгэлийн тодруулгын шаардлагуудыг УСНББОУС 30-д заасан байдаг. Үүнд: хейжийн үр дүнгүй байдал, хейжийн хэрэглүүрийн дансны үнэ, мөнгөн гүйлгээний хейжийн нөөцийн талаархи тодруулга хамаарна).

³² Тайлант үе 4-ийн хувьд тооцооллын тойм бүхий хүснэгт дэх үнэ цэнүүд (ҮЖ132-р параграфыг үзнэ үү) нь дараах хүснэгт дэх үнэ цэнүүдээс өөр байна. 1-ээс 3 дахь Тайлант үеийн хувьд 'бохир' дүнгүүд (өөрөөр хэлбэл, хүүний хуримтлуулалтыг агуулсан) нь 'цэвэр' дүнгүүдтэй (өөрөөр хэлбэл, хүүний хуримтлуулалтыг оруулаагүй) тэнцүү байдаг. Яагаад гэвэл, тухайн тайлант үеийн эцэс нь үүсмэл хэрэглүүрийн бүх хэсгүүд болон тогтмол хүүтэй ГВ-ын өр төлбөрийн хувьд төлбөр барагдуулалтын өдөр юм. Цаг хугацааны явц дахь үнэ цэнийн өөрчлөлтүүдийг тооцоолохын тулд Тайлант үе 4-ийн эцэс дэх тэдгээр тооцооллын тойм бүхий хүснэгтэнд цэвэр үнэ цэнүүдийг ашиглана. Дараах хүснэгтэнд бохир дүнгүүдийг, өөрөөр хэлбэл, тухайн хэрэглүүрийг барагдуулахын яг өмнөх хуримтлагдсан хүүг агуулсан, уг дуусгавар болголтын дүнг толилуулсан (энэ нь зөвхөн үлгэрчлэн харуулах жишээний зорилготой, тэгэхгүй бол мөнгө ба хуримтлагдсан ашиг, алдагдлаас бусад бүх дансны үнэ нь тэг байх юм).

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Жишээ 17—Санхүүгийн үр дүнгийн болон санхүүгийн байдлын тайланд үзүүлэх үр нөлөөний тойм <i>[Бүх дүнгүүд ОНВ-аар]</i>					
Тайлант үе	to	1	2	3	4
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн			(18,842)	77,577	(58,753)
Санхүүгийн байдлын тайлан					
ГВ-ын өр төлбөр	(1,200,000)	(1,045,298)	(1,464,031)	(1,555,591)	(1,397,984)
ВХХТС	0	(154,673)	264,116	355,553	194,141
ХТС		0	18,896	(58,767)	(13,004)
Мөнгө	1,200,000	1,166,773	1,098,390	1,030,160	978,641
Цэвэр хөрөнгө	0	(33,198)	(82,630)	(228,645)	(238,205)
<i>Цэвэр хөрөнгө/өмч</i>					
Цэвэр хөрөнгө/өмч		0	(18,824)	58,753	0
Хуримтлагдсан ашиг, алдагдал	0	33,198	101,454	169,892	238,205
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	0	33,198	82,630	228,645	238,205

ҮЖ137. Ашиг, алдагдалд тайлагнасан нийт хүүний зардал нь Б мужийн засгийн газрын эрсдлийн удирдлагын стратегийн үр дүн болох хүүний зардлыг тусган харуулдаг:

- (а) Тайлант үе 1-ийн хувьд уг эрсдлийн удирдлагын бодлого нь ОНВ-аар илэрхийлэгдсэн хувьсах хүүний түвшинг тусгах тийм хүүний зардал тайлагнах үр дүнтэй байна. Ингэхдээ валют-хоорондын хүүний түвшний свопын үр нөлөөг, үүн дотроо тогтмол хүүтэй ГВ-ын өр төлбөрийн мөнгөн гүйлгээ болон Тайлант үе 1-ийн туршид барагдуулсан, уг валют-хоорондын хүүний түвшний свопын тогтмол хэсгийн мөнгөн гүйлгээ хоорондох зөрүүг харгалзан үзсэн (энэ нь 1,200,000 ОНВ-ын зээлээс ОНВ-аар үүсэх хувьсах хүүний зардалтай тухайн хүүний зардал яг тэнцүү биш гэдгийг илэрхийлнэ). Тогтмол хүүтэй ГВ-ын өр төлбөрийн үнэ цэнийн өөрчлөлт (бодит үнэ цэнийн хейжийн залруулгаар илэрхийлэгдэх) ба валют-хоорондын хүүний түвшний свопын үнэ цэнийн өөрчлөлт хоорондох зөрүүгээс үүссэн зарим хейжийн үр дүнгүй байдал бас байдаг.
- (б) Тайлант үе 2-4-ийн хувьд уг эрсдлийн удирдлагын бодлого нь ОНВ-аар илэрхийлэгдсэн тогтмол хүүний түвшинг тусгах (өөрөөр хэлбэл, Тайлант үе 1-ийн эцэс дэх хүүний хувь хэмжээний орчин нөхцөлд үндэслэн уг гурван тайлант үеийн хувьд нэгтгэсэн нэг купоны тогтмол хүүтэй болгох) тийм хүүний зардал тайлагнах үр дүнтэй байна. Ингэхдээ Тайлант үе 1-ийн эцэст байгуулсан, хүүний түвшний свопын үр нөлөөг харгалзсан. Гэвч Б мужийн засгийн газрын хүүний зардалд түүний хейжийн харилцаанаас үүсэх хейжийн үр дүнгүй байдал нөлөөлнө. Хүүний түвшний свопын дагуу хүлээн авах хувьсах төлбөрүүд нь уг нэгтгэсэн эрсдэл өртөлтөөс үүсэх мөнгөн гүйлгээний нийт дүнгээс арай бага байх учраас Тайлант үе 2-ын хүүний зардал нь хүүний түвшний свопоор тогтворжуулсан тогтмол хүүний төлбөрүүдээс ялимгүй өндөр дүнтэй байна.³³ Хүүний түвшний свопын дагуу хүлээн авах хувьсах төлбөрүүд нь уг нэгтгэсэн эрсдэл өртөлтөөс үүсэх мөнгөн гүйлгээний нийт дүнгээс илүү байх учраас

³³ Өөрөөр хэлбэл, хүүний түвшний свопын мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлт нь уг нэгтгэсэн эрсдэл өртөлтийн мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлтөөс бага байх тул түүнийг бүхэлдээ нөхөхгүй (үүнийг зарим үед 'хейжийн хомсдол'-ын нөхцөл байдал гэж нэрлэдэг). Ийм нөхцөл байдалд хейжийн үр дүнгүй байдлыг хүлээн зөвшөөрдөггүй учраас мөнгөн гүйлгээний хейж нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн хейжийн үр дүнгүй байдалд хувь нэмэр оруулахгүй (УСНББОУС 41-ийн 140-р параграфыг үзнэ үү). Бодит үнэ цэнийн хейжээс үүсэх хейжийн үр дүнгүй байдал нь бүх тайлант үеүдийн ашиг, алдагдалд нөлөөлдөг.

Тайлант үе 3 ба 4-ийн хүүний зардал нь тэрхүү тогтворжуулсан хүүний төлбөрүүдтэй тэнцүү байна.³⁴

Жишээ 18—Хүүний түвшний эрсдэл ба Гадаад валютын эрсдлийн нэгдсэн хейж (Мөнгөн гүйлгээний хейж/Бодит үнэ цэнийн хейжийн хослол)

Өгөгдөл

ҮЖ138. В мужийн засгийн газар нь гадаад валют (ГВ)-аар илэрхийлэгдсэн, хувьсах хүүтэй өр төлбөрт хейж хийхийг хүссэн. Уг өр төлбөр нь Тайлант үе 1-ийн эхнээс Тайлант үе 4-ийн эцэс хүртэлх дөрвөн тайлант үеийн хугацаатай. В мужийн засгийн газрын бүртгэлийн валют нь түүний орон нутгийн валют (ОНВ) юм. В мужийн засгийн газар нь дараах эрсдэл өртөлттэй байна:

- (а) Мөнгөн гүйлгээний хүүний түвшний эрсдэл ба ГВ-ын эрсдэл: хүүний түвшний өөрчлөлтөнд хамааруулж болох уг хувьсах хүүтэй өр төлбөрийн мөнгөн гүйлгээний өөрчлөлтийг ОНВ-аар хэмжсэн.
- (б) Бодит үнэ цэнийн хүүний түвшний эрсдэл: ГВ-аар илэрхийлэгдсэн хувьсах хүүтэй өр төлбөрийн талаархи В мужийн засгийн газрын эрсдлийн удирдлагын стратегийн (доорх ҮЖ139(а) параграфыг үзнэ үү) дагуу уг хувьсах хүүтэй өр төлбөртэй холбоотой мөнгөн гүйлгээний хүүний түвшний болон гадаад валютын (дээрх (а) заалтыг үзнэ үү) нийт эрсдлийг ОНВ-аар илэрхийлэгдсэн тогтмол хүүтэй эрсдэлд своп хийсний үр дүнд үүсэх эрсдэл.

ҮЖ139. В мужийн засгийн газар нь дараах эрсдлийн удирдлагын стратегийг ашигласнаар өөрийн эрсдэл өртөлтөнд хейж хийдэг:

- (а) В мужийн засгийн газар нь өөрийн ГВ-аар илэрхийлэгдсэн, хувьсах хүүтэй өр төлбөрийг ОНВ-аар илэрхийлэгдсэн тогтмол хүүний эрсдэл болгон своп хийхийн тулд валют-хоорондын хүүний түвшний свопыг ашигладаг. В мужийн засгийн газар нь өөрийн ГВ-аар илэрхийлэгдсэн, өр төлбөрийн (үүн дотроо, хүүний) хувьд түүний нийт хугацаагаар хейж хийдэг. Иймээс ГВ-аар илэрхийлэгдсэн өр төлбөрийг гаргасан хугацаатай ижил хугацаанд В мужийн засгийн газар нь валют-хоорондын хүүний түвшний свопын хэлцлийг хийдэг. Валют-хоорондын хүүний түвшний свопын дагуу В мужийн засгийн газар нь (өр төлбөрийн хүүг төлдөг байсан) ГВ-аар хувьсах хүүг хүлээн авч, ОНВ-аар тогтмол хүү төлөх юм.
- (б) Хейж хийсэн өр төлбөрийн болон холбогдох валют-хоорондын хүүний түвшний свопын мөнгөн гүйлгээг В мужийн засгийн газар нь ОНВ-аар илэрхийлэгдсэн, нэгтгэсэн нэг тогтмол хүүний эрсдэл байдлаар авч үздэг. Тогтмол хүүтэй, хүүний түвшний эрсдлийн (ОНВ-аарх) талаархи өөрийн эрсдлийн удирдлагын стратегийн дагуу В мужийн засгийн газар нь хүүний төлбөрийг цаг хугацааны явцад одоогийн хувьсах хүүний түвшинтэй уялдуулах ба үүний тулд уг ОНВ-аар илэрхийлэгдсэн, нэгтгэсэн тогтмол хүүний эрсдлийг ОНВ-аар илэрхийлэгдсэн хувьсах хүүтэй эрсдэл болгон своп хийхээр шийдвэрлэсэн. Ингэснээр В мужийн засгийн газар нь (бүхэлдээ ОНВ-аар илэрхийлэгдсэн) хүүний түвшний свопыг ашигласан бөгөөд үүний дагуу (валют-хоорондын хүүний түвшний свопын тэрхүү төлөх хэсгийн хувьд хүүг тооцож төлдөг байсан) тогтмол хүүг хүлээн авах ба хувьсах хүүг төлнө.

ҮЖ140. Жишээ 18-д ашигласан үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэнд харуулав:

Жишээ 18—Үзүүлэлтийн тойм					
	to	Тайлант үе 1	Тайлант үе 2	Тайлант үе 3	Тайлант үе 4
ГВ-ын спот ханш [ОНВ/ГВ]	1.2	1.05	1.42	1.51	1.37

³⁴ Өөрөөр хэлбэл, хүүний түвшний свопын мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлт нь уг нэгтгэсэн эрсдэл өртөлтийн мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлтөөс их байх тул түүнийг бүрэн хэмжээнээс илүүгээр нөхнө (үүнийг зарим үед 'хейжийн илүүдэл'-ийн нөхцөл байдал гэж нэрлэдэг). Ийм нөхцөл байдалд мөнгөн гүйлгээний хейж нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн хейжийн үр дүнгүй байдалд хувь нэмрээ оруулдаг (УСНББОУС 41-ийн 140-р параграфыг үзнэ үү). Бодит үнэ цэнийн хейжээс үүсэх хейжийн үр дүнгүй байдал нь бүх тайлант үеүдийн ашиг, алдагдалд нөлөөлдөг.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Жишээ 18—Үзүүлэлтийн тойм					
	to	Тайлант үе 1	Тайлант үе 2	Тайлант үе 3	Тайлант үе 4
Хүүний муруй (жилийн сууриар улирал бүрийн хүүний түвшинг босоо чиглэлээр толилуулсан)					
ОНВ	2.50%	1.00%	3.88%	0.34%	[Х/гүй]
	2.75%	1.21%	4.12%	0.49%	
	2.91%	1.39%	4.22%	0.94%	
	3.02%	1.58%	5.11%	1.36%	
	2.98%	1.77%	5.39%		
	3.05%	1.93%	5.43%		
	3.11%	2.09%	5.50%		
	3.15%	2.16%	5.64%		
	3.11%	2.22%			
	3.14%	2.28%			
	3.27%	2.30%			
	3.21%	2.31%			
	3.21%				
	3.25%				
	3.29%				
	3.34%				
ГВ	3.74%	4.49%	2.82%	0.70%	[Х/гүй]
	4.04%	4.61%	2.24%	0.79%	
	4.23%	4.63%	2.00%	1.14%	
	4.28%	4.34%	2.18%	1.56%	
	4.20%	4.21%	2.34%		
	4.17%	4.13%	2.53%		
	4.27%	4.07%	2.82%		
	4.14%	4.09%	3.13%		
	4.10%	4.17%			
	4.11%	4.13%			
	4.11%	4.24%			
	4.13%	4.34%			
	4.14%				
	4.06%				
	4.12%				
	4.19%				

Нягтлан бодох бүртгэлийн арга механизм

ҮЖ141. В мужийн засгийн газар нь дараах хейжийн харилцааг сонгосон:³⁵

- (а) Хейжийн зүйл болох ГВ-аар илэрхийлэгдсэн хувьсах хүүтэй өр төлбөр (хувьсах хүүтэй ГВ-ын өр төлбөр) ба хейжийн хэрэглүүр болох валют-хоорондын хүүний түвшний своп хоорондох мөнгөн гүйлгээний хүүний түвшний эрсдэл болон ГВ-ын эрсдлийн хейжийн харилцааг мөнгөн гүйлгээний хейж гэж сонгох ('нэгдүгээр түвшний харилцаа'). Энэхүү хейжийн харилцааг Тайлант үе 4-ийн эцэс хүртэлх хугацаатайгаар Тайлант үе 1-ийн эхэнд (өөрөөр хэлбэл, t_0 -д) сонгосон.
- (б) Хейжийн зүйл болох уг нэгтгэсэн эрсдэл өртөлт ба хейжийн хэрэглүүр болох хүүний түвшний своп хоорондох хейжийн харилцааг бодит үнэ цэнийн хейж гэж сонгох ('хоёрдугаар түвшний харилцаа'). В мужийн засгийн газар нь өөрийн хүүний төлбөрүүдийг одоогийн хувьсах хүүний түвшинтэй уялдуулах ба үүний тулд уг ОНВ-аар илэрхийлэгдсэн, нэгтгэсэн тогтмол хүүний эрсдлийг ОНВ-аар илэрхийлэгдсэн хувьсах хүүтэй эрсдэл болгон своп хийхээр шийдвэрлэсэн үед буюу Тайлант үе 1-ийн эцэст энэхүү хейжийн харилцааг сонгосон ба Тайлант үе 4-ийн эцэс хүртэлх хугацаатай байна. Хейжийн зүйл гэж сонгосон уг нэгтгэсэн эрсдэл өртөлт нь дараах зүйлсийг ОНВ-аар илэрхийлдэг. Үүнд: мөнгөн гүйлгээний хейжид сонгосон мөнгөн гүйлгээний хүүний түвшний эрсдэл ба гадаад валютын эрсдэл (дээрх (а) заалтыг үзнэ үү) гэсэн хоёр зүйлсийн нийт мөнгөн гүйлгээний хувьд үнэ цэнэ нь Тайлант үе 1-ийн эцэс дэх (өөрөөр хэлбэл, уг нэгтгэсэн эрсдэл өртөлт ба хүүний түвшний свопын хоорондох хейжийн харилцааны сонголтын хугацаа) үнэ цэнэтэй харьцуулахад өөрчлөгдсөний үр дүн болох үнэ цэнийн хувьсан өөрчлөлт.

ҮЖ142. Үүсмэл хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнийн тойм, хейжийн зүйлсийн үнэ цэнийн өөрчлөлтүүд, мөнгөн гүйлгээний хейжийн нөөцийн тооцооллыг дараах хүснэгтэнд³⁶ харуулав.³⁷ Энэ жишээний хувьд хийсэн төсөөллүүдээс хамааран хейжийн харилцааны аль алины хувьд хейжийн үр дүнгүй байдал үүсэхгүй.³⁸

Жишээ 18—Тооцоолол					
	t_0	Тайлант үе 1	Тайлант үе 2	Тайлант үе 3	Тайлант үе 4
Хувьсах хүүтэй ГВ-ын өр төлбөр					
Бодит үнэ цэнэ [ГВ]	(1,000,000)	(1,000,000)	(1,000,000)	(1,000,000)	(1,000,000)
Бодит үнэ цэнэ [ОНВ]	(1,200,000)	(1,050,000)	(1,420,000)	(1,510,000)	(1,370,000)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт [ОНВ]		150,000	(370,000)	(90,000)	140,000
Хувьсах МГ-ний өөрчлөлтийн ӨҮЦ					
[ОНВ]	0	192,310	(260,346)	(282,979)	(170,000)
ӨҮЦ-ийн өөрчлөлт [ОНВ]		192,310	(452,656)	(22,633)	112,979

³⁵ Энэ жишээний хувьд хейжийн нягтлан бодох бүртгэлийн бүх шалгуур хангагдсан гэж төсөөлсөн (УСНББОУС 41-ийн 129-р параграфыг үзнэ үү). Хейжийн сонголтын дараах тайлбар тодорхойлолт нь зөвхөн энэ жишээг ойлгомжтой болгох зорилготой билээ (өөрөөр хэлбэл, энэ нь УСНББОУС 41-ийн 129-р параграфтаар шаардсан албан ёсны цогц баримтжуулалтын жишээ биш юм).

³⁶ Энэ жишээний хүснэгтүүдэд дараах товчилсон үгсийг ашигласан болно: 'ВХХТС' - Валют-хоорондын хүүний түвшний своп, 'МГ' - мөнгөн гүйлгээ, 'МГХ' - мөнгөн гүйлгээний хейж, 'МГХН' - мөнгөн гүйлгээний хейжийн нөөц, 'БҮЦХ' - бодит үнэ цэнийн хейж, 'ХТС' - хүүний түвшний своп, 'ӨҮЦ' - өнөөгийн үнэ цэнэ.

³⁷ Тооцооллын дараах хүснэгтэнд бүх дүнгүүдийг (үүн дотроо, хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүнгүүдийн нягтлан бодох бүртгэлийн зорилго бүхий тооцооллыг) эерэг (нэмэх) ба сөрөг (тоо) тоогоор илэрхийлсэн (жишээлбэл, мөнгөн гүйлгээний хейжийн нөөцийн хувьд хаалтан дотор тусгасан тоо нь гарз гэсэн утгатай байна).

³⁸ Мөнгөн гүйлгээний хейж/бодит үнэ цэнийн хейжийн хослолын хувьд нягтлан бодох бүртгэлийн арга механизмын хэрэглээнд илүү сайн төвлөрөн чиглэхийн тулд сурган заах зорилгоор тэдгээр төсөөллийг хийсэн болно. Хейжийн үр дүнгүй байдлын хэмжилт ба хүлээн зөвшөөрөлтийг Жишээ 16 ба Жишээ 17-д аль хэдийн үлгэрчлэн харуулсан. Гэвч хейжийн үр дүнгүй байдал нь янз бүрийн хүчин зүйлсийн үр дүн байж болох учраас бодит практикт ийм хейж нь ихэвчлэн төгс үр дүнтэй байдаггүй. Тэдгээр хүчин зүйлсэд тухайлбал дараах зүйлс хамаарна. Үүнд: зээлийн эрсдэл, хоног тоолох аргын ялгаатай байдал, хейжийн хэрэглүүрийн сонголтонд оруулсан эсэхээс хамааран валют-хоорондын хүүний түвшний свопод оруулсан өөр өөр валютын арилжааны зардал (ихэвчлэн 'валютын суурь' гэж нэрлэдэг).

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Жишээ 18—Тооцоолол	t₀	Тайлант үе 1	Тайлант үе 2	Тайлант үе 3	Тайлант үе 4
ВХХТС (хувьсах ГВ хүлээн авах/тогтмол ОНВ төлөх)					
Бодит үнэ цэнэ [ОНВ]	0	(192,310)	260,346	282,979	170,000
Бодит үнэ цэнийн өөрчлөлт [ОНВ]		(192,310)	452,656	22,633	(112,979)
МГХН					
Эхний үлдэгдэл	0	0	(42,310)	(28,207)	(14,103)
ГВ-ын дахин ангиллын эрсдэл		153,008	(378,220)	(91,030)	140,731
Дахин ангилал (тайлант үеийн МГ)		(8,656)	(18,410)	2,939	21,431
Үр дүнтэй МГХ-ийн олз/гарз		(186,662)	(479,286)	20,724	(135,141)
Хүүний түвшний эрсдэлд хамаарах дахин ангилал		0	(82,656)	67,367	(27,021)
МГХН-ийн хорогдуулга		0	14,103	14,103	14,103
Эцсийн үлдэгдэл		(42,103)	(28,207)	(14,103)	0
ХТС (тогтмол дүнг хүлээн авах/хувьсах дүнг төлөх)					
Бодит үнэ цэнэ [ОНВ]		0	(82,656)	(15,289)	(42,310)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт			(82,656)	67,367	(27,021)
Уг нэгтгэсэн эрсдэл өртөлтийн өнөөгийн үнэ цэнийн өөрчлөлт					
Өнөөгийн үнэ цэнэ [ОНВ]		(1,242,310)	(1,159,654)	(1,227,021)	(1,200,000)
Өнөөгийн үнэ цэнийн өөрчлөлт [ОНВ]			82,656	(67,367)	27,021

ҮЖ143. Хувьсах хүүтэй ГВ-ын өр төлбөр ба валют-хоорондын хүүний түвшний свопын хоорондох хейжийн харилцаа нь Тайлант үе 1-ийн эхнээс (өөрөөр хэлбэл, t₀) эхлэх бөгөөд хоёрдугаар түвшний харилцааны хувьд хейжийн харилцаа Тайлант үе 1-ийн эцэст эхлэх хүртэл үйлчилсэн хэвээр байна, өөрөөр хэлбэл нэгдүгээр түвшний харилцаа нь тусдаа хейжийн харилцаа байдлаар үргэлжилнэ. Гэвч нэгдүгээр түвшний харилцааны хейжийн нягтлан бодох бүртгэлд Тайлант үе 1-ийн эцэс дэх хоёрдугаар түвшний харилцааны хейжийн нягтлан бодох бүртгэлийн эхлэл нөлөөлдөг. Хоёрдугаар түвшний харилцааны бодит үнэ цэнийн хейж нь уг нэгдүгээр түвшний харилцааны хувьд мөнгөн гүйлгээний хейжийн нөөцөөс дүнгүүдийг ашиг, алдагдалд дахин ангилах хугацаанд нөлөө үзүүлдэг.

- (а) Бодит үнэ цэнийн хейжээр хейж хийсэн, бодит үнэ цэнийн хүүний түвшний эрсдлийг уг нэгдүгээр түвшний хейжийн харилцаанд хамаарах мөнгөн гүйлгээний хейжийн үр дүн (өөрөөр хэлбэл, үр дүнтэй хейж гэж тодорхойлогдох валют-хоорондын хүүний түвшний свопын олз буюу гарз) байдлаар цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрөх дүнд тусган оруулдаг.³⁹ Бодит үнэ цэнийн хүүний түвшний эрсдлийг (ОНВ-аар) илэрхийлэх ба эхний алхамаар цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрдөг, үр дүнтэй мөнгөн гүйлгээний хейжийн хэсгийн олз буюу гарзыг хоёр дахь алхамын үед мөнгөн гүйлгээний хейжийн нөөцөөс ашиг, алдагдалд нэн даруй (өөрөөр хэлбэл, тухайн тайлант үед) шилжүүлнэ гэсэн утгыг энэ нь илэрхийлнэ. Тэрхүү дахин

³⁹ Хувьсах хүүтэй ГВ-ын өр төлбөрийн мөнгөн гүйлгээний хүүний түвшний эрсдлийг тогтмол хүүний эрсдэл (ОНВ-аар) болгон өөрчлөх валют-хоорондын хүүний түвшний свопын гэрээ байгуулснаар өөрийн мөнгөн гүйлгээний хүүний түвшний эрсдэлд хейж хийсний үр дүнд, В мужийн засгийн газар нь үнэн хэрэгтээ бодит үнэ цэнийн хүүний түвшний эрсдлийг хүлээх юм (ҮЖ139-р параграфыг үзнэ үү).

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

ангиллын залруулга нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг хүүний түвшний свопын олз, гарзыг харилцан суутгаж, нөхдөг.⁴⁰ Хорогдуулсан өртгөөр бүртгэдэг, тогтмол хүүтэй (ОНВ-аарх) өрийн хэрэглүүр болох хейжийн зүйлээс ялгаатай нь, нэгтгэсэн эрсдэл өртөлтийг тухайн хейж хийсэн эрсдэлтэй холбоотой өөрчлөлтийн хувьд аль хэдийн дахин хэмжсэн байдаг учраас хейжийн зүйл болох уг нэгтгэсэн эрсдэл өртөлтийн тайлагналын хүрээнд тэрхүү дахин ангиллын залруулга нь бодит үнэ цэнийн хейжийн залруулгатай адил байна. Харин нэгдүгээр түвшний харилцааны хувьд мөнгөн гүйлгээний хейжийн нягтлан бодох бүртгэлийг мөрддөг учраас уг нэгтгэсэн эрсдэл өртөлтийн дахин хэмжилтийн үр дүн болох олз, гарзыг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө. Иймээс уг нэгтгэсэн эрсдэл өртөлтийг хейжийн зүйл гэж тайлагнах бодит үнэ цэнийн хейжийн нягтлан бодох бүртгэлийг мөрдөх нь тухайн хейжийн зүйлийн хэмжилтийг өөрчлөх үр дагаваргүй боловч хейжийн олз, гарзыг хэрхэн тайлагнахад (өөрөөр хэлбэл, мөнгөн гүйлгээний хейжийн нөөцийг ашиг, алдагдалд дахин ангилахад) нөлөөлдөг.

- (б) Тайлант үе 1-ийн эцэс дэх мөнгөн гүйлгээний хейжийн нөөцийн дүнг (42,310ТН) нэгдүгээр түвшний харилцааны хувьд уг мөнгөн гүйлгээний хейжийн үлдсэн хугацаанд (өөрөөр хэлбэл, Тайлант үе 2-оос Тайлант үе 4-ийн хооронд) хорогдуулна.⁴¹

ҮЖ144. Нэгтгэсэн эрсдэл өртөлтийн үнэ цэнийн өөрчлөлтийг дараах байдлаар тооцоолдог:

- (а) Уг нэгтгэсэн эрсдэл өртөлтийн үнэ цэнийн өөрчлөлтөд хейж хийж эхлэх үед (өөрөөр хэлбэл, Тайлант үе 1-ийн эцэс дэх хоёрдугаар түвшний харилцааны эхэнд) тэдгээр хувьсах хүүтэй ГВ-ын өр төлбөр ба валют-хоорондын хүүний түвшний свопоос тухайн хейжийн хугацаанд (өөрөөр хэлбэл, Тайлант үе 4-ийн эцэс хүртэл) хүлээгдэж буй бүх мөнгөн гүйлгээг төлөвлөн гаргаж, нийт өнөөгийн үнэ цэнийг (ОНВ-аар) тооцоолдог. Энэ тооцоолол нь уг нэгтгэсэн эрсдэл өртөлтийн өнөөгийн үнэ цэнийн өөрчлөлтийг тухайн хейжийн харилцааны эхлэлээс хойш хэмжихдээ лавлагаа цэг болгон дараагийн тайлант үеүдэд ашиглах тэрхүү өнөөгийн үнэ цэнийг тогтоох юм. Тооцооллыг дараах хүснэгтэнд үлгэрчлэн харуулав:

Жишээ 18—Нэгтгэсэн эрсдэл өртөлтийн өнөөгийн үнэ цэнэ (Эхлэлийн цэг)							
Нэгтгэсэн эрсдэл өртөлтийн өнөөгийн үнэ цэнэ							
		ГВ-ын өр төлбөр		ВХХТС-ГВ-ын хэсэг		ВХХТС-ОНВ-ын хэсэг	
		МГ	ӨҮЦ	МГ	ӨҮЦ	МГ	ӨҮЦ
		[ГВ]	[ГВ]	[ГВ]	[ГВ]	[ОНВ]	[ОНВ]
Хугацаа							
Тайлант үе 1	t ₀						
	t ₁						
	t ₂						
	t ₃						
	t ₄						
Тайлант үе 2	t ₅	(11,039)	(10,918)	11,039	10,918	(9,117)	(9,094)
	t ₆	(11,331)	(11,082)	11,331	11,082	(9,117)	(9,067)
	t ₇	(11,375)	(11,000)	11,375	11,000	(9,117)	(9,035)
	t ₈	(10,689)	(10,227)	10,689	10,227	(9,117)	(9,000)
Тайлант үе 3	t ₉	(10,375)	(9,824)	10,375	9,824	(9,117)	(8,961)

⁴⁰ Тооцооллын товчоо бүхий хүснэгт дэх (ҮЖ142-р параграфыг үзнэ үү) энэхүү дахин ангиллын залруулга нь мөнгөн гүйлгээний хейжийн нөөцийн тохируулгын тайлан дахь “Хүүний түвшний эрсдэлд хамаарах дахин ангилал” гэсэн мөрийн зүйл юм. (Жишээлбэл; Тайлант үе 2-ын эцэс дэх мөнгөн гүйлгээний хейжийн нөөцөөс ашиг, алдагдалд дахин ангилсан 82,656 ОНВ-ын олз—уг дүнг хэрхэн тооцоолсон гэдгийг ҮЖ144-р параграфас үзнэ үү).

⁴¹ Тооцооллын товчоо бүхий хүснэгт дэх (ҮЖ142-р параграфыг үзнэ үү) энэхүү хорогдуулга нь 14,103 ОНВ-ын дүн бүхий үечилсэн дахин ангиллын залруулга хийхэд хүргэх бөгөөд түүнийг мөнгөн гүйлгээний хейжийн нөөцийн тохируулгын тайлан дахь “МГХН-ийн хорогдуулга” гэсэн мөрийн зүйлд тусгана.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Жишээ 18—Нэгтгэсэн эрсдэл өртөлтийн өнөөгийн үнэ цэнэ (Эхлэлийн цэг)							
Нэгтгэсэн эрсдэл өртөлтийн өнөөгийн үнэ цэнэ							
		ГВ-ын өр төлбөр		ВХХТС-ГВ-ын хэсэг		ВХХТС-ОНВ-ын хэсэг	
		МГ	ӨҮЦ	МГ	ӨҮЦ	МГ	ӨҮЦ
		[ГВ]	[ГВ]	[ГВ]	[ГВ]	[ОНВ]	[ОНВ]
	t ₁₀	(10,164)	(9,528)	10,164	9,528	(9,117)	(8,918)
	t ₁₁	(10,028)	(9,307)	10,028	9,307	(9,117)	(8,872)
	t ₁₂	(10,072)	(9,255)	10,072	9,255	(9,117)	(8,825)
Тайлант үе 4	t ₁₃	(10,256)	(9,328)	10,256	9,328	(9,117)	(8,776)
	t ₁₄	(10,159)	(9,147)	10,159	9,147	(9,117)	(8,727)
	t ₁₅	(10,426)	(9,290)	10,426	9,290	(9,117)	(8,678)
	t ₁₆	(1,010,670)	(891,093)	1,010,670	891,093	(1,209,117)	(1,144,358)
Нийт дүн			(1,000,000)	1,000,000	(1,242,310)		
Нийт дүн-ОНВ-аар			(1,050,000)	1,050,000	(1,242,310)		
Нэгтгэсэн эрсдэл өртөлтийн ӨҮЦ [ОНВ]							
				Σ			
				←		(1,242,310)	

Хувьсах хүүтэй ГВ-ын өр төлбөр ба валют-хоорондын хүүний түвшний свопоос тухайн хейжийн хугацаанд хүлээгдэж буй бүх мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ нь Тайлант үе 1-ийн эцэст -1,242,310 ОНВ байна.⁴²

- (б) Дараагийн тайлант үеүдийн эцэст, уг нэгтгэсэн эрсдэл өртөлтийн өнөөгийн үнэ цэнийг Тайлант үе 1-ийн эцэст тогтоосонтой ижил арга замаар тэрхүү хейжийн үлдсэн хугацааны туршид тодорхойлно. Хувьсах хүүтэй ГВ-ын өр төлбөр болон валют-хоорондын хүүний түвшний свопоос уг хейжийн үлдсэн хугацаанд (өөрөөр хэлбэл, үр дүнтэй байдлын хэмжилтийн өдрөөс Тайлант үе 4-ийн эцэс хүртэл) хүлээгдэж буй үлдэгдэл бүх мөнгөн гүйлгээг энэхүү зорилгоор (хэрэв шаардлагатай бол) шинэчлэн баяжуулж, дараа нь дискаунтчилна. Эдгээр бүх өнөөгийн үнэ цэнүүдийн нийт дүн нь уг нэгтгэсэн эрсдэл өртөлтийн өнөөгийн үнэ цэнийг илэрхийлдэг. Тайлант үе 2-ын эцэс дэх энэхүү тооцооллыг дараах хүснэгтэнд үлгэрчлэн харуулав.

Жишээ 18—Нэгтгэсэн эрсдэл өртөлтийн өнөөгийн үнэ цэнэ (Тайлант үе 2-ын эцэст)							
Нэгтгэсэн эрсдэл өртөлтийн өнөөгийн үнэ цэнэ							
		ГВ-ын өр төлбөр		ВХХТС-ГВ-ын хэсэг		ВХХТС-ОНВ-ын хэсэг	
		МГ	ӨҮЦ	МГ	ӨҮЦ	МГ	ӨҮЦ
		[ГВ]	[ГВ]	[ГВ]	[ГВ]	[ОНВ]	[ОНВ]
Хугацаа							
t ₀							

⁴² Энэ жишээний хувьд хийсэн төсөөллүүдээс хамааран хейжийн харилцааны аль алины хувьд хейжийн үр дүнгүй байдал үүсэхгүй (^{УЖ}142-р параграфыг үзнэ үү). Үүний үр дүнд, хувьсах хүүтэй ГВ-ын өр төлбөр ^{6a} валют-хоорондын хүүний түвшний свопын ГВ-аар илэрхийлэгдсэн хэсгийн үнэмлэхүй дүнгүүд тэнцүү (⁶эхдээ сөрөг утгатай) байна. ^хейжийн үр дүнгүй байдал үүсдэг тохиолдолд тэдгээр үнэмлэхүй дүнгүүд тэнцүү байдаггүй, иймээс тухайн үлдсэн цэвэр дүн нь уг нэгтгэсэн эрсдэл өртөлтийн өнөөгийн үнэ цэнэд нөлөөлөх юм.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Жишээ 18—Нэгтгэсэн эрсдэл өртөлтийн өнөөгийн үнэ цэнэ (Тайлант үе 2-ын эцэст)							
Нэгтгэсэн эрсдэл өртөлтийн өнөөгийн үнэ цэнэ							
	ГВ-ын өр төлбөр		ВХХТС-ГВ-ын хэсэг		ВХХТС-ОНВ-ын хэсэг		
	МГ [ГВ]	ӨҮЦ [ГВ]	МГ [ГВ]	ӨҮЦ [ГВ]	МГ [ОНВ]	ӨҮЦ [ОНВ]	
Тайлант үе 1	t ₁						
	t ₂						
	t ₃						
	t ₄						
Тайлант үе 2	t ₅						
	t ₆						
	t ₇						
	t ₈						
Тайлант үе 3	t ₉	(6,969)	(6,921)	6,969	6,921	(9,117)	(9,030)
	t ₁₀	(5,544)	(5,475)	5,544	5,475	(9,117)	(8,939)
	t ₁₁	(4,971)	(4,885)	4,971	4,885	(9,117)	(8,847)
	t ₁₂	(5,401)	(5,280)	5,401	5,280	(9,117)	(8,738)
Тайлант үе 4	t ₁₃	(5,796)	(5,632)	5,796	5,632	(9,117)	(8,624)
	t ₁₄	(6,277)	(6,062)	6,277	6,062	(9,117)	(8,511)
	t ₁₅	(6,975)	(6,689)	6,975	6,689	(9,117)	(8,397)
	t ₁₆	(1,007,725)	(959,056)	1,007,725	956,056	(1,209,117)	(1,098,568)
	Нийт дүн		(1,000,000)		1,000,000		(1,159,654)
	Нийт дүн-ОНВ-аар		(1,420,000)		1,420,000		(1,159,654)
	Нэгтгэсэн эрсдэл өртөлтийн ӨҮЦ [ОНВ]						
							(1,159,654) ← Σ

Хүүний түвшний болон валютын ханшийн өөрчлөлт нь уг нэгтгэсэн эрсдэл өртөлтийн өнөөгийн үнэ цэнийг Тайлант үе 2-ын эцэст -1,159,654 ОНВ болоход хүргэсэн. Иймээс уг нэгтгэсэн эрсдэл өртөлтийн өнөөгийн үнэ цэнийн өөрчлөлт нь Тайлант үе 1-ийн эцэс ба Тайлант үе 2-ын эцэс хооронд 82,656 ОНВ-ын олз байна.⁴³

ҮЖ145. Хейжийн зүйлийн (өөрөөр хэлбэл, нэгтгэсэн эрсдэл өртөлтийн) өнөөгийн үнэ цэнийн өөрчлөлт ба хейжийн хэрэглүүрийн (өөрөөр хэлбэл, хүүний түвшний свопын) бодит үнэ цэнийг ашигласнаар тухайн мөнгөн гүйлгээний хейжийн нөөцөөс ашиг, алдагдалд шилжүүлэх холбогдох дахин ангиллыг (дахин ангиллын залруулгыг) тодорхойлдог.

ҮЖ146. В байгууллагын санхүүгийн үр дүнгийн болон санхүүгийн байдлын тайланд үзүүлэх үр нөлөөг дараах хүснэгтэнд харуулав (ойлгомжтой болгох үүднээс, хувьсах хүүтэй ГВ-ын өр төлбөрийн мөнгөн

⁴³ Энэ нь тооцооллын товч тойм бүхий хүснэгтэнд (ҮЖ142-р параграфыг үзнэ үү) уг нэгтгэсэн эрсдэл өртөлтийн өнөөгийн үнэ цэнийн өөрчлөлт байдлаар Тайлант үе 2-ын эцэст тусгасан дүн юм.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

гүйлгээний хейж ба нэгтгэсэн эрсдэл өртөлтийн бодит үнэ цэнийн хейж гэсэн уг хоёр хейжийн харилцаагаар мөрийн зүйлсийг⁴⁴ санхүүгийн байдлын тайланд задлан харуулдаг).⁴⁵

Жишээ 18—Санхүүгийн үр дүнгийн болон санхүүгийн байдлын тайланд үзүүлэх үр нөлөөний тойм <i>[Бүх дүнгүүд ОНВ-аар]</i>						
	Тайлант үе	to	1	2	3	4
Санхүүгийн үр дүнгийн тайлан						
Хүүний зардал						
	ГВ-ын өр төлбөр		45,122	54,876	33,527	15,035
	БҮЦХ-ийн залруулга		0	(20,478)	16,517	(26,781)
			45,122	34,398	50,045	(11,746)
Дахин ангилал (МГХ)			(8,656)	(18,410)	2,939	21,431
			36,466	15,989	52,983	9,685
МГХН-ийн хорогдуулга			0	14,103	14,103	14,103
Хүүний зардлын дүн			36,466	30,092	67,087	23,788
Бусад олз/гарз						
	ХТС		0	82,656	(67,367)	27,021
	ГВ-ын олз/гарз (өр төлбөр)		(150,000)	370,000	90,000	(140,000)
	ГВ-ын олз/гарз (хүү)		(3,008)	8,220	1,030	(731)
	ГВ-ын эрсдэлд хамаарах дахин ангилал		153,008	(378,220)	(91,030)	140,731
	Хүүний түвшний эрсдэлд хамаарах дахин ангилал		0	(82,656)	67,367	(27,021)
Бусад олз/гарзын дүн			0	0	0	0
Ашиг, алдагдал			36,466	30,092	67,087	23,788
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан						
Цэвэр хөрөнгө/өмч						
	Үр дүнтэй хейжийн олз/гарз		186,662	(479,286)	(20,724)	135,141
	Дахин ангилал (тайлант үеийн МГ)		8,656	18,410	(2,939)	(21,431)
	ГВ-ын эрсдэлд хамаарах дахин ангилал		(153,008)	378,220	91,030	(140,731)
	Хүүний түвшний эрсдэлд хамаарах дахин ангилал		0	82,656	(67,367)	27,021

⁴⁴ Энэ жишээнд ашигласан мөрийн зүйлс нь боломжит толилуулга юм. Мөн үүнээс өөр мөрийн зүйлсийг (энд харуулсан дүнгүүдийг агуулсан мөрийн зүйлсээс гадна) ашигласан толилуулгын янз бүрийн хэлбэр загвартай байж болно. (Хейжийн нягтлан бодох бүртгэлийн тодруулгын шаардлагуудыг УСНББОУС 30-д заасан байдаг. Үүнд: хейжийн үр дүнгүй байдал, хейжийн хэрэглүүрийн дансны үнэ, мөнгөн гүйлгээний хейжийн нөөцийн талаархи тодруулга хамаарна).

⁴⁵ Тайлант үе 4-ийн хувьд тооцооллын тойм бүхий хүснэгт дэх үнэ цэнүүд (ҮЖ132-р параграфыг үзнэ үү) нь дараах хүснэгт дэх үнэ цэнүүдээс өөр байна. 1-ээс 3 дахь Тайлант үеийн хувьд "бохир" дүнгүүд (өөрөөр хэлбэл, хүүний хуримтлуулалтыг агуулсан) нь "цэвэр" дүнгүүдтэй (өөрөөр хэлбэл, хүүний хуримтлуулалтыг оруулаагүй) тэнцүү байдаг. Яагаад гэвэл, тухайн тайлант үеийн эцэс нь үүсмэл хэрэглүүрийн бүх хэсгүүд болон тогтмол хүүтэй ГВ-ын өр төлбөрийн хувьд төлбөр барагдуулалтын өдөр юм. Цаг хугацааны явц дахь үнэ цэнийн өөрчлөлтүүдийг тооцоолохын тулд Тайлант үе 4-ийн эцэс дэх тэдгээр тооцооллын тойм бүхий хүснэгтэнд цэвэр үнэ цэнүүдийг ашиглана. Дараах хүснэгтэнд бохир дүнгүүдийг, өөрөөр хэлбэл, тухайн хэрэглүүрийг барагдуулахын яг өмнөх хуримтлагдсан хүүг агуулсан, уг дуусгавар болголтын дүнг толилуулсан (энэ нь зөвхөн үлгэрчлэн харуулах жишээний зорилготой, тэгэхгүй бол мөнгө ба хуримтлагдсан ашиг, алдагдлаас бусад бүх дансны үнэ нь тэг байх юм).

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Жишээ 18—Санхүүгийн үр дүнгийн болон санхүүгийн байдлын тайланд үзүүлэх үр нөлөөний тойм <i>[Бүх дүнгүүд ОНВ-аар]</i>						
	Тайлант үе	to	1	2	3	4
МГХН-ийн хорогдуулга			0	(14,103)	(14,103)	(14,103)
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн			42,310	(14,103)	(14,103)	(14,103)
Санхүүгийн байдлын тайлан						
ГВ-ын өр төлбөр	(1,200,000)	(1,050,000)	(1,420,000)	(1,510,000)	(1,375,306)	
ВХХТС	0	(192,310)	260,346	282,979	166,190	
ХТС		0	(82,656)	(15,289)	(37,392)	
Мөнгө	1,200,000	1,163,534	1,147,545	1,094,562	1,089,076	
Цэвэр хөрөнгө	0	(78,776)	(94,765)	(147,748)	(157,433)	
Цэвэр хөрөнгө/өмч	0	42,310	28,207	14,103	0	
Хуримтлагдсан ашиг, алдагдал	0	36,466	66,558	133,645	157,433	
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	0	78,776	94,765	147,748	157,433	

ҮЖ147. Ашиг, алдагдалд тайлагнасан нийт хүүний зардал нь В мужийн засгийн газрын эрсдлийн удирдлагын стратегийн үр дүн болох хүүний зардлыг тусган харуулдаг:

- Тайлант үе 1-ийн хувьд уг эрсдлийн удирдлагын бодлого нь ОНВ-аар илэрхийлэгдсэн тогтмол хүүний түвшинг тусгах тийм хүүний зардал тайлагнах үр дүнтэй байна. Ингэхдээ валют-хоорондын хүүний түвшний свопын үр нөлөөг харгалздаг.
- Тайлант үе 2-4-ийн хувьд, уг эрсдлийн удирдлагын бодлого нь ОНВ-аар илэрхийлэгдсэн хувьсах хүүний түвшний (өөрөөр хэлбэл, тайлант үе бүрд зонхилох, хувьсах хүүний түвшний) дагуу өөрчлөгдөх тийм хүүний зардал тайлагнах үр дүнтэй байна. Ингэхдээ Тайлант үе 1-ийн эцэст байгуулсан, хүүний түвшний свопын үр нөлөөг харгалздаг. Гэвч Тайлант үе 1-ийн эцэс дэх нэгдүгээр түвшний харилцааны хувьд мөнгөн гүйлгээний хейжийн нөөцөд тусгагдсан дүнгийн хорогдуулгын улмаас нийт хүүний зардлын дүн нь хувьсах хүүний дүнтэй тэнцүү биш байдаг.⁴⁶

Гадаад үйл ажиллагаа (Хавсралт Б)

ҮЖ148. Гадаад үйл ажиллагааны данснаас хасалтын дахин ангилалтай холбоотойгоор Хавсралт Б-гийн Б12, Б13, Б14, Б15-р параграфыг хэрхэн мөрдөхийг энэ жишээнд үлгэрчлэн харуулав.

Жишээ 19—Гадаад үйл ажиллагааны данснаас хасалт

Танилцуулга

ҮЖ149. Энэ жишээний хувьд уг эдийн засгийн байгууллага нь Б16-р параграфт тусгасантай адил бүтэцтэй бөгөөд Г хяналт тавигч байгууллага нь өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь В хяналтанд буй байгууллагад оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын Евро/Долларын эрсдэлд хейж хийхийн тулд А хяналтанд буй байгууллага дахь ам долларын зээлийг ашигласан гэж үзье. Г хяналт тавигч байгууллага нь алхам-алхамаар нэгтгэх аргыг ашигладаг. Хейж нь бүрэн үр дүнтэй бөгөөд В хяналтанд буй байгууллагыг данснаас хасахын өмнөх уг хейжийн хэрэглүүрийн үнэ цэнийн

⁴⁶ ҮЖ143(б) параграфыг үзнэ үү. Уг хорогдуулга нь хувьсах хүүний түвшний тархалттай адил үр нөлөө бүхий зардал болох юм.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Доллар/Евроны хуримтлагдсан нийт өөрчлөлт нь 24 сая € (олз) байна. Г хяналт тавигч байгууллагын бүртгэлийн валюттай (евро) харьцуулан хэмжихэд энэ нь В байгууллагад оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралттай яг уялдаж байсан.

ҮЖ150. Хэрэв нэгтгэлийн шууд аргыг ашигласан бол В хяналтанд буй байгууллагад оруулсан Г хяналт тавигч байгууллагын цэвэр хөрөнгө оруулалтын үнэ цэнийн 24 сая €-ны бууралтыг уг Г хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь В хяналтанд буй байгууллагатай холбоотой гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцөд бүхэлд нь тусгах байсан. Гэвч Г хяналт тавигч байгууллага нь алхам-алхамаар нэгтгэх аргыг ашигладаг учраас В хяналтанд буй байгууллагад оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын энэхүү 24 сая €-ны бууралтыг В хяналтанд буй байгууллагатай холбоотой Б хяналтанд буй байгууллагын гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц болон Б хяналтанд буй байгууллагатай холбоотой Г хяналт тавигч байгууллагын гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцийн аль алинд тусгана.

ҮЖ151. Б болон В хяналтанд буй байгууллагуудтай холбоотойгоор гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцөд хүлээн зөвшөөрсөн нийт дүнд уг нэгтгэлийн арга нөлөө үзүүлэхгүй. Нэгтгэлийн шууд аргыг ашиглана гэж үзвэл Г хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь Б болон В хяналтанд буй байгууллагуудын гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцүүд нь харгалзан 62 сая €-ны олзтой ба 24 сая €-ны гарзтай байна; харин алхам-алхамаар нэгтгэх аргыг ашиглавал, эдгээр дүнгүүд нь харгалзан 49 сая €-ны олзтой ба 11 сая €-ны гарзтай байна.

Дахин ангилал

ҮЖ152. В хяналтанд буй байгууллагад оруулсан хөрөнгө оруулалтыг данснаас хассан тохиолдолд уг хейжийн хэрэглүүрийн нийт 24 сая €-ны олзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөхийг УСНББОУС 41-ээр шаарддаг. Алхам-алхамаар нэгтгэх аргыг ашиглавал В хяналтанд буй байгууллагад оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын хувьд ашиг, алдагдалд дахин ангилах дүн нь ердөө 11 сая €-ны гарз байна. Г хяналт тавигч байгууллага нь нэгтгэлийн шууд аргыг ашигласан ба энэ нь түүний нягтлан бодох бүртгэлийн бодлого байсан бол уг хейжийн хэрэглүүр болон цэвэр хөрөнгө оруулалтын хувьд дахин ангилах дүнгүүдтэй уялдуулахын тулд Б ба В хяналтанд буй байгууллагуудын аль алины гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцүүдийг 13 сая €-гоор тохируулж болох юм. Өөрийн цэвэр хөрөнгө оруулалтанд хейж хийгээгүй байгууллага нь ийм дахин ангиллыг хийж болно.

Хөнгөлөлттэй зээл (МЗУ118-МЗУ127-р параграф)

Жишээ 20—Хөнгөлөлттэй зээлийн мөнгөн орлого (Хүүний хөнгөлөлт)

ҮЖ153. Орон нутгийн захиргааны байгууллага нь 5 жилийн хугацаанд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүлэх эмнэлэг барихын тулд олон улсын хөгжлийн агентлагаас 5 сая ТН-ийн зээлийн санхүүжилтийг хүлээн авсан. Уг зээлийг 5 жилийн хугацаанд дараах байдлаар буцаан төлнө гэж зээлийн гэрээнд заасан:

- Жил 1: Үндсэн зээлээс буцаан төлөхгүй
- Жил 2: Үндсэн зээлийн 10 хувь
- Жил 3: Үндсэн зээлийн 20 хувь
- Жил 4: Үндсэн зээлийн 30 хувь
- Жил 5: Үндсэн зээлийн 40 хувь

Төлөгдөөгүй зээлийн үлдэгдлээс жилийн 5 хувиар тооцож, хүүг жил бүр төлнө. Ижил төсөөтэй ажил гүйлгээний зах зээлийн холбогдох хүүний түвшин нь 10 хувь байсан.

ҮЖ154. Орон нутгийн захиргааны байгууллага нь 5 сая ТН-ийн хөнгөлөлттэй зээл авсан бөгөөд одоогийн зах зээлийн хүүний түвшнээс бага буюу 5 хувийн хүүтэйгээр уг зээлийг буцаан төлнө. Зах зээлийн хүүний түвшинг ашиглан дискаунтчилсан, уг зээлийн гэрээний нөхцлүүдийн дагуу төлөх гэрээний төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнэ ба зээлийн мөнгөн орлогын хоорондох зөрүүг УСНББОУС 23-ын дагуу хүлээн зөвшөөрнө.

ҮЖ155. Хөнгөлөлттэй зээлийг бүртгэх журналын бичилт нь дараах байдалтай байна:

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

1. Анх хүлээн зөвшөөрөх үед байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө (байгууллага нь хөнгөлөлттэй зээлийг дараагийн тайлант үед хорогдуулсан өртгөөр хэмждэг гэж үзсэн):

Дебит	Харилцах данс	5,000,000	
Кредит	Зээлийн өглөг (доорх Хүснэгт 2-ыг үз)		4,215,450
Кредит	Өр төлбөр эсвэл арилжааны бус орлого		784,550

Зээлийн мөнгөн орлогыг бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх.

Зээлийн зах зээлийн бус хэсгийг өр төлбөр эсвэл орлого гэж хүлээн зөвшөөрөхдөө УСНББОУС 23-ыг харгалзан үзнэ. Арилжааны бус орлого гэж үзэх уг зээлийн зах зээлийн бус хэсгийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийн журналын бичилтүүдийг тэрхүү Стандартын ХЗУ54-р параграфт харуулсан.

2. Жил 1: Байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Хүүний зардал (доорх Хүснэгт 3-ыг үз)	421,545	
Кредит	Зээлийн өглөг		421,545

Үр ашигт хүүний аргыг ашиглан хүүг (4,215,450 ТН х 10%) хүлээн зөвшөөрөх.

Дебит	Зээлийн өглөг (доорх Хүснэгт 1-ийг үз)	250,000	
Кредит	Харилцах данс		250,000

Төлөгдөөгүй үлдэгдлээс тооцож, төлсөн хүүг (5 сая ТН х 5%) хүлээн зөвшөөрөх.

3. Жил 2: Байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Хүүний зардал	438,700	
Кредит	Зээлийн өглөг		438,700

Үр ашигт хүүний аргыг ашиглан хүүг (4,386,995 ТН х 10%) хүлээн зөвшөөрөх.

Дебит	Зээлийн өглөг	750,000	
Кредит	Харилцах данс		750,000

Төлөгдөөгүй үлдэгдлээс тооцож, төлсөн хүү (5 сая ТН х 5% + буцаан төлсөн үндсэн дүн 500,000 ТН) болон үндсэн дүнг хүлээн зөвшөөрөх.

4. Жил 3: Байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Хүүний зардал	407,569	
Кредит	Зээлийн өглөг		407,569

Үр ашигт хүүний аргыг ашиглан хүүг (4,075,695 ТН х 10%) хүлээн зөвшөөрөх.

Дебит	Зээлийн өглөг	1,225,000	
Кредит	Харилцах данс		1,225,000

Төлөгдөөгүй үлдэгдлээс тооцож, төлсөн хүү (4.5 сая ТН х 5% + буцаан төлсөн үндсэн дүн 1.0 сая ТН) болон үндсэн дүнг хүлээн зөвшөөрөх.

5. Жил 4: Байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Хүүний зардал	325,826	
Кредит	Зээлийн өглөг		325,826

Үр ашигт хүүний аргыг ашиглан хүүг (3,258,264 ТН х 10%) хүлээн зөвшөөрөх.

Дебит	Зээлийн өглөг	1,675,000	
Кредит	Харилцах данс		1,675,000

Төлөгдөөгүй үлдэгдлээс тооцож, төлсөн хүүг (3.5 сая ТН х 5% + буцаан төлсөн үндсэн дүн 1.5 сая ТН) хүлээн зөвшөөрөх.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

6. Жил 5: Байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Хүүний зардал	190,909	
	Кредит Зээлийн өглөг		190,909

Үр ашигт хүүний аргыг ашиглан хүүг (1,909,091 ТН х 10%) хүлээн зөвшөөрөх.

Дебит	Зээлийн өглөг	2,100,000	
	Кредит Харилцах данс		2,100,000

Төлөгдөөгүй үлдэгдлээс тооцож, төлсөн хүү (2.0 сая ТН х 5% + буцаан төлсөн үндсэн дүн 2.0 сая ТН) болон үндсэн дүнг хүлээн зөвшөөрөх.

Тооцоолол:

Хүснэгт 1: Хорогдуулгын хуваарь (5 хувийн хүүтэй гэрээний эргэн төлөлтүүдийг ашиглах)

	Жил 0 ТН	Жил 1 ТН	Жил 2 ТН	Жил 3 ТН	Жил 4 ТН	Жил 5 ТН
Үндсэн дүн	5,000,000	5,000,000	5,000,000	4,500,000	3,500,000	2,000,000
Хүү	-	250,000	250,000	225,000	175,000	100,000
Төлөлт	-	(250,000)	(750,000)	(1,225,000)	(1,675,000)	(2,100,000)
Үлдэгдэл	5,000,000	5,000,000	4,500,000	3,500,000	2,000,000	

Хүснэгт 2: Гэрээний мөнгөн гүйлгээг дискаунтчлах (10 хувийн зах зээлийн хүүнд үндэслэсэн)

	Жил 1 ТН	Жил 2 ТН	Жил 3 ТН	Жил 4 ТН	Жил 5 ТН
Үндсэн дүнгийн үлдэгдэл	5,000,000	4,500,000	3,500,000	2,000,000	-
Хүүний өглөг	250,000	250,000	225,000	175,000	100,000
Нийт төлөлт (үндсэн дүн ба хүү)	250,000	750,000	1,225,000	1,675,000	2,100,000
Төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнэ	227,272	619,835	920,360	1,144,048	1,303,935
Төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнүүдийн нийт дүн					<u>4,215,450</u>
Хүлээн авсан мөнгөн орлого					5,000,000
Хасах: Мөнгөн зарлагын өнөөгийн үнэ цэнэ (анх хүлээн зөвшөөрөх үеийн зээлийн бодит үнэ цэнэ)					<u>4,215,450</u>
Арилжааны бус орлого гэж хүлээн зөвшөөрөх уг зээлийн зах зээлийн бус хэсэг					<u>784,550</u>

Хүснэгт 3: Үр ашигт хүүний аргыг ашиглан зээлийн үлдэгдэл ба хүүг тооцоолох

	Жил 1 ТН	Жил 2 ТН	Жил 3 ТН	Жил 4 ТН	Жил 5 ТН
Үндсэн дүн	4,215,450	4,386,995	4,075,695	3,258,264	1,909,091
Хүүний хуримтлуулалт	421,545	438,700	407,569	325,827	190,909
Хүүний төлөлт	(250,000)	(250,000)	(250,000)	(250,000)	(250,000)
Үндсэн дүнгийн төлөлт	-	(500,000)	(1,000,000)	(1,500,000)	(2,000,000)
Үлдэгдэл	4,386,995	4,075,695	3,258,264	1,909,091	-

Жишээ 21-Хөнгөлөлттэй зээлийн төлөлт (Үндсэн дүнгийн хөнгөлөлт)⁴⁷

ҮЖ156. Дээд боловсролыг дэмжих арга хэрэгсэл болгон Боловсролын яам нь зохих шалгуур хангасан оюутнуудад бага хүүтэй зээлийг эргэн төлөх уян хатан нөхцөлтэйгээр олгодог.

ҮЖ157. Яам нь тухайн санхүүгийн жилийн эхэнд дараах нөхцөл, болзолтойгоор 250 сая ТН-ийн зээлийг янз бүрийн оюутнуудад урьдчилан олгосон.

- Үндсэн дүнг дараах байдлаар төлнө:
 - Жил 1-ээс 3: үндсэн дүнгээс буцаан төлөхгүй
 - Жил 4: үндсэн дүнгийн 30 хувийг буцаан төлнө
 - Жил 5: үндсэн дүнгийн 30 хувийг буцаан төлнө
 - Жил 6: үндсэн дүнгийн 30 хувийг буцаан төлнө

⁴⁷ Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолохтой холбоотой аливаа асуудлуудыг энэхүү жишээнд хялбарчлах үүднээс оруулаагүй болно.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

6 дахь жилийн эцэст төлөгдөөгүй үлдэх үндсэн дүнгийн хэсгийг (250 сая ТН-ийн 10 хувь) чөлөөлнө.

- Хүүг тухайн зээлийн төлөгдөөгүй үлдэгдлээс жилийн 11.5 хувиар тооцож, жил бүр төлнө. Ижил төсөөтэй зээлийн хүүний зах зээлийн түвшин нь 11.5 хувь байсан гэж үзье.

Хувилбар 1: Хорогдуулсан өртөг

ҮЖ158. Хөнгөлөлттэй зээлийн мөн чанарыг үнэлсний дараа, боловсролын яам нь уг санхүүгийн хөрөнгийг 39-44-р параграфын дагуу ангилдаг. Жишээний баримт материалд үндэслэн, боловсролын яам нь тухайн санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр хэмжсэн гэж ангилсан.

ҮЖ159. Хорогдуулсан өртгөөр хэмжсэн тохиолдолд хөнгөлөлттэй зээлийг бүртгэх нэгдсэн журналын бичилт нь дараах байдалтай байна:

1. Анх хүлээн зөвшөөрөх үед байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Зээлийн авлага	236,989,595	
Дебит	Зардал	13,010,405	
Кредит	Харилцах данс		250,000,000

Зээлийн урьдчилгааг бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх.

Арилжааны бус зардал гэж үзэх уг зээлийн зах зээлийн бус хэсгийн хувьд зардлыг хүлээн зөвшөөрөхдөө МЗУ125(б) параграфыг харгалзан үзнэ.

2. Жил 1: Байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Зээлийн авлага	27,253,803	
Кредит	Хүүний орлого		27,253,803

Үр ашигт хүүний аргыг ашиглан хүүг (236,989,595 ТН х 11.5%) хуримтлуулах.

Дебит	Харилцах данс	28,750,000	
Кредит	Зээлийн авлага		28,750,000

Хүүний төлөлт, 250 сая ТН х 11.5%.

3. Жил 2: Байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Зээлийн авлага	27,081,741	
Кредит	Хүүний орлого		27,081,741

Үр ашигт хүүний аргыг ашиглан хүүг (235,493,398 ТН х 11.5%) хуримтлуулах.

Дебит	Харилцах данс	28,750,000	
Кредит	Зээлийн авлага		28,750,000

Хүүний төлөлт, 250 сая ТН х 11.5%.

4. Жил 3: Байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Зээлийн авлага	26,889,891	
Кредит	Хүүний орлого		26,889,891

Үр ашигт хүүний аргыг ашиглан хүүг (233,825,139 ТН х 11.5%) хуримтлуулах.

Дебит	Харилцах данс	28,750,000	
Кредит	Зээлийн авлага		28,750,000

Хүүний төлөлт, 250 сая ТН х 11.5%.

5. Жил 4: Байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Дебит	Зээлийн авлага	26,675,979	
	Кредит Хүүний орлого		26,675,979

Үр ашигт хүүний аргыг ашиглан хүүг (231,965,030 ТН х 11.5%) хуримтлуулах.

Дебит	Харилцах данс	103,750,000	
	Кредит Зээлийн авлага		103,750,000

Төлөгдөөгүй үлдэгдлээс хүлээн авсан хүү ба үндсэн дүнгийн хүлээн зөвшөөрөлт (250 сая ТН х 11.5%-ийн хүүний төлөлт + 75 сая ТН-ийн үндсэн дүнгийн буцаан төлөлт).

6. Жил 5: Байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Зээлийн авлага	17,812,466	
	Кредит Хүүний орлого		17,812,466

Үр ашигт хүүний аргыг ашиглан хүүг (154,891,009 ТН х 11.5%) хуримтлуулах.

Дебит	Харилцах данс	95,125,000	
	Кредит Зээлийн авлага		95,125,000

Төлөгдөөгүй үлдэгдлээс хүлээн авсан хүү ба үндсэн дүнгийн хүлээн зөвшөөрөлт (175 сая ТН х 11.5%-ийн хүүний төлөлт + 75 сая ТН-ийн үндсэн дүнгийн буцаан төлөлт).

7. Жил 6: Байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Зээлийн авлага	8,921,525	
	Кредит Хүүний орлого		8,921,525

Үр ашигт хүүний аргыг ашиглан хүүг (77,578,475 ТН х 11.5%) хуримтлуулах.

Дебит	Харилцах данс	86,500,000	
	Кредит Зээлийн авлага		86,500,000

Төлөгдөөгүй үлдэгдлээс хүлээн авсан хүү ба үндсэн дүнгийн хүлээн зөвшөөрөлт (100 сая ТН х 11.5%-ийн хүүний төлөлт + 75 сая ТН-ийн үндсэн дүнгийн буцаан төлөлт).

Хувилбар 2: Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжилт

ҮЖ160. ҮЖ157-р параграфт заасан нөхцлүүдээс гадна уг зээл нь үндсэн дүн ба хүүний төлөлтийг үндсэндээ тусгаагүй тийм дүнгээр тухайн хэрэглүүрийг дурын хугацаанд буцаан дуудах боломжийг боловсролын яаманд олгодог. Хөнгөлөлттэй зээлийн мөн чанарыг үнэлсний дараа, боловсролын яам нь тус санхүүгийн хөрөнгийн ангиллыг 39-44-р параграфын дагуу тодорхойлсон. Энэхүү жишээн дэх дуудах шинжийн улмаас тухайн хэрэглүүрийн мөнгөн гүйлгээ нь зөвхөн үндсэн дүнгийн болон хүүний төлбөрүүдээс үүсдэг гэж үзэх боломжгүй тул боловсролын яам нь уг санхүүгийн хөрөнгийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжинэ гэж дүгнэсэн.

ҮЖ161. Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан тохиолдолд хөнгөлөлттэй зээлийг бүртгэх нэгдсэн журналын бичилт нь дараах байдалтай байна:

1. Анх хүлээн зөвшөөрөх үед байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Зээлийн авлага	236,989,595	
Дебит	Зардал	13,010,405	
	Кредит Харилцах данс		250,000,000

Зээлийн урьдчилгааг бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх.

Арилжааны бус зардал гэж үзэх уг зээлийн зах зээлийн бус хэсгийн хувьд зардлыг хүлээн зөвшөөрөхдөө МЗУ125(б) параграфыг харгалзан үзнэ.

2. Жил 1: Байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Дебит	Зээлийн авлага	27,253,803	
	Кредит Хүүний орлого		27,253,803

Үр ашигт хүүний аргыг ашиглан хүүг (236,989,595 ТН х 11.5%) хуримтлуулах.

Дебит	Харилцах данс	28,750,000	
	Кредит Зээлийн авлага		28,750,000

Хүүний төлөлт, 250 сая ТН х 11.5%.

3. Жил 2: Байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Зээлийн авлага	27,081,741	
	Кредит Хүүний орлого		27,081,741

Үр ашигт хүүний аргыг ашиглан хүүг (235,493,398 ТН х 11.5%) хуримтлуулах.

Дебит	Харилцах данс	28,750,000	
	Кредит Зээлийн авлага		28,750,000

Хүүний төлөлт, 250 сая ТН х 11.5%.

Дебит	Бодит үнэ цэнийн залруулга	2,766,221	
	Кредит Зээлийн авлага		2,766,221

Бодит үнэ цэнийн залруулга (231,058,918ТН⁴⁸ – (235,493,398ТН + 27,081,741ТН – 28,750,000ТН))

4. Жил 3: Байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Зээлийн авлага	26,571,776	
	Кредит Хүүний орлого		26,571,776

Үр ашигт хүүний аргыг ашиглан хүүг (231,058,918 ТН х 11.5%) хуримтлуулах.

Дебит	Харилцах данс	28,750,000	
	Кредит Зээлийн авлага		28,750,000

Хүүний төлөлт, 250 сая ТН х 11.5%.

Дебит	Бодит үнэ цэнийн залруулга	2,620,867	
	Кредит Зээлийн авлага		2,620,867

Бодит үнэ цэнийн залруулга (226,259,827ТН⁶⁶ – (231,058,918ТН + 26,571,776ТН – 28,750,000ТН))

5. Жил 4: Байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Зээлийн авлага	26,019,880	
	Кредит Хүүний орлого		26,019,880

Үр ашигт хүүний аргыг ашиглан хүүг (226,259,827 ТН х 11.5%) хуримтлуулах.

Дебит	Харилцах данс	103,750,000	
	Кредит Зээлийн авлага		103,750,000

Төлөгдөөгүй үлдэгдлээс хүлээн авсан хүү ба үндсэн дүнгийн хүлээн зөвшөөрөлт (250 сая ТН х 11.5%-ийн хүүний төлөлт + 75 сая ТН-ийн үндсэн дүнгийн буцаан төлөлт).

Дебит	Зээлийн авлага	1,472,217	
-------	----------------	-----------	--

⁴⁸ Бодит үнэ цэнийн лавлагаа болгон энэ жишээний Хүснэгт 4-ийг үзнэ үү.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Кредит Бодит үнэ цэнийн залруулга 1,472,217

Бодит үнэ цэнийн залруулга (150,001,924ТН⁶⁶ – (226,259,827ТН + 26,019,880ТН – 103,750,000ТН))

6. Жил 5: Байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Зээлийн авлага	17,250,221	
	Кредит Хүүний орлого		17,250,221

Үр ашигт хүүний аргыг ашиглан хүүг (150,001,924 ТН x 11.5%) хуримтлуулах.

Дебит	Харилцах данс	95,125,000	
	Кредит Зээлийн авлага		95,125,000

Төлөгдөөгүй үлдэгдлээс хүлээн авсан хүү ба үндсэн дүнгийн хүлээн зөвшөөрөлт (175 сая ТН x 11.5%-ийн хүүний төлөлт + 75 сая ТН-ийн үндсэн дүнгийн буцаан төлөлт).

Дебит	Зээлийн авлага	3,750,048	
	Кредит Бодит үнэ цэнийн залруулга		3,750,048

Бодит үнэ цэнийн залруулга (75,877,193ТН⁶⁶ – (150,001,924ТН + 17,250,221ТН – 95,125,000ТН))

7. Жил 6: Байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Зээлийн авлага	8,725,877	
	Кредит Хүүний орлого		8,725,877

Үр ашигт хүүний аргыг ашиглан хүүг (75,877,193 ТН x 11.5%) хуримтлуулах.

Дебит	Харилцах данс	86,500,000	
	Кредит Зээлийн авлага		86,500,000

Төлөгдөөгүй үлдэгдлээс хүлээн авсан хүү ба үндсэн дүнгийн хүлээн зөвшөөрөлт (100 сая ТН x 11.5%-ийн хүүний төлөлт + 75 сая ТН-ийн үндсэн дүнгийн буцаан төлөлт).

Дебит	Зээлийн авлага	1,896,930	
	Кредит Бодит үнэ цэнийн залруулга		1,896,930

Бодит үнэ цэнийн залруулга (0ТН⁶⁶ – (75,877,193ТН + 8,725,877ТН – 86,500,000ТН))

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Хүснэгт 1: Хорогдуулгын хуваарь (11.5 хувийн хүүтэй гэрээний эргэн төлөлтийг ашиглах)

	Жил 0 Мян.ТН	Жил 1 Мян.ТН	Жил 2 Мян.ТН	Жил 3 Мян.ТН	Жил 4 Мян.ТН	Жил 5 Мян.ТН	Жил 6 Мян.ТН
Үндсэн дүн	250,000	250,000	250,000	250,000	250,000	175,000	100,000
Хүү	-	28,750	28,750	28,750	28,750	20,125	11,500
Төлөлт	-	(28,750)	(28,750)	(28,750)	(103,750)	(95,125)	(86,500)
Үлдэгдэл	250,000	250,000	250,000	250,000	175,000	100,000	-

Хүснэгт 2: Гэрээний мөнгөн гүйлгээг дискаунтчлах (11.5 хувийн зах зээлийн хүүнд үндэслэсэн)

	Жил 1 ТН	Жил 2 ТН	Жил 3 ТН	Жил 4 ТН	Жил 5 ТН	Жил 6 ТН
Үндсэн дүнгийн үлдэгдэл	250,000,000	250,000,000	250,000,000	175,000,000	100,000,000	25,000,000
Хүүний авлага	28,750,000	28,750,000	28,750,000	28,750,000	20,125,000	11,500,000
Нийт хүлээн авалт (үндсэн дүн ба хүү)	28,750,000	28,750,000	28,750,000	103,750,000	95,125,000	86,500,000
Мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ	25,784,753	23,125,339	20,740,215	67,125,670	55,197,618	45,016,000
Мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнүүдийн нийт дүн						<u>236,989,595</u>
Төлсөн мөнгөн дүн						250,000,000
Хасах: Мөнгөн орлогын өнөөгийн үнэ цэнэ (анх хүлээн зөвшөөрөх үеийн зээлийн бодит үнэ цэнэ)						236,989,595
Зардал гэж хүлээн зөвшөөрөх уг зээлийн зах зээлийн бус хэсэг						<u>13,010,405</u>

Хүснэгт 3: Үр ашигт хүүний аргыг ашиглан зээлийн үлдэгдэл ба хүүг тооцоолох

	Жил 1 ТН	Жил 2 ТН	Жил 3 ТН	Жил 4 ТН	Жил 5 ТН	Жил 6 ТН
Үндсэн дүн	236,989,595	235,493,398	233,825,139	231,965,030	154,891,009	77,578,475
Хүүний хуримтлуулалт	27,253,803	27,081,741	26,889,891	26,675,979	17,812,466	8,921,525
Хүүний хүлээн авалт	(28,750,000)	(28,750,000)	(28,750,000)	(28,750,000)	(20,125,000)	(11,500,000)
Үндсэн дүнгийн хүлээн авалт	-	-	-	(75,000,000)	(75,000,000)	(75,000,000)
Үлдэгдэл	235,493,398	233,825,139	231,965,030	154,891,000	77,578,475	-

Хүснэгт 4: Зээлийн бодит үнэ цэнэ

	Жил 1 ТН	Жил 2 ТН	Жил 3 ТН	Жил 4 ТН	Жил 5 ТН	Жил 6 ТН
Бодит үнэ цэнэ	236,989,595	235,493,398	231,058,918	226,259,827	150,001,924	75,877,193
Зах зээлийн хүүний түвшин (жилийн эхэнд)	11.5 хувь	11.5 хувь	12 хувь	13 хувь	14 хувь	14 хувь
Зах зээлийн хүүний	11.5 хувь	12 хувь	13 хувь	14 хувь	14 хувь	14 хувь

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

түвшин (жилийн эцэст)						
Хүүний хуримтлуулалт (11.5 хувиар)	27,253,803	27,081,741	26,571,776	26,019,880	17,250,221	8,725,877
Хүүний хүлээн авалт	(28,750,000)	(28,750,000)	(28,750,000)	(28,750,000)	(20,125,000)	(11,500,000)
Үндсэн дүнгийн хүлээн авалт	-	-	-	(75,000,000)	(75,000,000)	(75,000,000)
Бодит үнэ цэнийн залруулга	-	(2,766,221)	(2,620,867)	1,472,217	3,750,048	1,896,930
Үлдэгдэл	235,493,398	231,058,918	226,259,827	150,001,924	75,877,193	-

Жишээ 22—Хөнгөлөлттэй зээлийн төлөлт (Зээл олгох баталгаа)

ҮЖ162. Улаан буудайн тариалалтын улирал эхлэхийн өмнө, хөдөө аж ахуйн газар нь шалгуур хангасан тариаланчдад бага хүүтэй зээлийг тухайн улсын улаан буудайн тариалалтыг дэмжих арга хэмжээ болгон олгодог. Энэхүү зээлийг тариалалтын улирлын дурын хугацаанд тариалан эрхлэгчдийн хүсэлтээр олгох боломжтой бөгөөд дараагийн тариалалтын улирлаас өмнө буцааж төлөх ёстой.

ҮЖ163. 20х1 оны ургац хураалтын улирал эхлэхийн өмнө хөдөө аж ахуйн газар нь янз бүрийн тариаланчдад 100 сая ТН-ийн зээл олгох боломжтой байсан. Ургац хураалтын улирал эцэс гэхэд тус газар нь дараах нөхцөл, болзолтойгоор бүх 100 сая ТН-ийн зээлийг олгосон байв:

- Үндсэн дүнг дараагийн ургац хураалтын улирлаас өмнө буцааж төлнө.
- Зээлийн төлөгдөөгүй үлдэгдэлд хүү тооцохгүй. Адилтгах зээлийн зах зээлийн хүүний түвшин 1.5 хувь байсан гэж үзнэ.

Зээл олгох баталгааг үүсгэх үед тухайн хэрэглүүр зээлийн үнэ цэнийн бууралттай гэсэн ямар нэг шинж тэмдэг байгаагүй.

Хувилбар 1: Зээл олгох баталгааны хугацаанд тодорхойлсон, хүлээгдэж буй зээлийн алдагдал байхгүй

ҮЖ164. Хөдөө аж ахуйн газар нь зах зээлийн түвшнээс бага хүүтэй зээл олгох баталгаа гаргасан тул уг баталгааг 45(г) ба 57-р параграфын дагуу тайлагнана. Зээл олгох баталгааг анх бүртгэх нэгдсэн журналын бичилт нь дараах байдалтай байна:

1. Анх хүлээн зөвшөөрөх үед байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Зардал	1,477,833	
	Кредит	Зээл олгох баталгааны өглөг	1,477,833

Зах зээлийн түвшнээс бага хүүтэй зээл олгох баталгааны хүлээн зөвшөөрөлт.

Уг зээл олгох баталгааг 57-р параграфын дагуу эхлээд бодит үнэ цэнээр хэмжинэ.

ҮЖ165. Зээл олгох баталгааны хугацаанд өөр дансны бичилт хийх шаардлагагүй. Энэ нь хөдөө аж ахуйн газар тухайн баталгааны хувьд хураамж авахгүй байх сонголт хийсний үр дүн юм. Иймээс уг зээл олгох баталгаатай холбоотойгоор хүлээн зөвшөөрөх орлого байхгүй бөгөөд тус газар нь тухайн баталгааны хугацаанд ямар нэг зээлийн алдагдлыг тодорхойлоогүй.

ҮЖ166. Хөнгөлөлттэй зээлийг олгож, зээл олгох баталгааг хэрэгжүүлэх үед уг хөнгөлөлттэй зээлийн мөн чанарыг үнэлнэ. Хөдөө аж ахуйн газар нь уг санхүүгийн хөрөнгийг 39-44-р параграфын дагуу ангилна. Энэ жишээний баримт мэдээнд үндэслэн тус хөдөө аж ахуйн газар нь тухайн санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр хэмжсэн гэж ангилсан.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

ҮЖ167. Хөнгөлөлттэй зээлийг бүртгэх нэгдсэн журналын бичилт нь дараах байдалтай байна:

2. Анх хүлээн зөвшөөрөх үед байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Зээлийн авлага	98,522,167	
Дебит	Зээл олгох баталгааны өглөг	1,477,833	
	Кредит Мөнгө		100,000,000

Зээлийн урьдчилгааг бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх.

Уг зээл олгох баталгааг 57-р параграфын дагуу эхлээд бодит үнэ цэнээр хэмжинэ.

Арилжааны бус зардал гэж үзэх уг зээлийн зах зээлийн бус хэсгийн хувьд зардлыг хүлээн зөвшөөрөхдөө МЗУ125(б) параграфыг харгалзан үзнэ. Гэвч зээл олгох баталгааны нэг хэсэг байдлаар зардлыг өмнө нь хүлээн зөвшөөрсөн тул цаашид зардал хүлээн зөвшөөрөх шаардлагагүй.

3. Хүүг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

Дебит	Зээлийн авлага	1,477,833	
	Кредит Хүүний орлого		1,477,833

Үр ашигт хүүний аргыг ашиглан хүүг (98,522,167 ТН x 1.5%) хуримтлуулах.

Дебит	Харилцах данс	28,750,000	
	Кредит Зээлийн авлага		28,750,000

Хүүний төлөлт, 250 сая ТН x 11.5%.

4. Зээлийн буцаан төлөлтийг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

Дебит	Мөнгө	100,000,000	
	Кредит Зээлийн авлага		100,000,000

Хөдөө аж ахуйн газар нь 100 сая ТН-ийн үндсэн дүнг буцаан төлүүлж авна.

Хувилбар 2: Зээл олгох баталгааны хугацаанд тодорхойлсон зээлийн үнэ цэнийн бууралтын нотолгоо

ҮЖ168. Хөдөө аж ахуйн газар нь зах зээлийн түвшнээс бага хүүтэй зээл олгох баталгаа гаргасан тул уг баталгааг 45(г) ба 57-р параграфын дагуу тайлагнана. Зээл олгох баталгааг анх бүртгэх нэгдсэн журналын бичилт нь дараах байдалтай байна:

1. Анх хүлээн зөвшөөрөх үед байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Зардал	1,477,833	
	Кредит Зээл олгох баталгааны өглөг		1,477,833

Зах зээлийн түвшнээс бага хүүтэй зээл олгох баталгааны хүлээн зөвшөөрөлт.

Уг зээл олгох баталгааг 57-р параграфын дагуу эхлээд бодит үнэ цэнээр хэмжинэ.

ҮЖ169. Зээл олгох баталгааны хугацаанд хөдөө аж ахуйн газар нь тухайн улирлын улаан буудайн ургацын өгөөж анхны төсөвлөсөн хэмжээнээс бага байхаар хүлээгдэж буй гэдгийг тогтоосон. Бэлэн боломжтой байгаа хамгийн сүүлийн үеийн мэдээллийг ашигласнаар тус хөдөө аж ахуйн газар нь дараах тооцооллыг хийнэ:

- Зээлийн багцын нийт хугацаанд үл биелүүлэлт гарах магадлал 5 хувь байна; ба
- Тухайн үл биелүүлэлтийн алдагдал нь 35 хувь бөгөөд үндсэн дүнг буцаан төлөх үед үүснэ.

2. Үнэ цэнийн бууралтыг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

Дебит	Үнэ цэнийн бууралтын зардал	1,724,137	
Дебит	Зээл олгох баталгааны өглөг	1,477,833	
	Кредит Гарзын хасагдуулга		3,201,970

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

1.724 сая ТН-ийн үнэ цэнийн бууралтын зардлын хүлээн зөвшөөрөлт.

Үнэ цэнийн бууралтын зардал 1.724 сая ТН бөгөөд мөнгөн гүйлгээний авлагын дүнг (100 сая ТН) үл биелүүлэлтийн магадлал (5 хувь) ба тухайн үл биелүүлэлтийн алдагдлаар (35 хувь) үржүүлж, нэг жилийн үр ашигт хүүний хувиар (1.5 хувиар) дискаунтчилж, үүнийг тооцоолно.

ҮЖ170. Хөнгөлөлттэй зээлийг олгож, зээл олгох баталгааг хэрэгжүүлсэн тул уг хөнгөлөлттэй зээлийн мөн чанарыг үнэлнэ. Хөдөө аж ахуйн газар нь уг санхүүгийн хөрөнгийг 39-44-р параграфын дагуу ангилна. Энэ жишээний баримт мэдээнд үндэслэн тус хөдөө аж ахуйн газар нь тухайн санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр хэмжсэн гэж ангилсан.

ҮЖ171. Хөнгөлөлттэй зээлийг бүртгэх нэгдсэн журналын бичилт нь дараах байдалтай байна:

3. Анх хүлээн зөвшөөрөх үед байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Зээлийн авлага	96,798,030	
Дебит	Гарзын хасагдуулга	3,201,970	
	Кредит Мөнгө		100,000,000

Зээлийн урьдчилгааг бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх.

Үүсгэн гаргасан зээлийн үнэ цэнийн бууралттай, хөнгөлөлттэй зээлийн зах зээлийн бус хэсгийн хувьд зардлыг хүлээн зөвшөөрөхдөө МЗУ125(б) параграфыг харгалзан үзнэ. Гэвч зээл олгох баталгааны нэг хэсэг байдлаар зардлыг өмнө нь хүлээн зөвшөөрсөн тул цаашид зардал хүлээн зөвшөөрөх шаардлагагүй.

4. Хүүг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

Дебит	Зээлийн авлага	1,451,970	
	Кредит Хүүний орлого		1,451,970

Үр ашигт хүүний аргыг ашиглан хүүг (96,798,030 ТН x 1.5%) хуримтлуулах.

ҮЖ172. Зээл хугацаа дуусахаас өмнө, ургац хураалт нь уг баталгааны хугацаанд төсөвлөж байснаас идэвхитэй явагдсан. Үндсэн дүнгийн зээлийн алдагдал нь 500,000 ТН байхаар хүлээгдэж байв.

5. Үнэ цэнийн бууралтын олзыг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

Дебит	Зээлийн авлага	1,250,000	
	Кредит Үнэ цэнийн бууралтын олз		1,250,000

1.25 сая ТН-ийн үнэ цэнийн бууралтын олзын хүлээн зөвшөөрөлт.

Нийт 500,000ТН (99,500,000ТН-96,798,030ТН-1,451,970ТН)-ийн хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөхийн түлд 1.25 сая ТН-ээр бууруулах шаардлагатай.

6. Зээлийн буцаан төлөлтийг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

Дебит	Мөнгө	99,500,000	
	Кредит Зээлийн авлага		99,500,000

Хөдөө аж ахуйн газар нь 99.5 сая ТН-ийн үндсэн дүнг буцаан төлүүлж авна.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Тооцоолол

Хүснэгт 1: Хорогдуулгын хуваарь (1.5 хувийн хүүтэй гэрээний эргэн төлөлтийг ашиглах)

	Жил 0	Жил 1
	ТН	ТН
Үндсэн дүн	100,000,000	100,000,000
Хүү	-	-
Төлөлт	-	100,000,000
Үлдэгдэл	100,000,000	-

Хүснэгт 2: Гэрээний мөнгөн гүйлгээг дискаунтчлах (1.5 хувийн зах зээлийн хүүнд үндэслэсэн)

	Жил 1
	ТН
Үндсэн дүнгийн үлдэгдэл	100,000,000
Хүүний өглөг	-
Нийт төлөлт (үндсэн дүн ба хүү)	100,000,000
Төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнэ	98,522,167
Төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнүүдийн нийт дүн	98,522,167
Төлсөн мөнгөн дүн	100,000,000
Хасах: Мөнгөн зарлагын өнөөгийн үнэ цэнэ (анх хүлээн зөвшөөрөх үеийн зээлийн бодит үнэ цэнэ)	98,522,167
Зардал гэж хүлээн зөвшөөрөх уг зээлийн зах зээлийн бус хэсэг	1,477,833

Хүснэгт 3: Үр ашигт хүүний аргыг ашиглан зээлийн үлдэгдэл ба хүүг тооцоолох

	Жил 1
	ТН
Үндсэн дүн	98,522,167
Хүүний хуримтлуулалт	1,477,833
Хүүний хүлээн авалт	-
Үндсэн дүнгийн хүлээн авалт	100,000,000
Үлдэгдэл	-

Санхүүгийн баталгаа (МЗУ131-МЗУ136-р параграф)

Жишээ 23—Нэрлэсэн төлбөртэй гаргасан санхүүгийн баталгааны гэрээ

ҮЖ173. В байгууллага нь А улсын автомашины гол үйлдвэрлэгч юм. 20X1 оны 01 дүгээр сарын 01-нд А засгийн газар (гаргагч) нь В байгууллагын (зээлдэгчийн) 5 жилийн хугацаатай авсан бөгөөд 20X3 онд болон 20X5 онд тус бүр 25 сая ТН (тооцооны нэгж)-ээр хоёр удаа тэнцүү дүнгээр хэсэгчлэн буцаан төлөх 50 сая ТН-ийн зээлийг үл төлсөний санхүүгийн үр дагаврыг Б байгууллагад (эзэмшигч) нөхөн олгох санхүүгийн баталгааны гэрээг Б байгууллагатай байгуулсан. В байгууллага нь А засгийн газарт 5,000 ТН-ийн нэрлэсэн төлбөрийг төлнө. Анх хүлээн зөвшөөрөх үед А засгийн газар нь уг санхүүгийн баталгааны гэрээг бодит үнэ цэнээр хэмжинэ. Үнэлгээний арга зүй ашигласнаар А засгийн газар нь санхүүгийн баталгааны гэрээний бодит үнэ цэнийг 5,000,000 ТН гэж тодорхойлсон.

ҮЖ174. 20X1 оны 12 сарын 31-нд В байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүнг нягталж шалгаснаар, түүнчлэн хэтийн мэдээллийг, үүн дотроо автомашин үйлдвэрлэлийн салбарын хүлээгдэж буй хандлагыг үнэлснээр А засгийн газар нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдээгүй гэж тодорхойлсон. 45(в) параграфын хэмжилтийн шаардлагуудыг мөрдөж, А засгийн газар нь тухайн санхүүгийн баталгааны гэрээг дараах дүнгүүдийн аль өндрөөр хэмжинэ:

- (i) Энэ Стандартын дагуу тооцоолсон гарзын хасагдуулгын дүн; ба
- (ii) Анхны хүлээн зөвшөөрсөн дүнгээс тэдгээр хүлээн зөвшөөрсөн орлогын хуримтлагдсан дүнг хассан дүн.

А засгийн газар нь 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр гарзын хасагдуулгыг хэмжинэ. А засгийн газар нь анхны хүлээн зөвшөөрсөн дүнгээс илүүгүй дүнгээр гарзын хасагдуулгыг тооцоолно. Иймээс А засгийн газар нь өөрийн санхүүгийн байдлын тайландаа нэмэлт өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй. Уг санхүүгийн баталгааны гэрээтэй холбоотойгоор А засгийн газар нь бодит үнэ цэнийн болон зээлийн эрсдлийн хувьд УСНББОУС 30, *Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга*-д заасан тодруулгыг хийнэ. А засгийн газар нь уг хэрэглүүрийн анхны бодит үнэ цэнийн хувьд 1,000,000ТН-ийн (5,000,000ТН-ийн нийт төлбөр/5 жил) орлогыг өөрийн санхүүгийн үр дүнгийн тайландаа хүлээн зөвшөөрнө.

ҮЖ175. 20X2 онд автомашины үйлдвэрлэлийн салбарт бууралт үүссэн бөгөөд энэ нь В байгууллагад нөлөө үзүүлсэн. Хэдийгээр өөрийн хүүний төлбөрийн үүргийг биелүүлсэн боловч В байгууллага нь дампуурлаас сэргийлэхийн тулд үндсэн дүнгийн эхний буцаан төлөлтийг хийгээгүй. А засгийн газар нь В байгууллагад бүтцийн өөрчлөлт хийж чадах боломжит худалдан авагчтай (Г байгууллага) хэлцэл хийж эхэлсэн. Г байгууллага нь Б байгууллагад төлөх зээлийн сүүлийн хэсэгчилсэн төлбөрийг хариуцаж болох боловч эхний хэсэгчилсэн төлбөрийг төлөхгүй гэдгээ илэрхийлсэн. А засгийн газар нь санхүүгийн баталгааны гэрээний анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн гэж тодорхойлсон бөгөөд уг санхүүгийн баталгааны гэрээтэй холбоотой гарзын хасагдуулгыг нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр хэмжсэн. А засгийн газар нь нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг 25.5 сая ТН гэж тооцоолж, ийм хэмжээний зардал хүлээн зөвшөөрсөн ба өр төлбөрөө 22.5 сая ТН-ээр нэмэгдүүлсэн. (Г байгууллагад борлуулсны дараа, засгийн газар нь анхны хэсэгчилсэн төлбөрөөс 25 сая ТН-ийн, эцсийн хэсэгчилсэн төлбөрөөс 500,000 ТН-ийн алдагдал хүлээх бөгөөд нийт өр төлбөр 25.5 сая ТН болно. Иймээс санхүүгийн баталгааны одоогийн 3 сая ТН-ийн үлдэгдлийг 22.5 сая ТН-ээр нэмэгдүүлэх шаардлагатай юм.)

ҮЖ176. Анхны худалдан авалтын өдрөөр болон тухайн тайлангийн өдрөөр хийх журналын бичилтүүд дараах байдалтай байна:

1. Анх хүлээн зөвшөөрөх үед байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Харилцах данс	5,000	
Дебит	Зардал	4,995,000	
	Кредит	Санхүүгийн баталгааны гэрээ	5,000,000

2. Жил 1: Байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Дебит	Санхүүгийн баталгааны гэрээ	1,000,000	
	Кредит Орлого		1,000,000
<i>5,000,000 ТН-ийн орлогыг 5 жилийн хугацаанд хүлээн зөвшөөрнө.</i>			

3. Жил 2: Байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Санхүүгийн баталгааны гэрээ	1,000,000	
	Кредит Орлого		1,000,000
<i>5,000,000 ТН-ийн орлогыг 5 жилийн хугацаанд хүлээн зөвшөөрнө.</i>			

Дебит	Зардал	22,500,000	
	Кредит Санхүүгийн баталгааны гэрээ		22,500,000
<i>Нийт хугацаанд хүлээгдэж буй 25.5 сая ТН-ийн зээлийн алдагдлаас өр төлбөрөөр хүлээн зөвшөөрсөн 3,000,000 ТН-ийг хасна.</i>			

Бодит үнэ цэнийн хэмжилтийн анхаарах зүйлс (66-68-р параграф)

ҮЖ177. Жишиг үнэгүй өмчийн хэрэглүүрийг үнэлэх үнэлгээний янз бүрийн арга зүйг Үлгэрчилсэн жишээ 23-26-д харуулав. Үнэлгээний тохиромжтой арга зүйг сонгох үедээ МЗУ149-МЗУ154-р параграфын шаардлагуудыг харгалзан үзсэнээр мэргэжлийн шүүн тунгаалт хийдэг.

Жишээ 24—Жишиг үнэгүй өмчийн хэрэглүүрийн үнэлгээ (Ижил буюу төсөөтэй хэрэглүүрийн хувьд төлсөн ажил гүйлгээний үнэ)

ҮЖ178. 20X0 онд Үндэсний Баялагийн Сан нь хувийн компани болох Г байгууллагын 10 ширхэг өмчийн хувьцааг 1,000ТН-ээр худалдан авсан бөгөөд энэ нь тус Г байгууллагын эргэлтэнд байгаа саналын эрхтэй хувьцааны 10 хувийг илэрхийлэх юм. Үндэсний Баялагийн Сан нь жилээр санхүүгийн тайлангаа бэлтгэдэг бөгөөд 20X2 оны 12 дугаар сарын 31-нээр (өөрөөр хэлбэл, хэмжилтийн өдрөөр) Г байгууллага дахь өөрийн хяналтын бус өмчийн хувь оролцооны бодит үнэ цэнийг хэмжих шаардлагатай болсон.

ҮЖ179. 20X2 оны 12 дугаар сард Г байгууллага нь бусад хөрөнгө оруулагчдад өмчийн хувьцааг (арван ширхэг хувьцааг 1,200ТН-ээр) шинээр гаргаснаар санхүүжилтээ нэмэгдүүлсэн. 1,200 ТН-ээр өмчийн шинэ хувьцаа гаргах ажил гүйлгээний үнэ нь тэдгээр хувьцааг гаргасан өдрөөрх бодит үнэ цэнийг илэрхийлнэ гэж Үндэсний Баялагийн Сан дүгнэсэн.

ҮЖ180. Үндэсний Баялагийн Сан ба Г байгууллагын бусад хөрөнгө оруулагчдын аль аль нь ижил эрх, нөхцөл бүхий хувьцаатай. Бусад хөрөнгө оруулагчдад өмчийн хувьцааг шинээр гаргасан өдөр ба хэмжилтийн өдрийн хоорондох хугацаанд уг Г байгууллагын үйл ажиллагаа явуулдаг орчинд гаднын буюу дотоодын мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй. Иймээс 1,200 ТН нь Г байгууллага дахь түүний хяналтын бус өмчийн хувь оролцооны тухайн хэмжилтийн өдрөөрх бодит үнэ цэнийг хамгийн сайн төлөөлөн илэрхийлэх дүн юм гэж Үндэсний Баялагийн Сан дүгнэсэн.

Шинжилгээ

ҮЖ181. Хөрөнгө оруулагч нь тухайн үнэлж буй, жишиг үнэгүй өмчийн хэрэглүүртэй ижил төсөөтэй хэрэглүүрт саяхан хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд ажил гүйлгээний үнэ нь тус хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнийг төлөөлөн илэрхийлдэг тохиолдолд тэрхүү ажил гүйлгээний үнэ нь хэмжилтийн өдрөөр уг жишиг үнэгүй өмчийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг хэмжих ул үндэслэлтэй эхлэлийн цэг болно. Гэхдээ хөрөнгө оруулагч нь анхны хүлээн зөвшөөрөлтийн өдрөөс уг хэмжилтийн өдөр хүртэлх хугацаанд түүнд зохих ёсоор олдох боломжтой байгаа, тухайн санхүүжигчийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны талаархи бүх мэдээллийг ашиглах ёстой. Яагаад гэвэл, ийм мэдээлэл нь тухайн хэмжилтийн өдөр уг санхүүжигчийн жишиг үнэгүй өмчийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэд нөлөө үзүүлж болох юм.

Жишээ 25—Жишиг үнэгүй өмчийн хэрэглүүрийн үнэлгээ (Дискаунтчилсан мөнгөн гүйлгээ)

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

ҮЖ182. Сэргээгдэх эрчим хүч ашиглалтыг дэмжих санаачлагын нэг хэсэг болгон А засгийн газар нь Р байгууллагын 5 хувийн хяналтын бус өмчийн хувь оролцоог эзэмшдэг. Р байгууллага нь уг А улсад өндөр үр ашигтай нарны зай хураагуурыг боловсруулж буй хувийн компани юм. Доорх хүснэгтэнд харуулсанчлан, А засгийн газар нь тухайн байгууллагын 1,121.8 сая ТН-ийн үнэ цэнээс өрийн үнэ цэнийг (энэ тохиолдолд 240 сая ТН гэж үзье) хассанаар Р байгууллагын өмчийн тогтоосон бодит үнэ цэнийг тооцож гаргана. Р байгууллагын хүлээгдэж буй чөлөөт мөнгөн гүйлгээ (ЧМГ)-нээс тохируулах шаардлагатай, холбогдох үйл ажиллагааны бус зүйлс байхгүй гэж А засгийн газар дүгнэсэн.

ҮЖ183. Капиталын жинэлсэн дундаж өртөг (КЖДӨ) 8.9 хувь гэж үзэж, хүлээгдэж буй чөлөөт мөнгөн гүйлгээг (өөрөөр хэлбэл, хүүний зардал ба өрийн хөдөлгөөний өмнөх боловч хөшүүргийн нөлөөгүй татварын хувийг ашигласан татварын дараах мөнгөн гүйлгээ) дискаунтчилснаар Р байгууллагын үнэ цэнийг тооцоолсон. КЖДӨ-ийн тооцооллод дараах хувьсагчдыг оруулсан. Үүнд: өмчийн капиталын өртөг 10.9 хувь, өрийн капиталын өртөг 5.7 хувь, үр ашигт орлогын татвар 30 хувь, өрийг нийт капиталд хуваасан харьцаа 28.6 хувь, өмчийг нийт капиталд хуваасан харьцаа 71.4 хувь.

	Жил 0	Жил 1	Жил 2	Жил 3	Жил 4	Жил 5
	Мян.ТН	Мян.ТН	Мян.ТН	Мян.ТН	Мян.ТН	Мян.ТН
ЧМГ ⁴⁹	-	100	100	100	100	100
Терминал үнэ цэнэ ⁵⁰						1,121.8
ДМГ-ний арга, байгууллагын үнэ цэнээс өрийн бодит үнэ цэнийг хассан дүнг ашиглах						
Дискаунтын фактор ⁵¹		0.9182	0.8430	0.7740	0.7107	0.6525
ЧМГ ба терминал үнэ цэнийн өнөөгийн үнэ цэнэ ⁵²		91.8	84.3	77.4	71.1	797.2
Байгууллагын үнэ цэнэ	1,121.8					
Хасах: Өрийн бодит үнэ цэнэ	(240.0)					
Өмчийн тогтоосон бодит үнэ цэнэ	881.8					

ҮЖ184. Энэ жишээнд Р байгууллагын жишиг үнэгүй, бүх өмчийн хэрэглүүр нь ижил шинжүүдтэй ба эзэмшигчиддээ ижил эрх олгодог гэж үзсэн. Гэвч А засгийн газар нь дараах зүйлсийг харгалзахын тулд уг өмчийн тогтоосон бодит үнэ цэнийг (881.8 сая ТН) цаашид залруулах шаардлагатай гэж дүгнэсэн:

- Р байгууллага дахь А засгийн газрын хувь оролцоо нь хяналтын бус өмчийн оролцоо бөгөөд хяналттай холбоотой өгөөж байгаа гэж А засгийн газар дүгнэсэн учраас хяналтын бус хувь оролцооны хөнгөлөлт. Энэ жишээний зорилгын хувьд хяналтын бус оролцооны хөнгөлөлтийг 8.00 сая ТН гэж төсөөлсөн,⁵³ ба

⁴⁹ ЧМГ нь хүүний зардал ба өрийн хөдөлгөөний өмнөх мөнгөн гүйлгээг илэрхийлдэг. Хүүний зардлыг хасахгүйгээр татварын зардлыг тооцоолдог.

⁵⁰ Жил тутмын 100 сая ТН-ийн мөнгөн гүйлгээ нь тэг хувиар тасралтгүй өснө гэж үзсэнээр терминал үнэ цэнийг тооцоолсон. (өөрөөр хэлбэл, ирээдүйн мөнгөн гүйлгээнд инфляцийн үзүүлэх нөлөө нь зах зээлийн бууралтаар харилцан нөхөгдөхөөр хүлээгдэж байгаа гэж төсөөлсөн).

⁵¹ Дараах томъёог ашиглан дискаунтын факторыг тооцоолсон: $1/(1 + \text{КЖДӨ})^{\wedge \text{жилийн тоо}}$. Гэхдээ энэ томъёонд мөнгөн гүйлгээг тайлант үе бүрийн эцэст хүлээн авдаг гэж төсөөлдөг. Зарим үед мөнгөн гүйлгээг тухайн жилийн туршид их, бага ямар нэг хэмжээгээр жигд бусаар хүлээн авна гэж төсөөлөх нь илүү тохиромжтой байж болох юм (жилийн дундуур дискаунтчлах арга). Жилийн дундуур дискаунтчлах аргыг ашигласнаар 'n' жилийн хувьд дискаунтын факторыг дараах байдлаар тооцоолдог: $1/(1 + \text{КЖДӨ})^{\wedge (n - 0.5)}$.

⁵² ЧМГ болон терминал үнэ цэнийг харгалзах дискаунтын фактороор үржүүлж, өнөөгийн үнэ цэнийн дүнг тооцоолдог.

⁵³ Дээр дурдсан процесс нь өөрийн хяналтын бус өмчийн хувь оролцооны бодит үнэ цэнийг хэмжихдээ улсын секторын байгууллагын ашиглаж болох цорын ганц арга биш юм. Иймээс дээрх залруулгууд нь боломжит бүх залруулгын

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

- Р байгууллага дахь А засгийн газрын хувь оролцоо нь жишиг үнэгүй тул хөрвөх чадваргүй байдлын хөнгөлөлт. Энэ жишээний зорилгын хувьд хөрвөх чадваргүй байдлын хөнгөлөлтийг 4.09 сая ТН гэж төсөөлсөн.⁷¹

ҮЖ185. Эдгээрийн үр дүнд Р байгууллага дахь түүний 5 хувийн, хяналтын бус өмчийн хувь оролцооны уг хэмжилтийн өдрөөрх бодит үнэ цэнийг хамгийн сайн төлөөлөх үнэ нь доор харуулсанчлан, 32 сая ТН гэж А засгийн газар дүгнэсэн:

	Мян. ТН
Өмчийн тогтоосон бодит үнэ цэнэ х 5 хувь (өөрөөр хэлбэл, 881.8 х 5 хувь)	44.09
Хяналтын бус өмчийн хувь оролцооны хөнгөлөлт	(8.00)
Хөрвөх чадваргүй байдлын хөнгөлөлт	(4.09)
5 хувийн, хяналтын бус өмчийн хувь оролцооны бодит үнэ цэнэ	

Жишээ 26—Жишиг үнэгүй өмчийн хэрэглүүрийн үнэлгээ (Хязгаарлагдмал мэдээлэл бүхий тогтмол өсөлт)

ҮЖ186. Ф байгууллага нь хувийн компани юм. Т олон нийтийн хөрөнгө оруулалтын сан нь уг Ф байгууллагад 10 хувийн, хяналтын бус өмчийн хувь оролцоотой. Ф байгууллагын удирдлага нь хоёр жилээр төсвөө бэлтгэдэг. Гэхдээ дараагийн таван жилд хүлээгдэж буй өсөлтийн төлөвлөгөөний үндэслэл болох таамаглалуудыг авч хэлэлцдэг өөрийн Удирдах Зөвлөлийн жил тутмын хурлын материалыг Ф байгууллагын удирдлага нь Т олон нийтийн хөрөнгө оруулалтын сангийн менежерт өгдөг.

ҮЖ187. Удирдах Зөвлөлийн хурлын материалаас олж авсан уг мэдээлэлд үндэслэх ба Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцсэн өсөлтийн үндсэн таамаглалуудыг лавлагаа болгосноор Т олон нийтийн хөрөнгө оруулалтын сан нь хоёр жилийн төсвийг экстраполяци хийн тооцоолж, дискаунтчилсан мөнгөн гүйцлээний тооцооллыг гүйцэтгэдэг.

ҮЖ188. Ф байгууллагын удирдлагын хоёр жилийн дэлгэрэнгүй төсвөөс харвал, түүний борлуулалтын орлого, түүнчлэн хүү, татварын өмнөх ашиг (ХТӨА) нь 2003 онд харгалзан 200ТН ба 50ТН-д хүрэх юм. Борлуулалтын орлого нь цаашид 20Х8 он хүртэл жил тутам 5 хувиар өсөх ба ХТӨА-ийн ижил хувийн жинтэй (борлуулалтын орлогын хувиар илэрхийлвэл) байна гэж Ф байгууллагын удирдлага нь 2003 оны байдлаар хүлээж буйг Т олон нийтийн хөрөнгө оруулалтын сан ойлгож мэдсэн. Иймээс Т олон нийтийн хөрөнгө оруулалтын сан нь Ф байгууллагын ХТӨА-гийг дараах байдлаар төсөвлөсөн:⁵⁴

	Жил 1 Мян.ТН	Жил 2 Мян.ТН	Жил 3 Мян.ТН	Жил 4 Мян.ТН	Жил 5 Мян.ТН	Жил 6 Мян.ТН	Жил 7 Мян.ТН
Борлуулалт	150	200	210	221	232	243	255
ХТӨА-гийн хувийн жин	23%	25%	25%	25%	25%	25%	25%
ХТӨА	35	50	53	55	58	61	64

ҮЖ189. 20Х8 оны үед Ф байгууллага нь өөрийн тогтвортой өсөлтийн үе шатанд хүрнэ гэж түүний удирдлага найдаж буйг Т олон нийтийн хөрөнгө оруулалтын сан мөн ойлгож мэдсэн. Тогтмол өсөлтийн дискаунтын загварыг ашиглаж, терминал үнэ цэнийг тооцоолохын тулд Т олон нийтийн хөрөнгө оруулалтын сан нь уг Ф байгууллагын урт хугацааны хэтийн төлөв, түүний үйл ажиллагаа явуулдаг салбар болон улс орны эдийн засгийн байдалд үндэслэн терминал үнэ цэнийн урт хугацааны өсөлтийг 2 хувь гэж үзсэн. Хэрэв Ф байгууллага нь уг төсөвлөлтийн хугацааны эцсээр өөрийн тогтвортой өсөлтийн үе шатанд хүрээгүй байвал Т олон нийтийн хөрөнгө оруулалтын сан нь тогтвортой өсөлтийн

дэлгэрэнгүй жагсаалт гэж үзэж болохгүй. Шаардлагатай залруулга нь тухайн баримт материал болон нөхцөл байдлаас хамаардаг. Түүнчлэн, дээрх залруулгуудын дүнг дэлгэрэнгүй тооцоолоор дэмжин батлаагүй болно. Эдгээр залруулгыг зөвхөн үлгэрчлэн харуулах зорилгоор энд тусган оруулсан.

⁵⁴ Дискаунтчилсан мөнгөн гүйцлээний аргад ашиглах Ф байгууллагын ЧМГ-г гаргахдаа, Т олон нийтийн хөрөнгө оруулалтын сан нь Ф байгууллагын хоёр жилийн төсвийг, түүнчлэн уг санхүүжигчийн хөрөнгийн болон капиталын бүтэц, дахин хөрөнгө оруулалтын шаардлагууд, ажлын капиталын хэрэгцээний талаархи өөрийн ойлголтыг ашигласан.

үе шатанд хүрэх хүртэл төсөвлөлтийн хугацааг сунгаж, тэрхүү цэг дээр терминал үнэ цэнийг тооцоолох шаардлагатай юм.⁵⁵

ҮЖ190. Эцэст нь, Т олон нийтийн хөрөнгө оруулалтын сан нь Ф байгууллагын төсөөлсөн үржүүлэгчдийг түүний өрсөлдөгч, адилтгах компаниудын үзүүлэлтүүдтэй зэрэгцүүлснээр энэхүү үнэлгээг харилцан лавлагаа үүсгэж, шалгадаг.⁵⁶

Жишээ 27—Жишиг үнэгүй өмчийн хэрэглүүрийн үнэлгээ (Залруулсан цэвэр хөрөнгө)

ҮЖ191. А мужийн засгийн газар нь хувийн компани болох Ч байгууллагад 10 хувийн, хяналтын бус өмчийн хувь оролцоотой. Өөрийн хөрөнгө оруулагчдад, үүн дотроо А мужийн засгийн газарт цалингийн тооцооллын үйлчилгээ үзүүлдэг Ч байгууллагын хяналтын хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч байхгүй. Ч байгууллагын ажил гүйлгээ, улмаар үйлчилгээний хөлс нь түүний хөрөнгө оруулагчдын (хөрөнгө оруулагчид нь бүгд Я улсын Мужийн засгийн газрууд юм) ажиллагчдын нийт тооноос хамаардаг тул Ч байгууллага нь өөрийн өсөлтийн стратегигүй. Ч байгууллага нь маш бага ашгийн түвшинтэй бөгөөд түүнтэй адилтгах улсын секторын компани байхгүй.

ҮЖ192. А мужийн засгийн газар нь Ч байгууллага дахь өөрийн хяналтын бус өмчийн хувь оролцооны бодит үнэ цэнийг 20X1 оны 12 дугаар сарын 31-ний (өөрөөр хэлбэл, хэмжилтийн өдрийн) байдлаар хэмжих шаардлагатай. А мужийн засгийн газар нь Ч байгууллагын 20X1 оны 9 дүгээр сарын 30-наар огноолсон, хамгийн сүүлийн үеийн санхүүгийн байдлын тайланг хүлээн авсан.

ҮЖ193. Ч байгууллагын хамгийн сүүлийн үеийн санхүүгийн байдлын тайланд А мужийн засгийн газрын хийсэн залруулгууд нь дараах байдалтай байна:

- Ч байгууллагын гол хөрөнгө нь түүнийг анх 25 жилийн өмнө үүсгэн байгуулагдах үед худалдан авсан оффисын барилга юм. Үнэлгээний мэргэжилтэн нь хэмжилтийн өдрөөр уг барилгын бодит үнэ цэнийг 2,500 ТН гэж тогтоосон. Энэхүү үнэ цэнийг түүний 1,000 ТН-ийн дансны үнэтэй харьцуулсан.
- Төрийн өмчит компаниудад Ч байгууллагын оруулсан хөрөнгө оруулалтуудын бодит үнэ цэнэ нь 20X1 оны 9-р сарын 30-наас уг хэмжилтийн өдөр хүртэлх гурван сарын хугацаанд 500ТН-ээс 600ТН болж өөрчлөгдсөн.
- Ч байгууллага нь өөрийн эргэлтийн хөрөнгө болон богино хугацаат өр төлбөрийг бодит үнэ цэнээр хэмждэг гэдгийг А мужийн засгийн газар ажигласан. Ч байгууллагын үйл ажиллагааны хэмжээ нь маш жигд байдаг. Иймээс Ч байгууллагын 20X1 оны 9-р сарын 30-наарх санхүүгийн байдлын тайланд тусгасан эргэлтийн хөрөнгө болон богино хугацаат өр төлбөрийн дүн нь тухайн хэмжилтийн өдөр тэдгээрийн бодит үнэ цэнийг хамгийн сайнаар төлөөлөн илэрхийнэ гэж хөрөнгө оруулагч нь дүгнэсэн. Харин гажих ганц зүйл нь Ч байгууллагын худалдааны авлагад тусгасан 50ТН-ийн авлага 20X1 оны 9-р сарын 30-наас хойш найдваргүй болсон явдал юм.
- Ч байгууллагын удирдлагын загвар болон ашигт ажиллагаанд үндэслэн А мужийн засгийн газар нь түүний хүлээн зөвшөөрөөгүй байгаа биет бус хөрөнгийн дүн материаллаг бус гэж тооцоолсон.
- Ч байгууллагын 20X1 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон улирлын мөнгөн гүйлгээ нь материаллаг бус А мужийн засгийн газар тооцоолсон.

⁵⁵ Энэхүү жишээнд хоёр үе шаттай загварыг авч үзсэн. Эхний үе шатыг тодорхой тооны тайлант үеүдээр (20X2–20X8 он) илэрхийлнэ. Уг эхний үе шатны дараа, тогтмол өсөлтийн тайлант үе эхлэх бөгөөд Т олон нийтийн хөрөнгө оруулалтын сан нь Ф байгууллагын хувьд терминал үнэ цэнийг тооцоолно гэж үзсэн. Өөр зарим тохиолдолд хөрөнгө оруулагч нь хоёр шатат загвар биш, харин олон үе шатат загвар илүү тохиромжтой гэж дүгнэж болох юм. Олон үе шатат загвар нь тухайн тасалж авсан төсөвлөлтийн хугацаанаас цааших тайлант үеүдийг ерөнхийдөө хамарсан байдаг. Ийм тайлант үеүд нь терминал үнэ цэнийг тооцоолж болох тогтмол өсөлтийн үеэс өмнөх олон жилүүдийг хамарч болох бөгөөд энэ хугацаанд өсөлтийн түвшин буурч болох билээ.

⁵⁶ Энэхүү жишээний хувьд зах зээлийн оролцогч нар нь тухайн хэмжилтийн өдөр өмчийн хэрэглүүрийн үнийг тогтоохдоо харгалзах аливаа шаардлагатай залруулгыг (тухайлбал; хяналтын бус хувь оролцооны хөнгөлөлт, хөрвөх чадваргүй байдлын хөнгөлөлт гэх мэт) бодит үнэ цэнийн дүгнэлтэнд тусган оруулдаг гэж үзсэн.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

- Ч байгууллагын хөрөнгүүдээс ямар нэг томоохон борлуулалт хийнэ гэж А мужийн засгийн газар тооцоолоогүй. Иймээс Ч байгууллагын үнэ цэнийг тогтоох үедээ харгалзан үзэх шаардлагатай татварын материаллаг залруулга байхгүй гэж дүгнэсэн.

Ч байгууллага – Санхүүгийн байдлын тайлан (ТН)

	20X1.9.30	Залруулга	20X1.12.31-нээр тооцоолсон
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	2,000	1,500	3,500
Өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт	500	100	600
	2,500	1,600	4,100
Эргэлтийн хөрөнгө			
Худалдааны авлага	500	(50)	450
Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө	500	-	500
	1,000	(50)	950
Нийт хөрөнгө	3,500	1,550	5,050
ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР			
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,500	1,550	4,050
Богино хугацаат өр төлбөр	1,000	0	1,000
Нийт цэвэр хөрөнгө/өмч ба өр төлбөр	3,500	1,550	5,050

ҮЖ194. А мужийн засгийн газрын Ч байгууллага дахь 10 хувийн хяналтын бус хувь оролцоо нь аливаа залруулгыг (тухайлбал; хөрвөх чадваргүй байдлын хөнгөлөлт, хяналтын бус хувь оролцооны хөнгөлөлтийг) харгалзан үзэхийн өмнө 405ТН (10 хувь х 4,050ТН = 405ТН) байсан. Энэ жишээний зорилгын хувьд хөрвөх чадваргүй байдлын хөнгөлөлт нь 40ТН, хяналтын бус хувь оролцооны хөнгөлөлт нь 80ТН байна гэж төсөөлсөн.

ҮЖ195. Дээр дурдсан баримт материал болон нөхцөл байдалд үндэслэн А мужийн засгийн газар нь Ч байгууллага дахь түүний 10 хувийн хяналтын бус хувь оролцооны бодит үнэ цэнийг хамгийн сайн төлөөлөх үнэ уг хэмжилтийн өдрөөр 285ТН (405ТН – (40ТН – 85ТН) = 285ТН) байна гэж дүгнэсэн.⁵⁷

Жишээ 28—Арилжааны бус бүрэлдэхүүн хэсэгтэй, жишиг үнэгүй өмчийн хэрэглүүрийн үнэлгээ

ҮЖ196. 20X6 оны 7 дугаар сарын 01-нд А үндэсний засгийн газар нь Б Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банкны 1,000 ширхэг хувьцааг 5,000 ТН-ээр буюу нэгж хувьцааг 5ТН-ээр худалдан авсан. А үндэсний засгийн газар нь хяналтын бус хувьцаа эзэмшигч тул тус Банкны төсөв буюу мөнгөн гүйлгээний прогнозыг хүлээн аваагүй. А үндэсний засгийн газар нь өөрийн санхүүгийн тайлангаа бэлтгэдэг ба уг Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банкн дахь өөрийн хяналтын бус өмчийн хувь оролцооны бодит үнэ цэнийг 20X6 оны 12 дугаар сарын 31-нээр (өөрөөр хэлбэл, хэмжилтийн өдрөөр) хэмжиж байна.

ҮЖ197. Жишиг үнэгүй өмчийн хэрэглүүрийн хувьд 20X6 оны 7 дугаар сард төлсөн дүн (5,000ТН) нь Б Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банкн дахь уг хөрөнгө оруулагчийн хяналтын бус хувь оролцооны бодит үнэ цэнийг тухайн хэмжилтийн өдрөөр хэмжих зохих эхлэлийн цэг болно. Гэвч өөр бусад хүчин зүйлс оршин буйг илэрхийлэх нотолгоо байгаа, эсвэл уг ажил гүйлгээний үнэ нь тухайн хэмжилтийн өдрөөрх бодит үнэ цэнийн төлөөлөл биш гэдгийг бусад нотолгоо харуулж байвал тэрхүү төлсөн дүнг залруулах шаардлагатай эсэхийг А үндэсний засгийн газар нь үнэлэх хэрэгтэй. Тухайлбал; зарим тохиолдолд улсын секторын байгууллага нь тухайн хүлээн авагчид татаас олгохын тулд уг худалдан авсан хувьцааны бодит үнэ цэнээс илүү төлбөр шилжүүлж болох юм. Уг ажил гүйлгээний үнэ нь өмчийн хэрэглүүрийн төлбөр ба татаасыг агуулдаг учраас ийм тохиолдолд А үндэсний засгийн газар

⁵⁷ Дээр дурдсан процесс нь өөрийн хяналтын бус өмчийн хувь оролцооны бодит үнэ цэнийг хэмжихдээ улсын секторын байгууллагын ашиглаж болох цорын ганц арга биш юм. Иймээс дээрх залруулгууд нь боломжит бүх залруулгын дэлгэрэнгүй жагсаалт гэж үзэж болохгүй. Шаардлагатай залруулга нь тухайн баримт материал болон нөхцөл байдлаас хамаардаг. Түүнчлэн, дээрх залруулгуудын дүнг дэлгэрэнгүй тооцооллоор дэмжин батлаагүй болно. Эдгээр залруулгыг зөвхөн үлгэрчлэн харуулах зорилгоор энд тусган оруулсан.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

нь ажил гүйлгээний үнийг зохих ёсоор залруулж, тухайн төлбөрийн хөнгөлөлтийн хэсгийн хувьд зардал хүлээн зөвшөөрнө.

Жишээ 29—Арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн, жишиг үнэгүй өмчийн хэрэглүүрийн үнэлгээ

ҮЖ198. 20X1 оны 01 дүгээр сарын 01-нд А үндэсний засгийн газар нь Б Олон Улсын Хөгжлийн Банкинд 1,000 ТН шилжүүлсэн. Үүний хариуд Б банк нь 8.00 ТН-ийн нэрлэсэн үнэтэй 100 ширхэг энгийн хувьцааг гаргаж өгсөн. Тухайн ажил гүйлгээний баримтжуулалтаар нотлон харуулсанчлан, А үндэсний засгийн газар нь 1,000 ТН шилжүүлснээр 200 ТН-ийн хөнгөлөлт үзүүлж байна.

ҮЖ199. Уг ажил гүйлгээг тайлагнах үедээ А үндэсний засгийн газар нь 1,000 ТН-ийн шилжүүлгэд агуулагдаж буй хоёр бүрэлдэхүүн хэсгийг тогтоосон. Эхний бүрэлдэхүүн хэсэг нь 200ТН-ийн арилжааны бус зардал юм. Энэхүү бүрэлдэхүүн хэсгийг тайлагнах үедээ А үндэсний засгийн газар нь МЗУ128-МЗУ130-р параграфт дурдсан, заавар удирдамжийг мөрдөнө.

ҮЖ200. Хоёр дахь бүрэлдэхүүн хэсэг нь Б банкин дахь 100 ширхэг энгийн хувьцаа юм. УСНББОУС 41 нь санхүүгийн хэрэглүүрийг анхны хүлээн зөвшөөрөлтийн үед бодит үнэ цэнээр хэмжихийг шаарддаг бөгөөд ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжээгүй санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн хувьд шууд хамааруулж болох ажил гүйлгээний зардлыг нэмэх буюу хасах шаардлагатай байдаг.

ҮЖ201. Анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн бодит үнэ цэнийн хамгийн сайн нотолгоо нь ихэвчлэн тухайн ажил гүйлгээний үнэ байдаг тул уг ажил гүйлгээний баримтжуулалтаар нотлон харуулсан 800 ТН-ийн (100 энгийн хувьцаа х нэгжийн 8ТН-ийн нэрлэсэн үнэ) ажил гүйлгээний үнэ нь анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн зохистой үнэ гэж А үндэсний засгийн газар тодорхойлсон.

ҮЖ202. Ажил гүйлгээний баримтжуулалтаас гадна бусад үндэсний засгийн газруудтай Б банкны хийсэн адилтгах ажил гүйлгээнд үндэслэн А үндэсний засгийн газар нь нэгжийн 8ТН бол нэгж хувьцааны бодит үнэ цэнэ мөн гэж дүгнэсэн. Адилтгах ажил гүйлгээ бүрийн хувьд Б банк нь энгийн хувьцааг 8ТН-ээр гаргасан байна.

Жишээ 30—Өрийн үүргийн үнэлгээ: Жишиг үнэ

ҮЖ203. 20X1 оны 01 дүгээр сарын 01-нд Б мужийн засгийн газар нь ВВВ зэрэглэлтэй, худалдаа арилжааны зорилготой, таван жилийн хугацаатай, жил бүр 10 хувийн купоны тогтмол хүүтэй, 2 сая ТН-ийн өрийн хэрэглүүрийг нэрлэсэн үнээр гаргасан. Б мужийн засгийн газар нь энэхүү санхүүгийн өр төлбөрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан.

ҮЖ204. Хуримтлагдсан хүүг төлсний дараа, 20X1 оны 12 дугаар сарын 31-нд 1,000 ТН-ийн нэрлэсэн үнэтэй хэрэглүүрийг идэвхитэй зах зээлд хөрөнгө байдлаар 929 ТН-ээр арилжиж байв. Өөрийн өр төлбөрийн бодит үнэ цэнийн хэмжилтийн анхны орц мэдээ болгон Б мужийн засгийн газар нь идэвхитэй зах зээл дэх тухайн хөрөнгийн жишиг үнийг $(929ТН \times [2 \text{ сая ТН}/1,000ТН]) = 1,858,000ТН$ ашигладаг.

ҮЖ205. Идэвхитэй зах зээл дэх тухайн хөрөнгийн жишиг үнэ нь түүний өр төлбөрийн бодит үнэ цэнийг төлөөлөн илэрхийлэх эсэхийг тодорхойлохдоо, Б мужийн засгийн газар нь өр төлбөрийн бодит үнэ цэнийн хэмжилтэнд хамаарахгүй хүчин зүйлсийн үр нөлөөг тэрхүү хөрөнгийн жишиг үнэд тусган оруулдаг эсэхийг үнэлж үзнэ. Б мужийн засгийн газар нь тухайн хөрөнгийн жишиг үнэд залруулга хийх шаардлагагүй гэж тодорхойлсон. Иймээс түүний өрийн хэрэглүүрийн 20X1 оны 12 дугаар сарын 31-ний бодит үнэ цэнэ нь 1,858,000 ТН гэж Б мужийн засгийн газар дүгнэсэн. Б мужийн засгийн газар нь бодит үнэ цэнийн шатлалын Түвшин 1-д хамаарах өөрийн өрийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн хэмжилтийг УСНББОУС 30, *Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга*-ын дагуу ангилж, тодруулна.

Жишээ 31—Өрийн үүргийн үнэлгээ: Өнөөгийн үнэ цэнийн арга зүй

ҮЖ206. 20X1 оны 01-р сарын 01-нд В үндэсний засгийн газар нь ВВВ зэрэглэлтэй, таван жилийн хугацаатай, жил бүр 10 хувийн купоны тогтмол хүүтэй, 2 сая ТН-ийн өрийн хэрэглүүрийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд нэрлэсэн үнээр гаргасан. В үндэсний засгийн газар нь энэхүү санхүүгийн өр төлбөрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан.

ҮЖ207. 20X1 оны 12-р сарын 31-нд В үндэсний засгийн газар нь ВВВ зэрэглэлтэй хэвээр байна. Зах зээлийн нөхцөл байдал, үүн дотроо боломжит хүүний түвшин, ВВВ чанар бүхий зээлийн зэрэглэл ба хөрвөх чадварт хамаарах зээлийн тархалт нь уг өрийн хэрэглүүрийг гаргасан өдрөөс хойш өөрчлөгдөөгүй. Гэвч В үндэсний засгийн газрын үл гүйцэтгэлийн эрсдлийн өөрчлөлтийн улмаас түүний зээлийн тархалт нь 50 суурь оноогоор суларсан. Зах зээлийн бүх нөхцөл байдлыг харгалзан үзсэний дараа, В үндэсний засгийн газар нь хэрэв уг хэрэглүүрийг тухайн хэмжилтийн өдрөөр гаргасан бол өрийн хэрэглүүр 10.5 хувийн хүүтэй байх буюу тэрээр тус өрийн хэрэглүүрийн гаргалтаар түүний нэрлэсэн үнээс бага дүнг хүлээн авах байсан гэж дүгнэсэн.

ҮЖ208. Энэхүү жишээний зорилгын хувьд В үндэсний засгийн газрын өр төлбөрийн бодит үнэ цэнийг өнөөгийн үнэ цэнийн арга зүй ашиглан тооцоолно. Зах зээлийн оролцогч нь В үндэсний засгийн газрын үүргийг хариуцахын тулд авахаар хүлээж буй үнийг тооцоолохдоо дараах бүх орц өгөгдлийг ашиглана гэж В үндэсний засгийн газар дүгнэсэн:

- (a) Өрийн хэрэглүүрийн нөхцлүүд, үүнд дараах бүх зүйлс хамаарна:
 - (i) 10 хувийн купоны хүү;
 - (ii) 2 сая ТН-ийн үндсэн дүн; ба
 - (iii) дөрвөн жилийн хугацаа.
- (б) 10.5 хувийн зах зээлийн хүүний түвшин (үүнд: үл гүйцэтгэлийн эрсдэлд уг гаргалтын өдрөөс хойш орсон 50 суурь онооны өөрчлөлт хамаарна).

ҮЖ209. Түүний өр төлбөрийн бодит үнэ цэнэ нь 20X1 оны 12-р сарын 31-нд 1,968,641 ТН байна гэж В үндэсний засгийн газар нь өөрийн өнөөгийн үнэ цэнийн арга зүйд үндэслэн дүгнэсэн.

ҮЖ210. Зах зээлийн оролцогч нь өр төлбөрийг хариуцсаны нөхөн төлбөр болгон шаардаж болох ашиг буюу эрсдлийн хувьд В үндэсний засгийн газар нь өөрийн өнөөгийн үнэ цэнийн арга зүйд өөр ямар нэг нэмэлт орц мэдээг тусган оруулахгүй. В үндэсний засгийн газрын үүрэг нь санхүүгийн өр төлбөр учраас түүний хүүний түвшин нь тухайн өр төлбөрийг хариуцсаны төлөө нөхөн төлбөр болгон зах зээлийн оролцогчийн шаардаж болох эрсдэл буюу ашгийг угаасаа тусган агуулсан байгаа гэж В үндэсний засгийн газар дүгнэсэн. Түүнчлэн, В үндэсний засгийн газар нь тухайн өр төлбөрийг шилжүүлэхэд түүнд саад учруулах хязгаарлалтын оршин байдлын хувьд өөрийн өнөөгийн үнэ цэнийн арга зүйг өөрчлөн залруулахгүй.

Санхүүгийн хөрөнгийн ангилал (39-44-р параграф)

Жишээ 32—Эргэлтээс гаргах шинж бүхий капиталын захиалгын эрх

ҮЖ211. А Олон Улсын Хөгжлийн Банкны үйл ажиллагаанд оролцох ба дэмжлэг үзүүлэхийн тулд Б Холбооны Улсын Засгийн Газар нь дэлхий дахин дахь Дотоодын Нийт Бүтээгдэхүүнд өөрийн эзлэх хэмжээнд хувь тэнцүүлсэн байдлаар уг А Олон Улсын Хөгжлийн Банкинд тодорхой тооны захиалгын эрхээр хөрөнгө оруулж, тэдгээр эрхийг худалдан авсан. Захиалгын эрх бүр нь 1,000 ТН-ийн өртөгтэй бөгөөд А банкинд уг захиалгын эрхийг буцаан өгч, анхны оруулсан мөнгөө (өөрөөр хэлбэл, нэг захиалгын эрхэд 1,000 ТН) авах эрхийг Б засгийн газарт олгодог. А Олон Улсын Хөгжлийн Банк нь тэдгээр захиалгын эрхийн хувьд ногдол ашиг олгох үүрэг хүлээхгүй.

ҮЖ212. Б засгийн газар нь тэдгээр захиалгын эрхийн нөхцлүүдэд үндэслэн уг санхүүгийн хөрөнгийн тохиромжтой ангиллыг үнэлнэ.

ҮЖ213. Захиалгын эрх нь УСНББОУС 28, *Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга*-д заасан, өмчийн хэрэглүүрийн тодорхойлолтыг хангахгүй гэж Б засгийн газар нь уг санхүүгийн хөрөнгийн ангиллыг тодорхойлох үедээ дүгнэсэн.⁵⁸ Иймээс өмчийн хэрэглүүрийг цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих 43-р параграфт заасан сонголтыг хийх боломжгүй гэж Б засгийн газар дүгнэсэн.

⁵⁸ УСНББОУС 28-ын 15, 16, 17, 18-р параграфын заавар удирдамжийг харгалзан үзвэл, уг буцаах эрхтэй захиалгын эрх нь Банкны зүгээс түүнийг өмчийн хэрэглүүр гэж ангилах шаардлагуудыг хангах боломжтой юм. Гэхдээ УСНББОУС 28-ын

ҮЖ214. Түүнчлэн, захиалгын эрхийн гэрээний нөхцөл нь зөвхөн үндсэн дүнгийн болон хүүний төлбөрүүдийн хувьд тусгайлан заасан өдрүүдээр мөнгөн гүйлгээг үүсгэн бий болгож чадахгүй тул ийм захиалгын эрхийг хорогдуулсан өртгөөр, эсвэл цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн өрийн хэрэглүүр гэж ангилж болохгүй. Буцааж болох захиалгын эрхийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилах шаардлагатай гэж Б засгийн газар дүгнэсэн.

Үр ашигт хүүний арга (69-70-р параграф)

Жишээ 33—Хөнгөлөлттэй гаргасан ба ажил гүйлгээний зардалтай бондын үр ашигт хүүний хувийг хэмжих

ҮЖ215. А мужийн засгийн газар нь 500,000 ТН-ийн нэрлэсэн үнэтэй, 3 жилийн хугацаатай бонд гаргасан. Уг хэрэглүүр нь жилийн тогтмол 4 хувийн өгөөжтэй бөгөөд хүүг жил бүр төлдөг. Бондыг 2 хувийн хөнгөлөлттэй гаргасан бөгөөд А мужийн засгийн газар нь уг ажил гүйлгээний өдөр 12,000 ТН-ийн хөлсийг тухайн бондын андеррайтерт төлөх шаардлагатай юм.

ҮЖ216. Хэрэглүүрийн хорогдуулсан өртгийг тодорхойлохдоо, А мужийн засгийн газар нь үр ашигт хүүний хувийг тооцоолох ёстой. Үр ашигт хүүний хувь нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааны туршид тооцоолсон ирээдүйн мөнгөн төлбөрүүдийг тухайн санхүүгийн хэрэглүүрийн нийт дансны үнэ хүртэл яг нарийн дискаунтчилдаг хүүний хувь юм.

ҮЖ217. Урьдчилгаа төлбөр, хугацааны сунгалт болон бусад дуудах опцион байхгүй гэж үзсэн учраас ирээдүйн тооцоолсон мөнгөн гүйлгээ нь хүүний төлбөрийн хувьд жил бүр 20,000 ТН (20,000ТН=500,000ТН х 4 хувь), түүнчлэн хугацаа дуусахад төлөх 500,000ТН-ийн үндсэн дүнгийн төлбөр байна.

ҮЖ218. Уг ажил гүйлгээний өдөр бондын нийт дансны үнийг А мужийн засгийн газрын хүлээн авах цэвэр мөнгөн орлогод үндэслэн тооцоолно. Бондыг хөнгөлөлттэй гаргасан учраас А мужийн засгийн газар нь ажил гүйлгээний зардлын өмнөх байдлаар 490,000ТН (500,000ТН х (100 хувь – 2 хувь))-ийг хүлээн авна. Ажил гүйлгээний зардлыг харгалзан үзвэл гаргалтын дараах мөнгөн орлого нь 478,000ТН (490,000ТН – 12,000ТН) байна.

Жил	(а) Мөнгөн гүйлгээ	(б) Мөнгөн зарлага (ажил гүйлгээний зардал ба хүү)	(в) Мөнгөн зарлага (үндсэн дүн)	(г = а – б – в) Цэвэр мөнгөн зарлага
Жил 1 (эхэнд)	500,000	12,000	10,000	478,000
Жил 1 (эцэст)	-	20,000	-	(20,000)
Жил 2	-	20,000	-	(20,000)
Жил 3	-	20,000	-	(20,000)
Жил 4	-	20,000	-	(20,000)
Жил 5	-	20,000	500,000	(520,000)

ҮЖ219. Жил тутмын 20,000 ТН-ийн тооцоолсон мөнгөн гүйлгээ, түүнчлэн дуусгавар болгох үеийн үндсэн дүнгийн буцаан төлөлтийг нийт 478,000 ТН болгон яг нарийн дискаунтчилдаг хүүний хувийг тодорхойлсноор уг бондын үр ашигт хүүний хувийг тооцоолдог. Үндсэндээ, үр ашигт хүүний хувь нь А мужийн засгийн газрын хүлээн авсан цэвэр мөнгөн орлогод үндэслэн тооцогдох хүүний хувийг илэрхийлдэг.

ҮЖ220. Энэ жишээнд үр ашигт хүүний хувь нь 5.02 хувь байна. Бондын өгөөж нь 500,000 ТН-ийн үндсэн дүнгийн 4 хувь байна гэж тогтоосон тул энэ нь тохиромжтой хувь юм. Гэвч мөн чанарын хувьд А мужийн засгийн газар нь ердөө 478,000 ТН хүлээн авч, жил бүр 20,000 ТН-ийн хүүний төлбөр төлнө.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Иймээс ажил гүйлгээний зардал ба хөнгөлөлт нэмэгдэхийн хэрээр үр ашигт хүүний хувь нь гэрээний хүүний хувиас илүү их зөрүүтэй болдог.

Үр ашигт хүүний хувь = 5.02				
Жил	(а) Эхний үлдэгдэл	(б) Хүүний зардал	(в) Хүү/үндсэн дүнгийн төлөлт	(г = а + б - в) Эцсийн үлдэгдэл
Жил 1	478,000	23,980	20,000	481,980
Жил 2	481,980	24,180	20,000	486,160
Жил 3	486,160	24,389	20,000	490,549
Жил 4	490,549	24,610	20,000	495,159
Жил 5	495,159	24,841	520,000	-

ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗААВАР УДИРДАМЖ**АГУУЛГА**

	Параграф
Хэсэг А: Цар хүрээ	А.1
Цэвэр дүнгээр барагдуулах практик: Бараа бүтээгдэхүүнийг худалдан авах форвард гэрээ	А.2
Санхүүгийн бус хөрөнгийг буцаах опцион	
Хэсэг Б: Тодорхойлолт	
Санхүүгийн хэрэглүүрийн тодорхойлолт: Алтан гулдмай	Б.1
Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт: Үүсмэл хэрэглүүр ба суурь зүйлсийн жишээ	Б.2
Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт: Ирээдүйд төлбөрийг барагдуулах, цэвэр эсвэл нийт дүнгээр барагдуулах хүүний түвшний своп	Б.3
Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт: Урьдчилж төлсөн хүүний түвшний своп (Үүсэх үед эсвэл дараа нь урьдчилж төлсөн тогтмол хүүтэй төлбөрийн үүрэг)	Б.4
Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт: Хувьсах хүү-төлөх ба тогтмол хүү-хүлээн авах урьдчилж төлсөн хүүний түвшний своп	Б.5
Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт: Цэвэр дүнгээр тооцох зээл	Б.6
Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт: Хэрэгжүүлнэ гэж хүлээгдээгүй опцион	Б.7
Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт: Борлуулалтын тоо хэмжээнд үндэслэсэн гадаад валютын гэрээ	Б.8
Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт: Урьдчилж төлсөн форвард	Б.9
Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт: Анхны цэвэр хөрөнгө оруулалт	Б.10
Худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэдгийн тодорхойлолт: Богино хугацаанд ашиг олох сүүлийн үеийн бодит хэв маяг бүхий багц	Б.11
Нийт дансны үнийн тодорхойлолт: Тогтмол хүүтэй эсвэл зах зээлд суурилсан хувьсах хүүтэй, хугацаагүй өрийн хэрэглүүр	Б.12
Нийт дансны үнийн тодорхойлолт: Буурах хүүтэй, хугацаагүй өрийн хэрэглүүр	Б.13
Нийт дансны үнийг тооцоолох жишээ: Санхүүгийн хөрөнгө	Б.14
Нийт дансны үнийг тооцоолох жишээ: Шаталсан хүүний төлбөр бүхий өрийн хэрэглүүр	Б.15
Ердийн нөхцөлтэй гэрээ: Тогтсон зах зээлгүй	Б.16
Ердийн нөхцөлтэй гэрээ: Форвард гэрээ	Б.17
Ердийн нөхцөлтэй гэрээ: Хэвийн барагдуулалтын аль нөхцлийг мөрдөх вэ?	Б.18
Ердийн нөхцөлтэй гэрээ: Дуудах опционоор хийгдэх хувьцааны худалдан авалт	Б.19
Арилжааны өдрийн эсвэл барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийг ашигласнаар санхүүгийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх ба үл хүлээн зөвшөөрөх	Б.20
Хэсэг В: Дагалдах үүсмэл хэрэглүүр	
Дагалдах үүсмэл хэрэглүүр: Өрийн үндсэн хэрэглүүрээс салган тусгаарлалт	В.1
Дагалдах үүсмэл хэрэглүүр: Дагалдах опционыг салган тусгаарлалт	В.2
Дагалдах үүсмэл хэрэглүүр: Өмчийн урамшуулал	В.3
Дагалдах үүсмэл хэрэглүүр: Зохиомол хэрэглүүр	В.4
Дагалдах үүсмэл хэрэглүүр: Гадаад валютаарх хэрэглүүрийн худалдан авалт ба борлуулалтын гэрээ	В.5
Гадаад валютын дагалдах үүсмэл хэрэглүүр: Холбоо хамааралгүй гадаад валютын нөхцөл	В.6
Гадаад валютын дагалдах үүсмэл хэрэглүүр: Олон улсын худалдааны валют	В.7
Дагалдах үүсмэл хэрэглүүр: Өөрийн хүлээн зөвшөөрсөн бараг бүх хөрөнгө оруулалтыг нөхөхгүйгээр барагдуулахыг эзэмшигчид зөвшөөрдөг боловч түүнээс заавал шаардахгүй	В.8
Хэсэг Г: Хүлээн зөвшөөрөлт ба үл хүлээн зөвшөөрөлт	
Анхны хүлээн зөвшөөрөлт	Г.1
Санхүүгийн хөрөнгийн ердийн нөхцөлтэй худалдан авалт буюу борлуулалт	Г.2
Хэсэг Д: Хэмжилт	
Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн анхны хэмжилт	Д.1

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Олз ба гарз	Д.2
Хэсэг Е: Бусад	
УСНББОУС 41 ба УСНББОУС 2 – Хейжийн нягтлан бодох бүртгэл: Мөнгөн гүйлгээний тайлан	Е.1
Хэсэг Ж: Хөнгөлөлттэй зээл ба арилжааны бус өмчийн ажил гүйлгээ	
Хөнгөлөлттэй зээлийн хувьд “зөвхөн үндсэн дүн ба хүүний төлөлт” үнэлгээний дарааллыг тогтоох	Ж.1
Хөнгөлөлттэй зээл ба “зөвхөн үндсэн дүн ба хүүний төлөлт” үнэлгээ	Ж.2
Арилжааны бус бүрэлдэхүүн хэсгийн үнэлгээ	Ж.3
Арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн өмчийн хэрэглүүрийн мөн чанарыг шинжлэх	Ж.4
Хөнгөлөлттэй ба үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай зээлийг үнэлэхэд харгалзах хүчин зүйлс	Ж.5
Үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай хөнгөлөлттэй зээл	Ж.6
Хэсэг И: Үр ашигт хүүний арга	
Үр ашигт хүүний аргыг ашиглах шаардлага	И.1
Хэсэг К: Өрийн онцгой бүтцийн өөрчлөлт	
Өрийн онцгой бүтцийн өөрчлөлт	К.1

Хэрэгжүүлэх заавар удирдамж

Энэхүү хэрэгжүүлэх заавар удирдамж нь УСНББОУС 41-ийг дагалдах боловч түүний саллигүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

Хэсэг А: Цар хүрээ

А.1 Цэвэр дүнгээр барагдуулах практик: Бараа бүтээгдэхүүнийг худалдан авах форвард гэрээ

XYZ байгууллага нь өөрийн хүлээгдэж буй ашиглалтын шаардлагуудын дагуу нэг сая литр газрын тос худалдан авахын тулд тогтмол үнэтэй форвард гэрээг байгуулсан. Уг гэрээ нь арван хоёр сарын дараа тухайн газрын тосыг биетээр хүлээн авах эсвэл газрын тосны бодит үнэ цэнийн өөрчлөлтөнд үндэслэн цэвэр дүнгээр нь мөнгөөр төлөх буюу хүлээн авах байдлаар барагдуулах боломжийг XYZ байгууллагад олгодог. Энэхүү гэрээг үүсмэл хэрэглүүр байдлаар тайлагнах уу?

Хэдийгээр ийм гэрээ нь үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолтыг хангах боловч түүнийг заавал үүсмэл хэрэглүүр гэж тайлагнах шаардлагагүй юм. Анхны цэвэр хөрөнгө оруулалт байхгүй бөгөөд гэрээ нь газрын тосны үнэд үндэслэдэг ба түүнийг ирээдүйд барагдуулах учраас энэ гэрээ нь үүсмэл хэрэглүүр юм. Гэвч XYZ байгууллага нь барааг хүлээн авснаар тухайн гэрээг барагдуулах санаа зорилготой бөгөөд ижил төсөөтэй гэрээг цэвэр дүнгээр нь мөнгөөр барагдуулж байсан эсвэл газрын тосыг хүлээн авах ба үнийн богино хугацааны хэлбэлзэл буюу дилерийн ашиг олох зорилгоор тэрхүү нийлүүлэлтийн дараа, богино хугацааны дотор түүнийг борлуулдаг түүхэн туршлагагүй бол уг гэрээг УСНББОУС 41-ийн дагуу үүсмэл хэрэглүүр гэж тайлагнахгүй. Харин үүнийг (УСНББОУС 41-ийн 6-р параграфт заасанчлан, байгууллага нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж эргэлт буцалтгүйгээр ангилснаас бусад тохиолдолд) гүйцэтгэлийн гэрээ байдлаар тайлагнана.

А.2 Санхүүгийн бус хөрөнгийг буцаах опцион

XYZ байгууллага нь оффисын барилга өмчилдөг. XYZ байгууллага нь буцаах опционы гэрээг хөрөнгө оруулагчтай байгуулсан бөгөөд энэ нь тухайн барилгыг 150 сая ТН-ээр тэрхүү хөрөнгө оруулагчид буцаан өгөх эрхийг түүнд олгодог. Барилгын одоогийн үнэ цэнэ нь 175 сая ТН байна.⁵⁹ Опционы эрхийн хугацаа нь таван жилийн дараа дуусна. Хэрэв опционыг хэрэгжүүлвэл XYZ байгууллагын сонголтын дагуу биетээр хүргэн нийлүүлснээр эсвэл цэвэр дүнгээр нь мөнгөөр уг опционыг барагдуулж болох юм. XYZ байгууллага ба хөрөнгө оруулагчийн аль аль нь энэхүү опционыг хэрхэн тайлагнах вэ?

XYZ байгууллагын нягтлан бодох бүртгэл нь барагдуулалтын талаархи түүний санаа зорилго ба өмнөх практик туршлагаас хамаарна. Хэдийгээр уг гэрээ нь үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолтыг хангах боловч хэрэв XYZ байгууллага нь өөрийн опционыг хэрэгжүүлж, тухайн барилгыг өгснөөр гэрээг барагдуулах санаа зорилготой бөгөөд цэвэр дүнгээр нь барагдуулж байсан өмнөх туршлагагүй бол үүнийг үүсмэл хэрэглүүр гэж тайлагнахгүй (УСНББОУС 41-ийн 5-р параграфыг, мөн түүнчлэн УСНББОУС 41-ийн 6-р параграфыг үзнэ үү).

Харин хөрөнгө оруулагч нь нийлүүлэлт хийхийг шаардах чадвар, боломжгүй учраас өөрийн хүлээгдэж буй худалдан авалт, борлуулалт эсвэл ашиглалтын шаардлагуудыг хангахын тулд опционы гэрээг байгуулсан гэж дүгнэж болохгүй юм (УСНББОУС 41-ийн 8-р параграф). Түүнчлэн, уг опционыг цэвэр дүнгээр нь мөнгөөр барагдуулж болно. Иймээс хөрөнгө оруулагч нь уг гэрээг үүсмэл хэрэглүүр гэж тайлагнах ёстой. Өмнөх практикаас үл хамааран хөрөнгө оруулагчийн санаа зорилго нь нийлүүлэлтээр эсвэл мөнгөөр барагдуулах эсэхэд нөлөө үзүүлэхгүй. Хөрөнгө оруулагч нь опционыг гаргасан бөгөөд ийм опционы гаргагч нь нийлүүлэлт хийхийг шаардах чадвар боломжгүй учраас биетээр барагдуулах эсвэл мөнгөөр барагдуулах сонголтыг опционы эзэмшигч эдэлдэг, тэрхүү гаргасан опцион нь УСНББОУС 41-ийн гажих нөхцөл болох хэвийн нийлүүлэлтийн шаардлагыг хэзээ ч хангадаггүй.

Харин энэ гэрээ нь опцион биш, форвард гэрээ байсан ба биет нийлүүлэлтийг шаарддаг бөгөөд тухайн тайлагнагч байгууллага цэвэр дүнгээр нь мөнгөөр барагдуулах эсвэл барилгыг хүлээн хүлээн авах ба үнийн богино хугацааны хэлбэлзэл буюу дилерийн ашиг олох зорилгоор тэрхүү нийлүүлэлтийн дараа, богино

⁵⁹ Энэхүү заавар удирдамжид мөнгөн дүнг “тооцооны нэгж” (ТН) гэж тэмдэглэсэн.

хугацааны дотор түүнийг борлуулдаг өмнөх туршлагагүй бол уг гэрээг үүсмэл хэрэглүүр гэж тайлагнахгүй (гэхдээ УСНББОУС 41-ийн 6-р параграфыг бас үзнэ үү).

Хэсэг Б: Тодорхойлолт

Б.1 Санхүүгийн хэрэглүүрийн тодорхойлолт: Алтан гулдмай

Алтан гулдмай нь санхүүгийн хэрэглүүр (мөнгөтэй адил) эсвэл бараа бүтээгдэхүүн мөн үү?

Энэ нь бараа бүтээгдэхүүн юм. Гулдмай нь хөрвөх чадвар өндөртэй боловч мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг хүлээн авах гэрээний эрх тухайн гулдмайд угаасаа байдаггүй.

Б.2 Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт: Үүсмэл хэрэглүүр ба суурь зүйлсийн жишээ

Нийтлэг үүсмэл гэрээ ба тодорхойлсон суурь зүйлийн жишээ юу вэ?

УСНББОУС 41 нь үүсмэл хэрэглүүрийг дараах байдлаар тодорхойлсон:

Үүсмэл хэрэглүүр гэдэг нь энэ Стандартын цар хүрээнд хамаарах бөгөөд дараах бүх гурван шинж чанар бүхий санхүүгийн хэрэглүүр буюу бусад гэрээ юм:

- (а) **Тохиролцсон хүүний хувь, санхүүгийн хэрэглүүрийн үнэ, бараа бүтээгдэхүүний үнэ, гадаад валютын ханш, үнийн буюу ханшийн индекс, зээлийн зэрэглэл буюу зээлийн индекс, түүнчлэн уг гэрээний аль нэг талд тусгайлан хамаарахгүй санхүүгийн бус хувьсагч гэх мэт бусад хувьсагчдын (зарим үед ‘суурь зүйл’ гэж нэрлэдэг) өөрчлөлтийн хариу болгон түүний үнэ цэнэ өөрчлөгддөг.**
- (б) **Анхны цэвэр хөрөнгө оруулалт шаарддаггүй эсвэл зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөнд ижил төсөөтэй хариу үзүүлэхээр хүлээгдэж буй бусад төрлийн гэрээний хувьд шаардлагатай дүнгээс бага хэмжээний анхны цэвэр хөрөнгө оруулалт шаарддаг.**
- (в) **Ирээдүйн өдөр барагдуулдаг.**

Гэрээний төрөл	Үнэ тогтоох-барагдуулах үндсэн хувьсагч (суурь хувьсагч)
Хүүний түвшний своп	Хүүний түвшин
Валютын своп (гадаад валютын ханшийн своп)	Валютын ханш
Бараа бүтээгдэхүүний своп	Бараа бүтээгдэхүүний үнэ
Өмчийн своп	Өмчийн үнэ (өөр байгууллагын өмчийн хэрэглүүр)
Зээлийн своп	Зээлийн зэрэглэл, зээлийн индекс буюу зээлийн үнэ
Нийт өгөөжийн своп	Харгалзах хөрөнгө ба хүүний түвшний нийт бодит үнэ цэнэ
Худалдан авсан эсвэл гаргасан сангийн бондын опцион (дуудах эсвэл буцаах)	Хүүний түвшин
Худалдан авсан эсвэл гаргасан валютын опцион (дуудах эсвэл буцаах)	Валютын ханш
Худалдан авсан эсвэл гаргасан бараа бүтээгдэхүүний опцион (дуудах эсвэл буцаах)	Бараа бүтээгдэхүүний үнэ
Худалдан авсан эсвэл гаргасан хувьцааны опцион (дуудах эсвэл буцаах)	Өмчийн үнэ (өөр байгууллагын өмчийн хэрэглүүр)
Засгийн газрын өртэй уялдсан хүүний түвшний фьючерс (сангийн фьючерс)	Хүүний түвшин
Валютын фьючерс	Валютын ханш
Бараа бүтээгдэхүүний фьючерс	Бараа бүтээгдэхүүний үнэ
Засгийн газрын өртэй уялдсан хүүний түвшний форвард (сангийн форвард)	Хүүний түвшин
Валютын форвард	Валютын ханш

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Бараа бүтээгдэхүүний форвард
Өмчийн форвард

Бараа бүтээгдэхүүний үнэ
Өмчийн үнэ (өөр байгууллагын өмчийн
хэрэглүүр)

УСНББОУС 41-ийн дагуу үүсмэл хэрэглүүрийн шалгуурыг ихэвчлэн хангадаг гэрээнүүдийн жишээг дээрх жагсаалтанд харуулав. Энэхүү жагсаалтанд бүгдийг багтаагаагүй болно. Суурь зүйл бүхий аливаа гэрээ нь үүсмэл хэрэглүүр байж болох юм. Түүнчлэн, хэрэглүүр нь үүсмэл гэрээний тодорхойлолтыг хангадаг боловч тухайлбал; цаг агаарын үүсмэл хэрэглүүр (УСНББОУС 41-ийн МЗУ1-р параграфыг үзнэ үү), бараа бүтээгдэхүүн гэх мэт санхүүгийн бус зүйлийг худалдан авах буюу борлуулах гэрээ (УСНББОУС 41-ийн 6-8-р параграф ба УСНББОУС 41-ийн МЗУ8-р параграфыг үзнэ үү), байгууллагын өөрийн хувьцаагаар барагдуулах гэрээ (УСНББОУС 28-ын 25-29-р параграфыг үзнэ үү) бол УСНББОУС 41-ийн тусгай заалтуудыг мөрдөж болох юм. Иймээс байгууллага нь үүсмэл хэрэглүүрийн бусад шинж чанарууд байгаа эсэх, түүнчлэн тусгай заалтуудыг мөрдөх эсэхийг тодорхойлохын тулд тухайн гэрээг үнэлэх ёстой.

Б.3 Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт: Ирээдүйд төлбөрийг барагдуулах, цэвэр эсвэл нийт дүнгээр барагдуулах хүүний түвшний своп

Талууд хүүг тус тусдаа төлөх (нийт дүнгээр барагдуулах) эсвэл цэвэр дүнгээр барагдуулах нь хүүний түвшний свопыг УСНББОУС 41-ийн дагуу үүсмэл санхүүгийн хэрэглүүр гэж тодорхойлох эсэхэд нөлөө үзүүлэх үү?

Үгүй. Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт нь нийт дүнгээр эсвэл цэвэр дүнгээр барагдуулах эсэхээс хамаарахгүй.

Үлгэрчлэн харуулвал: ABC байгууллага нь 8 хувийн тогтмол хүүг төлөх ба улирал тутам шинэчлэн тогтоогдох гурван сарын хугацаатай ЛАЙБОР хүүнд үндэслэсэн хувьсах хүүг хүлээн авахыг түүнээс шаардах хүүний түвшний свопын гэрээг нөгөө талтайгаа (XYZ) байгуулсан. Тогтмол ба хувьсах дүнг 100 сая ТН бүхий нэрлэсэн дүнд үндэслэн тодорхойлдог. ABC ба XYZ байгууллага нь нэрлэсэн дүнг өөрчлөхгүй. ABC байгууллага нь 8 хувь ба гурван сарын хугацаатай ЛАЙБОР-ын хоорондох зөрүүд үндэслэсэн цэвэр мөнгөн дүнг улирал бүр төлнө эсвэл хүлээн авна. Өөр нэг хувилбар нь нийт дүнгээр хийгдэх барагдуулалт байж болох юм.

Уг гэрээний үнэ цэнэ нь суурь хувьсагчийн (ЛАЙБОР) өөрчлөлтөөс хамааран өөрчлөгдөх бөгөөд анхны цэвэр хөрөнгө оруулалтгүй ба ирээдүйд барагдуулах учраас энэ нь цэвэр дүнгээр эсвэл нийт дүнгээр барагдуулах эсэхээс үл хамааран үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолтыг хангана.

Б.4 Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт: Урьдчилж төлсөн хүүний түвшний своп (Үүсэх үед эсвэл дараа нь урьдчилж төлсөн тогтмол хүүтэй төлбөрийн гүүрэг)

Хэрэв нэг тал нь тогтмол хүү-төлөх ба хувьсах хүү-хүлээн авах хүүний түвшний свопын дагуу өөрийн үүргийг уг үүссэн өдөр урьдчилж төлсөн бол энэхүү своп нь үүсмэл санхүүгийн хэрэглүүр мөн үү?

Тийм. Үлгэрчлэн харуулвал: S байгууллага нь тогтмол хүү төлөх ба хувьсах хүү хүлээн авах 100 сая ТН-ийн нэрлэсэн дүнтэй, таван жилийн хугацаатай, хүүний түвшний свопын гэрээг нөгөө тал болох C байгууллагатай байгуулсан. Уг свопын хувьсах хэсгийн хүүний түвшинг гурван сарын хугацаатай ЛАЙБОР-оор улирал бүр шинэчлэн тогтоодог. Свопын тогтмол хэсгийн хүүний түвшин нь жилийн 10 хувь байна. S байгууллага нь свопын дагуу төлөх өөрийн 50 сая ТН-ийн (100 сая ТН х 10 хувь х 5 жил) тогтмол үүргийг уг үүссэн өдөр зах зээлийн хүүний түвшинг ашиглан дискаунтчилснаар урьдчилж төлсөн бөгөөд гурван сарын хугацаатай ЛАЙБОР-т үндэслэн улирал бүр шинэчлэн тогтоож, 100 сая ТН-ээс тооцох хүүг тухайн свопын хугацаанд хүлээн авах эрхээ хадгалан үлдсэн.

Уг хүүний түвшний свопын анхны цэвэр хөрөнгө оруулалт нь хувьсах хэсгийн дагуу хувьсах хүүг тооцох үндэслэл болох тухайн нэрлэсэн дүнгээс мэдэгдэхүйц бага байна. Энэ гэрээ нь хувьсах хүүтэй бонд гэх мэт зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөнд ижил төсөөтэй хариу үзүүлэхээр хүлээгдэж буй бусад төрлийн гэрээний хувьд шаардлагатай дүнгээс бага хэмжээний анхны цэвэр хөрөнгө оруулалтыг шаарддаг. Иймээс тухайн гэрээ нь “анхны цэвэр хөрөнгө оруулалтгүй эсвэл зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөнд ижил төсөөтэй хариу үзүүлэхээр хүлээгдэж буй бусад төрлийн гэрээний хувьд шаардлагатай дүнгээс бага хэмжээний анхны цэвэр хөрөнгө оруулалттай” гэсэн УСНББОУС 41-ийн нөхцлийг биелүүлж байна. Хэдийгээр S байгууллага нь ирээдүйн гүйцэтгэлийн үүрэггүй боловч тухайн гэрээний эцсийн барагдуулалт нь

ирээдүйд хийгдэх бөгөөд гэрээний үнэ цэнэ нь ЛАЙБОР индексийн өөрчлөлтөөс хамааран өөрчлөгдөнө. Иймээс уг гэрээг үүсмэл гэрээ гэж үзнэ.

Хэрэв тогтмол хүү төлөх үүргийг анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа урьдчилж төлсөн бол хариулт өөрчлөгдөх үү?

Хэрэв свопын тогтмол хэсгийг тухайн хугацааны туршид урьдчилж төлсөн бол үүнийг уг одоогийн свопын дуусгавар болголт ба УСНББОУС 41-ийн дагуу үнэлэх шинэ хэрэглүүрийн үүсэлт гэж үзнэ.

Б.5 Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт: Хувьсах хүү-төлөх ба тогтмол хүү-хүлээн авах урьдчилж төлсөн хүүний түвшний своп

Хэрэв нэг тал нь хувьсах хүү-төлөх ба тогтмол хүү-хүлээн авах хүүний түвшний свопын дагуу өөрийн үүргийг уг гэрээ үүссэн өдөр эсвэл дараа урьдчилж төлсөн бол энэхүү своп нь үүсмэл санхүүгийн хэрэглүүр мөн үү?

Үгүй. Хувьсах хүү-төлөх ба тогтмол хүү-хүлээн авах урьдчилж төлсөн хүүний түвшний своп нь тогтмол мөнгөн гүйлгээ бүхий өрийн хэрэглүүрийн өгөөжтэй зэрэгцүүлэгдэх урьдчилж төлсөн (оруулсан) дүнд үндэслэн өгөөжийг бий болгодог учраас түүнийг уг үүссэн өдөр урьдчилж төлвөл үүсмэл хэрэглүүр болохгүй, харин үүссэний дараа урьдчилж төлвөл цаашид үүсмэл хэрэглүүр байхаа болино. Тухайн урьдчилж төлсөн дүн нь үүсмэл хэрэглүүрийн “анхны цэвэр хөрөнгө оруулалтгүй эсвэл зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөнд ижил төсөөтэй хариу үзүүлэхээр хүлээгдэж буй бусад төрлийн гэрээний хувьд шаардлагатай дүнгээс бага хэмжээний анхны цэвэр хөрөнгө оруулалттай” гэсэн шалгуурыг хангахгүй юм.

Үлгэрчлэн харуулвал: S байгууллага нь хувьсах хүү төлөх ба тогтмол хүү хүлээн авах 100 сая ТН-ийн нэрлэсэн дүнгэй, таван жилийн хугацаатай, хүүний түвшний свопын гэрээг нөгөө тал болох С байгууллагатай байгуулсан. Уг свопын хувьсах хэсгийн хүүний түвшинг гурван сарын хугацаатай ЛАЙБОР-оор улирал бүр шинэчлэн тогтоодог. Свопын дагуу төлөх тогтмол хүүний төлбөрийг уг свопын нэрлэсэн дүнг 10 хувиар үржүүлснээр тооцоолно. Өөрөөр хэлбэл, жилд 10 сая ТН байна. S байгууллага нь свопын хувьсах хэсгийн дагуу хүлээх өөрийн үүргийг уг үүссэн өдөр одоогийн зах зээлийн хүүний түвшнээр урьдчилж төлсөн бөгөөд 100 сая ТН-ээс жилд 10 хувиар тооцогдох тогтмол хүүг хүлээн авах эрхээ хадгалан үлдсэн.

S байгууллага нь свопын нийт хугацааны туршид жил бүр 10 сая ТН хүлээн авна гэдгээ мэдэж байгаа тул уг гэрээний дагуу үүсэх мөнгөн орлогын гүйлгээ нь жил тутам тогтмол тэнцүү төлбөр бүхий санхүүгийн хэрэглүүрийн мөнгөн гүйлгээтэй ижил байна. Бусад бүх зүйл ижил учраас уг гэрээний анхны хөрөнгө оруулалт нь тогтмол тэнцүү төлбөр бүхий бусад санхүүгийн хэрэглүүрийн хөрөнгө оруулалттай адил байна. Иймээс хувьсах хүү-төлөх ба тогтмол хүү-хүлээн авах хүүний түвшний свопод оруулсан анхны цэвэр хөрөнгө оруулалт нь зах зээлийн нөхцөл байдлын өөрчлөлтөнд ижил хариу үзүүлэх үүсмэл бус гэрээний хувьд шаардагдах хөрөнгө оруулалттай тэнцүү байна. Энэ шалтгааны улмаас уг хэрэглүүр нь УСНББОУС 41-ийн “анхны цэвэр хөрөнгө оруулалтгүй эсвэл зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөнд ижил төсөөтэй хариу үзүүлэхээр хүлээгдэж буй бусад төрлийн гэрээний хувьд шаардлагатай дүнгээс бага хэмжээний анхны цэвэр хөрөнгө оруулалттай” гэсэн шалгуурыг хангахгүй юм. Ийм учраас уг гэрээг УСНББОУС 41-ийн дагуу үүсмэл хэрэглүүр гэж тайлагнахгүй. Хувьсах хүү төлөх үүргийг биелүүлсэнээр S байгууллага нь үнэн хэрэгтээ нөгөө тал болох С байгууллагад зээл олгож байна.

Б.6 Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт: Цэвэр дүнгээр тооцох зээл

A байгууллага нь таван жилийн хугацаатай, тогтмол хүүтэй зээлийг B байгууллагад олгосон, харин B байгууллага нь яг энэ үед таван жилийн хугацаатай, хувьсах хүүтэй, ижил дүнтэй зээлийг A байгууллагад олгожээ. A ба B байгууллага нь цэвэр дүнгээр тооцох гэрээтэй учраас энэхүү хоёр зээлийг үүсэх үед үндсэн дүнг шилжүүлээгүй. Энэ нь УСНББОУС 41-ийн дагуу үүсмэл хэрэглүүр мөн үү?

Тийм. Энэ нь үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолтыг хангана (үүнд тухайлбал, суурь хувьсагч байгаа, анхны цэвэр хөрөнгө оруулалтгүй эсвэл зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөнд ижил төсөөтэй хариу үзүүлэхээр хүлээгдэж буй бусад төрлийн гэрээний хувьд шаардлагатай дүнгээс бага хэмжээний анхны цэвэр хөрөнгө оруулалттай ба ирээдүйд барагдуулна). Уг зээлийн гэрээний үр нөлөө нь анхны цэвэр хөрөнгө оруулалтгүй хүүний түвшний свопын гэрээний нөхцөлтэй адил байна. Тухайн ажил гүйлгээ нь мөн чанарын хувьд үүсмэл хэрэглүүр үүсгэх үр дүнтэй тохиолдолд үүсмэл бус ажил гүйлгээг нэгтгэж, үүсмэл хэрэглүүр гэж тайлагнана. Ийм шинжийг илтгэх үзүүлэлтэд дараах зүйлс хамаарна:

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

- Тэдгээрийг нэг ижил хугацаанд хооронд нь уялдаатай байгуулдаг;
- Тэдгээр нь оролцогч ижил нөгөө талтай байдаг;
- Тэдгээр нь нэг ижил эрсдэлтэй холбоотой байдаг; ба
- Ганц ажил гүйлгээгээр мөн хэрэгжүүлэх боломжгүй ажил гүйлгээнүүдийг тус тусад нь салган задлах эдийн засгийн илт тодорхой хэрэгцээ шаардлага буюу бизнесийн бодит зорилгогүй байх.

УСНББОУС 41-д заасан үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт нь цэвэр дүнгээр барагдуулахыг шаарддаггүй учраас А ба Б байгууллага нь цэвэр дүнгээр тооцох гэрээгүй бол үүнтэй ижил хариулттай байна.

Б.7 Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт: Хэрэгжүүлнэ гэж хүлээгдээгүй опцион

УСНББОУС 41-д заасан үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт нь тухайн хэрэглүүрийг “ирээдүйд барагдуулах”-ыг шаарддаг. Тухайлбал; мөнгөн алдагдалтайн улмаас опционыг хэрэгжүүлэхгүй гэж хүлээж байгаа хэдий ч энэ шалгуур хангагдах уу?

Тийм. Опционыг хэрэгжүүлснээр эсвэл дуусвар хугацаа болсноор барагдуулдаг. Хэдийгээр төлбөрийн нэмэлт солилцоо хийгдэхгүй боловч хугацаа дуусалт нь барагдуулалтын нэг хэлбэр юм.

Б.8 Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт: Борлуулалтын тоо хэмжээнд үндэслэсэн гадаад валютын гэрээ

Бүртгэлийн валют нь Өмнөд Африкийн ранд болох Өмнөд Африкийн XYZ байгууллага нь Мозамбек улсад ам доллараар тооцогдох цахилгааны борлуулдаг. XYZ байгууллага нь ам долларыг тогтмол арилжааны ханшаар рандад хөрвүүлэх гэрээг хөрөнгө оруулалтын банкттай байгуулсан. 6.00 гэсэн тогтмол ханшаар тооцогдох ам долларын хариуд XYZ байгууллага нь Мозамбек улсад хийсэн борлуулалтын тоо хэмжээндээ үндэслэн ранд шилжүүлэхийг уг гэрээгээр шаарддаг. Энэ гэрээ нь үүсмэл хэрэглүүр мөн үү?

Тийм. Гэрээ нь (гадаад валютын ханш ба борлуулалтын тоо хэмжээ) хоёр суурь хувьсагчтай, анхны цэвэр хөрөнгө оруулалтгүй эсвэл зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөнд ижил төсөөтэй хариу үзүүлэхээр хүлээгдэж буй бусад төрлийн гэрээний хувьд шаардлагатай дүнгээс бага хэмжээний анхны цэвэр хөрөнгө оруулалттай ба төлбөрийн нөхцөлтэй. УСНББОУС 41 нь борлуулалтын тоо хэмжээнд үндэслэсэн үүсмэл хэрэглүүрийг өөрийн цар хүрээндээ хасдаггүй.

Б.9 Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт: Урьдчилж төлсөн форвард

Байгууллага нь нэг жилийн дараах форвард үнээр хувьцаа худалдан авах форвард гэрээг байгуулсан. Уг гэрээ үүссэн өдөр байгууллага нь тухайн хувьцааны одоогийн үнэд үндэслэн урьдчилж төлсөн. Энэхүү форвард гэрээ нь үүсмэл хэрэглүүр мөн үү?

Үгүй. Форвард гэрээ нь үүсмэл хэрэглүүрийн “анхны цэвэр хөрөнгө оруулалтгүй эсвэл зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөнд ижил төсөөтэй хариу үзүүлэхээр хүлээгдэж буй бусад төрлийн гэрээний хувьд шаардлагатай дүнгээс бага хэмжээний анхны цэвэр хөрөнгө оруулалттай” гэсэн шалгуурыг хангахгүй юм.

Үлгэрчлэн харуулвал: XYZ байгууллага нь нэг жилийн дараа нэг сая “Т” энгийн хувьцааг худалдан авахын тулд форвард гэрээ байгуулсан. “Т” хувьцааны одоогийн зах зээлийн үнэ нь нэгжийн 50ТН байна; “Т” хувьцааны нэг жилийн форвард үнэ нь нэгж хувьцаанд 55ТН байсан. XYZ байгууллага нь гэрээ үүсэх үед 50 сая ТН-ийн дүн бүхий форвард гэрээг урьдчилан төлөх шаардлагатай. 50 сая ТН-ийн форвард гэрээний анхны хөрөнгө оруулалт нь нэг сая ширхэг хувьцаа гэсэн суурь зүйлийг түүний нэгж хувьцааны 55ТН-ийн форвард үнээр үржүүлсэн уг төсөөлсөн дүнгээс, өөрөөр хэлбэл 55 сая ТН-ээс бага байна. Гэвч “Т” хувьцааг анх үүссэн өдөр уг 50ТН-ээр худалдан авч болох учраас анхны цэвэр хөрөнгө оруулалт нь зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөнд ижил төсөөтэй хариу үзүүлэхээр хүлээгдэж буй бусад төрлийн гэрээний хувьд шаардлагатай хөрөнгө оруулалттай ойролцоо дүнтэй байна. Иймээс уг урьдчилж төлсөн форвард гэрээ нь үүсмэл хэрэглүүрийн анхны цэвэр хөрөнгө оруулалтын шалгуурыг хангахгүй.

Энэхүү хэрэглүүр нь үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолтыг бүхэлдээ хангахгүй боловч ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих санхүүгийн хөрөнгийн ангиллын шалгуурыг хангах юм. Форвард

гэрээний нөхцөл нь зөвхөн үндсэн дүн ба хүүний төлбөр болох мөнгөн гүйлгээг XYZ байгууллага хүлээн авах шаардлагыг тусгаагүй учраас уг хэрэглүүр нь хорогдуулсан өртгөөр хэмжих нөхцлийг биелүүлэхгүй.

Б.10 Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт: Анхны цэвэр хөрөнгө оруулалт

Фьючерс гэрээ, бирж дээр арилжаалдаг гаргасан опцион гэх мэт олон үүсмэл хэрэглүүр нь маржин данстай байхыг шаарддаг. Уг маржин данс нь анхны цэвэр хөрөнгө оруулалтын нэг хэсэг мөн үү?

Үгүй. Маржин данс нь үүсмэл хэрэглүүрт оруулсан анхны цэвэр хөрөнгө оруулалтын нэг хэсэг биш юм. Маржин данс нь оролцогч нөгөө тал буюу клирингийн төвийн барьцаа хэлбэртэй байх бөгөөд бэлэн мөнгө, үнэт цаас буюу бусад тусгайлан заасан хөрөнгө, ихэвчлэн хөрвөх хөрөнгө хэлбэртэй байж болно. Маржин данс нь тусдаа тайлагнах тусдаа хөрөнгө юм.

Б.11 Худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэдгийн тодорхойлолт: Богино хугацаанд ашиг олох сүүлийн үеийн бодит хэв маяг бүхий багц

Худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолт нь “хэрэв энэ нь ... хамтад нь удирдан зохицуулдаг, тодорхойлсон санхүүгийн хэрэглүүрийн багцын нэг хэсэг бөгөөд богино хугацаанд ашиг олох сүүлийн үеийн бодит хэв маягийн нотолгоо байгаа бол санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэж ангилна” гэж заасан. Энэхүү тодорхойлолтыг мөрдөх зорилгын хувьд “багц” гэж юу вэ?

Хэдийгээр “багц” гэсэн нэр томъёог УСНББОУС 41-д илт тодорхой тодорхойлоогүй боловч түүнийг ашиглаж буй агуулгын хувьд багц нь тухайн бүлгийн нэгэн хэсэг байдлаар удирдан зохицуулдаг санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн бүлэг юм (УСНББОУС 41-ийн 9-р параграф). Санхүүгийн хэрэглүүрээс богино хугацаанд ашиг олох сүүлийн үеийн бодит хэв маягийг ийм багцад тусган оруулсан гэсэн нотолгоо байгаа бол хэдийгээр бие даасан санхүүгийн хэрэглүүрийг үнэн хэрэгтээ илүү урт хугацаагаар эзэмшиж болох боловч тэдгээр санхүүгийн хэрэглүүр нь худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэсэн шалгуурыг хангана.

Б.12 Нийт дансны үнийн тодорхойлолт: Тогтмол хүүтэй эсвэл зах зээлд суурилсан хувьсах хүүтэй, хугацаагүй өрийн хэрэглүүр

Гаргагч нь нийт дансны үнийг буцаан төлөх үүрэг хүлээдэггүй бөгөөд хорогдуулсан өртгөөр хэмжих шаардлагатай өрийн хэрэглүүрийг зарим үед байгууллагууд нь худалдан авах буюу гаргадаг. Хүү нь тогтмол эсвэл хувьсах түвшинтэй байж болно. Хүүний түвшин нь тогтмол эсвэл зах зээлд суурилсан хувьсах түвшин гэж тусгайлан заасан бол хорогдуулсан өртгийг тодорхойлох зорилгын хувьд тухайн анх төлсөн буюу хүлээн авсан дүн ба тэг дүнгийн (“дуусгавар болгох дүн”) хоорондох зөрүүг анхны хүлээн зөвшөөрөлтийн үед шууд хорогдуулах уу?

Үгүй. Хүүний түвшин нь тогтмол эсвэл зах зээлд суурилсан хувьсах түвшин гэж тусгайлан заасан бол нийт дансны үнийг буцаан төлөхгүй учраас уг анхны дүн ба дуусгавар болгох дүнгийн хоорондох зөрүүг хорогдуулахгүй. Хүүний төлбөр нь тогтмол эсвэл зах зээлд суурилсан хувьсах бөгөөд хязгааргүй хугацаанд төлөгдөх учраас уг хорогдуулсан өртөг (үр ашигт хүүний түвшнээр дискаунтчилсан ирээдүйн мөнгөн зарлагын гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ) нь тайлант үе бүрийн нийт дансны үнэтэй тэнцүү байна.

Б.13 Нийт дансны үнийн тодорхойлолт: Буурах хүүтэй, хугацаагүй өрийн хэрэглүүр

Хэрэв хугацаагүй өрийн хэрэглүүрийн тогтоосон хүүний түвшин нь цаг хугацааны явцад буурдаг бол нийт дансны үнэ нь тайлант үе бүрийн гэрээний нэрлэсэн дүнтэй тэнцүү байх уу?

Үгүй. Эдийн засгийн талаас авч үзвэл, гэрээний хүүний бүх эсвэл зарим төлбөр нь нийт дансны үнийн буцаан төлөлт байдаг. Жишээлбэл; хүүний түвшинг эхний арван жилийн хугацаанд 16 хувиар, үүнээс хойшхи тайлант үеүдэд тэг хувиар тогтоож болох юм. Гэрээт хүүний төлбөрийн зарим хэсэг нь нийт дансны үнийн буцаан төлөлтийг илэрхийлдэг учраас энэ тохиолдолд анхны дүнг үр ашигт хүүний аргыг ашиглан эхний арван жилийн хугацаанд тэг хүртэл хорогдуулна. Үүнээс хойшхи тайлант үеүдийн ирээдүйн мөнгөн зарлагын гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ нь тэг (дараагийн тайлант үеүдэд ирээдүйн мөнгөн төлбөр байхгүй) учраас нийт дансны үнэ нь 10 жилийн дараа тэг байна.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Б.14 Нийт дансны үнийг тооцоолох жишээ: Санхүүгийн хөрөнгө

УСНББОУС 41-ийн дагуу хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн хувьд нийт дансны үнийг хэрхэн тооцоолох вэ?

Нийт дансны үнийг үр ашигт хүүний арга ашиглан тооцоолдог. Угаасаа санхүүгийн хэрэглүүрийн хувьд үр ашигт хүүний түвшин нь тухайн санхүүгийн хэрэглүүртэй холбоотойгоор тооцоолсон мөнгөн гүйлгээг тэрхүү хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацаанд эсвэл хэрэв тохиромжтой бол үүнээс арай богино хугацаанд дискаунтчилж, анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн нийт дансны үнэтэй яг тэнцүү болгох тийм хувь хэмжээ байдаг. Үр ашигт хүүний түвшний салшгүй нэг хэсэг байдлаар төлсөн буюу хүлээн авсан бөгөөд тухайн ажил гүйлгээний зардалд шууд хамааруулж болох бүх хураамж, оноо болон бусад бүх хөнгөлөлт, урамшууллыг уг тооцоололд хамруулна.

Үр ашигт хүүний аргыг ашиглан нийт дансны үнийг хэрхэн тооцоолохыг дараах жишээнд үлгэрчлэн харуулав. А байгууллага нь дуусгавар болох хүртэл таван жилийн үлдсэн хугацаатай өрийн хэрэглүүрийг түүний 1,000ТН-ийн бодит үнэ цэнээр (үүнд ажил гүйлгээний зардал багтсан) худалдан авсан. Уг хэрэглүүр нь 1,250ТН-ийн гэрээний нэрлэсэн дүнтэй ба жил бүр төлөгдөх 4.7 хувийн тогтмол хүүтэй (1,250ТН x 4.7 хувь = жилд 59ТН) юм. Зээлдэгч нь уг өрийн хэрэглүүрийг нэрлэсэн дүнгээр урьдчилж төлөх сонголттой бөгөөд ингэж урьдчилж төлснөөр ямар нэг торгууль төлөхгүй гэж гэрээнд мөн тусгайлан заасан. Анх үүсэх үед тухайн байгууллага нь уг зээлдэгч урьдчилж төлөхгүй гэж бодож байна (иймээс санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед тэрхүү урьдчилсан төлбөрийн шинжийн бодит үнэ цэнэ нь мэдэгдэхүйц дүнтэй биш гэж уг байгууллага тодорхойлсон).

Хүүний орлого ба анхны хөнгөлөлтийг уг өрийн хэрэглүүрийн хугацаанд түүний дансны үнээс тогтмол хувь хэмжээгээр хуваарилахын тулд хүүг жил бүр 10 хувиар хуримтлуулах ёстой гэдгийг харуулж болох юм. Өрийн хэрэглүүрийн нийт дансны үнэ, хүүний орлого, мөнгөн гүйлгээний талаархи тайлант үе тус бүрийн мэдээллийг доорх хүснэгтэнд харуулав.

Жил	(а) Тухайн жилийн эхэн дэх нийт дансны үнэ	(б=а x 10%) Хүүний орлого	(в) Мөнгөн гүйлгээ	(г = а+б-в) Тухайн жилийн эцэс дэх нийт дансны үнэ
20X0	1,000	100	59	1,041
20X1	1,041	104	59	1,086
20X2	1,086	109	59	1,136
20X3	1,136	113	59	1,190
20X4	1,190	119	1,250+59	-

20X2 оны эхний өдөр байгууллага нь өөрийн мөнгөн гүйлгээний тооцооллыг хянан засварласан. Байгууллага нь гэрээний нэрлэсэн дүнгийн 50 хувийг 20X2 оны эцэст урьдчилж төлөх ба үлдсэн 50 хувийг 20X4 оны эцэст төлнө гэж хүлээж байна. Өрийн хэрэглүүрийн 20X2 оны нийт дансны үнийг УСНББОУС 41-ийн МЗУ161-р параграфын дагуу тохируулна. Байгууллага нь 20X2 онд болон дараагийн жилүүдэд авахаар хүлээж буй дүнг анхны үр ашигт хүүний түвшинг (10 хувь) ашиглан дискаунтчилсанаар нийт дансны үнийг дахин тооцоолно. Ингэснээр 20X2 оны шинэ нийт дансны үнэ нь 1,138ТН болно. 52ТН-ийн (1,138ТН-1,086ТН) тохируулгыг 20X2 онд ашиг, алдагдалд бүртгэнэ. Тооцооллын өөрчлөлтийг харгалзсанаар тохируулсан, уг нийт дансны үнэ, хүүний орлого, мөнгөн гүйлгээний талаархи мэдээллийг доорх хүснэгтэнд харуулав.

Жил	(а) Тухайн жилийн эхэн дэх нийт дансны үнэ	(б=а x 10%) Хүүний орлого	(в) Мөнгөн гүйлгээ	(г = а+б-в) Тухайн жилийн эцэс дэх нийт дансны үнэ
20X0	1,000	100	59	1,041
20X1	1,041	104	59	1,086
20X2	1,086+52	114	625+59	568
20X3	568	57	30	595
20X4	595	60	625+30	-

Б.15 Нийт дансны үнийг тооцоолох жишээ: Шаталсан хүүний төлбөр бүхий өрийн хэрэглүүр

Зарим үед байгууллага нь тухайн өрийн хэрэглүүрийн хугацаанд аажим нэмэгдэх эсвэл буурах урьдчилж тодорхойлсон хүүний түвшин (“шаталсан хүү”) бүхий өрийн хэрэглүүрийг худалдан авах буюу гаргадаг. Шаталсан хүүтэй өрийн хэрэглүүрийг 1,250ТН-ээр гаргасан бөгөөд дуусгавар болгох дүн нь 1,250ТН бол түүний нийт дансны үнэ нь уг өрийн хэрэглүүрийн хугацааны туршид тайлант үе бүрд 1,250ТН-тэй тэнцүү байх уу?

Үгүй. Хэдийгээр анхны дүн ба дуусгавар болгох дүн хоорондоо зөрүүгүй боловч байгууллага нь дансны үнээс тогтмол хувь хэмжээгээр тооцохын тулд уг өрийн хэрэглүүрийн хугацааны туршид хүүний төлбөрүүдийг хуваарилахдаа үр ашигт хүүний аргыг ашиглана.

Тухайн өрийн хэрэглүүрийн хугацаанд аажим нэмэгдэх эсвэл буурах урьдчилж тодорхойлсон хүүний түвшин (“шаталсан хүү”) бүхий өрийн хэрэглүүрийн хувьд үр ашигт хүүний аргыг ашигласнаар нийт дансны үнийг хэрхэн тооцоолохыг дараах жишээнд үлгэрчлэн харуулав.

20X0 оны 01 дүгээр сарын 01-нд А байгууллага нь өрийн хэрэглүүрийг 1,250ТН-ээр гаргасан. Үндсэн дүн нь 1,250ТН бөгөөд уг өрийн хэрэглүүрийг 20X4 оны 12 дугаар сарын 31-нд буцаан төлнө. Хүүний түвшинг үндсэн дүнгийн хувийн жингээр дараах байдлаар уг өрийн хэрэглүүрийн гэрээнд тусгайлан заасан. Үүнд: 20X0 онд 6.0 хувь (75ТН), 20X1 онд 8.0 хувь (100ТН), 20X2 онд 10.0 хувь (125ТН), 20X3 онд 12.0 хувь (150ТН), 20X4 онд 16.4 хувь (205ТН). Энэ тохиолдолд ирээдүйн мөнгөн зарлагын гүйлгээг түүний дуусгавар болох хугацаа хүртэл яг тэнцүү хувь хэмжээгээр дискаунтчлах хүүний түвшин нь 10 хувь байна. Иймээс тайлант үе тус бүрийн нийт дансны үнийг тодорхойлох зорилгоор хүүний мөнгөн төлбөрүүдийг уг өрийн хэрэглүүрийн хугацааны туршид дахин хуваарилна. Тайлант үе тус бүрийн хувьд тухайн тайлант үеийн эхэн дэх нийт дансны үнийг 10 хувийн үр ашигт хүүний түвшнээр үржүүлж, тэрхүү нийт дансны үнэ дээр нэмнэ. Уг тайлант үеийн аливаа мөнгөн төлбөрийг тэрхүү гарсан дүнгээс хасна. Үүний үр дүнд тайлант үе бүрийн нийт дансны үнэ нь дараах байдалтай байна:

Жил	(а) Тухайн жилийн эхэн дэх нийт дансны үнэ	(б=а x 10%) Хүүний орлого	(в) Мөнгөн гүйлгээ	(г = а+б-в) Тухайн жилийн эцэс дэх нийт дансны үнэ
20X0	1,250	125	75	1,300
20X1	1,300	130	100	1,330
20X2	1,330	133	125	1,338
20X3	1,338	134	150	1,322
20X4	1,322	133	1,250+205	-

Б.16 Ердийн нөхцөлтэй гэрээ: Тогтсон зах зээлгүй

Санхүүгийн хөрөнгийг худалдан авах гэрээний хувьд түүнийг арилжих тогтсон зах зээл байхгүй бол ийм гэрээ нь ердийн нөхцөлтэй гэрээ мөн үү?

Тийм. Тухайн хамаарах зах зээл дэх зохицуулалт буюу тогтсон журмаар ерөнхийдөө тогтоодог цаг хугацааны дотор уг хөрөнгийг нийлүүлэхийг шаарддаг нөхцлийг УСНББОУС 41-д заасан байдаг. Зах зээл гэсэн нэр томъёо нь албан ёсны хөрөнгийн бирж эсвэл зохион байгуулалттай биржийн бус зах зээлээр хязгаарлагдахгүй юм. Харин энэ нь санхүүгийн хөрөнгийг хэвийн байдлаар арилжаалдаг орчин гэсэн утгатай байдаг. Хүлээн зөвшөөрөгдөх цаг хугацаа гэдэг нь ажил гүйлгээг хийх ба хаалтын бичиг баримтыг бэлтгэх, эцэслэн дуусгахад талуудад шаардлагатай ул үндэслэлтэй, хэвийн тогтсон хугацаа юм.

Жишээлбэл; хаалттай захиалгаар гаргах санхүүгийн хэрэглүүрийн зах зээл нь мөн хамаарах зах зээл болно.

Б.17 Ердийн нөхцөлтэй гэрээ: Форвард гэрээ

ABC байгууллага нь М байгууллагын нэг сая ширхэг энгийн хувьцааг хоёр сарын дараа нэгжийг нь 10ТН-ээр худалдах авахын тулд форвард гэрээ байгуулсан. Уг гэрээ нь биржид арилждаг гэрээ биш юм. Энэ гэрээний дагуу ABC байгууллага нь хувьцааг биетээр хүлээн авах ба нөгөө талдаа 10 сая ТН-ийг мөнгөөр төлөх шаардлагатай. М байгууллагын хувьцааг нийтийн идэвхитэй зах зээлд өдөрт дундажаар 100,000 ширхэгийг арилжаалдаг. Ердийн нөхцөлтэй нийлүүлэлт нь 3 өдрийн дотор хийгддэг. Энэхүү форвард гэрээг ердийн нөхцөлтэй гэрээ гэж үзэх үү?

Үгүй. Тухайн хамаарах зах зээл дэх зохицуулалт буюу журмаар тогтоосны дагуу уг гэрээг барагдуулдаггүй учраас үүнийг үүсмэл хэрэглүүр гэж тайлагнах ёстой.

Б.18 Ердийн нөхцөлтэй гэрээ: Хэвийн барагдуулалтын аль нөхцлийг мөрдөх вэ?

Хэрэв байгууллагын санхүүгийн хэрэглүүрийг нэгээс олон идэвхитэй зах зээлд арилждаг бөгөөд төлбөр барагдуулалтын нөхцөл нь идэвхитэй янз бүрийн зах зээл бүрд өөр байдаг бол тэдгээр санхүүгийн хөрөнгийг худалдан авах гэрээ нь ердийн нөхцөлтэй гэрээ эсэхийг үнэлэхдээ аль нөхцлийг мөрдөх вэ?

Мөрдөх нөхцөл нь худалдан авалт бодитойгоор хийгдсэн зах зээлд хамаарах нөхцөл байна.

Үлгэрчлэн харуулвал: XYZ байгууллага нь ABC байгууллагын нэг сая ширхэг хувьцааг АНУ-ын хөрөнгийн бирж дээрээс, тухайлбал брокероор дамжуулан худалдан авсан. Уг гэрээний барагдуулалтын өдөр нь ажлын зургаан өдрийн дараа болно. АНУ-ын хөрөнгийн бирж дээр өмчийн хувьцааны арилжааг хэвийн нөхцлөөр ажлын гурван өдрийн дотор барагдуулдаг. Арилжааг ажлын зургаан өдрийн дараа барагдуулах учраас энэ нь ердийн нөхцөлтэй арилжааны чөлөөлөх нөхцлийг хангахгүй.

Гэвч XYZ байгууллага нь ажлын зургаан өдөр бүхий хэвийн барагдуулалтын хугацаатай гадаадын хөрөнгийн бирж дээр уг ажил гүйлгээг хийсэн бол энэхүү гэрээ нь ердийн нөхцөлтэй арилжааны чөлөөлөх нөхцлийг хангана.

Б.19 Ердийн нөхцөлтэй гэрээ: Дуудах опционоор хийгдэх хувьцааны худалдан авалт

А байгууллага нь XYZ байгууллагын 100 ширхэг хувьцааг дараагийн гурван сар доторх дурын хугацаанд нэгжийг 100ТН-ээр худалдан авах боломжийг түүнд олгох дуудах опционыг олон нийтийн зах зээлээс худалдан авсан. Хэрэв А байгууллага нь опционоо хэрэгжүүлвэл уг опционы зах зээлийн зохицуулалт буюу тогтсон журмын дагуу тухайн ажил гүйлгээг 14 хоногийн дотор барагдуулна. XYZ байгууллагын хувьцаа нь 3 хоногийн дотор барагдуулахыг шаарддаг олон нийтийн идэвхитэй зах зээлд арилжаалагддаг. Опционы хэрэгжүүлэлтээр хийгдэх хувьцааны худалдан авалт нь хувьцааны ердийн нөхцөлтэй худалдан авалт мөн үү?

Тийм. Опционы барагдуулалтыг тухайн опционы зах зээл дэх зохицуулалт буюу журмаар удирдан зохицуулдаг бөгөөд 14 хоногийн дотор хувьцааг олгосноор хийгдэх барагдуулалт нь ердийн нөхцөлтэй ажил гүйлгээ болох тул уг опционыг хэрэгжүүлснээр түүнийг цаашид үүсмэл хэрэглүүр гэж тайлагнахгүй.

Б.20 Арилжааны өдрийн эсвэл барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийг ашигласнаар санхүүгийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх ба үл хүлээн зөвшөөрөх

УСНББОУС 41 нь арилжааны өдрийн эсвэл барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийг ашигласнаар санхүүгийн санхүүгийн хөрөнгийг хүлээн зөвшөөрөх ба үл хүлээн зөвшөөрөх талаархи тусгай дүрэмтэй байдаг. Хадгаламжийн өглөг, худалдааны өглөгийн ажил гүйлгээ гэх мэт санхүүгийн өр төлбөр гэж ангилсан санхүүгийн хэрэглүүрүүдийн ажил гүйлгээнд энэхүү дүрмийг мөрдөх үү?

Үгүй. Санхүүгийн өр төлбөр гэж ангилсан санхүүгийн хэрэглүүрийн ажил гүйлгээний хувьд УСНББОУС 41 нь арилжааны өдрийн нягтлан бодох бүртгэл ба барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийн талаархи аливаа тусгай шаардлагуудыг тусгаагүй байдаг. Иймээс УСНББОУС 41-ийн 10 ба 35-р параграфт заасан, хүлээн зөвшөөрөлтийн болон үл хүлээн зөвшөөрөлтийн ерөнхий шаардлагуудыг мөрдөнө. Байгууллага нь “тухайн хэрэглүүрийн гэрээний нэг тал болсон” өдөр санхүүгийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө гэж УСНББОУС 41-ийн 10-р параграфт заасан. Талуудын аль нэг нь үүргээ гүйцэтгэсэн эсвэл тухайн гэрээ нь УСНББОУС 41-ийн цар хүрээнээс чөлөөлөгдөхгүй үүсмэл гэрээ байхаас бусад тохиолдолд ийм гэрээг ерөнхийдөө хүлээн зөвшөөрдөггүй. Санхүүгийн өр төлбөрийг зөвхөн дуусгавар болгосон үед, өөрөөр хэлбэл гэрээнд тусгайлан заасан үүргийг биелүүлсэн эсвэл чөлөөлсөн, цуцалсан, хугацаа дууссан үед үл хүлээн зөвшөөрнө гэж УСНББОУС 41-ийн 35-р параграфт заасан байдаг.

Хэсэг В: Дагалдах үүсмэл хэрэглүүр

В.1 Дагалдах үүсмэл хэрэглүүр: Өрийн үндсэн хэрэглүүрээс салган тусгаарлалт

Опцион бус дагалдах үүсмэл хэрэглүүрийг тухайн өрийн үндсэн хэрэглүүрээс салган тугаарлах шаардлагатай бол уг өрийн үндсэн хэрэглүүрийн болон дагалдах үүсмэл хэрэглүүрийн нөхцлүүдийг хэрхэн тодорхойлох вэ? Жишээлбэл; өрийн үндсэн хэрэглүүр нь тогтмол хүүтэй хэрэглүүр, хувьсах хүүтэй хэрэглүүр эсвэл тэг купонтой хэрэглүүр байх уу?

Өрийн үндсэн хэрэглүүрийн нөхцөл нь уг холимог (нэгдсэн) хэрэглүүрийн тогтоосон буюу дам илэрхийлсэн гол нөхцлүүдийг тусгадаг. Дам илэрхийлсэн эсвэл тогтоосон нөхцлүүд байхгүй бол байгууллага нь тухайн нөхцлийн талаар өөрийн шүүн тунгаалтыг хийнэ. Гэвч байгууллага нь тусгайлан заагаагүй бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлж болохгүй эсвэл уг холимог хэрэглүүрт нэгэнт тодорхой тусгагдаагүй, өөрөөр хэлбэл одоо байхгүй мөнгөн гүйлгээг бий болгож чадахгүй тийм дагалдах үүсмэл хэрэглүүрийг салган тусгаарлахад хүргэх байдлаар тухайн өрийн үндсэн хэрэглүүрийн нөхцлүүдийг тогтоож болохгүй юм. Жишээлбэл; таван жилийн хугацаатай өрийн хэрэглүүр нь жил бүрийн 40,000ТН-ийн тогтмол хүүний төлбөрүүдтэй бөгөөд түүний дуусгавар болгох 1,000,000ТН-ийн үндсэн дүнг өмчийн үнийн индексээр үржүүлэн тогтоодог бол уг хэрэглүүрийг тогтмол хүүтэй үндсэн гэрээ гэж тодорхойлохын оронд, хөвөх хүүтэй үндсэн гэрээ ба цэвэр дүнгээр тооцогдох хөвөх хүүтэй хэсэг бүхий өмчийн дагалдах своп гэж тодорхойлох нь тохиромжгүй юм. Энэ жишээний хувьд, тухайн холимог хэрэглүүрт хөвөх хүүний түвшин бүхий мөнгөн гүйлгээ байхгүй учраас үндсэн гэрээ нь жил бүр 40,000ТН төлөх тогтмол хүүтэй өрийн хэрэглүүр болно.

Түүнчлэн, уг холимог хэрэглүүр үүссэн үед тухайн дагалдах үүсмэл хэрэглүүрийг тэг (0) бодит үнэ цэнэтэй байлгах тийм байдлаар форвард, своп гэх мэт опцион бус дагалдах үүсмэл хэрэглүүрийн нөхцлүүдийг тодорхойлох ёстой. Опцион бус дагалдах үүсмэл хэрэглүүрүүдийг өөр бусад нөхцлөөр салган тусгаарлахыг зөвшөөрдөг бол нэг холимог хэрэглүүрийг өрийн үндсэн хэрэглүүр ба дагалдах үүсмэл хэрэглүүрийн янз бүрийн олон хослолуудаар задалж болох юм. Жишээлбэл; дагалдах үүсмэл хэрэглүүрийг хөшүүрэг үүсгэх нөхцлөөр, тухайн холимог хэрэглүүрт хараахан тусгагдаагүй жигд бус буюу бусад зарим эрсдлээр салган тусгаарлах. Иймээс тухайн холимог хэрэглүүрийг үүсэх үед тэг (0)-ээс өөр бодит үнэ цэнэ бий болгох үр дүн бүхий нөхцлүүдээр уг опцион бус дагалдах үүсмэл хэрэглүүрийг салган тусгаарлах нь тохиромжгүй юм. Дагалдах үүсмэл хэрэглүүрийн нөхцлийн тодорхойлолт нь уг санхүүгийн хэрэглүүрийг гаргах үед оршин байсан нөхцлүүдэд үндэслэдэг.

B.2 Дагалдах үүсмэл хэрэглүүр: Дагалдах опционыг салган тусгаарлалт

Асуулт В.1-ийн хариулт нь тухайн холимог хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрөх үед дагалдах үүсмэл хэрэглүүр тэг (0) бодит үнэ цэнэтэй байх тийм үр дүнтэйгээр уг опцион бус дагалдах үүсмэл хэрэглүүрийн нөхцлийг тодорхойлох хэрэгтэй гэдгийг илэрхийлсэн. Опционд суурилсан дагалдах үүсмэл хэрэглүүрийг салган тусгаарлах тохиолдолд уг холимог хэрэглүүр үүссэн өдрөөрх тухайн дагалдах үүсмэл хэрэглүүр нь тэг (0) бодит үнэ цэнэтэй эсвэл тэг (0) дотоод үнэ цэнэтэй (өөрөөр хэлбэл, мөнгөн ашиггүй) байхуйцаар тэрхүү дагалдах опционы нөхцлийг тодорхойлох ёстой юу?

Үгүй. Доор авч хэлэлцсэнчлэн, опционд суурилсан дагалдах үүсмэл хэрэглүүр бүхий холимог хэрэглүүрийн эдийн засгийн төлөв байдал нь тэрхүү холимог хэрэглүүр дэх опционы шинжийн хувьд тусгайлан заасан хэрэгжүүлэх үнээс (буюу хэрэгжүүлэх түвшнээс) үндсэндээ хамаардаг. Иймээс опционд суурилсан дагалдах хэрэглүүрийн (үүн дотроо, аливаа дагалдах буцаах эрх, дуудах эрх, хүүний түвшний дээд хэмжээ, хүүний түвшний доод хэмжээ, холимог хэрэглүүр дэх хүүний түвшний дээд, доод хэмжээний болон свопын шинж) салган тусгаарлалт нь уг холимог хэрэглүүрт баримтжуулсан опционы шинжийн тогтоосон нөхцлүүдэд үндэслэвэл зохино. Иймээс уг дагалдах үүсмэл хэрэглүүр нь тухайн холимог хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрөх үед заавал тэг (0)-тэй тэнцүү бодит үнэ цэнэ буюу дотоод үнэ цэнэтэй байх албагүй юм.

Хэрэв байгууллага нь опционд суурилсан дагалдах үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тэг (0) байхуйцаар тухайн дагалдах үүсмэл хэрэглүүрийн нөхцлийг тодорхойлох шаардлагатай бол тэрхүү опционыг тодорхой бус мөнгөн алдагдалтай болгох тийм үр дүнтэйгээр уг хэрэгжүүлэх үнийг (эсвэл хэрэгжүүлэх түвшинг) ерөнхийдөө тодорхойлох шаардлагатай байдаг. Энэ нь опционы шинжийг хэрэгжүүлэх тэг (0) магадлалтай гэсэн утгыг илэрхийлнэ. Гэвч холимог хэрэглүүр дэх опционы шинжийг хэрэгжүүлэх магадлал нь ерөнхийдөө тэг (0) байдаггүй учраас энэ нь анхны бодит үнэ цэнэ тэг (0) гэж үзэх тухайн холимог хэрэглүүрийн эдийн засгийн магадлалт шинж чанартай нийцэхгүй юм. Үүнтэй адилаар, хэрэв байгууллага нь опционд суурилсан дагалдах үүсмэл хэрэглүүрийн дотоод үнэ цэнийг тэг (0) байхуйцаар тухайн дагалдах үүсмэл хэрэглүүрийн нөхцлийг тодорхойлох шаардлагатай бол хэрэгжүүлэх үнэ (эсвэл хэрэгжүүлэх түвшин) нь тухайн холимог хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрөх өдрөөрх уг суурь хувьсагчийн үнэ (буюу түвшин)-тэй тэнцүү байна гэж төсөөлөх ёстой. Энэ тохиолдолд опционы бодит үнэ цэнэ нь зөвхөн цаг хугацааны үнэ цэнээс бүрдэнэ. Гэвч

тохиролцсон хэрэгжүүлэх үнэ нь тухайн холимог хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрөх өдрөөрх уг суурь хувьсагчийн үнэ (буюу түвшин)-тэй үнэхээр тэнцүү байхаас бусад тохиолдолд ийм төсөөлөл нь тухайн холимог хэрэглүүрийн эдийн засгийн магадлалт шинж чанартай, үүн дотроо опционы шинжийг хэрэгжүүлэх магадлалтай нийцэхгүй юм.

Опционы нөхцлөөр бол суурь зүйлийн үнэ ба уг опционы хэрэгжүүлэх үнийн хоорондох зөрүүд үндэслэсэн төлбөр нь тэрхүү тохиролцсон хэрэгжүүлэх үнэ болон ирээдүйн тусгайлан заасан өдөр буюу өдрүүд дэх тухайн суурь зүйлийн үнэ хоорондох харилцан холбооноос хамааран хийгдэж эсвэл хийгдэхгүй байж болно гэж үздэг, харин форвардын нөхцлөөр бол суурь зүйлийн үнэ ба форвард үнийн хоорондох зөрүүд үндэслэсэн төлбөр нь уг тогтоосон өдрөөр хийгддэг тул опционд суурилсан, дагалдах үүсмэл хэрэглүүрийн эдийн засгийн шинж чанар нь форвардад суурилсан дагалдах үүсмэл хэрэглүүрээс (үүн дотроо, форвард ба своп) үндсэндээ өөр байдаг. Иймээс опционд суурилсан дагалдах үүсмэл хэрэглүүрийн хэрэгжүүлэх үнийг тохируулах нь уг холимог хэрэглүүрийн шинж чанарыг өөрчилдөг. Нөгөө талаас, өрийн үндсэн хэрэглүүр дэх опцион бус дагалдах үүсмэл хэрэглүүрийн нөхцлийг тухайн холимог хэрэглүүр үүссэн өдрөөр тэг (0)-ээс өөр ямар нэг дүн бүхий бодит үнэ цэнэтэй байхаар тодорхойлсон бол тэрхүү дүн нь авсан эсвэл өгсөн зээлийг үндсэндээ илэрхийлнэ. Иймээс Асуулт В.1-ийн хариултанд авч хэлэлцсэнчлэн, тухайн холимог хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрөх үед тэг (0)-ээс өөр бодит үнэ цэнэ бий болгох үр дүн бүхий нөхцлүүдээр уг өрийн үндсэн хэрэглүүр дэх опцион бус дагалдах үүсмэл хэрэглүүрийг салган тусгаарлах нь тохиромжгүй юм.

В.3 Дагалдах үүсмэл хэрэглүүр: Өмчийн урамшуулал

Тэргүүн бус ээлжийн эрхтэй зээл олгож буй хамтарсан өмчит байгууллагууд нь хүү ба үндсэн зээлийг буцаан төлүүлэхээс гадна хэрэв тухайн зээлдэгч өөрийн хувьцааг хөрөнгийн биржид гаргавал тэрхүү зээлдэгч байгууллагын хувьцааг үнэгүй эсвэл маш бага үнээр (“өмчийн урамшуулал”) авах нөхцөлтэйгээр зээл олгохыг зарим үед зөвшөөрдөг. Өмчийн урамшууллын шинжийн улмаас уг тэргүүн бус ээлжийн эрхтэй зээлийн хүү нь бусад тохиолдолд тогтоогдох байсан түвшнээс бага хувь хэмжээтэй байдаг. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх байдлаар уг тэргүүн бус ээлжийн эрхтэй зээлийг бодит үнэ цэнээр хэмждэггүй (УСНББОУС 41-ийн 49(в) параграф) гэж үзвэл хэдийгээр тухайн зээлдэгч хөрөнгийн биржид хувьцаагаа арилжих эсэхээс болзошгүй хамаарах боловч уг өмчийн урамшууллын шинж нь дагалдах үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолтыг хангах уу?

Тийм. Өмчийн өгөөжийн эдийн засгийн шинж чанар ба эрсдэл нь өрийн үндсэн хэрэглүүрийн эдийн засгийн шинж чанар, эрсдэлтэй нягт уялдаа холбоотой байдаггүй (УСНББОУС 41-ийн 49(а) параграф). Өмчийн урамшуулал нь тухайн зээлдэгчийн хувьцааны үнийн өөрчлөлтөөс хамааран өөрчлөгдөх үнэ цэнэтэй ба зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөд ижил төсөөтэй хариу үзүүлэхээр хүлээгдэж буй бусад төрлийн гэрээний хувьд шаардахаас бага хэмжээний анхны цэвэр хөрөнгө оруулалтыг шаардана эсвэл анхны цэвэр хөрөнгө оруулалтыг шаардахгүй бөгөөд түүнийг ирээдүйд барагдуулах учраас энэ нь дагалдах үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолтыг хангана (УСНББОУС 41-ийн 49(б) параграф ба 9-р параграф). Хэдийгээр хувьцаа авах эрх нь тухайн зээлдэгч ирээдүйд хувьцаагаа биржид гаргах эсэхээс болзошгүй хамаарах боловч уг өмчийн урамшууллын шинж нь дагалдах үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолтыг хангана. Үүсмэл хэрэглүүр нь нэрлэсэн дүнтэй хамааралгүй ирээдүйн зарим үйл явдлын үр дүнд өөрчлөгдөж болох төлбөрийг шаарддаг гэж УСНББОУС 41-ийн МЗУ7-р параграфт заасан. Өмчийн урамшууллын шинж нь тогтмол төлбөрийн эрхгүй байхаас бусдаар ийм үүсмэл хэрэглүүртэй ижил төсөөтэй бөгөөд хэрэв ирээдүйн үйл явдал гарч тохиолдвол опционы эрх олгодог.

В.4 Дагалдах үүсмэл хэрэглүүр: Зохиомол хэрэглүүр

А байгууллага нь таван жилийн хугацаатай, хөвөх хүүтэй өрийн хэрэглүүрийг гаргасан. Үүний хамтаар А байгууллага нь таван жилийн хугацаатай, тогтмол хүү-төлөх ба хувьсах хүү-хүлээн авах хүүний түвшний свопын гэрээг В байгууллагатай байгуулсан. А байгууллага нь өрийн хэрэглүүр ба свопын хослолыг тогтмол хүүтэй зохиомол хэрэглүүр гэж үзсэн. Хэрэв үүсмэл хэрэглүүр нь өрийн үндсэн гэрээний дагуу төлөх эсвэл хүлээн авах хүүний дүнг өөрчилж чадах хүүний түвшинтэй уялдсан бол уг дагалдах үүсмэл хэрэглүүрийг түүний үндсэн хэрэглүүрийн хамт ангилахыг УСНББОУС 41-ийн МЗУ106(а) параграфтаар шаарддаг тул свопыг тусдаа тайлагнах нь тохиромжгүй гэж А байгууллага үзэж байна. Уг байгууллагын дүн шинжилгээ зөв үү?

Үгүй. Дагалдах үүсмэл хэрэглүүр нь уг үүсмэл бус үндсэн гэрээнд тусгагдсан нөхцөл ба болзол юм. УСНББОУС 41-ийг мөрдөх зорилгоор хоёр буюу хэд хэдэн тусдаа санхүүгийн хэрэглүүрүүдийг нэгдсэн нэг

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

хэрэглүүр (“зохиомол хэрэглүүр”-ийн нягтлан бодох бүртгэл) гэж үзэх нь ерөнхийдөө тохиромжгүй байдаг. Санхүүгийн хэрэглүүр бүр нь өөрийн нөхцөл, болзолтой бөгөөд тэдгээрийг тус тусад нь шилжүүлж эсвэл барагдуулж болох юм. Иймээс өрийн хэрэглүүр ба свопыг тусад нь ангилна. Энд дурдсан ажил гүйлгээ нь Асуулт Б.6-д авч хэлэлцсэн, уг үр дүн болох хүүний түвшний свопоос тусдаа мөн чанаргүй ажил гүйлгээнээс өөр юм.

В.5 Дагалдах үүсмэл хэрэглүүр: Гадаад валютаарх хэрэглүүрийн худалдан авалт ба борлуулалтын гэрээ

Нийлүүлэлтийн гэрээ нь (а) тухайн гэрээний аль нэг үндсэн оролцогч талын бүртгэлийн валют, (б) худалдан авах буюу нийлүүлэх уг холбогдох бараа, үйлчилгээний үнийг дэлхий дахинд хийгдэж буй худалдаа арилжаанд түгээмэл илэрхийлдэг валют, (в) тухайн ажил гүйлгээ хийгдэж буй эдийн засгийн орчинд санхүүгийн бус зүйлсийг худалдан авах буюу борлуулах гэрээнүүдэд нийтлэг ашигладаг валютаас бусад валютаар төлбөрийг хийдэг. УСНББОУС 41-ийн дагуу салган тусгаарлах хэрэгтэй дагалдах үүсмэл хэрэглүүр байна уу?

Тийм. Үлгэрчлэн харуулвал: Норвегийн байгууллага нь Франц дахь байгууллагад газрын тос худалдахыг зөвшөөрчээ. Хэдийгээр газрын тосны гэрээг дэлхий дахинд хийгдэж буй худалдаа арилжаанд ихэвчлэн ам доллараар илэрхийлдэг бөгөөд Норвеги улсад санхүүгийн бус зүйлсийг худалдан авах буюу борлуулах гэрээнд Норвегийн кроныг нийтлэг ашигладаг боловч уг газрын тосны гэрээг швейцар франкаар илэрхийлсэн. Аль ч байгууллага нь швейцар франкаар мэдэгдэхүйц их үйл ажиллагаа эрхлэн явуулдаггүй. Энэ тохиолдолд Норвегийн байгууллага нь уг нийлүүлэлтийн гэрээг швейцар франк худалдан авах гадаад валютын дагалдах форвард бүхий үндсэн гэрээ гэж үзнэ. Францын байгууллага нь уг нийлүүлэлтийн гэрээг швейцар франк худалдах гадаад валютын дагалдах форвард бүхий үндсэн гэрээ гэж үзнэ. Тухайн тайлагнагч байгууллага нь хэрэв тохиромжтой бол үүнийг мөнгөн гүйлгээний хейжийн хэрэглүүр гэж сонгосноос бусад тохиолдолд байгууллага бүр нь уг валютын форвардын бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд тусгана.

В.6 Гадаад валютын дагалдах үүсмэл хэрэглүүр: Холбоо хамааралгүй гадаад валютын нөхцөл

Санхүүгийн тайлангийн зүйлсийг еврод (түүний бүртгэлийн валют) үндэслэн санхүүгийн тайландаа хэмждэг А байгууллага нь газрын тосыг зургаан сарын дараа 1,000 ам доллараар худалдан авах гэрээг Б байгууллагатай байгуулсан. Тус Б байгууллагын бүртгэлийн валют нь Норвегийн крон юм. Уг газрын тосны үндсэн гэрээг тухайн байгууллагын хүлээгдэж буй худалдан авалт, борлуулалт буюу ашиглалтын шаардлагуудын дагуу (УСНББОУС 41-ийн 5-р параграф ба МЗУ8-р параграф) санхүүгийн бус зүйлийг нийлүүлэх зорилгоор байгуулсан ба тэр хэвээр эзэмшиж байгаа, түүнчлэн тус байгууллага нь УСНББОУС 41-ийн 6-р параграфын дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилахаар эргэлт буцалтгүй сонголт хийгээгүй тул энэ нь УСНББОУС 41-ийн цар хүрээнд хамаарахгүй. Газрын тосны нийлүүлэлт ба төлбөрөөс гадна талууд нь ам доллар ба Норвегийн кроны ханшийн хэлбэлзлийг уг 100,000 ам долларын нэрлэсэн дүнгээр үржүүлсэнтэй тэнцүү дүнг харилцан нөхөн олгоно гэж заасан гадаад валютын ханшийн хөшүүргийн нөхцлийг тэрхүү газрын тосны гэрээнд тусгасан. Уг дагалдах үүсмэл хэрэглүүрийг (гадаад валютын ханшийн хөшүүргийн нөхцлийг) УСНББОУС 41-ийн 49-р параграфын дагуу тэрхүү газрын тосны үндсэн гэрээтэй нягт уялдаатай гэж үзэх үү?

Үгүй. Хөшүүрэгдсэн гадаад валютын ханшийн нөхцөл нь тэрхүү газрын тосны үндсэн гэрээтэй нягт холбоогүй учраас түүнийг уг газрын тосны үндсэн гэрээнээс салган тусгаарлана (УСНББОУС 41-ийн МЗУ106(г) параграф).

Ам доллар нь А ба Б байгууллагын аль алины бүртгэлийн валют биш учраас 1,000 ам долларын дүн бүхий уг газрын тосны үндсэн гэрээний төлбөрийн нөхцлийг гадаад валютын үүсмэл хэрэглүүр гэж үзэж болно. Төлбөрийг ам доллараар хийхийг шаарддаг түүхий газрын тосны гэрээг УСНББОУС 41-ийн МЗУ106(г) параграфын дагуу гадаад валютын үүсмэл хэрэглүүр бүхий үндсэн гэрээ гэж үзэхгүй учраас энэхүү гадаад валютын үүсмэл хэрэглүүрийг салган тусгаарлахгүй.

Хөшүүрэгдсэн гадаад валютын ханшийн нөхцөл нь тухайн газрын тосны ажил гүйлгээний хувьд шаардлагатай төлбөрөөс гадна ам доллар ба Норвегийн кроны ханшийн хэлбэлзлийг уг 100,000 ам долларын нэрлэсэн дүнгээр үржүүлсэнтэй тэнцүү дүнг талууд харилцан нөхөн олгоно гэж заасан. Энэ нь газрын тосны үндсэн гэрээтэй холбоо хамааралгүй учраас үүнийг уг газрын тосны үндсэн гэрээнээс салган тусгаарлаж, УСНББОУС 41-ийн 49-р параграфын дагуу дагалдах үүсмэл хэрэглүүр гэж тайлагнана.

В.7 Гадаад валютын дагалдах үүсмэл хэрэглүүр: Олон улсын худалдааны валют

УСНББОУС 41-ийн МЗУ106(г) параграф нь холбогдох бараа, үйлчилгээний үнийг дэлхий дахинд хийгдэж буй худалдаа арилжаанд түгээмэл илэрхийлдэг валют гэж заасан. Тухайн гэрээний оролцогч үндсэн талуудын аль нэгний орон нутгийн хүрээнд худалдаа арилжаа хийгдэж буй зарим бүтээгдэхүүн, үйлчилгээний хувьд ашигладаг валют байж болох уу?

Үгүй. Холбогдох бараа, үйлчилгээний үнийг дэлхий дахинд хийгдэж буй худалдаа арилжаанд түгээмэл илэрхийлдэг валют нь зөвхөн нэг орон нутагт төдийгүй дэлхий дахинд хийгдэж буй ижил төсөөтэй ажил гүйлгээнд ашиглах цорын ганц валют юм. Жишээлбэл; Хойд Америк дахь байгалийн хийн улс дамнасан ажил гүйлгээг ихэвчлэн ам доллараар илэрхийлдэг ба ийм ажил гүйлгээг Европт ихэвчлэн еврогоор илэрхийлдэг бол ам доллар ба евроны аль аль нь дэлхий дахинд хийгдэж буй худалдаа арилжаанд тухайн бараа, үйлчилгээг түгээмэл илэрхийлдэг валют биш юм.

В.8 Дагалдах үүсмэл хэрэглүүр: Өөрийн хүлээн зөвшөөрсөн бараг бүх хөрөнгө оруулалтыг нөхөхгүйгээр барагдуулахыг эзэмшигчид зөвшөөрдөг боловч түүнээс заавал шаардахгүй

Хэрэв нэгдсэн хэрэглүүрийн нөхцөл нь өөрийн хүлээн зөвшөөрсөн бараг бүх хөрөнгө оруулалтыг нөхөхгүй байхад хүргэх тийм байдлаар уг нэгдсэн хэрэглүүрийг барагдуулахыг эзэмшигчид зөвшөөрдөг боловч түүнээс заавал шаарддаггүй бөгөөд гаргагч нь ийм эрхгүй бол (жишээлбэл; буцаах эрхтэй өөрийн хэрэглүүр) тухайн гэрээ нь эзэмшигч өөрийн хүлээн зөвшөөрсөн бараг бүх хөрөнгө оруулалтыг нөхөхгүй байх гэсэн УСНББОУС 41-ийн МЗУ106(а) параграфт заасан нөхцлийг хангах уу?

Үгүй. Хэрэв нэгдсэн хэрэглүүрийн нөхцөл нь өөрийн хүлээн зөвшөөрсөн бараг бүх хөрөнгө оруулалтыг нөхөхгүй байхад хүргэх тийм байдлаар уг нэгдсэн хэрэглүүрийг барагдуулахыг хөрөнгө оруулагчид зөвшөөрдөг боловч түүнээс заавал шаарддаггүй бөгөөд гаргагч нь ийм эрхгүй бол “эзэмшигч өөрийн хүлээн зөвшөөрсөн бараг бүх хөрөнгө оруулалтыг нөхөхгүй байх” гэсэн нөхцөл хангагдахгүй. Иймээс ийм нөхцөлтэй ба хүүний түвшний дагалдах үүсмэл хэрэглүүр бүхий хүүтэй үндсэн гэрээг тухайн үндсэн гэрээтэйгээ нягт уялдаа холбоотой гэж үзнэ. Эзэмшигч өөрийн хүлээн зөвшөөрсөн бараг бүх хөрөнгө оруулалтыг нөхөхгүй байхад хүргэх тийм дүнгээр барагдуулахыг тэрхүү эзэмшигч хүлээн зөвшөөрөхөд албадан хүргэх тухайн нөхцөл байдлын хувьд “эзэмшигч өөрийн хүлээн зөвшөөрсөн бараг бүх хөрөнгө оруулалтыг нөхөхгүй байх” гэсэн нөхцлийг хэрэглэнэ.

Хэсэг Г: Хүлээн зөвшөөрөлт ба үл хүлээн зөвшөөрөлт

Г.1 Анхны хүлээн зөвшөөрөлт

Г.1.1 Хүлээн зөвшөөрөлт: Мөнгөн барьцаа

Б байгууллага нь А байгууллагатай хийсэн өөр нэг ажил гүйлгээний (жишээлбэл; үнэт цаас зээлдүүлэх ажил гүйлгээ) барьцаа болгон уг А байгууллагад мөнгө шилжүүлсэн. Тэрхүү мөнгийг А байгууллагын хөрөнгөөс хууль ёсоор салгаж тусгаарлаагүй. А байгууллага нь хөрөнгө хүлээн авсан мэтээр уг мөнгөн барьцааг хүлээн зөвшөөрөх үү?

Тийм. Санхүүгийн хөрөнгийн эцсийн хэрэгжилт нь түүнийг мөнгөнд хөрвүүлэх явдал бөгөөд иймээс Б байгууллагын шилжүүлсэн мөнгөний эдийн засгийн үр өгөөжийг А байгууллага нь хүлээн зөвшөөрөхийн өмнө цаашид хувьсан өөрчлөлт хийх шаардлагагүй юм. Иймээс Б байгууллага нь мөнгийг үл хүлээн зөвшөөрч, А байгууллагаас авах авлагыг хүлээн зөвшөөрнө, харин А байгууллага нь тэрхүү мөнгийг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх ба Б байгууллагад төлөх өглөгийг хүлээн зөвшөөрнө.

Г.2 Санхүүгийн хөрөнгийн ердийн нөхцөлтэй худалдан авалт буюу борлуулалт

Г.2.1 Арилжааны өдөр эсвэл барагдуулалтын өдөр: Худалдан авалтын хувьд бүртгэх дүн

УСНББОУС 41-ийн арилжааны өдрийн болон барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг санхүүгийн хөрөнгийн худалдан авалтад хэрхэн мөрдөх вэ?

УСНББОУС 41 дэх арилжааны өдрийн болон барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг санхүүгийн хөрөнгийн худалдан авалтад хэрхэн мөрдөхийг дараах жишээнд үлгэрчлэн харуулав. 20X1 оны

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

12 дугаар сарын 29-нд байгууллага нь санхүүгийн хөрөнгийг 1,000ТН-ээр худалдан авах баталгаа гаргасан бөгөөд 1,000ТН нь түүний уг баталгааны (арилжааны) өдрөөрх бодит үнэ цэнэ юм. Ажил гүйлгээний зардал нь материаллаг бус байсан. Тухайн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь 20X1 оны 12 дугаар сарын 31-нд (санхүүгийн жилийн эцэст) 1,002ТН, 20X2 оны 01 дүгээр сарын 04-нд (барагдуулалтын өдөр) 1,003ТН байв. Доорх хоёр хүснэгтэд харуулсанчлан, тухайн хөрөнгийн хувьд бүртгэх дүн нь түүнийг хэрхэн ангилсан ба арилжааны өдрийн эсвэл барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийг ашигласан эсэхээс хамаарна.

Барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэл			
Үлдэгдэл	Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө
20X1 оны 12-р сарын 29			
Санхүүгийн хөрөнгө	-	-	-
Санхүүгийн өр төлбөр	-	-	-
20X1 оны 12-р сарын 31			
Авлага	-	2	2
Санхүүгийн хөрөнгө	-	-	-
Санхүүгийн өр төлбөр	-	-	-
Цэвэр хөрөнгө/өмч (бодит үнэ цэнийн залруулга)	-	(2)	-
Хуримтлагдсан ашиг, алдагдал (ашиг, алдагдлаар дамжуулан)	-	-	(2)
20X2 оны 01-р сарын 04			
Авлага	-	-	-
Санхүүгийн хөрөнгө	1,000	1,003	1,003
Санхүүгийн өр төлбөр	-	-	-
Цэвэр хөрөнгө/өмч (бодит үнэ цэнийн залруулга)	-	(3)	-
Хуримтлагдсан ашиг, алдагдал (ашиг, алдагдлаар дамжуулан)	-	-	(3)

Арилжааны өдрийн нягтлан бодох бүртгэл			
Үлдэгдэл	Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө
20X1 оны 12-р сарын 29			
Санхүүгийн хөрөнгө	1,000	1,000	1,000
Санхүүгийн өр төлбөр	(1,000)	(1,000)	(1,000)
20X1 оны 12-р сарын 31			
Авлага	-	-	-
Санхүүгийн хөрөнгө	1,000	1,002	1,002
Санхүүгийн өр төлбөр	(1,000)	(1,000)	(1,000)
Цэвэр хөрөнгө/өмч (бодит үнэ цэнийн залруулга)	-	(2)	-
Хуримтлагдсан ашиг, алдагдал (ашиг, алдагдлаар дамжуулан)	-	-	(2)
20X2 оны 01-р сарын 04			
Авлага	-	-	-
Санхүүгийн хөрөнгө	1,000	1,003	1,003
Санхүүгийн өр төлбөр	-	-	-
Цэвэр хөрөнгө/өмч (бодит үнэ цэнийн залруулга)	-	(3)	-

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Хуримтлагдсан ашиг, алдагдал (ашиг, алдагдлаар дамжуулан)	-	-	(3)
--	---	---	-----

Г.2.2 Арилжааны өдөр эсвэл барагдуулалтын өдөр: Борлуулалтын хувьд бүртгэх дүн

УСНББОУС 41 дэх арилжааны өдрийн болон барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг санхүүгийн хөрөнгийн борлуулалтад хэрхэн мөрдөх вэ?

УСНББОУС 41 дэх арилжааны өдрийн болон барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг санхүүгийн хөрөнгийн борлуулалтанд хэрхэн мөрдөхийг дараах жишээнд үлгэрчлэн харуулав. 20X2 оны 12 дугаар сарын 29-нд (арилжааны өдөр) байгууллага нь санхүүгийн хөрөнгийг түүний 1,010ТН-ийн одоогийн бодит үнэ цэнээр борлуулах гэрээ байгуулсан. Уг хөрөнгийг нэг жилийн өмнө 1,000ТН-ээр худалдан авсан бөгөөд түүний хорогдуулсан өртөг нь 1,000ТН байсан. Тухайн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь 20X2 оны 12 дугаар сарын 31-нд (санхүүгийн жилийн эцэст) 1,012ТН байв. 20X3 оны 01 дүгээр сарын 04-нд (барагдуулалтын өдөр) бодит үнэ цэнэ нь 1,013ТН болсон. Доорх хоёр хүснэгтэд харуулсанчлан, тухайн хөрөнгийн хувьд бүртгэх дүн нь түүнийг хэрхэн ангилсан ба арилжааны өдрийн эсвэл барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийг ашигласан эсэхээс хамаарна (тухайн хөрөнгийн аливаа гарзын хасагдуулга болон хүүний орлогыг энэ жишээний зорилгын хувьд харгалзан үзээгүй болно).

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийн талаархи борлуулагчийн эрх нь арилжааны өдрөөр дуусгавар болдог учраас уг байгууллага нь барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэдэг боловч ердийн нөхцлөөр борлуулсан санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг арилжааны өдөр ба барагдуулалтын өдрийн хоорондох хугацаанд санхүүгийн тайланд бүртгэдэггүй.

Барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэл			
Үлдэгдэл	Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө
20X2 оны 12-р сарын 29			
Авлага	-	-	-
Санхүүгийн хөрөнгө	1,000	1,010	1,010
Цэвэр хөрөнгө/өмч (бодит үнэ цэнийн залруулга)	-	10	-
Хуримтлагдсан ашиг, алдагдал (ашиг, алдагдлаар дамжуулан)	-	-	10
20X2 оны 12-р сарын 31			
Авлага	-	-	-
Санхүүгийн хөрөнгө	1,000	1,010	1,010
Цэвэр хөрөнгө/өмч (бодит үнэ цэнийн залруулга)	-	10	-
Хуримтлагдсан ашиг, алдагдал (ашиг, алдагдлаар дамжуулан)	-	-	10
20X3 оны 01-р сарын 04			
Цэвэр хөрөнгө/өмч (бодит үнэ цэнийн залруулга)	-	-	-
Хуримтлагдсан ашиг, алдагдал (ашиг, алдагдлаар дамжуулан)	10	10	10

Арилжааны өдрийн нягтлан бодох бүртгэл			
Үлдэгдэл	Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө
20X2 оны 12-р сарын 29			

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Авлага	1,010	1,010	1,010
Санхүүгийн хөрөнгө	-	-	-
Цэвэр хөрөнгө/өмч (бодит үнэ цэнийн залруулга)	-	-	-
Хуримтлагдсан ашиг, алдагдал (ашиг, алдагдлаар дамжуулан)	10	10	10
20X2 оны 12-р сарын 31			
Авлага	1,010	1,010	1,010
Санхүүгийн хөрөнгө	-	-	-
Цэвэр хөрөнгө/өмч (бодит үнэ цэнийн залруулга)	-	-	-
Хуримтлагдсан ашиг, алдагдал (ашиг, алдагдлаар дамжуулан)	10	10	10
20X3 оны 01-р сарын 04			
Цэвэр хөрөнгө/өмч (бодит үнэ цэнийн залруулга)	-	-	-
Хуримтлагдсан ашиг, алдагдал (ашиг, алдагдлаар дамжуулан)	10	10	10

Г.2.3 Барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэл: Мөнгөн бус санхүүгийн хөрөнгийн солилцоо

Хэрэв байгууллага нь барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийг ашиглан санхүүгийн хөрөнгийн борлуулалтыг хүлээн зөвшөөрдөг бол борлуулсан мөнгөн бус санхүүгийн хөрөнгийн хариуд хүлээн авах санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг УСНББОУС 41-ийн 105-р параграфын дагуу хүлээн зөвшөөрөх үү?

Нөхцөл байдлаас хамаарна. Хэрэв байгууллага нь санхүүгийн хөрөнгийн тухайн ангийн хувьд барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэдэг бол хүлээн авах санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн аливаа өөрчлөлтийг УСНББОУС 41-ийн 105-р параграфын дагуу тайлагнана. Харин байгууллага нь уг хүлээн авах санхүүгийн хөрөнгийг арилжааны өдрийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэдэг ангид хамааруулан ангилсан бол тэрхүү хүлээн авах хөрөнгийг УСНББОУС 41-ийн МЗУ19-р параграфт заасанчлан, арилжааны өдөр хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд байгууллага нь уг барагдуулалтын өдөр хүргэн нийлүүлэх тухайн санхүүгийн хөрөнгийн дансны үнэтэй тэнцүү дүнгээр өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

Үлгэрчлэн харуулвал: 20X2 оны 12 дугаар сарын 29-нд (арилжааны өдөр) А байгууллага нь худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэж ангилж, бодит үнэ цэнээр хэмждэг Б бондын хариуд хорогдуулсан өртгөөр бүртгэдэг А авлагын бичгийг борлуулах гэрээ байгуулсан. 12 дугаар сарын 29-нд хоёр хөрөнгийн аль алины бодит үнэ цэнэ нь 1,010ТН, харин А авлагын бичгийн хорогдуулсан өртөг нь 1,000ТН байсан. А байгууллага нь хорогдуулсан өртгөөр хэмждэг санхүүгийн хөрөнгийн хувьд барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийг, худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэсэн тодорхойлолтыг хангадаг хөрөнгийн хувьд арилжааны өдрийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэдэг. 20X2 оны 12 дугаар сарын 31-нд (санхүүгийн жилийн эцэст) А авлагын бичгийн бодит үнэ цэнэ нь 1,012ТН, Б бондын бодит үнэ цэнэ нь 1,009ТН болсон. 20X3 оны 01 дүгээр сарын 04-нд А авлагын бичгийн бодит үнэ цэнэ нь 1,013ТН, Б бондын бодит үнэ цэнэ нь 1,007ТН байв. Дараах журналын бичилтийг хийнэ:

20X2 оны 12 дугаар сарын 29

Дебит	Б бонд	1,010ТН	
Кредит	Өглөг		1,010ТН

20X2 оны 12 дугаар сарын 31

Дебит	Арилжааны гарз	1ТН	
Кредит	Б бонд		1ТН

20X3 оны 01 дүгээр сарын 04

Дебит	Өглөг	1,010ТН	
Дебит	Арилжааны гарз	2ТН	
Кредит	А авлагын бичиг		1,000ТН

Кредит	Б бонд	2ТН
Кредит	Хэрэгжүүлэлтийн олз	10ТН

Хэсэг Д: Хэмжилт

Д.1 Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн анхны хэмжилт

Д.1.1 Анхны хэмжилт: Ажил гүйлгээний зардал

Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэнээс бусад, санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн анхны хэмжилтэнд ажил гүйлгээний зардлыг оруулна. Энэ шаардлагыг практикт хэрхэн мөрдөх вэ?

Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжээгүй санхүүгийн хөрөнгийн хувьд, ажил гүйлгээний зардлыг анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнэ дээр нэмнэ. Санхүүгийн өр төлбөрийн хувьд, ажил гүйлгээний зардлыг анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнээс хасна.

Хорогдуулсан өртгөөр хэмждэг санхүүгийн хэрэглүүрийн хувьд, ажил гүйлгээний зардлыг үр ашигт хүүний арга ашиглан тооцоолсон, хорогдуулсан өртөгт тусган оруулах бөгөөд ингэснээр тухайн хэрэглүүрийн хугацааны туршид ашиг, алдагдалд шингээж хорогдуулна.

УСНББОУС 41-ийн 41 ба 111-р параграфын, эсвэл 43 ба 106-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг санхүүгийн хэрэглүүрийн хувьд, ажил гүйлгээний зардлыг уг дараагийн дахин хэмжилтийн өдрөөрх бодит үнэ цэнийн өөрчлөлтийн нэг хэсэг байдлаар цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө. Хэрэв санхүүгийн хөрөнгийг УСНББОУС 41-ийн 41 ба 111-р параграфын дагуу хэмждэг бол ажил гүйлгээний зардлыг үр ашигт хүүний арга ашиглан ашиг, алдагдалд шингээн хорогдуулах буюу ингэснээр тухайн хэрэглүүрийн хугацааны туршид ашиг, алдагдалд шингээж хорогдуулна.

Санхүүгийн хэрэглүүрийн шилжүүлэлт эсвэл данснаас хасалтын хувьд гарахаар хүлээгдэж буй ажил гүйлгээний зардлыг тухайн санхүүгийн хэрэглүүрийн хэмжилтэнд тусган оруулахгүй.

Д.2 Олз ба гарз

Д.2.1 УСНББОУС 41 ба УСНББОУС 4 – Цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө: Валютын бүрэлдэхүүн хэсгийн салган тусгаарлалт

УСНББОУС 41-ийн 41-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийг мөнгөн зүйлс гэж үзнэ. Иймээс байгууллага нь гадаад валютын ханшийн өөрчлөлттэй холбоотой дансны үнийн өөрчлөлтийг УСНББОУС 4-ийн 27(а) ба 32-р параграфын дагуу ашиг алдагдалд, харин дансны үнийн бусад өөрчлөлтийг УСНББОУС 41-ийн дагуу цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө. Цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан олз, гарзыг хэрхэн тодорхойлох вэ?

Энэ нь тухайн тайлагнагч байгууллагын бүртгэлийн валютаар илэрхийлэгдсэн, санхүүгийн хөрөнгийн⁶⁰ хорогдуулсан өртөг ба бодит үнэ цэнэ хоорондох зөрүү юм. УСНББОУС 4-ийн 32-р параграфыг мөрдөх зорилгын хувьд тухайн хөрөнгийг гадаад валютаар илэрхийлсэн, хорогдуулсан өртгөөр хэмжсэн хөрөнгө гэж үзнэ.

Үлгэрчлэн харуулвал: 20X1 оны 12 дугаар сарын 31-нд А байгууллага нь гадаад валютаар (ГВ) илэрхийлэгдсэн бондыг түүний бодит үнэ цэнэ болох 1,000 ГВ-аар худалдан авсан. Бонд нь дуусгавар болох хүртэл 5 жилийн үлдсэн хугацаатай, 1,250 ГВ-ын гэрээний нэрлэсэн дүнтэй, жил бүр төлөгдөх 4.7 хувийн тогтмол хүүтэй (1,250 ГВ х 4.7 хувь = жилд 59 ГВ) бөгөөд үр ашигт хүүний түвшин нь 10 хувь байсан. УСНББОУС 41-ийн 41-р параграфын дагуу А байгууллага нь уг бондыг дараагийн тайлант үеүдэд цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан учраас олз, гарзыг цэвэр хөрөнгө/өмчид

⁶⁰ Энэ жишээний зорилго нь УСНББОУС 41-ийн 41-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг санхүүгийн хөрөнгийн хувьд валютын бүрэлдэхүүн хэсгийг хэрхэн салган тусгаарлахыг үлгэрчлэн харуулах явдал юм. Иймээс УСНББОУС 41-ийн 73-93-р параграфт заасан, үнэ цэнийн бууралтын шаардлагуудын үр нөлөөг энэ жишээнд хялбарчлах үүднээс тусган харуулаагүй болно.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

хүлээн зөвшөөрнө. Уг байгууллагын бүртгэлийн валют нь орон нутгийн валют (ОНВ) юм. 1 ГВ-ын ханш нь 1.5 ОНВ ба бондын дансны үнэ нь 1,500 ОНВ (=1,000 ГВ x 1.5) байсан.

Дебит	Бонд	1,500 ОНВ	
Кредит	Мөнгө		1,500 ОНВ

20Х2 оны 12 сарын 31-нд гадаад валютын ханш өсөж, 1 ГВ нь 2 ОНВ болсон. Бондын бодит үнэ цэнэ нь 1,060 ГВ тул дансны үнэ нь 2,120 ОНВ (=1,060 ГВ x 2) болно. Хорогдуулсан өртөг нь 1,041 ГВ (=2,082 ОНВ) байна. Энэ тохиолдолд цэвэр хөрөнгө/өмчид хуримтлуулж, хүлээн зөвшөөрөх тухайн хуримтлагдсан олз буюу гарз нь 20Х2 оны 12 дугаар сарын 31-нээрх бодит үнэ цэнэ ба хорогдуулсан өртгийн зөрүү, өөрөөр хэлбэл 38 ОНВ (=2,120 ОНВ-2,082 ОНВ) байна.

20Х2 оны 12 дугаар сарын 31-нд уг бондын хувьд хүлээн авсан хүү нь 59 ГВ (=118 ОНВ) байв. Үр ашигт хүүний аргын дагуу тодорхойлсон хүүний орлого нь 100 ГВ (=1,000 x 10 хувь) байна. Тухайн жилд 1 ГВ-ын дундаж ханш нь 1.75 ОНВ байсан. Энэ асуултын зорилгын хувьд, дундаж ханшийг ашиглах нь тухайн жилийн туршид хүүний орлогыг хуримтлуулахад хэрэглэх спот ханшийн найдвартай, ойролцоо тооцоолол болно гэж төсөөлнө (УСНББОУС 4-ийн 25-р параграфыг үзнэ үү). Иймээс тайлагнасан хүүний орлого нь 175 ОНВ (=100 ГВ x 1.75) болно. Үүнд: анхны хөнгөлөлтийн 72 ОНВ-ын ([100 ГВ-59 ГВ] x 1.75) хуваарилалт багтсан. Иймээс уг бондын ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн ханшийн зөрүү нь 510 ОНВ (=2,082 ОНВ-1,500 ОНВ-172 ОНВ) байна. Мөн тухайн жилийн хувьд хүүний авлагад хамаарах ханшийн олз нь 15 ОНВ (=59 ГВ x [2.00-1.75]) байв.

Дебит	Бонд	620 ОНВ	
Дебит	Мөнгө	118 ОНВ	
Кредит	Хүүний орлого		175 ОНВ
Кредит	Ханшийн олз		525 ОНВ
Кредит	Цэвэр хөрөнгө/өмч дэх бодит үнэ цэнийн өөрчлөлт		38 ОНВ

20Х3 оны 12 сарын 31-нд гадаад валютын ханш өсөж, 1 ГВ нь 2.50 ОНВ болсон. Бондын бодит үнэ цэнэ нь 1,070 ГВ тул дансны үнэ нь 2,675 ОНВ (=1,070 ГВ x 2.50) болно. Хорогдуулсан өртөг нь 1,086 ГВ (=2,715 ОНВ) байна. Хорогдуулсан өртөг нь 1,086 ГВ(=2,715 ОНВ) байна. Цэвэр хөрөнгө/өмчид хуримтлуулж, хүлээн зөвшөөрөх тухайн хуримтлагдсан олз буюу гарз нь 20Х3 оны 12 дугаар сарын 31-нээрх бодит үнэ цэнэ ба хорогдуулсан өртгийн зөрүү, өөрөөр хэлбэл хасах 40 ОНВ (=2,675 ОНВ-2,715 ОНВ) байна. Иймээс цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн дүн нь 20Х3 он дахь тухайн зөрүүгийн өөрчлөлт болох 78 ОНВ (=40 ОНВ+38 ОНВ)-тай тэнцүү байна.

20Х3 оны 12 дугаар сарын 31-нд уг бондын хувьд хүлээн авсан хүү нь 59 ГВ (=148 ОНВ) байв. Үр ашигт хүүний аргын дагуу тодорхойлсон хүүний орлого нь 104 ГВ (=1,041 x 10 хувь) байна. Тухайн жилд 1 ГВ-ын дундаж ханш нь 2.25 ОНВ байсан. Энэ асуултын зорилгын хувьд, дундаж ханшийг ашиглах нь тухайн жилийн туршид хүүний орлогыг хуримтлуулахад хэрэглэх спот ханшийн найдвартай, ойролцоо тооцоолол болно гэж төсөөлнө (УСНББОУС 4-ийн 25-р параграф). Иймээс хүлээн зөвшөөрсөн хүүний орлого нь 234 ОНВ (=104 ГВ x 2.25) болно. Үүнд: анхны хөнгөлөлтийн 101 ОНВ-ын ([104 ГВ-59 ГВ] x 2.25) хуваарилалт багтсан. Иймээс уг бондын ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн ханшийн зөрүү нь 532 ОНВ (=2,715 ОНВ-2,082 ОНВ-101 ОНВ) байна. Мөн тухайн жилийн хувьд хүүний авлагад хамаарах ханшийн олз нь 15 ОНВ (=59 ГВ x [2.50-2.25]) байв.

Дебит	Бонд	555 ОНВ	
Дебит	Мөнгө	148 ОНВ	
Дебит	Цэвэр хөрөнгө/өмч дэх бодит үнэ цэнийн өөрчлөлт	78 ОНВ	
Кредит	Хүүний орлого		234 ОНВ
Кредит	Ханшийн олз		547 ОНВ

Д.2.2 УСНББОУС 41 ба УСНББОУС 4 – Гадаад байгууллагын хөрвүүлэлтээс үүссэн ханшийн зөрүү: Цэвэр хөрөнгө/өмчид эсвэл ашиг, алдагдалд?

Гадаад үйл ажиллагааны санхүүгийн тайлангийн хөрвүүлэлтээс үүссэн бүх ханшийн зөрүүг тухайн цэвэр хөрөнгө оруулалтыг данснаас хасах хүртэл цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө гэж УСНББОУС 4-ийн 37 ба 57-р параграфт заасан байдаг. Үүнд: УСНББОУС 41-ийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө ба цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн аль алиныг агуулах, бодит үнэ цэнээр бүртгэсэн санхүүгийн хэрэглүүрээс үүсэх ханшийн зөрүү хамаарна.

УСНББОУС 41 нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд, харин цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрөхийг шаарддаг.

Хэрэв гадаад үйл ажиллагаа нь түүний санхүүгийн тайланг уг хяналт тавигч байгууллагын санхүүгийн тайлантай нэгтгэдэг хяналтанд буй байгууллага бол тэрхүү нэгтгэсэн санхүүгийн тайланд УСНББОУС 41 болон УСНББОУС 4-ийн 44-р параграфыг хэрхэн мөрдөх вэ?

Гадаад үйл ажиллагааны санхүүгийн тайланд санхүүгийн хэрэглүүрийг тайлагнахдаа УСНББОУС 41-ийг, харин тухайн тайлагнагч байгууллагын санхүүгийн тайланд тусган оруулахын тулд уг гадаад үйл ажиллагааны санхүүгийн тайланг хөрвүүлэхдээ УСНББОУС 4-ийг мөрдөнө.

Үлгэрчлэн харуулвал: А байгууллага нь Х улсад оршин байдаг бөгөөд түүний бүртгэлийн валют ба толилуулгын валют нь тэрхүү Х улсын орон нутгийн валют (ХОНВ) юм. Мөн А нь Y улсад өөрийн хяналтанд буй байгууллагатай (Б байгууллага) бөгөөд түүний бүртгэлийн валют нь Y улсын орон нутгийн валют (YОНВ) байна. Б байгууллага нь худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэсэн тодорхойлолтыг хангах өрийн хэрэглүүрийн өмчлөгч ба иймээс түүнийг УСНББОУС 41-ийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг.

Б байгууллагын 20X0 оны санхүүгийн тайланд тусгах уг өрийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ ба дансны үнэ нь Y улсын орон нутгийн валютаар 100 YОНВ байна. А байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд уг хөрөнгийг тухайн тайлант үеийн эцэст хамаарах спот ханшаар (2.00) Х улсын орон нутгийн валютанд хөрвүүлнэ. Иймээс нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь дансны үнэ нь 200 ХОНВ (=100 YОНВ x 2.00) болно.

20X1 оны эцэст уг өрийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ нь Y улсын орон нутгийн валютаар 110 YОНВ болж өссөн. Б байгууллага нь уг худалдаа арилжааны хөрөнгийг 110 YОНВ-аар өөрийн санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрөх бөгөөд 10 YОНВ-ын бодит үнэ цэнийн олзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Тухайн жилийн туршид уг хэрэглүүрийн бодит үнэ цэнэ нь Х улсын валютаар 200 ХОНВ-аас 300 ХОНВ (=110YОНВ x 3.00) болж өссөний үр дүнд спот ханш нь 2.00-оос 3.00 болж нэмэгдсэн. Иймээс А байгууллага нь уг худалдаа арилжааны хөрөнгийг 330 ХОНВ-аар өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

А байгууллага нь Б байгууллагын цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланг “тухайн ажил гүйлгээний өдрийн ханш”-аар хөрвүүлнэ (УСНББОУС 4-ийн 44(б) параграф). Бодит үнэ цэнийн олз нь тухайн жилийн туршид хуримтлагддаг учраас А байгууллага нь практик үндэслэлтэй ойролцоо тооцоолол болгон дундаж ханшийг (УСНББОУС 4-ийн 25-р параграфын дагуу $[3.00 + 2.00] / 2 = 2.50$) ашигладаг. Иймээс уг худалдаа арилжааны хөрөнгийн бодит үнэ цэнэ нь 130 ХОНВ (=330 ХОНВ – 200 ХОНВ)-аар нэмэгдсэн боловч А байгууллага нь УСНББОУС 4-ийн 44(б) параграфыг даган мөрдөхийн тулд зөвхөн энэхүү 25 ХОНВ (=10 YОНВ x 2.5)-ын өсөлтийг өөрийн нэгтгэсэн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Үр дүн болох ханшийн зөрүүг өөрөөр хэлбэл, өрийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өсөлтийн үлдсэн дүнг (130 ХОНВ – 25 ХОНВ = 105 ХОНВ) тэрхүү гадаад үйл ажиллагаан дахь цэвэр хөрөнгө оруулалтыг данснаас хасах хүртэл УСНББОУС 4-ийн 57-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчид хуримтлуулан бүртгэнэ.

Д.2.3 УСНББОУС 41 ба УСНББОУС 4: УСНББОУС 41 ба УСНББОУС 4-ийн хоорондох уялдаа холбоо

УСНББОУС 41 нь санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийг хэмжих, түүнчлэн дахин хэмжилтээс үүссэн олз ба гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх талаархи шаардлагуудыг агуулсан байдаг. УСНББОУС 4 нь гадаад валютаар илэрхийлэгдсэн зүйлсийг тайлагнах ба ханшийн зөрүүг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх талаархи дүрмийг тусгасан байдаг. УСНББОУС 4 ба УСНББОУС 41-ийг ямар дарааллаар мөрдөх вэ?

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Санхүүгийн байдлын тайлан

Ерөнхийдөө, санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнэ, өртөг эсвэл хорогдуулсан өртгөөр хэмжилтийг УСНББОУС 41-ийн дагуу тухайн зүйлийг илэрхийлсэн гадаад валютаар эхлээд тодорхойлно. Дараа нь, хаалтын ханш эсвэл түүхэн ханшийг ашигласнаар уг гадаад валютын дүнг УСНББОУС 21 (УСНББОУС 41-ийн МЗУ224-р параграф)-ийн дагуу бүртгэлийн валютанд хөрвүүлнэ. Жишээлбэл; мөнгөн зүйлийн санхүүгийн хөрөнгийг (өрийн хэрэглүүр гэх мэт) УСНББОУС 41-ийн дагуу хорогдуулсан өртгөөр хэмждэг бол уг хорогдуулсан өртгийг тухайн санхүүгийн хөрөнгийг илэрхийлсэн валютаар тооцоолно. Дараа нь, уг гадаад валютын дүнг тухайн байгууллагын санхүүгийн тайланд хаалтын ханшийг ашиглан хүлээн зөвшөөрнө (УСНББОУС 4-ийн 27-р параграф). Мөнгөн зүйлийг тухайн гадаад валютаар илэрхийлэгдсэн, хорогдуулсан өртгөөр эсвэл бодит үнэ цэнээр хэмждэг эсэхээс үл хамааран ингэж мөрдөнө (УСНББОУС 4-ийн 28-р параграф). Гадаад валютаар, бодит үнэ цэнээр хэмждэг мөнгөн зүйлийн бус санхүүгийн хөрөнгийг (өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө хөрөнгө оруулалт гэх мэт) хаалтын ханшийг ашиглан хөрвүүлнэ (УСНББОУС 4-ийн 27(в) параграф).

Хэрэв санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг УСНББОУС 41-ийн дагуу гадаад валютын ханшийн өөрчлөлтийн эрсдлийн бодит үнэ цэнийн хейжийн хувьд хейжийн зүйл гэж сонгосон (эсвэл байгууллага нь УСНББОУС 29-ийн хейжийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудыг үргэлжлүүлэн мөрдөхийн тулд өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлого байдлаар сонгосон) бол хэдийгээр түүнийг УСНББОУС 4 (УСНББОУС 41-ийн 137-р параграф эсвэл УСНББОУС 29-ийн 99-р параграф)-ийн дагуу түүхэн ханшийг ашиглан хүлээн зөвшөөрөх байсан боловч тэрхүү хейжийн зүйлийг гажих нөхцөл болгон тухайн гадаад валютын ханшийн өөрчлөлтийн хувьд дахин хэмжинэ. Өөрөөр хэлбэл, гадаад валютын дүнг хаалтын ханш ашиглан хүлээн зөвшөөрнө. Гадаад валютаар илэрхийлэгдсэн түүхэн өртгөөр бүртгэдэг бөгөөд гадаад валютын ханшийн эрсдлийн хувьд хейж хийдэг (УСНББОУС 4-ийн 27(б) параграф) мөнгөн бус зүйлсэд энэхүү гажих нөхцлийг мөрдөнө.

Ашиг, алдагдал

Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн дансны үнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөлт нь олон хүчин зүйлсээс хамаардаг. Үүнд: энэ нь ханшийн зөрүү эсвэл дансны үнийн бусад өөрчлөлт эсэх, мөнгөн зүйлсээс (жишээлбэл; ихэнх өрийн хэрэглүүр) эсвэл мөнгөн бус зүйлсээс (жишээлбэл; ихэнх өмчийн хөрөнгө оруулалт) үүссэн эсэх, холбогдох хөрөнгө буюу өр төлбөрийг гадаад валютын ханшийн өөрчлөлтийн эрсдлийн хувьд мөнгөн гүйлгээний хейж гэж сонгосон эсэх, энэ нь гадаад үйл ажиллагааны санхүүгийн тайланг хөрвүүлсэнээс үүссэн эсэх гэх мэт. Гадаад үйл ажиллагааны эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн дансны үнийн өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөх асуудлыг өөр асуултанд (Асуулт Д.2.2-ыг үзнэ үү) авч үзнэ.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн, өндөр магадлалтай урьдчилан таамагласан ажил гүйлгээний мөнгөн гүйлгээний хейж гэж уг мөнгөн зүйлийг сонгосон, ингэснээр (УСНББОУС 41-ийн 140-р параграфт эсвэл УСНББОУС 29-ийн 106-р параграфт заасан) мөнгөн гүйлгээний хейжийн олз, гарзын хүлээн зөвшөөрөлтийн шаардлагуудыг мөрдөхөөс бусад тохиолдолд, тухайн тайлант үед анх хүлээн зөвшөөрсөн эсвэл өмнөх санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн ханшаас өөр ханшаар *мөнгөн зүйлийг* хүлээн зөвшөөрснөөр үүссэн аливаа ханшийн зөрүүг УСНББОУС 4 (УСНББОУС 41-ийн МЗУ224-р параграф, УСНББОУС 4-ийн 32 ба 37-р параграф)-ийн дагуу ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Гадаад валютын хөдөлгөөнтэй холбоотой дансны үнийн бүх өөрчлөлтүүдийг нэг мөр тууштай тайлагнах хэрэгтэй учраас өмнө хүлээн зөвшөөрсөн дүнгээс өөр дүн бүхий гадаад валютаар мөнгөн зүйлийг хүлээн зөвшөөрснөөр үүсэх зөрүүг дээрхтэй адил байдлаар тайлагнана. Мөнгөн зүйлийг санхүүгийн байдлын тайланд хэмжихтэй холбоотой бусад бүх өөрчлөлтүүдийг УСНББОУС 41-ийн дагуу ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Жишээлбэл; байгууллага нь цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг санхүүгийн хөрөнгийн олз, гарзыг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрдөг (УСНББОУС 41-ийн 111 ба МЗУ225-р параграф) боловч тухайн байгууллага нь гадаад валютын ханшийн өөрчлөлтөнд хамаарах дансны үнийн өөрчлөлтийг ямар ч байсан ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө (УСНББОУС 4-ийн 27(а) параграф).

Мөнгөн бус зүйлийн дансны үнийн аливаа өөрчлөлтийг УСНББОУС 41-ийн дагуу ашиг, алдагдалд эсвэл цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө. Жишээлбэл; УСНББОУС 41-ийн 106-р параграфын дагуу толилуулдаг өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтын хувьд, дансны үнийн нийт өөрчлөлтийг, үүн дотроо гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөөг цэвэр хөрөнгө/өмчид тусгана (УСНББОУС 41-ийн МЗУ226-р параграф). Гадаад валютаар илэрхийлсэн, хүлээн зөвшөөрөөгүй арилжааны баталгаа эсвэл өндөр магадлалтай

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

урьдчилан таамагласан ажил гүйлгээний мөнгөн гүйлгээний хейж гэж тухайн мөнгөн бус зүйлийг сонгосон бол (УСНББОУС 41-ийн 140-р параграфт эсвэл УСНББОУС 29-ийн 106-р параграфт заасан) мөнгөн гүйлгээний хейжийн олз, гарзын хүлээн зөвшөөрөлтийн шаардлагуудыг мөрдөнө.

Жишээлбэл; цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг, гадаад валютаар илэрхийлсэн бондын хорогдуулсан өртөг нь гадаад валютаар нэмэгдсэн (үр дүн болох олзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн) боловч түүний бодит үнэ цэнэ нь гадаад валютаар буурснаар (үр дүн болох гарзыг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн) дансны үнийн өөрчлөлтийн зарим хэсгийг цэвэр хөрөнгө/өмчид, харин зарим хэсгийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг тохиолдолд байгууллага нь ашиг, алдагдалд эсвэл цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрөх олз, гарзыг тодорхойлох зорилгоор энэхүү хоёр бүрэлдэхүүн хэсгүүдийг харилцан суутгаж, цэвэр дүнг гаргаж болохгүй.

Д.2.4 Жишиг үнэгүй өмчийн хэрэглүүрийн үнэлгээ

Эдгээр жишиг үнэгүй өмчийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнийг тодорхойлох үед үнэлгээний ямар арга зүй хамгийн тохиромжтой байх вэ?

Улсын секторын байгууллагууд нь жишиг үнэгүй өмчийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо ашиглаж болох үнэлгээний маш олон арга зүй байдаг. УСНББОУС 41 нь үнэлгээний тодорхой нэг арга зүй ашиглахаар заагаагүй, харин хэмжилтийн тохиромжтой арга зүйн сонголттой холбоотойгоор мэргэжлийн шүүн тунгаагч хийж, холбогдох бүх баримт материал болон нөхцөл байдлыг харгалзан үзэхийг сайшаан дэмжсэн байдаг. Тухайн ажил гүйлгээний баримт материал болон нөхцөл байдалд үндэслэн хэрэглэж болох үнэлгээний янз бүрийн арга зүйг Үзүүлэн 1-д үлгэрчлэн харуулав. Энэ нь бүгдийг багтаасан жагсаалт биш юм.

Үзүүлэн 1 – Үнэлгээний хандлага ба үнэлгээний арга зүй	
Үнэлгээний хандлага	Үнэлгээний арга зүй
Зах зээлийн хандлага	<ul style="list-style-type: none">• Санхүүжигчийн ижил буюу төсөөтэй хэрэглүүрийн хувьд төлөгдсөн ажил гүйлгээний үнэ (Үлгэрчилсэн жишээ 23-ыг үзнэ үү)• Зэрэгцүүлэгдэх компанийн үнэлгээний үржүүлэгч
Бусад хандлагууд	<ul style="list-style-type: none">• Дискаунтчилсан мөнгөн гүйлгээний арга (Үлгэрчилсэн жишээ 24-ийг үзнэ үү)• Ногдол ашгийн дискаунтчлалын загвар• Тогтмол өсөлтийн загвар (Үлгэрчилсэн жишээ 25-ыг үзнэ үү)• Капиталжуулалтын загвар• Тохируулсан цэвэр хөрөнгийн арга (Үлгэрчилсэн жишээ 26-г үзнэ үү)

Жишиг үнэгүй өмчийн хэрэглүүрийн эдийн засгийн шинж чанар ба улсын секторын байгууллагад үндэслэлтэйгээр олдох боломжтой мэдээлэл нь үнэлгээний хамгийн тохиромжтой арга зүйг сонгохдоо харгалзан үзвэл зохих хоёр хүчин зүйлс юм. Тухайлбал; зэрэгцүүлэгдэх боломжтой хангалттай олон компаниуд байгаа, эсвэл тухайн ажигласан ажил гүйлгээний суурь үндэслэл болон дэлгэрэнгүй мэдээллийг мэдэж буй тохиолдолд байгууллага нь уг зэрэгцүүлэгдэх компанийн үнэлгээний үржүүлэгчид илүү их ач холбогдол өгөх магадлалтай байдаг. Үүнтэй адилаар, улсын секторын байгууллага нь тухайлбал, дараах тохиолдолд дискаунтчилсан мөнгөн гүйлгээний аргад илүү их ач холбогдол өгөх магадлалтай байдаг:

- Улсын секторын байгууллагын мөнгөн гүйлгээ нь өсөлтийн жигд бус хувь хэмжээтэй тайлант үеүд гэх мэт өвөрмөц шинж чанаруудыг илэрхийлдэг байх (жишээлбэл; хожим нь илүү тогтвортой өсөлтийн түвшин болж, тогтворжсон өндөр өсөлттэй тайлант үе).
- Үүнтэй адилаар, жишиг үнэгүй өмчийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг хэмжих үедээ улсын секторын байгууллага нь тухайн тодорхой баримт материал болон нөхцөл байдалд үндэслэн дүгнэлт гаргаж болох юм (жишээлбэл; хөрөнгө оруулалтын шинж төрөл, хөрөнгө оруулалтын түүх ба хөгжлийн үе шат, санхүүжигчийн хөрөнгө болон өр төлбөрийн шинж төрөл, түүний капиталын бүтэц гэх мэт).

- (в) Тохируулсан цэвэр хөрөнгийн аргыг хэрэглэхэд тохиромжтой байх. Тухайн тодорхой баримт материал болон нөхцөл байдлыг харгалзан үзэхэд, үнэлгээний нэг арга зүй нь нөгөө арга зүйгээс илүү тохиромжтой байж болно.

Үнэлгээний хамгийн тохиромжтой арга зүйг сонгохдоо улсын секторын байгууллагын харгалзан үзэх шаардлагатай зарим хүчин зүйлсэд дараах зүйлс хамаарна (гэхдээ энэ нь бүгдийг багтаасан жагсаалт биш юм):

1. Улсын секторын байгууллагад ул үндэслэлтэйгээр олох боломжтой мэдээлэл;
2. Зах зээлийн нөхцөл байдал;
3. Хөрөнгө оруулалтын цар хүрээ ба хөрөнгө оруулалтын төрөл (богино хугацаат санхүүгийн хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг хэмжих тохиолдолд тухайн зах зээлийн ерөнхий төлөв байдлыг үнэлгээний зарим арга зүйгээр бусдаас илүү сайн тодорхойлдог байж болох юм);
4. Хөрөнгө оруулалтын амьдралын мөчлөг (өөрөөр хэлбэл, тухайн байгууллагын амьдралын мөчлөгийн янз бүрийн үе шатан дахь үнэ цэнийг үнэлгээний зарим арга зүйгээр бусдаас илүү сайн тодорхойлоход нөлөөлдөг байж болох зүйл);
5. Санхүүжигчийн бизнесийн шинж төрөл (тухайлбал; санхүүжигчийн бизнесийн хувьсамтгай буюу мөчлөгт шинж байдлыг үнэлгээний зарим арга зүйгээр бусдаас илүү сайн тодорхойлдог байж болно); ба
6. Байгууллагын үйл ажиллагаа явуулдаг салбар.

Бодит үнэ цэнийн хэмжилтийн арга зүй нь одоогийн зах зээлийн нөхцөл байдлыг тусгах ёстой. Байгууллага нь хэмжилтийн өдрөөр тухайн үнэлгээний арга зүйг туршин сорих замаар одоогийн зах зээлийн нөхцөл байдлыг уг арга зүй тусган илэрхийлж буй эсэхийг магадалж болох юм. Анх хүлээн зөвшөөрөх үед ажил гүйлгээний үнэ нь бодит үнэ цэнийг илэрхийлж байсан бөгөөд хөрөнгө оруулагч нь дараагийн тайлант үеүдэд бодит үнэ цэнийг хэмжихийн тулд ажиглах боломжгүй орц өгөгдөлд үндэслэсэн үнэлгээний арга зүйг ашиглах бол тухайн үнэлгээний арга зүй нь ажил гүйлгээний үнэтэй тэнцүү байгаа эсэхийг туршин шалгах ёстой (хэрэв ажил гүйлгээ нь арилжааны бус бүрэлдэхүүн хэсгийг агуулдаг бол өмчийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг дахин туршин шалгах). Жишиг үнэгүй өмчийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг хэмжилтийн өдрөөр хэмжих үедээ туршин сорилт ашиглах нь уг үнэлгээний арга зүй одоогийн зах зээлийн нөхцөл байдлыг тусгасан гэдгийг тухайн байгууллага магадлан шалгах ба тэрхүү үнэлгээний арга зүйд залруулга хийх шаардлагатай (тухайлбал; уг хэрэглүүрийн хувьд тухайн үнэлгээний арга зүйгээр харгалзан тусгаагүй шинж чанарууд байж болно, эсвэл анхны хүлээн зөвшөөрөлтийн үед байгаагүй шинэ баримт материал тэрхүү хэмжилтийн өдрөөс хойш гарч ирсэн) эсэхийг тодорхойлох зохих дасгал сургуулилт болдог.

Зарим нөхцөл байдалд байгууллага нь бодит үнэ цэнийг тодорхойлох үедээ үнэлгээний нэгээс олон арга зүйг ашиглах шаардлагатай байж болох юм.

Жишиг үнэгүй өмчийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн хэмжилтэнд зориулсан төрөл бүрийн арга зүйн жишээг Үлгэрчилсэн жишээ 23-26-д харуулав.

Д.2.5 Өртөг нь өмчийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн орлон төлөөлөгч болох

Өмчийн хэрэглүүрийн өртгийг дараагийн тайлант үеийн хэмжилтэнд шууд тэр чигээр нь ашиглаж болох уу?

Үгүй. Өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнээр хэмжих ёстой. Гэвч МЗУ140-р параграфт дурдсанчлан, бодит үнэ цэнийг хэмжихэд зориулсан сүүлийн үеийн мэдээлэл бэлэн боломжтой байхгүй тул өртөг нь бодит үнэ цэнийн тохиромжтой тооцоолол байж болно, эсвэл бодит үнэ цэнийн боломжит хэмжилтийн өргөн мужтай тохиолдолд өртөг нь тухайн муж дахь бодит үнэ цэнийн хамгийн сайн тооцооллыг илэрхийлдэг байж болох юм.

Хэсэг Е: Бусад

Е.1 УСНББОУС 41 ба УСНББОУС 2 - Хейжийн нягтлан бодох бүртгэл: Мөнгөн гүйлгээний тайлан

Хейжийн хэрэглүүрээс үүссэн мөнгөн гүйлгээг мөнгөн гүйлгээний тайланд хэрхэн ангилах вэ?

Хейжийн хэрэглүүрүүдээс үүсэх мөнгөн гүйлгээг тухайн хейжийн зүйлээс үүсэх мөнгөн гүйлгээний ангилалд үндэслэн үндсэн үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын ажиллагааны, санхүүгийн ажиллагааны гэж ангилдаг. УСНББОУС 41-ийг тусгахын тулд УСНББОУС 2-д заасан нэр томъёог шинэчлэн баяжуулаагүй байгаа боловч хейжийн хэрэглүүрээс үүсэх мөнгөн гүйлгээний тухайн мөнгөн гүйлгээний тайлан дахь ангилал нь УСНББОУС 41-ийн дагуу хейжийн хэрэглүүр гэж сонгосон тэдгээр хэрэглүүрийн ангилалтай нийцсэн байвал зохино.

Хэсэг Ж: Хөнгөлөлттэй зээл ба арилжааны бус өмчийн ажил гүйлгээ

Ж.1 Хөнгөлөлттэй зээлийн хувьд “зөвхөн үндсэн дүн ба хүүний төлөлт” үнэлгээний дарааллыг тогтоох

Байгууллага нь хөнгөлөлттэй зээл (санхүүгийн хөрөнгө) гаргадаг бол дараагийн тайлант үеийн хэмжилтийн зорилгоор түүний ангиллыг хэзээ үнэлэх вэ?

Байгууллага нь уг хөнгөлөлттэй зээл мөн чанарын хувьд үнэн хэрэгтээ зээл, буцалтгүй тусламж, эздийн хувь оролцоо эсвэл эдгээрийн хослол эсэхийг УСНББОУС 28 ба УСНББОУС 23-ын 42-58-р параграфт заасан зарчмуудыг мөрдсөнөөр юуны өмнө үнэлнэ. Ажил гүйлгээ эсвэл түүний нэг хэсэг нь зээл гэж уг байгууллага тодорхойлсон бол тэрхүү ажил гүйлгээний үнэ нь анх хүлээн зөвшөөрөх үед тухайн зээлийн бодит үнэ цэнийг төлөөлөн илэрхийлэх эсэхийг үнэлнэ. Байгууллага нь МЗУ144-МЗУ155-р параграфт заасан зарчмуудыг ашиглан уг зээлийн бодит үнэ цэнийг тодорхойлно.

Бодит үнэ цэнээр анх хүлээн зөвшөөрсний дараа, байгууллага нь тухайн хөнгөлөлттэй зээлийн ангиллыг 39-44-р параграфын дагуу дараагийн тайлант үеүдэд үнэлэх ба 61-65-р параграфын дагуу хэмжинэ.

Ж.2 Хөнгөлөлттэй зээл ба “зөвхөн үндсэн дүн ба хүүний төлөлт” (ЗҮДХТ) үнэлгээ

Хөнгөлөлттэй зээл нь ЗҮДХТ-ийн нөхцлийг хангадаг уу?

Тийм. Зээлийн төлөлт нь түүний анхны хүлээн зөвшөөрөлтийн үед тодорхойлсон бодит үнэ цэнэд үндэслэдэг тохиолдолд энэ нь зөвхөн үндсэн дүн ба хүүний төлөлтийг тусгана.

Гэвч санхүүгийн хөрөнгө нь тухайн гэрээний мөнгөн гүйлгээний хугацаа буюу дүнг өөрчилж болох тийм гэрээний нөхцлийг (жишээлбэл; тухайн зээлдэгчид тусгайлан хамаарах буцаан төлөлтийн болзошгүй шинж) агуулдаг бол тэрхүү гэрээний нөхцлөөс хамааран уг хэрэглүүрийн хугацаанд үүсэж болох гэрээний мөнгөн гүйлгээ нь зөвхөн үндсэн дүнгийн болон төлөгдөөгүй үндсэн дүнгээс тооцогдох хүүний төлөлтүүд эсэхийг байгууллага нь тодорхойлох ёстой. Хэрэв санхүүгийн хөрөнгийн нөхцлүүд нь аливаа бусад мөнгөн гүйлгээ үүсэхэд хүргэдэг эсвэл үндсэн дүн ба хүүг илэрхийлэх төлбөрүүдтэй үл нийцэх байдлаар мөнгөн гүйлгээг хязгаарладаг бол тухайн санхүүгийн хөрөнгө нь 40(б) болон 41(б) параграфт заасан, нөхцлийг хангахгүй. Ингэж тодорхойлохын тулд байгууллага нь тухайн гэрээний мөнгөн гүйлгээний өөрчлөлтийн өмнө ба дараа үүсэж болох гэрээний мөнгөн гүйлгээг үнэлэх ёстой. Мөн байгууллага нь уг гэрээний мөнгөн гүйлгээний хугацаа буюу дүнг өөрчилж болох аливаа болзошгүй үйл явдлын (өөрөөр хэлбэл, өдөөгчийн) шинж төрлийг үнэлэх шаардлагатай байж болох юм (МЗУ72-МЗУ75-р параграфыг үзнэ үү).

Хөнгөлөлттэй зээлийн нийтлэг шинж нь хүүний хөнгөлөлт юм. Хөнгөлөлттэй зээлийн гэрээний хүүний түвшин тэг (0) байх нь уг хэрэглүүрийг ЗҮДХТ нөхцлийг хангахад саад учруулахгүй юм.

Ж.3 Арилжааны бус бүрэлдэхүүн хэсгийн үнэлгээ

Өмчийн ажил гүйлгээний арилжааны бус бүрэлдэхүүн хэсэг нь уг ажил гүйлгээний зардалтай тэнцүү байж болох уу?

Үгүй. Байгууллага нь төлбөрийн хариуд энгийн хувьцаа гэх мэт өмчийн хэрэглүүр хүлээн авсан тохиолдолд тэрхүү өмчийн хэрэглүүр нь анх хүлээн зөвшөөрөх үед зарим үнэ цэнэтэй байх бөгөөд түүнийг бодит үнэ цэнээр хэмжих ёстой.

Анх хүлээн зөвшөөрөх үед байгууллага нь тухайн хэлцлийн мөн чанарыг шинжилж, уг олгосон төлбөрийн зарим хэсэг нь буцалтгүй тусламж буюу татаас гэх мэт арилжааны бус бүрэлдэхүүн хэсэг эсэхийг үнэлэх ёстой.

Ж.4 Арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн өмчийн хэрэглүүрийн мөн чанарыг шинжлэх

Арилжааны бус ажил гүйлгээнд тусган оруулсан өмчийн хэрэглүүрийг хэрхэн нотлон баталж болох вэ?

Арилжааны бус бүрэлдэхүүн хэсгийг бас агуулдаг ажил гүйлгээний нэг хэсэг байдлаар өмчийн хэрэглүүрийг тусган оруулсан эсэхийг үнэлэхдээ, байгууллага нь УСНББОУС 28-д заасан, өмчийн хэрэглүүрийн тодорхойлолт ба шаардлагуудыг мөрдөнө.

Өмчийн хэрэглүүр оршин буйг нотлох үзүүлэлтэнд дараах зүйлс хамаарч болох юм:

- (а) Хөрөнгө оруулалт хийгдэхээс өмнө эсвэл хөрөнгө оруулалтын хугацаанд тэрхүү өмчийн хэрэглүүрийн шилжүүлэлтийг (буюу ийм шилжүүлэлтийн ангийг) тухайн санхүүжигч байгууллагын цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсэг байдлаар тодорхойлох албан ёсны сонголт.
- (б) Санхүүжигч байгууллагын цэвэр хөрөнгө/өмч дэх борлуулж, шилжүүлж эсвэл эргэлтээс гаргаж болох одоогийн санхүүгийн хувь оролцоог тогтоох буюу нэмэгдүүлэх уг өмчийн хэрэглүүртэй холбоотой албан ёсны хэлцэл.
- (в) Борлуулж, шилжүүлж эсвэл эргэлтээс гаргаж болох өмчийн хэрэглүүрийн хүлээн авалт.

Ж.5 Хөнгөлөлттэй ба үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай зээлийг үнэлэхэд харгалзах хүчин зүйлс

Зээлийг хөнгөлөлттэй эсвэл үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай зээл эсэхийг үнэлэхдээ ямар хүчин зүйлсийг харгалзах хэрэгтэй вэ?

Хөнгөлөлттэй зээл ба үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай зээлийн аль аль нь хөнгөлөлтийн буюу үнэ цэнийн бууралтын бүрэлдэхүүн хэсэг байхгүй адилтгах зээлээс арай бага, ирээдүйн тооцоолсон мөнгөн гүйлгээтэй байдаг.

Өрийн хэрэглүүрийн гаргагч нь тухайн хэрэглүүрийг хөнгөлөлттэй зээл эсвэл үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай зээл гэж ангилах эсэхийг тодорхойлохын тулд түүний мөн чанарыг үнэлдэг.

Санхүүгийн хэрэглүүр нь хөнгөлөлттэй зээл гэдгийг илэрхийлэх шинжүүдэд дараах зүйлс хамаарна:

- Зээлдүүлэгч нь арилжааны бус бүрэлдэхүүн хэсгийг уг зээлийн ажил гүйлгээнд нэгтгэн оруулах зорилготой байх. Ингэснээр зээлдүүлэгч нь хэрэв тухайн ажил гүйлгээг зах зээлийн нөхцлөөр хэлэлцэн тохирсон бол хүлээн авах байсан мөнгөн гүйлгээний зарим хэсгийг чөлөөлөх санаа зорилготой байдаг;
- Хүү ба/буюу үндсэн дүнг хөнгөлөх замаар тухайн санхүүгийн хэрэглүүрийг зах зээлийн түвшнээс доогуур нөхцлөөр гаргадаг; ба
- Тухайн зээлийн гэрээний шинж чанарууд, өөрөөр хэлбэл зах зээлийн бус байдлаар хэлэлцэн тохирсон нөхцлүүд нь хөнгөлөлтгүй буюу зээлийн үнэ цэнийн бууралтгүй адилтгах зээлтэй харьцуулахад уг хэрэглүүрийн ирээдүйн тооцоолсон мөнгөн гүйлгээ буурахад хүргэдэг.

Үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийг (85-86-р параграфыг үзнэ үү) анх үүсэх үед ихэвчлэн зах зээлийн нөхцлөөр олгодог боловч тухайн тохиролцооны гэрээний нөхцлүүдийг уг зээлдэж буй байгууллага биелүүлж чадахгүй гэж үздэг учраас адилтгах хэрэглүүртэй харьцуулахад тооцоолсон арай бага мөнгөн гүйлгээтэй байдаг. Зах зээлийн нөхцлөөр хэлэлцэн тохирсон бол хүлээн авах байсан мөнгөн гүйлгээний зарим хэсгийг чөлөөлөх санаа зорилгоос ялгаатай нь, тухайн зээлдүүлэгч нь уг гэрээний мөнгөн гүйлгээний зарим хэсгийг цуглуулж авах боломжгүй гэж үздэг. Иймээс үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай зээл нь уг ирээдүйн тооцоолсон мөнгөн гүйлгээнээс илүү мөнгөн гүйлгээг тухайн зээлдүүлэгч цуглуулан авах боломжийг илэрхийлдэг. Харин хөнгөлөлттэй зээлийн хувьд уг ирээдүйн тооцоолсон мөнгөн гүйлгээ нь тухайн гэрээний мөнгөн гүйлгээтэй ойролцоо дүнтэй байх буюу нэмэлт ямар нэг мөнгөн гүйлгээ байхгүй гэдгийг илэрхийлнэ.

Ж.6 Үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай, хөнгөлөлттэй зээл

Хөнгөлөлттэй зээл нь үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай зээл байж болох уу?

Тийм. Зарим тохиолдолд мөн үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай, хөнгөлөлттэй зээлийг олгож болох юм. Тухайн санхүүгийн хөрөнгийн ирээдүйн тооцоолсон мөнгөн гүйлгээг муутгах үр нөлөө бүхий нэг буюу хэд хэдэн үйл явдлын улмаас хөнгөлөлттэй зээл нь анх үүсгэх үед зээлийн үнэ цэнийн бууралттай байж болох юм.

Жишээлбэл; үндэсний агаарын тээврийн компанийн дотоод нислэгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхийн тулд Сангийн Яам нь тус агаарын тээврийн компанид жил тутам зээл олгодог. Гэрээнд заасан, жилийн хүү нь тогтмол 6 хувь байдаг. Зээлийг олгох үед зах зээлийн хүүний түвшин 10 хувь байсан гэвэл энэ зөрүү нь хөнгөлөлтийг илэрхийлнэ.

Түүх сөхөж үзвэл, хэдийгээр хөнгөлөлттэй нөхцөлтэй боловч Сангийн Яам нь уг зээлийн гэрээний мөнгөн гүйлгээний ердөө 85 хувийг цуглуулж чаддаг байна. Энэхүү хандлага нь тухайн тайлант үеийн зээлийн гаргалтанд хэвээр хадгалагдана гэж Сангийн Яам үзсэн.

Зээл нь хөнгөлөлтийн нөхцөлтэй, хэдий тийм хөнгөлөлттэй боловч мэдэгдэхүйц зээлийн алдагдал гарахаар хүлээгдэж байгаа тул энэхүү жишээ нь үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай зээлийг илэрхийлнэ.

Хөнгөлөлттэй зээлийн хувьд хүлээгдэж буй зээлийн алдагдал нь уг зээл үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай зээл гэдгийг илэрхийлэх эсэх, эсвэл зээлийн хэвийн алдагдлыг харуулж буй эсэхийг үнэлэх үедээ байгууллага нь тухайн зээлийн ирээдүйн тооцоолсон мөнгөн гүйлгээг муутгах үр нөлөө бүхий нэг буюу хэд хэдэн үйл явдал гарч тохиолдсон эсэхийг харгалзан үздэг.

Хэсэг И: Үр ашигт хүүний арга

И.1 Үр ашигт хүүний аргыг ашиглах шаардлага

Хэрэглүүрийн гаргалтын ажил гүйлгээний зардал, аливаа урамшуулал буюу хөнгөлөлт нь мэдэгдэхүйц дүнтэй биш тохиолдолд хэрэглүүрийн хорогдуулсан өртгийг үр ашигт хүүний арга ашиглан хэмжих нь шулуун шугамын арга ашиглахтай ижил үр дүнд хүргэдэг.

Хэрэглүүрийн нийт дүнг үр ашигт хүүний арга ашиглан хэмжих нь шулуун шугамын арга ашигласантай харьцуулахад материаллаг бус зөрүүтэй тохиолдолд үр ашигт хүүний аргыг ашиглах шаардлагатай юу?

Хэрэглүүрийн хорогдуулсан өртгийн хэмжилт нь үр ашигт хүүний арга ашиглахыг шаарддаг. Гэвч практикт шулуун шугамын арга ашигласнаар үндсэндээ ижил үр дүнтэй байх тохиолдлууд байж болох юм.

УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-ны 10-р параграфт дараах байдлаар заасан: “Тухайн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрдөх ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын талаар хамааралтай ба үнэн зөв илэрхийлэх мэдээллийг агуулсан санхүүгийн тайланг бэлтгэхэд хүргэнэ гэж УСНББОУС3-өөс дүгнэсэн тийм нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг УСНББОУС-д тодорхойлж заадаг. Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрдсөний үр нөлөө нь материаллаг бус тохиолдолд тэдгээр бодлогыг мөрдөхийг шаарддаггүй...”

Хувилбар арга зүй нь, энэ тохиолдолд шулуун шугамын арга нь хорогдуулсан өртгийг үр ашигт хүүний аргаар хэмжсэнтэй үндсэндээ ижил үр дүнд хүргэдэг бол удирдлага нь УСНББОУС 41, *Санхүүгийн Хэрэглүүр-ээр* шаардсанчлан, үр ашигт хүүний аргыг хэрэглэх шаардлагагүй юм.

Өрийн хэрэглүүрийн нийт дүнг үр ашигт хүүний арга болон шулуун шугамын арга ашиглан хэмжихэд яагаад зөрүү үүсэж буйг дараах жишээнд үлгэрчлэн харуулав. А үндэсний засгийн газар нь 100,000 ТН-ийн нэрлэсэн дүнтэй бонд гаргасан. Бондын 10 хувийн өгөөжийг 5 жилийн эцэст түүний дуусгавар хугацаа болох хүртэл жил бүр төлнө. Уг бондыг 3 хувийн хөнгөлөлттэй гаргасан бөгөөд А үндэсний засгийн газар нь ажил гүйлгээний зардалд 2,000 ТН төлөх ёстой.

Хэмжилтийн хоёр арга зүйн аль алины хувьд А үндэсний засгийн газар нь тус хэрэглүүрийн гаргалтаар 95,000 ТН (95,000ТН=100,000ТН-2,000ТН-100,000x3 хувь) хүлээн авсан.

Шулуун шугамын арга

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Шулуун шугамын арга ашиглан хэрэглүүрийн нийт дүнг хэмжих нь хөнгөлөлт болон ажил гүйлгээний зардлыг түүний дуусгавар болох хугацаа хүртэл жигд хуваарилан хорогдуулахыг шаарддаг.

Жил	(а) Тухайн жилийн эхэн дэх нийт дансны үнэ	(б = 100,000 x 10 хувь) Хүүний зардал	(в) Ажил гүйлгээний зардал болон хөнгөлөлтийн хорогдуулалт	(г) Мөнгөн гүйлгээ	(д = а + б + в - г) Тухайн жилийн эцэс дэх нийт дансны үнэ
1	95,000	10,000	1,000	10,000	96,000
2	96,000	10,000	1,000	10,000	97,000
3	97,000	10,000	1,000	10,000	98,000
4	98,000	10,000	1,000	10,000	99,000
5	99,000	10,000	1,000	110,000	-

Үр ашигт хүүний арга

Үр ашигт хүүний арга ашиглан хэрэглүүрийн нийт дүнг хэмжих нь ирээдүйн тооцоолсон мөнгөн зарлагын гүйлгээг түүний хүлээгдэж буй хугацааны туршид тухайн хэрэглүүрийн нийт дансны үнэтэй яг тэнцүү байдлаар дискаунтчлах тийм хүүний түвшинг тооцоолохыг шаарддаг. Бондын тооцоолсон мөнгөн гүйлгээний дискаунтчлал нь 11.37 хувийн үр ашигт хүүний хувь бий болгоход хүргэдэг.

Жил	(а) Тухайн жилийн эхэн дэх нийт дансны үнэ	(б = а x 11.37 хувь) Хүүний зардал	(в) Мөнгөн гүйлгээ	(г = а + б - в) Тухайн жилийн эцэс дэх нийт дансны үнэ
1	95,000	10,797	10,000	95,797
2	95,797	10,888	10,000	96,685
3	96,685	10,989	10,000	97,673
4	97,673	11,101	10,000	98,774
5	98,774	11,226	110,000	-

Бондын нийт дүнг шулуун шугамын арга ашиглан хэмжих нь үр ашигт хүүний арга ашигласантай харьцуулахад материаллаг бус зөрүүтэй эсэхийг үнэлэх үедээ хэмжилтийн өдөр тус бүрээр нийт дүнг зэрэгцүүлж үзнэ, үүнийг доорх хүснэгтэнд дэлгэрэнгүй харуулав.

Жил	Шулуун шугамын арга Тухайн жилийн эхэн дэх нийт дансны үнэ	Үр ашигт хүүний арга Тухайн жилийн эхэн дэх нийт дансны үнэ	Зөрүү
1	95,000	95,000	-
2	96,000	95,797	203
3	97,000	96,685	315
4	98,000	97,673	327
5	99,000	98,774	226

Уг хоёр аргын хоорондох хэмжилтийн зөрүү нь бондын гаргалтын үеийн ажил гүйлгээний зардал ба хөнгөлөлтийн үр дүн юм. Өртөг нь тэг (0) рүү ойртох тусам шулуун шугамын арга эсвэл үр ашигт хүүний арга ашиглан бондыг хэмжсэний хоорондох зөрүү арай бага болно. Өртөг нэмэгдэхийн хэрээр зөрүү нь илүү их дүнтэй болно.

Түүнчлэн, шулуун шугамын аргыг эсвэл үр ашигт хүүний аргыг ашиглах нь материаллаг үр дүнтэй эсэхийг үнэлэх үед жилийн хүүний зардалд үзүүлэх нөлөөлөл цаашид анхаарал хандуулахыг шаардаж болох юм.

Хэсэг К: Өрийн онцгой бүтцийн өөрчлөлт

К.1 Өрийн онцгой бүтцийн өөрчлөлт

Өрийн онцгой бүтцийн өөрчлөлтийг УСНББОУС 41-д авч үзсэн үү?

Тийм. Өрийн онцгой бүтцийн өөрчлөлт нь санхүүгийн өр төлбөрийн засвар өөрчлөлт ба/буюу үл хүлээн зөвшөөрөлтийг хамардаг бөгөөд үүнийг УСНББОУС 41-д авч үзсэн. Өрийн онцгой бүтцийн өөрчлөлтөнд хамаарах шаардлагууд болон заавар удирдамжид дараах зүйлс хамаарна:

- (а) Санхүүгийн өр төлбөрийн анхны болон дараагийн хэмжилтийн шаардлагуудыг 57 ба 64-р параграфт заасан;
- (б) Санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлтийн шаардлагуудыг 35-38-р параграфт заасан;
- (в) Санхүүгийн өр төлбөрийн засвар өөрчлөлтийн хэмжээг үнэлэхэд зориулсан, мөрдөх заавар удирдамжийг МЗУ46-р параграфт заасан;
- (г) Хөнгөлөлттэй нөхцлөөр олгосон зээлийн хувьд мөрдөх заавар удирдамжийг МЗУ118-МЗУ127-р параграфт заасан;

СТОУС 9-ТЭЙ ХАРЬЦУУЛАЛТ

УСНББОУС 41, *Санхүүгийн Хэрэглүүр*-ийг СТОУС 9, *Санхүүгийн Хэрэглүүр-ээс* (үүн дотроо, 2015 оны 12 дугаар сарын 31 хүртэлх нэмэлт өөрчлөлтүүдөөс) үндсэндээ бэлтгэсэн болно. УСНББОУС 41 ба СТОУС 9-ийн хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

- УСНББОУС 41 нь тэг (0) буюу нэрлэсэн төлбөртэйгээр байгуулсан санхүүгийн баталгааны гэрээ болон хөнгөлөлттэй зээл, арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн өмчийн хэрэглүүр, бодит үнэ цэнийн хэмжилтийг тайлагнах талаархи нэмэлт мөрдөх заавар удирдамжийг агуулсан байдаг.
- УСНББОУС 41 нь зарим тохиолдолд СТОУС 9-д дурдсанаас өөр нэр томъёог ашигладаг. Хамгийн том жишээ нь “санхүүгийн үр дүнгийн тайлан” ба “цэвэр хөрөнгө/өмч” гэсэн нэр томъёоны хэрэглээ юм. СТОУС 9 дэх адилтгах нэр томъёо нь “дэлгэрэнгүй орлогын тайлан буюу тусдаа орлогын тайлан (хэрэв толилуулдаг бол)” ба “өмч” юм.
- УСНББОУС 41 нь “орлого” /revenue/ ба “орлого” /income/ нэр томъёог ялган авч үздэггүй. Харин СТОУС 9 нь “орлого” /revenue/ ба “орлого” /income/ нэр томъёог өөр хооронд нь ялган авч үздэг бөгөөд “орлого” /income/ нэр томъёо нь “орлого” /revenue/ нэр томъёоноос илүү өргөн утгатай байдаг.
- СТОУТХ 16, *Гадаад Үйл Ажиллагаанд Оруулсан Цэвэр Хөрөнгө Оруулалтын Хейж* болон СТОУТХ 18, *Санхүүгийн Өр Төлбөрийг Өмчийн Хэрэглүүрээр Барагдуулалт*-ын зарчмуудыг УСНББОУС 41-д бүрэн эрх бүхий хавсралтууд байдлаар тусган оруулсан. НББОУСЗ нь эдгээр СТОУТХ-г тусдаа баримт бичиг байдлаар гаргасан.
- УСНББОУС 41 нь УСНББОУС 29, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*-ээс авч үлдсэн, бодит үнэ цэнийн хэмжилтийн нэмэлт заавар удирдамжийг агуулсан байдаг.

ЗОХИОГЧИЙН ЭРХ, ХУДАЛДААНЫ ТЭМДЭГ, ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Саналын Төсөл, Зөвлөлдөх Баримт Бичиг, Санал Болгосон Практик Удирдамж болон УСНББОУСЗ-ийн бусад хэвлэлүүдийг ДНБХ-оос хэвлэн гаргасан бөгөөд түүний зохиогчийн эрхэд хамаарна.

Энэхүү хэвлэлд тусгагдсан материалуудад итгэл үзүүлэн үйлдэл хийсэн эсвэл үйлдлээ больсоны улмаас хэн нэгэнд хохирол учирсан тохиолдолд хохирол нь хайнга байдал буюу бусад шалтгаанаар үүссэн эсэхээс үл хамааран УСНББОУСЗ болон ДНБХ нь уг хохирлын хувьд хариуцлага хүлээхгүй болно.

‘International Public Sector Accounting Standards Board’ (Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл), ‘International Public Sector Accounting Standards’ (Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт), ‘Recommended Practice Guidelines’ (Санал Болгосон Практик Удирдамж), ‘International Federation of Accountants’ (Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо), ‘IPSASB’ (УСНББОУСЗ), ‘IPSAS’ (УСНББОУС), ‘RPG’ (СБПУ), ‘IFAC’ (ДНБХ), ‘IPSASB’ гэсэн лого, ‘IFAC’ гэсэн лого нь АНУ болон бусад улс орнууд дахь ДНБХ-ны худалдааны тэмдэг буюу бүртгэгдсэн худалдааны тэмдэг ба үйлчилгээний тэмдэг юм.

Зохиогчийн эрх © 2018 оны 8 дугаар сар, Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ). Бүх эрх хамгаалагдсан. Зөвхөн хувьдаа, худалдаа арилжааны бус зорилгоор ашиглахаас бусад тохиолдолд энэхүү баримт бичгийг хувиран олшруулах, хадгалах, шилжүүлэх буюу бусад адилтгах байдлаар ашиглахын тулд ДНБХ-ноос бичгэн зөвшөөрөл авах шаардлагатай. permission@ifac.org хаягаар хандана уу.

ISBN: 978-1-60815-378-7





**Улсын Секторын Нягтлан
Бодох Бүртгэлийн Олон
Улсын Стандартын Зөвлөл™**

529 тавдугаар өргөн чөлөө,
Нью Йорк, Нью Йорк 10017
Утас: + 1 (212) 286-9344
Факс: + 1 (212) 286-9570
www.ipsasb.org

УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр-ийн зарим үг хэллэгийн хувьд орчуулагчийн зүгээс хийсэн тайлбар

№	Параграф буюу лавлагаа	Тайлбар
	13(a)(i)	СТРИПС буюу STRIPS нь Separate Trading of Registered Interest and Principal of Securities-Үнэт Цаасны Нэрлэсэн Хүү ба Үндсэн Төлбөрийн Тусдаа Арилжаа гэсэн үгийн товчлол юм. Тухайлбал; 10 жилийн хугацаатай, жил бүр 10 хувийн нэрлэсэн хүү төлөх бөгөөд тухайн хугацааны эцэст үндсэн дүнг нэг удаа төлөх 100,000ТН-ийн нэрлэсэн дүнтэй бонд байлаа гэхэд үүнийг салгаж, хоёр буюу хэд хэдэн санхүүгийн хэрэглүүр болгож болно. Жишээлбэл; жил бүр буюу нийт 10 удаа төлөх хүүг нэг санхүүгийн хэрэглүүр, 10 жилийн дараа төлөх үндсэн дүнг өөр нэг санхүүгийн хэрэглүүр гэж үзэж болно. Орч.Ч.Д.
	69(a)	Credit-impaired financial asset-Зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгө. Санхүүгийн хөрөнгийн ирээдүйн тооцоолсон мөнгөн гүйлгээг муутгах үр нөлөө бүхий нэг буюу хэд хэдэн үйл явдал гарч тохиолдсон үед уг санхүүгийн хөрөнгийн зээлийн үнэ цэнэ буурсан гэж нэрлэдэг. Орч.Ч.Д.
	119(б)	Spread-Тархалт. Энэ нь хамгийн энгийнээр хэлбэл, борлуулагчийн борлуулах үнэ ба худалдан авагчийн авах үнийн хоорондох зөрүү юм. Гэхдээ практикт олон янзын тохиолдол бүрд бага зэргийн ялгаатай ойлголтыг илэрхийлдэг. Гадаад валютын арилжааны хувьд, энэ нь суурь валютыг борлуулагч борлуулахад бэлэн байгаа үнэ ба тэрхүү валютыг худалдан авагч авахад бэлэн байгаа үнийн хоорондох коэффициентийн зөрүү юм. Жишээлбэл; 1 ам долларыг 1.2 канад доллараар арилжих боломжтой үед үүнийг 1.2/1 (USD/CAD) буюу 1.2 гэсэн коэффициентээр илэрхийлдэг. Investopedia тольд гадаад валютыг ихэвчлэн 5 оронтой тоогоор илэрхийлдэг гэж тайлбарласан байна. Өөрөөр хэлбэл, суурь валютыг, энэ жишээнд ам долларыг худалдан авагч нь 1.2 канад доллараар сольж авахад бэлэн байгаа. Үүнийг бид USD/CAD-ын ханш 120 (өөрөөр хэлбэл, 1.2-ыг 100-гаар үржүүлэх) гэж хэлж болно. Харин борлуулагч нь суурь валют буюу ам долларыг 120.05 борлуулахыг зөвшөөрнө гэж үзье. Энэ тохиолдолд зөрүү буюу суурийн тархалт нь 0.05 (120.05-120) цент буюу 0.0005 доллар байна. Өөр нэг жишээ нь; санхүүгийн байгууллага нь харилцагчдын хүүтэй хадгаламжинд жилийн 10 хувийн хүү төлдөг, харин өөрийн олгодог зээлийн жилийн хүү нь 11 хувь гэвэл, цэвэр хүүний түвшний тархалт нь 1 хувь буюу 0.01 байна. Үнэт цаасны хувьд тухайлбал, опционы зах зээлийн үнэ нь 5 ам доллар, харин түүнийг хэрэгжүүлсэн үнэ нь 5.5 ам доллар гэвэл тархалт нь 0.5 ам доллар буюу 0.1 ((5.5-5)/5) болно. Мөн түүнчлэн, хүү, хувьцаа, бараа бүтээгдэхүүнийг өөр бусад дундаж буюу бенчмарк (стандарт) үзүүлэлттэй зэрэгцүүлж, тархалтыг тодорхойлдог. Орч.Ч.Д.
	135(a)	Central counterparty-Клирингийн төв байгууллага гэдэг нь ажил гүйлгээнд оролцогч нөгөө талын зээлийн эрсдлийг хүлээх бөгөөд валютын арилжаа, үнэт цаас, опцион, үүсмэл хэрэглүүрийн арилжааны хувьд клирингийн болон бусад барагдуулах үйлчилгээг үзүүлдэг санхүүгийн байгууллага юм. Клирингийн байгууллага нь янз бүрийн үнэт цаасны худалдан авалт ба борлуулалтыг тохируулах, нэг санхүүгийн байгууллагаас нөгөө санхүүгийн байгууллагад мөнгийг шилжүүлэх, мөнгө сангийн бэлэн байдлыг шалган магадлах, шилжүүлгийг бүртгэх, худалдан авагчид үнэт цаасыг хүргэх гэх мэт олон төрлийн клирингийн үйл ажиллагаа гүйцэтгэдэг. Орч.Ч.Д.
	МЗУ22	Beneficial interest-Жинхэнэ хувь оролцоо. Beneficial owner (жинхэнэ эзэн) гэдэг нь хөрөнгийн хуулийн эрх өөр нэг этгээдэд хамаарч байх үед өмч дэх тодорхой хөрөнгийн эрх (“захиран зарцуулах болон өмчлөлийн эрхийн бичиг”) тухайн этгээдэд хамаарах тохиолдолд хэрэглэдэг хуулийн нэр

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

		<p>томъёо юм. Жишээлбэл; хамтын сангийн хувьцааг итгэмжлэлийн банкаар эсвэл үнэт цаасыг брокероор дамжуулан эзэмшдэг боловч хөрөнгийн бодит өмчлөгч нь “жинхэнэ эзэн” байна. Хэдий тийм боловч хадгалан хамгаалах болон тохиромжтой байдлын үүднээс банк эсвэл брокер нь өмчлөлийн эрхийг эзэмшиж болох бөгөөд тэд нэрлэсэн буюу хуулийн эзэмшигч юм. Харин хөрөнгийн өмчлөгч нь жинхэнэ эзэн болно. Орч.Ч.Д.</p>
	МЗУ24(в)	<p>Out of the money put or call option-Мөнгөн алдагдалтай буцаах опцион эсвэл дуудах опцион. Дуудах опционы хувьд түүнийг хэрэгжүүлэх үнэ (өөрөөр хэлбэл ийм опционыг ашигласнаар үнэт цаасыг худалдан авах үнэ) нь суурь хөрөнгийн (үнэт цаасны) зах зээлийн үнээс их бол мөнгөн алдагдалтай гэнэ. Харин буцаах опционы хувьд түүнийг хэрэгжүүлэх үнэ (өөрөөр хэлбэл ийм опционыг ашигласнаар үнэт цаасыг худалдах үнэ) нь суурь хөрөнгийн зах зээлийн үнээс бага бол мөнгөн алдагдалтай гэнэ. Жишээлбэл; нэгж хувьцааг 12 ам доллараар худалдан авах дуудах опционы нэгжийг 3 ам доллараар буюу нийт 100 ширхэг опцион худалдан авсан гэж үзье. Хувьцааны зах зээлийн үнэ 10 ам доллар байх үед дуудах опционыг хэрэгжүүлвэл 1,200 /12x100/ ам доллараар 100 ширхэг хувьцаа худалдаж авах ба зах зээлийн үнээр буцааж борлуулвал 1,000 /10x100/ ам доллар болох бөгөөд зөрүү 200 ам доллар нь мөнгөн алдагдал болно. Гэхдээ ийм опционоос хүлээх бодит алдагдал нь 500 /1,000-1,200-300/ ам доллар байна. Орч.Ч.Д.</p>
	МЗУ25(г)	<p>In the money put or call option-Мөнгөн ашигтай буцаах опцион эсвэл дуудах опцион. Дуудах опционы хувьд түүнийг хэрэгжүүлэх үнэ (өөрөөр хэлбэл ийм опционыг ашигласнаар үнэт цаасыг худалдан авах үнэ) нь суурь хөрөнгийн (үнэт цаасны) зах зээлийн үнээс бага бол мөнгөн ашигтай гэнэ. Харин буцаах опционы хувьд түүнийг хэрэгжүүлэх үнэ (өөрөөр хэлбэл ийм опционыг ашигласнаар үнэт цаасыг худалдах үнэ) нь суурь хөрөнгийн зах зээлийн үнээс их бол мөнгөн ашигтай гэнэ. Жишээлбэл; нэгж хувьцааг 12 ам доллараар худалдан авах дуудах опционы нэгжийг 3 ам доллараар буюу нийт 100 ширхэг опцион худалдан авсан гэж үзье. Хувьцааны зах зээлийн үнэ 16 ам доллар байх үед дуудах опционыг хэрэгжүүлж, 1,200 /12x100/ ам доллараар 100 ширхэг хувьцаа худалдаж аваад буцаагаад зах зээлийн үнээр буюу 1,600 ам доллараар борлуулж болно. Энэ тохиолдолд мөнгөн ашиг нь 400 /1,600-1,200/ ам доллар байна. Харин бодит ашиг нь 100 /1,600-1,200-300/ ам доллар байна. Зах зээлийн үнэ 14.5 ам доллар байх үед опционыг хэрэгжүүлвэл хэдийгээр 50 /1,450-1,200-300/ ам долларын бодит алдагдалтай боловч мөнгөн ашиг нь 250 /1,450-1,200/ ам доллар байна. Орч.Ч.Д.</p>
	МЗУ34(в)	<p>at the money put or call option-Мөнгөн ашиггүй буцаах опцион эсвэл дуудах опцион. Буцаах буюу дуудах опционы хэрэгжүүлэх үнэ нь суурь хөрөнгийн зах зээлийн үнэтэй тэнцүү бол мөнгөн ашиггүй гэнэ. Орч.Ч.Д.</p>
	МЗУ37(д)	<p>Wash sale transaction-Угаах борлуулалтын ажил гүйлгээ. Жишээлбэл; татвар ногдуулах өндөр орлоготой боловч санхүүгийн хөрөнгийг борлуулахад алдагдал хүлээхээр байгаа тохиолдолд хөрөнгө оруулагч нь татварыг бууруулахын тулд угаах борлуулалтын аргыг хэрэглэдэг. Орч.Ч.Д.</p>
	МЗУ56	<p>Bank run буюу a run on the bank’s deposit-Банкны харилцах, хадгаламжаас байгууллага болон хувь хүмүүс мөнгөө бөөнөөр нэгэн зэрэг татаж авахын хэлдэг. Орч.Ч.Д.</p>
	МЗУ75	<p>Linked to inflation index-Инфляцийн индекстэй уялдсан. Тухайн валютаар илэрхийлэгдэх (төгрөг) инфляци нэмэгдэхэд инфляцийн индексээр санхүүгийн хэрэглүүрийн нэрлэсэн дүнг нэмэгдүүлнэ. 100.0 төгрөгийн нэрлэсэн үнэтэй бонд байлаа гэхэд инфляцийн индекс 1.05 буюу инфляци 5-н хувиар нэмэгдсэн бол нэрлэсэн дүнг 105 болгож, түүнээс хүүг тооцно. Харин үүн дээр leveraged inflation index гэвэл инфляцийн түвшинг хөшүүрэгдэж нэмнэ. Жишээлбэл; 2:1 инфляцийн хөшүүрэгтэй гэвэл энэ</p>

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

		жишээнд инфляци 5 хувиар нэмэгдсэн тул 2 гэсэн харьцаагаар хөшүүрэгдэж, 10 хувь болгох буюу бондын нэрлэсэн дүнг 100.0 төгрөгөөс 110.0 төгрөг болгож, үндсэн дүнг түүнчлэн үүнээс тооцогдох хүүг төлнө. Харин эсрэгээр, инфляци буурсан (дефляци), жишээлбэл; хэрэглээний индекс сөрөг буюу 2 хувиар буурсан гэж үзье. Ийм тохиолдолд хэрэв үндсэн дүнг хамгаалаагүй бол 100.0 төгрөгийн нэрлэсэн үнэтэй бондыг 98.0 төгрөгөөр буцаан төлөх ба энэ дүнгээс хүүг тооцно. Хэрэв үндсэн дүнг хамгаалсан гэвэл бондын нэрлэсэн дүнг 100.0 төгрөгөөр буцаан төлөх боловч хүүг 98.0 төгрөгөөс тооцоолно. Орч.Ч.Д.
	МЗУ96	Structured product-Нийлмэл бүтээгдэхүүн гэдэг нь нэг үнэт цаас, үнэт цаасны сагс, опцион, индекс, хэрэглээний бараа, өр, гадаад валют гэх мэт нэг буюу хэд хэдэн үүсмэл хэрэглүүрт үндэслэсэн санхүүгийн хэрэглүүр юм. АНУ-ын Үнэт Цаас Арилжааны Комиссын Дүрэм 134-д нийлмэл бүтээгдэхүүнийг “мөнгөн гүйлгээний шинж байдал нь нэг буюу хэд хэдэн индекс үзүүлэлтүүдээс хамаардаг үнэт цаас буюу түүний хөрөнгө оруулагчийн өгөөж ба гаргагчийн төлөх төлбөр нь суурь хөрөнгүүдийн үнэ цэнэ, индекс, хүүний түвшин, мөнгөн гүйлгээний өөрчлөлтөөс нөхцөлт хамааралтай буюу өндөр мэдрэмжтэй байх “дагалдах форвард гэрээ” эсвэл опцион эсвэл үнэт цаас юм” гэж тодорхойлсон байна. Харин “дагалдах форвард” гэдэг нь холимог хэрэглүүрийн өмчийн шинжийг илэрхийлэх санхүүгийн хэрэглүүр юм. Орч.Ч.Д.
	МЗУ145	Bid-ask spread-Санал болгосон худалдах-худалдан авах үнийн тархалт. Bid нь “гуйх” гэсэн үгнээс үүсэлтэй бөгөөд санал өгөх үнэ юм. Өөрөөр хэлбэл, худалдан авагч нь тэдээр худалдаж авъя, авч болно гэж санал болгосон үнэ байдаг. Харин ask нь “асуух, шаардах” гэсэн үгнээс үүсэлтэй бөгөөд борлуулагч нь тэдээр худалдан ав гэж санал болгосон худалдан борлуулах үнийг илэрийлдэг. Энэхүү хоёр үнийн хоорондох зөрүүг тархалт гэж нэрлэдэг. Жишээлбэл; борлуулагч нь 100ТН-ээр борлуулах саналтай, худалдан авагч нь 80ТН-ээр худалдан авах саналтай бол тэдгээрийн хоорондох зөрүү 20ТН нь тархалт болно. Эндээс тархалтын муж нь 0-20ТН гэж үзэж болно. Түүнчлэн, 80ТН-ээс 100ТН-ийн хоорондох үнийг тархалтын муж доторх үнэ гэж бас хэлдэг. Орч.Ч.Д.
	МЗУ158(в)	Loan syndication-Зээлийн нэгдэл гэдэг нь нэг зээлдэгчид зориулсан зээлийн янз бүрийн хэсгүүдийг санхүүжүүлэх зээлдүүлэгчдийн бүлгийг хамруулах үйл явц юм. Нэг зээлдэгчийн хүссэн зээл нь маш их дүнтэй, иймээс нэг зээлдүүлэгч олгох боломжгүй бол олон зээлдүүлэгч нь зээлийн нэгдэл үүсгэснээр тухайн зээлийг олгодог. Орч.Ч.Д.
	МЗУ159	Credit spread-Зээлийн тархалт. Credit spread-Зээлийн тархалт гэдэг нь АНУ-ын Төрийн сангийн бондын өгөөж ба түүнээс чанар муутай боловч ижил дуусгавар болох хугацаатай өрийн үнэт цаасны өгөөж хоорондох зөрүү юм. АНУ-ын Төрийн сангаас гаргасан үнэт цаас нь эрсдэлгүй байдаг тул санхүүгийн зах зээлд түүнийг бенчмарк (стандарт) хэмжигдэхүүн болгон ашигладаг байна. Өрийн үнэт цаас гаргагч төлбөрөө үл барагдуулах эрсдэл их байхын хэрээр түүний үнэт цаасны зээлийн тархалт их байдаг. Зээлийн тархалтыг хувиар биш, тоон дүнгээр илэрхийлдэг. Жишээлбэл; АНУ-ын Төрийн сангийн бондын хүү жилд 4%, үнэт цаас гаргаж буй компанийн санхүүгийн хэрэглүүрийн зээлийн хүү жилд 7.5% гэвэл, зээлийн тархалт нь 350 байна. Орч.Ч.Д.
	МЗУ259(в)(i)	Brent буюу Brent гэдэг нь газрын тосны тогтоцын Broom, Rannoch, Etive, Ness, Tarbert гэсэн 5 давхаргын нэрийн эхний үсгээр зохиосон товчилсон үг юм. Brent нь шингэн, тунгалаг газрын тосны дэлхий худалдааны ангилал бөгөөд түүний үнийг худалдаа, арилжаа хийх бенчмарк үнэ болгон ашигладаг. Түүхий нефтийг Баруун Техасын, Brentийн, Дубайн, Таписын, Минасын, ОПЕК-ийн гэж байршлаар ангилдаг бөгөөд Brent нь Хойд тэнгисийн Brent, Нинианы зэрэг нийт 15 ордуудаас олборлодог газрын тос юм байна. Орч.Ч.Д.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

МЗУ298	Long position-Нэмэгдэх төлөв байдал гэдэг нь хувьцаа, бараа бүтээгдэхүүн, валют гэх мэт хөрөнгийн үнэ цэнэ нэмэгдэнэ гэсэн хүлээлттэйгээр түүнийг худалдан авахыг хэлдэг. Харин short position-Буурах төлөв байдал гэдэг нь хөрөнгийн үнэ цэнэ буурна гэсэн хүлээлттэйгээр түүнийг борлуулахыг хэлнэ. Орч.Ч.Д.
УСНББОУС 30, Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга-д оруулсан нэмэлт өөрчлөлт-ийн ХЗУ44	Repo буюу Repurchase agreement (монголоор галиглавал ‘репо’, орчуулвал ‘буцаан худалдан авах’ гэсэн утгатай) нь үнэт цаасыг борлуулж, ялимгүй өндөр үнээр буцаан худалдан авах богино хугацаат хэлцэл юм. Орч.Ч.Д.
ҮЖ14	Leverage-Хөшүүрэг. Компанийн өрийн капиталыг өмчийн капиталд хуваасан харьцаа юм. Орч.Ч.Д.
ҮЖ14	Coverage ratio-Хүү нөхөлтийн харьцаа. Хүү, татвар, элэгдэл, хорогдуулгын өмнөх ашгийг хүүний зардалд хуваасан харьцаа бөгөөд зарим үед Times-interest-earned гэж нэрлэдэг буюу “Хүүг хэдэн удаа нугалах ашиг олсон” гэдгийг илэрхийлдэг. Орч.Ч.Д.
ҮЖ14	Headroom-Хоосон зай. Энэ нь үгчилвэл, “толгой дээрх орон зай” гэсэн утгатай тухайлбал, машинд сууж байхад толгойн орой ба машины кабины дотор талын тааз хоорондох сул зайг хэлдэг. Ерөнхийдөө, босоо чиглэлийн, дотоод сул орон зай юм. Харин нягтлан бодох бүртгэл, санхүүгийн хувьд, бизнест шаардлагатай мөнгө ба одоо бэлэн боломжтой байгаа мөнгө хоорондох зөрүүг илэрхийлдэг. Орч.Ч.Д.
ҮЖ18	Loan-to-value (LTV) ratio-Зээл-үнэ цэнэ (ЗҮЦ)-ийн харьцаа гэдэг нь зээлийн дүнг тухайн үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнэд хуваасан харьцаа юм. Ингэхдээ тэрхүү үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнийг зээлдүүлэгч нь үнэлж тогтоодог. Орч.Ч.Д.
ҮЖ27(б)	Investment grade-Хөрөнгө оруулалтын үнэ цэнэт. Non-investment grade-Хөрөнгө оруулалтын бус үнэ цэнэт. Компанийн зээлийн чанар нь “Стандарт энд Пүүрс”, эсвэл “Мүүдис”-ийн зэрэглэлээр ВВВ буюу түүнээс дээш үнэлгээтэй бол “хөрөнгө оруулалтын үнэ цэнэт”, харин ВВВ-ээс доош үнэлгээтэй бол “хөрөнгө оруулалтын бус үнэ цэнэт” гэж нэрлэдэг. Орч.Ч.Д.
ҮЖ27(в)	Yield to maturity-Дуусгавар хугацаа хүртэлх өгөөж. Үүнийг мөн “данс тооцооны өгөөж”, “эргэлтээс гаргалтын өгөөж” гэж нэрлэдэг бөгөөд бондыг түүний хугацаа дуусах хүртэл эзэмшвэл олох өгөөжийг илэрхийлдэг. Ирээдүйд олох хүү, үндсэн дүнгийн мөнгөн гүйлгээг одоогийн үнэ цэнэд харьцуулах замаар дуусгавар хугацаа хүртэлх өгөөжийг тооцоолдог. Орч.Ч.Д.
ҮЖ34	Bullet loan-Найрсаг зээл. Энэ нь зээлийн үндсэн дүнг, түүнчлэн зарим үед хүү ба үндсэн дүнг тухайн зээлийн гэрээний хугацааны эцэст төлөх зээл юм. Үүнийг албан бус, зохиомол нэр томъёо гэж тайлбарласан байна. Bullet гэдэг үг нь сум, бөмбөг, дугуй хар цэг гэх мэт утгатайгаас гадна хар ярианд маш сайн, гоё, янзын, лайтай гоё зэрэг утгатай байдаг. Орч.Ч.Д.
ҮЖ58	Revolving loan-Эргэлтийн уян зээл гэдэг нь тодорхой хэмжээний зээлийг авч, буцаан төлж, дахин зээлдэн авах боломжийг зээлдэгчид олгодог, мөн олгосон зээлээ буцаан татан авах буюу төлүүлэх боломжийг зээлдүүлэгчид олгодог тодорхой тогтсон хугацаагүй, уян хатан зээл юм. Орч.Ч.Д.
ҮЖ86	Op-market swap-Зах зээлийн түвшний своп. Өнөөгийн цэвэр үнэ цэнэ нь тэг байх хүүний түвшний своп буюу гадаад валютын своп юм. Орч.Ч.Д.
ҮЖ183	Terminal value-Терминал үнэ цэнэ. Терминал гэдэг үг нь эцэс, зах, төгсгөл гэсэн утгатай бөгөөд мөнгөн гүйлгээний прогнозын эцэс дэх үнэ цэнэ юм. Хөрөнгийн ашиглалтын хугацааны эцэс дэх үлдэх үнэ цэнэ (residual value) нь өчүүхэн бага байдаг бол терминал үнэ цэнэ нь нэлээд их дүнтэй байж болох төдийгүй цаашид өсөх хандлагыг ч илэрхийлж болно. Өөрөөр хэлбэл, энэ нь хөрөнгийн ашиглалтын хугацааны эцэс дэх үнэ цэнэ биш, зөвхөн прогнозын эцэс дэх үнэ цэнийг илэрхийлдэг тул үлдэх үнэ цэнээс эрс ялгаатай юм. Орч.Ч.Д.

УСНББОУС 41-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР